

القرآن الكريم

КУРАН  
КАРИМ

БА МОНГОЛ  
УТГА АГУУЛГА



ТУРК УЛСЫН ШАШНЫ ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ХЭВЛЭЛ /  
DİYANET İŞLERİ BAŞKANLIĞI YAYINLARI :1715  
ЭХ СУРВАЛЖ НОМУУД / KAYNAK ESERLER : 213

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ / GENEL KOORDİNATÖR  
ПРОФ. ДОК. ХУРИЕ МАРТИ / PROF. DR. HURİYE MARTI

ХЭВЛЭЛИЙГ ХАРИУЦСАН ЭРХЛЭГЧ / YAYIN YÖNETMENİ  
ПРОФ. ДОК. ФАТИХ КУРТ / DR. FATİH KURT

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ / KOORDİNASYON  
ЮНУС ИҮКСЕЛ / YUNUS YÜKSEL

МОНГОЛ ОРЧУУЛГЫГ БЭЛТГЭСЭН / MEALİ HAZIRLAYAN  
ШАШИН СУДЛАЛЫН МАГИСТР, АРАБ ХЭЛ-УРАН ЗОХИОЛЫН БАГШ:  
МАРХАБАГИЙН САЛИХ

ИСЛАМ СУДЛААЧ: БЭЖЭЭГИЙН БАТТОГТОХ  
КОМПЬЮТЕРИЙН ЭХИЙГ БЭЛТГЭСЭН:

ЧОЙСҮРЭНДОРЖИЙН ЭРДЭНЭБУЛГАН  
ОРЧУУЛГЫГ ХЯНАН ТОХИОЛДУУЛЖ, НАЙРУУЛАН ЗАССАН: МОНГОЛЫН  
ЗОХИОЛЧДЫН ЭВЛЭЛИЙН ГИШҮҮН, МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЬЯАТ  
ЗҮТГЭЛТЭН, ПРОФ ДОКТОР (PHD) ТАУКЕЙН СУЛТАН

ISBN 978-625-7137-06-5

2020-06-Y-0003-1715

СЕРТИФИКАТ № / SERTİFİKA NO: 12930

НОМ, СУРАХ БИЧГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ КОМИСС: /  
ESER İNCELEME KOMİSYON KARARI: 23.12.2019/130

1. P ХЭВЛЭЛ • АНКАРА • 2020

ХЭВЛЭЛ / BASKI

**TDV/İ**

YAYIN MATBAACILIK TİC. İŞLETMESİ

+90 312 354 91 31

ДИЗАЙН / TASARIM

МЕХМЕТ АЛИ КИРЖА

УГУР АЛТАНТОП

© ТУРКИЙН ШАШНЫ ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР /  
DİYANET İŞLERİ BAŞKANLIĞI

ХОЛБОО БАРИХ / İLETİŞİM

ШАШНЫ НОМ ХЭВЛЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГАДААД ХЭЛ, АЯЛГУУ ДЭЭРХ НОМ ХЭВЛЭЛИЙН ХЭЛТЭС

DİNİ YAYINLAR GENEL MÜDÜRLÜĞÜ

YABANCI DİL VE LEHÇELERDE YAYINLAR DAİRE BAŞKANLIĞI

TELEFONE: +90 312 295 72 81 • FAX: +90 312 284 72 88

E-MAIL / E-POSTA: YABANCIDILLER@DIYANET.GOV.TR

• KUR'AN-I KERİM MOĞALCA MEALİ •

الْقُرْآنُ الْكَرِيمُ

КУРАН СУДРЫН  
МОНГОЛ УТГА АГУУЛГА



## 1. СУРЕ ФАТИХА

Мекке-д илгээгдсэн. 7 айлдвар.

1. (Рахман) Машид энэрэлт, (Рахим) нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.
2. Бүхий л сайшаал ертөнцийн Эзэн Аллахад зохимой.
3. Аллах машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй.
4. Тэр үнэмшлийн өдрийн (ертөнцийн төгсгөлийн) эзэн.
5. Бид гагцхүү Чам дор сүсэглэн мөргөх бөгөөд зөвхөн Чамаас тусламж гуйна!
6. Биднийг шулуун замаараа хөтлөгтүн.
7. Чиний хилэгнэлд өртөгсөд болон төөрөлдөгсдийн замаар бус, Өөрийнхөө хайр ивээлд багтагсадын замаар хөтлөн соёрхогтун.

## 2. СУРЕ БАКАРА

Мадина-д илгээгдсэн. 286 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Алиф, Лам, Мим.
2. Энэ сударт огтхон ч эргэлзэх хэрэггүй, сүсэглэгчдийг зөв замд хөтлөгч мөн.
3. Тэд далдын хүчинд итгэцгээдэг, уншлага мөргөлөө зохих дэг жаягаар үйлдэцгээдэг, өөрсөд нь хүртээсэн хишгийг (Аллахын төлөө) зарцуулцгаадаг.
4. Тэд, Чамд (Мухаммед) болон Чамаас өмнөх илгээгдсэн (судруудад) итгэцгээдэг, мөн нөгөө ертөнцөд (хойд насанд) эргэлзээгүй итгэцгээдэг.
5. Ийнхүү тэд л Эзэнтний шулуун замаар дөтлөгсөд, гагцхүү тэд л хүсэл мөрөөдөлдөө хүрцгээх болно.
6. Ондoo итгэл үнэмшилтэй хүмүүст анхааруулсан ч, анхааруулаагүй ч ялгаагүй, тэд сүсэглэн залбирахгүй.
7. Аллах тэдний цохилох зүрх, сонсох чихийг битүүлчихсэн, харах нүдэнд нь харанхуй хөшиг оршдог. Үнэн шударгыг сонсохгүй, үзэхгүй. Тэд хойд насандаа хагуу гэгсгээлтэй учирна.
8. Зарим хүмүүс итгэдэггүй мөртлөө “Бид Аллахад болон хойд насны төлөө итгэн залбирдаг” гэж хэлэх нь бий.

9. Тэд Аллахыг, бас ариун сүсэгтнүүдийг мэхлэхийг оролддог, Үнэндээ зөвхөн өөрсдийгөө мэхлэж байгаагаа үл ухаарна.
10. Тэдний зүрх сэтгэл (хоёр нүүрт, агаа жөтөө гэгч) өвчинд баригджээ, Аллах тэдний өвчнийг улам хүндрүүлсэн. Тэд худлаа ярьсныхаа төлөө энэхүү хатуу гэсгээлд учирна.
11. Тэдэнд : “Газар дэлхий дээр үймээн самуун бүү тарь” гэж хэлвээс, тэд : “Бид гагцхүү засаж залруулагчид” гэж хэлнэ
12. Анхаарна уу! Хэрэг дээр тэд өөрсдөө үймээн самуун дэгдээгчид, даанч тэд үүнийгээ үл ухаарна.
13. Тэдэнд : “Үнэн сүсэгтний адил чин үнэнээсээ сүсэглэгтүн” гэж хэлвээс, тэд : “Мунхагуудын адил сүсэглэх гэж үү дээ?” гэгцгээнэ. Мэдэж авцгаана уу, үнэндээ тэд өөрсдийгөө үл ухаарах мунхагууд мөн.
14. Тэд үнэн сүсэгтнүүдтэй учирахдаа : “Бид ч сүсэглэсэн!” гэгцгээдэг. Хэрэв шайтан буюу чөтгөр шуламуудтай буйдхан үлдэхээрээ : “Бид чинь үнэндээ та нартайгаа хамт байгаа шүү, зүгээр л тэднийг тохуурхаж байгаа юм” гэгцгээдэг.
15. (Тохуурхсаныхаа төлөө) Аллах тэдний өөрсдөөр нь тохуурхдаг бөгөөд төөрөлдөгсдийн хамт мунхаг болгон улам төөрөгдүүлнэ.
16. Үнэндээ тэд зөв замыг төөрөгдлөөр арилжин авагсад. Тийм учраас ийнхүү арилжаанаасаа ашиг хонжоо олдоггүй, зөв замыг ч олдоггүй.
17. Тэд (харанхуйд) гал асааж эргэн тойрноо гэрэлтүүлмэгц Аллах тэдний гэрлийг унтрааж, гүн харанхуйд хоцорсон хүн лүүгээ адил мэлмий нь хаагдана.
18. (Тэд) дүлий (сайн сайханыг үл сонсоно), хэлгүй (сайн сайханыг үл ярина), сохор (сайн сайханыг үл харна). Тиймээс тэд чин үнэнийг эс олцгооно.
19. Эс бөгөөс (тэд) түнэр харанхуйд тэнгэрээс асгарах аянгат бороонд цохиулан, аянганд нэрвэгдэн үхэхээс айж балмагдан, хуруугаараа чихээ бөглөхийн адил байх болно. Аллах сүсэг бишрэлгүй амьтадын байдлыг сайн мэднэ.
20. Цахилах аянга тэдний харааг бүрэлгэх шахна, тэд аянга цахилах мөчид алхаж, гэрэл бүдгэрэн харанхуйлахад саатаж зогсоно. Хэрэв Аллах хүсвэл тэдний сонсгол болон харах мэлмийг үгүй хийж чадна. Үнэндээ Аллах бүхнийг чадах хүчтэй.
21. Аяа, хүмүүс минь ээ! Та болон та нарын өмнөхүүдийг бүтээсэн Аллахад мөргөн залбирагтун. Ингэвээс сүсэг бишрэлийн эзэд болцгооно.
22. Аллах та нарын төлөө газрыг дэвсгэр, тэнгэрийг цамхаг болгон бүтээсэн, тэнгэрээс бороо оруулан, та нарт хувь хишиг болгон төрөл бүрийн үр жимсийг ургуулсан. Энэхүү үнэнийг мэдэж байгаа мөртлөө Аллахтай аливааг бүү эн зэрэгцүүл!

23. Хэрэв Бидний үнэнч боол (Мухаммедэд) буулгасан, Куранд эргэлзэж байх аваас үүнтэй адилтгах нэгэн бүлэг сударыг зохиогтун! Хэрэв та нар шударга байвал, Аллах-аас бусад өөрсдийн гэрчүүдээ дуудаж хэлсэн бүхнийхээ үнэн мөнийг нотлогтун!
24. Хэрвээ тэгж эс чадвал, хэзээ ч хийж чадахгүй. Иймд, хүмүүн болон чулуун түлшнээс бүрэлдсэн, сүсэг бишрэлгүй этгээдэд зориулагдсан тамын галаас болгоомжлогтун!
25. (Аяа, Мухаммед) чин үнэнчээр сүсэглэгсэд, сайн үйлс бүтээгсдийн хувьд хаяагаар нь гол горхи хоржигнон урсах диваажинд очих баярт мэдээг дуулга!. Тэр диваажинд байдаг үр жимснээс хишиг хүртэх тоолонд: “энэхүү буян хишиг бидэнд өмнөх ертөнцөд хүртээсэнтэй төстэй” гэлцэнэ.(Гэхдээ тэрхүү жимсний дүр төрх нь өмнөх ертөнцийнхтэй адил боловч амт нь огт төсөөгүй байх аж.) Тэдний төлөө тэнд (цэвэр ариун охид) хань болох бүсгүйчүүд ч бас байх болно. Тэд тэндээ үүрд мөнх үлдэнэ.
26. Үнэндээ Аллах шумуулыг, тэрнээс арай илүү оршихуйг жишээ болгон өгөхөөс цааргалахгүй. Сүсэгтнүүд түүнийг Аллахаас (ирсэн) чин үнэн гэдэгт итгэдэг. Харин үл итгэгчид : “Аллах, энэ жишээгээр юуг харуулахыг хүссэн бэ?” гэцгээдэг. Аллах үүгээр олон хүнийг (үл бишрэгсэдийг) төөрөгдүүлдэг, бас олон хүнийг (сүсэглэн бишрэгсэдийг) зөв замд нь залдаг. Харин гагцхүү нүгэлтнүүдийг төөрөгдүүлдэг.
27. Тэд (бүтэлгүй этгээдүүд), Аллахад амлалт өгчихөөд дараа нь амлалтаасаа буцдаг. Аллахаас тогтоон төлөвшүүлэхийг зарлигдсан харилцаа, эв нэгдэл, амар амгаланг эвдэн, даян дэлхийд үймээн самуун дэгдээнэ. Үнэндээ тэд үүний хохирлыг өөрсдөө амсдаг юм.
28. Та нар Аллахад яагаад үл итгэцгээнэ вэ? Та нарыг амьгүй байхад амилуулж, цаг нь болоход бас л үхүүлж, дараа нь дахин амилуулна. Тэгээд (хамгийн сүүлд) тайлан тавихын тулд Аллахын өмнө очигцоох болно.
29. Аллах дэлхий дээрх бүхнийг та нарын төлөө бүтээсэн, дараа нь тэнгэрийг бүтээж, түүнийг долоон давхар болгон байршуулсан. Тэр бүхнийг зүй ёсоор мэдэгч бөлгөө.
30. (Аяа, Мухаммед) Нэгэнтээ Эзэнтэн чинь Мэлэкүүдэд буюу тэнгэрийн элчүүддээ хандан, “Би газар дэлхий дээр залгамжлагчаа бүтээнэ” гэжээ. Мэлэкүүд: “Газар дэлхийд үймээн самуун дэгдээж, цус урсгах нэгнийг бүтээх юм биш биз? Чухамхүү бид Чамайг онцгой хүндэтгэн дээдэлж, ариун шүтээн хэмээн эрхэмлэдэг” гэжээ. Хариуд нь Аллах: “Үнэндээ Би та нарын мэдэхгүйг мэднэ” гэв.
31. Аллах, Адамд бүхий л зүйлийн нэрсийг зааж сургасан. Дараа нь тэдгээрийг мэлэкүүдэд буюу тэнгэрийн элчүүдэд харуулан, “Хэрэв та нар үнэнээр хэлдэг бол Надад тэдгээрийн нэрсийг нэрлэгтүн” гэв.

32. Мэлэкүүд (тэнгэрийн элчүүд): Чи үлэмж их дээдэс мөн. Бид Чиний зааж сургаснаас өөр зүйлийг мэдэхгүй. Чи үнэндээ бүхнийг мэдэгч, үлэмж их ухааны эзэн билээ” гэцгээв.
33. Аллах : “Аяа, Адам! Тэдэнд эдгээрийн нэрсийг хэлээд өг.” гэв. Адам, мэлэкүүдэд тэдгээр зүйлсийн нэрсийг хэлмэгц Аллах “Газар тэнгэрийн ид шидийг болон та нарын ил далд үйлдлийг ч Бид мэднэ гээгүйсэн бил үү?” гэсэн.
34. Мэлэкүүдэд хандан (тэнгэрийн элчүүдэд) : “Адамыг хүндэтгэн мэхийцгээ” гэхэд тэд цөм мэхийн ёсолж хүндэтгэл үзүүлэв. Гагцхүү Иблис (чөтгөр шулам) л татгалзан эсэргүүцэж, биеэ тоосны улмаас сүсэг бишрэлгүй хоцров.
35. Бид Адамд хандан : “Аяа, Адам! Чи ханьтайгаа хамт диваажинд суурьш, тэнд хүссэнээрээ идэж ууцгаа. Гагцхүү энэхүү модны үр жимсэнд бүү хүр. Хэрэв гар хүрсэн байвал нүгэлтэн болцгооно” гэж сануулсан.
36. Тэр хоёрыг чөтгөр шулам уруу татан гэнэдүүлж, идэхийг хориглосон жимсийг идүүлэн буруутан болгосноос тэд суурьшсан газар (диваажингаас) хөөгдөв. Тэгээд тэдэнд (Адам, Хауа, Чөтгөр гуравт): “Үүнээс хойш бие биедээ өштөн дайсан болж газарт буугтун! Тодорхой хугацаанд газар дэлхийд суурьшин, газрыг ашиглан амьдарцгаа” хэмээн зарлигдав.
37. Тийнхүү, Адам Эзэнтнийхээ сургаал үгийг хүлээн авч хүлцэл өчин залбирав. Аллах түүний наминчалыг хүлээн зөвшөөрсөн. Учир нь Аллах гэмшил хүлцэлийг хүлээн авагч, үлэмж энэрэн нигүүлсэгч юм.
38. Бид тэдэнд : “ Тэндээс (диваажин) бүгдээрээ буугтун. Та нарт миний зүгээс нэгэн зам заагч (Аллахын элч) ирэхэд нь хэн Миний заасан замаар яваваас тэдний хувьд ямар нэгэн айдас түгшүүр, зовлон зүдгүүр үгүй” гэсэн билээ.
39. Үл сүсэглэгчид, Бидний айлдваруудыг үгүйсгэгчид бол угтаа тамынхан, тэндээ үүрд үлдэцгээнэ.
40. Аяа, Израйлын үр садаа! Миний та нарт хүртээсэн хувь хишигийг эргэн санацгааж, амлалтандаа хүрцгээгтүн. Тэгвэл би ч гэсэн та нарт өгсөн амлалтандаа хурье. Гагцхүү надаас айж эмээгтүн.
41. Миний, та нарт илгээсэн Тауратыг (Тора-г) бататгасан Куран сударт итгэгтүн. Түүнд үл итгэгчдийн анхдагч бүү бологтун. Миний айлдваруудыг өчүүхэн үнээр бүү наймаалцагтун, мөн надаас эмээгтүн.
42. Та нар үнэн, худал хоёрыг мэдсээр байж бүү хутгагтун. Үнэнийг бүү нууцлагтун.
43. Уншлага мөргөлөө ёсчлон бүрэн үйлдэцгээ, ариуслын өглөгөө өгцгөө, Рукуг (мэхийн ёслол) үйлдэгсэдтэй хамтдаа та нар ч гэсэн рукуг (мэхийн ёслол) үйлдэцгээ.
44. Та нар өөрийгөө умартаж, бусдад нигүүлсэнгүй байхыг тушаана гэж



- үү? Та нар номыг (Тауратыг) уншдаг хүмүүс шүү дээ, үүнийг үнэхээр эс ухаарна гэж үү?
45. Тэвчээр болон уншлага мөргөлөөр Аллахаас дэм тус хүсэгтүн. Үнэндээ чин сэтгэлтэй хүмүүсээс бусдад үүний дарамт их ээ.
  46. Тэд (Үнэн сэтгэлээсээ сүсэглэгчид), өөрийн Эзэнтэйгээ үнэхээр учирахаа, бас Түүн рүү эргэж очихоо чин сэтгэлээсээ итгэдэг.
  47. Аяа, Израйлын үр садаа! Та нарт илгээсэн Миний хишгийг, бас (нэгэн цагт) та нарыг ертөнцөд давуутай өргөмжилснийг минь санацгаагтун.
  48. Хэн нэгний төлөө нөгөө нэг нь үл нигүүлсэх, хэн нэгний ивээл нөгөөд нь үл тус болох, хэнээс ч үнэ төлөөс үл нэхэх, хэнээс ч тусламж авч эс чадах тэрхүү цаг мөчөөс (нөгөө ертөнцөөс) айгтун!
  49. Та нарыг зовоон тарчилгасан, охидуудыг чинь амьд үлдээж, хөвгүүдийг чинь хөнөөсөн Фиргауны бүлгээс Бид та нарыг аварсан. Энэ бол Эзэнтнээс та нарыг сорьсон агуу шалгалт байлаа.
  50. Та нарын төлөө далайг хаг ярж, та нарыг аварч, мөн Фиргауны бүлгийг нүдэн дээр чинь далайд живүүлсэн.
  51. Бид Муса-д дөчин шөнийн амлалт өгсөн. Тэрхүү хугацаа дуусмагц Тауратыг илгээв. Харин та нар түүний дараа нэгэн тугалыг бурханчлан шүтэж, өөрсдийнхөө толгойд зовлон хураасан.
  52. Дараа нь гэмшин хүлцэнэ байх гэж бид өршөөсөн.
  53. Тухайн үед та нарыг зөв замд оруулах гэж, зөв бурууг ялгагч судар Тауратыг Муса-д илгээсэн.
  54. Тэгэхэд Муса, ард олондоо хандан : “ Аяа, ард зон минь ээ! Та бүхэн, тугалыг бурханчилан шүтэж, өөрсдийгөө хууран мэхэллээ. Одоо бүхнийг Бүтээгч эзнээс уучлал эрж, наминчлал гуйж, тугалыг бурханы адил шүтсэн хорон муу санаатнуудаа устгацгаа. Бүтээгч Эзэнтнийхээ өмнө ингэсэн нь өлзийтэй байх болно. Аллах та нарын наминчлалыг хүлээж авна. Яагаад гэвэл Тэр хүлцэл наминчлалыг хүлээн авдаг, үлэмж нигүүлсэгч мөн” гэв.
  55. Тийнхүү ярихад та “Хүеэ, Муса! Бид Аллахыг өөрсдийн нүдээр харахаас нааш чиний үгэнд итгэхгүй.” гэж хэлцгээсэн. Тэрхэн мөчид даруй тэнгэр ниргэж аянга буусан, үүнийг ч та нар нүдээрээ үзээ биз дээ.
  56. Дараа нь хүлцэл өчих биз хэмээн та нарыг үхсэний чинь дараа дахин амилуулсан.
  57. Та нарыг үүлээр сүүдэрлэсэн. Мөн та нарт зориулж тэнгэрээс ид шидтэй халваа болон бөднө шувууг буулгаж, “хүртээсэн хишгээс ариун тансаг амттайг нь идэцгээ” гэлээ. Тэд бидэнд муу юм хийж чадаагүй, харин ч өөрсдөө зовж зүдэрсэн.
  58. Мөн тэгээд, Бид Мусагаар дамжуулан “ Энэ тосгон руу орогтун, бас

- тэнд хүссэнээрээ ханатал хооллогтун, хаалгаар нь мэхийн залбирч орогтун. “Аяа, Их Эзэн минь, биднийг өршөөж хайрла.” хэмээгтүн, “Бид та нарын нүглийг өршөөж, сайн үйлс хийгсэдэд илүү буян хайрлана” гэж хэлцгээсэн.
59. Тэр үед, тэдний доторх зальхай этгээдүүд, Бидний үгийг гуйвууллаа. Танхайран самуун дэгдээсний төлөө тэр зальхай этгээдүүдэд тэнгэрээс аюултай гэсгээл буулгасан.
60. Энэ үеэр Муса Ард түмнийхээ төлөө ундны ус гуйсан. Бид түүнд хандан: “Таягаараа чулууг цохь” гэж хэлсэн. Тэрхэн мөчид уг чулуунаас арван хоёр булаг бургилан ундарч, овог бүр өөрсдийн ус уух газраа мэдэж авсан. “Аллахын хишгээс хооллож, ундаалагтун. Харин газар дэлхий дээр үймээн самуун тарьж, гай зовлон бүү үйлдэгтүн” гэж Бид захилаа.
61. Хэсэг хугацаа өнгөрөхөд бөднө шувууны мах болон халваагаар хооллосон Израйлын үр садунд та нар: “Аяа, Муса! Бид ганц төрлийн хүнсээр тэсэж чадахгүй нь. Чи бидний төлөө Эзэнтэндээ залбирч гуйгаач, тэр бидэнд газар дэлхий дээр ургадаг хүнсний ногоо, өргөст хэмх, сармис, вандуй, сонгино гаргаж өгөг” гэгцгээсэн. Муса хариуд нь: “Та нар сайхан юмыг муу юмаар солихыг хүсэж байна гэж үү? Тийм бол нэгэн хот руу ( Египет ) очигтоо! Тэнд та нарын хүссэн бүхэн байгаа” гэсэн. Эцэст нь тэд зовлон, зүдгүүрт нэрвэгдэж, Аллахыг хилэгнүүлсэн. Үүний шалтгаан нь тэд Аллахын айлдваруудыг үгүйсгэж, Аллахын элчүүдийг хэлмэгдүүлэн хөнөөсөн. Түүгээр ч үл барам Аллахыг эсэргүүцэн хэт их даварсан явдал юм.
62. Сүсэглэн бишрэгчид, Еврейчүүд, Христчүүд, Сабийчүүд (од эрхэс, тэнгэрийг шүтэгсэд) дотороос Аллахад, хойд насны ертөнцөд итгэн сайн үйлс үйлдэгсэд Эзэнтний зүгээс гарцаагүй буян хишиг хүртэнэ. (Куран судар илгээгдэхээс өмнө нь ийм айлдсан.) Тэд айдас хүйдэс уй гашуу үл үзнэ.
63. Тэр үед та нарын толгой дээр “Тур” уулыг өргөж авчираад тулган байж ам өчиг авч : “Хойд насны зовлонгоос сэрэмжлүүлэхийн тулд, Бидний илгээсэн Таурат судрыг хатуу дагаж, түүнд буй айлдвар журмыг санаж явагтун.” гэж анхааруулсан билээ.
64. Хожим та нар амлалтаасаа буцаж, нүүр буруулсан. Аллахын өршөөл, энэрэл байхгүйсэн бол, гарцаагүй хохирогсод болох байсан.
65. Өөрсдийн чинь дотроос бямба гаригт загас барихгүй байх тухай хэм хэмжээ (шарият) зөрчигсөдийг та нар сайн мэдэж байгаа. Бид тэдэнд хандан, “Нэр төрөө гутааж сармагчин болморууд!” гэж хэлцгээсэн.
66. Энэхүү гэсгээлийг тэднээс өмнөх болон хойч үеийнхний хувьд сургаамж, үнэн сүсэгтнүүдийн хувьд сургаал болгосон.
67. Нэгнтээ Муса өөрийнхөө зон олондоо хандан “Аллах та нарт нэгэн

- үнээгээр тахил өргөхийг тушаана” гэв. Тэгтэл тэд “Чи биднээр тохуурхаагүй биздээ” гэж хэлцгээсэн. Муса: “Би мунхаг харанхуй, бүдүүлгээр тохуурхагч болохгүйн тулд итгэж залбирна.” гэж хэлсэн.
68. Тэд (Мусагийн зон олон): “Бидний төлөө Эзэнтэндээ залбир, тэр бидэнд үнээ ямар байхыг хэлэгтүн” гэгцгээсэн. Муса: “Эзэнтэн Үнээний хувьд хөгшин ч биш, залуу ч биш, энэ хоёрын завсарынх байг” гэсэн. Зарлигийг ёсоор болгогтун” гэв.
69. Тэд цаашлан, “Бидний төлөө Эзэнтэндээ наминчлан залбир, бидэнд үнээний өнгө зүс ямар байхыг тайлбарлагтун” гэгцгээв. Муса: “Эзэнтэн тэр үнээний өнгө зүс нь шав шар, харсан хүмүүсийг баясган гэрэлтүүлмээр байг” гэж зарлигдсан” гэв.
70. Тэд: “Бидний төлөө Эзэнтэндээ наминчлан залбир, түүний ямар үнээ болохыг бидэнд тайлбарлагтун. Яагаад гэвэл бидний хувьд ойлгомжгүй байна. Хэрэв Аллах хүсвэл бидний зам өлзийтэй болох биз” гэгцгээсэн.
71. Муса: “Эзэнтэн ингэж хэлж байна; “Тэр үнээ нь газар хагалдаггүй, газар усалдаггүй, эдэлгээнд сургагдаагүй, эрүүл, элдэв өнгө согоггүй байг” гэсэн гэв. Тэд хариуд нь: “Одоо л яг зөв зүйтэй ойлгууллаа” гэгцгээсэн. Тэд дургүй ч гэсэн үнээгээр тахил өргөцгөөв. Тэд бараг л тахил өргөхгүй байх байлаа.
72. Тэр үед, та нар нэг хүнийг алж, түүнийг хэн хөнөөсөн талаар хоорондоо маргалдацгаасан. Үнэндээ Аллах, та нарын нууцалсаныг илчлэнэ.
73. Аллах та нарт Мусагаар уламжлан: “Үнээний зарим мөчөөр шарилыг нь цохигтун (Энэ мөчид үхсэн хүн амилан, цустай гартныг заагаад өгнө.)” гэж хэлсэн. Аллах ийнхүү үхэгсэдийг дахин амилуулдаг, та нарыг ухаараг гээд өөрийнхөө ер бусын гайхамшигаа харуулдаг.
74. (Хүеэ, Иудэйчүүд ээ!) Үүнээс хойш та нарын зүрх сэтгэл хөрч, яг л чулуу шиг, түүнээс ч хатуу болсон. Яагаад гэвэл чулууны завсараас нь булагын ус урсах тохиолдол байдаг. Чулуу хагарах үед завсараас аяндаа ус гардаг явдал бий. Мөн зарим нэг чулуу Аллахаас айхдаа бутран унадаг. Ийнхүү, чулуу зөөлөрөх явдал байдаг ч та нарын зүрх ер зөөлөрдөггүй. Аллах та нарын үйлдэл бүхнийг анзаарагч байдаг.
75. (Аяа, мусулманчуудаа) үнэндээ тэд (Иудэйчүүд) сүсэглэн итгэнэ гэж горьдоод байгаа юм биш биз дээ? Тэдний нэг хэсэг нь Аллахын үгийг (Тауратыг) сонсож, ойлгосон ч, зориуд гуйвуулчихсан.
76. Тэд сүсэгтнүүдтэй учирвал: “Бид сүсэглэсэн” гэгцгээдэг. Өөр хоорондоо тусдаа уулзахдаа: “Аллахын өмнө мусулманчууд та нарын эсрэг нотолгоо болгохын тулд Аллахын (Тауратад) та нарт нээж өгсөн үнэнийг (Гэгээн элч Мухаммедийн шинж төрхийг) хэлээд л байх уу? Та нар ухаарахгүй байна гэж үү дээ?” гэнэ.
77. Өөрсдийнхөө ил далд үйлсийг Аллах мэдэж байгааг тэд мэддэггүй юм болов уу?

78. Тэдний дунд байгаа бичиг үсэг үл мэдэгчид нь: Таурат номыг (Тораг) мэддэггүй. Зөвхөн худал хов живийг мэднэ. Хоосон мөрөөдөлд автана.
79. Хөөрхийлөлтэй тэд, өөрийн гараар (Тауратыг засаж) ном бичээд, түүнийгээ өчүүхэн үнээр борлуулахын тулд, “Энэ бол Аллахын зүгээс ирсэн ном” гэлцдэгийг яана гэж! Түүнийг өөрсдийн гараар бичсэн нь (Тауратыг гуйвуулсан нь) даанч харамсалтаяа,! Ийнхүү наймаалах нь бузар аргаар ашиг хонжоо олох нь харамсмаар юм гээч!
80. Тэд: “Өөрсдийгөө тоотой хэдэн өдөр юу л бол гэхээс биш, тамын галд шатахгүй” гэж үзнэ. (Аяа, Мухаммед) Чи тэдэнд: “Аллах та нарт тийм амлалт өгсөн юм уу? Хэрэв тийм бол, Аллах өгсөн амлалтаасаа хэзээ ч үл буцна, Эсвэл та нар өөрсдийнхөө үл мэдэх зүйлээ Аллахын нэрийн өмнөөс хэлэх гэж үү?” хэмээн хэл!
81. Эсрэгээр муу үйл хийж, нүгэл үйлдэгсэд бол тамынхан, тэд тэндээ үүрд үлдэцгээнэ.
82. Харин төгс сүсэглэж, сайн үйлс бүтээгчид диваажингийхан. Тэд тэндээ мөнхөд оршицгооно.
83. Нэгэнтээ Бид Израйлын үр садаас, “Аллахаас бусдад бүү наминчлан залбирцгаа, эцэг эхдээ үнэнч байцгаа, ахан дүүстэй эвтэй найрсаг байгаарай, өнчин өрөөсөн, үгээгүй ядууст энэрэлтэй хандацгаа, хүмүүст сайн сайхныг ярьцгаагтун, уншлага мөргөлөө ёсоор бүрэн төгс үйлдэгтүн, ариуслын өглөг (зекаг) өгөгтүн” гэж хатуу захиж амлалтыг нь авсан. Та нарын цөөхөн хэдээс бусад чинь амлалтаасаа буцсан. Ер нь та нар угаасаа амлалтандаа хүрээгүй.
84. Мөн нэгэнтээ “Нэг нэгнийхээ цусыг бүү урсга, нэг нэгнийгээ нутаг уснаасаа бүү хөөгөөрэй” гэж та нараас хатуу амлалт авсан. Та нар үүнийг хүлээн зөвшөөрч, өөрсдөө гэрчлэн нотолсон билээ.
85. Дараа нь та нар амлалтаасаа няцаж, бие биенээ хөнөөж, өөрсдийнхөө дотроос нэг хэсгийг нутгаасаа хөөж гаргасан. Урван тэрсэлж, гэмт хэрэг үйлдэх замаар эсрэг талынханд тусалсан. Хэрэв тэд олзлогдоход хүрвэл төлөөс өгч аварцгаадаг. Үнэндээ тэднийг нутгаас нь хөөж гаргах нь нүгэл болох билээ. Та нар Таурат (Тора) номынхоо зарим хэсэгт нь итгэж, зарим хэсгийг нь үгүйсгэдэг юм уу? Ер нь та нарын ийнхүү үйлдэлийн гэгсгээл нь энэ яваа насандаа зовж зүдрэн, хойд насандаа шившигтэйгээр гэгсгээлд нэрвэгдэх явдал мөн. Учир нь Аллах та нарын хийсэн үйлийг мэдэж байгаа.
86. Тэд нөгөө ертөнцөө энэ яваа насныхаа амьжиргаагаараа арилжин авагсад, Тиймээс тэдний гэгсгээл эс зөөлөрнө, тэдэнд ямар ч тусламж эс үзүүлнэ.
87. Үнэндээ, бид Мусад Таурат (Тораг) судрыг өгсөн. Үүний дараа ар араас нь гэгээн элчүүдийг илгээв. Бид бас Мариямын хүү Иса-д ер бусын гайхамшигтай чанарыг өгч, түүнийг Рух-уль-Кудус буюу Жабрейл

элчээр дэмжүүлэв. Та нарын сэтгэлд үл нийцсэн зүйл авчирсан гэгээн элч ирэх тоолонд, та нар их зан гаргана гэж үү? Та нар Иса, Муса мэт гэгээн элч нарын заримыг нь үгүйсгэж, (Закария, Яхия нарын) заримыг нь хөнөөсөн шүү дээ!

88. Тэд “Бидний итгэл үнэмшил маань бүдгэрсэн” гэгцгээсэн. Тийм биш ээ! Үл тоомсорлон, биеэ тоосны төлөө Аллах тэднийг харааж зүхсэн. Ер нь тэдний дундаас төгс сүсэглэсэн нь тун цөөхөн.
89. Аллахын зүгээс тэдний гарт байгаа Таурат (Тораг) судрыг баталгаажуулах судар (Куран) ирэхэд түүнийг үгүйсгэцгээв. Тэд үүний өмнө (гэгээн элч Мухаммедын нэрээр) буруу номтнуудын эсрэг тусламж гуйж байсан. Тэгтэл өөрсдийнх нь таньж мэддэг чин үнэн (Куран судар) ирэхэд түүнийг бас үгүйсгэсэн. Итгэл, сүсэггүй амьтадад Аллахын хараал тусга.
90. Тэд, Аллахын илгээсэн Куран судрыг үгүйсгэх шалтгаан нь Аллах өөрийн хүссэн боолоо гэгээн элч болгосон атаархлаас үүдэлтэй. Улмаар тэд Аллахын хилэгнэлийг дахин дахин хүртлээ. Тэд өөрсдийн дур зоргоор арилжсан арилжаа нь ямар муу зүйл байв аа! Үл итгэгчдийг хамгийн муу гэгсгээл хүлээж байдаг.
91. Тэдэнд : “Аллахын илгээсэн судард (Куранд) сүсэглэгтүн” гэвэл, тэд : “Зөвхөн бидэнд илгээгдсэн Тауратад (Торад) сүсэглэнэ” гэгцгээж, хожим илгээгдсэн Кураныг үгүйсгэв. Хэрэг дээр (Куран) судар бол, тэдний гарт байгаа Тауратыг (Тораг) баталгаажуулах чин үнэн судар юм. (Аяа, Мухаммед) чи тэдэнд : “Хэрэв та нар Тауратад (Торад) итгэдэг юм бол, өмнө нь яагаад Аллахын гэгээн элч нарыг хөнөөсөн юм бэ?” хэмээн хэл.
92. Муса та нарт үнэнхүү нотолгоотой ер бусын гайхамшгийг авчирсан, гэтэл Мусаг (Тур уул руу) явсан хойно та нар тугалыг бурханчлан шүтэцгээсэн. Та нар ийнхүү харгислал үйлдэцгээв.
93. Бид та нарын толгой дээр “Тур” уулыг өргөж авчираад андгай авсан : “бидний илгээсэн номыг (Тораг) хүндэтгэн бариарай, мөн түүнийг сонсогтун”- хэмээхэд : “Бид сонслоо, эсэргүүцэж байна” гэгцгээсэн. Учир нь тэдний үл тоомсорлосноос болж тугалыг хайрлах сэтгэл тэдний зүрхэнд нь гүн шигдсэн. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Төгс сүсэгтэн болцгоо, та нарын сүсэглэл ямар муухай зүйлийг тушаадаг юм бэ?” гэж хэл.
94. Тэдэнд хэлэгтүн : “Хэрэв Аллахын ивээл дэх нөгөө ертөнцийн орон (диваажин) бусад хүмүүсийн хувьд бус, зөвхөн та нарынх бол бас та нарын энэ үгс үнэн бол, алив үхлийг хурдан ирээсэй гэж хүсэгтүн.”
95. Өмнө нь хийсэн олон нүгэлтэй тул тэд хэзээ ч хурдан үхэхийг хүсэхгүй. Аллах, зальхай этгээдүүдийг зүй ёсоор мэднэ.
96. Үнэндээ чи, тэднийг амьдрал дээр бүх хүмүүсээс давуу, мөн олон

бурхан шүтэгчдээс илүү амьдрахыг мөрөөддөг, бас тэдний хэн нь ч мянган жил амьдрах хүсэлтэйг нь олж харах болно. Харин олон жил амьдрах нь тэднийг гэгсгээлээс аврахгүй. Аллах тэдний гэм зэмийг тодхон харж байдаг.

97. (Аяа, Мухаммед) үүнийг хэлэгтүн : “Хэн нэг нь Жабрейлд өштөн болвол тэр Аллахын дайсан. Учир нь Жабрейл Аллахын тушаалаар илгээгдсэн судруудыг нотлон багатгагч, зөв замд залагч, бас мусулманчуудыг баярлуулагч, куран судрыг чиний зүрхэнд хоногшуулагч мөн.
98. Хэн нэг нь Аллахад, Аллахын мэлэүүдэд (тэнгэрийн элчүүдэд), гэгээн элчүүдэд, бас Жабрейлд, Микайлд хонзогнон өштөн болвол, Аллах үл сүсэглэгчдийн өштөн нь байх болно.
99. Бид чамд яруу тод айлдваруудыг илгээсэн. Түүнийг зөвхөн зөв замаас хазайгчид л эсэргүүцдэг.
100. Хэдэнтээ хэлэлцээр хийх бүрт тэдний нэг хэсэг нь түүнийг зөрчдөг байсан биз дээ? Тэдний олонх нь Тауратад (Торад) итгэдэггүй юм.
101. Аллахын зүгээс тэдний гарт байгаа Таурат (Тораг) судрыг багатгасан гэгээн элч (Мухаммед) ирэх үед ном илгээгдсэн зон олны нэг хэсэг нь үүнийг мэдэхгүй царайлан, Аллахын Таурат судрыг ар руугаа шийдсэн.
102. Тэд Сүлейманы хаанчлалын үед чөтгөр шулмын илбэдэх уншлагыг даган хууртагдсан. Сүлейман үл итгэгч, илбэчин болоогүй, гэхдээ чөтгөр шуламнууд нь хүмүүст илбэдэн хуурахыг зааж сүсэггүй болов. Тэд (шуламнууд) Вавилон дахь Хаарут ба Маарут нэртэй хоёр мэлэкт (тэнгэрийн элчид) илгээсэн илбэдэх аргыг хүмүүст заадаг байлаа. Тэр хоёр мэлэкт янз бүрийн хүмүүст илбэ ухааныг зааж өгөхөөс өмнө : “Бид сонжиж үзнэ, үл сүсэглэгч битгий болоорой” гэж хэлдэгсэн. Гэтэл тэд энэ хоёроос эхнэр, нөхөрийг эвдрэлцүүлэх илбийг суралцдаг байв. Гэхдээ, Аллахын зөвшөөрөлгүйгээр илбэдэж хэнд ч хор хөнөөл учруулж чаддаггүй байлаа. Тийнхүү, тэд өөрсдөд нь ашиг тусгүй зүйлийг суралцсан. Тэд Тауратыг (Тораг) орхин илбийг худалдаж авсан хүнд нөгөө ертөнцөд ямарч хувь хишиг байхгүй гэдгийг сайн мэдэж байсан. Тэд өөрстөө худалдаж авч байгаа зүйл нь ямар муухай гэдгийг мэддэг ч болоосой!
103. Хэрэв тэд наминчлан сүсэглэж, Аллагаас айж эмээсэн бол Аллах тэдэнд буян хишиг хайрлах байсан. Тэд үүнийг мэдсэн сэн бол гээч!
104. Аяа, төгс сүсэглэгсдээ! (Гэгээн элчдэд) “Ра’ина (биднийг ажиглагтун)” гэж бүү хэлэгтүн, “унзурна (биднийг хараач)” хэмээн хэлж, түүний үгийг сонсогтун. Буруу номтнууд хойд насандаа зовлонг гэгсгээл үзнэ.
105. Үл сүсэгтэнгүүд, ариун судар эзэмшигчид, олон бурхан шүтэгчид (Аллахыг хань нөхөртэй гэж үзэгчид) та нарт Эзэнтгээс ирэх сайн сайханыг хэзээч хүсэхгүй. Аллах энэрэн хайрлах хүндээ өөрийн

- ивээл хүндэтгэлийг (гэгээн элч болох боломжыг) зориулдаг, Аллах бол өгөөмөр энэрлийн эзэн билээ.
106. Бид аль нэгэн айлдварыг хүчингүй болгох ба мартуулах аваас, түүний оронд түүнээс арай илүүг нь, эсвэл төстэйг нь илгээнэ. Аллах аливааг эрхшээх чадалтайг чи мэдэхгүй гэж үү!
  107. Тэнгэр ба газар гагцхүү Аллахын өмч гэдгийг чи мэдэхгүй гэж үү! Та нарт Аллахаас өөр нөмөр нөөлөг, ивээн тэтгэгч, туслагч үгүй.
  108. Та нар өмнө нь Мусаг байцаасан шигээ өөрсдийнхөө гэгээн элчийг бас л байцаахыг хүсэж байна уу? Хэрвээ хэн нэгэн сүсэг бишрэлээ үл итгэлээр солих аваас тэр зөв замаас төөрөгдсөн байх болно
  109. Ариун судар эзэмшигчдийн олонх нь, чин үнэн (ислам шашин) тодорхой болсны дараа, агаа-жөтөөнд автан та нарыг сүсэг бишрэлээс чинь холдуулж, буруу номтон болгохыг хүсэцгээдэг. Аллахаас зарлиг ирэх хүртэл тэднийг уучилж, үл тоосугай. Үнэндээ Аллах бүхнийг эрхшээх чадалтай юм.
  110. Уншлага мөргөлөө ёсчлон үйлдэгтүн, ариуслын өглөг өгөгтүн. Та нар өөрсдийнхөө төлөө хийсэн сайн үйлс бүхнийгээ Аллахын ивээлээр олно. Эргэлзээгүй, Аллах та нарын юу хийж байгааг бүрэн дүүрэн харж байдаг.
  111. Тэд : “Еврейчүүд болон Христосчуудаас өөр хэн ч хэзээ ч, диваажинд орохгүй” гэж хэлцгээсэн. Энэ нь тэдний хий хоосон мөрөөдөл. (Аяа, Мухаммед): “Та нарын үгс үнэн бол нотолгоо гаргаж үзүүлэгтүн” гэж хэл.
  112. Үгүй ээ, тийм биш, Хэн нэгэн өөрийгөө Аллахад даатган сайн үйлс хийх аваас, хариу ивээлийг Эзэнтнээс хүртэх бөгөөд тэдэнд ямар ч уй гашуу, айдас-хүйдэс үгүй.
  113. Еврейчүүд: “Хиростосчууд ямар нэгэн үндэс суурьгүй (тэд зөв шашинтнууд биш)” гэвэл Христосчууд ч: “Еврейчүүд ямар нэгэн үндэс суурьгүй зөв шашинтнууд биш” гэнэ. Уул нь тэд бүгдээрээ судрыг (Христосчууд Инжилийг, Еврейчүүд Тауратыг) уншицгаадаг. Эрдэм мэдлэггүй хүмүүс ч тэдэнтэй адил ярьцгаадаг. Аллах тэдний хоорондох маргааныг ертөнцийн төгсгөлд ялган шүүж өгнө.
  114. Аллахын ариун сүмүүдэд (мэсжидүүдэд) Аллахын нэрийг дурдахыг хориглож, мэсжидүүдийг эвдэн сүйтгэхийг оролдогчдоос илүү зальхай этгээд байх гэж үү. Тийм хүмүүс мэсжидэд айж орвол зохино. Тэд энэ дэлхийд зовж зүдрэн, нөгөө ертөнцөд тамын хүнд гэгсээлтэй учирна.
  115. Дорно, өрнийн аль нь ч (бүх дэлхий) Аллахынх. Хаашаа зүглэсэн ч Аллахтай учрах болно. Аллах үнэхээр уудам, бүхнийг мэдэгч.
  116. Тэд “Аллах үр хүүхэдтэй” гэлцдэг (Яхудичууд Гүзайрыг, Христосчууд Иса (Есүс)-г, Арабын сүсэггүйчүүд Мэлэжүүдийг Аллахын хүүхэд

- гэнэ). Яалаа гэж дээ, Тэр үүнээс ангид. Тэнгэр, газар дахь бүх зүйл Аллахынх. Бүгд түүний эрхшээлд оршдог.
117. Аллах тэнгэр, газрыг оргүй хоосноос бүтээгч. Хэрэв нэгэн үйлийг бүтээхээр шийдэж, ямар нэгэн юм “Болтугай” гэхүйд тэр даруй ёсоор болдог.
118. Эрдэм мэдлэггүйчүүд, (Курайшийн хүнд сурталтнууд) “Аллах бидэнтэй яагаад нүүр тулан ярилцдаггүй юм вэ? Бидэнд яагаад нэгэн ер бусын шинж тэмдэг, тодорхой хайр ивээл илгээдэггүй юм вэ?” гэдэг. Эдгээрээс өмнөхүүд нь ч ингэж ярьдаг байсан. Тэдний бодол санаа ч төстэй. Үнэн хэрэг дээр бид төгс итгэл сүсэгтэй зон олонд айлдваруудыг маш тодорхой илгээсэн.
119. (Аяа, Мухаммед) Бид үнэндээ чамайг мусулманчуудыг баярлуулахаар, сүсэг бишрэлгүй этгээдүүдийг сэрэмжлүүлэхээр чин үнэнээр илгээсэн. Чи сүсэг бишрэлгүй тамд унагчдын төлөө хариуцлага хүлээхгүй.
120. Чи Еврейчүүд болон Христосчуудын шашинд орох хүртэл тэд чамд сэтгэл хангалуун болохгүй. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Аллахын зам бол хамгийн зөв зам” хэмээн хэл. Харин чамд чин үнэнийг илэрхийлэх нотолгоо илгээгдсэний дараа тэдний зугаа цэнгэлд хөтлөгдөн явбал чамд ямар ч анд нөхөр, ач тус олдохгүй.
121. Бидний илгээсэн судрыг үнэн сэтгэлээс уншдаг хүмүүс бий. Тэд үнэн сүсэгтэнгүүд. Хэрвээ хэн нэгэн Куран судрыг хүлээн зөвшөөрөхгүй бол тэд хохирол амсагчид юм.
122. Аяа, Израйлын үр сад аа! Та нарт миний илгээсэн хишгийг, бас та нарыг (нэгэн цагт) дэлхий даяр илүүтэй өргөмжилснийг минь санацгаатун.
123. Хүн хүндээ ач тус үл хүргэх, нэгнийхээ төлөө нөгөөгийн дэм тус хүлээж авагдахгүй болох, хэнийг ч хэн нэгэн үл өмөөрөх, хэн нэгнээс хэн ч төлөөс үл хүртэх, бишрэл сүсэггүйчүүд тусламж эс үзэх тэрхүү өдрөөс (ертөнцийн төгсгөлөөс) айгтун!
124. Нэгэнтээ Аллах Ибрахимыг хэдэн үгсээр шалгасныг санагтун. Ибрахим уг шаардлагыг бүрэн биелүүлэв. Аллах Ибрахимд: “Би чамайг хүмүүсийн шашны тэргүүнээр сонгож томилно.” гэхэд Ибрахим: “Бас миний удмаас ч” гэж гуйв. Аллах: “Миний (шашны тэргүүн сонгох) амлалганд зальхай, сүсэггүй этгээдүүд хамрахгүй” гэв.
125. Тэр үед, Бид ариун байрыг (Кагбаг) хүн төрлөхтний хуран чуулах төв, энх амгалангийн орон болгов. “Ибрахимын орон байрыг уншлага мөргөл үйлддэг газар болгож авагтун” гэв. Ибрахим, Исмайл хоёрт “Та нар Миний ариун байрыг (Кагбаг) тойрон мөргөгчид, байрлан сууж залбирагчид, мэхийн ёслогчид, сөгдөн мөргөгчдийн төлөө үүнийг цэвэрхэн эдлэгтүн” гэж тушаасан.
126. Тэгэхэд, Ибрахим, “Аяа, Эзэнтэн минь! Энэ хотыг (Мекке-г) аюулгүй, тайван хот болгогтун! оршин суугчдаас хэн Аллахад болон нөгөө



- ертөнцөд төгс итгэх аваас тэдэнд төрөл бүрийн амтат жимс, буян хишгээ хайрла”- гэж залбирлаа. Аллах: “буруу номтнуудыг ч түр зуур (энэ яваа насанд нь) хангана, хожим тэднийг там руу оруулна. Там бол хамгийн гутамшигтай орон” гэж хэлэв.
127. Ибрахим, Исмайл хоёр Кагба–гийн суурийг тавьж байхдаа : “Аяа, Эзэнтэн минь ээ! Бидний хөдөлмөрийг (Кагба-г) хүлээн авч соёрх, Чи хүслийг тод сонсогч, зүй ёсоор мэдэгч билээ!” гэж залбирсан.
128. “Аяа, Эзэнтэн минь ээ! Бид хоёрыг зөвхөн чамайг ятган бишрэгч болгон соёрх, бидний үр удмыг ч бишрэн сүсэглэгч мусулман болгож хайрлагтун. Бидэнд сүсэглэн мөргөх дэг журмыг ч зааж өгөгтүн, бидний бишрэл хүндэтгэлийг хүлээж авагтун. Учир нь Чи үнэхээр бишрэл хүндэтгэлийг хүлээн авагч, энэрэн нигүүлсэгч билээ”.
129. Тэд : “Аяа, Эзэнтэн минь ээ! Тэдэнд дотороос нь Чиний айлдваруудыг уншиж ойлгодог, (Куран) судар болон мэргэн ухааныг сургаж заах, тэдний нүгэл хилэнцийг ариусгах нэгэн гэгээн элчийг илгээгтүн ! Чи үнэндээ аугаа хүч чадалтай, мэргэн ухааны Эзэн билээ” хэмээн залбирав.
130. Өөрийгөө мунхаг болгосноос өөр хэн Ибрахимын шашинаас нүүрээ буруулах билээ? Бид Ибрахимыг энэ дэлхийн шилдэг гэгээн элч хэмээн сонгосон. Тэр хойд насандаа ч (нөгөө ертөнцөд) ухаант шударгуудын эгнээнд багтах болно.
131. Эзэнтэн түүнд: “Бишрэн дага” гэхэд “Би ертөнцийн Эзэнтнийг бишрэн дагана” гэсэн.
132. Нэгэнтээ Ибрахим, Якуб хоёр хөвгүүддээ гэрээслэн : “Хөвгүүд минь, Аллах та нарын төлөө энэ шашныг (Исламыг) сонгосон. Тиймээс та нар ч гагцхүү мусулман болж үхэгтүн” гэсэн.
133. Якубыг үхэлтэй тулгарах мөчид та нар дэргэд нь байсан юм уу? Тэр мөчид Яакуб хөвгүүддээ: “Би нөгчсөний дараа та нар хэнд мөргөх гэж байна?” гэхэд, тэд : “Чиний бурхан болон чиний өвөг дээдэс Ибрахим, Исмайл, бас Исхак нарын бурхан болох цорын ганц Аллахад мөргөнө. Бид гагцхүү Түүнийг бишрэн дагана” гэцгээжээ.
134. Тэд нэгэнт улиран одсон хүмүүс. Тэдний үйлийн үр тэднийх, та нарын үйлийн үр та нарынх. Тэдний үйл хэргийн төлөө та нар хариуцлага хүлээхгүй.
135. Тэд: “Еврей эсвэл Христос шашинтан болцгоогтун, тэгвэл та нар зөв замыг олно.” гэцгээсэн. Чи тэдэнд : “Үгүй ээ! бид Ханиф буюу мухар сүсэгээс ангид Ибрахимийн шашинд итгэх болно. Тэр Аллахад бусдыг эн зэрэцүүлэгсдийн нэгэн биш.
136. Та нар “Бид Аллахад, бидэнд илгээгдсэнд (Куранд), мөн Ибрахим, Исмайл, Исхак, Якуб болон тэдний ач зээ нарт илгээгдсэн сударт, Муса болон Исад илгээгдсэн сударт, мөн бүх гэгээн элч нарт, Эзэнтний зүгээс

- илгээгдсэн судар номуудад итгэцгээнэ. Бид тэднийг алаг үзэхгүй, бид гагцхүү Түүнийг дагагч Мусулманчууд.” хэмээн хэлцгээ!
137. Хэрвээ тэд (Еврей болон Христос) та нарын адил сүсэглэн итгэцгээсэн бол гарцаагүй зөв замыг олох байсан. Ариун сүсэглэлээс нүүр буруулбал та нартай тэрсэлдэх болно. Та нарыг тэднээс хамгаалахад Аллахын хүч хангалттай хүрэлцэнэ. Тэр бүхнийг сонсогч, бас мэдэгч байдаг билээ.
138. “Ийнхүү Аллахын айлдварт итгэлтэй байцгаа. Аллахын айлдвараас илүү юу байгаа юм бэ? Тиймээс бид зөвхөн Аллахад итгэн биширцгээнэ.”
139. “Аллахын тухай бидэнтэй мэтгэлцэх гээд байгаа юм уу? Үнэн хэрэг дээр Тэр бол бидний ч бурхан, та нарын ч бурхан. Бидний үйлдсэн үйл биднийх, та нарын үйлдсэн үйл та нарынх л байх болно. Бид Аллахыг зүрх сэтгэлээрээ холбогдон бишрэгсэд” хэмээн тэдэнд хэлэгтүн.
140. Эсвэл та нар “Ибрахим, Исмайл, Исхак, Якуб болон тэдгээрийн үр садыг Еврей эсвэл Христүүд байсан гэх нь үү? Аяа, Мухаммед тэдэнд : “Та нар илүү мэдэх үү, эсвэл Аллах уу? Гарт чинь Аллагаас ирүүлсэн нотолгоо байсаар атал түүнийг нуусан хүнээс илүү зальхай амьтан байх уу даа? Аллах та нарын хийсэн үйлдэл бүрийг анзааралгүй өнгөрөхгүй” гэж хэлэгтүн.
141. Тэд бол нэгэнт улирч одсон хүмүүс. Тэдний үйлийн үр тэднийх, та нарын үйлийн үр та нарынх. Та нар тэдний үйлийн төлөө хариуцлага хүлээхгүй.
142. Зарим мунхагууд, “Тэднийг (Мухаммед болон мусулманчуудыг) чиглэж айсуй Киблагаас юу буцаасан вэ?” гэнэ. Мухаммед минь : “Дорно ч, Өрнө ч, дөрвөн зүг бүгд Аллахынх. Аллах хүссэн хүнээ зөв замд оруулна” гэж хэлээрэй.
143. Та нар хүмүүст гэрч болохын төлөө, гэгээн элч та нарт гэрч болохын тулд, бид та нарыг ийнхүү сүсэгтэн ард түмэн болгосон. Чиний чиглэж айсуй зүгийг Кибла болгосон нь Гэгээн элчийг дагагчийг, урван эргэж буцагсадаас ялгахын тулд билээ. Энэ нь Аллахын зөв замд оруулсан хүмүүсээс бусдад нь мэдээж маш хүнд байх болно. Аллах та нарын өмнөх бишрэл сүсэгийг хэзээ ч талаар өнгөрүүлэхгүй. Аллах хүмүүнд машид нигүүлсэгч, нэн өршөөлт.
144. (Аяа, Мухаммед) Бид чиний нүүрээ тэнгэр өөд эргүүлж байсныг харж байна. Иймд, Бид чамайг сэтгэл дүүрэн байх Кибла рүү эргүүлэх болно. Ийнхүү нүүрээ Масжид Хараам руу (Мекке рүү) эргүүл. (Мусулманчууд) Та нар хаана байсан ч (уншлага мөргөлд) өөрсдийн нүүрээ тэр зүг рүү эргүүлэгтүн. Эргэлзээгүй, Ариун судар илгээгдсэн хүмүүс, Кибла солигдсоныг Эзэнтнээс ирсэн үнэн гэж үзэх болно. Аллах тэдний үйлдэлийг анхаарлаас гадуур үлдээхгүй.

145. (Аяа, Мухаммед) Чи ариун ном эзэмшигчдэд аливаа нотолгоог (ер бусын гайхамшгуудыг) авчирсан ч тэд чиний Киблаг дагахгүй. Чи ч тэдний Киблаг дагах нэгэн биш. Тэд ч нэг нэгнийхээ Киблаг дагацгаахгүй. Чамд ирсэн эрдэм мэдлэгийн дараа хэрэв тэдний хүсэл зоргоор жолоогоо алдвал, тэр цагт чи үг дуугүй зальхай этгээдүүдийн эгнээнд орох болно.
146. Бид өөрсдөд нь ариун судар буулгачихаад байхад тэд түүнийг (гэгээн элчийг) өөрсдийнхөө хөвгүүдтэй өөрцгүй таньцгаадаг. Тэдний нэг хэсэг нь хэрэг дээр чин үнэнийг мэдсээр байж нууцгаадаг.
147. Чин үнэн бол чиний Эзэнтнийх. Түүнд бүү эргэлзэцгээ!
148. Хүн бүрийн өөрсдөө чиг барьсан Кибла байдаг. Сайн сайхны төлөө яарцгаа. Хаана байсан ч Аллах та нарыг нэгтгэнэ. Аллахын хүч чадал нь бүх зүйлд хүрдэг.
149. Аль зүгээс замд гарсан ч (уншлага мөргөл үйлдэхдээ) нүүрээ Масжид Аль-Хараам руу харуул. Энэ бол хэрэг дээр Эзэнтнээс ирсэн чин үнэн. Аллах та нарын үйлдэл бүрийг мэднэ.
150. Бусад хүмүүсээс та нарын эсрэг нотолгоо болгохгүйн тулд та нар аль зүгээс гарсан ч нүүрээ Масжид Аль-Хараам руу эргүүлээрэй. Тэдний дундаас (тэр нотолгоог) зөвхөн зальхай этгээдүүд хэлдэг. Тэднээс бүү айтгун! Миний Та нарт зориулах хишгийг бүрэн хүртэх, бас зөв зам дээр байхын тулд надаас айтгун!
151. Учир нь өөрсдийн дундаас та нарт бидний айлдварыг уншиж өгдөг, нүгэлээс ариусгадаг, (Куран) судар, мэргэн ухааныг зааварлаж мэдэхгүй бүхнийг та нарт зааж сургадаг Гэгээн Элчийг явуулсан юм.
152. Та нар намайг санагтун. Би ч та нарыг санах болно. Надад талархаж байгтун, биеэ бүү тоогоорой.
153. Аяа, Мусулманчууд! Тэвчээртэйгээр, уншлага мөргөлөөр (Аллахаас) тусламж гуйгтун. Үнэндээ Аллах тэвчээртэнгүүдтэй хамт юм.
154. Аллахын төлөө алуулсан хүмүүсийг “үхэгсэд” гэж бүү хэлэгтүн. Тэд амьд. Гэвч та нар үүнийг мэдэрдэггүй юм.
155. Бид та нарыг бага зэрэг айлгаж, өлсгөж, мөн амь нас, мал хөрөнгө, ажил үйлсийг чинь доройтуулж шалгана. (Аяа, Мухаммед) тэвчээр хүлцэлтэй хүмүүсийг баярлуулаарай.
156. Ямар нэгэн гай зовлон тохиолдоход тэд: “Бид бүгд Аллахын ивээлд багтагсад бөгөөд гарцаагүй Түүний өмнө очино” хэмээн хэлцгээдэг.
157. Тэд Эзэнтнээс өршөөл, нигүүлсэл хүртэнэ. Мөн тэд дардан зөв замаар замнагсад юм.
158. Сафа, Маруа хоёр бол Аллахын тавьсан шинж тэмдэгүүд гэдэг нь эргэлзээгүй. Хэн ч байг Кагба-д Хаж эсвэл Умра ёсыг гүйцэтгэж, үүгээр тауаф буюу тойрон залбирах ёсыг үйлдвэл гэмгүй. Хэн ч байг

- сайн дураараа сайн үйл үйлдвээс Аллах эргэлзээгүй талархан ивээнэ. Аллах бүхнийг мэднэ.
159. Бид хүмүүст Таурат (Тора) судраар зөв замыг зааж өгснөөс ч хойно үүнийг нууж бүрхэгдүүлэгсэд Аллахын хараалыг, мөн бусад хилэгнэгсэдийн (Мэлэкүүд болон мусулманчуудын) хараалыг хүргэнэ.
160. Гагцхүү наминчлан сүсэглэгчид, өөрсдийн үйлдэлийг ухаарагчид, үнэнийг илчлэгчдийн хувьд өөр юм. Би тэдний наминчлалыг хүлээж авна. Би машид нигүүлсэгч, нэн өршөөгч шүү дээ.
161. Үл сүсэглэгчид, үл итгэсээр үхэгсэд Аллахын, мэлэкүүдийн, мөн бүх хүмүүсийн хараалыг хүргэх нь эргэлзээгүй.
162. Тэд мөнхөд тамын хараалд үлдэцгээнэ. Тэдний гэсгээл, гэм буруу үл хөнгөрнө, тэд хэзээ ч үл тоогдоно.
163. Та нарын бурхан цорын ганц Аллах. Түүнээс өөр бурхан үгүй. Тэр машид нигүүлсэгч, нэн өршөөгч билээ.
164. Тэнгэр, газрыг бүтээхэд, өдөр, шөнө солигдоход, хүмүүст ашиг тус өгөгч зүйлүүдтэй далайд сэлж яваа хөлөг онгоцнуудад, Аллах-ын тэнгэрээс хур буулгаж үхмэл төрх байдалтай газрыг тэр усаар амилуулахад, газар дэлхийд бүх төрлийн амьд амьтдыг тараан байрлуулахад, салхи болон тэнгэр, газрын хооронд зарлиг гүйцэтгэгч үүлнүүдийг чиглүүлэх нь ухаантай хүмүүсийн хувьд (Аллах-ын оршихуйг нь, Түүний цорын ганц болохыг нь нотлоход) үй олон баталгаа болдог нь эргэлзээгүй.
165. Зарим хүмүүс Аллахаас бусдыг Аллах-тай эн тэнцүү бурхад болгоцгоодог бөгөөд тэднийгээ (мусулманчуудын) Аллахыг хайрлаж байгаа шиг хайрладаг. Харин төгс сүсэгтэн олны Аллахын төлөө хайр нь (тэднийхээс) илүү их байдаг. Зальхай амьтад гэсгээл хүрсэн цагт бүхий л хүч чадал Аллахад хамааралтай байдгийг, Аллахын гэсгээлийн маш их сүр хүчтэй болохыг ухаарах болно.
166. Тэр цагт бусдыг урвуулагчид зовж зүдрэн, урвагчдыг бас хөсөр хаяна. Тэднийг холбосон учир шалтгаан, харилцаа холбоо нь таслагдана.
167. Урвагчид: “Хэрвээ, дэлхий рүү буцах (дахин төрөх) боломж ганц удаа ч олддог болоосой, тэгвэл тэдний биднээс урвасны адил бид ч тэднээс урвах юмсан.” гэнэ. Ийнхүү Аллах тэдэнд, өөрсдийн тарьсан муу үйлийн үрийг нь харуусал болгон харуулдаг, тэд тамаас хэзээ ч гарч үл чадмуй.
168. Аяа, хүмүүсээ! Газар дэлхий дээр буй ариун сайхан, (халал) бүхнийг идэцгээгтүн, чөтгөр шуламын урхинд бүү орогтун, Учир нь тэр та нарын илт дайсан шүү дээ.
169. Тэр та бүхнийг муу муухай руу, бузар булай руу, Аллахын тухай та нарын мэдэхгүй зүйлсийг Түүний эсрэг та нараар хэлүүлэх гэж хөтөлнө.
170. Тэдэнд хандан (Меккегийн мухар сүсэгтнүүдэд) : “Аллахын илгээсэн

судрыг (Кураныг) дагагтун” гэж хэлэхэд тэд : “Үгүй! Бид өөрсдийн өвөг дээдсээс уламжлагдан ирсэн замыг дагана” гэнэ. Хэрэв тэдний өвөг дээдэс нь юу ч ойлгоогүй, зөв замыг олоогүй хүмүүс байсан бол тэдний мөрийг хөөх гэж үү?

171. Үл сүсэгтнүүд уриа, дуудлагыг сонсмогц ойлгодоггүй амьтан лүүгээ адил юм. Мөн тэд дүлий, хэлгүй, сохорын адил ойлгодоггүй, юуг ч эс анзаардаг.
172. Аяа, сүсэгтэн олон минь ээ! Бидний та нарт хайрласан хишгээс амттайг нь хүртэцгээгтүн. Хэрвээ та нар зөвхөн Аллахад мөргөдөг бол Түүнд талархацгаагтун.
173. Аллах та нарт үхсэн амьтны сэг, цус, гахайн махыг бас Аллахын нэрээр хоолойгийг нь огтлон алаагүй малын махыг идэхийг хориглон бузар (хараам) хэмээн айлдсан. Гэхдээ хэн нэгэн аргагүйн эрхэнд (амьд үлдэхийн тулд) идэхэд хүрвэл дурлаж хүсэлгүйгээр, хэтрүүлэхгүйгээр хүртвэл нүгэл биш. Аллах нэн өршөөгч, машинд нигүүлсэгч билээ.
174. Үнэндээ Аллахын илгээсэн Тауратыг (Тораг), (гэгээн элч Мухаммедын мөн чанарыг) нууж, үүнийгээ өчүүхэн үнээр арилжагсад бол гэдэсээ зөвхөн галаар дүүргэгсэд. Аллах нөгөө ертөнцөд тэдэнтэй огт ярилцахгүй, бас өршөөхгүй. Тэд зовлонг гэгсгээл үзнэ.
175. Тэд зөв замыг буруу замаар, өршөөлийг гэгсгээлээр сольж авагсад. Тэд тамд хэрхэн тэсвэрлэх бол!
176. Аллах өөрийн судрыг үнэн зөвөөр илгээсэн болохоор үнэндээ үүний тухай зөрчилдөгсөд бол маш их хагаралд орогсод юм.
177. Та нар нүүрээ баруун, зүүн зүг рүү эргүүлэх нь жинхэнэ сайн үйлс биш. Харин, хэн Аллахад, нөгөө ертөнцөд, мэлэкүүдэд, ариун судруудад, гэгээн элчүүдэд итгэх бол, мөн хамаатан садандаа, өнчин өрөөсөнгүүдэд, үгээгүй ядууст, алсын замын зорчигсодод, гуйлга гуйгсадад, боолыг чөлөөлөхөд өөрийн дуртай баялагаас зарцуулах бол, бас уншлага мөргөл үйлдэн ариуслын өглөг өгж, амлалтаа биелүүлдэг, зовлон зүдгүүр, өвчин эмгэг болон дайн тулааны үед тэвчдэг бол жинхэнэ сайн үйлс эдгээр мөн. Эдгээр хүмүүс үнэнч шударгуу байгсад, мөн тэд чин сүсэгтэнгүүд мөн.
178. Аяа, сүсэгтэн олон минь ээ! Бусдын гарт хилсээр алуулагсадын өмнөөс цаазын ял асуух нь та нарын хувьд фарз (ариун үүрэг) боллоо. Эрх чөлөөтэй хүний төлөө эрх чөлөөтнийг, боолын төлөө боолыг, эмэгтэй хүний төлөө эмэгтэйг (цээрлүүлэн цаазын ял асууж болно). Амь хохирогсдын ах дүүгийн талаас өршөөвөл, цусан өшөө авахаас татгалзвал, заншлыг дагаж түүнд эд баялагаараа хариу барин, амины төлөөсийг бүрэн төлөх ёстой. Энэ бол Эзэнтний зүгээс үзүүлсэн хөнгөлөлт, өршөөл юм. Үүнээс хойш хэт давран, хэм хэмжээг зөрчих аваас (амины төлөөс авсны дараа дахин хүн амийн хэрэг үйлдвэл) Аллахын асар хүнд гэгсгээлийг үзэх болно.

179. Аяа, оюун ухааны эзэд ээ! Цаазлах бол та нарын хувьд амь насны баталгаа юм. (Та нарын амьдрал хатуу хамгаалалтад байгаа. Хүний амийг хөнөөсөн хүн өөрөө ч алуулахыг мэдэх ёстой. Тиймээс бузар бодлогоосоо татгалзах учиртай. Энэ нь цус урсгахаас сэргийлэхийн тулд чухал.) Та нар анхааралдаа авбал хамгаалагдана.
180. Хэн нэгэнд үхэл нүүрлэвэл, хэрэв эд хөрөнгөтэй бол, эцэг эх болон ойрын хамаатандаа үнэнч сэтгэлээр гэрээслэх хэрэгтэй. Энэ нь чин сүсэгтнүүдэд ариун үүрэг болгогдсон билээ.
181. Хэн нэгэн уг гэрээслэлийг сонссоныхоо дараа өөрчилбөл, чухамхүү үүнийг өөрчилсөн хүн нь нүгэлтэн болно. Аллах үнэхээр бүхнийг сонсож, мэдэж байдаг.
182. Хэн нэгэн гэрээслэгчийг алдаа гаргахаас сэрэмжилэн (гэрээслэгч ба сонсож зуучлагчийг) зөвшилцүүлвэл буруутан болохгүй. Аллах үнэнхүү нэн өршөөгч, машид нигүүлэгч билээ.
183. Аяа, сүсэгтэн олон минь ээ! Мацаг барих нь та нараас өмнөх ард түмэнд ариун үүрэг (фарз) болгогдсоны адил та бүхэнд ч гэсэн ариун үүрэг (фарз) болгогдсон. Та нар анхааралдаа авбал хамгаалагдана.
184. Мацаг нь тоотой хэдэн өдрүүд. Та нараас хэн нэгэн өвчтэй эсвэл аян замд явах юм бол бусад өдрүүдэд нөхөг. Мацаг барихад чадваргүй хүмүүс нь үгээгүй ядуу хүн цагтах хэмжээний өргөл өгөх хэрэгтэй. Харин хэн нэгэн сайн дураараа илүү өгвөл, өөрийнх нь хувьд илүү сайн үйлс болно. Хэрэв та нар мэдэж байгаа бол мацаг барих нь та нарын хувьд илүү сайн үйлс билээ.
185. Рамазан сар бол хүмүүст зөв замыг заагч, дөг ба тойруу замыг ялгах тод баталгаа болгож Куран судар илгээгдсэн сар юм. Тийм болхоор рамазан сартай золгосон хэн боловч энэ сард мацаг баригтун. Энэ сард өвчтэй эсвэл аян замд гарвал бусад өдрүүдэд нөхнө. Аллах та нарын төлөө амар хялбарыг хүсдэг, хүндрэлийг хүсдэггүй. Үнэндээ Аллах тогтоосон өдрөө та нараар гүйцээлгэснийхээ төлөө, та нарт зөв замыг заасныхаа хариуд та нар Аллахиыг өргөмжлөн магтаж, талархагтун.
186. Боолууд минь та нараас Миний тухай асуувал: Би тэдэнд ойрхон байна. Бас надад наминчлан залбирах аваас түүний залбирлыг хүлээн авч соёрхоно. Тэд зөв замаар явна гэвэл Миний урилгыг хүлээж авагтун, надад итгэцгээгтун.
187. Мацаг барьж буй шөнө та нар өөрсдийнхөө эхнэрт ойртох нь хүлээн зөвшөөрөгдсөн. Тэд та нарын хувьд нэгэн хувцас шиг, бас та нар тэдний хувьд нэгэн хувцас шиг билээ. Аллах та нарын өөрсдөдөө муу зүйл хийж байгааг мэдээд, гэмшлийг чинь хүлээж аваад, та нарыг өршөөсөн. Харин одоо тэдэнд (эхнэртээ) ойртоцгоогтун. Аллахын та нарын төлөө хувь заяа болгоосныг хайгтун. Үүрээр хар, цагаан утас ялгарч харагдах (үүрцайхаас өмнөх цаг) хүртэл идэж ууцгаагтун, дараа нь орой болтол мацаг барьцгаагтун. Мөн Аллахын мэсжидүүдэд (игтикаф төрлийн

- мөргөл) залбирал үйлдэх цагаар эр эмийн харилцааг тэвч бүү орогтун. Энэ бол Аллахын тавьсан хязгаар тул түүнийг бүү давагтун. Ийнхүү Аллах өөрийн айлдваруудаа хүмүүст тайлбарладаг. Тэд Аллахын айлдварыг анхааралдаа авбал хамгаалагдана. (бузараас болгоомжилно).
188. Нэг нэгнийхээ мал хөрөнгийг зүй бусаар бүү ашиглагтун. Нүгэл гэдгийг мэдсээр байж бусдын мал хөрөнгийг ашиглах зорилгоор эрх мэдэлтэнүүдэд авилга бүү өгөгтүн.
189. (Аяа, Мухаммед) Тэд чамаас сар шинийн тухай асууна. Тэдэнд : “Хүмүүсийн амь зуух, хөдөлмөрлөх, наймаа эрхлэх, мацаг барих, ууж идэх цаг зэрэг үйлс болон хаж мөргөлийн цаг хугацааг тооцоолохын төлөө байдаг.” хэмээн хэл. Сайн үйлс бол гэрийн ар талаас нь орохын нэр биш. Жинхэнэ сайн үйлс бол Аллагаас эмээх төгс сүсэглэгч хэн нэгний үйлс юм. Гэр лүүгээ хаалгаар нь орж байгтун, Аллагаас эмээгтүн. Ийнхүү та нар аз жаргалтай болно.
190. Та нар өөрсдийнхөө эсрэг дайтагсадтай дайтацгаа. Гэхдээ, өөрсдөө булааж эзлэхийн төлөө бүү довтол. Аллах хязгаарыг давсан, булаан эзлэгчдийг үл таашаана.
191. Тэд эхлээд дайн өдөөсөн бол тэднийг тааралдсан газартаа дарагтун, та нарыг нутгаасаа хөөж явуулсан шиг та нар ч тэднийг хөөж явуулагтун. Үймээн самуун бол дайтахаас ч илүү дорд зүйл. Тэд өөрсдөө дайтаагүй л бол та нар ч Мэсжид Аль-Хараамын дэргэд тэдэнтэй бүү дайтагтун. Хэрэв тэд та нарын эсрэг эхлээд дайгвал та нар ч үхтэл дайтагтун. Үл сүсэглэгчдийн гэгсгээл энэ юм.
192. Хэрэв тэд (дайн тулаанаас) татгалзвал та нар ч татгалза. Аллах нэн өршөөгч, энэрэн нигүүлсэгч.
193. Үймээн самуун бүрэн гүйцэд дарагдах хүртэл, Аллахыг сүсэглэх хүртэл тулалдагтун. Хэрэв тэд бууж өгөх аваас харгислагчдаас бусад руу нь дайсагнал болон дайралт бүү хийгтүн.
194. Хүндэтгэлтэй сарууд хоёр талд адилхан. Хүндэтгэвэл зохих зүйл аль алинд эн тэнцүү. Энэ саруудад дайтах, үл дайтах хоёр талд ижил. Энэ сард хэн та нар руу дайрах аваас та нар ч түүн рүү адилхан хэмжээнд дайрагтун. Аллахад чин үнэнчээр сүсэглэгтүн. Аллах чин сүсэгтэнгүүдийн талд.
195. Аллахын төлөө мал хөрөнгөө зарцуулагтун. (Харамч зан гаргаж) өөрсдийгөө аюул руу бүү түлхэгтүн. Сайн сайхан үйлс хийгтүн. Аллах сайн үйлс хийгчдийг үнэнхүү хайрладаг.
196. Хажы болон Умра мөргөлийг Аллахын төлөө ёс зүйгээр нь хийгтүн. Хэрвээ (дайн, өвчин мэт шалтгаанаар) саатвал гурван төрлийн малаар нэг өргөл өргөгтүн. Өргөл өргөгдөх газар хүрэх хүртэл толгойнхоо үсээ бүү хусуулагтун. Хэн нэгэн өвдвөл эсвэл толгойд нь ямар нэгэн шаналгаатай бол үсээ хусуулахгүйгээр гурван хоног мацаг бариг, үгүй

- бол өглөг өгч, эсвэл өргөл өргөгтүн. Эсэн мэнд үедээ хажы үйлдэх хүртэл Умраг үйлдэж дууссан хүн хажын үеэр гурван хоног, эргэж нутагтаа ирээд долоо хоног, нийлээд бүтэн арав хоног мацаг баригтун. Энэхүү гэр орон нь Мэсжид Аль-Хараамын дэргэд байдаг хүмүүсийнх. Та нар Аллахаас айгтун, Алладын гэсгээл үнэхээр маш хүнд гэдгийг мэдэгтүн.
197. Хажы бол тодорхой (гурван) саруудад билээ. Хэн нэгэн тэр хугацаанд хаж ёсыг гүйцэтгэхээр бол, эхнэртэйгээ хурьцал үйлдэх, нүгэл үйлдэх, хэрүүл уруул хийх нь хориотой. Та нар ямар нэгэн сайн үйл хийвээс Аллах түүнийг харж баймуй. Бэлтгэлээ сайн базаагаарай, замын бэлтгэлийн хамгийн сайн нь төгс сүсэглэл мөн. Аяа, оюун ухааны эзэд ээ, зөвхөн надаас айгтун.
  198. Хажы саруудад арилжаа наймаа, бусад ажил хийж Эзэнтнээс буян хишиг хүсэх нь ямар нэгэн нүгэл биш. Харин Арафатаас буцах цагт Машгарил-хараамын дэргэд Алладыг дурсагтун. Аллах та нарын зөв замыг заасны төлөө түүнийг дурсагтун. Өмнө нь та нар буруу замаар явагсад байсан.
  199. Дараа нь Арафатаас буцсан хүмүүсийн замаар буцагтун. Аллахаас өршөөл гуйгтун. Аллах үнэхээр нэн өршөөгч, машид нигүүлсэгч.
  200. Хажы мөргөлөө дууссанахаа дараа ч Алладыг өвөг дээдсээ санан дурсахын адил, бүүр түүнээс ч хүчтэй дурсагуй. “Эзэнтэн минь ээ! Энэ насанд минь хишиг хайрла” хэмээгсэдэд нөгөө ертөнцөд хувь хишиг үл ноогдоно.
  201. Зарим хүмүүс : “Аяа, эзэнтэн минь ээ! Энэ насанд ч, хойд насандаа ч хишгээ хайрла, бас биднийг тамын гэсгээлээс хамгаалаач” гэцгээдэг.
  202. Эд нарг хийсэн үйлийнх нь үрээр хүртээх хувь хишиг байдаг. Аллах тооцоо бодохдоо үнэхээр үтэр түргэн.
  203. Тоотой өдрүүдэд Алладыг дурсагтун. Үнэн сүсэгтэнүүд Мина дахь мөргөлөө үйлдэн яарч хоёр хоногийн дотор буцвал нүгэл үгүй. Аллахт наминчлан мөргөж, хожимдож буцсан хүмүүс ч нүгэл үл хурна. Аллахаас айгтун! Хэзээ нэгэн цагт Алладын өмнө очиж тооцоогоо бодохоо мэдэгтүн.
  204. (Аяа, Мухаммед) Зарим хүмүүсийн амьд ахуйн тухай хэлсэн үг нь чамайг гайхшруулна. Сэтгэл зүрхээр буруу санаат биш гэдгээ Аллахын нэрээр гэрчилдэг. Хэрэг дээр тэр жинхэнэ хорон муу санаат юм.
  205. Харин тэр салж одонгууд газар дэлхийг бусниулж, тариалангийн талбайг сүйтгэн, уг ажлыг үргэлжлүүлэхийг, үр удмыг нь хөнөөхийг оролдоно. Аллах танхайрагчдыг таалахгүй.
  206. Тэдэнд: “Аллахаас айгтун” гэвэл аминч үзэл болон их зан нь хөдөлж нүгэлтэн болдог. Түүнд там хангалттай. Там бол ёрын муу газар!



207. Зарим хүмүүс Аллахын талархлын төлөө амиа өгдөг. Аллах тийм боолууддаа машинд энэрэнгүй.
208. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Исламд бүрэн орогтун (Аллахын зарлиг ба хоригуудыг бүрэн хүлээж авагтун). Чөтгөр шуламд бүү итгэгтүн. Тэд та нарын атаат дайсан.
209. Хэрэв та нар Ислам шашны чин үнэнийг нотлох илэрхий баталгаа ирсний дараа замаа буруулбал Аллах аугаа хийгээд мэргэн ухааны эзэн гэдгийг мэдэгтүн.
210. Тэд (ислам шашнаас урвасан хүмүүс) Аллахын зарлиг болон мэлэкүүд (тэнгэрийн элчүүд) үүлэн сүүдрийн завсраар ирж, (зарим нэгийг диваажинд, нөгөө бүлгийг тамд оруулахаар ялган салгаж) асуудлыг нэгэн тийш болгохыг хүлээж буй гэж үү? Бүхий л үйл хэрэг Аллахын өмнө буцаагдана.
211. (Аяа, Мухаммед) Израйлын үр садаас, тэдэнд Бид өч төчнөөн ер бусын нотолгоонуудыг илгээснийг асуу. Хэн Аллагаас өөрт нь илгээсэн хувь хишгийг (айлдвар буюу ер бусын гайхамшигыг) өөрчлөх аваас, Аллах тэднийг гарцаагүй гэсгээнэ. Аллахын гэсгээл, шийтгэл нэн их хүнд.
212. Үл сүсэглэгчдэд амьд ахуй сайхан санагдаж, гоёж гоодон, бишрэлтэй хүмүүсийг элэглэн шоолно. Гэвч үнэн сүсэглэгчид нөгөө ертөнцөд тэднээс дээр байх болно. Аллах хүссэн хүндээ хязгааргүй хувь хишиг хүргээдэг.
213. Хүмүүс анх нэгдмэл нэг л ард түмэн байсан. (Нэг л итгэл үнэмшилтэй байв. Хожим тэдний зарим нь чин үнэнээр сүсэглэн, зарим нь үл наминчлан урвасан.) Дараа нь Аллах (мусулманчуудад диваажин бий хэмээн) баярлуулагч, (буруу номтнуудад там буйг) урьдчилан сануулагч гэгээн элчүүдийг илгээсэн. Хүмүүсийн хоорондох үл ойлголцолыг шүүж шийдвэрлэх гэгээн элчүүдтэй хамт чин үнэн судруудыг илгээсэн. Гагцхүү судар илгээгдсэн хүмүүс илэрхий айлдварууд ирсний дараа өөр хоорондын атаа жөтөөнөөс болж үл ойлголцолд орцгоосон. Тэгээд Аллах үнэн сүсэгтнүүдэд тэдний өөр хоорондоо маргалдаж ойлголцоогүй байгаа чин үнэнийг хүргэсэн. Аллах хүссэн хүнийгээ зөв зам руу оруулдаг.
214. (Аяа, мусулманчууд аа!) Та нар, өмнөх хүмүүс туулж өнгөрүүлсэн зовлонг үзээгүй байж диваажинд орох гэж санаархаа юу? Тэд өлсгөлөнд нэрвэгдэж, өвчин эмгэг нүүрлэж, айдас-хүйдэст автсан. Тэгээд гэгээн элч болон төгс сүсэглэгчид : “Бидэнд Аллахын ивээл хэзээ ирэх юм бэ?” гэлцэв. Аллахын ивээл үнэндээ ойрхон гэдгийг санагтун.
215. (Аяа, Мухаммед) Тэд чамаас: “Аллахын төлөө бид эд хөрөнгөөрөө хэрхэн өглөг өргөх бэ?” гэж асууна. “Өглөг өргөхөөр бол эцэг эх, ойр дотнынхонд, өнчин өрөөсөн, үгээгүй ядууст, холын аян замын гийчдэд өгөгтүн.” хэмээн хэл. Аллах та нарын буянтай үйл бүрийг эргэлзээгүй мэднэ.

216. (Аяа, сүсэгтнүүд минь) дайн бол та нарын хувьд үзэн ядах зүйл боловч ариун үүрэг болсон. Та нарын үзэн яддаг зүйл чинь эргэж эерэг үр дүн авчирч болно. Эсрэгээр таалан соёрхдог зарим зүйл эргэж уршиг тарьж ч болно. Юу ашигтай, ашиггүйг та нар биш Аллах мэднэ.
217. (Аяа, Мухаммед) Тэд чамаас: “Хүндэтгэлийн сард дайтах нь ямар вэ?” гэж асуух байх. “Тэр сард дайтах нь том нүгэл. Харин Аллахын зам дээр хориг тавих, Аллахыг үл тоомсорлох, Масжид Аль-Хараамын мөргөлд хориг тавих, түүний оршин суугчдыг Меккегээс хүчээр хөөж гаргах нь Аллахын өмнө бүр ч их нүгэл болно. Үймээн самуун дэгдээх- хүн алахаас ч илүү нүгэл.” хэмээн хэлэгтүн. Тэд чадвал та нарыг шашинаас чинь урвуулах хүртэл та нартай тасралтгүй дайтсаар л байх болно. Та нарын дундаас хэн нэгэн шашинаасаа татгалзаж, үл итгэгч болон үхвэл тэдний сайн сайхан үйлс нь энэ хорвоод ч, хойд ертөнцөд ч талаар болно. Бас тамынхан тэндээ үүрд үлдэцгээнэ.
218. Төгс сүсэглэгсэд, түүнийхээ төлөө ад үзэгдэн хөөгдөгсөд, Аллахын төлөө дайтагсад, тэд Аллахын энэрэл өршөөлийг хүлээнэ. Аллах нэн өршөөгч, машинд нигүүлсэгч.
219. (Аяа, Мухаммед) Тэд чамаас архи болон мөрийтэй тоглоомын тухай асуувал тэдэнд: “Тэр хоёрын хоёуланд нь асар их нүгэл бий, хүмүүст ялихгүй ашиг хүртээх боловч, тэдгээрийн нүгэл нь ашгаасаа ихээ” хэмээн хэл. Тэд чамаас: “Аллахын төлөө ямар өглөг өргөх вэ?” гэж асууна. “Хэрэгцээнээсээ илүүг өргө” гэж хэл. Энэ ба хойд ертөнцийн тухай эрэгцүүлэн бодуулахын тулд та нарт өөрийнхөө айлдваруудыг ийнхүү өгүүлнэ.
220. (Мухаммед ээ) Тэд чамаас өнчин өрөөсөнгүүдийн тухай асуух болно. “Тэднийг хүмүүжүүлэн, мал хөрөнгийг хамгаалж, буян үйлдэх нь сайн үйлс. Тэдний эрх ашгийн төлөө тэдэнтэй хамт амьдрах аваас тэд та нарын ахан дүүс. Аллах эвлүүлэгч эвдрэлцүүлэгч хоёрыг андахгүй. Хэрвээ Аллах хүсвэл та нарыг ч гэсэн зовоон тарчилгана. Аллах аугаа хийгээд мэргэн ухааны эзэн нь эргэлзээгүй.
221. Мусулманчууд аа! Буруу номтон эмэгтэйчүүд үнэн сүсэгтэн болтол тэдэнтэй бүү гэрлэгтүн. Тэдний гоо үзэсгэлэн та нарыг гайхшруулсан ч буруу номтон эмэгтэйгээс бишрэл сүсэгтэй шивэгчин илүү. Мөн үнэн сүсэгтэн эмэгтэйчүүдийг буруу номтон эрэгтэйчүүдтэй төгс итгэх хүртэл бүү гэрлүүлэгтүн. Эрхэмсэг тансаглал нь та нарын сэтгэлд таалагдсан ч, буруу номтон эрэгтэйгээс үнэн сүсэгтэй боол илүү. Учир нь сүсэг бишрэлгүй эр ч бай, эм ч бай, та нарыг там руу түлхэнэ. Аллах өөрийн таалалаар та нарыг диваажин руу, бас өөрийн өршөөл уучлал руу дуудана. Ийнхүү ухуулан таниулах гэж Аллах өөрийн айлдваруудыг хүмүүст тодорхой тайлбарладаг.
222. (Аяа, Мухаммед) Тэд чамаас эмэгтэйчүүдийн сарын тэмдгийн тухай асуух болно. Тэдэнд : “Тэр бол уршигтай. Сарын тэмдэг нь ирэн

- эхнэрээс хол байгтун. Сарын тэмдэг дуусах хүртэл (бэлгийн харьцаанд) бүү орогтун. Ариусгах үеэр Аллахаас хувь хишиг болгосон эрхтэнд хүрэгтүн.” хэмээн сурга. Аллах үнэндээ хүлцэн гэмшсэн, бузар юмнаас ангид цэвэрч хүмүүсийг хайрладаг.
223. Эхнэр хүн бол та нарын үр суулгах тариан талбай. Тарианыхаа талбайгаа Аллахын тушаасны дагуу хүссэнээрээ эдэлжгээ. Өөрийнхөө төлөө урьдаас сайн үйл хийгтүн. Аллахаас айгтун. Аллахтай хэзээд нүүр тулан учрахаа мэдэгтүн. Үнэн сүсэгтэнгүүдийг баярлуулагтун.
224. Сайн үйлс хийхгүйн төлөө, наминчлан сүсэглэхгүйн төлөө, хүмүүсийг эв эетэй байлгахгүйн төлөө Аллахын нэрийг барьж тангараглаж болохгүй. Аллах бүхнийг сонсогч, мэдэгч.
225. Учир зорилгогүй санамсаргүй ам тангараг өргөсний төлөө Аллах та нарыг буруутгахгүй. Харин санаатайгаар өргөсөн тангарагны чинь төлөө хариуцлага асууна. Аллах эргэлзээгүй өршөөгч, нэн нигүүлсэгч билээ.
226. Өөрсдийн эхнэртэйгээ ойртохгүй гэж тангараг өргөгсөд дөрвөн сар хүлээх хэрэгтэй. Хэрэв тэд дөрвөн сарын дотор хэлснээсээ буцаж торгуулиа төлөөд, эхнэртэйгээ ойртохыг хүсвэл Аллах эргэлзээгүй өршөөнө, зөвшөөрнө.
227. Хэрэв эрчүүд эхнэрээсээ салахыг санаархвал Аллах тэдний үгийг сонсож, санааг мэдэж байдаг.
228. Нөхрөөс салсан эмэгтэйчүүд гурван удаа сарын тэмдэг ирээд өнгөртөл хүлээнэ. Хэрэв тэд Аллах болон хойд ертөнцөд үнэхээр итгэцгээсэн бол Аллахын ивээлээр хэвлийдээ бий болсон хүүхэд буюу тогтсон үрийг нуух нь ариун шударга үйл биш. Тэд энэ хугацаанд эвлэрэхийг хүсвэл эрчүүд салсан эхнэрээ буцаан авах эрхтэй бөгөөд энэ нь зүйд нийцнэ. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн төлөө хариуцлага хүлээдгийн адил эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн төлөө хариуцлага хүлээнэ. Гэхдээ эр нөхрүүд нь (эмэгтэйчүүдийг асран тэтгэх амьдралд нь тусламж үзүүлэх үүрэгтэй тул) эмэгтэйчүүдээс нэгэн зэрэг давуу эрхтэй байна. Аллах үнэхээр аугаа, мэргэн ухааны эзэн билээ.
229. Гэр бүл цуцлалт хоёр удаа. Тийм болохоор зүй зохисоор эргэж ав, эсвэл сайхан сэтгэлээр явуулах хэрэгтэй. Аллахаас заяасан эр-эмийн ёсыг гүйцэтгэж чадахааргүй золгүй явдал тохиолдвол эхнэртээ өгсөн зүйлсээс ямар ч юм авч болохгүй. Харин Аллахын заяасан эр-эмийн ёсыг гүйцэтгэх чадваргүй аюул хоёуланд зэрэг тохиолдвол эмэгтэй салахын тулд эрэгтэйд бага ч гэсэн төлөөс өгвөл хоёулаа буруугүй болно. Энэ бол Аллахын ёс журам. Үүнийг бүү зөрчигтүн. Хэн нэгэн Аллахын ёсыг зөрчвөл тэр зальхай этгээд юм.
230. Хэрэв нөхөр нь эхнэрээс гурав дахь удаа салбал эхнэр нь өөр хүнтэй гэрлэж, түүнээсээ салтал хуучин нөхөртэй эргэж суухыг үл зөвшөөрнө. Хэрэв хоёр дахь нөхөр нь түүнээс салвал эмэгтэй нь хуучин нөхөртэй

- эвлэрэн, Аллахаас заяасан ёс журмыг сахин нийлэх аваас нүгэл болохгүй. Энэ бол мэддэг хүмүүст Аллахаас тогтоосон ёс журам.
231. Салсан эхнэрийнхээ хүлээлгийн хугацаа дуусмагц тэдэнтэй сайн сайхнаар эвлэргээгтүн. Эсвэл ёс төртэй явуулаарай. Тэдэнд зүй бусаар авирлах зорилгоор хохироон цааргалж болохгүй. Эвгүй авирлан, гэрлэх бодолгүй мөртлөө хүлээлгийн хугацааг сунгаж, муу үйл хийвэл өөртөө гай хураах болно. Алладын айлдваруудыг тоглоом тоохуу бүү болгогтун. Аллахаас та нарт өгсөн хувь хишиг болон ухуулан сэнхрүүлэхийн төлөө илгээсэн судруудыг, ариун замналыг санагтун. Аллахаас айгтун. Аллах бүхнийг мэдэгч гэдгийг мэдэгтүн.
232. Хэрэв салсан эхнэрийн хүлээх хугацаа нь дуусаж, бусад хүнтэй зүй зохисоор учирсан бол тэдний гэрлэлтэнд бүү саад учруул. Энэ нь та нарын дунд буй Аллахад болон нөгөө ертөнцөд итгэгч хэн нэгэнд сургамж юм. Энэ сургамжийг хүлээж авах ба Алладын тушаал зарлигийг биелүүлэх нь тун сайн өгөөжтэй бөгөөд хамгийн ариун үйлдэл юм. Та нар мэдэхгүй ч Аллах бүхнийг мэдэгч.
233. Хүүхдээ хөхөөр бүрэн тэжээх хүсэлтэй эхчүүд хоёр жил хөхүүлэх хэрэгтэй. Зүй ёсоор бол энэхүү хугацаанд эхчүүдийн хоол унд, хувцасаар нь хангах үүргийг хүүхдийн эцэг хүлээнэ. Хүн бүр өөрийн чадах зүйлээрээ л харууцлага хүлээнэ. Учир нь хүүхдийн төлөө эцэг, эхийн хэн нь ч хохирол амсах учиргүй. Эцэг нь нас барвал хэн нэгэн өв залгамжлагч нь эцгийн адил хүүхдийн эхэд хөрөнгө төлөөс төлөх үүрэгтэй. Хэрэв эцэг эх хоёр харилцан зөвшилцөж, хүүхдийг хоёр жилээс өмнө хөхнөөс гаргахаар байвал хэн нэгэнд нь нүгэл болохгүй. Хэрэв хүүхдээ бусад эхээр хөхүүлэх болвол хөхүүлсэн ээжид нь зохих төлөөсийг бүрэн өгвөл та нарт нүгэл үгүй. Аллахаас айгтун. Аллах та нарын үйлдлийг бүрэн харагч гэдгийг мэдэгтүн.
234. Та нарын дундаас хэн нэгэн нас барж, эхнэр нь бэлбэсэрбэл тэр эмэгтэй (хэн нэгэнтэй гэрлэхгүйгээр) дөрвөн сар арав хоног хүлээх ёстой. Энэхүү хугацаа дууссаны дараа уг эмэгтэйгийн шашины заншил ёсоор хийсэн зүйлд нь та нарын хувьд нүгэл болохгүй. Аллах та нарын юу хийж байгааг бүрэн мэдэгч билээ.
235. Хүлээх хугацаа нь гүйцээгүй эмэгтэйтэй уг хугацаа дууссаны дараа гэрлэх саналаа битүүхэн илэрхийлж эсвэл зорилгоо нууцлан хадгалбал та нарт нүгэл үл болно. Аллах та нарын гэрлэх бодолыг мэдэж байгаа. Гэхдээ нууцаар бүү хэлэлцэгтүн. Өөрсдийн айл аймгийн хүрээнд ярьж болно. Хүлээлгийн хугацааг гүйцэх хүртэл гэрлэхээс татгалзагтун. Аллах үнэндээ та нарын бодолыг тааж мэддэг. Түүнээс эмээгтүн. Аллах нэн өршөөгч, нэн уужим.
236. Эхнэртэй бэлгийн харилцаанд оролгүйгээр эсвэл сүй бэлэг төлөөгүй байхад салбал (ердөө гэрлэх ёслол хийх төдий буцаавал) нүгэл үгүй. Гэхдээ хэн хэн нь боломжийн хэрээр ашигтай бэлэг дурсгал, ямар

- нэгэн зүйл солилцогтун. Баян, ядуу хэн нь ч өөрсдийн боломжоор бэлэг сэлт өгөх нь сайн санаат хүмүүсийн гүйцэтгэвэл зохих журмын үүрэг мөн.
237. Хэрэв сүй бэлэг төлөвлөгдөөд, гагцхүү гэрлэж амжилгүй, бэлгийн харьцаанд оролгүйгээр салах аваас төлөвлөгдсөн сүй бэлгийн талыг эмэгтэйд өгөгтүн. Харин эмэгтэй нь уучилбал, эсвэл гэрлүүлэхээр хэлэлцсэн хүн уучилбал өөр хэрэг юм. Хүлцэл өчин төлбөр төлөөснөөс татгалзах нь чин үнэнч, хүнлэг ёстой ойр зүйл. Бие биедээ тусалж, харилцан энэрэлтэй байхыг бүү мартагтун. Аллах та нарын юу хийж буй бүхнийг зүй ёсоор харагч билээ.
238. Уншлага мөргөлөө, ялангуяа үд дундын уншлага мөргөлөө анхаарч сахигтун. Аллахын төлөө мэхийн ёсолж мөргөлөө үйлдэцгээгтүн. Аллахад хүндэтгэлтэйгээр мөргөлөө үнэнчээр үйлдэгтүн.
239. Түгшүүртэй нөхцөлд явган явангуут эсвэл мориноос буулгүй уншлага мөргөлөө үйлдэж болно. Аюулгүй нөхцөлд Аллах хэрхэн зааж сургасан, тэр ёсоор үйлдэгтүн.
240. Үхэлийн аюул гарцаагүй нүүрлэсэн цагт (үхэхээс өмнө) ардаа үлдэх эхнэрээ нэг жил хүртэл хувцас-хунар, хоол-ундаагаар хангахыг, гэрээс хөөж явуулахгүй байхыг гэрээслэгтүн. Хэрэв эмэгтэй нь өөрийн хүслээр гэрээс явбал тэдний ёс журмаар хийсэн зүйлийн төлөө та нарт нүгэл үгүй. Аллах аугаа бөгөөд мэргэн ухааны эзэн.
241. Салсан, бэлэвсэрсэн эмэгтэйчүүдэд зүй ёсоор (нөхрөөсөө) тусламж (мөнгө) өгөх нь үнэнч сүсэгтнүүдийн гүйцэтгэх журамт үүрэг мөн.
242. Аллах та нарт үнэнийг ойлгож ухаараг хэмээн ийнхүү өөрийнхөө айлдваруудыг тайлбарладаг.
243. Мянга түмээрээ байсан мөртлөө үхлээс айж нутаг уснаасаа дайжин явагсадыг мэдэх үү? Аллах тэдэнд хандан : “Үхэцгээгтүн” хэмээн тушаахад тэд (үхэцгээв). Дараа нь тэднийг Аллах дахин амилуулав. Аллах үнэндээ хүмүүст хайр энэрэлтэй. Гэтэл хүмүүсийн ихэнх нь талархаж мэддэггүй.
244. Аллахын төлөө дайтагтун. Аллах бүхнийг сонсож, мэдэж байдгийг мэдэгтүн!
245. Хэн нэгэн Аллахад чин сэтгэлээрээ өөрийн эд баялагыг зориулах аваас Аллах түүнд хэд дахин илүү хариу барина. Аллах шалган сонжихын тулд зарим хүмүүсийг тарчиг амьдралтай болгоно. Та нар бүгдээрээ Түүн рүү буцаж очицгооно.
246. (Аяа, Мухаммед!) Мусагийн дараа Израилийн үр садын толгойлогч хэн нэгнийг чи үзсэнгүй юу? Тэд өөрсдөд нь ирсэн гэгээн элчид : “Бидэнд нэгэн хаан илгээ. Тэгвэл бид Аллахын төлөө дайгъя” гэсэн. Гэгээн элч тэдэнд : “Хэрэв та нарт дайныг ариун үүрэг болговол татгалзах байсан юм уу?” гэв. Тэд : “Бид эх нутгаасаа хөөгдсөн, хөвгүүдээсээ хагацсан.

- Аллахын төлөө яагаад дайтахгүй билээ” гэж хэлцгээсэн. Гэтэл тэдэнд дайн ариун үүрэг болгогдоход цөөн хэдээс бусад нь татгалзав. Аллах, ийм зальт этгээдүүдийг сайн мэднэ.
247. Гэгээн элч тэдэнд : “Аллах, та нарт Талутыг хаан болгон илгээлээ”-гэв. Тэд: “Тэд бидэнд яаж хаан болох юм бэ? Түүнийг бодоход хаан болоход бид илүү тохиромжтой. Тэгээд ч түүнд олигтой эд хөрөнгө ч үгүй” гэв. Гэгээн элч тэдэнд : “Аллах та нарт үнэхээр Талутыг хаан болгосон. Аллах түүнд эрдэм мэдлэг, хүч чадлыг илүү заяасан. Аллах хүссэн хүндээ эрх мэдэлийг өгдөг. Аллах уужим, алив бүхнийг мэдэгч.” гэв.
248. Гэгээн элч тэдэнд: “Түүний хаанчлалын шинж тэмдэг болж нэгэн авдар ирнэ. Авдар дотор та нарыг тохинуулах зүйлс, Муса, Харун хоёроос үлдсэн (Мусагийн таяг, Харуны толгойн алчуур, Таурат судар бичигдсэн самбарууд зэрэг) өв бий. Тэднийг мэлэжүүд (тэнгэрийн элчүүд) үүрээд ирнэ. Хэрэв та нар Аллах болон хойд ертөнцөд итгэвэл энд (дээрх зүйлүүд болон Талутын хаанд өргөмжлөгдсөнтэй холбоотой) та нарт зориулагдсан тодоос тод бэлгэдлүүд бий.” гэв.
249. Тэгээд Талут цэргүүдтэйгээ замдаа гарахдаа тэдэнд хандан: “Аллах та нарыг нэг голоор шалгана. Хэн голын уснаас уух юм бол тэр миний харьяалалд биш. Мэдээж хэн нэгэн голын уснаас үл амсвал надтай хамт. Харин алгаараа нэг утган авч, амсабал гэм зэмгүй.” гэлээ. Гэвч цөөн хэдээс бусад нь голын уснаас уучихлаа. Тэгээд Талут болон түүнтэй хамт сүсэглэгчид голыг гатлахуйд (ардаа үлдсэн хэсэг) : “Бид Жалут болон түүний цэргийн эсрэг байлдах ямарч хүч чадал бидэнд алга”-гэцгээсэн. Аллахын ивээлд багтан, Аллахад итгэн бишрэгсэд: “Аллахын ивээлээр маш цөөн тоотой хүч ч их цэргийг ялж болно” гэлцэв. Аллах ямагт тэвчээртэнгүүдтэй хамт.
250. Тэгээд Жалут болон түүний цэргүүдтэй учирсан үедээ : “Эзэнтэн минь ээ! Биднийг тэвчээртэй болго, бидний өлмийг бат орших болго, бидэнд буруу номтнуудын эсрэг туслаач.” гэцгээсэн.
251. Аллахын ивээлээр тэд ялав. Дауд, Жалутыг алав. Аллах Даудад хаанчлалыг, мэргэн ухааныг өгч эрдэмд сургасан. Аллах хүмүүсийн нэг хэсгийг нөгөөгөөр нь хамгаалахгүй ад үзвэл газар дэлхий самарч дуусах биз. Аллах бүх даян дэлхийг өршөөн соёрхогч шүү дээ.
252. (Аяа, Мухаммед!) Энэ бол Аллахын айлдварууд. Үүнийг чамд гуйвалтгүй уншиж өгнө. Чи үнэхээр элч нарын нэгэн мөн.
253. Ийнхүү гэгээн элчүүдийн заримыг бусдаас давуутай болгосон. Аллах тэдний заримтай нь ярилцсан. (Гэгээн элч Мусатай) Зарим нэгнийх нь (Мухаммедиин) зэрэг зиндааг дээшлүүлсэн. Мариямын хүү Иса-д (Есүст) ер бусын гайхамшгуудыг хайрласан. Мөн түүнийг Рухул-кудусаар (Жебрайлаар) хүчирхэгжүүлсэн.(Үхсэнийг амилуулах, хэлгүйг яриулах, галзууг эдгэрүүлэх зэрэг). Хэрэв Аллах хүсвэл дараачийн үеийнхэн өөрт нь илэрхий нотолгоонууд илгээгдсэнийхээ

- дараа бие биеэ хөнөөхгүй л байсан. Гэвч тэд хоорондоо эв нэгдэлгүй байлаа. Тэдний зарим нь сүсэглэж, зарим нь эсэргүүцсэн. Хэрэв, Аллах хүсвэл тэд бие биетэйгээ дайтахгүй байх байсан. Аллах хүссэн зүйлээ хийдэг.
254. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Арилжаа наймаа, андлах ёс, өршөөл өмөөрөл үгүй болох өдөр ирэхээс өмнө (хойд ертөнцөд шүүгдэх өдөр) та нарт хувь хишиг болгосон мал хөрөнгөө Аллахын төлөө зарцуулагтун. Биеэ тоогсод - өөрийгөө хууран мэхлэгсэд мөн.
255. Аллах бол цорын ганц. Түүнээс өөр бурхан үгүй. Тэр мөнхөд оршигч, бүхий л оршин ахуйг эрхшээгч. Тэр нойрмоглодоггүй, зүүрмэглэдэггүй. Тэнгэр, газарт байгаа бүхэн Түүнд харьяалагдана. Түүний зөвшөөрөлгүйгээр хэн ч бусдыг ивээн соёрхож чадах билээ? Тэр, хүмүүсийн юу хийснийг, бас юу хийхийг мэддэг (Түүнд ямар ч зүйл нууц үлдэхгүй). Хүмүүс, Аллахын заяасан мэдлэгээс өөр юуг ч мэдэж чадахгүй. Түүний эрх мэдэлд тэнгэр, газар бүгд багтана. Тэнгэр, газрыг хамгаалах нь Түүнд огтхон ч хэцүү биш. Тэр бүхнээс дээгүүр, бүхнээс аугаа.
256. Шашинд (Исламд) албадлага үгүй, шударга ёс нь, бусармаг юмнаас ялгагдсан. Хэн нэгэн мухар сүсгийг үгүйсгэж Аллахад итгэвэл тэр бөх баг хугарашгүй хүрдийг барих болно. Аллах бүхнийг сонсогч, мэдэгч.
257. Аллах сүсэглэгсэдийн эзэн, тэднийг харанхуйгаас гэрэл рүү гаргадаг. Харин буруу номтнуудын эзэн нь чөтгөр шулам, тэднийг гэрлээс харанхуй руу оруулдаг. Ийнхүү тэд тамынхан, тэнд үүрд үлдэцгээдэг.
258. Аллах “өөртөө хаанчлал өглөө” гэж Эзэнтний тухай Ибрахимтай мэтгэлцсэн хүнийг (Намрутыг) үзсэнгүй үү? Ибрахим тэдэнд: “Миний Эзэнтэн үхсэнийг амилуулж, амьдыг үхүүлж чаддаг” гэхэд тэр: “Би ч гэсэн үхсэнийг амилуулж, амьдыг үхүүлж чадна.” гэв. (Тэр Намрут алах ял сонссон хоёрын нэгийг алж, нөгөөг явуулчихав) Ибрахим түүний тэнэглэлд гайхан : “Аллах нарыг зүүнээс мандуулдаг. Чи нарыг баруунаас мандуулчихлаа” гэхэд үл сүсэглэгч таг болсон. Аллах зальхай этгээдийг шулуун зам руу залахгүй.
259. Эсвэл үнсэн товрог болсон хоосон суурингийн хажуугаар явагч хүний (Үзэйрийн) жишээг үзсэнгүй юу? Тэр гайхшран: “Аллах тэднийг үхсэн хойно яаж амилуулах бол?” гэв. Аллах тэднийг зуун жил үхлүүлт байлгаж, дараа нь өөрийнхөө гайхамшгаа харуулахын тулд дахин амилуулан, мэлкүүдээр дамжуулан: “Хэр удаан амьгүй хэвтсэн бэ?” гэж асуув. Тэр : “Би нэг өдөр юм уу, өдрийн хагаст үхсэн” гэв. Аллах : “Үгүй ээ, чи зуун жил үхэж хэвтсэн. Хоол ундаагаа хар л даа. Огт муудаагүй байна. Харин илжгээ хар. (Түүний яс аль хэдийнээ цайчихсан байгаа биз) Би хүч чадлаа гайхуулан чамайг хүмүүст үзүүлж сургамж болгохын тулд ийнхүү хийсэн. Одоо хувхай яс руу хар, түүнийг яаж эвлүүлэн бие махбодтой босгохыг харах болно.” гэв. Үйл явдал өөрт

- нь ил тод болж, хувхай цайсан яс эвлэн махалж ер бусын гайхамшгаар амилан боссоньг харсны дараа тэр : “Аллах үнэндээ бүх юмыг эрхшээх чадалтай гэдгийг би мэдлээ” гэв.
260. Нэгэнтээ Ибрахим: “Аяа, эзэнтэн минь! Үхдэлийг яаж амилуулдаг юм вэ? Надад харуулаач?” гэхэд Аллах : “Чи надад итгээгүй юм уу?” гэв. Ибрахим : “Үгүй ээ! Нүдээрээ үзэж сэтгэлээ тайвшруулахын тулд” гэсэн. Аллах : “Хэрэв тийм бол, дөрвөн шувуу бариад, дараа нь тэдгээрийг хэрчиж эвдээд, хольж хутган, хажуудаа тавь. Тэгээд уул толгод бүхэн дээр нэг нэг эрхтнийг нь аваачиж хая. Дараа нь тэднийг өөр лүүгээ дууд, тэд чам дээр даруй буцаад ирэх болно. Аллах ялагдашгүй, мэргэн ухааны эзэн болохыг мэд” гэсэн.
261. Аллахын төлөө мал хөрөнгөө зарцуулагсад бол түрүү бүртээ зуун үр агуулсан тарианы долоон түрүүтэй адил. Аллах хүссэн хүнээ олон давхар ивээн тэтгэнэ. Аллахын хайр энэрэл хэмжээлшгүй, Тэр бүхнийг мэдэгч.
262. Мал хөрөнгөө Аллахын төлөө зарцуулагсад, түүнийг төвөгшөөгүй хүмүүс, өглөг авагсадыг үл гомдоогсад Аллахын ивээл хүртэнэ. Хойд насанд нь айдас хүйдэс, уй гашуу үгүй байх болно.
263. Сайхан үг, өршөөл уучлал хоёр хожим гомдоогч өглөгөөс хавьгүй илүү. Аллах баян, уужим (гэсгээхийн төлөө яардаггүй).
264. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахад болон хойд ертөнцөд итгэдэггүй мөртлөө хүмүүст сайн харагдахын тулд дүр эсгэж мал хөрөнгөө зарцуулагсадын адил өглөгүүдээ дурамжхан эсвэл бусдыг гомдоон байж өгж, талаар бүү болго. Тийм хүмүүс бол дээр нь тогтсон шороо нь адар борооноор урсан алга болдог хадан цохионы адил. Иймэрхүү өглөгөөрөө ямар ч ивээл хүртэж чадахгүй. Аллах үл сүсэглэгсэдийг зөв замд оруулдаггүй.
265. Аллахын ивээл таалалыг хүргэх, хожимын наминчлал сүсгээ бататгахын тулд мал хөрөнгөө өглөг болгон өгдөг хүмүүс бол хур буувал хоёр дахин их ургац авах, бороо ороогүй ч хөрсний чийгээ хадгалан, тэгээд ургацаа алддаггүй дэнж дээрх цэцэрлэгтэй адил ажгуу. Аллах та нарын юу хийж байгааг харж мэдэж байдаг.
266. Та нарын дотор Хасарваань болон үзэмтэй, хаяагаар нь булаг урсдаг, их хэмжээний ургац өгдөг цэцэрлэгтэй, насан өндөр болсон, үр хүүхэдтэй хэн нэгэнийг гай дайрч, цэцэрлэг нь галтай шуурганд үнсэн товрог болтол шатахыг хүсдэг гэж үү? (мэдээж үүнийг хэн ч хүсэхгүй) Аллах та нарыг ухааруулахын тулд өөрийн айлдваруудыг ийнхүү жишээлэн тайлбарладаг.
267. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Олсон орлогоосоо, бидний хувь хишиг болгож өгсөн үр тариа, жимс зэрэг зүйлсийн олигтойгоос нь буяны өглөг өгөгтүн. Өөрсдөө нүдээ анин байж дурамжхан авдаг чанар муутайг



- ялгаж өглөгөнд бүү өгөгтүн. Аллах та нарын буяны өглөгийг горьдогч биш, төгс магтаалын эзэн болохыг мэдэгтүн.
268. Чөтгөр шулам та нарыг ядуу зүдүүгээр айлгадаг, ичгүүр сонжуургүй харамч байхыг тулгадаг. Харин Аллах та нарт өршөөл хүлцэлийг, хайр энэрэлийг амладаг. Аллах өгөөмөр, бүхнийг мэдэгч.
269. Аллах мэдлэг ухааныг хүссэн боолдоо өгдөг. Хэн нэгэнд Аллах мэргэн ухааныг заяавал түүнд хэмжээлшгүй их сайн үйлийг ч заяана. Гагцхүү ухаан төгс хүмүүс л үүнийг ухамсарладаг.
270. Та нарын Аллахын төлөө хийсэн буян өглөгийг, амласан бүхнийг Аллах үнэхээр мэддэг билээ. Зальхай амьтадад (хэрцгий, харамч, мал хөрөнгөө нүгэлтний төлөө үрэн таран хийгчдэд) ямар ч ивээл, өмөөрөл үгүй.
271. Өглөгийг ил тодоор өгвөл зүгээр. (Бусдад үлгэр дуурайлал болно) Хэрэв нууцаар бас ядууст өгвөл бүр ч сайн. (өглөг авагчийг ичгэвтэр байдалд оруулахгүйгээр, өөрийгөө магтуулахгүйгээр). Энэ та нарын зарим нүглийг хөнгөлөх үндэс болно. Аллах та нарын хийж буй үйлдэл бүрийг мэддэг.
272. (Аяа, Мухаммед!) Тэднийг зөв зам руу оруулах чиний үүрэг биш. Аллах хүссэн хүнээ зөв замд оруулна. Та нарын сайн үйлсийн төлөө зарцуулсан бүхэн чинь өөрсдийнхөө төлөө юм. Та нарын хийх гэж буй сайн үйлс бүхэн чинь гагцхүү Аллахын таалалыг хүртэхийн төлөө хийгдэх учиртай. Та нарын сайн үйлсийн төлөө өгсөн бүхний чинь хариу та нарт эргэж өгөгдөх бөгөөд хэзээ ч шударга бус хандахгүй.
273. Өөрсдийгөө Аллахын замд зориулсан, амь зуух эрхээр хашаа ч явж чаддаггүй ядууст өглөг өгөцгөөгтүн. Ахуй байдлыг нь мэдэлгүйгээр хүсэмжилдэггүй байдлыг харж тэднийг баян чинээлэг гэж боддог. Тэдний нүүр царайнаас нь андашгүй. Тэд уваайгүй зан гаргаж, ямар нэгэн юм хүсдэггүй. Та нар ямар өглөг өгсөн ч Аллах бүхнийг мэддэг.
274. Мал хөрөнгөнөөс өдөр болон шөнө, ил, далд өглөг өгөгсөдөд зориулсан Аллахын талархал хэзээд бэлэн байдаг. Тэдэнд айдас хүйдэс, уй гашуу үгүй.
275. Мөнгө хүүлэгчид хойд насандаа чөтгөрд нэрвүүлэн солиорсон хүний адил босч ирэх болно. Учир нь тэд “Арилжаа наймаа бол хүүлэхтэй адил” гэнэ. Үнэндээ Аллах арилжаа наймааг зөвшөөрсөн ч хүүлэхийг бузар хэмээн айлддаг. Хэн нэгэн хүн хүүлэх нь бузар болох тухай Эзэнтний сургамжийг хүлээн авсанаас хойш бодлоосоо татгалзах аваас хураасан нь өөрт нь үлдэх бөгөөд түүний үйл хэргийг хэрхэх нь Аллахын эрхэнд үлдэнэ. Дахин хүүлэгсэд тамынхан, тэд тамд үүрд үлдэцгээнэ.
276. Аллах хүүлэхийг үгүй хийж, арилжаа наймааны өгөөжийг нэмэгдүүлнэ. Аллах үл сүсэглэгч, шунахай нүгэлтнийг таалахгүй.

277. Наминчлан залбирч, сайн үйлс хийвэл, уншлага мөргөлөө гүйцэтгэн, ариуслын өглөг өгвөл Аллахын талархал, шагналыг хүлээх болно. Тэдэнд айдас хүйдэс, уй гашуу үгүй.
278. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахаас айгтун. Хэрэв үнэхээр итгэж байгаа бол хүүлэсэн хүүг авахаас татгалзагтун.
279. Хэрвээ илүү хүүг авахыг зогсоохгүй бол Аллах болон гэгээн элч та нарын эсрэг дайтах болно. Хэрэв наминчлах юм бол мал хөрөнгө чинь та нарт эргэж олгогдоно. Бусдад гай болохгүй, өөрсдөө ч гай барцад үзэхгүй.
280. Хэрвээ өр төлбөртэй хүн боломжгүй бол тэр амьжиргаагаа дээшлүүлэх хуртэл хүлээцгээ. Зовлон тохиолдсон өр төлбөртэй хүмүүсээс авах авлагаа тэдэнд буяны өглөг болгон өгөх нь зөв ухаарвал та нарын хувьд нэн буянт үйлс болно.
281. Та нар Аллахад буцаан өгөгдөх, дараа нь хүн бүр өөрийнхөө хөдөлмөрийн үр дүнг шударгаар бүрэн үзэх тэрхүү өдрөөс (хойд ертөнцийн шүүгдэх өдрөөс) айгтун.
282. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Хэрэв та нар бие биендээ тодорхой хугацаагаар зээл өгч авах бол тэмдэглэж байгтун! Та нарын дотор бичиг үсэг мэддэг нэг нь үнэн зөв бичигтүн. Бичигч нь Аллахын өөрт нь сургасны дагуу бичихээс татгалзахгүй (Бүхнийг зүй ёсоор нь) бичигтүн. Өртэй хүн Аллахаас айж эмээн, төлбөрөө дутуугүй зөв бичүүлэгтүн. Хэрэв өр зээлтэй хүн оюуны хомсдолтой, эсвэл үүрэг хүлээх чадваргүй (хүүхэд, настан) эсвэл өөрөө хэлж бичүүлж чадахгүй (хэлгүй г.м) бол, түүний асран хамгаалагч шударгаар бичүүлэгтүн. Тэгэхдээ, хоёр эр хүнийг гэрчээр авагтун. Хэрэв хоёр эр хүн олдохгүй бол өөрсдийнхөө зөвшөөрсөн нэг эр хүнтэй хамт хоёр эмэгтэй хүн байж болно. Ийнхүү тэр хоёрын аль нэг нь андуурвал нөгөөх нь сануулдаг. Гэрчүүд дуудагдсан цагт бүү татгалзагтун. Өр зээл их ч бай, бага ч бай түүнийг эргүүлэн төлөх хугацааг нэмж бичихээс бүү залхуурагтун. Үүнийг хамгийн шударга, гэрчлэх боломжтой эргэлзээ төрүүлэхгүй болгох нь Аллахад тааламжтай. Гэхдээ хоорондоо шууд гардан хийдэг худалдаанд нотлох баримт бичихгүй байсан ч нүгэл үл болно. Арилжаа наймаа хэлэлцэх үедээ гэрч авагтун. Бичигч болон гэрчэд хохирол учруулж болохгүй. Хэрэв хохирол учруулбал та нар нүгэлтэн болно. Аллахаас айгтун. Аллах та нарт (энэ ба хойд насанд ач тустай үйлсийг) заана. Аллах бүхнийг бүрэн тодорхой мэдэгч билээ.
283. Хэрвээ аяллын замд (зээл авч) бичих хүн олдохгүй бол, (бичмэл баримтын оронд) барьцаа хөрөнгө өгч болно. Хэрэв бие биендээ итгэж тодорхой зүйлийг хадгалуулан үлдээвэл итгэл хүлээгч хадгаламжийг буцааж өгөгтүн. (Зээл өгсөн хүн өртэй хүнд итгэж зээлийн оронд ямар нэгэн зүйл барьцаанд үл авбал өртэй хүн өр зээлээ тохиролцсон хугацаанд буцаан төлөгтүн.) Аллахаас айгтун. Гэрчлэлийг бүү

- нууцлагтун. Хэн нэгэн түүнийг нуух юм бол түүний зүрх нүгэлтэн гэдгийг мэдэгтүн. Аллах та нарын хийсэн үйлдэл бүрийг мэдэгч билээ.
284. Тэнгэр болон газарт буй бүхэн Аллахынх. Өөрсдийн бодсоноо ил гаргасан ч, нуусан ч Аллах та нартай тооцоо бодно. Аллах уучлах хүнээ уучилдаг, хүссэн хүнээ гэсгээдэг. Аллахын хүч чадал бүх зүйлд хүрдэг.
285. Гэгээн элч өөртөө Эзэнтнээс илгээсэн сударт итгэсэн. Сүсэгтнүүд ч итгэлээ. Тэд бүгд Аллахад, мэлэкүүдэд, судар номнуудад, гэгээн элчүүдэд төгс итгэцгээсэн. Тэд: “Аллахын гэгээн элчүүдийг алагчлан үзэхгүй. Бид Чиний сонордуулгыг сонслоо, зарлигыг чинь хүлээн зөвшөөрлөө. Аяа, Эзэнтэн минь! Бид чамаас өршөөл эрж байна, чам руу буцна” гэгцгээсэн.
286. Аллах хэнд ч хэр хэмжээнээс хэтэрсэн зүйлийг үүрэг болгохгүй. Хэн сайн үйлс хийвэл буян нь өөрт нь оногдоно. Муу юм үйлдвэл нүглийг өөрөө өөртөө хураана. Тэд: “Эзэнтэн минь! Хэрэв бид мартвал эсвэл эндэж алдвал биднийг өршөөгтүн. Эзэнтэн минь! Биднээс өмнөх хүмүүст үүрүүлсэн шиг бидэнд ч гэсэн хүнд ачаа бүү үүрүүлж үзээрэй. Эзэнтэн минь! Бидний хүч чадал эс хүрэх зүйлсийг бидэнд бүү үүрэг болгогтун. Биднийг уучил, биднийг өршөө, биднийг хайрлаж энэр! Чи бидний Эзэнтэн билээ. Буруу номтнуудад эсэргүүцэхэд бидэнд тус дэм бологтун!” хэмээн залбирна.

### 3. СУРЕ АЛИ ИМРАН

Мадина-д илгээгдсэн. 200 айлдвар.

#### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Алиф, Лам, Мим. (Үүний утгыг зөвхөн Аллах тайлана)
2. Аллах бол цорын ганц. Түүнээс өөр бурхан үгүй. Тэр өнө мөнх амьд, бүхий л ахуйг эрхшээгч.
3. (Аяа, Мухаммед) Аллах чамд өмнөх судруудыг бататгах чин үнэн судрыг (Кураныг) илгээсэн. Өмнө нь Таурат (Тора) болон Инжилийг (Библийг) илгээсэн.
4. Таурат, Инжил хоёр нь өмнөх хүмүүст зөв замыг заагч байсан. Зөв бурууг ялгагч нотолгоонуудыг ил тод айлдсан (Кураныг) буулгасан. Аллахын айлдваруудыг эсэргүүцэгчид хагуу цээрлэл үзнэ. Аллах ялалтын эзэн, гэмт хэрэгтэнүүдийг цээрлүүлэгч мөн.
5. Үнэн хэрэг дээр газарт болон тэнгэрт байгаа бүхий л зүйлс Аллахад нууц биш.
6. Та нарыг эхийнхээ хэвлийд байхад чинь Өөрөө хүссэн дүр төрхийг

- хайрладаг. Түүнээс өөр ямарч бурхан үгүй. Тэр ялагч, мэргэн ухааны эзэн.
7. (Аяа, Мухаммед) Аллах чамд Куран судрыг илгээсэн. Түүнд ил тод айлдварууд бий. Тэр нь судрын язгуур үндэс мөн. Тэрчлэн битүүхэн агуулгатай айлдварууд ч бий. Сэтгэлдээ эргэлзээ агуулагсад будлиан тарьж өөрсдийн таамагласанаар тайлбарлахыг оролддог. Ийм айлдваруудын утгыг гагцхүү Аллах болон ухаантнууд л мэддэг. Тийм эрдэм мэдлэгтэнгүүд: “Бид үүнд (нуугдмал агуулгатай айлдваруудад) итгэцгээдэг, тэд Аллахаас айлдсан айлдварууд. Үүнийг зөвхөн оюун ухааны эзэд л ойлгож ухамсарладаг” хэмээн хэлнэ.
  8. Аяа, Эзэнтэн минь! Биднийг зөв замд оруулсны дараа бидний итгэл сэтгэлийг бүү хувиргагтун. Биднийг ивээлд авч хайрлагтун. Чи бол маш өгөөмөр сэтгэлтэн билээ.
  9. Аяа, Эзэнтэн минь ээ! Үнэндээ гарцаагүй ирэх тэр өдөрт (хойд ертөнцөд) хүмүүсийг нэгтгэн, хариу тооцоо хийгч Чи билээ. Аллах үнэндээ амлалтаа хэзээ ч зөрчихгүй.
  10. Үл сүсэглэгч буруу номтны мал, үр сад нь Аллахын гэгсгээл цээрлэлийн өмнө ямар ч тус болж чадахгүй. Тэд тамын галын түлээ түлш төдий.
  11. Одоогийн буруу номтнуудын байдал өмнөх Фиргауны түүнээс өмнөх хүмүүсийн төрх байдалтай адил. Тэд Бидний айлдваруудыг үгүйсгэдэг. Иймээс Аллах тэднийг гэмт хэргийн төлөө цээрлүүлнэ. Аллахын цээрлэл маш хүнд.
  12. (Аяа, Мухаммед) Үл сүсэглэгсдэд: “Та нар гарцаагүй ялагдана. Тамд очицгооно, там бол туйлын муухай газар” гэж хэлэгтүн.
  13. Буруу номтнууд аа! (Бадрийн дайнд) Тулалдсан хоёр талд нэг л сургаж бий. Нэг хэсэг нь Аллахын төлөө байлдагсад, нөгөө хэсэг нь үл сүсэглэгсэд. Тэдэнд Мусулманчуудын тоо хоёр дахин илүү мэт харагдана. Мусулманчуудын цөөхөн хэсгийг буруу номтнуудад хоёр дахин илүү харагдуулсан. Аллах хүссэн хүнээ ивээн тусалдаг. Гярхай ухаарсан хүмүүсийн хувьд энэхүү үйл явдалд эргэлзээгүй сургаж бий.
  14. Эхнэр хүүхэд, алт мөнгө, хурдан хүлэг, мал сүрэг, газар тариалан зэрэг нүд булаах эд зүйлс нь хүн гэдэг амьтанд нэн халуун дотно санагддаг. Эдгээр зүйлс нь цөөн хоног амьдралын сайн сайханы төлөө л юм. Жинхэнэ сайхан газар (диваажин) Аллахын нигур доор буй.
  15. (Аяа, Мухаммед) Зон олондоо : “Та нарт үүнээс ч илүү сайхан зүйл байдгийг хэлэх үү □ Төгс сүсэглэгчдийн хувьд Эзэнтний дэргэд хаяагаар нь ариун горхи урсдаг, мөнх орших диваажингууд бий. Мөн тэдэнд үнэнч ариун хань ижилүүд, Аллахын ивээл таалал байдаг” гэж хэл. Аллах боолуудаа маш тод хардаг.
  16. Тэд: (үнэн сүсэгтэнүүд) “Аяа, Эзэнтэн минь! Бид эргэлзэлгүй

- сүсэглэлээ. Тиймээс бидний нүглийг өршөөж, тамын гэгсгээлээс хамгаалагтун!” гэнэ.
17. Тэд-тэвчээртэнгүүд, үнэнчүүд, итгэн бишрэгсэд, Аллахын төлөө өглөг өргөгсөд, үүрийн гэгээнээр өглөөний уншлага мөргөл үйлдэн, Аллахаас өршөөл гуйгсад.
  18. Аллах өөрөөсөө ондоо бурхан үгүйг шударгаар гэрчилэв. Мэлэкүүд болон эрдэмтэн мэргэд ч Түүнээс өөр бурхан үгүй гэдгийг, Түүний бусдаас илүү мэргэн ухааны эзэн болохыг шударгаар гэрчилэв.
  19. Үнэндээ Аллахын бататгасан шашин бол Ислам шашин юм. Өмнөх судрын эзэд (Иүдэй болон Христүүд) өөрсөд нь үнэн мэдээлэл ирсний дараа хоорондын атаархлаар маргалдав. (Мухаммедийн гэгээн элч болохыг, Ислам шашны чин үнэнийг илэрхий нотолгооноос мэдсэн атал түүнийг санаатайгаар үгүйсгэв) Хэрэв хэн нэгэн Аллахын айлдваруудыг үгүйсгэн эсэргүүцвэл (Аллах түүний цээрлүүлнэ) учир нь Аллах үтэр түргэн тооцоо хийнэ.
  20. (Аяа, Мухаммед) Тэд чамтай шашны талаар маргалдах аваас : “Намайг дагагсадыг Аллахад даатгасан” гэж хэл. Мөн ариун судрын эзэд болон мунхагуудаас: “Та нар мусулман болсон юм уу?”-гэж асуутгун. Хэрэв тэд мусулман болсон юм бол зөв замд орсон нь тэр. Харин тэд нүүрээ буруулсан бол чамд ямар нэгэн гэм зэм үгүй. Чи зөвхөн дамжуулах үүрэгтэй. Аллах, өөрийнхөө боолуудыг харж байдаг.
  21. Аллахын айлдваруудыг эсэргүүцэгчдийг, гэгээн элчүүдийг хэлмэгдүүлэн алагсадыг, шударга ёсонд уриалагсадыг алагсадыг Аллах хатуу цээрлүүлэхийг анхааруулаарай.
  22. Энэ яваа насандаа ч, хойд яваа насандаа ч тэдний ажил үйлс талаар болно. Тэднийг хэн ч ивээн өмөөрөхгүй.
  23. (Аяа, Мухаммед) Ариун судраас хувь хүртэгсэдийг хараагүй гэж үү? Тэд Аллахын заасаны дагуу шийдвэр гаргахаар бол тэдний нэг хэсэг нь нүүр буруулан одно. Тэд үнэнээс нүүрээ буруулагсад.
  24. Энэ нь тэдний : “Биднийг тоотой хэдэн өдөр л гал шүргэнэ”-гэснээс үүдэлтэй. Шашны тухай тэдний санаанаас зохиож, бусдыг гүтгэх нь өөрсдийгөө хуурснаас болсон.
  25. Гарцаагүй шүүгдэх тэр өдөр Бид тэднийг нэг дор цуглуулж, хүн бүрт хийсэн үйлийнхээ хэрээр хариу бүрэн өгөгдөх, хэнийг ч үл өршөөх тэр цаг тэдний байдал ямар байх бол?
  26. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Бүхний эзэн Аллах минь! Чи хүссэн хүндээ хаанчлах эрх дарх өгдөг, хүссэн хүнээсээ эрх дархыг буцааж авдаг. Хүссэн хүнээ дээдлэн өргөмжөлдөг, бас хүссэн хүнээ дорд оруулдаг. Бүхий л сайн сайханы түлхүүр Чиний гарт (эрхшээлд). Чиний хүч чадал бүх юманд хүрдэг” хэмээн хэлэгтүн.

27. Чи шөнийг өдрөөр, өдрийг шөнөөр сольдог. Үхсэнийг амилуулдаг, амьдыг үхүүлдэг. Хүссэн хүндээ хязгааргүй хувь хишиг хүртээдэг.
28. Сүсэгтэнүүд сүсэгтэнүүдийг орхиж буруу номтнуудтай нөхөрлүүзэй. Хэн үүнийг хийх аваас Алладын нөхөрлөлийг үзэхгүй. Харин тэднээс айхын эрхээр нөхөрлөгсөдийн хувьд өөр хэрэг. Аллах та нарыг Өөрийнхөө гэсгээл цээрлэлээрээ айлган анхааруулж байдаг, эцсийн эцэст учрах газар чинь- Алладын нигур дор болой.
29. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Та нар сэтгэл дотороо нуусаныг ч, нуугаагүйг ч Аллах мэддэг. Түүгээр үл барам тэнгэр, газарт буй бүхнийг мэддэг. Алладын хүч чадал бүх юманд хүрдэг” гэж хэл.
30. Ертөнцийн төгөсгийн тэрхүү өдөр хүн бүрийн сайн, муу үйлдэл нь урьдаас нь тосч байдаг. Хүн бүр тэр өдөр муу үйлс өөрөөсөө хол байгаасай гэж хүсдэг. Аллах, та нарыг Өөрийнхөө эсрэг байхаас анхааруулж байдаг. Аллах боолууддаа машид энэрэнгүй.
31. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Хэрэв та нар Аллахад дотночилж байгаа бол намайг дагагтун. Ингэснээр Аллах та нарыг хайрлах бөгөөд нүгэлийг чинь өршөөнө. Аллах туйлын нигүүлсэгч, нэн өршөөгч” хэмээн хэлэгтүн.
32. Тэдэнд : “Аллах болон гэгээн элчийг (Мухаммедыг) хүлээн зөвшөөрцгөө” гэж хэл. Хэрэв нүүрээ буруулвал Аллах үл сүсэглэгч буруу номтнуудыг хайрладаггүй” гэж хэл.
33. Аллах Адам болон Нухыг, Ибрахим болон Имраны үр садыг гэгээн элчээр сонгож, ертөнцөд эрхэмлэн дээдэлсэн.
34. Тэдний үр сад- цус нэгтнүүд. Аллах бүхнийг сонсогч, мэдэгч билээ.
35. Нэгэнтээ, Имраны эхнэр (Факузагийн охин) : “Аяа, Эзэнтэн минь! Би хэвлийдээ тээсэн үрээ энэ хорвоогийн явдлаас чөлөөлж, Чамд даатгалаа. Энэхүү хүслийг минь болгоон соёрх. Чи үнэхээр бүхнийг сонсож, мэдэж байдаг шүү дээ” гэлээ.
36. Улмаар тэр охин төрүүлэв. Тэрбээр: “Аяа, Эзэнтэн минь! Би охин төрүүллээ” гэв. Аллах түүний юу төрүүлснийг угаас мэддэг аж. Имраны эхнэрийн хүссэн хүү нь охинтой адил биш билээ. Би түүнд Мариям гэсэн нэр хайрласан. Түүнийг болон үр садыг нь адлагдсан чөтгөр шуламын гай барцадаас хамгаалуулахын тулд Чамд залбирч байна” гэлээ.
37. Эзэнтэн Мариямын хүсэл шивнэлийг хүлээн авлаа. Түүнийг үзэсгэлэнтэй, төгс ухаантай болгон өсгөсөн. Закарияг түүний асран хамгаалагч болгов. Закария түүнийг харахын тулд өрөөнд нь орох бүртгээ хажууд хувь хишиг (идээ) байсныг харж: “ Аяа Мариям! Энэ чамд хаанаас ирдэг бэ?” гэжэд, Тэр : “Аллахаас ирдэг” гэдэг байлаа. Аллах үнэхээр хүссэндээ хязгааргүй хишгээ хүртээдэг билээ.
38. Тиймээс Закария: “Аяа, Эзэнтэн минь! Надад ч Өөрийн зүгээс нэгэн

- сайн үр хайрлаач! Чи үнэхээр хүсэлийг ёсоор боллогч билээ” гэж залбирав.
39. Закария мөргөлийн өрөөндөө уншлага мөргөлөө үйлдэж байхад мэлэжүүд түүнд: “Аллах чамайг Өөрийнхөө үгийг (Есүсийн ирэхийг) бататгагч, олны хүндэтгэл үзсэн, шуналгүй, эрхэмсэг дээдсээс гэгээн элч болох Яхия хүүг хайрласны тухай сайхан мэдээгээр баярлуулж байна” хэмээн өгүүлэв.
  40. Закария : Аяа, Эзэнтэн минь! Би нэгэнт нас өтлөж хөгширсөн, дээр нь миний эхнэр хүүхэд төрүүлдэггүй юм чинь надад яаж хөвгүүн заяахсан билээ?” гэв. Мэлэжүүд: “Аллах юу хүссэнээ бүтээдэг” гэж хариулав.
  41. Закария : “Аяа, Эзэнтэн минь! Надад (эхнэр минь жирэмслэх) нэгэн бэлгэдэл харуулаач?” гэв. Аллах түүнд : “Чиний бэлгэдэл гэвэл: Гурван өдөр хэлгүй болж, дохиогоор ойлголцох болно.(Зөвхөн Аллахт залбиран, магтах төдийд ярьж чадна) Иймд эрт орой Аллахыг олонтой санагалзан, шагшин магтаж залбир” гэв.
  42. Мэлэжүүд (тэнгэрийн элчүүд) : “Аяа, Мариям! Аллах чамайг эргэлзээгүй сонгосон, чамайг цэвэр ариун бүтээсэн, ертөнцийн бүхий л эмэгтэйчүүдээс илүү болгосон.
  43. Аяа, Мариям! Эзэнтэндээ захирагдан сөгдөн мөргө, чи ч гэсэн мэхийн ёслогсодтой хамт мэхийн ёсол!” гэв.
  44. (Аяа, Мухаммед!) Чамд илгээсэн энэхүү айлдварууд бол далдын мэдээнүүд. Тэдний хэн нь Мариямыг хамгаалалтандаа авах вэ гэж сугалаа татах үед, мөн өөр хоорондоо маргалдаж байх үед ч чи тэдний хажууд байсангүй.
  45. Тэрхэн мөчид мэлэжүүд : “Аяа, Мариям! Аллах чамд эцгийн оролцоогүйгээр Өөрийн ид шидээр мэндлэх нэгэн хүүгийн тухай баярт мэдээг дуулгах болно. Түүний нэр нь Масих Мариамын хүү Иса (Есүс). Тэр энэ дэлхийд ч, хойд ертөнцөд ч нэр хүндтэй, бас Аллахад ойр дотныхны нэгэн байна.
  46. Иса (Есүс) бол өлгийтэй байхдаа ч, нас бие гүйцсэн үедээ ч хүмүүстэй эзэн хаан мэт ярилцана. Мөн ухаан төгс, өгөөмөр нигүүлсэнгүй хүн байх болно” гэв.
  47. Мариям: “Аяа, Эзэнтэн минь! Надад хэн ч ойртоогүй байхад би яаж хүүхэдтэй болохсон билээ?” гэхэд мэлэжүүд : “Аллах хүссэнээ ингэж л бүтээдэг. Ямар нэгэн хэргийг бүтээхэд хүсвэл “болтугай” хэмээн тушаана. Тэгээд тэр дороо ёсоор болдог” хэмээн хариулав.
  48. Аллах Исад бичиг үсгийг, мэргэн ухааныг, Таурат болон Инжилийг зааж сургасан.
  49. Аллах Түүнийг Израйлын үр садад гэгээн элч болгон илгээсэн үед Иса (Есүс) тэдэнд хандан ийнхүү хэлэв: “Би та нарт Эзэнтнээс чинь ер бусын гайхамшиг авч ирлээ. Шавраар шувууны дүрс бүтээж, түүнийг

- үлээхүйд тэр Аллахын тушаалаар шувуу болно. Би Аллахын тушаалаар төрөлхийн сохорыг, уман өвчнийг анагаана, үхэгсэдийг амилуулна. Мөн та нарт гэр орондоо идэх, хадгалах хүнсний талаар мэдээ өгнө. Хэрэв итгэвэл эдгээрт та нарын хувьд тодорхой нотолгоо бий.
50. Би та нарт надаас өмнө илгээгдсэн Тауратыг (Тораг) бататгагч, та нарт бузар хэмээгдсэн зарим зүйлсийг ариусгагч байхын төлөө ирлээ. Та нарт Эзэнтнээс ер бусын ухаан (нотолгоо) авч ирсэн. Тиймээс Аллагаас айтгун! Надад захирагдагтун.
51. Үнэндээ Аллах миний ч, та нарын ч эзэн, түүнд залбиран мөргөцгөөгтүн. Энэ бол зөв шулуун зам.”
52. Гэгээн Иса (Есүс), тэдний эсэргүүцлийг, өөрийг нь хөнөөх зорилгыг нь мэдэрмэгц: “Аллахын төлөө надад хэн туслах вэ?” гэхэд Хауаричууд (Аллахад итгэн сүсэглэгчид) : “Бид Аллахын төлөө туслана. Бид Аллахад итгэсэн. Чи гэрчлэгтүн, бид үнэнхүү мусулманчууд.”- гэв.
53. (Хауаричууд): “Аяа, Эзэнтэн минь! Бид Чиний илгээсэн сударт итгэсэн, гэгээн элчийг хүлээн зөвшөөрсөн. Биднийг гэрчлэгсэдийн (чин үнэнд итгэгсэд) эгнээнд бичигтүн” гэцгээсэн.
54. (Еврейчүүд) Иса-г мэхэлсэн. Аллах ч тэдний эсрэг арга олов. (Израйлчууд Исаг алахаар завдахад Аллах аргыг нь олж Исаг тэнгэрт аваад гарчихав). Аллах арга ологсодын хамгийн гаргуун нь билээ.
55. Аллах энэхүү мөчид : “Аяа, Иса! Цаг нь болоход чиний амийг авна. Өөр рүүгээ өргөөд авчирна. Чамайг алах муу санаатнуудаас хамгаална. Чамайг дагасадыг хойд ертөнц хүртэл үл сүсэглэгсдээс дээгүүр зална. Дараа нь та нар Над руу буцах болно. Та нарын Исагийн тухай маргасан асуудлыг Би шүүх болно” гэв.
56. Эсэргүүцэгчдийг энэ дэлхий болон хойд насанд нь хатуу цээрлүүлнэ. Тэдэнд ямар ч туслагч олдохгүй.
57. Аллах наминчлан сүсэглэж, сайн үйлс бүтээгсдэд буян хишгээ бүрэн хайрлана. Аллах зальхай үйл үйлдэгсэдийг үл таашаана.
58. (Аяа, Мухаммед) Энэ бол чамд уншиж өгөх Бидний айлдварууд, ухаалаг зарлигууд (Куран судар) мөн.
59. Үнэндээ Аллахын дэргэд Исагийн (Есүс) сургамж (бүтээгдэх байдал) нь Адамынхтай адилхан билээ. Аллах Адамыг шавраар бүтээж, дараа нь “Болтугай” хэмээсэнд тэр ёсоор болсон.
60. Энэ бол Эзэнтнээс илэрхий болгосон үйл явдал. (Мухаммед) Үүнд бүү эргэлз.
61. Чамд Исагийн тухай мэдээ ирсэний дараа хэн нэгэн чамтай маргалдах аваас тэдэнд: “Хүрээд ирэгтүн, бид хөвгүүд, эхнэрүүд болон өөрсдийгөө нэг дор цуглуулан бүгдээрээ Аллахт залбирч, “Аллахын хилэгнэл худал яарихсадыг дайраг!” хэмээн хараал тавьцгаая” гэж хэл.



62. Исагийн тухай энэхүү үг үнэн билээ. Аллахаас өөр ямар ч бурхан үгүй. Аллах эргэлзээгүй ялалтын эзэн бөгөөд аугаа ухааны эзэн билээ.
63. Хэрэв тэд Аллахаас нүүр буруулвал танхайран даврагчид болох нь тэр. Аллах танхайран даврагчдыг бүрэн мэдэж байдаг.
64. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Аяа, ариун судрын эзэд ээ! (Иудэй болон Христчүүд) Бид бүгд хамтран дараах нэгдмэл нэг ойлголттой болцгооё. Гагцхүү Аллахад наминчлан мөргөцгөөе. Түүнийг юутай ч үл эн зэрэгцүүлэе. Аллахаас өөр бие биеэ бурханчилан дээдлэхгүй байцгаая” хэмээн хэлэгтүн. Хэрэв тэд үүнээс таггалзвал: “Бидний үнэн сүсэгт мусулман болохыг та нар гэрчлэгтүн” хэмээн хэл.
65. Аяа, ариун судрын эзэд ээ! Та нар Ибрахимыг (манай шашины гэж) юунд маргадаг юм вэ? Үнэндээ Таурат болон Инжил түүнээс хойш илгээгдсэн шүү дээ. Үүнийг ухаарахгүй байна гэж үү?
66. Ер нь та нар (Иудэй болон Христчүүд) мэддэг зүйлийнхээ талаар (Исагийн талаар) маргацгаасан. Харин өөрсдөө мэддэггүй зүйлийнхээ талаар (Ибрахимын тухай) юунд маргалдах юм вэ? Аллах (Ибрахимын тухай) бүхнийг мэддэг, харин та нар мэдэхгүй.
67. Ибрахим Еврей ч, Християн ч байгаагүй, тэр жинхэндээ мусулман. Олон бурхан шүтэгч буруу номтон ч биш ээ.
68. Үнэн хэрэг дээр Ибрахимын хамгийн ойр дотны хүмүүс, түүнийг дагагсад бол гэгээн элч (Мухаммед) бөгөөд түүнийг дагасан зон олон үнэн сүсэглэгсэд юм. Аллах төгс сүсэглэгсэдийн анд.
69. Ариун судрын эзэдээс хэсэг бүлэг нь та нарыг төөрүүлэхийг хүсдэг. Ингэснээр тэд зөвхөн өөрсдийгөө төөрүүлдэг. Гэхдээ тэд үүнийг анзаардаггүй юм.
70. Аяа, ариун сударын эзэд ээ! Аллахын айлдваруудыг, үнэн мөнийг мэдэх мөртлөө яагаад түүнийг хүлээн зөвшөөрдөггүй юм вэ?
71. Аяа, ариун судрын эзэд ээ! Мэдсээр байж яагаад хар, цагааныг хутган, үнэн, худал хоёрыг хольж, үнэнийг (Таурат судар дахь Мухаммедын мөн чанарыг) нуудаг вэ?
72. Ариун судрын эзэдийн нэг хэсэг нь: “Сүсэглэгсэд илгээсэн Куранд өдрийн эхэнд итгэж, орой эсэргүүцээрэй. Ингэвэл тэд (Ислам шашинаас) сүсэг бишрлээсээ таггалзаж юу магад” хэмээн ярилцдаг.
73. Бас тэд: “Өөрсдийнхөө шашинаас бусдад бүү итгэгтүн” гэнэ. (Мухаммед!) Чи тэдэнд : “Чин үнэн зам бол гагцхүү Аллахынх” гэж хэл. Бас тэд бие биеэндээ: “Та нарт илгээгдсэн амлалт бусдад ч адилхан өгөгдөхөд, эсвэл Эзэнтний чинь өмнө та нарын эсрэг нотолгоо авч ирэхэд нь бүү итгэгтүн” гэлцэнэ.(Тэд өөрсдийн шашны бус хүнийг гэгээн элч болохыг эс хүлээн зөвшөөрдөг). (Мухаммед) Чи тэдэнд : “Үлэмж их ивээл зөвхөн Аллахын эрхшээлд, Тэр түүнийг Өрийн

- хүссэн хүндээ л өгдөг. Аллахын хайр энэрэл уужим, Тэр бүхнийг мэдэгч” хэмээн хэл.
74. Аллах өөрийн энэрэлээ хүссэндээ хайрладаг, өгөөмөр энэрэлийн Эзэн.
75. (Мухаммед) Ариун судрын эздийн заримд нь хамаагүй их зүйл даатган өгсөн ч (найдвартай) буцааж өгдөг. Гэтэл заримд нь ганц динар итгэмжлэн өгсөн ч дэргэд нь харж зогсохгүй бол буцааж өгдөггүй. Учир нь тэд : “Бичиг үсэггүйчүүдэд халдвал (Манай шашныг шүтдэггүй хүмүүсийн мал хөрөнгөд нь халдвал) бидэнд хариуцлага оногдохгүй” гэнэ. Ийнхүү тэд мэдсээр байж Аллахыг хуурахыг оролдоно.
76. Тийм биш ээ! Хэн ч гэсэн амлалтаа үнэнчээр биелүүлж, Аллахын цээрлэлээс айвал Аллах ухаантнуудыг хайрладаг.
77. Аллахад өгсөн амлалт, тангарагаа өчүүхэн үнээр наймаалагсадад хойд насны хувь хишиг оногдохгүй. Аллах тэдэнтэй ярихгүй, тэднийг тоож анзаарах ч үгүй, нүгэлээс ч чөлөөлөхгүй. Тэдний төлөө хатуу цээрлэл байдаг.
78. Тэдний (Иудэй нарын) нэг хэсэг нь сударт байхгүй зүйлсийг байгаа мэтээр ойлгуулахын тулд хэл амаа билүүдэн: “Үүнийг Аллах илгээсэн” гэнэ. Үнэндээ түүнийг Аллах илгээсэн биш. Тэд мэдсээр байж Аллахын эсрэг зориуд худал ярьдаг.
79. Аллах хэн нэгэнд судар илгээж, мэргэн ухаан хайрлаж, гэгээн элч болговол дараа нь хүмүүст : “Аллахаас дайжиж миний боол болцгоогтун” гэж хэлэх нь зохимжгүй. Харин : “Илгээсэн судрыг бусдад зааж сургасан, өөрсдөө уншсаны төлөө Аллахын үнэнч боол (шашны мэдлэгтэй эрдэм номтон) болцгоорой” гэх нь зүй зохистой байх биз.
80. Аллах та нарт : Мэлэк (тэнгэрийн элч) болон гэгээн элчүүдийг бурханчилан шүтэхийг тушаахгүй. Та нарыг мусульман болсоныхоо дараа гэгээн элчүүд чинь буруу номтон болохыг тушаах гэж үү?
81. Нэгэнтээ Аллах гэгээн элчүүдэд амлалт авхуулж : “Би та нарт Ариун судар, мэргэн ухааныг хайрласан. Хожим та нар илгээсэн судар болон мэдлэгийг бататгах нэгэн гэгээн элч ирвэл та нар түүнд заавал итгэж, туслах хэрэгтэй. “Та нар миний айлдахыг хүлээн зөвшөөрсөн үү? Энэхүү хүнд айлдлалыг минь хүлээн авч байна уу?” хэмээхэд тэд: “хүлээн зөвшөөрлөө” гэж хариулцгаасан. Аллах : “Тийм бол гэрчлэгтүн. Би ч та нарын хамт гэрчлэгсэдийн нэг нь байх болно” гэв.
82. Үүний дараа хэн амлалтаасаа буцвал нүгэлтэн болно.
83. Тэд (Иудэй болон Христчүүд), Аллахын шашинаас өөр шашныг хүсдэг үү? Хүссэн, хүсээгүй тэнгэр болон газар дахь бүхий л зүйлс Аллахын эрхшээлд байна. Тэд Үнэндээ нөгөө ертөнцөд Аллахын мэдэлд шилжинэ шүү хэл.
84. Аяа Мухаммед! тэдэнд : “Бид бол Аллахад, бидэнд илгээгдсэнд

- (Куранд), Ибрахим, Исмайл, Исхак, Яакубт болон Яакубын хөвгүүдэд илгээгдсэнүүдэд, мөн Муса, Иса болон бусад гэгээн элчүүдэд Эзэнтгээс илгээсэн сударуудад итгэсэн. Бид тэднийг алагчлан ялгаварлахгүй. Бид гагцхүү Аллахыг хүлээн зөвшөөрөгсөд” хэмээн хэлэгтүн.
85. Хэн нэгэн Исламаас өөр шашиныг хүсвэл хүсэлт нь хүлээн авагдахгүй. Тэр хойд насандаа хохирогчдийн нэг нь болно.
  86. Аллахад наминчлан залбирч, гэгээн элчийн чин үнэнд гэрч болж, өөрсдөд нь ил тод нотолгоонууд ирсэний дараа үүнийг үгүйсгэсэн хүмүүсийг Аллах яаж шулуун замд оруулах билээ? Аллах зальхай этгээдүүдийг зөв, шулуун замд оруулдаггүй.
  87. Тэднийг гэгсгээх цээрлэл гэвэл Аллахын, мэлэкуүдийн, бүхий л хүн төрлөхтөний хараалд өртөх явдал билээ.
  88. Тэд үүрд тамд үлдэцгээнэ. Тэдний цээрлэл нь хөнгөвчлөгдөхгүй, уучлагдахгүй.
  89. Харин хожим гэмшиж наминчлан, засрагсадын хувьд өөр хэрэг. Аллах үнэнхүү нэн өршөөгч, машид нигүүлсэгч.
  90. Итгэн сүсэглэснийхээ дараа дахин буруу юм хийж, хүчтэй эсэргүүцэгчдийн гэмшил хэзээ ч өршөөгдөхгүй. Тэд төөрөлдөгсөд.
  91. Буруу номтон болж тэр чигээрээ үхэгсэд дэлхийг дүүргэх алт өгсөн ч тэдний хүсэлт хүлээн авагдахгүй. Тэд хатуу цээрлэл үзнэ. Тэдэнд ямар ч туслагч үгүй.
  92. Хайрласан зүйлсээ Аллахын төлөө өглөг болгож зарцуулахгүйгээр хэзээ ч буян хураахгүй. Та нар өглөгөд юу зарцуулсан ч Аллах түүнийг эргэлзээгүй мэднэ.
  93. Тауратыг илгээхээс өмнө Израйлын (Яакубын) зөвхөн өөрт нь харам (бузар) хэмээн хориглосон идээнүүдээс бусад нь бүгд Израйлын үр садад халал (ариун) хэмээн зөвшөөрөгдсөн билээ. Аяа, Мухаммед тэдэнд : “Хэрэв та нар үгэндээ үнэнч болвоос Тауратыг авчирч уншигтун” хэмээн хэл.
  94. Үүнээс хойш нотолгоонууд илэрхий болсоны дараа хэн нэгэн худал хэлж, Аллахыг гүтгэвэл тэд жинхэнэ зальхай этгээдүүд мөн.
  95. Тэдэнд : “Аллахын айлдал эргэлзээгүй чин үнэн (Ислам хэмээн нэрлэгдсэн) Ибрахимын шашиныг мөрдлөгө болгогтун. Тэр буруу номтон (олон бурхан шүтэгчдийн нэг нь) биш ээ” хэмээн хэл.
  96. Хүмүүсийн төлөө (мөргөл, сүсэглэлд зориулан) анх баригдсан ордон бол Мекке дэхь Кагба мөн. Тэр эв найртай, бүх дэлхийд шулуун замаар хөтлөгч юм.
  97. Тэнд ил тод нотолгоонууд, Ибрахимын орон байр бий. Хэн нэгэн түүнд орсоноор айх аюулгүй, амгалан байна. Боллоцотой хүмүүс Аллахын

төлөө Кагба-д хаж ёсны мөргөл үйлдэх нь ариун үүрэг мөн. Харин хэн нэгэн эсэргүүцвэл Аллах хэнээс ч хараат бус.

98. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Ариун судрын эзэд ээ! Аллах та нарын хийсэн үйлдэл бүрийг харж байхад юунд Аллахын айлдваруудыг үгүйсгэж байна вэ?” хэмээн хэл.
99. (Аяа, Мухаммед!) Тэдэнд : “Ариун судрын эзэд ээ! Та нар чин үнэнийг харсаар байтал үнэн сүсэглэгчсэдийг Аллахын чин шударга замаас хазайлгаж, буруу замыг заадаг нь ямар учиртай вэ? Аллах та нарын үйлдэл бүрийг мэдэж байгаа” хэмээн хэлэгтүн.
100. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Ариун судар илгээгдэгсэдийн дотроос алив нэгэн бүлэг хүмүүсийг хүлээн зөвшөөрвөл, тэд та нарыг сүсэгтэн болсны дараа дахин буруу номтон болгох болно.
101. Та нарт Аллахын айлдварууд уншигдаж байхад, Аллахын гэгээн элч та нарын дунд байсаар атал яаж буруу номтон болох юм вэ? Хэн Аллахад (Түүний куран сударт) итгэвэл тэр зөв, шулуун зам руу орно.
102. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахад чин үнэнээр сүсэглэн, энэ ертөнцөөс муслман хэвээрээ халигтун.
103. Аллахын татлагаас (Куран, шашин) бүгдээрээ чанга атгацгаагтун. Бутарч бүү салцгаагтун. Аллахын заяасан хувь хишгийг санагтун. Та нар нэгэнтээ бие биедээ дайсан байхад Аллах та нарын зүрх сэтгэлийг холбосны дараа Түүний ивээлээр (шашин нэгт) ахан дүүс болцгоосон. Та нар тамын ангальн ирмэг дээр байхад Аллах аварсан. Аллах та нарыг зөв зам руу оруулахын тулд айлдваруудаа тайлбарлаж өгдөг.
104. Та нарын дотор хүмүүсийг сайн сайхан руу уриалан, чин шударгыг зааж, муу муухайг хязгаарладаг нэг хэсэг хүмүүс байг. Тэд аз жаргалд умбагсад.
105. Аллахаас илэрхий нотолгоонууд ирсэний дараа хэрүүл-уруул болж, харсан зүг руу бутран сарнигсад (Иудэй болон христчүүд) шиг бүү бологтун. Тэд хойд ертөнцөд асар хүнд зовлонд учрах болно.
106. Нөгөө ертөнцөд заримын царай нь цайж, заримын нүүр царай пад хар болно. Тэр мөчид мэлэжүүд пад хар царайгнуудад хандан: “Та нар наминчлан сүсэглэснийхээ дараа урван тэрсэлсэн юм уу? Тэгвээс урван тэрсэлснийхээ хариуг амсах болно” гэнэ.
107. Харин гэгээлэг царайгнууд Аллахын хайр ивээл дор диваажинд байх бөгөөд тэнд мөнх үлдэцгээнэ.
108. Энэ бүхэн Аллахын айлдварууд. (Аяа, Мухаммед) Түүнийг чамд чин шудрагаар уншиж өгнө. Аллах ертөнцөд харгислалыг хүсдэггүй.
109. Тэнгэр болон газарт байгаа бүх юмс Аллахад харъяалагддаг. Үйлс бүхэн Аллахад эргэж очдог.
110. Аяа, Мухаммедийн зон олон! Та нар хүмүүсийн сайн сайхны төлөө

илэрхий ялгарсан, хүмүүсийг сайн сайханд хөтлөн, муу муухайгаас сэрэмжлүүлэн зогсоодог Аллахад төгс сүсэглэсэн энэрэлтэй түмэн билээ. Хэрэв ариун судрын эзэд сүсэглэсэн бол мэдээж тэдний хувьд дээр байх байсан. Тэдний дунд сүсэглэгсэд ч бий, гэхдээ олонхи нь муу санаат нүгэлтэнгүүд.

111. Тэд нэг хэсэг төвөг учруулахаас бусад чамд сүрхий хор уршиг тарьж чадахгүй. Хэрэв та нартай дайтахад хүрвэл ар нуруугаа харуулан ухарч зугатацгаана. Тэдэнд тусламж үл олддог.
112. Хаана ч гэсэн тэдний Аллах болон мусулманчуудын дэмжлэг авч чадаагүй нь зовж зүдэрч, бут цохигдох болно. Тэгээд Аллахын уур хилэнд өртөж, үгүйрэл хоосрол үзнэ. Энэ нь тэдний Аллахын айлдваруудыг үгүйсгэн эсэргүүцэж, гэгээн элчүүдийг хэлмэгдүүлэн хөнөөснөөс болов. Тэрчлэн Аллахын айлдваруудыг эсэргүүцэж, хэрээс хэтэрсэнээс болсон.
113. Тэд бүгд адилхан биш. Ариун судрын эзэдээс шөнийн цагаар босч, Аллахын айлдваруудыг уншиж, мөргөл үйлддэг хэсэг хүмүүс бий.
114. Тэд Аллахад, хойд ертөнцөд итгэцгээдэг, сайн сайхан руу тэмүүлэн, мууг тэвчиж, сайн үйлсийн төлөө яардаг. Эд бол буянтай сайн хүмүүс.
115. Тэд ямар ч сайн үйл үйлдсэн бай хөдөлмөр нь талаар өнгөрдөггүй. Аллах үнэн сүсэглэгсэдийг мэднэ.
116. Итгэл бишрэлгүй хүмүүсийн мал хөрөнгө ч, үр удам ч Аллахын цээрлэлээс аврагдахгүй. Тэд тамынхан. Тэндээ үүрд үлдэнэ.
117. Тэдний дурамжхан өгсөн өглөг нь зальхай олны тариаланг сүйтгэсэн хүйтэн шуургатай адил. Аллах тэдэнд шударга бус хандаагүй, харин тэд харгислал үйлдэн өөрсдийнхөө толгойд гай тарьсан.
118. Аяа сүсэгтнүүд минь ээ! Шашин нэгтнүүдээс бусдад бүү дотночилогтун. Тэд, та нарт хор хөнөөл учруулахаас ч буцахгүй, гай зовлонд унагахыг хүсдэг. Тэдний дайсагнал үгний сэжүүрээс нь анзаарагддаг. Харин дотроо нууж буй нь бүүр ч муухай. Ойлгож ухаарвал та нарт айлдваруудыг олонтой тайлбарласан билээ.
119. Та нар тэднийг анд нөхөр гэж үзсэн ч тэд та нарыг дотны нөхөр гэж үзэхгүй. Та нар ариун судар бүхэнд итгэдэг бол тэд та нарт итгэдэггүй. Уулзах бүрдээ: "бид ч сүсэглэгсэд" гэгцгээдэг. Буйдхан үлдэх цагт та нарт хорсохдоо хуруугаа хэмлэцгээдэг. Аяа, Мухаммед тэдэнд : "Хорсолдоо шагаж үхэцгээгтүн" гэж хэл. Аллах үнэндээ зүрх сэтгэлд буй бүхнийг мэднэ.
120. Хэрэв та нарт нэг сайн зүйл тохиовол тэд гутрана. Харин та нарт (хүндрэл бэрхшээл, өлсгөлөн, ялагдал мэт) гай барцад тохиолдвол баярлацгаадаг. Хэрэв, та нар тэвчээртэй байж, Аллахаас айх аваас тэдний заль мэх та нарт огтхон ч хор хүргэж чадахгүй. Аллах тэдний хийсэн бүхнийг мэднэ.

121. (Аяа, Мухаммед) Чи гэрээсээ эртлэн гарч сүсэглэгсэдийг дайны (Ухуд) тэргүүн шугманд байршуулсан билээ. Аллах үгийг чинь сонсож, байдлыг чинь мэдэж байсан.
122. Тэр үед та нарын хоёр бүлэг (Салама болон Хариса нарын бүлэг) зүрхшээн дайны талбараас ухрахаар шийдсэн. Аллах тэдний туслагч нь байсан. Ариун сүсэгтнүүд ямагт Аллахад итгэцгээгтүн.
123. Аллах үнэндээ Бадир-т байлдах үеэр та нарт тусалсан билээ. Харин та нар хүчин мөхөс байсан. (цэргийн тоо болон зэвсэг хүч чадал муу) Аллахад талархан залбирвал Түүнээс эмээгтүн.
124. (Аяа, Мухаммед) Тэр үед чи, сүсэглэгсэд хандан : “Эзэнтэн та нарт гурван мянган мэлэкүүдийг илгээн тусалбал хангалтгүй гэж үү?” гэсэн билээ.
125. Мэдээж хангалттай байх байсан. Хэрэв та нар байлдахад тэвчээртэй байж, Аллагаас айх аваас дайснууд халдан дайрахад Аллах зориулалт бүхий таван мянган мэлэкүүдээр та нарт тусална.
126. Аллах та нарыг баярлуулахын төлөө, та нарыг тайван байлгахын тулд хийсэн юмаа. Тусламж бүхнээс хүчтэй мэргэн ухааны эзэн Аллагаас ирнэ.
127. Энэхүү тусламж буруу номтнуудын нэг хэсгийг устгахын тулд, тэдний итгэл найдвар, эмх замбрааг алдуулж, горьдлогыг нь таслан буцаахын тулд өгөгдсөн юм.
128. (Аяа, Мухаммед) Ямар ч үйл хэрэгт чи хүчин мөхөсдөж болно. Аллах тэднийг уучилна, эсвэл (бодолоо өөрчлөхгүй бол) гэсгээн цээрлүүлнэ. Учир нь тэд зальхай этгээд.
129. Тэнгэр болон газарт байгаа бүхэн зөвхөн Аллахынх. Аллах хүссэн хүнээ өршөөдөг, хүссэн хүнээ гэсгээдэг. Аллах машид нигүүлсэгч, нэн өршөөгч билээ.
130. Аяа сүсэгтнүүд минь ээ! (Арилжаа наймаа хийхдээ) илүү ашиг хонжоог бодож бүү хүүлэн идэгтүн. Сансандаа хүрч жаргая гэвээс Аллагаас айгтун!
131. Бас үл сүсэглэгсэдийн төлөө бэлтгэгдсэн тамын галаас болгоомжлогтун!
132. Хайр энэрэлийг нь хүртэхийн тулд Аллахт, гэгээн элч нарт итгэн бишрэгтүн!
133. Аллагаас өршөөн нигүүлэгсэдэд, сүсэгтнүүдэд зориулсан тэнгэр, газар мэт энгүй уудам диваажин руу яарцгаагтун.
134. Үнэн сүсэгтнүүд элбэг дэлбэг, ядуу зүдүү аль ч үед Аллахын төлөө мал хөрөнгөө зарцуулдаг, өш хонзон авах чадалтай атал уур хилэнгээ барьж чаддаг, хар санаатнуудыг өршөөж чаддаг. Аллах ийнхүү буян үйлдэгсэдийг хайрладаг.
135. Үнэн сүсэгтнүүд нүгэлтэй муу үйл үйлдсэн дариудаа эсвэл өөрөө

- өөртөө уршиг тарьвал тэр дариудаа Аллахыг санаж, нүгэлээ наминчлан өршөөл гуйдаг. Нүгэлийг Аллагаас өөр хэн өршөөж чадах билээ! Ариун сүсэгтнүүд муу үйлүүдээ мэдвэл дахин зүтгэхгүй.
136. Ийнхүү ухамсар үйлдлийн хариу шагнал нь Аллахын өршөөл бөгөөд хаяанаас нь булаг урссан диваажин мөн билээ. Тэд диважинд үүрд оршино. Ийм сайн үйлс бүтээгсэдийн шагнал юутай сайхан гэж!
137. Та нараас өмнө ч олон үйл явдал болоод өнгөрсөн. Тиймээс дэлхийг хэрэн хэсэгтүн. Шударга үнэнийг (Аллахын айлдваруудыг) худал хуурмагтай адилхдаг хүмүүсийн хувь заяа ямар болсныг өөрсдийн нүдээр үзэгтүн!
138. Куран бол хүн төрлөхтөнд зориулсан чин үнэн тайлбар, үнэн сүсэгтнүүдийн хувьд зөв шударга зам, мөн ухуулга сургамж билээ.
139. (Аяа, мусулманчуудаа!) Байлдахад сул дорой байдал бүү үзүүлэгтүн, уйтгар гунигт бүү автагтун. Төгс сүсэглэгсэд дээгүүр өргөмжлөгдөх болно.
140. Хэрэв дайнд (Ухуудад) шархтвал дайсан ч мөн адил (Бадир) дайнд шархтсан билээ. Бид ийм явдлыг хүмүүсийн амьдралд ээлжлэн тохиолдуулна. Заримдаа ялж заримдаа ялагдах явдал бий. Аллах сүсэгтэн олныг (хоёр нүүртэнгүүдээс) ялгаж танихын тулд, бас Аллахын төлөө амь үл хайрлахын тулд ингэдэг. Аллах харгислагсадыг хайрладаггүй.
141. Бас үнэн сүсэгтнүүдийг нүглээс нь ариугтахын тулд, буруу номтнуудыг ялан дийлж устгахын тулд хүнд бэрх өдрүүдээр угтуулдаг.
142. Аяа сүсэгтнүүд мин ээ! Аллах та нарын чин шударгаар байлдсан эсэхийг тэвчээртэй байсныг тодорхой таньж мэдэхгүйгээр та нар аман дээр наминчалсан гэж диваажинд залрахыг бодож байна уу?
143. Та нар үхэлтэй нүүр тулгарахаасаа өмнө түүнийг хүсдэг байсан. Одоо ийнхүү түүнтэй жинхэнэ биеэр тулгарах болоод байна шүү дээ. Та нар хараад л байна.
144. Мухаммед гагцхүү нэг л гэгээн элч. Түүнээс өмнө ч олон гэгээн элч нар байсан. (Тэдний зарим нь жам ёсоор, зарим нь хүний гараар нас барсан) Хэрэв тэр жам ёсоор үхвэл, эсвэл хүнд алагдвал та нар ухрах хэрэг үү? Сүсэглэхээ болих уу? Хэн нэгэн ухрах аваас Аллахад хохирох явдал үгүй, өөрсдөө хохироцгооно. Аллах талархагсадыг шагнадаг.
145. (Үхэл бол) Маш тодорхой цаг хугацаанд тохиолдох тавилан тул хэн ч Аллахын зөвшөөрөлгүйгээр үхэхгүй. Хэн нэгэн амьд ахуйн буяныг хүсэх аваас өөрт нь түүнийг ч заяана. Хэн хойд насны буяныг хүсвэл түүнд ч заяана. Бид талархагсадыг шагнана.
146. Олон гэгээн элчүүд, олон сүсэгтэн ухаантнууд (Аллахын замд нэгдэн) байлдсан. Тэд Аллахын замд тулгарсан саад бэрхшээлүүдэд шантарч,

- сул дорой байдлаа үзүүлээгүй, бууж өгөөгүй. Аллах гэвчээртэнгүүдийг хайрладаг.
147. Тэд гагцхүү: “Аяа Эзэнтэн минь! Бидний нүгэлийг, алдаа эндэгдлийг маань өршөөгтүн. Биднийг дайнд тууштай болгогтун, дайсануудтай тэмцэхэд хүч чадал хайрлагтун” гэхээс өөр зүйл хүсдэггүй.
  148. Тиймээс, Аллах тэдэнд энэ дэлхий ба хойд ертөнцийн сайн сайхныг зориулав. Аллах буян үйлдэгсэдийг дэмжинэ.
  149. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Хэрэв буруу номтнуудад захирагдвал тэд та нарыг шашинаас урвуулан ухрааж, хор хохирол амсагсадын эгнээнд орох болно.
  150. Тэгж болохгүй. Мэдээж та нарын эзэн нь Аллах билээ. Тэр хамгийн сайн туслагч билээ.
  151. Аллахын тухай ямар ч баталгаа илгээгдээгүй зүйлсийг Түүнтэй эн зэрэгцүүлсэний төлөө буруу номтнуудын зүрх сэтгэлд айдаг төрүүлнэ. Тэдний очих газар бол там. Зальхай этгээдүүдийн очих газар юутай муухай гээч!
  152. Аллахын соёрголоор та нар дайснаа ялсан. Аллах та нарт өгсөн амлалтаа биелүүлсэн. Гэвч та нар олз омог харсаны дараа сул дорой байдал гарган, гэгээн элчийн тушаалын тухайд маргалдаж түүнийг эсэргүүцсэн. Та нарын зарим нь өнөөдрийн олз ашгийг, зарим нь хойд насны буяныг бодсон. Тэгээд Аллах та нарыг сорихын тулд ухраасан, бас өршөөсөн. Аллах үнэхээр сүсэгтнүүдийнхээ төлөө сайн сайхан бүхнийг гүйцэлдүүлэгч билээ.
  153. Тэр үед гэгээн элч дуудсан ч та нар эргэж харалгүйгээр холдож зугтацгаасан билээ. Тиймээс Аллах та нарын алдсан зүйлийнхээ төлөө хорсохгүйн тулд та нарт гуниг гутрал хайрласан. (дайны ялагдлаар гэсгээсэн юм). Аллах та нарын хийсэн үйлдэл бүрийг мэдэгч билээ.
  154. Тэрхүү зовлонгоос хойш Аллах та нарт амирлангуй нойрыг илгээн, заримыг чинь үүрэглүүлээд орхисон. Зарим нь хар толгойны харуусалд автсан. Тэд балар эртний хүмүүс мэт Аллахын тухай янз бүрийн таамаг бодолд дарагдав. “Бидэнд ялах найдлага бий үү?” гэцгээсэн. (Аяа, Мухаммед) тэдэнд : “Бүх үйл Аллахын эрхэнд” хэмээн хэл. Тэд дотороо нуусан муу санаагаа чамд илчлэхгүй. Тэд : “Бидэнд ялалтын найдлага байсан бол бид энд үхэхгүй байсан” гэлцэнэ. (Аяа, Мухаммед) тэдэнд : “Хэрэв та нар гэр орондоо байлаа ч үхэх тавилантай хүмүүс гарцаагүй үхэх газартаа очигцооно” гэж хэл. Аллах та нарын нууцыг шалгахын тулд, сэтгэлийг чинь ариусгахын тулд ийнхүү хийдэг. Та нарын сэтгэл дотор юу нуугдаж байгааг Аллах тодорхой мэднэ.
  155. (Ухуд дайнд) хоёр талын цэрэг нүүр тулахад тэдний зарим нь урвалаа, (гэгээн элчийн эсрэг байсан учраас) чөтгөр шулам тэднийг урвуулав.



- Аллах тэднийг уучилсан. Аллах эргэлзээгүй нэн өршөөгч, машид уужим.
156. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Үл сүсэглэгсэд шиг бүү байгтун. Тэд, аян замдаа яваа эсвэл дайнд мордсон ахан дүүсийнхээ тухай : “Хэрэв тэд бидэнтэй хамт байсан бол үхэх ч үгүй, алуулах ч үгүй байх байсан” гэж хэлцгээдэг. Учир нь Аллах үүнийг тэдний зүрхэнд үй гашуу болгосон. Аллах амилуулна, бас үхүүлнэ. Аллах та нарын хийсэн үйлдэл бүхнийг тод харагч билээ.
157. Хэрэв та нар Аллахын үйл хэргийн төлөө үхвэл, өөрөөр хэлбэл алагдвал, та нарт зориулсан Аллахын өршөөл, энэрэл тэдний насан туршдаа хураасан эд хөрөнгөнөөс үнэтэй.
158. Хэрэв та нар байгалийн жамаар үхсэн ч, дайнд алагдсан ч (ялгаагүй) Аллахын өмнө очигцооно.
159. (Аяа, Мухаммед) Чи зөвхөн Аллахын нигүүлслээр тэдэнд эелдэг зөөлөн хандсан. Хэрвээ бүдүүлэг, хатуу сэтгэлтэй байсан бол ямар ч эргэлзээгүй тэд чиний эргэн тойрноос зугаган одох байсан! Тийм учраас өршөөлтэй байж, тэднийхээ төлөө Аллахын өршөөлийг хүс, тэдэнтэй зөвлөлдөж бай! Зөвлөлдсөний дараа ямар нэгэн зүйл хийхээр шийдвэл Аллахад найд. Аллах эргэлзээгүй өөртөө найдвар тавигсадыг хайрладаг.
160. Аллах та нарыг ивээн тэтгэвэл та нартай хэн ч эн зэрэгцэхгүй. Харин Аллах ивээн туслахгүй бол та нарт өөр хэн туслах юм бэ? Үнэн сүсэглэгсэд гагцхүү Аллахад найдагтун!
161. Аль ч гэгээн элч нар итгэл найдлагад урван тэрслэхгүй. (дайны олзыг ёс бусаар завшихгүй). Хэрэв хэн нэгэн урван тэрслэж мэхлэх аваас шүүгдэх өдөр мэхэлсэн зүйлтэйгээ хамт ирнэ. Ийнхүү шударга бусад өртөлгүйгээр хүн бүр хийсэн хэрээр хариуг бүрэн хүртдэг.
162. Аллахын тааллыг хүлээсэн хүн Түүний цээрлэлийг хүлээсэн хүнтэй адил гэж үү? Аллахын гэсгээл үзсэн хүний очих газар нь там. Там бол ямар муухай орон гээч!
163. Аллахын өмнө хүмүүсийн зэрэг зиндаа нь янз бүр байдаг. Аллах тэдний хийсэн бүхнийг харж байна.
164. Аллах үнэндээ өөрийн айлдваруудыг уншиж өгдөг, нүглийг нь ариусгадаг, (зон олондоо) судрыг, мэргэн ухааныг сургадаг, гэгээн элчүүдийг илгээж, сүсэгтнүүдэд хэмжээллэггүй их энэрэл тус хүргэсэн. Учир нь тэд урьд өмнө илэрхий төөрөгдөлд автсан юм.
165. Та нарт тохиолдсон золгүй явдал та нарын дайсандаа учруулсан золгүй явдлын хагастай эн тэнцүү байсан юм. Та нар: “Энэ золгүй явдал яагаад тохиов оо?” гэж хэлцгээсэн. Мухаммед чи тэдэнд : “Энэ нь та нарын өөрсдөөс чинь шалтгаалсан!” Аллахын хүч чадал бүх юманд хүрнэ.
166. Хоёр талын тэрхүү тулааны үеэр та нарт тохиолдсон бүхэн Аллахын

- зарлигаар болсон. Энэ нь үнэн сүсэглэгчдийг таньж мэдэхийн тулд байсан юм.
167. Тэрчлэн хоёр нүүртэнгүүдийг ч ялгаж салгахын тулд байсан” гэж хэл. Тэдэнд: (хоёр нүүртэнгүүдэд) “Ирцгээгтүн, Аллахын төлөө тулалдагтун, эсвэл өөрийгөө хамгаалагтун!” гэхэд тэд : “Бид тулалдахыг мэдсэн байвал та нарыг дагах байсан.”-гэв. Тэд тэр өдөр сүсэглэхээс илүү биеэ тооход (үл сүсэглэлд) ойрхон байсан. Тэд зүрх сэтгэлдээ байгаагүйг хоосон үгээр ярьж байсан. Тэдний дотроо нуусныг Аллах сайн мэднэ.
168. Гэр орондоо сууж байж ахан дүүстээ: “Хэрэв бидний үгэнд орсон бол амиа алдахгүй байх байсан” гэж яригсадад Мухаммед чи : “Хэрэв үнэн ярьж байгаа юм бол үхлийг өөрсдөөсөө холдуулаад үзээч!” гэж хэлэгтүн.
169. Аллахын төлөө амь эрсдэгсэдийг үхсэн гэж бүү бодоцгоогтун! Мэдээж, тэд амьд. Тэд Аллахын дэргэд хувь хишиг хүртэцгээнэ.
170. Тэд Аллахын хайрласан энэрэл хайрд баярлаж, ардаа үлдэгсэдэд: “Өөрт нь ямар ч аюул занал, уй гашуун үгүй” гэдгийг баяртайгаар дуулгахыг хүсдэг.
171. Бас, Аллахаас илгээсэн хувь хишиг, хайр энэрэлд, Аллах төгс сүсэгтнүүдийн сайн үйлсийг хоосон үлдээхгүйд баярлана.
172. Ухудын тулалдаанд шархтсаныхаа дараа Аллахын болон гэгээн элчийн уриалгад нэгдэгсэдээ сайн үйлс бүтээж, ухаалагаар сүсэглэгсэдэд Аллахын асар их ивээл бий.
173. Тэдэнд зарим хүмүүс : “Зарим хүмүүс (Курайшууд) та нарын эсрэг цэрэг зассан. Тэднээс айгтун”-гэв. (энэ үг) Тэдний сүсэглэлийг улам нэмэгдүүлсэн бөгөөд тэд “Аллах бидэнд хангалттай, Тэр юутай сайхан Эзэн билээ” гэгцгээсэн.
174. Тэд Аллахын ивээл хайраар муу юм эс тохиож, буцаж ирцгээсэн. Аллахын тааллыг эрэлхийлэв. Аллах, аугаа их хайр энэрэлийн Эзэн.
175. Чөтгөр шулам өөрийнхөө ойр дотнуудыг айлгадаг. Хэрэв ариун сүсэгтэн байвал түүнээс бүү айгтун, харин Надаас айгтун!
176. (Мухаммед) Үл сүсэглэн уралдагсад чамайг гутралд бүү оруулаг! Тэд Аллахад ямар ч хор учруулж чадахгүй! Аллах тэдэнд, хойд насанд нь ямар ч хувь хишиг хүртээхгүйг хүсдэг. Тэдний хувьд зовлонт гэсгээл бий.
177. Үнэн сүсэглэлээ үл тоомсорлолоор арилжагсад Аллахад ямар ч хор хүргэж чадахгүй бөгөөд тэд хатуу цээрлэл хүлээнэ.
178. Үл сүсэглэгсэд, үнэндээ Бидний тэдэнд зориулсан урт нас, удаан жаргал мэт боломж өгөөжийг хэзээ ч өөрт нь өлзийтэй гэж бүү бодог. Бидний өгсөн боломжууд тэдний нүглийг улам нэмэгдүүлэхийн төлөө болж байгаа юм. Тэд хойд насандаа зовлонт гэсгээлтэй учрана.

179. (Аяа хоёр нүүртгэнгүүд) Аллах төгс сүсэглэгсэдийг энэ байгаагаар нь, сайныг муутай нь ялгалгүйгээр үлдээнэ гэж үгүй. Аллах та нарт далдын нууцыг мэдүүлнэ гэж ч үгүй. Гэхдээ хүсэж таалсан гэгээн элчүүддээ мэдүүлдэг. Тэгэхээр, та нар Аллахад, Түүний гэгээн элчүүдэд итгээрэй! Хэрэв та нар төгс сүсэглэн, Түүнээс айх юм бол, та нарт ч гэсэн их хэмжээний буян хишиг оногдоно.
180. Аллах өөрийн хэмжээлшгүй их хайр энэрэлээр олгосон зүйлсийг харамлагсадыг, харамч занг ашигтай гэж бүү бодог! Эсрэгээрээ энэ нь тэдэнд хор уршигтай. Тэдний харамласан зүйлүүд нь хойд ертөнцөд өөрсдийнх нь хүзүүг багалзуурдах болно. Тэнгэр, газрын өвлөл нь гагцхүү Аллахынх. Ийнхүү Аллах та нарын юу хийснийг зүй ёсоор нь мэдэгч билээ.
181. "Аллах ядуу, харин бид баян" хэмээгсэдийн (Иудэйчүүдийн) яриаг Аллах дамжиггүй сонссон. Бид, тэдний (энэ) ярьсныг, гэгээн элчүүдийг хэлмэгдүүлэн алсныг (үйлийн дэвтэрт) тэмдэглэж аваад тэдэнд: "Тамын догшин гэсгээлийг амсацгаагтун!" гэж хэлэх болно.
182. Энэ бол, та нарын үйлдсэн гэмт хэргийн хариу. Аллах өөрсдийн боолуудад харгислал хийдэггүй.
183. Тэд: (Иудэйчүүд) "Тэнгэрээс ирэх гал нэрвэн устгах нэгэн өргөл ирэх хүртэл, Аллах бидэнд ямар ч гэгээн элчид бүү итгэ хэмээн тушаасан" гэнэ. Аяа, Мухаммед тэдэнд: "Та нарт надаас өмнөх гэгээн элчүүд ил тод нотолгоонууд болон хэлсэн бүхнийг чинь авч ирсэн. Та нар хэлсэн үгэндээ эзэн байх юм бол, яах гэж тэднийг алсан юм бэ?" гэж хэлэгтүн.
184. Аяа, Мухаммед! Хэрэв тэд чамайг үгүйсгэвэл бүү гутар. Чамаас өмнөх ил тод нотолгоонууд болон судар номуудыг авч ирсэн гэгээн элч нарыг ч хүлээн зөвшөөрөөгүй юм.
185. Амьд бүхэн үхлийг амсах болно. Та нарын хийсэн буянт үйлийн хариу ертөнцийн төгсгөлийн өдөр бүрэн өгөгдөх болно. Хэн тамаас аврагдан диваажинд орно, тэр жинхэнэ зорьсондоо хүрнэ. Амьд ахуйн явдал бол ердөө л өөрийгөө хуурч байгаагаас өөр юу ч биш ээ.
186. Та нар эд хөрөнгө болон амь насаараа шалгалтанд орцгооно, тэгээд ариун судрын эзэдээс, үл сүсэглэгсдээс багагүй хор хөнөөл үзэж, хатуу үг сонсоцгоох болно. Хэрэв тэвчээртэй хандвал, Аллахаас айвал, энэ нь хатуу итгэлээр хийгдсэн хамгийн үнэ цэнэтэй зүйл байх болно.
187. Аллах тухайн үед "Ариун судрыг хүмүүст тайлбарлаж ойлгуулаарай, мөн бүү нуугаарай" хэмээн ариун судрын эзэдээс хатуу амлалт авсан билээ. Гэвч тэд үүнийг ар тийшээ шулуудсан, бас өчүүхэн өртгөөр арилжсан. Тэдний хийсэн арилжаа наймаа юутай муухай гээч!
188. Аяа, Мухаммед! Үйлдсэн муухай үйлдэлээрээ бардамнадаг, хийгээгүй юмныхаа төлөө магтуулахыг хүсэгсэдийг бүү тоо. Тэд Аллахын хатуу цээрлэлээс мултарна гэж бүү итгэ. Тэдэнд хатуу гэсгээл бий.

189. Тэнгэр, газрыг эрхшээх нь Аллахад хамааралтай. Аллахын хүч чадал бүх зүйлд хүрэлцэнэ.
190. Тэнгэр, газар бүтэхэд, өдөр шөнө ээлжлэн солигдоход оюун ухааны эздийн хувьд илэрхий нотолгоо бий.
191. Тэд суусан ч, боссон ч, хажуудлан хэвтсэн ч (үргэлж) Аллахыг эргэн бодно. Тэнгэр, газрын бүтсэний тухай эргэцүүлэн бодохдоо: "Аяа, эзэнтэн минь ээ! Чи тэднийг дэмий нэг бүтээсэнгүй. Чамайг бүхнээс ариун, үнэн хэмээн үздэг. Биднийг тамын галаас сэргийлэгтүн!" хэмээнэ.
192. Аяа, Эзэнтэн минь ээ! Чи хэнийг там руу оруулбал тэр тарчилна. Зальхай харгисуудад ямар ч туслагч үгүй.
193. Аяа, Эзэнтэн минь ээ! Бид хэн нэгэн хүнийг уриалан дуудагчийн (Мухаммедийн): "Аллахад сүсэглэн залбирцгаа!" гэснийг сонсож, сүсэглэцгээв. Эзэнтэн минь! Биднийг нүглийг өршөөн соёрхогтун. Муу муухай бүхнийг маань ариусгаж хайрла! Бидний амийг үнэн сүсэглэгсэдтэй хамт авагтун.
194. Аяа, Эзэнтэн минь ээ! Бидэнд Өөрийнхөө гэгээн элч нараар дамжуулан амласан зүйлсээ хайрла, биднийг ертөнцийн төгсгөлийн өдөр бүү шившиг болго, чи эргэлзээгүй амласнаасаа няцдаггүй шүү дээ!
195. Ийнхүү Эзэнтэн тэдний залбирлыг нь хүлээн зөвшөөрч: "Эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай, Би буян үйлдсэн хүмүүсийн сайн үйлсийг мартаггүй. Та нар бие биеэсээ үржин өссөн хүмүүс. Шашин сүсэглэсэнийхээ төлөө нутгаа сольсон, хөөгдсөн, Миний төлөө зовж зүдэрсэн, тулалдсан, дайнд амь эрсдсэн хүмүүсийн алдааг цайруулж, хаяагаар нь булаг урссан диваажингийн цэцэрлэгт оруулна. Энэ нь Аллахын шан харамж. Буян хишгийн хамгийн дээд нь Аллахынх болно" гэв.
196. Буруу номтнуудын (мөнгө, мал, нэр төр, албан тушаалын төлөө) хотоос хот дамжин хэсүүчилсэнд хууртавдаа!
197. Тэр бол өчүүхэн ч үнэ цэнгүй ашиг хонжоо. Тэдний эцсийн эцэст очих газар нь там. Тэр юутай муухай орон вэ!
198. Харин Эзэнтэнэс айхсадын хувьд, хаяагаар нь ариун булаг урсдаг, үүрд мөнх орших диваажин бий. Энэ нь Аллахын хувь хишиг. Аллахын ивээлд байх үнэнч хүмүүсийн хувьд хамгийн дээд шан харамж.
199. Ариун судрын эздийн дотор Аллахад төгс итгэн сүсэглэцгээдэг, Аллахын айлдваруудыг өчүүхэн үнээр арилжадаггүй, Аллахаас айх хүмүүс бий. Тэдэнд Эзэнтний буян хишиг оногддог. Аллах үнэндээ тооцоо бодохдоо үтэр түргэн билээ.
200. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Бэрхшээлийг тэвчицгээгтүн! (Дайсны эсрэг) туштай тэмцэгтүн! Хамгаалалтанд бэлэн байгтун! Аллахаас айгтун, ийнхүү та нар зол жаргалыг олно.

## 4. СУРЕ НИСА

Мадина-д илгээгдсэн. 176 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Аяа хүмүүс ээ! Өөрсдийн Эзэнтний өмнө сүсэглэн мөргөгтүн, Тэрбээр та нарыг нэг хүнээс (эрэгтэй хүнээс буюу Адамаас) бүтээж, түүнээс гэргийг нь (эмэгтэйг) бүтээж, тэр хоёроос үй олон эрэгтэй, эмэгтэйг түүгээр тараасан билээ. Та нар бие биеэс харилцан ямар нэгэн зүйл асуухдаа Түүний нэр барьж асуух тул Түүнээс айтгун. Мөн ураг төрлийн барилдлагаа таслахаас болгоомжлогтун. Үнэндээ Аллах та нарыг ажиглаж байдаг.
2. Өнчин өрөөсний мал хөрөнгийг бүү ашиглагтун. Өөрт нь өгөгтүн. Сайныг муугаар бүү солигтун. Тэдний мал хөрөнгийг өөрсдийн мал хөрөнгөтэй нийлүүлэн бүү идэгтүн. Учир нь энэ бол маш том нүгэл юм.
3. Хэрэв та нар өнчин өрөөсөн охидтой гэрлэвэл шударгаар хандаж чадахгүй хэмээн айх аваас өөртөө таалагдсан бүсгүйчүүдээс хоёр, гурав, дөрөв хүртэл эмэгтэйгэй гэрлэгтүн. Тэдний дунд мөн шудрага эрх тэгш харилцаж чадахгүй гэж айх аваас нэг л эмэгтэйгэй ханилаарай, эсвэл өөрсдийн шивэгчинтэй гэрлэхэд л хангалттай шүү дээ. Энэ нь шударга журамыг гажихгүйн тулд хамгийн зохистой арга.
4. Эмэгтэйчүүдийн махер буюу хувь хөрөнгийг чин сэтгэлээр бэлэг болгон өгөөрэй. Хэрэв тэд чин сэтгэлээр өгсөн (махерээс) хувь хөрөнгөөс нэг хэсгийг өөрсдийн зөвшөөрлөөр та нарт өгвөл, хүлээн авч эдлэх нь зүйтэй.
5. Амьдралынхаа эх сурвалж болгон Аллагаас хайрласан мал хөрөнгөө ухаан муутад бүү өгөгтүн. Харин тэднийг хооллуулан хувцаслаж, ерөөлийн сайхан үг хэлэгтүн.
6. Насанд хүрэх хүртэл өнчрөгсөдийг сонжиж байгтун. Хэрэв тэд зөв төлөвшин, мал хөрөнгөндөө эзэн болж чадахаар бол мал хөрөнгийг нь өөрсдөд нь хүлээлгэж өгөгтүн. Тэд насанд хүрэхээс өмнө мал хөрөнгийг яаран үрэн таран хийж бүү завшигтун. Баян чинээлэг хүмүүс өнчрөгсөдийн мал хөрөнгийг харж хандсаны төлөө шан харамж бүү хүртэгтүн. Хэрэв ядуу хүн тэдний мал хөрөнгийг хариуцан, харж хандвал зохих хэмжээгээр хүртэж болно. Тэдэнд мал хөрөнгийг нь буцааж өгөхдөө гэрч байлцуулагтун. Тооцоо бодоход Аллах хангалттай.
7. Эцэг эх, ойрын хамаатангуудаас өвлүүлэхээр үлдээсэн мал хөрөнгөөс их ч, бага ч гэсэн эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдэд зохих хэмжээгээр хувь оногдох ёстой.

8. Өв залгамжилсан эд хөрөнгийг хуваах үед албан ёсны өвлөгч биш ч гэсэн төрөл садан, ах дүүгийн холбоогүй ч гэсэн өнчин үгээгүй ядуус дэргэд нь байвал тэднийг хоосон үлдээлгүй зохих хэмжээгээр хувь хүртээж, ерөөлийн сайхан үг хэлэгтүн.
9. Хэн нэгэн өнчрөн үлдэх үр хүүхдийнхээ төлөө сэтгэл зовдогийн адил бусдын өнчин өрөөсөн хүүхдийн төлөө санаа зовогтун. (Өнчрөгсөдийн тухайд) Аллахаас айгтун. Шударга үнэнийг хэлэгтүн.
10. Өнчин хүүхдийн мал хөрөнгийг зальтай аргаар завшигсад үнэндээ хэвлийдээ гал тээж яваагийн адил. Тэд эргэлзээгүй тамын галд шатаж зовно.
11. Аллах та нарын хүүхдүүдийн өвлөлийн талаар ингэж тушааж байна. Үүнд: Нэг хүүд хоёр охиныхтой тэнцэх хувь оногдоно. Хэрвээ өв залгамчлагч охид хоёроос илүү байвал тэдэнд гэрээслэх эд хөрөнгийн гуравны хоёр хувь нь оногдоно. Өвлөгч ганц охин байвал гэрээслэл болсон хөрөнгийн тал хувь нь оногдоно. Хэрвээ үхсэн хүний хүүхдийн хамт өвөө, эмээ нь үлдэх аваас өвөө эмээ тус бүрт үлдээсэн эд хөрөнгийн зургааны нэг хувь оногдоно. Хэрэв үр хүүхэдгүй зөвхөн аав, ээж нь үлдэх аваас үлдээсэн эд хөрөнгийн гуравны нэг хувь нь нас барсан хүний эжид оногдоно. Хэрэв нас барсан хүний ах, эгч дүүс байх аваас үлдээсэн эд хөрөнгийн зургааны нэг хувь нь эжид оногдоно. Энэхүү гэрээслэлүүд нь өөд болсон хүний үхэхээс өмнө хийсэн гэрээслэл бөгөөд өр төлбөр төлөгдөж дууссаны дараа хуваагддаг. Эцэг, эх, үр хүүхдүүдийн хэн нь илүү ач тустай болохыг та нар мэдэхгүй. Энэхүү гэрээслэл нь Алладын айлдвар. Аллах үнэндээ бүхнийг мэддэг, далдын ухааны эзэн.
12. Хэрэв эхнэр чинь нас бараад хүүхэдгүй байвал үлдээсэн эд хөрөнгийн тал нь та нарт (эрэгтэйд) оногдоно. Хэрэв тэд хүүхэдтэй бол эхийн үлдээсэн эд хөрөнгийн дөрөвний нэг хувь нь та нарт (эрд нь) оногдоно. Энэхүү гэрээслэл нь үхэхээс өмнө хийсэн гэрээслэл болон өр төлбөр төлөгдсөний дараа хуваарилагдах ёстой. Хэрэв хүүхэдгүй байхдаа нас барвал үлдээсэн хөрөнгийн дөрөвний нэг нь эхнэрт чинь, харин хүүхэдтэй байсан үедээ нас барсан тохиолдолд үлдээсэн хөрөнгийн наймны нэг хувь нь эхнэрүүдэд чинь оногдоно. Энэхүү гэрээслэл ч үхэхээс өмнө хийсэн гэрээслэл болон өр төлбөр төлөгдсөний дараа хуваарилагдах ёстой. Хэрэв, нас барсан эрэгтэй эсвэл эмэгтэй нь эцэг, эх болон үр хүүхэдгүй бол түүний эд хөрөнгө нь эрэгтэй эсвэл эмэгтэй дүү нарын тус бүрд нь зургааны нэг нь, хэрэв нэгээс илүү бол гуравны нэг хувийг хамтран эзэмшинэ. Энэхүү гэрээслэл нь үхэхээс өмнө хийсэн гэрээслэл болон өр төлбөр төлөгдсөний дараа хэн ч хохирол амсахгүйгээр хийгдэх ёстой. Энэ нь Алладын баталсан гэрээслэл мөн. Аллах бүхнийг мэдэгч бөгөөд машид нигүүлсэгч.
13. Энэ бүхэн Аллахаас тогтоосон хууль цаазын хэм хэмжээ. Хэн Аллах

- болон түүний гэгээн элчид итгэн биширвэл Аллах түүнийг хаяагаар нь ариун булаг урсдаг диваажинд илгээнэ. Тэд тэнд мөнх үлдэцгээнэ. Энэ бол аугаа их аврал юм.
14. Хэн Аллах болон түүний гэгээн элчийг эсэргүүцэж, Аллахын тогтоосон хэм хэмжээг зөрчвөл үүрд тарчилан үлдэх там руу шидэгдэх болно. Энэ бол шившигт гэсгээл юм.
  15. Эхнэрүүдээс чинь садар самуун (зина буюу ёс бус хурьцал) явдалд холбогдсон гэж үзвэл дөрвөн хүнийг гэрчээр татагтун. Хэрэв, тэд ноглох юм бол тэр эмэгтэйг үхэн үхтэл нь, эсвэл Аллах тэдэнд авралын замыг зааж таалах хүртэл гэрийн хорионд байлгагтун.
  16. Та нараас хоёр хүн (эр,эм) садар самууны (зина буюу ёс бус хурьцал) бузар хэрэг үйлдвэл хоёуланг нь шийтгэгтүн. Хэрэв, тэд гэмшиж засарч, буян үйлдэх аваас тэднийг уучилах хэрэгтэй. Аллах эргэлзээгүй гэмшлийг хүлээн авагч, машид энэрэгч билээ.
  17. Хэн нэгэн ухаан мулгуугаас нүгэл үйлдэж, дараа нь хурдан гэмшиж наминчалбал Аллах түүний гэмшлийг хүлээн авна. Аллах бүхнийг мэдэгч, далдын мэргэн ухааны эзэн билээ.
  18. Харин, буруу үйлдлийг улам үргэлжлүүлж, үхэлтэй тулграх мөчид “Одоо л гэмшиж, наминчалж байна” хэмээн дуу алдагсдын гэмшил үр дүнгүй. Үл сүсэглэсээр үхэгсэдийн хувьд мөн тийм болой. Бид ийм этгээдүүдийн өмнө хатуу цэрлэл бэлтгэсэн болно.
  19. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Бэлбэсэн эмэгтэйчүүдийг албадлагаар богтлон авах, хүчээр бусдад өгөх нь зүйд үл нийцнэ. Тэдэнд анх хүртээсэн махер буюу хувь хөрөнгийн нэг хэсгийг буцааж авахын тулд шахалт үзүүлж болохгүй. Тэдэнтэй хүмүүнлэг ёсоор хандагтун. Тэд улайм-цайм ичгүүргүй зүйл үйлдвэл өөр шүү дээ. Хэрэв, тэд та нарт таалагдахгүй ч тэвчээртэй байцгаа. Та нарын үл таалах зүйлийг Аллах таалан ивээсэн байж болох шүү дээ.
  20. Хэрэв, эхнэрээсээ салж өөр эхнэртэй болохыг хүсвэл өмнөх эхнэрт их хэмжээгээр өгсөн махер буюу хувь хөрөнгийг буцааж бүү авагтун. Тэр эмэгтэйг гүтгэн, илэрхий нүгэл үйлдэж, махерээ буцааж авна гэж үү?
  21. Та нар нэгэнт эхнэр, нөхрийн барилдлагыг олж авчихаад эхнэрүүд чинь та нарт чин үнэн амлалт өгсөн байхад нэгэнт өгсөн махер буюу хувь хөрөнгийг буцааж авч яаж болохсон билээ?
  22. Эцгийнхээ гэрлэж байсан эмэгтэйчүүдтэй бүү гэрлэгтүн. Энэхүү айлдвар илгээгдсэнээс өмнө гэрлэсэн бол уучилна. Энэ бол үнэхээр маш ичгүүртэй, ой гутам, жинхэнэ мунхаг явдал.
  23. Ээжтэйгээ, охидуудтайгаа, эгч болон эмэгтэй дүүтэйгээ, авга эгчтэйгээ, нагац эгчтэйгээ, төрсөн ах дүүсийн охидуудтай, төрсөн эгч болон эмэгтэй дүүсийн охидуудтай, та нарыг хөхүүлсэн сүүн ээжтэйгээ, сүүн ээжийн төрүүлсэн охидуудтай, хадам ээжтэй, эхнэрийнхээ дагавар

охидуудтай гэрлэх нь хатуу цээрлэх, хориотой, бузар явдал. Дагавар охины ээжтэй (бэлгийн) харилцаанд ороогүй (салсан) бол дагавар охинтой нь гэрлэхэд нүгэл болохгүй. Мөн төрсөн хүүгийнхээ эхнэр буюу бэртэйгээ гэрлэх нь, бас төрсөн эгч дүү хоёр хүүхэнтэй зэрэг гэрлэх нь хатуу цээрлэл бүхий хориотой. Аллахын айлдвараас өмнөх үеийн явдал өнгөрсөнд хамааралтай. Аллах машид нигүүлсэгч, нэн өршөөгч билээ.

24. Гарын доорхи шивэгчинээс өөр, нэгэнт гэр бүл болсон эмэгтэйтэй гэрлэх нь хориотой. Энэ бол Аллагаас та нарт илгээсэн ариун үүрэг, буулгасан зарлиг мөн. Эдгээрээс бусдыг нь төлөв төвшин, завхай хэрэг үйлдэлгүйгээр өөрсдийн мал хөрөнгөө махер буюу хувь хөрөнгө болгон өгч эхнэр авах нь бүрэн зөвшөөрөгдөнө. Тэднийг ёслол авч гэрлэсэн бол анхны амласан махер буюу хувь хөрөнгийг заавал өгөгтүн. Махер буюу хувь хөрөнгө өгөгдсний дараа эхнэртэйгээ харилцан тохиролцож нэг шийдэлд хүрсэн бол нүгэл үл болно. (нөхөр нь анхны амалсанаас илүүг өгч болно, эхнэр нь зөвшөөрвөл нөхрийнхөө амалсанаас бага авч болно эсвэл бүр авахгүй байсан ч болно). Аллах бүхнийг мэддэг, мэргэн ухааны эзэн билээ.
25. Хэн нэгэн сүсэгтэн эмэгтэйчүүдтэй гэрлэхэд хөрөнгө чинээ нь хүрэхгүй бол өөрсдийнхөө эрхшээлд буй үнэн сүсэгтэй шивэгчинтэй гэрлэж болно. Аллах та нарын сүсэглэлийг сайн мэднэ. Та нар шашин нэгтэй тул ёс жудаг, ичгүүр сонжууртай, садар самуун явдалгүй, нууц амраггүй шивэгчин эмэгтэйчүүдэд тэдний эзэний хэлсэн махер буюу хувь хөрөнгө өгч түүнтэй сүй тавьж, эхнэрээ болгон авч болно. Хэрэв тэд гэрлэснийхээ дараа садар самуун явдал гаргавал тэдэнд эрх чөлөөтэй эмэгтэйчүүдэд оногдох шийтгэлийн талыг хүртээмүй. Энэ нь та нарын хэн нэг нь садар самуун хэрэг үйлдэхээс айхын тулд илгээгдсэн хэм хэмжээ. Харин та нар тэвчээртэй байвал илүү сайн хэрэг. Аллах машид өршөөгч, энэрэгч билээ.
26. Аллах та нарт (өөрийн зарлигуудыг) тайлбарлаж, та нарт өмнөхүүдийн замыг харуулахын зэрэгцээ та нарын гэмшилийг хүлээн авахыг хүсдэг. Аллах бүхнийг зүй ёсоор мэдэгч бөгөөд далдын мэргэн ухааны эзэн.
27. Аллах та нарын гэмшилийг чинь хүлээн авахыг хүсдэг боловч, гагцхүү өөрийн хүсэл тачаалын мөрийг хөөгсөд та нарыг садар самуунд оруулахыг хүсэцгээдэг.
28. Аллах, та нарын үүрсэн ачааг хөнгөлөхийг хүсдэг. Гэтэл хүмүүс шуналаа хязгаарлах талаар сул дорой байдаг.
29. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Бие биеийнхээ эд хөрөнгөнд зүй бусаар бүү хандаарай. Арилжаа наймааг чин сэтгэлээс зөвшилцөн хийж, бие биеэ бүү егүүтгэгтүн. Аллах үнэндээ та нарыг энэрэгч билээ.
30. Хэн Аллагаас тогтоосон энэхүү хэм хэмжээг зөрчин, зориудаар гэмт хэрэг үйлдэх аваас тэр тамд очно. Ингэх нь Аллахад онцын төвөггүй.



31. Хэрэв, та нар том нүгэлүүдээс болгоомжилвол, Бид бусад нүгэлүүдийг чинь уучилж, хүндлэл үзэх газарт (диваажин) оруулна.
32. Аллах хүмүүсийн заримыг нөгөөгөөс нь давуутай бүтээсэн. Бусдын давуу юм руу бүү тэмүүлэгтүн. Эрчүүдийн олсон хувь хишиг тэдний өөрт нь, эмэгтэйчүүдийн олсон нь мөн өөрт нь оногддог. Аллагаас нигүүлслийг хүсэгтүн. Аллах бүхнийг мэдэж байдаг.
33. Эцэг, эх болон ах дүүсийн ард үлдсэн мал хөрөнгийн өвлөгчдийг зааж өглөө. Та нар өөр хоорондоо туслан өв залгамжилахаар тохиролцсан хүмүүсийнхээ хувийг тэдэнд өгөгтүн. Аллах бүхнийг хянаж байдаг.
34. Аллах та нарын нэгийг нөгөөгөөс (хүч чадал, байлдах чадвар, эмэгтэйгээс эрчүүдийг илүү хүчтэй байх мэт) чанараар илүү бүтээсэн тул, эрэгтэйчүүд мал хөрөнгөө илүүтэй зарцуулдаг учраас, эмэгтэйчүүдийн хувь хишиг эрчүүдэд үүрэг болгогдсон. Ёс суртахуунтай эмэгтэйчүүд эрчүүдэд захирагддаг. Мөн тэд нөхрийн эзгүйд ч Аллахын хамгаалсан ивээлээр цэвэр ариун байдлыг сахидаг. Та нар эр нөхрөөсөө урвахвий хэмээн сэжиглэсэн эмэгтэйчүүдэд сургамж өгөгтүн. Хэрэв энэ арга үр дүнгүй болоход хүрвэл дэр бүү нийлүүлэгтүн. (шийтгэл хэлбэрийн арга) Тэгээд ч тусыг эс олвоос хөнгөвтөр жанчигтун. Уламаар та нарыг хүлээн зөшөөрвөл тэдэнд дарамт үзүүлэх хэрэггүй. Аллах үнэндээ машид аугаа бөгөөд эрхэмсэг билээ.
35. Хэрэв эхнэр, нөхрийн хоорондын харилцаанд ан цав үүсэхээс болгоомжилбол нөхөр болон эхнэрийн талаас тус бүр нэг шүүгчийг дуудагтун. Тэд эхнэр, нөхөр хоёрыг эвлрүүлэхээр бол Аллах тэдэнд тусалдаг. Аллах бүхнийг мэдэгч, бүхнийг эрхшээдэг.
36. Аллахад сүсэглэн мөргөцгөөвөл, Түүнтэй юуг ч бүү эн зэрэгцүүлэгтүн. Эцэг эх, хамаатан садан, өнчин өрөөсөнгүүд, үгээгүй ядуус, ахан дүүс, хөрш, холын хамаатан хөрш, ганзага нийлсэн дотны найз, аян замын зорчигч, эрхшээлдээ буй боол, шивэгчин бүхэнд туслан, сайн санааны үүднээс харилцагтун. Аллах их зантай, онгиороо сагсуу хүнийг үл таална.
37. Тэд (их зантай, сагцуучууд) харамч, бас бусдыг харамч занд сургадаг. Аллахын хайрласан хувь хишгийг нуудаг. Бид ийнхүү сүсэггүй амьтадад зовлонт гэсгээл бэлтгэсэн болой.
38. Аллахад болон хойд ертөнцөд үл итгэх мөртлөө өөрсдийн эд хөрөнгөөр гайхуулахыг боддог хүмүүс байдаг. Хэн чөтгөр шуламтай нөхсөнө, түүний нөхөд ч зальхай байж таарна.
39. Тэд Аллах болон хойд ертөнцөд итгэж, Аллахын хувь хишгээс ёсоор нь зарцуулбал юу нь буруу байх сан билээ! Аллах тэднийг сайн мэднэ.
40. Аллах өчүүхэн ч шударга бус ханддаггүй. Харин өчүүхэн сайн үйлс байвал түүнийг хэд дахин үржүүлж, Өрийн зүгээс ч их буян хайрлана.

41. (Аяа, Мухаммед!) Бид янз бүрийн ард түмний дотроос нь нэг гэрч томилж, үл сүсэглэгсдэд чамайг гэрч болгон илгээвэл тэдний байдал ямар байхсан билээ?
42. Аллахад үл сүсэглчид болон гэгээн элчийг эсэргүүцэгчид ертөнцийн төгсгөлийн тэр өдөр газар дор орохыг хүсэцгээдэг бөгөөд Аллахаас ямар ч үгээ нууж чадахгүй.
43. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Согтуу байсан үедээ юу хэлж байгаагаа мэдэх хүртэл уншлага мөргөл үйлдэхээр бүү завдагтун. Биеэ ариусган угаал үйлдэхээс наана уншлага мөргөл бүү хийгтүн. Харин аян замд яваа хүн бол өөр. Хэрэв та нар өвчтэй буюу аян замд яваа ахул эсвэл хүнд ба хөнгөнөөр бие зассан бол, тэрчлэн эхнэртэйгээ харьцаанд орвол, бас ус эс олдсон нөхцөлд цэвэрхэн элс буюу шороогоор гар нүүрээ арчиж, (таямму) ёсыг гүйцэтгэгтүн. Аллах үнэндээ машинд уучлан өршөөгч.
44. Аяа, Мухаммед! Дээдийн судраас хишиг хүртэгсэдийн (Иудэйчүүдийн) урван тэрслэлтийг худалдан авч (сонгож), та нарыг ч зөв замаас төөрүүлэхийг хүсэж буйг харсан уу?
45. Аллах та нарын дайсныг сайн мэддэг. Аллах та нарт эзэн, ивээн туслагч болоход бэлэн.
46. Иудэйчүүдийн зарим нь Таурат судрын үгийг зоргоороо өөрчилчихээд, (гэгээн элчийн эсрэг) “Бид чамайг сонсоод эсэргүүцэж байна. Харин бидний үгийг сонсогтун. Бид одоо чамайг сонсохгүй” гэнэ. Шашныг шоглон доромжилох зорилгоор хазгай ярж “рагина”(рагина үг-араб хэл дээр “биднийг захир” гэсэн утгатай харин иудэй хэл дээр шууд хэрэглэхэд “бидний малчин” гэсэн утгатай болхоор эл үгийг доог тохуу болгон хэрэглэсэн билээ) хэмээнэ. Хэрэв тэд “Бид сонсоцгоосон, бишрэн дагана, биднийг сонс, (унзурна) буюу биднийг ажигла” гэвэл тэдний хувьд илүү сайн, зөв шийдэл болох байсан юм. Гэвч эсэргүүцээний улмаас тэдэнд Аллахын шийтгэл хараал нь хүрсэн тул цөөн хэдийг нь эс тооцвол тэд үл сүсэглэмүй.
47. Аяа, ариун судрын эзэд ээ! Бид та нарын (хамар, хөмсөг, нүд зэрэг зарим эрхтнийг чинь үгүй хийж) нүүрийг гөлийтэл илбэж, буруу харуулахаас өмнө, мөн бямба гарагийн хориог үл тоомсорлогсдыг (Сабтийн ард олныг) гэсгээсэн лүүгээ адил та нарыг гэсгээхээс өмнө гарт чинь байгаа Таурат судрыг бататган илгээгдсэн Куранд итгэгтүн! Аллахын зарлиг нь ёсоор биелэх болно.
48. Аллах өөртэй нь бусдыг адилтгахыг хэзээ ч үл өршөөнө! Үүнээс бусад нүгэл хилэнцийг хүссэн ёсоор өршөөдөг. Хэн Аллахтай бусдыг эн зэрэгцүүлэнэ гэвэл тэр маш хүнд нүгэл, гүтгэлэг үйлдсэн болно.
49. Аяа, Мухаммед! өөрсдийгөө ямар ч гэм зэмгүй ариун цагаан хэмээн үздэг хүмүүсийг харсан уу? Тийм бишээ! Аллах гагцхүү таалсан хүнээ гэмгүй ариун болгоно. Тэдэнд өчүүхэн ч муухай зүйл хийгдэхгүй.

50. Тэдний Аллаһыг гүтгэн гүжирдэж буйг хараач! Энэ бол тэдэнд илэрхий нүгэл шүү дээ.
51. (Аяа, Мухаммед!) Ариун судраас хишиг хүртэгээдийг анзаарсангүй юу? Тэд мухар сүсэгт, (жибит, тагут) чөтгөр шуламын заасан бүхэнд итгэдэг бөгөөд буруу номтныг зааж: "Эд нар сүсэгтнүүдийг бодвол зөв замаар явагсад" гэлцдэг!
52. Харин тэд өөрсдөө Аллаһын хараал хүртэгээд юм. Аллаһын хараал хүрсэн хүнд тус дэм бологч олдохгүй.
53. Эсвэл тэд өөрсдөд нь нэгэн хувь хүртэхийг горьдогсод юм уу? Тийм бол тэд бусад хүмүүст өчүүхэн хувь ч өгөхгүй.
54. Үгүй бол тэд Аллаһаас хүмүүст өгөөрөөр хайрласан их хишигт агаархацгаадаг юм уу? Үнэндээ бид Ибраһимын үр удамд ариун судар болон мэргэн ухаан, аугаа их хаанчлалыг хайрласан шүү дээ.
55. Тэдний (Иудэйчүүдийн) зарим хэсэг нь түүнд (Мухаммедэд) итгэж, зарим нь татгалзсан юм. Тэдний хувьд шарагч гал - там л хангалттай!
56. Бидний айлдваруудыг үгүйсгээдийг галдан хуйхлана. Гэсгээлийн амтыг мэдрүүлэхийн тулд арьс нь зумлагдан түлэгдэж гүйцэх үед өөр баг өмсгөнө. Аллаһ гарцаагүй эрхэмсэг, мэргэн ухааны Эзэн билээ.
57. Үнэн сүсэгтнүүд болон буянтай зүйл үйлдсэн хүмүүсийг Бид хаяагаар нь ариун булаг урссан диваажинд оруулна. Тэд тэнд эгнэгт оршмуй. Тэдэнд зориулсан цэвэр ариун хань байдаг. Тэднийг сүүдэрлэг сайхан газарт залах болно.
58. Үнэндээ Аллаһ та нарт итгэмжилсэн зүйлийг зохистойгоор эзэнд нь буцааж өгөхийг, аливаа асуудалыг шүүн хэлэлцэх эрх эдэлвэл шударга байхыг зарлиг болгоно. Аллаһын та нарт хэлсэн сургаал, ухуулга нь юутай сайхан вэ! Тэр бүхнийг сонсож, бүхнийг хардаг мэргэн ухааны эзэн.
59. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нар Аллаһад, гэгээн элчид, өөрсдийн дундаас гарсан эрх мэдэлтнүүдэд итгэж, дагагтун, захирагдагтун. Хэрвээ аливаа асуудлын талаар маргалдавал Аллаһад, гэгээн элчид хандаарай. Хэрэв Аллаһ болон ертөнцийн төгөсгөлд итгэвэл ийнхүү хандах нь өгөөжтэй, төгс шийдэл болно.
60. Аяа, Мухаммед! Чамд илгээсэн Куран судар болон чамаас өмнө нь илгээгдсэнд (Таурат болон Инжилд) итгэсэн гэж хоосон зүтгэхээдийг чи анзаарсан уу? Тэд сүсэглэхийг хориглосон (тагут) чөтгөр шуламын заасан бүхэнд итгэхийг боддог. Харин чөтгөр шулам тэднийг урвуулан, замыг алдуулж, улам бүр төөрөлдүүлэхийг хүсдэг.
61. Тэдэнд "Аллаһын илгээсэн ариун судар болон гэгээн элч рүү очигтун!" гэвэл хоёр нүүртнүүдийн чамаас хэрхэн нүүр буруулан тонилохыг чи харах болно.
62. Өөрсдийн гараар үйлдсэн хэргийнхээ хариуд нэгэн зовлон учрах цагт

- тэд чамд дээр ирж, Аллахын нэрээр андгайлан: "Бид гагцхүү эв эе, сайн сайхныг л хүссэн шүүдээ" гэвэл чи яах вэ?
63. Аллах тэдний зүрх сэтгэлд юу нуугдаж буйг мэднэ. Чи тэднээс зай барьж, ухуулан сэнхрүүл, итгүүлэн үнэмшүүл.
  64. Бид бүх гэгээн элчийг- зөвхөн Аллахын зарлигаар та нарыг захируулахын тулд илгээсэн. Тэд өөрийн толгойд лай хурааж, улмаар чам дээр ирж Аллахын өршөөлийг эрэх аваас, гэгээн элч нар ч тэдний өмнөөс өршөөл гуйвал Аллах эргэлзээгүй тэднийг өршөөж, энэрэн нигүүлсэх болно.
  65. Аяа, Мухаммед! Аллахын нэрээр тангараглая! Тэд хоорондын маргаанаа чамар шүүн таслуулахаар урихаас наана, чиний шүүн тасалсан асуудлын тухайд тэдний эргэлзээ арилахаас наана, чамд төгс итгэхээс наана тэд жинхэнэ сүсэгтэн болж чадахгүй.
  66. Тэдэнд "Өөрсдийгөө өөрсдөө хөнөөсүгэй! Нутагаасаа зайлан тонилцгоо!" хэмээн тушаавал тэдний олонхи нь биелүүлнэ гэж үү? Хэрэв тэдэнд өгсөн ухуулга сургамжийг зүй ёсоор гүйцэтгэсэн бол мэдээж тэдний хувьд өлзийтэй болж, итгэл үнэмшил бөх бат төлөвших байсан билээ.
  67. Тэгвэл мэдээж, Бид тэдэнд аугаа их буян хишиг (диваажин) хайрлах байсан юм.
  68. Бас зөв шулуун замаар хөтлөн явуулах байсан юм.
  69. Хэн, Аллах болон гэгээн элчид итгэн сүсэглэвэл, Аллахын өршөөлд багтсан гэгээн элчүүд, чин үнэнч сүсэглэгсэд, Аллахын төлөө амь насаа зориулагсад болон сайн үйл үйлдэгсэдтэй хамт байх болно. Тэгвэл юутай сайхан нөхөрлөл байхсан билээ!
  70. Энэ бол Аллахын ивээл талархал. Аллах Өөрийнхөө таалалд нийцэх хүмүүсийг сайн мэднэ.
  71. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Сэрэмжтэй байгтун! Дайсны эсрэг хэсэг бүлгээрээ эсвэл цөм нэгдэн мордогтун.
  72. Та нарын дунд дайсаны эсрэг тулалдахаас мултран үлдэхихээд та нарт ямар нэгэн гай барцад тохиолдвол : “Бид тэдэнтэй цуг байгаагүйгээс Аллах өршөөжээ” гэнэ.
  73. Хэрэв та нар Аллахын ивээлээр ялалтанд хүрвэл та нартай ямар нэгэн найз нөхрийн холбоо байхгүй юм шиг : “Ээ дээ, би та нартай хамт байсан сан бол энэ аугаа ялалтыг би ч хуваалцах байсан юм” гэж хэлнэ.
  74. Иймд амьд ахуй цагаа хойд ертөнцийн төлөө арилжигсад Аллахын төлөө дайтагтун. Хэн Аллахын төлөө дайтаж амь эрсдэх буюу ялах аваас Бид түүнд аугаа их буян хишиг хайрлах болно.
  75. Та нар яав даа! “Аяа, Эзэнтэн минь, Биднийг хүн зон нь харгис дарангуйлагч энэ хотоос гаргаж хайрла. Бидэнд өөрийнхөө дэргэдээс

- нэгэн өмгөөлөн хамгаалагч илгээж өгөөч” хэмээн залбирч буй чадал мөхөс эрчүүд, буурай эмэгтэйчүүд, нялх хүүхдүүдийг хамгаалахын тулд Аллахын төлөө яагаад байлдадаггүй юм бэ?
76. Сүсэгтнүүд Аллахын төлөө, үл сүсэглэгсэд чөтгөр шуламын төлөө тулалддаг. Тиймээс чөтгөр шуламын нөхдийн эсрэг байлдацгаагтун. Тэднийг ялна. Учир нь чөтгөр шуламын заль мэх мөхөс.
77. (Аяа, Мухаммед!) Өөрсдөд нь (дайн самуун дэгдээгчидэд): “(дайтахаас) Савраа татагтун, уншлага мөргөл үйлдэж, ариуслын өглөгөө өгөгтүн” хэмээн хэлэгдсэн хүмүүсийг чи харсангүй юу? Тэдэнд дайтах үүрэг оногдоход нэг хэсэг нь: Аллахаас айхын адил дайсанаасаа айдаг. Бүр үүнээс ч илүү айж түгшидэг. Тэд: “Эзэнтэн минь! Юуны төлөө бидэнд дайныг үүрэг болгов? Бидэнд хоромхон боловч амьд явах боломж яагаад өгсөнгүй вэ□” гэнэ. (Аяа, Мухаммед) тэдэнд: “Энэ насны ашиг тус бага. Төгс сүсэглэж, Аллахаас айхсадын хувьд хойд ертөнц илүү буянтай. Та нарт өчүүхэн ч шударга бус юм үл хийгдэнэ” гэж хэлэгтүн.
78. Та нар хаана байсан ч, тэнгэрт тулсан өндөр хэрэмийн дотор байсан ч, цаг нь ирэхдээ үхэл та нарыг олоод иднэ. Хоёр нүүргэн тэдэнд нэг сайн үйлс тохиолдвол: “Энэ Аллахын зүгээс” гэлцэнэ. Харин муу үйлс тохиолдвол: “Энэ чамаас боллоо” гэнэ. (Аяа, Мухаммед) тэдэнд: “Бүх зүйл Аллахын зарлиг” гэж хэлэгтүн. Энэ хүмүүс яагаад ганц ч үг ойлгодоггүй юм вэ!
79. Чамд тохиох сайн үйлс Аллахаас, Аллахын хайр ивээл. Харин чамд тохиох аливаа муу үйлс чамаас шалтгаална. (Аяа, Мухаммед) Бид чамайг хүн төрлөхтөнд өөрийнхөө элч болгон илгээсэн. Гэгээн элч болсныг чинь Аллах бүрэн гэрчилнэ.
80. Хэн нэгэн гэгээн элчид итгэн дагавал Аллахад итгэн биширсний илрэл. Хэн нэгэн нүүр буруулвал бид чамайг тэдэнд хяналт тавиулахаар илгээгээгүй болой.
81. Тэд: “Зарлигийг чинь гүйцэтгэе” гэгцгээдэг атал чамаас холдмогц тэдний зарим хэсэг нь хэлснээсээ буцан, нууцаар зөвлөлддөг. Аллах тэдний шивэр авир нууцхан яриаг тэмдэглэж байдаг. Чи тэднээс зай барьж, Аллахад найдагтун. Чиний хувьд Аллах л хангалттай гэрч.
82. Тэд өдий хүртэл Кураны тухай эргэцүүлэн боддоггүй гэж үү? Хэрэв Куран судар Аллахаас өөр хэн нэгэн хүнээс ирсэн бол тэд Куран судраас янз бүрийн зөрчил олох л байсан юм.
83. Тэдэнд мусулманчуудтай холбоотой амар амгалан эсвэл айдас түгшүүрийн дохио ирмэгц тэд үнэн мөнийг ололгүйгээр зарлачихдаг. Хэрэв тэд уг мэдээг гэгээн элчид, эсвэл өөрсдийн эрх мэдэлтнүүдэд танилцуулсан бол түүний юу болохыг тэд мэдэх л байсан юм. Аяа, мусулманчууд! Аллах та нарыг өгөөмөрөөр өршөөн нийгүүлсээгүй бол та нарын ихэнх чинь чөтгөр шуламын замаар талийх байсан юм.

84. (Аяа, Мухаммед) Аллахын төлөө тулалдагтун. Чи гагцхүү өөрийн хийсэн үйлдлийн төлөө хариуцлага хүлээнэ. Үнэн сүсэгтнүүдийг тулалдаанд уриалан дуудагтун! Аллах буруу номтнуудын сүр хүчийг номхруулж чадна. Аллахын үнэнхүү хүч чадал агуу бөгөөд Түүний гэсгээл цээрлэл хамгийн хагуу.
85. Хэн сайн сайхан үйлсэд дэм тус болвол, тэр л сайн хувь хишиг хүртэнэ. Хэн муу үйл хэрэгт тус үзүүлнэ, тэр муухай хувь хүртэнэ. Аллахын хүч чадал бүхий л зүйлд хүрнэ.
86. Хэн нэгэн та нартай мэндэлвэл түүнээс ч илүү элгэмсгээр хариу мэндлэгтүн. Аллах эргэлзээгүй бүхний тооцоог асуух болно.
87. Аллах цорын ганц, Түүнээс өөр бурхан үгүй. Гарцаагүй тохиох ертөнцийн төгсгөлийн өдөр та бүхнийг нэг дор цуглуулна. Аллагаас өөр үнэн үгтэн хэн байгаа юм вэ?
88. Аяа, үнэн сүсэгтнүүд! Та нар юунд хоёр нүүртэн, буруу номтнуудын талаар хуваагдмал саналтай байдаг вэ? Аллах тэднийг хийсэн нүглийн төлөө эсрэг тэсрэг болгосон. Аллах төөрөгдүүлсэн хүнийг та нар зөв замд оруулах гэж үү? Нэгэнт Аллах төөрүүлсэн, тэдэнд хэзээ ч зөв зам олж өгч чадахгүй.
89. Тэд өөртэйгээ адил та нарыг үл сүсэглэгчид болоосой хэмээн хүсч буй. Аллахын замд эргэн орохоос наана тэдэнтэй бүү нөхөрлөгтүн. Хэрэв Аллахын замд эргэн орохоос таггалзвал тэр даруйдаа барьж авч устгагтун. Тэднийг анд нөхөд, туслагч бүү болгогтун.
90. Гагцхүү та нартай эв найрамдлын холбоо бүхий ард түмэнтэй нэгдсэн хэн нэгнийг мөн та нартай төдийгүй өөрийн ард түмэнтэй ч тулалдахад зүрх сэтгэл нь хүрэхгүй та бүхэн дээр ирэгсэдэд гар бүү хүрэгтүн. Хэрэв Аллах хүсвэл, тэднийг та нарын толгойд гаргах байсан. Тийм үед тэд та нартай тулалдах байсан. Хэрэв тэд та нараас зайлан одвол байлдахаас таггалзан, бууж өгөлгүй хэлэлцээр хийхийг хүсвэл тэдэнтэй тэмцэхийг Аллах хэзээ ч зөвшөөрөхгүй.
91. Мөн та нар хийгээд өөрсдийн зон олонтойгоо эвтэй найрсаг байхыг хүсдэг бас нэгэн хүмүүс байдгийг та нар олж мэднэ. Тэд үймээн самуунд уриалбал шуудран ороход бэлэн болдог. Хэрэв та нараас айхгүй, бууж өгөхгүй бол, дайнаас савраа тагахгүй бол, тэднийг хаа олсон газраа барьж авч устгагтун. Ийнхүү ариун дайны тухайд Бид та нарт илэрхий эрх олгосон.
92. Үнэн сүсэгтнүүд бие биеэ санаатай болон санамсаргүй егүүтгэвэл зөвтгөх зүйл биш. Хэн нэгэн үнэн сүсэгтний аминд нь санамсаргүй хүрсэн бол хариуд нь нэг сүсэгтэн боолыг эрх чөлөөтэй болгож, амь үрэгдсэн сүсэгтний ар гэрт төлөөс төлөх хэрэгтэй. Амь үрэгдсний ар гэр өршөөвөл өөр шүү дээ. Харин дайсагнасан этгээдийн аминд санамсаргүй хүрсэн бол (тэр нь үнэн сүсэгтэн байвал) төлөөс төлөлгүйгээр сүсэгтэн нэг боолыг эрх чөлөөтэй болгох хэрэгтэй. Хэрэв

- амь үрэгдсэн хүн найрамдалын хэлэлцээртэй талынх байсан бол, хүний амь егүүтгэгч этгээд амь үрэгдэгчийн ар гэрийнхэнд төлөөс төлж, нэг сүсэгтэн боолыг эрх чөлөөтэй болгох ёстой. Эдгээр боломж нь үгүй буруутны хувьд Аллахад нүглээ наминчлан, хоёр сар дараалан мацаг барих хэрэгтэй. Аллах бүхнийг мэдэгч мэргэн ухааны эзэн.
93. Хэн нэгэн үнэн сүсэгтний аминд санаатайгаар хүрвэл түүний шийтгэл нь үүрд үлдэх халуун там байх болно. Аллахын уур хилэн, хараал түүнд хүрнэ. Хүнд бэрх гай зовлонгийн цээрлэл түүний төлөө бэлтгэгдэх бөлгөө.
94. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахын төлөө (тулалдахаар) мордвол хянуур болгоомжтой байгтун. Та нарт мэндлэхээр (мусулман болсноо илэрхийлэн) ирсэн хэн нэгнийг амьд ахуйн өчүүхэн (олзны) хөрөнгийг бодож: “Чи сүсэгтэн биш” хэмээн бүү хэлэгтүн. Учир нь Аллагаас та нарт хүртээх олз элбэг. Өмнө нь та нар ч гэсэн тийм л сүсэггүй байхад Аллах та нарт итгэл бишрэл хайрласан юм. Тиймээс хянуур болгоомжтой үйл үйлдэгтүн. Аллах та нарын хийж буй бүх үйлсийг мэдэгч билээ.
95. Ямар ч шалтгаангүйгээр (сохор, доголон, өвчтэй зэрэг) тулалдаанд оролцоогүй хүмүүс болон Аллахын төлөө мал хөрөнгө, амь насаа үл хайрлан тулалдсан сүсэгтэн хоёр адил биш. Мал хөрөнгө, амь насаараа дэнчин тавьж байлдсан хүмүүсийг Аллах амиа хохойлон үлдэгсэдээс нэг эрэмбэ дээгүүр тавих болно. Аллах тулалдаанд оролцсон ба хүндэтгэх шалтгаанаар оролцож чадаагүй хүмүүсийг нэгэн адил ивээн соёрхоно. Гэхдээ, тулалдагсадыг гэртээ үлдэгсэдээс илүү таалж, их шан харамж олгон соёрхдог билээ.
96. Аллах тэдэнд аугаа хүндэтгэл, өршөөл болон нигүүлсэл хайрласан билээ. Аллах нэн өршөөгч, онцгой нигүүлсэгч билээ.
97. Мэлэкүүд (тэнгэрийн элчүүд) хүлцэл өчилгүй, буруу номтнуудад уусч, өөртөө лай хураасан этгээдүүдийн амийг таслах цагт: “Та нар итгэл бишрэлийн хувьд ямар байсан юм бэ?” гэж асуухад тэд: “Бид энэ газарт (Меккед) эрх мэдэлгүй дорой байсан юм” гэж хариулна. Мэлэкүүд : “Нутаг солих байсан бол Аллахын орчлон уудам бус уу?” гэнэ. Ийнхүү тэдний очих газар бол халуун там билээ. Тэр бол мөн ч ёоз муутай газар аа!
98. Гэхдээ учир мэдэхгүй, аргагүй байдалд орсон, зам мэдэхгүй төөрөлдсөн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд болон хүүхдүүдийн хувьд асуудал өөр юм.
99. Тэднийг Аллах өршөөж магадгүй. Аллах машид өршөөгч, ивээн соёрхогч билээ.
100. Хэн Аллахын төлөө нүүдэл хийвэл газар дэлхийн хаана нэгэн өнцөг буланд суурьших орон болон элбэг амгаланг олно. Хэн нэгэн Аллах болон гэгээн элчийн төлөө нүүдэл хийж, энэхүү замд амь үрэгдвэл,

Аллах түүнийг ивээлдээ авна. Аллах машинд ивээн соёрхогч бөгөөд нигүүлсэгч билээ.

101. Газар дэлхийд аялан явахад самуун дэгдээх буруу номтнуудын дайралтад өртөхөөс эмээж, уншлага мөргөлөө товчилоход хүрвэл нүгэл үгүй. Үл сүсэгслэгч буруу номтнууд та нарын илэрхий дайснууд шүү дээ.
102. (Аяа, Мухаммед) Дайн тулааны үеэр чи мусулманчуудтай хамт байж, тэдэнтэй цуг уншлага мөргөл үйлдвэл тэдний нэг хэсэг нь чамтай хамт уншлага мөргөлөө үйлдэг. Зэр зэвсгээ ойрхон байлгагтун. Уншлага мөргөлийн сөгдөх ёсыг үйлдсэний дараа тэд чамайг хамгаалж, ар талд чинь бэлэн байгтун. Дараа нь нөгөө хэсэг нь чамтай хамт мөргөгтүн. Хамгаалалтын зэр зэвсэгийг өөрсдийнхөө хажууд бэлэн байлгагтун. Учир нь буруу номтнууд анзааргагүй байдлыг ашиглан гэнэтийн дайралт хийхийг бодно. Хэрэв, усан бороо болон өвчний улмаас зэвсгээ хажуудаа тавьсан бол гэмзэм үгүй. Гэхдээ, хянуур болгоомжтой байгтун. Аллах үл сүсэглэгч дайснуудад зовлонт гэсгээлийг зэхсэн байдаг.
103. Уншлага мөргөл хийж дуусахад Аллахыг босоо, суугаа, хэвтээ аль ч байдлаар дурсан санагтун. Тайван цагт уншлага мөргөлөө ёс жаягаар нь бүрэн үйлдэгтүн. Уншлага мөргөл нь үнэн сүсэгтнүүдэд тодорхой цаг хугацаагаар үйлдэх ариун үүрэг болгогдсон билээ.
104. Дайсныг нэхэж, үлдэн хөөхөд сул дорой байдал бүү гаргагтун. Та нар бэрхшээл зовлон амсах аваас дайсан ч тийм бэрхшээл зовлон амсаж буй хэрэг. Харин тэдний хүсээгүй, горьдоогүй зүйлийг (Аллахын төлөө амиа золиослох, ивээл соёрхолыг, ялалтыг) та нар Аллагаас хүсдэг. Аллах бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн.
105. (Аяа, Мухаммед!) Чамайг олны дунд Аллахын заасны дагуу шийдвэр гаргаг гэж чин үнэн судар Кураныг чамд илгээсэн билээ. Иймд урвагчдыг бүү өмгөөлөгтүн.
106. Аллагаас уучлал эрэгтүн. Аллах машинд өршөөгч, онцгой нигүүлсэгч юм.
107. Өөртөө гай барцад тарьсан хүмүүсийг бүү өмгөөлөн хамгаалагтун. Аллах гай барцадтай нүгэлтнүүдийг үл ташаана.
108. Тэд гай барцадаа хүмүүсээс нуусан ч Аллагаас нууж үл чадна. Тэд шөнөжин Аллахад үл таалах (бусдыг хорлон муулах, хуурамчаар гэрчлэх, худлаа танграглах) зэрэг хорлон сүйтгэх зүйл ярилцаж, төлөвлөхөд Аллах тэдэнтэй хамт байсан юм. Аллах тэдний хийсэн бүхнийг бүрэн мэдэгч, ярьсан бүхнийг сонсогч байдаг.
109. Та нар амьд ахуй цагтаа тэдний төлөө маргалдан өмгөөлцгөөсөн, гэтэл хойд ертөнцөд Аллахын өмнө тэдний төлөө хэн маргалдан өмөөрч, хэн тэднийг төлөөлж чадах вэ?



110. Хэн нэгэн муу үйл үйлдэж, эсвэл өөрөө өөртөө гай тарьж, дараа нь Аллахаас өршөөл эрвэл Аллах машид өршөөгч, онцгой нигүүлсэгч болохыг олж мэдэх болно.
111. Хэн нүгэл үйлдвэл түүний уршиг өөрт нь оногдоно. Аллах бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн.
112. Хэн нүгэл буюу муу үйл үйлдэж, түүнийгээ хоёр дахь хүн дээр тохвол, хэрэг дээр тэр гүтгэлэг болон илэрхий нүглийг өөрөө хүлээх болно.
113. (Аяа, Мухаммед) Хэрэв, чамд Аллахын хайр энэрэл, нигүүлсэл байхгүйсэн бол тэдний нэг хэсэг нь чамайг төөрөлдүүлэхийг оролдох болно. Гэвч тэд зөвхөн өөрсдийгөө л төөрөлдүүлнэ, чамд өчүүхэн ч хор хөнөөл учруулж чадахгүй. Учир нь Аллах чамд зориулан ариун Кураныг, түүгээр уламжлан мэргэн ухааныг илгээсэн. Бас чиний мэдэхгүй зүйлийг зааж сургасан. Аллахаас чамайг шагнасан их боломж, хайр энэрэл нь аугаа их билээ.
114. Тэдний нууцхан шивэр-авир худал үгийн ашиг тус ер үгүй. Хэрэв, өглөг өгөхөд, хайр энэрэлд, хүмүүсийн эв эед чиглэгдвэл өөр хэрэг шүү дээ. Хэн эдгээр буянт үйлсийг Аллахын таалалд нийцэг хэмээн үйлдвэл, Бид түүнд асар их буян хайрлах болно.
115. Хэн нэгэн Аллахын зөв шулуун зам өөрт нь тодорхой болсны дараа гэгээн элчийг эсэргүүцэн, үнэн сүсэгтнүүдийн замаас өөр замыг сонговол Бид түүнийг тэр чигээр нь орхин, халуун там руу оруулах болно. Там юутай муухай газар гээч?
116. Аллах Өөртэй нь аливааг эн зэрэгцүүлэхийг хэзээ ч үл өршөөнө. Үүнээс бусад хүссэн хүнээ өршөөдөг. Харин хэн нэгэн Аллахтай аливааг эн зэрэгцүүлэн зүйрлэвээс зүгээ алдан төөрөлдөх нь тэр ээ!
117. (Меккегийн олон бурхан шүтэгч буруу номтнууд нь) Аллахаас зайлсхийн эмсийн нэрээр нэрлэгдсэн хуурамч бурхадад залбирцгаадаг. Үнэндээ тэд эсрэг зүтгүүлсэн чөтгөр шуламд залбирцгаадаг.
118. Аллах чөтгөр шуламыг харааж зүхнэ. Чөтгөр шулам тэр мөчид ч зөрүүдлэн: “Чиний боолуудын дотор би ч зохих хувь эзэлдэг” гэж зүтгэнэ.
119. Би тэднийг гарцаагүй төөрөгдөлд оруулна, (урт амьдрал, хойд нас, хариу гэгсгээл үгүй гэх мэтчилэн) хоосон мөрөөдөлд автуулан горьдооно. Хиймэл бурхадад зориулан (тэдний хуучин хуурмаг ёс) малынхаа чихийг нь огтлохыг тушаана. Үүнээс гадна: “Аллахаас заяасан эрхтнийг өөрчлөхийг (боолуудыг засч тайган болгох, тэднийг им тамгатай болгохыг) тушаана” гэв. Хэн Аллахын оронд чөтгөр шуламтай нөхөрлөвөл тэр өөрт нь илэрхий гай хөнөөл авчирна.
120. Чөтгөр шулам тэдэнд амлалт өгч, сэтгэлийн зовлонд унагаана. Тэднийг хууран мэхлэхийн тулд худал амлалт өгдөг.

121. Ийнхүү тэдний очих газар нь халуун там юм. Түүнээс ондоо нэг ч газрыг олохгүй.
122. Үнэн сүсэгтнүүд болон буян үйлдэгсэдийг Бид хаягаар нь ариун булаг урсах цэцэрлэгт хүрээлэн бүхий диваажинд оруулах бөгөөд тэд тэндээ үүрд орших болно. Аллахын амлалт үнэн. Аллахаас өөр үнэн үгтэн хэн байхсан билээ?
123. (Аяа, олон бурхан шүтэгч буруу номтнууд) Та нарын ба ариун судрын эзэдийн ч хоосон мөрөөдлөөр юу ч бүтэхгүй. Хэн нэгэн муу үйлс үйлдвэл түүнийхээ шийтгэлийг энэ ба хойд насанд өөрөө хүртэнэ. Тэр Аллахаас өөр ямар ч ивээн, туслагчийг үл олно.
124. Эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай төгс сүсэглэж, буянт үйл үйлдэх аваас диваажинд очино. Тэдэнд өчүүхэн ч шударга бус явдал үл тохионо.
125. Буянт үйл үйлдэж, өөрийгөө Аллахад зориулан, гэгээн элч Ибрахимийн авч ирсэн шашинд сүсэглэсэн хүнээс өөр хэн сайн сайхан байхсан билээ? Аллах Ибрахимыг анд нөхрөө болгон сонгосон!
126. Тэнгэр, газарт буй бүхэн Аллахад харьяалмуй. Аллах бүхнийг бүрэн дүүрэн мэддэг.
127. (Аяа, Мухаммед) Тэд чамаас эмэгтэйчүүдийн тухай шийдэл асууцгаана. Тэдэнд : “Эмэгтэйчүүдийн тухай Аллах та нарт шийдвэр өгнө.” хэмээн хэл. Та нар зохих хувь хишгийг (өвлүүлэх хөрөнгийн зохих хувь) нь өгөөгүй бас та нарын бусдад гэрлүүлэхгүйгээр өөрсдтэй нь гэрлэхийг хүссэн өнчин хүүхнүүдэд, сул дорой хүүхдүүд болон өнчин өрөөсөнгүүдэд шударгаар халамж үзүүлэх тухай та нарт уншигдаж буй Куран судрын айлдварууд ч үүнийг тайлбарлаж байна. Та нарын үйлдсэн буян бүхнийг Аллах зүй ёсоор нь мэддэг.
128. Хэрэв, эмэгтэй хүн эр нөхрийнхөө дургүйцэл ба сэтгэлгүйд санаа зовж, болгоомжилвол тэд хэл амаа ололцон амьдарвал нүгэл үл болно. Эв эе үнэхээр их буян болох билээ. Хардалт, харамлалт хүний заягдамал шинж. Хэрэв эхнэртэй халамжтай байж, бие биендээ сайн хандвал Аллах үйлдсэн бүхнийг чинь мэднэ.
129. Та нар хичнээн зүтгэсэн ч гэсэн эхнэрүүдийнхээ дунд бүхэлдээ шударга зөвшилцөлд хүрч эс чадна. Нэгэнд нь хамаг зүрх сэтгэлээ өгч, бусдыг нь албадан уяатай байлгасны адил анхааралгүй бүү орхигтун. Хэрэв харилцаагаа сайжруулж, анхаарал тавьбал Аллах үнэхүү уучлагч. нигүүлсэгч билээ.
130. Хэрэв тэд нэгэнт салах аваас Аллах уужим ухаанаар, нэг нэгнээс нь хамааралгүй болгоно. Аллахын хайр энэрэл, мэргэн ухаан аугаа болой.
131. Тэнгэр, газарт буй бүхэн Аллахад харьяалмуй. Бид, та нараас өмнө ариун судар хүртэгсэд болон та нарт ч : “Аллахаас айгтун” гэж гэрээсэлсэн билээ. Хэрэв та нар буруу номтон байсан ч тэнгэр, газарт

- буй бүхэн Аллахад харьяалагддаг. Аллах хязгааргүй баян, магтаалын эзэн байхад зохистой.
132. Тэнгэр, газарт буй бүхий л ахуй орчин Аллахад хамаарна. Түүнийг удирдан залахад Аллахын хүч хангалттай.
  133. Аяа, хүмүүс ээ! Аллах хүсвэл та нарыг үгүй хийж, оронд чинь бусад хүмүүсийг авчирна. Үүнийг хийхэд Аллахын хүч чадал төгс бөлгөө.
  134. Хэн хорвоогийн сайн сайхныг хүсвэл одоогийн ба хойд хорвоогийн буян хишиг нь Аллахын мэдэлд. Аллах бүхнийг сонсогч, бүхнийг урьдчилан харагч билээ.
  135. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахын төлөө гэрч болохдоо эцэг, эх, хамаатан садангуудын эрх ашигт хохиролтой байсан ч шударга ёсыг эрхэмлэгтүн. Гэрч хүсэгч баян, ядуу байх нь ялгаагүй, шударга байгтун. Аллах аль алинд нь хамгаас ойрхон тул тэдний байдлыг сайн мэднэ. Хүсэл сонорхолынхоо боол болж, шударга ёсыг бүү гажигтун. Хэл амаар хууран үглэсэн ч гэрчлэхээс татгалзсан ч Аллах хийсэн бүхнийг чинь мэднэ.
  136. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахад, Түүний элч нарт, тэдэнд илгээсэн ариун сударт итгэцгээгтун. Хэн Аллахад, Түүний мэлэкуүдэд, ариун судруудад, гэгээн элч нарт үл итгэж, ертөнцийн төгсгөлийн өдрийг үгүйсгэвэл үнэнхүү төөрөгдөлд орно.
  137. Эхлээд сүсэглэж дараа үгүйсгэгсэд, дараа нь дахин сүсэглэж дахин үгүйсгэгсэд болон өөрсдийн үгүйсгэл эсэргүүцлээ улам бүр лавшруулагсадыг Аллах эс өршөөх бөгөөд зөв замд ч эс оруулна.
  138. (Аяа, Мухаммед) Урвагч, хоёр нүүртэнгүүдэд хатуу цээрлэл байдгийг сануулагтун.
  139. Тэд сүсэглэгсэдийг орхичихоод үл сүсэглэгч буруу номтнуудтай нөхөрлөнө. Тэд буруу номтнуудаас хүндэтгэл, соёрхол горьдож явна уу? Үнэндээ, хүндэтгэл, нэр төр бол жинхэнэ утгаараа Аллахад харьялагдмуй.
  140. Аллах Өөрийн ариун судраар (Куранаар) үүнийг айлдсан : “Аллахын айлдваруудыг буруутган, тоохуурхаж буйг сонсвол, тэд өөр юм ярих хүртэл тэдэнтэй хамт бүү суугтун. Үгүй бол та нар ч тэдний багийг өмсөх болно. Аллах эргэлзээгүй хоёр нүүртэнгүүд хийгээд буруу номтнуудыг цуглуулан халуун тамд оруулах болно.
  141. Тэд (хоёр нүүртэнгүүд) та нарыг отож байдаг. Аллахын ивээлээр та нар ялбал : “Бид та нартай хамт байсан шүү дээ” гэнэ. Хэрэв та нар ялагдвал буруу номтнуудад хандан : “Бид та нарт туслан, мусулманчуудаас хамгаалсан шүү дээ” гэнэ. Аллах ертөнцийн төгсгөлийн өдөр бүхнийг шүүх бөгөөд үнэн сүсэгтнүүд хохирол амсахгүйн тулд Аллах буруу номтнуудад давуутай боломж олгохгүй.
  142. Хоёр нүүртэнгүүд Аллахыг хууран мэхлэхийг оролддог. Гэвч Аллах

- тэднийг хуурч (хариуг нь өгч), төөрөгдүүлдэг билээ. Тэд уншлага мөргөл үйлдэхдээ дүр эсгэн залхуурч, жинхэнэ сэтгэлээс биш (буян хүсэхгүй), Аллахыг тун бага дурсдаг.
143. Тэд сүсэгтэй, сүсэггүйн аль нь ч биш, хоёрын хооронд тээнэгэлзэгчид юм. Аллах төөрөгдүүлсэн хүнийг чи зөв шулуун замд оруулж эс чадна.
  144. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Үнэн сүсэгтнүүдийг орхичихоод буруу номтнуудтай бүү нөхөрлөгтүн. Өөрсдийгөө буруутгах баримтаа Аллахын өмнө дэлгэх гэсэн юм уу?
  145. Хоёр нүүртэнгүүд гарцаагүй халуун тамын ёроолд унана. Тэднийг аврах ямар ч туслагч та нар олохгүй.
  146. Харин нүглээ наминчлан, засарсан хүмүүс Аллах руу санаа нь эргэсэн, шашны хувьд Аллахад итгэн сүсэглэсэн үнэн сүсэглэгсэдтэй адил. Аллах үнэн сүсэглэгсэдэд даруй диваажин руу хандсан буян хишиг хайрламуй.
  147. Хэрэв бишрэн сүсэглэж Аллахын буян хишигт талархах аваас Аллах та нарыг юуны төлөө гэсгээн цээрлүүлэх билээ! Аллах талархан хүндэтгэгч, бүхнийг мэдэгч.
  148. Харгислал, шударга бусад өртсөн хүн л биш юм бол, Аллах муухай хашгирахыг, муу үг дэлгэхийг үл таалмуй. Аллах бүхнийг сонсч, мэдэж байдаг.
  149. Та нар сайн үйлийг илчлэх буюу нуух ахул эсвэл муухай явдлыг уучлах аваас Аллах үнэхээр өршөөгч, онцгой хүчтэй болой.
  150. Аллах болоод гэгээн элчүүдийг эсэргүүцэн, түүнийг бие биеэсээ холдуулах санаа өвөртлөгсөд, тэрчилэн гэгээн элчүүдийн заримд нь итгэж нөгөөд нь үл итгэж, завсарын замаар оролдогсод бий.
  151. Тэд бол жинхэнэ буруу номтон мөн. Бид үл сүсэглэгч буруу номтнуудын хувьд зовлонг гэсгээл бэлдсэн болой.
  152. Аллах болон гэгээн элчүүдэд итгэн мөн тэднийг (нэг нэгнээсээ ялган) холдуулахыг хүсдэггүй хүмүүс Аллахын ивээл хишиг хүртэнэ. Аллах машид ивээгч, бас энэрэгч билээ.
  153. (Аяа, Мухаммед) Ариун судар хүртэгсэд (Иудэйчүүд болон христчүүд) чамаас нэгэн судрыг тэнгэрээс буулгахыг хүсэцгээнэ. Үнэндээ тэд Мусагаас үүнээс илүү юм хүсэж: “Бидэнд Аллахыг ил тодоор харуулаад аль” хэмээн авирласан. Ийнхүү авирласны төлөө тэнгэр ниргэж, тэднийг бут цохисон юм. Улмаар тэдэнд яруу тод баталгаанууд ирээд байхад ч тугалыг бурханчлан шүтсэн. Бид үүнийг ч уучилсан. Мусад ил тод нотолгоо бүхий ер бусын гайхамшгийг өгөцгөөсөн билээ.
  154. Таурат судрын үзэл санааг хүлээж аваагүй тул тэднээс амлалт авахаар Тур уулыг толгойд нь тулгаж байгаад: “Мэхийн ёсолж энэхүү хаалгаар орцгоогтун” гэж хэлсэн. Мөн : “Бямба гарагт хэмээс бүү хэтрэгтүн.

- Бүү загасчлагтун” хэмээн сануулсан. Ийнхүү бид тэднээс хатуу андгай тангараг авсан болой.
155. Гэтэл тэд тангарагаасаа буцаж Аллахын айлдваруудыг эсэргүүцэж, гэгээн элчүүдийг хэлмэгдүүлэн егүүтгэж, гэгээн элч Мухаммедэд: “Бидний итгэл бишрэл хаагдсан” гэж хэлсэн учраас цээрлүүлэн, Аллах тэдний зүрхийг ч тамгалсан. Тийм болохоор тэдний цөөхөн нь сүсэглэцгээсэн.
  156. Мөн тэд Исаг (Есүсийг) үгүйсгэн, Мариямыг муухай гүтгэн гүжирдсэний төлөө ч цээрлүүлсэн.
  157. Мөн “Бид, Аллахын элч, Мариямын хүү Исаг алсан” гэж хэлсний учир хараал, цээрлэл үзүүлсэн. Үнэндээ тэд Исаг алж чадаагүй, цовдлоогүй, гагцхүү цовдолсон хүн Иса-тай адил харагдсан. Тэд Исагийн оронд өөр нэгнийг цовдолсон юм. Үнэндээ түүний тухай мэтгэлцсэн хэн боловч эргэлзээн дунд үлдсэн. Тэдний гарт энэ тухай ямар ч баталгаатай баримт байхгүй. Гагцхүү таамаг санаандаа хөтлөгдөж буй. Эргэлзээгүй, тэд Исаг алж чадаагүй билээ.
  158. Үгүй дээ, Аллах түүнийг Өөр рүүгээ өргөөд аваад явсан. Аллах ялгуулсан хүчтэй, аугаа мэргэн ухааны эзэн билээ.
  159. Ариун судар хүртэгсэд, бүр үхэжийн өмнө Исад итгэцгээсэн. Ертөнцийн төгсгөлийн өдөр (Исаг цовдолсон, тэр Аллахын хүү байсан гэж бурсны худал болохыг) Иса тэдэнд гэрч болох болно.
  160. Еврейчүүдийн харгислал хийгээд олон хүмүүнийг Аллахын зөв шулуун замаас хазайлгасны учир бид тэдэнд зөвшөөрөгдсөн олон сайн зүйлсийг хориглосон.
  161. Ийнхүү тэдэнд хориглосон атал тэднээс ашиг хонжоо (зээлийн хүү) авагсад, мөн хүмүүсийн мал хөрөнгийг шударга бусаар завшигчид, тэд нараас үгүйсгэгсэдийн төлөө Бид тэдэнд урьд өмнө халал (ариун) байсан зүйлийг харам (бузар) болгож, хатуу зовлонт цээрлэл бэлдсэн болой.
  162. Тэдний дотроос эрдэмтэд, үнэн сүсэглэгсэд, чамд болоод чиний өмнөх элчүүдэд илгээгдсэн сударт итгэдэг сүсэглэгсэд, уншлага мөргөлийг ёсчлон үйлдэгсэд, өглөг өргөн баригсад, Аллах болон хойд ертөнцөд итгэгсэдэд Бид аугаа их буян хишиг өгөх болно.
  163. (Аяа, Мухаммед) Бид Нухад болон түүнээс хойших гэгээн элч нарт ариун илгээлт хайрласан лугаа адил чамд ч мөн Ибрахим, Исмайл, Исхак, Яакуб болон тэдний үр садад, Иса, Аюб, Юнус, Хаарун, Сулейман нарт ч ариун илгээлт хайрласан. Бас Даудад ариун судар Забурыг хайрласан юм шүү.
  164. Мөн олон гэгээн элчүүдийг илгээсэн. Тэдний тухай мэдээллээс урьд өмнө чамд хэлсэн ба хэлээгүй зүйлүүд ч бий. Аллах Мусатай шууд ярилцсан билээ.

165. Аллахын өмнө хүмүүст шалтаг болгохгүйн тулд Бид итгэн бишрэгсэд гэгээн элч нарыг баяртай мэдээ дуулгагч болгон, эсэргүүцэгчдэд сэрэмжилүүлэгч болгон илгээлээ. Аллах ялгуулсан хүчирхэг, мэргэн ухааны эзэн.
166. Харин, Аллах чамд илгээсэн Куран судраар чиний гэгээн элч болохыг гэрчилсэн буй. Аллах (бусдын мэддэггүй) эрдэм мэдлэгээрээ Куран судрыг илгээсэн. Мэлэжүүд ч үүнийг гэрчилнэ. Бусад гэрч үгүй ч гэсэн Аллахын гэрчлэл хангалттай.
167. Өөрөө буруу номтон болчихоод бусдыг Аллахын замаас төөрүүлэгсэд өөрсдөө хол төөрч будилигсад мөн.
168. Үл сүсэглэн бузар харгислал үйлдэгсэдийг Аллах үл уучлах бөгөөд зөв шулуун замд эс оруулна.
169. Харин, тэднийг халуун тамд оруулах бөгөөд тэд тэндээ үүрд үлдэнэ. Энэ нь Аллахын хувьд тун амархан.
170. Аяа, хүмүүс ээ! Гэгээн элч Мухаммед та нарт Эзэнтнээс чин үнэнийг авч ирсэн. Тийм болохоор үнэн сүсэглэх нь та нарын хувьд илүү дээр. Үл сүсэглэх аваас Аллах та нараар дутахгүй. Тэнгэр болон газарт буй бүхэн Аллахад харьялагдмуй. Аллах аугаа мэдэгч, мэргэн ухааны эзэн.
171. Аяа, ариун судрын эзэд ээ! Шашныхаа хэм хэмжээнээс бүү хальцугай. Аллахтай холбоотой чин үнэнээс бусдыг бүү яригтун. Үнэндээ Мариямын хүү Иса Аллахын элч бөгөөд Аллагаас Мариямд зориулсан ганц үг ба Аллахын онцгой ид шид мөн. Аллах хийгээд Түүний гэгээн элч нарт итгэн сүсэглэгтүн. Иса, Мариям хоёртой хамт “Аллах гурвуулаа” гэж бүү хэлэгтүн. Ийнхүү, алдаагаа засаж, мухар сүсэгээс холдох нь та нарын хувьд буянтай хэрэг. Аллах цорын ганц бурхан. Тэр бээр үр хүүхдээс ангид. Тэнгэр, газарт буй бүхэн Түүнд харьяалмуй. Аллахын батлан хамгаалалт нь хангалттай.
172. Иса ч тэр, Аллахад ойрхон мэлэжүүд ч Түүний боол болхоос татгалздаггүй. Хэн Аллахад итгэн сүсэглэхээс татгалзан бие тоох юм бол ертөнцийн төгсгөлд Өөрийнхөө өмнө цуглуулан тооцоо хийх болно.
173. Харин сүсэглэн, буянт үйлсийн мөр хөөгсөдөд буян хишгийг харамлалгүй өгөх бөгөөд Өөрийн хайр энэрэлийг нэмэгдүүлнэ. Харин итгэн сүсэглэхээс татгалзан, их зан гаргагсадыг зовлонт гэсгээлээр цээрлүүлнэ. Тэдний хувьд Аллагаас өөр эзэн ч, ивээн туслагч ч эс олддоно.
174. Аяа, хүмүүс ээ! Та нарт Аллахын ивээлээр хүчирхэгжсэн Мухаммед шиг бат бөх нотолгоо ирлээ. Бид та нарт маш хурц гэрэл гэгээ болох Куран судрыг буулгалаа.
175. Харин Аллахад сүсэглэж, Куран сударт итгэгсэдийн хувьд тэднийг Аллах өгөөмөр энэрэл хайрдаа багтааж, шулуун замаар хөтлөн зална.

176. Аяа, Мухаммед! Тэд чамаас эцэг эхгүй, үр хүүхэдгүй өөд бологсодын өвлөлийн тухай асууна. Тэдэнд : “Аллах та нарт хамаатан садангийн тухай зөв шийд өгмүй. Хэрэв эцэг эхгүй, үр хүүхэдгүй нэгэн нас барах аваас тэр эгч буюу охин дүүтэй бол мал хөрөнгийн тэн хагас нь оногдоно. Хэрэв нас барсан хүн эмэгтэй байгаад үр хүүхэдгүй бол түүний төрсөн ах дүү нь (эрэгтэй) өв залгамжлагч болно. Хэрэв түүнд хоёр эгч буюу охин дүү байвал тэдэнд талийгаачийн үлдээсэн эд хөрөнгийн гуравны хоёр оногдоно. Бас өв залгамжлагчид нь нэг эрэгтэй, нэг эмэгтэй байвал эрэгтэйд нь хоёр эмэгтэйгийн хувь оногдоно. Аллах та нарыг үл төөрөгдүүлэхийн учир ийнхүү ухааруулан тайлбарлаж байна. Аллах бүхнийг зүй ёсоор нь мэдэгч билээ.

## 5. СУРЕ МАЙДА

Мадина-д илгээгдсэн. 120 айлдвар.

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Аяа сүсэгтнүүд минь ээ! Амлалтаа биелүүлэгтүн. Доор дурьдаж хориглосноос бусад ан амьтад (агнах, хоолойг нь хэрчин алж идэх нь) хүлээн зөвшөөрөгдсөн. Гэхдээ хаж мөргөлийн үед ихрамтай (хаж ёс гүйцэтгэчийн нөмрөг) байхад ан агнах нь ариун зөв зүйл гэж бүү бодогтун. Аллах аливааг хүссэнээрээ тушаана.
2. Аяа сүсэгтнүүд минь ээ! Аллахын хаж мөргөлийн дэг жаягт, хориот саруудад, өргөлд зориулсан тусгай тэмдэгтэй малд, Аллахын хайр энэрэл болон таалалыг хүсч ариун Кагдад ирэгсдэд хүндэтгэлгүй бүү хандагтун. Та нар ихрамаа тайлж, ердийн байдалд эргэж орсон хойно ан гөрөө хийж болно. Та нарыг Месжид Аль-Хараамд ороход саад болсон хүмүүсийн дайсагнал нь тэдэнтэй хэрээс хэтрэн маргалдах шалтгаан бүү болог. Сайн үйлс болон ариун журмыг сахихад тусалцаагтун. Нүгэлт болон дайсагнах явдалд бүү тусалцаагтун. Аллахаас айгтун, Аллахын цээрлэл үнэнхүү хатуу.
3. Та нарт: Үхсэн амьтны сэг, цус, гахайн мах, Аллахын алдраар цус гаргаагүй (хоолойгоо огтлохгүйгээр) алсан аливаа амьтны мах (харам) бузар. Үүний зэрэгцээ усанд унаж үхсэн, цохиж алсан, өндрөөс унаж үхсэн, мөргөлдөж үхсэн малын мах болон араатанд идүүлснээс үлдсэн сэг (харам) бузар. Харин амь нь тасалдаагүй байхад та нар өөрсдөө хоолойгийг нь огтлон алсан бол халалд (ариун буюу зөвшөөрөгдсөнд) тооцогдоно. Мөн зохиомол бурхадад зориулж нядалсан малын мах(харам) бузар. Мэргэ, төлгөний сумаар азаа үзэх нь хориотой. Энэ бүхэн нүгэл. Өнөөдөр буруу номгнууд та нарын шашны хувьд

- итгэл алдарсан. Тэднээс бүү эмээгтүн, Надаас айгтун. Эдүүгээ Би та нарын шашныг төгс болгож, та нарт зориулсан хувь хишгээ бүрэн гүйцэтгэв. Та нарт ислам шашныг таалан соёрхов. Хэрэв, хэн нэгэн өлсөж харангадахын эрхээр хориглосон хүнсийг идвэл нүгэл болохгүй. Аллах үнэнхүү нэн өршөөгч, машид нигүүлсэгч билээ.
4. Аяа, Мухаммед! Тэд чамаас өөрсдийнхөө төлөө юу халал буюу ариун хэмээн зөвшөөрөгдсөнийг асууцгаана: “Та нарт цэвэр ариун зүйлс зөвшөөрөгдсөн. Аллахын та нарт заасан ёсоор ан авд сургасан амьтадын (бүргэд, анчин нохой г.м) барьж өгснийг идэцгээ. Мөн тэднийг ан авд тавихдаа “(бисмилла) Аллахын алдраар эхэллээ” гэж хэлэгтүн. Аллагаас айгтун, Үнэндээ Аллах тооцоо бодохдоо үтэр түргэн” хэмээн тэдэнд хэлэгтүн.
  5. Өнөөдөр эдгээр цэвэр ариун бүхнийг та нарт зөвшөөрсөн. Түүнчлэн ариун судар хүртэгсэдийн (Иудэй ба христчүүдийн) цус гарган хоолойг огтлон төхөөрсөн малын мах нь та нарын хувьд ариун (халал)-д тооцогдоно. Сүсэглэгч та нарын хоол хүнс ч тэдэнд ариун. Үнэн сүсэгтнүүд ариун ёс суртахуунтай эмэгтэйчүүдтэй гэрлэвэл, түүнчлэн та нараас өмнө ариун судар хүлээн авагсдын ариун ёс суртахуунтай эмэгтэйчүүдтэй махэр буюу хувь хөрөнгийг нь өгч гэрлэвэл, мөн садар самуун явдалгүй эмэгтэйтэй гэрлэвэл, нууц амраг болохгүйгээр гэрлэвэл та нарын хувьд ариун (халал)-д тооцогдоно. Хэрэв, хэн нэгэн сүсэг бишрэлээсээ няцвал хамаг үйл хэрэг нь талаар өнгөрч, хойд ертөнцөд их хор уршиг амсана.
  6. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Уншлага мөргөл үйлдэхээр бол нүүрээ бүтнээр, гараа тохой хүртэл угаагтун. Толгойгоо норгож арчигтун. Хөлөө шагай хүртэл угаагтун. Жүнүб буюу биеийн цэвэр байдлыг алдсан бол (эр эмийн харьцаанд орсон бол) усанд орж бүх биеэ угаагтун. Харин, өвчтэй буюу аян замд яваа бол, эсвэл хүнд ба хөнгөнөөр бие засвал, эсвэл эхнэртэйгээ энгэр зөрүүлсэн үед ус олж чадахгүй байх аваас таяммум (нүүр, гараа хуурай элс буюу цэвэр шороогоор арчих) хийгтүн. Аллах та нарт төвөг учруулахыг хүсэхгүй. Гэвч наминчлан залбирч талархаг хэмээн та нарыг цэвэр ариун болгох үүднээс та нарт зориулах хувь хишгээ гүйцэд өгөхийг эрмэлздэг.
  7. Аллах та нарт хувь хишгээ хайрлахад: “Бид сонслоо, ёсоор даган мөрдлөө” хэмээн хатуу амлалт өгснөө санагтун. Аллагаас айгтун. Аллах үнэндээ та нарын сэтгэл зүрхэнд буй бүхнийг мэдэгч билээ.
  8. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахын төлөө шудрагаар гэрч бологтун. Аль нэгэн ард олонд сансан өс хонзон чинь шудрага зарчимаас гажиж болохгүй. Шудрага байгтун. Энэ нь үнэн сүсэглэл, саруул ухаанд ойр зүйл. Аллагаас айгтун. Аллах үнэндээ та нарын юу хийснийг бүрэн мэднэ.



9. Итгэн биширч, буянт сайн үйл үйлдэгсэдэд Аллах өршөөл, буян хишиг амалсан болой.
10. Буруу номтон болж, Бидний айлдваруудыг гүгүйсэгчид халуун тамынхан юм.
11. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахын та нарт хайрласан хувь хишгийг санагтун. Нэгэнтээ хэсэг хүмүүс та нарт нүгэлт гараараа халдахыг завдахад Аллах тэдэнд саад хийсэн. Аллахаас айгтун. Үнэн сүсэгтнүүд зөвхөн Аллахыг түшээрэй.
12. Үнэндээ Аллах Израйлын үр удмаас хатуу амлалт авсан билээ. Бид тэдний дундаас арван хоёр овог аймаг тус бүрийг төлөөлөх арван хоёр удирдагчийг сонгон авч явуулсан юм. Аллах тэдэнд : “Би та нартай хамт. Хэрэв, та нар уншлага мөргөлөө үйлдэн, өглөг өгч, миний элч нарт итгэж, тэднийг дэмжиж, Аллахын төлөө сайн санаагаар зээл тусламж үзүүлбэл нүглээс чинь хэлтрүүлж, хаяагаар нь булаг урссан цэцэрлэгт хүрээлэн бүхий диваажинд оруулах болно. Хэрэв хэн нэгэн эсэргүүцэл үзүүлбэл тэр зөв шулуун замаас төөрөгдөх болно” гэж хэлсэн.
13. Тэд амлалтаасаа няцсаны учир Бид тэднийг хараалаар ниргэж, чулуун зүрхтэй болголоо. Тэд Тауратын үгийг өөрчилж, өөрсдөд нь илгээгдсэн ухуулга суртлыг мартагчаасан юм. Тэдний цөөхнөөс бусад нь урван тэрсэлж буйг чи байнга мэдэрнэ. Тийм байсан ч чи тэднийг (хэрэв нүглээ наминчлан сүсэглэвэл) уужим сэтгэл гарган уучил. Аллах сайн үйл бүтээгсэдийг хайрламуу.
14. Өөрсдийгөө “Бид Христчууд” хэмээгсдээс ч хатуу амлалт авсан билээ. Тэд Инжилд (Бибил)-д илгээгдсэн суртал ухуулгын заримыг мартсан. Тиймээс Бид ертөнцийн төгсгөл хүртэл тэдний хооронд дайсагнал ба өс хонзонг оруулсан. Аллах тэдний үйлдсэн хэргийг хэлж өгөх болно.
15. Аяа, ариун судар эзэмшигчэд ээ! Та нарын ариун судраас (Инжил болон Таурат) нуусан зүйлүүдийн ихэнхийг ил тод тайлбарлах, та нарын нуусаны ихэнхийг уучилах Бидний элч ирлээ. Үнэндээ та нарт Аллахаас нэгэн гэгээн гэрэл (Мухаммед), хүндтэй судар (Куран) ирсэн болой.
16. Аллах өөрөөсөө таалал нигүүсэл хүссэн хүмүүсийг энэ судраар дамжуулан аврал, энх амгалангийн зам руу хөтөлнө. Мөн Өөрийн эрх мэдлээр харанхуйгаас гэрэл гэгээнд гаргаж, зөв шулуун замд оруулдаг.
17. Мариямын хүү Иса-г (Есүсийг) Аллахтай адилтгахад үнэхээр буруу номтон болсон. Тэдэнд: “Хэрэв Аллах, Мариямын хүү Иса-г, түүний эхийг, цаашилбал газар дээрх амьд бүхнийг үгүй хийхийг хүсвэл Аллахыг хэн хорьж чадахсан билээ!” гэж хэлэгтүн. Тэнгэр, газрын, тэдний завсарын бүхий л зүйл Аллахад харьяалагдмуу. Аллах хүссэн бүхнээ бүтээдэг, Түүний хүч чадал бүх зүйлд хүрэлцээтэй.

18. Иудэйчүүд болон Христчүүд : “Бид Аллахын хөвгүүд, Түүний хайр ивээлд багтагсад” гэж хэлцгээдэг. Тэдэнд : “Тийм юм бол Аллах юуны төлөө та нарыг нүглийнхээ хэрээр гэсгээдэг вэ? Үнэндээ, та нар Аллахын бүтээсэн хүмүүс шүү дээ” гэж хэл. Аллах хүссэн хүнээ өршөөж, хүссэн хүнээ гэсгээдэг. Тэнгэр, газар хийгээд тэдгээрийн хооронд буй бүхэн Аллахад харьяалагдмуй. Эцсийн эцэст та нарын очих газар Аллахын өмнө юм шүү.
19. Аяа, ариун судар эзэмшигчид ээ! Гэгээн элч нарын цуваа тасрах үеэр та нарт Бидний элч хүрэлцэн ирлээ. Та нараар : “Бидэнд баярт мэдээ дуулгагч, айлган сүрдүүлэгч ирээгүй” гэж хэлүүлэхгүйн тулд “Баярт мэдээ дуулгагч, бас айлган сүрдүүлэгч” гэгээн элч (Мухаммедийг) явууллаа. Аллахын хүч чадал бүхий л зүйлд хүрэлцээтэй.
20. Нэгэнтээ Муса өөрийнхөө зон олондоо: “Аяа, олон түмэн минь ээ! Аллахын та нарт хайрласан хувь хишгийг санагтун. Та нарын дундаас элч нарыг дэвшүүлэн, мөн та нарын дундаас эрх мэдэлтэй хаан гаргаж ирлээ. Орчлон ертөнцөд хэнд ч хайрлаж байгаагүй (тэнгэсийн дээгүүр зам гаргах, үүлийг сүүдэрлэх, тэнгэрээс хоол хүнс илгээх зэрэг) хувь хишгийг та нарт хайрласан” гэв.
21. Мөн : “Аяа, олон түмэн минь ээ! Аллахын та нарт хүлээн зөвшөөрсөн ариун газарт (Кудүс бас Шам) орогтун, бас бүү эргэж буцагтун. Үгүй бол та нар хохирол амсагацын нэг нь болно” гэж хэлсэн.
22. Тэд хариуд нь : “Аяа, Муса! Тэнд хүчирхэг нэг үндэстэн бий. Тэд гараад явах хүртэл бид тийшээ хэзээ ч орохгүй. Хэрэв, тэд тэндээс гараад явбал эргэлзээгүй бид орох болно” гэж хэлцгээсэн.
23. Тэдний дотроос Аллагаас айдаг, Аллахын ивээл хайрыг хүртсэн хоёр хүн тэдэнд хандаж : “Хотын хаалгаар орогтун. Хаалгаар оронгуут гарцаагүй ялалтанд хүрнэ. Хэрэв, та нар үнэн сүсэгтэн бол Аллахад л итгэгтүн” гэв.
24. Аяа, Муса! “Тэд тэнд байгаа цагт бид тийшээ хэзээ ч орохгүй. Чи Эзэнтэнтэйгээ хамт хоёулаа очиж байлдагтун. Бид энд хүлэээнж л байя” гэв.
25. Муса : “Аяа, Эзэнтэн минь ээ! Би өөрийгөө болон ахан дүүсээс бусдыг захирч чадахгүй нь. Энэ эвдэрсэн олноос намайг салгаж аль” хэмээн учирлав.
26. Аллах : “Тэднийг тэрхүү хосгүй сайхан газарт очихыг дөчин жилийн хугацаагаар хориглов. Тэд эзгүй талд төөрөлдөн тэнүүчилж яваг. Эвдэрсэн олны төлөө бүү санаа зовогтун” гэж хэлсэн.
27. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Адамын хоёр хүүгийн (Абил, Кабил) явдлыг үнэнээр нь уншиж өг” гэв. Абил, Кабил хоёулаа Аллахын таалалд нийцэхийн тулд өргөл барьсан аж. Аллах Абилын өргөлийг хүлээж аваад нөгөөгийнхийг нь эс хүлээн авчээ. Өргөл нь хүлээж авагдаагүй

- Кабил нь : “Би чамайг заавал ална” гэв. Абил : “Аллах, чин үнэнээр сүсэглэгсэдийн өргөлийг л хүлээн зөвшөөрдөг билээ,
28. Чи намайг алахаар гар далайвал, би чамайг алах гэж гар далайхгүй. Би бол ертөнцсийн Эзэн Аллахаас л айдаг” гэж хариулав.
  29. Абил: “Чамайг миний болон өөрийн нүглийг давхар үүрээд, халуун тамд ороосой гэж хүсдэг. Энэ бол зальхай дарангуйлагчдад оногдох хувь хишиг” гэв.
  30. Кабилын хүсэл тачаал ахан дүүсээ алахад түүнийг түлхлээ. Ийнхүү тэр дүүгээ хөнөөж зовон тарчилагч боллоо.
  31. Аллах түүнд дүүгийнхээ цогцосыг хэрхэн оршуулахыг заах хон хэрээг илгээв. Хон хэрээ хошуугаараа газар тоншиж ухлаа. Кабил үүнийг харсны дараа: “Ээ халаг минь! Дүүгийнхээ цогцосыг далдлахын тулд хон хэрээгийн дайтай болж чадахгүй ч гэж дээ” гэж харамсав. Тэр ийнхүү гэмшигсэдийн эгнээнд орсон юм.
  32. (Кабилын Абицыг хөнөөсөн сургамжаар) Израйлын үр саад Бид: “Хэн нэгэн танхай балмад хэрэг үйлдээгүй, бусдыг хэлмэгдүүлэн алаагүй, тийм үнэнч хүний аминд хүрвэл бүх хүн төрлөхтнийг алсантай адил. Харин хэн нэгэн бусдын амийг аврах аваас бүх хүн төрлөхтнийг аварсантай адил” хэмээн зарлиг буулгасан. Бидний гэгээн элч тэдэнд үнэнхүү яруу тод баримтуудтайгаа ирсэн билээ. Гэсэн ч тэдний олонхи нь (биеэ тоон, хүн алж) хэт даварцаасан.
  33. Аллах болон Түүний гэгээн элчийн эсрэг дайсагнагсадын, мөн газар дэлхий дээр үймээн самуун дэгдээгсдийн гэгсгээл бол : цаазлан хороох, загалмай дээр цовдлох, хөл гарыг нь зөрүүлэн цавчих, газар орноосоо хөөх зэргийн аль нэг нь байх болно. Энэ нь тэдний хувьд амьдын там бөгөөд хойд ертөнцөд түүнээс ч хатуу гэсгээн цээрлүүлэх шийтгэл хүлээнэ.
  34. Энэхүү зарлиг буулгахаас өмнө нүглээ наминчлагсад энд үл хамаарна. Аллахыг нэн өршөөгч бөгөөд машинд нигүүлсэгч хэмээн мэдтүгэй.
  35. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Хүсэл зорилгоо гүйцэлдүүлнэ гэвэл Аллахаас айгтун. Түүнд ойртох замыг хайгтун. Мөн энэ хорвоо болон хойд ертөнцөд авралыг олохоор Түүний төлөө тэмцэгтүн.
  36. Газар дэлхий дээр байгаа бүхэн бас түүн дээр нэмээд тэр хэмжээний юм буруу номтнуудын мэдэлд байсан ч тэрхүү бүхнийг хойд насны нүгэл хилэнц, гэсгээл цээрлэлээс аврагдахын тулд төлөөс болгон өгсөн ч хүлээн зөвшөөрөгдөхгүй. Тэд хатуу цээрлэл үзэх болно.
  37. Тэд халуун тамаас гарахыг мөрөөднө. Гэвч гарч чадахгүй. Тэд мөнхийн зовлон гэсгээл үзнэ.
  38. Эр, эм хулгайчийн гэмт хэргийн хариу шийтгэл болгон гарыг нь тас цавчигтун. Энэ бол Аллахын зүгээс илгээгдсэн сургамж бөлгөө. Аллах аугаа бөгөөд мэргэн ухааны эзэн.

39. Хэн (хулгай хийж) гэмт хэрэг үйлдсэний нүгэлээ наминчлан засарвал Аллах түүний гэмшилийг хүлээн авна. Аллах нэн өршөөгч бөгөөд машинд нигүүлсэгч билээ.
40. Үнэндээ тэнгэр, газрыг эзэгнэн эрхшээх нь Аллахын харьяалалд буй. Аллах таалснаа өршөөж, эс таалснаа гэгсгээдэг. Үүнийг та нар мэдэхгүй гэж үү? Аллахын хүч чадал бүх зүйлд хүрнэ.
41. Аяа, гэгээн элч минь ээ! Аман дээр: “Бид итгэн сүсэглэсэн” хэмээгээд, зүрх сэтгэлээрээ үл сүсэглэгсэд болон Иудэйчүүдийн дотроос үл сүсэглэн, биеэ тоохын төлөө яардаг хүмүүст бүү гутрагтун. Тэд ямагт худал хуурмагт итгэцгээн, чам руу хандаагүй хүмүүсийн үгийг сонсоцгоодог. Дараа нь (тэдний сонсож буй хүмүүс) ариун судрын үгийг өөрчилж, утгыг нь гуйвуулдаг. Тэд : “Хэрэв та нарт зарлиг өгөгдвөл хүлээн авагтун, хэрэв өгөгдөхгүй бол тагталзагтун!” гэцгээдэг. (Аяа, Мухаммед) Аллах хэн нэгний сэтгэлийг хувиргахыг хүсвэл, чи юу ч хийж чадахгүй. Аллах тэдний зүрх сэтгэлийг ариусгахыг хүсээгүй болгоо. Тэд энэ насандаа зовж зүдрэн, хойд насандаа хатуу цэрлэл үзнэ.
42. Тэд худал хуурмагт итгэж, бузарыг (харам)–ыг иддэг хүмүүс. (Аяа, Мухаммед) Хэрэв тэд чиний өмнө маргалдан ирвэл тэдний маргааныг шийдсэн ч, эс тоосон ч ялгаагүй. Нүүр өгөхгүй байсан ч болно. Хэрэв, нүүр эс өгсөн ч тэд чамд хор хүргэж эс чадна. Харин, тэдний маргааныг шүүвэл чин шударгыг эрхэмлэгтүн. Аллах үнэндээ шударга ёсыг эрхэмлэгсэдийг таална.
43. Тэдний гарт Аллахын зарлиг бичигдсэн ариун судар Таурат байсаар байтал (тэд түүнийг зөвшөөрдөггүй атал) яагаад чамаар шүүлгэхээр ирдэг билээ. Харин дараа ч чиний гаргасан шийдвэрийг эсэргүүцэн нүүр буруулан явцгаана. Учир нь тэд (Таурат болон Куранд ч) итгэдэггүй хүмүүс шүү дээ.
44. Бид дотор нь зөв зам болон гэрэл гэгээг тусгасан ариун судар Тауратыг илгээсэн. Аллахад төгс сүсэглэсэн гэгээн элчүүд түүнд түшиглэн Иудэйчүүдийн дунд шийдвэр гаргадаг. Мөн Аллахын ариун судрыг хамгаалах хариуцлагаа ухамсарласан Израйлийн эрдэмтэд, гэгээн ухаантнууд Тауратыг үндэс болгон шийдвэр гаргадаг. Тэд Тауратыг өөрчилөхөөс сэргийлэн хамгаалахад хяналт тавьдаг. Үүнийг чин үнэн хэмээн гэрчилдэг. Тиймээс (Аяа, Израйлийн гэгээн ухаантнууд аа!) Хүмүүсээс бүү айгтун. Харин Надаас эмээгтүн. Миний айлдваруудыг өчүүхэн үнээр бүү худалдагтун. Хэн Аллахын айлдварын дагуу эс шүүвэл буруу номтон болно.
45. Тэдэнд (Израйлийн үр саад) зориулан Тауратыг илгээхдээ: “амийг амиар, нүдийг нүдээр, хамрыг хамраар, чихийг чихээр, шүдийг шүдээр, шархыг шархаар хариу тооцоо хийх зарлиг болгосон. Харин, хэн өшөө авахаас тагталзан өршөөвөл өөрийнх нь нүгэл өршөөгдөх болно.

- Аллахын илгээсэн айлдваруудын дагуу хэрэг шүүгээгүй хүн өөрөө зальхай, шударга бусын эзэн болно.
46. Бид тэдний (гэгээн элчүүдийн мөрөөр) араас нь өмнө илгээгдсэн ариун судар Тауратыг баталгаажуулагч Мариямын хүү Иса-г (Есүсийг) илгээсэн. Түүнд зөв замыг заагч, шударга ёс, гэрэл гэгээ болсон, өмнөх ариун судар Тауратыг баталгаажуулагч, үнэнч сүсэгтнүүдийн хувьд зөв зам болон сургамж болох ариун судар Инжилийг илгээсэн болой.
  47. Ариун Инжилийн эзэд, Аллахаын түүнд айлдсан зарлигийн дагуу шийдвэр гаргаг. Аллахаын илгээсэн айлдваруудын дагуу шийдвэр үл гаргагсад танхай балмадууд юм.
  48. (Аяа, Мухаммед) Бид чамд урьд нь илгээгдсэн ариун судруудыг бататгагч, түүнийг хамгаалагч, жинхэнэ судар Кураныг илгээсэн юм. Чи тэдний дунд Аллахаын чамд илгээсэн Кураны айлдварын дагуу шийдвэр гарга. Чамд ирсэн үнэнийг гажуудуулж тэдний хүсэл тачаалд бүү автагтун. Зон олон минь ээ! Та нарын тус бүрт янз бүрийн эрх зүйн хэм хэмжээ, зам мөрийг зааж өгсөн. Хэрэв, Аллах таалсан бол та бүхнийг нэг л сул ард түмэн болгох байсан. Гэхдээ та нарт олгосон хэм хэмжээ, зам мөрүүдэд та нарыг сорихын тулд янз бүрийн зон олон болгосон. Тиймээс буянтай үйлсийн төлөө яар. Та нар бүгдээрээ эцэст нь Аллахаын өмнө очих болно. Аллах та нарын маргалдсан зүйлийн үнэн худалыг мэдэгдэх болно.
  49. Тэдний (Иудэй болон христчүүдийн) хоорондын явдлыг чамд илгээсэн Кураны айлдварын дагуу шүүгтүн. Тэдний хүсэл тачаалд бүү автагтун. Мөн чамайг, Аллахаын илгээсэн зарим айлдваруудаас самууруулж төөрөгдүүлэхээс болгоомжлогтун. Хэрэв тэд Аллахаын илгээсэн айлдваруудаас нүүр буруулах аваас Аллах тэднийг зарим нэг нүгэлд зохицсон цээрлэл хүлээлгэнэ. Үнэндээ хүмүүсийн нэлээд нь танхайран төөрөгсөд мөн.
  50. Эсвэл тэд харанхуй бүдүүлэг үеийн зарлиг шийдвэрүүдийг хүсээд байгаа юм уу? Аллахаад жинхэнэ сүсэглэсэн ард түмэнд Аллахаас илүү үнэн шударга шүүгч хэн байх билээ?
  51. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Еврэйчүүд болон Христчүүдтэй бүү нөхөрлөгтүн. Тэд бие биетэйгээ анд нөхөр. Та нарын хэн нэгэн тэдэнтэй нөхөрлөвөл тэднийх болно. Үнэндээ Аллах урван тэрслэгч ард түмнийг гайтуулна.
  52. Зүрх сэтгэл нь гажигтай хоёр нүүртнүүд: “Цаг хугацаа өөрчилөгдвөл ямар нэгэн гай дайрахаас бид айж байна” хэмээн тэдэнтэй (урван тэрслэгчидтэй) сүл бэлдэх оролдлого хийж буйг чи харах болно. Аллах (гэгээн элч болон мусулманчуудад) тун удахгүй нэгэн ялалт заяана эсвэл Өөрийн зүгээс нэг зарлиг илгээнэ. Тэгэхүүд тэд зүрх сэтгэлдээ нууж явсан юмныхаа (буруу номтнуудтай нөхөрлөсөнийхээ) төлөө гэмших болно.

53. Харин үнэн сүсэглэгсэд : “Та нартай хамт байх болно гэж Аллахын алдрыг барьж хатуу тангараг өгөгсөд үнэхээр эд нар юм уу?” гэж асууна. Ингэхлээр тэдний (хоёр нүртнүүдийн) бүхий л үйлс талаар болж, өөрийн толгойдоо гай барцад хураагч болно.
54. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нарын дотроос хэн өөрийн шашнаас урвах аваас Аллах тэдний оронд Өөрөө таалах, тэд ч Аллахыг таалдаг тийм хүмүүсийг өөрөөр хэлбэл үнэн сүсэгтнүүдэд энэрэнгүй, буруу номтнуудад хатуу, Аллахын төлөө тэмцэдэг, гүтгэн гүжирдэгсдийн шүүлтээс зүрхшээдэггүй, тийм түмнийг авчирах болно. Энэ бол Аллахын хайр энэрэл бөгөөд Аллах таалсан хүнд түүнийг хүртээмүй. Учир нь Аллах уужим, бүхнийг мэдэгч билээ.
55. Үнэндээ та нарын үнэнч анд гэвэл Аллах, Түүний гэгээн элч, чин сэтгэлээр уншлага мөргөлөө үйлддэг, өглөг өгдөг, зохих ёсоор мэхийн наминчилдаг сүсэгтнүүд мөн болой.
56. Хэн Аллах, Түүний гэгээн элч болон мусулманчуудыг анд нөхөр болговол Аллахыг дэмжигсэд (Аллахын тал өөрөөр хэлбэл Түүний чин үнэн шашных) бөгөөд тэд ялалтанд хүрэх болно.
57. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нараас өмнө судар илгээгдсэн хүмүүсийн (Иудэй болон христчүүдийн) дотроос та нарын шашныг доромжлон тоглоом тохуу болгогсод болон буруу номнуудтай бүү нөхөрлөгтүн. Та нар үнэн сүсэгтнүүд мөн бол Аллахаас айгтун.
58. Та нар уншлага мөргөлд дуудах үед тэд уншлага мөргөл болон та нарыг доромжлон, тоглоом тохуу болгоно. Учир нь тэд ухааран ойлгодоггүй хүмүүс.
59. (Аяа, Мухаммед) тэдэнд : “Аяа, ариун судрын эзэд ээ! Аллахад болон Аллахаас бидэнд илгээсэн сударт, бас өмнөх гэгээн элч нарт илгээгдсэн сударуудад сүсэглэсний төлөө биднийг шүүмжлэх гэж үү? Үнэндээ та нарын ихэнх нь танхайрагсад мөн” хэмээн хэлээрэй.
60. Мөн тэдэнд : “Аллахаас та нарт зориулсан хатуу цээрлэлийн тухай хэлж өгөх үү? Аллахыг хилэгнүүлж, хараалыг нь хүртэгсэдийг Аллах дотроос нь сармагчин, гахай болгон хувиргаж, чөтгөр шулам шүтэгсэд болгоно. Тэдний байх газар нь машид муухай. Тэд зөв замаас төөрч, тэнүүлчлэн одно” хэмээн хэлээрэй.
61. Та нар хоёр нүүртнүүдтэй учрах мөчид тэд: “Бид наминчлан сүсэглэсэн” гэж худал хэлцгээдэг. Хэрэг дээр үл тоомсорлон орж ирээд, үл тоомсорлосоор гараад явчихдаг. Аллах тэдний нуусан бүхнийг (муу санааг) сайн мэддэг.
62. Чи буруу номтнуудын олонхи нь нүгэл үйлдэх, дайсагнах, бузар юмыг идэх эрмэлзлэлийг харах болно. Тэдний үйлдэлүүд нь юутай муухай юм гээч?
63. Тэдний гэгээн сэтгэгчид болон эрдэмтэд нь тэдний худал хэлэхийг,

- бузар юм идэхийг нь яагаад хориглодоггүй юм вэ? Тэдний араншин, юутай муухай юм бэ!
64. Иудэйчүүд : “Аллах гарцаагүй харамч” гэж хэлсэний төлөө тэдний гар хүлэгдэж, хараал идэг! Эсрэгээр, Аллахын хүчирхэг гар (хүч чадал) нь өгөөмөр, хүссэнийг өгдөг. Аллагаас чамд илгээсэн Куран, тэдний олонхийн төөрөгдөл, үл тоомсорлолыг улам гааруулна. Бид тэдний дунд ертөнцийн төгсгөл хүртэл үргэлжлэх дайсагнал, өш хонзонг шургууллаа. Тэд хэзээ нэгэн цагт дайны гал асаавал Аллах түүнийг унтраах болно. Тэд газар дэлхий дээр дур зоргоор танхайрана. Аллах танхайрагчдыг үл таална.
  65. Хэрэв ариун судрын эзэд наминчлан итгэж, үнэнчээр сүсэглэвэл Бид тэдний нүглийг өршөөж, буян хишиг дүүрэн диваажинд оруулахсан билээ.
  66. Хэрэв тэд Таурат, Инжил болон Эзэнтнээс илгээсэн бусад судар, айлдваруудын дагуу үйл хэрэг явуулсан бол эргэлзээгүй тэд өөрсдийнхөө дээрээс ч (модны жимс) доороос ч (газрын үр жимс, жимсгэнэ) бэлээхэн хүртэх байсан юм. Тэдний дунд (хойш, урагш холбирдоггүй) тогтвортой хэсэг хүмүүс бий. Гэвч тэдний олонхийн хийдэг үйлдлүүд нь их л муухай байдаг.
  67. Аяа, гэгээн элч минь ээ! Эзэнтнээс чамд илгээсэн бүхий л зааврыг тэдэнд дамжуул. Хэрэв, чи дамжуулахгүй юм бол гэгээн элчийн үүргийг эс гүйцэтгэсэн болно. Аллах чамайг хүмүүсийн хорлолоос хамгаалах болно. Аллах үнэндээ буруу номтнуудыг зөв замаар хөтлөхгүй.
  68. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Аяа, ариун судрын эзэд ээ! Та нар Таурат, Инжил болон та нарт Эзэнтнээс илгээсэн Куран судрын дагуу үйлдэл хийхгүйгээр үнэн сүсэгтэнд тооцогдохгүй” хэмээн хэл. Эзэнтнээс чамд илгээсэн Куран судар, тэдний олонхийн муухай үйлдэл болон үл тоомсорлолыг улам нэмэгдүүлдэг. Чи ийм хүмүүсийн төлөө бүү гутараарай.
  69. Сүсэглэгсэд, Иудэйчүүд, Сабийчүүд, Христчүүдээс хэн нэгэн Аллахад болон ертөнцийн төгсгөлийн өдөрт итгэж, сайн үйлс үйлдэх аваас тэдэнд айх аюул, гунигт явдал үгүй болой. (Иудэйчүүд, Сабийчүүд, Христчүүд нарт илгээгдсэн судруудад ч ийн айлдсан буй)
  70. Бид Израйлийн үр садаас хатуу амлалт авч, тэдэнд элчүүдээ илгээсэн билээ. Гэгээн элч нар тэдний сэтгэлд үл нийцэх айлдвар авчирвал тэд гэгээн элч нарын заримыг нь үгүйсгэн, заримыг нь егүүтгэсэн юм.
  71. Тэд (Еврейчүүд) гэгээн элчүүдийг егүүтгэснээр ямар ч гай түтгэр эс тохионо гэж бодоцгоож, сохор, дүлий болцгоодог. Дараа нь нүглээ наминчлан Аллах тэдний гэмшлийг хүлээн авсан. Үүний дараа ч тэдний олонхи нь сохор, дүлий хэвээр байв. Аллах тэдний хийсэн бүхнийг харж байсан юм.

72. Мариямын хүү Иса-г (Есүсийг) : “Аллах” хэмээсэн хүмүүс жинхэнэ буруу номтон. Иса тэдэнд : “Аяа, Израйлийн үр сад аа! Миний болон та нарын эзэн болсон Аллахад мөргөгтүн. Хэн нэгэн Аллахаыг бусадтай эн зэрэгцүүлэн, Аллахаас бусдыг бурхан хэмээн илтгэвэл түүнд диваажинг үл зөвшөөрөх бөгөөд түүний очих газар нь халуун там байх болно. Зальхай этгээдүүдэд туслагч үгүй” гэж хэлсэн.
73. Аллахаыг, “гурван бурханы нэг нь” гэдэг хүмүүс жинхэнэ буруу номтон болсон билээ. Үнэндээ Аллахаас өөр бурхан үгүй. Хэрэв тэд хэлсэнээсээ буцахгүй бол тэдний буруу номтнууд нь энэ ба хойд насанд хатуу цэрлэл үзнэ.
74. Өдий хүртэл тэд Аллахад наминчлан залбираагүй гэж үү дээ? Аллахаас уучлал эрхгүй үү? Аллах нүглээ наминчлан сүсэглэгсдэд нэн өршөөлтэй, машид энэрэлтэй.
75. Мариямын хүү Иса нэг л гэгээн элч. Түүнээс өмнө ч олон гэгээн элч нар ирээд өнгөрсөн. Исагийн эх нь чин үнэнч эмэгтэй. Тэд хоёулаа ч бусдын адил хоол иддэг хүн бөгөөд бурхан биш. (Аяа, Мухаммед) Бид тэдэнд айлдваруудыг яаж яруу тод тайлбарлахыг харагтун. Дараа нь тэдний хэрхэн нүүр буруулж зөрүүдэлснийг үз.
76. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Та нарт ашиг болон хор учруулж эс чадах Аллахаас өөр юманд мөргөх гэж үү?” хэмээн хэл. Аллах бүхнийг сонсогч, мэдэгч билээ.
77. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Аяа, ариун судрын эзэд ээ! Та нар шашныхаа хэм хэмжээнээс бүү давагтун. Урьд өмнө төөрөлдсөн, бусдыг ч төөрөгдүүлсэн, зөв замаас зайлсхийсэн олны хүсэл тачаалд бүү хөтлөгдөгтүн” хэмээн хэл.
78. Израйлийн үр садаас буруу номтон бологсодод, Давуд болон Мариямын хүү Исагийн хэлээр, өөрөөр хэлвэл Забур болон Инжил сударт хараал өгөгдсөн юм. Энэ нь тэдний эсэргүүцснээс, хэмээс хэтэрснээс л үүдсэн юм.
79. Тэд өөрсдөө үйлдсэн нүглээс бие биеэ хориглосонгүй. Тэдний хийсэн үйлдлүүд нь асар муухай!
80. Чи тэдний (Израйлийн үр садын) олонхи буруу номтнуудтай нөхөрлөснийг харах болно. Тэдний өөрсдийнхөө төлөө урьдаас (хойд ертөнцийн төлөө) бэлтгэсэн үйлс нь асар их муу байв. Гиймээс Аллахаыг хилэгнүүлэн, ийнхүү үүрдийн гэсгээл дотор үлдэв.
81. Хэрэв тэд Аллахад, гэгээн элчид, тэдэнд илгээсэн Куран сударт итгэсэн бол буруу номтнуудтай нөхөрлөхгүй байсан. Гэвч тэдний олонхи нь муу санаагангууд.
82. Аяа, Мухаммед! Чи Иудэйчүүд болон эн зэрэгцүүлэгчдийг үнэн сүсэгтнүүдийн өштөн дайсан болохыг харах болно. Бас : “Бид Христчүүд” гэгсэдийн дотроос үнэн сүсэгтнүүдийн хамгийн дотны



- нөхөр нь болохыг ч гарцаагүй ажиглана. Энэ нь христчүүдийн дунд ухаант лам, гэлэн гэцэлүүд байсантай, тэд биеэ тоодоггүйтэй холбоотой юм.
83. Тэд гэгээн элчид илгээсэн Куран судрыг сонссон үед чин үнэнийг таньж мэдээд, нүдээр нь нулимс мэлтэлэхийг чи харах болно. Тэд : “Аяа, Эзэнтэн минь! Бид наминчлан сүсэглэлээ. Биднийг үнэний гэрч болгогсодын эгнээнд багтааж үз” гэнэ.
  84. “Яагаад бид Аллахад болон бидэнд ирсэн чин үнэнд үл сүсэглэцгээх билээ? Харин ч Эзэнтэн биднийг шударга олонтой хамт диваажинд оруулахыг хүсч байна” гэнэ.
  85. Ийнхүү ярьсаных нь төлөө Аллах тэдэнд хаяагаар нь ариун булаг урссан диваажингаар шагнах бөгөөд тэд тэндээ үүрд оршмуй. Энэ бол сайн үйлс үйлдэгсэдийн шагнал бөлгөө.
  86. Буруу номтон, Бидний айлдваруудыг худал хуурмаг хэмээн үгүйсгэгчид халуун тамынхан мөн.
  87. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахын та нарт халал (цэвэр ариун) хэмээн зөвшөөрсөн зүйлсийг хараам (бузар) хэмээн тооцож хэмээс бүү хэтрэгтүн. Аллах үнэндээ хэрээс хэтэрсэн хүмүүсийг үл таална.
  88. Аллах та нарт хувь хишиг болгосны цэвэр ариунаас нь хүртэгтүн. Ийнхүү өөрсдөө итгэж сүсэглэсэн Аллахаас айгтун.
  89. Аллах та нарын болгоомжгүйгээс хэлсэн андгай тангарагын төлөө хариуцлага тооцохгүй. Харин мэдсээр байж амлалтаасаа буцвал хариуцлага тооцдог. Түүний төлөөс нь гэрийнхэндээ зориулсан дунд зэргийн хоол хүнсээр арван үгээгүй ядууг нэг удаа хооллуулах, эсвэл тэдэнд нэг ээлжийн хувцас олгох, үгүй бол нэг боол (эсвэл шивэгчин)-г эрх чөлөөтэй болгох явдал болой. Үүнийг хийх боломжгүй хүн гурван өдөр мацаг барих хэрэгтэй. Энэ нь та нарын андгай тангарагаасаа няцсаны хариу юм. Иймээс, андгай тангарагаа сахигтун. Аллах та нарын наминчлалын төлөө айлдваруудаа ийнхүү тайлбарлаж баймуй. Магад та нар талархах биз.
  90. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Архи, мөрийтэй тоглоом, хуурамч чулуун барималыг бурханчлан шүтэх, мэргэ төлгө зэрэг жигшүүртэй араншин нь чөтгөр шуламын үйлс юм. Хүсэл зорилгодоо хүрье гэвэл үүнээс хол байгтун. Магад та нар авралыг олж мэдэх биз.
  91. Чөтгөр шулам л архи, мөрийтэй тоглоомоор та нарын дунд дайсагнал, өш хонзонг шургуулж, та нарын Аллахыг санан дурсахад, уншлага мөргөл үйлдэхэд чинь саад болохыг хүсдэг. Та нар цаашдаа ч үүнийгээ зогсоохгүй юу?
  92. Аллах болон гэгээн элчид итгэн дагагтун. Тэднийг эсэргүүцэхээс болгоомжлогтун. Хэрэв, итгэн дагахаас татгалзвал Манай гэгээн элч чин үнэнийг ил тодоор уламжлах үүрэгтэйг мэдэгтүн.

93. Бишрэн сүсэглэж, сайн үйл үйлдэгсэд, Аллахаас айцгааж, итгэл үнэмшилдээ тогтвортой байгсад, сайн үйлс үйлдэж түүнийг үргэлжлүүлэгсэд, Аллахаас айж болгоомжилж итгэл үнэмшилээсээ салж хагацалгүй явагсадыг, дахин Аллахаас айцгааж сайн үйлс үйлдэгсэд урьд өмнө идсэн зүйлүүдийнхээ төлөө нүгэл эс хурна. Аллах сайн үйл үйлдэгсэдийг хайрладаг.
94. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллах хэн нэгнийг Өөрийг нь харалгүйгээр айсан эсэхийг мэдэхийн тулд : Ихрам (хаж ёсны) хувцастайгаар хоёр гараар, эсвэл жадаар амархан агнаж болох ан аваар шалгадаг. Хэн үүний дараа уг хэм хэмжээг зөрчвөл (ихрамтай байж ан агнавал) хатуу цээрлэл үзнэ.
95. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нар Ихрам хувцастай байхдаа ан гөрөө бүү хийгтүн. Амьтны амийг бүү таслагтун. Та нарын хэн нэгэн зориудаар амьтныг алвал хариуцлагыг нь өөрөө хүлээх бөгөөд түүний шийтгэл нь тэр хэмжээний мал байх болно. Та нарын дотроос шударга хоёр нь энэ шийтгэлийн төлөө нэрлэгдсэн малыг Кагбагийн дэргэд нядлан, өглөг өгнө. Эсвэл ядуучуудыг хооллуулах, үгүй бол дүйцэхүйц хоногийн мацаг барих хэрэгтэй. Энэ нь үйлдсэн хэргийн шийтгэл юм. Ингэсэнээр Аллах нүглийг уучилна. Уг хэргийг давтан үйлдсэн хүнийг Аллах цээрлүүлэх болно. Аллах аугаа бөгөөд нүгэлтнийг гэсгээн шийтгэгч билээ.
96. Та нарт болон аян замд явагсадад далай тэнгисээс ан хийх, бас түүнийг идэх нь хориотой биш. Харин ихрам хувцастай хаж ёс гүйцэтгэх үед хуурай газрын ан авлах нь хориотой. Аллахаас айгтун. Хойд насандаа Түүний өмнө зовох болно.
97. Аллах хүндэтгэлтэй орон байр болох Кагбаг, хаж ёсны сарыг, өргөлийн малыг, түүний хүзүүнд зүүсэн тэмдэгүүдийг хүмүүсийн амьд яваа болон хойд насны баталгаа болгосон. Энэ нь Аллахын газар, тэнгэрт буй бүхнийг эргэлзээгүй мэддэг, бүхнийг мэдэгч болохыг та нарт ухааруулж буй хэрэг бөлгө.
98. Мэдэцгээгтүн! Аллахын цээрлэл хатуу ч гэсэн Аллах машид өршөөгч, онцгой нигүүлсэгч билээ.
99. Гэгээн элчийн үүрэг бол гагцхүү Аллахын айлдваруудыг уламжлах явдал юм. Аллах бол та нарын ил, далд үйлс бүхнийг мэддэг.
100. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Бузар муухай юмны их байгаа нь чамайг гайхшруулсан ч бузар ба цэвэр ариун хоёр адилхан биш. Аяа, оюун ухааны эзэд ээ! Хэрэв зорьсондоо хүрье гэвэл Аллахаас айгтун, магад аврагдаж мэдэх юм” хэмээн хэл.
101. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нарт мэдэгдсэн хойноо харамсал төрүүлэх юмны тухай бүү асуугтун. Хэрэв Куран судрын айлдварууд илгээгдэх үеэр асуувал та нарт тодорхой мэдэгдэх байсан. Өмнөх асуултуудын

- төлөө Аллах та нарыг өршөөсөн. Аллах машид өршөөгч, машид уужим. (нүгэлтнийг цээрлүүлэхэд яарахгүй)
102. Та нараас өмнө нэгэн зон олон ийнхүү асуугаад буруу номтон болсон.
103. Аллах Бахира, Саяба, Уасила, Хам нарыг товлон бүрдүүлээгүй. Гэтэл буруу номтнууд Аллахыг гүжирдэн гүтгэдэг, тэдний олонхи нь үүнийг гүтгэлэг болохыг ухаардаггүй.
104. Тэдэнд: “Аллахын илгээсэн Куран сударт, гэгээн элчийн хэлсэн үгэнд итгэгтүн” гэж хэлэхэд, тэд : “Өвөг дээдсийн маань шашин бидэнд хангалттай” гэж хариулна. Тэдний өвөг дээдэс нь юу ч ухаараагүй, зөв замыг баримтлаагүй байсан ч тэдний шашныг баримтлах гэж үү?
105. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Өөрсдөө нүглээс ангид байгтун. Өөрсдөө зөв замаар явбал төөрөлдөгсөд та нарт хор уршиг тарьж чадахгүй. Хожим бүгд Аллахын өмнө очих болно. Аллах та нарын хийсэн үйл бүхнийг хэлж өгөх болно.
106. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нарын хэн нэгэн нас барахын өмнө захиас үг хэлвэл, та нарын дотроос хоёр шударга хүн гэрч бологтун. Хэрэв, та нар харийн нутагт аян замд явж байхад үхэлтэй нүүр тулгарвал өөр (гарал үүсэл,шашин нь ондоо байж болно) хоёр хүнийг гэрч болгогтун. Харин та нарт эргэлзээ төрвөл тэр хоёр гэрчийг уншлага мөргөлийн дараа аваад үлдэгтүн. Тэд : “Бидний ойр дотныхон байсан ч андгай тангарагаа мөнгөөр арилжахгүй. Аллахын төлөө гэрчлэлээ нуухгүй. Хэрэв түүнийг нуувал уул шугмандаа нүгэлтэн болно” хэмээн Аллахын нэр барьж андгай тангараг өргөдөг.
107. Хэрэв, тэр хоёулаа гэрчилж, өвлөлд хор хүргэж нүгэл үйлдсэн нь илэрвэл өвлөх эрхтэй хүнээс, мөн гэрээслэгчийн ойр дотны хүмүүсээс хоёр хүнийг тэдний оронд сонгож, тэр хоёроос: “Бидний гэрчлэл түрүүчийн хоёрынхоос илүү үнэн, бид хэм хэмжээнээс хэтрээгүй. Хэрэв, түрүүчийн хоёр гэрчийн адил болох аваас зальхай этгээдэд тооцогдох болно” гэсэн андгай тангарагыг Аллахын нэрээр барьж өргөдөг.
108. Энэ нь гэрчлэлийг шаардлагын хэмжээг хангахад, эсвэл андгай тангараг өгсний дараа саад бэрхшээл учрахаас болгоомжилоход илүүтэй тус болох арга юм. Аллагаас айгтун, Аллах муу санаатай хүмүүсийг зөв замаар хөтлөхгүй.
109. Ертөнцийн төгсгөлийн өдөр Аллах гэгээн элч нараа цуглуулж : “Зон олноо сүсэг бишрэлд уриалахдаа ямар хариу авцгаасан вэ?” гэж асууна. Гэгээн элч нар нь : “Бид ямар ч юм мэдэхгүй шүү дээ, аливаа далдыг зөвхөн чи л мэддэг шүү дээ” гэж хариу өгцгөөнө.
110. Тэр үед Аллах : “Аяа, Мариямын хүү Иса! Чамд болон эхэд чинь өгсөн буян хишгийг минь санагтун. Тэр үед Би чамайг Жабрейл мэлчээр (элчээрээ) дамжуулан хамгаалсан юм. Чи өлгийтэй байхдаа

- ч (гэгээн элч болж), өсөж дунд зэргийн насандаа ч хүмүүст хандан ярьдаг байсан. Тэгэхэд чамд ариун судрыг, мэргэн ухааныг, Таурат болон Инжилийг зааж сургасан. Тэгээд Миний зарлигаар шавраар шувуу дүрсэлж, түүнийгээ үлээхүйд миний тааллаар амилан ниссэн билээ. Мөн миний зарлигаар төрөлхийн сохор, уяман өвчтнийг эмчлэн анагаасан. Миний зарлигаар үхсэнийг амилуулж чадсан билээ. Энэхүү мөчид Иудэйчүүд чам руу дайрахаас сэргийлсэн юм. Харин чи тэдэнд илэрхий нотолгоотой ирэхэд, тэрдний дотроос чамайг үгүйсгэгсэд : “Энэ бол харваас илбэ” гэж хэлцгээхэд Би чамайг хамгаалсан юм” гэв.
111. Тэр үед Би Хавари нарт : “Надад болон Миний элчид сүсэглэгтүн” гэж айлдвар буулгасан. Тэд : “Бид сүсэглэлээ, Чи бидний үнэн сүсэгтэн болсныг гэрчлэгтүн” гэж хэлцгээсэн.
112. Хавари нар : “Аяа Мариямын хүү Иса! Чиний Эзэнтэн бидэнд зориулж тэнгэрээс хүндэтгэлийн зоог буулгаж чадах уу?” гэв. Хариуд нь (Иса) : “Хэрэв та нар үнэн сүсэгтэнгүүд бол Аллагаас айгтун” хэмээн сануулсан.
113. Хаваричүүд : “Бид түүнээс чинь идэхийг хүсэж байна. Тэрбээр бидний сэтгэл тайвшираг. Чи үнэн өгүүлсэн эсэхийг мэдэж, чиний гэгээн элч болохыг нүдээрээ харсан гэрчүүд болцгооё” гэв.
114. Мариямын хүү Иса : “Аяа, Эзэнтэн Аллах минь ээ! Бидэнд зориулж тэнгэрээс хүндэтгэлийн зоог буулгаж хайрла, энэ нь урьд хойчийнхны хувьд баяр хөөр буюу бидэнд ер бусын сургамж болон үлдэг. Бидэнд буян хишгээ хайрлагтун, Чи бол хамгийн өгөөмөр буянтан билээ” гэж гуйв.
115. Аллах : “Эргэлзээгүй, Би та нарт тэнгэрээс хүндэтгэлийн зоогийг илгээх болно. Үүний дараа та нарын дотроос хэн нэгэн эсэргүүцвэл түүнийг хорвоод хэнийг ч гэсгээж байгаагүй хатуу гэсгээлээр цээрлүүлэх болно” хэмээн хариулав.
116. Тэгээд Аллах : “Аяа, Мариямын хүү Иса! Чи хүмүүст: “Аллахаас ондоо намайг болон ээжийг минь бурхан хэмээн үзэгтүн” гэж хэлсэн юм уу?” гэв. (Иса) : “Аяа, Аллах минь! Чиний тухай надад ямар ч эргэлзээ байдаггүй. Чамайг шагшин магтмуй. Би хэлэх эрхгүй зүйлийг хэзээ ч ярихгүй. Хэрэв би үүнийг хэлсэн бол Чи эргэлзээгүй мэдэхсэн билээ. Түүгээр ч үл барам миний зүрх сэтгэлийг Чи нэвт мэддэг. Харин, би Чинийхийг (мэдэгдээгүй зүйлээ) мэдэхгүй билээ. Далдыг мэдэгч гагцхүү чи л шүү дээ” гэж хэлсэн.
117. Би тэдэнд зөвхөн Чиний тушаасаныг л хэлсэн : “Аллахад сүсэглэгтүн, Тэр бол миний болон та нарын Эзэнтэн” гэхээс өөр юм хэлээгүй. Би тэдний дунд байхдаа байдлыг ажиглаж байлаа. Тэгээд Чи намайг Өөр рүүгээ аваачсаныхаа дараа тэднийг ажиглагч нь зөвхөн чи л байлаа шүү дээ. Чи бүхнийг зүй ёсоор нь харагч билээ”.

118. Тэднийг цээрлүүлэх, уучлахын аль нь ч Чиний бүрэн эрх билээ. Чи аугаа ялагч, мэргэн ухааны эзэн шүү дээ.”
119. Аллах : “Өнөөдөр (ертөнцийн төгсгөлийн өдөр) үнэнч хүмүүсийн хувьд үнэний мөрөөр явсанахаа ач тусыг үзэх өдөр мөн. Тэд хаягаар нь ариун булаг урсдаг диваажинд очих бөгөөд тэндээ үүрд оршино. Аллах тэднийг таалах бөгөөд тэд ч Аллахыг таална. Энэ бол аугаа их аврал билээ” гэв.
120. Тэнгэр болон газрыг, тэнд буй бүхий л ахуй байдлыг Аллах эрхшээнэ. Тэр бүхнийг эрхшээх хүч чадалтай.

## 6.СУРЕ АНГАМ

Мекке-д илгээгдсэн. 165 айлдвар.

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Тэнгэр, газрыг бүтээж, гэрэл харанхуйг бий болгосон Аллахыг магтах нь зохистой. Гэтэл буруу номтнууд бусдыг Эзэнтэнтэйгээ эн зэрэгцүүлсээр л байна.
2. Аллах та нарыг (та нарын дээдэс Адамыг) шавраар бүтээж, дараа нь хүний амьд ахуйн цаг хугацааг тодорхойлсон. Мөн энэ ертөнцийн төгсгөлийн цаг хугацаа ч Түүний мэдэлд болой. Гэтэл та нар үхсэний дараа амилахад ч эргэлздэг!
3. Тэнгэрт ч, газарт ч зөвхөн Аллах. (Гагц Түүнийг наминчлан залбирах ёстой). Аллах та нарын ил далд бүхнийг, та нарын үйлдэх сайн муу үйлдэл бүхнийг мэдэж байдаг.
4. Буруу номтнууд Эзэнтнээс ямар нэгэн айлдвар ирсэн ч үндсээрээ татгалздаг.
5. Тэдэнд илгээгдсэн чин үнэнийг ч (Кураныг) худал гэж үзсэн. Тиймээс доромжлон, тоглоом тохуу хийсэн зүйлийн хариу (цээрлэл) удахгүй нүүрлэх болно.
6. Өөрсдөөс нь өмнөх үеийнхнээс хичнээн хүнийг Бид хөнөөж үгүй болгосныг тэд хараагүй гэж үү? Бид газар дэлхий дээр та нарт олгоогүй боломжыг тэдэнд олгосон билээ. Бид тэдний төлөө тэнгэрээс хур буулгаж, хөл доороос нь гол ус гарган урсгасан юмдаг. Хожим үйлдсэн нүгэлийнх нь төлөө бусниулан, оронд нь өөр үндэстнийг бүтээсэн юм.
7. (Аяа, Мухаммед!) Хэрэв Бид чамд тэдний хүссэнчлэн цаасан дээр бичигдсэн нэгэн судрыг илгээвэл тэд түүнийг гараараа бариад үзсэн ч: “Энэ бол илэрхий илбэ” хэмээн үл итгэнэ.
8. Тэд : “Яагаад гэгээн элч Мухаммедэд тэнгэрээс нэгэн элч (мэлэк) эс

- илгээнэ вэ?!” гэж асууна. Хэрэв, Бид түүнд мэлэк илгээвэл тэдний хэрэг шийдэгдэж тэдэнд нүд ирмэх ч боломж үл олдох байсан юм.
9. Бид гэгээн элчийг мэлэк болгон илгээвэл түүнийг хүн төрхтэй болгож тэднийг илүү ихээр эргэлзээнд оруулах байлаа.
  10. (Аяа, Мухаммед!) Чамаас өмнө илгээгдсэн гэгээн элчүүд ч доромжлогдсон. Доромжлогсодын тоглоом тохуу нь тэдний өөрсдийн толгойд гай болсон билээ.
  11. Тэдэнд : “Та нар дэвэн дэлхийг хэсч, (гэгээн элчүүдийг) худалч хэмээгсэдийн сүүлчийнх нь хэрхэн төгссөнийг харагтун” гэж хэл.
  12. Тэднээс : “Газар, тэнгэрт буй бүхэн хэний харьяалалд вэ?” хэмээн асууж, тэдэнд : “Аллахынх” гэж хариул. Тэрбээр өршөөл нигүүлсэлийг өөрийнхөө хувь болгон авсан. Эргэлзээгүй тохиох ертөнцийн төгсгөлийн өдөр та нарыг цуглуулна. Харин, өөрөө өөртөө хор уршиг таригсад үл сүсэглэнэ.
  13. Өдөр, шөнөөр оршигч бүхэн Аллахад харьяалмуй. Аллах бүхнийг сонсогч, мэдэгч билээ.
  14. Тэднээс : “Тэнгэр, газрыг бүтээгч, буян хишиг хайрладаг, бусдаас буян хишиг хүсдэггүй Аллагаас өөр хүнтэй нөхөрлөх гэж үү?” хэмээн асуугтун. Мөн тэдэнд : “Би Аллахад итгэн бишрэгсэдийн хамгийн эхнийх нь байхаар тушаагдсан. Хэрхэвч олон бурхан шүтэгсэдийн эгнээнд бүү орогтун” гэж хэл.
  15. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Хэрэв, би Эзэнтнээ эсэргүүцвэл аугаа өдрийн цээрлэлээс айж байна” хэмээн хэл.
  16. Тэр өдөр хэн гэгсгээлээс хэлтэрнэ, Аллах түүнд өршөөл хайрласан нь тэр. Энэ нь жинхэнэ ялалт аврал юм.
  17. Хэрвээ Аллах чамд ямар нэгэн уй гашуу учруулах аваас түүнийг Аллагаас өөр хэн ч зайлуулж эс чадна. Харин Аллах чамд ямар нэгэн сайн үйл илгээвэл хэн ч саад хийж чадахгүй. Аллахын хүч чадал бүхий л юманд хүрэлцээтэй.
  18. Тэр боолуудаа захирах үнэмлэхүй эрх мэдэлтэн. Тэрбээр мэргэн ухаанаар үйл хэргээ гүйцэлдүүлж, бүхнийг мэдэж байдаг.
  19. (Аяа, Мухаммед) “Гэрч болох үүднээс хамгийн том зүйл юу вэ?” гэж тэднээс асуугтун. “Та бидний хооронд (Миний гэгээн элч эсэхэд) Аллах гэрч болно. Энэ Куран нь та нарт, мөн Куран илгээгдсэн хүмүүст сануулга болгохын тулд надад илгээгдлээ. (Хөөе, хоёр нүүртнүүд ээ!) Та нар Аллагаас гадна, түүнтэй эн тэнцүү бурхад байгааг гэрчилж чадах юм уу? Би ч гэрчилж чадахгүй! Аллах цорын ганц бурхан. Би та нарын Аллахтай зүйрлэсэн юмнаас ангид шүү!” хэмээн хэлэгтүн.
  20. Биднээс ариун судар хүртэгсэд (Иудэй болон христчүүд) Мухаммедыг өөрсдийн хүүгийн адил андахгүй танина. Харин өөрөө өөртөө уршиг таригсад Мухаммедын гэгээн элч эсэхэд итгэдэггүй.

21. Аллахыг худал гүжирдэн гүтгэгчид болон Түүний айлдваруудыг үгүйсгэгчдээс илүү зальхай этгээд байна гэж үү? Тийм зальхай этгээдүүдэд ямар ч аврал үгүй.
22. Ертөнцийн төгсгөлийн өдөр Бид тооцоо хийхээр тэдний бүгдийг цуглуулж, Аллахтай бусдыг эн тэнцүүлэгсэдэд: “Та нарын зохиож олоод байсан бусад бурхад чинь хаана байна?” гэж асуух болно.
23. Тэд мэдэн будилж: “Аллахын алдарыг барьж танграглая. Бид өөр бурхан байдаг гэж хэлээгүй шүү дээ” гэж булзааруулна.
24. Тэд өөрсдийнхөө тухай хэрхэн худал хэлж байгааг харж байна уу? Тэдний гараар бүтээсэн зохиомол бурхад нь тэднийг орхин арилах болно.
25. (Аяа, Мухаммед) Тэдний дунд чамайг сонсох хэсэг ч буй. Гэвч (Кураныг) эс ойлгуулах үүднээс Бид тэдний сэтгэлийн мэлмийг сохор болгож, чихийг нь бөглөчихсөн. Тэд бүхий л ер бусын гайхамшигийг харлаа ч түүнд итгэхгүй. Бүр буруу номтнуудын өмнө чамтай мэтгэлцэн маргахдаа: “Энэ нь (Куран) эртний домог төдий л зүйл” гэж хэлцгээнэ.
26. Тэд бусдыг (куран судраас) зөв замаас холдуулахыг оролдон, өөрсдөө ч түүнээс хол зугтаагаана. Ийнхүү өөрсдийгөө өөрсдөө баллаж, үүнийгээ өөрсдөө ч ухаарах чадваргүй болно.
27. Тэдний халуун тамын ирмэг дээр зогсох үеийн царайг харвал: “Харамсалтай юм. Амьд ертөнцөд буцаад очихсон. Тэгвэл Эзэнтнийхээ айлдваруудыг үл үгүйсгэн, түүнд итгэн сүсэглэгсэдийн эгнээнд орохсон” гэж дуу алдаж буйг чи сонсох болно.
28. Үгүй ээ, тэдний өмнө нь сэтгэл дотроо нууж байсан зүйлс нь илэрчихлээ. Тэд амьдын энэ ертөнцөд буцаж ирсэн ч хориглосон зүйлсийг давтан үйлдэнэ. Учир нь тэд угаасаа худалч хүмүүс.
29. Тэд: “Гагцхүү, энэ хорвоогийн амьдралаас өөр амьдрал үгүй, бид дахин хэзээ ч амилахгүй” гэж хэлцгээдэг.
30. (Аяа, Мухаммед) Тэдний Эзэнтний өмнө зогсож буй царайг чи харсансан бол ч! Аллах тэдэнд: “Энэ нь (үхсэнээс хойш амилах нь) үнэн биш гэж үү?” хэмээн асууна. Тэд: “Тиймээ, үнэн юм байна. Эзэнтний алдарыг барьж танграглая” гэж дуу алдаагаана. Аллах тэдэнд: “Үл сүсэглэн, эсэргүүцэнийхээ цээрлэлийг амсагтун” гэнэ.
31. Аллахын өмнө очихийг худал хэмээгсэд - үнэндээ зовлон амсагсад. Ертөнцийн төгсгөл гэнэт тохиоход: “Ээ, чааваас! Амьд ахуйдаа хэнэггүй байсныхаа төлөө харамсаж байна” гэлцэнэ. Тэд ийнхүү нүглээ нуруундаа үүрэх болно. Анхаарагтун! Тэдний нуруундаа үүрсэн нүгэл нь юутай муухай юм бэ!
32. Амьд ахуй цагийн амьдрал нь хуурамч бөгөөд зугаа цэнгэл төдий зүйл. Үнэн сүсэгтнүүдийн хувьд хойд ертөнцийн амгалан илүү дээр. Та нар ойлгохгүй байна гэж үү?

33. Тэдний хэл амнаас болж чамайг гунигт автахыг Бид мэднэ. Гэхдээ чиний гэгээн элч эсэхийг үгүйсгээгүй. (дотроос мэдэж байсан ч биеэ тоосноос болж эсэргүүцэнэ) Ер нь зальхай этгээдүүд л Алладын айлдваруудыг үгүйсгэдэг юм шүү дээ.
34. Чамаас өмнөх гэгээн элчүүдийг ч худалч хэмээн үгүйсгэсэн юм. Тэд (гэгээн элчид) үгүйсгэгдсэндээ, хавчигдан зүдэрсэндээ сэтгэлээр унахгүйгээр Биднээс тусламж иртэл тэвчээртэй байж чадсан юм. Алладын үгийг хэн ч өөрчилж чадахгүй. Үнэндээ, чамд ч гэгээн элчүүдийн тухай үнэн мэдээлэл илгээгдсэн билээ.
35. Тэдний нүүр буруулах нь чамд хэцүү байвал газар дээр нуугдах ангал, тэнгэрт гарах шат олж, ер бусын гайхамшигийг харуулаад аль? Үгүй бол тэвчээртэй байж үз! Хэрэв, Аллах хүсвэл тэднийг зөв зам руу оруулах л байсан. Тиймээс, чи Алладын ивээлийг ойлгодоггүй хүмүүсийн тоонд бүү ор.
36. Анхаарал тавьж сонсогчид л чиний уриалгыг хүлээн авна. (Чиний үгийг үл тоомсорлогчид үхдэлийн адил) Үхдэлүүдийг Аллах дахин амилуулдаг. Дараа нь тэд Алладын өмнө ирцгээнэ.
37. Тэд (Меккегийн буруу номтнууд): “Эзэнтнээс чинь яагаад ер бусын гайхамшигийг бидэнд илгээдэггүй юм вэ?” гэж асууна. (Аяа, Мухаммед) Чи тэдэнд : “Ер бусын гайхамшиг хайрлахад Алладын хүч чадал нь хүрнэ” гэж хэл. Гэвч тэдний олонхи нь үл мэддэг.
38. Газар дэлхий дээрх жигүүртэн шувууд, цахилж яваа ан амьтад бүхэн та нарын адилхан амьд амьтад. Бид тэр бүхний хувь тавиланг орхигдуулалгүй Лаухил-Махфуз буюу хувь тавилангийн дэвтэрт бүрэн бичсэн. Эцэст нь тэд бүгд Эзэнтнийхээ өмнө хуран цугларч, сөгдөх болно.
39. Бидний айлдваруудыг үгүйсгэгдсэн үнэнийг сонсох чадваргүй дүлий, үнэнийг хэлэх чадваргүй хэлгүйчүүд. Тэд гүн харанхуйд үлдэгсэд. Аллах хүссэн хүнээ төөрөгдүүлж, таалсан хүнээ зөв замаар хөтлөнө.
40. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Та нар үнэнч юм бол хэлээд аль? Хэрэв та нарт Алладын гэсгээл, эсвэл ертөнцийн төгсгөлийн өдөр тулгарвал Аллахаас өөр хэнд залбирдаг юм вэ?” хэмээн хэлэгтүн.
41. Тиймээ, Та нар зөвхөн Аллахт залбирах болно. Та нарын ангижрахыг хүссэн аюулаас Аллах хүсвэл ангижруулна. Та нар ч тэднийг (Аллахад эн зэрэгцүүлсэн юмнуудаа) маргах болно.
42. Үнэндээ, Бид чамаас өмнөх зон олонд ч гэгээн элчүүдийг илгээсэн. (Тэд гэгээн элчүүдийг хүлээн зөвшөөрөөгүй юм.) Тэгээд Бид тэднийг үнэн сүсэглэгч болгохын тулд үгүйрэл, тарчиг амьдралаар шийтгэсэн юм.
43. Бид тэднийг шийтгэж шалгах үед яагаад наминчлан залбираагүй юм вэ? Учир нь тэдний зүрх сэтгэл мөс мэт хөлдсөн, чөтгөр шулам тэдний аш авирыг өөртөө зохиомжтой болгон харуулсан.



44. Тэдэнд илгээсэн ухуулга суртлыг мартсан үед нь Бид тэднийг сорих үүднээс бүхий л зүйлсийн үүдийг цэлийтэл нээж өгсөн. Тэдэнд зориулагдсан хувь хишигт баярлан ташаарч цэнгэхэд нь Бид тэднийг гэнэт цээрлүүлэв. Тэд ийнхүү итгэл алдан цөхрөн унав.
45. Ийнхүү, зальхай этгээдүүдийн үндэс нь таслагдав. Бүхий л сайшаал ертөнцийн эзэн Аллахынх юм.
46. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Хэрэв Аллах та нарын сонсох, харах мэдэрхүйг чинь устган, зүрх сэтгэлийн чинь гэрэл гэгээг хааж орхивол түүнийг Аллагаас өөр ямар бурхад хэвийн болгох билээ?” гэж хэлэгтүн. Бид айлдваруудаа хэрхэн тайлбарлаж ухааруулахыг харагтун. Гэвч тэд нүүрээ буруулцгаадаг.
47. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Та нарт Аллахын цээрлэл илэрхий байдлаар хүрээд ирвэл зальхай хүмүүсээс өөр хэн хөнөөл амсах вэ?” гэж хэл.
48. Бид гэгээн элчүүдийг буян ивээлээр баярлуулахыг, зовлонгоос сэргийлүүлэгч болгон илгээсэн. Наминчлан сүсэглэж, буянтай үйлс бүтээгсэдийн хувьд айдас хүйдэс, уйтгар гуниг үгүй болой.
49. Бидний айлдваруудыг үгүйсгэгсэд буруутай хэрэг үйлдсэний цээрлэлийг амсах болно.
50. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Би та нарт, Аллахын буян хишиг надад буй гэж хэлэхгүй. Мөн далдын нууцыг ч мэдэхгүй, өөрийгөө мэлэк (тэнгэрийн элч) гэж хэлэхгүй. Би гагцхүү Аллахын илгээсэн бүхнийг дагаж мөрдөнө” хэмээн хэлэгтүн. Нүдтэй, нүдгүй хоёр адилхан гэж үү? Та нар ухаараагүй гэж үү?
51. Эзэнтнийхээ өмнө очихоос айхсадыг сэрэмжлэхийн тулд түүгээр (Куранаар) дамжуулан анхааруулга өг. Тэдний хувьд Аллагаас өөр анд ч, ивээн тэтгэгч ч үгүй болой. Тиймээс тэд сэрэмжтэй байх нь зүйтэй.
52. (Аяа, Мухаммед) Аллахын таалалыг хүсэн, эрт-орой Аллахт итгэн сүсэглэгсэдийг хажуугаасаа бүү хөөгтүн! Тэдний өмнөөс чи юуг ч эс хариуцмуй, тэд ч чиний өмнөөс юуг ч эс хариуцмуй. Тийм болхоор чи тэднийг хөөх аваас зальхай этгээдийн эгнээнд багтах болно.
53. Үүний дараа Бид: “Бидний дундаас Аллахын хайр энэрэл болон сайн сайхныг хүртэгсэд эд мөн үү?” хэмээн хэлүүлэх үүднээс тэднийг сорьсон. (Тухайлбал, ядуучуудыг наминчлуулан, чинээлэг баячуудыг бас шалгасан) Аллах наминчлагсадыг илүү сайн мэддэг шүү дээ?
54. Бидний айлдваруудад итгэгсэд чам дээр ирэхэд тэдэнд : “Саламун алэйкум (амар байна уу?)” гэж мэндлэн, “Эзэнтэн чинь энэрэл нигүүлсэлийг өөртөө үүрэг болгон хүлээсэн. Та нараас хэн нэг нь мэдэлгүйгээр нүгэл үйлдээд дараа нь гэмшиж, сүсэглэн засвал Аллах түүнийг уучлан өршөөнө” хэмээн хэл.
55. Нүгэлтнүүдийн замыг тодорхой болгохын тулд айлдваруудаа Бид яруу тод тайлбарлаж байна.

56. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Аллахыг хойш нь тавьчихаад бусдад мөргөж буйг харж залхлаа. Та нарын хүсэл тачаалыг би зөвшөөрөхгүй. Хэрэв зөвшөөрөн дагах аваас төөрөлдөж, зөв зам олоогүй нэг нь болж хувирна” гэж хэлэгтүн.
57. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Би Эзэнтнээс ирсэн яруу тод баталгаануудад (Куранд) тулгуурлана. Харин та нар түүнийг худал гэлцдэг. Та нарын яаравчлан хүсэж буй гэсгээл надад байхгүй. Эрх мэдэл бүхэн Аллахаынх. Аллахаын зарлиг чин үнэн. Аллах хамгийн шударга шийдвэр гаргагч” хэмээн хэлээрэй.
58. Мөн тэдэнд : “Та нарын яаравчлан хүсэж буй гэсгээл-цээрлэл миний гарт байсан бол мэдээж та бидний хоорондын асуудал гарцаагүй шийдвэрлэгдэх байсан юм. (Та нарыг хүйс тэмтрэх байсан) Аллах зальхай этгээдүүдийг илүү сайн мэддэг.
59. Далдын ухааны түлхүүр Аллахаын мэдэлд болой. Түүнийг зөвхөн Аллах л мэднэ. Хуурай газарт болон далай тэнгист буй бүхнийг зөвхөн Аллах мэддэг. Тэр мэдэлгүйгээр ганц ч навч үл унамуй. Газрын гүнд дарагдсан ширхэг буудайн үр, өгөрсөн ба шинэхэн ургасан ургамал бүгд Лаухил-махфуз буюу хувь тавилангийн номонд бичигдсэн байгаа.
60. Аллах та нарыг шөнө үхдэлтэй адил нойрсуулж, өдөр юу хийж буйг чинь мэддэг. Дараа нь та нарыг хэмжээтэй хугацаанд амьд яваг гэж өглөө сэрээдэг. Эцэст та нарын буцаж очих газар Аллахаын нигур болой. Тэгээд та нарын хийснийг яруу тодоор хэлж өгнө.
61. Тэр боолууддаа зарлиг буулгагч бөгөөд та нарыг хамгаалагч мэлжүүдийг илгээдэг. Та нарын амьдрах хугацааг дуусгахад хүрвэл, амийг чинь авах мэлэк явуулна. Аллахаын зарлигыг гуйвалтгүй биелүүлнэ.
62. Дараа нь тэднийг чин үнэний эзэн болох Аллахаын өмнө аваачина. Анхаарагтун! Үнэндээ төгс шийдвэр зөвхөн Аллахаын эрх мэдэлд. Аллахаын тооцоо хийх нь тун амар бөгөөд нэн шуурхай билээ.
63. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Биднийг газар, тэнгисийн түнэр харанхуйгаас аварвал үнэнхүү талархаж, наминчлан залбирах болно!” хэмээн та нар нууцхан залбирч хүсэх болно. Ийм гүн харанхуйгаас та нарыг Аллахаас өөр хэн аврах вэ?” хэмээн хэлэгтүн.
64. “Тэрхүү түнэр харанхуйгаас болон, бүх зовлон зүдгүүрээс та нарыг Аллах л аварна. Гэтэл, та нар дахин Түүнийг бусадтай эн зэрэгцүүлдэг шүү дээ” гэж хэл.
65. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Аллах, та нарын толгой дээрээс чинь (чулуу, шувуу, мэлхий, царцааг), хөл доороос чинь гэсгээл явуулахад эсвэл та нарыг өөр хооронд зөрчилдүүлэн, цээрлүүлэхэд Аллахаын хүч чадал хүрнэ” гэж хэл. Бид айлдваруудаа тэдэнд ойлгуулахын тулд хэрхэн тайлбарлаж буйг харагтун.

66. Энэхүү Куран чин үнэн атал зон олон чинь үгүйсгэдэг. Чи тэдэнд: “Би та нарын хамгаалагч биш” хэмээгтүн!
67. Урьдчилан илгээсэн мэдээ бүр хэрэгжвэл зохих хугацаатай. Үүнийг мөдхөн мэдэх болно.
68. (Аяа, Мухаммед) Бидний айлдваруудын тухай тоглон, доромжлон, тохуурхаж ярилцаж буй хүмүүсийг үзвэл, тэд өөр юм ярих хүртэл тэдэнд бүү ойрт. Хэрэв, чөтгөр шулам чамайг мартуулахад хүрвэл (санамсаргүй хамт суучихвал) эргэж сэхээрсэн хойно тэр зальхай этгээдүүдтэй нэг дор бүү суугтун.
69. Сэрэмжлэн Аллахаас айхсад тэдний (зальхай этгээдүүдийн) өмнө ямар ч хариуцлага үл хүлээнэ. Харин сэрэмжлүүлэх нь зүй ёсны юм. Ингэхэд тэд юутай ч сэрэмжлэн, Эзэнтнээс айх болно.
70. Шашныг тоглоом тохуу болгогсодыг болон амьд ахуйн эрхшээлд хууртагсадыг түр орхиж, Куран судраар анхааруул. Тухайлбал: “Янз бүрийн хүн өөрийн зан араншингаас болж балрах вий. Тэдэнд Аллахаас өөр ямар ч анд, өмөөрөгч үгүй. Янз бүрээр төлөөс төлсөн ч хүлээн авагдахгүй” хэмээн сэрэмжлүүлэгтүн. Тэд үйлдсэн нүглээсээ болж гэсгээлд орно. Үл сүсэглэснийхээ төлөө тэдэнд буцлам халуун ус, амьдаар тамлах цээрлэл оногдох болно.
71. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Аллахаас өөр, тус ч болохгүй, хор ч хүргэхгүй зүйлд бид залбирах уу? Эсвэл Аллах биднийг зөв замд хөтлөн оруулсны дараа ухарч, чөтгөр шуламын төөрүүлснээр эзгүй хээр мангартаж, тэнүүчилж явахад нөхөд нь зөв замыг харуулж “наашаа эргээрэй!” гэж дуудсан хүнтэй адил байх гэж үү? Аллахын заасан зам бол жинхэнэ зөв зам. Ертөнцийн Эзэнтний эрхшээлд орох нь бидэнд тушаагдсан” гэж хэлэгтүн.
72. Аллахаас айж, уншлага мөргөлийг ёсчлон үйлдэх нь бидэнд тушаагдсан. Ертөнцийн төгсгөлийн өдөр та нар Аллахын эрхшээл дор цугларах болно.
73. Аллах тэнгэр, газрыг аугаа ухаанаар бүтээсэн. Аллах : “Болтугай!” хэмээн айлдахад бүх юм ёсоор болмуй. Түүний айлдвар чин үнэн. Ертөнцийн төгсгөлийн дохионы бүрээний дуу хангинахад бүхий л эрх мэдэл Түүнд оногдоно. Тэр ил, далд бүхнийг мэдэгч, мэргэн ухаанаар үйл бүтээгч, бүхнийг мэдэгч билээ.
74. Нэгэнтээ Ибрахим өөрийн эцэг Азерт : “Та хиймэл бурхадыг үнэхээр шүтээ юу? Би таныг болон таны зон олныг илэрхий төөрөлдөгсөд гэж ойлголоо” гэв.
75. Ибрахимын итгэл сүсэглэлийг багатгахын тулд түүнд тэнгэр, газрын нэгэн гайхамшигийг үзүүлсэн билээ.
76. Ибрахим шөнийн харанхуй нөмрөх цагаар нэг одыг үзэж: “Энэ бол

- миний Эзэнтэн” гэв. Од замхран жаргахад: “Би унтран алга болох зүйлд дургүй” гэсэн.
77. Тэр мандаж буй сарыг харангуутаа : “Миний Эзэнтэн энэ юм байна” гэв. Тэр шингэх үеэр: “Эзэнтэн надад зөв замыг эс үзүүлвээс мэдээж, би төөрөлдөгсдийн эгнээнд орох юм байна” гэв.
  78. Тэр мандаж буй нарыг хараад : “Энэ бол бүхнээс том юм байна. Миний жинхэнэ Эзэнтэн энэ” гэв. Тэр нар жаргахыг хараад : “Аяа, зон олон минь ээ! Би үнэхээр Аллахыг хиймэл бурхадтай эн зэрэгцүүлсэн та нарын тэр зүйлсийг зөвшөөрөхгүй” гэв.
  79. “Би үнэхээр буруу шашнаас чин үнэн шашин руу эргэлээ. Тэнгэр, газрыг оргүй хоосноос бүтээсэн Аллах руу эргэлээ. Түүнийг бусадтай адилтгагсадтай хамт биш ээ” гэв.
  80. Тэгтэл, зон олон нь түүнтэй маргалдав. Ибрахим тэдэнд хандан : “Аллах намайг үнэхээр аварч зөв замд орууллаа. Та нар Тэр тухайд надтай юунд маргалдах гэсэн вэ? Би та нарын Түүнтэй адилтгасан хиймэл бурхадаас айхгүй. Гэхдээ, Эзэнтний хүссэн зүйл бол өөр хэрэг. Эзэнтний минь энгүй эрдэм бүхнийг хамарсан. Та нар өдий хүртэл эргэцүүлэн бодоогүй юу?” гэж хэлсэн.
  81. Та нар ямар нотолгоогүй хиймэл зүйлийг Аллахтай адилтгахаас айхгүй байхад би та нарын Аллахтай эн зэрэгцүүлсэн зүйлээс айх гэж үү? Та нар үнэнд сөгдвөл энэ хоёрын (Аллах ба зохиомол бурхан) алианаас нь илүү айх ёстой вэ?
  82. Аллахад итгэн сүсэглэж, сүсэг бишрэлдээ өөр санаа бодол хольж хутгаагүй хүмүүс айх аюулгүй, жинхэнэ итгэн бишрэгсэд мөн. Тэд зөв замаа олсон хүмүүс.
  83. Өөрийнхөө зон олондоо няцаалт өгөг гэж Бидний зүгээс Ибрахимд зориулсан нотолгоо энэ л байна. Бид хүссэн хэн нэгнийхээ байр суурийг дээшлүүлнэ. Эзэнтэн чинь үнэхээр мэргэн ухааны эзэн, бүхнийг мэдэж байдаг.
  84. Бид Ибрахимд Исхак болон Якубыг заяаж, тэд бүгдийг зөв замд оруулсан. Өмнө нь Нухыг ч зөв замд оруулсан. Ибрахимын үр удмаас Дауд, Сүлейман, Аюб, Юсуф, Муса, Харун нарыг зөв зам руу залсан. Бид чин шударга үйлс хийсэн хүмүүсийг ийнхүү шагнадаг.
  85. Закария, Яхия, Иса болон Илияс нарыг ч зөв замд оруулсан. Тэд бүгд эрхэмсэг хүмүүс билээ.
  86. Исмайл, Алиясаг, Юнус болон Луг нарыг ч зөв замд оруулан, тэднийг тухайн цаг үеийн даян дэлхийн хүн ардаас дээгүүр өргөмжилсөн юм.
  87. Тэдний эцэг өвгөд, үр удам, ах дүү нараас ч заримыг нь сонгож, зөв замд оруулсан.
  88. Аллахын зөв шулуун зам бол энэ билээ. Аллах өөрийн боолуудаас таалснаа зөв замаар хөтлөмүй. Хэрэв, тэд өөр бурхадыг санаанаас

- зохиож Аллахтай эн зэрэгцүүлнэ гэвэл тэдний үйлдсэн бүхэн талаар өнгрөх болно.
89. Бид тэдэнд ариун судар, мэргэн ухааныг, гэгээн элч нарыг илгээсэн билээ. Буруу номтнууд тэднийг эс зөвшөөрвөл, эсэргүүцэхгүй нэгэн улст тушаах болно.
  90. Гэгээн элч нар бол Аллахын заасан зөв замаар явагсад. Тиймийн учир (Аяа, Мухаммед) чи тэдний замаар замнагтун! Тэдэнд : “Би үүний төлөө (гэгээн элч болж Куран судрыг уламжилсаныхаа төлөө) та нараас ямар ч хөлс нэхэхгүй. Куран бол даян дэлхийн бүхий л хүн ардад зөвхөн номлол ухуулга юм!” гэж хэлэгтүн.
  91. Тэд (Иудэйчүүд) Аллахыг үнэн мөнөөр нь таньдаггүй юм. Тэд : “Аллах хэнд ч юу ч илгээгээгүй” гэж хэлцгээдэг. Мухаммед чи тэдэнд: “Мусагийн хүн төрөлхтөнд гэрэл гэгээ, зөв шулуун зам болгон авчирсан ариун судрыг (Тауратыг) хэн илгээсэн билээ? Та нар түүнийг хэсэг хэсэг болгон цаасан дээр буулгаж аваад, заримыг нь харуулж, олонхийг нь нууцалдаг шүү дээ. Үнэндээ, та нарт болон өвөг дээдэст чинь мэдэхгүй юмыг тэр судраас зааж сургасан. Түүнийг Аллах л илгээсэн” хэмээн хэлээрэй. Дараа нь тэднийг бүр мөсөн орхи. Тэд өөрсдийнхөө танхай балмад орчиндоо наргисаар байг.
  92. Куран бол өмнөх судруудыг нотлон батагах, эх хот болох Меккегийн оршин суугчид болон тэдний эргэн тойрны (бүхий л хүн төрлөхтөнд) хүмүүст хойд насны тарчилгааг сануулахын тулд чамд илгээсэн ариун судар билээ. Ертөнцийн төгсгөлд итгэгсэд энэ сударт ч итгэнэ. Мөн уншлага мөргөлүүдээ алгасалгүй гүйцэтгэнэ.
  93. Аллахыг гүтгэсэн, өөрт нь ямар ч сургамж илгээгдээгүй ч гэсэн : “Надад ариун сургамж илгээгдсэн” гэж хэлэгсэд буюу “Аллахын илгээсэнтэй адил судрыг би ч илгээж чадна” гэж хэлсэн хүмүүсээс муухай зальхай этгээд бий гэж үү? (Аяа, Мухаммед) Зальхай этгээдүүд амьсгаа нь дээр ирж үхэл, зовлонд учрах цагт тэднийг тарчилган шийтгэгч Аллахын мэлэцүүд гараа сунган одоо амиа өгөгтүн! Та нар Аллахыг гүжирдэн гүтгэж, Түүний айлдваруудыг үл тоомсорлосны төлөө өнөөдөр зовлонт гэгсгээлээр шийтгүүлэх болно” хэмээн тушаана. Тэрхэн мөчид тэдний царайг харвал уу?
  94. Бид та нарыг анх хэрхэн бүтээсэн бол түүнтэй адил Бидний өмнө нэг нэгээрээ ирцгээнэ. Бидний хайрлан шагнасан зүйлсийг та нар хөсөр хаясан. Аллахтай эн зэрэгцүүлэн хиймэлээр бүтээсэн өнөөх бурхад чинь яасан вэ? Та нарын хоорондын холбоо тасарч, хүсэл горьдлого болсон зохиомол бурхад чинь арилан одлоо.
  95. Яс болон үрийг хагалж, алив үр жимсийг соёолуулагч нь Аллах мөн. Үхдлээс амьдыг, амьдаас үхдлийг бүтээгч бас Аллах. Иймээс та нар яагаад зөрүүдлэн түүнээс нүүр буруулна вэ?
  96. Харанхуйг түрж, үр цайлгагч бол Аллах. Тэр түр амраахын тулд

- шөнийг, цаг хугацааг тооцоолохын тулд нар, сар хоёрыг бүтээсэн. Энэ бүхэн нь үнэмлэхүй хүч чадлын эзэн, бүхнийг мэдэгч Аллахын зүй зохистой шийдвэр юм.
97. Эх газар болон далай тэнгис харанхуйлахад та нар замаа олог гэж ододыг бүтээсэн. Ухаалаг хүн ардын төлөө Бид айлдваруудаа ил тод мэдэгдсэн.
  98. Аллах та нарыг нэгэн хүнээс (Адам эцэгээс) бүтээсэн. Та нарын хувьд байрлах нэгэн газар, түр зуурын нэгэн орчин (эхийн хэвлий, эрийн эрхтэн буюу зоо нуруу) бий. Бид ухаалаг хүн ардад айлдваруудаа яруу тодоор тайлбарласан билээ.
  99. Аллах тэнгэрээс хур бороо оруулан, түүний усаар ургамал бүхнийг соёолуулж, ногоо навчыг нь дэлгэж, эгнүүлэн ургуулсан тарианаас ургац хураалгав. Хасарвааны дал модны их биеэс хонгорцогыг, усан үзэмийн цэцэрлэгийг ургуулж, янз бүрийн өнгө, амттай чидун анарын цэцэрлэгийг бий болголоо. Эдгээр нь үр жимсээ өгч байхад тус бүрийн булцайн боловсрохыг нь харагтун. Энэ бүхэн бол сүсэглэгч хүн ардын төлөө (Аллах бий гэдгийг) харуулах нотолгоонууд билээ.
  100. Урван тэрслэгчид Аллахын бүтээсэн жинг (буг чөтгөрийг) Түүнтэй эн зэрэгцүүлэв. Мөн Аллахын тухайд юу ч мэдэхгүй атал Тэрбээр охид, хөвгүүдтэй хэмээн бургцаав. Аллах чин ариун, тэдний хэлж буйгаас тэс ондоо, эрхэмсэг бөлгөө.
  101. Тэнгэр, газрыг оргүй хоосноос бүтээгч Аллахт эхнэр үгүй. Иймд хэрхэн хүүхэдтэй байхсан билээ? Тэр бүхнийг бүтээн бий болгосон, бүхнийг мэдэж байдаг.
  102. Ийнхүү, та нарын Эзэнтэн бол Аллах мөн. Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Тэр бүхнийг бүтээгч, тиймийн учир Түүнд сүсэглэн мөргөгтүн, Тэр бүхийг эрхшээн хамгаалагч, ажиглагч болой.
  103. Хорвоод түүнийг үзэж чадах нүд үгүй. Харин Тэр мэлмий бүхнийг соёорхон харж байдаг. Тэр машинд энэрэнгүй, бүхнийг мэдэгч билээ.
  104. Эзэнтнээс чинь та нарт яруу тод нотолгоонууд илгээгдлээ. Хэн үүнийг сүсэглэн дагавал түүнд өөрт нь ашиг тустай. Хэн нэгэн эс харах аваас, өөрт нь хор уршигтай. Ийнхүү, Мухаммед миний бие та нарын харгалзагч биш ээ.
  105. Буруу номтнууд: “Чи Кураныг хэн нэгнээс суралцсан” гэж хэлэх тул, тэрчлэн ухамсарт хүмүүст үнэнийг эрэгцүүлэх боломж олгохын төлөө Бид айлдваруудаа тус тусд нь ийнхүү тайлбарлаж өгцгөөдөг.
  106. (Аяа, Мухаммед) Эзэнтнээс чамд илгээгдсэн зүйлийг (Кураныг) дагагтун. Аллахаас өөр ямар ч бурхан үгүй. Аллахтай бусдыг эн зэрэгцүүлэгчдээс нүүрээ буруулагтун.
  107. Хэрэв, Аллах хүссэн бол гэд Аллахыг зохиомол бурхадтай эн

- зэрэгцүүлэхгүй байх байсан. Бид (Мухаммед) чамайг тэдний хамгаалагч болгоогүй, чи ч тэдний харгалзагч биш.
108. Та нар тэдний Аллагаас өөр мөргөдөг зохиомол бурхадыг нь бүү хараагтун. Хэрэв, тэгвэл тэд хэмээс хэтэрч, ухааралгүйгээр Аллахыг хараах болно. Ийнхүү Бид алив хүн ардын итгэл-үнэмшил, ааш-араншинг өөрсдөд нь гоёмсог сайхан харуулсан. Эцсийн эцэст тэд Аллахын өмнө сөгдөх болно. Аллах тэдний юу хийснийг өөрсдөд нь тайлбарлан хэлж өгнө.
  109. Хэрэв тэдэнд ер бусын гайхамшиг ирвэл, түүнд бүрэн итгэхээ мэдэгдэн, Аллахын алдрыг барьж андгайладаг. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Ер бусын гайхамшиг зөвхөн Аллахын эрх мэдэлд” хэмээн хэлэгтүн. Ер бусын гайхамшиг ирлээ ч магад тэд түүнд итгэхгүй. Та нар хэрхэн мэдэх билээ.
  110. Тэд угаас сүсэггүй тул Бид тэдний үнэнийг мэдрэх зүрх сэтгэл, харах нүдийг нь буруу тийш эргүүлчихнэ. Угаас итгэн сүсэглээгүйтэй нь адил төөрөгдүүлэн, тэнэмэл чигээр нь орхимуй.
  111. Бид буруу номтнуудад мэлэкүүдийг явуулсан ч, үхэгсэдийг тэдэнтэй яриулсан ч, бүхнийг өмнө нь цуглуулж авчирсан ч, Аллах таалахгүй бол тэд итгэн сүсэглэхгүй. Аллах хүссэн бол өөр шүү дээ. Тэдний олонхи нь үүний утга учрыг ойлгохгүй.
  112. Тэрчлэн, гэгээн элч бүрт хүн болон буг чөтгөр, шуламуудыг дайсан болгочихсон. Тэд нэг нэгийгээ гоё үгээр хууран ухуулна. Хэрэв, Эзэнтэн чинь хүсвэл үүнийг тэд хийхгүй байсан. Тэднийг гүжирдлэг, гүтгэлгээр нь хөсөр орхигтун.
  113. Хойд ертөнцөд үл итгэгсэдийн зүрх сэтгэл нь тэдний хий хоосон, гоё үгэнд хуургаж л байг, сэтгэл нь ханаж л байг, үйлдсэн нүглээ үйлдэж л байг гээд хууран мэхэлдэг.
  114. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Аллах, та нарт яруу тод судар илгээсэн байхад би Аллагаас өөр эрх мэдэлтнийг хайх болж байна уу?” хэмээн хэл. Бидний зүгээс өөрсдөд нь ариун судар илгээгдсэн Иудэй болон христчүүд Куран нь Эзэнтнээс илгээгдсэн чин үнэн судар болохыг мэддэг. Чи энэ тухайд эргэлзэхийн хэрэггүй!
  115. Эзэнтний үг (Куран) Чин үнэн хийгээд шударга гэдэг нь бүрэн төгс тогтоогдсон болой. Түүний үгийг хэн ч өөрчилж чадахгүй. Аллах бүхнийг сонсогч, бүхнийг мэдэгч шүү дээ.
  116. Хэрэв чи дэлхий дээрх хүмүүсийн олонхийг дагаад байвал, тэд чамайг Аллахын замаас төөрүүлдэнэ. Тэд зөвхөн хуурамч зүйлд итгэн, худлаа ярьдаг.
  117. Эзэнтэн чинь, өөрийнхөө заасан замаас хазайгсадыг үнэхээр сайн мэддэг, зөв шулуун замаар замнаж буйг ч бас мэдэгч билээ.

118. Аллахын айлдваруудад үнэхээр итгэж байгаа бол Аллахын алдарыг барьж нядалсан амьтадын махыг идэгтүн.
119. Зөвхөн аргагүйн эрхэнд орох хүртэл идэхийг хориглон харам (бузар)-т тооцох зүйлүүдийг Аллах та нарт ил тод тайлбарласан шүү дээ! Ингэхлээр, яагаад Аллахын нэр барьж нядлсан малыг идэдэггүй вэ? Үнэндээ хүмүүсийн нэлээд нь ухаараагүйгээс, хувийн хүсэл тачаалдаа автан бусдыг төөрөгдүүлдэг. Эзэнтэн чинь, үнэндээ хэмээс хэтэрсэн хүмүүсийг сайн мэддэг.
120. Та нар ил, далд нүгэл үйлдэхийг цээрлэгтүн! Нүгэл хураагсад үйлдсэн нүглийнхээ шийтгэлийг зохих ёсоор хүртэх болно.
121. Аллахын алдарыг барьж нядлаагүй амьтадын махнаас бүү идэгтүн! Хэрэв, идвэл том нүгэл болно! Чөтгөр шуламууд өөрсдийн талынхныг та нартай мэтгэлцэн маргалдахад түлхэнэ. Хэрэв, тэдний үгэнд орох аваас эргэлзээгүй олон бурхан шүтэгч буруу номтон болцгооно.
122. Хэрэг дээр, Үхдэл байхад нь Бид амилуулж өөрт нь хүмүүсийн дунд явж чадах гэрэл гэгээ хайрласан хүн ба харанхуй дотор (үл сүсэглэл дотор) үлдэж, түүнээс гарч чадахгүй болсон хүн хоёрыг адилтгаж болно гэж үү? Буруу номтон үл сүсэглэгсэдэд, тэдний хийснийг өөрт нь зохимжтой болгон харагдуулсан болой.
123. Түүнчлэн, түр аргацааж байг хэмээн Бид хот суурин бүрийн гол нүгэлтэнгүүдийг ихэс дээдэс болгосон. Гэтэл аргацаасан заль мэх нь тэдний өөрсдийг нь дайрдагийг анзаардаггүй!
124. Тэдэнд Мухаммедын гэгээн элч болохыг нотолсон зарим айлдвар ирсэн үед тэд : “Аллахын бусад элч нарт илгээсэнтэй адил илгээлт бидэнд ирэхээс наана итгэхгүй” гэнэ. Аллах гэгээн элчийг хэрхэн байршуулахаа Өөрөө л мэднэ. Эдгээр нүгэлтнүүд үйлдсэн хуурамч арга мэхийнхээ төлөө Аллахын өмнө зовлонг гэгсгээл хийгээд хатуу цээрлэл үзэх болно.
125. Аллах хэн нэгнийг зөв шулуун замаар хөтлөхийг хүсвэл түүний цээжийг Исламд зориулж уужруулна. Харин хэн нэгнийг төөрүүлэхийг хүсвэл цээжийг нь бачууруулдаг. Наминчлан залбирах нь буруу номтнуудад тэнгэрт дүүлэхээс ч хэцүү. Ийнхүү Аллах үл сүсэглэгсэдийг ийм нэгэн бузар булай дунд зовооно.
126. (Аяа, Мухаммед) Энэ (ислам шашин) бол Эзэнтний чинь зөв зам мөн. Сургамж авах хүмүүсийн төлөө Бид айлдваруудаа ийнхүү яруу тод тайлбарлаж байна.
127. Эзэнтний дэргэд тэдэнд зориулсан энх амгалангийн харш (дарус-салам буюу диваажин) байдаг. Тэдний үйлдсэн эрхэм үйлсийн хэрээр Аллах дэмжлэг үзүүлнэ.
128. (Аллах) Тэднийг (жин буюу буг чөтгөрүүдийг) бүгдийг нь цуглуулах өдөр : "Аяа, жин нар аа! Та нар олон хүнийг уруу татсан" хэмээн



хэлэгдэх болно. Жинн нарын хүмүүсээс олж авсан найз нөхөд нь : "Эзэнтэн минь, бид бие биенээс ашигласан. Чиний бидэнд зориулсан хугацааны төгсгөлд хүрэлцэн ирлээ" гэнэ. Аллах тэдэнд: "Та нарын очих газар- там. Тэнд үүрд үлдэцгээнэ. Хэрэв, Аллах хүсвэл өөр асуудал" гэв. Эзэнтэн чинь эргэлзээгүй мэргэн ухааны эзэн, бүхнийг мэдэгч.

129. Ийнхүү Бид, үйлдсэн нүглийн төлөө гэмт этгээдүүдийг холбон уяж, хазаарлана.
130. (Аллах) Аяа, жинн нар болон хүмүүсийн зон олон оо! “Та нарын дотроос Миний айлдваруудыг та нарт хүргэдэг, ертөнцийн төгсгөлийн өдөргэй тулгарахыг сануулдаг гэгээн элчүүд ирээгүй гэж үү?” гэхэд тэд : “Нүгэлээ наминчлан, өөрийгөө гэрчилж байна” гэцгээдэг. Тэднийг энэ насны амьдрал хуурсан, тэд өөрсдийн буруу номтон болсонд өөрсдөө гэрч болцгооно.
131. Аллах үнэндээ, хот суурингийн амгалан олныг зальхай аргаар түйвээн бусинуулахгүй.
132. Хойд насанд хүн бүрийн үйлдсэн сайн, муу үйлдэлд дүйцэх эрэмбэ оногдоно. Эзэнтэнд тэдний үйлдсэн үйл бүхэн илэрхий билээ.
133. Аллах нэн баян, хайр энэрэлийн эзэн. Хэрэв, Тэр хүсвэл та нарыг үгүй хийж, өөр нэгэн ард түмний үр удмаас бүтээсэн шиг, та нарын байранд өөр нэгэн ард олныг авч ирэх болно.
134. Та нарт амлагдсан бүхэн ертөнцийн төгсгөлийн өдөр эргэлзээгүй ирэх болно. Та нар түүнээс салж чадахгүй.
135. Аяа, Мухаммед! Тэдэнд : “Аяа олон түмэн минь ээ! Өөрсдийн хэр чадлаараа хийгтүн, Би ч хэлсэндээ хүрч, хэр чадлаараа ажиллана. Хорвоогийн төгсгөлд хэн хаана оршихыг мөдхөн мэдэх болно. Зальхай этгээдүүд хүслээ биелүүлж чадахгүй нь эргэлзээгүй” хэмээн хэлнэ үү?
136. Итгэл сүсэггүй этгээдүүд Аллахын бүтээсэн үр тариа, мал сүргээс Аллахын төлөө нэг хэсэг, зохиомол бурхадын төлөө бас нэг хэсэг хувь үлдээгээд: “Энэ Аллах-д, энэ нь бидний бурхдад” гэгцгээнэ. Тэднийхээр бол зохиомол бурхадын хувиас Аллах-д өгч болохгүй, харин ч Аллахын хувиас тэдний бурхдад хүртээж болно гэнэ. Тэдний санаархал юутай муухай юм гээч!
137. Сүсэггүйчүүдийн нөхөд нь (чөтгөр шуламууд) үл сүсэглэгчдийг хорлох, тэдний ихэнхийн итгэл үнэмшлийг бузарлах үүднээс үр хүүхдээ хөнөөх зуршилыг тэдэнд тааламжтай болгон харуулдаг. Хэрэв, Аллах хүссэн бол тэд үүнийг хийхгүй байсан биз. Тийм юм бол тэднийг гүтгэлэг, худал хуурмаг юмтай нь хамт хөсөр орхигтун.
138. Тэд өөрсдийн мухар сүсэгээр : “Эдгээр мал сүрэг болоод үр тариа бусдад харам (бузар) болой. Тэднийг гагцхүү бидний таалсан хүмүүс л идэж болно. Энэ мал амьтадыг унах, ачаалах, Аллахын нэрээр нядлах

- нь хориотой” гэж хэлцгээсэн. Ийнхүү Аллахыг гүтгэвэл, Аллах тэднийг гэсгээн цээрлүүлэх болно.
139. Тэд бас: “Эдгээр мал амьтадын хэвлийд буй төл нь амьд гарвал зөвхөн манай эрчүүдэд зориулагдана, эхнэрүүдэд маань (харам) хориотой” гэнэ. Харин төл нь амьгүй төрвөл эр, эм гэлгүй бүгдээрээ дундаа идэж л байдаг. Аллах тэднийг худал хуурмаг гүтгэлэгийн төлөө гэсгээн цээрлүүлнэ. Аллах мэргэн ухааны эзэн, бүхнийг мэдэгч билээ.
140. Бүдүүлэг харанхуй мунхагын гайгаар төрсөн үрээ хөнөөсөн, Аллахын нэр барьж худал хэлсэн, Аллахаас хүртээсэн хувь хишгийг бузар (харам) гэсэн этгээдүүд илэрхий хохирол амссан. Үнэндээ жинхэнэ төөрөлдөгсөд бөгөөд зөв замаар явагсадаас хол хөндий хүмүүс.
141. Аллах босоо ба хазгай ургадаг янз бүрийн жимсний цэцэрлэгийг ургуулсан. Үр жимис нь харилцан адилгүй болон үр тариаг өнгө хэлбэр нь адилхан атал амт нь тэс өөр чидун хийгээд анарыг ургуулсан. Боловсорч гүйцсэн цагт үр жимсийг нь хүртэгтүн, ургацыг нь хураах цагт зохих өглөг өгөгтүн (аравны нэгийг), харин үрэн таран бүү хийгтүн. Аллах үрэлгэн хүмүүсийг эс таалмай.
142. Мал сүрэгээс ачлага уналга даахыг нь, хүнсэнд нядлахыг нь зөвшөөрсөн. Аллахын хайрласан хувь хишгийг л хүртэгтүн, чөтгөр шуламыг бүү дагагтун! Чөтгөр шулам бол та нарын илэрхий дайсан шүү дээ.
143. Аллах хосоор (эр,эмээр) нь найман толгой мал бүтээсэн : хониноос хоёр, ямаанаас хоёр. (Аяа, Мухаммед) Үл сүсэглэгчдэд хандан : “Аллах эдгээрийн хоёр эрийг харам (бузар) болгов уу? эсвэл хоёр эмийг үү? Үгүй бол хоёр эм малын хэвлийд буй үр төлийг харам (бузар) болгов уу? Хэрэв та нарын үг үнэн бол надад хэлээд өг” хэмээн асуугтун.
144. Мөн эр, эм хосоор тэмээнээс хоёрыг, үхэрээс хоёрыг бүтээв. (Аяа, Мухаммед) Үл сүсэглэгчдэд хандан : “Аллах эдгээрийн хоёр эрийг харам (бузар) болгов уу? Эсвэл эмийг үү? Үгүй бол хоёр эм малын хэвлийд буй үр төлийг хориглов уу? Аллах ийнхүү зарлиг болгоход та нар түүний дэргэд гэрчээр байсан юм уу?” хэмээн асуугтун. Хүмүүсийг төөрөгдүүлэхийн тулд юу ч мэдээгүй атал Аллахын нэр барьж худал хэлж гүжирдэчдээс зальхай хэн байна вэ? Аллах зальхай этгээдүүдэд зөв замыг заяахгүй.
145. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Надад илгээгдсэн зүйлсийн дотроос идэх ёстой хүмүүсийн хувьд бузар (харам) зүйл олсонгүй. Гэвч, үхсэн малын сэг, урссан цус, гахайн мах нь жинхэнэ бузар бөгөөд Аллахаас бусдын нэр барьж нядалсан мал бузар (харам)” хэмээн хэл. Гэхдээ, хэн нэгэн амьд үлдэхний эрхээр аргагүй байдалд хүрвэл хүсэл тачаалдаа авталгүйгээр эдгээрээс идэж болно. Учир нь Эзэнтэн чинь машид өршөөгч, энэрэн нигүүлсэгч шүү дээ.
146. Бид, Еврэйчүүдэд туурайтныг идэхийг хориглосон. Мөн үхэр, хонины

- хавирга нурууны өөх, чөмөгний тос, дотор өөхнөөс бусад өөхийг хориглосон. Тэд хэм хэмжээг зөрчсний төлөө Бид тэднийг ийнхүү шийтгэсэн билээ. Бид эргэлзээгүй үнэнч шүү дээ.
147. (Аяа, Мухаммед) Хэрэв тэд (Иудэйчүүд) чамайг худалч хэмээн эс хүлээн зөвшөөрвөл тэдэнд : “Эзэнтний нигүүлсэл, хайр энэрэл хязгааргүй. Харин Түүнийг хилэгнүүлбэл та нарыг нүгэлтнүүдээс салгаж авахгүй (та нар гэсгээлээс аврагдахгүй)” гэж хэлэгтүн.
148. Аллахтай бусдыг эн зэрэгцүүлэгсэд : “Хэрэв Аллах хүссэн бол бид болоод бидний өвөг дээдэс Түүнтэй бусдыг эн зэрэгцүүлэхгүй байсан, түүнчлэн юуг ч бид бузарлахгүй байсан билээ” гэгцгээдэг. Тэднээс өмнөх хүмүүс бидний үзүүлсэн цээрлэлийг хүлээх хүртэл гэгээн элчээ ийнхүү үгүйсгэсэн билээ. (Аяа, Мухаммед) тэдэнд : “Та нарт мэддэг зүйл байвал Бидэнд харуулагтун. Ер нь та нар худал хэлж, хий хоосон төсөөлөлдөө хөтлөгддөг шүү дээ!” хэмээн хэл.
149. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Хамгийн яруу төгс нотолгоо бол Аллахынх. Хэрэв, Аллах хүсвэл та нарын бүгдийг зөв замд оруулна” гэж хэлэгтүн.
150. Тэдэнд : “Алив! Аллах үүнийг хориглосон гэдгийг нотлох өөрсдийнхөө гэрчүүдийг дуудагтун!” гэж хэл. Хэрэв тэд тийнхүү гэрчлэх аваас чи тэдэнтэй хамт гэрч бүү бологтун. Бидний айлдваруудыг үгүйсгэн, хойд ертөнцөд үл сүсэглэгсэдийн хий хоосон мөрөөдөлд бүү автагтун. Учир нь тэд Аллахтай бусдыг эн зэрэгцүүлдэг юм.
151. Тэдэнд : “Ирцгээгтүн, Эзэнтнээс та нарт юуг бузар хэмээн хориглосныг би уншиж өгье: “Аллахтай юуг ч бүү эн зэрэгцүүлэгтүн! Эцэг эхээ тэтгэж буян үйлдэгтүн, үгүйрэл ядуурлаас айж үр хүүхдээ бүү хөнөөгтүн. Бид тэдэнд болон та нарт ч хувь хишиг хүртээнэ. Ил, далд ичгүүргүй юм бүү хийгээрэй. Зайлшгүй биш юм бол, шударга бусаар бусдыг хэлмэгдүүлэж, Аллахын зарлигийг зөрчиж хүнийг бүү хөнөөгтүн. Та нарыг ухаарч мэдэг гэж Аллах ийнхүү сургамжилж байна” гэж хэл.
152. Мөн та нар өнчин өрөөсөн хүүхдийн насанд хүрэх хүртэл мал хөрөнгөнд бүү ойртогтун! Гагцхүү тэдний сайн сайханы төлөө зөв зохистой байдлаар зарцуулж болно. Хэмжүүрийн жинлүүрийг үнэн зөв байллагтун. Бид хэн нэгэнд хэрээс хэтэрсэн зүйлийг үүрэг болгохгүй. Хэрвээ, та нар шүүгч ба гэрч болох үед ойр дотныхан байсан ч шударга ёсыг баримтлагтун. Аллахад өгсөн андгай тангаргаа үнэнчээр сахигтун. Ийнхүү Аллах, та нарт сургамж болгох үүднээс энэ бүхнийг захиж байна.
153. Энэ бол миний зөв шулуун зам болой. Тиймээс үүнийг дагагтун. Өөр замаар бүү явагтун. Бусад замууд та нарыг Аллахын замаас төөрөгдүүлнэ. Та нарыг тамын зовлонгоос сэрэмжлүүлэх үүднээс Аллах үүнийг сургамж болгосон билээ.
154. Аллахын өмнө хэзээ нэгэн цагт очиход итгүүлж, сайн үйлс үйлдэгсэдэд

- буян хишгээ гүйцээх, замыг чинь залж тайлбарлаж өгөх, (израйлийн ард түмнийг) зөв замаар хөтлөн, хайр энэрэл үзүүлэх үүднээс Бид Муса'д ариун судар буулгасан болой.
155. Бид илгээсэн энэхүү ариун судар Куран бол нэн буянтай ном. Аллахын ивээлд багтах гэвэл түүнийг дагаж, сэрэмжтэй байгтун.
156. “Биднээс өмнө хоёр ард түмэнд (Иудэй болон Христчүүд) ариун судар илгээгдсэн. Тэдний уншсан судраас бид мэдсэн зүйлгүй” хэмээн хэлүүлэхгүйн тулд Би та нарт Куран судрыг илгээсэн юм шүү!
157. Эсвэл : “Хэрэв бидэнд ариун судар илгээгдсэн бол, бид тэднээс илүү зөв шулуун замаар замнах байсан юм” гэж хэлүүлэхгүйн тулд (Куран судрыг илгээсэн юм). Үнэндээ, та нарт Эзэнтний зүгээс яруу тод нотолгоо, зөв зам, энэрэл нигүүлсэл ирсэн болой. Ийнхүү Аллахын айлдваруудыг худал хэмээж, түүнээс нүүр буруулагсадаас илүү зальхай этгээд байх гэж үү? Бидний айлдваруудаас нүүр буруулцгаасан учир тэднийг хамгийн хатуу гэсгээлээр шийтгэх болно.
158. Тэд, зөвхөн өөрсөд нь (үхэлийн) мэлэжүүд ирэхийг, эсвэл Эзэнтэн чинь өөрөө морилохыг, үгүй бол Эзэнтний зарим нэг айлдвар, бэлгэдэл ирэхийг нь хүлээцгээж байна уу? Гэхдээ, Эзэнтний чинь зарим нэг айлдвар, бэлгэдэл ирсэн ч, урьд өмнө итгэн сүсэглээгүй хүмүүсийн, итгэн биширлээ ч гэсэн нэг буянтай үйл хийгээгүй (буянт үйлд нь нөлөөлөх сүсэггүй) хүмүүсийн сүсэглэл нь түүнд ямар ч ашиг тус өгөхгүй. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Хүлээцгээгтүн, Бид ч гэсэн хүлээцгээнэ” хэмээн уламжлагтун.
159. Шашин сүсэглэлд хэд хуваагдан, бүлэглэгсэдтэй чиний холбогдол үгүй шүү. Тэдний үйлс Аллаhad илэрхий. Аллах тэдний хийж асныг дараа нь өөрт нь хэлж өгөх болно.
160. Хэн, нэг л сайн үйлс хийвэл түүнээс арав дахин илүү буян эдлэнэ. Харин нэг муу үйлс хийвэл гагцхүү хийсэн хэргийн хэрээр шийтгэл оногдоно, шударга бус юм хийгдэхгүй.
161. (Аяа, Мухаммед) Тэдэнд (үл сүсэглэгсэд) : “Аллах намайг зөв шулуун замаар, өөрөөр хэлбэл үнэн шашин руу, Ибрахимийн үнэн зөв зам руу хөтөлсөн. Тэр бол буруу номтон биш байсан” хэмээн сануулагтун.
162. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Миний уншлага мөргөл, залбирал, амьдрал, үхэл бүгд л ертөнцийн Эзэн Аллахын төлөө” хэмээн хэлэгтүн.
163. “Аллах ямарч ижилгүй. Би түүнд (Ганц Аллахад итгэн залбирахад) харьяалагдсан. Би мусулманчуудын анхных мөн” хэмээн хэл.
164. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Аллах алив бүхний Эзэнтэн атал би түүнээс өөр бурхан хайна гэж үү?” хэмээн хэлэгтүн. Хүн бүр өөрөө үйлдсэн нүглийн тарчилгааг өөрөө хүлээнэ. Бусдын нүгэлийг өөр хэн ч үүрэхгүй. Эцэст нь та нар Аллахын өмнө очих болно. Тэр үед Аллах та нарын зөрчил маргааны хар-цагаан, буруу-зөвийг хэлж өгнө.

165. Аллах та нарыг газар дэлхийн захирагч болгосон. Өөрсдөд чинь хайрласан буян хишгээрээ та нарыг сорихийн тулд нэгийн чинь байр суурийг нөгөөдүүлээс дээгүүр эрэмбэлсэн. Аллах үнэхээр үтэр түргэн тооцоо хийгч, бас машид өршөөн, нигүүлсэгч болой.

## 7.СУРЕ АГРАФ

Мекке-д илгээгдсэн. 206 айлдвар.

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Алиф, Лам, Мим, Сад.
2. (Аяа, Мухаммед) Энэхүү судар (Куран) үл сүсэглэгдэд анхааруулга, мусулманчуудад ухуулга-сургамж болгохын төлөө чамд илгээгдсэн юм. Үл сүсэглэгдэд эсэргүүцэний төлөө сэтгэлээр бүү уна!
3. Эзэнтнээс чинь та нарт илгээгдсэн судрыг бишрэн дагагтун! Аллахыг мартаж бусадтай бүү нөхөрлөөрэй. Та нар сургамж авахдаа тун алгуур юм даа!
4. Бид нэлээн хот сууринг түйвээсэн! Бидний гэсгээл тэдэнд шөнө нойрондоо байхад эсвэл өдрийн амралтын цагаар ирсэн болой.
5. Бидний гэсгээл ирсэн үед тэд : “Бид үнэхээр зальхай хүмүүс байсан юм байна” хэмээн уйлагнав.
6. Мэдээж Бид өөрсдөд нь элч илгээгдэгдээс, бас элчүүдээс заавал хариуцлага асуух болно.
7. Ертөнцийн төгсгөлийн өдөр Бид тэдэнд (юу хийж асныг нь) байдлыг тодорхой тайлбарлаж өгөх болно. Үнэндээ Бид тэднээс холдож байгаагүй шүү дээ!
8. Тэр өдөр хүмүүсийн хийсэн сайн-муу үйлс бүхэн дэнслэгдэх болно. Хэний буянтай үйлсийн жин илүү дарна, тэд тамын гэсгээлээс аврал ологсод байх болно.
9. Хэний жин бага дарна, тэд Бидний айлдваруудад итгээгүйгээс өөрсдийгөө хохиролд учруулагсад юм.
10. Үнэндээ Бид та нарыг дэлхийд байршуулж, амьдрах боломжоор хангасан байхад Аллахын ивээлд талархаж залбирах чинь тун бага байна шүү дээ!
11. Үнэндээ Бид та нарыг бүтээж, дараа нь хүний дүрсэнд оруулсан. Тэгээд мэлжүүдэд (тэнгэрийн элчүүдэд) хандан: “Адамд мөргөгтүн” гэж хэлэв. Иблис-шуламаас бусад нь бүгдээрээ мөргөсөн. Гагцхүү Иблис-шулам л мөргөөгүй юм.
12. (Аллах Иблис шуламд): “Би мөргөхийг тушаасан атал чи яагаад

- мөргөөгүй юм бэ?” гэж асуув. Шулам: “Би Адамаас (хүнээс) хавьгүй дээр. Чи намайг галаар, түүнийг шавраар бүтээсэн шүү дээ” гэж хариулав.
13. (Аллах) : “Тийм юм бол тэндээс (диваажингаас) зайл! Энд биеэ тоон, их зан гаргахыг цээрлэдэг юм. Тиймээс үтэр түргэн арилагтун! Эргэлзээгүй, чи хамгийн адгийнх” гэсэн юм.
  14. (Иблис) : “Ертөнцийн төгсгөлийн өдөр хүн төрөлхтний дахин амилах өдөр хүртэл надад (амьд явах) боломж өгөөч!” гэж гуйв.
  15. (Аллах) : “Үнэндээ чи боломж олгогдогсодын нэг нь болсон (чамд боломж олгов)” гэв.
  16. (Иблис) : “Тийм бол намайг Чи өөрөө төөрөгдүүлсэн учир би ч тэдний (Адам буюу хүмүүс ба түүний үр садын) эсрэг Чиний заасан зөв шулуун зам дээр тосож, саад учруулах болно.” гэв.
  17. Бас : “Тэгээд би тэдний ар, өврөөс, баруун, зүүнээс дайрана. Тэдний ихэнх нь Чиний хайрласан буян хишигт талархдаггүйг Чи харах болно” гэв.
  18. (Аллах) : “Дорд үзэгдэн, талархал хүртээгүй байдлаараа эндээс зайлж үз! Чамайг дагасан хүмүүсийг хамтатган, бүгдээр тамын тогоог дүүргэж цээрлүүлэх болно.” гэв.
  19. (Аллах) Адамд хандан: “Аяа, Адам! Эхнэрийнхээ хамт диваажинд орж байрлагтун. Диваажингийн жимснээс хүссэнээрээ сонгож идэцгээгтүн. Гагцхүү, энэ нэгэн модонд бүү ойртогтун!(түүний үр жимсийг бүү идээрэй) Хэрэв ойртвол зальхай амьтад болно шүү дээ!” гэж сануулав.
  20. “Гэтэл чөтгөр шулам тэр хоёрын (Адам ба түүний эхнэр) ичимтгий эрхтнийг сөхөж, шившиглэн муу санаа өвөртлөн уруу татахын тулд: “Аллах та хоёрыг мэлэк (тэнгэрийн элч) болгохгүйн тулд, эсвэл диваажинд байлгахгүйн тулд энэхүү модны үр жимснээс идэхийг хориглосон биз” гэж ховлов.
  21. Бас тэдэнд : “Би та хоёрт чин үнэнээс сургамжилж байсан шүү” хэмээн тангараг өргөсөн.
  22. Ийнхүү тэр хоёрыг хуурч уруу татан, нэр төрийг нь гутаав. Тэд модны жимсийг идмэгц ичиг (эрхтэн) нь сөхөгдөн, диваажингийн навчаар өөрсдийнхөө доод эрхтэнээ далдлав. Эзэнтэн тэдэнд : “Би та нарт энэ модыг хориглосон биш бил үү? Чөтгөр шулам та нарын илэрхий дайсан гэж Би хэлээгүй бил үү?” хэмээн зэмлэв.
  23. Тэр хоёр: “Аяа, Эзэнтэн минь ээ! Бид өөрсдөө өөртөө уршиг тарьцгаалаа. Хэрэв, Чи өөрөө өршөөн уучилж, энэрэхгүй бол бид үнэнхүү хүнд уршигтай учирч нэг мөсөн дүүрэх болно” гэж гэмшицгээв.
  24. Аллаx тэдэнд: “Та нар (чөтгөр шулам ба Адам буюу хүн төрөлхтөн) бие биедээ дайсан болцгоож, газар дэлхийд буугтун. Та нарын хувьд газар дэлхийд тодорхой хугацаагаар орших, аж төрөх боломж заяагдсан” гэв.

25. Аллах: “Та нар газар дээр амьдарцгаана, мөн тэнд үхэцгээнэ, (ертөнцийн төгсгөлийн өдөр) тэндээс дахин амилан, (булшнаасаа) гарцгаах болно” гэж хэлэв.
26. Аяа, Адамын үр удам аа! Бид та нарт ичих эрхтнүүдээ далдлах хувцас, гоёлын зүйлсийг хайрласан. Үнэн сүсэглэлийн хувьцас түүнээс ч сайн. Эдгээр нь Аллахын бэлгэдэлүүд, үүнээс дүгнэлт хийж, сургамж авах болно.
27. Аяа, Адамын үр удам аа! Чөтгөр шулам та нарын эцэг эхийн ичимтгий эрхтнийг өөрсдөд нь харуулахын тулд хувцасыг нь тайлуулан диваажингаас гаргасан лугаа адил та нарыг ч бүү мэхлэг. Учир нь чөтгөр шулам болон түүний харьяалалд буй этгээдүүд та нарыг далдаас ч харж чаддаг, харин та нар тэднийг харж чадахгүй. Бид чөтгөр шуламыг үл сүсэглэгсэдийн анд найз болгосон бөлгөө!
28. Буруу номтнууд бузар булай юм үйлдэхийн цагт: “Бид өвөг дээдсийнхээ ийнхүү хийж буйг харсан билээ. Аллах ч бидэнд үүнийг зарлиг болгосон” гэнэ. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Аллах өөрийн боолуудад хэзээ ч бузар явдлыг үл тушаадаг! Та нар өөрсдөө мэдэхгүй зүйлд Аллахын нэр барьж худал хэлэх гэж үү?” хэмээн хэл.
29. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Аллах надад шударга ёсыг зарлигдсан. Хаана байсан ч уншлага мөргөл үйлдэхдээ Аллах руу (Мөрглөө гагцхүү Түүнд зориулагтун) нүүрээ харуулж байгтун. Мөн шашинаа зөвхөн Түүнд зориулж, чин үнэн сэтгэлээр наминчлан мөргөгтүн. Аллах анхлан яаж бүтээсэн лүгээ адил Түүн рүү эргэж очино” гэж хэлэгтүн.
30. (Аллах хүн төрөлхтний) Зарим хэсгийг зөв зам руу чиглүүлж, зарим хэсгийг төөрөгдүүлэх нь зайлшгүй боллоо. Яагаад гэвэл, тэд Аллахыг орхиж, чөтгөр шуламтай нөхөрлөж, өөрсдийгөө зөв замаар замнаж байна хэмээн бодоцгоодог!
31. Аяа, Адамын үр удам аа! Та нар Мэсжидэд (сүмд) мөргөл үйлдэхдээ гоё хувцасаа өмсөгтүн. Мөн идэж, ууцгаагтун. Гэхдээ бүү үрэлгэн байгтун. Аллах үнэндээ үрэлгэн байгсадыг үл таална.
32. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Аллахын өөрийнхөө боолуудад хайрласан гоё хувцас, ариун хишгийг хэн бузарлаж (харам болгон хориглож) чадах вэ? Тэр нь (гоё хувцас, ариун хишгүүд) энэ хорвоод үнэн сүсэгтнүүдийнх бөгөөд хойд ертөнцөд ч зөвхөн үнэн сүсэгтнүүдэд зориулагдсан” хэмээн хэлэгтүн. Бид айлдваруудаа ухаант хүмүүст ийнхүү яруу тод тайлбарлаж буй болой.
33. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Аллах ил, далд бузар үйл үйлдэхийг, нүглийг болон бусдад зохисгүй хандахыг, ямар нэгэн байдлаар нотолгоогүй зүйлийг Аллахтай эн зэрэгцүүлэхийг, өөрөө мэдэхгүй зүйлийг Аллахын нэр барьж дур зоргоор ярихыг хориглосон” хэмээн хэл.

34. Зон олон бүрт заяагдсан (үхэлийн) цаг хугацаа бий. Тэрхүү цаг хугацаа нь ирэхүйд ганц хормоор ч хойшлуулж, урагшуулж үл чадмуй.
35. Аяа, Адамын үр сад аа! Та нарт өөрсдийн чинь дотроос Миний айлдваруудыг тайлбарлах гэгээн элчүүд ирэхэд чин үнэнээр сүсэглэж, хүмүүжсэн хүмүүст айх аюул, гутрал гуниг үгүй.
36. Бидний айлдваруудыг худал гэж үгүйсгэгчид, биеэ тоон үл тоомсорлогчид халуун тамынхан, тэд тэндээ эгнэгт үлдэнэ.
37. Аллахыг гүжирдэн гүтгэгчид болон Түүний айлдваруудыг худал гэж үгүйсгэгсэдээ илүү зальхай этгээд байна гэж үү? Тэдэнд Лаухил-Махфуз буюу хувь тавилангийн дэвтэрт бичигдсэн хувь заяа нь оногдмуй. Эцэст нь Бидний элч мэлжүүд ирж тэдний амийг авахдаа: “Аллахтай эн зэрэгцүүлэн шүтсэн зохиомол бурхад чинь яасан вэ?” гэж асууна. Тэд : “Биднийг орхиж алга болсон!” гэж хариулна. Ийнхүү тэд өөрсдийн үл сүсэглэлдээ өөрсдөө гэрч болцгоодог юм.
38. Аллах тэдэнд (өөрсдийнхөө айлдваруудыг үгүйсгэгчдэд) хандан: “Та нар өөрсдөөс чинь өмнө ирээд явсан чөтгөр шуламын сүг болон буруу номтнуудтай цуг тамын галд орогтун” гэж хэлнэ. Тамын галд орсон бүхэн өмнөх зам нэгтнүүдийг хараан зүхэх болно. Эцэст нь бүгдээрээ цуглармагц сүүлчийнх нь өмнөхүүдийг зааж : “Аяа, Эзэнтэн минь ээ! Эд нар биднийг төөрөгдүүлсэн. Тэдэнд халуун тамын зовлонг хоёр дахин илүү хүртээ!” гэцгээх болно. Аллах тэдэнд : “Бүгдээрэнд чинь хоёр дахин илүү гэсгээл оногдоно. Гэвч та нар гэсгээл цээрлэлийн хатуу зовлонг үл мэддэг” гэнэ.
39. Тэдний өмнөхүүд нь сүүлчийнхэндээ : “Та нарт биднээс илүү юм юу ч байхгүй! Та нар ч хийснийхээ хэрээр гэсгээл амсагтун” гэцгээнэ.
40. Бидний айлдваруудыг худал хэмээн үгүйсгэгчид болон биеэ тоон, үл тоомсорлогчдоод тэнгэрийн үүд хаалга нээгдэхгүй. Хүсэлт нь хүлээн авагдахгүй. Зүүний сүвэгчээр тэмээ багтаж өнгрөх хүртэл тэд диваажинд үл ормуй. Бид нүгэлтнүүдийг ийнхүү гэсгээнэ.
41. Тамд тэдний төлөө галаар бэлтгэсэн ор хөнжил байдаг. Бид зальхай этгээдүүдийг ингэж гэсгээдэг юм.
42. Наминчлан, буянтай сайн үйл хийгсэд бол -Бид хэн нэгэнд хэр чадлаас нь хэтэрсэн үүрэг оногдуулдаггүй-. Тэд диваажингийнхан, тэнд эгнэгт оршмуй.
43. (Даваажинд) Бид тэдний зүрх сэтгэлээс нь ош хонзонг хөөн зайлуулна. Хажуугаар нь ариун булаг урсгамуй. Тэд : “Бүхий л сайшаал талархал биднийг зөв замаар хөтөлсөн Аллахт зориулагдаг! Хэрэв, Аллах биднийг зөв замаар хөтлөөгүйсэн бол өөрсдөө зөв замыг хэзээ ч олж чадахгүй байсан билээ. Эзэнтний маань гэгээн элчүүд л чин үнэнийг бидэнд авчирсан” гэнэ. Аллах тэдэнд : “Та нарын үйлдсэн сайн үйлсийн хариуд өвлүүлэх диваажин чинь энэ байна” гэж айлдана.



44. Диваажингийнхан тамынханд хандан : “Эзэнтний маань бидэнд амалсан зүйл нь чин үнэн болохыг олж мэдлээ. Та нар ч гэсэн Танай Эзэнтний амалсан зүйл чин үнэн болохыг олж мэдсэн үү?” гэж хашгирдаг. Тамынхан: “Тиймээ” гэгцгээнэ. Энэ үеэр тэдний дундаас нэгэн дугарагч : “Аллахын хараал зальхай этгээдүүдэд хүрэг!” гэж хашгирна.
45. Тэд (зальхай этгээдүүд), Аллахын дардан замд саад учруулж, мушгин гуйвуулна, хойд нас, ертөнцийн төгсгөлд үл итгэдэг юм.
46. Даваажингийнхан болон тамынхны дунд тусгаарласан хөшиг буй. Тэдний дээрх Аграф хэмээх дэнжигнүүр дээр тэднийг гадны төрхөөр нь таньдаг хүмүүс байдаг. Тэд диваажингийнханд : “Та нарт эрүүл энхийг хүсье!” гэж хашгирцаана. Учир нь тэд диваажинд хараахан орж амжаагүй, найдлага тавигсад билээ.
47. Тэдний хараа тамынхан дээр тусахад : “Аяа, Эзэнтэн минь ээ! Биднийг энэхүү зальхай этгээдүүдтэй бүү нийлүүлэгтүн” гэж залбирна.
48. Аграф дээр байгсад тамынхныг нүүр төрхөөр нь таньж мэдээд : “Та нарын хураасан эд хөрөнгө болон эрхэмсэг зан чинь юунд тус болох вэ?” гэж асууна.
49. (Аграф дээр зогсогчид тамынханд диваажингийнхныг заангуут) : “Та нарын, Аллахын хайр энэрэл хүртэхгүй гэсэн хүмүүс чинь эд нар юм уу?” Харин ч тэдэнд: “Диваажинд орогтун! Та нарт ямар ч айх аюул, гутрал гуниг тохиолдохгүй” хэмээн хэлнэ.
50. Тамынхан, диваажингийнханд хандан : “Аллахын та нарт хайрласан ус ундаанаас бидэнд өгөөч!” гэж хашгиралдан гуйна. Тэд (диваажингийнхан): “Аллах эдгээрийг буруу номгнуудад заяагаагүй” хэмээн хариулна.
51. Буруу номгнууд - өөрсдийн шашин, итгэл бишрэлээ доромжлон, тоглоом тохуу болгогсад, мөн амьдын жаргалд ташаарч хууртагсад билээ. Бидний айлдваруудыг үгүйсгэсэн нь эдгээр өдрүүдтэй учруулахыг мартсаны нэгэн адил, Бид ч энэ өдөр тэднийг мартаж, хөсөр хаяна.
52. Бид сүсэглэгч ард олонд зам заагч, нигүүлсэгч нэгэн судар илгээн түүнийг боловсролтойгоор нэгт нэгэнгүй тайлбарлаж өгсөн.
53. Буруу номгнууд бэлэнчилсэн зүйл хүсдэг. Түүний үр дүн ирэх өдөр (ертөнцийн төгсгөлийн өдөр), түүнийг (куран судар) мартагсад : “Үнэндээ Эзэнтний элчүүд чин үнэнийг авч ирсэн юмсан. Одоо биднийг тэтгэгч, ивээн энэрэгчид байгаа юм болов уу? Эсвэл нүгэл үйлдэхээ больж, сайн үйлс хийхийн тулд гэрэлт ертөнц руу буцаан илгээж болохсон болов уу?” гэгцгээдэг. Тэд үнэхээр өөртөө лай хураасан хүмүүс. Тэдний зохиомол бурхад нь нүдэнд ч үзэгдэхгүй орхиж одсон.
54. Үнэндээ танай Эзэнтэн болох Аллах тэнгэр, газрыг зургаан өдөрт

- бүтээсэн. Дараа нь Аршыг (сансар огторгуйг) эрхшээсэн. Тэрбээр шөнөөр (харанхуйгаар) өдрийг бүрхсэн. Өдөр, шөнө хоёр ээлжлэн солигдож байхаар зохицуулав. Бас нар, сар, оддыг Өөрийн эрхшээлд оруулсан. Бүтээх, эрхшээн захирах нь зөвхөн Түүнийх болохыг анхаарагтун! Аугаа их Аллах бүхий л ертөнцийн эзэн билээ.
55. Эзэнтэндээ талархалтаяа, нууцаар залбиран гуйгтун. Хэмээс хэтрэгсэдийг Тэр ташаахгүй.
  56. Аллах даян дэлхийг төлөвшүүлэн зассаны дараа бүү танхайран самуурагтун! Аллахаас айж эмээн, Түүний хайр энэрэлийг горилон залбирагтун. Үнэндээ Аллахын энэрэл ивээл нь сайн үйл үйлдэгсдэд ойрхон байдаг.
  57. Тэрбээр өөрийн хайр энэрэлийнхээ өмнө салхилуулан хур борооны баярт мэдээг илгээнэ. Салхи нүсэр үүлсийг түрэхэд түүнийг гандуу газар руу нүүлгэж, бороо оруулж түүгээр Бид төрөл бүрийн жимс жимсгэнэ ургуулдаг. Тэрчлэн үхэгсэдийг ч амилуулна. Үүнээс сургамж авцгаах биз дээ.
  58. Аллахын ивээлээр үржил шимтэй газарт ургамал шигүү элбэг ургадаг. Энэ нь итгэл сэтгэлтэй сүсэгтнүүдийн жишээ. Үржил шимгүй газарт ургамал сийрэг тарчиг ургадаг. (энэ бол сүсэг муутай, итгэл бишрэлгүйн жишээ) Итгэн бишрэгсэдэд Бид өөрсдийн айлдваруудаа ийнхүү зөвлөн тайлбарладаг.
  59. Бид Нухыг өөрийн зон олонд гэгээн элч болгон илгээсэн. Тэр ард олондоо: "Аяа, ард олон минь ээ! Аллахт итгэж, мөргөн залбирагтун! Та нарт түүнээс өөр бурхан байхгүй. Би та нарт тохиох аугаа өдрийн гэсгээлээс айж байна" гэж хэлэв.
  60. Гэтэл нутгийн толгойлогчид нь : "Бид чамайг илэрхий төөрөгдөлд орсон гэж ойлгодог" гэв.
  61. (Нух) Тэдэнд хандан: "Аяа, ард олон минь ээ! Би огтхон ч төөрөлдөөгүй. Миний бие бүхий л ертөнцийн Эзэнтнээс илгээгдсэн элч болой" гэж хариулав.
  62. Би та нарт Аллахын зарлигийг уламжлах бөгөөд ухуулан таниулах сургамж айлдах болно. Та нарын мэдэхгүй зүйлийг Аллахын илгээснээр мэддэг юм.
  63. Мөн: "Та нарт сургамж өгөх, биеэ тоохоос сэрэмжлэх, Эзэнтний хайр ивээлд багтаахын тулд та нарын дунд буй нэгэн хүнээр дамжуулан ухуулга – сургаал илгээсэнд нь гайхмаар байна гэж үү?" гэв.
  64. Тэд түүнийг (Нухыг) худалч хэмээн хүлээн зөвшөөрсөнгүй. Тиймээс, Нухыг болон түүнтэй хамт усан онгоцонд байгсадыг аварч, Бидний айлдваруудыг худал хэмээн үгүйсгэгчдийн бүгдийг усанд живүүлсэн юм. Тэд үнэхээр сохорсон хүмүүс байлаа.
  65. Мөн Бид Гад омог руу ч түүний хамаатан садан Худыг илгээсэн. Худ

- тэдэнд хандан: "Аяа ард олон минь ээ! Аллахад наминчлан мөргөгтүн! Та нарт түүнээс өөр бурхан байхгүй. Та нар Түүнээс айж имээхгүй гэж үү?" хэмээн анхааруулсан.
66. Түүний харьяат олны эрхэм дээдсүүд нь: "Үнэндээ бид чамайг солиорсон гэж үзэж байна, мөн чамайг худалч гэж бодож байна" гэв.
67. (Худ): "Аяа, ард олон минь ээ! Би солиороогүй байна. Харин ертөнцийн Эзэнтний зүгээс илгээгдсэн нэгэн элч болой" гэж хариу өчив.
68. "Би та нарт Эзэнтний илгээлтийг уламжлана. Би та нарын хувьд итгэлтэй ухуулагч юм"
69. "Эзэнтний зүгээс та нарт сэрэмжлүүлэхийн тулд өөрсдийн чинь дотроос нэгэн хүнээр дамжуулан сургамж ирүүлсэн нь гайхмаар байна гэж үү? Нухын ард олон мөхсөний дараа Аллах та нарыг тэдний арыг залгамжлагч болгосныг, та нарын бие бялдрыг бусдаас илүү заяасныг санагтун! Аллахын хайрласан хувь хишгийг санагтун! Тэгвээс та нар зовлонгоос аврагдаж юу магад" гэж сануулав.
70. Тэд: "Эцэг өвгөдөөс уламжлан залбиран мөргөж ирсэн бурхадаас татгалзуулж, биднийг гагцхүү Аллахад мөргүүлэхийн тулд ирсэн юм уу? Хэрэв, чиний хэлсэн зөв юм бол биднийг сүрдүүлж буй тэр гэгсгээлээ аваад ир!" гэгцгээв.
71. (Худ): "Эзэнтний уур хилэн, гэгсгээл та нарыг гарцаагүй дайрана. Та нар болоод эцэг өвгөд чинь янз бүрээр нэрлэдэг бурхадын (зохиомол бурхадын) тухайд Аллах ямар ч нотолгоо илгээгээгүй байхад та нар надтай маргалдана гэж үү! Хэрэв тийм бол Аллахын цээрлэлийг хүлээгтүн, Би ч та нартай хамт хүлээгсэдийн нэг болог" гэв.
72. Тэгээд Бид Өөрийн нигүүлслээр Худыг хамт байгсадтай нь цуг аварч, Бидний айлдваруудыг худал гэж үгүйсгэсэн үл сүсэглэгчдийн үндсийг тасалсан юм.
73. Мөн адил Бид, Самудын ард олонд түүний хамаатан Салих-ыг гэгээн элчээр илгээлээ. Тэр: "Аяа, ард олон минь ээ! Аллахад залбиран мөргөгтүн! Та нарт Түүнээс өөр бурхан байхгүй. Та нарт Эзэнтнээс ил тод, (Миний гэгээн элч болсны нотолгоо) ер бусын гайхамшиг ирсэн. Аллагаас ирүүлсэн энэхүү ингэн тэмээ та нарт ер бусын гайхамшиг байх болно. Өөргөө хатуу гэгсгээл учруулахгүйн тулд түүнийг дураар нь орхигтун! Аллахын бүтээсэн тал дээр тааваараа идээшлэг! Түүнд ямар нэгэн хор бүү хүргэгтүн!" хэмээн сануулав.
74. Аллах та нарыг Гад-ын ард түмний дараа тэдний залгамжлагч болгож (Хижр)ын газар нутагт суурьшуулсныг санагтун! Та нар энэ нутгийн тал хөндийг орд харш барин, уулыг нь ухаж орон байр болгосон. Тиймээс Аллахын та бүхэнд хайрласан хувь хишгийг санагтун! Мөн газар дэлхий дээр үймээн самуун бүү таригтун!
75. Салихын зон олны ихэмсэг дээдэс нь сүсэгтнүүдийг дорд үзэж: "Та

- нар, Салихыг Эзэнтний зүгээс илгээгдсэн үнэнхүү элч хэмээн мэдэж байна уу?" гэхэд тэд : “Бид түүний гэгээн элч гэдэгт итгэдэг, төгс сүсэглэгчгээдэг” хэмээн хариулав.
76. Өнөөх ихэмсэг дээдэс нь: “Та нарын итгэсэн зүйлд бид ердөө ч үл итгэнэ” гэв.
  77. Тэгээд ихэмсэгүүд нөгөө ингийг алж, Эзэнтний зарлигийг зөрчицгөөж, түүгээр ч үл барам: “Аяа, Салих! Хэрэв чи үнэхээр гэгээн элч юм бол биднийг сүрдүүлсэн тэр гэгсгээлээ үзүүлээд аль!” хэмээн ихэрхэв.
  78. Тэгтэл, тэр даруй газар чичэрч, тэд бүгдээрээ орон гэртээ өвдөг сөгдсөн хэвээр хошиж мөхлөө.
  79. Салих тэднээс нүүр буруулж : “Аяа ард олон минь ээ! Үнэндээ би та нарт Эзэнтний зарлигийг уламжлан, сургаал айлдсан. Гэвч та нар сургаал айлдагчийг тохуурхан зөвшөөрөөгүй билээ” гэв.
  80. Бас Лутыг өөрийн ард олонд нь (Садум-д) гэгээн элчээр илгээсэн. Лут өөрийн ард олонд хандан : “Та нар газар дэлхийд урьд өмнө хэн ч үйлдээгүй бузар үйлийг үйлдэх гэж үү?” хэмээн сануулав.
  81. Мөн: “Та нар хүсэл тачаалаа эмэгтэйчүүдээр биш эрэгтэйчүүдээр хангадаг. Та нар үнэхээр Аллахын хэм хэмжээг зөрчигсөд мөн!” гэв.
  82. Түүний ард олон нь : “Лут болон түүний хамсаатнуудыг хот суурингаас хөөж явуулагтун. Тэд их цэвэр ариун хүмүүсийн дүр эсгэгчид” гэхээс өөр юм ярьсангүй.
  83. Тэгээд Бид Лут болон гэр бүлийнхнийг аварсан. Гагцхүү түүний эхнэр нь хотод үлдэж, цээрлэл үзэгчдийн эгнээнд орсон билээ.
  84. Тэдний дээрээс (чулуугаар) бороо оруулав. Ийнхүү нүгэлтэнүүдийн төгсгөл хэрхэснийг харагтун!
  85. Мадияны ард олонд өөрийн хамаатан Шугайбыг гэгээн элчээр илгээв. Тэр ард олондоо хандан : “Аяа, зон олон минь ээ! Аллахад мөргөгтүн! Та нарт Түүнээс өөр бурхан байхгүй. Та нарт Эзэнтнээс яруу тод нотолгоо ирсэн. Тиймээс жингийн тухайг бүү дэнжигнүүлээрэй. Хүмүүст юм өгөхдөө бүү дутуу хэмжигтүн. Аллах гэгээн элчээ илгээн, газар дэлхийг төвшитгэсний дараа үймээн самуун бүү таригтун. Хэрэв, бишрэн сүсэглэглэвэл та нарт тэр нь өлзийтэй гэв.
  86. Мөн сүсэглэгсэдийг сүрдүүлэн, Аллахын замаас урвуулан, буруу зам руу хөтлөх гэж бүү оролдогтун. Аллах та нарыг цөөхүүл байхад үржүүлж өсгөснийг санагтун. Танхайрагчдын тавилан хэрхэн төгссөнийг харцгаагтун!
  87. Та нарын нэг хэсэг нь миний гэгээн элч гэдэгт итгэж, нөгөө хэсэг нь үл итгэвэл, Аллах бидэнд зарлигаа илгээх хүртэл тэвчигтүн. Тэр хамгийн шударга шийдвэр гаргагч билээ.
  88. Түүний ард олны ихэмсэг дээдэсүүд: “Аяа, Шугайб! Бид чамайг

- дулдуйдагсадынхаа хамт хотоос хөөж гаргана. Эсвэл та нар манай шашин рүү буцаж ирцгээ” гэв. Шугайб : “Бид хүсээгүй байсан ч ингэх гэж үү?” хэмээн хариулав.
89. Аллах биднийг зохиомол хуурамч шашинаас аварсан атал бид дахин түүн руу буцвал үнэндээ Аллахыг гүжирдсэн хэрэг болно. Иймд, Аллах охтхон ч хүсээгүй байхад бид тэр зохиомол хуурамч шашин руу буцаж орохгүй. Эзэнтний маань эрдэм мэдлэг эрхшээдэггүй зүйл гэж ер үгүй. Бид зөвхөн Аллахад найддаг. “Аяа, Эзэнтэн минь ээ! Бидний болоод ард олны маань хоорондох маргааныг чин үнэнээр нь шүүж өгөгтүн. Чи бол хамгийн шударга шүүгч билээ.
  90. Мөн түүний ард олны сүсэг бишрэлгүй ихэс-дээдэс нь : “Хэрэв, та нар Шугайбыг дагах аваас их хохирлыг амсах нь эргэлзээгүй” хэмээн сүрдүүлэв.
  91. Иймээс газар чичирч, тэд бүгдээрээ орон гэртээ сөхөрсөн чигээрээ хөшиж мөхсөн болой.
  92. Шугайбыг худал хэмээн үгүйсгэгчид ийнхүү цээрлэл үзэж, энэ хорвоод байгаагүй мэт ул мөргүй боллоо. Тэд жинхэнэ хохирол амсагсад болцгоосон билээ.
  93. Шугайб тэднээс нүүр буруулж : “Аяа, зон олон минь ээ! Үнэндээ би та нарт Эзэнтний зарлигийг уламжлан, сургамж айлдсан билээ. Нэгэнт эсэргүүцсэн үл сүсэглэгчдийн төлөө гашуудаад ч яах билээ?” гэв.
  94. Бид ямар нэгэн хот руу гэгээн элч илгээсэн л бол тэдний оршин суугчид Аллахад наминчлан залбираг гээд тэдэнд үгүйрэл, бэрхшээл учруулан шалгадаг.
  95. Дараа нь Бид тэрхүү муу юмыг нь сайн сайхнаар сольдог. Гэтэл тэд баяжиж өсөж үржээд Аллахын ачийг мартаж: “Манай эцэг өвгөд ч зовлон, жаргалыг үзэж явсан шүү дээ” гэж хэлцгээсэн. Иймээс тэднийг санаандгүй байхад гэнэтийн гэсгээлд учруулсан юм.
  96. Хэрэв тэр хотуудын оршин суугчид сүсэглэж, (нүглээс) болгоомжилсон бол, мэдээж Бид тэднийг тэнгэр, газрын баялагт бялхуулах байсан юм. Бид тэдний араншин, нүглийн төлөө нэрвэсэн болой.
  97. Бидний илгээсэн элчийг үгүйсгэдэг хотуудын оршин суугчид шөнө дөлөөр унтацгааж байхад нь Бидний аюумшигт цээрлэл ирэхгүй гэдэгт бат итгэж байна гэж үү?
  98. Мөн тэр гэсгээл цээрлэл өглөө эрт эсвэл наргин цэнгэж байхад нь гэнэт дайрахаас болгоомжилдоггүй юм уу?
  99. Тэд Аллахын урхинаас мултрана гэдэгт итгэлтэй байдаг юм биш биз? Гагцхүү хохирол амсагч ард иргэд л Аллахын урхинаас сэрэмжилдэггүй юм.
  100. Өмнөх эздүүдийн дараа газар дэлхийг өвлөн авагсдад өдий хүртэл энэ үнэн (өмнөх ард иргэдийн гэсгээл) тодорхой болоогүй гэж үү дээ?

- Хэрэв бид хүсвэл тэднийг ч үйлдсэн нүглээр нь гай зовлонд учруулна гэдгийг тэд мэдээгүй байна уу? Тэдний зүрх сэтгэлийг тамгалсан учир тэд үнэнийг сонсож чадахгүй.
101. Аяа, Мухаммед! Тэр хотуудын заримын тухай чамд тайлбарлаж байна. Үнэндээ, гэгээн элчүүд нь тэдэнд яруу тод нотолгоонууд авч ирцгээсэн юм. Гэвч тэд өмнө нь худал хэмээн хүлээн зөвшөөрөхгүй зүйлд итгэдэггүй юм. Үл сүсэглэгсэдийн зүрх сэтгэлийг Аллах ийнхүү тамгалдаг бөлгөө.
  102. Бид тэдний олонхи нь амлалтандаа хүрсэнийг үзээгүй. Харин ч ихэнх нь худалч, хуурмаг байсныг олж харсан юм.
  103. Дараа нь тэдний араас Бид Мусаг ер бусын гайхамшигуудтай хамт Фиргаун болоод түүний ард түмэнд илгээсэн боловч, тэд үүнийг бас л үгүйсгэсэн юм. Сагсууран танхайрагчдын хувь заяа хожим хэрхэн төгсөхийг харатун!
  104. Муса тэдэнд хандан : “Аяа Фиргаун! Үнэндээ би ертөнцийн Эзэнтний илгээсэн элч мөн” хэмээн сануулав.
  105. “Муса Миний бие Аллахын нэрийн өмнөөс гагцхүү чин үнэнийг ярих ёстой. Үнэндээ та нарт Эзэнтнээс яруу тод нотолгоонууд авч ирсэн. Иймд Израйлын үр садыг чөлөөлж, надтай хамт явуулагтун” гэсэн.
  106. (Фиргаун): “Хэрвээ чи ер бусын гайхамшиг авч ирсэн бол, бас үнэнч шударгуудын нэгэн юм бол, алив түүнийгээ бидэнд харуулагтун” гэв.
  107. Муса таягаа газар руу шидэв. Тэр, даруй могой болж хувирав.
  108. Тэгээд гараа өврөөсөө гаргасан даруйд гэнэтхэн гэгээ цацруулан хүмүүсийн нүдэнд цав цагаан болж харагдсан.
  109. Фиргауны ард олны дээдэс нь: “Энэ бол эргэлзээгүй илбэч юм байна” гэв.
  110. Фиргаун : “Та нарыг нутгаас (Египет) чинь хөөх гэж байна. Ямар зөвлөлтөө өгөх юм вэ?” гэв.
  111. Фиргауны ардууд : “Муса болон түүний ахан дүүсийн ажиллагааг зогсоон, хотын илбэчдийг цуглуулах хүмүүс явуулагтун.
  112. Хамгийн чадвартай илбэчдийг чам дээр авч ирэг” гэж зөвлөцгөөв.
  113. Хотын илбэчид Фиргаун дээр ирцгээн: “Хэрэв, бид түүнийг ялбал биднийг шагнах юм байгаа биз?” гэлцэв.
  114. Фиргаун: “Тиймээ, шагнана.Тэгээд та нар миний хамгийн ойр дотны хүмүүс байх болно” гэв.
  115. Илбэчид: “Аяа, Муса, таягийг чи эхлээд шидэх үү, эсвэл бид шидэх үү?” хэмээн асуув.
  116. Муса: “Та нар шидэгтүн” гэв. Тэд таяг, утас юугаан шидэцгээж, хүмүүсийг илбэдэн ховсдож, таяг утас нь могой болж хувирч, тэднийг сүрхий айлгав. Тэд ийнхүү ид шидийг үзүүлэв.

117. Бид (Аллах) Мусад : “Чи ч таягаа шид” гэж зарлиг буулгав. Муса таягаа шидэхэд тэр даруйд таяг аварга могой болон хувирч тэдний хуурамч могойнуудыг залгиж орхилоо.
118. Ийнхүү тэдний хуурамч илбэ илэрч, үйлс бүхэн нь талаар өнгөрлөө.
119. Ингээд, Фиргауны талынхан ялагдлаа хүлээж, шившигээ дэлгэн буцацгаав.
120. Харин илбэчид бүгдээрээ өвдөг сөгдөн, мөргөцгөөлөө.
121. Тэд : “Бид бүхий л ертөнцийн Эзэнтэнд төгс итгэлээ” гэгцгээв.
122. Мөн: “Муса, Харун хоёрын Эзэнтэнд!” хэмээн давтлаа.
123. Фиргаун : “Би зөвшөөрөл олгоогүй байхад та нар түүнд наминчалсан! Энэ бол хэрэг дээр хотын ард иргэдийг эндээс хөөхийн тулд зохиож буй та нарын арга мэх. Тиймээс, та нар хэрхэн цээрлэгдэхээ ойрын хугацаанд мэдэх болно!” гэв.
124. “Би та бүхний баруун гар, зүүн хөлийг чинь зөрүүлэн цавчиж, тэгээд бүгдийг чинь дүүжлэн хороох болно!” хэмээн зандрав.
125. Тэд(Илбэчид) : “Биднийг хөнөөвөл Эзэнтэн рүүгээ эргэж очмуй” гэгцгээв.
126. Мөн: “Чи биднийг гагцхүү Эзэнтнийхээ илгээсэн айлдваруудад итгэснийхээ төлөө буруутгаж байна. Аяа, Эзэнтэн маань! Бидэнд хүлцэл-гэвчээр хайрлагтун! Мөн бидний амийг үнэн сүсэгтэн хэвээр авагтун” хэмээн залбирцгаав.
127. Фиргауны ард олны дээдэс нь : “Чи, Муса болон түүний ард олны танхайралд нь, бас чамайг болон бурхадыг чинь хөсөр орхиход нь боломж өгч байгаа юм уу?” гэгцгээв. (Фиргаун) тэдэнд: “Бид тэдний бүх хөвгүүдийг нь устгаж зөвхөн эмэгтэйчүүдийг нь амьд үлдээмүй! Ийнхүү бид тэднийг захирах давуу эрхтэй байх болно!” гэж хариулав.
128. Муса ард түмэндээ хандан : “Аллахаас дэм тус гуйцгаая, тэвчээртэй байцгаая. Энгүй уудам дэлхий Аллахад харьяалагдах нь маргаангүй! Аллах хүссэн боолуудад түүнийг өвлүүлдэг. Эцсийн амжилт Аллагаас айж буй гэгээн ухаантнуудынх” гэв.
129. Мусагийн ард түмэн түүнд (Мусад) хандан : “Чи бидэнд ирэхээс өмнө ч бид зовж байсан, чамайг ирсэнээс хойш ч зовж байна” гэгцгээв. Муса: “Эзэнтэн дайснуудыг чинь сөнөөж, тэдний оронд та нарыг тавьж, та нарын юу хийхийг харж магадгүй юм” гэлээ.
130. Бид үнэндээ, Фиргауны бүлгийг ухаарч, сургамж аваг гээд олон жилийн турш газрыг нь цөлжүүлж, ургац алдуулан туршсан билээ.
131. Тэдэнд сайн сайхан ирсэн үед : “Бид үүнийг хүртэх ёстой, эрхтэй” гэж хэлцгээдэг. Хэрэв гай зовлон тохиолдвол Муса хийгээд түүний хамсаатнуудын гай гэж бодоцгоодог. Үгүй ээ! Тэдэнд ирсэн гай зовлон Аллахын гэгсгээл. Харин, тэдний олонхи нь үүнийг ойлгодоггүй.

132. Тэд (Фиргаун болон түүний талын хүмүүс) : “Биднийг илбэдэхийн тулд ямар ч ер бусын гайхамшигийг харуулсан ч бид чамд үл итгэмүй!” гэнэ.
133. Тиймээс, Бид тэдэнд ер бусын гайхамшиг болгож үер, царцаа, бөөс, мэлхий, цус зэрэг аюулыг илгээсэн билээ. Тэгсэн ч тэд их зан гаргаж, нүгэлтэн болцгоосон.
134. Харин гай зовлон толгойд нь төөнөхөд : "Аяа, Муса! Эзэнтнийхээ чамд амласан ёсоор бидний төлөө Түүнд залбирч, биднийг зовлонгоос ангижруулахыг гуйгаач! Чи ингэвэл бид чамд төгс итгэж, Израилийн үр удмыг чамтай хамт явуулах болно" гэцгээсэн юм.
135. Бид тэднийг гай зовлонгоос тодорхой хугацаагаар салгасан ч тэд амлалтаасаа няцсан юм.
136. Бидний айлдваруудыг худал хэмээн үгүйсгэж, үл тоомсорлосон тул тэднийг далайд живүүлж, гэсгээсэн билээ.
137. Хавчилга үзсэн олныг (Израилийн үр садыг) өгөөж буянтай нутгийн (Сирийн Шам нутаг) баруун, зүүн хэсгийг эзэмшүүлсэн юм. Израилийн үр сад нь тэвчээр гаргасны хариуд нь Аллахын тэдэнд өгсөн амлалт нь бүрэн биелэгдсэн билээ. Мөн Бид Фиргаун болон түүний ард түмний бүтээн байгуулсан бүхнийг үнсэн товрог болгосон юм.
138. Израилийн үр удмыг тэнгис далай гатлуулан авчрав. Тэд хуурамч зохиомол бурхад шүтдэг нэгэн ардад ирэнгүүт: “Аяа, Муса! Бидэнд энэ хүмүүсийнх шиг бурхан бүтээж өгөөч” гэж гуйв. (Муса) тэдэнд : “Та нар үнэхээр харанхуй мунхаг хүмүүс юм даа!” гэв.
139. Мөн: “Тэдний шүтдэг зохиомол шашин нь гарцаагүй мөхнө. Тэдний хийсэн бүхэн талаар өнгөрмүй” гэж хариулав.
140. (Муса) Тэдэнд: “Аллах та нарыг бусдаас дээгүүр өргөмжилсөн байхад би та нарын төлөө Аллагаас өөр Бурхан хайх гэж үү?” гэв.
141. Бид та нарыг зовоон тарчилгасан, хөвгүүдийг чинь хороосон, эмэгтэйчүүдийг чинь доромжилоод аваад үлддэг байсан Фиргауны садар самуун бүлгээс аварсан шүү дээ! Энэ бүхэн Эзэнтний зүгээс та нарыг шалгасан их сорилго байсан болой!
142. (Надад наминчлан залбирахад нь зориулж) Мусад гучин шөнийн хугацааг өгсөн, тэгээд түүн дээр арван шөнийг нэмж, ийнхүү Эзэнтний тогтоосон хугацаа дөчин шөнө боллоо. Муса ах-дүү Харунд хандан : “Миний оронд манай ардыг чи удирдагтун. Тэдэнд журам сахиул, үймээн самууны эздийн замаар бүү орогтун!” гэж захилаа.
143. Муса, товлосон хугацаанд ирж, Эзэнтэн нь түүнтэй ярилцахад (Муса): “Аяа, Эзэнтэн минь ээ! Өөрийгөө надад харуулаач! Чамайг сайн хармаар байна” гэв. (Аллах) : “Чи хэзээ ч Намайг харж чадахгүй ээ! Гэхдээ тэр уул руу хар. Хэрэв уул байрандаа хөдлөхгүй байж чадвал чи намайг харах болно!” хэмээн хэлэв. Тэгээд Эзэнтэн ууланд сүр хүчээ буулгаж уулыг үнсэн товрог болгож тэгшлэв. Муса ухаан алдачихлаа.



- Улмаар ухаан оронгуутаа : “Аллах чи ариун догшин. Чамд наминчлан залбирлаа. Мөн би Чамд итгэн бишрэгсэдийн анхдагч нь байх болно” гэж хэллээ.
144. (Аллах) : “Аяа, Муса! Үнэндээ Би чамайг олны дундаас гэгээн элчээр сонгож, Надтай ярихыг зөвшөөрлөө. Чамайг өөрийн гэгээн элч болгосныг хүлээн авч, надад талархагсадын эгнээнд багтаж явагтун” гэв.
145. Бид Мусагийн төлөө Тауратын (Тора) самбарууд дээр ухуулга сургаал, зарлигуудыг бичсэн. Үүнд : “Түүнийг (Тауратыг) чандлан сахь, ард олондоо түүнд буй хамаг сайн зааварчилгааг дагаж мөрдөхийг тушаа! Би та нарт муу санаат мунхагуудын (Фиргаун ба түүний бүлгийн) түйвээгдсэн ор суурийг харуулна.
146. Газар дэлхий дээр шударга бусаар биеэ тоон өөрсдийгөө өргөмжлөгсөдийг айлдваруудаас холдуулах болно. Тэд бүхий л ер бусын гайхамшигийг үзсэн ч түүнд үл итгэмүй. Зөв шулуун замыг харсан ч түүгээр замнахгүй. Харин төөрөгдлийн замыг үзвэл ухаан жолоогүй түүнийг дагана. Энэ нь Бидний айлдваруудыг үгүйсгэн, түүний гадна үлдсэнтэй холбоотой.
147. Бидний айлдварууд хийгээд хойд ертөнцтэй учрахыг үгүйсгэгсдийн бүхий л үйлс талаар болно. Тэд гагцхүү үйлдсэн үйлийнхээ хэмжээгээр шийтгэгдэх бөлгөө.
148. Муса Аллахад наминчлан залбирахын тулд Тур ууланд явсны дараа түүний ардууд гоёлын зүйлүүдээрээ мөөрдөг нэгэн тугалын дүр бүтээсэн. Тэд, тугалтай ярилцаж чадахгүй хийгээд тэдэнд зөв зам зааж чадахгүй гэдгийг ухаарахгүй юм гэж үү дээ! Тэд түүнийг бурханчлан шүтээд зальхайчууд болов оо!
149. Өөрсдийнхөө үнэхээр төөрөлдсөнийг (тугалыг шүтэн) машид харамсан сая л ухаарч: “Хэрэв, Эзэнтэн маань биднийг өршөөн энэрэхгүй бол, бид гашуун зовлон амсах нь!” хэмээн халаглав.
150. Буцаж ирсэн Муса зон олондоо уурлаж хилэгнэн, урам нь хугарч: “Миний эзгүйд ар хударгаар минь та нар (тугалыг бурханчлан шүтэж) муухай зүйл үйлдсэн байна. Эзэнтнийхээ зарлигийг хүлээлгүйгээр юунд яарсан вэ?” хэмээн уурандаа Тауратын самбаруудыг шийдлэн, садан төрөл Харуныг үстэж, өөр рүүгээ угз татав. Харун : “Аяа, дүү минь ээ! Энэ олон чинь намайг дээрэлхэн алах шахлаа. Чи намайг дайсны шившиг болгож, тэдний дунд бүү илгээгтүн!” хэмээн гуйв.
151. Муса : “Аяа, Эзэнтэн минь ээ! Намайг болоод миний ахан дүү Харуныг өршөөн соёрх. Биднийг ивээл энэрэлдээ багтааж хайрлагтун! Чи хамгийн илүү энэрэн нигүүлсэгч шүү дээ!” хэмээн залбирав.
152. Тугалыг бурханчлан шүтэгсэд гарцаагүй Эзэнтний хилэнг хүртэж, энэ насны зовлон эдэлнэ. Аллахыг гүтгэгсэдийг Бид ийнхүү шийтгэнэ.

153. Муу үйл үйлдэн буруугаа хүлээн гэмшиж, чин үнэнээр сүсэглэвэл Эзэнтэн чинь дараа ч гэсэн уучлан өршөөно!
154. Муса тайвширсаныхаа дараа Тауратын самбруудыг гартаа авлаа. Тэнд : “Эзэнтнээс айж эмээгсэдэд зөв зам, хайр энэрэл буй” гэж бичигдсэн бөлгөө.
155. Муса Бидний (Аллахын) тогтоосон цаг болоход товлогдсон газарт аваашихын тулд ард олноос далан хүнийг сонгож авлаа. Тэдний хөл дор газар хүчтэй чичирхүйд Муса : “Аяа, Эзэнтэн минь ээ! Чи тийн хүссэн бол намайг болон тэднийг аль хэдийнээ хөнөөж чадахсан билээ. Гэтэл, эл тэнэгүүдийн үйлдсэн нүглийн төлөө одоо биднийг хөнөөх гэж үү? Энэ нь гагцхүү Чиний сорилт биз дээ. Энэхүү сорилтын дагуу хүссэнээ зөв замаар хөтөлж, хүсээгүйгээ төөрөгдүүлдэг. Чи бол биднийг ивээгч, уучилж өршөөгч Эзэнтэн билээ! Өршөөн соёрхогчдын хамгийн сайн нь Чи билээ!” гэж хэлэв.
156. Мөн: “Бидэнд энэ болон хойд насанд буян хайрлагтун. Бид үнэнхүү Чамайг бишрэн шүтдэг!” гэв. Аллах түүнд : “Би хэн хүссэнээ гэсгээн цээрлүүлнэ. Харин Миний энэрэл хайр хүн төрөлхтний бүгдэд нь хүртээлтэй. Биеэ тоох, нүгэл үйлдэхээс сэргэмжлэгчдэд, өглөг өгөгчдөд, айлдваруудад минь итгэн сүсэглэгсэдэд зориулна” хэмээн хариулав.
157. Тэд, өөрсдөд нь буй Инжил, Таурат хоёрт (элч Мухаммедын нэр болон шинж тэмдэг) бичигдсэн, үмми (бичиг үсэггүй) гэгээн элч Мухаммедыг итгэн дагагсад юм. Тэр гэгээн элч сайн сайхныг зааж, бузар муухайг таслан зогсоодог, цэвэр ариун зүйлийг халал, бузар муухайг хараам болгодог, хүнд ачааг хөнгөлөн, дарамтаас чөлөөлдөг билээ. Мөн тэд (Мухаммедыг итгэн дагагчид) түүнийг хүндэтгэн дэм тус үзүүлдэг, тэрчлэн түүнд илгээсэн сударт (Куран) итгэн бишрэгсэд юм. Ийнхүү тэд ертөнцийн төгсгөлийн зовлон гэсгээлээс аврагдах болно.
158. Аяа, Мухаммед тэдэнд : “Аяа, хүмүүс ээ! Би бол та бүхэнд Аллагаас илгээсэн гэгээн элч болой. Тэнгэр, газрыг эрхшээгч Аллах бөлгөө. Түүнээс өөр ямар ч бурхан байхгүй. Тэрбээр үхсэнийг амилуулж, амьдыг үхүүлдэг. Тиймээс Аллахад, Түүний илгээсэн үмми (бичиг үсэг сураагүй) гэгээн элчид итгэн сүсэглэгчтүн. Тэр ч Аллах болон Түүний сургаалыг шүтдэг. Зөв шулуун зам олъё гэвэл түүнийг дагагтун” хэмээн хэл.
159. Мусагийн ард олны дотор зөв зам руу хөтлөх, үнэн, шударга ёсыг сахидаг нэгэн зон олон бий.
160. Бид тэднийг арван хоёр овог аймагт хуваасан юм. Ард олон нь Мусагаас ундны ус хүсэхэд : “Таягаараа чулууг цохь” хэмээн тушаасан билээ. Муса таягаараа чулууг цохиход түүнээс арван хоёр булаг оргилон гарав. Овог аймаг бүр өөрсдийнхөө ундны булгийг мэдэж авсан. Бид тэдний толгой дээр үүлийг сүүдэрлүүлж, тээрэмдсэн будаа болон

- бөднө шувууг буулгаж, тэдэнд: “Бидний хайрласан хувь хишгийн цэвэр ариунаас нь идэгтүн” гэлээ. Тэд энэхүү хайр ивээлийг мэдрээгүйгээр үл барам үгүйсгэсэн ч Бидэнд хор уршиг учруулж чадахгүй, харин ч өөрсдөө өөртөө гай учруулсан болой.
161. Тэр үед тэдэнд (Израйлийн өвөг дээдэст): “Та нар хотод суурьшиж, хүссэнээрээ идэж уугтун. Хотын хаалгаар орохдоо: “Аяа, Аллах! Бидний нүглийг өршөө” гэж хэлээд залбирч, өвдөг сөгдөж орогтун. Тэгвээс, Бид та нарын гэм нүгэлийг өршөөж, сайн үйлс үйлдэгсдэд илүү буян өгөх болно” гэж сануулсан.
162. Гэтэл тэдний доторх зальхай этгээдүүд Аллахын үгийг өөрчилсөн юм. Иймээс зальхай үйл хийсэний төлөө тэдэнд тэнгэрийн гэгсээлийг явуулав.
163. Зочилон ирэгсэдээс далайн эрэгний усан боомт, тэр хотын байдлыг асуугтун. Тэд загасчлахыг хориглосон бямба гарагт хоригийг зөрчиж байсан билээ. Учир нь загаснууд бямба гарагт усан дээр хөвж гаран тэдний өмнө ирцгээж, бусад өдөр ирдэггүй байлаа. Бид тэднийг нүгэл үйлдсэнийхээ төлөө ийнхүү сорьдог юм.
164. Тэдний дотроос хэсэг хүмүүс : “Аллахад хөнөөгдөх, эсвэл хатуу гэгсээлээр цэрлэгдэх хүмүүст та нар юунд сургамж айлдана вэ?” гэв. Сургамж айлдагсад : “Эзэнтнээс уучлал гуйхын төлөө, Аллахын уур хилэнгээс сэрэмжлүүлэхийн тулд ийнхүү айлддаг” гэж хариулав.
165. Тэд сургамжийг мартахад Бид бузар муухай явдлаас өөрсдийгөө сэрэмжлэгсэдийг аварч, муу үйлийнх нь төлөө зальхай этгээдүүдийг хатуу цээрлүүлсэн билээ.
166. Хориглосон зүйлсүүдээс үл сэрэмжлэн, бие тоосон учраас тэдэнд: “Адгийн муу сармагчин болцгоо” хэмээн тушаав.(тэд даруй сармагчин болж хувирав)
167. (Аяа, Мухаммед!) Тухайн үед Эзэнтэн тэдэнд (Израйлчуудад): “Ертөнцийн төгсгөл хүртэл та нарыг хатуу гэгсээн цээрлүүлэгчдийг шууд илгээж байх болно” хэмээн мэдэгдэв. Эзэнтэн эсэргүүцэгчдийг гэгсгээхдээ үтэр түргэн ч, үнэндээ машид өршөөгч бөгөөд энэрэгч болой.
168. Бид тэднийг (Израйлчуудыг) дэлхий дээр хэд хэдэн бүлэгт хуваасан юм. Тэдний дотор гэгээн ухаантнууд ч, бузар муухай юмнууд ч бодлоо өөрчлөх биз хэмээн боломж олгохын тулд тэднийг сайн муугийн аль алинаар ч сорьж үзсэн.
169. Тэдний дараа сулхан отгийнхан Тауратыг өвлөн авлаа. Тэд ариун, бузарыг үл ялган, өчүүхэн хорвоогийн баялгийг авчихаад: “Биднийг Аллах заавал өршөөнө!” гэнэ. Тэдний зам мөрт иймэрхүү хишиг таарах аваас мөн л авсаар л байна. Аллахад зөвхөн үнэнийг хэлэх тухай ариун судраар тэднээс амлалт авагдсан биш билээ үү? Тэд судрыг, судар

- доторхыг уншаагүй юм гэж үү? Үнэндээ хойд ертөнц бол Аллагаас айж эмээгсэд ивээлтэй. Үүнийг та нар ухаарахгүй юм гэж үү дээ.
170. Ариун судрыг бат бэх баримтлан, уншлага мөргөл үйлдэгсэд сайн сайхантай учирна. Бид сайн үйлс хийгсэдийн буян заяаг талаар өнгөрүүлэхгүй.
  171. Нэгэнтээ Бид тэдний дээгүүр уулыг сүүдэр лүүгээ адил төөнүүлж тавьсан. Тэр уул өөрсдийн толгой дээр унана гэж бодоцгоосон бололтой. Бид тэдэнд : “Бидний та нарт илгээсэн Таурат судрыг хичээнгүйлэн барьж чандлан сахигтун, түүнийг уншиж тунгаан бодогтун. Ингэвээс гэгээрэн аврагдаж болох юм” хэмээн сануулсан.
  172. Эзэнтэн Адамын хөвгүүдийн нуруунаас (эрхтнээс) үр удамыг нь гаргаад өөрсдөд нь өөрсдийг нь гэрчээр татаж : “Би та нарын Эзэнтэн биш гэж үү?” хэмээн асуухад тэд: “Гиймээ, Та бидний Эзэнтэн, бид гэрчилж байнам!” гэгцээсэн. Ертөнцийн төгсгөлийн өдөр “Бид нар үүнийг мэдээгүй байсан” гэж хэлүүлэхгүйн тулд ийнхүү хийсэн билээ.
  173. Мөн: “Бидний өвөг дээдэс Аллахтай өөр бурхадыг эн зэрэгцүүлсэн юм билээ. Бид тэдний үр хойч нь болцгоожээ. Болчимгүйчүүдийн төлөө биднийг хөнөөх гэж үү дээ?” хэмээн хэлүүлэхгүйн тулд хийсэн бөлгөө.
  174. Тэдний бодолыг өөрчлөх гэж, Бид айлдваруудаа ийнхүү яруу тод тайлбарладаг билээ.
  175. (Аяа, Мухаммед) тэдэнд (Израйлчуудад) энэхүү нэгэн хүний тухай өгүүлэмжийг уншиж өгөөрэй. Бид түүнд айлдваруудаа өгсөн, тэр түүнээс тагталзан, тэгээд түүнтэй чөтгөр шулам нөхцөв. Тэр төөрөлдөгсөдийн тоонд орсон.
  176. Хэрэв, Бид хүсвэл айлдваруудаар дамжуулан түүний зиндааг дээшлүүлж болох байсан. Гэвч эдийн шуналд автан, хөрөнгө мөнгөний боол боллоо. Түүний төрх нь нохойтой андуурмаар адил болсон. Хөөсөн ч, хөөгөөгүй ч хэлээ унжуулан юм горьддог. Энэ бол Манай айлдваруудыг үгүйсгэгчдийн үлгэр жишээ юм. Энэхүү өгүүлэмжийг тэдэнд хэлж өгөөрэй. Магад эрэгцүүлэн бодох биз.
  177. Бидний айлдваруудыг худал хэмээн үгүйсгэн, өөртөө зовлон учруулсан хүмүүсийн үлгэр жишээ юутай муухай юм гээч!
  178. Аллах хэнийг ивээлд авна, тэр зөв замыг олно. Мөн хэнийг төөрөлдүүлнэ, тэр хохирол амсана.
  179. Үнэндээ Бид жинн (буг чөтгөр шулам) ба хүмүүсийн нэг хэсгийг тамын төлөө бүтээсэн. Тэд зүрх сэтгэлтэй ч, мэдрэх чадваргүй хүмүүс. Нүдтэй ч түүгээр юм хардаггүй, чихтэй ч, түүгээр юм сонсодоггүй. Тэд ердөө л амьтад лугаа адил, бүр амьтадаас ч дор төөрөгдсөн хүмүүс. Гиймээс тэд харанхуй мунхаг, үл тоомсорлогчид билээ.
  180. Хамгийн эрхэм алдарууд зөвхөн Аллахад зохимой. Тэгвэл Түүнийг тэрхүү алдраар нь нэрлэн, залбирагтун. Түүний нэр алдаруудыг эсэн

- бусаар ашиглагсадыг бүү тоогтун. Тэд хийсэн үйлийнхээ цээрлэлийг хүртэцгээх болно.
181. Бидний бүтээсэн хүмүүсийн дотор үнэний зам руу хөтлөх үнэний төлөө итгэлтэй нэгэн зон бий.
  182. Бидний айлдваруудыг худал хэмээн үгүйсгэгчдийг нууцхан (анзааралгүй байхад), зугуухнаар гэсгээл руу ойртуулна.
  183. Би тэдэнд боломж олгоно. Учир нь Миний арга мэх бат бэх юм.
  184. Тэд өөрсдийн анд (Мухаммедийг) эрүүл саруул гэдгийг ухаардаггүй юм уу? Үнэндээ, тэр бол яруу тод сэрэмжлүүлэгч шүү дээ.
  185. Тэд (буруу номтнууд) тэнгэр, газар хэний эрхшээлд байгааг, Алладын бүтээсэн алив бүхний тухай, өөрсдийн үхэл-мөхөл ойртсон тухай эргэцүүлэн бодсонгүй юу? Тэд одоо Куранаас өөр ямар үгэнд итгэцгээх юм бол?
  186. Аллах төөрөгдүүлсэн хүний замыг хэн ч засаж чадахгүй. Аллах тэднийг төөрсөн чигээр нь сохроор тэнүүлж орхидог юм.
  187. (Аяа, Мухаммед) Тэд чамаас ертөнцийн төгсгөлийн өдөр хэзээ болохыг асууцгаана. Тэдэнд: “Түүний хэзээ тохиохыг Аллах л мэднэ. Хүссэн цагт ирүүлнэ. Ертөнцийн төгсгөл нь тэнгэр, газарт (түүнд буй бүхэнд) хүнд нүсэр гачаалтай үйлс. Тэр та нарт ч гэсэн санамсаргүйгээр тохиох болно” гэж хэл. Тэд энэ тухай чамайг тодорхой мэддэг юм шиг асуудаг бөлгөө. Тэдэнд : “Түүнийг зөвхөн Аллах мэднэ. Гэвч, хүмүүсийн олонхи нь үүнийг үл ойлгодог” хэмээн хэлэгтүн.
  188. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Би, Алладын зарлигаас гадуур өөртөө ямар нэгэн ашиг, хохирол хүргэх хүч чадлын эзэн биш ээ. Хэрэв би далдыг төсөөлж чаддагсан бол хязгааргүй ашиг хонжоо олж, осол эндэгдлээс ангид байх сан билээ. Би гагцхүү сүсэглэгсэдийг сэрэмжлүүлэгч, баярт мэдээ дууллагч төдий” хэмээн тэдэнд хэлэгтүн.
  189. Аллах, та нарыг нэг хүнээс (Адамаас) бүтээсэн. Мөн хамтдаа аз жаргалыг олог гээд түүнээс ханийг нь (Хауа эхийг) бүтээсэн билээ. Тэр эхнэртэй ойртсоноос эхнэр нь амархан жирэмсэн болов. Хэсэг хугацаа өнгөрч түүний бие хүндэрсэн үед Аллахад хандан: “Хэрвээ, Чи бидэнд бие бялдар, ухаан төгс хөвгүүн хайрлах аваас бид Чамд үнэнчээр талархах болно” гэж залбирцгаав.
  190. Аллах тэдэнд ухаан төгс үр хайрласан ч тэдний үр сад нь бусдыг Аллахтай эн зэрэгцүүлж эхэлсэн. Хиймэл бурхадад итгэн сүсэглэв. Аллах тэдний эн зэрэгцүүлсэн зүйлсээс эрхэмсэг дээгүүр болой.
  191. Тэд, өөрсдөө бусдаас бүтээгдсэн атал, улмаар өөрсдөө юу ч бүтээж чадахгүй байж, алив юмсыг Аллахтай эн зэрэгцүүлнэ гэж үү дээ?
  192. Үнэндээ тэдний хиймэл бурхад нь бусдад ч, тэдэнд ч ямар ч тус хүргэж чадахгүй.

193. Хэрэв, тэр хиймэл бурхадыг зөв шулуун зам руу дуудах аваас тэд та нарыг эс дагамуй. Мөн дуудсан ч, чимээгүй байсан ч тэр хариу хэлж эс чадна.
194. (Аяа, үл сүсэгтэнүүдээ!) Аллахаас өөр бусад шүтэж сүсэглэсэн бүхэн чинь та нартай адилхан боол болой. Хэрэв та нарын үзэл бодол, үг яриа чинь үнэн юм бол, алив тэднийг дууд л даа, та нарт хариу өгөх нь үү!
195. Тэдэнд явах хөл, барих гар байна гэж үү? Мөн харах нүд, сонсох чих байна уу? (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Аллахтай эн зэрэгцүүлсэн зүйлсээ дуудагтун! Тэгээд надад хүссэн урхиа тавигтун! Чадах аваас намайг хоромхон нүд ирмэг зуур хөнөөгтун” хэмээн хэлэгтүн.
196. Мөн тэдэнд: “Үүндээ, Куран судрыг илгээсэн Аллах миний анд хамгаалагч мөн. Тэрбээр зөвхөн эрхэм хүмүүсийг өмгөөлөн хамгаална” гэж хэл.
197. Харин та нарын Аллахыг мартаж, итгэн биширсэн зохиомол бурхад чинь та нарт гараа сунгахгүй. Мөн өөртөө ч тус хүргэж эс чадна.
198. Тэднийг зөв зам руу урин дуудах аваас эс сонсмуй. Чам руу харж байгаа мэт санагдавч хэрэг дээр чамайг үл харна.
199. (Аяа, Мухаммед) нигүүлсэлийн замыг барь, сайн сайхан явдлыг тушаа! Мөн мунхагуудаас хол байгтун.
200. Хэрэв, чамайг чөтгөр шулам ятгах аваас Аллахад залбирагтун! Аллах эргэлзээгүй бүхнийг сонсож, мэдэгч билээ.
201. Тэгээд ухаантнууд өөрсдийг нь чөтгөр шулам эргэлдүүлбэл Аллахыг санаж, үнэнийг ухаарцгаан, сэрэмжилж чаддаг.
202. Чөтгөр шулам сүсэггүй ахан дүүсээ бузар булай юм руу уйгагүй уруу татахаас ер залхдаггүй юм.
203. (Аяа, Мухаммед!) Хэрэв, чи тэдэнд ёр бусын гайхамшиг авч ирээгүй бол, тэд : “Чи түүнийг өөрөө хийхгүй яасан юм бэ?” гэлцэдэг. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Би гагцхүү Эзэнтний зүгээс надад илгээгдснийг л дагах болно. (Бие даан ер бусын гайхамшгийг бүтээхгүй) Итгэн сүсэглэгчдэд Эзэнтнээс ирүүлсэн ил тод нотолгоонууд бол энэхүү Куран мөн. Тэдний хувьд зөв шулуун зам хийгээд энэрэл нигүүлсэл юм” хэмээн хэлэгтүн.
204. Эзэнтний энэрэлд багтахыг хүсвэл Куран судар уншигдаж байхад анхаарал тавьж, чимээгүй сонсогтун.
205. (Аяа, Мухаммед) Чи өглөө, оройн аль ч цагт чин сэтгэлээр бодолхийлэн эмээж, намуун дуугаар Аллахыг дурсах уншлагаа үйлдэн, Эзэнтэндээ залбирагтун! Сэтгэлгүй хүмүүсийн тоонд бүү орогтун.
206. Үнэндээ, Эзэнтний чинь дэргэдэх мэлэкууд (тэнгэрийн элчүүд) Түүнд хүлцэн мөргөхөөс тагталздаггүй, хэзээ ч их зан гаргадаггүй. Тэд Аллахыг шагшин магтаж, сөгдөн мөргөдөг билээ.

## 8. СУРЕ АНФАЛ

Мадина-д илгээгдсэн. 75 айлдвар.

- Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.**
1. (Аяа, Мухаммед) Тэд чамаас (дайны) олзны тухай асуух болно. Тэдэнд : “Олз Аллах болон Түүний элчийн мэдэлд байх болно. Үнэнхүү сүсэглэгсэд болвол Аллахаас айж, хоорондоо эвтэй байгтун! Аллахад болон Түүний элчийг хүлээн зөвшөөрсүгэй!” гэж хариул!
  2. Аллах санан дурсагдах үеэр, зүрх сэтгэл нь зовинон Түүний айлдварууд уншигдахад итгэл нь батждаг, Эзэнтнийхээ төлөө итгэл, сэтгэл шулууддаг хүмүүс бол-Үнэн сүсэгтнүүд мөн.
  3. Тэд уншлага мөргөлөө бүрэн гүйцэтгэж, Бидний хайрласан хувь хишгээс Аллахын төлөө (ядууст) өглөг өргөдөг юм.
  4. Ийнхүү, тэд жинхэнэ, үнэн сүсэгтнүүд болой. Тэдэнд Эзэнтний хүндэтгэл, ивээл, эрхэм буян ч байгаа билээ.
  5. (Дайны олзлыг хуваалцах тухай зарлигийг зарим хүмүүс таалаагүйтэй адил) Аллах чамайг үнэн шударгын төлөө (даинд) мордуулахдаа үнэндээ сүсэглэгсэдийн нэг хэсэг нь үүнд дургүй байдаг.
  6. Чин үнэн илэрхий болсны дараа ч тэд улайм-цайм үхэл рүү түлхэж байгаа мэт чамтай арцалдацгаана.
  7. Тэр үед Аллах (сүсэг бишрэлгүй) хоёр бүлгийн аль нэг нь та нарт баригдахыг амлав. Та нар болохоор зэвсэггүй бүлгийг өөрсдийнх болгохыг хүссэн. Харин Аллах Өөрийн үгсээр чин үнэнийг (ислам шаныг) ил болгохыг, үл сүсэглэгчдийг тас цохихыг хүссэн билээ.
  8. Хэдийгээр нүгэлтнүүд хүсэхгүй байлаа ч Аллах чин үнэнийг нотлоно, танхай балмадуудыг устгана.
  9. Нэгэнтээ та нар өөрийн Эзэнтнээсээ тусламж гуйж байсан юм. “Аллах та нарын араас мянган мэлж (тэнгэрийн элч) явуулан туслана” хэмээн хүсэлтийг чинь хүлээн авсан.
  10. Аллах та нарыг баярлуулж, зүрх сэтгэлийг чинь тайвшруулахын тулд үүнийг хийсэн. Тусламж зөвхөн Аллахаас ирнэ. Аллах үнэхээр аугаа хүчирхэг, мэргэн ухааны эзэн билээ.
  11. Тухайн үед Аллах та нарыг тайван нойрсуулсан юм. Угаалга ариутгал хийхийн тулд, чөтгөр шуламаас та нарын сэтгэлд хоргодсон эргэлзээг зайлуулахын тулд сэтгэл дүүрэн, өлмий бат байхын тулд тэнгэрээс бороо оруулсан.
  12. Тэр мөчид Эзэнтэн чинь мэлжүүдэд : “Би та нартай хамт дайны талбарт баймуй! Үнэн сүсэгтнүүдийг дэмжигтүн. Үл сүсэглэгсэдийн зүрхэнд

- айдас хуруулмуй. Тэднийг шилэн хүзүүдэж, жанчиж, гар хурууг нь цавчигтун” хэмээн мэдээ өгнө.
13. Энэ бол, тэд Аллах хийгээд Түүний элчийг эсэргүүцсэнээс үүдэлтэй. Хэн нэгэн Аллах болон Түүний элчийг эсэргүүцэх аваас Аллах гэсгээх болно.
  14. Аяа, буруу номтнууд! Амьд ахуй болон хойд насандаа цээрлэл амсагтун. Үл сүсэглэгсэдийн хувьд тамын хатуу гэсгээл баймуй.
  15. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Буруу номтны харгис цэрэгтэй тулалдахад хүрвэл бүү ухарцгаа!
  16. Харин хэн нэгэн дайны өдөр, тулааны байрлалыг өөрчлөх, эсвэл өөрийн бусад бүлэглэлтэй нэгдэхээс ондоо шалтгаанаар дайны талбарыг орхиж ухрах аваас Аллахын хилэгнэлд өртөх болно. Түүний очих газар нь там бөгөөд тэр нь юутай муухай гээч?
  17. (Аяа, сүсэгтнүүд!) Тэгээд тэднийг та нар алаагүй, харин Аллах хөнөөсөн болой. (Аяа, Мухаммед) Атга шороог дайсан руу чи биш, Аллах цацсан юм шүү дээ! Энэ нь сүсэглэгсэдийг сайтар сорихын тулд байсан юм. Аллах эргэлзээгүй бүхнийг сонсогч, мэдэгч билээ.
  18. Эргэлзээгүй, Аллагаас мусулманчуудад олгосон чин үнэн шагнал нь энэ бөгөөд Тэр бээр үл сүсэглэгсэдийн элдэв ов мэхийг амжилтгүй болгодог.
  19. (Аяа, үл сүсэглэгсэд ээ!) Та нарын хүссэнээр ялалт ирлээ. (Гэхдээ гай болохын тулд ирсэн шүү дээ.) Үл тоомсорлол, дайсагналаас татгалзвал та нарт илүү өлзийтэй. Хэрэв, гэгээн элчтэй дахин дайсагнах аваас Бид ч гэсэн түүнд туслах болно. Танай цэргийн тоо олон байсан ч та нарт тус болохгүй! Учир нь Аллах үнэн сүсэгтнүүдтэй хамт шүү дээ!
  20. Аяа, сүсэгтэн олон минь ээ! Аллах болон Түүний элчид дуулгавартай байгтун! Мөн та нар түүнийг (Кураныг) сонссоор байж нүүрээ бүү буруулцгаагтун!
  21. Сонсоогүй атлаа: “Бид сонслоо” хэмээгсэдийн адил бүү бологтун!
  22. Учир нь дүлий, хэлгүй, үл ухаарагсад Аллахын нигур дор амьд бүхний хамгийн адаг нь.
  23. Хэрэв Аллах тэднээс өлзий буяныг харсансан бол тэднийг сонсох чадвартай болгохсон билээ. Харин, сонсох чадвартай болголоо ч гэсэн тэд тэртээ тэргүй нүүр буруулан шударга юмнаас булгах юм.
  24. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нарт амьдрал бэлэглэх итгэл бишрэлд уриалахад Аллах болон Түүний элчийн үгэнд орогтун. Аллах хүнийг, түүний зүрх сэтгэлийг нэвт хардагийг мэдтүгэй. Хэзээ нэгэн цагт Аллахын өмнө цугларахаа бүү маргаарай.
  25. Зальхай амьтадын өөрт нь оногдоод зогсохгүй, бусдыг хорлох уршигаас нь болгоомжилогтун! Аллахын гэсгээл хатуу болохыг мэдэж авагтун.



26. Та нар нэгэнтээ дэлхий дээр дорой буурай цөөхүүлээ байснаас бусдын дарамт булаалтаас айдаг байсан шүү дээ. Тиймээс та нарыг (Мадина) хотод суурьшуулан, ивээл тусламжаар хүчирхэгжүүлэн, цэвэр ариун буян хишиг хүргээсэн билээ. Үүнд та нар талархан баярлагцагтун.
27. Аяа сүсэгтэн олон минь ээ! Аллах болоод Түүний элчээс бүү урван тэрсэлцгээ. Мэдсээр байж өөрсдөд чинь (өөр хоорондоо) даатгасан итгэлийг бүү хөөсөрдүүлээрэй!
28. Мал хөрөнгө, үр хүүхэд чинь та нарын хувьд нэг л сорилт гэдгийг мэдэж авагтун. Аллахын буян барагдашгүй.
29. Аяа, сүсэгтэн олон минь ээ! Аллагаас айж эмээх аваас та нарт сайн, муу хоёрыг ялгах хүч чадал өгөх бөгөөд нүгэл хилэнцээс чинь ангижруулж, ивээн тэтгэнэ. Аллах энгүй их хайр энэрэлийг эзэгнэгч билээ.
30. (Аяа, Мухаммед) Буруу номтнууд нэгэнтээ чамайг барьж хорих, алах, эсвэл Меккегээс (эх орноос чинь) хөөх арга самбаа хайсан билээ. Тэд залливал Аллах ч арга мэх хэрэглэнэ. Аллах арга мэх хийхдээ нэн чадамгай бөлгөө.
31. Бидний айлдварууд уншигдахад тэд: “Тиймээ, Бид аль хэдийнээ сонссон. Хүсвэл ийм үгийг бид ч хэлж чадна. Энэ бол эрт баларынхны үлгэрээс өөрц үгүй” хэмээнэ.
32. Мөн тэд : “Аяа, Аллах! Хэрэв, энэ судар (Куран) Чиний зүгээс ирсэн нь үнэн юм бол алив, бидний дээр тэнгэрээс чулуун бороо оруулаадах, эсвэл энд аюулт гэсгээл явуулаад үзүүлэдэх” гэлцэв.
33. Аяа, Мухаммед! Чамайг тэдний дунд байхад Аллах тэднийг гэсгээн цээрлүүлэхгүй. Тэд өөрсдөө хүлцэл өршөөл эрвэл Аллах тэднийг үл шийтгэмүй.
34. Тэд бусдыг Месжид Аль-Харамийн хаалгаар оруулахгүй байхад Аллах тэднийг яахан цээрлүүлэхгүй байхсан билээ□ Месжид Аль-Харамийн эзэд (хариуцагчид) нь тэд биш, гэгээнт сүсэгтнүүд билээ. Гэхдээ үүнийг тэдний олонхи нь мэддэггүй юм.
35. Кагбагийн хажууд тэдний залбирал нь шүгэлдэж исгэрэх, алга ташихаас өөр юу ч биш ээ. (Үл сүсэгтнүүд ээ), Буруу номтон болсныхоо хариуг амсацгагтун.
36. Буруу номтнууд мал хөрөнгөө хүмүүсийг Аллахын гэгээн замаас нь төөрөлдүүлэхийн төлөө үрцгээдэг. Цаашдаа ч үрцгээх болно. Тэр нь өөрсдөд нь гай зовлон авчирдаг. Эцэст нь ялагдана. Тэд гарцаагүй халуун там руу туугдах болно.
37. Ийнхүү, энэхүү бохир бузар юмыг цэвэр ариунаас нь ялган салгахын тулд бүхий л бохирыг нэг дор овоолсны бүгдийг нь там руу хөнтөрч хаяна. Ийнхүү тэд жинхэнэ хохирол амсагсад бөлгөө.
38. (Аяа, Мухаммед!) Буруу номтнуудад хандан : “Хэрэв тэд биеэ тоохоо больж, гэгээн элчид дайсагнахаа зогсоовол өмнөх нүгэлүүд чинь

- өршөөгдөнө. Харин эс зогсоовоос өмнө нь гэгээн элчид дайсагнагсдын адил шийтгэгдэх болно” гэж хэл.
39. Хор хөнөөл арилж, шашин бүрэн утгаараа Аллахынх болох хүртэл тэдэнтэй тулалдагтун. Хэрэв тэд муу санаагаа орхих аваас Аллах тэдний хийснийг харж үзэх болно.
  40. Хэрэв тэд (сүсэглэн) наминчлан залбирвал Аллах та нарын ивээгч болохыг мэдэж авагтун. Тэр юутай эрхэмсэг, юутай эрхэм ивээгч юм бэ?
  41. Аяа, сүсэгтнүүд ээ! Хэрэв, Аллахад бүрэн итгэвэл, сүсэгтэн, үл сүсэгтэн хоёр тал нүүр тулан (Бадрийн тулаан) зөв, буруу хоёр танигдсан өдөр Мухаммедэд илгээсэн айлдваруудад бишрэн залбирах аваас та нарын олсон олзны тавны нэг нь гарцаагүй Аллахын төлөө, түүнчлэн гэгээн элч, түүний хамаатан садангуудад, мөн өнчин өрөөсөнгүүдэд, ядууст, замдаа үлдэгсэдэд зориулагдахыг мэдэж авагтун. Аллахын хүч чадал бүхнийг эрхшээмүй.
  42. Тэр үед, та нар хөндийн наад талд (Мадинагийн талд), тэд (дайснууд) нөгөө талд нь, харин (курайшын) жингийн цуваа та нарын доод талд байсан билээ. Хэрэв тэдэнтэй уулзахаар тохиролцсон ч та нар (тэд цэргийн тоогоор хэд дахин илүү учраас) хэлэлцэн тохирсон цагт уулзах боломжгүй байсан. Гэвч Аллах, болох ёстой хувь тавиланг гүйцээхийн тулд, ийнхүү хийв. Энэ нь үгүй болох ёстой нь яруу тод нотолгоог үзээд үгүй болох, амьдрах ёстой нэг нь ил тод баталгаагаар эсэн мэнд оршиг гээд ийнхүү хийсэн болой. Аллах бүхнийг сонсогч, мэдэгч шүү дээ.
  43. (Аяа, Мухаммед!) Аллах чиний зүүдэнд дайсны тоог цөөхнөөр үзүүлсэн. Хэрэв, тэднийг чамд үй олон болгон харуулсан бол гарцаагүй та нар зүрхшээн айж, урвалт бий болох байсан. Гэвч Аллах үүнээс аварсан. Аллах эргэлзээгүй сэтгэлийн гүнд нуугдаж буйг мэдэж байдаг.
  44. Дайсантай нүүр тулах цагт Аллах болох ёстой хувь тавиланг гүйцээхийн тулд тэднийг та нарын нүдэнд цөөхөн болгож, тэдний нүдэнд та нарыг ч багасган харагдуулана. Бүхий л үйл хэрэг гагцхүү Аллах руу эргүүлэгдэнэ (Аллахын зарлигаар болно).
  45. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Дайсантай тулгарахын цагт тэсвэр хатуужлыг сахиж, Аллахыг байнга санан дурсагтун. Тэгвээс ялах болно.
  46. Аллах болоод Түүний элчийг хүлээн зөвшөөрөгтүн. Хоорондоо бүү харгалдагтун. Эс тэгвээс та нарыг айдас эзэмдэж, хүч чадал чинь бууран доройтмуй. Та нар тэвчигтүн. Эргэлзээгүй Аллах тэвчээр хатуужлыг эрхэмлэгсэдтэй цуг бөлгөө.
  47. Бусдыг омгорхон, дээрэлхэж эх орноосоо дайжигсад лугаа адил, бас Аллахын зөв замд саад бологсод (үл сүсэглэгсэд) лугаа адил бүү бологтун. Аллах тэдний үйлдэл бүхнийг мэдэж байсан билээ.
  48. Тэр үед чөтгөр шулам тэдэнд хийсэн үйлдэлийг нь өөрсдөд нь гоё

сайхан харагдуулж : “Одоохондоо та нарыг хэн ч ялан дийлэхгүй. Би бол та нарын дэмжигч” гэв. Гэтэл, хоёр тал халз тулахад чөтгөр шулам нүүрээ буруулан ухран зугатаж : “Би та нарт ямар ч хамаагүй шүү дээ. Би та нарын хараагүй юмыг харж баймуй. Үнэндээ би Аллахаас айж байна. Аллахаын гэсгээл цээрлэл хатуу шүү” хэмээн зайлав.

49. Тэр үед хоёр нүүртэнгүүд хийгээд зүрхний гажигтангууд : “Эд нарыг (муслманчуудыг) өөрсдийнх нь шашин хуурсан. (Өөрсдийн шашинаар бардамнан, давуу хүчний эсрэг байлдана)” хэмээв. Хэн Аллахаыг түшинэ, Аллах түүнийг тэтгэнэ. Аллах үнэндээ аугаа бөгөөд мэргэн ухааны эзэн бөлгөө.
50. Аллахаын мэлэжүүд тэр үл сүсэглэгсэдийн нүүр болон ар нурууг жанчиж, “тамын галын хуйхлах зовлонг амсагтун” хэмээн тэдний амийг хэрхэн тасалсаныг харсансан бол уу!
51. Энэ бол өөрсдийнхөө гараар тарьсан хэргийн гай бөлгөө. Аллах үнэндээ өөрийн боолуудад хэзээ ч шударга бусаар ханддаггүй.
52. Тэд нарын (буруу номтнуудын) араншин Фиргауны омог болон тэднээс өмнөх хүмүүсийн араншинтай нэн төстэй. Тэд Аллахаын айлдваруудыг эсэргүүцэн нүгэлтэн болсон тул гэсгээгдсэн. Аллахаын цээрлэл хатуу хийгээд Тэр үнэнхүү хүчирхэг билээ.
53. Тэднийг цээрлүүлсний учир гэвэл, Аллах нэгэн ард олонд хайрласан хишгийг тэд өөрсдөө өөрчлөх хүртэл буцаахгүй (Аллах хайрласан хишгээ хор уршигтай солихгүй). Аллах бүхнийг сонсогч, мэдэгч шүү дээ.
54. Тэдний араншин Фиргауны ард болон тэднээс өмнөх хүмүүсийн араншинтай нэн төстэй. Тэд Эзэнтнийхээ айлдваруудыг үгүйсгэсэн билээ. Тиймээс Бид ч тэднийг үйлдсэн нүглийн хэрээр түйвээсэн. Фиргауны ардыг усанд живүүлсэн. Тэд бүгдээрээ гэмтнүүд байсан юм.
55. Аллахаын нигур дор буй амьтадын хамгийн адаг нь буруу номтнууд мөн. Яагаад гэвэл тэд үл сүсэглэдэг.
56. (Аяа, Мухаммед) Чи тэдэнтэй гэрээ хэлэлцээ хийвэл тэд түүнийгээ байнга зөрчидөг. Тэд Аллахаас айдаггүй юм.
57. Хэрэв, тэдэнтэй дайны үед учирвал арынханд нь сургамж болгох үүднээс хатуу цохилт өгөгтүн.
58. Аль нэгэн омгийн урван тэрслэхийг сэжиглэвэл хэлэлцээгээ цуцалсанаа мэдэгдээрэй. Аллах үнэндээ урван тэрслэгсэдийг үл хайрладаг.
59. Тулалдаанд амьд үлдсэн буруу номтнууд (Аллахаын гэсгээлээс) “аврагдсан” хэмээн бүү бодог. Тэд (Аллахаыг) мөхөсдүүлж үл чадна.
60. Дайсантайгаа тулалдахын тулд боломжоороо зэр зэвсэг, уналга морьд бэлтгээрэй. Түүгээр Аллахаын дайсныг, өөрсдийнхөө дайсныг мөн бусад дайснуудыг айлгагтун. Тэднийг та нар танихгүй, Аллах л таньдаг. Та

- нарын Аллахын төлөө зориулсан зүйлс чинь Аллахын ивээлээр бүрэн эргүүлэн төлөгдөнө. Та нарт шударга бус юм хийгдэхгүй.
61. (Аяа, Мухаммед!) Дайтсан тал найрамдал хүсвэл, чи ч хүлээн зөвшөөр. Аллахыг түшиглэ. Тэр бүхнийг сонсогч хийгээд мэдэгч шүү дээ.
  62. Хэрэв, тэд хэлэлцээгээр мэхлэхийг санаархах ахул, чамд Аллахын тусламж л хүрэлцээтэй. Аллах чамайг тусламжаараа, бас үнэн сүсэгтнүүдээрээ дэмжинэ.
  63. Аллах тэдний (мусулманчуудын) зүрх сэтгэлийг нэгтгэсэн. Харин чи газар дэлхийн бүх баялагийг зориулсан ч тэдний зүрх сэтгэлийг нэгтгэж эс чадах бөлгөө. Харин Аллах тэднийг нэгтгэсэн. Аллах бүхнээс аугаа бөгөөд мэргэн ухааны эзэн билээ.
  64. Аяа, гэгээн элч ээ! Чамд болон чамайг дагасан үнэн сүсэгтнүүдэд туслахад Аллахын чадал хангалттай.
  65. Аяа, гэгээн элч ээ! Үнэн сүсэгтнүүдийг дайсны эсрэг тулалдаанд зоригжуулагтун. Хэрэв та нарт хүчирхэг тууштай хорин хүн байвал хоёр зууг (дайсныг) ялах болно. Учир нь дайныг хүсэгчид чин үнэнийг үл ухаардаг хүмүүс билээ.
  66. Аллах ийнхүү та нарын ачааг хөнгөллөө. Та нарын хүчин мөхөсдснийг Тэр мэдсэн. Та нарын дунд хүчирхэг тууштай зуун хүн байвал хоёр зуун хүнийг ялах болно. Харин та нарт тийм л мянган хүн байвал Аллахын ивээлээр хоёр мянгыг ялна. Аллах тууштай, тэвчээртэй хүмүүсийн хамт байдаг.
  67. Дэлхий дээр дайснаа давуу байдлаар нь ялахаас наана бусдыг олноор олзлох нь гэгээн элч нарт зохисгүй болой. (Аяа, Мухаммед!) Та нар төлбөр авч ашиг хонжоо олохыг бүү хүсэгтүн. Аллах та нарт хойд ертөнцийн буяныг л хүсдэг. Аллах аугаа хүчирхэг, мэргэн ухааны эзэн мөн.
  68. Аллахын илэрхий хориглоогүй үйл үйлдэгсэдийг үл цээрлүүлэх тухай өмнөх зарлиг үгүйсэн бол олзлогсдоос төлөөс авсныхаа төлөө та нар хүнд цээрлэл үзэх л байсан юм.
  69. Олноосоо зөвхөн халал буюу зөвшөөрөгдсөнийг болон цэвэр ариуныг нь идэгтүн. Аллахаас айгтун. Аллах үнэхээр өршөөгч, хайрлан энэрэгч билээ.
  70. Аяа, гэгээн элч ээ! Та нарын эрхшээлд буй олзлогсодод: “Хэрэв та нарын зүрх сэтгэлд ямар нэгэн өлзий буян байхыг Аллах харвал та нараас авснаас ч (төлөөснөөс) илүү сайныг та нарт хайрламуй. Тэгээд та нарыг өршөөмүй. Учир нь Аллах нэн өршөөгч бөгөөд машид энэрэгч шүү дээ” хэмээн хэлэгтүн.
  71. Хэрэв тэд чамайг хорлохыг оролдвол (бүү гомд) өмнө нь Аллахад ч уршиг тарьж (Аллахын зарлигаас урван тэрсэлсэн) байсан юм. Аллах

тэднийг дарах хүч чадал хийгээд боломжийг чамд өгсөн. Аллах мэргэн ухааны Эзэн бөгөөд бүхнийг зүй ёоор мэдэгч шүү дээ!

72. Үнэнхүү сүсэглэж, гэгээн элчийг даган нутгаас дүрвэгсэд, Аллахын төлөө сэтгэл зүрх, амь нас, мал хөрөнгөө зориулан тулалдагсад, дүрвэгсэдийг орон байраар хангаж туслагчид бол жинхэнэ бие биендээ итгэн нөхөрлөгсөд мөн. Харин сүсэглэсэн атлаа (Меккегээс Медине руу) нүүж чадаагүй хүмүүс нүүж ирэх хүртэл та нартай ахан дүүсийн ямар ч холбоогүй байх болно. Гэхдээ тэд шашны талаар та нараас тусламж гуйвал та нар тэдэнд туслах үүрэгтэй. Хэрэв, тэд та нарын хэлэлцээ хийсэн ардын дунд байвал асуудал өөр байх болно. Аллах та нарын үйлдэж буй бүхнийг харж байдаг юм.
73. Буруу номтнууд ч бие биеэдээ анд нөхөд. Хэрэв та нар үүнийг эс үйлдэх аваас газар дэлхий дээр үймээн самуун дэгдэж, амгалан байдал үл тогтоно.
74. Үнэнчээр сүсэглэж, (Меккегээс Медине руу) нүүдэл хийгсэд, Аллахын төлөө тулалдагсад, нүүж ирэгсэдэд орон байр өгч, тусалцаа үзүүлэгсэд бол жинхэнэ үнэн сүсэглэгсэд мөн. Тэдэнд Эзэнтний ивээл, үнэт хувь хишиг бий.
75. Хожим ч гэсэн сүсэглэн (Меккегээс Медине руу) нүүж ирэгсэд болон Аллахын төлөө та нартай хамт тулалдагсад та нарын нэгэн адил үнэлэгдэх болно. Аллахын номын ёсоор ахан дүүс хүмүүс бие биеэсээ (залгамжлах) бусдаас илүү ойр дотно болой. Аллах эргэлзээгүй бүхнийг зүй ёсоор нь мэдэгч билээ.

## 9. СУРЕ ТАУБА

Мадина-д илгээгдсэн. 129 айлдвар.

1. Энэ нь Аллах болон Түүний гэгээн элчийн зүгээс, та нартай хэлэлцээ хийсэн урвагч (олон бурхан шүтэгч) буруу номтнуудад өгөгдсөн зарлиг болой. (хэлэлцээг хүчингүй болгох тухай)
2. (Аяа, олон бурхан шүтэгч буруу номтнууд аа!) Та нар газар дэлхий дээр дөрвөн сарын турш чөлөөтэй хэсүүчлэгтүн! Тэгээд та нар Аллахыг мөхөсдүүлж эс чадахаа, Аллах буруу номтнуудыг дорд үзэхийг мэдтүгэй!
3. Энэ нь их хаж мөргөлийн өдөр Аллах болон гэгээн элчийн зүгээс хүмүүст хандан : “Аллах хийгээд Гэгээн элч нь олон бурхан шүтэгч буруу номтнуудаас ангид” хэмээн гаргасан зарлиг мөн. Хэрэв дариу гэмшин наминчлах аваас та нарын хувьд илүү өлзийтэй байх болно. Харин нүүр буруулан тагалзах аваас Аллахын эсрэг зогсож, Түүнийг

мөхөсдүүлж эс чадахыг мэдэгтүн! (Аяа, Мухаммед!) Үл сүсэглэгсэд зовлонг гэгсгээл оногдохыг дуулга.

4. Харин, буруу номтнуудаас та нартай хэлэлцээ хийсэн хүмүүс түүнийг үл зөрчвөл, та нарын эсрэг хэнд ч туслаагүй бол тэдэнтэй хийсэн хэлэлцээний хугацаа дуустал ёсчлон сахигтун. Аллах үнэнхүү үнэн сүсэглэгсэдийг таалдаг билээ.
5. Хориот (дайн тулаан хориотой) дөрвөн сар нэгэнт өнгөрсний дараа буруу номтнуудыг хаа таарсан газар нь хөнөөгтүн, баривчлагтун, хоригтун, бүхий л замыг бүслэн хаагтун. Харин тэд гэмшиж, наминчлан, уншлага мөргөлийг үйлдэж, ариуслын өглөгөө өгөх аваас тэднийг чөлөөлөгтүн. Аллах эргэлзээгүй нэн ивээгч бөгөөд машинд энэрэн хайрлагч шүү дээ.
6. Хэрэв буруу номтнуудаас хэн нэгэн чамаас толгой хоргодохыг хүсвэл, түүнд Аллахын сургаалыг сонсох хүртэл хоргодох боломж олго. Дараа нь түүнийг аюул осолгүй газар аваачигтун. Учир нь тэд юуг ч эс ойлгодог ард билээ.
7. Буруу номтнуудын хувьд Аллах болон Түүний гэгээн элчтэй хэрхэн хэлэлцээ хийх вэ? Гагцхүү Мэсжид Аль-Харамын дэргэд та нартай хэлэлцээ хийгээд зөв шударга байвал та нар ч тэдэнд үнэнч байгтун. Аллах үнэндээ төгс сүсэглэж, нүгэлээс сэрэмжилдэг хүмүүсийг таалдаг билээ.
8. Тэдэнтэй хэрхэн энхийн гэрээтэй байж болох юм бэ? Учир нь тэд ялвал төрөл садангийн холбоогоо ч, хэлэлцээгээр хүлээсэн үүргийг ч хүндэтгэн сахихгүй шүү дээ. Тэд та нарыг аман дээрээ баярлуулавч сэтгэл зүрхээрээ таалдаггүй юм. Тэдний олонхи нь танхай этгээдүүд.
9. Тэд Аллахын айлдваруудыг өчүүхэн үнээр наймаалцаж, хүмүүсийг Аллахын замаас төөрөгдүүлдэг. Тэдний ааш араншин үнэхээр муухай.
10. Тэд үнэн сүсэглэгчийн тухайд ах дүү ёсыг ч, хэлэлцээний үүргийг ч хамгаалдаггүй. Иймээс тэд бол жинхэнэ хэмээс хэтрэгсэд болой.
11. Харин тэд гэмшиж, уншлага мөргөл үйлдвэл, өглөг өгвөл тэд та нарын шашин нэгт ахан дүүс болно. Бид, ухамсарт ардуудад өөрийн айлдваруудаа ийнхүү ил тод тайлбарладаг юм.
12. Хэрэв тэд хэлэлцэн тохирсны дараа тангарагаа зөрчиж, та нарын шашин руу халдан довтлох аваас тэр үл сүсэглэгсэдийн толгойлогчийн эсрэг довтлогтун. Тэдэнд үнэн тангараг гэж үгүй. Ингэвэл тэд үл тоомсорлохоо зогсоож юу магад!
13. (Аяа, мусулманчууд аа!) Тангарагаасаа няцаж, гэгээн элчийг эх орноосоо (Меккегээс) хөөн гаргахыг зөвшөөрсөн, та нарын эсрэг түрүүлээд дайн дэгдээсэн хүмүүсийн эсрэг та нар тулалдаж болохгүй гэж үү дээ? Эсвэл тэднээс айж байгаа юм уу? Хэрэв үнэн сүсэглэгсэд бол Аллахаас л айх ёстой.

14. Тэдэнтэй тулалдагтун, та нарын гараар Аллах тэднийг цээрлүүлж, шившиг болгож, тэднийг ялахад та нарт туслаж, төгс сүсэгтэн олны зүрх сэтгэлийг анагаамуй.
15. Мөн тэдний зүрх сэтгэлээс уур хилэнг нь хөөмүй. Аллах хүссэн хүнийхээ залбиралыг хүлээн авна. Тэр бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн бөлгөө!
16. Үгүй бол Аллах та нарыг орхино гэж бодож байна уу? Аллах та нарын дотроос тулалдагсадыг, Аллах болон Түүний элчээс, бас сүсэглэгдээс өөр хэнийг ч ивээгчээ эс болгогсодыг Эзэнтэн мэдэхгүй гэж бодож байна уу? Аллах та нарын хийж буй бүхнийг мэдэгч билээ.
17. Буруу номтнууд өөрсдийнхөө үл сүсэглэлээ мэдсээр атлаа, Аллахын ариун газар (мечиг)-ийг засварлахаар очих нь зохисгүй. Тэдний үйл аль хэзээ талаар болсон. Тэд халуун тамд эгнэгт оршмуй.
18. Аллахын ариун газар болох мечитүүд-ийг зөвхөн Аллах хийгээд хойд ертөнцөд итгэгсэд, уншлага мөргөлөө зүй ёсоор нь үйлдэгсэд, ариуслын өглөгөө өгөгсөд, гагцхүү Аллахаас айхсад л (барих, засах, сэргээх гэх мэтчлэн үйлчилгээг) хариуцана. Тэд зөв шулуун замаар замнагсадын нэгэн болно.
19. (Аяа, үл сүсэглэгсэд ээ!) Хаж мөргөл үйлдэгсдэд уух ус өгөхийг, мөн Мэсжид Аль-Харамыг сэргээн засварлагсадыг Аллах хийгээд хойд ертөнцөд итгэж, Түүний төлөө тулалдагсадтай эн тэнцүү гэж бодож байна уу? Тэд Аллахын нигур дор эн тэнцүү байх учиргүй. Аллах зальхай хүмүүсийг зөв шулуун замаар эс хөтөлмүй.
20. Үнэн сүсэглэгсэд, гэгээн элчтэй хамт Меккегээс нүүж, Аллахын төлөө бие сэтгэл, мал хөрөнгөө зориулан, хамаг хүчээрээ дайтагсад нь Аллахын нигур дор дээд зиндааг эзэгнэнэ. Ийнхүү тэд авралд хүрэх хүмүүс бөлгөө.
21. Эзэнтэн тэднийг Өөрийн хайр энэрлээр, адис ерөөлөөр, дуусахгүй хувь хишигтэй диваажингаараа баярлуулна.
22. Тэд диваажинд мөнхөд оршмуй. Аллахаас тэдэнд үлэмж их буян хайрлах болно.
23. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Хэрэв та нарын эцэг, ахан дүүс чинь итгэл бишрэлээс үл сүсэглэлийг илүү таалах аваас тэднийг догтно хүн бүү болгогтун. Та нараас хэн нэгэн тэднийг анд найзаа болгох аваас зальхай этгээдэд тооцогдох нь тэр ээ.
24. (Аяа, Мухаммед!) Тэдэнд : “Хэрэв та нарын эцэг, хөвгүүд, ахан дүүс, гэргий болон омог чинь, хураасан эд баялаг чинь, алдахаас болгоомжилсон арилжаа наймаа чинь, нүд баясгах гэр орон чинь бүгд та нар Аллах хийгээд Түүний элчээс, Аллахын төлөө тулалдагсадаас илүү харагдаад байвал та нар Аллахын гэсгээл ирэх хүртэл хүлээгтүн. Аллах танхай балмад ардыг зөв шулуун замаар эс хөтлөнө” хэмээн хэл.

25. Аллах олон тулалдаанд, бас Хунейны тулалдааны үеэр та нарт тусалсан билээ. Та нар цэргийнхээ тооны олонд бардамнасан билээ. Тооны олон нь хэнд ч тус болохгүй. Та нарт уужим газар давчуу мэт санагдсан. Тэгээд та нар ялагдал хүлээж, (гэгээн элчийг цөөн хүнтэй орхин) ухран зугатсан билээ.
26. Дараа нь Аллах гэгээн элч хийгээд сүсэгтэн олонд тэвчээр, амар амгаланг илгээж, та нарт үл үзэгдэх хүч (мэлэкүүд) илгээж, үл сүсэглэгсэдийг цээрлүүлсэн. Үл сүсэглэгсдийн ял ийм л ажээ.
27. Аллах үүний дараагаар таалсан хүний гэмшлийг нь хүлээн авч түүнд ислам шашныг шүтэн бишрэх хувь тавиланг заяасан юм. Аллах аугаа ивээгч, онцгой энэрэгч билээ.
28. Аяа, сүсэгтнүүд минь! Буруу номтнууд Аллахт бишрэн шүтдэггүй болохоор бохир буюу харам (бузар) мөн. Тиймээс тэд энэ жилээс хойш Мэсжид Аль-Харамд орж болохгүй. Хэрэв, ядуу зүдүү байдлаас айх аваас Аллах хүсвэл Өөрийн өгөөмөр хишгээр та нарыг баяжуулах болно. Аллах бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн бөлгөө.
29. Өөрсдөд нь ариун судар илгээгдэгсэдийн (Христчүүд болон Еврейчүүд) дотроос Аллах хийгээд хойд ертөнцөд үл итгэгсэд, Аллах болон Түүний элчийн хориглосныг үл ойшоодог, чин үнэн шашныг эс хүлээн зөвшөөрөгсөд та нарын өмнө хүлцэн бууж өгч, өөрсдийн гараар төлөөс төлөх хүртэл дайтагтун.
30. Еврейчүүд : “Гузайр бол Аллахын хүү” гэгцгээсэн. Христчууд ч : “Иса буюу Масих бол Аллахын хүү” гэгцгээсэн. Энэ нь тэдний өмнөх үл сүсэглэгсэдийн (мухар сүсэгт өвөг дээдсийн) үгтэй адил, санаанаас зохиосон худал үг болой. Аллах тэднийг ниргэх болтугай. Тэд чин үнэнээс хэрхэн төөрөлдөнө гээч!
31. Хэдийгээр тэдэнд “цорын ганц Аллахыг шүтэцгээ!” хэмээн зарлигдаж, “Түүнээс өөр ямар ч бурхан үгүй” гэсэн ч, тэд (Еврейчүүд, Христчүүд) Аллахыг орхиж өөрсдийн эрдэмтэд, санваартнууд болон Мариамын хүү Масихийг (Иса-г) бурхан хэмээн үздэг. Аллах тэдний эн зэрэгцүүлсэнээс эрхэм дээд бөлгөө.
32. Тэд Аллахын гэрлийг (шашныг) амаараа үлээж унтраахыг санаархавч, Аллах үл зөвшөөрнө. Хэдийгээр үл сүсэглэгсэд түүнийг үзэн ядаж байсан ч, Аллах гэрэл гэгээгээ бүрэн гийгүүлсээр байх болно.
33. Буруу номтнууд үзэн ядаж байсан ч, Аллах чин үнэн шашинаа бусад шашнаас дээгүүр өргөмжлөхийн төлөө гэгээн элчээ (Мухаммедийг) шударгаар, чин үнэн шашинтайгаар илгээсэн юм.
34. Аяа, сүсэгтнүүд минь ээ! (Еврей) хахамууд, (Христос) санаавартангуудын олонхи нь хүмүүсийн мал хөрөнгийг шударга бусаар ашиглаж, хүмүүсийг Аллахын зөв замаас хазайлгана. Тэрчлэн



- алт мөнгө хураан зоорилж, түүнийгээ Аллахын төлөө эс зарцуулагсадад зовлонг гэсгээл байдгийг сануулагтун.
35. Ертөнцийн төгсгөлийн өдөр тэрхүү хурааж зоорилсон баялаг нь халуун тамд улайсгагдаж, түүгээр тэдний дух, сүвээ, нурууг тамгалах мөчид : “Энэ бол та нарын шунахай сэтгэлээр хадгалсан мал хөрөнгө чинь! Одоо түүний амтыг үзэгтүн!” хэмээн хэлэгдэх болно.
  36. Аллах тэнгэр, газрыг бүтээсэн өдрөөс эхлэн, Аллахын бичээсээр эргэлзээгүй саруудын тоо арван хоёр болсон. Тэдгээрээс дөрөв нь (Зилкагда, зилхижжа, мухаррам, режеб нэртэй) дайтахыг хориглосон хүндэтгэлтэй сарууд юм. Энэ бол чин үнэн шашин. Эдгээр саруудад хэм хэмжээг зөрчиж, өөртөө нүгэл бүү хураацгаатун. Буруу номтнууд бүгдээрээ цуглан та нартай дайтасны адил, та нар ч цугларан тэдэнтэй байлдагтун. Аллах эргэлзээгүй сүсэглэгсэдтэй хамт гэдгээ мэдэгтүн.
  37. Хүндэтгэлтэй сарыг хойшлуулах, солих зэрэг нь үл тоомсорлолыг лавшруулахаас цаашгүй бөгөөд түүгээр буруу номтнууд төөрөлддөг. Тэд Аллахын хориот саруудын тоог өөрчлөхийн тулд нэг жил зөвшөөрч, өөр нэгэн жил хориглодог. Ийнхүү тэд хориот болгосныг зөвшөөрөлтэй болгодог. Тэдний энэ бузар үйлс өөрсдөд нь сайхан харагддаг. Ийнхүү Аллах үл сүсэглэгсэдийг зөв замаар эс хөтөлмүй!
  38. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нарт юу гэгч юм болов оо? “Аллахын төлөө аян дайнд мордогтун!” гэхүйд суусан газраасаа ховхрох дургүй. Аль эсвэл хойд ертөнцийн шан харамжаас (диваажингаас) өнөөдрийн жаргалыг илүү таалж байна уу? Үнэндээ энэ хорвоогийн зугаа цэнгэл хойд буян заяатай зүйрлэхэд юу ч биш шүү дээ.
  39. Аллахын төлөө аян дайнд эс мордох аваас та нарыг хатуу гэгсээн цээрлүүлж, оронд чинь өөр ард түмнийг ирүүлнэ. Тэглээ гээд та нар Аллахт өчүүхэн уршиг тарьж чадахгүй. Аллахын хүч чадал бүхнийг эрхшээхэд хүрэлцээтэй.
  40. Хэрэв та нар гэгээн элчид туслахгүй юм бол Аллах туслах болно. Нэгэн цагт буруу номтнууд, түүнийг (Мухаммедийг) Меккегээс хөөхөд агуйд буй хоёрын нэг (Абу Бакиртэй хамт) болох Аллах түүнд тусалсан юм. Тэр үед гэгээн элч анд нөхөр Абу Бакирт хандан: “Чи бүү гунигла, эргэлзээгүй Аллах бидэнтэй цуг болой” гэж хэлсэн. Тэгээд Аллах түүний зүрх сэтгэлийг тайвшруулан нүдэнд үл үзэгдэх мэлэкүүдээр тусалцуулав. Ийнхүү үл сүсэглэгсэдийн үгийг үнэ цэнэгүй болгов. Аллахын айлдвар хамгийн их эрхэмсэг. Аллах бүхнээс аугаа бөгөөд мэргэн ухааны эзэн.
  41. Аяа, үнэн сүсэгтнүүд ээ! Хүнд, хөнгөн ямар ч нөхцөлд Аллахын төлөө мал хөрөнгө, амь насаа зориулагтун. Ухаардагсан бол энэ нь та нарт илүү өлзийтэй.
  42. Хялбар олз, боломжийн аян зам байвал тэд (хоёр нүүртэнгүүд) чамайг эргэлзээгүй дагах байсан. Гэвч туулах зам нь тэдэнд хүнд байсан

- учир татгалзаж: "Бидний хүч чадал хүрэх нь гарцаагүй бол та нартай цуг гарах байсан. (дайтахсан)" гэж Аллахын нэрээр андгайлана. Тэд ингэснээрээ өөрөө өөртөө лай хураасан. Аллах тэдний худалч байсныг мэднэ.
43. (Ая, Мухаммед!) Аллах чамайг өршөөх болтугай. Үнэнч ба худалч хоёр танигдтал чи тэдэнд гэртээ үлдэх зөвшөөрөл өгөхгүй яасан вэ□
  44. Аллах хийгээд хойд ертөнцөд итгэгсэд, малаа ч, амиа ч үл хайрлан, тулалдаанаас чөлөөлөхийг хүсэхгүй юм. Аллах ийм үнэн сүсэглэгчдийг сайн мэднэ.
  45. Гагцхүү Аллах хийгээд хойд ертөнцөд үл итгэгсэд мөн сэтгэлдээ эргэлзээтэй, түүнээс болж хоёрдмол санаатай явагсад л элдэв шалтгаан тоочин чамаас зөвшөөрөл гуйна.
  46. Тэд аянд мордохыг үнэхээр хүссэн бол юутай ч гэсэн бэлтгэлээ базаах ёстой шүү дээ. Гэвч тэдний аянд мордохыг Аллах эс таалсан учир тэднийг саатуулж, "Үлдэгсэдтэй хамт үхээнцээр үлдэгтүн" хэмээн айлдсан.
  47. Тэд та нартай цуг явсан бол та нарыг эвдрэлцүүлэн, зальхай юмыг дэвэргэж, та нарт хор уршиг тарихыг оролдох байсан. Учир нь тэдний дотор тагнан турших хүмүүс байсан. Аллах зальхай этгээдүүдийг сайн мэднэ.
  48. (Ая, Мухаммед) Үнэндээ тэд өмнө ч гэсэн олныг үймүүлэн, янз бүрийн заль гаргасан оролдлого хийсэн юм. Эцэст нь тэд үзэн ядсан ч чин үнэн тодорч, Аллахын зарлиг давамгайлсан билээ.
  49. Тэдний дунд : "Намайг чөлөөлөгтүн. Үймээн самуунд бүү оруул" гэж хэлдэг хүмүүс бий. Угаасаа тэд үймээн самуунд өртөцгөөсөн. Буруу номтон, сүсэггүй этгээдийг угаасаа тамын гал хүрээлэн угтдаг.
  50. (Ая, Мухаммед) Хэрэв чамд ямар нэгэн сайн зүйл тохиох аваас тэд үзэн яддаг. Харин чамд ямар нэгэн гай зовлон тохиох үед : "Бид угаасаа урьдаас сэрэмжлүүлэг авсан юм" гэж хэлээд тэд бөөн баяр хөөр болон буцацгаадаг.
  51. (Ая, Мухаммед) Тэдэнд : "Бидэнд зөвхөн Аллагаас заяадаг хувь тавилан оногдоно. Аллах бидний Эзэн мөн. Сүсэгтнүүд Түүнд итгэцгээх болтугай" хэмээн хэлэгтүн.
  52. Мөн тэдэнд : "Та нар бидэнд хоёр төрлийн сайн сайхны (ялалт эсвэл Аллахын төлөө амиа золиослох) аль нэгийг хүсдэг гэж үү? Бид ч та нарт Аллах Өөрийн зүгээс гэгсгээл илгээхийг эсвэл бидний гараар цээрлүүлэхийг хүсэн хүлээж байсан. Тийм болхоор та нар ч хүлээгтүн, бид ч та нартай цуг хүлээмүй" гэж хэл.
  53. Мөн тэдэнд : "Та нар мал хөрөнгөөсөө сайн дураараа ч бай, дургүй ч бай өглөг өглөө ч гэсэн Аллах таалан хүлээж авахгүй. Яагаад гэвэл та нар танхай балмад хүмүүс" хэмээн хэлээрэй.

54. Тэдний өглөг хүлээн зөвшөөрөгддөггүй шалтгаан нь: "Тэд Аллах хийгээд Түүний Элчийг эсэргүүцсэн, уншлага мөргөл үйлддэггүй, уншлаа ч гэсэн залхуу, сэтгэлээрээ биш, өглөг өгдөггүй, өглөө ч гэсэн дурамжхан зэрэг асуудалтай шууд холбоотой.
55. (Аяа, Мухаммед) Тэдний мал хөрөнгө, үр хүүхдүүдэд гайхшрах хэрэггүй. Аллах тэднийг амьд ахуй цагт тэр эд хөрөнгөөр нь зовоож, бишрэл сүсэггүйгээр нь амиа алдахыг нь хүсдэг!
56. Тэр хоёр нүүртэнгүүд: “ Бид үнэхээр та нарын адил Аллахад итгэдэг шүү дээ” хэмээн Аллахын нэрээр тангарагладаг. Үнэндээ тэд та нарын адил биш, аймхай хулчигарууд билээ.
57. Хэрэв тэд ямар нэгэн хоргодох хэрэм, эсвэл агуй, эсвэл багтах нүх олвол тийшээ гүйн толгой хоргодох болно.
58. (Аяа, Мухаммед) Тэдний зарим нь өглөгийн тухайд чамайг зэмлэдэг. Хэрэв өглөгөөс өөрт нь оногдвол баярлацгааж, эс өгөгдвөл уурлацгаадаг.
59. Хэрэв тэд, Аллах хийгээд Түүний элчийн хайрласанд сэтгэл хангалуун байвал: "Аллах бидэнд хангалттай. Аллах хийгээд Түүний Элч бидэнд өгөөмөр баялагаасаа хайрлана. Үнэндээ бид зөвхөн Аллахад залбирцгаадаг" хэмээсэн бол өлзийтэй байхсан.
60. Өглөгүүд (зекат) гагцхүү ядууст, үгээгүйчүүдэд, өглөг хураагч түшмэлүүдэд, зүрх сэтгэл нь Ислам руу эргэгсэдэд, боолуудыг чөлөөлөхийн төлөө, өрөнд баригдагсад, Аллахын төлөө зүтгэгсэд, мөн аян замдаа үлдэгсэд зориулагдана. Энэ бол Аллагаас оногдуулсан фарз буюу ариун үүрэг мөн. Аллах бүхнийг мэдэгч, мэргэн ухааны Эзэн билээ.
61. Тэдний (хоёр нүүртэнгүүдийн) зарим нь: “Юм болгоныг сонсдог нэгэн чих” гэж гэгээн элчийг шүүмжлэн гомдоодог. (Аяа, Мухаммед) тэдэнд: "Тэр бол та нарын хувьд буянтай чих шүү. Яагаад гэвэл тэр Аллахад сүсэглэж, мусулманчуудад итгэдэг. Мөн та нарын дундаас сүсэглэгсэдийн төлөө Аллах илгээсэн нэгэн нигүүлсэл мөн” хэмээн хэл. Аллахын элчийг гомдоогсдод хатуу гэсгээл бий!
62. Тэд та нарыг баярлуулахын тулд Аллахын нэр барин андгайлдаг. Хэрэв тэд үнэнхүү мусулман байсан бол Аллах хийгээд Түүний элчийн таалалд нийцэх нь илүү зохистой!
63. Хэн нэгэн Аллах болон Түүний элчийг эсэргүүцвэл тамд очиж, түүнд эгнэгт үлдэнэ гэдгийг мэддэггүй юм уу? Мэддэггүй бол зовлонгийн туйл энэ болой.
64. Хоёр нүүртэнгүүд, өөртөө холбоотой, өөрсдийнх нь зүрх сэтгэлд нуусныг илчлэх нэгэн бүлэг айлдвар илгээгдэхээс айдаг. (Аяа, Мухаммед) Тэдэнд : "Та нар шашныг доромжлоод үзээрэй! Аллах та бүхний сэрэмжлэн айж буй юмыг чинь гарцаагүй илчлэх болно!" гэж хэлэгтүн.

65. Хэрэв тэднээс (доромжлон дооглож буй учрыг) асуувал тэд: “Бид зүгээр л тоглосон” гэнэ. (Аяа, Мухаммед) Тэдэнд : "Та нар Аллах хийгээд Түүний айлдваруудыг, бас Түүний Элчийг доромжлон тохуурхах гэж үү дээ?" хэмээн асуугтун.
66. Та нар сүсэглэж итгэснийхээ дараа урван тэрсэлцгээсэн. Бид та нарын зарим хэсгийг (гэмшил эрэгсэдээс) өршөөсөн ч, нөгөө хэсгийг чинь дахин урваж, нүгэлт болсныхоо төлөө цээрлүүлнэ.
67. Хоёр нүүртэй эрэгтэйчүүд болон хоёр нүүртэй эмэгтэйчүүд бүгд ялгаагүй адилхан. Тэд муу муухайг тушаадаг, сайн сайхан явдалд саад учруулдаг, гар нь татганаж, өглөг өгөхөөс харамладаг. Тэд Аллахыг мартсан. Аллах ч тэднийг мартсан (үл тоож, цээрлүүлсэн). Эргэлзээгүй, хоёр нүүртэнгүүд ёс бус танхайрагчид мөн.
68. Аллах, хоёр нүүртэй эрэгтэйчүүд хийгээд хоёр нүүртэй эмэгтэйчүүдэд, үл сүсэглэгсдэд эгнэгт үлдэх тамыг амласан. Там тэдэнд хангалттай. Аллах тэднийг хараасан юм. Тэдэнд зориулсан төгсгөлгүй мөнхийн гэсгээл бий.
69. (Аяа, хоёр нүүртэнгүүд ээ!) Та нар ч өмнөхүүдтэйгээ адилхан байна! Тэд хүч чадлаараа та нараас хамаагүй илүү, эд хөрөнгө болон хүүхдүүдээрээ ч илүү байсан. Тэд энэ хорвоогийн хувь хишгийг хүртсэн билээ. Та нар ч өөрсдийн хувь хишгээ хүртцгээрэй! Мөн тэд хэрхэн самууран танхайрсан бол та нар ч самууран танхайрцгаа! Харин тэдний үйлдсэн сайн үйлс бүхэн энэ яваа хийгээд хойд насанд нь талаар өнгөрсөн. Ийнхүү, тэд л хохирол амссан билээ!
70. Тэдэнд өөрсдөөс нь өмнөх Нух, Гад, Самудын омгийхны, Ибрахимын ардын, Мадияны оршин суугчдын, тэрчлэн түйвээгдсэн хотуудын (Лутын ард олон) тухай мэдээ ирээгүй гэж үү?! Тэдэнд гэгээн элчүүд нь ил тод нотолгоонуудыг авч ирсэн билээ. Харин Аллах тэдэнд муухай юм хийгээгүй. Тэд өөрсдийгөө муу муухай бүхэнтэй учруулсан юм.
71. Үнэн сүсэгтэй эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд бие биеэндээ анд найзууд болой. Тэд хүмүүсийн сайн үйлсийг ухуулан, муу бүхнийг хориглодог. Уншлага мөргөлөө зүй ёсоор гүйцэтгэж, өглөг (зэкэт) өгч, Аллах хийгээд Түүний Элчид итгэн биширч, дагадаг. Иймд Аллах тэднийг ивээл нигүүлсэлдээ багтаамуй. Аллах эргэлзээгүй аугаа, мэргэн ухааны эзэн билээ.
72. Аллах үнэн сүсэгтэн эрчүүд болон эмэгтэйчүүдэд тэнд эгнэгт үлдэх, хаяагаар нь ариун булаг урсдаг диваажингуудыг амласан. Бас Адн диваажинд сайхан орон байр амласан билээ. Гэхдээ Аллахын таалал бүхнээс аугаа! Эрхэм дээд жаргал, аврал-энэ билээ.
73. Аяа, гэгээн элч минь ээ! Буруу номтнуудтай, хоёр нүүртэн урвагчидтай байлд, тэдний эсрэг хатуу бай. Тэдний очих газар болох халуун там юутай муухай гээч?

74. (Аяа, Мухаммед) Хоёр нүүртнүүд юу ч хэлээгүй гэж Аллахын нэр барьж андгайлдаг. Хэрэг дээр нүгэлтэй юм ярьдаг Ислам шашныг хүлээж авсны дараа дахин урван үл сүсэглэгсэд болцгоосон. Тэгээд үл бүтэх юмны төлөө толгойгоо гажиглан, гэгээн элчийн талаар хар санаа өвөрлөсөн. Аллах хийгээд Түүний элч өгөөмөр хишгээрээ баяжуулсны хариуд ийнхүү хар санаа өвөрлөв. Хэрэв тэд гэмшиж наминчалбал өөрсдөд нь өлзийтэй сайн байхсан билээ. Харин наминчлахаас нүүр буруулвал Аллах тэднийг энэ яваа насанд ч, хойд ертөнцөд ч хатуу цээрлүүлэх болно. Тэдэнд газар дэлхийд ямар ч найз, өмгөөлөн туслагч эс оллоно.
75. Тэдний зарим нь : “Хэрэв Аллах бидэнд өгөөмөр хишгээсээ хүртээх аваас бид мэдээж өглөг өргөж, чин үнэн журмыг сахигсад болцгооно” гэж Аллахад андгай тангараг өргөцгөөсөн.
76. Аллах тэдэнд өгөөмөр хишгээсээ хүртээхэд, тэд харамч зан гаргаж, амлалтаасаа буцав.
77. Аллах тэднийг амлалтаасаа буцаж, худал хэлсний төлөө Өөртэй нь нүүр тулгарах өдөр (ертөнцийн төгсгөлийн өдөр) хүртэл зүрх сэтгэлд нь урвагч байх занг суулгасан бөлгөө.
78. Аллах тэдний дотоод нууцыг, шивнэлдэн ярилцахыг мэддэгийг ухаардаггүй юм болов уу? Аллах бүхий л далдын нууцыг сайн мэдэж байдаг юм.
79. Мусулманчуудын өгөөмөр сэтгэлээр өглөг өгснийг буруушаан, хэр чадлаар өглөг өгснийг нь доромжлон тохуурагсадыг Аллах доог тохуу хийж, хатуу гэгсгээлтэй учруулна.
80. (Аяа, Мухаммед) Чи тэдний төлөө өршөөл эрсэн ч, эс эрсэн ч, бүр далан удаа өршөөл эрсэн ч Аллах тэднийг хэзээ ч үл өршөөмүй. Учир нь тэд Аллах хийгээд Түүний элчийг үгүйсгэж эсэргүүцсэн юм. Аллах эвдэрсэн хүмүүсийг зөв зам руу үл хөтлөмүй.
81. Дайнд явалгүй ард үлдэгсэд ар хударгаар Аллахын элчийг эсэргүүцэж, хөөрцгөөсөн. Тэд мал хөрөнгөө, амь насаа зориулан Аллахын төлөө байлдахыг хүссэнгүй. Харин ч нэг нэгэндээ : “Энэ халуунд дайнд бүү мордогтун” гэлцэв. (Аяа, Мухаммед) Хэрэв тэд ойлгодогсон бол тэдэнд: “Тамын гал үүнээс ч халуун” хэмээн сануулаарай.
82. Тэд хураасан нүглийнхээ хариуд нь бага инээж, их уйлах хэрэгтэй.
83. Хэрэв, Аллах чамайг дайны аюулаас аварч, дайнд очилгүй Мадинад үлдсэн хүмүүсийн дунд буцааж оруулахад тэд дараагийн тулалдаанд очих зөвшөөрлийг чамаас хүсвэл: “Та нар надтай хамт хэзээ ч дайнд явахгүй, надтай хамт хэзээ ч дайснуудтай байлдахгүй. Яагаад гэвэл та нар эхлээд хойш суухыг илүүд үзсэн. Одоо ч ард үлдэгсэдтэй хамт үлдэгтүн” хэмээн хэлэгтүн.
84. Тэдний дотроос үхэгсэдийн хэнийх нь ч төлөө уншлага мөргөл (жаназа

- мөргөл) хэзээ ч бүү үйлд, булшин дээр ч бүү оч. Учир нь тэд Аллах хийгээд Түүний элчийг эсэргүүцэн үл сүсэглэж, бузар хэвээр үхэцгээсэн билээ.
85. Тэдний мал хөрөнгөнд бүү шунагтун. Аллах, тэднийг энэ хорвоод тэрхүү мал хөрөнгөөр нь гэгсгээн цээрлүүлэхийг, сүсэггүй буруу номтон хэвээрээ үхэхийг нь хүссэн бөлгөө.
  86. “Аллахад сүсэглэж, Түүний элчтэй мөр зэрэгцэн тулалдагтун” хэмээсэн нэгэн бүлэг айлдвар бууж ирэхүйд тэдний чинээлэг хэсэг нь дайнаас сугарч үлдэх зөвшөөрөл хүсч: “Биднийг орхино уу? Ард үлдэгсэдтэй хамт хоцроё” гэх нь гарцаагүй.
  87. Тэд гэртээ үлдэгсэдтэй хамт байхыг хүссэн. Тэдний зүрх тамгалагдсан. Тиймээс тэд юу ч эс ухаармуй.
  88. Харин гэгээн элч хийгээд түүнтэй хамт яваа үнэн сүсэгтэнгүүд мал хөрөнгө хийгээд амь насаараа дэнчин тавьж байлдсан. Иймд энэ ба хойд насны бүхий л буянт үйлс тэднийх бөгөөд тэд сайн сайханд хүрэх болно.
  89. Аллах тэдэнд хаяагаар нь ариун булаг урссан диваажинг бэлдсэн. Тэд тэндээ эгнэгт оршмуй. Энэ бол аугаа, хосгүй жаргал, аврал бөлгөө.
  90. Бадауичүүдээс (Арабын цөлд амьдардаг овог) хэсэг хүмүүс шалтаг заан, чамаас зөвшөөрөл хүсээд ирлээ. Аллах болоод Түүний элчид худал хэлэгсэд суугаад хоцров. Тэдний дотроос үл сүсэглэн буруу номтон бологсодыг зовоох гэгсгээл бий.
  91. Хэрэв, Аллах хийгээд Түүний элчид сүсэг бишрэлээрээ таалалтай бол дорой буурайчуудад, өвчинд нэрвэгдэгсэд, зохих зардал олоогүйчүүдэд дайнд мордохгүй бол нүгэл болохгүй. Буян үйлдэгсэдийг хариуцлаганд татах учир үгүй. Аллах өршөөгч бөгөөд энэрэгч бөлгөө.
  92. Тулалдаанд очихын тулд чамаас уналга гуйгаад ирэгсэдэд чи: “Надад та нарт унуулах унаа үгүй” гэж хэлсэн. Тэд хэрэгцээндээ зарцуулах юм олоогүйдээ гутран, нулимс унагаасан тул (дайнд мордоогүй тул) тэдэнд нүгэл үгүй.
  93. Баян чинээлэг мөртлөө (гэртээ) үлдэхийн тулд чамаас зөвшөөрөл гуйхсад хариуцлага хүлээх ёстой. Тэд ард үлдэгсэдийн (хөгшин хүмүүс, эмэгтэйчүүд, хүүхдүүдийн) хамт үлдэхийг илүү хүсэцгээсэн. Тэдний зүрх тамгалагдсан. Тиймээс тэд юу ч эс ухаарна.
  94. Дайнаас буцаж ирэх үед тэдэнтэй учирвал тэд чамд шалтгаан тоочино. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Шалтгаан бүү тоочигтун. Бид та нарт хэзээ ч итгэхгүй. Аллах та нарын (урвасны) тухай бидэнд мэдэгдсэн. Аллах хийгээд Түүний гэгээн элч та нарын үйлс бүхнийг харж байдаг. Хожим та нар ил, далд бүхнийг мэдэгч Аллахын өмнө очих болно. Тэгээд та нарын хийсэн нүглийг өөрсөд чинь хэлж өгөх болно” хэмээн сануулагтун.

95. Тэдэн рүү буцаж ирэхүйд, тэд өөрсдөө шийтгүүлэхээс аврагдахын тулд Аллахын нэр барин андгайлах болно. Тэднээс хол байгтун. Тэд бузар булай амьтад. Хураасан нүглийнхээ хариуд, тэдний очих газар нь халуун там байх болно.
96. Тэд та нарыг сэтгэл хангалуун байлгах гээд Аллахын нэр барин андгайлдаг. Гэхдээ, та нар тэдэнд сэтгэл хангалуун байлаа ч, Аллах бузар булай ард түмнийг хэзээ ч эс таалмуй.
97. Бадауичүүд, үл сүсэглэл хийгээд хоёр нүүр гаргах талаар гаргуун, тэрчлэн Аллахын гэгээн элчид илгээсэн журмыг үл ойлгоход таарсан амьтад. Аллах бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн билээ.
98. Бадауичүүдийн зарим нь Аллахын төлөө зарцуулах зүйлээ нарийн тооцдог, та нарын гай зовлонд учрахыг л хүлээдэг. Үнэндээ, тэр гай зовлон өөрсдөд нь тохиолдоно. Аллах бүхнийг сонсогч, бүхнийг зүй ёсоор нь мэдэгч билээ.
99. Бадауичүүдийн зарим нь Аллах хийгээд хойд ертөнцөд итгэцгээдэг. Аллахын төлөө зарцуулсан зүйлсээ Аллахад дөтлөн ойртох, гэгээн элчийн ивээл залбиралыг хүртэх барьцаа болгодог. Үнэндээ тэрхүү өгсөн зүйлээрээ дамжуулан Аллахад дөтлөн ойртдог. Аллах тэднийг хайр энэрэлдээ (диваажинд) авна. Аллах үнэхээр машид өршөөгч, энэрэгч буюу.
100. Исламын шашинд орохоор анхлан их нүүдэл хийгсэд болоод тэдэнд тусламж үзүүлэгсэд (ансар) мөн тэдний буянт мөрийг дагагсадыг Аллах таалалдаа авсан, тэд ч Аллахт талархалтай болсон. Аллах тэдэнд, хаяагаар нь ариун булаг урссан диваажингуудыг бэлдсэн болой. Тэд тэнд мөнх оршино. Энэ бол хосгүй жаргал, аврал мөн.
101. Та нарын эргэн тойрон дахь Бадауи (нүүдэлчин) Арабуудын дотор хоёр нүүртэнгүүд бий. Мадинагийн оршин суугчдын дотор ч улам эсэргүүцэгч хоёр нүүртэнгүүд бий. Чи тэднийг мэдэхгүй, Бид тэднийг мэднэ. Бид тэднийг хоёр удаа (энэ яваа насанд хийгээд хойд ертөнцөд) гэгээн цээрлүүлнэ. Дараа нь тэд тамын их гэгсгээл рүү түлхэгдэх болно.
102. Нөгөө нэг хэсэг хүмүүс нүгэлээ наминчилдаг агал буянт сайн үйлсийг муу үйлстэй хугадаг. Магадгүй, Аллах тэдний гэмшлийг хүлээж авах биз. Үнэндээ Аллах нэн өршөөгч бөгөөд энэрэгч билээ.
103. (Аяа, Мухаммед) Тэдний мал хөрөнгөөс өглөг аваад, тэднийг түүгээр ариусгаж, элбэг дэлбэг болгон, тэдний төлөө залбирагтун. Учир нь чиний залбирал тэдний хувьд нэгэн тайтгарал юм. Аллах бүхнийг сонсогч, зүй ёсоор нь мэдэгч билээ.
104. Тэд боолуудын гэмшлийг уучлан, өргөлийг нь хүлээн авагч нь зөвхөн Аллах гэдгийг мэддэггүй юм уу? Аллах алив гэмшлийг уучлагч бөгөөд машид энэрэгч шүү дээ.
105. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Ажил үйлсээ хийгтүн! Та нарын үйл хэргийг

- Аллах хийгээд Түүний гэгээн элч, бас үнэн сүсэгтэнгүүд харах болно. Ил, далд бүхнийг мэдэгч Аллахаын өмнө очих болно. Аллах та нарын үйлдсэн бүхнийг чинь мэдүүлэх болно.
106. Аян дайнд оролцолгүй ч гэсэн Аллахаын зарлигийг хүлээсэн хүмүүс бий. Аллах тэднийг гэсгээн цээрлүүлнэ эсвэл гэмшилийг нь хүлээж уучилна. Аллах бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн мөн.
107. Зарим этгээдүүд (хоёр нүүртэнгүүд) хор уршиг хүргэх, үл тоомсорлох, сүсэгтэнгүүдийн хооронд ан-цав үүсгэх, үймээн самуун тарихын тулд урьд өмнө Аллах хийгээд Түүний Элчийг эсэргүүцэгчийн очих байр болгон сүм (масжид дирар) барьцгааж, “Бид зөвхөн сайн сайхныг л хүссэн юм” гэж тангараглана. Хэрэг дээр Аллах тэдний туйлын худалч болохыг гэрчилмүй.
108. (Аяа, Мухаммед) Чи тэдний сүмд очиж, хэзээ ч уншлага мөргөл бүү үйлд. Анхнаасаа төгс сүсэглэл дор баригдсан сүм (Куба масжид) чиний уншлага мөргөл үйлдэхэд илүү зохимжтой. Тэнд өөрийгөө ариусгахыг эрхэмлэдэг сүсэгтэнгүүд бий. Аллах бүх талаараа ариуцсан хүмүүсийг таалдаг юм.
109. Барилгыг (Ислам шашны суурийг) Аллахаас айж, Түүний тааллын төлөө тавьсан хүн сайн уу? Эсвэл түүнийг нурах шахсан эрэг дээр барьж, өөрөө ч түүнтэй хамт тамын гал руу унсан хүн сайн уу? Аллах зальхай хүмүүсийг зөв зам руу эс хөтлөмүй.
110. Тэдний зүрх нь зүсэгдэн үхэх хүртэл барьж байгуулсан сүм нь сэтгэлд нь эргэлзээ болон үлдэнэ. Аллах бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн мөн.
111. Аллах хэрэг дээр сүсэгтнүүдийн мал хөрөнгө, амь насыг нь, диваажингаар сольж авдаг юм. Тэд Аллахаын төлөө тулалдана, алацана. Үүнтэй холбоотой чин үнэн Таурат, Инжил болон Куранд бичигдсэн билээ. Аллахаас илүү амлалтандаа хүрдэг хэн байна вэ? Түүнтэй хийсэн энэхүү солилцоондоо баярлагтун. Энэ нь том завшаан болой.
112. Аллаhad наминчлагсад, уншлага мөргөл үйлдэгсэд, Аллахаыг талархан магтагсад, мацаг баригсад, мэхийн залбирагсад, сөгдөн мөргөгсөд, сайн үйлийг тушааж муу үйлийг хориглогсод, Аллахаас тогтоосон хэм хэмжээг сахигсад бүгд диваажинд очино. Энэхүү баярт мэдээг тэдэнд (сүсэгтнүүдэд) дууллагтун.
113. Олон бурхан шүтэгч буруу номтнууд халуун тамд унах нь тодорхой болсны дараа, хэдийгээр хамаатан садан байсан ч гэгээн элч болон үнэн сүсэгтнүүд тэдний төлөө өршөөл гуйх нь зөв биш ээ.
114. Ибрахим элч аавынхаа төлөө өршөөл гуйсан нь зөвхөн түүнд өгсөн амлалтаас үүдэлтэй. Аллахаын дайсан байсныг мэдсэний дараа тэр эцгээсээ холдсон. Ибрахим үнэхээр машид дөлгөөн зантай, тэвчээр тэсвэртэй байлаа.



115. Аллах нэгэн ардыг зөв шулуун замд оруулсны дараа, юунаас болгоомжлохыг өөрсдөд яруу тод тайлбарлах хүртэл тэднийг төөрөгдөлд эс оруулмай. Эргэлзээгүй, Аллах бүхнийг мэдэгч бөлгөө.
116. Тэнгэр, газрыг эрхшээх нь гагцхүү Аллахынх билээ. Тэр үхсэнийг амилуулдаг, амьдыг үхүүлдэг. Та нарын хувьд Аллагаас өөр ямар ч анд найз хийгээд туслагч үгүй.
117. Аллах мусулманчуудын дотроос хэсэг хүмүүсийн сэтгэл нь хувирсан хэцүү мөчид гэгээн элчийг дагасан их нүүдэл хийгсэд болон тэдэнд туслагсадын наминчлалыг хүлээн авч өршөөсөн болой. Аллах тэдэнд маш энэрэнгүй учраас тэдний наминчлалыг хүлээж авсан.
118. Дайнд оролцоогүй ард үлдсэн гурван хүний гэмшилийг Тэр хүлээж авсан юм. Газар дэлхий хэдий уудам ч гэсэн тэдэнд давчуу санагдаж, сэтгэл нь улам бүр бачууран, Аллагаас аврал эрэхээс өөр аргагүй болсныг ухаарцагасан юм. Дараа нь (хуучин үнэн сүсэгтэн байдалдаа эргэх хэмээн) тэдний наминчлалын төлөө Аллах гэмших боломж олгов. Аллах үнэхээр гэмшлийг хүлээж авагч, машид энэрэгч бөлгөө.
119. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллагаас айгтун бас үнэнч хүмүүстэй хамт байгтун.
120. Мадинагийн оршин суугчид хийгээд түүний эргэн тойрон дахь Бадауичууд дайнд оролцохгүй гэгээн элчээс хоцрох, өөрсдийнхөө амиа бодох, Аллахын элчийн хамт туулахгүй, сугаран үлдэх зэрэг нь зохисгүй. Учир нь тэдний Аллахын төлөө ангаж цангах, ядарч туйлдах, өлсөх, үл сүсэглэгсдийг хилэгнүүлэх алхам, тэрчлэн дайсныг дийлсэн ялалтууд бүхний төлөө Аллах сайн үйлс болон буян хайрлах болно. Аллах сайн үйлс үйлдэгсдийн буян хишгийг талаар орхихгүй.
121. Мөн тэдний Аллахын төлөө бага ч бай, их ч бай зориулсан зүйлс, дайнд туулж өнгөрүүлсэн зам мөр Аллагаас тэдний үйлдсэн сайн үйлсийн төлөө шагнах буянтай хэрэг болж бичигдэнэ.
122. Мусулманчууд цөмөөрөө дайнд мордох нь зөв биш ээ. Тэдний бүлэг тус бүрээс нэг хэсэг нь шашны ухааныг суралцаж дайнаас буцаж ирэгсэдийг болгоомжлохын тулд сэрэмжүүлэх нь өлзийтэй биш гэж үү?
123. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нарт ойр байгаа үл сүсэглэгсэдтэй байлдагтун. Тэд та нарын хүч чадал илүү болохыг мэдэж аваг. Аллах эргэлзээгүй үнэн сүсэглэгсэдтэй хамт гэдгийг та нар мэдэгтүн.
124. Аливаа нэгэн бүлэг (Куран судрын нэг бүлэг) илгээгдэхэд хоёр нүүртэнгүүдийн зарим нь (доромжлон): “Энэхүү бүлэг айлдвар та нарын хэнийг чинь итгэл үнэмшлийг бататгав?” гэж асууна. Харин сүсэглэгсэдийн хувьд тэдний итгэл үнэмшлийг нь батжуулан, хөөрөн баясацгаадаг бөлгөө.
125. Зүрх сэтгэлд нь өвчин нүүрлэсэн үл сүсэглэгсэд хийгээд хоёр

- нүүртэнгүүдийн хувьд энэхүү бүлэг айлдварууд тэдний үгүйсгэлийг улам нэмэгдүүлэн, тэд үл сүсэгтэн хэвээрээ үхэцгээсэн.
126. Тэд жил бүр нэг эсвэл хоёр удаа (өөрсдөд нь гай зовлон тохиож) сорилтонд орж буйгаа мэддэггүй гэж үү? Тиймээс тэд гэмшдэг ч үгүй, ухаардаг ч үгүй.
  127. Хэзээ нэгэн цагт бүлэг айлдварууд илгээгдвэл тэд бие биерүүгээ хараад: “Та нарыг хэн нэгэн харж байна уу” гэж асууцгаагаад зайлсхийгээд явцгаадаг. Эргэлзээгүй, тэд үл ухаарах амьтад учраас Аллах тэдний зүрх сэтгэлийг урвуулсан бөлгөө.
  128. Үнэндээ та нарт өөрсдийн чинь дотроос нэгэн гэгээн элч ирсэн. Та нарын хүнд байдал түүнийг их зовоосон. Тэр та нарт дуртай, үнэн сүсэгтэнгүүдэд машинд энэрэнгүй, нигүүлсэнгүй ханддаг.
  129. (Аяа, Мухаммед) Хэрэв тэд чамаас нүүр буруулвал чи тэдэнд: “Аллах надад хангалттай, Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Би зөвхөн Түүнд найдана. Тэр бол агуу аршийн (огторгуйн) Эзэн мөн” хэмээн хэлэгтүн.



Мадина-д илгээгдсэн. 109 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Алиф Лам Ра. Энэ нь далдын ухаанаар дүүрэн судрын айлдварууд болой.
2. Өөрсдийн чинь дотроос нэгэн хүнд : “Хүмүүсийг Аллахын хилэгнэлээс сэрэмжлүүл, бишрэн сүсэглэгсэдийг Эзэнтний дэргэд тэдний төлөө эрхэм дээд хүндлэл байгаагаар баярлуулагтун” хэмээн Бид айлдахад эдгээр хүмүүсийг гайхшруулсан болов уу? Буруу номтнууд : “Энэ бол гарцаагүй илбэдэлт” гэгцээсэн юм.
3. Та нарын Эзэнтэн Аллах тэнгэр, газрыг зургаан өдөрт бүтээсэн. Дараа нь аршийг (огторгуйг) Өөрийн эрхшээлд оруулж, алив бүхнийг удирдан залсан. Түүний зөвшөөрөлгүйгээр хэн ч өмөөрөн ивээгч болж чадахгүй. Аллах бол та нарын Эзэнтэн мөн. Түүнд мөргөн залбирагтун. Өдий хүртэл ухаарахгүй байна гэж үү?
4. Бүгдээрээ Аллахын өмнө буцаж очих болно. Аллахын амлалт чин үнэн. Тэр бүхнийг оргүй хоосноос бүтээж, үнэн сүсэглэгчид болон буянт сайн үйлс үйлдэгсэдийг шударгаар шагнахын тулд эргэж амилуулдаг. Харин үл сүсэглэгсэдэд үгүйсгэл хийснийх нь төлөө шалзлам халуун уснаас ундаа бэлтгэн зовлонт гэсгээл үзүүлнэ.
5. Аллах нарыг туяатай, сарыг гэгээтэй бүтээсэн. Он жилийн тооллыг, цаг

- хугацааны тооцоог та нарт мэдүүлэхийн тулд сарны дамжин өнгөрөх байрлалыг тодорхой тэмдэглэсэн. Аллах тэдгээрийг чин ухаанаар бүтээсэн. Тэр ухаарал бүхий хүмүүст зориулан айлдваруудаа яруу тод тайлбарладаг.
6. Үнэндээ өдөр, шөнө хоёр солигдоход болон тэнгэр газарт Аллахын бүтээсэн зүйлүүдэд сэрэмжилдэг хүмүүсийн хувьд үй олон нотолгоонууд буй.
  7. Хэрэг дээр бидэнтэй учрахыг хүсдэггүй, амьд ахуйн амьдралд сэтгэл нь ханаж, түүгээр сэтгэлээ зогоогсод бол бидний айлдваруудаас ангид хоцрогсод мөн.
  8. Ийнхүү, хураасан нүгэлийнхээ төлөө тэдний очих газар нь халуун там.
  9. Үнэнчээр сүсэглэж, буянт үйл үйлдэгсэдийг итгэн сүсэглэлийнх нь төлөө Эзэнтэн нь зөв замаар хөтлөн, хаяагаар нь ариун булаг урсах баян тансаг диваажинд оруулна.
  10. Тэдний (диваажинхны) залбирал нь: “Аяа, Аллах! Чи бол бүхнээс ариун, чин үнэнч!” хэмээх явдал юм. Мөн тэдний мэндчилгээ нь: “(Ассаламу Галайкум) Танд амар амгаланг соёрхох болтугай!” гэх бөгөөд залбирлын төгсгөл нь: “Бүхийл магтаал талархал Ертөнцийн Эзэн Аллахад зохицмой” гэх явдал юм.
  11. Хэрэв Аллах хүмүүст, тэдний сайн сайхан бүхнийг яаран хүсдэг шиг муу юмыг яаравчлан өгсөнсөн бол, үнэндээ тэдний үхлийн хугацаа болсон байх сан. Гэвч Бидэнтэй уулзахыг үл тэмүүлэгсэдийг сохроор төөрөлдөн хэрж явахад нь боломж өгмүй.
  12. Хүмүүнд ямар нэгэн гай зовлон тохиолдвол суусан ч, боссон ч Бидэнд наминчлан залбирдаг. Хэрэв Бид гай зовлонгийг нь арилгавал тэрхүү залбирлыг умартан, бахь байдгаараа үл тоомсорлон яваад өгнө. Ийнхүү хэрээс хэтэрч даврагсадын ааш аяг нь өөрт нь сайхан санагддаг.
  13. Та нараас өмнөх хэсэг хүмүүсийг зальхай явдлынх нь төлөө, мөн гэгээн элчүүдийн өөрсдөл нь авчирсан нотолгоонуудад итгээгүйн төлөө үгүй хийсэн. Бид нүгэлт хүмүүсийг ингэж гэсгээдэг юм.
  14. Дараа нь хэрхэхийг сорих үүднээс тэдний оронд та нарыг газар дэлхий дээр залгамжлагч болгон илгээсэн билээ.
  15. Тэдэнд Бидний илэрхий айлдварууд уншигдахад Бидэнтэй уулзахыг үл хүсэгчид: “Үүнээс өөр Куран авч ир, эсвэл үүнийг өөрчил” хэмээн тулгана. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Би дур мэдэн өөрчилж үл чадна. Гагцхүү надад илгээгдсэнийг л дагаж мөрдөнө. Эзэнтнээ эсэргүүцэх аваас аугаа их өдрийн (Ертөнцийн төгсгөлийн өдрийн) гэсгээлээс айн чичэрмүй” хэмээн хэлэгтүн.
  16. Мөн: “Хэрэв Аллах хүссэн бол би үүнийг та нарт уншихгүй байсан. Аллах ч үүнийг та нарт илгээхгүй байсан. Би үүнээс өмнө насныхаа

- ихэнхийг та нарын дунд өнгөрүүлсэн. Өдий хүртэл үүнийг ухаарахгүй байна гэж үү дээ?” хэмээгтүн.
17. Аллахыг гүжирдэн гүтгэсэн, Түүний айлдваруудыг худал хэмээгсдээс илүү зальхай этгээд байх уу даа? Нүгэлтэнгүүд хэзээ ч аврагдахгүй, зорилгодоо хүрч чадахгүй.
  18. Тэд Аллахад үл итгэн өөртөө хор хөнөөл ч үгүй, ашиг ч үгүй юманд мөргөцгөөж: “Энэхүү бурхад Аллахын дэргэд биднийг ивээгчид мөн” гэлцэнэ. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Та нар тэнгэр газарт Аллахын үл мэдэх юм байдгийг мэдэж, Түүнд хэлж өгөх гэж байна уу?” хэмээгтүн. Үгүй ээ, Аллах тэдний зохиомол бурхадаас ангид бөгөөд аугаа их бөлгөө.
  19. Хүмүүс уг нь нэг л нэгдмэл ард түмэн байсан, дараа нь тэд бие биетэйгээ өрсөлдөн, арсалдсан, зөрөлдөцгөөсөн.(янз бүрийн шашин бий болж, зохиомол зүйлд залбиран шүтэх болов.) Хэрэв, Эзэнтнээс урьдчилан хэлсэн үг (хойд ертөнцөд шийтгэх тухай үг) үгүйсэн бол, тэдний булаацалдан зөрөлдсөн зүйлсийн тухай даруй (гэсгээх) шийдвэр гаргах байсан юм.
  20. Мөн тэд (Меккегийн ард олон): “Түүнд (Мухаммедэд) юуны төлөө Эзэнтнээс нэгэн нотолгоо бүхий ер бусын гайхамшиг илгээгддэггүй юм вэ?” гэж асууна. Аяа, Мухаммед! тэдэнд: “Далд бүхнийг гагцхүү Аллах эрхшээмүй. Та нар хүлээцгээгтүн. Би ч та нартай хамт хүлээх болно” хэмээн хэлэгтүн.
  21. Хүмүүст гай зовлон тохиолдоход энэрэн хайрлавал тэд Бидний айлдваруудыг үгүйсгэх арга чарга хайх юм. Аяа, Мухаммед! тэдэнд: “ Аллахын цээрлэл үтэр түргэн” гэж хэл. Үнэндээ, Бидний элчүүд (мэлэүүд) та нарын арга мэхийг бичиж байдаг.
  22. Аллах та нарыг газраар, далайгаар зорчиулдаг. Тэдний суугаа хөлөг онгоц намуухан нэгэн салхиар урагшлан, хүмүүс хөөрөн баясч явахад гэнэт шуурга босч, тал талаас хүчтэй давалгаа оволзоход тэд ингээд давалгаанд цохиулах нь хэмээн бодож, “Хэрэв, биднийг үүнээс аврах юм бол бид чамайг бишрэн шүтэх болно” гэж үнэн сүсэгээрээ Аллахад залбирцгаадаг билээ.
  23. Аллах тэднийг авармагц тэд газар дээр зохисгүй танхайрдаг юм. Аяа, хүмүүс минь ээ! Та нарын танхайрлын уршиг та нарыг дайрах болно. Амьдралын түр зуурын цэнгэлийг эдлээд эцэст нь Бидний өмнө ирэх болно. Тэр цагт хийсэн үйлдлийг чинь Бид хэлж өгөх болно.
  24. Үнэндээ ахуй амьдралын жишээ нь Бидний тэнгэрээс оруулдаг бороотой адил билээ. Газар дэлхийн хүмүүс болон амьтадын идэж уух ургамал хүнс ургаж, газар дэлхий өнгө засч сэргэн мандахад газрын эзэд их ургац авна хэмээн горьдоно. Тэр мөчид өдөр буюу шөнө Аллахын зарлиг бууж, ургамал жимс бүхэн үндсээрээ тасарч, юу ч

- ургахгүй мэт харагдахын адил болно. Бид ухаарах хүмүүст зориулан айлдваруудаа ийнхүү тайлбарладаг юм.
25. Аллах боолуудаа амар амгалангийн оронд урьж баймуй. Тэр хүссэн хүнээ зөв шулуун замд оруулмуй.
  26. Буян үйлдэгсдэд сайн сайхан юм, бас илүү боломж бий. Тэдний нүүр царай хир буртаггүй, басамжлагдахгүй. Тэд диваажингийнхан бөгөөд тэндээ эгнэгт оршимуй.
  27. Харин муу үйл үйлдэгсдэд хийсэн хэргийн хэрээр цээрлэл оногддог. Тэд шившигт унана. Аллахын цээрлэлээс тэднийг хэн ч аварч чадахгүй. Нүүрэнд нүглийн бузар илрэн шөнийн харанхуй мэт харанхуйлна. Ийнхүү, тэд халуун тамынхан бөгөөд тэндээ эгнэгт оршимуй.
  28. Мөн тэр өдөр (Ертөнцийн төгсгөлийн өдөр) Бид тэднийг үгүй хийнэ. Тэгээд үл сүсэглэгсдэд: “Та нар болон Аллахтай эн зэрэгцүүлсэн юмс дор бүрдээ байраа эзэлцгээгтүн” хэмээх болно. Тэднийг бие биеэс нь ялган салгана. Тэдний Аллахтай эн зэрэгцүүлсэн зохиомол бурхад нь: “Та нар, биднийг шүтэж байгаагүй шүү дээ!” гэнэ.
  29. Мөн: “Та нар болоод бидний дунд гэрч болоход Аллах л хангалттай. Бид та нарын шүтлэгүүдээс огтхон ч мэдээлэлгүй байсан шүү” гэж хэлцгээнэ.
  30. Ийм л үед хүн бүр хийсэн зүйлээрээ сорилтонд ормуй. Мөн өөрсдийн жинхэнэ Эзэн болох Аллахын нигур дор буцаагдах бөгөөд тэдний ивээн хамгаална гэж итгэн зохиосон хуурамч юмс бүхэн тэднийг орхин одно.
  31. Аяа, Мухаммед! “Тэнгэр, газраас та нарт хэн хувь хишиг хүртээх вэ? Сонсох, харах чадварыг чинь хэн залж удирдах вэ? Хэн үхлээс амьдийг, амьдаас үхлийг бий болгох вэ? Үйл хэрэг бүхнийг хэн гүйцэтгэх вэ?” хэмээн асуувал тэд дариухан “Аллах” гэж хэлцгээх болно. Аяа, Мухаммед : “Тэгвэл та нар Аллагаас айхгүй юу” хэмээн хэл.
  32. Та нарыг жинхэнэ бүтээгч эзэн бол Аллах мөн. Чин үнэн үгүй газарт төөрөгдлөөс өөр юу байх билээ? Тэгвэл та нар яахлаараа үнэнээс гаждаг юм вэ?
  33. Ийнхүү бузар булай үйлдэлд Эзэнтний: “Тэд хэзээ ч үл сүсэглэмүй” хэмээх зарлиг нь зохистой байх болно.
  34. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Та нарын Аллахтай эн зэрэгцүүлсэн зүйлсийн чинь дотор (зохимол бурхадын) юмыг оргүй хоосноос бий болгож, дараа нь үхүүлж, дахин амилуулах чадвартай нь байгаа юм уу? Аллах оргүй хооснос бий болгож, дараа нь түүнийг үхүүлж, дахин амилуулж чадна. Та нар үнэнээс юунд гаждаг юм вэ?” хэмээн хэлэгтүн!
  35. Мөн: “Та нарын эн зэрэгцүүлсэн юмнуудаас чинь зөв шулуун зам руу хөтлөх хэн байна вэ?” хэмээн асуугтун. Тэдэнд: “Аллах л зөв шулуун зам руу хөтөлмуй. Тэгвэл зөв зам руу хөтөлдөгийг дагах нь зохистой уу, Эсвэл зөв зам руу хөтөлж чадаагүй эсрэгээр бусдад хөтлүүлэхэд

- хүрсэн хэн нэгэнд итгэх нь зохистой уу? Та нарт юу болоод байна вэ? Яахлаар алдаатай шийдвэр гаргадаг юм вэ?” хэмээн хэлээрэй.
36. Тэдний олонхи нь хоосон таамаглалыг дагацгаадаг. Үнэхээр хоосон таамаглал нь чин үнэний дэргэд юу ч биш ээ. Аллах үнэхээр тэдний ааш араншинг зүй ёсоор мэддэг билээ.
  37. Энэхүү Куран Аллахаас өөр хэн нэгнийх хэмээн гүтгэж болохгүй. Куран бол түүнээс өмнө илгээгдсэн (Таурат, Инжил зэрэг) судруудыг бататган Аллахын айлдваруудыг ил тод тайлбарлана. Тэр бүхий л ертөнцийн Эзэнтний зүгээс илгээгдсэн нь ямар ч эргэлзээгүй билээ.
  38. Үгүй бол тэд Кураныг Мухаммед өөрөө санаанаас зохиосон гэгцгээж байна уу? Аяа, Мухаммед! Тэдэнд: “Хэрэв үнэнч юм бол, Аллахаас өөр дуудаж чадах хүнээ дуудаж, Куран судрын бүлэгтэй адил бүлгийг дуудан зохиогоод аль?!” хэмээн хэлэгтүн.
  39. Тийм биш ээ, Тэд ухаан нь хүрэхгүй, утга агуулгыг нь ойлгож чадахгүй юмыг (Кураныг) худал хэмээдэг. Тэдний өмнөхүүд ч ийнхүү худал хэмээн үгүйсгэсэн билээ. Тиймээс, чи зальхай этгээдүүдийн төгсгөл нь ямар болсныг харатгун!
  40. Тэдний дунд Куранд итгэдэг ч, үл итгэгчид ч буй. Эзэнтэн чинь танхайран үймээн дэгдээгсэдийг сайн мэднэ.
  41. Аяа, Мухаммед! Хэрэв тэд чамайг худал хэмээх аваас: “Миний үйл хэрэг надад, та нарын үйл хэрэг та нарт хамаарагддаг. Та нар миний хийснээс, Би ч гэсэн та нарын хийснээс ангид баймуй” гэж хэл.
  42. Тэдний дунд чамайг сонсох хүмүүс ч бий. Ойлгон ухаарахгүй ч дүлийчүүдэд сонсгож чадах уу?
  43. Мөн чамайг тандаж харагсад ч бий. Харж чадахгүй байхад, сохруудыг чи зөв замд оруулж чадах уу?
  44. Үнэндээ Аллах хүмүүст хэзээ ч шударга бусаар эс хандмуй. Харин хүмүүс өөрсдөө өөртөө бусармаг зүйл хийдэг.
  45. Тэд нэг дор цугларах Ертөнцийн төгсгөлийн өдөр ирэхүйд ердөө (энэ дэлхийд) гэгээн өдрийн ганц цаг л үлдсэн мэт хоорондоо танилцаагаах бөлгөө. Аллахтай уулзахыг худал хэмээн үзэж, зөв шулуун замаар үл замнагсад нь хохирол амсацгаадаг болой.
  46. Аяа, Мухаммед! Тэдэнд зориулсан гэгсгээлийн заримыг чамд тохсон ч, чамайг үхүүлсэн ч тэд бидний өмнө сөгдөх болно. Эцэст нь Аллах тэдний хийсэн үйлдэл бүхэнд гэрч болмуй.
  47. Ард бүхэн өөрийн элчтэй. Тэдний гэгээн элчүүд нь ирэхүйд тэдэнд зориулж шударга шийдвэр гарна.Тэдэнд хэн ч шударга бусаар хандахгүй.
  48. Тэд : “Хэрэв та нар үнэнч бол энэхүү амлалт нь хэзээ болох вэ?” гэж асууна.

49. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Би өөртөө ч гэсэн Аллахын хүссэнээс өөрөөр ямар ч ач тус, хор хөнөөл хүргэж эс чадна. Хэн бүхэнд тохиолдох үхэл бий. Цаг нь болоход өчүүхэн төдий ч эс хойшлогдоно, бас эс урагшлагдана” хэмээн хэл.
50. “Та нарт Аллахын гэсгээл өдөр юм уу шөнийн аль нэгэнд тохиох аваас нүгэлтнүүд алийг нь яаравчлан сонгох байсан вэ?” гэж асуугтун. (сонгохоос зугтаагаана)
51. “Аллахын гэсгээл ирсний дараа түүнд итгэх гэсэн юм уу? Эсвэл одоо юу? Үнэндээ та нар түүнийг (гэсгээлийг) яаран хүссэн шүү дээ” хэмээн хэлэгдэх болно л доо.
52. Дараа нь тэрхүү зальхай амьтадад: “Мөнхийн гэсгээлийг амсагтун. Хийсэн нүглийнхээ хариуг амсагтун” гэж хэл!
53. Тэд чамаас “Энэ үнэн үү?” гэж асууцгаана. Чи: “Тиймээ, тэр үнэн. Эзэнтнийхээ нэрээр андгайлан хэлье. Эргэлзээгүй, тэр машид үнэн болой. Та нар Аллахын цээрлэлээс хаашаа ч зайлж чадахгүй” гэж хэлэгтүн.
54. Зальхай этгээд бүр дэлхий дээрх бүхий л баялаг өөрийнх байсан бол, гэсгээл үзэх цагт түүнийг (нүгэлийнхээ төлөөсөнд) өгчихөөд, гүн харамсах байсан биз. Гэхдээ, тэдний тухайд шударга шийдвэр гарах бөгөөд зальхай явдал хийгдэхгүй.
55. Мэдтүгэй. Тэнгэр, газар дээрх бүхэн үнэндээ Аллахынх бөлгөө. Аллахын амлалт чин үнэн болохыг дахин санагтун. Гэвч тэдний олонхи нь үүнийг эс мэддэг.
56. Тэр амилуулдаг, бас үхүүлж чаддаг. Та нар зөвхөн Түүний өмнө буцаан очих болно.
57. Аяа, хүмүүс ээ! Эзэнтний чинь ухуулга сургаал нь та нарын итгэл үнэмшлийн согогийг эдгээнэ. Үнэн сүсэглэгэсэдийн хувьд зөв шулуун зам, хайр энэрэл (Куранаар дамжин) ирсэн амуй.
58. Аяа, Мухаммед! “Тэд Аллахын хайр энэрэл, нигүүлслэл, ивээлээр бий болсон энэхүү зүйлст хөөрөн баясгацгаагтун. Энэ бол хураасан эд хөрөнгөнөөс буянтай” хэмээн хэлэгтүн.
59. Аяа, Мухаммед! “Аллах та нарт хувь хишгээсээ юу илгээснийг харж байна уу? Та нар тэр хувь хишгийн заримыг нь ариун, заримыг нь бузар хэмээн ялгаварласан. Аллах та нарт ийнхүү ялгахыг зөвшөөрсөн гэж үү? Аль эсвэл та нар Аллахыг гүжирдээд байна уу?” хэмээн асуугтун.
60. Аллахын эсрэг худал гүжирдэгсэд ертөнцийн төгсгөлийг юу гэж бодоцгоогоод байна? Аллах үнэхээр хүмүүсийг энэрэгч ажгуу. Гэвч, хүмүүсийн олонхи нь үүнийг мэддэггүй юм.
61. Аяа, Мухаммед! Чи ямар байдалтай байсан ч, Кураны аль хэсгийг уншсан ч ямар үйл үйлдсэн ч, түүнтэй оролдож байх үед ч Бид та нарыг хянаж ажиглаж байдаг. Газар, тэнгэрт буй хумхын тоосны чинээ зүйл ч,

- түүнээс том, бага ч зүйл байсан ч Аллахын хяналтаас гадна үлдэхгүй (нуугдаж чадахгүй). Энэ бүхэн Лаухил-Махфуз буюу хувь тавилангийн номонд тодорхой бичигдсэн болно.
62. Мэдтүгэй! Эргэлзээгүй, Аллахын анд нарт (үнэнч мэргэдүүдэд) айдас хүйдэс үгүй, тэд гуниг зовлон туулахгүй.
  63. Тэд бол, Аллахад төгс итгэцгээсэн, үнэнч сүсэгтнүүд мөн.
  64. Тэдэнд энэ хорвоод болон хойд насанд ч баярт мэдээ баймуй. Аллахын айлдвар хэзээ ч өөрчлөгдөхгүй. Энэ бол баяр баясалангийн дээд нь бөлгөө.
  65. Аяа, Мухаммед! Үл сүсэгтнүүдийн үг нь чамайг бүү гуниглуулаг. Бүхний эрх дарх Аллахынх. Тэр бүхнийг сонсогч, зүй ёсоор нь мэдэгч.
  66. Тэнгэр, газарт буй амьтай, амьгүй бүхэн зөвхөн Аллахын эзэгнэл дор гэдгийг санаж явагтун. Ийм байхад Аллахаас бусад эн зэрэгцүүлсэндээ мөргөгсөд хэний хойноос гэлдрэнэ вэ? Үнэндээ тэд хоосон мөрөөдөлдөө хөтлөгдөж, дэмий юм чалчдаг.
  67. Аяа, Хүмүүн төрөлхтөн! Аллах та нарыг амраахын төлөө шөнийг, үзэж харахын төлөө (хөдөлмөрлөхийн чинь төлөө) өдрийг бүтээсэн билээ. Сонсож ухаарах хүмүүст сургамж авах нотолгоо хангалттай буй.
  68. Тэд (хиймэл бурханд бишрэгсэд): “Аллах хүүхэдтэй юм” гэгцгээсэн. Үгүй ээ! Тэр үүнээс ангид. Түүнд дутагдах зүйл алга. Тэнгэр, газарт буй бүхэн Түүнийх. Энэ тухайд та нарт ямар ч баталгаа байхгүй. Та нар Аллахын тухайд мэдэхгүй зүйлсээ ярцгаах гэж үү дээ!
  69. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Аллахыг гүжирдэн гүтгэгсэд хэзээ ч авралыг олохгүй” хэмээн хэлэгтүн.
  70. Тэд амьдралын өчүүхэн зугаа цэнгэлийг л эдлээд дараа нь бидний өмнө ирнэ. Эцэст нь үл сүсэгтэн буруу номтон болсоных нь төлөө тэднийг зовлонг гэгсгээлтэй учруулна.
  71. Аяа, Мухаммед! Тэдэнд Нухын тухай уншиж өг. Тухайн үед тэр өөрийнхөө зон олондоо хандан: “Аяа, улс түмэн минь ээ! Би та нарын дунд байх нь, Аллахын айлдваруудыг ухуулан сэнхрүүлэн сануулах нь та нарт хүнд тусаад байгаа бол би зөвхөн Аллахад найдах болно. Та нар ч гэсэн Аллахтай зүйрлэдэг нөгөө хиймэл бурхадтайгаа хамжин миний эсрэг хийх юмаа бэлтгээрэй. Тэр үйл чинь та нарт гай бүү болог! Үүнийхээ дараа намайг зай завсаргүй шүүгтүн!” гэв.
  72. Мөн: “Хэрэв та нар миний үгийг үл тоон нүүр буруулах аваас, би ч та нараас шан харамж хүсээгүй билээ. Миний шан харамж гагцхүү Аллахад баймуй. Надад Аллахыг шүтэгсэдийн нэг нь байх нь тушаагдсан” гэв.
  73. Тэд Нух элчийг худалч хэмээн хүлээн зөвшөөрөөгүй билээ. Иймд бид Нух болон түүнтэй хамт хөлөг онгоцон дээр байсадыг аварч, усанд живсэн хүмүүсийн оронд тэднийг залгамчлагч болгосон юм.



- Бидний айлдваруудыг худал хэмээгсэдийг далайд живүүлэв. Сануулга авагсадын хувь заяа ямар болсоныг харатгун!
74. Гэгээн элч Нухын дараа Бид элчүүдийг өөрсдийнх нь зон олонд нь илгээсэн болой. Тэд зон олондоо нотолгоо бүхий ер бусын гайхамшигуудыг авч ирцгээсэн. Гэвч өмнө нь худал хэмээн үл итгэцгээсэн юманд тэд гэгээн элчүүд ирсний дараа ч итгэсэнгүй. Ийнхүү хэрээс хэтэрч даврагсадын зүрх сэтгэлийг Бид тамгалсан юм.
  75. Тэдний араас ч Фиргаун болон түүний эрхмүүдэд Муса, Харун хоёрыг олон нотолгоо бүхий ер бусын гайхамшигуудтайгаа илгээсэн билээ. Гэвч тэд үл тоомсорлон, ихэмсэг зан гаргацгааж, нүгэлтэн болцгоосон.
  76. Бидний зүгээс тэдэнд чин үнэн нотолгоо ирэхэд : “Энэ бол эргэлзээгүй хуурамч илбэ” гэцгээсэн.
  77. Муса: “Та нарт илгээсэн чин үнэнийг ингэж хэлэх гэж үү? Энэ бол илбэ гэж үү дээ? Хуурамч илбэчид амжилтанд хүрч чадахгүй юм” хэмээн сануулав.
  78. Тэд: “Та нар биднийг өвөг дээдсийн минь замналаас (шашинаас) гаргах гээд, мөн энэ газрыг (Египет) та хоёр эзэгнэн, ёслол төгөлдөр амьдрах гээд ирсэн юм уу? Бид та хоёрт итгэхгүй” гэцгээсэн.
  79. Мөн Фиргаун ч гэсэн : “Мэдлэг чадвартай бүх илбэчдийг миний өмнө авч ирэгтүн” хэмээн тушаав.
  80. Ид шидтэй илбэчид ирмэгц, Муса тэдэнд : “шидэх гэснээ шидэгтүн” гэв.
  81. Тэд (олсоо) шидмэгц, Муса : “Энэ бол та нарын хуурамч илбэ төдий. Аллах түүнийг юу ч биш болгомуй. Учир нь Аллах бүтэлгүйчүүдийн үйлсийг дэмждэггүй” гэв.
  82. “Нүгэлтэнгүүд үл таалавч ч, Аллах чин үнэнийг өөрийнхөө үгээр нотлоно.”
  83. Фиргаун болон түүний зон олны дээдсийн уршигаас айж болгоомжилсон Мусагийн талын хэсэг хүмүүс итгэн биширцгээв. Фиргаун үнэндээ энэ нутагт давуу эрхтэй хэтэрхий дарангуйлагч байсан билээ.
  84. Муса: “Аяа, зон олон минь ээ! Хэрэв Аллахад итгэн биширч, хүлээн зөвшөөрсөн бол Түүнд найдаж, түшиж тулагтун” гэв.
  85. Тэд: “Бид зөвхөн Аллахад найдаж байна. Аяа, Эзэнтэн минь! Биднийг энэхүү зальхай олны үймээнд бүү оруулагтун” хэмээн гуйв.
  86. Мөн: “Биднийг Өөрийн хайр энэрэлээр тэр үл сүсэглэгч түмнээс аварч хайрла” хэмээн залбирав.
  87. Бид Муса болон түүний ахан дүүст нь : “Ард түмнийхээ төлөө Мисирт (Египетэд) орон байр баригтун. Орон гэрээ уншлага мөргөлийн газар болгож, уншлага мөргөлөө үйлдэгтүн. Үнэн сүсэглэгсдэд баярт мэдээг дуулагтун” гэсэн айлдварыг илгээсэн болой.

88. Муса хэлрүүн: “Аяа, Эзэнтэн минь! Чи үнэндээ Фиргаун болон түүний ард олонд энэ хорвоогийн ёслол төгөлдөр, эд баялаг бүхнийг өгсөн. Энэ чинь эдгээр хүмүүсийг замаас нь төөрөгдүүлэхийн төлөө байсан юм уу? Тэдний эд баялагийг үгүй болго, сэтгэл зүрхийг нь чангалагтун. Тэд зовлонт гэгсгээл үзэхээс наана итгэн сүсэглэхгүй шүү” гэв.
89. (Аллах): “Та хоёрын хүсэлт ёсоор болсон. Шашныхаа төлөө ухуулан сэнхрүүлэх ажлаа үргэлжлүүлээрэй. Мунхагуудын замаар бүү дагагтун” гэв.
90. Мөн: Израйлийн хүн ардыг тэнгис гатлуулан явуулчихлаа. Фиргаун болон түүний цэргүүд тэднийг харгислан хөөсөн. Эцэст Фиргаун өөрөө тэнгист живэх аюулд тулгарахад: “Би Израйлийн үр удмыг сүсэглэсэн бурханаас өөр ямар ч бурхан үгүй гэдэгт бүрэн итгэлээ. Би ч Мусулман боллоо” гэж залбирав.
91. “Дөнгөж одоо л сүсэглэв үү! Үнэндээ чи өмнө нь эсэргүүцэгч, үймээн дэгдээгч байсан билээ!”
92. Бусдад сургамж болгох үүднээс Бид өнөөдөр чиний зөвхөн амьгүй цогцосыг чинь аврана. Үнэндээ хүмүүсийн олонхи нь бидний айлдварууд болон ер бусын гайхамшигуудаас мэдээлэл муутай юм.
93. Үнэндээ, Бид Израйлийн үр садыг (Фиргауныг мөхсөний дараа) тав тухтай сайхан газарт байршуулсан бөгөөд тэдэнд цэвэр ариун хувь хишиг хүртээсэн юм. Өөрсдөд нь эрдэм мэдлэг (Таурат) илгэгдсний дараа хоорондоо зөрчилдөж эхэлсэн. Эзэнтэн тэдний маргалдаан зөрчилдөөний талаар ертөнцийн төгсгөлийн өдөр шүүж шийдвэрлэх болно.
94. Аяа, Мухаммед! Хэрэв, Бидний илгээсэн сударт эргэлзэж байгаа бол чамаас өмнөх ариун судрыг (Таурат, Инжил) уншигсадаас асуу. Үнэндээ, Эзэнтэнээс чинь чамд чин үнэн (Куран) илгээгдсэн болой. Тиймээс чи ямагт бүү эргэлзэгтүн.
95. Чи хэзээ ч Аллахын айлдваруудыг үгүйсгэгчдэд бүү итгэ. Тэгвээс чи хохирол амсах болно.
96. Аллахыг хилэгнүүлэн гэгсгээл хүртэгсэд үнэндээ сүсэглэдэггүй юм.
97. Тэдэнд бүхий л нотолгоонуудыг үзүүлсэн ч зовлонт гэгсгээлийг амсах хүртлээ итгэн сүсэглэдэггүй болой.
98. Гагцхүү Юнусын ард олноос бусад хотынхон (гэгсгээл үзэн байж) сүсэглэсэн ч ашиг тус олохгүй. Юнусын ард олон сүсэглэх үед Бид өөрсдөөс нь энэ хорвоогийн зовлон бэрхшээлийг холдуулсан. Мөн хэсэг хугацаанд (энэ хорвоогийн) хувь хишгээс ашиглуулсан билээ.
99. Аяа, Мухаммед! Хэрэв Эзэнтэн чинь хүссэн бол, дэлхий дээрх бүх хүмүүс сүсэглэх байсан. Чи хүмүүсийг албадан сүсэглүүлэх гэж үү?
100. Аллахын зарлиггүйгээр хэн ч сүсэглэх боломжгүй. Ухаан бодолгүй хүмүүст л Аллах гэгсгээл хүртээмүй.

101. Аяа, Мухаммед! “Тэнгэр, газарт юу байна вэ? Харагтун” Гэвч үл сүсэглэгчдэд нотолгоонууд болон сэрэмжлүүлэг ашиг тус өгөхгүй.
102. Тэд гагцхүү өөрсдөөсөө өмнөхүүдэд тохиосон өдрүүд лүгээ адил юмыг хүлээцгээж баймуй. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Тэгвэл та нар хүлээгтүн, Би ч та нартай хамт (та нарын гэсгээл үзэхийг чинь) хүлээгсэдийн нэг нь болоё” хэмээн хэл.
103. Бид эхлээд гэгээн элчүүдээ, үнэнч сүсэглэгсдээ аврах болно. Ийнхүү үнэн сүсэглэгсэдийг аврах нь бидний үүрэг болой.
104. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Аяа, хүмүүс ээ! Хэрэв миний шашинаас эргэлзэж байгаа бол би Аллахаас ондоо та нарын мөргөдөг хиймэл юманд мөргөж сүсэглэхгүй. Харин гагцхүү та нарын амийг таслах Аллахад мөргөж залбирна. Надад зөвхөн үнэн сүсэглэгч байх нь тушаагдсан” хэмээн хэлэгтүн.
105. Аяа, Мухаммед! “Чи Аллахыг цорын ганц хэмээн үздэг Ханиф (үнэн ариун) шашин руу тууштай эргэ. Буруу номтнуудыг бүү дагагтун.
106. Чамд ашиг ч, хохирол ч үзүүлж үл чадах Аллахаас өөр юманд бүү залбир. Дараа нь эс тэгвэл эргэлзээгүй зальхай амьтдын нэг нь болмуй.
107. Хэрэв, Аллах чамд нэгэн хор хөнөөл хүртээх аваас үүнийг Аллахаас өөр хэн ч эс ангижруулмуй. Аллах чамд сайн сайхан үйлсийг хандуулвал түүний хайр энэрэлд саад болох хүн үгүй. Аллах буянт сайн үйлээ өөрийн боолуудаас хүссэндээ хүртээдэг юм. Тэр машинд ивээгч, их л нигүүлсэгч бөлгөө.
108. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Аяа, хүмүүс ээ! та нарт Эзэнтгээс чинь чин үнэн (Куран) ирлээ. Хэн зөв замд орно, түүний ашиг тус өөрт нь оногдоно. Хэн төөрөгдөнө, түүний уршиг өөрт нь ирнэ. Би та нарын хамгаалагч биш ээ.” хэмээн хэлэгтүн.
109. (Аяа, Мухаммед) Чамд илгээгдсэн айлдварыг дагагтун. Аллах шийдвэрээ гаргах хүртэл тэвчээртэй байгтун. Аллах хамгийн шударга шүүгч билээ.



Мекке-д илгээгдсэн. 123 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Алиф, Лам, Ра. Энэ бол аугаа ухааны эзэн, бүхнийг мэдэгч Аллахын зүгээс илгээгдсэн, айлдварууд нь бататгагдаж, ил тод тайлбарлагдсан судар мөн.
2. Аяа, Мухаммед! Тэдэнд дараах зүйлсийг сануулагтун: “Аллахаас

- бусдад бүү мөргөгтүн. Үнэндээ би Аллахын зүгээс та нарт илгээгдсэн (буруу номтонуудыг) сэрэмжлүүлэгч, (Мусулманчуудыг) баярлуулагч гэгээн элч билээ.
3. Та нар Эзэнтнээсээ өршөөл гуйгтун. Түүнд залбирцгаагтун. Аллах та нарыг тодорхой хугацаа хүртэл сайн сайхан амьдруулаг. Эрхэм сайн хүмүүсийг цаглашгүй их хайрлаг. Хэрэв та нар татгалзвал би та нарын агуу өдрийн гэгсгээлд учрахаас айх юм даа.
  4. Эцсийн эцэст та нарын очих газар бол Аллах(Аллахын нигур дор) болой. Бүхий л зүйлд Аллахын чадвар хүрэлцэнэ гэдгийг сануул.
  5. Тэд харагдахгүйн тулд буруу тийшээ эргэнэ. Толгойгоо хувцасаараа нөмөрлөө ч Аллах тэдний ил, далд үйлдсэн бүхнийг мэдэж байдаг юм. Тэр бол сэтгэлийн гүнд байгааг ч бүрнээр мэдэгч бөлгөө.
  6. Газар дэлхий дээрх бүхий л амьд амьтны амь зуулга нь гагцхүү Аллахаас ажгуу. Аллах тэдний амьд ахуйдаа газрыг, үхсэн хойно орших нутгийг мэднэ. Энэ бүхэн Лаухил Махфузд (хувь тавилангийн дэвгэрт) ил тод баймуй.
  7. Аллах та нарын хэн нь сайн арга ухаан сийлэхийг чинь сорихын тулд өөрийн сансар огторгуй нь усан дээр байхад тэнгэр газрыг зургаан хоногт бүтээсэн юм. Хэрэв чи (Мухаммед) тэдэнд: “Үхсэнийхээ дараа дахин амилах болой” гэвэл үл сүсэглэгсэд: “Энэ бол илэрхий хуурамч илбэ” хэмээн хариулна.
  8. Хэрэв, Бид тэдэнд илгээх гэгсгээлээ нэгэн хором ч хойшлуулах аваас тэд: “Өнөөх, гэгсгээл нь яасан вэ?” гэж дооглоно. Харин гэгсгээл ирсэн өдөр (дахин зайлуулагдахгүй) орох газар олохгүй балмагдана. Ийнхүү, тэдний дооглосон юм өөрсдийнхөө толгойд буух нь тэр ээ!
  9. Хэрвээ Бид хүмүүнд хайр энэрлийг амсуулчихаад дараа нь буцааж авбал тэд цөхөртлөө итгэл алдран үл тоомсорлох болно.
  10. Харин тэдэнд тохиосон гай зовлонгийн дараа Бид сайн сайхан хишгээрээ шагнавал тэр: “Бүхий л гай зовлон надаас холдлоо” гэж баярлан бардамнана.
  11. Гагцхүү тэсвэр тэвчээр үзүүлж, сайн үйл үйлдэгсэд л ивээгдэнэ. Нэн их буян хишиг хүртэх болно.
  12. Аяа, Мухаммед! Буруу номтнууд болон үл сүсэгтэнүүдийн бидэнд: “яагаад тэнгэрээс эд баялаг буудаггүй юм вэ? Түүнтэй хамт нэгэн мэлж (тэнгэрийн элч) яагаад ирдэггүй юм вэ?” гэж шалгаасанд чи сэтгэл давчдана. Өөрт чинь айлдваруудынхаа заримыг нь хэлж өгөхөөс түтгэлзэх вий. Үнэндээ чи бол тэднийг зөвхөн сэрэмжлүүлэгч шүү дээ. Бүхнийг эрхшээгч зөвхөн Аллах бөлгөө.
  13. Тэд: “Кураныг Мухаммед өөрөө зохиосон” гэж байна уу? Тэдэнд: “Хэрэв та нарын зөв бол Аллахаас өөр туслалцуулахаар чадах бүхнээ дуудагтун. Үүнтэй адил 10 бүлэг айлдвар зохиож үзэгтүн” хэмээн хэл

14. Мөн: “Та нарын дуудсан юмнууд чинь хариу хэлж эс чадах аваас энэхүү Куран Аллахын эрдэм мэдлэгээр илгээгдсэн болохыг мэдтүгэй. Аллахаас өөр ямар ч бурхан үгүй. Та нар одоо хэрнээ итгэн сүсэглэхгүй гэж үү?” хэмээн асуугтун!
15. Амьд ахуй байдал болон зөвхөн түүний жаргал цэнгэлийг л хүсдэг хүнд тэдний хөдөлмөрийн хөлсийг бүрэн хүртээмүй. Тэдний хөлс хүч дутуу үнэлэгдэхгүй.
16. Харин тэдний хувьд хойд ертөнцөд тамын галаас өөр юу ч оногдохгүй. Тэдний амьд ахуйдаа хийсэн үйл хэрэг бүхэн нь талаар өнгөрмүй. Бас хийсэн сайн сайхан үйлс нь ч дэмий хоосон болой.
17. Эзэнтний зүгээс яруу тод нотолгоо бүхий Куран болон Эзэнтний (Жабрейл) гэрч ирсэн юм. Энэхүү ил тод нотолгоо ирэхээс өмнө манлайлан хөтлөгч, хайр энэрэл болон илгээгдсэн Мусагийн судрыг эзэмшсэн хүмүүс амьдралын эх үүсвэр болсон эд хогшил тэднийг хүсдэг хүмүүстэй эн тэнцүү гэж үү? Ийнхүү, эд хөрөнгийн шуналтнууд Куранд итгэдэггүй юм. Хэн Кураныг үгүйсгэнэ, түүний байх газар нь там мөн. Тиймээс Куранд бүү эргэлзэгтүн. Учир нь тэр бол Эзэнтний зүгээс илгээгдсэн чин үнэн бөлгөө. Гэвч хүмүүсийн олонхи нь үүнд үл итгэцгээнэ.
18. Аллахыг гүтгэсэн амьтадаас илүү зальхай этгээд байна гэж үү? Ийм хүмүүс ертөнцийн төгсгөлийн өдөр Эзэнтний өмнө ирэх болно. Тэдний гэрчүүд: “Эзэнтнийгээ гүтгэгсэд эд нар мөн!” гэж хэлцгээх болно. Аллахын хараал зальхай этгээдэд тусахыг санаж явагтун.
19. Зальхай амьтад хүмүүсийг Аллахын зөв замаас хазайлган саад болох бөгөөд Аллахын зам буруу, тойруу байхыг хүснэ. Тэд хойд ертөнцийг үгүйсгэцгээдэг билээ.
20. Тэд газар дэлхийд Аллахыг мөхөсдүүлж (цээрлэлээс мултарч) эс чадах бөгөөд тэдэнд Аллахаас өөр нөмөр нөөлөг ч үгүй. Тэдний гэсгээл давхар давхар нэмэгдмүй. Тэд чин үнэнийг сонсож, харж чадахгүй.
21. Ийнхүү тэд өөрсдийгөө хор хөнөөлд учруулсан бөгөөд тэдний хуурамчаар зохиосон бурхад нь өөрсдийг нь орхиж одно.
22. Эргэлзээгүй, тэд хойд ертөнцөд хамгийн их цээрлэл амсагсад мөн!
23. Үнэхээр бүрэн сүсэглэж, буянт үйл үйлдэгсэд, бас Эзэнтний өмнө чадалгүйгээ мэдэрч хүлцэл өчигсөд диваажингийнхан бөгөөд тэд эгнэгт тэндээ үлдэцгээнэ.
24. Энэ хоёр бүлгийн (үнэн сүсэглэгсэд ба үл сүсэглэгсэд) нэг нь дүлий, сохор мэт бөгөөд нөгөө нь сонор чихтэй, хурц мэлмийтэй мэт. Энэ хоёр адилхан гэж үү?. Үүнээс сургамж авахгүй юм уу?
25. Нэгэнтээ Бид Нухыг өөрийн ардад нь гэгээн элчээр илгээсэн билээ. Тэр тэдэнд: “Би та нарыг тодорхой сэрэмжлүүлэгч юм.” гэв.

26. Мөн: “Та нар Аллагаас бусдад бүү мөргөгтүн. Та нарын зовоох өдрийн гэсгээлд учрахаас айж байна” хэмээн зон олондоо хэлэв.
27. Нух элчийн зон олны эрхэмсэг дээдэс нь: “Чи бол бидэнтэй адилхан жирийн л хүн. Ухвар мөчид, мулгуу хүмүүсээс өөр чамайг дагасан хүнийг хараагүй. Та нарт биднээс илүү юм харагдахгүй байна. Түүгээр ч барахгүй бид та нарыг худалч хэмээн бодож баймуй.” гэж хариулав.
28. Нух тэдэнд : Аяа, ард олон минь! Хэрэв би Эзэнтнийхээ зүгээс илгээсэн яруу тод нотолгоонд үндэслэж, Тэр надад өөрийн хайр энэрлийг өгөөд, гэгээн элч болгосон байхад энэ нь та нарт үл харагдан, үзэн ядаж байвал бид та нарыг албадах юм гэж үү?
29. Аяа, ард олон минь! Би та нарт шашныг авч ирсний төлөө шан харамж, эд баялаг хүсэхгүй. Миний шан харамж гагцхүү Аллахад хамааралтай. Би үнэн сүсэглэгсэдийг хөөх нэгэн биш ээ. Учир нь тэд эргэлзээгүй Аллахтай учрана. Харин би та нарыг харанхуй мунхаг гэж үзнэ.
30. Аяа, ард олон минь! Хэрэв би тэднийг өөрөөсөө хөөж явуулах аваас намайг хэн Аллахын гэсгээлээс аврах вэ? Та нар үнэхээр ухаарахгүй юм гэж үү?
31. Би та нарт : “Аллахын баялаг надад бий” гэхгүй, бас “Далдын нууцыг мэднэ” гэж хэлэхгүй. Мөн “Өөрийгөө Аллахын мэлэч” гэж хэлэхгүй. Мөн та нарт дорд үзэгдэгсэдийн тухайд “Аллах тэдэнд хэзээч сайн сайхныг үл хайрламуу” гэж хэлэхгүй. Тэдний зүрх сэтгэлд буйг Аллах илүү сайн мэднэ. Тэр үед би (дээрх бүхнийг хэлсэнсэн бол) эргэлзээгүй зальхай амьтан болохсон билээ.” гэв.
32. Нухын хэлсний хариуд нь түүний хүмүүс: “Аяа, Нух! Үнэндээ чи бидэнтэй мөргөлдлөө, түүгээр ч барахгүй хэрүүл уруулын галыг асаалаа. Хэрэв чиний хэлсэн үг үнэн юм бол, биднийг сүрдүүлсэн зүйлээ үзүүлээд аль?!” гэлцэв.
33. Нух: “Аллах л хүсэх аваас та нарт гэсгээлийг илгээнэ. Харин та нар Түүнийг эсэргүүцээд хүчийг нь мөхөсдүүлж эс чадна.” хэмээн хариулав.
34. Мөн: “Хэрэв би та нарт сургамж өгөхийг хүссэн байлаа ч, Аллах та нарын төөрөгдөхийг (гэсгээхийг) чинь хүсэх аваас, миний сургамж та нарт ерөөсөө ч ашиг тус эс өгмүй. Аллах та нарыг бүтээсэн Эзэн бөгөөд хэзээ нэгэн цагт Түүний өмнө эргэж очих болно.” гэв.
35. Тэд, “Кураныг Мухаммед санаанаасаа зохиосон” хэмээн хэлэх нь үү? Аяа, Мухаммед, Тэдэнд: “Хэрэв би түүнийг санаанаасаа зохиосон юм бол нүгэл нь надад тусмуй. Гэвч би та нарын үйлдсэн нүгэлээс ангид байх болно.” хэмээн хэлэгтүн.
36. Нухт: “Үнэндээ чиний ард олны өмнөх сүсэглэгсдээс бусад нь хэзээ ч үл сүсэглэмүй. Тэдний ааш араншны төлөө бүү бухимд....
37. ...Бидний айлдварын дагуу нэгэн хөлөг онгоц хийж харуул. Зальхай

- этгээдийн тухай Надад бүү ханд. Учир нь тэд тэртээ тэргүй усанд живэцгээх болно.” хэмээн айлдвар ирлээ.
38. Нух хөлөг онгоц хийлээ. Тэдний дээдэс хажуугаар нь явж өнгөрөх бүртгээ доог тохуу хийцгээв. Нух тэдэнд : “Хэрэв та нар биднийг доог тохуу хийж байгаа бол хожим бид ч та нарыг нэгэн адил доог тохуу хийх болно” гэж хариулав.
39. Мөн: “Тарчилгах зовлон (усан галав) хэнийг нэрвэхийг, тамын мөнхийн гэгсгээл хэний толгой дээр буухыг удахгүй мэдэх болно.” хэмээн сануулав.
40. Эцэст нь Бидний зарлиг бууж хөлөг онгоц усанд автан эхлэхүйд Нухт: “Амьтадын тус бүрээс нь нэг хосыг (эр, эм) авч, өөрийн гэр бүл болон Аллахын гэгсгээл хүртэгсэдээс бусад сүсэглэгсэдийг онгоцонд оруул!” хэмээн тушаав. Угаасаа түүнтэй хамт сүсэглэсэн хүн тун цөөхөн билээ.
41. Нух тэдэнд: “Та нар хөлөг онгоцонд суугтун. Түүний явах, зогсох нь Аллахын алдраар (зарлигаар) байх болно. Үнэндээ Эзэнтэн маань нэн ивээгч, машид нигүүлсэгч болой.” гэв.
42. Тэдний суусан хөлөг онгоц уул шиг давалгааг зүсэн урагшилж байлаа. Нух бусдаас зайдуу байсан хүүдээ: “Аяа, хүү минь! Бидэнтэй цуг, онгоцон дээр гар. Үл сүсэглэгсэдтэй хамт битгий үлд” гэж дуудав.
43. Гэтэл хүү (Канган) нь: “Би, уснаас намайг аврах нэгэн уулан дээр гарна” гэв. Аав Нух: “Өнөөдөр Аллах өөрөө өршөөл үзүүлснээс бусад хэн ч түүний гэгсгээлээс аврагдахгүй” хэмээн хариулах зуур тэр хоёрын дунд аврага их давалгаа орж ирээд, хүү нь усанд живлээ. Аллахын гэгсгээл үзэх учиргүй хүмүүс ч усанд живсэн юм.
44. Тэр мөчид: “Аяа, газар чи усаа залги! Аяа, тэнгэр чи ч усан бороогоо зогсоо” гэсэн Аллахын зарлиг бууж, ус татарч, зарлиг гүйцээгдэв. Хөлөг онгоц Жуди уулын орой дээр ирж тогтов. Ийнхүү “Зальхай түмэн сөнөтүгэй!” хэмээн тушаагдав.
45. Нух Эзэнтэндээ хандан: “Аяа, Эзэнтэн минь! Хүү маань халуун элгэн, миний гэр бүлийн нэгэн билээ. Чиний айлдвар чин үнэн, хамгийн шударга, хамгийн дээд шүүгч минь Чи билээ” хэмээн залбирлаа.
46. Аллах: “Аяа, Нух! Хүү чинь чиний гэр бүлээс биш ээ. Түүний хийсэн нь зохисгүй байсан юм. Мэдэхгүй юмныхаа тухай надаас бүү асуугтун. Үнэндээ, Би чамд харанхуй бүдүүлэгчүүдийн адил болохгүй байхыг зөвлөж баймуй” гэв!
47. Нух: “Аяа, Эзэнтэн минь! Мэдэхгүй юмныхаа талаар Чамаас асуухаас айж, Чамд хоргодмуй” хэмээн чамд залбирч байна. Чи л намайг өршөөн соёрхохгүй бол үнэндээ би хохирол амсагсадын нэг нь болмуй” хэмээн залбирав.
48. Аллах: “Аяа, Нух! Чи болон чамтай хамт байсан хэсэг хүмүүс ба амьтадад Бидний зүгээс хайрласан амар амгалан хийгээд өлзий буянаар

- (хөлөг онгоцноос) буугтун. Хожим Бид хэд хэдэн ард олонд энэхүү амьдралын сайн сайхныг түр зуур эдлүүлээд, дараа нь тэднийг зовлонт гэсгээлтэй учруулна” хэмээв.
49. (Аяа Мухаммед!) Энэ бол далдын өгүүлэл болой. Бид үүнийг чамд сургамж болгон илгээж байна. Өмнө нь үүнийг чи болон чиний ард олон ч эс мэддэг байсан. Тиймээс тэвчээртэй бай, эцсийн эцэст үнэн сүсэгтнүүд амжилтанд хүрмүй.
50. Бид Гадын ард олонд түүний садан төрөл болох Худ элчийг илгээсэн билээ. Худ тэдэнд: “Аяа, ард олон минь! Аллахад мөргөгтүн. Та нарын хувьд Түүнээс өөр бурхан үгүй. Та нар гагцхүү Түүнийг гүтгэсээр баймуй”
51. Аяа, ард зон минь! Гэгээн элчийн хувьд би та нараас ямар ч шан харамж хүсэхгүй. Миний шан харамж бол зөвхөн намайг бүтээгч Аллахад л хамааралтай. Үүнийг ухаарахгүй гэж үү?”
52. Аяа, ард олон минь! Эзэнтнээсээ өршөөл гуйгтун. Дараа нь Түүнд наминчлан залбирцаагтун. Тэр та нарын дээрээс буяны бороо оруулан, хүч чадал нэмнэ. Нүгэл үйлдэж (Аллахаас) нүүрээ бүү буруулагтун” хэмээн зөвлөв.
53. Тэд: “Аяа, Худ! Чи бидэнд тодорхой нотолгоо авч ирээгүй. Чиний хэлсэн үгээр залбирдаг бурхадаа орхихгүй, бас чамд итгэдэггүй”...
54. “Чамайг манай бурхадын аль нэг нь нэрвэсэн байна гэж хэлье” гэгцгээв. Худ хариу хэлэн: “Үнэндээ би Аллахыг гэрч болгоно. Та нар ч гэсэн гэрч бологтун, би та нарын Аллахтай адилтгасан хиймэл юмнаас ангид баймуй...”
55. Та нар бүгдээрээ хүссэн хорлолоо хийгээрэй. Бүр зай завсаргүй хийгтүн...
56. Та бидний Эзэнтэн болсон Аллахад итгэнэм. Тэр эрхшээлдээ оруулаагүй нэг ч амьтан үгүй. Миний Эзэнтэн зөв шулуун зам дээр байгаа нь эргэлзээгүй.
57. Хэрэв та нар нүүр буруулах аваас надад хохирох зүйл үгүй. Миний хувьд та нарт илгээгдсэн элчийнхээ үүргийг биелүүлсэн. Эзэнтэн та нарын оронд өөр нэгэн ардыг авч ирвэл та нар Түүнд ямар ч хор хөнөөл учруулж эс чадмуй. Яагаад гэвэл миний Эзэнтэн бүхнийг хянаж байдаг билээ” хэмээн Худ учирлав.
58. Бидний зарлиг буумагц, Худ болон түүнтэй хамт сүсэглэгсэдийг нигүүлсэлээрэ аварсан юм. Мөн хүнд гэсгээлээс ч аварсан.
59. Ийнхүү Гадын ард олон Эзэнтнийхээ айлдваруудыг үгүйсгэж, гэгээн элчүүдийг эсэргүүцэж, дарангуйлагч бүрийн зам мөрийг дагацгаасан юм.
60. Тэднийг амьд ахуй цагийн болоод хойд ертөнцийн хараал нэрвэнэ.



- Гадын ардууд Эзэнтнийг эсэргүүцсэнийг бүү мартаарай. Худын ард болох Гадууд Аллахын хайр энэрэлээс ангид хоцроно гэдгийг санагтун.
61. Бид Самудын ард олонд түүний садан төрөл Салихийг гэгээн элчээр илгээлээ. Салих тэдэнд: “Аяа, зон олон минь! Та нар Аллахад мөргөгтүн, Та нарт Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Тэр та нарыг шавраар бүтээсэн, газар дэлхий дээр амьдрал бэлэглэсэн билээ. Иймд Түүнээс өршөөл эрэгтүн. Түүнд залбирагтун. Эзэнтэн (өөрийн боолуудад) машинд ойрхон, залбирлыг нь хүлээн авагч бөлгөө” хэмээн хэллээ.
  62. Тэд: “Аяа, Салих! Чи өмнө нь бидний найдлага хүлээсэн нэгэн байсан билээ. Одоо биднийг өвөг дээдсийн минь шүтэж ирсэн юмнаас татгалзуулах болж байна уу? Үнэндээ бид чиний уриалж буй зүйлд эргэлзэж байна” гэв.
  63. Салих: “Аяа, ард түмэн минь! Би Эзэнтнээсээ ирсэн яруу тод нотолгоонд үндэслэгдэж, түүний хайр энэрэлд багтсан агал эсэргүүцэл үзүүлбэл, Түүний гэгсгээлээс хэн намайг аврах юм вэ? Та нар бол надад гай хөнөөл учруулахаас өөр юу ч хийж чадахгүй...”
  64. Аяа, ард түмэн минь! Аллагаас илгээсэн энэхүү ингэн тэмээ та нарт ер бусын гайхамшиг. Түүнийг зүгээр орхигтун, өөрийн дураар бэлчиг, алив хорыг бүү хүргэгтүн. Үгүй бол та нар ойрын хугацаанд гэгсгээлд нэрвэгдэнэ” хэмээн сануулав.
  65. Гэвч Самудынхан эх мал болох тэр ингэнийг алчихсан юм. Салих тэдэнд: “Та нар орон гэртээ гурав хоног жаргаж авцгаагтун. (дараа нь гэгсгээл нэрвэнэ) Энэ бол худал биш шүү” хэмээн сануулав.
  66. Бидний зарлиг (товлогдсон хугацаа нь) ирэхүйд, Салих хийгээд түүнтэй хамт сүсэглэгсдийг хайр энэрлээрээ тэр өдрийн гэгсгээлээс аврав. Эргэлзээгүй, Эзэнтэн чинь машинд хүчирхэг бөгөөд аугаа билээ.
  67. Зальхай этгээдүүдэд муу ёрын нэгэн дуу сонсогдож, тэд орон гэртээ өвдөг сөхөрсөн хэвээрээ хөшиж хөлдсөн билээ.
  68. Тэд эндээ хэзээ ч аж төрж байгаагүй мэт (орон байр нь хоосорч) үлдсэн юм. Самудынхан Эзэнтнийг эсэргүүцсэнийг та нар мэдэгтүн. Самудын ард түмэн (Аллахын хайр энэрэлээс) машинд алслагдан үгүй боллоо.
  69. Бидний элч мэлэк нар Ибрахимд баярт мэдээ авчран: “Таны амар амгаланг эрье” гэж мэндчилэв. Ибрахим ч хариу мэндэлсний дараа яаравчлан шарсан тугал авчруулав.
  70. Ибрахим тэднийг хоол руу гараа сунгахгүй байхыг хараад, тэднээс бишүүрхэн болгоомжлов. Тэд: “Битгий айгтун! Бид Лутын ардуудыг цээрлүүлэхээр ирцгээлээ” гэв.
  71. Зочидод үйлчилж байсан Ибрахимийн эхнэр (үүнийг сонсож гайхаж) инээд алдав. Бид түүнд (Ибрахимийн эхнэрт) Исхакийг, түүний араас Якубыг төрүүлэх тухай мэдээг дуулган баярлуулсан юм.

72. Ибрахимийн эхнэр: “Ээ хөөрхий! Миний бие хөгширсөн, өвгөн маань өндөр настай атал би хүүхэд төрүүлэх гэж үү? Энэ нь үнэхээр гайхал төрүүлмээр явдал юм” хэмээн гайхшрав.
73. Алладын элч мэлэк нар: “Алладын зарлигт гайхах гэж үү? Танайд Алладын хайр энэрэл, буян хишиг заяах нь ээ. Аллах үнэхээр магтан дээдлэхэд зохистой” хэмээн мэдэгдэв.
74. Ибрахимийн айдас түгшүүр арилж, баярт мэдээг сонссоны дараа Лутын ард түмний тухайд бидэнтэй мэтгэлцэв.
75. Ибрахим бол үнэхээр халамжтай, зөөлөн сэтгэлтэй Аллахад үнэнч нэгэн билээ.
76. Алладын элч мэлэк нар: “Аяа, Ибрахим! Маргалдахаа боль! Эзэнтний зарлиг нэгэнт ирчихлээ. Лутын ардыг эргэж буцаахын аргагүй, гэсгээл ирнэ” гэв.
77. Бидний элч мэлэк нар Лут дээр ирэхэд Лут ард олныхоо зүггүйгээс нэрэлхэн: “Өнөөдөр нэн харуусалт өдөр болох нь ээ” хэмээн харамсав.
78. Лутын ард яаран түүний дэргэд ирцгээлээ. Урьд өмнө ч тэд муу үйл үйлдэж явсан билээ. Лут тэдэнд: “Аяа, ард олон минь! Эд нар миний охидууд бөгөөд та нарын хувьд илүү ариун, зохистой. Аллагаас айгтун, намайг зочдын маань өмнө бүү шившиг болгогтун. Та нарын дунд ухаалаг нэгэн байхгүй гэж үү?” хэмээн асуув.
79. Элч нар: “Танай охидод бид хамаагүй болохыг мэдэх билээ. Үнэндээ бидний юу хүсч буйг чи сайн мэднэ шүү дээ” гэв.
80. Лут: “Ай даа, та нарыг эсэргүүцэх хүчтэйсэн болоосой. Эсвэл түшиж дэмжих хүчирхэг нэгэн тулгууртай ч байсан бол!” хэмээн халаглав.
81. Элч нар: “Аяа, Лут! Үнэндээ, бид Эзэнтний элч нар болой. Эднүүс чамд хэзээ ч халдаж эс чадмуй. Шөнийн цагаар гэр бүлтэйгээ хамт гараад яв. Эхнэрээс чинь өөр хэн ч ар луугаа бүү санаа зовог. Эхнэр чинь тэдэнтэй хамт гэсгээгдэнэ. Тэдэнд амлагдсан гэсгээлийн хугацаа нь өглөө тохиох болой. Өглөө тун ойртож байна бус уу?” гэж анхааруулав.
82. Зарлиг буусан цагт тэдний орон байрыг орвонгоор нь эргүүлж орхиод, тэдний дээрээс халаасан чулуун бороо оруулсан юм.
83. Тэр чулуунд Эзэнтний тамга залагдсан билээ. Ийм л гэсгээл нь зальхай этгээдэд ойрхон байх болно.
84. Бид Мадияны ардуудад тэдний садан төрөл Шугайб элчийг илгээсэн. Гэгээн элч Шугайб зон олондоо хандан: “Аяа, ард олон минь! Та нар зөвхөн Аллахад мөргөгтүн. Мөн та нарын хувьд Түүнээс өөр бурхан үгүй. Тэгээд жинлүүрийн хэмжээг бүү хасагтун. Үнэндээ би та нарыг чинээлэг хүмүүс гэж харж байна. Та нарыг хүлээж буй аугаа өдрийн гэсгээлээс айх юм даа” гэв.
85. Цаашлаад: “Аяа, ард олон минь! Та нар жинлүүр хэмжээний хувьд

- шударга байгтун. Хүмүүст эд зүйлсийг бүү дутуу өгөгтүн. Бас газар дэлхий дээр танхайрахгүй, хэмээс хэтрэхгүй амьдарцгаа!”.
86. “Хэрэв үнэн сүсэгтэн байвал Алладын (ариунаар нь) үлдээсэн буян хишиг та нарт өлзийтэй байх болно. Би та нарын хамгаалагч биш.” хэмээн ухуулав.
87. Тэд: “Аяа, Шугайб! Чиний шашны чинь мөргөл чинь бидний өвөг дээдсийн шүтэж буй бурхадыг орхихыг, эсвэл эд хөрөнгөө хүссэнээрээ зарцуулахаас тагталзахыг тушааж байгаа юм уу? Чи номхон дөлгөөн, ухаалаг нэгэн байсан шүү дээ” гэлцэв.
88. Шугайб тэдэнд: “Аяа, ард олон минь! Би Эзэнтнээсээ надад яруу тод нотолгоо (гэгээн элч байх), буян хишиг хайрлаж байхыг та нар харахгүй байна гэж үү? Алладын зарлигийг зөрчих гэж үү дээ?! Тиймээс, та нарт хориглосон юмсаа өөрөө хийж, та нарын эсрэг болохыг хүсэхгүй байна. Чадах ядахаараа та нарыг засч залруулахыг хүсэж байна. Миний амжилтанд хүрэх нь гагцхүү Аллахаас хамааралтай. Би зөвхөн Аллахад найдаж, Түүнд хандмуй”.
89. Аяа, ардууд минь! Намайг эсэргүүцсэнээр Нух, Худ, Салих нарын ард олонд тохиосон гэсгээл зовлон та нарт учрахгүй гэж үү? Бас Лутын ардууд ч та нараас холгүй байгаа шүү дээ!”
90. Эзэнтнээс уучлал эрэгтүн. Түүнд наминчлан залбирцаагтун. Эзэнтэн үнэхээр нигүүлсэгч, нэн их энэрэгч билээ” зэргээр сануулав.
91. Тэд: “Аяа, Шугайб! Бид чиний хэлсний ихэнхийг үл ойлгомуй. Мөн чамайг бидний дотор нэгэн сул дорой амьтан хэмээн үздэг. Ах, дүү нар чинь үгүйсэн бол чамайг чулуугаар нүдэж алах байсан. Чи бидний хувьд хүндэтгэлтэй хүн биш ээ!” хэмээн хариулцгаав.
92. Шугайб: “Аяа, ард олон минь! Миний ах дүү нар та нарт Аллахаас ч илүү хүндтэй гэж үү? Та нар Аллахыг мартацгаасан. Эзэнтэн минь та нарын ааш авирыг сайн мэднэ.
93. Аяа, ард олон минь! Та нар бололцооныхоо хэрээр хийгтүн. Би ч өөрийнхөөрөө ажиллая. Хэн гэсгээлт цээрлэлтэй учрахыг, мөн хэн худалч болохыг мөдхөн мэдэх болно. Эцсийг хүлээгтүн. Би ч та нартай хамт хүлээе” гэв.
94. Бидний зарлиг буумагц Шугайб болон түүнтэй хамт сүсэглэгсэдийг Бид хайр энэрэлээрээ аварсан юм. Харин зальхай амьтад муу ёрын орь дуу сонсогдож, газар дэлхий донслоход орон байранд өвдөг сөхрөн сэрийж хоцорлоо.
95. Тэнд хэн ч аж төрж байгаагүй мэт гэр орон нь эзгүйрэв. Самудын ардууд Алладын хайр энэрэлээс хагацсаны адил Мадияны ардууд ч гэсгээл үзэвэй.
96. 97. Үнэндээ Бид Мусаг Өөрсдийнхөө нотолгоо, ер бусын гайхамшигуудаар Фиргаун болон түүний эрхмүүдэд гэгээн элч болгон

- илгээсэн билээ. Гэвч тэд Фиргауны ятгалгаар түүнд захирагдав. Фиргауны зарлиг нь буруу ташаа байсан юм.
98. Фиргаун ертөнцийн төгсгөлийн өдөр ард олноо хөглөн тамын гал руу орно. Түүний очих газар нь юутай муухай гээч?!
99. Тэд энэ хорвоо хийгээд ертөнцийн төгсгөлийн өдөр ч хараагдаж, бузар муухай юмнаас үл сална. Энэ юутай хувь тавилан гээч?!
100. Аяа, Мухаммед! Энэ нь улс сүйрэн мөхсөн нутгийн тухай мэдээлэл болой. Бид үүнийг чамд зориуд тайлбарлаж байна. Тэдний заримаас нь ул мөр үлдсэн, зарим нь ор сураггүй болсон юм.
101. Бид тэдэнд шударга бусаар хандаагүй билээ. Гэвч, тэд өөрсдөө өөртөө гай тарьсан. Эзэнтний чинь зарлиг буусан цагт тэдний Аллахийг орхиж шүтсэн хиймэл бурхад нь өөрсдөд нь ямар ч тус дэм болсонгүй. Харин ч хор уршиг тарьсан.
102. Эзэнтэн чинь хот улсуудын зальхай ардыг хараандаа авахдаа ингэж сүйрүүлдэг. Алладын гэгсгээл үнэндээ уршигтай, маш хатуу.
103. Хойд ертөнцийн гэгсгээлээс айсан хүний хувьд энэхүү өгүүлэл сургамжтай. Ийнхүү тэр өдөр болох Ертөнцийн төгсгөлд бүх хүмүүс Алладын өмнө тайлан тавихын тулд нэг дор цугларах, бүгдээрээ бэлэн байх өдөр мөн.
104. Бид түүнийг (ертөнцийн төгсгөлийг) тодорхой хугацаагаар хойшлуулна.
105. Тэр өдөр ирэхүйд Алладын зөвшөөрөлгүйгээр хэн ч ярьж эс чадмуй. Тэдний зарим нь зовлонд унаж, нөгөө хэсэг нь аз жаргалд умбана.
106. Зовлонд унагсад нь тамд орж, орь дуу тавин орилж, тарчилна.
107. Тэнгэр, газрын зохицол хэр удаан үргэлжлэнэ, тэд ч тийм л хугацаагаар тэнд тарчилна. Харин Алладын таалал өөр шүү дээ. Эзэнтэн хүссэнээ зүй ёсоор нь бүрэн гүйцэтгэгч болой.
108. Аз жаргалд умбагсад диваажинд орцгооно. Тэнгэр, газрын зохицол хэр удаан үргэлжлэнэ, тэд ч тэнд удаан хугацаагаар оршино. Алладын таалал ийнхүү өөр юм даа. Энэ бол төгсгөлгүй хувь хишиг мөн.
109. Аяа, Мухаммед! чи тэдний зохиомол бурхан шүтсэнд эргэлзэх хэрэггүй. Тэд гагцхүү өөрсдийн өвөг дээдсийнхээ адил шүтнэ. Бид тэдэнд дахин шанг, гэгсгээлийг дутаалгүйгээр бүрэн хүртээх болно.
110. Бид Мусад ариун судрыг (Тауратыг) илгээсэн. Энэ тухайд урвалт бий боллоо. Түүний ардын дунд Тауратын талаар зөрчилдөөн үүсгэсэн юм. Хэрэв Эзэнтэн урьдчилан сануулж байгаагүй бол тэдний талаар одоо ч даруй шийдвэр гаргах байсан. Тэд үнэндээ түүнд эргэлзсэн юм.
111. Эзэнтэн чинь, хүн бүрийн үйл хэрэг бүтэх боломжийг олгодог. Эзэнтэн чинь, тэдний хийж буй үйлдэл бүрийг мэдэж байдаг.
112. Аяа, Мухаммед! Чи чин үнэн Эзэнтнийхээ тушаалын ёсоор шударга

- замыг сонго, чамтай хамт наминчлан сүсэглэгсэд ч тийм л байг. Хэмээс бүү хэтрэгтүн. Аллах та нарын үйлдэж буй бүхнийг харагч байдаг.
113. Зальхай этгээдүүдийг бүү дагагтун, эс тэгвэл тамын галд өртмүй. Та нарын хувьд Аллагаас өөр ивээгч анд үгүй. Өөр ямар ч ивээн туслагч үгүй.
114. Өдрийн хоёр зааг буюу үүр, үдшээр мөн шөнийн цагаар уншлага мөргөлөө үйлдэгтүн. Үнэндээ буянт сайн үйлс нь муу бүхнээс ангижруулмуй. Энэ нь ухаарах хүмүүст ухуулан таниулах сургамж болой.
115. Аяа, Мухаммед! Тэвчээртэй байгтун. Аллах буянт сайн үйл хийгсэдийн хувь хишгийг талаар орхихгүй.
116. Та нараас өмнөх эринд амьдарсан ухаантнууд дэлхий дээрх танхайрал, үймээн самууныг яагаад таслан зогсоогоогүй юм вэ? Тэднээс Бид цөөнхийг нь танхайрлын эсрэг байсны төлөө аварлаа. Харин зальхай этгээдүүд нь эд хөрөнгөндөө бардамнан мансуурч, нүгэлтэн байх болно.
117. Ард түмэн нь үнэн шударга байсан хот суурингуудыг Эзэнтэн маань үндэслэлгүйгээр үл түйвээнэ.
118. Эзэнтэн чинь хүсвэл бүх хүмүүсийг цор ганц үндэстэн (нэг шашинт) болгох байсан билээ. Гэвч тэд зөрөлдөхөө эс зогсоох ажгуу.
119. Гагцхүү Эзэнтний чинь хайр энэрэлд багтсан хэн нэгэн өөр шүү дээ. Угаасаа Эзэнтэн чинь тэднийг үүний төлөө бүтээсэн юм. Эзэнтний : “Би тамыг буг чөтгөр болон хүмүүсээр дүүргэнэ” хэмээсэн ёсоор болсон билээ.
120. Гэгээн элчүүдийн тухай мэдээллүүдийг чиний сэтгэлийг тайвшруулахын тулд тайлбарлана. Түүний дотор чамд чин үнэн сүсэглэгсэд хандсан ухуулан таниулах сургамж илгээгдэх болно.
121. Аяа, Мухаммед! Үл сүсэглэгсэд: “Та нар өөрийн сансанаараа хийгтүн. Бид ч өөрийнхөөрөө хийх болно” гээ!
122. Мөн: “Та нар үйлдсэнийхээ үр дүнг хүлээцгээ. Бид ч хүлээх болно” хэмээн хэл!
123. Тэнгэр, газрын далдын нууц зөвхөн Аллахад хамаармуй. Алив үйл хэрэг Аллахын өмнө буцаж очно. Тиймээс, Аллахт залбир, түүнийг түшиглэн найдагтун. Эзэнтэн та нарын хийж буй үйл бүхнийг зүй ёсоор нь мэдэгч бөлгөө.

## 12. СУРЕ ЮСУФ

Мекке-д илгээгдсэн. 111 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Алиф, Лам, Ра. Энэ бол ил тод судрын (Кураны) айлдварууд мөн.
2. Бид, Кураныг та нар ойлгог хэмээн Араб хэл дээр буулгасан болой.
3. Аяа, Мухаммед Бид Кураныг чамд илгээснээр өөрт чинь өгүүлэмжүүдийн хамгийн сайныг тайлбарлаж өгнө. Үүнээс өмнө чи үнэндээ энэхүү айлдваруудын тухай мэдээлэлгүй байсан.
4. Нэгэнтээ Юсуф аавдаа хандан: “Аав аа, Би зүүдэндээ арван нэгэн од болон нар, сарыг надад мэхийн ёсолж буйг харлаа” гэв.
5. Аав Якуб нь: “Хүү минь, зүүдээ ах наргаа бүү хэлээрэй. Тэд атаархан өрсөлдөж чамд муу санах вий. Чөтгөр шулам үнэндээ хүмүүний илт дайсан шүү” хэмээн сануулав.
6. Мөн: “Зүүдэнд үзсэний адил Эзэнтэн чамайг гэгээн элчээр сонгомуй, бас зүүдний тайлалыг зааж сургамуй. Өвөг дээдэс Ибрахим, Исхак нарт хувь хишгээ төгс хайрласан шиг чамд болоод Якуб миний үр удамд хувь хишгээ төгс хүртээх юм байна. Эзэнтэн бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн билээ” хэмээн хариулав.
7. Үнэндээ Юсуф болон түүний ах нарын тухай өгүүлэмж сонирхсон хүмүүст нэн сургамжтай билээ.
8. Нэгэнтээ Юсуфын ах нар: “Юсуф болон түүний дүү (Бунямин) аавд биднээс илүү хайрлагддаг. Харин бид илүү чадвартай шүү дээ. Аав маань илт зөнөглөж, төөрч байна” гэлцэв.
9. Тэдний дотроос нэг нь: “Юсуфыг алагтун эсвэл алс хол цөллөгтүн. Ингэвэл аавийн халамж та нарт хандах болно. Үүний дараа та нар (нүгэлээ наминчилж) дахин буян хишигтэй хүмүүс болмуй” гэв.
10. Бас өөр нэг нь (Яхуза): “Юсуфыг алах хэрэггүй, харин нэгэн худгийн ёроолд хаягтун. Дараа нь түүнийг жинчдийн нэг нь олж аваг” гэв.
11. Тэд энэхүү саналыг зөвшөөрөн аавдаа ирсний дараа: “Аав аа, та Юсуфын тухайд бидэнд яагаад итгэдэггүй юм вэ? Үнэндээ бид түүнд сайн сайхныг л хүсдэг ээ”...
12. “Маргааш түүнийг бидэнтэй цуг явуул, элбэг дэлбэг идэж уугаад, тоглог. Үнэхээр бид түүнийг хамгаалах болно” гэлцэв.
13. Эцэг Якуб: “Та нар түүнийг дагуулаад явбал би санаа зовох байх. Та нар хайнга хандаж, хараа салгахын цагт түүнийг чоно идчихнэ хэмээн би айж байна” хэмээн хариулав.

14. Тэд: “Бид ийм олуулаа байж түүнийг чононд идүүлбэл үнэхээр хараал идэг” гэлцэн шуугилдав.
15. Эцэст нь аав нь Юсуфыг дагуулаад явууллаа. Тэд Юсуфыг дагуулж яваад нэгэн дуугаар санаа нийлэн түүнийг худагт хаяхаар тохирцгоов. Аллах Юсуфт ийн айлдсан билээ: “Хожим энэ үйлийн тухай ярьж өгөх болно. Тэр үед тэд чамайг Юсуф хэмээн танихгүй” гэж айлдав.
16. Тэд орой аавдаа уйлаан майлаан болцгоож ирлээ.
17. Тэд: “Аяа, аав минь! бид уралдан тоглоод явахдаа Юсуфыг эд юмныхаа дэргэд үлдээцгээсэн билээ. Тэгтэл түүнийг чоно идчихжээ. Үнэнийг өчсөн ч чи бидэнд үл итгэх биз” хэмээн худал уйлалдав.
18. Тэд Юсуфын цамцанд хуурамчаар цус түрхэж ирцгээсэн ажгуу. Аав нь: “Үгүй ээ, та нарын хүсэл тачаал чинь энэ үйл хэргийг гоё сайхнаар харуулсан байна. Одоо надад тэвчих л үлдлээ. Та нарын худлаа хэлснийг илчлэх талаар гагцхүү Аллагаас тусламж эрэх минь!” гэв.
19. Нэгэн жингийн цуваа нөгөө худагт ирмэгц ус авхуулахаар ховоо барьсан хүнээ худаг руу явуулав. Очоод ховоогоо худаг руу шидэнгүүт: “Баярт мэдээ дуулгая аа! Энд нэгэн хөвгүүн байнам” хэмээн хашгирав. Тэд түүнийг эд барааны адил наймаалахын тулд нууцлав. Харин Аллах тэдний юу хийх гэж буйг мэдэж байв.
20. Тэгээд тэд түүнийг өчүүхэн үнээр буюу хэдхэн зоосоор арилжиж орхив. Угаасаа тэд түүнийг чухалчилж үзээгүй юм.
21. Түүнийг худалдаж авсан Мисирийн нэгэн иргэн өөрийн эхнэртээ хандан: “Түүнийг сайн асар, бидэнд хэзээ нэгэн цагт ашиг өгч магад, эсвэл хүүгээ болгоцгооё” гэв. Ийнхүү Бид Юсуфыг тэр газарт (Мисирт) байрлуулсан. Мөн түүнд зүүдний тайлалыг зааж сургалаа. Аллах өөрийнхөө зорьсон үйл хэрэгт үнэнхүү хүчирхэг. Гэвч ихэнх хүмүүс үүнийг ойлгодоггүй юм.
22. Юсуф Идэр залуу насанд хүрэхэд Бид түүнд мэргэн ухаан, эрдэм мэдлэг хайрласан. Буянт үйл үйлдэгсэдэд Бид ийнхүү шан харамжаа барьдаг.
23. Юсуфын амьдардаг айлын эзэгтэй (Зулиха) түүнд таатай хандаж, өөртөө ойртуулахын тулд үүдээ түгжин: “Алив нааш ир” хэмээн урив. Юсуф түүнд: “Аллах өршөөтүгэй. Чиний нөхөр бол миний эзэн, тэр надад сайн хандсан, би түүнд муу юм хийвэл урвасан хэрэг болох билээ. Урван тэрслэгчдийг Аллах өршөөхгүй” хэмээв.
24. Тэр эмэгтэй Юсуфт үнэхээр сэтгэлтэй болсон билээ. Хэрэв Эзэнтний айлдварыг хараагүйсэн бол Юсуф ч сэтгэл алдарч мэдэх байсан биз. Ийнхүү Бид түүнийг бузар булай, ичгүүр сонжуургүй явдлаас аварлаа. Учир нь тэр үнэхээр биширч сүсэглэсэн Бидний үнэнч боолуудын нэг нь билээ.
25. Тэгээд тэр хоёр үүд рүү уралдан ухасхийхэд гэрийн эзэгтэй түүний

- цамцны хойд хормойг тастан авч үлдэв. Тэд хоёулаа гэрийн эзэнтэй үүдэнд мөргөлдөхөд эхнэр нь нөхөртөө хандан: “Эхнэрийг чинь доромжлохыг санаархсан этгээдийг шоронд хийх, эсвэл зовлонт гэсгээл үзүүлэх ёстой” гэж мэлзэв.
26. Юсуф: “Үнэндээ, тэр өөрөө намайг оролдсон” хэмээн учирлав. Гэтэл эмэгтэйн садан талаас нэгэн гэрч гарч ирээд: “Хэрэв залуугийн цамц нь урдаасаа урагдсан бол эмэгтэйн хэлсэн нь зөв, Юсуфын худал байх болно.”
  27. “Хэрэв түүний цамц нь ар хормой талаас урагдсан бол эмэгтэй худал хэлсэн болж, тэр залуу үнэн хэлэгсэдийн нэг нь болно” гэв.
  28. Нөхөр нь Юсуфын цамцыг араасаа урагдсаныг хараад: “Эргэлзээгүй, энэ бол эмэгтэйчүүд та нарын заль мэх байх нь ээ. Та нарын завхайрал хэрээс хэтэрсэн!”
  29. “Юсуф чи энэ тухай элдэв яриа бүү дэлгэ. Харин эхнэр чи нүглийнхээ төлөө өршөөл гуй. Чи үнэхээр алдсан” хэмээн зэмлэв.
  30. Эцэст энэ явдал олны сонорт хүрэв. Хотын зарим эмэгтэйчүүд: “Манай эрхэмийн эхнэр нь өөрийнхөө боолдоо сэтгэл алдран, түүнийг оролдсон байна. Энэ бол илэрхий эвдэрсэн бузар явдал” гэлцэв.
  31. Ийнхүү зальхай бүсгүй эмэгтэйчүүдийн хов живийг сонсоод, тэднийг гэртээ урилаа. Тэдэнд элбэг дэлбэг зоогийн ширээ засч, түшиж тухлах дэр өгч, тус бүрийн гарт нь жимс цэвэрлэж идэх хутга бариулаад Юсуфт хандан: “Алив тэдний өмнө өөрийгөө харуулаад аль?!” гэв. Эмэгтэйчүүд Юсуфыг харангуут нүд нь орой дээр гарч гайхшран, сэтгэл алдарснаас хутгаар хуруугаа эсгэцгээв. Тэд алмайран, ам амандаа шуугин: “Аяа, Аллах минь, Энэ бол хүн биш эрхэмсэг нэгэн мэлэк юм байна” гэлцэв.
  32. (Зүлиха) бүсгүй тэдэнд: “Тийм ээ, үүний төлөө би та нарт чичлүүлсэн шүү дээ. Би түүнийг уруу татах гэж оролдсон нь үнэн боловч тэр ариун ёс суртахуунтай нэгэн байсан. Гэхдээ, энэ цаашид ч миний тушаалыг эс зөвшөөрвөл шоронд орж зовлонгоо эдлэх болно” гэв.
  33. Юсуф: “Аяа, Эзэнтэн минь. Эд нарын шахалтанд орсноос шоронд орсон минь илүү дээр. Хэрэв намайг энэ эмэгтэйчүүдийн бузар булай үйлдлээс аврахгүй юм бол би тэдэнд уруу татагдаж, мунхаг тэнэгүүдийн нэг нь болмуй” хэмээн залбирав.
  34. Эзэнтэн түүний залбирлыг ёсоор болгоож, эмэгтэйчүүдийн ов мэхээс аврав. Аллах чин үнэндээ хүссэнийг ёсоор болгож, бүхнийг сонсож, мэдэж байдаг билээ.
  35. Тэд Юсуфын нотолгоонуудыг сонссон боловч түүнийг хэсэг зуур заавал шоронд хорих нь зүйтэй гэж үзэв.
  36. Түүнтэй хамт шоронд хоёр залуу цуг орлоо. Тэдний нэг нь: “Би зүүдэндээ усан үзэм шүүслэж, дарс хийж байна гэж зүүдлэв” гэлээ.



- Нөгөөх нь: “Би толгой дээрээ талх тавчихсан түүнийг нь шувууд тоншиж байна гэж зүүдэндээ харсан. Бидний зүүдний тайлалыг хэлж өгөөч. Бид чамайг сайхан сэтгэлтэй хүн хэмээн бодож байна” гэв.
37. Юсуф ийн өгүүллрүүн: “Гаднаас хоол ирэхээс өмнө зүүдний чинь тайлалыг хэлж өгмүй. Энэ бол Эзэнтний надад зааж сургасан эрдэм болой. Үнэндээ би Аллахад үл сүсэглэгч, хойд ертөнцийг үгүйсгэгч нэгэн ард түмний шашиныг орхисон болой.”
  38. “Өөрийнхөө өвөг дээдэс Ибрахим, Исхак болон Якубын шашиныг дагасан. Бид Аллахад аливааг эн зэрэгцүүлэх ёсгүй. Энэ бол Аллахын бидэнд болоод хүмүүст хайрласан хишиг, гэвч хүмүүсийн олонхи нь үл талархдаг.”
  39. “Аяа, шоронгийн анд нөхөд минь! Та нарт салангид олон янзын бурхад илүү юу, цорын ганц дийлдэшгүй Аллах илүү юу?”
  40. “Та нарын Аллахыг умартаж тэр тахин шүтэж буй чинь, та нар болоод өвөг дээдсийн чинь зохиосон нэрээс өөр юу ч биш ээ. Аллах тэдний тухайд зохиомол бурханыг шүт хэмээн ямар нэгэн айлдвар, нотолгоо илгээгээгүй юм. Эрх мэдэл зөвхөн Аллахад хамаарагдмуй. Тэр та нарт өөрөөсөө бусдыг шүтэхгүй байхыг зарлигдсан билээ. Ийнхүү чин шударга шашин бол энэ болой. Гэвч хүмүүсийн олонхи нь түүнийг мэддэггүй.
  41. Аяа, шоронгийн анд нөхөд минь! Та хоёрын нэг нь өөрийн эзэндээ дарс хундаглаж очих болно. (Өөрөөр хэлбэл, шоронгоос гарч хан эзэндээ дарс хундаглагч байх нь) Харин нөгөөх чинь дүүжлэгдэн, шувууд толгойг нь тонших ажгуу. Та нарын асууж буй зүйлийн тайлал ийнхүү байх болно” хэмээн хариулав.
  42. Юсуф, аврагдахаа мэдсэн нэгэнд нь хандан: “Намайг эзэнтнийнхээ дэргэд дурс” гэв. Гэвч чөтгөр шулам түүнд эзэнтнийхээ дэргэд дурсахыг нь мартуулав. Үүнээс болж Юсуф шоронд нэлээд хэдэн жилийг өнгөрүүлэв.
  43. Нэг өдөр эзэн Хаан нь: “Би зүүдэндээ долоон туранхай үнээ нь долоон тарган үнээг идэж буйг, бас долоон ногоон түрүү, долоон хатсан түрүү үзлээ. Аяа, мэргэдүүд минь, зүүд тайлдаг аваас миний зүүдийг тайлж өгөгтүн?!” гэв.
  44. Тэд: “Энэ бол их л бүрхэг зүүд юм. Тиймээс, бид ийм зүүдийг тайлаж чадахгүй нь ээ” гэв.
  45. Шоронгоос гарсан нөгөө хоёрын нэг нь хэсэг хугацааны дараа Юсуфыг санаж: “Энэхүү зүүдний тайлалыг удахгүй мэдүүлнэ, намайг дариухан шорон руу явуулагтун” гэв.
  46. Түүнийг шоронд явууллаа. Тэр Юсуф дээр очоод: “Аяа, үнэн үгтэй Юсуф минь! Чи надад энэхүү зүүдний тайлалыг хэлж өг. Долоон туранхай үнээ долоон тарган үнээг идсэн ажгуу. Бас долоон ногоон

- түрүү, долоон хатсан түрүү байжихуй. Тэгээд, би хүмүүст чиний хариуг хэлж очно. Тэд чиний үнэ цэнийг мэдмүй” гэв.
47. Юсуф: “Та нар долоон жилийн турш тариа тарина. Тэгээд хураасан ургацнаас хүнсэнд хэрэглэх бага зэргийг дарж аваад үлдсэнийг муудуулахгүйн тулд түрүү чигээр нь хадгалах болно.”
  48. “Дараа нь долоон жил хуурайшин ургац алдана. Тэр үед бага зэргийг үрэнд зориулан үлдээж, нөөцлөснөөсөө бусдыг нь иднэ.”
  49. “Үүний дараа их хуртай жилүүд тохиож, хүмүүс жимс шахаж шүүслэмүй” хэмээн хариулав.
  50. (Үүнийг сонссон) Эзэн Хаан: “Түүнийг над руу авчрагтун” хэмээн тушаав. Хааны элч Юсуф дээр ирэхүйд Юсуф түүнд: “Эзэн хаан руугаа буцаж очоод, нөгөө хуруугаа эсгэсэн эмэгтэйчүүдийн тухай асуугтун. Тэр тухай мэддэг байна уу? Харин Эзэнтэн минь тэдний бузар явдлыг тодорхой мэддэг” гэв.
  51. Хаан өөрийн эхнэр болон нөгөө эмэгтэйчүүдийг цуглуулж аваад: “Та нар Юсуфыг уруу татаж санаархасны зорилго юу байсан вэ?” гэж асуув. Эмэгтэйчүүд: “Аллах өршөөх болтугай, Бид түүнээс ямар ч муу зүйл олж хараагүй” гэлцэв. Эрхэм дээдсийн эхнэр ч гэсэн: “Одоо чин үнэн тодорхой боллоо. Үнэндээ, би түүний бие сэтгэлийг эзэмдэхийг санаархсан билээ. Тэр жинхэнэ үнэнч хүн билээ” хэмээн хэлэв.
  52. Юсуф: “Зарлигийг буцаасан шалтгаан нь түүний эзгүйд түүнд муу юм санаагүйнх бөгөөд Аллах урвагч муу санаатныг өршөөдөггүйг мэдүүлэхийн төлөө билээ” гэв.
  53. “Гэхдээ би өөрийгөө үл зөвтгөмүй. Учир нь Аллахын ивээл, энэрэл илгээгдсэнээс бусдыг хувийн тачаал нь муухай юм руу хөтлөнө. Эзэнтэн машид өршөөгч бас машид нигүүлсэгч билээ” гэв.
  54. Тэгээд хаан: “Түүнийг над руу авчрагтун. Би түүнийг өөртөө хувийн зөвлөгч болгоно” гэв. Юсуф ирж Хаан түүнтэй ярилцаж: “Өнөөдөр чи бидний дэргэд яруу алдарын эзэн хийгээд итгэл найдвартай нэгэн болмуй” гэв.
  55. Юсуф: “Намайг улс гүрнийхээ өв сангийн захирагчаар томилогтун. Яагаад гэвэл би маш сайн хамгаална, маш сайн мэднэ” гэж гуйв.
  56. Ийнхүү Бид Юсуфыг тэр газарт хүссэн байр сууриа эзлэг гээд эрх мэдэлтэй болгосон. Бид өөрсдийн хүссэн хэн нэгэндээ хайр энэрэлээ хүртээмүй. Мөн сайн үйл үйлдэгсэдийн буян заяаг талаар болгохгүй.
  57. Бишрэн сүсэглэгчдэд амьд ахуйн эд хөрөнгөөс хойд насны буян заяа хавьгүй илүү байх болно.
  58. (Өлсгөлөнд нэрвэгдсэн нэгэн жил) Юсуфын ах нар (тариа будаа эрж Мисирт) ирлээ. Юсуф тэднийг хүлээн авч, шууд таньсан ч тэд дүүгээ таньсангүй.

59. Юсуф тэдэнд (гурил, будаа өгч) ачаа барааг бэлтгүүлж: “Та нар дараа эцэг нэгтэй дүү Буныминыг над дээр дагуулж ирээрэй. Би та нарт (гурил будаа) бүрэн хэмжээгээр өгч буйг, мөн зочломтгой хандсаныг минь та нар харэхгүй байна гэж үү?”
60. “Хэрэв түүнийг дагуулж ирэхгүй юм бол үүнээс хойш би ч та нарт (гурил будаа) өгөхгүй. Над руу хандсаны ч хэрэггүй” гэв.
61. Тэд: “Бид түүнийг эцгээс зөвшөөрөл авч дагуулж ирэхийг хичээх болно. Хэлснийг чинь биелүүлнэ” хэмээн амлав.
62. Юсуф өөрийн туслагчиддаа хандан: “Тэдний (гурил будаатай) арилжсан зүйлийг ачаа дотор нь хийчихээрэй. Гэртээ харьсан хойно түүнийгээ хараад бидэнд буцааж өгөхийн тулд ирж мэдэх юм” гэлээ.
63. Тэд аав дээрээ эргэж ирээд: “Аяа, аав аа! Мисирийн эзэн бидэнд дахиад гурил будаа өгөхөөс татгалзсан. Харин дүү Буныминыг цуг явуулбал будаа авч болох байх. Бид түүнийг эргэлзээгүй хамгаалах болно” гэлцгээв.
64. Якуб аав нь тэдэнд: “Үүнийг өмнө түүний ах Юсуфыг та нартай дагуулж явуулсны адил итгэх гэж үү? Хамгийн сайн хамаалагч, нигүүлсэнгүй нь Аллах болой” хэмээн хариулав.
65. Дараа нь тэд ачаа бараагаа задалтал өөрсдийнх нь төлбөрт өгсөн зүйлсийг буцаан өгснийг хараад: “Аяа, эцэг минь ээ! Бид үүнээс илүү юу хүсэх вэ? Бидний үнэт зүйлс буцаагдсан байна. Дүүгээ дагуулж очвол үүгээр дахин хүнс авч ирмүй. Мөн дүүгээ ч хамгаална, бас нэг тэмээ ачаа илүү авч ирнэ. Энэ нь (эзэн Хааны хувьд) өчүүхэн зүйл шүү дээ!” гэлцэв.
66. Эцэг Якуб цааш нь: “Хэрэв, та нар бүгдээрээ баригдчихвал яая гэх вэ? Ямар ч байсан дүүгээ эсэн мэнд авчирахаа Аллахын нэр барьж андгайлахаас нааш түүнийг та нартай хамт явуулахгүй гэхэд хүүхдүүд нь: “Бидний энд ярьсан бүхэнд Аллах гэрч болог” хэмээн андгайлав.
67. Эцэг нь: “Аяа, хөвгүүд минь ээ! Хот руу бүгдээрээ нэг хаалгаар бус өөр өөр хаалгаар орогтун. Гэхдээ, Аллагаас ирэх алив зүйлээс та нарыг хамгаалж эс чадмуй. Алив эрх мэдлийг гагцхүү Аллах эрхшээх бөлгөө. Би зөвхөн Аллахад найднам, түүнд итгэгсэд Аллахад найдлага тавих болтугай!” хэмээн залбирав.
68. Тэд хотод ирээд эцгийн заасан ёсоор орсон боловч Аллагаас ирэх хувь заяанаас ангижирж чадсангүй. Гагцхүү Якубын хэлсэн хүслийг л биелүүлсэн төдий байлаа. Якуб бол бидний заасан эрдэм ухааныг эзэмшсэн нэгэн бөлгөө. Гэвч хүмүүсийн олонхи нь үүнийг эс мэдэцгээдэг.
69. Якубын хөвгүүд Юсуфтай уулзахад тэр Бунымин дүүгээ тэврэн хажуудаа авч: “Би бол чиний ах шүү дээ, тэдний хийсэн хэрэгт бүү гомд” гэв.

70. Юсуф Тэдний ачаа барааг базаасны дараа ус уух аягаа дүүгийнхээ ачааны завсар нуулгав. Дараа нь хэн нэгэн хүн: “Хүүе, энэ жингийнхэн жинхэнэ хулгайчид байна!” хэмээн хашгирлаа.
71. (Якубын)Хөвгүүд тэдэн рүү эргэж хараад: “Юу чинь алга болсон юм бэ?” гэж асуув.
72. Нөгөө хүн: “Эзэн хааны ус уудаг аягыг алдчихлаа. Олж өгсөн хүнийг нэг тэмээ ачаагаар шагнана. Би үүнийг биечлэн батлаж баймуй” гэв.
73. Хөвгүүд: “Аллахын нэрээр андгайлая. Бид энд үймээн самуун гаргахын төлөө ирээгүй, хулгайч ч биш ээ” гэв.
74. Юсуфын ажилчид: “Та нар худалч болж таарвал ямар шийтгэл хүлээх вэ?” гэв.
75. Хөвгүүд: “Аяга хэний ачаанаас гарна, тэр боол болог. Түүнийг аваад үлдэцгээгтүн. Зальхай этгээдүүдийг ингэж шийтгэдэг юм.” гэв.
76. Ажилчид урьдаар Юсуфын ах нарын ачаа барааг онгичиж, эцэст аягаа Юсуфын дүүгийн ачаанаас гаргаж ирэв. Бид Юсуфт ийм аргыг заасан билээ. Үгүй бол, хааны хууль дүрмээр дүүгээ өөртөө авч үлдэж чадахгүй. Харин, Аллах ийм л байхыг хүссэн юм. Бид хүссэн хэн нэгнийхээ нэр төрийг ийнхүү өргөмжилдөг. Эрдэм мэдлэгтэй алив бүхний дээр илүү сайн мэдэгч нэгэн буй.
77. Ажилчид: “Хэрэв тэр хулгай хийсэн бол түүний ах нар ч урьд өмнө ч хулгай хийсэн байж таарна” гэлцэв. Юсуф тэдний гүтгэлгийг мэдэж байсан ч дотроо нууж, тэдэнд юу ч хэлсэнгүй. “Та нар маш хүнд байдалд баймуй. Аллах та нарын юу ярьж буйг маш сайн мэдмүй” хэмээн бодов.
78. Хөвгүүд : “Аяа, дээдэс минь! Түүний өтөл настай аав нь бий юм сан. Түүний оронд бидний аль нэгийг аваад үлдэнэ үү. Үнэндээ бид таныг эрхэмсэг сайн үйлстэн хэмээн харж баймуй” гэж гуйв.
79. Юсуф: “Аллах ивээгтүн! Бидний юм хэний ачаанаас гарна, түүнийг авч үлдэнэ. Эс тэгвэл бид нүгэлтэн болмуй” гэв.
80. Тэд цөхрөнгөө барж, горьдлого тасарсан хойно буцан очиж нууцаар зөвлөлдөв. Тэдний дотор хамгийн ахмад нь болох Якуза: “Эцэг маань та нараас Аллахын нэр барьж амлалт авсныг, мөн урьд нь Юсуфын хувьд гэмтэй байснаа мэдэхгүй байна уу? Аавын зөвшөөрөлгүйгээр Аллахын зарлиг надад ирэхээс нааш би эндээс хөдлөхгүй. Аллах хамгийн шударга шүүгч мөн.
81. Та нар аав руугаа эргэж очоод: “Аяа, аав минь! Хүү чинь үнэхээр хулгай хийсэн, Бид зөвхөн харсан юмаа гэрчилнэ. Далдыг харж чадахгүй.
82. Итгэхгүй бол Бидний байсан хотынхноос цуг явсан жинчидээс асуу. Бид үнэнийг өчиж баймуй” хэмээн аавд хэлэгтүн гэв.
83. Залуус аавдаа очиж болсон явдлыг өчихөд эцэг Якуб: “Үгүй ээ, Та нарын хүсэл тачаал энэ зүйл рүү хөтөлжээ. Надад гагцхүү тэвчих л

- үлдлээ. Аллах тэдний бүгдийг нь надад буцаан өгөх болтугай. Аллах бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн билээ” хэмээн залбирав.
84. Якуб тэднээс нүүр буруулан: “Хайран Юсуф минь дээ!” гэж гуниглан, удаан гашуудан уйлснаас хоёр нүд нь цэхийн цайж, уй гашуугаа дотроо хадгалсаар л байв.
  85. Ажилч хөвгүүд нь: “ Аллахын алдраар андгайлмуй. Та Юсуфыг дурссаар байж эцэст нь өвчлөн, уй гашуугаас болж амиа алдаж мэднэ шүү” хэмээцгээв.
  86. Якуб: “Би уй гашуу, уйтгар гунигаа зөвхөн Аллахтай хуваалцана. Та нарын эс мэдэх зүйлсийг Аллахын ивээлээр мэдэх болно.
  87. Аяа, хөвгүүд минь ээ! Та нар явж Юсуф болон дүүгээ эрэгтүн. Аллахын ивээл, энэрэлээс хэзээ ч горьдлогоо бүү таслагтун. Зөвхөн үл сүсэглэгч, буруу номтнууд л Аллахын ивээл, энэрэлийг хүсдэггүй юм” гэв.
  88. Улмаар хөвгүүд нь Мисирт эргэн очиж Юсуфтай уулзан: “Аяа, эрхэм дээдэс минь! Бид болоод бидний гэр бүл өлсгөлөнд нэрвэгдлээ. Бидний бэл бэнчин ч өчүүхэн байна. Тиймээс, бидэнд хүрэлцээтэй хүнс өгөгтүн. Мөн өглөг буян хайрлагтун. Аллах үнэндээ өглөг өгөгсөдийг шагнаж урамшуулмуй” хэмээн гуйв.
  89. Юсуф: “Та нар, харанхуй бүдүүлэг авирлаж надад болон дүүдээ юу хийснээ мэдэж байна уу?” хэмээн байцаав.
  90. Тэд: “Чи үнэхээр Юсуф мөн гэж үү?” хэмээн гайхшрав. Юсуф: “Би бол Юсуф мөн! Энэ бол миний дүү. Аллах бидэнд хайр энэрлээ үзүүлсэн. Хэн Аллагаас айж, тэвчээртэй байх аваас Аллах эргэлзээгүй ивээнэ. Аллах буянтай үйл хийгсэдийн хөдөлмөрийг талаар болгохгүй” гэв.
  91. Тэд: “Бид Аллахын нэрийг барьж тангараглая. Аллах чамайг үнэхээр биднээс дээгүүр өргөмжилсөн юм. Бид үнэндээ нүгэлтэнгүүд боллоо” гэлцэв.
  92. Юсуф: “Өнөөдөр та нарыг зэмлэхгүй. Аллах та нарыг өршөөх болтугай. Аллах хамгийн нигүүлэгч болой.”
  93. “Та нар миний энэ цамцыг авч яваад, эцгийн маань нүүрэн дээр баригтун. Тэгвээс түүнд хараа ормуй. Дараа нь гэр бүлээрээ бүгдээрээ над руу ирцгээгтүн” гэв.
  94. Ийхүү жингийн цуваа (Мисирээс Шам руу) хөдөлмөгц тэдний эцэг Якуб гэгээн элч: “Хэрэв та нар намайг зөнөсөн гэж үзэхгүй бол би Юсуфын үнэрийг мэдэрч байна” гэв.
  95. Түүний бусад хүүхдүүд нь: “Аллахын нэрээр андгайлая. Чи урьдын хэвээр зөнөглөж байна” гэлцэв.
  96. Баярт мэдээ дуулгагч ирээд Юсуфын цамцыг түүний нүүрэн дээр барихад дариухан хараа нь орлоо. Якуб: “Би та нарын эс мэдэх зүйлсийг Аллахын ивээлээр мэднэ гэж хэлж байгаагүйсэн билээ үү?” гэв.

97. Хөвгүүд нь: “Аяа, аав минь ээ! Бид үнэхээр төөрөлдөж алдсан. Бидний нүгэлийн төлөө Аллахаас өршөөл гуйгтун” хэмээн хүслээ.
98. Якуб: “ Та нарын төлөө Эзэнтнээсээ өршөөл гуйх болно. Тэр эргэлзээгүй аугаа өршөөгч хийгээд машинд нигүүлсэгч билээ” гэлээ.
99. Якуб гэгээн элч болон тэдний гэр бүлийнхэн бүгдээрээ хамтдаа Юсуф дээр ирэхэд, Юсуф эцэг эхээ тэврэн хүлээн авч: “Аллахын тааллаар Мисирт амар жимир орцгоогтун” хэмээн хэлэв.
100. Юсуф эцэг эхийгээ хүндтэй сэнтийд залав. Тэд бүгдээрээ Юсуфын өмнө мэхийн ёсолж, сөгдөн мөргөлөө. Тэгээд Юсуф: “Аяа, эцэг минь! Энэ бол миний урьд өмнө зүүдэлсэн зүүдний тайлал болой. Эзэнтэн маань миний зүүдийг чин үнэн болголоо. Эзэнтэн минь надад хайр энэрлээ үзүүллээ.Намайг болоод ахан дүүсийн маань эв нэгдлийг чөтгөр шулам бусниулсны дараа намайг шоронгоос гаргаж та нарыг элсэн цөлөөс энд авч ирж, Эзэнтэн ивээлдээ аваг. Эзэнтэн үнэхээр хүссэн хүндээ хайр энэрлээ үзүүлдэг. Тэр бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн билээ.”
101. “Аяа, Эзэнтэн минь! Чи намайг эрх мэдэлтэн (гэгээн элч) болгон, зүүд тайлахыг зааж сургалаа. Аяа, тэнгэр хийгээд газрыг бүтээгч! Энэ хорвоо хийгээд хойд ертөнцөд миний эзэн нь чи бөлгөө. Намайг мусулман чигээр нь үхүүлж, сайн үйл үйлдэгсэдийн дунд оруулагтун?!” хэмээн залбирав.
102. Аяа, Мухаммед! Далдын мэдээ болсон энэхүү өгүүлэмжийг чамд илгээж байна. Юсуфын ах нар нь түүнд муу санаа өвөрлөх үед чи тэдний дэргэд байгаагүй билээ.
103. Чи хичнээн их хүсэвч хүмүүсийн нэлээд нь үл сүсэглэдэг юм.
104. Чи Кураны айлдварыг тэдэнд хүргэсний төлөө тэднээс ямар ч шан харамж хүсэхгүй. Куран бүхий л ертөнцийн хүмүүст ухуулан сэнхэрүүлэх сургамж бөлгөө.
105. Тэнгэр, газарт өч төчнөөн гайхамшгууд бий. Хүмүүс түүнд анхаарал тавилгүйгээр хажуугаар нь няцан өнгөрцгөөдөг.
106. Тэдний ихэнх нь Аллахад итгэдэггүй, итгэлээ ч түүнтэй элдвийг эн зэрэгцүүлдэг юм.
107. Тэд Аллахын аймшигт гэсгээл өөрийг нь нэрвэхээс, эсвэл ертөнцийн төгсгөл анзаараагүй байхад гэнэт тохиохоос болгоомжилдоггүй юм уу? Өөрсдийгөө баттай хамгаалагдсан гэж боддог юм болов уу?
108. Аяа, Мухаммед!: “Энэ бол миний зам мөр. Би болон намайг дагагсад, ил тод нотолгоогоор хүмүүсийг Аллахад урайлж байна. Аллах цэвэр ариун, чин үнэн. Би үл сүсэглэгчдийн нэг нь биш ээ!” хэмээн хэлэгтүн.
109. Чамаас өмнө хотын иргэдээс эрэгтэйчүүдийг л гэгээн элчээр илгээж айлдварууд өгч байсан. Гэгээн элчид итгээгүй хүмүүс хаа сайгүй хэсүүлэн явахдаа өөрсдөөс өмнөхүүдийн хувь заяа хэрхэн төгсгөл

болсныг хараагүй гэж үү? Үнэн сүсэгтнүүдийн хувьд хойд ертөнцийн орон өлзийтэй. Та нар үүнийг ухаарахгүй байна гэж үү?

110. Гэгээн элч нар зон олныхоо сүсэглэхээс горьдлого тасарч, худалч боллоо гэж бодох цагт тэдэнд бидний тусламж ирж, хүссэн хүнээ аврах юм. Харин үл сүсэглэгч буруу номтнуудад илгээсэн зовлон гэгсгэлүүд үл буцаагдана.
111. Тэдний хүүрнэлд ухаалаг хүмүүсийн хувьд сургамж бий. Куран бол санаанаас зохиогдсон зүйл бус. Тэр урьдах судруудыг багатгана, бүхнийг яруу тод тайлбарлана. Бас үнэнч сүсэглэгчдийн хувьд зөв замыг залагч, бидний хайр энэрэл бөлгөө.



Мекке-д илгээгдсэн. 43 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Алиф, Лам, Мим, Ра. Эдгээр нь Куран судрын айлдварууд болно. Аяа, Мухаммед! чамд Эзэнтнээс чинь илгээгдсэн зүйлүүд чин үнэн. Гэвч хүмүүсийн ихэнх нь үл итгэцгээдэг билээ.
2. Та нарын харж байгаачлан тэнгэрийг тулгуур баганагүй бүтээсэн. Дараа нь арш буюу сансар огторгуйг эрхшээж, нар болоод сарыг эрх мэдэлдээ оруулсан Аллах мөн. Эдгээрийн тус бүр нь тодорхой хугацаагаар эргэлддэг. Аллах бүхий л үйлсийг гүйцэтгэдэг. Та нарыг өөрийн Эзэнтэйгээ учрахаа мэдэг гэж айлдваруудаа нарийвчлан тайлбарладаг юм.
3. Аллах газрыг уудам болгон дэлгэж түүн дээр уул нурууд, гол мөрөнгүүдийг, мөн бүхий л жимс ургамлыг эр, эм хосоор нь бүтээж, шөнийг өдрийн хучилга болгов. Энэ бүхнийг эрэгцүүлэн бодох хүмүүсийн хувьд нотолгоонууд бий.
4. Газар дэлхий дээр хөрш тивүүд оршмуй. Усан үзэмийн цэцэрлэг, тариан талбай дангаар болон салаалан ургасан дал мод бий. Энэ бүхэн нь нэг л усаар услагддаг ч Бид тэднийг янз бүрийн амттай болгон бүтээсэн. Энэ ч гэсэн ухаарах хүмүүст Аллахын ид шидийг ойлгуулах яруу тод нотолгоонууд болой.
5. Аяа, Мухаммед! Хэрэв, гайхал чинь төрж буй бол тэдний: “Бид үхэж шороо болсоныхоо дараа дахин амилах гэж үү?” гэсэн асуултанд гайхах нь зүй. Тэд Эзэнтнийг үгүйсгэгчид. Ертөнцийн төгсгөлийн өдөр тэдний хүзүүнд нь төмөр гинж зүүгдэж, тэд халуун тамын эзэд болж, тэндээ эгнэгт оршмуй.
6. Тэд чамаас сайн юмнаас урьдаар муу юмыг яаран хүлээнэ. Үнэндээ

- тэднээс өмнө ч сургамж авахуйц (Аллахын цээрлэлтэй учирсан) жишээнүүд байлаа. Хүмүүс нүгэл үйлдсэн ч Аллах өршөөлтэй байдаг. Тэрчлэн Эзэнтний чинь гэсгээл ч нэн хатуу болой.
7. Үл сүсэглэгсэд: “Эзэнтнээс нь түүнд (Мухаммедэд) яагаад нэгэн ер бусын гайхамшиг илгээгдээгүй юм вэ?” гэлцдэг. Үнэндээ, чи ердөө л сэрэмжлүүлэгч шүү дээ. Угтаа аль ч ард олныг зөв зам руу хөтөлдөг удирдагч байдаг юм.
  8. Алив эхчүүд тээж буйг (тухайлбал, тэр нь хүү юу, эсвэл охин уу? Ихэр үү, ганц уу? Жаргах уу, Зовох уу? Амьдрал нь урт уу, богино уу?) бүгдийг түүгээр ч барахгүй хэвлийд тээх хугацааг богиносгох, уртасгахыг ч Аллах мэднэ. Аллахын эрхшээсэн бүхий л юм хугацаа хэмжээтэй.
  9. Аллах ил, далд бүхнийг мэдмүй. Тэрбээр, аугаа бөгөөд онцгой эрхэмсэг бөлгөө.
  10. Та нараас нууцхан эсвэл, ил ярьдаг аль нь боловч, мөн шөнө дөлөөр нуугддаг хийгээд өдөр ил гардаг аль нь боловч Аллахад ил тод болой.
  11. Алив хүнийг урдаас нь тосож, хойноос нь дагаж хамгаалдаг Аллахын элч мэлэж нар буй. Алив ард өөрсдийн ахуй байдлаа өөрсдөө өөрчлөх хүртэл Аллах тэднийг өөрчлөхгүй. Харин нэгэн ардад хор уршиг тарихыг хүсвэл үүнийг хэн ч зайлуулж эс чадмуй. Тэдэнд Аллахаас өөр ямар ч туслагч эзэн үгүй.
  12. Тэрбээр, та нарыг айлгахын тулд тэнгэр цахилуулан, аянга буулгаж, найдлага төрүүлэхийн тулд өтгөн хар үүлсийг бий болгоно.
  13. Тэнгэрийн дуугарах чимээ Аллахын ариун үнэнийг шагшин магтмуй. Мэлэж элч нар ч айж эмээн түүнийг шагшин магтана. Тэд Аллахын талаар хоорондоо маргалдаж байхуйд, Тэр аянга цахилиулж, онилсон нэгийг нь ниргэх болно. Аллахын арга асар хүчтэй. Тэглээ ч зарим нь Аллахын талаар маргах дуртай.
  14. Чин үнэн залбирал гагцхүү Аллахад зориулагдмой. Түүнээс өөр бурханд залбирвал хиймэл бурхад нь тийм залбиралыг хүлээж авч эс чадна. Амандаа ус дусаах болов уу? хэмээн хий горьдон, алгаа тосч, ус руу гараа сунгаж дэмий зогссон хүний аманд ус дуслахгүй. Буруу номтнууд үүнтэй адил ажгуу. Үл сүсэглэгсэдийн залбирал гагцхүү төөрөгдөл мөн.
  15. Үнэндээ тэнгэр хийгээд газарт буй бүхэн (элч мэлэжүүд, буг чөтгөр, хүмүүс) мөн тэдний сүүдэр ч гэсэн эрт орой хэзээ нэгэн цагт, хүссэн хүсээгүй Аллахад сөгдөн мөргөцгөөх болно.
  16. Аяа, Мухаммед! Сүсэгтнүүдээс: “Тэнгэр, газрын Эзэнтэн хэн бэ?” хэмээн асуугаад, “зөвхөн Аллах” гэж хэлэгтүн. “Та нар Аллахаас зайлсхийж, өөртөө ч нэмэр үгүй, хор ч үгүй зүйлийг Эзэнтэн болгож байна гэж үү дээ?” хэмээн хэл! “Сохор ба харах мэлмийтэй хүн эсвэл



гэрэл гэгээ хийгээд тас харанхуй хоёр эн тэнцүү гэж үү?” хэмээн асуугтун. Үгүй бол, үл сүсэглэгсэд Аллахын бүхий л амьтадыг бүтээсэн лугаа адил бүтээдэг гэж Аллахтай эн зэрэгцүүлсэн юмнуудын бүтээсэн нь Аллахынхтай адилхан мэт харагдсан гэж үү?” Тэдэнд: “Алив бүхнийг бүтээгч нь Аллах бөгөөд Тэр цорын ганц. Мөн сүрлэг хүчтэй” гэж хэл!

17. Аллах тэнгэрээс бороо оруулахад жалгаар дүүрэн ус хөөсрөн үерлэж урссан. Үнэт зүйлс эсвэл багаж хэрэгсэл хийхээр галд хайлуулсан метал ч ийнхүү хөөсрөнө. Аллах үнэн худлын ялгааг ийнхүү жишин харуулмай. Харин хөөс замхран алга болдог бөгөөд хүмүүст ашигтай нь газарт тунаж үлддэг. Аллах ингэж жишээ үзүүлдэг бөлгөө.
18. Аллагаас итгэн сүсэглэхэд уриалсныг хүлээж авагсадад сайн сайхан юм бий. Харин Түүнийг хүлээн аваагүй хүмүүс газар дэлхий дээрх бүх юмс мөн түүнтэй адилтгах бүх зүйлс өөрсдийнх нь байвал хойт ертөнцийн тамлалаас аврагдахын тулд тэр бүхнийг зарцуулах биз. Гэвч тэр тус болохгүй тэдэнтэй сайтар тооцоологдох болно. Тэдний очих газар нь халуун там бөгөөд тэр юутай муухай оромж гээч!
19. Аяа, Мухаммед! Эзэнтнээс чинь чамд илгээгдсэн Кураныг чин үнэн хэмээн үздэг хүн ба түүнийг хардаггүй сэтгэл нь сохорсон хүн хоёр адилхан гэж үү? Гагцхүү оюун ухааны эзэд л түүнээс сургамж авч чаддаг юм.
20. Тэд Аллахын айлдваруудыг биелүүлэгчид бөгөөд амлалтаа үл няцаагчид мөн.
21. Тэд Аллахын туслахыг тушаасан зарлигийг үргэлжлүүлэгсэд бөгөөд Эзэнтнээсээ эмээж, эцсийн өдрийн тооцооноос сэргийлдэг хүмүүс билээ.
22. Мөн тэд Эзэнтнийхээ тааллыг хүсэж, тэвчээр гаргацгаадаг, уншлага мөргөлөө зүй ёсоор нь үйлдэцгээдэг, өөрсдөд нь хайрлагдсан хувь хишгээс ил далдаар (Аллахын төлөө) зарцуулсгаадаг, мөн муу мухайг сайн сайхнаар солигсод мөн. Иймд хойд хорвоогийн үр жимс нь тэднийх болно.
23. Тэд Гадын нэртэй диваажинд орцгооно, тэдний өвөг дээдсийн, хань ижилийн, үр хүүхдүүдийн буянтнууд ч тэнд орцгоох болно. Хаалга бүрээс элч мэлэч нар орж ирээд:
24. “Хатан тэвчээртэй байсны чинь хариуд та нарын амар амгаланг эрж байна! Хойд хорвоогийн чинь орон байр юутай сайхан юм бэ?” хэмээнэ.
25. Харин Аллахад сайхан амлалт өгчихөд дараа нь түүнийгээ зөрчигсөд, Аллахын туслалцахыг тушаасан зарлигийг үргэлжлүүлээгүй этгээдүүд, газар дэлхий дээр танхайран үймээн самуун дэгдээгчид— тэд бүгд Аллахын хараалыг хүртэж, хойд ертөнцөд цээрлэл үзнэ.
26. Аллах хэн нэгний хувь хишгийг элбэг дэлбэг, хэн нэгний хишгийг нь

- тарчиг буурай болгоно. Үл сүсэглэгсэд амьдын жаргалдаа ташаарч байгаа. Амьдын жаргал нь хойд ертөнцийнхтэй харьцуулвал түр зуурын амин зуулга гэсэн үг.
27. Буруу номтон үл сүсэглэгсэд: “Эзэнтнээс нь түүнд (Мухаммедэд) яагаад ер бусын гайхамшиг илгээгддэггүй вэ?” гэлцэх юм. Аяа, Мухаммед тэдэнд: “Аллах хүссэн нэгийгээ төөрөгдүүлмүй, өөрт нь үнэнчээр итгэсэн нэгийг зөв зам руу залдаг” хэмээн хэлэгтүн.
  28. Тийм л сүсэглэгчдийн зүрх сэтгэл нь Аллахыг дурсан санаж, залбирснаар амирлангуй болж, ханамж авдаг. Гагц Аллахыг санаж дурссанаар сэтгэл амирладгийг бүү мартагтун.
  29. Үнэнчээр сүсэглэж, буян үйлдэгсэд аз жаргалтай байх бөгөөд сайн сайхан газарт (Диваажинд) байх болно.
  30. Аяа, Мухаммед! Чамд илгээсэн судрыг (Кураныг) Аллахыг үгүйсгэсэн хүмүүст уншиж өгөг гэж чамайг явуулсан. Тэднээс өмнө ч тийм хүмүүс байсан. Тэдэнд: “Тэр (Аллах) миний Эзэнтэн бөгөөд Түүнээс өөр бурхан үгүй. Зөвхөн Түүнийг түшиж тулмуй, гагц Түүнд гэмших болно” хэмээн хэл.
  31. Хэрэв, Куранаар уулсыг нурааж, усыг эргүүлэн, газар хага үсрэн үхэгсэдийг амилуулан яриулсан ч (итгэхгүй хүн хэвээр байх болно)... Гэвч бүх үйлс Аллахад хамаарагдмуй. Сүсэгтнүүд үүнийг мэдэхгүй гэж үү? Аллах хүссэн бол бүх хүмүүнийг ялгаварлалгүй зөв зам руу хөтлөх байсан. Аллахын амлалт хэрэгжих хүртэл үгүйсгэгсэд өөрсдийн үйлдсэн хэргийн төлөө гай зовлонтой учирч, цээрлэгдээд байх бөгөөд эсвэл гай зовлон гэр орныхны хажууд нь буух болно. Эргэлзээгүй, Аллах амлалтаасаа хэзээ ч буцахгүй.
  32. Аяа, Мухаммед! Чамаас өмнөх гэгээн элчүүдийг ч доог тохуу болгоцгоосон юм. Би буруу номтон, үл сүсэглэгсэдэд түр зуурын боломж өгч, дараа нь тэднийг цээрлүүлсэн. Миний гэсгээл ямаршуу байна даа?
  33. Хүн бүрийн үйлдсэн хэргийг хянан ажиглагч бол Аллах биш гэж үү? (Тэр хиймэл бурхадтай адил байна уу?) Тэд Аллахтай аливааг эн зэрэгцүүлгээсэн билээ. Аяа, Мухаммед тэдэнд: “Бурханыхаа нэрсийг нэрлэгтүн?” гэж хэл. “Даян дэлхий дээр Аллахын үл мэдэх зүйлс байгаа мэтээр түүнийг та нар Аллахт хэлж өгөх гэсэн юм уу? Эсвэл хоосон үгээр тэднийг нэрлэх гэсэн юм уу?” хэмээн асуугтун. Тийм биш, үнэндээ үл сүсэглэгсэдэд өөрсдийнх нь хийсэн хэрэг сайхан харагдсан бөгөөд тэд зөв замаас төөрөгдсөн бөлгөө. Аллах төөрөгдүүлсэн хүнийг зөв зам руу залах хэн ч үгүй болой.
  34. Тэдэнд энэ хорвоод ч гэсгээл баймуй. Гэвч хойд ертөнцийн гэсгээл түүнээс илүү хүнд. Тэднийг Аллахын гэсгээлээс аврах хэн ч үгүй.
  35. Үнэн сүсэглэгсэдийн төлөө амлагдсан диваажингийн дүр төрх гэвэл: Хаяагаар нь ариун булаг урсана. Жимс жимсгэнэ хийгээд сэрүүн сүүдэр нь үүрд баймуй. Ийнхүү гэгээн сүсэгтэнгүүдийн эцсийн орших газар

- нь ийм болой. Харин үл сүсэглэгсэдийн эцэст очих газар нь халуун там бөлгөө.
36. Аяа, Мухаммед! Бидний зүгээс өөрсдөд нь ариун судар (Таурат, Инжил) илгээгдэгсэдээс итгэн бишрэгсэд нь судар (Куран)-д баясана. Чиний эсрэг бүлэглэсэн хүмүүсээс Куран судрын зарим хэсгийг нь үгүйсгэгсэд ч бас бий. (Аяа, Мухаммед) тэдэнд: “Би зөвхөн Аллахад итгэн залбирахыг, мөн аливааг эн зэрэгцүүлэхгүй байхыг хүлээн зөвшөөрч тушаагдсан. Хүмүүсийг Аллахын зам руу урайлан дуудаж байна. Зөвхөн Аллахын зарлигийг биелүүлнэ” хэмээн хэлэгтүн.
  37. Ийнхүү Бид Кураныг Араб хэл дээр зарлиг болгон буулгасан. Хэрэв чамд энэ эрдэм мэдлэг ирснээс хойш үл сүсэглэгсэдийн эрхээр хөтлөгдвөл Аллахын цээрлэлээс чамайг өмөөрөн аврах нэг ч халамжит, хамгаалагч олдохгүй.
  38. Чамаас өмнө ч гэгээн элч нарыг илгээж, тэдэнд ч хань ижил, үр хүүхэд хайрласан. Аллахын зөвшөөрөлгүйгээр ямар ч гэгээн элч ер бусын гайхамшиг үзүүлэх боломжгүй. Бүхий л цаг хугацааны хувьд бичигдсэн зарлиг бий.
  39. Аллах түүнээс хүссэнийг арилгаж, хүссэнийгээ хэвээр нь үлдээнэ. Хувь тавилангийн ном (Лаухил -Махфуз) Аллахын нигур дор бөлгөө.
  40. Аяа, Мухаммед! Үл сүсэглэгчдэд амласан гэгсгээлийн нэг хэсгийг чамд харуулсан ч эсвэл түүнээс өмнө (харуулахгүйгээр) чиний амийг авсан ч, чиний үүрэг бол Аллахын зарлигийг бусдад түгээх л явдал байх болно. Харин Бидний үүрэг бол хариу тооцоо хийх явдал юм.
  41. Бид (Бидний сүр хүч) тэдний газар дээр ирж, тал талаас нь хумиж буйг тэд харахгүй байна гэж үү дээ? Аллах л бүхнийг шүүн шийтгэнэ. Түүний зарлигийг хэн ч эсэргүүцэж чадахгүй. Түүний тооцоо хийх нь үтэр түргэн билээ.
  42. Тэднээс (буруу номтнуудаас) өмнөхүүд ч бусармаг (заль мэх) зүйл хийлгэсэн. Түүний эсрэг бүхий л арга хэмжээ Аллахын зүгээс. Аллах алив бүхний юу хийснийг мэдэж байдаг. Буруу номтнууд энэ хорвоогийн эцсийн сайн сайхан нь хэнийх болохыг удахгүй мэдэх болно.
  43. Аяа, Мухаммед! Үл сүсэглэгсэд чам руу хандан: “Чи бол Аллахын зүгээс илгээгдсэн гэгээн элч биш” хэмээн хэлнэ. Тэдэнд: “Чи бидний хооронд миний гэгээн элч эсэхэд Аллах болон түүний ариун судрыг мэддэг хүмүүсийн гэрчлэл хангалттай” хэмээн өчигтүн!

## 14. СУРЕ ИБРАХИМ

Мекке-д илгээгдсэн. 52 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Алиф, Лам, Ра. Аяа, Мухаммед! Эзэнтний зарлигаар хүн ардыг түнэр харанхуйгаас гэрэл гэгээ рүү гаргахад бүхнээс эрхэм, бүхий л хэлээр сайшаагдсан Аллахын зөв зам руу залахад зориулж Биднээс чамд илгээсэн судар бол- энэхүү Куран мөн.
2. Тэнгэр, газарт буй бүхэн бүгд Аллахын баялаг. Харин үл сүсэглэгсэдийн хувьд зовлонгт гэсгээл тохиох нь юутай харамсалтай вэ?
3. Тэд энэ хорвоогийн амьдралыг хойд ертөнцөөс илүү хайрладаг, Тиймээс Аллахад хүрэх замд саад хийж, түүнийг тойруу болгохыг хүсэцгээдэг юм. Ийнхүү тэд үнэнхүү улам холдож төөрөгдсөөр байна.
4. Аллахын зарлигийг сайтар тайлбарлаж өг гээд Бид гэгээн элч бүрийг зөвхөн өөрсдийнх нь ардад өөрсдийн хэлээр илгээсэн юм. Аллах хүссэн хэн нэгнийг төөрөгдүүлж, хүссэн хүнээ зөв зам руу хөтөлдөг. Аллах машид хүчирхэг бөгөөд мэргэн ухааны эзэн.
5. Бид Мусар: Ард олноо харанхуйгаас гэрэл гэгээ рүү гарга, туулж өнгөрүүлсэн бэрх өдрүүдийг сануул гэж ер бусын нотолгоо, гайхамшигуудаар илгээсэн билээ. Үүнд бэрхшээлийг тэвчих, сайн сайхныг даах (талархах) хүмүүсийн хувьд сургамж баймуй.
6. Тэр үед Муса өөрийн ард олондоо хандан: “Та нарт хүртээсэн Аллахын хувь хишгийг санагтун. Тэр та нарыг тухайн үед Фиргауны талынхны цуст гараас аварсан. Тэд та нарыг хамгийн муугаар гэсгээж, хөвгүүдийг чинь алж, эхнэр хүүхнүүдийг чинь амьд үлдээдэг байлаа. Энэ нь та нарт Эзэнтний зүгээс илгээгдсэн их сорилт байсан юм” хэмээн хэлэв.
7. Тэр үед Эзэнтэн чинь та нарт : “Хэрэв та нар миний буянд талархваас хойч үеийнхэнд чинь хувь хишгээ ахиу өгнө, харин үл тоомсорловоос миний гэсгээл нэн хатуу” хэмээн мэдэгдсэн юм.
8. Муса зон олондоо хандан: “Хэрэв та нар хийгээд газар дэлхийн бүх хүмүүс Аллахыг үгүйсгэж, эсэргүүцэл үзүүлбээс Аллахыг яаж ч чадахгүй. Аллах эргэлзээгүй ямар ч юмаар дутагдаж гачигдахгүй, магтвал зохилтой юм шүү”
9. Та нараас өмнөх Нух, Гад болон Самуд нарын ардуудын ч мөн түүнээс хойших тоог зөвхөн Аллах мэдэх олон түмний тухай мэдээлэл та нарт ирээгүй гэж үү? Тэд бүгдийг гагцхүү Аллах мэднэ. Гэгээн элч нар нь тэдэнд ер бусын гайхамшигаар ирцгээсэн ч тэд хуруугаараа дохиж элч нартаа хандан: “Үнэндээ Бид та нарын гэгээн элч болохыг зөвшөөрөхгүй, та нарын суртал ухуулгад итгэдэггүй” гэлцэв.

10. Тэдний гэгээн элч нар нь: “Та нар тэнгэр болоод газрыг бүтээгч Аллахад эргэлзэх гэж үү дээ? Аллах та нарын нуглийг өршөөхийн тулд сүсэглэхийг уриалсан, бас та нарыг гэсгээх хугацааг хойшлуулах боломж олгомуй” гэв. Тэд: “Та нар бидэнтэй адилхан хүн шүү дээ. Биднийг өвөг дээдсийн маань шүтэж асан зүйлсээс татгалзуулах гэж байна. Хэрэв тийм бол бидэнд ил тод нотолгоонууд харуулаарай” гэлцэв.
11. Гэгээн элч нар нь тэдэнд: “Тиймээ, үнэндээ бид та нартай адилхан хүмүүс. Гэвч, Аллах хувь хишгээ (гэгээн элч болох онцлогыг) боолуудаасаа хүссэн нэгэндээ хайрладаг. Аллахын зарлиггүйгээр ямар нэгэн нотолгоо, ер бусын гайхамшиг үзүүлэх боломжгүй. Үнэн сүсэгтэнгүүд гагцхүү Аллахад итгэж найддаг.”
12. “Дөг зөв руу хөтөлсөн Аллахад яагаад итгэн найдахгүй гэж? Та нарын бидэнд учруулсан гай барцатад бид тэвчмүй. Тиймээс итгэх хүмүүс зөвхөн Аллахад итгэж найдаг” гэв.
13. Харин үл сүсэглэгсэд өөрсдийнхөө гэгээн элч нарт хандан: “Та нарыг газар нутгаасаа үг дуугүй хөөж гаргах болно. Эсвэл та нар бидний шашинд орох болно” гэв. Тиймээс Эзэнтэн гэгээн элч нарт: “Бид зальхай этгээдийг үгүй хийх болно” хэмээн айлдав.
14. Дараа нь тэнд та нарыг байрлуулах болно. Энэ ялалт бол Миний өмнө ирэхээс (байцаагдахаас) айж эмээгсдэд хамаармуй” гэв.
15. Гэгээн элч нар Аллагаас ялалт хүсэцгээсэн учир хүнд сурталт, зальхай этгээдүүд бүгд хохирол амсав.
16. Тэдэнд гэсгээн зовоох там буй, тэнд идээ бээрт усаар цангаагаа гаргах болно.
17. Тэд түүнийг амсан, арай хийж залгина. Тал бүрээс нь үхэл бүслэнэ. Гэвч тэд үхэж эс чадна. Үүний дараа бас хатуу, гэсгээл үзнэ.
18. Эзэнтнийг үгүйсгэгсэдийн сайн арга мэх нь шуургатай өдөр хийсэх үнсний адил. Тэд энэ хорвоод хийсэн, өөдтэй зүйлсээсээ өчүүхэн ч ашиг хүртэж чадахгүй. Энэ бол асар их төөрөгдөл мөн.
19. Тэнгэр хийгээд газрыг үнэнхүү Аллах бүтээснийг чи харахгүй гэж үү? Хэрэв Аллах хүсвэл та нарыг үгүй хийж, оронд чинь цоо шинэ нэгэн ард түмнийг бүтээнэ.
20. Энэ нь Аллахад тийм ч хэцүү зүйл биш ээ.
21. Ертөнцийн төгсгөлийн өдөр бүх хүмүүс дахин амилан Аллахын нигур дор очих бөгөөд сул доройчууд нь ихэмсэгүүдэд хандан: “Бид та нарыг дагасан билээ. Одоо та нар, Аллахын гэсгээлээс өчүүхэн ч хэсгийг биднээс зайлуулж чадах юм уу?” хэмээн асууна. Хариуд нь тэд: “Аллах биднийг зөв шулуун замд хөтөлсөн бол бид ч гэсэн та нарыг зөв зам руу хөтлөх байсан билээ. Одоо бид гомдоллосон ч, тэвчсэн ч адил юм. Учир нь бид зайлсхийх газаргүй болсон” хэмээн хариулав.

22. Бүх юм нэгэн тийш болж, хүмүүс диваажин, тамд хуваагдаж дуусах цагт чөтгөр шулам тэдэнд: “Аллах та нарт (итгэн сүсэглэгэсэдийг хүндэтгэл үзүүлэх, үгүйсгэгчдийг цээрлүүлэх тухай) чин үнэн амлалтаа өгсөн билээ.(Тэр үнэн болж таарлаа.) Би ч гэсэн та нарт (диваажин, там үгүй гэж) амлалт өгч байсан. Би урваж худлаа хэлжээ. Угаасаа надад та нарыг албадах ямар ч хүч байгаагүй билээ. Би зүгээр л та нарыг уруу татахад өөрсдөө миний урилгыг хүлээн авсан шүү дээ. Тиймээс намайг буруутгах бус, өөрсдийгөө зэмлэгтүн. Би та нарыг аварч чадахгүй. Та нар ч намайг аварч эс чадна. Анхнаасаа та нарын намайг Аллахтай эн зэрэгцүүлэхийг чинь эсэргүүцсэн билээ. Зальхай амьтад үнэхээр хатуу цээрлэлтэй учирлаа даа” гэв.
23. Үнэнчээр сүсэглэж сайн үйлс үйлдэгсэд Эзэнтнийхээ зөвшөөрлөөр хаяагаар нь ариун булаг урсдаг диваажингуудад орцгооно. Тэнд үүрд орших болно. Диваажинд тэд бие биетэйгээ “салем” (амар амгалан уу?) хэмээн мэндэлцгээнэ.
24. Аяа, Мухаммед! Аллах ийм нэгэн жишээ илгээснийг хараагүй уу? Элэгсэг сайхан үг бол бат бөх үндэстэй, салаа мөчир нь тэнгэр өөд тэмүүлсэн, саглагар модтой адил” гэдэг бөлгөө.
25. (тэр мод) Эзэнтний зарлигаар зохих хугацаанд үр жимсээ өгнө. Аллах хүмүүсийг сургамж аваг хэмээн ийн үлгэрлэмүй.
26. Харин олхиогүй муу үг (Аллахад итгэхгүй үл тоомсорлодог үг) уг үндсээрээ ховхрон унасан, дахин ургаж эс чадах мод лугаа адил бөлгөө.
27. Аллах сүсэглэгэсэдийг энэ яваа хийгээд хойд насанд ч чин үнэн залбиралаар баттай зогсооно. Харин зальхай этгээдүүдийг төөрөгдүүлмүй. Аллах болгоосон бүхнээ хиймүй.
28. Аллахын хувь хишигт харалган хандаж, ард олноо төөрөгдүүлэн хөнөөлийн голомтод унагаагсадыг чи харсан уу?
29. Тэдний хөнөөлийн голомт нь халуун там болой. Тэд түүнд ормой. Тэр юутай муухай газар гээч!
30. Тэд (хүмүүсийг) Аллахын зөв замаас төөрөгдүүлэхийн тулд Түүнтэй эн зэрэгцүүлэх зохиомол бурхадыг гараар хийв. Аяа, Мухаммед! тэдэнд: “Та нар одоохондоо амьд ахуйн цагт сайн сайхныг эдлээрэй. Та нарын очих газар угаасаа халуун там мөн” хэмээн хэлэгтүн.
31. (Аяа, Мухаммед) Миний сүсэгтэн боолуудад: “наймаа хэлцэл ч үгүй, найз нөхдийн тус ч үгүй болох тэр өдөр ирэхээс өмнө уншлага мөргөлөө зөв зүйтэй үйлдэцгээгтүн. Мөн бидний хүртээсэн хувь хишгээс (Аллахын төлөө) ил, далдаар буяны өглөг өг!” гэж хэлэгтүн.
32. Аллах тэнгэр, газрыг бүтээсэн. Тэгээд тэнгэрээс хурыг буулгаж, түүгээрээ хувь хишиг болгон та нарт төрөл бүрийн үр жимсийг ургуулж өгсөн. Аллах тааллаараа далай тэнгисийг гатлаг хэмээн хөлөг онгоцыг та нарт эзэмшүүлэв. Мөн гол мөрөнг ч гэсэн та нарын эрх мэдэлд өгсөн.

33. Эмх цэгцтэй орчлоор (нэгэн хэмээр) цуцалтгүй эргэлдэх нар сарыг, бас шөнө, өдрийг та нарын эрх мэдэлд өгсөн.
34. Тэр та нарын хүссэн бүхнийг өгсөн. Хэрэв Аллахын хүртээсэн хувь хишгийг тоолвол хэзээ ч тоолж барахгүй. Үнэндээ, хүн гэдэг амьтан сэтгэл хандаггүй, боллоо гэж талархдаггүй, ач тус мэддэггүй юм.
35. Нэгэнтээ Ибрахимын ийнхүү хэлснийг санацгаа: “Аяа, Эзэнтэн минь! Энэ хотыг (Меккег) айх аюулгүй тайван болгож аль? Намайг болоод миний үр садыг хиймэл бурханд мөргөхөөс аварч өршөө?!”
36. “Аяа, Эзэнтэн минь ээ! Тэр (хиймэл бурхад) үнэндээ үй олон хүмүүсийг замаас нь төөрөгдүүлсэн шүү дээ. Хэн намайг дагах аваас миний талынхан, харин хэн миний эсрэг босох аваас яая гэхэв! Чи тэдэнд машид өршөөгч хийгээд энэрэгч шүү дээ.”
37. “Аяа, бидний Эзэнтэн ээ! Уншлага мөргөлөө зөв зүйтэй үйлдэг хэмээн би үр удмынхаа нэг хэсгийг нүцгэн хөндий дэх чиний ариун газрын (Кагбагийн) дэргэд суурьшуулсан юм. Хүмүүсийн нэг хэсгийн зүрх сэтгэлийг түүн рүүгээ чиглүүлж хайрла! Тэдэнд үр жимснээсээ хувь хишиг хүртээгтүн. Ийнхүү тэд талархах бөлгөө.”
38. “Аяа, Эзэнтэн минь ээ! Бидний ил, далд хийсэн бүхнийг Чи мэдэж байдаг. Газар, тэнгэрт буй бүх юмс Аллахаас далд байдаггүй.
39. “Өтөл насанд минь надад Исмайл, Исхак хоёрыг хайрласан Аллахыг шагшин магтмуй. Эзэнтэн үнэхээр хүсэл, залбирлыг ямагт сонсогч билээ.”
40. “Аяа, Эзэнтэн минь! Намайг хийгээд ур удмыг минь уншлага мөргөлөө зүй ёсоор нь үйлддэг болгож хайрла. Аяа, Эзэнтэн минь! залбирлыг минь хүлээн авагтун?!”
41. Аяа, Эзэнтэн минь ээ! Шүүлтийн өдөр ирэхэд намайг, миний эцэг эхийг, мөн сүсэгтэн олныг маань өршөөж хайрлагтун?” гэв.
42. Аяа, Мухаммед! Зальхай этгээдүүдийн ааш авир, үйлдэл бүхнийг Аллах үл мэддэг гэж бүү бодогтун. Үнэндээ, Аллах тэдний гэгсгээлийг айсандаа нүд нь бүлтэрэх өдрийг хүртэл сунгаж буй болой.
43. (Тэр өдөр) тэдний нүд нь бүлтийж, эргэж харж эс чадан, цээж нь хоосрон, хийгээр дүүрч, толгойгоо гэлжийлгэж, яаран гүйлдэх болно.
44. Аяа, Мухаммед! Хүмүүст гэгсгээл ирэх өдрийнх нь тухай анхааруулагтун. Тэр өдөр зальхай этгээдүүд ийн царайчилмуй: “Аяа, Эзэнтэн минь ээ! Бидэнд өчүүхэн хугацаатай ч гэсэн боломж өгч хайрлагтун. Бид чиний дуудлагыг хүлээн авч, элч нарыг чинь дагамуй” хэмээн гуйна. Чи тэдэнд: “Урьд өмнө нь та нар бидэнд гай барцад тохиолдохгүй” хэмээн андгай тавиад байгаагүйсэн билүү?” хэмээн хэл.
45. Та нар өөрсдөө өөртөө зальхай хэрэг үйлдэгсэдийн нутагт суурьшсан. Бид тэднийг хэрхэн гэгсгээсэн нь та нарт тодорхой боллоо. Ийнхүү та нарт жишээг харууллаа.

46. Тэд үнэхээр элдэв аргаар мэхэлсэн. Тэд заль мэхээрээ уул нүүлгэхээр байсан ч тэдний арга мэхийг Аллах гүйцэлдүүлэхгүй.
47. Аллах өөрийнхөө элч нарт өгсөн амлалтаасаа буцна гэж бүү бодогтун. Эргэлзээгүй, Аллах аугаа хүчирхэг бөгөөд жинхэнэ хариу шүүгч бөлгөө.
48. Тэр өдөр газар нь өөр нэг газраар, тэнгэр нь өөр нэг тэнгэрээр өөрчлөн солигдох бөгөөд хүмүүс цор ганц хүчирхэг Аллахын нигур дор цуглармуй.
49. Тэр өдөр, чи нүгэлтэнгүүдийг гинжээр дөнгөлүүлсэн байхыг олж харах болно.
50. Тэдний цамц нь хар тосоор будагдан, нүүр нь дөлөнд автсан байх юм.
51. Алив хүмүүн өөрийн үйлдсэн нүглийнхээ хэрээр Аллагаас гэсгээл хүртэхийн учир тийн буй. Аллах жинхэнэ үтэр түргэн тооцоо бодогч.
52. Хүмүүст анхааруулга бичихийн тулд, Аллах цорын ганц гэдгийг мэдүүлэхийн учир, мөн оюун ухааны эзэд сайтар ухаарч сургамж авахын тулд энэхүү Куран судар хүмүүнд илгээгдсэн болой.

## 15.СУРЕ ХИЖР

Мекке-д илгээгдсэн. 99 айлдвар.

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Алиф, Лам Ра. Энэ бол судар хийгээд Кураны ил тод айлдварууд мөн.
2. Үл сүсэглэгсэд (Ертөнцийн төгсгөлийн аюумшиг тулаад ирэхэд): “Мусулман болох нь яав даа” хэмээн харамсана.
3. Аяа, Мухаммед! Тэднийг орхигтун. Идэж ууг, тоглон наадаж, хуурамч хорвоогийн жаргал цэнгэлд хуургаж яваг. Удахгүй тэд хийсэн хэргийн гэсгээлийг амсах болно.
4. Бид аливаа нэгэн хот суурин газрыг урьдчилан тодорхой нэгэн хугацаа товлохгүйгээр үл сөнөөнө.
5. Ямар ч ард олон өөрт нь тохиох хувь тавиланг урагшлуулах, эсвэл хойшлуулах чадваргүй.
6. Тэд: “Аяа, чи, (Мухаммед) Кураны хишиг хүртэгч ээ! Гарцаагүй, чи тэнэг юм аа.
7. Хэрэв чи, чин шударга байсан бол бидэнд ч мэлэүүд буюу Аллахын элч нарыг яагаад дагуулж ирдэггүй юм вэ?” гэнэ.
8. Бид мэлэч элч нарыг гагцхүү үнэн шударгаар хэрэгцээтэй үед нь илгээдэг. Тэр үед тэдэнд ямар ч боломж эс олгомуй.



9. Кураныг эргэлзээгүй бид илгээсэн бөгөөд түүнийг бид л хамгаалмуй.
10. Аяа, Мухаммед! Үнэндээ чамаас өмнөх овог аймгуудад гэгээн элчүүдийг илгээсэн юм.
11. Тэд өөрт нь илгээгдсэн гэгээн элч бүхнээр доог тохуу хийсэн.
12. Бид нүгэлтэнгүүдийн (Меккегийн үл сүсэглэгсэд) зүрх сэтгэлийг яг тийм байдлаар төлөвшүүлсэн билээ.
13. Тэд Куранд итгэдэггүй. Тэдний өмнөх хүмүүс ч тийм л байсан билээ. (Аллахын цээрлэлтэй учруулсан)
14. Бид тэдэнд тэнгэрээс нэгэн үүд хаалгыг нээгээд тэд түүгээр дээшилвэл, (бидний мэлкүүд болон сүнс сүлдийн ертөнцийг үздэг болоосой.)
15. Тэд: “Бидний нүд бүрэлзэн, эсвэл илбэдүүлсэн байжээ” хэмээцгээх сэн.
16. Эргэлзээгүй, бид огторгуйд ододыг бүтээж, сонирхогчдод зориулж тэнгэрийг чимэглэсэн юм.
17. Хараал идмэр чөтгөр шуламаас ийнхүү тэнгэр огторгуйг хамгаалсан бөлгөө.
18. Хулгайчийн адил сэмээрхэн чагнадаг чөтгөрүүдийг харвасан одууд үлдэн хөөнө.
19. Бид газрыг дэлгэж, түүн дээр уулсыг байршуулж, тэнд өвс ургамлыг зохих хэмжээгээр ургууллаа.
20. Тэрхүү газар дээр та нарын хийгээд та нараар үл тэжээлгэгчдийн амьжиргааны хэрэгцээг бүтээсэн.
21. Юм бүхний сан хөмрөг нь зөвхөн бидний нигур дор бөгөөд түүнийг тодорхой хэмжээгээр буулгамуй.
22. Үүлсийг хөөх салхийг илгээж, тэнгэрээс хурыг буулган, түүгээр та нарыг ундаалав. Эс тэгвэл та нар тэр их усыг хуримтлуулан хадгалж чадахгүй.
23. Үнэхээр Бид бүхнийг амилуулж, бас үхүүлмүй. Бүхнийг эзэгнэх болно.
24. Эргэлзээүй, та нараас өмнө ирсэн ба хойно ирэгсэд бидэнд илэрхий байдаг.
25. Эзэнтэн чинь тэдний бүгдийг нь Ертөнцийн төгсгөлийн өдөр цуглуулах болно. Тэр мэргэн ухааны эзэн хийгээд бүхнийг мэдэгч.
26. Бид хүмүүнийг (Адамыг) шавраар бүтээж дүрсжүүлэн, хатаасан.
27. Харин буг чөтгөрийг түүнээс өмнө утаагүй улалзах галаас бүтээсэн билээ.
28. Эзэнтэн чинь тэр мөчид мэлкүүдэд хандан: “Би хэлбэржүүлэн хатаасан шавраар хүнийг бүтээх болно” гэсэн билээ.
29. Дараа нь би түүний хүн төрхийг бусад эрхтэнүүдийн хамт бүтээж, сүр хүчээрээ үлээн амин сүнс оруулахуйд та нар түүнд сөгдөн мөргөцгөөнө.”

30. Ийнхүү мэлэжүүд цөм сөгдөн мөргөцгөөсөн.
31. Гагцхүү Иблис (чөтгөр л) сөгдөн мөргөхөөс татгалзсан билээ.
32. (Аллах) түүнд: “Аяа, Иблис чи яагаад сөгдөн мөргөдөггүй юм бэ?” гэж асуулаа.
33. (Иблис): “Чиний шавраар хэлбэржүүлэн бүтээсэн хүн чинь миний сөгдөн мөргөхөд зохимжтой биш” хэмээн хариулав.
34. (Аллах): “Тийм бол чи диваажингаас зайл. Эндээс хөөгдсөн.”
35. Ертөнцийн төгсгөлийн өдөр хүртэл чамайг хараал идэг!” гэлээ.
36. (Иблис): “Аяа, Эзэнтэн минь! Хэрэв тийм юм бол хүмүүн дахин амилах хүртэл надад боломж өгөгтүн?” гэв.
37. Аллах түүнд: “Товлогдсон нэгэн хугацаа хүртэл чамд боломж олголоо” гэв.
38. Тэр нь Аллахын нигур дор ирэх товлогдсон хугацаа болой.
39. (Иблис): “Аяа, Эзэнтэн минь! Чи намайг төөрөгдүүлсний хариуд би газар дэлхий дээрх хүмүүст нүгэлийг чимэглүүлэн харуулж, бүгдийг нь буруу замд оруулна.”
40. “Гагцхүү Чиний ариун шударга боолуудыг төөрөгдүүлж чадахгүй байх” гэв.
41. (Аллах): “Энэ бол Над руу хүргэх зөв шулуун зам мөн” гэв.
42. “Чамайг дагаж замаа алдагсадаас бусад Миний боолуудад чи нөлөөлж чадахгүй!” гэв.
43. Эргэлзээгүй, тэд бүгдийн (Иблис болон түүний талынхны) очих газар нь халуун там болой.
44. Халуун там долоон хаалгатай. Хаалга бүрээр тэд хэсэг бүлгээр хуваагдан орно.
45. Гэгээн сүсэгтнүүд жимсний цэцэрлэгтэй, элбэг устай булаг бүхий диваажинд залармуй.
46. Тэдэнд: “Диваажинд амгалан морилцгоо” хэмээн мэндчлэх болно.
47. Бид, тэдний зүрх сэтгэл дэх гомдолыг цайруулж, тэд ахан дүүс болцгоож, олбогон дээр бие биенээ харан заларцгаах болно.
48. Тэд диваажинд зүдрэхийг үл үзмүй, тэндээс хэзээ ч эс гаргагдмуй.
49. (Аяа, Мухаммед) Миний боолуудад мэдэгдэгтүн: “Би үнэхээр машид ивээгч бас энэрэнгүй билээ.”
50. Харин Миний гэсгээл нэн хатуу.
51. Тэдэнд Ибрахимын зочдын тухай болон өөрийнхөө талаар хэлж өгөгтүн.
52. Нэгэнтээ Аллахын мэлэжүүд Ибрахим дээр ирж амар амгаланг асуув. Ибрахим: “Үнэндээ бид та нараас айдаг юм шүү” гэв.

53. Тэд: “Бүү айгтун. Бид чамайг цэцэн билэгт нэгэн хөвгүүний тухай мэдээгээр баярлуулах гэж ирлээ.”
54. Ибрахим: “Өтөл насны сүүдэр нэгэнт тусчихаад байгаа намайг хэрхэн баярлуулах билээ?”
55. Тэд: “Бид чамд чин үнэн тааламжит мэдээг дуулгаж баймуй. Тиймээс горьдлого тасрагсадын нэгэн бүү бол!
56. Ибрахим: Төөрөлдөгсөдөөс өөр Эзэнтний энэрэл хайранд хэн цөхрөн горьдлогоо тасрах вэ?
57. “Аяа, элчүүд ээ! та нар өөр ямар үүрэгтэй ирсэн вэ?
58. Элч мэлэкүүд: “Биднийг нүгэлт ард түмнийг цээрлүүлэхийн тулд илгээсэн болой,
59. Гагцхүү тэднээс Лут-ын гэр бүлийг аварна,
60. Гэвч Лутын эхнэрийг үл аварна. Түүнийг сүйрэгсэдийн хамт үлдээхээр болсон” гэв.
61. Элч мэлэкүүд Лутын гэрт ирэхүйд:
62. Лут тэдэнд: “Үнэндээ, та нар үл таних хүмүүс байна шүү?”
63. Элч мэлэкүүд: “Бид чамд тэдний (чиний ард олны) эргэлзэж байсан зовлонт гэсгээлийг авч ирлээ.
64. Ийнхүү чамд үнэнийг хэлэхээр ирлээ. Гарцаагүй бид чин үнэнийг хэлмүй.
65. Чи шөнө дунд гэр бүлийн гишүүд хүүхэд шуухадаа авч замд гар, чи ч тэдний араас нь дагагтун. Та нарын хэн нь ч эргэж бүү хараг, тушаасан газарт хүрэх хүртэл зогсохгүй явагтун.
66. Бид, “танай хүмүүс үүр цайх цагаар гарцаагүй хиар цохигдоно” гэдгийг Лутад урьдчилан мэдэгдсэн билээ.
67. Садум хотын иргэд хүмүүний дүрстэй элч мэлэк нарыг хараад үймүүлэн доромжлохоор Лутын гэрт баяртайгаар орж ирлээ.
68. Лут тэдэнд: “Эд нар миний зочид, Эдний өмнө намайг бүү гутаагтун.”
69. “Аллахаас айгтун, намайг бүү шившиг болгогтун” гэв.
70. Хотын иргэд: “Бид чамайг, бусдын ажилд хөндлөнгөөс оролцохыг хориглосон биш билүү?” хэмээв.
71. Лут: “Энэ бол миний охидууд, хүсвэл эдэнтэй гэрлэж болно” гэв.
72. Элч мэлэкүүд: “(Аяа, Лут!) Чиний амь насаар андгайлан хэлье, тэд тачаалдаа улангасан сохроор төөрөлдөж байна шүү дээ.” хэмээв.
73. Нар мандахад тэдэнд гаслант орь дуу сонсогдов.
74. Бид тийнхүү тэдний сууринг орвонгоор нь эргүүлж, дээр нь шатаасан шавраар чулуун бороо оруулсан юм.
75. Энэхүү үйл явдлыг анзаарсан хүнд олон сургамж бий.

76. Тэрхүү хотын балгас болсон ул мөр эдүүгээ ч (Мекке, Шам хоёрын дунд) зам дээр байж л байна.
77. Үнэн сүсэгтнүүдийн хувьд энд нэгэн сургамж байгаа.
78. Айкегийн ардууд (гэгээн элч Шугайбын зон олон) ч үнэнхүү зальхай улс байсан юм.
79. Бид тэднийг ч гэгсгээн шийтгэсэн бөгөөд Садум, Айке хоёр ч харгуй зам дээр баймуй.
80. Үнэндээ, Хижрын ардууд ч (Салихын ард олон) гэгээн элчүүдийг үгүйсгэсэн билээ.
81. Бид тэдэнд өөрсдийн ер бусын гайхамшигуудыг илгээсэн ч зөрүүдлэн нүүр буруулсан юм.
82. Тэгээд, тэд (Аллахын гэгсгээлээс мултрахын тулд) ууланд агуй ухаж, бат бөх оромж бэлтгэн орогносон.
83. Тэднийг ч үүр цайхуйд гаслант орь дуу эзэмдэн сөнөөв.
84. Тэдний бодож олсон арга, (агуйлан бэлтгэсэн бат бөх оромжууд нь) тус болсонгүй.
85. Бид тэнгэр, газрыг хийгээд тэдгээрийн хоорондох ахуй байдлыг цэгцтэй, дүрэм журмаар бүтээсэн бөгөөд ертөнцийн төгсгөл ирэх нь эргэлзээгүй. (Аяа, Мухаммед) Тэдэнтэй одоохондоо найрсаг байх нь өлзийтэй.
86. Эзэнтэн бүхнийг бүтээгч онцгой мэргэн.
87. Андгайлан хэлье, Бид чамд (уншлага мөргөлийн хэсэг бүрийн эхэнд) байнгын давтагдах долоон айлдвар (Фатиха бүлэг) хийгээд аугаа Кураныг илгээсэн бөлгөө.
88. Үл сүсэглэгсэдийн зарим хэсэгт Бидний хайрласан зүйлийг бүү илүү үз, итгэн сүсэглэсэнгүй хэмээн бүү гунь, харин үнэн сүсэглэгсэд хайр энэрэлийн жигүүрээ дэлгэ, өршөөл энэрэлтэй байгтун.
89. Тэдэнд: “Үнэнхүү би та нарын яруу тод (гэгсгээлээс) сэрэмжлүүлэгч мөн!” хэмээн хэл.
90. Салан тусгаарлагсад (Иудэйчүүд болон Христчүүдэд Таурат, Инжилийн зарим хэсэгт итгэж, зарим хэсэгт үл итгэсэн ) гэгсгээл илгээсэн лүүгээ адил гэгсгээл илгээнэ.
91. Тэд Кураныг олон хэсэг болгон хуваасан. (Өөрөөр хэлбэл Таурат болон Инжилийн дотор буйг ялгасан лүүгээ адил Кураны зарим хэсэгт нь итгэж, зарим хэсэгт нь үл итгэсэн.)
92. 93. Эзэнтний нэр барьж андгайлая. Тэдний амьд ахуйдаа хийсэн хэргийн төлөө заавал ял асуух болно.
94. Чамд илгээсэн зарлигийг чи тэдэнд л анхааруулж, буруу номтнуудаас зайгаа барь!

95. Чамайг элэг доог болгон доромжлогсодыг гэсгээхэд бидний хүч хангалттай.
96. Аллахтай бусдыг эн зэрэгцүүлснээ тэд тун удахгүй мэдэх болно.
97. Чамайг доог тохуу болгон, тэдний ярьсанд чиний зүрх шаналж буйг Бид нэгэнт мэдэж байгаа.
98. Эзэнтнийгээ шагшин магтаж, бишрэн мөргөгсөдтэй хамт байгтун.
99. Ийнхүү нас эцэслэх хүртэл Эзэнтэндээ мөргөн залбир!

## 16. СУРЕ НАХЫЛ

Мекке-д илгээгдсэн. 128 айлдвар.

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Аллахын зарлиг (Ертөнцийн төгсгөлийн өдөр) гарцаагүй ирнэ. Түүний ирэхийг бүү яаран хүлээгтүн. Аллах Түүнтэй эн зэрэгцүүлсэн бүхнээс ангид бөгөөд нэн эрхэмсэг бөлгөө.
2. Аллах өөрийн хүссэн боолууддаа “Надаас өөр ямар ч бурхан үгүй, Nadaас айгтун” хэмээн сэрэмжлүүлэхээр элчүүдээ (айлдвараа мэлчүүдээр дамжуулан гэгээн элчидээ) илгээсэн.
3. Тэр тэнгэр, газрыг цэгцтэй дүрэм журмаар бүтээсэн. Аллах үл сүсэглэгчдийн эн зэрэгцүүлсэн бүхнээс ангид билээ.
4. Тэр хүмүүнийг нэгэн дусал үрийн шингэнээр бүтээсэн. Гэтэл тэд Эзэнтнийг эсэргүүцэгч болон гараад ирлээ.
5. Тэр мал амьтадыг ч бүтээлээ. Та нарын төлөө тэдэнд дулаацах (ноос, арьс, шир) зүйлс хийгээд бусад ашиг тустай түүхий эд баймуй. Мөн тэдний махыг та нар идэцгээнэ.
6. Та нар тэднийг орой бэлчээрээс тууж ирэхдээ, өглөө билчээхүйд бахархах сэтгэл төрүүлнэ.
7. Их л бэрхшээл зүдэргээнээр зөөвөрлөх ачаа бараагаа алс хотуудад та нар энэхүү амьтадад ачаалан хүргэж өгдөг билээ. Эзэнтэн чинь үнэхээр тусархуу бөгөөд энэрэнгүй.
8. Та нарт уналга хийгээд бахархал болгохоор морь, луус, илжигийг бүтээсэн. Аллах та нарын үл мэдэх олон юмсыг бүтээдэг юм.
9. Зөв шулуун замаар залах нь Аллахын мэдэлд баймуй. Замын зарим нь муруй, тойруу байдаг. Аллах таалах аваас хэн бүхнийг зөв шулуун замаараа хөтлөх болно.
10. Аллах та нарын төлөө тэнгэрээс хур буулгадаг. Та нар түүгээр ундаалж, түүгээр нь өөрийн газарт малаа бэлчээнэ.

11. Тэр та нарын төлөө үр тариа, чидун, дал мод, усан үзэм болон бусад олон үр жимсийг ургуулж өгдөг. Ухаарах хүмүүсийн хувьд энэ бүхэнд (Аллах буй бөгөөд агуу болоход нь) бэлгэдэж итгэх нотолгоо агуулагдаж байдаг.
12. Аллах та нарын төлөө өдөр-шөнийг, нар-сарыг, ододыг зарлигаараа захируулсан бөлгөө. Ойлгох хүнд ч гэсэн өдий төдий нотолгоо буй.
13. Тэрбээр газар дэлхий дээр зүсэн бүрийн өнгийн, зүйл зүйлийн юмсыг (амьтан, ургамлыг) та нарт үйлчлүүлэхээр бүтээсэн болой. Энд ч гэсэн бодох хүмүүст сургамж авах зүйл бий.
14. Мөн та нарыг загасны шинэ махаар хооллог гэж, сувд болон гоёл зүйлсийг гаргаж аваг гэж далай тэнгисийг эрхшээсэн. Түүний хайр энэрэлийг хүртэж, түүнд талархахын тулд тэнгис далайд усан онгоцууд давалгааг зүсэж хэрхэн урагшлахыг та нар харах болно.
15. Та нарыг бүү гуйваж дайваг хэмээн газар дэлхий дээр уулсыг бат бөх байршуулж, ашиглахад зориулж гол мөрөнг, төөрөгдүүлэхгүйн тулд зам харгуйг бүтээсэн.
16. Тэрчлэн элдэвийн тэмдэгүүдийг бүтээсэн. Шөнө зорчивол тэдгээрийг харж, оддоор баримжаалан замаа олох ажгуу.
17. Тэгэхлээр бүхнийг бүтээгч ба юуг ч эс бүтээдэг хиймэл бурхан хоёрыг зүйрлэж болно гэж үү? Хүмүүс үүнийг ч ухаарахгүй юм гэж үү?
18. Ийнхүү та нар Аллахын хайрласан хувь хишгийг хэзээ ч тоолж эс бармуй. Аллах машид ивээгч, нэн их энэрэгч билээ.
19. Аллах та нарын ил далд хийсэн бүхнийг мэдэж байдаг юм.
20. Хүмүүсийн Аллахтай эн зэрэгцүүлэн шүтсэн хиймэл бурхад нь юуг ч эс бүтээж чадмуй, өөрөө угаас зохиомолоор бүтээгдсэн амьгүй зүйл болой.
21. Тэр зохиомол бурхад нь амьгүй үхмэл зүйлс. Мөн тэдгээр нь хүмүүнийг хэзээ дахин амилахыг ч эс мэдэж чадмуй.
22. Хүмүүний бурхан нь цорын ганц билээ. Хойд насанд үл итгэгсэдийн зүрх сэтгэл үүнийг үгүйсгэдэг юм. Тиймээс тэд үл тоомсорлодог, их зантай байдаг.
23. Аллах тэдний ил, далд үйлдэл бүхнийг эргэлзээгүй мэдэж байдаг. Аллах биеэ тоогсдыг үл таалмуй.
24. Тэдэнд: “Танай хийсэн бурхад чинь та нарт юуг буулгасан бэ?” гэж асуухад тэд: “Улирагсадын үлгэр домогийг л” гэж хариулна.
25. Тиймийн учир ертөнцийн төгсгөлийн өдөр тэд өөрсдийн нүглийг бүрэн дүүрэн, харанхуй бүдүүлгээр өөрсдөө замыг нь алдуулагсадын нүглийн нэг хэсгийг үүрэх болно. Тэдэнд оногдсон нүгэл нь юутай муухай юм гээч!
26. Тэднээс өмнөх үл сүсэглэгчид ч гэсэн гэгээн элч нарыг мэхэлсэн юм.

- Тиймээс муу санаа шингэсэн орон байрыг сууриар нь нураахад дээвэр нь тэдний дээрээс дарсан билээ. Эзэнтний гэсгээл тэднийг санаандгүй шахуу ниргэсэн юм.
27. Улмаар сэхээрхүйн өдөр Аллах тэднийг зовлонд унагаан: “Та нарын надтай эн зэрэгцүүлсэн нөгөө бурхад чинь хаана байна? Энэ талаар та нар гэгээн элчүүдтэй маргалддаг биз дээ?” хэмээн асууна. Мэдлэгийн эзэд (гэгээн элчүүд болон эрдэмтэд): “Өнөөдөр эргэлзээгүй зовлон тарчилгаа бүхэн үл сүсэглэгсэдийг дайрах вий!” гэлцэнэ.
  28. Аллахын элч-мэлэк нар өөрөө өөртөө гай таригсадын амийг нь авах мөчид тэд хүлцэнгүй царайлан: “Бид ямар ч муу үйл үйлдээгүй шүү дээ” хэмээнэ. “Тийм биш ээ, та нарын юу үйлдэж асаныг Аллах чин үнэнээр нь мэддэг.
  29. Та нар эгнэгт үлдэх халуун тамын үүд хаалгуудаар орцгоогтун. Аллахыг үл зөвшөөрөн, их зан гаргагсадын очих газар юутай муухай юм!
  30. Сүсэглэгсдээс: “Эзэнтэн чинь та нарт юу хайрласан юм бэ?” хэмээн асуувал: “Сайн сайхныг” гэж хариулна. Сайн үйл үйлдэгсэдэд энэ ертөнцийн буян оногдоно. Хойд ертөнцөд ч бүүр сайхан баймуй. Үнэн сүсэгтнүүдийн орших газар нь юутай сайхан гээч!.
  31. Тэд хаяагар нь булаг урсдаг Гадн диваажинд очно. Тэдний хүссэн бүхэн тэндээс олдоно. Үнэн сүсэгтнүүдэд Аллах ийнхүү хүндэтгэл үзүүлэх авай.
  32. Тийм сүсэгтнүүдийг мэлэкүүд буянтай чигээр нь төрөл арилжуулан: “Та нарын амар амгаланг эрье? Буянт үйлийнхээ төлөө диваажинд орогтун” хэмээдэг болой.
  33. Үл сүсэглэгсэд зарлиг гүйцэтгэгч мэлэкүүд болон Аллахын зарлиг ирэхийг хүлээнэ гэж үү? Тэд нараас өмнөх буруу номтнууд ингэж л байсан. Аллах тэдэнд шударга бусаар хандаагүй, харин ч тэд өөрсдөө өөртөө л гай болсон.
  34. Тиймийн учир, тэд үйлдсэн хэргийнхээ төлөө гэсгээл үзсэн, доог тохуу хийсний хариуг амслаа.
  35. Үл сүсэглэгчид эцэст нь: “Хэрэв Аллах хүссэн бол бид, бидний өвөг дээдэс ч Түүнээс өөр хэнийг ч шүтэхгүй байх байсан, Түүний зарлиггүйгээр ямар ч юмыг бузарлахгүй байсан” гэнэ. Тэднээс өмнөх нь ч ингэдэг л байсан. Гэгээн элч нарын үүрэг нь шашны үзэл санааг уламжлах л явдал байлаа шүү дээ!
  36. Бид ард түмэн бүрт: “Аллахыг шүтэн мөргөгтүн, тагут буюу буг чөтгөр, шулам гэх мэтчилэн уруу татагсадаас ангид байгтун” хэмээн гэгээн элч нарыг илгээсэн. Ийнхүү Аллах тэдний заримыг зөв зам руугаа хөтөлсөн бол зарим нь төөрөгдөх ёстой байлаа. Тэгвэл газар дэлхийгээр хэрэн хэсүүчилж, (гэгээн элч нарыг) худал хуурмаг хэмээн үгүйсгэгчдийн хувь тавилан хэрхэснийг харатгун.

37. Аяа, Мухаммед! Чи тэр үл сүсэглэгсэдийг зөв замд оруулахыг хичнээн их хүссэн ч, Аллах өөрөө төөрөгдүүлсэн хүнээ өршөөхгүй бөгөөд тэдэнд туслагчид үл олдмуй.
38. Үл сүсэглэгсэд : “Аллах үхэгсэдийг дахин амилуулж чадахгүй!” хэмээн Аллахын нэр барин андгайлсан. Үгүй шүү, Аллахын амлалт чин үнэн (үхсэнийг амилуулна). Гэвч хүмүүний олонхи нь үүнийг ухаардаггүй юм.
39. Аллах тэдний төөрөгдсөн зүйлийг нь тэдэнд тайлбарлахын тулд, үл сүсэглэгсэдийн худал хуурмаг байдлыг өөрсдөд нь мэдүүлэхийн тулд үхэгсэдийг ийнхүү дахин амилуулдаг билээ.
40. Бид алив зүйлийг бүтээхийг хүсвэл, тэр тухайд гагцхүү “Бологтун!” хэмээн тушаавал даруй тэр ёсоор болдог юм.
41. Дарангуйлалд автсаныхаа дараа Аллахын төлөө дүрвэн нүүдэл хийгсэдийг Бид энэ хорвоогийн таатай газарт байршуулна. Хэрэв тэд мэддэгсэн бол хойд ертөнцөд эдлэх буян нь бүүр ч илүү байх болно.
42. Тэд их нүүдэл хийгээд хатамжлан хичээн гэвчигсэд бөгөөд Эзэнтэндээ итгэн найдагсад билээ.
43. Аяа, Мухаммед чамаас өмнө Бид гагцхүү эрэгтэйчүүдийг өөрсдөд нь айлдвар буулгаж, гэгээн элчээр илгээсэн билээ. Хэрэв үүнийг эс мэдэх аваас мэргэн ухааны эздээс (Таурат, Инжил судрыг уншсан хүмүүсээс) асуугтун.
44. Гэгээн элчүүдийг ер бусын нотолгоонууд болон ариун судруудын хамт илгээсэн юм. Хүмүүнд илгээгдсэн хэм хэмжээнүүдийг (шариятын ёс суртахууныг) чамд ч гэсэн тодорхой тайлбарлуулаг, бас тэднийг ухаарч ойлгог хэмээн Бид чамд энэхүү Кураныг буулгасан билээ.
45. Элдэв аргаар ов мэх гаргагсад Аллах өөрсдийг нь газрын гав руу оруулахаас, гэнэтийн тохиолдлоор ямар нэгэн гэсгээл буухаас айдаггүй юм у?
46. Аль эсвэл тэд зорчин явахдаа ч гай барцаг тохиолдохоос айдаггүй гэж үү? Тэд алив цэрлэлээс зугатаж мултрахгүй ээ!
47. Эсвэл, азгүй тохиолдлоор өөрсдөө айж балмагддаг аймшигтай гэсгээлтэй учрахаас айдаггүй гэж үү? Эзэнтэн чинь (боолуудаа гэсгээн цэрлүүлэхэд яардаггүй) нэн их өрөвч бөгөөд бас онцгой энэрэнгүй билээ.
48. Тэд Аллахын бүтээсэн алив зүйлсийн сүүдэр нь хүртэл Аллахад сөгдөн мөргөж, баруун, зүүнгүй мэхийн ёсолж буйг хардаггүй гэж үү?
49. Тэнгэр, газар дээрх алив амьд бүхэн хийгээд мэлэкүүд их зан гаргахгүйгээр Аллахад сөгдөн мөргөмүй.
50. Тэд Эзэнтнээс айж эмээн, өөрсдөд нь тушаагдсан бүхнийг ёсоор үйлдмүй.



51. Аллах: “Хоёр бурханд бүү сүсэглэгтүн. Аллах цорын ганц болой. Тиймээс надаас айтгун” гэж айлдмуй.
52. Тэнгэр, газар дээрх алив бүхэн зөвхөн Аллахын мэдэлд баймуй. Сүсэг, залбирал ямагт Аллахад зориулагдана. Тийм байхад Аллахаас өөр хэнээс айдаг вэ?
53. Та бүхэнд буй буян хишиг бүхэн зөвхөн Аллахын зүгээс болой. Хэрэв гай барцат тохиолдвол бас л Түүнд залбирцгаагтун.
54. Тэгээд та нарт тохиолдсон гай түйтгэрээс Аллах та нарыг аварсан атал хүмүүсийн зарим нь даруй Түүнийг бусадтай эн зэрэгцүүлэхийг яана?
55. Бидний өөрсдөд нь заяасан буян хишгийн хариуд тэд залбирахгүй, ач тус мэддэггүй юм. Тийм л юм бол эд хөрөнгөнийхөө цэнгэлийг түр эдэлж л байгаарай, эцэст нь юунд хүргэхийг удахгүй мэдэх цаг ирмүй.
56. Мөн тэд Бидний өөрсдөд нь хүртээсэн хувь хишгээс юу ч мэдэхгүй, зохиомол бурхадад хувь оноодог. Аллахын нэрээр ангдайлая. Та нар санаагаараа зохиосон юмныхаа төлөө заавал шүүгдэх болно.
57. Тэд: “Мэлэкүүд бол Аллахын охид” хэмээн гүтгэж, тэр “охидыг” их бүтээгчид хамааруулна. Аллах эл гүтгэлээс ангид. Мухар сүсэгтнүүд таалсаныгаа (хөвгүүдийг) өөртөө өмчлөнө.
58. Харин, тэдний хэн нэгэнд эхнэр чинь охин төрүүллээ хэмээн мэдэгдвэл баярлахын оронд баргар царайлан бухимдана.
59. Хүргэсэн мэдээ таалагдаагүйгээс бусдын нүүр руу харж чадахгүй зайлсхийнэ. Өөрийгөө шившиг болгон түүнийг асрах уу? аль эсвэл шороонд булах уу? ” хэмээн бодолд дарагдана. Эд нарын шийдвэр юутай муухай юм вэ?
60. Хойд ертөнцөд үл итгэгсэдийн дүр төрх дээр дурдасны адил муухай. Харин эрхэмсэг сайн шинж Аллахад зохимой. Тэр хүчирхэг бөгөөд мэргэн ухааны эзэн билээ.
61. Хэрэв Аллах хүмүүнийг үйлдсэн хэргийн төлөө тэр дор нь шийтгэвэл газар дэлхий дээр нэг ч амьд амьтан эс үлдэх асан бөлгөө. Гэвч тэднийг тодорхой хугацаагаар хойшлуулах бөгөөд гэсгээх цаг нь ирсэн мөчид өчүүхэн ч хугацаагаар ухраах буюу түргэсгэх боломжгүй.
62. Тэд өөрсдийнхөө үл таалах юмыг (охицыг) Аллахад хамааруулж, сайхан бүхнийг (хөвгүүдээ) өөрсдийнх нь хэмээн худлаа цуурдаг. Ямар ч эргэлзээгүй тэд тамд хаягдаж, тамын халуун галд шатна.
63. Аяа, Мухаммед! Аллахын алдраар андгайлая! Бид чамаас өмнө ч олон ардад гэгээн элч нарыг илгээсэн юм. Харин чөтгөр шулам тэдний бузар булай юмнуудыг гоё харуулж, уруу татсан. Тэр (чөтгөр) өнөөдөр ч тэдний анд хэвээрээ. Тэдний хувьд зовлонт гэсгээл байх болно.
64. Аяа, элч минь! Бид чамд Куран судрыг гагцхүү тэдний маргалдаж буй юмыг тайлбарлуулахын тулд, мөн сүсэглэсэн ард түмэнд зөв зам, энэрэл хайр өгүүлэхийн тулд буулгасан болой.

65. Аллах тэнгэрээс хур буулгаж, үхмэл газрыг дэвтээн амилуулдаг. Энд ч гэсэн ухаарах хүмүүст сургамж авах нотолгоонууд бий.
66. Эргэлзээгүй, мал амьтны хувьд ч та нарт сургамж болох зүйл байдаг. Бид тэдгээрийн цус, сэвс хоёрын завсараас нь ялгаран гарах цэвэр ариун, ашиг тустай сүүг та нарт уулгадаг юм.
67. Дал модны үр жимс хийгээд усан үзэмээс та нар дарс ба сайхан ундаа бэлтгэдэг. Ухаарах хүний хувьд энд ч гэсэн өч төчнөөн нотолгоонууд бий.
68. Эзэнтэн чинь зөгийд хандан ийн айлдана: “Уул хад, мод бут хийгээд хүмүүс зориуд бэлтгэсэн үүрнүүдийг өөртөө үүр болго.
69. Дараа нь элдэв үр жимсийг амталж, хүлцэнгүйгээр Эзэнтнийхээ замаар нисэгтүн” гэнэ. Түүний ходоодноос хүмүүст эм болох янз бүрийн өнгөтэй бал ялгарна. Үүнд ч хүмүүний сургамж болох нотолгоо бүхий анагаах шид бий.
70. Аллах та нарыг бүтээж, дараа нь цаг нь болоход үхүүлэн авч одмуй. Та нарын зарим нь эхлээд эрдэм мэдэж, дараа юуг ч мэдэхгүй болж амьдралын хэрэгцээгүй шатанд (өвгөрч зөнөх) хүрэх болно. Эргэлзээгүй, Аллах аугуу мэдлэгийн эзэн, машид хүчирхэг болгоо.
71. Аллах та нарын нэгнээс нөгөөд нь амьдралын хишгийг илүү хүртээсэн. Амьдралын хишгийг илүү хүртэгсэд өөрсөдтэйгээ адил болгохгүйн тулд хувь хишгээсээ гар доорх хүмүүст өгдөггүй юм. Тэд Аллахын хувь хишгийг үгүйсгэх гэж үү?
72. Аллах та нарт хань ижил хайрлаж, ханиасаа үр хүүхэд, ач зээ өгч, цэвэр ариун зүйлээр хангалаа. Ийн атал тэд хий хоосон бурханд итгэж Аллахын хайр энэрэлийг үгүйсгэх гэж үү дээ?
73. Буруу номтнууд Аллахыг зөнд нь орхиод тэнгэр газраас өөрт нь ямар ч хувь хишиг олж өгч үл чадах зүйлсэд (зохиомол бурхадад) итгэн сүсэглэдэг.
74. Аллахтай өөр юмыг бүү эн зэрэгцүүл, Аллах бүхнийг мэднэ, харин та нар мэдэхгүй.
75. Аллах, ийм нэгэн жишээг илгээж байна. Үүнд: Юуг ч, яаж ч үл чадах бусдын эрхшээлд буй нэгэн боол ба биднээс сайхан хувь хишиг оногдсон, түүнээсээ ил, далдаар өглөг өгдөг (эрх чөлөөтэй) хүн хоёр адил уу? Үнэндээ бүхий л магтаал Аллахад зохимой. Гэвч буруу номтнуудын олонхи нь үүнийг ойлгодоггүй.
76. Аллах бас л энэхүү хоёр хүнийг жишээ болгож байна: “Тэдний нэг нь хэлгүй, юу ч хийж чадахгүй, тэр бол эзэндээ дараа болхоос цаашгүй. Түүнийг хаана явуулсан ч юу ч бүтээж ирдэггүй. Нөгөө хүн нь зөв шулуун замаас гаждаггүй, бусдыг шударга байхыг шаарддаг нэгэн. Ийнхүү энэ хоёр адил гэж үү? (Хиймэл бурхадыг Аллахтай зүйрлэх нь үүнтэй ижил ажгуу)

77. Аллах тэнгэр, газрын нандин нууцыг эзэгнэдэг болой. Ертөнцийн төгсгөл нь нүд ирмэхийн зуур, эсвэл түүнээс ч түргэн тохиомуй. Эргэлзээгүй, Аллах алив бүхнийг эрхшээгч мөн.
78. Аллах та нарыг эхийн хэвлийгээс юу ч мэдэхгүй байдалтай гаргаад, талархан залбируулахын тулд чих, нүд, бодол санаа хайрласан юм.
79. Тэд тэнгэрийн уудамд нисч буй шувууг харахгүй байна гэж үү? Тэдгээрийг Аллахаас өөр хэн ч тогтоон барьж чадахгүй. Энүүнд ч гэсэн бишрэн сүсэглэгчдэд (Аллахыг таниулах) сургамж нотолгоонууд буй.
80. Аллах та нарт орон гэрийг тав тухтай сууц болгов. Та нарыг нүүж суухад хөнгөн тохиромжтой болгон малын арьсаар сууц төхөөрөн өгч, малын ноос, унгас, хялгасаар ахуйн нэг хэсэг хэрэглэх эд зүйл хийгээд арилжаа наймааны хэрэгслийг бүтээн өглөө.
81. Аллах өөрийн бүтээсэн зүйлээр та нарт зориулан сүүдрэвч хийж, уулсын дунд хоргодох газар, агуй бэлтгэн өгч, халуунаас аврах хувцас, дайн тулааны цагт хамгаалах хуягт өмсгөл өгсөн. Та нарыг Өөрт нь итгэн сүсэглэгч хэмээн ийнхүү хувь хишгээрээ шагнасан юм.
82. Аяа, Мухаммед! Тэд чамаас урван нүүр буруулсан ч Чиний үүрэг бол гагцхүү бидний шашны судрыг яруу тод хүргэх явдал мөн.
83. Тэд Аллахын тусыг хүлээн зөвшөөрдөг атал дараа нь үгүйсгэцгээдэг. Тэдний олонхи нь үл сүсэглэгч, буруу номтнууд мөн.
84. Ертөнцийн төгсгөлд шүүгдэх өдөр Бид ард түмэн тус бүрээс гэрч авч ирнэ. (Тэдний сүсэгтэн, үл сүсэгтэн эсэхийг гэгэээн элч нар нь гэрчлэнэ.) Тэр цагт үл сүсэглэгчдэд тайлбар хэлж, сайн үйл үйлдэх хэмээн хичээсэн ч зөвшөөрөл үл олгогдоно, тэд уучлал гуйх явдал ч шаардагдахгүй.
85. Харгис зальхай этгээдүүд гэсгээгдэхэд түүнийг нь эс хөнгөлмүй, хугацаа нь ч үл хойшлогдмуй.
86. Үл сүсэглэгчдэд Аллахтай эн зэрэгцүүлсэн зүйлсээ хараад: “Аяа, Эзэнтэн минь! Эд нар бол бидний Чамтай эн зэрэгцүүлсэн өнөөх бурхад юмаа” гэлцэнэ. Харин цаадуул нь : “Та нар жинхэнэ худалчид юм” хэмээн очинө.
87. Тэр өдөр тэд Аллахад итгэсэнэ харуулахыг оролдовч хуурамч сүсэглэл нь аяндаа илэрч үгүйсгэгдэнэ.
88. Үл сүсэглэн, Аллахын замаас бусдыг төөрөгдүүлэгчдэд бузар булай хэргийн төлөө Бид гэсгээл дээр нь гэсгээл нэмэх болно.
89. Бид тэр өдөр ард зон бүлгийн дотроос нь нэг гэрч гаргаж ирнэ. Аяа, Мухаммед, чамайг ч тэдний гэрч болгоно. Бид чамд алив бүхнийг ил тод тайлбарлах, мусулманчуудад зөв зам мөрийг заах, баярт мэдээ хийгээд хайр энэрэл болох энэхүү Куран судрыг буулгасан болой.
90. Эргэлзээгүй, Аллах та нарт шударга байхыг, сайн үйл хийхийг, ах дүү

- хамаатан садандаа туслахыг зарлигдмуй. Харин ичгүүр сонжуургүй, садар самуун, ад үзэгдэх явдал, хүчирхийлэлийг бүрэн хориглоно. Та нарыг сургамж аваг хэмээн ийн ухуулан сэнхрүүлнэ.
91. Та нар Аллахад амлалт өгсөн бол түүнийгээ сахигтун. Ийнхүү та нар Аллахийг гэрч болгож андгай тангараг тавьсан болохоор түүнийгээ бүү зөрчигтун. Аллах та нарын хийж буй бүхнийг сайн мэднэ.
  92. Нэг омог аймаг нөгөөгөөс хүний тоо болон мал хөрөнгөөр давуу болсны төлөө (өмнөх эвлэлдсэн омогийг орхин, өөр омогтой эвлэлдэхийн тулд) тангараасаа няцан, эрчилсэн утсаа эргэж задалсан эхнэр луугаа адил бүү бологтун. Аллах та нарыг ийнхүү сорьж, маргалдаж, зөрөлдсөн асуудлыг чинь Ертөнцийн төгсгөлийн тэр өдөр тодорхой тайлбарлаж өгнө.
  93. Хэрэв Аллах хүссэн бол та нарын бүгдийг нэг л ард болгох байсан. Гэвч Тэр хүссэнийгээ төөрөгдүүлж, хүссэнийгээ зөв шулуун замаар хөтөлмүй. Тэгээд хийсэн үйл бүхэндээ байцаагдах болно.
  94. Та нар андгай тангарагаасаа няцахыг өөр хоорондын ов мэх бүү болгогтун. Тэгэх аваас итгэл бишрэлийн замаасаа хальгирч, мөн хойд ертөнцийн хүнд гэсгээлтэй учирна.
  95. Аллахад өгсөн андгай тангарагаа өчүүхэн зүйлээр бүү арилжигтун. Хэрэв мэддэгсэн бол Алладын буян хишиг та нарын хувьд эд хөрөнгийн ашгаас хавьгүй өлзийтэй билээ.
  96. Та нарт буй бүхэн, амьд ахуйн эд баялаг барагдмуй. Харин Алладын нигур дор буй бүхэн үүрд оршмуй. Бид хатамжит тэвчээртэн нарыг хийж буй зүйлээс ч илүү юмаар шагнах болно.
  97. Эр ч бай, эм ч бай, Мусулман болж, сайн үйл хийвэл, тэдний ахуй амьдралыг өөд нь татаж, хийж бүтээснээс ч илүү шан харамжаар урамшуулах болно.
  98. Аяа, Мухаммед! Куран уншихын цагт чулуунд хөөгдсөн чөтгөр шуламаас (түүний уруу татахаас) аврагтун хэмээн Аллахад залбир.
  99. Үнэндээ Эзэнтэндээ сүсэглэж, зөвхөн Түүнд найдвар тавигсадыг чөтгөр шулам захиран эрхшээж эс чадмуй.
  100. Түүний эрх мэдэл зөвхөн өөрийг анд хэмээн үзэж, (Аллахтай) бусдыг эн зэрэгцүүлэгсэд л үйлчлэх болно.
  101. Бид (Аллах) нэг айлдварыг нөгөөгөөр нь солиход -Аллах юуг айлдсаныг өөрсдөө мэдэх болно- Тэд гэгээн элчид: “Чи жинхэнэ гүтгэгч юм” хэмээцгээдэг. Үгүй ээ, тийм биш. Тэдний олонхи нь ойлгодоггүй ард олон юм.
  102. Аяа, Мухаммед! “Тэдэнд Кураныг өөрийнхөө Жабрейл элч мэлэкээр сүсэгтнүүдийн итгэлийг багатгахын тулд, мөн тэдэнд зөв зам, баярт мэдээ болгон, чин үнэнээр буулгасан” хэмээн хэл.
  103. Бид тэдний (үгүйсгэгсэд) “Кураныг Мухаммедэд нэг хүн заадаг” гэсэн

- үгийг мэдэж байгаа. Тэдний хэлээд буй хүн нь харийн хэлтэй. Куран бол яруу тод Араб хэл дээр билээ.
104. Алладын айлдваруудад үл итгэгсэдийг Аллах өршөөхгүй. Тэдэнд зовлонг гэгсгээл оногдмуй.
105. Гагцхүү Алладын айлдваруудад үл итгэгсэд л түүнийг гүтгэдэг. Чухам, тэд л жинхэнэ худалчид мөн.
106. Хэн нэгэн сүсэглэснийхээ дараа итгэл алдран Алладын үгүйсгэвэл, эсвэл биеэ тоон сагсуурч сайн дураар буруу номтон болвол, тэр Алладын хилэгнүүлэн хүнд цээрлэл үзнэ. Харин сэтгэлээрээ итгэн сүсэглэсний дараа бусдын шахалтаар хүчээр дээрх байдалд ороход хүрвэл Алладын гэгсгээлд хамааралгүй болно.
107. Энэ нь хойд насны буянаас энэ хорвоогийн амьдралыг илүүд үзсэнээс үүдэлтэй юм. Эргэлзээгүй, Аллах үл сүсэглэгсэдийг зөв зам руу үл хөглөх бөлгөө.
108. Анхаарагтун! Аллах тэдний зүрх сэтгэлийг хааж, мэлмийг боож, сонголыг нь битүүлчихсэн болой. Тэд юуг ч анзаарахгүй байгаа.
109. Ямар ч эргэлзээгүй хойд ертөнцөд зовлон үзэх болно.
110. Аяа, Мухаммед! Үүний дараа хөөгдөж туугдан Мадинад дүрвэн нүүгсэдэд, дайнд оролсогсодод, хүнд хүчрийг тэвчигсэдэд Аллах өөрөө тусална. Эзэнтэн тэднийг маш ихээр ивээгч, нэн энэрэгч байх болно.
111. Ертөнцийн төгсгөлийн өдөр хүн бүр өөрийгөө хамгаалахыг оролдоно. Түүний зэрэгцээгээр хүн бүрт хийсэн үйлийн төлөө хариу хүртгээх бөгөөд тэдэнд муу юм (шударга бус явдал) хийхгүй.
112. Аллах нэгэн сууринг (Меккег) ийнхүү жишээ болгов. Энх амгалан энэ сууринд оршин суугчдад тал бүрээс элбэг дэлбэг буян хишиг ирдэгсэн. Гэвч түүний оршин суугчид Алладын хайр хишгийг үл тоомсорлож, Аллах хайрласныг мэдэрсэнгүй. Аллах, үүний хариуд нь тэдэнд өлсгөлөн, айдас, түгшүүр нөмрүүлэв.
113. Тэдэнд дотроос нь гэгээн элчээр Мухаммед ирэхүйд түүнийг үгүйсгэв. Тэд харгис зальхай байсны төлөө гэгсгээлийн галд шатах болно.
114. Аллахаас та нарт хайрласан хувь хишгийн цэвэр ариуныг нь идэгтүн. Хэрэв, та нар зөвхөн Алладах сүсэглэн залбирвал түүний хувь хишигт талархагтун.
115. Аллах та нарт: үхсэн амьтны сэг, цус, гахайн махыг мөн Аллахаас бусдын нэрээр алсан амьтныг харам буюу бузар хэмээн хориглов. Гэхдээ хэн нэгэн амьд үлдэхийн эрхээр аргагүй байдалд хүрвэл өл залгах төдий идэж, хэрээс үл хэтэрвэл Аллах өршөөнө, энэрэнгүй байна.
116. “Энэ Халал, тэр хараам” хэмээн амны зоргоор бүү яригтун! Хэрэв тэгвэл гүжирдсэнд тооцмуй. Алладын нэр барьж худал хэлсэн хүмүүс авралыг эс үзэн, зорьсондоо хүрэхгүй.

117. Тэдний хувьд амьд ахуй цагийн өчүүхэн жаргал, хойд ертөнцийн хатуу гэсгээл буй.
118. Аяа, Мухаммед! Урьд нь тайлбарласнаа Иудейчүүдэд ч хориглосон болой. Бид тэдэнд шударга бусаар хандаагүй, гагцхүү тэд өөрсдөө өөртөө зальхай үйлдэл хийсэн юм.
119. Эс мэдэхийн улмаас муу үйл үйлдэж дараа нь гэмшиж залбиран, сайн үйлээр гэмээ цайруулсан хүнийг Аллах өршөөх болно. Эзэнтэн үнэндээ уучлана, энэрнэ.
120. Ибрахим үнэхээр Аллахад итгэн биширсэн, чин үнэнээр сүсэглэсэн удирдагч билээ. Тэр хэзээ ч зохиомол бурхан шүтэгсэдийн нэг нь байгаагүй юм.
121. Тэр бол Аллахын энэрэл хайранд талархагч асан билээ. Тиймээс Аллах түүнийг гэгээн элчээр сонгон авч, зөв замаар залсан.
122. Бид түүний энэ насанд нь сайн сайхныг хайрласан, хойд насандаа ч эрхэм дээдсийн дунд байлгах болно.
123. Аяа, Мухаммед! Дараа нь бид чамд: “Чин үнэн шашинд итгэсэн Ибрахимын мөрийг хөө! Аллахтай бусдыг эн зэрэгцүүлэгсэдээс тэр ангид байсан хэмээн айлдсан бөлгөө.
124. Бямба гарагийн талаар маргалдагсдад, Иудэйчуудад тэр өдрийг хүндэтгэлтэй өдөр болгов. Гэхдээ, тэд юуны төлөө зөрөлдөж асаныг Эзэнтэн гарцаагүй дахин амилахуйн өдөр шүүн тунгаамуй.
125. (Аяа, элч минь!) Эзэнтний зам руу мэргэн ухаан хийгээд яруу сонсголт ухуулга сэнхрүүлгээрээ уриалагтун! Тэдэнтэй ухаалаг нотолгоотойгоор мэтгэлцэгтүн. Эзэнтэн хэрэг дээр замаасаа төөрөлдөгсөдийг сайн мэдмүй. Бас зөв шулуун замаар замнаж буйг ч илүү сайн мэдмүй.
126. Хэрэв та нар дайснаас өш авахыг хүсвэл, өөрсдийн хохирсон хэмжээгээр тооцоо бод! Хэмээс бүү хэтрүүлэгтүн. Харин тэвчин өнгөрүүлвэл тэвчээртнүүдэд илүү өлзийтэй билээ.
127. Аяа, Мухаммед тэвчигтун! Чиний тэвчээр гагцхүү Аллахын ач тусаар бүтнэ. Тэдний тухайд сүсэглэн залбирсангүй хэмээн гуних хэрэггүй. Тэдний муухай ов мэхэнд бүү бачимдагтун.
128. Аллах үнэхээр сайн үйл үйлдэгсэд хийгээд үнэн сүсэглэгсэдтэй хамт байгаа.

## 17.СУРЕ ИСРА

Мекке-д илгээгдсэн. 111 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Нэгэн шөнө Аль-Харамас эргэн тойрондоо буян хишиг хурсан Аль-Акса мэсжидад (сүмд) өөрийн үнэнч боол Мухаммед гэгээн элчийг шилжүүлэн суулгасан Аллах нь чин ариун билээ. Энэ нь түүнд бидний ер бусын гайхамшигуудыг харуулахын төлөө байлаа. Аллах үнэхээр бүхнийг сонсож, харж байдаг юм.
2. Бид Муса-д Таурат судрыг хайрлаж, түүнийг Израйлын зон олонд зам мөрийг заагч, удирдагч болгон : “Надаас бусдыг Эзэнтэн хэмээн бүү үзэгтүн” гэж захилаа.
3. Аяа, Нухтай хамт (усан онгоцонд) суулгасан хүмүүсийн үр садаа аа! Нух бол үнэхээр олонтой талархан биширсэн боол асан байсан юм.
4. Бид ариун судартаа Израйлын үр садад: “Та нар даян дэлхийд (Палестиний нутагт) багтай мэдээгээр хоёр удаа самуун дэгдээж, хэмээс хэтэрч дур зоргоор авирласан” хэмээн мэдэгдсэн билээ.
5. Эхний үймээний үеэр Бид та нар руу хүчирхэг хүмүүсээ илгээсэн. Тэд гэр орныг чинь нэгжиж шалгасан нь зүй ёсны үйлдэл болов.
6. Дараа нь та нарыг тэднээс давуутай болгон мал хөрөнгө, үр хүүхэд хайрлан, хүн амын тоог нэмэгдүүлсэн.
7. Израйлын үр сад аа! Хэрэв, буян үйлдэх аваас өөрсдөдөө л буян үйлдсэнд тооцогдмуй, харин муу үйл үйлдэх аваас өөрсдөдөө л муу үйл үйлдсэн хэрэг болно. Ийнхүү хоёр дахь гэгсгээл ирэхүйд Бид та нарын нүүрийг салам урж, бас өмнө нь орсон шигээ Байтул Макдис сүм рүү бас л орог, эзэлж авсан газрыг түйвээг хэмээн хүчирхэг боолуудаа дахин илгээсэн юм.
8. Эзэнтэн магадгүй та нарыг өршөөнө, дахин үймээн самуун хийвэл дахин гэгсгээн цээрлүүлэх болно. Тэгээд халуун тамыг үл сүсэглэгчдийн төлөө шорон гяндан болгосон болой.
9. Энэхүү Куран нь хүмүүнийг эргэлзээгүй хамгийн зөв зам руу хөтөлдөг. Сайн үйл бүтээсэн сүсэгтэн нарт асар их буян байгаа тухай баярт мэдээг дуулгана.
10. Харин хойд ертөнцөд үл итгэгсдэд зовлонт гэгсгээл зэхсэн болой.
11. Хүн гэдэг амьтан сайн сайхныг хүсч залбирахын адил, бухимдан уурлахдаа муу муухайг өөрлүүгээ хандуулдаг. Хүн ер нь яаруу амьтан шүү дээ.
12. Бид өдөр, шөнө хоёрыг ид шидийнхээ хоёр бэлгэдэл болгон бүтээсэн

- юм. Эзэнтнийхээ хувь хишгийг хайж, он жилийн тоог хийгээд тооцоолж мэдэхийн тулд шөнийн харанхуйг бүдэг болгож, өдрийг гэрэл гэгээтэй болгосон. Ингэж Бид бүхнийг шашин ба амьдралын тухай яруу тодоор тайлбарласан билээ.
13. Бид хүн бүрийн үйлдлийг өөрсдийн хүзүүнд нь тохож, (хүзүүнд юм зүүсэн шувуу мэт) хойд ертөнцийн өдөр түүнийг хувь хүний үйлийн дэвтэр болгон дэлгэж үзүүлнэ.
  14. Тэр мөчид: “Үйлийнхээ дэвтэрээ унш! Өнөөдөр чи өөрөө өөртөө гэрч болоход хангалттай” хэмээгдэх болно.
  15. Хэн зөв шулуун замыг сонгох аваас өөрийнхөө сайн сайхны төлөө сонгоно. Харин хэн төөрөгдөлд орно, түүний хор хөнөөлийг өөрөө хүлээнэ. Бусдын нүглийг өөр хүн үүрэхгүй. Бид гэгээн элч илгээхгүйгээр хэнийг ч гэсгээхгүй.
  16. Бид аль нэгэн хотыг сүйтгэхийг хүсэх аваас тэндэхийн эрх дархтануудад Алладын зарлигийг дагахыг тушаана. Тэгтэл гэд зарлигаа зөрчиж танхайрдаг. Тиймээс тэднийг цээрлүүлэхэд хүрнэ. Тэгээд тэднийг бүрэн сүйрүүлнэ.
  17. Бид Нухаас хойш гэгээн элч нарыг хүлээн зөвшөөрөөгүй олноос бишгүй л сөнөөсөн. Эзэнтэн боолуудын нүглийг харж мэдэж байдаг билээ.
  18. Хэн нэгэн зуурдын амьдралыг хүсэх аваас бид ч таалсан хүндээ хүссэн бүхнээ өгөх болно. Дараа нь түүнийг Алладын буян хишгээс хүртэлгүй хоцорсон дорд амьтан болгон, халуун тамд оруулан гэсгээнэ.
  19. Харин хэн нэгэн хойд ертөнцийг (диваажинг) хүсэж, үнэнч сүсэгтэн ёсоор л хойд насны буянт үйлийн төлөө зүтгэвэл тэдгээрийн хичээл зүтгэлийг талархан хүлээн авах болно.
  20. Амьд ахуйн зуурдын жаргалыг хүсэгчдэд ч, хойд насны буяныг хүссэн тэдэнд ч Эзэнтний зориулсан зүйлийг өгмүй. Эзэнтний чинь буян хишиг хязгааргүй билээ.
  21. Бид хүмүүсийн нэгийг нь нөгөөгөөс давуутай болгосныг харагтун. Үнэндээ хойд ертөнцийн эрх ямба хамаагүй илүү бөгөөд олон давуу чанартай.
  22. Аллахаас бусдыг бүү бурхан хэмээгтүн. Тэгвээс дорд үзэгдэн, хоосон хоцорно.
  23. Аллах бусдад биш, зөвхөн өөрт нь сүсэглэн залбирахыг, мөн эцэг эхдээ халамжтай байхыг зарлигдсан болой. Хэрэв тэдний нэг нь буюу хоёулаа чиний гар дээр нас өтлөх аваас тэдэнд “Түй” гэж бүү хэл. Тэднийг бүү зэмэл, эвлэг сайхан харилц.
  24. Нигүүлсэх сэтгэлээр хандан: “Эзэнтэн минь ээ, тэд намайг нялх балчираас минь энхрийлэн өсгөсөн лүгээ адил, Чи ч тэднийг энэрэлдээ багтааж, болгон соёрхогтун?!” хэмээн залбир.



25. Хэрэв, та нар өгөөмөр эрхэм хүмүүс байвал сэтгэлд чинь юу буйг Эзэнтэн чинь сайн мэднэ. Тэр үнэхээр талархан залбирсаныг ивээнэ.
26. Төрөл садандаа зохих юмыг нь өгөгтүн. Ядуус, холын аян замд явагсадад өглөг өгөгтүн. Гэхдээ үрэлгэн байж болохгүй.
27. Үрэлгэнчүүд бол чөтгөр шуламын ахан дүүс. Харин чөтгөр шулам Эзэнтний эсрэг бөгөөд харалган хоцрогч мөн.
28. Хэрэв чи Эзэнтний өгөөмөр хишгээс горилсоор л боломжгүйгээс (буяны өглөг өгч чадаагүй) харж үзэж эс чадваас тэдэнд элэгсэг ханд.
29. Алагаа тэнийлгэдэггүй харамч бүү бай, бас алагаа байдгаараа дэлгэн бүү үрэлгэн бол. Тэгвэл хожим харамсаж, тарчиг амьдрахад хүрнэ.
30. Эргэлзээгүй, Эзэнтэн таалсан хүндээ өгөөмөр хувь хүртээдэг, мөн хүссэн хүндээ хэр хэмжээтэйг өгнө. Тэр боолуудаа бүрэн мэддэг, бас сайн харж байдаг.
31. Тарчиг амьдарлын эрхээр үр хүүхдээ бүү хөнөөгтүн. Бид тэднийг ч, та нарыг ч ивээнэ. Тэднийг алах нь асар хүнд нүгэл мөн.
32. Зина буюу садар самуунд бүү автагтун. Энэ бол ёс бус, ичгүүр сонжуургүй, бузрын зам болой.
33. Алладын олгосон эрхээс гадуур хүний амийг бүү егүүтгэгтүн. Хэрэв хэн нэгэн шударгуу бусаар алагдсан ахул түүний ойрын төрлийнхөнд Бид эрх өгсөн. (Зүй ёсоор өш авах, амины төлөөс нэхэх, эсвэл уучлан өршөөх эрхийг Аллах өгсөн.) Хэрэв өш авч хариу егүүтгэхээр бол хэмээс бүү хэтрэг (хүн амины хэрэгтнээс бусдад бүү халдагтун. Алуурчны бие эрхтэнг тарчилгаж эс болно.) Үнэндээ хохирогчийн ар нь Алладын тусыг хүртэх болно.
34. Өнчин өрөөсний мал хөрөнгөнд бүү халдагтун. Харин тэд насанд хүрэх хүртэл зөвхөн өөрт нь зохистойгоор, ашигтайгаар зарцуулж болно. Амлалтандаа үнэнч байгтун. Амлалтын үр дүнг хойд ертөнцөд тооцох болно.
35. Алив юмыг авч өгөлцөхдөө бүрэн төгс, үнэн зөв хэмжиж тооцоорой. Энэ нь илүү сайн, эцэстээ илүү өлзийтэй байх юм.
36. Мэдэхгүй юмтай бүү оролд! Мэдэхгүйг мэднэ, сонсоогүйг сонссон, хараагүйг харсан хэмээн бүү хэл! Эцсийн өдөр чих, нүд, сэтгэл зүрх бүгд байцаагдах болно.
37. Хаа газар бүү бардаж онгир. Тэглээ гээд л газрыг сэт цохиж эс чадна. Өндрөөрөө уултай эн зэрэгцэж чадахгүй.
38. Энэхүү муухай бүхнийг Эзэнтэн чинь таалдаггүй, ад үздэг юм.
39. Ийнхүү эдгээр нь Эзэнтэн чамд айлдсан мэргэн ухаан болой. Аллагаас өөр ямар ч юмыг бурхан хэмээн бүү бод! Эс тэгвээс шийтгүүлэн, Алладын ивээл нигүүлслэлээс гадна хоцорч, халуун тамд хаягдах болно.

40. Эзэнтэн та нарт зөвхөн хөвгүүдийг заяаж, мэлэкүүдээ өөрийн охид болгон авсан гэж үү? Тийм биш ээ, та нар мэдэхгүйгээр үнэхээр дур зоргоор ярих юм.
41. Тэд сургамж авах гэж Кураныг дахин тайлбарлалаа. Гэвч энэ нь үл сүсэгтнүүдийг улам гаарууллаа.
42. Аяа, Мухаммед тэдэнд: “Хэрэв тэдний хэлсэнчлэн Аллахтай эн зэрэгцэх өөр бурхан байсансан бол тэд тэнгэрийн эзэн Аллахаас илүү байхын тулд өөр нэгэн зам хайх байсан шүү дээ!” хэмээн хэлэгтүн!
43. Аллах тэдний хэлснээс тэс ондоо, чин ариун, агуу эрхэмсэг оршмуй.
44. Долоон давхар тэнгэр, газар болон тэнд орших бүхий амьд амьтад Аллахаг чин ариун хэмээн үздэг ба Түүнийг эс магтагчид ер үгүй болой. Гэвч та нар тэдгээрийн сайшаал магтаалыг эс ойлгомуй. Аллах үнэхээр аугаа, уян зөөлөн бөгөөд машид өршөөгч билээ.
45. Аяа, Мухаммед! Чи Куран уншихуйд хойд ертөнцөд үл итгэгсэд ба та нарын хооронд бид далд хөшиг татах болно.
46. Тэгээд Бид тэднийг Кураныг эс ойлгохоор болгон, итгэлийг нь алдагдуулан, чихийг нь дүлий болгосон. Чи Куранд Эзэнтнийхээ тухай дурсахад тэд уцаарлан зугтацгаана.
47. Чамайг Кураныг уншихдаа тэд хэрхэн сонсож буйг, мөн чамд чих тавих үеэр өөр хоорондоо шивнэлдэхийг, зальхай этгээдүүд: “Та нар илбэдэн хуулах нэгнийг дагаж буй” гэснийг, бүгдийг бид сайн мэднэ.
48. Тэд чамайг (илбэчин, найрагч, солиотой гэхчлэн) элдэв юмтай зүйрлэснийг хараач хөөе! Тиймээс тэд төөрөлдсөн бөгөөд зөв замыг хэзээ ч эс олох болно.
49. Тэд: “Бид хувхай өмхий шороо болсон хойноо дахин амилан, цоо шинэ хүн болох гэж үү дээ?” хэмээнэ.
50. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Та нар чулуу эсвэл төмөр болон хувирсан ч дахин амилуулах болно” хэмээн хэл!
51. “Аль эсвэл санаанд оромгүй ямар нэгэн эд болж хувирсан ч дахин амилуулах болно” хэмээн хэл. “Тэд биднийг хэн буцааж амилуулах вэ?” гэж асууна. “Та нарыг бүтээсэн Аллах дахин амилуулна” гээ. Тэд толгойгоо сэгерэн (ёжлон): “Энэ чинь тэгээд хэзээ болох юм вэ?” гэж асууна. “Тун удахгүй биз дээ” хэмээн хариулаарай.
52. Аллах тэр нэгэн өдөр та нарыг буцаан дуудна. Та нар түүнийг сайшаан магтаж, оршуулгын байдлаар богинохон хугацааг өнгөрөөсөн мэт бодно.(энэхүү өдрийг сана)
53. Миний боолуудад: “Тэд элэгсэг даруу яриг. Учир нь чөтгөр шуламууд тэдний хооронд сэв суулган үймүүлнэ. Чөтгөр шулам бол хүмүүний илт дайсан шүү дээ” хэмээн хэл.
54. Эзэнтэн чинь та нарыг хамгийн сайн мэднэ.Хүсвэл энэрэн тэтгэж,

- эсвэл гэсгээн цээрлүүлмүй. Бид чамайг буруу номтнуудыг хаацайлан хамгаалахаар илгээгээгүй билээ.
55. Эзэнтэн чинь тэнгэр, газарт буй хэн бүхнийг сайн мэднэ. Бид үнэндээ гэсгээн элч нарыг бие биеэс нь илүү өргөмжилсөн бөлгөө. Дауидад Бид Забур судрыг хайрласан юм.
56. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Аллахаас өөр бурхан хэмээн итгэсэн юмнуудаа дуудаад үз л дээ. Тэд та нарын гай барцадыг зайлуулж чадахгүй. Өөрчилж чадахгүй.
57. Тэдний “бурхан” хэмээн залбирсан зүйлс ч: “Бидний аль нь Аллахт арай ойр байх юм вэ?” хэмээн арга зам эрэлхийлдэг. Аллахын ивээлийг горьдон, гэсгээлээс нь айдаг. Учир нь тэд Аллахын гэсгээлээс сэрэмжлэх ёстой.
58. Аллахыг эсэргүүцэн үгүйсгэдэг нэгэн хот (ардууд) байлаа ч бид тэднийг Ертөнцийн төгсгөлийн өдрөөс өмнө сүйрүүлэх болно. Эсвэл хатуу цээрлүүлнэ. Энэ тухай Лаухил-Махфуз буюу хувь тавилангийн сударт бичээстэй буй.
59. Түрүүчийн хүмүүс худал хэмээн үгүйсгэсэн тул Бид Курайшын ардуудад дахин нотолгоонуудыг (ер бусын гайхамшиг) илгээхээс түдгэлзсэн билээ. Бид Самудын ардад яруу тод нотолгоо болгон нэгэн ингэн тэмээ илгээхүйд тэд үл итгэн түүнийг алчихсан. Тийнхүү зальхай этгээдүүд болсон юм. Гиймээс бид яруу тод нотолгоо бүхий ер бусын гайхамшигаа айлгахын тулд илгээдэг болой.
60. Бид Мухаммед чамд нэгэнтээ: “Эзэнтэн хүмүүсийг алган дээр тавьсан мэт мэддэг” хэмээн хэлсэн билээ. Бидний чамд Исра шөнө үзүүлсэн үзэгдэл ба Куранд хараасан ёрын модыг (Заккум модыг) гагцхүү хүмүүий төлөө нэгэн сорилт болгосон болой. Бид үл сүсэглэгсэдийг айлгасан ч тэдний хэрээс хэтэрсэн төөрөгдөлийг улам бүр даамжруулдаг.
61. Нэгэнтээ мэлэк нарт: “Адамд мэхийн ёсолж мөргөгтүн!” хэмээсэн. Тэгэхүйд Иблисээс бусад нь бүгд мэхийн мөргөсөн. Иблис: “Би Чиний шавраас бүтээсэн хүнд сөгдөн мөргөнө гэж үү?” гэсэн.
62. Мөн: “Надаас илүү бүтээсэн хүн чинь энэ юм уу? Хэрэв надад дахин амилах өдөр хүртэл боломж өгвөл би түүний үр удмын цөөн хэдээс бусдыг нь уруу татан эрхэндээ оруулмуй” гэв.
63. Аллах ийн айлдав: “Зайлагтун!” Тэднээс (хүмүүний үр удмаас) хэн чамайг дагавал уул шугамандаа түүний ч, чиний ч шийтгэл халуун там байх болно!”
64. “Тэднээс чадах хэрээр уруу тагах биз. Тэдэн рүү морьтой, явган хамаг хүчээрээ дайрах биз. Тэрчлэн мал хөрөнгө, үр хүүхдийг нь эзэгнэнэ биз. Мөн тэдэнд хуурамч амлалт ч өгөх биз. Гэсэн ч чөтгөрийн амлалт нь гагцхүү зэрэглээ төдий шүү дээ.

65. “Намайг мэдэх үнэнч боолуудад минь чи нөлөөлж чадахгүй. Эзэнтэн чинь тэднийг ивээн хамгаалахад хангалттай”
66. Аяа, хүмүүн төрөлхтөн! Эзэнтэн, Өөрийн уужим ивээлээр та нарыг буян хишгээ эрэн олж аваг хэмээн та нарын төлөө далайгаар хөлөг онгоцыг явуулсан. Тэр үнэхээр та нарт машинд нигүүлсэнгүй билээ.
67. Далай тэнгист та нарт гай зовлон тохиохуйд Аллагаас өөр сүсэглэн мөргөж буй бүхэн чинь зайлан одно. Аллах та нарыг аварч эрэг дээр гаргахад та нар тэр дор умартан Түүнээс нүүр буруулдаг шүү дээ. Угаасаа хүмүүн бол маш харалган ажгуу.
68. Далайн осолоос эсэн мэнд мултгарлаа ч гэсэн Аллах та нарыг газрын гав руу оруулахаас, эсвэл дээрээс чинь чулуун мөндөр оруулахаас айдаг гэж үү? Түүнээс хамгаалагчийг та нар эс олмуй.
69. Эсвэл та нарыг дахин далай руу илгээн, эс итгэж залбираагүйн төлөө шуурга босгон, усанд живүүлэхээс айхгүй байна уу? Биднээс та нарыг өмөөрөх хэнийг ч эс олмуй.
70. Хэрэг дээр Бид Адамын үр удмыг (хүмүүний) өргөмжлөн, тэднийг хуурай газар дээр уналга унуулан, далайд хөлөг онгоцонд суулгаж, амтат хүнсээр хангаж, бусад амьтадаас хамаагүй давуутай бүтээсэн билээ.
71. Ертөнцийн төгсгөлийн өдөр Бид бүх хүмүүнийг удирдагчидтай нь хамт дуудна. Үйлийн дэвтэрийг хэний баруун гарт нь атгуулна, тэр номоо уншина. Тэдэнд өчүүхэн чинээ шударгуу бус зүйл хийгдэхгүй.
72. Энэ хорвоогийн сэтгэл нь сохорсон хүн хойд ертөнцөд ч сохор байх бөгөөд замаасаа төөрөлдөнө.
73. (Аяа, Мухаммед) Тэд, Бидний эсрэг муу юм хийхийн тулд чамд Куранаас бусдыг хийлгэн, Биднийг гүтгэх шахсан. Тэгсэн л бол тэд чамайг уруу татан анд нөхөр болгох асан буй за.
74. Хэрэв Бид чамайг (сүсэг бишрэлийг чинь) бататгаагүйсэн бол чи бага ч гэсэн тэдэн рүү хэвийх байсан болой.
75. Тэгсэн ахул ямар ч эргэлзээгүй Бид чамд энэ хорвоо хийгээд үхлийн зовлон зүдгүүрийг давхар давхар амсуулах байв. Тэгээд Биднээс хамгаалах ямар ч туслагчийг чи олохгүй байх байсан.
76. Тэд чамайг байсхийн оролдож, нутгаас чинь (Меккегээс) зайлуулах шахсан. Хэрэв тэгсэн сэн бол тэд чамаас хойш тэнд нэн их удахгүй байсан биз ээ.
77. Энэ бол чамаас өмнөх Бидний гэгээн элч нарын баримталсан жаяг болой. (Гэгээн элчийг хавчин гадуурхсан ардыг бусниулан сөнөөх нь угаас Аллахын сонгосон зам юм.) Бидний замаас чи ямар ч өөрчлөлтийг эс олмуй.
78. Аяа, Мухаммед! Өдрийн нар хэлбийх цагаар, үдшийн бүрий болж (тодорхой цагуудад) уншлага мөргөл үйлд. Мөн өглөөний уншлага

- мөргөл үйлд. Миний мэлэжүүд ч өглөөний уншлага мөргөлийг гэрчилдэг.
79. Шөнийн дунд сэрээд хувьдаа сайн дурын (нафил) уншлагаа үйлд. Эзэнтэн чинь чамайг магтаалын сайхан байранд (Аугаа нигүүлслэлийн байранд) зогсоож юу магад.
  80. Аяа, Мухаммед! “Эзэнтэн минь ээ! Намайг орох газраар бүдрээлгүй оруулж хайрла. Гарах газраар минь мөн зохистойгоор гаргаж хайрла? Надад туслагч хүч чадал хайрлагтун?” хэмээн залбир.
  81. Мөн: “Чин үнэн (Ислам) ирж, худал хуурмаг нуран уналаа. Угаасаа худал хуурмаг алга болох учиртай” гэж хэл.
  82. Бид сүсэгтэн олны төлөө анагаах увидас, хайр энэрэл болох Кураныг буулгамуй. Харин буруу номтнуудын хувьд гагцхүү хор хөнөөлийг нь нэмэгдүүлмүй.
  83. Бид хүмүүнд хувь хишгээ хүртээн, сайн сайхныг хийвэл тэд нүүр буруулан уруу царайлаад унана. Харин гай барцад тохиолдвол арга ядан цөхөрдөг юм.
  84. Аяа, Мухаммед тэдэнд: “Хүн бүр ухаарсан хэрээр амьдардаг ч хэний зам зөв болохыг Аллах мэдмүй” хэмээн хэл.
  85. Аяа, Мухаммед! Тэд чамаас сүнсний талаар асуумуй, тэдэнд чи: “Сүнс, Эзэнтний эрхшээх зүйл” хэмээн хариулагтун. Та нарт эрдэм мэдлэгээс өчүүхэн төдий л өгөгдсөн болой.
  86. Хэрэв Бид хүсвэл чамд илгээсэн айлдварыг (Кураныг) буцаан авч чадах билээ. Тэгсэн байх аваас хожим Бидний эсрэг түүнийг буцаан ирүүлэх ямар ч хүчийг эс олмуй.
  87. Харин Эзэнтний чинь хайр энэрэлээр түүнийг чамаас буцааж авахгүй юм. Эзэнтний чамд зориулсан хайр энэрэл үнэхээр их билээ.
  88. Аяа, Мухаммед! Хэрэв хүмүүн болоод буг чөтгөрүүд энэхүү Курантай адил судар зохиох гэж цуглаад, бие биендээ дэмжлэг үзүүлсэн ч зохиож эс чадмуй.
  89. Бид энэхүү Куранд хүмүүсийн төлөө янз бүрийн жишээг тунхаглан тайлбарласан. Гэсэн ч хүмүүсийн олонхи нь татгалзаж улам эсэргүүцсэн билээ.
  90. Үл сүсэглэсэд: “Чи бидний төлөө газар дороос ундарга сайтай нэгэн булаг оргилуулахаас нааш бид чамд хэзээ ч итгэхгүй.”
  91. “Эсвэл чамд дундуур нь булаг урсгасан дал модны ба усан үзэмний цэцэрлэг бий болгог.”
  92. “Эс бөгөөс чи цэцэрхэж байгаа шигээ, тэнгэрийн мандалыг бидэн дээр хэсэг хэсгээр буулга, тэрчлэн Аллах хийгээд мэлэжүүдийг бидний өмнө даруй ирүүл!”
  93. “Эс бөгөөс чи алтан тоног бүхий байшинтай болохоос нааш чамд

- итгэхгүй, эсвэл чи тэнгэрт дүүлж бидний уншиж чадах (чиний гэгээн элч болохыг нотлох) нэгэн судрыг бидэнд буулгаж ирэхээс нааш чамайг тэнгэрт гарсан гэж үл итгэмүй” гэлцэв. Аяа, Мухаммед тэдэнд: “Аллах чин үнэн. Би Аллахын элч бөгөөд ердөө л хүн төдий. (Аллахын зарлиггүйгээр хэн ч ер бусын гайхамшиг, нотолгоонуудыг үзүүлж чадахгүй)” хэмээн хэлэгтүн.
94. Хүмүүст зөв, шулуун замыг заагч (Куран ба гэгээн элч) ирэхүйд үл сүсэглэгсэдийн: “Аллах энгийн нэг хүнийг элчээр томиллоо гэж үү” хэмээн ярьсан үг нь тэдний итгэл бишрэлд саад болсон юм.
95. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Хэрэв газар дэлхий дээр нутаглаж явагсад бүгд зарлиг гүйцэтгэгч Аллахын элч мэлэжүүд байсан сан бол Бид тэдэнд тэнгэрээс нэгэн зарлиг гүйцэтгэгч мэлэжийг элч болгон буулгахсан билээ” хэмээн хэл.
96. Аяа, Мухаммед!: “Та бидний хооронд (миний Аллахын гэгээн элч мөн эсэхэд) гэрч болоход Аллаха хангалттай. Аллаха өөрийн боолуудыг сайн мэддэг бөгөөд тэр нэн гярхай” хэмээн хэл.
97. Гагцхүү Аллахын залаан чиглүүлэгсэд зөв шулуун замаар замнамуй. Аллаха хэнийг төөрөлдүүлнэ, түүнд Аллахаас өөр туслагч үгүй. Бид тэднийг Ертөнцийн төгсгөлийн өдөр сөхрөн унасан сохор, хэлгүй, дүлий чигээр нь дахин амилуулан цуглуулмуй. Тэдний очих газар нь халуун там бөгөөд гал намсах бүрийд Бид түүнийг дүрэлзүүлэн өрдмүй.
98. Тэд Бидний ер бусын гайхамшигт итгэхгүйгээр “Бид хувхай яс, ялзарсан хөрс болчихсон хойно ч буцаад амилан, бас л хүн болно гэж үү?” хэмээн ярьсны шан ийм байх бөлгөө.
99. Тэнгэр, газрыг бүтээсэн Аллаха түүн шиг юмыг бүтээх чадалтайг тэд үнэхээр харахгүй байна гэж үү? Аллаха тэдний төлөө үхэх, дахин амилах цаг хугацааг товлосон нь эргэлзээгүй үнэн. Тэгэвч харгис зальхай этгээдүүд гэжүүдлэн үл тоомсорлож, үгүйсгэх дуртай.
100. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Та нар Эзэнтний хайр хишгийн сангийн эзэн болсон бол үргэгдчихэнэ хэмээн айж, хав дарж байхсан. Хүн ийм л харамч амьтад” хэмээн хэл.
101. Үнэндээ, Бид Мусад есөн төрлийн ер бусын гайхамшигуудыг хайрласан юм. (Аяа, Мухаммед) Израйлын үр удмаас асуу. Нэгэнтээ Муса Фиргауны ард олонд ирэхүйд Фиргаун түүнд: “Аяа Муса, би чамайг илбэдүүлсэн хүн гэж бодож байна” гэсэн билээ.
102. Муса: “Аяа, Фиргаун! Үүнийг (есөн ер бусын гайхамшигийг) гагцхүү тэнгэр, газрын Эзэнтэн (миний гэгээн элчийн) нотолгоо болгон буулгасныг чи мэдэх болно. Аяа, Фиргаун! Би ч гэсэн чамайг үнэндээ нэг мөсөн сүйрнэ хэмээн бодож байна” гэсэн юм.
103. Фиргаун тэднийг Мисирин нутгаас хөөн зайлуулахыг сэдэв. Гэвч

- Бид Фиргаун болон түүнтэй хамт байгсадын бүгдийг усанд живүүлсэн билээ.
104. Үүний дараа Израйлын үр садад хандан: “Энэ нутагт (Мисирт) суурьшигтун, хойд ертөнцийн өдөр ирэхүйд Бид та нарыг цуглуулж авчирна” гэв.
  105. Бид Кураныг чин үнэнээр буулгасан, Куран ч чин үнэн зарлиг ёсоор буусан болой. Аяа, Мухаммед! Бид чамайг гагцхүү баярт мэдээг дуулгагч, сэрэмжлүүлэгч болгон илгээсэн билээ.
  106. Кураныг хүсүүст тогтуун уншиж өгөг хэмээн түүнийг хэд хэдэн суре (бүлэг), айлдварууд болгон, хэсэг хэсгээр нь илгээсэн юм.
  107. Аяа, Мухаммед! хүмүүст: “Та нар Куранд итгэнэ үү, эс итгэнэ үү хамаагүй. Түүнээс өмнө эрдэм мэдлэг заяагдсан хүмүүст Кураныг уншахүйд тэд сэтгэл хангалуун сөгдөн мөргөдөг” гэж хэл.
  108. Тэд: “Эзэнтнээ чин үнэн хэмээн дээдэлмүй. Түүний амлалт эргэлзээгүй биелэгдэнэ!” гэнэ.
  109. Ийнхүү тэд нулимсаа мэлтэлзүүлэн сөгдөн мөргөх бөгөөд Кураны уншлага нь тэдний талархлыг улам өдөөнө.
  110. Чи тэдэнд: “Та нар Аллах гэж нэрлэнэ үү, Рахман гэж нэрлэнэ үү, алинаар нь нэрлэсэн ч ялгаагүй сайн зохимой. Учир нь Аллахын олон сайхан нэр буйг хэлэгтүн. Уншлага мөргөлөө чи өөрөө хэт чанга дуугаар биш, хэт шивнэх ч биш, дундын намуун аялгуугаар уянгалуулан үйлдэгтүн.
  111. “Бүхий л магтаал соёрхол зөвхөн Аллахынх. Үр хүүхдээс ангид, эрх мэдэл, хаанчлалд эн зэрэгцүүлэшгүй, гай зовлонгоос аврах туслагч шаардлагагүй байх нь (Өөрт нь гай зовлон нэрвэх гэж үгүй) гагцхүү Аллахт бүрэн зохино” хэмээн Аллахыг дээдлэн магтан залбирагтун.



Мекке-д илгээгдсэн. 110 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Бүхий л магтаал соёрхол Аллахт зохимой. Үнэнч боолдоо (Мухаммедэд) Кураныг илгээв. Түүнд ямар ч гөжүүд байдал гаргаагүй.
2. Чин үнэн болох тэр судар агуу гэсгээлийн тухай сануулахын тулд, сүсэглэн шүтэж, буян үйлдэгсэд сайхан шан харамж (диваажин) оногдох тухай баярт мэдээ дуулгахын учир илгээгдсэн болой.
3. Буянтай үйл үйлдэгсэд тэндээ эгнэгт оршмуй.

4. Мөн “Аллах хүүхэдтэй” хэмээн худлаа цуурсан хүмүүст санамж болгохын тулд илгээгдсэн.
5. Энэ тухай тэдэнд болон өвөг дээдэст нь мэдлэг байгаагүй. Тэдний амнаас нь гарч буй үгнийнх нь (нүгэл) нүсэр хүнд. Тэд зөвхөн худал ярих дуртай.
6. Тэд энэхүү сударт (куранд) үл итгэцгээх аваас тэдний үл тоомсорлолын төлөө чи (Мухаммед) дотроо хямран, аминаасаа уйдах чинь илүүц.
7. Бид хүмүүсийг үйлээрээ хэн нь дээр болохыг сорихын тулд газар дэлхийд буй бүх юмыг түүний чимэг болгосон.
8. Бид хэзээ нэгэн цагт газар дэлхий дэх алив бүхнийг устган, газрыг цөлжүүлэн, хувхай хуурай хөрс болгон өөрчлөнө.
9. (Аяа, Мухаммед) Кахф болон Рахимын эздийг Бидний ер бусын гайхамшигуудын бэлгэдэл хэмээн ойлгосон уу?
10. Нэгэнтээ хэдэн залуус үлдэж, агуйд толгой хоргодохдоо : “Эзэнтэн минь ээ! Энэрэл нигүүлсэлээ бидэнд хайрлаач! Бидний үйлийг авралын зам руу хөтөлж, зөв замыг залагтун” хэмээн залбирцаав.
11. Бид агуйд нь тэдний чихийг өнө удаанаар бөглөсөн (өч төчнөөн жилээр унтуулсан) болой.
12. Тэд агуйд ямар хугацаагаар байсныг талцан маргалдагч хоёр талын хэн нь сайн тооцоолж чадахыг сорихын тулд эргэж сэрээсэн юм.
13. (Аяа, Мухаммед) Бид тэдэнд тохиолдсон үйл явдлыг чамд чин үнэнээр хүүрнэнэ. Үнэндээ тэд, Эзэнтэндээ сүсэглэсэн залуус байсан билээ. Бид тэдний үнэн төрхийг бататгасан юм.
14. Бид тэдний зүрх сэтгэлийг нь бататган холбоо барив. Тэд (зальхай удирдлагын эсрэг) бослого гаргаж: “Бидний Эзэнтэн, тэнгэр хийгээд газрын эзэн. Бид Түүнээс бусдыг бурхан хэмээн хэзээ ч итгэн залбирахгүй. Аллахтай бусдыг эн зэрэгцүүлбэл үнэндээ алдас болох билээ” хэмэн хэлцгээв.
15. Манай энэ ардууд Аллагаас бусдыг бурханчлан итгэлээ. Тэгвэл, тэд нөгөө бурхантай холбоотой яагаад ил тод нотолгоо харуулдаггүй юм вэ? Ер нь Аллахыг худалч хэмээн гүтгэхээс муухай зальхай явдал байгаа гэж үү?
16. Тэрхүү ардын дотроос нэг нь ийн хэлрүүн: “Та нар нутгийнхаа олноосоо, мөн Аллахтай эн зэрэгцүүлсэн юмнуудаас холдон салцгаажээ. Одоо агуйдаа толгой хоргодогтун. Эзэнтэн та нарт хайр энэрэлээ түгээж, үйлсийг чинь бүтээнэ” гэв.
17. Аяа, элч минь! Чи тэнд байсансан бол нар мандахдаа агуйн баруун гар талаар өнгөрснийг, хэвийж жаргахдаа зүүн гар талаар нь даялан гарахыг хармуй. Тэд агуйн дунд хэсгийн сэлүүхэн зайд хэвтэж байгаа. Энэ бол Аллахын ер бусын гайхамшигуудын нэг нь болой. Аллах хэн



- нэгнийг өршөөвөл тэр зөв шулуун замаар замнамуй. Харин хэн нэгнийг төөрөгдүүлбэл түүнд зөв зүгийг заах анд үл олмуй.
18. Чи тэднийг үзвэл сэрүүн буй гэж бодох байх, гэвч тэд унтаагаараа байгаа. Бид тэднийг баруун, зүүнгүй хөрвөөлгөдөг. Тэдний нохой нь хоёр хөлөө урагш жийн, агуйн үүдэнд хэвтэж байгаа. Хэрэв, чи тэднийг харсан ахул айдаст автан, ухаан жолоогүй зугтаж одох асан.
  19. Ийнхүү Бид тэднийг хэр удаан хэвтсэнээ бие биенээсээ асууг хэмээн сэрээсэн. Тэдний нэг нь: “Та нар энд хэр удсан бэ?” гэж асуув. Нөгөөдүүл нь : “Нэг өдөр юм уу, өдрийн тал хэртэй хэвтсэн биз” хэмээв. Тэдний нэг нь : “Энд хэр удсаныг Эзэнтэн чинь илүү сайн мэдмүй. Энэ мөнгийг өгөөд нэгийгээ хот руу явуулая. Хэний хол хүнс цэвэрхэн түүнээс хүнс худалдан авч ирэг. Гэхдээ хэн нэгэн хүнд бидний тухай мэдэгдэхээс болгоомжлох хэрэгтэй” гэв.
  20. Учир нь хотынх тэднийг бариад авбал чулуугаар нүдэж ална, эсвэл өөрийн шашинд албадан оруулах байсан. Тэгвэл хэзээч Эзэнтний авралыг үл үзмүй.
  21. Ийнхүү, үхсэнийг дахин амилуулах тухай Аллахын амлалт хичнээн үнэн болохыг, ертөнцийн төгсгөл ямар ч эргэлзээгүй тохиохыг хүмүүст сануулан ийнхүү мэдүүлэв. Энэ мөчид агуйд нойрсогсодын нутаг усных нь тэдний явдлын тухай хоорондоо маргалдав. Зарим нь: “Тэдний дээгүүр оромж байшин баригтун. Эзэнтэн тэдний байдлыг илүү сайн мэднэ” гэв. Тухайн нутгийн эрх мэдэлтнүүд нь: “Бид тэдний дээгүүр бунхан-сүм барьцгаая” хэмээн хэлцээсэн.
  22. Хүмүүс Асхаби-Кахфийн (агуйд нойрсогсодын) тооны тухайд маргалдаж зарим нь : “Тэд гурвуулаа байсан, дөрөв дэх нь нохой байсан” гэхэд бас нэг нь: “Тавуулаа байсан, зургаа дахь нь тэдний нохой” гэв. Энэ бүгд үзэлгүйгээр тааж хэлсэн үг байлаа. Бас нэг нь: “Тэд долуулаа байсан, нохой нь наймдах нь” гэв. Аяа, Мухаммед! Тэдэнд : “Тэдний тоог Эзэнтэн минь сайн мэднэ. Тэдний тухай мэдэх хүмүүс цөөнхөн. Ийнхүү чи Асхаби – Кахфийн тухайд энэ бол зүгээр нэг мэтгэлцээн, яруу тод нотолгоо байсаар байхад бүү маргалд, бас тэдний тухай хэн нэгнээс юуг ч бүү асуугтун.
  23. Алив юмны тухайд: “Би үүнийг маргааш заавал хийнэ” хэмээн бүү амал.
  24. “Хэрэв, Аллах таалвал” хэмээн үгийг нэмж хэл. Хэрэв уг үгийг мартвал Эзэнтнээ дурсан санаж: “Миний Эзэнтэн намайг зөв шулуун зам руу ойртуулна хэмээн хүснэ” гэж залбир.
  25. Тэд уулын агуйдаа гурван зуун жил болжихуй. Мөн түүн дээр дахиад ёсон жил нэмсэн билээ (гурван зуун есөн жил болсон).
  26. (Аяа, Мухаммед!) Тэдэнд : “Тэдний хичнээн жил агуйд байсныг Аллах л сайн мэдмүй. Тэнгэр, газрын далдыг Аллах эзэгнэмүй. Аллах юутай

- хурц хараатай, юутай сонор вэ! Тэдэнд Аллагаас өөр ямар ч ивээгч үгүй. Аллах шийдвэр гаргахдаа хэнтэй ч хамтрахгүй” хэмэн хэлэгтүн.
27. (Аяа, Мухаммед!) Эзэнтний чинь судраас чамд ямар нотолгоо мэдээ ирсэн ч уншигтун! Түүний айлдварыг хэн ч эс өөрчилмүй. Чи Түүнээс ондоо ямар ч нөмөр нөөлөг эс олмуй.
  28. Чи Эзэнтний ивээлийг эрж, өглөө, орой тэвчин залбирагсадтай хамт тэвчээртэй байгтун. Энэ насны жаргал цэнгэлд умбан, тэднийг маргуузай. Зүрх сэтгэл нь Биднээс урвасан, өөрийнхөө хий хоосон мөрөөдөлд хөтлөгдсөн, ааш араншин нь хэрээс хэтэрсэн хүмүүсийг бүү дагагтун.
  29. (Аяа, Мухаммед!) Тэдэнд : “Энэхүү чин үнэн (куран) Эзэнтнээс чинь илгээгдсэн. Хэн хүссэн нь сүсэглэмүй, эс хүссэн нь үл сүсэглэмүй” хэмээн дамжуул. Бид зальхай этгээдэд улалзах гал нь холоос бүчиж авдаг халуун тамыг бэлдсэн. Тэд орь дуу тавин ус гуйх аваас тэдэнд хайлсан төмөр лүгээ адил нүүрийг мулзлах буцлам халуун ус өгөгдөх болно. Энэ бол юутай муухай унд, юутай муухай газар гээч!
  30. Үнэндээ сайн үйлс үйлдэж, сүсэглэгсэдийн буян заяа талаар өнгрөхгүй.
  31. Тэдэнд хаяагаар нь гол горхи урсдаг Адн-ын диваажин оногдмуй, Тэд тэнд алтан бугуйвч зүүж, нимгэн болон зузаан торгоор өмсгөл өмсөнө, түшлэгтэй сайхан сэнтийд тухлан заларна. Энэ нь юутай сайхан хүндэтгэл, юутай тухтай газар вэ!
  32. (Аяа, Мухаммед!) Чи тэдэнд энэхүү хоёр хүнийг жишээ болгон таниулагтун : Бид тэдний нэгэнд нь эргэн тойронд нь дал мод ургасан, дунд нь тариалангийн талбайтай усан үзэмийн хоёр цэцэрлэгийг бэлтгэсэн.
  33. Хоёр цэцэрлэгийн алинд ч дутуу дулим зүйлгүй. Үр жимсээ бүрэн өгсөн. Бид тэдний дундуур ариун булаг урсгасан болой.
  34. Энэхүү цэцэрлэгийн эзэний орлого нь элбэг байна. Тэр хамт яваа нөхөртөө бардамнаж: “Би чамаас эд хөрөнгөөр баян, хүний тоогоороо ч илүү” хэмээн сагсуурна.
  35. Тийнхүү тэр цэцэрлэгтээ орохдоо бардамнан сагсуурч өөртөө нүгэл үйлдэн: “Би энэ бүхнийг мөнхөд оршино хэмээн бодном” гэж онгиров.
  36. “Бас ертөнцийн төгсгөлийг тохионо гэж огтхонч эс бодмуй. Намайг Эзэнтний өмнө эргүүлэн аваачих юм бол, мэдээж л үүнээс илүү сайхан газар олж авч чадна” хэмээв.
  37. Түүнтэй хамт яваа нөхөр нь: “Чамайг эхлээд газрын шорооноос, дараа нь нэг дусал уснаас бүтээж, дараа нь бүрэн хүн төрхтэй болгосон Аллахад үнэхээр итгэдэггүй гэж үү?” хэмээн асуув.
  38. Харин миний Эзэнтэн бол Аллах, би Эзэнтэндээ хэнийг ч эн зэрэгцүүлэхгүй.

39. Чи өөрийнхөө цэцэрлэгт орохдоо: “Алив бүхэн Аллахын тааллаар! Сүр хүч гагцхүү Аллахынх (Аллахын ивээл, туслалцаагүйгээр миний гараар юу ч бүтэхгүй)” хэмээн яагаад хэлдэггүй юм вэ? Чи намайг хөрөнгө чинээ, үр хүүхдээр дутуу хэмээн үзсэн ч...
40. Эзэнтэн надад чиний цэцэрлэгээс ч илүүг хайрлаж, чинийх дээр тэнгэрийн гамшиг бууж, цэцэрлэг чинь нүцгэн тал болон хувирч юу магад.
41. Эсвэл цэцэрлэгийн чинь ус ширгэн, чи түүнийг эргэн олж эс чадаж болох шүү дээ!” гэв.
42. Эцэст нь бардамнасан эрийн цэцэрлэг гамшигт сүйрэн, үзэмний моднууд нь хугаран унав. Цэцэрлэгт зориулсан хөрөнгөндөө харамссан өнөөх эр хоёр алгаа байсхийн үрснээ: “Ээ чавас, Эзэнтнийг бусадтай эн зэрэгцүүлэхгүй байх минь ч яавдаа!” хэмээн халаглав.
43. Түүнд туслах Аллагаас өөр хэн ч олдсонгүй. Өөрөө өөртөө ч тус болж чадсангүй.
44. Ийнхүү хүлцэл, ноёрхолын алин ч гагцхүү чин үнэн Аллахынх болой. Тэр наминчлан залбирсан боолдоо сайхан шан харамж хайрладаг. Түүний эцсийн үр дүн нь өлзийтэй байдаг.
45. Аяа, Мухаммед! Чи тэдэнд энэ хорвоогийн аж төрлийн талаар дараах жишээг таниул : Бид тэнгэрээс хур буулгаж, үүгээр эх дэлхийн өвс ургамал дэлгэрснээ, намар шарлаж хатан салхинд хийсэн алга болно. Амьд ахуйн жаргал үүнтэй ижил буюу. Аллахын хүч чадал алив бүхэнд хүрэлцээтэй.
46. Мал хөрөнгө хийгээд эхнэр хүүхэд амьд ахуй цагийн чимэг төдий. Харин мөнхөд үлдэх зүйл бол сайн үйлсийн буян болой. Түүнээс хүлээх үр дүн Аллахын эрхэнд бөгөөд амьд ахуйн баяр цэнгэлээс хавьгүй илүү бөлгөө.
47. Тэр өдөр (Амьдралын төгсгөлийн өдөр) Бид уулсыг үүлсийн адил байрнаас нь хөдөлгөн, газрыг хавтгай нүцгэн болгосныг чи харах болно. Мөн Бид хэнийг ч үлдээхгүй бүгдийг (бүх үхдэлүүдийг ч) цуглуулах болно.
48. Ийнхүү тэд бүгдээрээ эгнээ эгнээгээр жагсан Эзэнтний чинь нигур дор очмуй. Эзэнтэн тэдэнд: “Андгайлан хэлье, Та нар Бидний анх бүтээсэн лүгээ адил байдлаар (мал хөрөнгө, үр хүүхэдгүй нүцгэн чигээр) Бидэн дээр ирцгээлээ. Та нарт зориулан ийм өдрийг товлоогүй гэж бодоо биз дээ!” хэмээв.
49. Тэгээд хүмүүсийн өмнө үйлийнх нь дэвтрийг гаргаж тавихуйд, нүгэлтэнгүүдийн айж балмагдсаныг чи харах болно. Тэд: “Ээ лай минь! Ийм л юм байх ч гэж дээ!” Энэ дэвтэрт их ч, бага ч гэхгүй бүхнийг тоолж бүртгэн бичсэн байна шүү дээ” гэлцэн халаглана. Тэд үйлдсэн

бүхнээ тэндээс нэгт нэгэнгүй, ил тод харах болно. Эзэнтэн чинь хэнд ч шударга бусаар эс хандмуй.

50. (Мөн санагтун) Бид мэлэжүүдэд: “Адамд сөгдөн мөргөгтүн!” гэж сануулсан юм. Иблисээс бусад нь бүгдээрээ сөгдөн мөргөгцөөсөн. Иблис жин буюу буг чөтгөрүүдийн нэгэн учраас Эзэнтнийхээ зарлигийг биелүүлээгүй билээ. Аяа, боолууд минь ээ! Ийм атал та нар Надаас урваж, түүнийг болон үр удмыг нь анд найзаа болгоцгоох юм гэж үү? Үнэндээ тэд та нарын илэрхий дайсан шүү дээ. Харгис заальхайчуудын хувьд ийнхүү хийсэн солио нь юутай муухай юм гээч!
51. Би тэнгэр, газар хийгээд өөрсдийг нь бүтээхдээ тэднийг (Иблис хийгээд түүний үр удмыг) гэрчээр эс дуудсан болой. Мөн уруу татан төөрөгдүүлэгчдийг туслагчаа болгон аваагүй билээ.
52. Мөн тэр өдөр (ертөнцийн төгсгөлийн өдөр) Аллах хиймэл бурхан шүтэгсдэд: “Алив, та нар Надтай эн зэрэгцүүлж зохиосон бурхадаа дуудагтун!” гэв. Тэгэхүйд тэд дуудавч цаадуул нь харуулж эс чадмуй. Бид тэдний хооронд аюултай нэгэн, хөлгүй ангал үүсгэсэн болой.
53. Нүгэлтэнгүүд халуун тамыг харсан дариудаа, тийшээ орохоо сайтар ойлгоцгооно. Гэвч түүнээс зайлсхийн нуугдаж аврагдах газар эс олцгоомуй.
54. (Андгайлан хэлье) Бид энэхүү Куранд хүмүүсийг ухуулан-сэнхрүүлэхийн төлөө янз бүрийн жишээг ил тод тайлбарласан. Харин хүмүүс алив бүхнээс зайлсхийж, гөжүүдлэн маргагчид бөлгөө.
55. Өөрсдөд нь зөв шулуун зам (Куран) ирчихээд байхад хүмүүнийг сүсэглэн итгэхэд, бас Эзэнтнийхээ өршөөл энэрэлийг эрэхүйд нь юу саад болно вэ? Гагцхүү өвөг дээдэст тохиолдсон бүхэн өөрсдөд нь тохиолдохыг, аль эсвэл гэсгээлийг харсаар байж өөрсдөд нь тохиолдохыг хүлээсэн нь саад болсон болой.
56. Бид элч нараа гагцхүү сүсэглэгчдэд баярт мэдээ дуулгагч, сэрэмжүүлэгч болгон илгээдэг. Гэвч үл сүсэглэгсэд маргахдаа чин үнэнийг няцаахын тулд гагцхүү худал хуурмагыг өмнөө барьдаг. Мөн тэд Бидний айлдварууд болон сэрэмжлүүлэг болгосон бүхнээр доог тохуу хийцгээдэг билээ.
57. Өөрсдөд нь Эзэнтний айлдваруудыг сануулсаар атал гар нь юу хурааснаа умартан түүнээс нүүр буруулагчаас илүү харгис зальхай хэн байх билээ. Бид үүнийг үл ойлгог хэмээн түүний зүрхийг нь битүүмжилж, чихийг нь дүлийрүүлсэн болой. Чи тэднийг зөв шулуун зам руу дуудсан ч тэд тэр замаар эс явмуй.
58. Гэвч Эзэнтэн чинь машид өршөөгч, хайр энэрэлийн эзэн билээ. Хэрэв, Аллах тэднийг хураасан (нүглийнх нь) төлөө гэсгээхээр таалсан ахул, тэр дариу гэсгээлийг хүртээх болно. Гэвч тэдэнд товлосон цаг хугацаа буй бөгөөд тэд үүнээс зугтаж хоргодох оромж эс олох бөлгөө.

59. Эдгээр хот суурин газруудын ардууд нь (Худ, Салих, Лут, Шугайб гэгээн элч нарын ардууд) харгислал үйлдсэнийх нь төлөө хүйс тэмтэрсэн юм. Мөн тэдгээрийг гэгсгээхийн тулд ч тодорхой цаг хугацааг товлосон билээ.
60. Нэгэнтээ Муса өөрийн хажуугийн залууд хандан: “Хичнээн жил явах хэрэг гарсан ч хамаагүй хоёр тэнгисийн бэлчирийг хүрэхээс нааш би үл зогсмуй, яваад байх болно” гэв.
61. Гэтэл тэд бэлчир хүрэхийн цагт загасныхаа тухай таг мартаж, тэр загас нь гулсан унаж далай руу чиглэн одов.
62. Тэд нэлээд газар хөдөлсний дараа Муса залууд: “Нөгөө замын хүнсийг гаргаад ир. Үнэндээ алжаан ядрав бололтой гэв.
63. Залуу: “Аяа, Бид хясааны тэнд зогсож амрахад загасаа мартчихсан байна. Таныд хэлэхийг чөтгөр шулам л намайг мартуулж орхижээ. Тэр загас тэнгисэнд унаж сэлж одсон нь хачин юм гээч” гэв.
64. Муса: “Бидний зорьж яваа газар бол тэр хясаа байсан юм” хэмээн хоёулаа ирсэн замаар буцацгаав.
65. Тэд загасаа гэсэн газарт Бидний хайр энэрэл, мэргэн ухаан хайрласан нэгэн боолтой (Хизир гэгээн элчтэй) учрав.
66. Муса түүнд хандан: “Таныд заяагдсан мэргэн ухааныг заалгахын тулд чамайг дагаж болох уу?” хэмээн гуйв.
67. Тэр (Хизир): “Чи надтай хамт явж барахгүй биз дээ.
68. Дотоод мөн чанарыг мэдэхгүй юмтай тулгарахдаа хэрхэн тэвчих болдоо?” гэв.
69. Муса: “Хэрэв, Аллах таалах аваас, миний тэвчээртэй байхыг чи харах болно. Би чиний үгнээс ясан ч гарахгүй” гэв.
70. Тэр (Хизир): “Хэрэв чи намайг дагах юм бол, бидний өмнө учрах юмны тухай би чамд ойлгуулхаас нааш бүү асуугтун!” гэв.
71. Тэгээд хоёулаа цааш явцгааж, нэгэн усан онгоцонд суув. Гэтэл Хизир усан онгоцыг цоолж эхлэв. Муса тэсэлгүй: “Усан онгоцонд буй хүмүүсийг усанд живүүлэхээр цоолов уу? Чи үнэхээр хачин жигтэй юм хийж байна шүү” гэлээ.
72. Тэр (Хизир): “Чамайг надтай хамт явж чадахгүй хэмээн хэлсэн биш билээ үү?” гэв.
73. Муса: “Чиний сануулсныг мартсаны минь төлөө өршөөгөөрэй. Надад бүү төвөг удагтун” гэв.
74. Хоёулаа бас л цааш явцгаав. Замд нэгэн хөвгүүн тааралдсанд Хизир түүнийг эгүүтгэж орхилоо. Муса бас л тэвчсэнгүй: “Гэмгүй амьтныг юунд хөнөөв дээ? Үнэхээр аюумшигтай хэрэг хийлээ шүү дээ” гэв.
75. Тэр (Хизир): “Чамайг надтай хамт явж чадахгүй хэмээн сануулсан биш билээ үү?” гэв.

76. Муса : “Үүнээс хойш бас нэг юм асуух аваас намайг бүү дагуулж явагтун. Амлалтаа хэдэнтэй зөрчсний төлөө чиний сануулга эцэслэн дууслаа” гэв.
77. Тэд улам цаашлаад нэгэн сууринд хүрэлцэн ирж, тэднээс хоол хүнс хүсэхүйд тэд хонцоны хувь өгөхөөс таггалзав. Тухайн сууринд хариугүй нуран унах шахсан нэгэн шавар байшинг хараад тэд түүнийг үтэр түргэн засварлан босгов. Муса Хизирд хандан : “Хэрэв хүсвэл чи үүний төлөө шан хөлс авч болох байж дээ” гэв.
78. Хизир : “Чи бид хоёрын салах зам энэ л юм байна. Чиний тэсч ядаад дахин давтан асуусан үйлийн учрыг тайлж өгмүй.
79. Усан онгоц бол тэнгист ажиллаж амь зуулгаа олдог ядуусынх байсан юм. Түүнийг цоолсон учир гэвэл тэр хавьд бат бөх усан онгоцуудыг булааж авдаг нэгэн хаан байсан юм. Одоо цоорхой усан онгоцыг булаах шаардлагагүй болно.
80. Тэр алагдсан хөвгүүний эцэг эх нь үнэнч сүсэглэгсэд байсан юм. Хүү эрийн цээнд хүрсэн хойно буруу номтон болж, эцэг эхээ уруу татан, үл сүсэглэл рүү түлхэхээс би сэрэмжилсэн юм.
81. Тиймээс Эзэнтний зүгээс тэр хөвгүүний оронд эцэг-эхэд нь түүнээс ариун, чин үнэнч, илүү энэрэнгүй нэгэн үр хайрлаг хэмээн хүссэн юм.
82. Нөгөө нурсан байшин уг суурин дахь хоёр өнчин хүүхдийнх бөгөөд түүний дор тэдэнд зориулагдсан эрдэнэс байсан билээ. Тэдний эцэг нь үнэнч шударга хүн байсан тул Эзэнтэн чинь тэр хоёр эрийн цээнд хүрч Аллахын хайр энэрэл болох эрдэнэсээ гаргаж авахыг нь хүссэн ажгуу. Би эдгээрийг өөрөө дур мэдэн хийгээгүй, Аллахын зарлиг байсан юм. Ийнхүү чиний тэсч ядаад асан юмны чинь үнэн учир энэ болой.
83. Аяа, Мухаммед! Тэд (Иудэйчүүд) чамаас Зулкарнайн-ы тухай асуух болно. Тэдэнд : “Би та нарт түүний тухай хэлж өгье” хэмээн хэл.
84. Үнэндээ Бид түүнийг газар дэлхийд эрх мэдэл хийгээд хүч чадлын эзэн болгосон болой. Тэгээд түүнд хэрэгтэй бүх юмсынх нь төлөө замыг нь зааж өгсөн.
85. Тэр ч (Аллахын зүглүүлсэн) тэр замаар явж, баруун этгээд руу аян дайн хийсэн юм.
86. Улмаар яван явсаар наран жаргах зүгт хүрэхэд нар баргар хав харанхуй болж хиртэснийг олж харав. Мөн тэр хавиар нэгэн ардуудтай учрав. Тэгээд Бид түүнд: “Аяа Зулкарнайн! Чи тэднийг гэсгээн цээрлүүлэх, аль эсвэл сайн сайхнаар хандах замын нэгийг сонго” хэмээн тушаав.
87. Зулкарнайн тэдэнд : “Хэрэв, хэн нэгэн харгис зальхай үйл хийх аваас бид тэднийг шийтгэмүй. Дараа нь тэд Эзэнтний өмнө очих болно. Эцэст нь аймшигтай гэсгээлээр шийтгэмүй.
88. Харин хэн нэгэн сайн үйл үйлдэж, сүсэглэх аваас түүний төлөө машинд

- сайхан шан харамж баймуй. Бидний зарлигийг ёсоор болгохсодод амар хялбарыг тушаамуй” хэмээн хэллээ.
89. Дараа нь тэр нар ургах зүг рүү, зүүн тийш чиглэсэн замыг дагасаар явлаа.
  90. Яван явсаар наран мандах зүгт хүрмэгц, нар нэгэн ардын дээрээс төөнөж байхыг үзлээ. Бид тэдэнд хаалт заяагаагүй. (Тэр ардууд нарнаас хамгаалах гэр орон, хувцас хунаргүй аж.)
  91. Энд ч гэсэн дээрхтэй адил (өөрийн хэлснээ хэрэгжүүлэв). Бид түүний (цэрэг, зэвсгийн) талаар бүрэн мэдээлэлтэй байсан бөлгөө.
  92. Дараа нь дахин нэгэн замыг даган явмуй.
  93. Тэгээд яван явсаар хоёр уулын завсар хүрсэнд, бусдын хэлийг эс ойлгох нэгэн ардтай учрав.
  94. Тэр ард түмэн: “Аяа, Зулкарнайн! Энэ нутагт Яажуж ба Мажуж үймээн самуун тарьж байна. Хэрэв, чамд татвар төлбөл, тэд болон бидний хооронд нэгэн хэрэм бариулж өгөх үү?” гэж асуув.
  95. Зулкарнайн: “Эзэнтний маань надад хайрласан эрх мэдэл хийгээд хаанчлал та нарын надад өгөх зүйлээс илүү өлзийтэй. Та нар надад хүн хүчээр туслагтун, тийнхүү та нарын хооронд бөх бат хэрэм барьж өгье” гэв.
  96. “Надад төмөр цуглуулан авчирч өгөгтүн” гэв. Түүгээр хоёр уулын завсарыг дүүргэмэгц тэр: “Хөөрөгдцгөө! Төмөр улайсан баяжихад, дээрээс нь хайлмал зэс цугтагсаа” гэв. Ийнхүү төмөр зэс хольсон бөх бат хэрэм хаалт хийгдлээ.
  97. Яажуж, Мажуж нар хэрэмийг давж ч, цоолж ч чадсангүй.
  98. Зулкарнайн: “Энэ нь Эзэнтний маань хайр энэрэл болой. Эзэнтний маань амлалт ирэхүйд Тэр үүнийг газартай тэгшлэмүй. Эзэнтний маань амлалт чин үнэн” хэмээн айлдав.
  99. Тэр өдөр (дахин амилах өдөр) Бид тэднийг (Яажуж, Мажуж нарыг) шахсалдуултал бүрээ бишгүүр үлээж, нэг дор цуглуулна.
  100. Тэр өдөр Бид үл сүсэглэгсэдийн нүдний өмнө халуун тамыг харуулах болно.
  101. Тэдний нүд хөшиглөгдсөн. Миний айлдваруудыг харахгүй. Чих нь (Кураныг) сонсохгүй.
  102. Буруу номтнууд Надаас урван Миний боолуудыг бурхан болгоно гэж бодно уу? Бид халуун тамыг үл сүсэглэгсэдэд нэгэн оромж болгон бэлдсэн баймуй.
  103. (Аяа, Мухаммед) Тэдэнд : “Та нарт хийсэн үйлдлийнхээ хэрээр хор хөнөөлд учруулагсадын тухай мэдүүлэх үү?” гэв.
  104. Тэдний амьд ахуйдаа хийсэн хөдөлмөрийн үр дүн талаар болсон ч тэд өөрсдийгөө сайн үйл бүтээгсэд хэмээн ойлгодог.

105. Ийнхүү тэд Эзэнтнийхээ айлдварууд хийгээд Түүнтэй нүүр тулахаа үгүйсгэсэн учраас бүх үйл хэрэг нь талаар өнгөрсөн бөлгөө. Дахин амилахуйн өдөр Бид ямар ч үйл хэргийг өчүүхэн ч тоож үзэхгүй.
106. Бидний айлдварууд хийгээд элчүүдийг доог тохуу хийж доромжлон, үл сүсэглэсэн тул тэдний гэгсгээл зөвхөн халуун там л байх болно.
107. Үнэн сүсэглэж, буянтай сайн үйлс хийгсэдийн очих газар нь Фирдаус хэмээн диваажин байх бөлгөө.
108. Тэд тэндээ эгнэгт үлдэх бөгөөд тэндээс хагацахыг хэзээч үл хүсмүй.
109. Аяа, Мухаммед! Тэдэнд : “Хэрэв, Эзэнтний минь айлдварыг бичихийн тулд тэнгисийн ус бэх болж, бид дээр нь төдий чинээг дахин нэмсэн ч Эзэнтний минь айлдварын үгс барагдахгүй, харин тэр тэнгисийн ус барагдаж юу магад” хэмээн сануулагтун.
110. Аяа, Мухаммед! Тэдэнд : “Би ч та нарын адил хүн мөн. Та нарын эзэн гагцхүү Аллах мөн болох тухай Түүнээс надад айлдал илгээгдсэн. Хэн Эзэнтэнтэйгээ учрахыг хүсвэл сайн сайхан үйлс хийгтүн. Эзэнтэндээ наминчлан залбиран мөргөхдөө юуг ч Түүнтэй бүү эн зэрэгцүүлэгтүн” хэмээн хэлээрэй.



Мекке-д илгээгдсэн. 98 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Каф, Ха, Яа, Айн, Сад.
2. Энэ нь Эзэнтний чинь, Закария боолдоо зориулсан хайр энэрэлийн өгүүлэл болой.
3. Тэр нэгэнтээ, Эзэнтэндээ намуун дуугаар наминчлан ийнхүү залбирав:
4. “Аяа, Эзэнтэн минь ээ! Яс минь хэврэгшэн, үсэнд минь хяруу суулаа. Эзэнтэн минь, би Чамаас хүсэн, залбирахдаа хэзээ ч итгэл алдарч байгаагүй ээ!
5. Үнэндээ миний ойрынхоос намайг залгамжлан Аллахын зам мөрийг хөөх хүн гарахгүй бол яах вэ? хэмээн санаа зовох юм. Мөн эхнэр маань нэгэнт цэвэршсэн. Гэлээ ч өөрийнхөө ивээл энэрлээр надад нэгэн хөвгүүн хайрлаач.
6. Тэр намайг болон Якубын удам судрыг залгамжлаг. Аяа, Эзэнтэн минь! үүнийг Өөрийн таалалд нийцүүлэгтүн.”
7. Аллах өөрийн мэлэкуүдээр дамжуулан : “Аяа, Закария мэдэгтүн! Бид чамд нэгэн хөвгүүний тухай баярт мэдээг дуулгамуй. Түүний нэр Яхия. Бид ийм нэрийг урьд өмнө хэнд ч өгч байгаагүй юм” хэмээн айлдав.



8. Закария: “Эзэнтэн минь, Эхнэр маань нэгэнт цэвэршсэн, миний өтөл нас таргагтаа тулчихаад байхад надад яаж хүү заяах юм вэ” гэв.
9. Алладын мэлэжүүд : “Тийм л байх болно. Эзэнтэн чинь: “Энэ бол надад төвөггүй зүйл. Чи урьд нь байгаагүй байхад Би чамайг хоосноос бий болгож бүтээсэн шүү дээ” хэмээн хэлүүлсэн” гэв.
10. Закария : “Эзэнтэн минь, надад нэгэн шинж тэмдэг мэдэгдэ” гэв. Аллах: “Чамд илгээж буй шинж тэмдэг гэвэл - чиний бие эрүүл саруул атал гурван хоног хүмүүстэй ярих чадамжаа алдана” хэмээн айлдав.
11. Ийнхүү Закария залбиралын газраас ард түмнийхээ өмнө гарч ирээд тэдэнд “Өглөө оройгүй Аллахыг шагшин магтаж байхыг” дохионы хэлээр уриалав.
12. Бид түүнд: “Аяа, Яхия! (Гаурат) судрыг чанд сахигтун!” хэмээн тушаав. Бид угаас хүүхэд ахуйд нь түүнд мэргэн ухаан хайрласан юм л даа.
13. Мөн түүнд нигүүлсэх сэтгэл, гэгээн ариуныг хайрласан. Тэр машид итгэн сүсэглэгч байсан билээ.
14. Эцэг эхтээ халамжтай асан бөгөөд эсэргүүцэн түрэмгийлэгч биш байсан.
15. Түүний мэндэлсэн өдөр, нас барах өдөр, мөн дахин амилах өдөр түүний амар амгаланг айлтгая.
16. (Аяа, Мухаммед!) Тэдэнд (Куран) сударт буй Мариямын тухай сануулагтун. Тэр үед Мариям гэрээсээ гарч, дорно зүгийн нэгэн газарт очиж суурьшсан юм.
17. Мариям хүмүүсээс өөрийгөө тусгаарлах хөшиг татсан билээ. Бид түүн рүү өөрийн сүнсээ (Жабрейл мэлэжийг) илгээсэн. Жабрейл түүний өмнө жинхэнэ эр хүний төрхөөр харагдсан юм.
18. Мариям: “Би чамаас айж, машид ивээгч Алладын ивээлд хоргодмуй. Хэрэв, чи үнэн сүсэглэх аваас надад бүү хүрэгтүн□!” гэв.
19. Жабрейл мэлэк: “Би ердөө л чамд цэвэр ариун нэгэн хүүг хайрлахын тулд илгээгдсэн Эзэнтний чинь элч болой” хэмээв.
20. Мариям : “Надад нэг ч эр хүн ойртоогүй бөгөөд онгон ариунаараа байхад би яаж хүүхэдтэй болох сон билээ?” хэмээн асуув.
21. Жабрейл мэлэк: “Тэр тийм л байх болно. Эзэнтэн чинь: “Энэ бол надад төвөггүй зүйл. Үүнийг өөрсдийн зүгээс хүмүүст ер бусын гайхамшиг, хайр энэрэл болгомуй. Энэ бол хувь тавилангийн үйл” хэмээн хэлүүлсэн” гэв.
22. Тийнхүү Мариям жирэмслэн буйдхан газар руу яваад өглөө.
23. Тэрээр нярайлахаар өвдөж нэгэн хасарвааны дал модны сүүдрийг бараадав. Тэгээд: “Халаг гэж! Энэ бүхнээс өмнө хорвоог орхиж, мартагдах минь яав аа!” хэмээн шаналав.

24. Тэгтэл Жабрейл дал модны дэргэдээс дугарч: “Бүү гунь, Эзэнтэн хөл дороос чинь нэгэн булаг урсгасан”
25. “Наад модоо өөр рүүгээ доргион тагвал дээрээс чинь боловсорч гүйцсэн шинэ хасарваань жимс бууж ирмүй”
26. Хасарваань идэж, усаар ундаалж, сэргэгтүн! (баяр хүргье). Хэрэв, хэн нэгэнтэй учирвал : “Би машид нигүүлсэгч Алладын төлөө мацаг (дуугаа хураах мацаг) барина хэмээн андгайлсан. Өнөөдөр хэнтэй ч эс ярмуй” хэмээн хэлэгтүн” гэв.
27. Мариям удалгүй нярайлан, хүүхдээ тэвэрсээр зон олондоо ирэв. Нутгийнхан: “Аяа, Мариям! Чи хэнч хийгээгүй нүгэлт үйл үйлдсэн байна”
28. Аяа, Хааруны охин дүү! Эцэг чинь муу нэгэн байгаагүй, эх чинь ч гэсэн шалиг завхай яваагүй юм!” гэлцэв.
29. Мариям нярай хүүг зааж: “Түүнээс асуугтун” гэдгийг дохиж ойлгуулав. Тэд: “Бид өлгийтэй хүүхэдтэй яаж ярих юм бэ?” хэмээцгээв.
30. Аллахын ер бусын гайхамшигаар хэлд орсон Иса хүү: “Мэдэгтүн! Би үнэндээ Аллахын боол болой. Аллах надад ариун судрыг (Инжилийг) хайрлан, намайг гэгээн элч болголоо”
31. “Хаана байсан ч намайг буян хишигтэй болгон бүтээсэн. Амьд ахуй цагтаа надад уншлага мөргөл үйлдэж, ариуслын өглөг өгөхийг үүрэг болгосон.
32. Намайг ээждээ энэрэлтэй болгож, зальхай, танхай болгоогүй.
33. Миний мэндэлсэн өдөр, үхэх өдөр, дахин амилах өдөр надад амар амгаланг заяана” хэмээн өчив.
34. Энэ бол тэд (Иудэйчүүд хийгээд Христчүүд) эргэлзэн маргалдсан Мариямын хүү Исагийн тухай чин үнэн айлдвар билээ.
35. Аллах хүүтэй байх ёсон үгүй. Аллах түүнээс ангид. Аллах ямар нэг үйл болгохыг хүсвэл “Болтугай” хэмээхүйд даруй зүй ёсоор болдог бөлгөө.
36. Иса : “Үнэндээ Эзэнтэн миний ч, та нарын ч Эзэнтэн, цорын ганц болой. Тиймээс Түүнд сүсэглэн мөргөгтүн. Зөв шулуун зам энэ болой” гэв.
37. Иудэйчүүд болон Христчүүдийн бүлэгүүд Исагийн талаар хоорондоо зөрчилдөн маргалдав. Нөгөөх агуу өдөр (ертөнцийн төгсгөлийн өдөр) үл сүсэглэгсдэд ямар харамсалтай байх бол?
38. Тэд ертөнцийн төгсгөлд Бидний нигур дор ирэхэд чих нь сонсодог, нүд нь харах болно! Гагцхүү харгис, зальхай этгээдүүд өнөөдөр амьд ахуйдаа илэрхий төөрөгдөл дунд явна.
39. (Аяа, Мухаммед!) Чи тэдний хэрэг бүхэн шийдэгдэж харамсалд автах тэр өдрийн тухай сануулагтун. Яагаад гэвэл тэд өдий хүртэл үл хайхран, үл сүсэглэлд автсан баймуй.

40. Эргэлзээгүй, Бид газар дэлхий хийгээд түүн дээр буй бүхнийг өвлөж эзгнэмуй. Мөн тэд бүхлээрээ Бидэнд буцаагдаж ирмуй.
41. Чи сударт буй Ибрахимыг дурсагтун. Учир нь тэрээр үнэнч шударга гэгээн элч байсан билээ.
42. Нэгэнтээ Ибрахим эцэгтээ хандан: “Аяа, эцэг минь ээ! Сонсох ч үгүй, үзэх ч үгүй, чамд ямар ч тус эс болох юмнуудад яах гэж сүсэглэн мөргөдөг бэ?”
43. Аяа, эцэг минь ээ! Үнэндээ чамд заяагдаагүй эрдэм надад заяагдлаа. Тиймээс намайг дагагтун. Би чамд зөв шулуун зам зааж өгмүй.
44. Аяа, эцэг минь ээ! Чөтгөр шуламд бүү сүсэглэн мөргө. Чөтгөр шуламууд машид нигүүлсэгч Аллахыг эсэргүүцсэн билээ.
45. Аяа, эцэг минь ээ! Машид нигүүлсэгч Аллахын гэгсгээл чамайг нэрвэж, чи чөтгөр шуламтай андлах бий хэмээн би айж байна” хэмээн хэлэв.
46. Энэхүү мөчид Ибрахимын эцэг (Азар) : “Аяа, Ибрахим! чи миний бурхадаас нүүр буруулах юм гэж үү? Андгайлан тангараглая. Хэрэв чи энэ байдлаасаа үл татгалзвал би чамайг чулуугаар нүдэж ална. Чи надаас ангид бай” хэмээв.
47. Ибрахим: “Чи амар амгалан байх болтугай! Би чиний төлөө Эзэнтнээс өршөөл гуймуй. Аллах намайг энэрэх болно.
48. Би та нар хийгээд та нарын Аллахаас бусад сүсэглэн мөргөж буй бурхадаас холдон салмуй. Эзэнтэндээ наминчлан залбирмуй. Эзэнтэндээ залбирвал заяа муутай нэгэн болохгүй хэмээн найдаж байна” гэв.
49. Тэгээд Ибрахим тэд болон тэдний мөргөж буй Аллахаас бусад бурхадаас салахуйд Бид түүнд Исхак болон Яакуб хэмээх хоёр хүүг хайрласан бөгөөд хоёуланг нь гэгээн элч болгосон билээ.
50. Бид тэднийг энэрэн хайрлаж, үнэнч хүмүүсийн хэлээр сайшаан магтагдах эрхэмсэг дээд зиндаатай болгосон.
51. (Аяа, Мухаммед!) Чи (Куран) сударт буй Мусга ч санан дурсагтун. Тэр ариун сэтгэлт боол, гэгээн элч байсан билээ.
52. Бид Тур уулын баруун талаас түүнийг дуудаж, хөөрөлдхийн тулд өөрийн эрх мэдэлд ойртуулсан юм.
53. Бид түүнийг хайр ивээлдээ багтаан, дүү Харуныг нь гэгээн элч болгосон билээ.
54. (Аяа, Мухаммед!) Чи (Куран) сударт буй Исмайлыг ч санан дурсагтун. Тэр үнэхээр амлалтандаа чин үнэнч. гэгээн элч байсан билээ.
55. Тэрээр гэр бүлдээ уншлага мөргөл хийхийг, ариун өглөг өгөхийг тушаадаг байсан. Иймээс Эзэнтнийхээ таалалд багтсан юм шүү.
56. (Аяа, Мухаммед!) Чи (Куран) сударт буй Идрисийг ч санан дурсагтун. Тэр ч үнэнч шударга гэгээн элч байсан билээ.

57. Бид түүнийг эрхэмлэн дээгүүр өргөмжилсөн юм шүү.
58. Аллахын ивээлдээ багтаан хайрласан эдгээр гэгээн элч нар бол Адамын үр удмаас, Бидний Нухтай хамт усан онгоцонд суулгасан хүмүүсийн үр удмаас, мөн Ибрахим, Исрайлын (Якуб) үр удмаас, Бидний гэгээн элчээр сонгон зөв шулуун зам руу хөтөлсөн хүмүүсээс байсан юм шүү. Аллахын айлдварууд уншигдахуйд тэд сөхрөн мөргөж, уяралын нулимс мэлтэлзүүлдэг асан болой.
59. Тэд энэ хорвоог орхин одсоны дараа тэдний орыг уншлага мөргөлөө орхисон, хүсэл тачаалдаа автагсад эзэлсэн юм. Тиймээс тэдний орыг эзлэхэд ертөнцийн төгсгөлд Гаая хэмээх халуун тамд хаягдан, урван тэрсэлснийхээ хариуг амсах болно.
60. Харин хэн Аллахт наминчлан залбирч, буянтай сайн үйл үйлдэнэ, тэр диваажинд орно, тэдэнд ямар ч шударга бус явдал тохиохгүй.
61. Диваажин бол машинд энэрэгч Аллагаас боолууддаа далдаар амалсан Адн диваажингууд билээ. Түүний амлалт эргэлзээгүй биелэх болно.
62. Тэд диваажинд мэлэкүүдийн: “Салам” хэмээх мэндчилгээгээс ондоо үг сонсохгүй. Тэнд өглөө, орой өөрсдөд нь зориулагдсан хувь хишиг бэлэн баймуй.
63. Ийнхүү Бидний боолууд чин үнэнээр сүсэглэгсэд эзэгнэх диваажин энэ шүү дээ.
64. Жабрейл мэлэк : “Аяа, Мухаммед! Бид гагцхүү Эзэнтний чинь зарлигаар л газар дээр буумуй. Бидний урд өмнөх хийгээд хожмын, мөн эдгээрийн хоорондын үйл явдлыг мэдэх эрх нь зөвхөн Аллахын эрхэнд буй. Эзэнтэн чинь хэзээ ч мартахгүй.
65. Аллах тэнгэр, газар хийгээд тэдний хооронд буй бүхний Эзэнтэн мөн. Тиймээс Түүнд сүсэглэн мөргөгтүн, тэрхүү мөчид тэвчээртэй байгтун. Чи Түүнтэй ижил нэрт амьдаа нар байдаг гэж мэддэг үү?
66. Хүмүүс: “Би үхсэнийхээ дараа үнэхээр дахин амилан (булшнаасаа) гарах юм гэж үү дээ?” хэмээн асуудаг.
67. Урьд нь юу ч биш байхад, Бид түүнийг хоосноос бий болгон бүтээснийг хүмүүсийн үр сад бодохгүй гэж үү?
68. Эзэнтнийхээ алдраар андгайлан хэлье. Бид тэднийг, мөн чөтгөр шуламыг дахин амилах өдөр нэг дор цуглуулан халуун тамыг тойруулан өвдөг сөхрүүлэн суулгацгаана.
69. Хэсэг бүлэг тус бүрээс машинд нигүүлсэгч Аллахын эсрэг нүгэл үйлдэгсэдийг олны өмнө гаргаж ирнэ.
70. Тамын галд шатвал зохих нь хэн болохыг Бид сайн мэднэ.
71. Та нарын дотроос халуун тамын дэргэд очихгүй нэг ч хүн үгүй. Энэ нь зөрчихийн аргагүй Эзэнтний чинь зарлиг мөн.

72. Дараа нь Бид үнэн сүсэгтнүүдийг аварч, харгис зальхай этгээдүүдийг өвдөг сөхөрсөн хэвээр нь тамд үлдээмүй.
73. Тэдэнд Манай яруу тод айлдварууд уншигдахуйд буруу номтнууд сүсэглэгсдэд хандан : “Хоёр бүлэгээс альнийх нь очих газар сайн, хэний цугларах газар нь илүү гоё бэ?” хэмээн асууна.
74. Урьд өмнө ч Бидний айлдваруудад итгээгүй чинээлэг, сайхан олныг үгүй хийсэн юм.
75. Аяа, Мухаммед! Тэдэнд : “Хэн нэгэн төөрөгдөл дунд байх аваас машид энэрэгч Аллах түүнд тодорхой хугацаа өгмүй! Дараа нь өөрсдөд нь амлагдсан гэсгээлийг, аль эсвэл ертөнцийн төгсгөлийг харсан үед хэний байр суурь нь ганхаж, хэний очих газар нь үзлийн муухай гэдгийг аяндаа мэдэх болно” хэмээн хэлэгтүн.
76. Ийнхүү Аллах зөв шулуун замыг сонгогсодын зам мөрийг илүү дэмжинэ. Үүрд үлдэх сайн үйл бүхэн Эзэнтний чинь нигур дор бөгөөд буян хишиг, шан харамжийн хувьд илүү өлзийтэй болой.
77. (Аяа, Мухаммед!) Бидний айлдваруудыг эсэргүүцэн: “хойд насанд надад мал хөрөнгө, үр удам хайрлагдана” хэмээн яригсадыг чи үзсэн үү?
78. Тэр далдын нууцыг мэддэг болоо юу? Эсвэл машид нигүүлсэгч Аллахаас (хойд насандаа мал хөрөнгө, үр хүүхэд хүртэхээр) ам өчиг авсан юм уу?
79. Үгүй ээ, Бид тэдний ярьсан бүхнийг бичиж аваад, гэсгээлийг нь улам нэмэгдүүлнэ.
80. Бид тэдний хэлж буй бүх юмыг(мал хөрөнгө үр хүүхдийг) өвлөн авч хариуцан, тэрээр өөрөө ч Бидний өмнө (Аллахын өмнө) орь ганцаараа ирэх болно.
81. Тэд нэр алдар хөөцөлдөн, Аллахаас өөр хиймэл бурхадад итгэн биширсэн юм.
82. Үгүй ээ, Тэдний шүтэж асан зохиомол бурхад нь мөргөл залбиралыг нь үгүйсгэж, тэдний эсрэг дайсан болох авай.
83. Аяа, Мухаммед! Урван тэрслэхэд түлхдэг чөтгөр шуламыг Бид буруу номтнууд руу илгээснийг чи хараагүй юу?
84. Тэдний гэсгээгдэхэд бүү яарагтун. Бид тэдний (товлогдсон) өдөр хоногийг тоолж байгаа.
85. Тэр өдөр чин үнэнчээр сүсэглэгсэдийг машид нигүүлсэгч Аллахын нигур дор нэн хүндэтгэлтэйгээр цуглуулмуй.
86. Харин нүгэлтэнгүүдийг ангуулж цангуулан халуун там руу туух болно.
87. Эзэнтний нигур дор амлалт авагсадаас бусад нь хэн ч гэсэн ивээл өмөөрөлд багтахад хүч чадал нь хүрэхгүй.
88. Тэд (Иудэйчүүд ба Христчүүд): “Аллах үр хүүхэдтэй” хэмээн хэлцгээв.

89. Андгайлан тангараглая, та нар үнэхээр дур зоргоороо муухай юм ярьж байна.
90. Үүнээс болж (энэхүү гүтгэлээс) тэнгэр ниргэж, газар чичирхийлэн, уулс нурах шахсан.
91. Учир нь тэд Машид нигүүлсэгч Аллаһыг “хүүхэдтэй” хэмээсний улмаас болой.
92. Хүүхэдтэй байх нь машид нигүүлсэгч Аллаһад үл зохимой.
93. (Ертөнцийн төгсгөлийн өдөр) Тэнгэр, газарт Аллаһад боол болж эрхшээгддэггүй хэн ч үгүй.
94. Тэр бээр, бүхнийг тойрон хүрээлсэн бөгөөд бүрэн тоогоор нь мэдмүй.
95. Тэд бүгд ертөнцийн төгсгөлийн өдөр Аллаһын өмнө нэг нэгээрээ ирмүй.
96. Бишрэн сүсэглэж, сайн үйл үйлдсэн бүхнийг Аллаһ сэтгэл зүрхийг нь үнэн хайраараа баясгах болно.
97. (Аяа, Мухаммед!) Бид Кураныг үнэнхүү сүсэглэгсдэд баярт мэдээг дуулгаг гэж, зөрүүд түмнийг сэрэмжлүүлэг хэмээн чиний хэлээр хялбарчилан илгээсэн болой.
98. Тэднээс өмнө ч олон зальхай түмнийг үгүй хийсэн билээ. Одоо тэдний үгүйдээн нэгийг нь ч болов харж чадна гэж үү? Эсвэл дуу чимээгийг нь сонсоно гэж үү? (тэд ул мөргүй алга болсон шүү дээ)



Мекке-д илгээгдсэн. 135 айлдвар.



***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллаһын алдраар эхэлье.***

1. Та, Ха.
2. Бид Кураныг чамд гай зовлон болог хэмээн буулгаагүй билээ.
3. Гагцхүү Аллаһаас айн эмээгсэдийн төлөө ухуулга-сэнхрүүлгэ болгон илгээсэн юм.
4. Газар дэлхий хийгээд тэнгэр огторгуйг бүтээсэн Аллаһын зүгээс хэсэг хэсэгээр илгээсэн.
5. Машид нигүүлсэгч Аллаһ Аршийг (сансар огторгуйг) эзэгнэсэн юм.
6. Тэнгэр, газар хийгээд тэдгээрийн хооронд буй, бас газар доорх бүхэн Түүнд харьяалмуй.
7. Ил, далдын алинар ярьсан ч Аллаһ үнэндээ нууцыг төдийгүй түүнээс ч далд юмыг мэдэх бөлгөө.

8. Аллахаас өөр ямар ч бурхан үгүй. Төгс төгөлдөр олон сайхан нэр гагцхүү Аллахынх.
9. (Аяа, Мухаммед!) Мусагийн тухай адал явдалт өгүүлэл чамд хүрсэн үү?
10. Тухайн үед Муса дүрэлзсэн гал үзээд гэр бүл рүүгээ хандан : “Та нар хүлээгтүн! Дүрэлзсэн нэгэн гал үзлээ. Би түүнээс халуун цог авчирмуй, эсвэл галын дэргэдээс нэгэн учир мэдэх хүн олмуй” гэв.
11. Муса галын дэргэд хүрч очихуйд: “Аяа Муса!” хэмээсэн дуу сонсогдов.
12. Тэрбээр: Би чиний Эзэнтэн байна. Дариу углавчаа тайл. Учир нь чи ариун хөндий Туа-д байна шүү!
13. Би чамайг гэгээн элчээр сонголоо. Одоо айлдварыг минь сонс,
14. Эргэлзээгүй, Би Аллах мөн. Надаас өөр ямар ч бурхан үгүй. Надад наминчлан залбир, Намайг санан дурсахын тулд уншлага мөргөл үйлд.
15. Ертөнцийн төгсгөл ирэх нь эргэлзээгүй. Хүн бүр хийсэн үйлийнхээ хэрээр хувь хүртэх тэр өдрийг Би нууцалмуй.
16. Тэрхүү өдөрт үл итгэн, өөрийн хүсэл тачаалдаа хууртагсад чиний (ертөнцийн төгсгөлд итгэх) итгэлийг алдагдуулах вий. Хэрэв тэгвэл хатуу гэгсгээлтэй учирна шүү.
17. Аяа, Муса! Баруун гарт чинь байгаа юм юу вэ?
18. Муса: Энэ бол миний таяг, үүнийг тулдаг ба модны навчийг үүгээр унагаж хониндоо өгдөг. Бас өөр зориулалтаар ч хэрэглэнэ.
19. Аллах: Аяа, Муса! Наадахаа газарт хая! хэмээн зарлигдав.
20. Муса түүнийг газарт хаяхуйд таяг нь муруйж тахиралдсан могой болон хувирвай.
21. Аллах: Түүнийг бариад ав. Бүү айтгун. Бид түүнийг өмнөх таяг байдалд нь оруулна! гэв.
22. Одоо чи гараа өвөртөө хийгээд буцаад гарга. Ингэхэд чиний (арьсний өвчинтэй) гар өө сэвгүй, гэрэлтсэн цав цагаан байх болно. Энэ бол бидний хоёр дахь гайхамшиг.
23. Одоо чамд хамгийн агуу гайхамшигуудаа харуулах болно.
24. Фиргаун дээр очигтун. Тэр үнэхээр хэмээс хэтэрсэн байна.
25. Муса: “Эзэнтэн минь, Миний сэтгэл доторыг уужруулаад аль?;
26. Миний үйл хэргийг хялбарчилж хайрла;
27. Миний хэлний тултирааг засч хайрла;
28. Тэд миний үгийг ойлгодог болог;
29. 30. Гэр бүлээс минь садан төрөл Харуныг надад туслагч болгон хайрла;
31. Түүгээр намайг дэмжүүлэн хайрла;

32. Түүнийг миний үйл хэрэгт хамтрагч болгон хайрла;
33. Тэгснээр бид чамайг ихэд шагшин магтана.
34. Мөн Чамайг цуцалтгүй дурсмуй.
35. Эргэлзээгүй, Чи биднийг ямагт харж байдаг билээ” хэмээн залбирав.
36. Аллах: “Ая, Муса! Чиний наминчлан хүссэнийг ёсоор болгосон болой.
37. Бид чамд үүнээс өөр ч нэгэн буянтай үйлс хийсэн.
38. Тухайн үед эхийн чин зүрх сэтгэлд нь зохих айлдварыг суулгасан юмдаг.
39. Тухайлбал, хүүхдийг (Мусаг) авдарт хийж, (Нил) мөрөнд хая. Гол мөрөнгийн давалгаа түүнийг эрэг дээр гаргаж орхиг. Улмаар түүнийг Миний болон түүний дайсан Фиргаун олж аваг” хэмээсэнсэн. Миний ивээл халамжинд өсгөн хүмүүжүүлэхийн тулд чамд Өөрийн (Аллах) зүгээс өхөөрдөм хайрыг өгсөн болой.
40. Тэр үед эгч чинь Фиргауны ордонд очиж: “Та нарт түүнийг асран бойжуулах нэгэн хүнийг зааж өгч болох сон болов уу?” гэсэн. Бид тийнхүү эх чинь тайтгаран баярлаг, уйтгар гунигаа умартаг хэмээн чамайг эхэд чинь эргүүлэн өгүүлсэн юм. Дараа нь чи нэгэн хүнийг хөнөөхүйд Бид чамайг алив түгшүүр хийгээд гэгсгээлээс аварч, янз бүрийн сорилтоор шалгасан билээ. Ая, Муса! Чи тэгээд олон жилийг Мадияны ард түмний дунд өнгөрөөж, хувь тавилангаараа ийшээ зохих хугацаанд буцаж ирсэн юм.
41. Тэгээд Би чамайг Өөрийнхөө гэгээн элч болгон сонгосон юм.
42. Чи Харун дүүтэйгээ хамт Бидний ер бусын гайхамшигуудыг аваачигтун. Намайг дурсах тухайд анхаарлаа бүү сулруулцгаагтун.
43. Та хоёр Фиргаун дээр очигтун. Тэр хэмээс хэтэрч байна.
44. Гэхдээ түүнтэй эв эээр яригтун. Ятгалыг хүлээн авч юу магад! Эсвэл өөрийн араншинг бодож Аллахын хилэгнэлээс айх биз.
45. Муса, Харун хоёр: “Ая, Эзэнтэн минь ээ! Үнэндээ, тэр биднийг дээрэлхэн цээрлүүлэхээс, эсвэл улам гаарч, ёс бус авирлан хэмээс хэтрэхээс бид айж байна” гэлцэв.
46. Аллах тэдэнд: “Та нар бүү айгтун. Хэрэг дээр Би та нартай хамт бөгөөд бүхий л байдлыг сонсож, харж байх болно.”
47. Та нар Фиргаун дээр очиж түүнд: “Бид Эзэнтний чинь илгээсэн элч нар мөн. Израйлын үр садыг бидэнтэй цуг явуул, тэднийг бүү зовоо. Бид чамд Эзэнтний ер бусын гайхамшигийг авч ирсэн. Зөв шулуун замаар замнагсад л Аллахын гэгсгээлээс аврагдана”
48. “Аллахын гэгээн элч нарыг үгүйсгэж, Аллахаас урвагсад гэгсгээлтэй учирна хэмээн айлдвар илгээгдсэн” гэж хэлцгээгтүн.
49. Тэд Фиргаун дээр очиж Аллахын айлдварыг мэдэгдэхэд Фиргаун: “Ая, Муса! Та нарын Эзэнтэн чинь хэн юм бэ?” хэмээн асуув.



50. Муса: “Манай Эзэнтэн бол аливаа юмыг хэлбэр дүрстэй болгоод, тэдэнд зөв шулуун замыг заасан Аллах мөн” гэж хариулав.
51. Фиргаун: “Урьд өмнөх үеийнхний байдал хэрхсэн вэ?” гэж асуув.
52. Муса: “Тэдний тухай мэдээлэл, Эзэнтний минь нигур доорх хувь тавилангийн сударт буй. Эзэнтэн хэзээ ч андахгүй, бас мартахгүй.” гэж хариулав.
53. Аллах та нарт газрыг өлгий болгож, дээгүүр нь та нарын төлөө зам харгуй гаргаж, тэнгэрээс хур оруулан, Бид (Аллах) түүгээр зүйл бүрийн жимс, ургамлыг хосоор нь ургуулсан болой.
54. Ийнхүү та нар идэгтүн, мал сүрэгээ бэлчээгтүн. Эргэлзээгүй, энэ бүхэнд мэргэн ухааны эздийн хувьд (Аллах буйг мэдүүлэх) зохих нотолгоонууд бий.
55. Бид та нарыг газрын хөрснөөс шороо шавраар бүтээсэн, үхсэн хойно түүн рүү буцаах бөгөөд нэг удаа дахин амилуулан, түүнээс гаргамуй.
56. Андгайлан тангараглая, Бид Фиргаунд бүхий л ер бусын гайхамшигуудаа үзүүлсэн ч тэр худал хэмээн хүлээн зөвшөөрсөнгүй.
57. Тэр: “Аяа, Муса! Чи ид шидээр илбэдэн, биднийг газар нугтаас минь хөөж гаргах хэмээн ирсэн юм уу?”
58. Бид ч гэсэн чамд тийм л ид шидийг үзүүлнэ. Чи одоо бидэнтэй уулзах цаг ба газраа товлогтун. Хэн хэн нь хэлсэн үгэндээ эзэн болцгооё” гэв.
59. Муса: “Та нартай уулзах цаг бол баярын өдөр хийгээд хүмүүсийн цугларах бага үдийн цаг болог” хэмээн хэлэв.
60. Фиргаун буцаж яваад илбэчдээ цуглуулж ирлээ.
61. Муса тэдэнд: “Аяа, муу монди нар аа! Аллахыг зүхэж болохгүй шүү! Тэгэх аваас Аллах та нарыг гэсгээн үнсэн товрог болгоно. Аллахыг гүжирдэн гүтгэгсэд ялагдана шүү” хэмээн сануулав.
62. Тэд хоорондоо (Муса, Харун хоёрын талаар) мэтгэлцэн, нууцхан зөвлөлдөж эхлэв.
63. Тэд: “Энэ хоёр эргэлзээгүй ид шидтэй илбэчид. Та нарыг илбэдэн ховсдож, эх нутгаасаа хөөх гэж байна, мөн эрхэм шашиныг чинь үгүй хийнэ.”
64. “Тиймээс аргалж мэхлэх бүх илбэчдийг цуглуулж ирцгээгтүн. Өнөөдөр хэн давуу байна, тэр л гарцаагүй ялагч болно” гэлцэв.
65. Тэд: “Аяа, Муса! Чи эхлээд хаях юм уу, эсвэл бид түрүүлж хаях юм уу?” хэмээн асуув.
66. Муса: “Үгүй, та нар эхлээд хаягтун” гэв. Тэдний шидсэн аргамж дээс болон таяг нь илбэний хүчээр муруйж эвхэрсэн могой мэт харагдав.
67. Муса дотороон айж түгшиж эхлэв.

68. Бид (Аллах) түүнд: “Бүү айгтун! Чи эргэлзээгүй тэднээс давуу байх болно” хэмээн айлдав.
69. Улмаар, “баруун гаргаа буй таягаа шидэгтүн. Тэдний хийсэн бүхнийг залгих болно. Учир нь тэдний үзүүлбэр нь эгэл илбэний ов мэх төдий юм. Илбэчид хаана очсон ч нэр төр олохгүй” хэмээн сануулав. (Муса таягаа шидэхэд тэр Фиргауны илбэчдийн могойг нэг нэгэнгүй залгиж эхлэв.)
70. Ийнхүү бүх илбэчид: “Бид Муса, Харун хоёрын Эзэнтэнд сүсэглэн итгэмүй” хэмээн тэдний өмнө сөхрөн унав.
71. Фиргаун уурлан: “Намайг зөвшөөрөхөөс өмнө та нар түүнд итгэлээ гэж үү дээ?! Тэр юутай ч та нарт илбэ ухааныг заасан бишрэлт хүн чинь байж таарах нь! Би та нарын хөл, гарыг мөчлөн цавчаад, дал модон дээр цовдлон тэлүүрдмүй. Тэр цагт бидний хэний гэгсгээл хатуу болоод нөр удааныг мэдэх болно” хэмээн зандрав.
72. Илбэчид: “Чамайг бидэнд ирсэн яруу тод нотолгоонуудаас, мөн биднийг бүтээсэн Эзэнтээс хэзээ ч дээгүүр тавихгүй. Ямар зарлиг гаргасан ч бай, чи зарлиг нөлөөгөө зөвхөн энэ насанд явуулахаас хэтрэхгүй.”
73. “Бидний алдааг чиний шахалтаар үйлдсэн илбэнийхээ нүглийг өршөөгтүн хэмээн, бид үнэхээр Эзэнтэндээ наминчилж байна. Аллах илүү өлзийтэй бөгөөд үүрд мөнх шүү дээ.” хэмээн хэлцгээв.
74. Үнэндээ хэн Эзэнтэндээ нүгэлтэн хэвээр очино, тэр тамд орно. Гэд тэнд үхэх ч үгүй, амилах ч үгүй.
75. Хэн сайн үйл үйлдэж, сүсэгтэн хэвээр Түүнд очино, тэр эрхэмсэг зиндаанд орших болно.
76. Тэрхүү эрхэмсэг орших газар нь хаяагаар нь булаг урссан Гадн диваажин болой. Гэд тэндээ үүрд үлдмүй. Энэ нь нүглээс ангид хүмүүст зориулсан шан харамж бөлгөө.
77. Бид үнэндээ Муса-д: “Үнэнч боолуудыг минь (Израйлын үр садыг) шөнө дунд авч, замд гар! Таягаараа тэнгисийг балбан хуурай зам гаргаж өг. Фиргаун нэхэн хөөж гүйцэхээс бүү санаа зов. Усанд живнэ ч гэж бүү айгтун!” хэмээн айлдсан.
78. Тэдний араас нэхэн хөөсөн Фиргаун болон түүний цэргүүд тэнгисэнд живлээ.
79. Фиргаун ард түмнээ зөв замаар хөтлөхгүй ийнхүү төөрөгдүүлээ.
80. Аяа, Израйлын үр садаа! Бид та нарыг атаат дайснаас чинь аварлаа. Та нарт Таурат судрыг хүргэхийн тулд Тур уулын баруун сугыг амалсан билээ. Мөн Та нарт халваа болон бөдөн шувууг буулгалаа.
81. Та нарт хайрласан цэвэр ариун хувь хишгээс идэгтүн. Гэхдээ хэмжээг

- бүү хэтрүүлээрэй. Тэгвээс, хилэгнэл минь нэрвэх болно. Хэнд хилэгнэвэл, тэр гэсгээлтэй учирна.
82. Сайн үйлс үйлдэж, сүсэглэж, зөв шулуун замаар замнагчдыг Би үнэхээр ивээн соёрхоно.
  83. Бид: “Аяа, Муса! Чамайг Тур ууланд яаран ирэхийн тулд ард түмнээс чинь түрүүлэн ирсэн нь юу билээ?” гэж асуув.
  84. Муса: “Тэд миний араас айсуу. Эзэнтэн минь, өөрөө талархах болтугай хэмээн яаравчлан ирсэн маань энээ!” хэмээн хариулав.
  85. Аллах: “Үнэндээ, Бид чиний дараа ардуудыг чинь сорьсон. Самири тэднийг замаас нь төөрөгдүүлсэн байна” хэмээн айлдав.
  86. Тэгээд Муса гутарч бухимдсаар, ардууддаа эргэж ирээд: “Аяа, зон олон минь ээ! Эзэнтэн маань та нарт сайхан амлалт өгөөгүй сэн бил үү? Эсвэл тэр амлалт хэт хол мэт санагдав уу? Аль эсвэл та нар Эзэнтнийхээ хилэгнэлд нэрвүүлэхийг хүсээ юу? Тиймийн учир надад өгсөн амлалтаасаа няцлаа гэж үү?” хэмээн шалгаав.
  87. Тэд: “Бид чамд өгсөн амлалтаасаа өөрсдийн эрхээр няцаагүй билээ. Харин бид Фиргауны ард түмний их хэмжээний үнэ цэнэтэй зүйлсийг авч гарсан билээ. Самиригийн тушааснаар тэднийг гал дээр хаясан. Самири ч гэсэн хаясан” гэв.
  88. Тэгээд Самири галд шатаасан зүйлсийг хайлуулан, түүгээр нэгэн тугалын дүрсийг урласан. Тэр жинхэнэ тугалын адил мөөржээ. Тэд: “Энэ бол та нарын ч, Мусагийн ч бурхан болой. Гэвч Муса үүнийг мартсан” хэмээв.
  89. Тэд тугал асуултанд хариулж чаддаггүйг, хор хөнөөл ч, ашиг тус ч өгч эс чадахыг мэдэхгүй гэж үү?
  90. Үнэндээ Муса Тур ууланд буцаж ирэхээс өмнө Харун тэдэнд: “Аяа, зон олон минь ээ! Та нар үүнээс болж нэгэн сорилтонд орлоо. Та нарын Эзэнтэн бол эргэлзээгүй машид нигүүлэгч Аллах билээ. Тиймээс намайг дагаж, миний тушаалыг ёсоор болгогтун (тугалыг бүү шүтэгтүн)” гэж сануулсан юм.
  91. Тэд: “Муса бидэн дээр эргэж иртэл түүнд залбиралаа үргэлжлүүлмүй” гэлцэв.
  92. Муса буцаж ирээд дүүдээ хандан: “Аяа, Харун! Эд нарыг төөрөгдөлд орсныг харсан үедээ миний араас ирэхэд чинь юу саад болсон бэ?”
  93. Чи яагаад миний араас нэхэн ирээгүй юм бэ? Чи миний тушаалыг эсрэгүүцлээ гэж үү? гэв.
  94. Харун: “Аяа, хамаатан ахан дүү минь ээ! Миний сахал, үстэй бүү зууралд. Би чамайг: “Израйлын үр садын дунд хагарал гаргалаа, миний үгийг дагасангүй” гэж уурлана хэмээн эмээсэн бөлгөө” гэв.
  95. Муса Самирид хандан: “Аяа, Самири чи юу хийчив дээ?” хэмээн асуув.

96. Самири: “Би тэдний хараагүй юмыг харсан билээ. Жабрейл элчийн замаас нь атга шороо авч тугал руу цацсан.(Тэгээд тугал мөөрсөн юм.) Би явцуу хүслийнхээ эрхэнд хөтлөгджээ” хэмээн хариулав.
97. Муса: “Зайлагтун! Насан туршдаа “надад бүү ойрт!” хэмээн амьдарцгаа! (Дараа нь Самири халдварт өвчтэй болж үргэлжлэн “надад бүү ойрт” хэмээсэн.) Чиний хувьд хэзээ ч үл аврагдах нэгэн гэсгээлийн өдөр баймуй. Тэр хэзээ ч өөрчлөгдөхгүй. Сүсэглэн мөргөж буй бурханаа хар л даа! Андгайлан тангараглая, бид үүнийг шатааж, үнсийг нь далай тэнгис рүү цацах болно.
98. Та нарын бурхан бол цорын ганц Аллах мөн. Тэр алив бүхнийг мэддэг.
99. Аяа, Мухаммед! Бид өнгөрсөн үйл явдлын тоймоос нэгээхэн хэсгийг нь ийнхүү чамд өгүүлж баймуй. Бид өөрийн зүгээс чамд Кураныг өгсөн билээ.
100. Хэн Куранаас нүүр буруулах аваас, тэр ямар ч эргэллээгүй дахин амилах өдөр нүглийнхээ хүнд ачааг үүрмүй.
101. Тэд хүнд зовлонгоос эгнэгт үл салмуй. Дахин амилахуйн өдөр тэдний үүрсэн ачаа нь юутай муухай юм гээч!
102. Бишгүүр бүрээ үлээгдэх (Аллахын дохио) тэр өдөр Бид харалган нүдтэй, харалсан царайтай хамаг нүгэлтэнүүдийг цуглуулмуй.
103. Тэд хоорондоо: “Бид дэлхий дээр ердөө л аравхан хонолоо” хэмээн нууцхан шивнэлдэцгээнэ.
104. Тэдний юу гэж ярилцахыг нь Бид сайн мэдмүй. Шулуун шударга зарим нь: “та нар тэнд ердөө ганц л өдөр байсан” гэнэ.
105. Аяа, Мухаммед! Тэд чамаас (ертөнцийн төгсгөлийн өдөр) “уул юу болох вэ?” хэмээн асуумуй. Тэдэнд: “Эзэнтэн минь тэднийг үнсэн товрог болгон хийсгэнэ” хэмээн хэл.
106. Ийнхүү газрыг тэв тэгшхэн, эзгүй тал болгож үлдээмүй.
107. Чи тэнд бүдрэн унах овор товонг ч эс үзмүй.
108. Тэр өдөр хүмүүс дуудаачийг ямар ч эсэргүүцэлгүй дагацгаах болно. Дуу чимээ болгон нигүүлсэгч Аллахын сүрээс айж, нам гүн болох бөгөөд чи хяхнах чимээнээс бусдыг үл сонсмуй.
109. Тэр өдөр машид нигүүлсэгч Аллах зөвшөөрч, үгийг нь таалан болгоосноос бусдынх нь өмгөөлөл тусыг эс олмуй.
110. Аллах тэдний өнгөрсөн ба ирээдүйг мэддэг болой. Харин тэд өөрсдөө үүнийг мэддэггүй юм.
111. Мөнхийн амьд, эрхэмсэг орших Аллахад хүн бүр тэргүүнээ гудайлган, мэхийн ёслоно. Нүгэлтэнүүд хүчин мөхөсдөнө.
112. Үнэнчээр сүсэглэж, сайн үйл үйлдэгсэд: “буян хорогдож, нүгэл нэмэгдэнэ” хэмээн санаа зовохгүй.
113. Хүмүүс сургамж авах биз, итгэн сүсэглэх байх хэмээн араб хэл дээр

- Куран судрыг ийнхүү буулгасан билээ. Мөн түүнд төрөл бүрийн сануулгуудыг тайлбарласан бөлгөө.
114. Аллах бүхнээс эрхэмсэг, чин үнэн эзэнтэн мөн. (Аяа, Мухаммед!) Чамд Кураны айлдвар бүрэн дуусахаас наана унших гэж бүү яарагтун. “Аяа, Эзэнтэн минь ээ, эрдэм мэдлэгийг минь нэмэгдүүл” хэмээн залбир.
  115. Үнэндээ Бид өмнө нь Адамд (диваажин дахь модны жимсийг идэхгүй байх) тушаал өгсөн. Тэр үүнийг мартсан. Бид түүнд үүнийг биелүүлэх нэгэн зүтгэл олж харсангүй.
  116. Тэр үед Бид элч нартаа: “Адамд (хүмүүнд) сөгдөн мөргөгтүн” гээд тэд сөгдөн мөргөсөн. Харин Иблис таггалзсан юм.
  117. Бид: “Аяа, Адам! Энэ Иблис (чөтгөр шулам) бол чи болоод эхнэрийн чинь агаат дайсан. Тиймээс та хоёрыг уруу татан диваажингаас гаргаж, зовлонд унагаах вий.”
  118. “Диваажинд та нар өлсөхийг үл мэдэж, нүцгэн ч үлдэхгүй.”
  119. “Мөн тэнд та нар ангаж цангахгүй, аагим халуунд тарчилахгүй” хэмээн сануулсан.
  120. Эцэгт чөтгөр шулам тэднийг уруу татан: “Аяа, Адам! Чамд үхэшгүй мөнхийн хутаг олох модны жимс болон эгнэгт жаргах газрыг харуулна” хэмээн шивнэв.
  121. Тэгээд тэд (Адам эцэг ба Хауа эх хоёр) тэрхүү жимсээс идэхэд тэдний ичэмхий газрууд нь сөхөгдөж ичснээс түүнийгээ диваажин дахь модны навчнуудаар бэлэг эрхтнээ халхалцгаав. Ийнхүү Адам нүгэл үйлдэж, Аллахын ёсыг гажив.
  122. Дараа нь Эзэнтэн түүнийг өрөвдөж, гэмшсэн наминчлалыг нь хүлээн авч, зөв шулуун замд оруулсан билээ.
  123. Аллах тэдэнд: “Та нар (Адам Хауа болон үр удам) бие биендээ дайсагнан диваажингаас гарцгаагтун. Хэрэв миний зүгээс нэгэн зөв шулуун зам (судар) ирж, хэн түүнийг дагана, тэр үл төөрөлдөх ба бэрхшээл зовлон үзэхгүй.
  124. Хэн Миний айлдвар сургамжаас нүүр бууруулна, тэр тарчиг амьдарч, Ертөнцийн төгсгөлийн өдөр түүнийг сохор хэвээр нь амилуулна.
  125. Тэд: “Эзэнтэн минь, намайг юунд ингэж сохор байдалтай амилуулсан вэ? Би хараатай байсан шүү дээ?! гэж халаглах болно.
  126. Аллах: “Тийм ээ, Миний айлдварууд чамд илгээгдэхэд чи түүнийг хөсөр орхисон билээ. Харин өнөөдөр чи ч хөсөр хаягдлаа! хэмээн айлдана.
  127. Ийнхүү Эзэнтнийхээ айлдваруудад үл сүсэглэж, хэмээс хэтрэгсэдийг Бид ийнхүү гэсгээмүй. Хойд ертөнцийн гэсгээл маш хатуу, өнө мөнх болой.
  128. Өмнөх олон үеийг нь Бид гэсгээснийг тэд ухаардаггүй юм уу? Тэд өмнөх олны нутагт яваа бус уу? Үнэхээр сургамж эс авдаг гэж үү? Уул

## 21. СУРЕ АНБИЯ

- нь ухаантай хүмүүсийн хувьд энд үнэхээр сургамж болох олон зүйл байгаа шүү дээ!
129. Хэрэв Эзэнтнээс чинь өмнө нь айлдсан айлдвар хийгээд товлогдсон нэгэн цаг хугацаа үгүйсэн бол тэд гарцаагүй даруй сүйрэх л байсан бөлгөө.
130. Аяа, Мухаммед! Үл сүсэглэгсэдийн хэлснийг үл тоон, тэвчиж үз. Эзэнтэндээ нар мандахаас өмнө, жаргахаас өмнө болон шөнө дунд, бага үд ба үдээс хойш залбиран, шагшин магтаж сангалзагтун. Аллах ивээх болно.
131. Бид үл сүсэглэгсэдийг сорин туршихын тулд тэдний зарим хэсэгт нь олгосон хувь хишиг, амьд ахуйн сайн сайхныг бүү шохоорхогтун. Эзэнтнээс чамд хүртээсэн хувь хишиг ивээлтэй бөгөөд өнө мөнх бөлгөө.
132. Аяа, Мухаммед! Гэр бүлийнхэндээ (зон олондоо) уншлага мөргөл үйлдэхийг тушааж, өрөө ч энэ тухайд тууштай байгтун. Бид чамаас алив хувь хишиг эс хүсмүй. Харин ч чамайг бүхнээр хангамуй. Эцсийн буян хишиг үнэн сүсэгтэнд зориулагдмуй.
133. Тэд (үл сүсэгтнүүд): “Тэрхүү Эзэнтэн бидэнд яагаад яруу тод нотолгоо бүхий ер бусын гайхамшигийг ирүүлдэггүй юм вэ?” гэнэ. Тэдэнд түрүүчийн судрууд дахь (Таурат, Инжил дэх) яруу тод нотолгоонуудыг хамтатгасан Куран судар ирсэн биш үү?
134. Хэрэв, Бид тэднийг үүнээс өмнө (Мухаммед гэгээн элчийг илгээхээс урьд) гэсгээн хөнөөсөн бол тэд: “Аяа, Эзэнтэн минь ээ! Бидэнд яагаад нэгэн гэгээн элч илгээсэнгүй вэ? Бид зовж зүдрэхээс өмнө Таны айлдваруудад итгэн бишрэх байсан юм” гэхсэн билээ.
135. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Бүгдээрээ гэсгээлийг хүлээнэ. Та нар ч хүлээгтун. Эргэлзээгүй, хэн зөв замын эзэн болохыг, хэн зөв шулуун замаас төөрөлдснийг удахгүй мэдэх болно” хэмээн хэлэгтүн.



Мекке-д илгээгдсэн. 112 айлдвар.

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Хүмүүстэй тооцоо бодох өдөр ойртоло. Тэд үүнийг үл анзааран, үнэнээс нүүр буруулцагаж байна.
2. Эзэнтнээс өөрсдөд нь ухуулан сэнхрүүлэх сануулга ирэхүйд тэд түүнийг доог тохуу болгон сонсоцгооно.
3. Тэдний итгэл үнэмшил нь царцанги болой. Тэр харгис зальхай

- этгээдүүд шивнэлдэн: “Мухаммед бол та нарын адил ердийн хүн шүү дээ. Хуурамч илбийг харсаар байж түүнд автацгаах гэж үү дээ?” гэлцэж, нууцхан ярилцана.
4. Мухаммед: “Эзэнтэн тэнгэр, газарт яригдсан бүхнийг мэдэж байдаг. Тэр зүй ёсоор нь сонсогч, мэдэгч бөлгөө” гэв.
  5. Тэд: “Үгүй ээ, энэ бол Мухаммедын элий балай зүүд болой. Эсвэл өөрөө санаанаас зохиосон биз, аль эсвэл тэр яруу найрагч байх. Үгүй бол түрүүчийн гэгээн элч нарын адил бидний нотолгоо бүхий ер бусын гайхамшигийг авч ирэг” гэлцэв.
  6. Тэднээс өмнө Бидний сүйрүүлсэн хотын ардуудын нэг нь ч сүсэглээгүй байхад одоо тэд сүсэглэх юм гэж үү дээ?
  7. Аяа, Мухаммед! Чамаас өмнө ч Бид гагцхүү өөрсдөд нь айлдвар буулгасан эрэгтэйчүүдийг гэгээн элчээр илгээсэн билээ. Хэрэв, үүнийг эс мэдэх аваас мэргэн ухааны эздээс асуугтун.
  8. Бид гэгээн элчүүдийг хоол, унд идэж уудаггүй бодгаль амьтан болгож бүтээгээгүй болой. Мөн тэд энэ хорвоод үхэшгүй мөнх биш ээ.
  9. Дараа нь тэдэнд өгсөн амлалтаа Бид нотолсон юм. Ийнхүү Бид тэд хийгээд Өөрсдийн хүссэн хүмүүсээ аварсан. Харин хэмээ хэтрэгсэдийг цээрлүүлсэн юм.
  10. Үнэндээ, Бид та бүхний сүр хүч хийгээд нэр төрийг агуулсан Куран судрыг та нарт илгээсэн юм. Та нар үүнийг одоо хэрнээ эс ухаарна гэж үү?
  11. Бид харгис зальхайнуудын өч төчнөөн хот сууринг сүйтгэж, оронд нь өөр ардыг бий болгосон билээ.
  12. Тэд Бидний гэгсгээл ирсэнийг мэдэнгүүт зайлан одохыг оролдсон.
  13. “Бүү зугтагтун! Хамгийн чинээлэг ахуйдаа, нутаг орондоо буцацгаа! Та нараас байцаан асуух зүйл буй” хэмээн Алладын элч мэлэктүүд хошигнон хэлэв.
  14. Тэд: “Ээ халаг, бид үнэхээр зальхай этгээд байж л дээ!” гэлцэн халаглав.
  15. Бид өөрсдийг нь хяр цохиж, шатаасан галыг унтраах хүртэл тэдний ийнхүү гасалсан дуу нь тасраагүй билээ.
  16. Бид тэнгэр, газар хийгээд тэдгээрийн хооронд буй бүхнийг тоглоом болгож бүтээгээгүй билээ.
  17. Хэрэв Бид Өөрийгөө зугаацуулах ёстой бол үүнийг Өөрийн нигур дор болгоох асан буй за. Бид тийн хийх шаардлагатай байсан бол хийнэ шүү дээ.
  18. Тийм ээ, Бид худал хуурмагийг чин үнэнээр бут ниргэхийг хүсвэл халз урьдаас нь цохино шүү дээ. Тэгээд тэр даруу сүйрч үгүй болно. Аяа, хүмүүс ээ! Алладыг худал хуурмагаар дүрсэлсэн үгс чинь юутай харамсалтай вэ?!

19. Тэнгэр, газарт буй бүхэн Аллахынх болой. Түүний дэргэдэх элч мэлэк нар Түүнд сүсэглэн бишрэхээс хэзээ ч залхуурахгүй, ихэмсэг зан гаргадаггүй.
20. Тэд, эцэж цуцахыг үл мэдэн өдөр, шөнөгүй Түүнийг хүндлэн дээдлэнэ.
21. Харин буруу номтнуудын газар дээр гараар зохиосон хиймэл бурхад нь үхэгсэдийг амилуулж чадах юм уу?
22. Хэрэв, тэнгэр газарт Аллахаас өөр бурхад байсансан бол тэр хоёулаа (газар, тэнгэр хоёр) эвдрэн сүйрэх байсан биз. Отгоргуй уудмыг эзэгнэгч Аллах буруу номтнуудын дүрсэлсэн зүйлүүдээс тэс ондоо, түүнээс ангид ажгуу.
23. Аллах болгоосон зүйлүүдээсээ болж байцаагдахгүй. Харин хүмүүс байцаагдан шүүгдэх болно.
24. Аль эсвэл тэд үнэхээр Түүнээс өөр олон бурхадыг зохиож авсан юм уу? Аяа, Мухаммед! Тэдэнд: “Алив, нотолгоонуудаа харуулаарай. Харин энэ бол (Куран) надтай хамт байгсадын судар. Надаас өмнө байгсадын судар бол Таурат, Инжил, Забур зэрэг билээ” хэмээн хэлэгтүн. Гэвч тэдний олонхи нь чин үнэнийг үл мэдмүй. Тийм учраас нүүр буруулцгаадаг ажгуу.
25. Аяа, Мухаммед! Бид чамаас өмнө илгээсэн гэгээн элч нарт гагцхүү: “Эргэлзээгүй Надаас өөр ямар ч бурхан үгүй. Тиймээс зөвхөн Надад сүсэглэн мөргөгтүн” хэмээн айлдсан бөлгөө.
26. Гэвч, буруу номтнууд: “Мэлэкүүдийн зарим нь Аллахын хүү” гэж хэлцгээсэн. Аллах үүнээс ямагт ангид. Харин мэлэкүүд бол Аллахын чадварлаг боолууд нь болой.
27. Тэд хэзээ ч Аллахаас түрүүлж ярьдаггүй бөгөөд гагцхүү Түүний зарлигийг л гүйцэтгэдэг юм.
28. Аллах тэднй өмнөх хийгээд ирээдүйг мэддэг бөгөөд тэд гагцхүү Аллахын таалсан бүхнийг ивээлдээ авдаг юм. Тэд Аллахаас айж эмээн чичирцгээмүй.
29. Тэдний дундаас хэн нэг нь: “Би Аллахаас өөр нэгэн бурхан” гэх юм бол Бид түүнийг халуун тамаар гэсгээмүй. Харгис зальхай этгээдийг ийнхүү гэсгээдэг билээ.
30. Тэнгэр, газар нэгэн цул байхад Бид түүнийг зааглан салгасан юм. Амьд бүхнийг усаар бүтээснийг буруу номтнууд хардаггүй гэж үү дээ? Аллахын ид шидэнд итгэхгүй гэж үү?
31. Газар дайвалзан, хүмүүст тавгүй болохоос сэрэмжлэн дээр нь уулсыг тогтоож, зорьсон газартаа хүрэг гэж уулын зам жалгаар өргөн замыг зурайлгасан болой.
32. Бид тэнгэрийг аюулгүй, хязгааргүй цамхаг болгож бүтээсэн билээ. Тэгсээр байхад үл сүсэглэгсэд Аллахын ер бусын ид шидийг нотлох гайхамшигуудыг ч анзаардаггүй юм.



33. Аллах өдөр, шөнө, нар, сарыг бүтээсэн. Эдгээрийн тус бүр нь цамхаг доторх мандалд өөр өөрийн замаар аяндаа эргэлдэнэ.
34. Аяа, Мухаммед! Бид чамаас өмнө ч, хэнд ч, үхэшгүй мөнхийн хувийг заяагаагүй билээ. Хэрэв, чи үхвэл тэр үл сүсэгтнүүд мөнх наслах гэж үү?
35. Алив амьд бүхэн үхлийг амсмуй. Бид та нарыг сайн хийгээд муу үйлээр сорьж шалгамуй. Эцсийн эцэст та нар бүгдээрээ Бидний өмнө буцан ирэх болно.
36. Аяа, Мухаммед! Үл сүсэглэгсэд чамайг харсан үедээ: “Бидний бурхадыг үгүйсгэдэг. Нөгөөх нь энэ юм уу?” хэмээн чамаар доог тохуу хийцгээнэ. Хэрэг дээр тэд өөрсдөө машинд нигүүлсэгч Аллахаын судрыг хүлээн зөвшөөрдөггүй, үгүйсгэж байна шүү дээ.
37. Хүмүүн төрөлхтөн угаас тэвчээргүй бөлгөө. Та нарт мөдхөн яруу тод нотолгоо бүхий гайхамшигуудыг харуулмуй. Гэсгээн цээрлүүлэхэд намайг бүү яаруулагтун.
38. Хүмүүс: “Ярьсан чинь үнэн юм бол, наад гэсгээл чинь хэзээ ирэх юм вэ?” хэмээн асууна.
39. Үл сүсэглэгсэд тэр өдөр нүүр хийгээд ар нуруугаа ч галын дөлөөс хамгаалж чадахгүйгээ, хэнээс ч ямар ч тусламж авч чадахгүйгээ мэддэгсэн ч болоосой. Мэддэг л юм бол гэсгээлийн хурдан ирэхийг хүсэхгүй л байсан биз дээ.
40. Үнэндээ тэдэнд ертөнцийн төгсгөл гэнэт ирж самгардах бөгөөд тэд түүнийг зайлуулж чадахгүй, тийм боломж ч тэдэнд өгөхгүй билээ.
41. Аяа, Мухаммед! Үнэндээ, чамаас өмнөх гэгээн элчүүд ч доог тохууд өртсөн билээ. Гэвч доог хийгсэд өөрсдийн доог тохууны золиос болсон юм шүү.
42. Аяа, Мухаммед! Тэднээс: “Машид нигүүлсэгч Аллахаын гэсгээлээс та нарыг өдөр, шөнөгүй хэн хамгаалж чадах юм вэ?” хэмээн асуугтун. Тэд Аллахаыг санан дурсахаас зайлсхийсэн болой.
43. Тэднийг хамгаалах биднээс өөр бурхад байгаа юм уу? Тэдний бишрэн шүтдэг бурхад нь өөрсдийгөө ч хамгаалж чадахгүй. Бидний зүгээс ч тусламж эс олмуй.
44. Тиймээ, тэднийг болон өвөг дээдсийг нь амьд ахуйн жаргалд умбуулсан. Удаан ч амьдруулсан. Бид газар нутгийг нь тал талаас нь хүрээлэн хумиж буйг тэд харахгүй байна гэж үү? Тэгээд ч ялна гэж горьдоно уу?
45. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Бид та нарыг Аллахаын айлдвараар сануулж байна” хэмээн хэл. Гэвч, дүлий хүнд сануулсан ч сонсдоггүй юм.
46. Хэрэв тэдэнд Эзэнтний чинь гэсгээлээс өчүүхэн зүйл мэдэгдвэл тэд ямар ч эргэлзээгүй: “Ээ, халаг! Бид үнэхээр зальхай тэнэгүүд байж дээ!” хэмээн харамсана.

47. Ертөнцийн төгсгөлийн өдөр Бид шударга ёсны хэмжүүр хэрэглэмүй. Хэн ч шударга бусад эс өртмүй. Чимх будааны дайтай сайн муу үйл байсан ч Аллахын өмнө ирүүлэн хэмжиж, тооцох болно. Бидний тооцоо бодох чадамж хангалттай билээ.
48. Бид үнэндээ Муса, Харун хоёрт сайн, муу хоёрыг ялган салгах, үнэн сүсэглэгсэдийн хувьд гэрэл гэгээ хийгээд ухуулга сургамж болох судрыг илгээсэн юм.
49. Чин үнэн сүсэгтнүүд үзээгүй ч Эзэнтнээс айж эмээдэг. Дахин амилахуйн өдөр тохиохоос ч айж чичирцгээдэг.
50. Куран бол Бидний буулгасан чин үнэн ухуулан таниулах сургамж билээ. Тэгтэл үүнийг ч үгүйсгэх гэж үү?
51. Үнэхээр Бид өмнө нь Ибрахимд шударга явдлыг хайрласан бөгөөд түүнийг гэгээн элч болохыг сайн мэддэг байлаа.
52. Тэр үед Ибрахим эцэгтээ, бас ард олондоо хандан: “Та нарын сүсэглэн мөргөж буй энэ дүрсүүд чинь юу юм вэ?” хэмээн асуусан.
53. Тэд: “Өвөг дээдэс маань үүнд сүсэглэн мөргөснийг харсан юм л даа” гэлцэжээ.
54. Ибрахим: “Үнэндээ та нар ч, өвөг дээдсийнхээ адил илэрхий төөрөгдөлд автжээ” гэв.
55. Тэд: “Чи бидэнд үнэнийг хэлээд байна уу? эсвэл тоглож байна уу?” хэмээн гайхшрав.
56. Ибрахим: “Үгүй ээ, Аллах бол тэнгэр, газрын Эзэнтэн бөгөөд тэдгээрийг бүтээгч мөн. Би ч үүнийг гэрчилсэгсэдийн нэг болой” гэв.
57. Аллахын нэр барьж андгайлая! Та нар эндээс холдож явангуут та нарын зохиомол бурхадад үзүүлээд өгөмз!” гэв.
58. Дараа нь Ибрахим гар хийцний зохиомол бурхадыг хэмх цохиж, тэд буцаж ирээд үүнээс асууг хэмээн тэдний томыг л үлдээв.
59. Тэд баяраас буцаж ирээд хэмхэрхий бурхадыг харангуут: “Манай бурхадыг хэн ийн болгочих оо вэ? Хэн ч байсан ёстой л харгис зальхай бөлгөө” хэмээн шуугилдацгаав.
60. Зарим нь: “Ибрахим нэртэй нэгэн залуу эднийг муулж байгаа гэснийг сонссон” юм гэлээ.
61. Тэгтэл тэдний ахмад нь: “Ибрахимыг дариу олон түмний өмнө авч ирэгтүн! Муучлан үгүйсгэснийг хүмүүс гэрчлэгтүн” гэв.
62. Ибрахимыг ирэхүйд: “Хөөе Ибрахим! манай бурхадыг чи ийм болгоо юу?” хэмээн шалгацгаав.
63. Ибрахим: “Үгүй, үүнийг бурхадын хамгийн том нь үйлдсэн биз. Хэрэв, тэр ярьж чаддаг бол түүнээс асуу” хэмээн хэлэв.
64. Тэгэхүйд, тэд: “Та нар жинхэнэ харгис зальхай этгээд юм даа” гэж бие биеэ шүүмжилцгээлээ.

65. Дараа нь тэд гэмшин царай алдаж: “Үнэндээ, эднүүсийн ярьж чаддаггүйг Аяа, Ибрахим чи ч мэднэ биз” гэгцгээнэ шүү дээ.
66. Ибрахим: “Хэрэв тийм бол, Аллаһыг орхиж, өөрсдөд чинь тус ч, ус ч болохгүй зүйлд итгэн сүсэглэх гэж үү?”
67. Та нарын Аллаһыг орхиж сүсэглэн мөргөсөн зүйлийг үзэн ядмуй. Та нар үнэхээр эс ухаарах юм гэж үү?” гэв.
68. Тэдний зарим нь: “Та нар Ибрахимыг галдан шатаасан ч хамаагүй, өөрсдийнхөө бурхадад туслагтун. Чаддаг л юм бол өшөөг авагтун!” гэв.
69. Тэгэхэд Бид: “Аяа, гал аа! Ибрахимийн төлөө сэрүүн бөгөөд аюулгүй бол!” хэмээн тушаав.
70. Тэд Ибрахимд заналхийхэд Бид тэдний өөрсдөд нь бэрхшээл, зовлон учруулав.
71. Бид Ибрахимыг Лутын хамт аварч, ертөнцийн үр өгөөжтэй, энх амгалангийн оронд илгээсэн болой.
72. Тийнхүү Бид Ибрахимид Исхакийг, мөн Якубыг онцгой хишиг болгон хайрлаж, тэдний цөмийг нь эрхэм сүсэгтэн болгосон юм.
73. Бид тэднийг зарлигийнхаа дагуу хүмүүст зөв шулуун замыг үзүүлдэг удирдагч болгож, сайн үйлс хийхийг, уншлага мөргөлөө зүй ёсоор нь үйлдэхийг, ариуслын өглөг өгч байхыг айлдсан юм. Тэд үнэхээр бидэнд итгэн сүсэглэгсэд болсон бөлгөө.
74. (Аяа, Мухаммед) Лутыг санагтун! Бид Лут-д мэргэн ухаан, эрдэм мэдлэгийг хайрласан. Түүнийг бузар муухай явдал үүрлэсэн суурингаас нь аварсан. Тэнд үнэхээр үлгэргүй, бузар булай хүмүүс байсан ажгуу.
75. Бид Лут-ыг өөрийн хайр энэрэлд багтаасан. Тэр жинхэнэ сайн үйл үйлдэгсэдийн нэгэн байсан билээ.
76. (Аяа, Мухаммед) Нухыг санагтун! Эдгээр гэгээн элч нараас Нух ч хүсэлт тавьсан юм. Бид түүний залбирлыг хүлээн авч, гэр бүлийнхний нь хамт асар их гай барцад-усан галаваас аварсан билээ.
77. Энэхүү айлдваруудыг маань худал хэмээн үгүйсгэсэн ард түмнээс түүнийг аварсан юм. Учир нь тэд бол хорон санаат ардууд байсан бөгөөд Бид тэдний бүгдийг усанд живүүлсэн билээ.
78. Түүнчлэн Дауит болон Сүлейманыг санан дурсагтун. Нэгэнтээ шөнийн цагаар нэг омгийн хонь бусдын тариан талбайг сүйтгэсэн тухай хэргийг шүүхэд Бид тэдний шүүх ажиллагааг харж байсан.
79. Бид шүүн таслах аргыг тэр дариуд Сүлейманд сануулсан. Тэдний тус бүрд нь мэргэн ухаан, эрдэм мэдлэгийг хайрласан юм. Уулс болон шувуудыг Дауитын хамт Аллахт залбирахыг сургав. Бид ийнхүү хийсэн билээ.
80. Бид та нарыг тулалдааны үеэр шархдахаас хамгаалахын тулд Дауит-т

- хуяг дуулга хийх урлагийг зааж сургасан. Та нар үүнд талархсан гэж үү?
81. Бид Сүлейманы тушаалд догшин шуургыг захируулав. Шуурга түүний тушаалаар Бидний адислалаар ёроөгдсөн газар (Шам, Масан) руу очихоор боллоо. Бид алив бүхнийг мэддэг.
  82. Түүнд чөтгөр шуламыг бас захируулан, тэднийг усан доогуур шумбах (тэнгисийн ёроолоос сувд авч гарах), бас бусад ажлыг ч хариуцуулав. Тэднийг түүний хараанд байлгаж хянаж байсан бөлгөө.
  83. Бас Аюп-ыг санан дурсагтун. Нэгэнтээ: “Надад нэгэн гайтай өвчин үүрлэлээ. Чи нигүүлсэгсэдийн хамгийн нигүүлсэнгүй нь болой” хэмээн Эзэнтэнд залбирсан.
  84. Бид түүний залбирлыг хүлээн авч, өвчнийг нь илааршуулав. Тэрчлэн сүсэглэн мөргөгсөдөд сургамж болгохын тулд түүнд гэр бүлийг нь, бас түүнтэй хамт алдсан бүхнийг нь дүйцүүлэн дахин хайрласан билээ. (Аллах Аюп-ыг сорихын тулд үр хүүхэд, мал хөрөнгийг нь авч, өөрийг нь өвчин эмгэгтэй болгож, зовоосон ч тэр үл дугаран, шаналгаага тэвчин, хатуужил харуулсан тул өвчнийг нь ангижруулан, урьдынхаас нэг дахин илүү үр хүүхэд, эд баялаг хайрлав.)
  85. Бас Исмайл, Идрис, Зулькифлыг ч санан дурсагтун. Тэд бүгд тэвчээр хатуужлаа харуулагсад билээ.
  86. Тэгээд Бид тэднийг өөрийнхөө энэрэлдээ багтаасан. Тэд бүгдээрээ сайн сүсэгтнүүд байлаа.
  87. Бас Юнусыг дурсан санагтун. Нэгэн цагт тэр нутгийнхны бишрэл сүсэггүй байсанд нь уурлан нутгаасаа явж одохуйд, тэр Биднийг хяхан хавчихгүй хэмээн бодсон бөлгөө. Тийнхүү гүн харанхуйд (загасний хэвлийд) хавчигдаж: “Аяа, Аллах! Чамаас өөр ямар ч бурхан үгүй. Чи бол гарцаагүй чин үнэн. Би үнэхээр алдаа хийсэн байна” хэмээн залбирсан юм.
  88. Тэгээд Бид түүний залбирлыг хүлээн авч, аврага загас залгисан гай зовлонгоос нь аварсан юм. Бид үнэн сүсэглэгсэдийг ийнхүү авармуй.
  89. Бас Закарият ч санацгаа. Нэгэнтээ тэр: “Аяа, Эзэнтэн минь ээ, намайг үр удамгүй гон бие бүү үлдээгтүн. Чи бол өвлүүлэгчдийн хамгийн өгөөмөр нь билээ” хэмээн залбирсан.
  90. Бид түүний залбирлыг хүлээн авч, түүнд Яхиа хүүг хайрлаж, эхнэрийг нь хүүхэд төрүүлэх болгосон билээ. Тэд сайн сайхны төлөө яарсан юм. Бидэнд найдвар тавьж, биднээс айн эмээж, залбирцгаадаг байв. Нөгөөтэйгүүр хүндэтгэлтэй хандан залбирдаг билээ.
  91. Мөн нэр төр, ёс суртахуунаа ариунаар хадгалсан бүсгүй Мариамыг санан дурсагтун. Түүнийг Бид ивээл энэрэлээрээ тэтгэснээр жирэмсэн болж Исаг төрүүлсэн юм. Мариа болон түүний хөвгүүнийг бүхий л ертөнцөд ер бусын гайхамшигийн нотолгоо болгосон юм.

92. Аяа, хүмүүс ээ! Та нарын цорын ганц шашин бол энэхүү Ислам шашин мөн. Би та нарын Эзэнтэн билээ. Тиймээс зөвхөн Надад сүсэглэн мөргөгтүн.
93. Хүмүүс шашны талаар хэд хэдэн хэсэгт хуваагдчихлаа. Гэвч бүгдээрээ Бидний нигур дор эргэж ирмүй.
94. Тиймээс хэн нэгэн үнэнчээр сүсэглэн, сайн үйл үйлдэх аваас түүний хичээл зүтгэл талаар болохгүй. Бид түүний үйл бүхнийг тэмдэглэн бүртгэж байх болно.
95. Бидний түйвээн хөнөөсөн хот суурины иргэд энэ хорвоод эргэж ирэх магадлал үгүй.
96. Эцэст нь Яажүж, Мажүжын хэрэм хаалт нээгдэхэд тэд уул, толгод бүрээс гарч ирнэ.
97. Чин үнэнээр амлагдсан Ертөнцийн төгсгөлийн өдөр ойртохуйд үл сүсэглэгсэдийн нүд нь орой дээр гарч: “Ээ халаг, юутай харамсалтай вэ! Бид энэ өдрийг үл тоосморлон, ёстой л харгис зальхай этгээд байж дээ!” хэмээн халаглана.
98. Аяа, үл сүсэгтнүүд ээ! Та нар хийгэд Аллахаас өөр итгэн биширсэн бүхэн чинь халуун тамын түлээ болог. Өөрсдөө тэр галд орцгоох болно.
99. Хэрэв тэд (хиймэл бурхад нь) жинхэнэ бурхан бол тамын гал руу орохгүй байсан биз. Үнэндээ, бүгд (хиймэл бурхад болон түүнд сүсэглэгсэд) тэндээ үүрд үлдэцгээх болно.
100. Тэдний хувьд тамд гаслан уйлайхаас өөр сонсох юм үгүй болй.
101. Эргэлзээгүй, Бидний зүгээс сайн сайхан зүйл (диваажин) хүртэгсэд халуун тамаас ангид байх юм.
102. Тэд халуун тамын анирыг ч эс сонсох бөгөөд диваажинд сэтгэл хангалуун эгнэгт үлдэцгээх ажгуу.
103. Хамгийн агуу айдас ч тэднийг түгшээхгүй. Аллахын мэлэк элч нар нь: “Та нарт амлагдсан нөгөө өдөр энэ болой” хэмээн угтан золгомуй.
104. Тэр өдөр Бид номын хуудсыг хуйлах лугаа адил тэнгэрийг давхарлан эвхэнэ. Амьтадыг анх хэрхэн бүтээсэн, түүний адил дахин бүтээнэ. Энэ бол Бидний өөртөө хүлээсэн амлалт бөгөөд түүнийг ёсоор болгомуй.
105. Үнэндээ, Бид Таурагад бичсэний дараа Забурт ч гэсэн: “Газар дэлхийг эрхэмсэг боолууд маань өвлөх болно” хэмээн бичсэн болой.
106. Энэхүү Куранд Аллахад сүсэглэн мөргөх ард түмэнд хүрэлцэхүйц таниулга сургамж буй.
107. Аяа, Мухаммед! Бид чамайг орчлон ертөнцөд гагцхүү энэрэл нигүүлсэл болгон илгээсэн билээ.
108. Тэдэнд (хүмүүст): Надад “Та нарын бурхан бол цорын ганц Аллах мөн” гэсэн айлдвар ирсэн. “Түүнийг хүлээн зөвшөөрсөн үү?!” хэмээн хэлэгтүн.

109. Хэрэв, тэд дахин нүүр буруулах аваас: “Би та нарт бүгдийг тайлбарласан. Гэхдээ та нарт амлагдсан гэсгээл чухам ойр, хол эсэхийг би эс мэдэх бөлгөө.
110. Аллах ил, далд үг бүхнийг эргэлзээгүй мэднэ.
111. Би эс мэдмүй. Тэрхүү гэсгээлийн өдрийн хойшлогдсон нь магад та нарыг сорих шалгалт, эсвэл зуурдын тайтгарал байж юу магад” хэмээн хэлэгтүн.
112. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Эзэнтэн минь! Шударгаар шүүж хайрлагтун. Та нарын хуурамч дүрсийн эсрэг байж, бишрэн сүсэглэх эзэн минь зөвхөн энэрэн нигүүлсэгч Аллах мөн” хэмээн айлдав.



Мадина-д илгээгдсэн. 78 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Аяа хүмүүс ээ! Эзэнтнээсээ айгтун. Газар дэлхий донслох Ертөнцийн төгсгөлийн өдрийн цээрлэл үнэхээр нүсэр хүнд юм шүү.
2. Тэр нэгэн өдөр хөхүүл эхчүүд балмагдахдаа хүүхдээ хөхүүлэхээ умартан, жирэмсэн эхчүүд зулбах аюул тохиолдохыг харна. Хүмүүсийг ухаан балартсан хөлчүү байдлаар хармуй. Хэрэг дээр согтуу бус, Аллахын гэсгээл маш хатуугаас тэр л дээ.
3. Зарим хүмүүс Аллахын тухай мэдэхгүй атал арсалдан мэтгэж, харалмар чөтгөр шуламыг дагадаг.
4. “Хэн чөтгөр шуламтай нөхцөн нөхөрлөнө. Аллах түүнийг төөрөгдүүлж, халуун тамын гэсгээл рүү хөтлөн аваачдаг” хэмээн зарлигдсан болой.
5. Аяа, хүмүүс ээ! Хэрэв дахин амилахын тухай эргэлзэж буй аваас (Бидний ид шидийг мэдэж авагтун). Бид та нарыг анх шавар шороогоор бүтээж, дараа нь үрийн дуслаас, дараа нь нүжирсэн цуснаас, дараа нь дүрстэй ба дүрсгүй хэсэг махнаас бүтээсэн болой. Та нарт ойлгуулах хэмээн ийн тайлбарласан бөлгөө... Мөн Бид Өөрсдийн хүссэнийг (хэвлийд буй хүүхдийг) тодорхой цаг хугацаанд тэнд хүлээлгэмүй. Дараа нь нярай хүүхэд болгон гаргамуй. Дараа нь эрийн цээнд хүргэнэ. Мөн та нарын дотроос зарим нь нялхаараа эндэж, зарим нь мэдлэг хуримтлан, улмаар өглөн зөнөж таалал төгсөх болно. Мөн газар дэлхийг хуурайшин хатсан үхмэл байдлаар хармуй. Хэрэв, бид дээрээс нь хур буулгавал тэрээр амилан үржиж, төрөл бүрийн сайхан ургамлыг хос хосоор нь ургуулмуй.
6. Ийм байхын учир гэвэл Аллах эргэлзээгүй чин үнэн билээ. Тэр үхсэнийг амилуулдаг бөгөөд бүхэнд ид хав нь хүрдэг.

7. Ертөнцийн төгсгөл ирэх нь бас эргэлзээгүй. Аллах булшинд байгаа үхтэл бүхнийг амилуулан гаргамуй.
8. Хүмүүсийн зарим нь мэдлэггүй, удирдлагагүй, гэгээрүүлэх гэгээн сударгүй хэрнээ Аллахын тухай арсалдан мэтгэлцэх дуртай.
9. Тэд хүмүүсийг Аллахын замаас төөрөлдүүлэхийн тулд бардамнан явдаг. Тиймээс тэд энэ хорвоод гутамшиг зовлонтой учирна. Дахин амилахуйн өдөр Бид түүнд халуун тамын гэсгээлийг амсуулмуй.
10. Энэ бол өөрийн чинь гараар үйлдсэн нүгэлийн хариу болой. Үнэндээ Аллах хэнд ч шударгуу бусаар эс хандмуй.
11. Хүмүүсийн зарим нь Аллахад ёс төдий сүсэглэдэг. Өөрт нь сайн сайхан тохиох аваас сүсэглэсэн хэвээр байдаг. Харин гай барцат тохиох аваас бултан зайлж, энэ хорвоод ч, хойд ертөнцөд ч зовлон үзнэ. Энэ нь илэрхий гачлан зовлон бөлгөө.
12. Тэд, Аллахыг орхиж, өөрт нь тус ч, ус ч эс болох зүйлсэд мөргөн залбирдаг. Энэ нь жинхэнэ төөрөгдөл болой.
13. Мөн тэд ашгаасаа хор хөнөөл нь илүү зүйлсэд (зохиомол бурхад) залбирдаг. Тэр (зохиомол бурхад) юутай муухай ивээгч, юутай муухай нөхөр гээч!
14. Аллах үнэнчээр сүсэглэж, сайн үйлс үйлдэгсэдийг хаяагаар нь булаг урссан диваажинд оруулмуй. Аллах үнэхээр таалсан бүхнээ болгоомуй.
15. Хэн нэгэн Аллах гэгээн элчдээ энэ хорвоо хийгээд хойд ертөнцөд хэзээ ч туслахгүй хэмээн бодож буй бол, тэр хүзүүгээрээ дүүжлэгдээд оосорыг өөрөө огтлоод үзэг л дээ. Энэ арга нь түүний хилэнг арилгаж чадах нь уу? харагтун.
16. Ингэж Бид Кураныг яруу тод айлдваруудтай буулгасан. Аллах хүссэн хүнээ зөв зам руу оруулдаг.
17. Эцэст нь Сүсэглэгсэд, Иудэйчүүд, Сабичүүд, Христууд, Мажусичүүд (галыг шүтэгсэд), олон бурхан шүтэгч буруу номтнууд, энэ бүхэнд Ертөнцийн төгсгөлийн өдөр Аллах зарлиг буулгана. Муслманчуудыг бусдаас нь ялган салгана. Аллах алив бүхний гэрч ажгуу.
18. Аяа, Мухаммед! Тэнгэрт буй бүхэн (Аллахын элч мэлэкүүд г.м), газарт буй бүхэн (хүн, буг чөтгөр) амьд амьтад, нар, сар, тэнгэрийн эрхэс, уулс, ой мод, адгуус амьтад, үй олон хүмүүс Аллахад сөгдөн мөргөнө. Үүнийг чи харахгүй байна гэж үү? Нэг хэсэг нь үл тоомсорлосноос гэсгээл хүртэнэ. Аллах хэн нэгнийг дорд үзвэл түүнийг хэн ч өргөмжлөн хүндлэхгүй. Аллах эргэлзээгүй хүссэнээ хиймүй.
19. Хоёр өрсөлдөгч (Муслман болон буруу номтод) Эзэнтнийхээ тухайд маргалдав. Үл сүсэглэгсдэд галаар хувцас өмсүүлж, толгой дээр нь буцлам халуун ус цутгагдах болой.
20. Түүгээр тэдний хэвлий хийгээд арьсийг хайлуулах болно.

21. Тэдэнд зориулсан төмөр ташуур буй.
22. Тэд тамын гачаал зовлонгоосоо салахаар оролдох бүрийд тэднийг буцааж оруулан : “Шатаах галын гэгсгээлийг амсагтун!” хэмээгдэнэ.
23. Аллахт итгэн сүсэглэж, буянт үйл үйлдэгсэдийг хаяагаар нь булаг урсах диваажинд оруулмай. Тэд тэнд алтан бугуйвч, сувдан сондороор гоёцгооно. Тэдний өмсөх хувцас нь үнэт хоргой, торго байх бөлгөө.
24. Тэд бол (Ла-Илаха-Иллааллах, Мухаммед Расулаллах) гэсэн сайшаалын үгс айлдан, эрхэм Аллахын зөв шулуун зам руу хүргэгдсэн хүмүүс билээ.
25. Үл сүсэглэгдэд, Аллахын зөв замд саад бологсдод, тэрчлэн байнгын оршин суугчид болон холоос яваа зорчигчид, бүхий л хүмүүсийн залбирлын газар-Масжид Аль-Харамын замд саад бологсдод, мөн Масжид-Аль-Харамд байхад урваж, харгис зальхай үйлдэл хийхийг санаархагсдад ч хатуу цээрлэлийн амтыг үзүүлэх болно.
26. Тухайн үед Бид Ибрахимд Кагба-гийн байрлалыг зааж өгч: “Надтай хэнийг ч гэсэн бүү эн зэрэгцүүл. Тойрон алхаж залбирагсад, эгцлэн харж зогсон залбирагсад, сөгдөн мөргөн залбирагсадын төлөө миний ариун орон болох Кагбаг цэвэр ариун байлга” хэмээн айлдсан билээ.
27. Хүмүүсийг хаж мөргөлд уриалан дуудагтун. Тэд явган эсвэл эцэж цуцсан тэмээ унаж (алсын замыг) туулж ирцгээнэ.
28. Тэд өөрт нь оногдох ашиг тусыг харцгааг, бас Аллахын өөрсдөд нь буян хишиг болгож хайрласан малаас товлосон (курбаны) өдрүүдэд Аллахын нэрээр өглөг өгөг. Өөрсдөө тэр курбанд зориулсан махнаас идэцгээгтүн. Бас үгээгүй ядуусыг хооллуулагтун.
29. Дараа нь тэд биеэ ёсчлон цэвэрлэцгээг, (усанд орж, хумс, үсээ авхуулан) авсан амлалт, андгай тангарагаа биелүүлцгээг, мөн ариун Кабаг тойрон залбираг.
30. Хаж мөргөлийн дэг ёс энэ болой. Хэн Аллахын номлолыг хүндэтгэнэ, түүнд Эзэнтний нигур дор өлзий буян буй. Та нарын хувьд Куранд хориглосноос бусад мал амьтад халаал-цэвэр ариун хэмээн зөвшөөрөгдлөө. Тиймээс сэжиглэм бузар муухай зохиомол бурхадаас хол байгтун, худал хуурамч үгнээс ангид байцгаа.
31. Аллахтай бусдыг эн зэрэгцүүлэлгүйгээр, үнэнчээр сүсэглэгтүн. Хэн Аллахтай алив бусдыг эн зэрэгцүүлнэ, тэр яг л тэнгэрээс унахуйд нь шувууд шүүрэн одсон, эсвэл шуурга алс хол хийсгэн хаясан зүйлийн адил болно.
32. Нөхцөл байдал ийм ажгуу. Хэн Аллахын шашны онцлох шинжийг хүндэтгэнэ, тэр нь зүрх сэтгэлийн дуудлага болой.
33. Тодорхой хугацаа хүртэл Аллахын нэрээр Курбанд зориулсан малыг унаж, төллүүлж, сааль сүүгийг нь ашиглаж болно. Дараа нь тэдгээрийг төхөөрөх газар бол Байтуллагийн дэргэд (Кагба) болой.



34. Бид, алив ард олонд хайрласан мал сүргээс Алладын алдрыг дурсаж, курбан буюу өглөг болгон өргөхийг тэмдэглэсэн юм. Та нарын Эзэнтэн чинь цор ганц Аллах болой. Тийм болохоор зөвхөн Түүнд мөргөн залбирагтун. (Аяа, Мухаммед) Аллахад итгэн бишрэгч эгэл ардад баярт мэдээ буй.
35. Алладын алдрыг дурсахуйд тэдний зүрх сэтгэл нь догдлоно. Мөн өөрсдөд нь тохиох бэрхшээлийг тэвчинэ, уншлага мөргөлөө зүй ёсоор нь үйлдэнэ, Бидний өөрсдөд нь хувь хишиг болгон өгсөн зүйлсээс Алладын нэрээр сайн сайхны төлөө өглөг өргөж зарцуулсанаа.
36. Курбаны өглөг болгох бог малыг (тэмээ, үхрийг ч гэсэн) та нарт Алладын шашины бэлгэдэл тэмдэгүүдийн нэг болгосон. Та нарын төлөө түүнд илүү өлзий буян буй. Тиймээс тэдний урд хоёр хөлийг нь өвдөглүүлэн уяж, хоолойг огтлохдоо Алладын алдрыг дурсагтун. Нэгэнт хажуулдуулан унагааж, амь тасалсан хойно төхөөрөн, өөрсдөө идэхийн хамт хүлцэн гуйгсад болон та нарын гарыг харагсадыг хооллуулагтун. Ийнхүү та нар талархаг хэмээн Бид малыг та нарт ийн захируулсан болой.
37. Мэдээж тэдний мах, цус нь Аллахад эс очмуй. Гагцхүү Түүнд та нарын чин сүсэглэл нь очмуй. Та нарыг зөв шулуун замаар хөтөлсөн Алладын эрхэмлэн дээдэлсний чинь төлөө тэдгээрийг (малыг) та нарт захируулсан болой. Аяа, Мухаммед! Сайн үйлс үйлдэгсэдэд баярт мэдээг дуулгагтун.
38. Аллах сүсэглэсэдийг эргэлзээгүй хамгаална. Харин хор уршигтай урвагчдыг хэзээ ч үл таална.
39. Харгис зальхай явдалд автан, дайн самуунд нэрвэгдэгсэдэд эсэргүүцэл үзүүлэхийг зөвшөөрсөн болой. Тэдэнд туслан хамгаалахдаа Алладын хүч чадал хангалттай билээ.
40. Тэд зөвхөн: “Бидний Эзэнтэн Аллах” гэснийхээ төлөө гэм зэмгүйгээр нутгаасаа хөөгдсөн хүмүүс. Хэрэв, Аллах хүмүүсийг хүмүүсээр хамгаалуулахгүй байвал Христын сүмүүд, Иудэйчүүдийн залбирлын газрууд, Алладын нэр олонтой дурсагдах Мэсжидүүд (Мечит) бүгд адил сүйтгэгдэх байсан. Хэн Алладын шашинд туслана, Аллах түүнд тусална. Аллах үнэндээ машид хүчирхэг бөгөөд нэн агуу бөлгөө.
41. Хэрэв, Бид тэдэнд (Алладын шашинд туслагчдад) газар дэлхий дээрх бүх эрх мэдлийг өгвөл тэд уншлага мөргөлөө үйлдэн, ариуслын өглөг өгч, бусдыг сайн сайханд уриалж, бузар муухайг таслан зогсоох л байсан. Бүхий л үйлийн үр дүн Алладынх болой.
42. Аяа, Мухаммед! Хэрэв тэд (Меккегийн үл сүсэглэгчид) чамайг худалч хэмээн хүлээн зөвшөөрөхгүй бол чи ганцаараа биш ээ! Өмнөх Нухын ардууд, Гад болон Самудын ардууд ч гэгээн элч нараа хүлээн зөвшөөрөөгүй юм.
43. Тэрчлэн Ибрахим хийгээд Лут-ын ардууд ч ийм байсан юм.

44. Мөн Мадияны ардууд ч ийм байсан билээ. Муса-г ч худалч хэмээн үгүйсгэсэн юм. Тэгээд Би эдгээр үл сүсэглэгсдэд хэсэг хугацаагаар боломж өгөөд, дараа нь тэднийг гэсгээсэн билээ. Ямар байна даа?
45. Оршин суугчид нь харгис зальхай нүгэлтэн байснаас олон хот сууринг туйвээсэн билээ! Одоо тэд орвонгоороо эргэж, хоосон худаг, хоосорсон шилтгээнүүд л үлдлээ!
46. Тэд (Чамайг үгүйсгэгсэд) хаа сайгүй хэрэн хэсүүчлээгүй гэж үү? Ийнхүү тэдний эдгээрийг мэдрэх зүрх сэтгэл, сонсох чих үгүй юм уу? Үнэндээ, тэдний нүд нь сохор бус, аюулхай цээжин дэх сэтгэл нь сохор ажгуу.
47. Аяа, Мухаммед!Тэд (үл сүсэглэгсэд) тохуурхан чамаас гэсгээлээ яравчуулахыг хүсэцгээдэг. Гэвч Аллах амлалтаасаа буцахгүй.(Цаг нь болоход гэсгээлээ үзнэ) Эргэлзээгүй, Эзэнтний чинь нигур дорх нэг өдөр та нарын тоолж буй мянган жилтэй тэнцүү болой.
48. Оршин суугчид нь харгис зальхай байсан ч олон хот сууринд боломж олгон хүлээлгээд, дараа нь тэднийг гэсгээсэн юм. Эцэст буцаж ирэх газар нь Миний нигур дор билээ.
49. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Хүмүүс ээ, би та нарт гагцхүү тодорхой сэрэмжлүүлэгч төдий шүү дээ” хэмээн сануулагтун.
50. Наминчлан сүсэглэж, сайн үйл үйлдэгсэдийн хувьд өршөөл хийгээд үнэ цэнэтэй, дуусашгүй, өгөөмөр хувь хишиг байгаа” хэмээн хэлэгтүн.
51. Бидний айлдваруудыг сулруулахын төлөө зүтгэгсэд бол тэр халуун тамынхан мөн.
52. Аяа, Мухаммед! Чамаас өмнө хэн нэгэн элч, гэгээнтнийг илгээхэд тэд Аллахын айлдваруудыг судлан зорьсон цагт чөтгөр шулмас түүний чин хүсэлд саад болон эргэлзээ төрүүлдэхийг хичээсэн байлаа. Аллах чөтгөрийн саад, эргэлзээг үгүй хийгээд өөрийн айлдваруудаа бататгадаг байлаа. Аллах бүхнийг мэдэгч, мэргэн ухааны Эзэн бөлгөө.
53. Аллахын ийнхүү хийснээр зүрхэнд шар ус хурагсадыг, итгэл үнэмшил нь алдарагсадыг чөтгөрийн саад түйтгэрээр сорьдог байв. Харгис зальхайчууд (чин үнэнээс) холдон, төөрөлдсөөр байна.
54. Аллахын ийн хийсэн нь эрдмийн эзэд Кураныг Аллахын зүгээс ирсэн чин үнэн гэдгийг мэдэж, түүнд итгэж, зүрх сэтгэлээрээ сүсэглэхийн төлөө байлаа. Аллах сүсэглэгсэдийг эргэлзээгүйгээр зөв зам руу хөтөлж байдаг юм.
55. Үл сүсэглэгсэд ертөнцийн төгсгөлийн өдөр гэнэт ирэх хүртэл, эсвэл үйлийн үртэй нэгэн өдрийн гэсгээл тохиох хүртэл Куранд эргэлзсээр байдаг юм.
56. Тэр өдөр эзэгнэл зөвхөн Аллахынх ажгуу. Хүмүүнийг шударгаар шүүх болно. Сүсэглэж сайн үйлдэгсэд болвоос Нагим диваажинд байх бөлгөө.

57. Харин үл сүсэглэж, Бидний айлдваруудыг үгүйсгэгсэд зовлонт гэсгээлтэй учирна.
58. Аллахын төлөө нутгаасаа дүрвэсэн, дараа нь дайсны гараар амь үрэгдсэн, эсвэл хувь тавилангаар нас барсан хүмүүст Аллах ямар ч эргэлзээгүй өгөөмөр хувь хишиг хайрлана. Хишиг хүртээгсэдээс хамгийн сайн нь Аллах билээ.
59. Аллах тэднийг үнэнхүү тааламжит газарт зална. Аллах аугаа мэдэгч, машид нигүүлсэгч бөлгөө.
60. Үнэндээ ийм баймуй! Хэн харгислалд өртөж, түүний хариуг зохих ёсоор авсан ч, дараа нь дахин хүчирхийлэл, харгислалд автвал Аллах түүнд эргэлзээгүй туслана. Аллах машид нигүүлсэгч, нэн өршөөгч билээ.
61. Аллах ийнхүү шөнийг өдөр, өдрийг шөнө болгоно. (Өдөр шөнийн тэнцэл ба урт, богино болох нь улирлын солилцоогоор зохицуулагдаж байна.) Аллах бүхнийг сонсогч, бас зүй ёсоор нь харагч билээ.
62. Энэ бүхэн Аллахын чин үнэнтэй холбоотой бөгөөд буруу номтнуудын сүсэглэн мөргөж буй бүхэн хоосон зүйл. Аллах үнэхээр дээгүүр бөгөөд аугаа ажгуу.
63. Аллах тэнгэрээс хур буулгаж, түүгээр газар дэлхийг ногооруулж буйг чи харахгүй байна гэж үү дээ! Аллах машид хайрлан энэрэгч, бүхнийг бүрэн дүүрэн мэдэгч болой.
64. Тэнгэр, газарт буй бүхэн зөвхөн Түүнийх билээ. Үнэндээ, Аллах гачигдаж дутагдах юмгүй (баян), магтвал зохилтой билээ.
65. Аллах газар дэлхийн бүх зүйлийг, Өөрийн зарлигаар тэнгис далайгаар явагч хөлөг онгоцуудыг та нарт захируулсныг, тэнгэрийг газар луу унагаахгүй тогтоон барьж байгааг хараагүй гэж үү? Тэнгэрийг зөвхөн Ертөнцийн төгсгөлийн өдөр Өөрийнхөө зарлигаар буулгана. Аллах, хүн төрөлхтөнд үнэхээр энэрэнгүй, машид нигүүлсэнгүй ажгуу.
66. Аллах та нарыг эхлээд амьдруулсан, дараа нь үхүүлнэ, дараа нь дахин амилуулах болой. Хүмүүн үнэндээ машид тоомсоргүй, харалган билээ.
67. Бид ард түмэн бүрт өөрсдөө гүйцэтгэх нэгэн сүсэг мөргөлийн ёс журмыг (шариатыг) тогтоож өгсөн билээ. Аяа, Мухаммед! Тэд (үл сүсэглэгсэд) энэ тухайд чамтай бүү мэтгэлцэг. Тэднийг Эзэнтний зүг рүү хандуул. Чи маргаангүй зөв шулуун зам дээр байгаа.
68. Хэрэв тэд чамтай маргалдвал: “Аллах та нарын хийсэн бүхнийг сайн мэдэж буй”
69. “Аллах ертөнцийн төгсгөлийн өдөр та нарын байнга зөрөлдөн маргалдсан зүйлийг шүүн шийдвэрлэнэ” хэмээн хэлэгтүн!
70. Аллах тэнгэр, газарт буй бүхнийг мэддэг гэдгийг та нар ухаардаггүй юм уу? Энэ тухай хувь тавилангийн дэвтэрт (Лаухул Макфузд) бичигдсэн байгаа. Энэ тухай мэдэх нь Аллахад үнэнхүү хялбар болой.

71. Тэд Аллагаас өөр ямар ч нотолгоо үл буулгагдсан, өөрсдөө мэддэггүй нэгэн зүйлд (хиймэл бурхадад) сүсэглэн шүтдэг. Ийм л зальхай этгээдэд ямар ч туслагч үгүй.
72. Үл сүсэглэгч (Куффаруудад) Манай айлдваруудыг уншиж өгөхөд тэдний царайнаас дургүйцлийн шинжийг олж харна. Тэд манай айлдваруудыг уншиж өгсөн хүн рүү дайрахад ч бэлэн байдаг. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Би та нарт үүнээс ч долоон дор юмны тухай дуулгадаг ч юм билүү? Тэр бол тамын гал. Аллах түүнийг үл сүсэглэгсдэд зориулсан. Тэр юутай муухай газар юм гээч!” хэмээн хэл.
73. Аяа, хүмүүс ээ! Та нарт нэгэн жишээ өгөгдлөө. Үүнийг сонсогтун: Та нарын Аллахыг орхиж, шүтэн тахисан зүйлс чинь бүгдээрээ нийлээд ганц ялааг ч бүтээж чадахгүй. Ялаа тэднээс бие цогцосоос нэг юм булаахад тэд түүнийгээ ч буцааж авч чадахгүй. Учир нь шүтсэн, шүтүүлсэн хоёулаа чадал мөхөс билээ.
74. Тэд Аллахыг зохих ёсоор хүндэтгэн үзсэнгүй. Гэхдээ Аллах аугаа хүчирхэг бөгөөд машид эрхэмсэг ажгуу.
75. Аллах мэлэкүүд болон хүмүүсийн аль алианаас элчээ сонгосон. Аллах хязгааргүй бүхнийг сонсогч, харагч билээ.
76. Аллах боолуудынхаа өнгөрсөн ба ирээдүйг мэддэг. Эцэст нь аливаа үйл бүхэн Аллах руу буцаагдмуй.
77. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Эзэнтэндээ мэхийн мөргөгтүн, сөгдөн мөргөгтүн, мөн сүсэглэн мөргөгтүн. Бас сайн үйл үйлдэгтүн, тэгвээс зорилгодоо хүрэх болно.
78. Аллахын төлөө чин сэтгэлээр тэмцэгтүн. Тэр та нарыг сонгосон, мөн шашны тухайд та нарт ямар нэгэн хүндрэл учруулаагүй.(шалтгаантай бол албадахгүй) Энэ бол та нарын эцэг Ибрахимийн шашин болой. Аллах та нарыг үүнээс өмнө (Инжил болон Тауратад) ч, одоо ч (Куранд) элч нарыг та нарт гэрч болохын тулд, та нар ч хүмүүст гэрч болохын тулд “мусулман” хэмээн нэрлэсэн бөлгөө. Гиймээс уншлага мөргөлөө зүй ёсоор нь үйлдэгтүн, ариуслын өглөгөө өгөгтүн, бас Аллахыг түшигтүн. Тэр бол та нарын Эзэнтэн болой. Аллах юутай сайхан Эзэнтэн бэ, юутай сайхан ивээгч бэ!



## 23. СУРЕ МҮМИНУН

Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Үнэнч сүсэглэгсэд эргэлзээгүй, аз жаргалд хүрнэ.
2. Тэд уншлага мөргөлдөө хянамгай байдаг.

3. Тэд хоосон яриа, үр ашиггүй зүйлсээс ангид.
4. Тэд ариуслын өглөгөө өгөцгөөдөг.
5. Тэд ичгүүр сонжууртай, нэр төрөө хамгаалдаг.
6. Өөрийн эхнэрүүд хийгээд боол шивигчин нартай байвал буруугүй.
7. Хэн энэ бүхнээс бусдыг хүснэ, тэр хэм хэмжээг зөрчигчид мөн.
8. Тэд (сүсэгтнүүд) өөрсдийн авсан үүрэг, амлалтандаа үнэнч болой.
9. Тэд уншлага мөргөлөө нямбай ёсчлон үйлдэцгээдэг.
10. Ийнхүү тэд диваажингийн жинхэнэ эзэд билээ.
11. Тэд Фирдаус хэмээх диваажинг өвлөн авч, тэндээ үүрд үлдэцгээнэ.
12. Бид үнэндээ хүмүүнийг шаврын зуурмагаар бүтээсэн билээ.
13. Дараа нь түүнийг найдвартай газар болох хэвлийд байх дусал болгон хувиргасан юм.
14. Тэгээд тэрхүү дуслар нөжирсөн цус бүтээж, цусыг цул мах болгон, махнаас ясыг бүтээж, улмаар ясыг махаар бүрсэн билээ. Дараа нь түүнийг өөр нэгэн амьд онцгой бүтээл (хүмүүн) болгон бүтээсэн юм. Агуу Аллах бол хамгийн уран бүтээгч мөн.
15. Үүний дараа та нар эргэлзээгүй үхэх болно.
16. Дараа нь та нарыг ертөнцийн төгсгөлийн өдөр эргэлзээгүй дахин амилуулна.
17. Бид та нарын дээгүүр долоон зам (Долоон давхар тэнгэрийг) бүтээсэн. Бид бүтээсэн (амь) амьтадын талаар мэдээлэлтэй байдаг юм.
18. Бид тэнгэрээс зохих хэмжээгээр хур буулгаж түүнийг газар дээр тогтоов. Түүнийг ширгээн үгүй хийхэд бидний хүч чадал хүрэлцэнэ.
19. Ийнхүү хурын усаар та нарын иддэг хасарваань, усан үзмийн ороонгны цэцэрлэгийг ургуулсан.
20. Бас Тур-Сина ууланд соёолсон модыг бий болгосон. Түүнээс тос болоод хоолны хольц (чидун жимс) гарган авдаг болов.
21. Үнэндээ, мал амьтадад ч та нар сургамж авах зүйл буй. Тэдгээрийн сүүгээр та нарыг ундаалмуй. Мөн тэдгээрт та нарын төлөө ашигтай олон зүйлс буй. Бас тэдний махыг ч идэцгээнэ.
22. Тэднийг хийгээд усан онгоцыг унаагаа болгон ачаална.
23. Бид Нухыг өөрийн ард түмэнд нь гэгээн элчээр илгээсэн. Тэр ард олондоо: “Аяа, зон олон минь ээ! Гагцхүү Аллахад сүсэглэн мөргөгтүн, Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Аллагаас айдаггүй юм гэж үү дээ?” хэмээн хэлэв.
24. Түүний ард түмний үл сүсэглэгээд нь: “Нух бол та нарын адил хүн шүү дээ, гэтэл та нараас илүү эрх мэдэлтэй байх гэнэ. Хэрэв, Аллах гэгээн элч илгээх байсан бол элч-мэлэжүүдээ явуулах байсан шүү дээ. Бид ийм үгийг өвөг дээдсээсээ ч сонсоогүй билээ”

25. “Тэр бол ердөө л солиотой амьтан. Тиймээс, нэг хэсэгтээ түүнийг ажиглаж хүлээгтүн!” гэлцэв.
26. Нух: “Аяа, Эзэнтэн минь! Тэд намайг худал хэмээн үгүйсгэсний хариуд намайг ивээн туслагтун?” хэмээн залбирав.
27. Бид түүнд: “Бидний айлдсаны дагуу, мөн Бидний нүдний өмнө хөлөг онгоц хийгтүн. Бидний тушаал бууж, зуухны ус буцлан оргилох цагт, алив амьтадаас эр, эм нэг хосыг, мөн өөрийнхөө гэр бүлийнхнээс урьд нь шийтгэгдсэнээс бусдыг нь усан онгоцонд суулгагтун. Үл сүсэглэсэдийн тухайд надад залбирахын хэрэг үгүй. Тэд усанд живэх болно” хэмээн айлдав.
28. Чи өөртэй хамт байгсадтай усан онгоцонд гарсны дараа: “Биднийг харгис зальхай түмнээс ангижруулсан Аллахыг шагшин магтмуй” хэмээн хэл.
29. Мөн: “Аяа, Эзэнтэн минь! Намайг үр өгөөжтэй нэгэн газарт хүргэж хайрла. Хамгийн сайн байршуулагч Чи билээ?” хэмээн залбир.
30. Үүнд үнэндээ олон сургамж буй. Бид ийнхүү боолуудаа сорьдог юм.
31. Тэднээс хойш өөр нэгэн зон олныг бий болгосон.
32. Тэдэнд ч дотроос нь нэгэн гэгээн элчийг (Лутыг) илгээв. Лут олон түмэндээ хандан: “Аяа, зон олон минь! Гагцхүү Аллахад сүсэглэн залбирагтун. Түүнээс ондоо ямар ч бурхан үгүй. Аллагаас айдаггүй юм уу?” гэв.
33. Түүний ард түмнээс, үл сүсэглэгч хойд ертөнцөд очихыг үгүйсгэгч, Бид энэ хорвоод өөрсөд нь чинээлэг аж байдал хайрласан зарим зөрүүд хүмүүс: “Энэ бол ердөө л та нарын адил хүн, та нарын идсэнийг идэж, уусныг уудаг.
34. Та нар өөрсөдтэйгээ адилхан нэгэн хүнийг дагавал гарцаагүй хохирол амсах болно.
35. Та нарыг үхэж хувхай яс, хумхийн тоос болсон хойно чинь дахин амилцгаана гэж сануулж байна уу?
36. Та нарт амлагдсан энэ нь үнэхээр үнэмшилгүй алсын алсад юм!
37. Бидэнд энэ хорвоогийн амьдрал л заяагдсан. Бид үхдэг, нэг нь үхвэл нөгөөдүүл маань төрнө, харин үхсэнийхээ дараа дахин амилна гэж үгүй.
38. Энэ хүн Аллахын тухайд ердөө л худал хэлж буй, бид түүнд эс итгэмүй” гэлцэв.
39. Иймд гэгээн элч: “Аяа, Эзэнтэн минь! Намайг худал хэмээгсэдийн эсрэг зогсоход туслагтун?! хэмээн залбирав.
40. Аллах: “Тун удахгүй тэд харамсах болно” хэмээн айлдав.
41. Тэд үнэхээрийн муухай ёрын орь дуугаар нэрвэгдэв. Тэднийг бид хөсөр

- новш болгон шүүрдэв. Ийнхүү зальхай хүмүүс Аллахын энэрэлээс ангид хоцров!
42. Бид тэднээс хойш өөр нэгэн зон олныг бий болголоо.
  43. Ямар ч ард түмэн өөрсдөд нь товлогдсон цагаас өмнө эсвэл хойно явахгүй.
  44. Дараа нь Бид гэгээн элчүүдээ ээлж дараалан илгээсэн билээ. Аль ч ард түмэнд гэгээн элч ирэхүйд, тэд түүнийг худал хэмээн үгүйсгэсэн билээ. Бид ч тэднийг ар араас нь үгүй хийгээд, сургамжит түүх болгон хувиргалаа. Ийнхүү үл сүсэглэгчид Аллахын хайр энэрэлээс ангид үлдсэн болой!
  45. Дараа нь Бид айлдварууд хийгээд яруу тод нотолгоогоор Муса болон түүний ахан дүү Харуныг илгээлээ.
  46. Ийнхүү Бид тэднийг Фиргаун болон түүний ардад илгээсэн юм. Харин тэд бардамнасан ихэмсэг улс байлаа.
  47. Тэд: “Бидэнтэй адил энэ хоёрт итгэх гэж үү? Эдний ардууд бидэнд боолчлогдож байгаа биз дээ?” гэлцэв.
  48. Ингэж тэд Муса, Харун хоёрыг хүлээн зөвшөөрсөнгүй. Тийм болохоор өөрсдөө ч сүйрсэн юм.
  49. Бид магад тэд (Израйлийн үр сад) зөв замыг олог гэж, Мусад ариун судрыг (Тауратыг) хайрласан билээ.
  50. Бид Мариямын хүү Иса болон түүний эхийг ер бусын гайхамшгийнхаа нотолгоо болгож, ус элбэгтэй, өндөрлөг толгодын дунд амар жимэр байршуулсан юм.
  51. “Аяа, гэгээн элчүүд ээ! Цэвэр ариун хүнсээс идэгтүн. Сайн үйлс үйлдэгтүн. Би та нарын хийж буй бүхнийг мэдэж баймуй.
  52. Үнэндээ та нарын зон олон бол нэг л ард түмэн (нэг л шашинтнууд). Би ч та нарын цорын ганц Эзэн мөн. Надаас айгтун!” хэмээн сануулсан билээ.
  53. Гэвч тэд (зон ардууд) шашны хувьд хэд хэдэн хэсэгт хуваагдаж, бүлэг бүр өөрсдийн шашиндаа талархцгаав.
  54. (Мухаммед) Одоо чи тэднийг нэг хэсэгтээ (насан эцэслэх хүртэл) төөрөлдсөн чигээр нь орхигтун.
  55. Бид тэдэнд мал хөрөнгө, хүн бүл хайрласныг тэд:
  56. Өөрсдийг нь яаруу-сандруу малжууллаа хэмээн бодож байна уу? Үгүй дээ, тэд учрыг нь даанч ойлгохгүй байна даа.
  57. Харин Эзэнтнээсээ айж эмээгсэд;
  58. Эзэнтнийхээ айлдваруудад итгэгсэд;
  59. Эзэнтэндээ бусдыг эс эн зэрэгцүүлэгсэд;
  60. Мөн Эзэнтний өмнө эргэж очихоос эмээн өглөг өргөгсөд бол,

61. (Тэд) сайн үйлсийн төлөө яарагсад бөгөөд түүнийхээ төлөө уралдагсад бөлгөө.
62. Бид, хүмүүсийн хэр чадалд тааруулан үүрэг хүлээлгэдэг. Бидний өмнө чин үнэнийг хэлэгч нэгэн ном бий. (Тэр Лаухул Махфуз буюу хувь тавилангийн дэвтэр.) Тэд шударга бусад хэзээ ч үл өртмүй.
63. Гэвч тэд (нүгэлт үл сүсэглэгчид) итгэлгүй, хайхрамжгүй. Үүнээс ч өөр муу муухай үйл үйлддэг юм.
64. Эцэст нь Бид тэдний элбэг дэлбэг эд хөрөнгийг нь гайтуулан цээрлүүлэхүйд тэд орь дуу тавин, зовлонгоо эдлэнэ.
65. “Өнөөдөр орилоод нэмэргүй! Бидний зүгээс та нарт ямар ч тусламж үгүй!.
66. Бидний айлдварууд уншигдахүйд та нар үл итгэн, нүүр буруулцгаасан билээ.
67. (Масжид-Аль-Харам буюу Кагбагийн иргэд байсанаараа) ихэмсэглэн бардамнаж, шөнөжин дэмий бурж будилдагсан билээ.
68. Тэд Кураны тухай огт бодоогүй гэж үү? Аль эсвэл тэдэнд, өвөг дээдэст нь ч ирж байгаагүй зүйл ирлээ гэж үү?
69. Үгүй бол, гэгээн элчээ таниагүйгээс үүнийг үгүйсгэж байна уу?
70. Аль эсвэл түүнийг (гэгээн элчийг) галзуу солиотой гэж бодно уу? Үгүй шүү дээ, Харин ч гэгээн элч тэдэнд чин үнэнийг авч ирсэн. Гэвч, тэдний олонхи нь чин үнэнээс жийрхдэг юм.
71. Хэрэв, чин үнэн (Куран) тэдний муухай хүсэл тачаалд нь нийцсэн бол тэнгэр, газар болон түүнд буй бүхэн гарцаагүй сүйрэх байсан биз. Эсрэгээр нь, Бид тэдэнд ухуулан таниулах Кураныг ирүүлсэн. Тэд Кураны айлдваруудаас зайлсхийв.
72. Аяа, Мухаммед! Эсвэл чи тэднээс шан харамж гуйсан юм уу? Эзэнтний чинь өгөөж нь түүнээс хавьгүй илүү өлзийтэй. Тэр хишиг хүртээгсэдийн хамгийн эрхэмсэг нь шүү дээ.
73. Мэдээж, чи тэднийг зөв зам руу дуудна.
74. Гэвч ергөнцийн төгсгөлд үл итгэгсэд бол чин шударга замаас зайлсхийгсэд мөн.
75. Хэрэв, Бид тэднийг өрөвдөж, толгойд нь нүүрлэсэн гай зовлонг зайлуулсан ч тэд төөрөлдсөндөө зөрүүдлэн, сажилсаар л одно.
76. Тэднийг гай зовлонгоор цээрлүүлсэн ч Эзэнтнээ хүлцэн зөвшөөрөөгүй, наминчлан залбирсангүй.
77. Тэдний өмнө таны гэсгээлийн үүдийг нээх цагт л балмагдан бүрмөсөн итгэл алдарна.
78. Аллах та нарыг чих, нүд, сэтгэл зүрхтэй болгосон ч талархах талаар тун алгуур юм.



79. Аллах та нарыг газар дэлхий дээр хаа сайгүй өсгөн үржүүлсэн. Чинхүү та нар хожим Түүний өмнө цугларна шүү дээ.
80. Тэр үхэгсэдийг амьдруулж, амьд амьтадыг үхүүлэх болой. Шөнийг өдрөөр солих нь Түүний эрхшээлд буй. Та нар үүнийг ухаардаггүй юм гэж үү?
81. Гэтэл тэд өвөг дээдсийнхээ ярьдгийг ярьж, үүнийг ойлгодоггүй юм.
82. Тэгээд тэд: “Бид үхэж хувхай яс, шороо болсон хойноо үнэхээр дахиад амилах юм гэж үү?”
83. Энэ нь бидэнд ч, бидний өвөг дээдэст ч амлагдсан зүйл. Энэ бол өмнөхүүдийн үлгэр домог төдий” гэлцэв.
84. Аяа, Элч минь! Тэднээс: “Хэрэв та нар мэддэг л юм бол энэ дэлхий хийгээд үүнд буй бүхэн хэнийх юм вэ?” хэмээн асуугтун.
85. Тэд: “Яриангүй л Аллаыхынх” гэх болно. Хэрэв тийм юм бол эргэцүүлэхгүй юм гэж үү?” хэмээн хэл.
86. “Долоон давхар тэнгэрийн, аугаа сансар огторгуйн Эзэн хэн вэ?” хэмээн асуувал;
87. Тэд: “Аллах л...” хэмээн хариулах болно. “Хэрэв тийм юм бол түүнээс айдаггүй юм уу?” гэж асуугтун.
88. Тэдэнд: “Хэрэв, та нар мэдэж байгаа юм бол, алив бүхнийг эрхшээгч эзэн хэн вэ? Өөрөө алив бүхэнд нөмөр нөөлөг болдог, бусад нь түүнд нөмөр нөөлөг болж чаддаггүй нь хэн вэ?” хэмээн асуу.
89. Тэд: “Аллах л” хэмээн хариулах болно. Хэрэв тийм юм бол юунд будилна вэ?! хэмээн сануулагтун.
90. Үнэндээ Бид тэдэнд чин үнэнийг авч ирсэн. Харин тэд бол жинхэнэ худалчид болой.
91. Аллах хүүхэдгүй бөгөөд Түүнтэй адилтгах ямар ч бурхан үгүй. Хэрэв тийм байсан бол бурхан бүр өөрийн бүтээнснээ эзэгнэн, харсан зүг рүүгээ явах байсан бөгөөд тэд нэг нь нөгөөгөөс давуу эрхтэй болно хэмээн өрсөлдөх байсан ажгуу. Аллах тэдний зохиомжилсон зүйлсээс ангид бөлгөө.
92. Аллах ил, далд бүхнийг мэдмүй. Тэр түүнтэй эн зэрэгцүүлж зүйрлэсэн бүхнээс агуу болой.
93. Аяа, Мухаммед! “Эзэнтэн минь ээ! Хэрэв, тэдэнд анхааруулсан зовлонт гэсгээлийг надад харуулахаар бол;
94. Эзэнтэн минь ээ! Намайг тэр харгис зальхай түмний дунд бүү байлгагтун” хэмээгтүн.
95. Эргэлзээгүй, тэдэнд амалсан гэсгээлээ чамд харуулахад ч бидний хүч чадал хүрэх билээ.
96. Тэдний үйлдсэн муу муухайн хариуд нь чи сайн сайхан үйл хийгтүн. Бид тэдний тайлбарыг сайн мэдэж буй болой.

97. Аяа, Мухаммед! “Аяа, Эзэнтэн минь ээ! Чөтгөр шулмасын уруу татах арга мэхээс намайг хамгаалагтун! хэмээн өөрт чинь залбирч байна” гээ.
98. “Эзэнтэн минь тэдний надад ойртохоос нь сэрэмжлүүлэгтүн” хэмээн, “өөрт чинь залбирнам” хэмээн хэл.
99. Эцэст нь үл сүсэглэгсэдийн хэн нэгэнд үхэл тохиолдвол: “Эзэнтэн минь! Намайг энэ хорвоод илгээгтүн” хэмээгээд залбирна.
100. Тэр: “Магад би дэмий өнгөрүүлсэн энэ хорвоод сайн үйл үйлдэхсэн” гэнэ. Үгүй ээ! Энэ бол түүний айсандаа хэлсэн хоосон үг. Тэднийг дахин амилахуйн өдөр хүртэл энэ хорвоод буцаахад саад болох нэгэн хаалт бий.
101. Бүрээ бишгүүр үлээгдэхэд тэдний хоорондын төрөл садангийн холбоос үгүй болно. Хүн бүр өөрийн зовлонгоор шаналж, бие биенээ ч эрж сураглах чадваргүй болно.
102. Муугаас сайн үйлсийнхээ жин нь илүү дарсан хүн авралыг олж, мөрөөдлөө биелүүлэх болно.
103. Харин, муу үйлсийнхээ жин нь илүү дарсан хүн хор уршиг амсах болно. Тэд халуун тамд эгнэгт үлдэх болой.
104. Халуун там тэдний нүүрийг нь хуйхлан, шүдийг нь ярзайлгаж орхино.
105. Та нарт Миний айлдварууд уншигдахуйд та нар үүнийг худал хэмээн үгүйсгэсэн биз дээ?”
106. Тэд: “Аяа, Эзэнтэн минь ээ! Бид бол муу ёрлож, төөрөлдсөн улс байжээ.
107. Эзэнтэн минь! Биднийг эндээс гаргаад аль? Хэрэв дахин нүгэл үйлдвээс бид гарцаагүй харгис зальхай этгээд болмуй” гэлцэнэ.
108. Аллах тэдэнд: “Та нар тамд тарчилан үлдэцгээгтун. Надаас өршөөл бүү эрэгтүн!” хэмээн хариулна.
109. Үнэндээ манай боолуудын нэг хэсэг нь: “Эзэнтэн минь ээ! Бид сүсэглэн итгэлээ. Биднийг өршөөн соёрхогтун? Биднийг хайрлан энэрэгтүн! Чи хайрлан ивээгсэдийн хамгийн эрхэмсэг нь билээ” хэмээж байсан.
110. Та нар тэднийг (гэгээн элч нарыг) доог тохуу хийсэн бөгөөд энэхүү доог тохуу чинь та нарт миний айлдваруудыг мартуулсан юм. Та нар тэднийг ямагт дооглон инээлдэж байсан билээ.
111. Үнэхээр та нарын доог тохууг тэвчсэний төлөө Би өнөөдөр тэднийг шагнаж байна. Эргэлзээгүй, тэд тамаас жинхэнэ аврагдагсад бөлгөө.”
112. Аллах тэднээс (үл итгэгсэдээс) : “Та нар газар дэлхийд хэдэн жил амьдарсан бэ?” хэмээн асуув.
113. Тэд : “Бид нэг өдөр, эсвэл түүнээс ч бага хугацаагаар амьдарсан болов уу? Гэхдээ, тоо баригчдаасаа (тооллогын элч нараас) асуугтун” хэмээн хариулцгаана.

114. Аллах: “Хэрэв мэддэгсэн бол та нар газар дэлхийд үнэндээ түр зуурхан байсан” гэнэ.
115. Аяа, Хүмүүний үр садаа! Бид та нарыг утга учиргүй бүтээсэн буюу эргэж Бидний өмнө буцаж ирэхгүй хэмээн боддог юм уу?
116. Чин үнэн Эзэн- Аллах нэн эрхэмсэг. Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Тэр гайхамшигт сансар огторгуйн эзэн бөлгөө.
117. Хэн нотолгоогүйгээр Аллахаас өөр бурхан буй хэмээн сүсэглэн шүтэх аваас, тэр Эзэнтний өмнө тайлан тавих болно. Үл сүсэглэгсэд хэзээ ч авралыг эс олно.
118. Аяа, Мухаммед! “Эзэнтэн минь, туслан ивээгтүн! Хайр энэрэлдээ багтаагтун. Энэрэн хайрлагчдын хамгийн эрхэмсэг нь чи бөлгөө” хэмээн залбирагтун.



Мадина-д илгээгдсэн. 64 айлдвар.

- Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*
1. Ийнхүү энэ бүлэг айлдварыг илгээлээ. Түүнд буй тушаал зарлигуудыг ариун үүрэг болгоно. Та нар ухаарч сургамж авахад энд яруу тод айлдварууд илгээсэн бөлгөө.
  2. Зина буюу садар самуун эрэгтэй, эмэгтэй аль алиныг зуун удаа жанчиж, ташуурдагтун. Та нар Аллах хийгээд хойд ертөнцөд итгэдэг бол, Аллахын шашины (шариятыг) эрх зүйн хэм хэмжээг гүйцэлдүүлэхдээ тэднийг бүү өрөвдөгтүн. Тэднийг цээрлүүлэхдээ сүсэглэгсэдийн нэг хэсэг нь харж байг.
  3. Садар самуун (зина) эрэгтэй гагцхүү садар самуун эмэгтэйтэй буюу буруу номтон эмэгтэйтэй гэрлэх нь; садар самуун эмэгтэйтэй гагцхүү тийм л эрэгтэйтэй, эсвэл буруу номтон эрэгтэйтэй гэрлэвэл зохистой. Энэ нь үнэн сүсэгтэнгүүдэд хориотой.
  4. Ариун ёс суртахуунтай эмэгтэйчүүдийг садар самуун хэмээн гүтгэж, тэдний нэр төрийг сэргээхийн тулд дөрвөн гэрчээр нотолж чадаагүй хүнийг наян удаа жанчигтун (ташуурдагтун). Мөн тэдний гэрчлэлийг хэзээ ч бүү хүлээн зөвшөөрөгтүн. Тэд нүгэлтэнгүүд болой.
  5. Дараагаар нь гэмшин хүмүүжигсэд үүнд үл хамаарна. Учир нь Аллах машид өршөөгч, хайрлан энэрэгч билээ.
  6. Хань ижилүүдээ садар самуун явдалтай (зина) хэмээн гүжирдэж, өөрөөсөө өөр гэрч олоогүй хүн, өөрийнхөө мэдүүлгийн үнэн болохыг нотлон Аллахын нэрийг барьж дөрвөн удаа андгай тангараг өргөг.

7. Харин тав дахь дээрээ “Хэрэв би худал хэлсэн бол Аллахын хараал намайг ниргэг” хэмээн андгай, амлалт аваг.
8. Эхнэр нь нөхрийгөө үнэхээр худал хэлснийг нотлон, дөрвөн удаа Аллахын нэр барьж тангараглавал шийтгэгдэхгүй.
9. Харин тав дахь дээрээ “хэрэв нөхрийн маань ярьсан нь үнэн бол намайг Аллахын хараал нэрвэг” хэмээн амлаг.
10. Хэрэв, та нарт Аллахын энэрэл, нигүүсэл зориулагдаагүй бол, Аллах наминчлал, гэмшлийг хүлээн авагч биш, мэргэн ухааны эзэн биш байсан бол яахсан бэ? (эдгээр чин үнэн шийдвэрүүдийг хэн гаргахсан вэ?)
11. Та нарын дотроос хэсэг хүмүүс (Гэгээн элчийн хань Айшагийн тухай) гүтгэлэг хов-жив тараасан байна. Энэ та нарт уршигтай хэмээн бүү бодогтун. Магад та нарын хувьд өлзийтэй ч байж болно. Гүтгэлэг тараасан хүмүүсээс хэн ямар хэмжээний нүгэл үйлдэнэ, тэр хэмжээний гэсгээл хүртэнэ. Гол үүрэг гүйцэтгэн гүтгэсэн хүнд маш хүнд гэсгээл оногдоно.
12. Энэхүү гүтгэлгийг сонссон эрэгтэй, эмэгтэй сүсэгтэнгүүд шашин нэгтнүүдээ бодож: “Энэ бол илэрхий гүтгэлэг байсан” хэмээн хэлэхэд яахлаар хэл ам нь эвлээгүй юм бол?
13. Энэ тухайд тэд яагаад дөрвөн гэрч авч ирээгүй юм вэ? Нэгэнт гэрч авч ирээгүй болохоор Аллахын өмнө худалчид тооцогдоно.
14. Та нарт энэ хорвоо хийгээд хойд ертөнцөд Аллахын энэрэл нигүүлсэл байгаагүй сэн бол, гүтгэлэг хов ярьж, хараасныхаа төлөө гарцаагүй хүнд гэсгээлтэй учирах байсан буй за.
15. Тухайн үед та нар сансан зоргоор мэддэггүй юмыг чалчиж, хуурамч гүтгэлэг тарааж, үүнийг жирийн явдал гэж ойлгосон. Энэхүү гүтгэлэг нь Аллахын өмнө том хэрэг ажгуу.
16. Та нар үүнийг сонссон даруйдаа: “Ийм л юм ярих нь бидэнд зохимжгүй. Аллах, Чи бол чин ариун билээ! Энэ бол маш муухай гүтгэлэг” хэмээн яагаад хэлээгүй вэ?
17. Хэрэв та нар сүсэглэн итгэсэн нэгэн бол, үүнээс хойш иймэрхүү үгийг давтахгүй байхыг Аллах та нарт сануулж байна.
18. Аллах айлдваруудаа та нарт ийнхүү ил тод тайлбарладаг. Аллах бүхнийг мэдэгч, гайхамшгийн эзэн билээ.
19. Сүсэглэн итгэгсэдийн дунд бузар муухай үгс тараахыг хүсэгсэд энэ хорвоо хийгээд хойд ертөнцөд ч хатуу гэсгээл үзнэ. Аллах мэддэг, та нар үүнийг эс мэддэг юм.
20. Хэрэв та нарт Аллахын өршөөл, нигүүлсэл зориулагдаагүйсэн бол, мөн Аллах өрөвч энэрэнгүй биш байсан бол (та нарын байдал ямар байх сан) аль хэзээ цээрлүүлэгдэх л байсан.

21. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Чөтгөр шулмасыг бүү дагагтун. Хэн чөтгөрийн хойноос дагана, чөтгөр түүнийг ичгүүр сонжуургүй, муу муухай бүхэнд сургадаг юм. Та нарт Алладын өршөөл, нигүүлсэл ирээгүй бол, та нарын хэнд ч цэвэр ариун чанар заяагдахгүй байсан бөлгөө. Гэвч Аллах хүссэнээ ариусгамуй. Аллах бүгдийг сонсож, мэдэж байдаг.
22. Та нарын дотроос хувь хишиг хийгээд эд баялагийн эзэд бологсод хамаатан садан, ядуу барлаг, Алладын төлөө нутаг сэлгэгсдэд эд хөрөнгөөсөө өгөхгүй хэмээн бүү хатуурагтун. Харин ч тэдний алдааг уучилж өршөөгтүн. Алладын та нарыг өршөөн нигүүлсэхийг та нар таалахгүй гэж үү дээ? Аллах машид өршөөгч хийгээд хайрлан энэрэгч шүү дээ.
23. Ариун ёс суртахуунтай, чин үнэн сэтгэлтэй үнэн сүсэглэгч эмэгтэйчүүдийг ёс бусаар гүтгэгсэд энэ хорвоо хийгээд хойд ертөнцөд хараал хүртэж, хүнд гэсгээлтэй учрана.
24. Тэр өдөр тэдний хэл, гар, хөлнүүд нь өөрсдийн үйлдсэн нүглийн гэрч нь болно.
25. Тэр өдөр Аллах тэдэнд зохих гэсгээлийг нь бүрэн хүртээх бөгөөд тэд Алладын яруу тод, чин үнэн байсныг мэдэцгээнэ.
26. Зальхай эмэгтэйчүүд тийм л эрчүүдэд, зальхай эрчүүд мөн тийм л эмэгтэйчүүдэд тохирох бөгөөд цэвэр ариун эмэгтэйчүүд тийм л эрчүүдэд, харин цэвэр ариун эрэгтэйчүүд тийм л эмэгтэйчүүдэд зохимжтой болой. Эдгээр нь тэдний гүтгэлэгээс ангид бөлгөө. Цэвэр ариун хүмүүс өршөөл нигүүлсэл, өгөөмөр хишгийн эзэн болно.
27. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нар өөрсдийн гэр орноос өөр бусдын гэрт зөвшөөрөлгүйгээр, эсвэл гэрийн эзэнтэй мэндлэлгүйгээр бүү орогтун. Энэ нь та нарын хувьд өлзийтэй гэдгийг эрх биш ухаарч ойлгох биз дээ.
28. Хэрэв тэр айл эзгүй байдлыг мэдсэн бол та нарт зөвшөөрөл өгөгдөхөөс нааш тийшээ бүү орогтун. Хэрэв та нарт “Буцаж явагтун” хэмээгдвэл даруй буцагтун. Энэ нь та нарын хувьд илүү ариун үйл болой. Аллах та нарын хийснийг зүй ёсоор мэдэгч бөлгөө.
29. Дотор нь өөрсдөд чинь хамаарагдах эд зүйл буй эзгүй айлд (гэр, орд харш) орвол гэм зэм үгүй. Та нарын ил, далд хийсэн бүхийг Аллах мэдэж байдаг юм.
30. Аяа, Мухаммед! Үнэн сүсэгтэн эрчүүдэд хэлэгтүн: “Үл таних эмэгтэй хүн рүү нэвт шувт бүү ширтэг! Садар самуун явдлаас сэрэмжлэгтүн. Энэ нь тэдний хувьд ариун үйл болой. Аллах үнэхээр тэдний хийж буй зүйлийн талаар бүрэн мэдээлэлтэй байдаг”
31. Мөн үнэн сүсэглэгч эмэгтэйчүүдэд ч ийн хэлэгтүн: Үл таних эрчүүдийг нэвт шувт бүү ширтэг! Бие далдлан, садар самуун явдлаас сэрэмжлэгтүн. Ердийн ил байж болохоос (нүүр, гарын бугуй, хөлийн

шагайн хэсэг) бусад биеэ далдалж явагтун. Алчуураараа толгой, энгэрээ бүтээж ороогтун. Өөрийн нөхөр, эцэг, хадам эцэг, өөрийн болон өргөмөл хөвгүүд, төрсөн ах дүү нар, төрсөн ах дүү нарын хөвгүүд, төрсөн эгч дүүс нарын хөвгүүд, мусулман эмэгтэйчүүд, өөрсдийн зарц шивэгчин нар эсвэл эмэгтэйчүүдтэй ойртох боломжгүй болсон (өтөлсөн ба бусад шалтгаан) хүмүүс, эмэгтэй хүний нүцгэн эрхтэнийг танин мэдэхгүй нялх хүүхдүүдээс бусад хүмүүст далдлан нуух эрхтэнээ бүү үзүүлэгтүн. Далд эрхтнүүдээ бусад хүн харахуйцаар хөлөө дээш өргөж, шал бүү дэвсэгтүн. (анхаарал татахуйц байдлаар бүү алхагтун). Аяа, чин сүсэгтэн нараа! Хүсэл зорилгоо биелүүлье хэмээн бодож байгаа бол Аллахад залбирагтун!

32. Та нарын дунд буй ганц бие эр-эмийг, насанд хүрсэн хөвгүүн, бүсгүйчүүдийг, гэрлээгүй боол, шивэгчинүүдийг санаа нийлвэл хооронд нь гэрлүүлэгтүн. Хэрэв тэд ядуус байвал Аллах өөрийн хайр ивээлээр баяжуулах болой. Аллах нэн өршөөгч, бүхнийг мэдэгч ажгуу.
33. Хөрөнгө чинээ муугаас гэрлэж чадаагүй хүмүүс Аллахын ивээл энэрэлээр эд хөрөнгөтэй болтол ёс суртахуун, ариун байдлаа хадгалаг. Өөрсдийн боол, шивэгчинүүдээс эздэд зохих төлбөр төлж эрх чөлөөтэй байхаар хэлцэл хийхийг хүсвэл, итгэлтэй буй нөхцөлд, тэдэнтэй хэлэлцэн тохирогтун. Мөн Аллахын та нарт хайрласан хувь хишгээс тэдэнд өгөгтүн. Ариун ёс суртахууныг сахигч шивэгчинүүдээ түр зуурын дур сонирхлын үүднээс садар самуунд бүү албадагтун. Хэрэв тэднийг хэн нэгэн хүчирхийлбэл Аллах ивээн, энэрэх болно.
34. Үнэндээ, Бид та нарт яруу тод айлдваруудыг, урьд өмнөх хүмүүсийн тухай сургамж жишээг, үнэн сүсэгтнүүдэд зориулсан ухуулгатуулыг дэлгэрэнгүй айлдлаа.
35. Аллах бол тэнгэр, газрын гэрэл гэгээ ажгуу. Түүний гэрэл гэгээ нь шилэн дэнлүү лугаа адил. Тэр дэнлүү бол дорнын ч биш, өрнийн ч биш, гал хүргэсэн ч, хүргээгүй ч бивал модны тосноос бадамлан асмуй. Энэ нь улам бүр гэрэлтэн гэгээрдэг болой. (Итгэл, залбирлын гэрэл гэгээг үүнтэй зүйрлэх билээ.) Аллах таалсан хүнээ өөрийнхөө гэрлээр гэгээрүүлмүй. Аллах хүмүүст зүйрлэл, жишээг ийнхүү илгээдэг. Тэр алив бүхнийг мэдэгч.
36. Аллах өөрийг нь дээдлэн, өөрийнхөө нэрийг санан дурсахыг тушаасан Мечитүүдэд үнэн сүсэгт мусулманууд эрт орой Аллахт наминчлан залбирч, Түүнийг шагшин магтмуй.
37. Тэдний (мусулманууд) худалдаа наймаа нь өөрсдөд нь Аллахыг санан дурсахад, уншлага мөргөл үйлдэхэд, ариусалын өглөгөө өгөхөд саад болдоггүй. Тэд зүрх нь түгшиж, нүд нь орой дээрээ гарах нэгэн өдрөөс айдаг юм.
38. Учир тэд сайн үйлийнхээ төлөө Аллах сайн шагнал өгөөсэй, хайр

- энэрэлээсээ илүү ихийг хүртээгээсэй хэмээн хүсдэг. Аллах хүссэн хүндээ тооцоо бодолгүйгээр хувь хишиг хүртээдэг.
39. Харин үл сүсэглэгсэдийн үйл хэрэг нь цөлийн зэрэглээ лугаа адил бөгөөд ангаж цангасан хүн үүнийг ус хэмээн андуурдаг, бөгөөд ойртоод очиход юуг ч эс олмуй. Харин ч Аллах хажууд нь байгааг мэдрэнэ. Аллах түүний тооцоог бүрэн гүйцэд харах бөгөөд Аллах тооцоог бодохдоо үтэр түргэн болой.
  40. Эсвэл (үл сүсэглэгсэдийн үйл хэрэг нь) захгүй далайн түнэр харанхуй лугаа адил болой. Давалгаа дээр дээрээсээ хуйлран ирэхүйд, дээгүүр нь үүл нүүгэлтэн, нэг харанхуйг нөгөө харанхуй нөмөрч, хүн гараа өргөхөд түүнийгээ бараг эс үздэг тэнгисийн ёроол мэт юм. Аллах хэн нэгэнд гэрэл эс хайрлах аваас түүнд гэгээтэй юм байдаггүй.
  41. Тэнгэр, газарт буй бүхэн дүүлэн нисэж буй шувууд Аллахыг шагшин магтаж буйг мэдэхгүй гэж үү? Аллах тэдний залбирал болон санан дурссаныг мэднэ. Аллах тэдний хийж буй бүхнийг бүрэн мэддэг билээ.
  42. Тэнгэр, газрын эзэгнэл гагцхүү Аллахынх бөгөөд эргэж очих газар зөвхөн Аллахын өмнө ажгуу.
  43. Аллах үүлсийг хөөж, бие биетэй нь давхарлан нийлүүлээд, дараа нь бөөн үүлс болгосоныг чи хараагүй юу? Мөн түүнээс бороо орохыг чи харах болно. Аллах дээрээс уул мэт үүлнээс мөндөр буулгаж, хэн хүссэнийгээ түүгээр нэрэвдэг, хэн хүссэнээсээ түүнийг холдуулдаг. Цахилах аянга хүний нүдийг сохлох шахна.
  44. Аллах өдөр шөнийг ээлжлүүлнэ. Харах мэлмийтэй хүний хувьд үүнд зохих сургамж буй.
  45. Аллах алив амьтныг усаар бүтээсэн билээ. Тэдгээрийн зарим нь хэвлийгээрээ, зарим нь хоёр хөлөөрөө, зарим нь дөрвөн хөлөөрөө явна. Аллах алив хүссэнээ бүтээдэг. Эргэлзээгүй Аллахын хүч чадал алив бүхэнд хүрмүй.
  46. Үнэхээр Бид яруу тод айлдваруудаа тайлбарласан. Аллах хүссэнийгээ зөв шулуун зам руу хөтөлдөг.
  47. Урван тэрслэгчид: “Бид Аллах болон Түүний гэгээн элчид итгэлээ, бас дагацгаалаа” хэмээх мөртлөө дараа нь тэдний зарим нь Аллахын замаас нүүр буруулцгаана. Тэд сүсэглэн итгэгсэд биш ээ!
  48. Тэдний тухайд шийдвэр гаргахаар Аллах болон Түүний гэгээн элчид дуудагдахуйд нэг хэсэг нь очихоос татгалздаг.
  49. Хэрэв чин үнэн тэдний талд байвал тэд гэгээн элчийг хүлээн зөвшөөрч ирцгээдэг.
  50. Тэдний зүрх сэтгэлд нь согог өвчин байгаа юм уу? Эсвэл гэгээн элчид эргэлзэж байдаг юм уу? Аль эсвэл Аллах болон Түүний элчийг өөрсдөд нь шударга бусаар хандах вий хэмээн айцгаадаг юм уу?. Үнэндээ жинхэнэ харгис зальхайнууд өөрсдөө шүү дээ.

51. Тэдний талаар зарлиг буулгахаар Аллах болон Түүний элчид уригдахад үнэн сүсэгтэнгүүдийн хариу бол: “Бид сонслоо, хүлээн зөвшөөрч захирагдлаа” хэмээх үг бөлгөө. Тэд жинхэнэ авралыг олж, хүсэл зорилгоо биелүүллэгээн.
52. Хэн Аллах болон Түүний элчид захирагдаж, Аллагаас айж эмээнэ, тэд аз жаргалыг ологсод болой.
53. Хоёр нүүргэнгүүдийг тулалдаанд гарахыг тушаавал, “гарцаагүй гарна!” гэнэ. Аллахад даруй андгайлан ам очиг өгнө. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Андгай тангараг болоод яах вэ? Та нарын тангараг угаасаа хуурамч. Түүний оронд зөнгөөрөө захирагдагтун. Аллах та нарын хийж буй бүхнийг мэдэж байгаа” хэмээн хэлэгтүн.
54. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Аллахад болон гэгээн элчид захирагдагтун. Хэрэв та нар нүүр буруулах аваас үүнийг мэдэгтүн. Гэгээн элч өөрт нь оногдсон үүргийг өөрөө хариуцна. Та нар өөртөө оногдсон үүрэгтээ эзэн болцгоо. Хэрэв, гэгээн элчид захирагдах аваас зөв шулуун замыг олох болно. Гэгээн элчийн үүрэг бол гагцхүү яруу тод уриалах явдал болой” хэмээн хэлэгтүн.
55. Аллах та нарын дотроос сүсэглэн мөргөж, сайн үйл үйлдэгсэдэд : “Өөрсдөөс чинь өмнөхүүдийг эрх мэдлийн эзэд болгосон лугаа адил газар дэлхий дээр эрх мэдлийн эзэд болгохыг таалж сонгосон шашиныг бэхжүүлэхийг, айдас-хүйдэсийг тайван амгалангаар солихыг амалсан билээ. Тэд надад наминчлан залбирсан, надтай юуг ч эн зэрэгцүүлдэггүй. Харин амлалтын дараа эсэргүүцвэл тэд танхайрагч нүгэлтнүүд болно.
56. Уншлага мөргөлөө зүй ёсоор нь үйлдэж, ариуслын өргөлөө өгч, гэгээн элчийг дагацгаагтун. Тэгвээс, та нар хайр энэрэлийг хүртэх болно.
57. Буруу номтнууд газар дэлхийд (Аллах болон гэгээн элчийг) мөхөсдүүлэнэ хэмээн бүү бодог. Тэдний очих газар нь там. Тэр юутай муухай газар гээч!
58. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нарын гар доорх боол шивэгчинүүд, насанд хүрээгүй хүүхдүүд чинь дараах цаг хугацаанд зөвшөөрөлгүй та нарын хажууд бүү очигтун. Тухайлбал, өглөөнийхөө уншлага-мөргөлийн өмнө, үдийн цагаар хувцасаа тайлах үед, мөн шөнийн уншлага-мөргөлийн дараа тус тус болой. Эдгээр цагуудад та нар нүцгэлэх тул хориотой хугацаа юм. Эдгээр цагуудаас бусад үед бие биендээ хэрэгцээ шаардлагаар орж гарах нь та нарын хэнд ч нүгэл эс болмуй. Аллах айлдваруудаа та нарт ийнхүү тайлбарлаж байна. Аллах аугаа ухаантан бөгөөд гайхамшгийн эзэн билээ.
59. Мөн хүүхдүүд чинь эрийн цээнд хүрэх үедээ ч урьд үеийнхэн зөвшөөрөл авч байсан лугаа адил өрөөнд чинь зөвшөөрөл авч орог. Аллах та нарт айлдваруудаа ийнхүү яруу тод тайлбарлаж байна. Аллах аугаа бөгөөд гайхамшгийн эзэн бөлгөө.



60. Гэрлэх горьдлогоо алдсан ахмад настай эмэгтэйчүүд далдлах биеэ ил гаргалгүйгээр гадуур хувцасаа тайлахад нүгэл эс болмуй. Үүнээс илүү дэгийг сахивал бүр ч өлзийтэй. Аллах бүхнийг сонсогч, мэдэгч билээ.
61. Бусадтай хамт хооллож, ундаалж буй сохор, доголлон, тахир татуу өвчтөнд гэм зэм, нүгэл үгүй. Хүмүүс ээ! Өөрсдийн гэрээс эсвэл эцэг эхийнхээ гэрээс, эсвэл ах, эгч, дүү нарынхаа гэрээс, эсвэл авга хийгээд нагац ах, эгч, дүү нарынхаа гэрээс, эсвэл түлхүүр нь та нарт байгаа гэрээс, эсвэл анд найзынхаа гэрээс хоол идвэл ямар нэгэн нүгэл эс болно. (Олуулаа эсвэл ганцаараа идсэн ч). Мөн та нар аливаа нэгэн гэрт орохдоо Аллахын адис ерөөлт амар мэндээр нэг нэгэндээ (Ассаламу алайкум хэмээн) мэндэлж байгтун. Та нарыг ухаарч мэдэгч хэмээн Аллах айлдваруудаа ийн тайлбарлана.
62. Үнэн сүсэгтэнгүүд, гагцхүү Аллах хийгээд Түүний элчид зүрх сэтгэлээрээ итгэн сүсэглэгсэд ажгуу. Тэд, гэгээн элчтэй хамт байхдаа түүнээс зөвшөөрөл авалгүйгээр орхиж үл явмуй. (Аяа, элч минь!) Чамаас зөвшөөрөл хүсэгсэд бол Аллах хийгээд гэгээн элчид сүсэглэгсэд ажгуу. Тиймээс, зарим үйл хэргийн төлөө чамаас зөвшөөрөл хүсэхүйд, зөвшөөрөл өгөгтүн. Мөн тэдний төлөө Аллахаас өршөөл гуйгтун. Аллах үнэхээр машид өршөөгч, онцгой хайрлан энэрэгч болой.
63. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Гэгээн элчийг өөрсдөө бие биеэ дуудаж буй мэтээр бүү дуудагтун. Та нарын дотроос элдэв шалтагаар далимдуулан элчээс сэм зайлан одогсодыг Аллах мэдмүй. Гэгээн элчийн тушаалыг эсэргүүцэгчид өөрсдөд нь нэг гай зовлон тохиохоос, эсвэл өөрсдөд нь хатуу гэгсээл ирэхээс сэрэмжилцгээг.
64. Тэнгэр, газарт буй бүхэн Аллахынх. Аллах, та нарын ямар байдалтай байгааг сайн мэднэ. Хүмүүс Түүний өмнө буцаагдах өдөр хийсэн үйл бүхнийг нь өөрт нь хэлж өгнө. Аллах алив бүхнийг зүй ёсоор нь мэдэгч мөн.



Мекке-д илгээгдсэн. 77 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Бүхий л орчлон ертөнцөд сэрэмжлүүлэг болгохын тулд өөрийн боолд (Мухаммедэд) зөв, буруу хоёрыг ялган салгах хэмжүүр болсон Кураныг буулгасан. Аллах юутай аугаа вэ?
2. Тэнгэр, газрын хаанчлал түүнд хамаарагдмуй. Тэр үр хүүхэдгүй, ямар ч хамтрагч үгүй. Тэр алив бүхнийг бүтээж, түүнд зохицсон хэм хэмжээг тогтоосон.

3. Үл сүсэглэгсэд Аллагаас зугтаж , юуг ч бүтээж үл чадах, эсрэгээрээ өөрөө бүтээгдсэн, мөн өөрсдөд нь хор хөнөөл ч, ашиг тус ч эс болох, хэн нэгэнд үхэл, амьдрал ч үл бэлэглэх, үхэгсэдийг дахин амилуулж булшнаас нь гаргахад хүч чадал нь эс хүрэх зохиомол зүйлсийг бурхан хэмээн, түүнийг тахин шүтэцгээсэн билээ.
4. Буруу номтнууд: “Куран бол Мухаммедийн санаанаас зохиосон нэгэн худал хуурмаг зүйл бөгөөд түүнд өөр хүмүүс тусалсан буйз аа” хэмээн харгис зальхай явдалд автсан. Ийнхүү тэд гэгээн элчийг гүтгэлээ.
5. Мөн тэд: “Куран бол аль дивангарын үлгэр домог, тэр бусдаар бичүүлж аваад өглөө оройд уншуулж цээжилсэн байх” гэнэ.
6. Аяа, Мухаммед! “Кураныг тэнгэр, газрын нууцыг мэддэг Аллах буулгасан юм. Аллах машинд ивээн энэрэгч” хэмээн тэдэнд хэлэгтүн.
7. Тэд бас л: “Хоол идэж, зах зээл хэсэж явдаг юу гээч гэгээн элч вэ? Аллах яагаад түүнтэй хамт өөрсдийн боолуудад сэрэмжлүүлэг болох нэгэн элч мэлэк илгээдэггүй юм вэ?”
8. “Эсвэл түүнд яагаад тэнгэрээс нэгэн эрдэнэс баялаг буулгаагүй, бас жимсийг нь идэх нэгэн цэцэрлэг ч зориулсангүй вэ?” гэлцэнэ. Мөн зальхай этгээдүүд сүсэглэгсэд хандан: “ Та нар зөвхөн илбэдсэн хүнийг л дагаж буй” хэмээнэ.
9. Аяа, Мухаммед! Тэд чиний тухай ямар жишээ өгүүлснийг хар л даа! Тэд зөв шулуун зам олохооргүй төөрч будиллаа.
10. Хэрэв, Аллах таалан соёрхох аваас чамд тэдний хэлснээс ч илүү сайныг, хаяагаар нь булаг урссан цэцэрлэг, орд харш бүхий диваажинг бэлэглэх болно.
11. Гэвч, тэд ертөнцийн төгсгөлийг худал хэмээн үгүйсгэсэн. Бид ертөнцийн төгсгөлийг хүлээн зөвшөөрөөгүй хүмүүст дүрэлзсэн гал бүхий тамыг бэлтгэсэн баймуй.
12. Халуун там тэднийг алсаас хармагцаа, тэд дүрэлзсэн галын догшин сүрлэг, буцлан хүрхирэх дууг сонсоцгооно.
13. Тэд гар, хөлөө хүлүүлэн халуун тамын давчуу газарт шидэгдэхдээ хурдхан үхэх юмсан хэмээн хүсэх болно.
14. Тэдэнд: “Та нар өнөөдрийн үхлийг хүсээд зогсоогүй, олон удаагийн үхлийг өөрсдөө хүсээрэй” хэмээн хэлэгдэнэ.
15. Аяа, Мухаммед! Тэднээс: “Энэ илүү өлзийтэй юу, аль эсвэл үнэн сүсэглэгсэд шагнал болгон, мөнх амгалан орших газар болгон амлагдсан диваажин илүү өлзийтэй юу?” хэмээн асуугтун.
16. Үнэн сүсэгтнүүд диваажинд юу хүснэ, тэр бүгд бэлэн бөгөөд тэнд үүрд орших болно. Энэ бол Эзэнтнээс биелүүлэхийн төлөө хүсэх амлалт ажгуу.
17. Мөн тэр өдөр Эзэнтэн чинь тэднийг, мөн Аллагаас өөр бусад тахин

- шүтсэн зүйлсийг нь нэг дор дэлгэн тавиад: “Миний боолуудыг та нар төөрөгдүүлсэн үү, аль эсвэл тэд өөрсдөө зөв шулуун замаас төөрсөн үү?” хэмээн асуух болно.
18. Тэд (тахин шүтсэн зүйлс нь): “Аяа, Аллах чи чин ариун юм. Чамаас бусадтай нөхөрлөх, шүтэх нь бидэнд эс зохицмуй. Гэвч Чи тэдэнд хийгээд тэдний өвөг дээдэст арвин их хувь хишиг хүртээсэн ч Чамайг дурсахаа умартацгаасан бөгөөд үр удамгүй болтол сүйрэх ардууд болцгоолоо” хэмээн хариулна.
  19. Та нарын бишрэн шүтэж асан зүйлс чинь үнэндээ өөрсдийн чинь хэлснийг (зохиомол зүйлийг бурхан хэмээснийг) үгүйсгэлээ. Та нар гэгсгэлээс мулгарч чадахгүй. Өөрт ч тус нэмэр болохоос өнгөрсөн. Та нараас хэн харгис зальхай үйлдэл хийнэ, тэр хүнд цээрлэл амсах болно.
  20. Аяа, Мухаммед! Чамаас өмнө илгээгдсэн гэгээн элчүүд ч хоол идэж, зах зээлээр хэсдэг л байсан. Аяа, хүмүүс ээ! Бид та нарын нэгийг нөгөөгөөр чинь сорьсон юм. Сорилтыг давж чадах юм уу? Эзэнтэн бүхнийг харж байдаг.
  21. Бидэнтэй нүүр тулахыг үл хүсэгчид (үл сүсэгтнүүд): “Бидэнд яагаад элч мэлэкүүд илгээдэггүй юм вэ? Эсвэл Эзэнтэн бидэнд харагдах нь яасан вэ?” гэж асууцгаана. Үнэндээ, тэд өөрсдийгөө дээгүүр үнэлэн, төөрөлдөж, хэмээс хэтэрсэн билээ.
  22. Аллахын элч-мэлэк нарыг үзэх нь өөрсдөд нь өлзийтэй болохгүй. Элч мэлэк нар тэдэнд: “Диваажин та нарт оногдохгүй” хэмээн хариулах болой.
  23. Бид тэдний үйлдсэн үйлдлийг нягтлан үнсэн товрог болгон хийсгэнэ. (Үл сүсэглэсний төлөө зарим сайн үйлсийг нь ч үл тоон, үнэ цэнэгүй болгоно.)
  24. Тэр өдөр диваажинд үлдэгсэдийн орших газар нь машид сайхан амгалан, амарч тухлах газар нь ихэд тансаг байх болно.
  25. Тэр өдөр тэнгэр үүлээр хучигдан Аллахын элч-мэлэк нар дэлхий дээр бууж ирнэ.
  26. Тэр өдөр жинхэнэ эзэгнэл машид нигүүлсэнгүй Аллахынх ажгуу. Харин үл сүсэглэгсэдийн хувьд машид хатуу өдөр болой.
  27. Мөн тэр өдөр харгис зальхай этгээдүүд “Ээ, халаг! Гэгээн элчтэй цуг замыг сонгох минь яав даа!” хэмээн хуруугаа хэмлэнэ.
  28. “Халаг минь ээ! Тэр нэг юмтай юунд нөхөрлөв өө!”
  29. “Куран судар ирчихээд байхад, тэр чөтгөр шулам л намайг төөрөгдүүллээ. Чөтгөр угаас хүн төрөлхтний атаат дайсан!” гэнэ.
  30. Гэгээн элч: “Аяа, Эзэнтэн минь! Зон олон минь үнэндээ Кураныг хөсөр орхин явцгаалаа” гэнэ.
  31. Аяа, Мухаммед! Бид ингэж гэгээн элч бүрт зарим нүгэлтнүүдийг

- эсрэг тавьж дайсагнуулсан юм шүү. Хэдий тийм боловч зөв зам заахад туслалцаа үзүүлэх талаар Эзэнтэн чинь хангалттай.
32. Буруу номтнууд: “Куран түүнд яагаад бөөндөө, нэгмөсөн буулгагдаагүй юм бэ?” хэмээн асууна. Бид Кураныг чиний зүрх сэтгэлд хоногшуулахын тулд ийнхүү нэг нэгээр нь, тус тусдаа айлдсан болой.
  33. Үл сүсэглэгчид чамд ямар асуулт тавьсан ч Бид чамд чин үнэн хариу, хамгийн сайн тайлбарыг даруй илгээж байлаа.
  34. Тэд нүүрээрээ чирэгдэн там дээр цугларагсад мөн. Тэдний очих газар нь юутай муухай, сонгосон зам нь маш буруу болой.
  35. Бид Мусад судрыг хайрлаж, дүү Харуныг туслахаар нь өгсөн юм.
  36. Бид тэдэнд: “Айлдваруудыг маань худал хэмээн үгүйсгэсэн ардад очигтун” гэв. Эцэст нь тэр ард олон зөв шулуун зам руу ирээгүйгээс газартай тэгшлэгдсэн билээ.
  37. Нухын ард олныг ч элч нарыг худал хэмээн хүлээн зөвшөөрөөгүй болохоор далайд живүүлсэн, хүмүүний төлөө нэгэн сургамж болгосон. Харин харгис зальхайнуудад хатуу гэсгээлийг зэхсэн баймуй.
  38. Гад, Самуд, Рассын оршин суугчид болон тэдгээрийн хоорондын өч төчнөөн олныг ч...
  39. Бид тэдний тус бүрт нь үлгэр жишээ харуулсан юм. (Ухуулга сургамжыг сонсоогүй, бардамнасан болохоор нь) цөмөөрөнгийг нь үгүй хийсэн.
  40. Үнэндээ Меккегийн үл сүсэглэгсэд сүйрэл дагуулах (чулуугаар) аадар бороо оруулсан хотод ирсэн ч тэд түүнийг хараагүй гэж үү? Тэд үхсэний дараа дахин амилахыг хүсдэггүй юм.
  41. Аяа, Мухаммед! Тэд чамайг харсан даруйдаа тохуурхан: “Аллахын илгээсэн гэгээн элч энэ юм гэж үү?” хэмээнэ.
  42. Мөн: “Бид тууштай байгаагүйсэн бол тэр биднийг бурхадаас маань төөрөгдүүлэх нь байна шүү” гэлцэнэ. Гэхдээ, тэд эцсийн өдөр гэсгээлийг үзэхийн цагт хэн нь замаасаа төөрөлдсөнийг аяндаа мэдэх болно.
  43. Аяа, Мухаммед, хэлээч дээ! Өөрийнхөө таалсан бүхнийг бурхан болгож авсан хүмүүсийг чи өмөөрч чадах юм уу?
  44. Аль эсвэл тэдний ихэнх нь чиний ухуулгыг сонсож, ойлгодог гэж бодоо юу? Тэд адгуусын адил, бүр түүнээс ч дор замаа алдагсад мөн.
  45. Эзэнтэн сүүдрийг хэрхэн хойшлуулсаныг харсангүй юу? Хэрэв хүссэн бол түүнийг нэг байранд хөдөлгөөнгүй болгох болой. Дараа нь түүнд Бид нарыг нотолгоо болгов. (Өөрөөр хэлбэл нар ургахад сүүдрийг гэрч болгосон.)
  46. Улмаар сүүдрийг зугуухан огшуулан өөр рүүгээ татаж авсан юм.
  47. Та нарын төлөө Аллах шөнийг нөмрөг, нойрыг амралт болгож, өдрийг амь зуулгын эрхээр тал тал тийшээ явах цаг болгосон.

48. Аллах хайр энэрэлийнхээ хурыг оруулахаас өмнө сайхан мэдээний бэлгэдэл болгон салхийг илгээсэн билээ. Ийнхүү тэнгэрээс хурын тунгалаг усыг буулгасан юм.
49. Түүгээр үхмэл хөрсийг амилуулж, өөрсдийн бүтээсэн амьтад хийгээд үе олон хүмүүсийн цангааг тайлав.
50. Хүмүүс сургаж аваг хэмээн хур бороог энд тэнд ээлжээр оруулав. Гэвч хүмүүсийн олонхи нь Аллахын ач тусыг ухаарахгүйгээр үл тоомсорлосон билээ.
51. Хэрэв Бид хүсвэл хот, суурин тус бүрт гэгээн элч илгээх байсан юм.
52. (Гэвч орчлон ертөнцөд сэрэмжлүүлэгчийн үүргийг Бид чамд өгсөн юм) Тиймээс үл сүсэглэгсдэд бүү бууж өг. Кураныг ашиглан тэдэнтэй цуцалтгүй тэмцэгтүн.
53. Аллах цэнгэг ба шорвог устай хоёр тэнгисийн хооронд (холилдуулахгүйн тулд) зөрлөгийн хаалт далан босгосон.
54. Аллах хүмүүнийг Дусал уснаас бүтээж тэднийг эр, эмийн урагаар ялгасан билээ. Эзэнтэн чинь ийнхүү хүчирхэг ид шидтэй.
55. Ийм байхад үл сүсэглэгсэд Аллахыг орхиж, өөрсдөд нь ямар ч ашиг тус болдоггүй зүйлсийг шүтэн мөргөцгөөдөг юм. Үл сүсэглэгчид Эзэнтнийхээ эсрэг чөтгөр шулмаст туслах юм даа.
56. (Аяа, элч минь!) Бид чамайг гагцхүү баярт мэдээг дуулгагч, сэрэмжлүүлэгч болгон илгээсэн юм шүү.
57. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Би та нараас хариу шан харамж хүсэхгүй. Гагцхүү Эзэнтнийхээ зөв шулуун замыг дагахыг хүсэгч л төдий билээ.
58. Үхэшгүй мөнх Аллахыг түшиж, чин ариун хэмээн магтагтун. Боолуудынхаа нүглийг мэдэх нь түүнд хангалттай.
59. Аллах тэнгэр, газар хийгээд тэдний хооронд буй бүхнийг зургаан өдөрт бүтээж, дараа нь агуу сансар огторгуйг эрхшээсэн. Тэр аугаа нигүүлсэгч мөн. Үүнийг Аллахын агуу гайхамшгийг мэдэгчдээс асуугтун.
60. Үл сүсэглэгчдэд: “Нигүүлсэгч Аллахад сөгдөн мөргөгтүн” хэмээгдэхүйд тэд: “Нигүүлсэгч гэдэг юу вэ? Чиний тушаасан зүйлд сөгдөн мөргөх гэж үү дээ?” хэмээнэ. Энэхүү зарлиг тэдний үзэн ядалтыг улам бүр нэмэгдүүлмүй.
61. Ийм л агуу буян хишгийн эзэн болсон Аллах тэнгэрийн оддын ордыг бүтээж, тэнд илчит нарыг, гэрэлт сарыг бүтээсэн билээ.
62. Аллах ухуулга сэнхрүүлгэ авахыг хүсэгчид болон наминчлан залбирахыг хүссэн хэн нэгний төлөө өдөр, шөнө хоёрыг ээлжлүүлэв.
63. Аугаа нигүүлсэгчийн ивээсэн боолууд нь газар дэлхий дээр элэгсэг, дотно, даруу явдаг бөгөөд мунхагууд өөрт нь хатуу үг хэлбэл хариуд нь “Амар амгалан болтугай” хэмээн зөрөн өнгөрдөг (мунхагуудтай үг сөрөхийг хүсдэггүй) болой.

64. Тэд шөнө болгон Эзэнтэндээ сөгдөн залбирч, мөргөлийн үеэр босоогоор хүндэтгэл үзүүлнэ.
65. Тэд: “Аяа, Эзэнтэн минь! Тамын гэсгээлийг биднээс холдуулж хайрла. Гамшигт гэсгээл бол дайсны чинь үзвэл зохих үүрдийн цээрлэл шүү дээ” гэнэ.
66. Там бол үнэхээр муухай байр, муу ёрын газар.
67. Ивээлт боолууд нь хөрөнгө зарцуулахдаа үрэлгэн ч бус, харамч ч бус, дундаж байр суурийг баримталцгаадаг юм.
68. Тэд Аллахтай эн зэрэгцүүлсэн элдэв бурхадыг тахин шүтдэггүй. Аллахын хориглосон амийг (хүнийг) шударгуу бусаар эс хөнөөх бөгөөд садар самуунд автдаггүй билээ. Үүнийг зөрчвөл нүгэлийнхээ гэсгээлийг амсах нь баараггүй болой.
69. Тухайлбал, дахин амилахуйн өдөр гэсгээл нь хоёр дахин нэмэгдэж, тэнд үүрд доромжлуулан үлдэх болно.
70. Хэн наминчлан сүсэглэж, сайн үйл үйлдэнэ, Аллах тэдний муу үйлийг сайн үйлээр солино. Аллах машид ивээн тэтгэгч, онцгой энэрэн хайрлагч билээ.
71. Хэн нүгэлээ наминчлан гэмшиж, сайн үйл үйлдэнэ, тэр Аллахын зүг эргэж буй хэрэг.
72. Тэд худал хуурамчаар гэрч болохгүй, дэмий чалчаа үгэнд чих тавихгүй, мөрөөрөө яваад өнгөрдөг.
73. Өөрсөд нь Эзэнтний айлдварууд болон ухуулга сургамж өгөгдвөл үзээгүй, сонсоогүй царай гаргахгүй, талархан хүлээн авдаг юм.
74. Тэд: “Аяа, Эзэнтэн минь! Биднийг баясгах хань ижил, үр хүүхэд хайрла, биднийг чин сүсэгтэнүүдийн ухуулагч болгож хайрла” хэмээн залбирна.
75. Тэд ийнхүү хүлцэл тэвчээр гаргасны төлөө хамгийн эрхэм шагналаар (диваажингаар) шагнагдана. Аллахын элч нар тэднийг хүндлэл, мэндлэлээр угтан авах бөлгөө.
76. Тэд тэндээ үүрд орших бөгөөд диваажин юутай сайхан орон байр юм гээч!
77. Аяа, Мухаммед! Үл сүсэглэгсдэд: “Та нарын уншлага, залбирал үгүй байваас Эзэнтэн тоохгүй шүү дээ. Та нар үнэндээ гэгээн элч болон Кураныг худал хэмээн үгүйсгэсэн. Тиймээс зовлонт гэсгээлтэй учрах болно” хэмээн хэлэгтүн!

## 26. СУРЕ ШУГАРА

Мекке-д илгээгдсэн. 227 айлдвар.

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Та. Син. Мим.
2. Эдгээр нь яруу тод Куран судрын айлдварууд мөн.
3. Аяа, Мухаммед! Тэдний сүсэглэн итгээгүйн төлөө бухимдан, өөрийгөө хөнөөх шахлаа шүү дээ.
4. Бид хүссэн бол тэнгэрээс ер бусын нотолгоо бүхий нэгэн гайхамшиг буулгахад тэд сөхрөн мөргөх л байсан.
5. Нигүүлсэгч Аллахаас өөрсдөд нь нэгэн шинэ сургамж ирэх бүрт тэд түүнээс нүүр буруулцгаадаг юм.
6. Тэдний Кураныг худал хэмээн үгүйсгэн, доог тохуу хийсний гай барцад нь өөрт нь оногдох болно.
7. Тэд газар дэлхийг хардаггүй юм гэж үү? Бид тэнд элдэв төрлийн гоо үзэсгэлэнт ургамал цэцгэсийг ургуулсан билээ.
8. Тэдгээрт Аллахын ид хавыг харуулах бэлгэдэлүүд бий. Гэвч тэдний олонхи нь үл итгэдэг хүмүүс бөлгөө.
9. Эргэлзээ огт үгүй, Эзэнтэн чинь аугаа бөгөөд эгнэшгүй хайр энэрэлийн эзэн мөн.
10. Нэгэнтээ Эзэнтэн чинь Мусад ийн айлдан: “Тэрхүү харгис зальхай ардад очигтун!”
11. “Өөрөөр хэлбэл Фиргауны ардад очигтун! Тэд бидний гэсгээлээс айхгүй юм гэж үү?” хэмээв.
12. Муса: “Аяа, Эзэнтэн минь! Үнэндээ тэд намайг хүлээн зөвшөөрөхгүй болов уу?” хэмээн айж баймуй.
13. Тэгэх аваас миний дотор бачуурч, хэл маань ээдэрч бухимдана. Иймд надад туслалцуулахаар Харуныг ч элч болгож өгөөч?!
14. Тэдний хэлдгээр тулгасан нүгэл ч буй. Тэдний хорлох халдлагаас айж байна” гэв.
15. Аллах: “Үгүй ээ, тэд чамайг хэзээ ч алж эс чадах юм. Тиймээс та нар ер бусын гайхамшигуудтай минь очигтун. Бид, та нартай хамт бөгөөд мэтгэлцээнүүдийг сонсож байх болно” гэв.
16. Хоёулаа Фиргаун дээр очоод: “Бид орчлон ертөнцийн Эзэнтний элч нар байна;
17. Тиймээс, Израйлын үр садыг чөлөөлж, бидэнтэй хамт явуулагтун! хэмээн хэлээрэй” гэв.

18. Тэд хоёулаа Фиргаунд Аллахын айлдварыг хүргэхэд Фиргаун Мусад хандан: “Бид чамайг бага балчираас чинь асарч, эрийн цээнд хүргэсэн биш билүү? Амьдралынхаа олон жилийг бидний дунд өнгөрүүлээгүй ээн бил үү?”
19. Эцэст нь чи хүн алж хэрэг үйлдсэн. Түүгээр ч барахгүй бидний тусыг мартсан!” хэмээн зэмлэв.
20. Муса: “Би тэр хэргийг эндэж, мэдэлгүйгээр хийсэн билээ;
21. Тэгээд, та нараас айж зугтсан юм. Эцэст нь Эзэнтэн маань надад мэргэн ухаан хайрлаж, намайг гэгээн элчээр илгээлээ;
22. Чи Израйлын үр садыг боолчилсон. Чиний надад үүрэг болгосон хувь хишиг чинь тэр л дээ!” гэв.
23. Фиргаун: “Чиний орчлон ертөнцийн Эзэнтэн гээд байгаа чинь юу юм бэ?” хэмээн асуув.
24. Муса: “Тэнгэр, газар болон тэдгээрийн хооронд буй бүхий л амьд амьтны Эзэнтэн. Хэрэв, та нар үнэхээр ухаарч ойлгодог хүмүүс л юм бол” гэв.
25. Фиргаун эргэн тойронд байгсдад хандан: “Мусагийн ярьсныг сонссон биз дээ?!” гэв.
26. Муса: “Тэр та нар хийгээд өвөг дээдсийн чинь Эзэнтэн.”
27. Фиргаун: “Бидэнд илгээгдсэн энэ элч бол үнэхээр солиотой амьтан юм.”
28. Муса: “Хэрэв, ухаарч ойлгох аваас Тэр бол өрнө, дорны хийгээд тэдгээрийн хооронд орших бүхний эзэнтэн мөн.”
29. Фиргаун: “Хэрэв, чи надаас өөр алив юмыг бурхан хэмээн шүтэх аваас би чамайг гянданд суулгах болно!”
30. Муса: “Тэгээн элч болоход минь яруу тод нотолгоо авч ирсэн ч тэгнэ гэж үү?”
31. Фиргаун: “Хэлсэн үг чинь үнэн юм бол (ер бусын гайхамшигаа авч ирээд) харуулаад аль?!” хэмээн зандрав.
32. Муса таягаа шидмэгц тэр аврага луу болон хувирлаа.
33. Мөн тэрээр гараа өврөөсөө гаргахад гар нь хүмүүст цав цагаан болж харагдан, гэрэл гэгээ гэрэлтүүлсэн мэтээр хувирлаа.
34. Фиргаун эргэн тойрны хүмүүст хандан: “Эднүүс бол чадварлаг илбэчид байна!
35. Тэр та нарыг илбэдэн ховсдож эх нутгаас чинь хөөхийг санаархаж байна. Та нар одоо үүнд юу гэмээр байна даа?” гэж асуув.
36. Тэд: “Тэднийг түр орхин, хот суурингууд руу зарлагуудыг илгээ;
37. Бүхий л эрдэм чадалтай шидтэнгүүдийг цуглуулан авч ирэг” хэмээв.
38. Товлосон өдрийн тодорхой цагт хотын ид шидтэнүүд цугларав.
39. Хэн нэгэн олон нийтэд хандан: “Та нар цугларч гүйцсэн үү?” гэхэд



40. Цугларсан хүмүүс: “Хэрэв, ид шидтэнүүд ялвал бид тэднийг дагах болно” гэв.
41. Хотын ид шидтэнүүд ирээд Фиргаунд хандан: “Хэрэв, бид ялах аваас шагнал байгаа юу?” хэмээн асуув.
42. Фиргаун: “Тийм ээ, тэр тухайд огт эргэлзэх хэрэггүй, та нар миний шадар туслахууд болцгоох болно” гэж хариулав.
43. Муса тэдэнд: “Алив, Та нар хаях юмаа хаяцгаагтун” гэв.
44. Тэд аргамж дээс, таяг юугаан шидэцгээж: “Фиргауны нэр сүрийн төлөө гарцаагүй ялах болно” гэж хэлцгээсэн билээ.
45. Дараа нь Муса таягаа шидэхэд тэр нь даруй аврага луу болон хувирч, нөгөөдүүдийн хуурамчаар илбэдсэн зүйлсийг нь хуу хаман залгилж орхилоо.
46. Үүнд алмайрсан хотын илбэчид сөхрөн унцгаалаа.
47. 48. Тэд: Орчлон ертөнцийн Эзэнтэнд, Муса, Харун хоёрын эзэнд итгэн биширлээ” хэмээцгээв.
49. Гэтэл Фиргаун хилэгнэн: “Миний зөвшөөрөлгүйгээр түүнд итгэн сүсэглэсэн гэж үү! Энэ бол та нарт илбэ ухааныг сургасан хүн байх нь ээ. Та нарыг хэрхэн гэгсгэхийг удахгүй мэдэх болно. Та нарын хөл, гарыг солибуулан тас цавчаад, цаазын модон дээр цовдлон тэлүүрдмүй!” хэмээн зандрав.
50. Илбэчид: “Зүгээр ээ! Бид үхлээ гээд Эзэнтэн рүүгээ буцаагдах болно;
51. Мусад анхлан сүсэглэсэн учир Эзэнтэн маань бидний эндэгдлийг өршөөнө хэмээн горьдмуй” гэв.
52. Тэгээд Бид Мусад хандан: “Үнэнч боолуудаа дагуулан шөнө дөлөөр мордогтун! Гарцаагүй мөшгин мөрдөгдөх болно” хэмээн айлдав.
53. Ийнхүү Фиргаун хот суурингуудад цэрэг цуглуулагчдыг илгээлээ.
54. Фиргаун: “Үнэндээ эд нар (Израйлын үр сад бол) тоо цөөхөн, хагас хугас нэгэн бүлэг;
55. Тэд биднийг хилэгнүүлсэн;
56. Харин бид сэрэмжлэн бэлэн байгаа хүмүүс” хэмээн сүржигнэв.
57. Ийнхүү Бид тэднийг (Фиргаун болон түүний ардыг) цэцэрлэгүүдээс нь тунгалаг булаг горхинуудаас нь салгав.
58. Мөн эрдэнэсийн сан хийгээд үзэсгэлэнт орон байруудыг ч үгүй хийсэн билээ.
59. Энэхүү үнэт эрдэнэс болон үзэсгэлэнт орд харшуудыг нь Израйлын үр садад өв залгамжлуулан үлдээсэн юм.
60. Фиргауны цэргүүд хотоос шөнө дөлөөр гарсан хүмүүсийн араас наран мандахад үлдэн хөөж, гүйцэж ирэв.

61. Ингээд хоёр бүлэг нэг нэгнийгээ хармагцаа, Мусагийн хүмүүс: “Бид гарцаагүй баригдах нь ээ” гэлцэв.
62. Муса: “Үгүй ээ, Эзэнтэн минь ямар ч эргэлзээгүй надтай хамт бөгөөд надад нэгэн гарц үзүүлэх болно” гэв.
63. Тэгэхэд Бид Мусад хандан: “Тэнгисийг таягаараа цохигтун!” хэмээн тушаав. Тэгтэл тэнгис хоёр тийш ярагдан, (арван хоёр салаа зам буй болж) тэнгисийн ярагдсан усны давалгаанууд хоёр талдаа аварга уул мэт болж тогтов.
64. Үлдэн хөөсөн Фиргауны хүмүүсийг энд саатуулан зогсоов.
65. Тэгээд Бид Муса болон түүнтэй хамт явагсадын бүгдийг нь аварсан билээ.
66. Дараа нь Фиргауны бүлэг болох нөгөөдүүлийг усанд живүүллээ.
67. Эргэлзээгүй үүнд нэгэн сургамж байсан юм. Гэсэн ч тэдний олонхи нь эс сүсэглэцгээсэн.
68. Эзэнтэн чинь үнэхээр аугаа бөгөөд эгнэшгүй хайр энэрэлийн эзэн шүү дээ.
69. Аяа, Мухаммед! Тэдэнд Ибрахимын тухай өгүүллийг хэлж өг.
70. Тэр үед Ибрахим өөрийн аав болон ард түмэндээ хандан: “Та нарын сүсэглэн мөргөцгөөдөг зүйлс чинь юу вэ?” хэмээн асуув.
71. Тэд: “Бид шавар бурхадыг тахин шүтэж, тэднийг бишрэн залбирсаар ирлээ” хэмээн хариулав.
72. Ибрахим: “Тэгвэл, та нарын гуйн залбирсныг тэд сонсдог уу?”
73. Эсвэл та нарт ашиг тус хийгээд хор хөнөөл учруулж чадах уу?” хэмээн асуулаа.
74. Тэд: “Үгүй ээ, гэвч бид өвөг дээдсийнхээ ийнхүү сүсэглэдэгийг харсан юм” гэв.
75. Ибрахим: “Та нарын тахин шүтэж байгаа юм чинь юу вэ?;
76. Тэртээ өвөг дээдсийн чинь тахин шүтсэнийг бодож үзэцгээсэн үү?;
77. Та нар сайтар мэдэж авагтун, тэд чинь миний атаат дайсан юм шүү дээ, гагц орчлон ертөнцийн Эзэнтэн гэвэл миний шүтээн болой.
78. Тэр намайг бүтээсэн, бас надад зөв шулун замыг заасан;
79. Намайг хооллож, ундаалдаг нь ч Тэр,
80. Өвчин тусахад намайг анагаах увидас өгөгч нь мөн Тэр билээ.
81. Миний амийг авах нь, дараа нь дахин амилуулах нь ч Тэр мөн.
82. Хойд ертөнцөд залрах өдөр алдаа эндэгдлийг минь өршөөн соёрх хэмээн Түүнээс наминчилж хүсдэг.
83. Аяа, Эзэнтэн минь! Надад мэргэн ухааныг хайрлан, намайг сайн үйл үйлдэгсэдийн эгнээнд багтаан соёрхогтун?!

84. Хойч үеийнхний дунд сайн сайхнаар дурсагдан үлдэх тавиланг надад хайрлагтун.
85. Буян хишиг дүүрэн (Нагим) диваажинг надад өвлүүлэгтүн.
86. Аавыг маань өршөөн соёрхогтун. Учир нь тэр төөрөлдөгсөдийн нэг байсан билээ.
87. Ертөнцийн төгсгөлд дахин амилахын өдөр намайг бүү шившиглэгтүн. гэв.
88. Тэр өдөр, мал хөрөнгө, үр удмын аль нь ч ашиг тус эс болно.”
89. Гагцхүү Аллах руу цэвэр ариун сэтгэл, чин зүрхээрээ ирэгсэд тусыг олох билээ.
90. Тэр өдөр диваажин ч үнэн сүсэглэгсдэд ойртуулагдах аж.
91. Там төөрөлдөгсөдөд ил тодоор харуулагдах болно.
92. Буруу номтнуудаас: “Аллахаас өөр тахин шүтсэн зүйл чинь алив, хаана байна?
93. Тэд та нарт, тэрчлэн өөрсдөдөө туслаж чадах болов уу” хэмээн асуугдах болно.
94. Ийнхүү зохиомол бурхад ч, төөрөгсөд ч халуун там руу шидэгдмүй.
95. Чөтгөр шулмасынхан бөөн бөөнөөрөө там руу унах болно.
96. Тэд тамын тогоонд нэг нэгэнтэйгээ ийнхүү арсалдан хэрэлдэнэ:
97. Аллахын алдраар андгайлан хэлье, үнэндээ бид их л төөрөлдсөн байна шүү дээ
98. Нэгэнтээ бид та нарыг (зохиомол бурхадыг) ертөнцийн Эзэнтэнтэй эн зэрэгцүүлсэн биз дээ □
99. “Биднийг гагц тэр нүгэлтэнгүүд л төөрөлдүүлчихлээ.”
100. “Одоо бидэнд ямар ч өмгөөлөн ивээгч алга;
101. Бас ямар ч ойр дотны найз нөхөд ч алга.”
102. “Хэрэв биднийг амьд хорвоо руу буцах юм бол үнэн сүсэгт мусулман болох юмсан” гэлцэнэ.
103. Эргэлзээгүй, үүнд нэгэн сургамж буй. Гэвч тэдний олонхи нь үл сүсэглэдэг юм.
104. Эзэнтэн чинь үнэндээ ялгуусан аугаа бөгөөд эгнэшгүй хайр энэрэлтэй билээ.
105. Нухын ард олон ч гэгээн элчүүдийг хүлээн зөвшөөрөөгүй юм.
106. Тухайн үед тэдний садан төрөл Нух тэдэнд хандан: “Та нар Аллахын гэгсгээлээс айдаггүй юм уу?;
107. Би үнэхээр та нарт илгээгдсэн итгэлт гэгээн элч мөн;
108. Тиймээс Аллахаас айж, намайг дагагтун;

109. Үүний хариуд би та нараас ямар ч шан харамж хүсэхгүй. Миний шан харамж гагцхүү ертөнцийн Эзэнтэнд хамааралтай;
110. Тийм болохоор Аллахаас айж, намайг дагагтун!” хэмээн хэлсэн.
111. Тэд: “Чамайг хамгийн сул дорой амьтад дагалаа гэж бид чамд сүсэглэн итгэх юм уу?” хэмээн хариулав.
112. Нух: “Би тэдний юу хийснийг мэдэхгүй;
113. Хэрэв мэддэг юм бол, тэдний тооцоо нь гагцхүү Эзэнтэнд хамааралтай юм шүү дээ;
114. Би сүсэглэн итгэсэн хэнийг ч хөөхгүй;
115. Би зөвхөн ил тод сэрэмжлүүлэгч билээ” гэв.
116. Тэгэхэд тэд: “Аяа, Нух! Энэ ухуулгаа зогсоохгүй бол чам руу чулуу нүүлгэх болно шүү!” гэв.
117. Нух: “Аяа, Эзэнтэн минь! Зон олон маань намайг худал хэмээн буруутгалаа.
118. Намайг тэднээс салгаж үзээч! Намайг болон надтай хамт буй үнэн сүсэгтнүүдийг аварч хайрла!” хэмээн залбирав.
119. Ийнхүү Бид түүнийг болон түүнтэй хамт байгсадыг (хүн ба амьтадыг) усан онгоцонд суулган аварсан билээ.
120. Харин бусдыг нь усанд живүүлсэн юм.
121. Үүнд үнэндээ бодит сургамж буй. Гэвч тэдний олонхи нь үл сүсэглэдэг юм.
122. Эзэнтэн чинь үнэндээ ялгуулсан аугаа бөгөөд эгнэшгүй хайр энэрэлтэй.
123. Гадийн ардууд ч гэгээн элч нарыг хүлээн зөвшөөрөөгүй юм.
124. Тэр үед түүний садан төрөл Худ хүмүүстээ хандан: “Аллахаас айдаггүй юм уу?;
125. Би үнэхээр та нарт илгээгдсэн итгэлт гэгээн элч мөн.
126. Тиймээс Аллахаас айж, намайг дагагтун,
127. Үүний хариуд би та нараас ямар ч шан харамж хүсэхгүй. Миний шан харамж гагцхүү ертөнцийн Эзэнтэнд хамааралтай.
128. Та нар дов толгод бүхэнд бэлгэдэл босгон хөөрөн баясаж, цаг нөхцөөх юм уу?
129. Бат бөх, битүү байр сав барьж гайхуулсанаараа үүрд мөнх үлдэнэ хэмээн санаж байна уу?
130. Бусдыг гэгсгээвэл харгис дарангуйлагч лугаа адил цээрлүүлэх гэж үү?
131. Тийм болохоор Аллахаас айж, намайг дагагтун.
132. Та нарын мэдэж буй бүхнийг хайрласан Аллахаас айгтун.
133. Тэр та нарт мал сүрэг хийгээд үр хүүхдийг;
134. Мөн цэцэрлэгүүд хийгээд булагийн усыг хайрласан (Аллахаас айгтун).

135. Үнэндээ би та нарт тохиох аугаа өдрийн гэсгээлээс айж баймуй” гэв.
136. Тэгэхэд тэд: “Чи сургамж өглөө ч, өгөөгүй ч бидэнд нэгэн адил;
137. Энэ нь (гараар урласан бурханд залбиран шүтэх нь) урьд өмнөхүүдээс уламжилсан ёс заншил юм;
138. Бид хэзээ ч гэсгээгдэхгүй” гэлцэв.
139. Ийнхүү тэд Худ гэгээн элчийг хүлээн зөвшөөрөөгүй тул бид өөрсдийг нь дуусгавар болгосон юм. Эргэлзээгүй, үүнд нэгэн сургамж байсан ч тэдний олонхи нь үл сүсэглэцгээсэн билээ.
140. Эзэнтэн чинь ялгуусан аугаа бөгөөд эгнэшгүй хайр энэрэлтэй.
141. Самудын ардууд ч гэгээн элч нарыг хүлээн зөвшөөрөөгүй юм.
142. Тухайн үед тэдний садан төрөл Салих: “Та нар Аллахаас айдаггүй юм уу?”
143. Би үнэхээр та нарт илгээгдсэн итгэлт гэгээн элч мөн;
144. Тиймээс Аллахаас айж, намайг дагагтун;
145. Үүний хариуд би та нараас ямар ч шан харамж хүсэхгүй. Миний шан харамж гагцхүү ертөнцийн Эзэнтэнд хамааралтай;
146. Та нар энд айх аюулгүй үлдэнэ хэмээн санаж байна уу?
147. Цэцэрлэг хийгээд, булагт,
148. Тарайн талбай хийгээд, цэцэг навч нь сагсайх хасарваань дунд айх аюулгүй үлдэнэ хэмээн санаж байна уу?;
149. Амиа хохойлохын тулд уулыг агуйлан орон байр урлах юм уу? ;
150. Аллахаас айж, намайг дагагтун;
151. Хэмээс хэтэрсэн танхайчуудыг бүү дагагтун;
152. Тэд газар дэлхий дээр муу муухай юмтай зууралдан, хуучин дадлаасаа салахгүй” хэмээн ухуулав.
153. Тэд Салихт хандан: “Чи ёстой л солирсон амьтан юм;
154. Чи бол бидэнтэй адил хүн шүү дээ. Хэлсэн чинь үнэн юм бол ер бусын гайхамшигаа харуулаад аль?! хэмээн сагсуурав.
155. Салих: “Энэ байна! Энэ ингэн тэмээ бол тэрхүү ер бусын гайхамшиг мөн. Ус уух ээлжийн нэг өдөр нь түүнийх, нөгөө өдөр нь та нарынх болог;
156. Түүнийг бүү хорлоцгоогтун, хорлон хөнөөвөл та нар аугаа өдрийн гэсгээлтэй учирах болно” хэмээн сануулав.
157. Гэвч, тэд ингийг алчихаад хожим туйлаас харамссан юм.
158. Тэгээд тэд гэсгээлд нэрвэгдсэн билээ. Үнэндээ үүнд нэгэн сургамж байлаа. Гэвч, тэдний олонхи нь үл сүсэглэцгээсэн юм.
159. Эзэнтэн чинь эргэлзээгүй аугаа бөгөөд эгнэшгүй хайр энэрэлийн эзэн шүү дээ.

160. Лутын ардууд ч гэгээн элч нарыг хүлээн зөвшөөрөөгүй юм.
161. Тэдний садан төрөл Лут: “Та нар Аллахаас айдаггүй юм уу?;
162. Би үнэхээр та нарт илгээгдсэн итгэлт гэгээн элч мөн;
163. Тиймээс Аллахаас айж, намайг дагагтун;
164. Үүний хариуд би та нараас ямар ч шан харамж хүсэхгүй. Миний шан харамж гагцхүү ертөнцийн Эзэнтэнд хамааралтай;
165. Энэ хорвоод та нар яахлаар эрчүүд рүү дайрцгаадаг юм вэ?;
166. Эзэнтнээс чинь та нарт заяасан эхнэрүүдээс юунд салсан юм вэ? (Эхнэрээ орхиод эрчүүдтэй хавьтах юм уу?) Үнэндээ та нар хэмээс хэтэрсэн ичгүүргүй амьтад” гэв.
167. Тэд: “Аяа, Лут! Хэлсэн энэ үгнээс буцахгүй бол нутгаас хөөгдөх болно!” хэмээн сүрдүүлэв.
168. Лут: “Би та нарын ааш авирыг үнэхээр жигшиж байна!;
169. Аяа, Эзэнтэн минь! Намайг болоод миний гэр бүлийг, тэдний үйлдсэн бузараас аварч хайрла?!” хэмээн залбирав.
170. Бид түүнийг болон түүний гэр бүлийг аварсан билээ.
171. Бид ганц буурай эмгэнийг (Лутын эхнэр) тэр ардын дунд үлдээсэн юм.
172. Дараа нь бусдыг бүгдийг нь үгүй хийсэн.
173. Бид тэдний дээрээс чулуун бороо оруулав. Тэрхүү сэрэмжлүүлэн гэсгээх бороо юутай муухай юм гээч!
174. Үнэндээ энд нэгэн сургамж буй. Гэвч тэдний олонхи нь үл сүсэглэцгээсэн билээ.
175. Эзэнтэн чинь үнэхээр аугаа бөгөөд эгнэшгүй хайр энэрэлтэй.
176. Айкегийн ардууд ч гэгээн элч нарыг хүлээн зөвшөөрсөнгүй.
177. Шугайб тэдэнд хандан: “Та нар Аллахаас айдаггүй юм уу?;
178. Би үнэхээр та нарт илгээгдсэн итгэлт гэгээн элч мөн,
179. Тиймээс Аллахаас айж, намайг дагагтун,
180. Үүний хариуд би та нараас ямар ч шан харамж хүсэхгүй. Миний шан харамж гагцхүү ертөнцийн Эзэнтэнд хамааралтай,
181. Та нар жин хэмжүүрээ бүрэн байлгаж, бүү дутуу хагас хэмжигтүн!
182. Мөн зөв жин хэмжүүрээр хэмжигтүн.
183. Та нар хүмүүсийн хөлс хүчийг дутуу бодож болохгүй. Мөн газар дэлхий дээр танхайран, үймээн самуун бүү таригтун.
184. Та нар болон та нарын өмнөх үеүүдийг бүтээсэн Аллахаас айгтун” гэв.
185. Тэд: “Чи үнэхээр илбэдүүлсэн байна;
186. Чи ч гэсэн, бидэнтэй адил хүн шүү дээ. Бид чамайг угаасаа худалч нэгэн хэмээн бодож баймуй.

187. Хэрэв, чи үнэн хэлсэн бол, бидний дээрээс тэнгэрийг бутлан буулгагтун” гэж шаардав.
188. Шугайб: “Эзэнтэн минь та нарын хийсэн бүхнийг маш сайн мэддэг” хэмээн хариулав.
189. Тэд Шугайб элчийг хүлээн зөвшөөрөөгүй юм. Тэднийг сүүдэрт өдрийн гэсгээл дайрав. Энэ бол аугаа өдрийн гэсгээл байлаа.
190. Үнэндээ үүнд нэгэн сургамж байсан юм. Гэвч тэдний олонхи нь үл сүсэглэцгээсэн билээ.
191. Эзэнтэн чинь үнэнхүү аугаа бөгөөд эгнэшгүй хайр энэрэлтэй.
192. Энэхүү Куран бол эргэлзээгүй ертөнцийн Эзэнтнээс айлдсан илгээлт болой.
193. (Аяа, Элч минь) Түүнийг миний итгэлтэй элч Жабрейл чиний зүрх сэтгэлд шингээсэн юм.
194. Чамайг сэрэмжлүүлэгсэдийн нэг нь болгох хэмээсэн билээ.
195. Куран яруу тод араб хэлээр буусан.
196. Тэрээр урьд өмнөхүүдийн судруудад ч дурьдагдсан болой.
197. Кураныг Израйлийн гэгээн ухаантнууд мэдэх болсон нь тэдний (Меккегийн буруу номтнуудын) хувьд нэгэн нотолгоо биш гэж үү?
198. Хэрэв Бид Кураныг араб бус нэгэнд буулгасан бол;
199. Түүнийг (тэр ардын) үл сүсэглэгсдэд уншиж өгсөн ч, тэд үл итгэцгээх байсан.
200. Ийнхүү Бид Кураныг нүгэлтэнгүүдийн зүрх сэтгэлд нь суулгасан болой.(Нүгэлтэнгүүд Кураныг уншихад ойлгож байсан ч залбирдаггүй юм.)
201. Тэд хатуу гэсгээлийг үзэхээс наана Куранд үл итгэцгээнэ.
202. Тийнхүү гэсгээл нь тэдэнд анзаараагүй байхад гэнэт ирэх болно.
203. Тэр мөчид үл сүсэглэгсэд: “Бидэнд наминчлан залбирах цаг өгөгдөх болов уу?” хэмээн сандралдана.
204. Тэд бидний гэсгээлийн үтэр түргэн ирэхийг хүссэн юм болов уу?
205. (Аяа, Мухаммед!) Харцгааж байна уу? Бид тэднийг олон жилийн турш сайн сайхнаар цэнгүүлээд;
206. Дараа нь тэдэнд товлогдсон гэсгээл тохиох аваас;
207. Цэнгэн жаргасан хувь хишиг нь юунд ч тус эс болох болой.(гэсгээлээс аварч чадахгүй).
208. Бид ямар ч хот сууринг сэрэмжлүүлэгч гэгээн элч илгээлгүйгээр сүйтгээгүй юм.
209. Энэ бол нэгэн сэрэмжлүүлэг. Бид шударга бусаар цээрлүүлээгүй билээ.
210. Кураныг чөтгөр шулмас авчраагүй юм.

211. Энэ нь тэдний хувьд зохистой биш бөгөөд угаасаа чадал ч үгүй билээ.
212. Тэд үнэхээр (хулгайгаар) айлдварыг сонсох нь хязгаарлагдсан юм.
213. Аяа, Мухаммед! Аллахтай эн зэрэгцүүлсэн алив бурхадыг бүү тахин шүтэгтүн, тэгвээс чи ч гэсгээл хүртэгсэдийн нэг нь болно.
214. Чи юуны урьд ойрын ах дүүс нараа сэрэмжлүүл.
215. Мөн чамайг дагасан үнэн сүсэгтэнгүүдэд хайр энэрэлийнхээ далавчаа дэлгэ.
216. Хэрэв, ахан дүүс чинь чамайг эсэргүүцвэл: “Та нарын хийсэн бүхнээс ангид” хэмээн хэлэгтүн.
217. Аугаа хийгээд эгнэшгүй энэрэлтэй Эзэнтнийгээ түшиж тулагтун.
218. Тэр чамайг уншлага мөргөлийн үеэр харах болно.
219. Мөн уншлага мөргөлийн дундах наминчлал, залбиралын хөдөлгөөн бүрийг чинь харж байдаг.
220. Аллах үнэхээр алив бүхнийг сонсогч, мэдэгч билээ.
221. Харин чөтгөр шулмас хэнийг дулдуйдахыг нь хэлж өгөх үү?
222. Тэд ховч нүгэлтнүүдийг дагаж дулдуйдана.
223. Ховч гүтгэгчид чөтгөр шулмасын үгэнд чих тавих бөгөөд тэдний олонхи нь худалчид мөн.
224. Яруу найрагчдыг төөрөлдөгсөд дагаж далбагнана.
225. Тэдний ам жалга бүрээр тэнүүчилж явааг чи хараагүй гэж үү?
226. Тэд хийгээгүй ажлыг хийсэн мэтээр, худал юмыг үнэн мэтээр ярьдаг. (Чи үнэхээр хараагүй гэж үү?)
227. Гэвч, бишрэн сүсэглэж сайн үйл үйлдэгсэд, Аллахыг маш ихээр дурсагсад харгис зальхай явдалд өртвөл түүнээс өөрсдийгөө хамгаалагсад өөр шүү дээ. Харин харгис зальхай үйл үйлдэгсэд ямар газарт очихоо мөдхөн мэдэх болно.



Мекке-д илгээгдсэн. 93 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Та, Син. Энэ нь Кураны буюу яруу тод судрын айлдварууд болой.
2. Үнэн сүсэглэгсэдийн хувьд баярт мэдээ бөгөөд зөв шулуун замыг залагч бөлгөө,
3. Тэд уншлага мөргөлөө үйлддэг, ариуслын өглөгөө өргөцгөөдөг, хойд ертөнцөд чин үнэнчээр итгэцгээдэг.



4. Бид, хойд ертөнцөд үл итгэгсэдийн үйл араншинг өөрсдөд нь үнэмшилтэй харуулсан. Түүгээр тэд мөнхөд мунгинаж явах болно.
5. Тэд гэгсгээлийн хамгийн хүнд муухайтай нь учрана. Хойд ертөнцөд хамгийн их хор хөнөөлд өртөгсөд ажгуу.
6. (Аяа, Мухаммед!) Ямар ч эргэлзээгүй, Куран бол чамд мэргэн ухааны эзэн, бүхнийг мэдэгч Аллахын зүгээс өгөгдсөн болой.
7. Тэр үед Муса гэр бүлийнхэндээ хандан: “Би үнэхээр нэг гал үзлээ. Гал гарсан газар дээр очиж нэг мэдээ авч ирье, эсвэл та нарыг дулаацуулахын тулд галын цогыг авч ирье” гэж хэллээ.
8. Түүнийг гал гарсан газарт ойртоход ийн өгүүлэх дуу сонсогдов: “Галын дэргэд буюу ойролцоо байсан хүмүүст буян хишиг оногдог! Бүхий л ертөнцийн эзэн болох Аллах чин ариун;
9. Аяа, Муса! Аугаа бөгөөд мэргэн ухааны эзэн-Аллах би мөн.
10. Муса таягаа шид!” хэмээн тушаав. Муса таягаа шидэхэд түүнийг могой лугаа адил мурилзан буйг хармагцаа эргэж ч харалгүйгээр зугтан одлоо. Тэр мөчид Аллахын дуу сонсогдож: “Аяа, Муса! Бүү ай! Миний өмнө гэгээн элчүүдэд айдас үгүй ” хэмээн хэллээ.
11. Хэрэв, хэн нэгэн шударгуу бус юм хийж, дараа нь үйлдсэн муу үйлээ сайн үйлээр солих аваас, түүний төлөө Би машид өршөөн соёрхогч бөгөөд нэн энэрэгч байнам.
12. Гараа өвөртөө хийгтүн. Гар чинь цав цагаан болоод гарч ирнэ. Энэ нь Фиргаун болон түүний ардуудад үзүүлэх ер бусын есөн гайхамшигуудын нэг нь мөн. Тэд үнэндээ эвдэрсэн хүмүүс” гэв.
13. Ер бусын гайхамшигуудыг үзүүлэхэд тэд: “Энэ бол илэрхий илбэний ид шид” хэмээн хэлцгээв.
14. Тэд ийнхүү гайхамшгуудад дотороо итгэж байсан агал зальхай, бардам зангаараа хүлээн зөвшөөрсөнгүй. Танхайрагсадын хувь заяа хэрхэн төгсөхийг харатгун.
15. Бид Сүлейман, Дауит хоёрт эрдэм мэдлэгийг хайрласан билээ. Тэд: “Биднийг үнэн сүсэглэгч боол нарынхаа олонхиос дээгүүр өргөмжилсөн Аллахыг шагшин магтмуй” хэмээн хэлцгээв.
16. Тэгээд Сүлейман гэгээн элч болон шашныг тэргүүлэх тухайд Дауит аавыгаа залгамжлан: “Аяа, хүмүүс ээ! Бидэнд шувуудын хэлийг зааж сургасан. Мөн энэ хорвоогийн алив бүхнээс хүртээгдсэн билээ. Энэ бол Аллахын илэрхий хайр энэрэл шүү дээ” гэв.
17. Сүлейманы өмнө буг чөтгөр, хүмүүн, шувуудаас бүрдсэн дайчид цугларлаа. Тэд бүгд дэгтэй журамлагдсан билээ.
18. Тэд Шам хотын орчимд шоргоолжны хөндийд ирэхэд нэгэн шоргоолж: “Аяа, шоргоолжууд аа! Сүлейман хийгээд түүний олон цэрэг дайчдыг санамсаргүйгээр няц даруулахгүйн тулд үүрэндээ орцгоогтун” гэв.

19. Сүлейман түүний үгийг сонсоод инээмсэглэн: “Аяа, Эзэнтэн минь! Надад болон эцэг эхэд маань хайрласан хувь хишигт талархахыг, Чиний таалалд нийцэх сайн үйлийг гүйцэлдүүлэхийг минь хүлээн авч соёрхогтун! Өөрийнхөө ивээлээр намайг эрхэм хүмүүсийн эгнээнд багтаагтун?” хэмээн залбирав.
20. Сүлейман шувуудыг ажиглан бүртгэснээ: “Худхуд шувуу надад яагаад харагдахгүй байна! Эсвэл алга болсон юм уу?” гэж асуув.
21. Түүнийг хатуу цээрлүүлнэ, эсвэл хоолойг нь хэрчмүй. Үгүй бол ирж чадаагүй шалтгаанаа надад даруй ирүүлэг!” гэв.
22. Худхуд удалгүй хүрч ирээд: “Би чиний мэдээгүй нэгэн зүйлийг мэдлээ. Бас чамд Сабагийн орноос баттай нэгэн мэдээ авч ирлээ” хэмээв.
23. Үнэндээ Саба улсад нэгэн эмэгтэй хаан болж, бүхнийг захиран эрхшээснийг харлаа. Тэрбээр өөрт нь алив хэрэгтэй бүхнээр гоёж, бүхнийг эдлэн хэрэглэдэг аж. Мөн эрхэм сэнтийтэй юм байна;
24. Тэр болон түүний ардууд Аллахыг орхиж, нарыг тахин шүтэж буйг олж мэдсэн. Чөтгөр шулмас тэдэнд өөрсдийнх нь үйлсийг гоёчлон харуулж, тэднийг зөв замаас нь төөрөгдүүлжээ. Иймээс тэд зөв шулуун замыг эс олох бололтой.
25. Тэд тэнгэр, газрын далд бүхнийг ил гаргагч, бас та нарын ил, далд үйлдэл бүхнийг мэдэгч Аллахад сөгдөн залбирдаггүй. (чөтгөр шулам тэднийг төөрөгдүүлсэн.)
26. Аугаа сансар огторгуйн эзэн Аллахаас өөр бурхан үгүй.
27. Сүлейман Худхудад хандан: “Чи үнэн хэлсэн үү, худал хэлсэн үү, удахгүй очиж харах болно!;
28. Миний энэхүү захаг тэдэнд аваачиж өгөөд зайдуу зогсож ямар хариу хэлэхийг хүлээ” хэмээн тушаав.
29. Өвөөлж Худхуд захаг аваачиж өгөхөд, Саба ардын эзэн хаан Балкис: “Аяа, эрхэм дээдэс ээ! Надад нэгэн чухал захаа ирлээ;
30. “Энэ захаа Сүлейманаас ирсэн байна. Захианы утга гэвэл: Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэл;е;
31. Та нар биеэ үл тоон, намайг үл эсэргүүцэж, надад захирагдан хүлцэж ирэгтүн” хэмээсэн байна.
32. “Аяа, ноёд дээдэс ээ! Энэ тухай зөвөлгөө, санал хэлцгээгтүн. Би та наргүйгээр ямар ч шийдвэр гаргахгүй” гэв.
33. Тэд (ноёд нь): “Бид зэвсэглэсэн хүчирхэг дайчид билээ. Одоохон зарлигаа буулгаад аль?! Бид зарлигийг чинь биелүүлэхэд бэлхэн!” хэмээн хариулцгаалаа.
34. Хатан хаан тэдэнд: “Алив хаадууд ч хот сууринг эзлэхдээ түүнийг сүйтгэдэг. Тухайн ардын эрхэм сурвалжит хүмүүсийг доромжлон дорд үзнэ. Тэгэхлээр, тэд ч ингэцгээх болой.

35. Би тэдэнд бэлэг сэлт илгээж, элчүүд ямар хариутай буцаж ирэхийг хүлээнэ!” хэмээн шийдэв.
36. Тэгээд элчүүд Сүлейманд хүрэлцэн ирэхүйд тэр элч нарт: “Та нар надад эд баялгаар тал засах гэж байгаа юм уу? Аллахаас надад хайрласан хишиг нь та нарын өгсөнөөс илүү өлзийтэй. Бэлэг сэлтээрээ өөрсдийгөө л баясгагцаарай;
37. Та нар нутагтаа буцацгаа! Та нарыг эсэргүүцэж чадахааргүй дайчидтай очиж, газар нутгаас чинь хөөн зайлуулж, шившиг болгоно!” гэв.
38. Элч нар буцсаны дараа Сүлейман цэргүүддээ хандан: “Аяа, эрэлхэг дайчид аа! Тэд над дээр хүлцэн ирэхээс өмнө та нарын хэн нь хатан хаан Балкисын сэнтийг надад авч ирэх вэ?
39. Буг чөтгөрөөс Ифрит хэмээх нэг нь: “Энэ суудлаасаа босохоос чинь өмнө би түүнийг чамд авчирч өгмүй. Ингэхэд миний хүч чадал хангалттай, бас өөртөө итгэлтэй байна” гэв.
40. Судраас их эрдэм мэдлэгийг авсан нэгэн номч (Асхаб-бин-Бархиа): “Нүдээ ирмэхийн хооронд би түүнийг чамд авчирч өгмүй” гэв. Тэгээд Сүлеймен хатан хааны сэнтийг хажууд нь байхыг хармагцаа: “Энэ бол Эзэнтнээс надад хайрласан ид шид. Намайг бардамнах нь уу, эсвэл наминчлан хүлцэх нь уу хэмээн сорьсны шинж. Хэн хүлцэн талархана, тэр өөрийнхөө тусын тулд юм. Хэн эс хүлцэн, эс талархана, Аллах үнэндээ түүний талархлаар дутахгүй. Мэдэж авагтун. Эзэнтэн эргэлзээгүй өгөөмөр хийгээд чинээлэг болой.”
41. Сүлейман үргэлжүүлэн: “Түүний сэнтийг даруй өөрчлөгтүн. Балкис хатан таньж чадна уу, үгүй үү? харцгаая” гэв.
42. Хатан хаан хүрэлцэн ирэхэд түүнд: “Чиний сэнтий ийм байлуу? хэмээн асуухад тэр: “Яг л мөн байна” хэмээн хариулав. Сүлейман гэгээнтэн (Аллахыг мэдрүүлэх) үүднээс: “Бидэнд өмнө нь эрдэм мэдлэг хайрлагдсан, бид ийн мусулман болсон билээ.
43. Аллахаас бусад тахин шүтсэн зүйлс Аллахад залбирахад саад болдог. Хатан хаан замаасаа төөрөгдсөн байна. Учир нь тэр үл сүсэглэгч ардаас билээ” гэв.
44. Түүнд: “Орд руу ор” хэмээв. Хатан хаан ордод оронгуут усан мандал хэмээн санаж, шуумагаа сөхөн, шилбээ гаргав. Сүлейман түүнд: “Энэ бол шил толиор хийж, болор хавтангаар өнгөлсөн харш” гэхэд хатан хаан: “Аяа, Эзэнтэн минь! Би үнэхээр өөртөө гай барцаг хураажээ. Одооноос Сүлейманий хамт бүхий л ертөнцийн Эзэн Аллахад залбирна” хэмээн амлав.
45. Аллахад сүсэглэн мөргөг хэмээн Бид Самудийн ардуудад түүний садан төрөл Салихыг илгээсэн юм. Гэвч, тэд хоёр бүлэг болж хоорондоо маргалдцгаав.
46. Салих: “Аяа, олон түмэн минь ээ! Та нар юуны учир сайн сайхны оронд

- муу мухай юм руу зүтгэнэ вэ? Та нар Аллахын ивээлийг хүссэн сэн бол, магад та нар хайр энэрэлийг нь хүртэх сэн билээ” гэв.
47. Тэд: “Чи болон чамтай хамт байгсадаас болж бидэнд муу ёр тохиосон билээ” гэв. Салих: “Бүхий л хувь тавилан Аллагаас шалтгаална. Үнэндээ та нар сорилтод орсон ард түмэн шүү дээ” хэмээн хариулав.
  48. Уг хотод хуучин зуршлаасаа салдаггүй, газар бүрт дандаа гай барцат тарьдаг есөн этгээд байсан билээ.
  49. Тэд Аллахын алдраар андгайлцгааж: “Салих болон гэр бүлийнхнийг шөнө дунд эгүүтгээд дараа нь түүний ойрын хамаатнуудад андгай барьж: “Бид Салихийн гэр бүлийг хөнөөгдөхөд тэнд байгаагүй юм шүү, бид үнэнийг хэлж байна хэмээн хэлцгээе” гэлцэв.
  50. Ийнхүү тэд нэгэн ов мэх сэдэв. Харин бид ч тэдний эсрэг нэгэн аргыг нууцхан сэдсэн билээ.
  51. Тэдний ов мэх юугаар төгссөнийг харагтун! Бид тэднийг бүхий л ардуудтай нь хамт хүйс тэмтэрсэн юм.
  52. Тэд харгис зальхай байсан тул хамаг орон байр нь сүйрэв. Ухаарах улст үүнд ч нэгэн сургамж буй.
  53. Бид наминчлан сүсэглэж, нүгэлээс сэрэмжлэгсэдийг аварсан бөлгөө.
  54. Бид бас Лутыг өөрийнхөө ардад гэгээн элч болгон илгээсэн юм. Тэр ард олондоо хандан: “Та нар харсаар байтал ичгүүр сонжуургүй зүйл хийх гэж үү?”
  55. Та нар эмэгтэйчүүдийг үл хайхран, хүсэл тачаалаа эрчүүдээр хангах гэж үү дээ? Та нар жинхэнэ мунхаг - мунаг хүмүүс юм гээч!” хэмээн халаглав.
  56. Түүний ард нь: “Лутын гэр бүлийг хотоос хөөн гаргагтун. Учир нь тэд ёс журамтны дүрийг эсгэгчид шүү дээ” гэхээс өөр хариулт хэлж эс чадав.
  57. Тиймээс, Бид Лутыг болон түүний гэр бүлийн бусад гишүүдийг авран, гагцхүү эхнэрийг нь хотын ардуудын дунд үлдээхээр шийдсэн юм.
  58. Тэгээд бид тэдний дээрээс чулуун бороо оруулсан. Цээрлүүлэгдсэн хүмүүсийн дээрээс орсон бороо юутай муухай гээч!
  59. Аяа, Элч минь! “Бүхий л сайшаал Аллахад, амар амгалан түүний таалсан боол гэгээн элчид зориулагдмуй. Аллах илүү өлзийтэй юу, эсвэл Түүнтэй эн зэрэгцүүлсэн зүйлс үү?” хэмээн хэлэгтүн.
  60. Тэнгэр, газрыг бүтээж, тэнгэрээс хурыг буулгаж, түүгээр ганц мод ч ургуулж чаддаггүй та нарт үзэсгэлэнт цэцэрлэгүүдийг ургуулж өгсөн хэн билээ? Аллагаас өөр бүхнийг бүтээгч бурхан байдаг гэж үү! Үгүй, тэд чин үнэний замаас төөрөлдсөн ардууд юм.
  61. Газар дэлхийг хүмүүн ба адгуус амьтадын орших нутаг болгон, түүний энд тэндээс гол горхи урсгаж, тэдэн дээр уулсыг байршуулсан,

- түүнчлэн хоёр тэнгисийн хооронд далан (саад) байгуулсан хэн билээ? Аллахаас өөр (бүхнийг бүтээгч) бурхан байдаг гэж үү? Үгүй, үнэндээ тэдний олонхи нь чин үнэнийг мэддэггүй юм.
62. Гай зовлон тулгарч залбирахад уг залбиралыг нь хүлээн авч соёрхон, гай барцатаас авардаг. Та нарыг газар дэлхийг өвлөн эрхшээдэг болгосон хэн билээ? Аллахаас өөр бурхан байна гэж үү? Та нар тун бага ухаарч байна шүү дээ.
  63. Эх газар хийгээд далай тэнгисийн түнэр харанхуйд та нарт замыг чинь зааж, хайр ивээлийн хурыг буулгахын өмнө сэрүүн салхийг сэвэлзүүлдэг хэн билээ? Аллахаас өөр бурхан байна гэж үү? Аллах тэдний эн зэрэгцүүлсэн зүйлээс машид эрхэмэг бөлгөө.
  64. Амьд ахуйг анхлан бүтээж, хожим үхсэний дараа дахин амилуулагч хэн вэ? Та нарт тэнгэр, газраас хувь хишиг хүртээгч хэн билээ? Аллахаас өөр бурхан байна гэж үү? (Аяа, Мухаммед!) тэдэнд: “Хэрэв, та нар чин үнэнч юм бол баттай нотолгоогоо авч ирэгтүн” хэмээн хэлээрэй.
  65. Мөн: “Тэнгэр, газрын далд нууцыг Аллахаас өөр хэн ч мэдэхгүй. Хэзээ дахин амилахаа ч мэдэхгүй” гэж хэл.
  66. Үнэндээ тэдэнд хойд ертөнцийн тухай мэдлэг мэдээлэл хангалттай. Гэвч тэд энэ тухайд эргэлзэж буй. Бүүр ч таг харанхуй.
  67. Үл сүсэглэн эсэргүүцэгчид: “Үнэндээ, бид болон өвөг дээдэс маань хумьхын тоос болсоныхоо дараа үнэхээр дахин амилж гарч ирнэ гэж үү?”
  68. Үнэндээ энэхүү сүрдүүлэг үүнээс өмнө бидэнд болон өвөг дээдэст ч хийгдсэн билээ. Энэ нь урьд өмнөхүүдийн үлгэр домогоос өөр юу ч биш ээ!” гэв.
  69. (Аяа, Мухаммед!) тэдэнд: “Газар дэлхийгээр хэсээд нүгэлтэнгүүд хэрхэн төгссөнийг харцгаагтун” хэмээн хэлээрэй.
  70. Тэднээс болоод бүү гутар, тэдний хорон санаа, ов мэхний төлөө бүү бухимдагтун!
  71. Тэд: “Та нарын хэлсэн чинь үнэн юм бол сүрдүүлээд байгаа гэсгээл чинь хэзээ болох юм бэ?” гэж асууна.
  72. (Аяа, Мухаммед): “ Та нарын яаран хүлээсэн цээрлэлийн зарим нь ойртсон байх шүү!” хэмээн сануулаарай.
  73. Эзэнтэн чинь, хүмүүст ихээхэн ивээл энэрэлтэй. Гэвч хүмүүсийн олонхи нь наминчлан залбирдаггүй юм.
  74. Эзэнтэн чинь тэдний сэтгэлийн ил, далд бүхнийг маргаангүй мэддэг.
  75. Хувь тавилангийн яруу тод сударт (Лаухул Махфузд) газар, тэнгэрийн далдын нууцаас тэмдэглэгдээгүй зүйл огт үгүй.
  76. Куран бол Израйлын үр садын маргасаны ихэнхийг тайлбарлаж өгнө.

77. Куран бол үнэн сүсэгтнүүдийн хувьд тод шулуун зам бөгөөд энэрэл, нигүүлсэл бөлгөө.
78. Эзэнтэн чинь Израйлын үр садад зориулж ертөнцийн төгсгөлийн өдөр шударга шийдвэр гаргана. Тэр машинд аугаа, нэн их мэргэн.
79. Аяа, Мухаммед! Аллахыг эргэлзээгүй түшиж тулагтун. Чи яруу тод, чин үнэн дээр буй болой.
80. Чи үнэндээ ухуулга сургамжаа үхэгсдэд (үхээнц сэтгэлтэй үл сүсэглэгчдэд) сонсгож эс чадмуй, мөн нүүр буруулсан дүлийчүүдэд ч сонсгож эс чадах бөлгөө.
81. Төөрөлдсөн сохрыг чи зөв шулуун зам руу эргүүлж эс чадмуй. Гагцхүү бидний айлдваруудад итгэж, чин сүсэгтэн бологсдод ухуулга сургамжаа сонсгож чадна.
82. Тэдэнд урьдчилан сануулсан үг (ертөнцийн төгсгөл ойртсон тухай) биеллээ олох мөчид газрын гаваас нэгэн амьтан гаргаж үзүүлнэ. Уг амьтан тэдэнд хүмүүс бидний айлдваруудад итгээгүй тухай мэдэгдэнэ.
83. Тэр өдөр янз бүрийн ардын тус бүрээс Бидний айлдваруудыг үгүйсгэгчдээс нэг хэсэг хүмүүсийг цуглуулна. Хүмүүс цуглан иртэл тэд жагсан зогсож байх юм.
84. Эцэст нь тэд бүгд Аллахын өмнө ирэхэд: “Та нар учрыг нь ухаараагүй байж Миний айлдваруудыг худал хэмээн үгүйсгэсэн биз дээ? Зарлигаас гадуур юу хийсэн вэ?” гэж асуугдах болно.
85. Өөрсдийн харгис зальхай явдлаас болж урьдчилан сануулсан гэгсгээл тэдэнд тохиохуйд, тэд дугарч эс чадах бөлгөө.
86. Бид тэдний амар амгалангийн төлөө шөнийг (нам гүм харанхуй), ажиллаж хөдөлмөрлөг хэмээн өдрийг гэрэл гэгээтэй болгосныг тэд үнэхээр хараагүй гэж үү? Итгэн сүсэглэдэг хүмүүст үүнд өч төчнөөн бэлгэдлүүд буй.
87. Бишгүүр бүрээ үлээгдэх тэр өдөр, Аллахын таалсанаас (элч, гэгээнтнүүд, ариун журмаар үхэгсэдээс) бусад, тэнгэр хийгээд газарт буй бүхэн айдаст автаж, бүгд Аллахын өмнө хүлцэн ирнэ.
88. Чи уулсыг хараад, тэднийг байрандаа хөдөлгөөнгүй байна хэмээн санана уу? Гэвч тэд үүл нүүх мэт хөврөнө. Энэ нь алив бүхнийг бат бөх урлагч Аллахын ид шид билээ. Аллах үнэндээ та нарын хийсэн бүхнийг бүрэн дүүрэн мэдэж байдаг.
89. Хэн нэгэн сайн үйлээрээ (Аллахын нигур дор) ирэх аваас түүнд илүү шан харамж өгөгдөнө. Тэд тэр өдрийн айдас түгшүүрээс ангид байх болно.
90. Харин муу үйлээрээ ирэх аваас тэдэнд: “Та нар үйлдсэн хэргийнхээ хэрээр шийтгэгдэх болно” хэмээгдэж, нүүрээрээ там руу шидэгдэнэ.
91. (Аяа, Мухаммед!) “Надад гагцхүү энэ хотын (Меккегийн) Эзэнтэн-

Аллахад мөргөн залбир хэмээн тушаагдсан болой. Аллах уг хотыг өргөмжилөн адисласан бөгөөд алив бүхэн Түүнийх бөлгөө. Мөн надад мусулман болохыг тушаасан болой.

92. Тэрчлэн, Куран уншихаар тушаагдсан” хэмээн хэлэгтүн. “Тиймээс хэн зөв шулуун замаас эс хазайна, түүний ивээл хайр өөрт нь хамааралтай. Хэн төөрч будилна, түүний гай барцат нь өөрт нь оногдоно. Би зөвхөн сэрэмжлүүлэгч болой” хэмээн хэл.
93. Мөн: “Бүхий л сайшаал Аллаhad хамааралтай. Аллах та нарт ер бусын гайхамшгуудаа харуулахад Түүнийг таньж авцгаах болно. Эзэнтэн чинь та нарын хийсэн бүхнээс мэдээлэлгүй бус шүү дээ” хэмээгтүн.



Мекке-д илгээгдсэн. 88 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Та. Син. Мим.
2. Энэ нь саруул судрын (Кураны) айлдварууд мөн.
3. Бид сүсэглэгчдийн төлөө чамд Муса болон Фиргауны тухай туульсын нэг хэсгийг бодитоор нь уншиж өгөх болно.
4. Үнэндээ Фиргаун тэнд (Мисирт) хэмээс хэтэрсэн юм. Ард олноо бүлэглэн хувааж, тэдний нэг бүлгийг (Израйлын үр садыг) дорд үзэн, хөвгүүдийг нь алж, эмс охидуудыг нь амьд үлдээсэн юм. Тэр ийнхүү танхайран сагсуурагч нэгэн билээ.
5. Бид тэнд дарлагдан доромжлогсодыг ивээлдээ авч, дотроос нь тэргүүлэгч сонгон, Фиргауны зон олны баялгийг өвлүүлэх нь зүйтэй гэж үзэв.
6. Бид тэднийг (Мисир болон Шамд) хүчирхэгжүүлэн, Фиргаун болон түүний зөвлөх Хаман мөн тэдний дайчид айн сэжиглэж асан ардуудаар (Израйлийн үр садаар) тэднийг захируулах нь зүйтэй гэж үзсэн юм.
7. Бид Мусагийн эхэд: “Түүнийг хөхүүл! Хэрэв хорлогдоно хэмээн айвал түүнийг төмөр авдранд хийж, далайд (Нил мөрөнд) хаячих. Үхнэ байх хэмээн бүү айж гунигла. Бид түүнийг чамд буцаан авчирч өгөх бөгөөд хожим гэгээн элчээр сонгоно” хэмээн айлдсан билээ.
8. Фиргауны гэр бүлийнхэн өөрт нь атаат дайсан болох, уй гашуу авчирах Муса хүүг Нил мөрөнгөөс олж авлаа. Фиргаун болон Хаман, тэдний цэрэг дайчид ийнхүү төөрөлдөв.
9. Фиргауны эхнэр (Асия) авдар дотроос хүү гараад ирмэгц энрэх сэтгэл төрж: “Энэ хүүхэд бид хоёрын нүдний цөцгий мэт байг! Түүнийг бүү

- алагтун. Бидэнд тус болж юу магад, эсвэл өргөж авцгааг” хэмээн нөхөртөө хэлэв. Тэд зөвшилцөн зөвшөөрсөн ч хожим Фиргауны хувь тавилан хэрхэн төгсөхийг мэдэрч чадаагүй билээ.
10. Мусагийн эх үймрэн санаа алдаж, шаналан гансарч үүр цайлгалаа. Бид хүү нь буцаад ирэхэд итгүүлэн тайвшруулахгүйсэн бол тэр бүх нууцыг дэлгэх л байсан.
  11. Эх нь Мусагийн эгчид: “Түүний мөрийг дага” хэмээн захилаа. Эгч нь дүүгээ алсаас ажиглаж байсан билээ.(Фиргауны хүмүүс үүнийг мэдээгүй юм)
  12. Ээж нь ирэх хүртэл Бид түүнийг өөр эмэгтэйгээр хөхүүлэхийг нь бузар хэмээн хориглосон юм. Хүүхэд ч үл таних эхийг хөхсөнгүй. Хүүгийн эгч нь: “Би та нарт хүүг асран тойлох, энэрэнгүй нэгэн бүлийг зааж өгвөл ямар сан бол?” гэж хэлэв.
  13. Ийнхүү Бид эхийн магнай тэнийж байг, бүү уйтгарлан гуниглаг, Аллахын амлалт чин үнэн болохыг мэдэг хэмээн хүүг өөрийн өвөрт нь буцаав. (Үүний дараа Мусагийн ээж нь хүүгээ гэртээ авчран хөхүүлдэг боллоо.) Харин тэдний олонхи нь үүнийг мэддэггүй юм.
  14. Мусагийн нас бие гүйцэж, эрийн цээнд хүрэхүйд Бид түүнд мэргэн ухаан, эрдэм мэдлэг хайрласан. Бид сайн үйл үйлдэгсдэд ийнхүү шан харамж өгдөг юм.
  15. Муса хотын оршин суугчид амирлангуй цагаар үл анзаарагдан хот руу орлоо. Тэнд зодолдож буй хоёр хүнийг харав. Түүний нэг нь өөрийн овгийнхон, нөгөө нь дайсных байсан ажгуу. Тэгтэл түүний овгийн хүн Мусагаас тусламж хүсэхэд тэр дайсагнагч этгээдийг нударгалан унагаав (алав). Муса: “Энэ маань чөтгөрийн үйл боллоо. Чөтгөр үнэнхүү уруу татдаг дайсан юм байна” хэмээн бодож;
  16. “Аяа, Эзэнтэн минь! Би өөртөө нүгэлт лай хураалаа. Намайг өршөөж хайрла” хэмээн залбирахад Аллах түүнийг өршөөлөө. Аллах үнэхээр машид өршөөгч, нэн энэрэгч билээ.
  17. Муса: “Аяа, Эзэнтэн минь! Надад хайрласан ивээл энэрэлийн чинь төлөө нүгэлтэнгүүдийг жанчих зодуур болон хувирахаас хамгаалагтун?!” хэмээн гуйв.
  18. Тэрээр маргааш өглөө нь хот дотор айж түгшин, эргэн тойрноо ажигласаар явж байлаа. Гэнэт өчигдөрийн тусламж эрэгч этгээд бас л нэг хүнтэй зодолдож байснаа хашгиран түүнээс бас тусламж гуйлаа. Муса: “Үнэндээ, чи зодоонч этгээд юм!” гэв.
  19. Муса дайсны талын хүн рүү гар далайж завдтал тусламж эрэгч этгээд өөрөө зодуулах вий хэмээн сандрахдаа: “Аяа, Муса! Чи өчигдөр өөр нэгнийг алсан шигээ одоо намайг алах гэж байна уу? Чи эвлэрүүлэгч биш газар дэлхийн эвдрүүлэгч болох гэсэн юм уу?!” гэв.
  20. Тэгтэл хотын захаас нэг хүн гүйж ирээд: “Аяа, Муса! Дээдсүүд чамайг



- алахаар зөвлөлдөж байна. Хотоос үтэр түргэн зайл! Надад итгэгтүн, би чамд сайныг санан зөвлөж байнам” гэв.
21. Муса айж сандран тал тал тийш харан хотоос гарангуут: “Аяа, Эзэнтэн минь! намайг харгис зальхай ардаас аварч хайрла” хэмээн залбирав.
  22. Тэгээд Мадиян руу зүглэх зуур: “Эзэнтэн маань намайг зөв шулуун замаар хөтлөгтүн” хэмээн залбирав.
  23. Муса, Мадияны булгийн дэргэд ирэхэд малаа услаж буй хэсэг хүмүүсийг харлаа. Өөр булагаас хонь малаа эргүүлж яваа хоёр залуухан бүсгүйг харснаа: “Та нар яагаа вэ? Хонио услахгүй яав?” хэмээн асуухад тэд: “Тэд малаа услаж дуусахыг хүлээж байна. Эцэг маань насан өгөл болой” хэмээн хариулав.
  24. Муса, тэдний хонь малыг булаг руу тууж, услаж өгөөд, дараа нь сүүдэр нөмөрлөнгүүт: “Аяа, Эзэнтэн минь! Надад ямар ч буян хайрласан ч, хүсэн хүлээмүй” хэмээн залбирав.
  25. Тэгэхэд хоёр бүсгүйн нэг нь ичэмхийрэн түүн рүү ойртож ирээд: “Аав маань мал сүргийг усалсаны хариуг барих гээд таныг урьж байна” гэв. Муса өвгөн дээр очоод өөрт нь тохиолдсон зүйлийг өгүүлэхэд Шугайып: “Бүү ай, Чи харгис зальхай хүмүүсээс аврагдсан” гэв.
  26. Хоёр охины нэг нь: “Аав аа, түүнийг хөлсөөр ажлуул. Танд тэр болгон олдохгүй хүч чадалтай, итгэлтэй, сайн туслагч болох шинжтэй юм” гэлээ.
  27. Шугайып түүнд: “Надад найман жил хөлсөөр ажилла. Хариуд нь хоёр охиныхоо нэгийг чамтай гэрлүүлэх бодолтой байна. Хэрэв өөрөө хүсвэл арван жил байсан ч болно. Гэхдээ, арван жил хэмээн албадахгүй. Аллах таалах аваас миний сайн үйлтэн болохыг мэднэ” гэв.
  28. Муса: “Энэ нь та бид хоёрын хэлэлцээ болог. Энэ хоёр хугацааны алийг нь ч биелүүлбэл илүү юм бүү шаардагтун. Бидний үгэнд Аллах гэрч” гэв.
  29. Муса товлосон хугацааг дуусган, эхнэрийнхээ хамт Мисирийг зорин явж байтал Тур уулын зүгээс нэгэн галыг харангуут, эхнэртээ хандан: “Та нар энд түр хүлэээнж байгтун. Би үнэхээр гал харсан. Удахгүй та нарт нэгэн мэдээ, эсвэл та нарыг дулаацуулах нэгэн цог авч ирмүй” гэв.
  30. Тэр галын гэрэлд ойртон ирэхэд хөндийн баруун ухаад буй модтой шүтээн газраас: “Аяа, Муса! Мэдэж авагтун! Би бүхий л орчлонгийн эзэн Аллах болой” гэсэн дуу сонсогдов.
  31. Мөн “Таягаа шид!” хэмээн тушаасанд Мусагийн шидсэн таяг нь могой лугаа адил мурилзахад тэр эргэж ухран зугатав. Эргэж харж чадаагүй бөгөөд бас л Аллах дугаран: “Аяа, Муса, нааш ир, бүү ай. Үнэндээ чи аюулгүй байгаа шүү” хэмээн айлдав.
  32. “Тараа өвөртөө хий. Гар чинь гэмтэлгүй, цав цагаан болж гарна. Тэгэхүйд айж эмээлгүй, сүрээ алдахгүй, гараа сугандаа хавчуул. Энэ

- бол Фиргаун болон түүний сурвалжит дээдэст үзүүлэх Эзэнтний чинь зүгээс өгөгдсөн хоёр баттай нотолгоо болой. Учир нь тэд үнэхээр танхайран эвдэрсэн хүмүүс” хэмээн айлдав.
33. Муса: “Аяа, Эзэнтэн минь! Би үнэндээ тэдний нэгийг нь алчихсан юм шүү дээ. Тиймээс намайг тэд хорлох байх хэмээн айж баймуй” гэв.
  34. Мөн: “Садан төрөл миний Харун намайг бодоход хэлэмгий юмсан. Түүнийг миний гэгээн элч болохыг нотлох туслахаар зөвшөөрч, надтай хамт илгээж хайрла. Үнэндээ, тэдний татгалзахаас эмээж байна” гэв.
  35. Аллах: “Бид садан төрөлөөр чинь дамжуулан, дайчдыг чинь хүчирхэгжүүлэн, та хоёрт хүч чадал өгнө. Тэд та нартай эн зэрэгцэж чадахгүй. Та нар болон та нарыг дагагсад бидний айлдварын хүчээр ялах болно” хэмээн айлдав.
  36. Ийнхүү Муса тэдэнд Бидний яруу тод айлдваруудтай ирэхэд тэд: “Энэ бол ердөө л хуурамч илбэ. Урьд өмнөх өвөг дээдсээс ч ийм зүйл сонсож байгаагүй билээ” хэмээн хэлцгээв.
  37. Муса: “Эзэнтэн маань! Өөрийн нигур дороос хэн зөв шулуун зам авч ирсэнийг, бас сайн сайхан зүйл хэнд заяагдахыг хамгийн сайнаар мэдэгч бөлгөө. Харгис зальхай хүмүүс хэзээ ч сайн сайхныг олохгүй” гэв.
  38. Фиргаун: “Аяа, сурвалжит дээдэс ээ! Та нарын хувьд надаас өөр бурханыг би мэдэхгүй. Аяа, Хаман! Алив, надад зориулан шатаасан тоосгоор нэгэн цамхаг босго! Түүний орой дээр гарвал Мусагийн бурханыг харж юу магад. Үнэндээ би түүнийг худалч хэмээн бодож байна” гэв.
  39. Фиргаун ба түүний дайчид нь ханхалзан, хэрээс хэтрэвэй. Үнэндээ тэд Бидний нигур дор (Аллахын өмнө) ирэхээ тоосон ч үгүй.
  40. Бид түүнийг болон цэрэг дайчдыг нь цөмийг далайд хаясан юм. Харгис зальхай этгээдүүд хэрхэн төгссөнийг хар л даа!
  41. Бид тэднийг там руу дуудах анхдагч болгон сонголоо. Дахин амилахуйн өдөр тэд тусламжыг эс хүртэцгээх бөлгөө.
  42. Бид энэ дэлхийд тэдний нуруун дээр хараал үүрүүлэв. Тэд, дахин амилахуйн өдөр Аллахын ивээл энэрэлээс ангид, царай алдан хоцроно.
  43. Үнэндээ, Бид урьд өмнөх олон ардыг (Нух, Гад, Самуд, Лут нарын ардыг) үгүй хийсний дараа ухааран сэнхрэг хэмээн хүмүүст ил тод нотолгоо, зөв зам, ивээл энэрэл болгон Таурат судрыг (Тора-г) Мусад хайрласан билээ.
  44. (Аяа, Мухаммед!) Бид Мусад зарлиг буулгахад чи шүтээн хөндийн баруун ухаад байгаагүй юм. Түүнийг өөрийн нүдээр ч хараагүй билээ.
  45. Харин Бид (Мусагаас хойш) олон ардыг бий болгосон бөгөөд тэд урт амьдралыг туулсан юм. Чи Мадан ардын дунд ч байгаагүй. Бидний

- айлдваруудыг ч тэдэнд уншиж өгөөгүй билээ. Гэхдээ тэр мэдээг чамд бид илгээсэн юм.
46. Бид Мусаг дуудан чимээ өгөх үед чи Тур ууланд байгаагүй юм. Гэхдээ, энэ нь чамаас өмнө өөрсдөд нь сэрэмжлүүлэгч (гэгээн элч) ирээгүй ардуудад сэрэмжлүүлэхийн чинь тулд, тэдний ухуулга сургамж авахын тулд Эзэнтнээс чинь хайр энэрэл болгон чамайг гэгээн элчээр илгээсэн болой.
  47. Хэрэв тэдний хийсэн хэргээс болж өөрсдөд нь нэгэн гай зовлон тулгарахад тэд: “Эзэнтэн минь! Бидэнд нэгэн гэгээн элч илгээсэнсэн бол бид Чиний айлдваруудыг бишрэн дагаж, сүсэглэгсэд болох байсан” хэмээн хэлүүлэхгүйн тулд тэдэнд чамайг илгээсэн юм.
  48. Бидний зүгээс тэдэнд чин үнэн (гэгээн элч) ирэхүйд: “Муса-д өгөгдсөн (ер бусын гайхамшиг) лугаа адилаар Мухаммедэд ч өгөх ёстой биздээ?” хэмээн хэлцгээсэн. Тэд урьд нь Муса-д өгөгдсөнийг ч хүлээн зөвшөөрөөгүй байсан биш бил үү? Тэд “Таурат, Куран хоёр бие биеэ дэмжигч хоёр илбэ. Энэ хоёрын алинд нь ч итгэхгүй” хэмээсэн юм.
  49. (Аяа, Мухаммед!): “Хэрэв, та нар үнэн үг хэлэгсэд бол Аллахын зүгээс энэ хоёроос ч илүү нэгэн судрыг олоод ирэгтүн, тэгвээс би түүнийг дагамуй” хэмээн хэлэгтүн.
  50. Хэрэв, тэд чамд хариулт өгч эс чадах аваас, гагцхүү өөрсдийн хүсэл тачаалын боол хэмээн ойлгоорой. Аллахын айлдсан зөв замаас гажиж, хүсэл тачаалынхаа боол болсон хүнээс илүү төөрөлдөгч байх уу даа? Аллах харгис зальхай хүмүүсийг угаас зөв шулуун зам руу эс хөтөлмүй.
  51. Үнэндээ, Тэд ухаарч ойлгог хэмээн Бид айлдвараа (Кураныг) тасралтгүй тайлбарласан.
  52. Куранаас өмнө ч илгээсэн нэгэн судрыг хүлээн авагсад (Христ болон Иудэйчүүдийн дунд байсан үнэн сүсэгтнүүд) Куранд итгэдэг юм.
  53. Куран тэдэнд уншигдахуйд: “Бид түүнд итгэцгээлээ. Энэ бол Эзэнтний зүгээс илгээгдсэн чин үнэн үг. Бид өмнө нь ч мусулман байсан юм шүү” гэлцэнэ.
  54. Тэд тэвчээртэй байсны төлөө (хоёр судрын хоёуланд нь итгэсний төлөө), муу муухайг сайн сайхнаар зайлуулсны төлөө, мөн Бидний хайрласан хувь хишгээс сайн сайхны төлөө зарцуулсан тул тэдэнд хоёр дахин илүү буян хишиг оногдох болно.
  55. Тэд үр ашиггүй дэмий яриаг сонсмогцоо, түүнээс холдож: “Бидний үйл хэрэг бидэнд, та нарын үйл хэрэг та нарт. Та нар амар амгалан байх болтугай. Бид харанхуй мунхагуудаас тусламж хүсэхгүй” гэнэ.
  56. (Аяа, Мухаммед!) Чи хүссэн хүн бүхнийг зөв шулуун замд оруулж чадахгүй. Харин Аллах хүссэн бүхнээ зөв шулуун замд оруулна. Зөв шулуун зам олохсодыг Аллах сайн мэднэ.
  57. Тэд: “Чамтай хамт шулуун замыг дагах аваас, газар нутгаасаа хөөгдөнө”

- гэнэ. Бид тэднийг Өөрсдийн зүгээс төрөл бүрийн үр жимс ирүүлэх, гайхалтай, амгалан нэгэн газарт (Меккед) суурьшуулаагүйсэн билээ үү? Гэвч, тэдний олонхи нь үүнийг мэддэггүй юм.
58. Амьдралынхаа элбэг дэлбэгт баярхан бардамнасан олон хот сууринхныг Бид бусниулсан. Ийнхүү тэднээс хойш тэр газруудад маш цөөхөн хүмүүс л суурьшсан даа. Эцэст нь Бид л тэдний өв залгамжлагч нь болсон юм.
  59. Эзэнтэн чинь хотын төвд тэдэнд айлдваруудыг маань уншиж өгсөн гэгээн элчийг илгээхээс наана тэр хот сууринг сүйтгээгүй билээ. Оршин суугчид нь харгис зальхай юм болохоос гадна ямар ч хот сууринг сүйтгээгүй юм шүү.
  60. Та нарт хайрласагдсан зүйлс, гагцхүү энэ хорвоогийн амьдралыг залгуулах тэтгэлэг, гоёл чимээ төдий. Харин Аллахын дэргэдэх (диваажин дахь) буян хишиг бүхэн илүү өлзийтэй бөгөөд үүрд мөнх болой. Үүнийг ухаарахгүй байна гэж үү?
  61. Бидний зүгээс сайхан амлалт өгсөн, түүнийхээ биелэлийг диваажинг үзэх хүн ба амьд ахуйн түр зуурын хишиг хүртэж, дахин амилахуйн өдөр (гэсгээгдэх) хүн хоёр ижил гэж үү?
  62. Тэр өдөр Аллах тэдэнд: “Та нарын Надтай эн зэрэгцүүлэн зохиосон зүйлс чинь хаана байна вэ?” хэмээн асууна.
  63. Өөрсдөд нь гэсгээлийн тухай зарлиг ирэгсэд: “Аяа, Эзэнтэн минь! Эднийг бид төөрөлдүүлсэн билээ. Өөрсдөө хэрхэн төөрөлдсөний адилаар тэднийг ч ийн төөрөлдүүлсэн бөлгөө. Бид тэднээс салж чам руу ойртож байна. Угаасаа тэд бидэнд сүсэглэн мөргөөгүй байсан хүмүүс” гэв.
  64. Мөн тэдэнд: “Аллахтай эн зэрэгцүүлсэн нөгөө зохиомол зүйлсээ дуудагтун” хэмээгдэх болно. Тэд дуудсан ч зохиомол зүйлс нь хариулж эс чадаагаадаг ажгуу. Тэд даруй гэсгээлийг үзэцгээнэ. Тэд амьд ахуйдаа зөв шулуун замаар замнасан ч болоосой!” хэмээн харамсана.
  65. Тэр өдөр Аллах: “Та нар илгээгдсэн гэгээн элч нарт юу гэж хариулсан вэ?” хэмээн асууна.
  66. Гэвч тэр өдөр тэдэнд алив бүхний (таатай) мэдээ үл сонсогдох бөгөөд бие биеэнээс ч асууж эс чадмуй.
  67. Харин хэн наминчлан сүсэглэж, сайн үйл үйлдэнэ, тэр хүсэл зорилгоо хангах магадлалтай.
  68. Эзэнтэн чин хүссэн бүхнээ бүтээж, хүссэн бүхнээ сонгомуй. Харин үл сүсэглэгсдэд сонгох эрх үгүй. Аллах чин ариун бөгөөд тэдний эн зэрэгцүүлсэн зүйлээс ангид, аугаа эрхэмсэг болой.
  69. Мөн Эзэнтэн чинь тэдний сэтгэлд нь буй ил, далд бүхнийг мэдэж байдаг.
  70. Тэр ийм л Аллах билээ. Аллагаас өөр ямар ч бурхан үгүй. Амьд ахуйн

- ба хойд хорвоогийн бүхий л сайшаал-магтаал Түүнд хамааралтай. Зарлиг, шийдвэр гагц Аллахын зүгээс бөгөөд бүгдээрээ Түүний өмнө очицгооно.
71. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Та нар хариулна уу? Хэрэв Аллах түнэр харанхуй шөнийг дахин амилах өдөр хүртэл тасралтгүй үргэлжлүүлбэл Аллахаас өөр ямар бурхан та нарыг гэрлээр гийгүүлж чадах сан бол? Та нар сонсохгүй байна гэж үү?” хэмээгтүн.
  72. “Та нар хариулна уу? Хэрэв Аллах өдрийг дахин амилах өдөр хүртэл тасралтгүй үргэлжлүүлбэл Аллахаас өөр ямар бурхан та нарын унтаж амраахын төлөө амгалан шөнийг хайрлах сан бол? Та нар өдий хүртэл хараагүй гэж үү?”
  73. Аллах өөрийн ивээлээр та нарыг амарч тухлаг хэмээн шөнийг, хувь хишгээ эрж талархаг хэмээн өдрийг бүтээсэн болой.
  74. Тэр өдөр Аллах тэднээс: “Надтай эн зэрэгцүүлэн зохиосон зүйлс чинь хаана байна вэ?” хэмээн асууна.
  75. Мөн тэр өдөр ард түмэн бүрээс нэгэн гэрч (гэгээн элч) гарган ирж үл сүсэглэгсдэд: “Алив, та нар баттай нотолгоонуудаа авч ирэгтун!” гэнэ. Тэгэхүйд тэд чин үнэн гахцхүү Аллахынх гэдгийг мэдэх бөгөөд тэдний зохиосон зүйлс нь (хиймэл бурхад) өөрсдөөс нь зайлан одно.
  76. Үнэндээ Карун Мусагийн ардын нэгэн байсан ч тэдний эсрэг адгийн хорон мууг үйлдсэн юм. Бид түүнд асар их эрдэнэсийн баялаг хайрласан бөгөөд түлхүүрүүд нь хэд хэдэн хүчтэн арай ядан даахаар хүнд нүсэр байсан билээ. Тэр үед ард түмэн нь түүнд: “Чи бүү хөөрцөглө. Хөөрөн онгиросодыг Аллах үл таалмуй”.
  77. Аллахын чамд хайрласан зүйлсийг дөрөөлөн (баялагын ач тусаар) хойд ертөнцийн сайн оромжийг хүс. Гэхдээ энэ хорвоо дахь хувь хишгээ ч бүү умарт. Аллахын чамд сайн сайхныг хайрласан лүгээ адил чи ч гэсэн бусдад буян үйлдэгтүн. Бас газар дэлхийд үймээн самуун бүү хүсэгтүн. Аллах үнэндээ танхайран, үймээн самуун таригсадыг хэзээ ч эс таалмуй” гэв.
  78. Харин Карун: “Энэхүү эд баялаг өөрийнхөө эрдэм мэдлэгээр бүтсэн” гэв. Аллах өөрөөс нь өмнөх олон түмнээс, түүнээс ч илүү хүчтэй, цуглуулж хараасан нь түүнээс ч илүү хүмүүсийг үгүй хийснийг тэр үнэхээр мэдэхгүй байна уу? Гэвч нүгэлтэнгүүдийн нүгэлийг асуухын хэрэгцээ үгүй. (Аллах түүнийг сайн мэдэх бөгөөд бүгд бичээстэй байгаа)
  79. Карун олны өмнө үнэтэй цэнэтэйгээр гайхуулан гарч ирлээ. Зөвхөн амьд сэрүүн ахуйн жаргал цэнгэлийг хүсгэсэд гайхшран: “Аяа, Карунд заяасан баялаг бидэнд ч заяагдсан болоосой. Үнэндээ тэр элбэг хангалуун эд баялгийн эзэн байжээ” хэмээн шагшрав.
  80. Харин өөрсдөд нь эрдэм мэдлэг заяагдагсад: “Харламар юм байх гэж!

Үнэнчээр итгэн сүсэглэж, сайн үйл үйлдэгсэдийн хувьд Каруны эд хөрөнгөнөөс Аллахын буян хишиг илүү байлгүй дээ! Тийм буян хишиг гагцхүү хагамжит тэвчээртнүүдэд оногдоно” гэлцэв.

81. Эцэст нь Каруныг орд харшынхаа хамт газрын гав руу орууллаа. Аллахын эсрэг, түүнийг өмгөөлөх ямар ч туслагч олдсонгүй. Тэр өөрийгөө ч аварч чадаагүй юм.
82. Дөнгөж өчигдөрхөн түүний оронд байхыг хүсэгсэд өглөө нь: “Ээ халаг! Аллах хүссэн боолынхоо хувь хишгийг нэмэгдүүлэх, хязгаарлахын алийг нь ч чадах юм даа. Хэрэв, Аллах биднийг хайр энэрэлдээ аваагүйсэн бол, биднийг ч газрын гав руу оруулах асан буй за. Гэхдээ хараа биз дээ! Үл сүсэглэгсэд тамаас аврагдана гэж үгүй юм даа” гэлцэв ээ!
83. Тэртээ хойд ертөнцийн оромж баймуй! Бид түүнийг газар дэлхий дээр биеэ үл тоох, үймээн самуун үл хүсэх хүмүүст зориуллаа. Эцсийн сайн сайхан бүхэн үнэн сүсэглэгч, гэгээн ухаантнуудынх болой.
84. Хэн сайн үйл үйлдэнэ, тэр түүнээс илүү сайн сайхныг хүртэнэ. Хэн муу үйл үйлдэнэ, тэр муу үйлийнхээ хэрээр гэгсгээл үзнэ.
85. (Аяа, Мухаммед!) Чамд Кураныг илгээсэн, таниулахыг үүрэг болгосон Аллах чамайг мэдээж л эргэж буцах газар руу чинь (Ариун Меккед) буцаамуй. Чи: “Эзэнтэн маань, хэн зөв замаар ирсэнийг, хэн илэрхий төөрөлдсөнийг сайн мэдмүй” хэмээгтүн.
86. Чи гэгээн элч болохоос өмнө өөрт чинь энэ судар бууж ирнэ хэмээн найдаагүй билээ. Гэвч, Эзэнтэн чинь ивээн энэрч, чамд түүнийг илгээлээ. Тиймээс, үл сүсэглэгсдийг хэзээ ч бүү өмөөр.
87. Аллахын айлдварууд чамд илгээгдсний дараа үл сүсэглэгсэд бүү саад болог! Тэднийг Эзэнтэн рүүгээ уригтун. Чи хэзээ ч эн зэрэгцүүлэгчдийн нэгэн бүү бологтун!
88. Аллахтай эн зэрэгцүүлэн өөр бурхадыг бүү тахин шүтэгтүн. Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Аллах цорын ганц. Түүнээс бусад алив бүхэн сөнөмүй. Эцсийн зарлиг зөвхөн Аллахынх бөгөөд бүгдээрээ Түүний өмнө буцаж очих болно.



Мекке-д илгээгдсэн. 69 айлдвар.



*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Алиф, Лам, Мим.

2. Хүмүүс: “Бид сүсэглэцгээсэн” гэж хэлээд сорилтоос мултрана гэж бодсон юм биш биз дээ?
3. Үнэндээ тэднээс өмнөхүүдийг ч сорьж шалгасан юм. Тэдний хэн нь үнэнч, хэн нь худалч болохыг Аллах угаасаа сайн мэддэг.
4. Аль эсвэл муу үйл үйлдэгсэд Биднээс (гэгсгээлээс) мултарчихна хэмээн боддог юм уу? Тэдний санаа юутай муухай юм вэ?
5. Хэн нэгэн Аллахтай учран золгохыг горьдох аваас Аллахын товлосон цаг эргэлзээгүй ирэх болой. Аллах бүхнийг сонсогч, мэдэгч болно.
6. Хэн нэгэн сайн сайхны төлөө тэмцвэл, тэр өөрийнхөө төлөө тэмцэнэ. Аллах бүхий л орчлонгоос хараат бус.
7. Үнэнчээр сүсэглэн, сайн үйл үйлдэгсэдийн нүгэлийг бүрэн өршөөнө, хийсэн үйлийн хамгийн сайханд нь хариу барина.
8. Бид эцэг эхдээ халамжтай байхыг хүмүүст тушаасан билээ. Хэрэв тэд чиний эс мэдэх юмыг Надтай эн зэрэгцүүлэхийг хүчлэх аваас, тэднийг бүү дагагтун. Эцэст нь миний өмнө ирэх бөгөөд тэр цагт өөрсдийн хийсэн бүхнийг чинь хэлж өгөх болно.
9. Үнэнчээр сүсэглэн, сайн үйл үйлдэгсэдийг Бид эрхэм хүмүүсийн эгнээнд багтаах болно.
10. Хүмүүсийн зарим нь: “Аллахад итгэн сүсэглэлээ” хэмээн хэлцгээдэг. Аллахын төлөө аливаа бэрхшээл тохиолдвол, хүмүүсээс шалтгаалсан гай барцатыг Аллахын илгээсэн гэгсгээл мэтээр ойлгодог. Хэрэв, Эзэнтнээс чинь нэгэн тус дэм ирэх аваас “Үнэндээ бид та нартай хамт байсан шүү” гэдэг юм. Аллах бүх хүмүүсийн зүрх сэтгэлд буйг сайн мэдэхгүй гэж үү?
11. Аллах чин сэтгэлээсээ сүсэглэн итгэгсэдийг сайн мэднэ. Хоёр нүүртэнгүүдийг ч тодорхой мэднэ.
12. Буруу номтнууд, үнэн сүсэглэгсэд: “Бидний замыг дагагтун, та нарын нүглийг бид үүрцгээе” хэмээн хэлцгээдэг. Хэрэг дээр тэд мусулмануудын ямар ч нүгэлийг үүрэхгүй. Тэд жинхэнэ худалчид мөн.
13. Тэд өөрийн ачааг (ялыг) төөрөлдүүлэгсэдийн ачаатай хамт үүрцгээх болно. Мөн дахин амилахуйн өдөр худал хуурмаг үгийнхээ төлөө гарцаагүй шүүгдэн байцаагдах болно.
14. Бид Нухыг өөрийнх нь ардуудад гэгээн элчээр илгээсэн юм. Тэдний дунд мянган жилээс тавин жил дутуу хугацаагаар (950 жил) байв. Ард олон нь харгис зальхай байснаас (зохиомол бурханыг шүтэж, Нухыг хүлээн зөвшөөрөөгүйгээс) усан галавт нэрвэгдсэн билээ.
15. Бид Нух болон усан онгоцонд байгсадыг аварч, энэ явдлыг даян дэлхийд сургамж болголоо.
16. Бид Ибрахимыг ч өөрийнхөө зон олонд нь гэгээн элчээр илгээсэн. Тэр

- ардууддаа хандан: “Аллахад мөргөн залбирч, түүнээс айж эмээгтүн. Хэрэв, ухаарахсан бол та нарт энэ нь өлзийтэй.
17. Та нар Аллахыг орхиж, шавар бурхадыг тахин шүтэж, оргүй худал үг зохиоцгоож байна. Аллахыг орхиж тахин шүтсэн зүйлс чинь та нарт буян хишиг өгч эс чадна. Буян хишгийг Аллахын нигур дороос хайгтун. Түүнд мөргөн залбирагтун, талархагтун. Хожим Түүний өмнө очих болно шүү.
  18. Та нар намайг худал хуурмагт тооцох аваас, өмнөх ардууд ч гэгээн элч нараа үгүйсгэсэн. Гэгээн элчийн үүрэг бол гагцхүү Аллахын айлдварыг хүргэхэд л оршино.
  19. Аллах бүхий л амьд ахуйг анх хэрхэн бүтээснийг, үхсэний дараа нь хэрхэн дахин амилуулсныг хүмүүс хараагүй гэж үү дээ? Аллахад энэ нь тун хялбархан” гэв.
  20. (Аяа, Мухаммед): “Та нар дэлхийг хэрэн хэсүүчилцгээ, Аллаха анхлан хэрхэн бүтээснийг харагтун. Үүнээс хойш Аллаха түүнийг үхүүлэн дахин бий болгоно. Үнэндээ алив бүхэнд Аллахаын хүч чадал бүрэн хүрнэ;
  21. Аллаха таалсан хүнээ гэсгээж, таалсаныгаа ивээн энэрэдэг. Эцэст нь түүний өмнө очигцооно” хэмээн хэлэгтүн.
  22. Та нар тэнгэр хийгээд газрын алинд байсан ч Аллахаын гэсгээлээс мултарч эс чадна. Та нарт Аллахаас өөр анд нөхөр, өмөөрөн туслагч эс олдоно.
  23. Аллахаын айлдварууд хийгээд хожмын тэр өдөр Түүнтэй учран золгохоо үгүйсгэгсэд Миний энэрэл нигүүлсэлээс горьдлого тасрах бөгөөд зовлонт гэсгээлтэй учрана.
  24. Ибрахимын ардуудын түүнд өгсөн хариулт нь: “Ибрахимыг алагтун, эсвэл шатаагтун!” гэхээс өөрчлөгдөшгүй. Аллаха түүнийг галаас аварсан юм. Ибрахимыг гал руу хаяхад түүнийг тойрсон дөлийг хүн шатахааргүй сэрүүн болгосон. Үнэндээ, үүнд сүсэглэн итгэсэн ардуудад зохих сургамжууд байгаа нь эргэлзээгүй.
  25. Ибрахим ард олондоо хандан: “Та нар амьд ахуйдаа өөр хоорондын нөхөрлөлд тус болог гэж бодон Аллахаыг орхиж, шавар бурхадаа цутгаж авцгаасан. Гэвч, хожмын өдөр бие биендээ дайсагнан, нэг нэгнийгээ хараан зүхэх болно. Та нарын очих газар халуун там бөгөөд та нарт ямар ч туслагч олдохгүй” хэмээн хэлэв.
  26. Лут Ибрахимын шашинд залбирав. Ибрахим түүнд: “Би гарцаагүй Эзэнтний (заасан газар руу нүүдэл хийнэ) зүг рүү эргэнэ. Тэр аугаа бөгөөд мэргэн ухааны эзэн” хэмээв.
  27. Бид түүнд Исхак болон Якубыг хайрласан билээ. Бид түүний үр садад Гэгээн элч хийгээд Судрыг зориулав. Өөрт нь энэ хорвоогийн



- хүндэтгэлийг үзүүлсэн. Эргэлзээгүй, тэр хойд ертөнцөд ч эрхэм хүмүүсийн эгнээнд багтана.
28. Бид Лутыг өөрийнхөө ардуудад гэгээн элч болгон илгээсэн. Тэр ард олондоо хандан: “Та нар урьд өмнө нь дэлхий дээр ямар ч ард түмний хийгээгүй нэгэн бузар булайг хийж баймуй;
  29. Та нарын эмэгтэйчүүдээс холдож эрчүүдтэй нөхцөх нь, зам тосож тонуул хийж буй нь, бүлэглэн цугларч илэрхий ичгүүргүй зүйл үйлдэх нь зайлшгүй юм гэж үү?” гэв. Үүний хариуд нь: “Хэрэв, чи чин үнэнч юм бол, Аллахын гэсгээлийг ирүүлээд аль?!” гэлцэв.
  30. Лут: “Эзэнтэн минь! Энэхүү бузар булай түмний эсрэг надад тусламж үзүүлэн хайрлагтун?!” хэмээн залбирав.
  31. Манай элч мэлэкүүд Ибрахимд (хоёр хүү хайрлах) баярт мэдээг авч ирэхүйд, тэд ийн хэлрүүн: “Бид энэ хотын (Садумын) ардыг үгүй хийнэ. Тэндэхийн оршин суугчид харгис зальхай хүмүүс ажгуу” гэв.
  32. Ибрахим тэдэнд: “Тийм ээ, гэхдээ тэнд Лут байгаа шүү дээ!” гэв. Элч нар: “Бид тэнд хэн оршин суудгийг сайн мэднэ. Лут болон түүний гэр бүлийг аврана. Гагцхүү эхнэр нь гэсгээл үзэх хүмүүсийн дунд үлдэх болно” хэмээн хариулав.
  33. Бидний элч мэлэкүүд Лут дээр ирэхэд Лут иргэдийнхээ бузар булай явдлын төлөө зовнин ичиж бухимдав. (Учир нь элч мэлэкүүд үзэсгэлэнт хархүүгийн дүрсээр бууж ирсэн билээ.) Элч мэлэкүүд: “Бүү ай, бүү уйтгарлан гунигла! Бид чамайг болон чиний гэр бүлийг аврана. Харин эхнэр чинь гэсгээл үзэгчдийн дунд үлдэх болно.
  34. Бид, энэ хотын оршин суугчдад бузар үйлийнхээ төлөө тэнгэрээс гэсгээл буулгамуй” хэмээн хэлэв.
  35. Ухаарах хүмүүсийн хувьд Бид үнэхээр сургамж авахуйц яруу тод жишээ үлдээсэн болой.
  36. Бид Мадяны ардад өөрсдийн садан төрөл Шугайбыг гэгээн элчээр илгээсэн юм. Тэгээд Шугайб: “Аяа, ард зон минь ээ! Аллахад сүсэглэн мөргөгтүн, хойд ертөнцийн өдрөөс айгтун. Газар дэлхий дээр үймээн самуун, бузар булай юм бүү хийгтүн!” гэв.
  37. Гэвч тэд Шугайбыг хүлээн зөвшөөрөөгүй билээ. Иймээс газар хүчтэй донслон, тэд боссон, суусан чигээрээ хожимдон хоцров.
  38. Бид Гад болон Самудыг ч үгүй хийсэн билээ. Тэдэнд юу тохиолдсоныг оршин суусан газраас нь илт харж болно. Чөтгөр шулмас тэдний хийсэн үйлийг эрхэм сайханаар харагдуулж, зөв шулуун замаас нь төөрөгдүүлсэн. Уг нь тэд соргог байсан ч (ухаараагүй юм).
  39. Бид Карун, Фиргаун, Хаманыг ч үгүй хийсэн юм. Муса тэдэнд үнэхээр яруу тод нотолгоонуудыг авч ирсэн юм. Гэвч тэд газар дэлхий дээр их зан гаргаж, биеэ тооцгоосон билээ. Гэсэн ч бидний гэсгээлээс зугатан мултарч чадсангүй.

40. Тэд бүгдийг нүглийнх нь улмаас гэсгээн цээрлүүлсэн. Бид заримын дээрээс чулуугаар нүүлгэж, заримыг аймшигт орь дуугаар нэрвэсэн, заримыг нь газрын гаваар оруулсан, заримыг усанд живүүлсэн. Аллах тэдэнд шударга бус юм үйлдээгүй, тэд өөрсдөө өөртөө харгислал үйлдсэн билээ.
41. Аллахаас бусдыг эзэн хэмээгсэдийн жишээ нь бэлбэсэн аалз үүрээ зассантай адил бөлгөө. Тэд ухаарахсан бол оромжийн хамгийн хэврэг нь аалзны тор шүү дээ.
42. Аллах тэдний Өөрийг нь орхиж ямар зүйлийг шүтэн залбирдагийг мэддэг ажгуу. Аллах ялгуусан аугаа хүчтэй, мэргэн ухааны эзэн билээ.
43. Бидний хүмүүсийн төлөө дурьдсан энэхүү жишээнүүдийг зөвхөн эрдэм мэдэлгэтнүүд л ухаарч ойлгодог юм.
44. Аллах тэнгэр, газрыг чин үнэн болгон бүтээсэн. Үүнд, сүсэглэн итгэгсэдийн хувьд нэгэн нотолгоо буй.
45. (Аяа, Мухаммед!) Чамд айлдсан судрыг унш, бас уншлага мөргөлөө үйлд. Уншлага мөргөл нь үнэндээ жигшүүртэй үйл болон муу муухайгаас салгадаг юм. Аллахыг санан дурсах нь залбирал бүхнээс агуу бөлгөө. Аллах та нарын хийсэн бүхнийг мэдэж байдаг юм.
46. Та нарын дунд харгис зальхай этгээдээс бусад, судрын эзэдтэй хамгийн ёслол төгөлдөр (эрдэмлэг, соёлтой) мэтгэлцээн хийгтүн. Тэдэнд: “Бидэнд буулгагдсанд ч, та нарт буулгагдсанд ч сүсэглэн итгэцгээлээ. Бидний бурхан ч, та нарын бурхан ч нэг л шүү дээ. Бид Түүнд итгэн бишрэгчид мөн” хэмээн хэлэгтүн.
47. (Аяа, Мухаммед!) Бид урьд өмнөхүүдэд ч судар илгээсний адил чамд ч судрыг буулгалаа. Бид судар буулгасан Иудэй болон Христчүүдийн дотор ч Куранд итгэдэг хүмүүс бий. Бидний айлдваруудыг гагцхүү буруу номтнууд л хүлээн зөвшөөрдөггүй юм.
48. Чи үүнээс өмнө ном уншаагүй, бичиг үсэг мэддэггүй хүн байсан. Хэрэв ийм л (ном уншиж, бичиж чаддаг) байсан бол үл тоомсорлогч, эсэргүүцэгчид бүүр ч эргэлзэх байсан билээ.
49. Үгүй ээ, Куран бол өөрсдөд нь эрдэм мэдлэг заяагдсан хүний зүрх сэтгэл дэх яруу тод айлдварууд бөлгөө. Бидний айлдваруудыг гагцхүү харгис зальхай этгээдүүд л үгүйсгэцгээдэг юм.
50. Тэд: “Түүнд Эзэнтнээс нь яагаад өөр нотолгоо бүхий ер бусын гайхамшигууд буулгагддаггүй юм вэ?” гэлцэнэ. Чи тэдэнд: “Нотолгоот ер бусын гайхамшигууд гагцхүү Аллахад буй. Харин би бол зөвхөн илэрхий сэрэмжлүүлэгч болой” хэмээн хэлэгтүн.
51. Өөрсдөд нь уншигдаж буй Судрыг чамд Бид буулгах нь тэдэнд хангалтгүй гэж үү? (Үүнээс илүү ямар гайхамшиг хэрэгтэй юм вэ?) Энэхүү сударт сүсэглэн итгэсэн хүмүүсийн хувьд хайр талархал, ухуулга-ганиулга буй нь эргэлзээгүй.

52. (Аяа, Мухаммед) Хэлэгтүн: “Та бидний хооронд гэрч болоход Аллах хангалттай. Тэнгэр, газарт буй бүхэн түүнд илэрхий байгаа. Хоосон зүйлд итгэж, Аллахыг эсэргүүцэгчид бол эргэлзээгүй хор уршиг амсах болно.
53. Тэд чамаас гэсгээлийн үтэр түргэн ирэхийг хүснэ. Хэрэв түүний товлогдсон хугацаа байгаагүйсэн бол гэсгээл мэдээж тэднийг аль хэдийнээ нэрэвчихсэн байхсан. Гэвч гэсгээл тэдэнд санаанд үгүй байхад гэнэт ирэх болно.
54. Тэд чамаас гэсгээлийн түргэн ирэхийг хүснэ. Ертөнцийн төгсгөлийн өдөр халуун там үл сүсэглэгсэдийг шууд бүслэн авах болно.
55. Тэр өдөр, гэсгээл тэдний толгой дээрээс хийгээд хөл доороос нь нэрвэнэ. Аллах тэдэнд: “Үйлдсэн хэргийнхээ гэсгээлийг амсацгаатун” хэмээн айлдана.
56. Аяа, сүсэгтэн боолууд минь ээ! Миний бүтээсэн газар дэлхий цэлгэр уудам. Хаана хүсвэл тэнд очиж Надад сүсэглэн залбирагтун.
57. Алив амьд бүхэн үхлийг амсан, эцэст нь бидний өмнө буцаад ирнэ.
58. Үнэнчээр сүсэглэн, сайн үйл үйлдэгсэдийг Бид хаяагаар нь ариун булаг урсадаг диваажингийн орд харшид байрлуулах бөгөөд тэд тэнд үүрд оршино. Ийнхүү сайн үйлс бүтээгсэдийн шагнал юутай сайхан гээч!
59. Тэд ямагт тэвчээрийг сахин, бүхий л талаар гагц Эзэнтнийгээ түшин тулдаг.
60. Амьд адгуусын ихэнх нь өөрсдийнхөө хувь хишгээ өөрсдөө даадаггүй. Тэд болон та нарыг Аллах л хувь хишигтэй болгоно. Тэр алив бүхнийг сонсож, мэдэж байдаг юм.
61. Хэрэв, чи тэднээс (буруу номтнуудаас): “Тэнгэр, газрыг хэн бүтээсэн вэ? Нар, сар хоёрыг хэн эрхшээсэн вэ?” хэмээн асуувал, тэд гарцаагүй “Аллах” хэмээн хариулцгаадаг. Тэгсэн атал яагаад Аллахт залбирахаас татгалздаг юм вэ?”
62. Аллах боолуудынхаа хувь хишгийг хүссэн хэн нэгэнд элбэг дэлбэг, хүссэн хэн нэгэнд дутуу дулимаг болгон заяадаг. Аллах үнэхээр бүхнийг мэдэж байдаг юм.
63. Хэрэв тэднээс: “Тэнгэрээс хур буулгаж, түүгээр үхмэл газрыг амилуулагч нь хэн билээ?” хэмээн асуувал тэд: “Аллах” хэмээн хариулцгаадаг. (Аяа, Мухаммед!) Чи тэдэнд: “Бүхий л сайшаал магтаал Аллахад хамаарагдмуй” хэмээн хэлэгтүн. Гэвч тэдний олонхи нь үүнийг ойлгодоггүй юм.
64. Амьд ахуйн цаг бол түр зуурын инээд наргиан, зугаа цэнгэл, хуурамч төдий зүйл. Харин хойд ертөнцийн орон нь жинхэнэ амьдрал болой. Тэд үүнийг мэддэг ч болоосой.
65. Тэд усан онгоцонд суусан даруйдаа л чин сэтгэлээрээ Аллахад

залбирцгаадаг. Харин тэднийг Аллах эсэн мэнд эх газар дээр гарангуут л тэд Аллахыг умартан, түүнтэй элдэв юмыг эн зэрэгцүүлж эхэлнэ.

66. Тэд Бидний өөрсдөд нь хайрласныг үл тоомсорлож, амьдралынхаа үлдсэн хугацааны баяр цэнгэлд умбаж л байг! Гэвч мөдхөн мэдэцгээх бөлгөө.
67. Үл сүсэглэгсэд эргэн тойрныхоо хүмүүс айван-тайван байхад бид Мекке хотыг энхийн, ариун шүтээний газар болгосныг үзээгүй юм уу? Тэд үнэхээр бузар юм бүхэнд итгэдэг. Аллахын хувь хишигт харалган хандах гэж үү дээ?
68. Аллахыг гүжирдэгсэдээс эсвэл чин үнэн ирчихээд байхад түүнийг үл хүлээн зөвшөөрөгсөдөөс илүү харгис зальхай амьтан байх уу даа? Үл сүсэглэгсэдийн байх газар нь халуун там биш билүү!
69. Гэхдээ, Бидний төлөө тэмцэгчиддээ уул шугамандаа Бид Өөрсдийн замыг зааж өгөх болно. Аллах ямагт сайн үйл үйлдэгсэдтэй хамт билээ.



Мекке-д илгээгдсэн. 60 айлдвар.

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Алиф, Лам, Мим.
2. Ромчууд ялагдвай.
3. Үнэндээ (Арабын орнуудад) хамгийн ойрхон газарт байгаа тэд ялагдлынхаа дараа буцаж ялах болно.
4. Хэдхэн жилийн дотор ийм болох болой. Өнгөрсөн, эдүгээ, хожмын бүхий л үйлс Аллахын эрхшээлд баймуй. Мөн тэр өдөр үнэн сүсэглэгчид баярлах болно.
5. Энэ нь Аллахын тусламжаар болой. Тэр гагцхүү Өөрийн болгоон таалсанд л тусалдаг билээ. Аллах ялгуулсан аугаа бөгөөд машид нигүүлсэгч.
6. Энэхүү ялалт Аллахын амлалт болой. Аллах амлалтаасаа үл няцана. Гэвч, хүмүүсийн олонхи нь үүнийг ойлгодоггүй юм.
7. Тэд, амьд ахуй цагийн гадны өнгө төрхийг л мэдмүй. Харин хойд ертөнцийг бүрэн дүүрэн үл тоомсорлодог.
8. Тэд өөрсдийн тухай эрэгцүүлэн бодсонгүй гэж үү? Аллах тэнгэр, газар болоод тэдгээрийн хооронд буй бүхнийг гагц чин үнэн болгож, бас товлосон нэгэн хугацаагаар бүтээсэн билээ. Хүмүүсийн олонхи нь Эзэнтэнтэйгээ эргэн учрахаа үгүйсгэж байдаг.

9. Тэд, газар дэлхий дээр хэрэн хэсүүчүүлж өөрсдөөс нь өмнөхүүдийн төгсгөл юу болсныг хараагүй гэж үү? Урьд өмнө байгсад өөрсдөөс нь илүү хүч чадалтай асан билээ. Тэд газар шороог хагалж, түүнд эдгээрийн барьж босгосноос илүү ихийг барьж босгоцгоосон юм. Мөн гэгээн элчүүд ч тэдэнд ямар олон яруу тод нотолгоонуудыг авч ирсэн билээ дээ. Аллах угаасаа тэднийг харгислаагүй юм. Гэвч тэд өөрөө өөртөө л харгислал үйлдэж байна.
10. Үүний дараа муу үйл үйлдэгсэдийн төгсгөл бүр ч муухай болно. Учир нь тэд Аллахын айлдваруудыг үгүйсгэгчид бөгөөд доог тохуу хийгсэд билээ.
11. Аллах, анхны амьд ахуйг бүтээдэг, дараа нь (үхсэний дараа) дахин амилуулдаг. Эцэст нь та бүгд Түүний өмнө буцаж очих болно.
12. Ертөнцийн төгсгөлийн өдөр нүгэлтэнгүүдийн урам хугарч, дуугаа хураана.
13. Аллахтай эн зэрэгцүүлсэн зүйлсээс нь тэд ямар ч тусыг эс олно. Тэр цагт нөгөө эн зэрэгцүүлсэн зүйлсээ ч үгүйсгэцгээх болно.
14. Ертөнцийн төгсгөлийн өдөр (Муу, сайн хоёр; Мусулман, буруу номтон хоёр бие биенээс) ялгарах бөлгөө.
15. Харин сүсэглэн итгэж, сайн үйл үйлдэгсэд диваажингийн цэцэрлэгт зугаацана.
16. Бидний айлдваруудыг хийгээд хойд ертөнцөд учрахыг хүлээн зөвшөөрөөгүй үгүйсгэгсэдийн тухайд тэд ямагт гэгсээлтэй учрана.
17. Тиймийн учир өглөө, орой гэлгүй Аллахыг сайшааж санагалзагтун.
18. Тэнгэр, газар дахь хамаг магтаал Аллахад зохимой. Үдийн цагаар мөн орой болохоос өмнө Түүнийг шагшин магтацгаа.
19. Аллах үхсэнээс амьдыг, амьдаас үхсэнийг бүтээдэг. Үхмэл газрыг дахин сэргээнэ. Ийнхүү та нар ч үүнтэй адил үхээд амилах болно.
20. Та нарыг шороогоор (шавар) бүтээсэн нь, дараа нь хүн болж газар бүр тархсан нь Аллахын ид шидийн нотолгоо, тэмдэгүүдийн нэг болой.
21. Захирагдан тогтворжихын чинь тулд өөрсдийн төрлөөс хань ижилтэй болгож, та нарын хооронд хайр, энэрэл үүсгэсэн нь мөн л Аллахын нотолгоо тэмдэгүүд мөн. Эрэгцүүлэн боддог хүмүүсийн хувьд үүнд олон сургамж байгаа нь эргэлзээгүй.
22. Тэнгэр, газрын бүтээгдсэн нь та нарын хэл, өнгө царай янз бүр байгаа нь бас л Түүний нотолгоонууд билээ. Үүнд ч мэдлэг бүхий хүмүүст олон сургамж буй нь маргаангүй.
23. Шөнө унтаж нойрсох чинь нь, тэрчлэн өдөр Аллахын хайр ивээлээс хувь хишгээ хайх нь Түүний нотолгоонуудын нэгэн мөн. Чих тавих хүмүүсийн хувьд үүнд ч олон сургамж буй.
24. Та нарт цахилах аянгыг айдас түгшүүр хийгээд итгэл найдвар болгон

- харуулсан нь, тэнгэрээс үхмэл газрыг сэргээх хур бороо оруулах нь ч түүний багтай ид шидийн нотолгоонуудын нэг нь мөн. Ойлгох ухаантай зон олны хувьд үнэндээ үүнд бас л цөөнгүй сургамж буй.
25. Тэнгэр, газрыг өөрийнхөө зарлиг ёсоор тогтоосон нь Түүний хүчирхэгийн нэгэн нотолгоо болой. Хожим та нарыг зарлан дуудмагц газар дороос бүгдээрээ түргэн гарч ирэх болно.
  26. Тэнгэр, газарт буй бүхэн Аллахынх мөн. Тэд бүгдээрээ Аллахын эрхшээлд баймуй.
  27. Амьд ахуйг үгүйгээс (хоосон) бий болгосон, түүнийг үхүүлж дахин амилуулдаг ч Аллах. Энэ бол Түүнд машид хялбар. Тэнгэр болон газар дахь шинж чанар хамгийн эрхэм дээд нь Аллахт хамааралтай. Тэр ялгуусан аугаа бөгөөд мэргэн ухааны эзэн.
  28. Аллах та нарын өөрсдөөс чинь жишээ татдаг. Бидний хайрласан хувь хишгээс чинь та нарын боолууд тэгш хуваалцахад, эрх чөлөөтэй хүнээс та нар өөрсдөө айж эмээдгийн адил боолуудаасаа айж эмээхэд бэлэн үү? Үүнтэй санал нийлэх үү? Ойлгох хүмүүсийн хувьд бид айлдваруудаа ийнхүү нарийвчлан тайлбарлаж баймуй.
  29. Гэвч харгис зальхай этгээдүүд ухаан муугаас шуналынхаа боол болцгоодог. Аллахын төөрөгдүүлсэнийг хэн залруулж чадах билээ? Тэдэнд ямар ч туслагч олдохгүй.
  30. (Аяа, Мухаммед!) Чин үнэн шашин руу сэтгэл хоёрдохгүй, эргэж буцалтгүй хандагтун! Аллах хүмүүнийг тэрхүү чанараар бүтээсэн. Аллахын бүтээлд өөрчлөлт үгүй. Энэ бол зөв шашин. Гэвч хүмүүний нэлээд нь үүнийг эс мэддэг.
  31. Аллахаас айж сөгдөгтүн. Уншлага мөргөлөө үйлдээрэй. Аллахтай бусдыг адилтгахсадаас ангид байгтун.
  32. Шашныг бутарган хувааж, бүлэглэгсэдийн эгнээнд бүү орогтун. Тэд бүлэг тус бүр өөрсдийн гэх шашнаар баясацгаадаг юм.
  33. Хүмүүст гай зовлон тохиолдоход Эзэнтэндээ үнэн сэтгэлээсээ залбирна. Дараа нь Аллах тэдэнд буян хишгээ хайрлавал зарим нь тэр дороо ташаарч, Эзэнтэнтэй элдэв бусдыг эн зэрэгцүүлж эхэлдэг.
  34. Ийнхүү өөрсдөд нь хайрласан буян хишгийг даахгүй биеэ тооно. Аяа, үл сүсэглэгчид ээ! Түр зуур ч баярлацгааж байгаарай. Баярласан хэрээ бахирахыг мөдхөн мэдэцгээх болно.
  35. Эсвэл Аллахтай элдэв юмыг эн зэрэгцүүлэхийн үнэнийг гэрчлэх нотолгоог Бид тэдэнд буулгасан юм гэж үү дээ?
  36. Бид хүмүүст хайр энэрэлээ амтлуулахад тэд түүнд баярлан хөөрдөг. Харин өөрсдийн хийсэн үйл хэргээсээ болж гай зовлон тохиохуйд даруй итгэл алдардаг.
  37. Аллах таалсан хүнийхээ буян хишгийг элбэг дэлбэг болгож,

- зарим хүнийг тарчиг ядмаг болгодгийг тэд хараагүй гэж үү? Үнэн сүсэгтнүүдийн хувьд энд зохих сургамжууд буй.
38. Ойрын төрөл төрөгсөддөө, үгээгүй ядууст, аян замд яваа хүмүүст тусламж, өглөг өгөгтүн. Аллахын таалалыг хүсэгсэдийн хувьд энэ нь өлзийтэй. Ийм хүмүүс хүссэнээ биелүүлцгээдэг юм.
  39. Хүүлсэн мөнгөө бусдын эд хөрөнгөтэй нийлүүлэн өсгөнө гэвэл өсөж үржихгүй. Харин Аллахын таалалыг хүсэж өгсөн ариуслын өглөг арвижин нэмэгдэнэ. Үүний хариуд нь хэд дахин илүү буян хураах болно.
  40. Аллах та нарыг бүтээгээд дараа нь хувь хишиг хүртээсэн. Дараа нь үхүүлж, дахин амилуулна. Тэгвэл та нарын Аллахтай эн зэрэгцүүлэн зохиосон зүйлсийн аль нь үүнийг хийж өгч чадах вэ? Аллах тэдний эн зэрэгцүүлсэн элдэв юмнаас ангид бөгөөд аугаа эрхэм бөлгөө.
  41. Хүмүүсийн өөрсдийн үйлдсэн үйлээс нь болж эх газарт хийгээд далай тэнгист эмх замбараа алдагдана. Аллах тэднийг засрах биз хэмээн зөвхөн зарим хэргийн төлөө л цээрлүүлсэн.
  42. (Аяа, Мухаммед!) Хүмүүст: “Даян дэлхийг хэрэн хэсэж өмнөхүүд эцэст хэрхэн төгссөнийг харагтун” хэмээн хэл. Тэдний олонхи ч элдэв бурхад шүтэгсэд асан билээ.
  43. Аллахаас эргэлт буцалт үгүй ертөнцийн төгсгөлийн өдөр ирэхээс өмнө нүүрээ чин үнэн шашин руу хандуул. Тэр өдөр хүмүүс хэсэг бүлэг болон диваажин, тамд хуваагдана.
  44. Хэн буруу номтон байвал, тэр үгүйсгэлийнхээ гэсгээлийг амсана. Хэн сайн үйл үйлдэнэ, тэр өөрсдийнхөө төлөө диваажинд орон байраа зэхнэ.
  45. Аллах үнэнчээр сүсэглэж, сайн үйл үйлдэгсэдийг Өөрийн ивээл энэрэлээрээ шагнана. Тэр үнэхээр үл сүсэглэгсэдийг эс хайрламуй.
  46. Аллах та нарыг өөрийнхөө ивээл энэрэлд авахын тулд, өөрийнхөө зарлигаар хөлөг онгоцуудыг явуулахын тулд, буян хишгээс нь хүртэхийн төлөө эрмэлзүүлэхийн тулд, түүнчлэн та нарын наминчлан талархахын тулд, хур бороо авчрах баярын салхины чимээг сонсож байхын тулд хийсэн буян бүхэн нь түүний нотолгоонуудын нэгэн болой.
  47. Бид чамаас өмнө ч өөрсдийн чинь ард олонд нь өч төчнөөн гэгээн элчүүдийг илгээсэн. Гэгээн элчүүд тэдэнд яруу тод нотолгоонуудыг авч ирсэн юм. (Гэвч тэд хүлээн зөвшөөрөхгүй, нүүр буруулцгаасан) Бид нүгэлтнүүдийг гэсгээн цээрлүүлсэн. Үнэн сүсэглэгсэд туслах нь Бидний үүрэг шүү дээ.
  48. Аллах салхийг илгээж, тэд үүлсийг хөөнө. Дараа нь Аллах өөрийн таалалаар тэнгэрийн уудамд дэлгэж, хэсэг хэсгээр бөөгнүүлэн, хаа сайгүй тараан байрлуулна. Эцэст нь тэдгээрийн дундаас хур буухыг чи үзмүй. Аллах хүссэн боолуудад хурыг буулгамагц, тэд баярлан баясна.

49. Учир нь тэд бороо ороогүй байхад аль хэзээ цөхрөнгөө барсан байлаа.
50. Аллахын хайр энэрэлийн ул мөрийг харцгаа: Үхмэл газрыг хэрхэн амилуулж байна вэ? Тэр үнэхээр үхэгсэдийг ч гарцаагүй амилуулна. Бүхий л зүйлд түүний хүч чадал нь хүрэлцээтэй.
51. Хэрэв, Бид хавсарга салхийг илгээж, улмаар тариа нь шарлан хатсаныг эзэд нь үзвэл тэд биднийг яаж үл тоомсорлох вэ?
52. Чи үхэгсдэд үгээ сонсгож эс чадмуй, бас буруу хараад зугтаж байгаа дүлийчүүдэд дуугаа сонсгож эс чадмуй.
53. Бас хараагүйчүүдийг ч төөрөгдлөөс нь аварч, зөв зам руу оруулж эс чадмуй. Чи гагцхүү бидний айлдваруудад итгэдэг хүмүүст л үгээ сонсгож чадна. Тэд мусулманчууд билээ.
54. Тийм ээ, Аллах та нарыг сул дорой бүтээсэн, дараа нь сул доройгоос хүч чадалтай болгосон. Улмаар хүч чадлыг чинь барж хөгшрүүлсэн. Аллах юуг хүснэ, тэднийг бүтээдэг. Тэр их зөнч, аугаа хүчирхэг бөлгөө.
55. Ергөнцийн төгсгөл болох өдөр, нүгэлтэнгүүд (энэ хорвоод) ганцхан цаг ч байж чадсангүй хэмээн харамсан андгайлдаг. Тэд амьд ахуйн хорвоод ч ийнхүү бултан худал хэлдэг.
56. Эрдэм мэдлэгтэй, сүсэглэлтэй хүмүүс тэдэнд: “Та нар Аллахын ивээлээр дахин амилах өдөр хүртэл тэнд (хорвоод) байсан. Одоо бол ергөнцийн төгсгөлийн өдөр. Та нар үүнийг мэддэггүй байсан шүү дээ!” гэж хэлнэ.
57. Тэр өдөр харгис зальхайчуудын тоочсон шалтгаан нь тус болохгүй. Аллахаас таалан соёорхохыг хүссэн ч эс зөвшөөрөгдөнө.
58. Бид энэхүү Куранд хүмүүсийн төлөө үнэндээ янз бүрийн жишээ сургамжийг дурьдсан. Чи тэдэнд нэгэн айлдвар хэлсэн ч үл сүсэглэгсэд дахиад л: “Та нарын хэлдэг ерөөс худал” хэмээн давтана.
59. Мунхагуудын сэтгэлийн мэлмийг Аллах угаас ийнхүү боодог.
60. (Аяа, Мухаммед!) Хүлцэн тэвчигтүн! Аллахын амлалт чин үнэн. Үл итгэдэг хүмүүс чиний тэвчээрийг алдагдуулах вий, болгоомжлогтун!



Мекке-д илгээгдсэн. 34 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Алиф, Лам, Мим.
2. Энэ нь мэргэн ухаан агуулсан Судрын айлдварууд мөн.
3. Сайн үйл үйлдэгсдэд хайр энэрэл, зөв шулуун зам буй.



4. Тэд, уншлага мөрглөө зүй ёсоор нь үйлдэж, ариуслын өглөг өгдөг бөгөөд хойд ертөнцөд баттай сүсэглэн итгэцгээдэг.
5. Ийнхүү тэд, Эзэнтнийхээ зөв шулуун зам дээр буй бөгөөд жинхэнэ хүсэл зорилгодоо хүрэгсэд мөн.
6. Хүмүүсийн зарим нь эрдэм мэдлэггүйгээс бусдыг Аллахын замаас төөрөгдүүлэн, тэднийг доог тохуу хийхийн тулд дэмий хоосон үгийг (хууч яриа, үлгэр домог) худалдан авдаг (сонгодог). Тэд зовлонт гэгсээлтэй учрана.
7. Түүнд Бидний айлдварууд уншигдахуйд сонсоогүй мэт, чих нь таг дүлий мэт, ихэмсэг дүр гарган нүүр буруулдаг. Чи түүнд зайлшгүй гэгсээлийн тухай сануулаарай.
8. Үнэнчээр сүсэглэж, сайн үйл үйлдэгсэдийн төлөө буян хишиг нь арвин Нагим хэмээх диваажин буй.
9. Тэд тэнд үүрд мөнх оршино. Аллахын амлалт чин үнэнч. Тэр машид аугаа, мэргэн ухааны эзэн.
10. Аллах тэнгэрийг та нарын харж буй шиг тулгуургүй бүтээж, та нарыг шилгээж бүү дайвалзуулаг хэмээн газар дээр уулсыг байршуулсан бөгөөд тэнд алив амьтадыг бүтээсэн. Мөн тэнгэрээс хур буулгаж, түүгээр сайхан ургамалыг үржүүлсэн.
11. Эдгээр нь Аллахын бүтээлүүд болой. Аллагаас өөр бурхад гэгчид юу бүтээсэн вэ? Надад үзүүлээд аль?! Эсрэгээр харгис зальхайчууд илэрхий төөрөлдөж байгаа.
12. Бид Лукманд мэргэн ухааныг хайрласан.Түүнд: “Аллахад талархан амьдар” гэв. Хэн талархах аваас, тэр өөрийнхөө төлөө талархах болно. Хэн биеэ тооно, Аллах түүний талархлаар дутахгүй. Харин ч хамаг магтаалын эзэн бөлгөө.
13. Нэгэнтээ Лукман хүүдээ: “Хүү минь! Аллахыг элдэв юмтай бүү эн зэрэгцүүл! Аллахтай алив бүхнийг эн зэрэгцүүлэх нь үнэндээ хамгийн муухай гэмт хэрэг” хэмээн сургамжлав.
14. Бид хүмүүнд эцэг эхтээ халамжтай байхыг тушаасан. Эх нь түүнийг зовлон туулсаар явж хэвлийдээ тээв. Хоёр ой хүргээд хөхнөөс нь гаргав. Тийм болохоор эхлээд Надад, дараа эцэг эхдээ талархаж, тус хүргэ! Эргэж ирэх газар чинь миний нигур дор шүү.
15. Хэрэв, эцэг эх чинь чамайг өөрөө ч эс мэдэх зүйлтэй намайг зүйрлэн эн зэрэгцүүлэхийг албадах аваас, тэднийг бүү дагагтун. Гэхдээ энэ хорвоод (шашиндаа хор уршиг болохооргүйгээр) сайн зөвлөлгөө өг. Надад итгэгсэдийн зам мөрийг дагагтун. Эцэст нь та нар бүгдээрээ миний өмнө буцаж ирнэ. Тэр цагт үйлдсэн зүйлийг чинь хэлж өгөх болно.
16. Лукман сургамжаа үргэлжлүүлсээр л: “Аяа, хүү минь! Чиний хийсэн хэрэг (сайн эсвэл муу), нэгэн гичний үрийн дайтай байсан ч, энэ нь

- аврага хадан цохион дотор, эсвэл энгүй тэнгэрт юм уу, газрын гүнд байлаа ч Аллах (хойд ертөнцөд тооцоо хийх цагт) түүнийг (чиний өмнө) гаргаж ирнэ. Аллах үнэндээ зөнч, бүхнийг мэдэгч бөлгөө” гэв.
17. “Аяа, хүү минь! Уншлага мөргөлөө бүрэн гүйцэт үйлд, сайн үйлийг дэмжиж, муу муухайг хоригло, тохиолдсон бэрхшээлд тэсвэр хатуужилтай бай. Энэ бүхэн сэтгэл шулуудан, хичээн зүтгэвэл зохих үйл хэрэг юм шүү!
  18. Хүмүүсийг дорд үзэн, бүү ихэмсэг зан гарга, бүү бардамнагтун! Аллах биеэ тоож, бардамнагсадыг үл таалмуй.
  19. Алгуур тайван алхал, өндөр дуу бүү гаргаарай. Учир нь хамгийн тохиромжгүй дуу илжигнийх бөлгөө.
  20. Аллах тэнгэр, газарт буй бүхнийг та нарын хэрэгцээнд зориулж өгснийг, ил, далдаар ч гэсэн буян хишгээ (эдийн ба оюун санааны) та нарт элбэг дэлбэгээр хүртээснийг үнэхээр үзэхгүй байна гэж үү дээ? Тийм агал мэдлэггүй, зам мөрийг заадаг гийгүүлэгчгүй, гэгээн сударгүй хэрнээ хүмүүний зарим нь Аллахын тухайд арсалдан маргалдана гээч!
  21. Хэрэв тэдэнд: “Аллахын буулгасныг бүү алдагтун” гэвэл тэд: “Үгүй, бид өвөг дээдсийнхээ итгэн биширсэн шашнаас салахгүй” гэнэ. Чөтгөр шулмас тэднийг дүрэлзсэн галын гэсгээл рүү дуудаж байсан ч тэгэх юм гэж үү!
  22. Хэн өөрийгөө Аллахт даатган, сайн үйл үйлдэнэ, тэр үнэндээ бөх бат залуурыг барина. Бүх үйл хэргийн төгсгөл нь Аллахад хамааралтай.
  23. (Аяа, Элч минь!) Хэн нэгэн үл сүсэглэх аваас, түүний үл тоомсорлол нь чамайг бүү гутрааг. Тэдний буцаж ирэх газар нь миний өмнө шүү дээ. Бид тэдний энэ хорвоод хийсэн үйл бүхнийг өөрсдөд нь мэдүүлэх болно. Эргэлзээгүй, Аллах зүрх сэтгэлд буй бүхнийг мэдэж байдаг.
  24. Бид амьд ахуйд нь тэдэнд ахархан жаргах боломж олгоод, хойд насанд нь өршөөлгүй гэсгээлээр нэрвэмүй.
  25. Аяа, Мухаммед чи тэднээс: “Тэнгэр, газрыг хэн бүтээсэн бэ?” хэмээн асуувал тэд мэдээж: “Аллах” хэмээн хариулна. “Сайшаал, магтаал бүхэн Алллахынх” хэмээн хэлэгтүн. Гэвч, тэдний олонхи нь үүнийг мэддэггүй юм.
  26. Тэнгэр, газарт буй бүхэн Аллахынх. Аллах үнэхээр алив бүхнээр дутаж гачигддаггүй баян, магтан сайшаахад бүрэн зохимой.
  27. Хэрэв, газар дэлхийд буй бүх мод (Аллахын айлдварыг тэмдэглэхийн тулд) өдөн үзэг, тэнгэс бэх болчихлоо гэхэд, дээр нь долоон тийм тэнгис бэх болон нэмэгдлээ ч Аллахын айлдваруудыг бичихэд дундарна гэж үгүй. Аллах үнэхээр ялгуусан аугаа бөгөөд мэргэн ухааны эзэн бөлгөө.
  28. (Аяа, хүмүүс ээ!) Та нарын анх бүтээгдэх, мөн дахин амилах чинь цор ганцхан хүнийг бүтээх, дахин амилуулах төдий зүйл ээ. Аллах бүхнийг сонсогч, харагч билээ.

29. Аллах өдрийг шөнө, шөнийг өдөр болгож, нар, сарыг эрхшээсэн. Тус бүрдээ тодорхой хугацаагаар хөдөлж буйг, мөн Аллах та нарын хийж буй бүхнээс мэдээлэлтэй гэдгийг хараагүй гэж үү?
30. Учир нь Аллах чин үнэн болох нь эргэлзээгүй. Харин тэдний Аллагаас бусдыг тахин шүтэх нь утга учиргүй, хоосон зүйл. Гагцхүү цорын ганц Аллах л эрхэмсэг дээгүүр бөгөөд нэн их аугаа.
31. Та нарт нотолгоонуудаа харуулахын тулд Аллахын хайр энэрэлээр хөлөг онгоцнууд далай тэнгисээр сэлэн явж байсныг та нар хараагүй гэж үү дээ? Ийнхүү үүнд тэсвэр хатуужилтай бүхэнд талархагч хүмүүст сургамжууд байгаа нь эргэлзээгүй юм.
32. Уулс мэт аврага давалгаанууд нөмрөн авахуйд тэд Аллахад чин сэтгэлээсээ залбирч гуйна. Аллах тэднийг авран эрэг дээр гаргавал тэдний зарим нь дундыг баримталдаг. Бидний айлдваруудыг угаасаа урван тэрслэгч, буруу номтнууд л хүлээн зөвшөөрдөггүй.
33. Аяа, хүмүүс ээ! Эзэнтнээсээ айгтун. Эцэг нь хүүдээ, хүү нь эцэгтээ ач тус эс болох өдрөөс эмээцгээгтүн. Аллахын амлалт чин үнэн. Амьдын жаргал та нарыг бүү хуураг. Өнгөлөн хуурагч чөтгөр шулмас та нарыг (Аллахын нэрийг барьж) бүү хуураг.
34. Ертөнцийн төгсгөлийн тухай мэдээлэл гагцхүү Аллахын нигур дор буй. Аллах хур бороог хүссэн цагтаа буулгана, хэвлийд буй хүүхдийг (хөвүүн ба охин эсэхийг, эрүүл ба эмгэгтэй эсэхийг, азтай ба азгүй болохыг) гагцхүү Тэр мэднэ. Хэн ч маргааш өөрт нь юу тохиохыг, бас хаана үхэхийг эс мэддэг болой. Үнэхээр бүхнийг бүрэн мэдэгч, бүрэн мэдээлэл авагч нь цорын ганц Аллах мөн.

## 32. СУРЕ САЖДЭ

Мекке-д илгээгдсэн. 30 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Алиф, Лам, Мим.
2. Энэ судар нь ертөнцийн Эзэнтний зүгээс буулгагдсанд хэзээ ч эргэлзээ үгүй болой.
3. Үл сүсэглэгсэд: “Кураныг Мухаммед өөрөө зохиосон” гэж ярьдаг гэнэ үү? Тийм биш ээ! Тэр чамаас өмнө өөрсдөд нь ямар ч сэрэмжлүүлэгч (гэгээн элч) ирээгүй ардуудыг зөв шулуун замыг олог хэмээн сануулахын тулд Эзэнтнээс чинь чамд илгээсэн чин үнэн болой.
4. Аллах тэнгэр, газар болон тэдгээрийн хооронд буй бүхнийг зургаан өдөрт бүтээж, дараа нь сансар огторгуйг эрхшээсэн. Та нарт Түүнээс

өөр ямар ч эзэн, өмөөрөн ивээгч үгүй. Энэ тухай бодож, сургамж авахгүй юм гэж үү?

5. Аллах тэнгэрээс газар хүртэлх алив бүхий л үйл хэргийг эрхшээн удирддаг. Дараа нь уг үйл хэргийн үргэлжлэх хугацаа нь та нарын тоолж буй мянган жилтэй тэнцэх нэг өдөрт Түүний өмнө хүрнэ.
6. Аллах ил, далдыг мэдэгч нэн агуу хийгээд машид энэрэл нигүүлсэгч билээ.
7. Тэр бүхнийг маш урнаар бүтээсэн юм. Хүмүүнийг анхлан шавраар бүтээж эхэлсэн.
8. Дараа түүний үр удмыг өчүүхэн дусалаар бүтээсэн.
9. Дараа нь түүнийг бүрэн дүрсжүүлэн, өөрийн шидээр үлээн амь оруулав. Та бүхэнд чих, нүд, зүрх заяасан. Гэвч та нар ачлах сэтгэлээр тун дульхан ажгуу.
10. Тэд (Үл сүсэглэгсэд): “Бид газар доор шороотой хутгалдаж үгүй болсны дараа ч үнэхээр дахин бүтээгдэнэ гэж үү?” хэмээдэг. Тэд үнэндээ Эзэнтэнтэй эргэж учрахаа үгүйсгэгсэд билээ.
11. (Аяа, Мухаммед) тэдэнд: “Та нарын амийг авахын төлөө томилогдсон элч мэлэк үүнийг гүйцэтгэнэ. Тэгээд Эзэнтэн рүүгээ эргэж буцах болно” хэмээн хэлэгтүн.
12. Хэрэв, нүгэлтэнгүүд Эзэнтнийхээ өмнө толгой гудайлгаж: “Аяа, Эзэнтэн минь! Бид үнэнийг харлаа, сонслоо! Одоо биднийг амьд ахуйн хорвоо рүү буцаагаад өгөөч, тэгээд л зөв үйлс үйлдэцгээе, бид үнэндээ одоо л баттай итгэж байна” хэмээн хэлэхийг чи харах сан бол!
13. Хэрэв, Бид хүссэн бол хүн бүрт зөв шулуун зам заахсан билээ. Гэхдээ, Миний: “Тамыг буг чөтгөр болон гэмт хэрэгтэн хүмүүсээр дүүргэнэ” гэсэн үг маань баттай амлалт юм шүү!
14. “Тэрхүү өдөртэй золгохоо мартсаны гэсгээлийг одоо амсагтун. Бид ч та нарыг мартсан юм. Үйлдсэн хэрэгийнхээ төлөө үүрдийн гэсгээлээ амсацгаагтун”.
15. Өөрсөд нь айлдварууд яригдахад сөгдөн мөргөдөг, Эзэнтэндээ их зан гаргалгүй, сайшаан залбирч, эрхэмлэдэг хүмүүс л үнэхээр бидний айлдваруудад итгэдэг юм.
16. Тэд орноосоо босож, (шөнө сэрж уншлага мөргөлөө үйлдэж), айдас түгшүүр, итгэл найдвар хослон Эзэнтэнд залбирцгаадаг. Мөн Бидний өгсөн буян хишгээсээ Аллахын замд зарцуулцгаадаг юм.
17. Тэдний хийсэн үйлийн хариу болгож нууцхан бэлтгэсэн, нүдээ басыгах буян хишгийг хэн ч эс мэдэх бөлгөө.
18. Үнэн сүсэглэгч хүн муу санаатантай адил гэж үү? Үгүй ээ!
19. Үнэнчээр сүсэглэн, сайн үйл үйлдэгсэдийн хувьд тэдний хийсэн үйлийн хэрээр диваажинд бэлтгэсэн байр бий.

20. Харин зөв замаас төөрөлдсөн муу санаатны хувьд тэдний очих газар нь халуун там мөн. Хэрэв тэндээс гарахыг хүсэх бүртгээ эргэж буцаагдаж, тэдэнд: “Өөрсдөө худал хэмээн үгүйсгэсэн тамын галын гэсгээлээ амсацгаагтун!” гэж хэлэгдэх болно.
21. Бодолоо өөрчлөг гэж тэдэнд хойд насанд хамгийн том гэсгээлийн өмнө юуны урьд энэ хорвоогийн гэсгээлийг ч амсуулж үзнэ.
22. Өөрт нь Эзэнтнийх нь айлдваруудын тухай ухуулах санамж өгөгдөөд байхад түүнээс нүүр буруулахаас муухай зальхай юм гэж байж болох уу даа? Эргэлзээгүй, Бид нүгэлтэнгүүдэд хүртэх ёстой гэсгээлийг нь хүртээмүй.
23. Бид Мусад үнэндээ Таурат судрыг илгээсэн билээ. (Аяа, Мухаммед!) Чи уг судартай нүүр учрахаа бүү эргэлзэгтүн. Бид Мусаг Израйлын үр садад удирдан залагч болгосон.
24. Тэднийг тэвчээр заан, айлдваруудад маань итгэлтэй болсон үед дотроос нь бидний тушаалаар зөв шулуун зам руу залах удирдагчдыг томилсон билээ.
25. Эзэнтэн чинь, дахин амилахуйн өдөр тэдний маргалдсан зүйлийг шүүж өгмүй.
26. Эдүүгээ өөрсдөө амьдардаг нутагт нь (Меккед) Бид урьд өмнө хэрээс хэтэрч даварсан олон хүнийг үгүй хийсэн маань тэдэнд сургамж болоогүй юм уу? Эдгээрт үнэндээ сургамжууд буй. Энэ нь Тэдний сонорт хүрдэггүй юм уу?
27. Бид хувь хуурай газарт хурын усыг хүргэж, түүгээр өөрсдөө болон мал амьтад нь тэжээгдэх ургамал ургуулсныг тэд үнэхээр хараагүй гэж үү? Үүнийг анзаардаггүй юм уу?
28. Тэд: “Хэрэв, та нарын үг үнэн юм бол, тэр зарлиг хэрэгжих өдөр хэзээ тохиох юм вэ?” хэмээн асуудаг.
29. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Зарлиг гүйцэтгэгдэх өдөр буруу номтнуудын наминчлал тус болохгүй, өөрсдөд нь боломж ч эс өгөгдөнө” гэж хэл.
30. Тиймээс, чи тэднийг түр орхин хүлээ. Угаасаа тэд ч хүлээгсэд болой.



Мадина-д илгээгдсэн. 73 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Аяа, гэгээн элч минь! Аллахаас айгтун. Үл сүсэглэгсэд хийгээд хоёр нүүртэнгүүдийг бүү дагагтун. Аллах бүхнийг нь мэдэгч, мэргэн ухааны эзэн.

2. Эзэнтний чинь чамд айлдсанаас (Куранаас) бүү төөрөлд (Түүнийг дагагтун). Эргэлзээгүй Аллах та нарын хийсэн бүхнээс мэдээлэлтэй бөлгөө.
3. Аллахыг түшигтүн. Аллах эзэн байхад хангалттай шүү дээ.
4. Аллах нэг хүний цээжинд хоёр зүрх заяагаагүй, та нарын зихар болгосон эхнэрийг өөрсдийн чинь эхийн адил үздэггүй, өргөмөл хүүхдийг чинь төрүүлсэн гэдэггүй билээ. Та нарын ярьдаг юм хоосон үг. Аллах чин үнэнийг айлддаг, зөв шулуун зам руу залдаг.
5. Тэднийг (өргөмөл хүүхдийг) төрүүлсэн эцгийнх нь нэрээр овоглогтун. Энэ нь Аллахын өмнө шударга зүйл. Хэрэв тэдний эцгийг нь мэдэхгүй бол тэд та нарын шашин нэгт ахан дүүс, анд нөхөд гэсэн үг. Харин мэдээгүйгээс алдаж эндвэл буруугүй, нүгэлгүй. Мэдсээр байж зориуд хийвэл нүгэлтэй. Аллах машид өршөөн ивээгч, нэн энэрэгч бөлгөө.
6. Гэгээн элч үнэнчээр сүсэглэсэдэд өөрсдийнх нь амьнаас ч эрхэм болой. Гэгээн элчийн гэргий нь тэдний эхээс өөрцгүй. Аллахын сударт өгүүлснээр (өв залгамжлах тал дээр) ахан дүүс хүмүүс нэг нэгэндээ сүсэглэгсдээс ч, их нүүдэл үйлдэгсдээс ч илүү ойр. Гэвч өөрийнхөө анд найз нартаа буянт сайн үйл үйлдэх нь зохистой. Эдгээр нь сударт бичээстэй буй.
7. Тухайн үед Бид гэгээн элчүүдээс амлалт авсан билээ; Чамаас, Нухаас, Ибрахимээс, Мусагаас бас Мариямын хүү Исагаас хатуу амлалт авсан.
8. Учир нь чин үнэнчүүдийг Аллах чин шударгын тухайд байцаана. Үл сүсэглэгсдэд хатуу гэсгээл бэлтгэдэг.
9. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахын та нарыг гэх хувь хишгийг санацгаагтун. Та нарын эсрэг довтлохоор буруу номтнуудын цэрэг давшихад Бид тэдний эсрэг хүчтэй шуурга, мөн та нарт үл үзэгдэх дайчдыг (элч мэлжүүдийг) илгээсэн билээ. Аллах та нарын хийсэн бүхнийг харж байдаг.
10. Тэд тэр үеэр та нарын (дээд, доод) бүх талаас довтлон дайрсан. Та нарын нүд орой дээрээ гарч, зүрх чинь дэлсэж байлаа. Аллахын тухай янз бүрийн бодолд ч автсан билээ.
11. Ийнхүү сүсэглэгчид сорилтонд орж, газар дайвалзахын адил толгой эргэлдсэн.
12. Тэр мөчид хоёр нүүртэнгүүд хийгээд зүрхний гажигтай хүмүүс: “Аллах болон Түүний гэгээн элч бидэнд худал амалсан юм байжээ” хэмээсэн.
13. Тэдний зарим хэсэг нь: “Аяа, Ясрибийн (Мадинагийн) оршин суугчид аа! Одоо та нар энд байж болохгүй, буцсан нь дээр!” гэхэд бас нэгэн хэсэг нь гэгээн элчээс: “Үнэндээ гэр орон минь ундуй-сундуй эзгүй үлдсэн билээ” хэмээн зөвшөөрөл хүсэв. Хэрэг дээр тэдний гэр орон нь эзгүй биш ердөө л зугтахыг хүсэж байв.
14. Хэрэв Мадинагийн тал бүрээс тэдний эсрэг дайрч, бууж өгөхийг

- (сүсэглэхээ больж, мусулмануудын эсрэг байлдахыг) шаардваас тун амархан зөвшөөрөх л байсан юм.
15. Тэд өмнө нь ухарч зугтахгүй хэмээн Аллах-д амлалт өгсөн билээ. Иймд өгсөн амлалтын хариуцлагыг Аллах тэднээс асуух болой.
  16. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Үхлээс эсвэл алуулахаас зугтаж гарсан ч та нарт түүний ашиг тус үгүй. Амьдралын цэнгэлийг өчүүхэн зуур эдлэнэ шүү дээ” хэмээн хэлэгтүн.
  17. Мөн: “Хэрэв Аллах та нарт нэгэн муу муухайг хүсвэл, Аллахын гэсгээлээс хэн аврах вэ? Эсвэл энэрэлийг хүсвэл, Түүний хайр энэрэлд хэн саад хийх вэ?” хэмээн асуугтун. Тэд өөрсдөдөө Аллагаас өөр ямар ч эзэн нөмөр нөөлөг эс олж чадна.
  18. Аллах та нарын дотроос дайнаас арагш чангаагадыг, бас ахан дүүс нартаа: “Бидэнд ирж нэгдэгтүн” хэмээн хэлэгсэдийг яруу тод мэднэ. Угаасаа тэдний дотор тулалдаанд оролцогсод нь тоотой билээ.
  19. Тэд та нар дээр ирсэн ч атархуу. Хэрэв нэгэн аюул учирвал амь тавих гэж байгаа хүний адил нүдээ эргэлдүүлэхийг чи хармуй. Тэгээд аюул нь арилахын цагт олзны хувь руу хомхойрон шунахдаа хатуу гүтүү үг хаяж та нарыг гомдооно. Тэдэнд сүсэг бишрэл байхгүй. Гиймээс Аллах тэдний хөдөлмөрийг талаар болгоно. Энэ нь Аллахын хувьд хялбархан.
  20. Тэд сүрдэн айхдаа дайсны цэрэг ухрахгүй мэт үзнэ. Хэрэв бидний дайчид буцаж ирвэл тэд цөлийн нүүдэлчин Арабуудын (Бадауи) дунд толгой хоргодон зогсож, та нарын тухай эчнээ төдий асуухыг бодно. Угаасаа та нарын дунд байлаа ч, айхын эрхээр тун цөөхөн нь тулалдаанд оролцох байсан юм.
  21. Үнэндээ та нарын төлөө, мөн Аллах болон хойд ертөнцийн өдөрт найдагсад ба Аллахыг дурсан санагсадын төлөө гэгээн элчид гайхалтай дуурайлал буй.
  22. Үнэн сүсэгтэнгүүд дайсны хүчийг харахдаа: “Энэ бол Аллах болон Түүний гэгээн элчийн бидэнд даатгасан үйл мөн. Аллах болон Түүний гэгээн элч чин үнэнийг хэлдэг” гэлцэв. Энэхүү итгэл нь тэдний сүсэг бишрэлийг, мусулман ёсны жудгийг улам бататгав.
  23. Үнэн сүсэглэгсэдийн дотор Аллахт өгсөн амлалтандаа үнэнч эрчүүд олон буй. Тэдний зарим нь амиа алдав, зарим нь амиа золиослохыг хүлээж байна. Тэд амлалтаа хэзээ ч зөрчдөггүй юм.
  24. Аллах үнэнч хүмүүсийг үнэнч байсны хэрээр шагнана. Аллах хүсэх аваас хоёр нүүртэнгүүдийг гэсгээн цээрлүүлнэ, эсвэл гэмшин наминчлах боломж хайрлана. Аллах эргэлзээгүй машид өршөөгч, нэн энэрэгч билээ.
  25. Аллах буруу номтнуудыг уур хилэнгээрээ буцаана. Тэд хүссэндээ хүрэхгүй. Аллахын туслалцаа сүсэгтнүүд тулалдаанд ялахад хүрэлцээтэй. Аллах хүчирхэг хийгээд аугаа болой.

26. Аллах ариун судрын эзэдээс дайсанд туслагсадыг хориглолтоос нь гаргаж, зүрх сэтгэлд нь үхлийн айдас хуруулах бөлгөө. Та нар тэдний нэг хэсгийг хороосон, нэг хэсгийг олзлон авсан шүү дээ.
27. Тэгээд тэдний газар нутаг, орон байр, мал хөрөнгө, хүний хөл хүрээгүй онгон зэлүүд газрыг нь та нарт Аллах өвлүүлсэн билээ. Алив бүхэнд Алладын хүч чадал хүрэлцээтэй.
28. Аяа, Гэгээн элч минь ээ! Илүү хангамж хүсэж, чамайг гомдоосон эхнэрүүддээ: “Хэрэв, та нар энэ хорвоогийн амьдын жаргал хийгээд тансаглалыг хүсэх аваас, алив ирцгээгтүн, би та нарт хүрэлцэх юм өгч, сайн сайхнаар буцаан явуулая!
29. “Хэрэв Аллахыг Түүний гэгээн элчийг, хойд ертөнцийн буянт газрыг хүсвэл Аллах та нарын дотроос сайн үйл үйлдэгсэдийн төлөө асар том шагналыг (нүдээр үзэж, чихээр сонсоогүй, өдрийн бодолд ч ороогүй хувь хишгийг) бэлтгэсэн байна” хэмээн хэлэгтүн.
30. Аяа, гэгээн элчийн гэргий нар аа! Та нараас хэн нэгэн илэрхий ичгүүртэй зүйл үйлдвэл түүний гэсгээл хоёр дахин нэмэгдмүй. Энэ нь Аллахд маш хялбархан.
31. Та нараас хэн нь Аллах болон Түүний элчийг ёсчлон дагаж, сайн үйл үйлдэх аваас Бид түүний шан харамжийг ч хоёр дахин нэмэгдүүлмүй. Мөн түүнд (диваажинд) өгөөмөр хувь хишиг бэлтгэсэн болой.
32. Аяа, гэгээн элчийн гэргий нар аа! Та нар алив жирийн эмэгтэйчүүдтэй адил биш ээ. Хэрэв, та нар Аллахаас айж байгаа бол үл таних эрчүүдэд ялдам байдлаар бүү хандагтун. Тэгвээс, зүрх сэтгэлдээ гажигтай эрчүүд горьдлогод автах бөлгөө. Мөн намбалаг, тохьтой ярьж байгтун.
33. Та нар гэр орондоо ёс жаяг сахин сууцгаагтун. Хуучны бүдүүлэг үеийн эмэгтэйчүүдийн адил ил задгай бүү хувцаслагтун. Уншлага мөргөл үйлдэгтүн, ариуслын өглөг өгөгтүн. Аллах хийгээд Түүний элчийг бишрэн дагагтун. Аяа, гэгээн элчийн гэр бүлийнхэн ээ! Аллах та нараас бузарыг арилгаж, цэвэр ариун байлгахыг хүсэж баймуй.
34. Гэртээ уншигдсан Аллахын айлдваруудыг, гэгээн эрдмийг тогтоон авцгаагтун. Аллах нэн энэрэнгүй, бүхий мөн чанарыг мэдэгч, алив бүхнээс мэдээлэлтэй бөлгөө.
35. Мусулман эрчүүд хийгээд эмэгтэйчүүд, сүсэглэгч эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд, Аллахад илгэн дагагч эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд, шударга эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд, уужим тэвчээртэй эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд, Аллахаас эмээсэн даруухан эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд, өглөг өгдөг эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд, мацаг барьдаг эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд, ичгүүр сонжууртай эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд, Аллахыг ихээр санан дурсагч эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд та бүхэнд Аллах өршөөл хийгээд том буян хишиг бэлтгэсэн байгаа.



36. Аллах хийгээд Түүний гэгээн элчүүд нэгэн үйлийн талаар зарлиг буулгахад сүсэглэн итгэсэн эрэгтэй хийгээд эмэгтэйд өөрсдийн үйлийг (сонирхлыг) урьдал болгож болохгүй. Хэн Аллах болон Түүний гэгээн элчийг эсэргүүцвэл тэр үнэхээр илэрхий төөрөгдөлд орох болно.
37. (Аяа, Мухаммед!) Нэгэн цагт Аллахаын ивээн тэтгэсэн, өөрөө ч аз жаргалд умбуулсан нэгэн хүнд хандан: “Эхнэрээ бүү явуул. Аллахаас айгтун!” хэмээн хэлсэн билээ. Аллахаын ил айлдах зүйлийг чи сэтгэл дотроо хадгалсан юм. Хүн амьтан ёжлон дооглох вий хэмээн нэрэлхэж айсан. Уг нь Аллахаас айх ёстой байсан юм. Сүсэгтнүүдийн өргөж авсан хүүхдүүд нь гэр бүлээ цуцалбал, тэдний эхнэрүүдийг өөрсдийнхөө гэрлэлтэнд бүртгүүлэхэд зовохгүйн тулд, Бид Зайт буюу (гэгээн элчийн өргөмөл хүүхэд) эхнэрээ явуулсны дараа түүнийг (Зейнепийг) чамтай гэрлэхийг тушаасан билээ. Зейнептэй суух тухай Аллахаын тушаал үг дуугүй биелэгдэх болно.
38. Аллахаын гэгээн элчид тушаасан зүйлд зовлон бэрхшээл үгүй. Өмнө нь ирээд одогсодод ч Аллахаас тодорхойлсон зам ийм болой. Аллахаын зарлиг өөрчлөгдөхгүй бөгөөд зайлшгүй биелэх ёстой.
39. Гэгээн элчүүд Аллахаын илгээсэн зарлиг тушаалуудыг хүргэдэг юм. Тэд Аллахаас айх бөгөөд өөр хэнээс ч айхгүй. Эргэж тооцоо хийхэд Аллахаын хүч чадал хангалттай.
40. Мухаммед бол та нарын дунд буй эрчүүдийн альны ч эцэг нь бус. Тэр Аллахаын гэгээн элч нарын сүүлчийнх нь болой. Аллах алив бүхнийг мэдэж байдаг.
41. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахаыг олонтоо санан дурсагтун.
42. Мөн өглөө оройд Түүнийг шагшин магтагтун.
43. Аллах та нарыг түнэр харанхуйгаас гэрэл гэгээ рүү гаргахын тулд айлдвар энэрэлээ илгээсэн билээ. Түүний элчүүд ч та нарын төлөө өршөөл гуйцгаадаг. Аллах үнэн сүсэглэгчдэд машид энэрэнгүй.
44. Тэд Аллахаын өмнө очиход “Та нарт амар амгаланг хүсье” гэсэн мэндчилгээг хүлээн авах болно. Аллах тэдний төлөө өгөөмөр буянаа бэлтгэсэн байна.
45. Аяа, Гэгээн элч ээ! Бид чамайг чин үнэнийг гэрчлэгч, баярт мэдээг дуулгагч, сэрэмжлүүлэгч болгон илгээсэн юм шүү.
46. Тэрчлэн, Аллахаын болгоосноор Түүний цорын ганц гэдэгт, ивээл энэрэлд уриалан дуудах гэрэлт дэнлүү болгон чамайг илгээсэн билээ.
47. Аллахаын агуу энэрэл хайр, өгөөмөр хишиг байгаа тухай үнэн сүсэгтнүүдэд баярт мэдээг дуулгагтун.
48. Чи үл сүсэглэгсэд хийгээд хоёр нүүртэнгүүдэд бүү итгэгтүн. Тэдний учруулсан гай барцатыг бүү тээгтүн. Гагцхүү Аллахаыг түшиж тул, өмөрөөн дэмжихэд Аллах л хангалттай.
49. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нар сүсэгтэн эмэгтэйтэй гэрлэх, дэр

нийлүүлэхээс өмнө салвал тэдний хувьд товт хугацааг хүлээх шаардлагагүй. Чин сэтгэлээсээ зохих хэмжээний бэлэг сэлт өгч, нэр төртэй явуулагтун.

50. Аяа, гэгээн элч минь! Махр хэмээн хувь бэлгийгээ өгсөн эмэгтэйчүүдтэй, Алладын ивээлээр олзлон аваад өөрийн эрхшээсэн шивэгчинтэй, чамтай хамт шилжин суурьшсан авга ах хийгээд авга эгчийнхээ охидтой, нагац ах хийгээд нагац эгчийнхээ охидтой гэрлэхийг чамд зөвшөөрсөн билээ. Мөн үнэн сүсэгтэн нэгэн эмэгтэй өөрийн биеэ гэгээн элчид зориулж, гэгээн элч түүнтэй гэрлэхийг хүсвэл тус тус хүлээн зөвшөөрөгдсөн бөлгөө. Эдгээр нь бусад сүсэгтэн нарт бус, гагцхүү чамд хүлээн зөвшөөрөгдсөн болно. Бид эхнэрүүд хийгээд эрхшээсэн шивэгчин, боол нарын тухайд тэдэнд (төгс сүсэгтэн олонд) юуг үүрэг болгосноо мэдмүй. Эдгээрийг чамд хүндрэл учруулахгүй хэмээн ийн болгосон юм. Аллах машид өршөөгч хийгээд нэн энэргч шүү дээ.
51. Чи эхнэрүүдээс хүссэнийгээ хойшуулж, хүссэнийгээ хажуудаа авч болно. Түр хойшлуулсан эхнэрүүдээс таалсан нэгнийгээ дахин хажуудаа авахад чамд нүгэл үгүй. Ингэх нь тэднийг аз жаргалтай болгоход, эс гуниглуулахад, чиний өгч буй зүйлсэд сэтгэл хангалуун болгоход илүү дөхөмтэй болой. Аллах та нарын зүрх сэтгэлд буй бүхнийг мэддэг юм. Аллах бүхнийг мэдэгч, машинд энэргч билээ.
52. Эдгээр эхнэрүүдээс хойш, өөрийн эрхшээсэн шивэгчин нараас бусад эмэгтэй гоо үзэсгэлэнгээрээ чамд таалагдсан ч түүнтэй гэрлэх нь хориотой. Бас эдгээрийн (өөрийн эхнэрүүдийн) оронд өөр эмэгтэйчүүд авах нь ч хориотой. Аллах алив бүхнийг ажиглаж баймуй.
53. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нар зоогонд урин залагдахаас өөр тохиолдолд гэгээн элчийн гэрт зөвшөөрөлгүй бүү орогтун. Гагцхүү та нар урин залагдсан үедээ л орцгоогтун. Та нар ханатал идэж ундаалж дууссаны дараа эрээ цээргүй яриа дэлгэн сааталгүй тарцгаагтун. Зохисгүй байдал чинь гэгээн элчид төвөг учруулна. Гэвч тэр (та нарт үүнийг хэлэхээс) санаа зовж баймуй. Харин Аллах чин үнэнийг хэлэхээс зовохгүй. Гэгээн элчийн эхнэрүүдээс ямар нэгэн зүйл хүсэх гэж байгаа бол хөшигний цаанаас хүсэгтүн. Энэ нь та нарын хэн хэний чинь зүрх сэтгэлд сэвгүй болой. Алладын гэгээн элчийг гомдоох, түүний дараагаар эхнэрүүдтэй нь гэрлэх нь та нарт хатуу хориотой. Ийм үйлдэл нь Алладын өмнө асар хүнд гэмт хэрэг мөн.
54. Та нар алив юмыг ил гаргах ба нуун далдлах аваас хэзээ ч бүү эргэлз, Аллах бүхнийг мэдэж байдаг.
55. Гэгээн элчийн эхнэрүүдийн хувьд эцэг, хөвгүүд, төрсөн ах дүүс, төрсөн ах, дүү нарын хөвгүүд, эгч-дүүсийн хөвгүүд, сүсэгтэн эмэгтэйчүүд, өөрийн эрхшээлд буй боол, шивэгчин нартай нүүрний гивлүүргүйгээр

- уулзаж нүүр учрах нь нүгэл болохгүй. Аллахаас айгтун. Тэр эргэлзээгүй бүхнийг харж байдаг.
56. Аллах үнэндээ Гэгээн элчийг энэрэн хайрладаг. Мэлэжүүд ч түүнийг өргөмжилөн хүндэтгэдэг. Аяа, сүсэгтнүүд минь! Та нар ч түүнийг дээдлэн, амрыг айлтгаж байгтун.
  57. Аллах болон Түүний гэгээн элчийг гомдоогсодыг Аллах энэ хорвоо хийгээд хойд ертөнцөд ч хараах бөгөөд тэдэнд гэсгээл зовлон бэлдсэн баймуй.
  58. Үнэн сүсэглэгч эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүдийг гүжирдэж гомдоогсод бол гүтгэлэг болон түүний нүгэлийг нуруундаа үүрэх болно.
  59. Аяа, гэгээн элч минь! Эхнэрүүддээ, охидууддаа, сүсэгтэн эмэгтэйчүүдэд гадуур нөмрөгөө нөмөрч явахыг захигтун. Энэ нь тэдний эрх чөлөөт байдлыг таниулахад, бусад хүмүүс халдахгүй байхад ашигтай. Аллах машинд өршөөгч, нэн энэрэгч шүү дээ.
  60. Хэрэв, хоёр нүүртэнгүүд, зүрх сэтгэл нь гажигтай хүмүүс, хотод (Мадинад) хов жив тараагсад гэмт явдлаасаа салахгүй бол тэднийг хязгаарлах боломжийг Бид чамд олгоно. Тэгээд тэд чамтай тун ахархан хугацаанд л хөрш байх болно.
  61. Тэд бүгд хараалд нэрвэгдэн, хаа таарсан газар баригдаж, алуулж талуулна.
  62. Энэ нь улиран одогсодын тухайд ч Аллахын баримталсан ёс журам байсан юм. Чи Аллахын тодорхойлсон ёс журмаас хэзээ ч өөрчлөлтийг олохгүй.
  63. Хүмүүс чамаас ертөнцийн төгсгөлийн хугацааны талаар асууцгаах болно. (Аяа, Мухаммед): “Үүний тухай мэдээлэл гагцхүү Аллахын нигур дор, би мэдэхгүй” хэмээгтүн. Чи яаж мэдэх билээ? Магад түүний хугацаа ойртсон биз.
  64. Аллах үл сүсэглэгсэдийг ивээл энэрэлээс холдуулан, тэдэнд халуун тамын гэсгээл бэлтгэсэн байгаа.
  65. Тэд тэндээ эгнэгт үлдмуй. Мөн тэдэнд өмөөрөгч ч, туслагч ч эс олдмуй.
  66. Тэдний нүүр нь галд хуйхлагдах тэр өдөр: “Даанч яавдаа! Бид, Аллах хийгээд гэгээн элчид захирагдсан ч болоосой” хэмээн харамсана.
  67. Бас тэд: “Аяа, Эзэнтэн минь ээ! Бид зөвхөн өөрсдийн удирдагчид хийгээд ахмадуудыг л дагаж асан билээ. Тэд л биднийг замаас минь төөрөгдүүлчихлээ.
  68. Аяа, Эзэнтэн минь ээ! Тэдэнд хоёр дахин гэсгээлийг өгч, мөн хараалын муугаар хараагтун” хэмээн халаглана.
  69. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нар ч Мусаг зовоож гомдоогсодын адил бүү

бологтун. Гэвч Аллах түүнийг гүтгэлэг гүжирдлэгээс нь ангижруулан, цагаатгасан юм. Тэр Аллахын өмнө очиход нэр төртэй байлаа.

70. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахас айгтун. Чин шударга үг хэлэгтүн.
71. Тэгэх аваас Аллах та нарын үйлийг зөвтгөн, нүгэлүүдийг чинь өршөөх болно. Хэн Аллах болон Түүний гэгээн элчид итгэн захирагдана, тэр үнэнхүү их амжилтыг олно.
72. Бид ариун үүргийг тэнгэр, газар хийгээд уул нуруудад өргөн барьсан ч тэд үүнийг үүрэхээс татгалзан эмээсэн билээ. Харин хүмүүн үүнийг хүлээж авсан. Үнэндээ, хүмүүн төрөлхтөн зальхай бөгөөд мунхаг ажгуу.
73. Дээрх ариун үүргийг зөрчсний учир Аллах хоёр нүүртэн эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүдийг, үл сүсэглэгч эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүдийг гэсгээх бөгөөд, энэхүү ариун үүрэгтээ үнэнч сүсэгтэн эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүдийг энэрэн ивээнэ. Аллах машид өршөөгч, нэн энэрэгч билээ.



Мекке-д илгээгдсэн. 54 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Тэнгэр хийгээд газар дахь алив бүхнийг эзэгнэгч Аллахыг шагшин магтамуу. Хойд ертөнцөд ч хамаг магтаал Түүнийх. Тэр мэргэн ухааны эзэн хийгээд алив бүхнээс мэдээлэлтэй.
2. Тэр газар руу юу орж, газраас юу гарч буйг, бас тэнгэрээс юу бууж, тэнгэр өөд юу хөөрч буй бүхнийг мэднэ. Тэр машид энэрэгч хийгээд нэн өршөөгч бөлгөө.
3. Үл сүсэглэгсэд : “Ертөнцийн төгсгөлийн цаг бидэнд үл тохиомуй” хэмээн хэлцгээдэг. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Үгүй ээ! Алив далдын нандин нууц бүхнийг мэдэгч Эзэнтнийхээ алдраар танграглая. Эргэлзээгүй тэр өдөр та нарт тохиох болно. Тэнгэр хийгээд газарт буй нүсэр хүнд юм ч, хумхын тоос ч Аллагаас нуугдаж эс чадмуй. Мөн түүнээс том ч, жижиг ч бай, сударт бичигдээгүй нэг ч зүйл үгүй” хэмээн хэлэгтүн.
4. Аллах сүсэглэн итгэж, сайн үйл үйлдэгсэдийг сайшаан урамшуулахын тулд (алив бүхнийг хувь тавилангийн судар болох Лаухул Махфуз хэмээх тэр сударт) тусгасан байдаг. Тэд өршөөл, өгөөмөр хишгийг эзэгнэх болно.

5. Бидний айлдваруудыг сул дорой болгохыг хичээгсэд хатуу цээрлүүлэгдэн зовлонг гэгсгээлтэй учрана.
6. Эрдэм мэдлэгтнүүд Эзэнтнээс чамд буулгасан Кураны чин үнэн болохыг, тэр нь ялгуулсан аугаа, магтвал зохилтой Аллахын зам руу хөтөлдгийг мэддэг.
7. Буруу номтнууд: “Та нар булшан дотор ялзарч үрэгдэн, үмхий шороо болсон хойно эргэлзээгүй дахин амилж, бодгаль амьтан болно хэмээн цуурдаг хүнийг та нарт харуулах уу?” хэмээн бие биедээ сайрхдаг.
8. “Тэр Аллахын тухай худал гүтгэлэг тараадаг юм уу? Аль эсвэл орон гаран эргүү юм болов уу?” Тийм биш ээ! Хойд ертөнцөд үл итгэхийн гэгсгээл, асар их төөрөгдөлд автаж байгаа нь тэр ээ!
9. Тэд тэнгэр хийгээд газарт өөрсдийг тал талаас нь бүсэлж байгаа юмыг хардаггүй юм уу? Бид хүсвэл тэднийг газрын гав руу оруулна, аль эсвэл дээрээс нь тэнгэрийг хэсэглэн унагаана. Эргэлзээгүй, үүнд Эзэнтэндээ итгэсэн алив боолд сургамж буй.
10. Бид Дауидад (өөрийн гэгээн элч болгон, Забур судрыг буулгаж) давуу чанар хайрласан юм. “Аяа, уулс хийгээд шувууд аа! Дауидтэй хамт Намайг шагшин магтагтун” хэмээн айлдсан. Ийнхүү түүнд төмрийг яруулж өгсөн билээ.
11. “Чанартай хуяаг дуулга хийгтүн. Гогцоо сүлжээгийн хэмжээг зохистой тааруулагтун, бүгдээрээ сайн үйлдэгтүн. Би, та нарын үйлдсэн бүхнийг харж баймуу” хэмээн айлдсан юм.
12. Бид Сүлейманд өглөө нэг сард дүйх, орой мөн нэг сард дүйх хугацааны замыг туулах салхи шуургыг эрхшээх эрдмийг хайрласан билээ. Мөн түүний төлөө хайлуулсан зэсийг булаг мэт ундруулан урсгаж өглөө. Эзэнтний чинь зарлигаар буг чөтгөрүүд ч түүн дор ажиллаж асан билээ. Тэднээс хэн нь Бидний зарлигийг зөрчинө, түүнд халуун тамын гэгсгээлийг амсуулсан юм.
13. Тэгээд тэд Сүлейманд хүссэнээр нь байшин барилгууд, (зэс, шилээр) гайхамшигтай баримал, аврага том тэвш, тогоонуудыг хийж өгсөн. Аяа, Дауидын гэр бүл ээ! Та нар талархагтун. Надад талархах боолууд маань тун цөөхөн шүү!” хэмээсэн.
14. Бид Сүлейманий үхэлийн талаар зарлигдахад түүний үхэлийн тухай таягийг нь нүхлэн идсэн хорхой л мэдээлсэн билээ. Тэр түшиж зогссон таягаа алдан унахад л буг чөтгөрүүд үхсэнийг нь сая л мэдсэн юм. Хэрэв тэд далдыг мэддэг байсан бол, ийм л хүнд бэрхшээл зовлонд автахгүй байсан билээ.
15. Сабагийн ардуудын нутагладаг газарт (Аллахын ид шидийг үзүүлэх) нэгэн нотолгоо буй. Тухайлбал: баруун талд нэг, зүүн талд нэг цэцэрлэгтэй байсан аж. Бид тэдэнд: “Эзэнтнийхээ хувь хишгээс

- идэцгээгтүн, Түүнд талархагтун. Энэ бол тун сайхан хот суурь. Эзэнтэн чинь та нарыг ивээн энэрэгч” хэмээн хэлсэн.
16. Гэвч тэд талархахаас татгалзсан. Иймд Бид хүчтэй үер буулган, тэдний хоёр цэцэрлэгийг гашуун сухайт, зэрлэг ширэнг бүхий могойн модтой цэцэрлэг болгон хувиргасан юм.
  17. Бид тэднийг биеэ тоон, ачийг эс санасаных нь төлөө ийнхүү гэсгээн цээрлүүлсэн. Бид бардамнан, ачийг эс санагсадыг л цээрлүүлдэг юм.
  18. Бид буян хишиг хайрласан суурингууд болон тэдний хооронд анхаарал татах (Шам ба Иемений хоорондын) хот, тосгодыг бий болгов, Тэдгээрийн хооронд явах (хоол хүнс худалдан авахгүй ч гэсэн) зорчигчид өглөөнөөс их үд, их үдээс орой гэхэд хүрэх буудлуудын зайг тогтоож өгсөн. Тэдэнд: “Өдөр шөнөгүй тайван, аюулгүй зорчицгоогтун!” хэмээн хэлсэн.
  19. Тэд: “Аяа, Эзэнтэн минь! Чи буудлуудын хоорондын зайг холдуулж өгөөч” хэмээн өөрсдөдөө лай хураасан. Бид хойч үеийнхний төлөө тэднийг домог мэт өгүүллэг болгож, орвонгоор нь эргүүлж орхисон. Хүлээсэн үүргэндээ тэвчээртэй, эд хөрөнгөнд талархагчдын хувьд үүнд олон сургамж буй нь эргэлзээгүй.
  20. Үнэндээ чөтгөр шулмасын тэдний тухайд (төөрөлдүүлэх) бодол нь биелэлээ олов. Нэг хэсэг сүсэгтнүүдээс бусад нь бүгдээрээ түүнд хөтлөгдөн одов.
  21. Хэрэг дээр чөтгөр шулмас тэднийг захирах чадалгүй билээ. Энэ нь гагцхүү хойд ертөнцөд итгэгсэдийг үгүйсгэгчдээс ялгаж авахын төлөө сорилт байсан юм. Эзэнтэн чинь алив бүхнийг хянан ажиглагч билээ.
  22. Тэдэнд: “Аллахаас өөр бурханд тооцсоныгоо дуудацгаagtун. Тэд чинь тэнгэр хийгээд газрын алинд ч хумхын тоосны чинээ юмыг эрхшээх чадал үгүй бөгөөд тэнгэр, газрыг бүтээхэд тэдний оролцоо огт байхгүй. Аллахад тэдний аль нь ч туслаж чадахгүй” хэмээн хэлэгтүн.
  23. Аллахын нигур дор, Өөрийнх нь болгоосноос бусад хэний ч өмөөрөл тусыг эс өгмүй. Гагцхүү тэдний зүрх сэтгэлээс айдас түгшүүр нь ангижирмагц: “Эзэнтэн чинь (ивээл энэрэлийн талаар) юу айлдсан юм бэ?” хэмээн асууцгаана. Аллахын ивээл энэрэл хүртэгсэд: “Чин үнэнийг айлдсан” хэмээн хэлцгээнэ. Аллах эрхэмсэг дээгүүр, нэн их аугаа билээ.
  24. (Аяа, Мухаммед!): “Тэнгэр хийгээд газраас та нарт хэн хувь хишиг хүртээдэг вэ?” хэмээн асууж, хариу болгон: “Аллах!” хэмээн хэл. Үнэндээ бид, эсвэл та нарын аль нэг нь зөв шулуун зам дээр, аль нэг нь илэрхий төөрөгдөл дээр байнам” гэж хэл.
  25. Тэдэнд: “Бидний үйлдсэн нүгэлд та нар хариуцлага хүлээхгүй. Бид ч гэсэн та нарын үйлдсэн хэргийн төлөө хариуцлага үүрэхгүй” хэмээгтүн.
  26. “Эзэнтэн маань бид бүгдийг хэзээ нэгэн цагт нэг дор цуглуулна. Дараа

- нь та бидний талаар чин үнэн шийдвэр гарган, шүүн ялгамуй. Тэр хамгийн шударга шүүгч, алив бүхнийг онцгой сайн мэдэгч” хэмээн хэлээрэй.
27. Бас л тэдэнд сануулан: “Түүнтэй (Аллахтай) зүйрлэн эн зэрэгцүүлсэн зүйлсээ надад харуулаад аль? Байхгүй шүү дээ! Хэзээ ч боломжгүй зүйл !!!” хэмээн хэл. Эсрэгээрээ Аллах аугаа ялагч, мэргэн ухааны эзэн мөн.
  28. Бид чамайг хүн төрөлхтөнд гагцхүү баярлуулагч, сэрэмжлүүлэгч болгон илгээсэн билээ. Гэвч хүмүүсийн олонхи нь үүнийг мэддэггүй юм.
  29. Тэд “Хэрэв, та нар чин үнэнийг хэлэгсэд ахул энэ амалсан амлалт (ертөнцийн төгсгөл) чинь хэзээ тохиох вэ?” хэмээн асуудар.
  30. Тэдэнд: “Та нарын хувьд гэсгээлийн нэгэн өдөр амлагдсан буй. Түүнээс өчүүхэн төдий ч хойшлуулах, урагшлуулах явдал үгүй” гэж хэл.
  31. Буруу номтнууд: “Бид Куранд ч, түүнээс өмнөх судруудад ч итгэхгүй” гэлцэнэ. Тэрхүү харгис зальхай этгээдүүд Эзэнтний өмнө саатуулагдаж, бие биетэйгээ маргалдаж зогссоныг харвал, тэдний номой доройчууд нь дээдэстээ хандан: “Та нар байгаагүйсэн бол бид мэдээж сүсэгтэн болох байсан!” хэмээн гомдоллоно.
  32. Ихэмсэг дээдэс нь номой доройчуудад: “Та нарт зөв шулуун зам ирээд, тэгээд бид та нарыг төөрөгдүүлсэн юм уу? Эсрэгээрээ өөрсдийн эрхээр нүгэлд унасан шүү дээ!” гэнэ.
  33. Номой доройчууд нь ихэмсэг дээдэстээ: “Үгүй шүү! Та нарын өдөр шөнөгүй сэдсэн заль мэх чинь бидэнд саад болсон. Тэр үед Аллахтай бусдыг эн зэрэгцүүлэхийг, эсэргүүцэн үгүйсгэхийг та нар бидэнд тушаадаг байсан шүү дээ” гэнэ. Ийнхүү тэд зовлонг гэсгээлийг амсахын цагт л дотроо харамсацгаадаг. Бид буруу номтнуудын хүзүүнд дөнгө зүүж, хийсэн нүглийн хэр хэмжээгээр л цээрлүүлэх болно.
  34. Бид аль нэгэн хотод сэрэмжлүүлэгч (гэгээн элч) илгээхэд хотын чинээлэг хэсэг нь: “Бид чиний гэгээн элч эсэхийг хүлээн зөвшөөрөхгүй” гэнэ.
  35. Мөн тэд: “Бид баян чинээлэг, олон үр хүүхэдтэй тул зовлон бэрхшээлтэй учрахгүй” хэмээн бардамнана.
  36. (Аяа, Элч минь!) Тэдэнд: “Эзэнтэн таалсанаа элбэг дэлбэг хишигтэй болгож, хүссэнээ тарчиг ядуу болгоно. Гэвч хүмүүсийн олонхи үүнийг ойлгодоггүй” хэмээн хэлэгтүн.
  37. Та нарын эд баялаг хийгээд үр садын аль нь ч та нарыг Бидний нигур дор ойртуулж чадахгүй. Харин хэн үнэнчээр сүсэглэн, сайн үйл үйлдэнэ, тэр хийсэн үйлийнхээ хэрээр давхар буян хишиг хүртэнэ. Мөн диваажингийн хойморт залран амар тайван баясч суух болно.

38. Бидний айлдваруудыг үгүйсгэн хүчингүй болгохыг эрмэлзэгсэд Аллахын гэгсгээлтэй учрах болно” гэж хэл.
39. (Аяа, Элч минь!) Тэдэнд: “Эзэнтэн хүссэндээ хувь хишгийг ихээр нь хайрлаж, хүссэнээсээ хувь хишгээ танадаг болой. Аллахын төлөө зарцуулсны орыг Аллах нөхөж дүүргэх болно. Тэр хувь хишиг хүртээгсэдийн хамгийн өлзийтэй нь шүү дээ” хэмээн хэлэгтүн.
40. Тэр өдөр Аллах, тэд бүгдийг цуглууж, элч мэлэкүүдээсээ: “Эднүүс та нарт сүсэглэн шүтсэн үү?” хэмээн асууна.
41. Элч мэлэкүүд нь: “Чи чин ариун болой, бидний эзэн бол эднүүс биш. Та өөрөө шүү дээ. Тэд биднийг шүтээгүй буг чөтгөрийг тахин шүтдэг байсан бөгөөд олонхи нь тийм л байсан юм” гэв.
42. Та нар, өнөөдөр нэг нэгэндээ ашиг тус ч, хор хөнөөл ч эс хүргэж чадмуй. Бид (Аллах) харгис зальхайчуудад: “Өөрсдөө худал хэмээж итгээгүй тамын галын гэгсгээлээ амсацгаагтун” хэмээх ажгуу.
43. Бидний яруу тод айлдварууд уншигдахуйд тэд: “Энэ хүн бол (Мухаммедийг) өвөг дээдсийн чинь шүтэж асан зүйлээс төөрөгдүүлэхийг л хүсдэг юм” гэв. Мөн Бидний айлдварыг “санаанаас зохиосон хуурамч зүйл” гэсэн. Үл сүсэглэгсэд өөрсдөд нь ирсэн чин үнэний тухайд: “Илэрхий илбэний ид шид” гэлээ.
44. Бид тэдэнд сурах бичиг болгон судар хайрлаагүй бөгөөд чамаас өмнө сэрэмжлүүлэгч (гэгээн элч) илгээгээгүй болой.
45. Тэднээс өмнөхүүд ч (гэгээн элч нарыг) хүлээн зөвшөөрөөгүй билээ. Тэд (Меккегийн буруу номтнууд) урьд өмнөхүүдэд Бидний хайрласаны (хүч чадлын хувьд) аравны нэгэнд ч хүрээгүй атлаа Миний гэгээн элчийг хүлээн зөвшөөрсөнгүй. Намайг хүлээн зөвшөөрөөгүй хүмүүсийн төгсгөл яасан билээ?
46. Аяа, Элч минь тэдэнд: “Би та нарт нэгэн зүйлийг ухуулан сэнхрүүлэх гэсэн юм. Аллахын төлөө хоёроороо, нэг нэгээрээ босоцгоогтун. (Наминчлан залбирцаагтун, хүсэл тавигтун.) Дараа нь эргэцүүлэн бодоцгоогтун. Та нарын ахан дүүс (Мухаммед) ер галзуураагүй. Гагцхүү хагуу гэгсгээл ирэхээс өмнө та нарт сэрэмжлүүлэгч нэгэн билээ” хэмээн хэлэгтүн.
47. Мөн тэдэнд: “Би та нараас хөлс хүч нэхээгүй, тэр та нарынх болог. Миний хариу хөлс гагцхүү Аллахад хамаарагдмуй. Аллах алив бүхний гэрч” хэмээн хэл.
48. Мөн тэдэнд: “Эзэнтэн минь эргэлзээгүй, чин үнэнээр бүтэлгүй явдлыг бут цохино.(Гагц чин үнэнийг л илэрхийлнэ) Тэр нууц, далд бүхнийг сайн мэднэ” гэж хэлэгтүн.
49. Мөн тэдэнд: “Чин үнэн ирлээ, худал хуурмаг зүйл юуг ч эс бүтээнэ, бас алга болсныг хэвэндээ оруулж чадахгүй” гэж хэл.
50. “Хэрэв, би төөрөгдвөл уршиг нь минийх. Хэрэв, би зөв зам дээр байвал,



энэ нь Эзэнтний маань надад айлдсан Кураны ач тус. Эргэлзээгүй Тэр бүхнийг сонсогч, илүү ойрхон” хэмээн хэлэгтүн.

51. Тэднийг айж сандралдан, орох гарахаа олохгүй, ойроос баригдан, тамын галд хаягдах гэж байгааг чи хардаг ч болоосой.
52. Тэд (бүх зүйл өнгөрсөний дараагаар) “Бид түүнд итгэлээ” хэмээн хэлцгээнэ. Гэвч тийм л алс холоос (хойд ертөнцөөс) сүсэг бишрэлтэй яаж учран золгох вэ дээ?
53. Үнэндээ тэд урьд өмнө нь түүнийг (гэгээн элчийг) хүлээн зөвшөөрөөгүй юм. Тэд алс холоос нүдээрээ үзээгүй далдын нууцыг онилон, мэдэхгүй атал санаанд орсноо амаараа бурцаав.
54. Ийнхүү урьд өмнөхүүдэд хийгдсэний адилаар, тэд ба тэдний хүсэж горьдсон зүйлсийн хооронд саад тотгор бий болно. (Итгэн сүсэглэх, диваажинд очих нь тэдний хувьд хоосон мөрөөдөл, хий үзэгдэл юм.) Учир нь тэд энэ тухай (Амьд ахуйн хорвоод байхдаа ч) их л эргэлзэж байсан билээ.

### 35. СУРЕ ФАТЫР

Мекке-д илгээгдсэн. 45 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Бүхий л магтаал тэнгэр, газрыг бүтээгч хоёр, гурав, дөрвөн далавчтай мэлэкүүдийг тэнгэрийн элч болгон илгээсэн Аллахад хамаарагдана. Аллах бүтээхээр таалсаныгаа өргөмжилдөг. Аллахын хүч чадал эргэлзээгүй алив бүхэнд хүрдэг.
2. Аллахын хайр энэрэлээс нь хүмүүст зориулсан зүйлийг тогтоон саатуулагч үгүй билээ. Аллахын хориглон саатуулсан зүйлийг илгээж чадах хүч үгүй. Тэр аугаа эрхэмсэг, мэргэн ухааны эзэн.
3. Аяа, хүмүүс ээ! Аллахын та нарт хайрласан хувь хишгийг байнга санагтун. Аллахаас өөр та нарт тэнгэр, газраас хувь хишиг хүртээх бүтээгч байна гэж үү? Аллахаас өөр ямар ч бурхан байхгүй. Ийм атал та нар Аллахын бишрэл залбиралаас хэрхэн тагталзах вэ?
4. Аяа, Мухаммед! Тэд чамайг хүлээн зөвшөөрөхгүй бол (бүү гунигла). Чамаас өмнөх гэгээн элчүүд ч үгүйсгэгдсэн юм. Бүхий л үйл хэрэг зөвхөн Аллахын өмнө очих болно.
5. Аяа, хүмүүс ээ! Эргэлзээгүй, Аллахын амлалт чин үнэн. Тиймээс та нар амьд ахуйн явдалд бүү хууртагтун! Тэрчлэн, залилагч чөтгөр шулмас ч та нарыг Аллахын тухайд бүү хуураг.
6. Чөтгөр шулмас та нарын илт дайсан мөн. Та нар ч түүнийг өөрийнхөө

- дайсан хэмээн үзэгтүн. Чөтгөр шулмас өөрсдийн талынхныг халуун там руу түлхэн уриалдаг.
7. Үгүйсгэгсдийн хувьд хойт ертөнцийн хатуу гэсгээл буй. Харин сүсэглэж, сайн үйл үйлдэгсэдийн хувьд ивээл энэрэл, том буян хишиг буй.
  8. Муу үйл хэрэг нь өөрт нь эрхэм санагдаж, үүнийг өөрөө сайн сайхнаар төсөөлсөн хүн бол, муу муухайг огтхон ч хүсэхгүй зөв замаа олсон хүнтэй адил гэж үү? Аллах таалсаныгаа төөрөгдөл рүү чиглүүлж, таалсаныгаа зөв шулуун зам руу хөтөлдөг. Аяа, Мухаммед үл сүсэглэгсдийн төлөө гуниглан, өөрийгөө бүү буруутга. Аллах тэдний юу хийснийг бүрэн дүүрэн мэдэж байгаа билээ.
  9. Аллах салхи шуурга явуулж үүлсийг хөдөлгөнө. Бид түүнийг үхмэл хуурай газар руу илгээж хур бороо оруулна. Хурын усаар тэр газрыг сэргээн амилуулдаг. Үхэгсэдийн дахин амилах нь ийм байх ажгуу.
  10. Хэн нэр төр, алдар гавьяаг горилоно, тэр мэдэгтүн! Нэр төр, алдар гавьяа бүхэн зөвхөн Аллахынх болой. Сайхан үг Аллахад хүрдэг, үүнийг сайн үйлс өргөмжилдөг. Муу үйл үйлдэж, заль мэх гаргагсадад хатуу гэсгээл буй. Мөн тэдний заль мэх талаар өнгөрмүй.
  11. Аллах та нарыг эхлээд шороо шавраар, дараа нь үрийн дуслаар бүтээсэн. Улмаар та нарыг хос (эр, эм) болгосон. Аллахын эрдэм ивээлгүйгээр ямар ч эмэгтэй жирэмслэхгүй, үр хүүхэд төрүүлэхгүй. Амьд амьтан бүхний нас урт, богино байх нь Лаухул махфуз хэмээх хувь тавилангийн сударт бичээстэй байдаг. Энэ нь Аллахын хувьд хялбархан билээ.
  12. Хоёр тэнгис адилгүй, нэг нь цэнгэг амны цангаа тайлдаг, нөгөө нь шорвог давстай байх жишээтэй. Энэ хоёрын тус бүрээс нь та нар шинэхэн мах (загас) идэцгээдэг, бас зүүлтний гоёл чимэглэлийг гаргаж авцгаадаг. Та нар Аллахын хайр энэрэлээс хувь хишгээ эрж хайхдаа хөлөг онгоцнууд далайн усыг зүсэн хөвж буйг харж, магад талархах биз.
  13. Аллах шөнийг өдөр, өдрийг шөнө болгов. Тэр нар, сарыг хүмүүсийн ашиг тусын тулд эрхшээсэн. Эдгээрийн тус бүр нь товлогдсон нэгэн хугацаагаар урсан эргэлддэг. Энэ бүхнийг хийгч нь Аллах. Түүнээс өөр та нарын тахин шүтэцгээсэн зүйлс чинь хялгасан чинээ юмыг ч эзэгнэж үл чадна.
  14. Хэрэв та нар тэднийг (шавар бурхадыг) дуудвал, дуугийг чинь сонсож чадахгүй. За яахав сонслоо гэсэн ч хариу өгч чадахгүй. Ертөнцийн төгсгөлийн өдөр Аллахтай эн зэрэгцүүлсэнийг чинь тэд тоохгүй, мэдрэхгүй. Тэр өдөр тэдний байдлын талаар Аллахаас өөр хэн ч чамд мэдээлэл өгч чадахгүй.
  15. Аяа, хүмүүс ээ! Та нар Аллахаар дутах болно. Харин Аллах юугаар ч дутаж гачигдахгүй, гагцхүү сайшаан магтахад тохиромжтой.

16. Аллах таалах аваас та нарыг үгүй хийж, оронд чинь өөр зон олныг авч ирнэ.
17. Энэ нь, Аллахад ер хэцүү биш ээ!
18. Ямар ч нүгэлтэн бусдын нүглийг үүрэхгүй. Нүгэл нь ихтэй хэн нэгэн нүглээ үүрүүлэхийн тулд өөр хэн нэгнийг дуудах ахул, тэр нь түүний садан төрөл байсан ч түүний нүглээс өчүүхэнийг ч үүрэлцэхгүй. Чи харалгүйгээр гагцхүү Эзэнтнээсээ айж эмээдэг, уншлага мөргөлөө үйлдэгсэдийг л ажиглан сэрэмжлүүлж чадна. Хэн нэгэн нүглээсээ ариусах аваас тэр гагцхүү өөрийнхөө төлөө л ариусана. Эцсийн эцэст байх газар чинь Аллахын өмнө байх болно.
19. Сохор ба хараатай хоёр (буруу номтон ба мусулман хоёр) адил биш.
20. Харанхуй ба гэрэл (худал ба үнэн хоёр) адил биш.
21. Сэрүүн сүүдэр ба төөнөм халуун хоёр (диваажин ба там хоёр) адил биш.
22. Амьд ба үхсэн хоёр адил биш. Аллах үнэндээ чин үнэнийг таалсан хүндээ сонсгомуй. Харин чи бол булшинд байгсдад (буруу номтнуудад) албадан сонсгож эс чадмуй.
23. Чи ердөө л сэрэмжлүүлэгч шүү дээ.
24. Үнэндээ Бид чамайг (мусулмануудад) чин үнэний (үнэн шашны) баярт мэдээг дуулгагч, буруу номтнуудыг тамын галаар айлгагч болгон илгээсэн билээ. Сэрэмжлүүлэн айлгагч гэгээн элч илгээгдээгүй алив ард үгүй билээ.
25. Хэрэв, тэд чамайг худал хэмээн үгүйсгэх аваас бүү уйтгарлан гунигла. Тэднээс өмнөхүүдийг ч худалч хэмээж үгүйсгэсэн юм. Тэдэнд гэгээн элчүүд Сахифа (бичээсүүд), Таурат, Забур, Инжил зэрэг сударуудтай илгээгдсэн билээ.
26. Үүний дараа Би тэр үгүйсгэгсдийг (хатуу гэгсгээлээр) цээрлүүлсэн юм. Миний гэгсгээл ямар байсныг хараа биз дээ.
27. Чи хараагүй гэж үү? Аллах тэнгэрээс хурыг буулгаж, түүгээрээ төрөл бүрийн үр жимсийг ургуулсан. Мөн Аллах цагаан, улаан, тас хар зүсэм бүрийн өнгөтэй зурвас бүхий уулсыг бүтээсэн.
28. Түүнчлэн хүмүүс, адгуус амьтад, мал сүргийг ч төрөл бүрийн өнгө зүстэй бүтээсэн. Боолуудын дотроос юуны урьд эрдэмтэн мэргэд л Аллагаас айцгаадаг. Аллах эргэлзээгүй ялалтын эзэн, нэн өршөөгч мөн.
29. Аллахын судрыг уншигсад, уншлага мөргөлөө бүрэн үйлдэгсэд, өөрсдөд нь хайрлагдсан хувь хишгээс (Аллахын ивээлийн төлөө) ил, далдаар зарцуулагсад бол хохиролд эс өртөх арилжаа наймааг, сайн сайхныг л горьдоцгоодог.
30. Яагаад гэвэл Аллах тэдний шан харамжийг бүрэн гүйцэт өгөх бөгөөд

- элбэг дэлбэг хайр энэрэлээсээ тэдэнд бүр ч илүү өгдөг. Аллах үнэхээр ивээн энэрэгч, бага ч гэсэн сайн үйлийн төлөө ихээр хариу баригч.
31. Бидний чамд илгээсэн судар (Куран) бол чин үнэн бөгөөд өмнөх судруудыг бататгадаг. Аллах үнэндээ өөрийнхөө боолуудын талаар бүрэн мэдээлэл авагч бөгөөд агуу харагч билээ.
  32. Тиймээс Бид өөрсдийн таалсан боолондоо Куран судрыг өвлүүлэн өгсөн юм. Тэдний зарим нь өөрөө өөртөө зальхай юм үйлдэж (Кураныг уншсан ч хэрэг дээр дагахгүй), зарим нь дундыг баримтална. (Удаан хугацаагаар хэрэг дээр хэрэглэсэн ч заримдаа анхаарал тавьдаггүй.) Харин бас нэг нь Аллахын тааллаар сайн үйлсийн төлөө яаравчилна. Энэ нь аугаа энэрэл мөн.
  33. Тэд Гадын диваажинд орцгооно. Тэнд алтан бугуйвч, сувдан зүүлтээр гоёх бөгөөд өмсгөл нь хоргой, торго байх болно.
  34. Тэд: “Бүхий л сайшаал соёхрол нь биднийг гуниглалаас ангижруулсан Аллахынх мөн. Эзэнтэн маань үнэхээр машинд ивээн энэрэгч, бага үйлсийн хариуд элбэг дэлбэг шан хайрлагч” хэмээн талархана.
  35. “Тэр биднийг хайр энэрэлээрээ диваажинд байршуулсан. Энд ямар ч бэрхшээл, зүдэргээн алга” хэмээнэ.
  36. Харин үл сүсэглэгсдэд тамын халуун гал буй. Тэд үхье гэсэн ч үхэж үл чадна, гэгсгээл нь хөнгөвлөлдөхгүй тарчилна. Бид үл сүсэглэн хэрээс хэтрэгсэдийг ийнхүү гэгсгээн цээрлүүлдэг.
  37. Тэд тамд байхдаа: “Аяа, Эзэнтэн минь ээ! Биднийг эндээс гаргаж аль?! Амьд ахуйдаа хийснээс ондоо нэгэн сайн үйл үйлдэцгээе” хэмээн наминчлан залбирна. Аллах: “Бид та нарт ухуулга сургамж авахыг хүссэн хүний амьдралтай тэнцэх хугацаа болон ухуулга сургамж авч чадахуйц хорвоог өгөөгүй сэн бил үү? Та нарт сэрэмжлүүлэхээр гэгээн элчийг илгээсэн биш бил үү? Одоо гэгсгээлийн амтыг үзэцгээгтүн. Харгис зальхай амьтадад аврагч үгүй” хэмээх болно.
  38. Аллах тэнгэр, газрын бүх нууцыг мэднэ. Бүр зүрх сэтгэлийн гүнд буй нууцыг ч мэднэ.
  39. Аллах та нарт дэлхий даяр халифа буюу шашны төлөөлөн удирдах эрх мэдлийг өглөө. Хэн буруу номтон байвал, буруу номтны уршиг өөрт нь оногдоно. Буруу номтнуудын үл тоомсорлол нь Эзэнтний нигур дор Түүний уур хилэнг нэмэгдүүлж, өөрт нь хор уршгийг л ихэсгэнэ.
  40. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Та нар Аллахыг орхиж, тахин шүтсэн зохиомол бурхадаа харцгаасан уу? Тэд газар дэлхийд юуг бүтээсэн вэ? Надад харуулаад аль?! Эсвэл тэнгэр огторгуйг Аллахтай хамтарч бүтээсэн юм уу? Үгүй бол, Бид тэдэнд (энэ талаар) нэгэн номыг хайрлаад, тэд тухайн номонд буй нотолгоонуудыг баримталж байна уу? Үгүй ээ, тийм биш ээ! Харгис зальхай этгээдүүд бие биеэ хуурахыг л амалдаг юм.

41. Аллах тэнгэр, газрыг сүйдэхээс сэргийлэн баттай тогтоон барьж байдаг. Хэрэв энэ хоёр сүйрэхээр бол Аллахаас өөр хэн ч түүнийг аргадан тогтоож чадахгүй. Аллах ихэд уужим (гэсгээхийг яардаггүй), машид өршөөгч бөлгөө.
42. Тэд (эн зэрэгцүүлэгч буруу номтнууд): “Хэрэв бидэнд нэгэн сэрэмжлүүлэгч (гэгээн элч) ирэх аваас, аливаа нэгэн ардуудаас илүүтэйгээр зөв шулуун зам дээр байх болно” хэмээн Аллахад мундаг андгайлан тангарагласан билээ. Гэвч өөрсдөд нь сэрэмжлүүлэгч (Мухаммед) ирэхүйд мөн л зайлсхийн одов.
43. Тэд хаа сайгүй бардамнан, муу заль зохиосон юм. Муу санаа эзнээ отож, тэд ухсан нүхэндээ өөрсдөө унав. Тэд урьд өмнөхүүдийн (сүйрч, гэсгэгдэн цэрлэлтэй учирсан) замаас өөр юмыг хүлээж байсан юм уу? Чи Аллахын заасан замын ямарч өөрчлөлтийг олж чадахгүй. Тэрчлэн чи Аллахын тодорхойлсон замын солигдохыг (хэн нэгний гэсгээл нөгөө хүнийхээр солигдож будилахыг) олж харахгүй.
44. Тэд газар дэлхийг хэрэн хэсүүчлэхдээ өөрсдөөс нь өмнөхүүдийн хувь заяа хэрхэн төгссөнийг хараагүй юм гэж үү дээ? Үнэндээ тэд, эд нараас ч илүү хүчирхэг байсан шүү дээ. Тэнгэр, газрын алинд ч Аллахыг сул дорой болгох ямар ч хүч үгүй шүү дээ. Тэр бүхнийг гарцаагүй мэдэгч, алив бүхэнд хүч чадал нь хүрэгч бөлгөө.
45. Хэрэв, Аллах хүмүүсийг хийсэн хэргээр нь нэгэн зэрэг хүйс тэмтрэх юм бол газар дэлхий дээр ямар ч амьд амьтан үлдэхгүй байсан биз. Гэвч Аллах тэдний гэсгээлийг тодорхой хугацаагаар хойшлуулна. Тооцоо бодох хугацаа ирмэгц тэднийг хийсэн хэргийн хэр хэмжээгээр цээрлүүнэ. Аллах үнэхээр боолуудаа харж, хянаж байдаг юм.



Мекке-д илгээгдсэн. 83 айлдвар.

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Ясин
2. Мэргэн ухаанаар дүүрэн Куранаар андгайлая.
3. (Аяа, Мухаммед) Чи ямар ч эргэлзээгүй гэгээн элч нарын нэгэн мөн.
4. Чи зөв шулуун зам дээр байна.
5. Аугаа эрхэмсэг, машид энэрэнгүй Аллахын буулгасан Кураны заасан зам дээр байна.
6. Өвөг дээдэс нь урьдчилан сэрэмжлүүлэгдээгүй, анзаараагүй үлдсэн нэгэн ардуудад сэрэмжлүүлэхийн тулд буулгагдсан.

7. Тэдний олонхи нь гэсгээл хүртэх ёстой байв. Учир нь тэд сүсэглэн итгээгүй юм.
8. Бид тэдний хүзүүнд (эрүүнд тултал) дөнгө зүүсэн билээ. Тийм болохоор тэд мэхийн мөргөх боломжгүй, толгой нь дээшээ гэдийсэн хэвээр үлдэнэ.
9. Бид тэдний урдаас нь нэгэн, араас нь бас нэгэн хашлага босгож, нүдийг нь хаасан юм. Ийнхүү, шүтэн бишрэх зам нь хаагдсан тул тэд юуг ч олж харахгүй.
10. Тэднийг урьдчилан сэрэмжлүүлсэн ч, сэрэмжлүүлээгүй ч нэгэн адил, сүсэглэн залбирахгүй.
11. Чи гагцхүү Кураны айлдварт уярсан, энэрэлт Эзэнтнээ хараагүй ч итгэсэн, айж эмээсэн хүмүүст л сэрэмжлүүлж чадах болно. Тэднийг ивээн тэтгэгдэх болсноор нь, үнэт шагналаар нь (диваажингаар) баярлуулагтун.
12. Бид эргэлзээгүй үхэгсэдийг дахин амилуулна. Тэдний өмнөх болон дараачийн хийсэн бүхнийг бичсэн баймуй. Бид алив бүхнийг яруу тод нэгэн сударт (Лаухил Махфуз-д) тоолж нэг бүрчлэн бүртгэсэн буй.
13. (Аяа, Мухаммед!) Тэдэнд, нэгэн цагт элч нар ирсэн (Антакия) хотын иргэдийг жишээ болгон хэлж өг.
14. Тухайн үед Бид тэдэнд хоёр элчээ илгээсэн билээ. Гэвч тэд хоёуланг хүлээн зөвшөөрөөгүй юм. Бид гурав дахь элчээ илгээн тэр хоёрт туслалцуулав. Бидний элч нар : “Бид та нарт илгээгдсэн Аллахын жинхэнэ элч нар шүү дээ!” гэв.
15. Тэд: “Та нар бидэнтэй адилхан жирийн хүмүүс юм. Нигүүлсэгч Эзэнтэн ямар нэгэн зүйл буулгаагүй. Та нар үндэсгүй худлаа ярьж байна” гэлцэв.
16. Элч нар : “Эзэнтэн маань мэдэж байгаа, бид ямар ч эргэлзээгүй та нарт илгээгдсэн элч нар мөн” ;
17. “Бидний үүрэг бол ил тод байдлаар Аллахын зарлигийг та нарт бүрэн хүргэх явдал” хэмээн хэлэв.
18. (Буруу номтнууд) : “Та нар бидэнд муу ёр шүглэн ирцгээлээ. Хэлснээсээ үл буцах аваас эргэлзээгүй бид та нарыг чулуугаар нүдэх бөгөөд бидний зүгээс зовлонт гэсгээл хүртэх болно” гэв.
19. Элчүүд: “Муу ёр та нартай цуг зайлах болтугай. Та нарт сургамжилж байгаа нь муу ёр гэж үү? Тийм биш ээ! Үнэндээ та нар хэрээс хэтэрсэн улс байгаа” гэв.
20. Тэгэхүйд хотын нөгөө захаас нэгэн хүн (Хабиб Нажжар) гүйж ирээд: “Аяа, ард түмэн минь! Энэ элчүүдийг дагацгаагтун” ;
21. “Зөв шулуун замыг олсон, бишрэн сүсэглэхэд уриалж, та нараас ямар нэгэн хариу хөлс нэхэхгүй эдгээр элч нарыг дагацгаагтун” ;

22. “Би яахлаар өөрийг минь бүтээсэн, та нар өмнө нь очиж сөгдөх ёстой Аллахад бишрэн сүсэглэхгүй билээ?” ;
23. “Би Түүнээс өөр бурханыг тахин шүтэхэд Аллах намайг нэгэн хор уршигтай учруулбал, зохиомол бурхадын өмөөрөл надад ямар ч ашиг тус болохгүй, аварч ч чадахгүй” ;
24. “Тэгсэн бол би илэрхий төөрөгдөлд орох болно”;
25. “Би маргаанүй та нарын Эзэнтэнд сүсэглэн итгэлээ. Намайг сонсогтун” хэмээн уриалав.
26. (Ийнхүү хэлсний төлөө харгис этгээдүүд түүнийг чулуугаар нүүлгэн хөнөөв.) Бид түүнд: “Алив, Диваажинд орогтун!” хэмээн далдаас зарлиг буулгав. Энэ хүн (Хабиб Нажжар) : “Аяа, миний зон олон! Хүмүүс мэдсэн ч болоосой” ;
27. Эзэнтэн минь намайг юуны төлөө энэрэн өргөмжилснийг мэдсэн ч болоосой!” хэмээн өгүүлэв.
28. Бид дараа нь түүний ард олонд тэнгэрээс цэрэг дайчид (мэлэкууд) илгээсэнгүй. Бидэнд илгээх хэрэгцээ ч байсангүй.
29. Гагцхүү аймшигтай орь дуугаар тэд гэнэтхэн үгүй болсон юм.
30. Өөрсдөд нь ирсэн гэгээн элч нарыг элэг доог болгон доромжилсон боолууд юутай харамсалтай гээч!
31. Тэд (Меккегийн оршин суугчид) Өөрсдөөс өмнө хичнээн хүнийг (эсэргүүцсэн учир) хөнөөснийг, тэд нар нь хэзээ ч эд нарт буцаж ирэхгүйг ухаарахгүй юм гэж үү?
32. Мэдээж тэд бүгдээрээ (ертөнцийн төгсгөлийн өдөр) Бидний өмнө цугларах болно.
33. Үхмэл газар тэдний хувьд нэгэн чухал бэлгэдэл нотолгоо бөлгөө. Бид түүнийг амилуулж, дээр нь тэд хүнсэнд хэрэглэх тариа ургуулмуй.
34. Мөн тэнд хасарваань, усан үзмийн цэцэрлэгүүд бий болгож, дундуур нь булаг урсгасан билээ.
35. Тэд Аллахын буй болгосон үр жимс хийгээд өөрсдийн гараар бэлдсэн зүйлийг идэцгээг хэмээн ийм болгосон ажгуу. Тэд үүнд талархахгүй юм гэж үү дээ!
36. Газар дээр ургуулсан бүхнийг, тэдний өөрсдөө хараахан мэдээгүй зүйлийг хос хосоороо бүтээсэн Аллах дутагдлаас ангид билээ.
37. Тэдэнд шөнө ч гэсэн нэгэн сургамжит бэлгэдэл мөн. Хэрэв тэднээс өдрийг салгавал түнэр харанхуйд үлдэх билээ.
38. Нар бол тодорхой хязгаарын хүрээнд хөвнө. Энэ нь ялгуулсан алдарт, эрдмийн эзэн Аллахын товлосон хувь заяа мөн.
39. Бид сарны хувьд өөрчлөгдөх хугацааны хоорондын хэмжээг тодорхойлов. Тэр хасарваань модны мөчрийн хатсан адил хавирган хэлбэр олж, эцэст нь битүүрнэ.

40. Нар сарыг гүйцэн нийлэх, шөнө өдрийг гүйцэх боломжгүй. Тус бүр нь тодорхой орон зайд хөвнө.
41. Бид тэдний (сүсэглэгсдийн) үр садыг (гэгээн элч Нухын) хөлөг онгоцонд дүүртэл суулгасан нь тэдний хувьд нэгэн том сургамж байсан юм.
42. Мөн тэдэнд уг хөлөг онгоцтой адил өөр уналгыг бүтээсэн билээ.
43. Хэрэв, Бид хүсэх аваас тэднийг усанд живүүлнэ. Тэгвээс, тэдэнд ямар ч өмгөөлөгч олдохгүй, тэд хэзээ ч эс аврагдмуй.
44. Үүнээс гадна тэднийг товлосон хугацаа хүртэл амьд ахуйн буян хишгээр ивээн тэтгэж, энэрэн хайрласан юм шүү дээ.
45. Тэдэнд: “Эзэнтний энэрэлд багтахын тулд өмнөх ба хойдох (амьд ахуйн ба хойд насны) гэгсгээлээс сэрэмжлэгтүн” хэмээн сануулсан билээ.
46. Эзэнтний айлдваруудаас аливаа нэгэн айлдвар ирэхэд тэд түүнээс нүүр буруулцгаасан юм.
47. Тэдэнд : “Аллахаас та нарт хувь хишиг болгон хайрласныг сайн үйлсийн төлөө зарцуулагтун (ядууст өглөг өгөгтүн)” хэмээхэд буруу номтнууд үнэн сүсэглэгсдэд хандан : “Аллах таалан болгоохуйд хооллох хэн нэгнийг бид л хооллуулах гэж үү? Та нар үнэхээр илэрхий төөрөлдсөн байна шүү” гэнэ.
48. Тэд: “Хэрэв та нар үнэнч юм бол үнэхээр, тэр сүрдүүлэг чинь хэзээ тохиох вэ?” хэмээн асууна.
49. Ийнхүү тэд (хорвоогийн ашиг хонжоо болон бусад асуудлаар) маргалдаж байхдаа өөрсдийг нь гэнэтхэн нэрвэх аймшигтэй нэгэн орь дуу хүлээж байдаг.
50. Тэр мөчид тэд гэрээслэл үлдээх, гэр рүүгээ буцах ч боломж олдохгүй.
51. Сур буюу бишгүүр бүрээ үлээгдэхэд, тэд булшнаасаа босож Эзэнтэн рүүгээ гүйцгээнэ.
52. Тэд: “Ээ чааваас! Биднийг мөнхийн нойрноос хэн сэрээчихээ вэ?” гэлцэнэ. Энэрэн нигүүлсэгч Аллахын амлалт нь энэ шүү дээ. Гэгээн элч нар үнэнийг хэлсэн байгаа биз дээ!” хэмээн мэлэкүүд хэлнэ.
53. Энэхүү аймшигтай орь дуу сонсогдмогц тэд бүгд Бидний өмнө даруйхан цугларах болно.
54. Тэр өдөр хэнд ч өчүүхэн төдий ч шударга бус зүйл хийгдэхгүй. Та нар зөвхөн хийсэн үйлийнхээ хариуг л хүртээмүй.
55. Тэр өдөр диваажингийнхан хөгжилдэн баясах болно.
56. Тэд болон хань ижлүүд нь сүүдрийн сэнтийд залран тухламуй.
57. Тэнд тэдний төлөө төрөл бүрийн жимс болон хүссэн бүхэн нь байх болно.



58. Мөн тэдэнд машид энэрэгч Алладын “Амар байцгаана уу?” хэмээх мэндчилгээ ирнэ.
59. “Аяа, нүгэлтэнгүүд ээ! Алив өнөөдөр ялгаран, салцгаагтун.
60. “Аяа, Хүмүүний үр сад аа! Би та нарт чөтгөр шуламд бүү мөргөгтүн. Тэр бол та нарын илт дайсан юм шүү дээ” хэмээн андгайлан хэлээгүйсэн билүү?
61. Зөвхөн надад мөргөн залбирцгаагтун. Зөв шулуун зам бол энэ мөн” хэмээн хэлээгүйсэн билүү?
62. Чөтгөр шулам үнэндээ та нарын олон ардыг хуурч төөрөгдүүлсэн. Үүнийг ухаарахгүй юм гэж үү?
63. Та нарт амлагдсан халуун там бол энэ мөн!
64. Буруу номтон болсны хариуд одоо тийшээ орцгоогтун.
65. Тэр өдөр Бид тэдний амыг нь үдмүй. Бидний өмнө тэдний гар нь ярьж, хийсэн хэрэгт нь хөл нь гэрч болно.
66. Хэрэв Бид хүсвэл тэднийг сохор болгох байсан. Тэгвээс тэд зөв зам олохын төлөө зүтгэнэ. Гэвч хэрхэн харах билээ дээ?
67. Хэрэв, Бид хүсвэл тэдний дүр төрхийг зогссон газар дээр нь (сармагчин, гахай, чулуу зэргээр) өөрчлөх байсан. Тэгээд тэд урагшаа ч, хойшоо ч явж эс чадах байсан билээ.
68. Бид хэн нэгэнд урт нас заяавал, түүнийг хүүхэд, идэр залуу, хөгшин болгосоор л бие мах бодийг нь сулруулмай. Тэд үүнийг ухаарахгүй юм гэж үү дээ?
69. Бид түүнд (гэгээн элчид) дуу шүлэг зааж сургаагүй. Угаасаа түүнд үл зохимой. Түүнд гагц сэнхрүүлгэ, яруу тод Кураныг айлдан сургасан юм шүү дээ.
70. Энэ нь амьд бүхэнд сэрэмжлүүлэг, буруу номтнуудад гэсгээлийн чин үнэн болохыг мэдүүлэн ухуулахын төлөө болой.
71. Бид сүр хүчээрээ тэдний төлөө адгуус амьтадыг бүтээснийг, тэдгээрийг өөрсдөө эзэгнэн эрхшээж байгааг мэддэггүй юм уу?
72. Бид адгуус амьтадыг номхон болгож тэдэнд эзэмшүүлсэн. Тэд заримыг нь уналга болгон, заримыг нь хүнсэндээ хэрэглэдэг бөлгөө.
73. Энэ амьтдад тэдний хувьд их ашиг тус, уух ундаа (сүү) буй. Тэд энэхүү буян хишигт яагаад талархадаггүй юм бэ?
74. Тэд ямар нэгэн ашиг тус өгөх байх хэмээн горьдож, Аллахаас ондоо бурхадыг гараараа хийгээд авцгаасан.
75. Тэр бурхад нь тэдэнд туслах чадваргүй аж. Харин ч тэдний эсрэг бэлтгэгдсэн зүйл болой. (Ертөнцийн төгсгөлийн өдөр тэдний гэмт хэргийг гэрчлэн, гэсгээгдэхэд нэрмээс болно.)

76. (Аяа, Элч минь!) Тэдний үг чамайг бүү гутрааг. Бид тэдний ил далд хийсэн бүхнийг мэднэ.
77. Бид хүмүүсийг үрийн ганц дуslaар бүтээснийг тэд мэддэггүй юм уу? Одоо тэд Аллахыг илэрхий эсэргүүцэх боллоо.
78. Тэд өөрсдийн хэрхэн бүтээгдсэнийг умартаж, Бидэнд хүмүүсийн амьд ахуй болон, хувхай ясыг жишээ болгохыг оролдож байна. “Энэ хувхай ясыг хэн дахин амилуулах вэ?” хэмээнэ.
79. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Анхлан бүтээгч нь дахин амилуулна. Тэр бүхий л амьдрал ахуйг сайн мэднэ” хэмээн хэлэгтүн.
80. Аллах та нарын төлөө ургаа модноос галыг гаргасан. Та нар ийнхүү мод галлахыг мэдсэн.
81. Тэнгэр, газрыг бүтээгч нь тэдгээрийн адилыг бүтээж чадахгүй гэж үү дээ? Гиймээ чадна. Тэр алив бүхнийг мэдэгч, онцгой бүтээгч билээ.
82. Аллах аливаа юмыг бүтээхийг хүсвэл, ердөө л “Болтугай” хэмээхэд хангалттай. Тэгээд л ёсоор болдог юм.
83. Бүхий л эрх мэдэл өөрийн гарт (эрхшээлд) нь буй, тэгээд ч та нар өмнө нь эргэж очих Аллах дутагдлаас ангид бөгөөд аугаа алдар цууны эзэн мөн.



Мекке-д илгээгдсэн. 182 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Зарлигийг хүлээн гадаа жагссан,
2. Үүлсийг хөөн зайлуулсан,
3. (Аллахаас дэмжлэг хүсэн) айлдвар уншиж буй элч мэлэкүүдийн алдраар андгайлав.
4. Та нарын бурхан цор ганц.
5. Тэр тэнгэр, газар хийгээд тэдгээрийн хооронд буй бүхний Эзэнтэн мөн. Тэрчлэн өрнө дорнын Эзэнтэн мөн.
6. Бид ойрын тэнгэрийг одоор чимэглэсэн билээ.
7. Тэдгээрийг хэрээс хэтэрсэн үймүүлэгч чөтгөр шуламаас хамгаалсан юм.
8. Тэд тэнгэрт буй элч мэлэкүүдийн үгийг чагнаж эс чадмуй. Тэд тал бүрээс галтай одоор буудагдаж адлан хөөгдөнө.
9. Тэдэнд хойд ертөнцийн салшгүй гэгсгээл зориулагдсан.

10. Тэнгэр дэх дээдсийн үгийг (мэлэкүүдийн үгийг) хулгайгаар сэмхэн сонсогчдыг галт одод хөөн зайлуулна.
11. (Аяа, Мухаммед) Тиймээс тэднээс асууцгаа! Тэднийг буй болгон бүтээж, үхсэний дараа дахин амилуулах хэцүү гэж үү? Эсвэл Бидний буй болгосныг бүтээхэд хэцүү юм уу? (Тухайлбал: тэнгэр, газар, элчүүд, аварга биетнүүдийг бүтээх нь) Бид үнэндээ тэдний уг болох Адам эцгийг шавраар бүтээсэн шүү дээ.
12. Үгүй ээ, чи гайхахад тэд чамайг доог тохуу болгосон.
13. Ухуулга сургамж өгөгдсөн ч тэд хүлээн аваагүй юм.
14. Ганц нэгэн ер бусын нотолгоо гайхамшигийг үзсэн ч түүнийг доог тохуу болгоцгоосон.
15. Тэд : “Энэ бол илэрхий илбэ юмаа”...
16. “Бид үхэж, шороо хувхай яс болчихсон хойноо дахин амилах юм гэж үү дээ?”
17. “Бидний өвөг дээдэс ч дахин амилах юм гэж үү?” хэмээн хэлцгээсэн.
18. (Аяа, Мухаммед!) Тэдэнд : “Тийм ээ, та нар шившиг болон дахин амилцгаана” гэж хэлэгтүн.
19. Тэд нэгэн аймшигтай орь дууг (Исрафил мэлэкийн татсан бүрээний дууг) сонсонгуут хойд ертөнцөд цугларан, өөрсдөө үзэх гэгсгээлээ хүлээн, эргэн тойрноо харцгаана.
20. (Тэр мөчид үл сүсэглэгсэд) : “Ээ халаг! Энэ нь нөгөө шүүн гэгсгээх өдөр юм байна шүү дээ!” хэмээн халаглана.
21. (Тэдэнд): “Ийнхүү энэ чинь, та нарын худал хэмээж асан шүүн тунгаах өдөр чинь шүү дээ” хэмээн хэлэгдэнэ.
22. Аллах мэлэкүүдэд: “Харгис зальхайчуудыг, тэдний хамсаатан нарыг, түүнчлэн Аллахаас өөр тахин шүтэж байсан бурхадыг нь цуглуулагтун.
23. Тэдэнд халуун тамын замыг зааж өгөгтүн.
24. Гэхдээ тэднийг түр саатуулагтун. Яагаад гэвэл тэд байцаагдах учиртай юм” хэмээн тушаана.
25. Тэдэнд: “Та нар бие биендээ туслахгүй юм уу?” хэмээн хэлэгдэнэ.
26. Тийм ээ, тэд өнөөдөр хүлцэнгүй болцгоосон.
27. Тэд бие биетэйгээ нүүрэлдэн маргацгаана.
28. Аялдан дагагсад толгойлогсод хандан: “Та нар андгай тангараг өргөн биднийг уруу татаж, албадсан биз дээ” гэлцэнэ.
29. Толгойлогсод нь : “Үгүй ээ, та нар өөрсдөө сүсэглээгүй шүү дээ” гэж хариулна.
30. “Бид та нарыг албадах чадалгүй байсан. Та нар угаасаа төөрөлдөгсөд байсан шүү дээ”,

31. “Эзэнтний бидэнд хэлсэн үг нь үнэн болж таарлаа. Үнэндээ бид хэлсэн ёсоор нь гарцаагүй гэсгээгдэх улс юм”,
32. “Бид та нарыг урвуулжээ. Бид өөрсдөө ч үнэхээр төөрөлдсөн юм” гэв.
33. Ийнхүү тэд тэр өдөр хамтдаа гэсгээн цээрлүүлэгсэд болой.
34. Бид нүгэлтэнгүүдийг ийнхүү шийтгэнэ.
35. Тэд үнэхээр тийм л байсан: “Аллахаас өөр бурхан үгүй” хэмээн сануулахад үл тоомсорлосон билээ.
36. Тэд : “Орон гаран нэг найрагчийн үгэнд итгэж, угаасаа шүтэж ирсэн бурхадаа хөсөр хаях гэж үү?” хэмээдэг байлаа.
37. Тийм биш ээ. Тэр (Мухаммед) чин үнэн шашин авч ирсэн. Мөн гэгээн элчүүдийг багатгасан билээ.
38. Өнөөдөр та нар хатуу гэсгээлийн амтыг үзэх болно.
39. Та нарын амсах гэсгээл гагцхүү үйлдсэн хэргийн хэмжээгээр оногдоно.
40. Гагцхүү Аллахын үнэнч боолууд л гэсгээлээс чөлөөлөгдөнө.
41. Тэд тодорхой хувь хишиг хүртэнэ.
42. Төрөл бүрийн жимсээр дайлагдан хүндлэгдэнэ.
43. Буян хишгийн цэцэрлэгт (Нагим хэмээн диваажингийн оронд) ,
44. Тэд хүндэтгэлийн сэнтийд заларцгаана.
45. Тэднийг булгийн ариун усаар дүүргэсэн аяга барин угтана,
46. Тэрхүү тунгалаг ус ташаан уугсад цэнгэлийг эдлэнэ.
47. Толгой өвтгөхгүй, согтоодоггүй цагаан дарс мэлтэлзүүлсэн аягыг тасралтгүй барина.
48. Тэдний хажууд нь урьд өмнө хэний ч шунан ширтээгүй, тоос хүргэмгүй, хархан нүдтэй гоо бүсгүйчүүд байх болно.
49. Тэдний царай нь өндөг мэт өөгүй, ариун цагаан байх ажээ.
50. Диваажинд заларагсад бие биедээ элгэмсүү хандаж, хүүрнэлдэнэ.
51. Тэдний нэгэн : “Миний нэгэн найз байсан билээ;
52. Тэр надад хандан: “Чи үнэхээр сүсэглэн итгэгсдийн нэгэн юм уу?”
53. Бид үхээд өмхий шороо, хувхай яс болсон хойноо ч дахин амилж тооцоо бодогдох гэж үү?” гэдэгсэн.
54. Түүнтэй уулзаад үзэх үү? Түүний байр суурь ямар байгаа болоо?” хэмээн хажуугийнхаа хүнд хэлэв.
55. Тэр ийнхүү ярьж, эргэн тойрноо ажигласнаа өнөөх буруу номтон найзаа тамын голоос олж хараад :
56. Аллах өршөөх болтугай! Чи намайг ч хөнөөх шахсан байна шүү дээ” гэв.

57. Хэрэв Эзэнтний маань хайр энэрэл үгүй сэн бол, би ч халуун тамд орогсодын нэг нь болох байж л дээ”.
58. Бид үүнээс хойш үхэхгүй юм уу?
59. Энэ бол бидний эхний үхэл. Амилсны дараа дахин үхэхгүй. Гэсгээгдэх ч үгүй.
60. Энэ бол диваажинд орогсодын олсон буян хишиг, үнэнхүү аз жаргал мөн.
61. Сайн үйл үйлдэгсэд ийм л аврал, аз жаргалын төлөө үйлдэцгээг.
62. Одоо тэгвэл аль нь өлзийтэй вэ? Энэхүү дайллага ба эсвэл Заккум модын аль нь дээр вэ?
63. Бид энэхүү Заккум модыг харгис зальхайчуудыг хойд насанд нь гэсгээхийн тулд бүтээсэн юм.
64. Тэр бол тамын ёроолд ургадаг мод бөлгөө.
65. Түүний үр жимс нь яг л чөтгөр шуламын толгойтой адил болой.
66. (Тамынхан) Түүнээс идэцгээж, гэдэсээ дүүргэнэ.
67. Түүний араас нь идээ бээрээр найруулсан буцлам халуун ус уулгана.
68. Дараа нь тэдний очих газар нь баттай халуун там билээ.
69. Тэд үнэхээр өвөг дээдсээ төөрөлдсөн хэмээн үзсэн юм.
70. Эцэст нь тэрхүү өвөг дээдсийнхээ зам мөрөөр гүйцгээлээ.
71. Тэдний өмнөхүүдийн олонхи нь төөрөгдөлд автсан билээ.
72. Үнэндээ Бид тэдэнд ч сэрэмжлүүлэгсдийг илгээсэн юм.
73. Өмнөх сэрэмжлэгдэгсдийн төгсгөл хэрхэн дууссаныг нэг харцгаа!
74. Алладын чин үнэнч сүсэгтэн боолууд л гэсгээлээс ангид оршимой.
75. Нух Бидэнд очиж залбирсан юм. Харин Бид залбиралыг хамгийн сайхнаар хүлээн авагч билээ!
76. Бид өөрийг нь болон түүний гэр бүлийг том аюулаас (усанд живэхээс) аварсан.
77. Нухын үр удмыг үл таслан аж төрүүлэв.
78. Хойч үеийнхний дунд Бид түүнийг алдаршуулсан.
79. Дэлхий даяар гэгээн элч “Нухын амарыг айлтгая” хэмээх талархлыг үлдээв.
80. Бид сайн үйл үйлдэгсэдийг ийнхүү шагнаж урамшуулдаг юм.
81. Нух бол үнэхээр төгс сүсэглэгч нарын нэгэн билээ.
82. Нухаас бусад түүний буруу номтон хүмүүсийг нь усанд живүүлсэн юм.
83. Ибрахим ч түүний (Нухын) зам мөрийг дагагсадын нэгэн байлаа.
84. Учир нь Ибрахим бол Эзэнтэндээ ариун сэтгэлээрээ ирсэн хүн байв.

85. Тэр үед Ибрахим эцэг хийгээд ард олондоо хандан: “Та нар ямар юмыг тахин шүтэж байна вэ?
86. Аллахаас ондоо хуурамч бурхадыг тахин шүтдэг юм уу?
87. Уул шугамандаа ергөнцийн Эзэнтний тухайд ямар бодолтой байна вэ?” гэв.
88. Ибрахим одод руу нэг харснаа:
89. “Миний бие муу байна” гэв.
90. Ардууд нь ар нуруугаа харуулан зайлан одоцгоов.
91. Ибрахим тэдний бурхадын дэргэд ганцаараа очоод хошигнон : “(тэнд тавигдсан хоол хүнсийг хармагцаа) “Та нар яагаад иддэггүй юм вэ?”
92. Та нар яагаад ярьдаггүй юм бэ?” гэв.
93. Улмаар дөхөж ирээд баруун гараараа хүчтэй цохиж, тэдний хиймэл бурхадыг хагалсаар байлаа.
94. Ардууд нь түүнийг үзээд Ибрахим рүү яаран гүйцгээж ирлээ.
95. Ибрахим тэдэнд : “Та нар өөрсдийн гараар хийгээд авсан зүйлсэд шүтэн мөргөдөг юм уу?
96. Үнэндээ та нарыг ч, та нарын гараар хийсэн зүйлийг ч Аллах бүтээсэн шүү дээ” гэв.
97. Тэд: “Ибрахимд зориулан байшин (том зуух) баригтун. Түүний дотор гал түлэн, дүрэлзэн асахад Ибрахимыг түүнд шиддэгтүн!” хэмээн шуугилдав.
98. Тэд Ибрахимыг гал руу шидэж хорлохыг оролдов. Гэвч Бид Ибрахимыг аварч, тэднийг мухардуулав.
99. Ибрахим: “Би Эзэнтнийхээ тушаасан зүг рүү явна. Тэр намайг зөв шулуун замаар хөтлөнө” гэв.
100. Тэрбээр санасан газартаа очсон хойно: “Аяа, Эзэнтэн минь ээ! Надад нэгэн хүүхэд хайрлаач!” хэмээн залбирав.
101. Бид түүнд дөлгөөн хүү хайрлан баярлууллаа.
102. Хүү Исмайл нь ухаан суусан цагт Ибрахим (аав нь) түүнд : “Аяа хайрт хүү минь! Би чамайг алж Эзэнтэндээ өргөл болгон барихаар тушаагдлаа хэмээн зүүдэллээ. Гэгээн элчийн зүүд бодит биелэлээ олдог юм. Чи энэ тухайд юу бодож байна вэ? Бодогтун” гэв. Хүү нь : “Аяа, аав аа! Чамд юу тушаагдсаныг ёсоор нь гүйцэтгэгтүн. Аллах тийн таалсан бол намайг хатамжит тэвчээртэнгүүдийн эгнээнээс олох болно.” хэмээн хариулав.
103. Тэгээд хоёулаа Аллахын зарлигийг дагаж, Ибрахим хүүгээ хажуудуулан хэвтүүлэн хоолойг нь огтлох гэж оролдовч хутга нь даасангүй.
104. Бид түүнд : “Аяа, Ибрахим!

105. Зүүдээ ёсоор болголоо. Бид эрхэмсэг хүмүүсийг ийнхүү шагнаж урамшуулдаг” хэмээн дуугарав.
106. Энэ бол том сорилт билээ.
107. Бид хариуд нь түүнд нэгэн том өргөлийн мал (диваажингаас нэгэн хуц) хайрлаж аврав.
108. Хойч үеийнхний дунд Бид түүнийг алдаршуулав.
109. Мөн “Ибрахимын амарыг айлтгая” гэсэн хүндэтгэлийг бэлгэдэл болгов.
110. Бид сайн эрхэм хүмүүсийг ийнхүү шагнаж урамшуулдаг болой.
111. Учир нь тэр Бидний үнэн сүсэглэгч боолуудын нэгэн байлаа.
112. Тэгээд Бид гэгээн элчүүдийн эрхэмийн нэг болсон Исхакийг түүнд (Ибрахимд) хайрласан баярт мэдээг дуулгасан билээ.
113. Бид Ибрахим, Исхак хоёрт шашин ба эд баялагийн хишгийг зориулав. Харин тэр хоёрын үр удмаас буянтай сайн үйл үйлдэгчид ба өөрсдөд нь илэрхий муу юм үйлдэх зальхай этгээдүүд ч гарах байлаа.
114. Бид Муса, Харун хоёрт гэгээн элч байх өндөр алдрыг хайрлав.
115. Бид тэднийг болон ард түмнийг нь (израйлын үр садыг) том аюулаас (Фиргауны боолчлолоос) аварсан билээ.
116. Тэднийг дэмжин туслахуйд ялалт байгуулсан юм.
117. Тэр хоёрт нэн ойлгомжтой Таурат судрыг олголоо.
118. Мөн хоёуланг нь зөв шулуун зам руу хөтөлсөн.
119. Хойч үеийнхэнд тэр хоёрын тухай алдар хүндийг үлдээсэн болой.
120. Муса, Харун хоёр амар амгаланг олтугай.
121. Бид эрхэм хүмүүсийг ийнхүү шагнаж урамшуулдаг юм.
122. Тэд хоёулаа Бидний үнэнч сүсэгтэн боолуудын нэгэн мөн.
123. Илияс ч гэгээн элч нарын нэгэн билээ.
124. Тухайн үед тэр ард олондоо хандан: “Та нар Аллахаас айдаггүй юм уу?”
125. Хамгийн шилдэг бүтээгч Аллахыг хөсөр орхиж, Багылыг (алтаар цутгасан хиймэл бурханыг) тахин шүтэцгээх гэж үү дээ?
126. Аллах та нарын ч, та нараас өмнөх өвөг дээдсийн чинь ч Эзэнтэн мөн.” хэмээн ухуулав.
127. Зон олон нь түүнийг худалч хэмээн үгүйсгэв. Тиймээс тэд там руу илгээгдэхээс өөр аргагүй болов.
128. Аллахын чин үнэнч сүсэгтэн боолуудын хувьд өөр л дээ.
129. Хойч үеийнхэнд Илиясын алдрыг мөнхжүүлэв.
130. “Илияс амар амгаланг олтугай” гэсэн хүндэтгэлийг үлдээв.
131. Бид эрхэм сайн хүмүүсийг ийн шагнаж урамшуулдаг юм.
132. Тэр бол Бидний үнэн сүсэглэгч боолуудын нэгэн байлаа.

133. Лут ч гэгээн элч нарын нэгэн байсан билээ.
134. Бид тухайн үед Лут хийгээд түүний гэр бүлийн бүгдийг аварсан юм.
135. Ард үлдэгсдийн дунд зөвхөн настай нэгэн эмэгтэй (Лутын эхнэр) байсан юм.
136. Дараа нь Бид ард үлдэгсдийг нь хүйс тэмтэрсэн.
137. (Аяа, Меккегийн иргэд ээ!) Та нар тэр газраар өглөө бүр дайран өнгөрдөг.
138. Орой ч гэсэн дайрч буй. Үүнийг эс ухаарцгаах юм гэж үү?
139. Үнэндээ Юнус ч гэгээн элч нарын нэгэн билээ.
140. Тэр цагт Юнус ард олноосоо дайжин зугтаж, ачаа тээвэрлэсэн усан онгоцонд сууж амжсан юм.
141. Хөлөг онгоцны ачааг хөнгөлөх зорилгоор шоо хаялцахад Юнус хожигдож, өөрийн эрхгүй тэнгис рүү үсрэн унав.
142. Түүнийг аварга том загас залгиж орхилоо. Юнус: “Ард олноо орхин Аллахын зарлигаас гадуур явсан учир ийнхүү шийтгүүллээ” хэмээн өөрийгөө муулаж байлаа.
143. Хэрэв тэр Аллахыг санан дурсагсадын нэгэн биш байсан бол,
144. Дахин амилах өдөр хүртэл загасны гэдсэнд үлдэх байсан юм.
145. Бид түүнийг загасны аманд зуулган эрэг дээр гаргаж авлаа. Юнус тэр үед өвчтэй байлаа.
146. Бид түүний сүүдэрлэж байхын тулд аварга том хулууг ургуулав.
147. Тэгээд Бид түүнийг зуун мянга эсвэл түүнээс ч илүү олон ардад гэгээн элчээр илгээлээ.
148. Эцэст нь тэд амлагдсан зовлонг үзэж байж сүсэглэн итгэсэн юм. Бид тэднийг тодорхой хугацаа хүртэл ивээн тэтгэсэн болно.
149. (Аяа, Мухаммед!) Тэднээс (Меккегийн оршин суугчдаас): “Охидууд Эзэнтнийх, харин хөвгүүд та нарынх юм уу?” хэмээн асуугтун.
150. Үгүй бол Бид элч мэлэк нарыг охид болгон бүтээснийг тэд харж байсан гэж үү?
151. Мэдтүгэй! Тэд илэрхий худлаа хэлдэг юм шүү.
152. “Аллах хүүхэдтэй” гэж ярьдаг тэд жинхэнэ худалчид мөн.
153. Аллах охидыг хөвгүүдээс илүү дээдэлсэн болж байна уу?
154. Та нар яачихаа вэ? Яахлаар ийм шийдвэр гаргадаг юм вэ?
155. Яагаад тунгаан боддоггүй юм вэ?
156. Үгүй бол, Аллах хүүхэдтэй гэдгийг гэрчлэх нотолгоо та нарт байна гэж үү?
157. Та нар үнэнч юм бол, өөрсдийн номоо үзүүлээд аль!
158. Тэд Аллах болон буг чөтгөрийн хооронд ураг төрлийн холбоо буй



- хэмээн чалчисан. Тиймээ, буг чөтгөрүүд ч тэдний тамд очихоор бэлтгэгдснийг сайн мэднэ.
159. Аллах тэдний зохиомжилсноос ангид.
  160. Аллахын чин үнэнч сүсэгтэн боолууд л зохиомол зүйл ярьдаггүй.
  161. Аяа, Буруу номтнууд! Та нар болоод та нарын тахин шүтсэн зүйлс!
  162. Та нарын аль нь Аллагаас урвуулж эс чадна.
  163. Тамд орох ёстой хэн нэгнээс бусдыг төөрөгдүүлж эс чадна.
  164. Тэгэхүйд мэлэжүүд: “Эзэнтээс минь бидэнд бэлэглэсэн орон байр буй.
  165. Бид Аллахт бишрэн залбирахаар дараалж зогсож байдаг;
  166. Бид эргэлзээгүй Аллахыг шагшин магтаагаамуй” хэмээн хэлнэ.
  167. Харин Меккегийн буруу номтнууд ийнхүү хэлнэ:
  168. “Хэрэв бидэнд өмнөхүүдийн шиг нэгэн судар байсан бол;
  169. Бид ч Аллахын чин үнэнч боолууд болох байсан!” гэлцэнэ.
  170. Хэрэг дээр тэд тэр судрыг үгүйсгэсэн юм. Хожим түүний уршгийг мэдэцгээх болно.
  171. Бид гэгээн элч-боолуудынхаа тухай ийн амлалт өгсөн болой.
  172. Ийнхүү тэд гарцаагүй Аллахын дэмжлэгийг хүлээнэ.
  173. Манай дайчид эргэлзээгүй ялалт байгуулах болно.
  174. Тийм болохоор чи нэг хэсэг (Меккегийн буруу номтнуудаас) зай барь.
  175. Чи тэднийг харзана, бэрхшээл тулгарахад тэд ч удалгүй харцгаах болно.
  176. Тэд Бидний гэсгээлийг яаран хүсэж байна гэж үү?
  177. Бидний гэсгээл тэдний хашаа байранд буухад сануулга авагсдын угтах өглөө нь юутай ёозгүй болно гээч!
  178. Тиймээс чи нэг хэсэг тэднээс зай барь.
  179. Чи тэднийг бэрхшээлтэй тулгарах үед хар, тэд ч тэр үед харцгаах биз.
  180. Аяа, Мухаммед! Сүр жавхлант Эзэнтэн чинь тэдний зохиомжилсон зүйлээс эрхэмсэг бөгөөд ангид.
  181. Гэгээн элч нарын амар амгаланг эртүгэй!
  182. Бүхий л магтаал ертөнцсийн Эзэнтэн болох Аллахад зохимой.



Мекке-д илгээгдсэн. 88 айлдвар.

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Сад. Яруу тод сануулга болох Куранаар андгайлан тангараглая.

2. Буруу номтнууд өөрсдийгөө дээдлэн эсэргүүцээр л байна.
3. Тэднээс өмнө ч эсэргүүцсэн олон хүнийг Бид мөхөөсөн билээ. Тэд уйлаан-майлаан болж зовлон амссан юм. Гэвч тэд гэсгээлээс аврагдах нь нэгэнт өнгөрсөн байлаа.
4. Тэд бас өөрсдийнх дотроос сануулан сэрэмжлүүлэгч нэгэн ирэхэд гайхацгаасан. Тэрбээр үл сүсэглэгсэд : “Энэ бол ёстой илбэчин, худалч юм!
5. Олон бурхадых цорын ганц бурхан болгох нь уу? Энэ бол үнэхээр хачирхалтай явдал.” гэлцэв.
6. Тэдний нэг хэсэг нь (Курайш овгийн дээдэс) улайран: “Гарч явцгаагтун! Өөрсдийнхөө бурхадын төлөө үнэнч байдлаа хадгалан, тэвчигтүн. Та нараас хүсэх зүйл ердөө л энэ шүү дээ;
7. Бид үүнийг өөр шашинтнаас ч (христиан) сонсоогүй жинхэнэ худал үг;
8. Бидний дотроос зөвхөн түүнд л судрыг (Куран) буулгалаа гэж үү?” гэлцэв. Үгүй ээ, Тэд миний айлдварын (Кураны) тухайд эргэлзэж буй. Тэд Миний гэсгээлийн амтыг хараахан мэдрээгүй байгаа.
9. Үгүй бол, хязгааргүй сүр жавхланта ялалтын эзэн, нэн их өгөөмөр Эзэнтний хайр энэрэлийн сан хөмрөг тэдний хажууд байна гэж үү?
10. Эсвэл тэнгэр, газар хийгээд тэдгээрийн хооронд буй бүхний эзэгнэл тэдний гарт байна гэж үү? Хэрэв тийм бол (тэнгэр эрхэсийн) замд хөөрцгөөж үзэг.
11. Тэд энэ л газарт суурьшсан эсрэг хүчнээс ялагдал хүлээсэн цэргүүд.
12. Тэднээс өмнө Нухын ард олон, Гадынхан, гадас эзэгнэгч Фиргауны зон олон ч гэгээн элч нарыг хүлээн зөвшөөрөөгүй юм.
13. Самудынхан, Лутын ард олон, Айкагийнхан ч гэгээн элч нарыг хүлээн зөвшөөрөөгүй билээ. Тэд бол гэгээн элчийн эсрэг бүлэглэл мөн.
14. Тэд бүгд гэгээн элч нарыг худал хэмээцгээсэн болохоор Миний гэсгээлийг үзэх ёстой боллоо.
15. Мөн тэд ч (Меккегийн буруу номтнууд) хойшлуулшгүй нэг удаагийн аймшигт орь дууг (Исрафилийн бишгүүрийн дууг) хүлээцгээж баймуу.
16. Тэд даажигнаж : “Эзэнтэн ээ! Бидэнд үзүүлэх гэсгээлээ тооцоо бодох өдрөөс өмнө өгөхгүй юу?” хэмээн тохуурхана.
17. (Аяа, Мухаммед!) Тэдний хэлсэн бүхнийг тэвчигтүн, Бидний хүчирхэг боол Дауидыг санагтун. Тэр Аллахад эргэлзээгүй итгэн, залбирсан юм.
18. Бид түүнд уулсыг захируулав. Уулс эрт орой түүнтэй хамт сайшаан мөргөдөгсэн.
19. Мөн шувуудыг ч түүнд захируулав. Тэд бүгд (уулс болон шувууд) Аллахад итгэсэн юм.
20. Ийнхүү Бид түүний эрх мэдлийг бэхжүүлэн, түүнд мэргэн ухаан (гэгээн

- элчийн дархлал, аугаа ухаан, цэцэн мэргэн чанар) зохистой шийдвэр гаргах ухаалаг чанар хайрласан билээ.
21. (Аяа, Мухаммед) Чамд заргалдагчдын тухай мэдээ хүрсэн үү? Тэд ханаар авирч михраб-д (мөргөл үйлдэх газар) орсон юмсан.
  22. Тэд Дауидын өмнө хүрэлцэн очтол Дауид тэднээс сэргэж орхив. Тэд Дауидад хандан: “Та бүү айгтун! Бид бол бие биетэйгээ шөргөөцөлдсөн заргалдагчид билээ. Бидэнд чин шударга үгээ хэлэгтүн. Бидэнд зөв шулуун замыг зааж өгөгтүн” хэмээн хэлцгээв.
  23. Тэдний нэг нь: “Миний энэхүү ахан дүү ерин есон эм хоньтой. Харин надад ганцхан эм хонь байтал түүнийгээ ч надад өг” хэмээн маргалдаж намайг дийлээд ам ангайлгахгүй юм” гэж гомдоллов.
  24. Дауид : “Энэ чиний ганц эм хонийг өөрийн хоньтой нийлүүлж авах зорилгоор чамайг албаджээ. Үнэндээ хамтрагсдын ихэнх нь ийнхүү нэг нэгнийхээ эрхэнд халддаг. Харин сүсэглэн итгэж, сайн үйл үйлдэгсэд үүнд хамаарахгүй. “Тэвч гэд тун цөөхүүлээ” гэв. Эцэст нь Дауид Бидний өөрийг нь сорьж буйг мэдээд Эзэнтнээсээ өршөөл гуйж, бөхийн сөгдөн мөргөсөн билээ.
  25. Бид Дауидийн алдааг өршөөсөн билээ. Дауидийн хувьд Бидний нигур дор элгэмсэг дотно байдал, сайхан ирээдүй буй.
  26. Аяа, Дауид! Бид чамайг даян дэлхийд шашны эрх мэдэлтэн болголоо. Тиймээс хүмүүсийн маргааныг шударгаар шүүж тунгаагтун. Шуналдаа бүү хөтлөгд. Эс тэгвээс Аллахын замаас төөрөлдөнө. Аллахын замаас төөрөлдөгсөдөд, ертөнцийн төгсгөлийн өдрийг мартсаны төлөө хатуу гэгсгээл баймуу.
  27. Тэнгэр, газар хийгээд тэдгээрийн хооронд буй бүхнийг Бид зүгээр л нэг дэмий бүтээгээгүй юм. Санаандгүй гэнэт бий болсон гэдэг нь үл сүсэглэгсэдийн хоосон бодол. Аяа, үл сүсэглэгсэдийн очих халуун там юутай муухай гээч!
  28. Бид, үнэнчээр сүсэглэн, сайн үйл үйлдэгсэдийг газар сайгүй үймээн самуун таригсадтай адил хэмээн үзнэ гэж үү дээ? Эсвэл гэгээн сүсэгтнүүдийг зөв замаас хазайсан буруу номтнуудтай адилтгана гэж үү дээ?
  29. (Аяа, Мухаммед!) Энэхүү Куран бол үнэнч боолуудын маань бодож эргэцүүлэхэд, ухаантнуудын сургамж авахад нь зориулан чамд буулгасан буяны судар болой.
  30. Бид Дауидад Сүлейманыг хайрласан. Тэр юутай эрхэм хүн гээч! Тэр Аллахад чин үнэнээс итгэсэн гэгээн элч билээ.
  31. Нэгэнтээ түүнд хурдан хүлэгүүдийг зааж өглөө.
  32. Тэгэхүйд Сүлейман: “Би Эзэнтнээ санан дурсахаас алгуурлан хурдан хүлэгүүдэд илүү элэгсэг ханджээ. Ийнхүү харсаар байж наран жаргачихжээ” хэмээн харамсав.

33. Улмаар : “Тэднийг (морьдыг) надад авч ирэгтүн.” хэмээн тушаав. Тэгээд морьдын хүзүү, шилбийг илэн таалснаа, алж төхөөрөн махыг нь өглөг болгон тараав. (Учир нь морьдод анхаарал тавьсаар оройн уншлага мөргөлөө умартсан юмсанжээ)
34. Бид үнэндээ Сүлейманыг сорьсон юм. Тэгээд түүний сэнтий дээр нэгэн шарилыг хаяж орхисон. Тэр үүнийг сорилт болохыг ухааран залбирав.
35. Тэр: “Аяа, Эзэнтэн минь! Намайг өршөөн соёрхогтун. Надаас хойш хэнд ч эс оногдох нэгэн хаанчлалын эрх мэдлийг надад өгч хайрла. Чи үнэхээр өгөөмөр билээ” хэмээн гуйж залбирав.
36. Бид тэгээд хүссэн зүг руу авч явах салхийг түүнд захируулсан билээ.
37. Мөн том харш босгох барилгачид, тэнгист шумбан шүр сувд шүүрэгч чөтгөр шулмасыг түүнд захируулсан юм.
38. Бусад нь угаас гинжээр гавлагдсан байсан юм.
39. Энэ бол Бидний хайр энэрэл болой. Түүнийг зарцуулах уу, үгүй үү? Хүссэнээрээ бай, Бид чамтай тооцоо үл бодно.
40. Бидний нигур дор түүний өмнө гэрэлт сайхан ирээдүй бий.
41. (Аяа, Мухаммед!) Тухайн үед Эзэнтэндээ залбиран: “Намайг чөтгөр шулмас зовоон тарчилгалаа” гэсэн үнэнч боол Аюбыг ч санан дурсагтун.
42. Хариуд нь түүнд : “Хөлөөрөө газар дэвс! Дэвсэлсэн газраас чинь уусан ч, угаалганд хэрэглэсэн ч болохоор цэнгэг ус ундарна” хэмээсэн билээ.
43. Бидний зүгээс нэгэн хайр энэрэл, гэгээн ухаантны хувьд сургамж болгог хэмээн түүнд гэр бүлийг нь, мөн түүнээс хэд дахин илүүг хайрласан билээ.
44. Бид түүнд: Гартаа туг өвс авч, түүгээрээ (эхнэрээ) ороолго, амалсан тангарагаа бүү зөрч” гэж хэлсэн. Бид түүний хатамжит тэвчээрийг таньсан юм. Тэр Аллахад үнэнчээр итгэсэн юутай сайн хүн вэ!
45. (Аяа, Мухаммед!) Итгэл сүсэглэлдээ үнэнч, шашны хувьд гярхай манай боолууд Ибрахим, Исхак, Якуб нарыг санагтун.
46. Бид тэднийг хойд ертөнцийг боддог, чин үнэнч хүн болгосон юм.
47. Тэд Бидний дэргэдэх шилдэг жинхэнэ эрхэмүүдийн тоонд ормуу.
48. Исмайл, Алясаг, Зулкифил нарыг санагтун. Тэд бүгд эрхэм сайчууд болой.
49. Энэ бол нэгэн сануулга мөн. Гэгээн ухаантнуудын хувьд эргэлзээгүй гэрэлт сайхан ирээдүй буй.
50. Тэр нь Гадн диваажин бөгөөд хаалга үүд нь тэдэнд нээлттэй байх болно.
51. Тэд сэнтий дээрээ тааваараа тухлан, олон төрлийн жимс, ундаа авчруулах бөлгөө.

52. Хажууд нь тэдэнтэй үе тэнгийн, нөхрөөс бусдыг үл тоодог, гоо үзэсгэлэнт гэргий нар нь байх болно.
53. Энэ нь хойд ертөнцийн шүүлтийн өдөр та нарт амлагдсан шагнал, хүндэтгэл билээ.
54. Энэ нь, Бидний хайрласан дуусашгүй хувь хишиг болой.
55. Энэ бол чин үнэн. Харин урвагчдын очих газар нь үнэхээр муухай шүү.
56. Тэр – там. Тэд түүнд хаягдана. Тэр юутай муухай газар гээч!
57. Ийнхүү тэд буцлам халуун ус ба идээ бээрийн амтыг үзэг.
58. Тэдэнд үүнтэй төстэй өөр ч, янз бүрийн гэсгээлүүд буй.
59. Үл сүсэглэгчид даган баясагчдын хамт тамд ороход толгойлогчдод нь: “Энэхүү бүлэг хүмүүс бол та нартай хамт халуун там руу орогсод мөн. Тэдний өчил хүлээн авагдахгүй” гэгдэхэд удирдагч нар нь: “Тэд ч амар амгаланг эс үзмүй” хэмээцгээдэг.
60. Харин аялдан дагагсад удирдагч нартаа хандан: Үгүй дээ, үнэндээ та нар адгийн муу бөгөөд амар амгаланг эс үзмүй. Уг гэсгээлийг бидэнд та нар авч ирсэн шүү дээ. Энэ юутай муухай газар вэ?” гэлцэнэ.
61. Мөн аялдан дагагсад : “Аяа, Эзэнтэн минь! Үүнийг бидэн дээр хэн авч ирсэн байна, тэр халуун тамын гэсгээлийг хоёр дахин илүү үзэг!” хэмээнэ.
62. (Харин үл сүсэглэгсэд) толгойлогчид: “Амьд ахуйн хорвоод адгийн муугаар боддог хүмүүсийг бид энд яагаад олж харахгүй байна вэ?”
63. Тэднийг доог тохуу хийдэг байсан биз дээ. Одоо тэднийг танихаа байв уу? Тамд хамт байгаа ч харахгүй байна уу?” гэнэ.
64. Халуун тамынхан ийнхүү хэрүүл маргаан болох нь эргэлзээгүй.
65. (Аяа, Мухаммед!) Тэдэнд : “Би үнэндээ ердөө л нэг сэрэмжлүүлэгч билээ. Сүр жавхлантай цорын ганц Аллахаас өөр бурхан үгүй” хэмээн хэлэгтүн.
66. Тэр тэнгэр, газар хийгээд тэдний хооронд буй бүхний Эзэнтэн бөгөөд ялалтын эзэн, нэн өршөөн энэрэгч мөн.
67. (Аяа, Элч минь!) Тэдэнд : “Энэ бол (Аллахын цорын ганц болохыг сануулах гэгээн элчийн тухай) аугаа нэгэн мэдээ юм.
68. Гэвч та нар түүнээс нүүр буруулцгааж байна.
69. Хязгааргүй уудамд байгсадын (Адам эцгийн бүтээгдсэн тухай элч мэлэч нарын) маргаанаас би юуг ч ойлгон мэддэггүй байлаа.
70. Харин яруу тод сануулагч гэгээн элч болсны хувьд л энэхүү эрдэм надад оногдлоо” хэмээн хэл.
71. Тэр үед Эзэнтэн чинь мэлэжүүдэд хандан : “Би шавраар нэгэн хүмүүнийг бүтээнэ;
72. Би түүнийг бүтээгээд хэлбэршүүлж, бас эрхтнүүдийг гүйцээж, жинхэнэ

- хүн болгож, түүн рүү сүр хүчээр үлээн амилуулсны дараа та нар бүгдээрээ түүнд сөгдөн мөргөгтүн” гэв.
73. Мэлэкүүд бүгд сөгдөн мөргөцгөөв.
74. Гагцхүү Иблис (чөтгөр шулам) л сөгдөн мөргөлгүй, их зан гаргаж, буруу номтон болов.
75. Аллах: “Аяа, Иблис! Сүр хүчээрээ бүтээсэн хүнд (Адам эцэгт) сөгдөн мөргөхөд чинь юу саад болсон бэ? Ихэмсэг бардамнал уу? Эсвэл өөрийгөө эрхэм дээдэс хэмээн үзсэнээс үү?” гэж асуув.
76. Иблис: “Би яагаад ч түүнээс илүү. Учир нь Чи намайг галаар, түүнийг шавраар бүтээсэн биз дээ” хэмээн хариулав.
77. Аллах түүнд : “Тэгвэл чи эндээс (диваажингаас) үтэр түргэн тонил! Үнэхээр хөөгдсөн нэгэн боллоо;
78. Ертөнцийн төгсгөлийн өдөр хүртэл хараал минь чамайг нэрвэг!” гэв.
79. Иблис : “Аяа, Эзэнтэн минь! Тэгвэл дахин амилахуйн өдөр хүртэл надад боломж өгөгтүн” хэмээн залбирав.
80. Аллах: “Боломж олгогдсны нэгэн чи болог;
81. Дахин амилахуйн өдөр хүртэл!” гэв.
82. Иблис : “Чиний адис ерөөлөөр тангараглая, би тэд бүгдийг хууран урвуулна;
83. Гагцхүү тэдний дотроос чин үнэнээр сүсэглэсэн боолуудыг чинь урвуулж чадахгүй” хэмээв.
84. Аллах: “Миний үг чин үнэн. Би зөвхөн үнэнийг хэлдэг;
85. Чи болон чамайг дагагсадын бүгдээрэнгээр халуун тамыг дүүргэмүй!” хэмээн айлдав.
86. (Аяа, Мухаммед!) Тэдэнд : “Миний бие Аллагаас ирүүлсэн айлдваруудыг та нарт уламжилсны төлөө ямар ч үнэ хөлс авахгүй. Би Аллахыг санаанаас зохиогч биш ээ;
87. Куран бол хүн төрөлхтний хувьд нэгэн ухуулга, сургамж билээ;
88. Түүний мэдээллийн үнэн болохыг тодорхой хугацааны дараа мэдэцгээх болно” гэв.

## 39. СУРЕ ЗУМАР

Мекке-д илгээгдсэн. 75 айлдвар.

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Энэ судар нь ялгуулсан мэргэн ухааны эзэн, аугаа Аллахаас буулгасан бөлгөө.
2. (Аяа, Элч минь!) Уг судрыг Бид чамд чин үнэнээр үнэн бүхнийг тусган буулгасан. Тиймээс шашинаа ариун байлган, Аллахад мөргөж залбирагтун.
3. Санаж явагтун, ариун шашин гагцхүү Аллахынх шүү. Аллахаас бусдыг эзэн хэмээгсэд : “Бид тэдгээрт мөргөхдөө биднийг Аллах руу ойртуулна хэмээн сүсэглэн залбирсан” гэлцдэг. Аллах тэдний маргалдсан асуудлын талаар ертөнцийн төгсгөлийн өдөр шүүн тунгааж, шийдвэр гаргана. Аллах худалчид хийгээд үл тоомсорлогчдыг зөв шулуун зам руу эс хөтлөнө.
4. Хэрэв Аллах хүүхэд хүсвэл өөрөө бүтээсэнүүдээс аль дуртайг сонгож авах байсан биз. Тэр үүнээс (хүүхэдтэй болохоос) ангид. Аллах цорын ганц бөгөөд сүр хүчтэй.
5. Аллах тэнгэр, газрыг чин үнэнээр бүтээсэн. Шөнийг өдрөөр, өдрийг шөнөөр солино. Нар, сар хоёрыг (бүтээсэн зүйлүүд болон боолуудынхаа төлөө) эрхшээнэ. Тэд тус бүрдээ тодорхой хугацаагаар оршин өнгөрмүй. Мэдэгтүн! Тэр ялалтын эзэн бөгөөд нэн өршөөгч билээ.
6. Аллах та нарыг цорын ганц амиас (Адам эцэгээс) бүтээж, дараа нь түүнээс гэргийг (Хауа эхийг) бүтээсэн юм. Та нарын төлөө хосоор нь найман амьтан бүтээсэн. Бас та нарыг ч эхийн хэвлийд (үрийн шингэнээс цус, түүнээс махан бие болгон гурав шатлан) гурван харанхуйн дотор (гэдэс, хэвлий, эхэс) бүтээдэг билээ. Ийнхүү Аллах та нарыг бүтээгч Эзэнтэн чинь мөн. Хаанчлалын эрх (Алив бүхнийг эрхшээх) Түүнийх болой. Түүнээс өөр ямар ч бүтээгч үгүй. Ийм байхад Түүнд мөргөн залбирахаас яагаад нүүр буруулцгаана вэ?
7. Хэрэв буруу номтон байвал Аллах та нараар дутахгүй. Тэр боолуудынхаа буруу номтон байхыг эс таалмуй. Хэрэв наминчлан сүсэглэвэл талархах болно. Ямар нэгэн нүгэлтэн бусдын нүглийг эс үүрнэ. Эцэст нь та бүгд Эзэнтний өмнө очицгооно. Тэр хийсэн бүхнийг чинь хэлж өгөх болно. Тэр зүрх сэтгэлд буй бүхнийг бүрэн мэднэ.
8. Хүн гэдэг амьтан нэгэн гай зовлон тохиолдвол Эзэнтэндээ мөргөн сөгдөж, гуйж залбирч унана. Аллах түүнд сайн сайхан хайрлавал өмнөх залбиралаа умартан, бусдыг Аллахын замаас төөрөгдүүлэхийн

тулд Түүнтэй элдэв юмыг эн зэрэгцүүлж эхэлдэг. (Аяа, Мухаммед!) Тэдэнд : “Одоогоор үл тоомсорлон, ташаарч бай. Чи эргэлзээгүй халуун тамынхан мөн” хэмээн хэлэгтүн.

9. Эсвэл хойд насны гэсгээлээс айж, Аллахын ивээл энэрлээс горьдон, шөнө дунд сөхрөн мөргөж, босож сүсэглэн залбирсан хүн буруу номтнуудтай адил гэж үү? (Аяа, Мухаммед!) Тэдэнд : “Мэддэг, мэдлэггүй хоёр адил гэж үү?” хэмээн хэл. Үнэндээ гэгээн ухааны эзэд л сургамж авдаг юм.
10. (Аяа, Мухаммед!) Миний өмнөөс : “Аяа, сүсэгтэн боолууд минь ээ! Эзэнтнээсээ айгтун! Энэ хорвоод сайн үйл үйлдэгсэд хойд хорвоод ч буянтай сайн үйл буй. Аллахын бүтээсэн газар уудам. Хүлцэн тэвчигсэд хүртээх шан харамж нь хязгааргүй” хэмээн айлдаарай.
11. (Аяа, Мухаммед!): “Би шашинаа ариун байлгаж, Аллахад сүсэглэн залбирахын төлөө тушаагдсан ;
12. Надад Мусулманчуудын анхдагч нь байх хувь заяа тушаагдсан” хэмээн хэл.
13. (Аяа, Мухаммед!) : “Хэрэв Эзэнтнийгээ эсэргүүцвэл аугаа өдрийн гэсгээлээс айж баймуй” хэмээн хэлэгтүн.
14. “Тиймээс би шашинаа (хамтатгахаас, бузараас) хамгаалан, ариун байлгасаар л Аллахад сүсэглэн залбирна.
15. Та нар үл сүсэглэгсэд : “Аллахаас өөр хүссэн зүйлдээ залбирцгаа!” хэмээн хэлэгтүн. Мөн тэдэнд: “Аугаа өдөр өөрийгөө болон гэр бүлийнхнээ хор хөнөөлд учруулагсад бол жинхэнэ хохирогсод болно. Мэдтүгэй, энэ чинь илэрхий хор хөнөөл мөн” гэж хэл.
16. Тэднийг дээр, дооргүй дүрэлзсэн гал бүчиж байдаг. Аллах ийнхүү гэсгээлээр боолуудаа айлгадаг” гэж хэл. Аяа, боолууд минь ээ! Надаас, Миний гэсгээлээс айгтун.
17. Тагут буюу шавар бурхадаас, чөтгөр шуламаас, тэднийг тахин шүтэхээс зугтаж, Аллахыг чиглэсэнд баяр хүргэмүй. (Аяа, Мухаммед!) Ийнхүү Миний боолуудад баярт мэдээг дуулгагтун.
18. Тэр боолууд айлдварыг чин сэтгэлээрээ сонсож, үгийн хамгийн сайхныг дагацгаадаг болой. Ийнхүү тэд бол Аллахын зөв шулуун замд хөтлүүлэгсэд болой. Жинхэнэ гэгээн ухааны эзэн тэд байнам.
19. (Аяа, Мухаммед!) Гэсгээгдэх ёстой хэн нэгнийг, халуун тамд буй хэн нэгнийг чи аврах юм гэж үү?
20. Гагцхүү Аллахаас айж сүсэглэдэг хүмүүст л хаяагаар нь булаг урссан, олон давхар орд харш бүхий диваажин буй. Энэ нь Аллахын амлалт мөн. Аллах өгсөн амлалтандаа үнэнч юм шүү.
21. Аллах тэнгэрээс хур буулгаж, түүгээр газрын булгийг ундаалж, дараа нь төрөл бүрийн тариа ургуулж буйг чи хараагүй гэж үү? Дараа нь



- түүнийг хатааж гандуулан шарлуулсан. Дараа нь түүнийг хуурай хаягдал болгомуй. Ухааны эздийн хувьд эдгээрт зохих сургамж буй болой.
22. Аллах Исламын төлөө хэн нэгний зүрх сэтгэлийг нээсэн бол, тэр Эзэнтнийхээ гэгээн нөмөрт багтсан нь тэр биш үү? Аллахыг санан дурсах болоход чулуун зүрх гаргагсадын хувьд нэн харамсалтай. Тэд илэрхий төөрөлдөгсөд мөн.
  23. Аллах нандин сайхан үгээ, нэг нэгнийгээ давтан өгүүлдэг айлдвар байдлаар судар болгон буулгасан болой. Эзэнтнээс айхсадын үс нь үрвийж чичирнэ. Талархал, өршөөлийн тухай айлдваруудыг уншигсадын сэтгэл нь уярч, Аллахын айлдварт бишрэнэ. Ийнхүү Куран судар нь Аллахын зөв шулуун зам бөлгөө. Аллах хүссэн хүнээ үүгээр зөв зам руу хөтөлнө. Аллах хэн нэгнийг төөрөгдүүлвэл түүнийг зөвтгөх хүн олдохгүй.
  24. Ертөнцийн төсгөлийн өдөр нүүрээ халхлан гэсгээлээс хамгаалахаар оролдсон хүний байдал ямар байх билээ? Харгис зальхай этгээдүүдэд: “Хийсэн хэргийнхээ уршгийг үзэгтүн” хэмээгдэх болой.
  25. Тэднээс өмнөхүүд ч гэгээн элчүүдийг худал хэмээн үгүйсгэсэн тул тэдэнд гэнэтийн гэсгээл ирсэн юм.
  26. Аллах тэдэнд амьд хорвоогийн зовлонг амтлуулсан. Харин хойд ертөнцийн гэсгээл түүнээс ч хатуу гэдгийг мэддэг ч болоосой.
  27. Бид үнэндээ сургамж аваг хэмээн энэхүү Куранаар хүмүүст янз бүрийн сургамж жишээг иш татлаа.
  28. Энэ бол өө сэвгүй араб хэл дээрх Куран мөн. Тэд төөрөгдлөөс сэрэмжлэг дээ.
  29. Аллах та нарт ийм нэгэн сургамж жишээг өгүүлж байна: Хоорондоо өрсөлдөөн, зөрчилтэй, хэд хэдэн эзэнтэй нэг хүнийг (боолыг) зөвхөн нэг эзэнтэй хүнтэй адилтгаж болох уу? Олон эзэнтэй боол хэнд нь үйлчлэхээ мэдэхгүй толгой эргэнэ. Бүхий л магтаал зөвхөн Аллахынх. Гэвч тэдний олонхи нь үүнийг мэдэхгүй.
  30. Эцэст нь чи ч, тэд ч үхэцгээх нь үнэн.
  31. Улмаар та нар ертөнцийн төгсгөлийн өдөр Эзэнтнийхээ өмнө очиж маргалдацгаах болно.
  32. Аллахыг гүтгэсэн, илэрхий үнэнийг (Кураныг) үгүйсгэсэн хүнээс илүү харгис зальхай амьтан байх гэж үү? Буруу номтнуудын очих газар нь там биш гэж үү?
  33. Чин үнэнийг авчирсан ба хүлээн зөвшөөрсөн хүмүүс жинхэнэ гэгээн ухаантнууд мөн.
  34. Тэдний хувьд Эзэнтнийх нь өмнө хүссэн бүхэн нь бий. Сайн үйл үйлдэгсэдийн шагнал ийм болой.

35. Аллах тэдний үйлдлийн хамгийн мууг арилган, хамгийн сайнд тохирсон шагналыг олгоно.
36. Аллах Өөрийнхөө боолоо (Мухаммедыг) хамгаалахад хангалттай биш гэж үү? Үл сүсэглэгсэд Аллахаас өөр тахин шүтсэн зүйлээрээ чамайг айлгахыг оролдоно. Аллахын төөрөгдүүлсэн хүнийг зөв шулуун зам руу залах хэн ч олдохгүй.
37. Аллахын зөв зам руу залсан хүнийг хэн ч төөрөгдүүлж чадахгүй. Аллах ялгуулсан хүчирхэг, өш хонзон авагч биш.
38. Хэрэв чи тэднээс : “Тэнгэр, газрыг хэн бүтээсэн вэ?” хэмээн асуувал, мэдээж “Аллах!” гэж хариулна. (Аяа, Мухаммед!) Тэднээс : “Хэрэв тийм бол надад хэлж өгнө үү? Аллах надад хор хүргэхийг хүсвэл, та нарын Аллахыг орхиж шүтсэн шавар бурхад чинь Түүний хор хөнөөлийг таслан зогсоож чадах уу? Хэрэв Аллах надад хайр энэрэл хүсвэл, тэд Түүнд саад болж чадах уу?” хэмээн асуугтун. (Аяа, Мухаммед!) : “Аллах надад хангалттай. Сэтгэл шулуудвал гагцхүү Түүн руу тэмүүлэгтүн. Бүхий л хэргээ Аллахт даатгагтун” хэмээн хэлэгтүн.
39. (Аяа, Мухаммед!) : “Аяа, зон олон минь! Өөрсдийн чадлынхаа хэрээр хийгтүн. Би ч чадах чинээгээр ажиллая.
40. Зовлон гэсгээл хэнийг дайрахыг, мөнхийн цээрлэлтэй хэний учрахыг та нар удахгүй мэдэцгээх болно” хэмээн хэлэгтүн.
41. (Аяа, Мухаммед!) Эргэлзээгүй Бид үнэндээ Кураныг чамд хүн төрөлхтний төлөө, чин үнэний төлөө буулгасан болой. Хэн зөв шулуун замаар явна, тэр нь өөрийн төлөө болой. Хэн нэгэн урваж, төөрөлдөнө, тэр өөртөө гай барцад олно. Чи тэдний төлөөний хүн биш ээ!
42. Аллах үхэх нэгний амийг таслана. Амьд нэгнийг нойрсож байхад үхүүлнэ. Үхэх цаг нь ирэгсэдийн амийг нь авч, үхэх цаг нь болоогүй хүмүүсийн товлогдсон хугацаа ирэх хүртэл түр азнана. Эрэгцүүлэн бодох нэгэнд үүнд ч гэсэн сургамж буй.
43. (Аяа, Мухаммед!) Үл сүсэглэгсэд Аллахаас бусдыг ивээгч болгохыг эрмэлзэнэ. Тэдэнд : “Тэд юуг ч чадахгүй, ойлгохгүй байсан ч ивээн тэтгэгч болгох гэж үү?” хэмээн хэл.
44. Тэдэнд: “Бүхий л энэрэл ивээл Аллахаас. Тэнгэр, газрын эзэгнэл гагцхүү Түүнийх. Та нар бүгд Түүний өмнө очигцоох болно” хэмээн хэл.
45. Цорын ганц Аллахыг санан дурсвал, хойд ертөнцөд үл итгэгсэд хямсагнан дотороо таалдаггүй юм. Аллахаас өөр бусад шүтэн бишрэгсэдийг санан дурсвал баярлан баясана.
46. (Аяа, Мухаммед!) Тэдэнд : “ Аяа, тэнгэр газрыг бүтээгч, ил далд бүхнийг мэддэг Аллах минь! Боолуудынхаа дунд буй маргаан

- зөрөлдөөний талаар шудрагаар шүүх эзэн гагцхүү Чи билээ.” хэмээн хэл.
47. Хэрэв газар дэлхийд буй бүхэн, бас түүнээс нэг дахин илүү нь ч тэр харгис зальхай амьтадынх байсан бол, тэд ертөнцийн төгсгөлийн өдрийн аймшигт гэсгээлээс аврагдахын тулд мэдээж эдгээрийг золиослох асан билээ. Үнэндээ (тэр өдөр) тэдний огтхон ч санаанд нь ороогүй зүйлс Алладын зүгээс гарч ирэх бөлгөө.
  48. Тэдний амьд ахуйдаа хийсэн муу бүхэн (тэр өдөр) ил болж, доог тохуу хийж асан зүйлс нь өөрсдийн хүзүүг ороох болно.
  49. Хүмүүст нэгэн гай зовлон тохиохуйд Биднээс залбиран гуйцгаадаг. Дараа нь Бид хайр энэрэл үзүүлвэл тэд: “Энэ бол миний эрдэм мэдлэгийн ач тус” хэмээн ташаарна. Тийм биш ээ! Энэ бол зөвхөн сорилт юм. (Ивээн тэтгэвэл эсэргүүцэн ташаарах уу? Эсвэл талархан зөвшөөрөх үү? гэдгийг шалгаж буй хэрэг.) Гэвч тэдний олонхи нь үүнийг мэдэхгүй.
  50. Үүнийг тэднээс урьдахууд ч хэлсэн билээ. Гэвч хураасан эд хөрөнгө бүхэн нь тэднийг аварч чадаагүй билээ.
  51. Тийм болохоор хийсэн муу муухай бүхэн нь өөрсдийг нь нэрвэнэ. Эдгээрээс харгис зальхай үйл үйлдэгсэдийн нүгэл нь өөрт нь гай болно. Тэд энэхүү зовлонг хөнгөвчилж эс чадна.
  52. Аллах хүссэн хүнийхээ хувь хишгийг нэмэгдүүлж, хүсээгүй нэгнийхийг гарчиг дутуу болгодог гэдгийг тэд мэдэхгүй юм гэж үү? Итгэн сүсэглэгчдийн хувьд үүнд зохих сургамжууд буй.
  53. (Аяа, Мухаммед!) Миний өмнөөс тэдэнд хэлэгтүн : “Аяа, өөртөө гай барцад хураасан боолууд минь! Алладын хайр энэрэлийн талаар итгэл бүү алдагтун! Аллах хүссэн хүнийхээ бүх нүглийг өршөөн хэлтэрүүлдэг. Тэр нэн их өршөөгч, машинд энэрэгч.
  54. Та нар бусдаас аврал авч эс чадах гэсгээл ирэхээс өмнө Эзэнтэн рүүгээ эргэгтүн. Хүлцэн дагагтун.
  55. Гэнэтийн аюулт гэсгээл ирэхээс өмнө Эзэнтнээс та нарт буулгагдсан яруу сайхан үгэнд (Куранд) уяран сүсэглэгтүн.
  56. Нүгэлт хэн нэгэн: “Алладын тухайд алдаж эндсэн минь Алладын шашин болон эрх зүйн хэм хэмжээг доог тохуу болгосон маань юутай харамсалтай вэ?” хэмээх өдрөөс сэргийлэгтүн.
  57. Аль эсвэл : “Аллах надад зөв шулуун замыг хайрласан бол, мэдээж би гэгээн ухаантнуудын эгнээнд багтах байсан.” хэмээх.
  58. Аль эсвэл гэсгээлийг хармагц : “Даанч яавдаа! Амьд хорвоод дахин нэг удаа буцвал наминчлан залбирч, сайн үйл үйлдэгсдийн эгнээнд орохсон!” хэмээх (өдрөөс сэргийлэгтүн!)
  59. (Аллах тэдэнд): “Үгүй дээ чамд миний айлдварууд ирсэн. Чи түүнийг

- худал хэмээн үгүйсгэн үл тоомсорлож, буруу номтон болсон шүү дээ.” гэж хэлнэ.
60. Ертөнцийн төгсгөлийн өдөр Аллахыг гүтгэгсдийн нүүр царай пад хар болохыг чи харах болно. Их зан гарган бардамнагсдад халуун тамд оромж олдохгүй гэж үү?
  61. Эзэнтэн чинь гэмт хэргээс, Аллахтай бусдыг эн зэрэгцүүлэхээс сэргийлдэг хүмүүсийг жаргал цэнгэлд умбуулан гэсгээлээс аварсан. Тэд гай зовлонтой учрахгүй, гуниг гутралд автахгүй.
  62. Аллах алив бүхнийг бүтээгч, алив бүхнийг эрхшээн захирагч мөн.
  63. Тэнгэр, газрын түлхүүр, ид шид Аллахын эрхшээлд болтой. Аллахын айлдваруудыг үгүйсгэгсэд бол хор хөнөөлд учрагсад билээ.
  64. (Аяа, Мухаммед!) : “Аяа, харанхуй мунхагууд аа! Аллагаас бусдыг тахин шүтэхийг надад тушаах гэсэн юм уу?” гэж хэл.
  65. (Аяа, Мухаммед!) Чамд ч, чамаас өмнөх гэгээн элчүүдэд ч ийнхүү айлдвар өгөгдсөн. Аллахтай бусдыг эн зэрэгцүүлэх аваас, үйл хэрэг бүхэн чинь талаар өнгөрч гарцаагүй хохирол үзэгсэдийн тоонд ормуу!
  66. Тиймээс, гагц Аллахад л сүслэглэн мөргө, Аллахын хувь хишигт талархагсдын нэгэн бологтун.
  67. Тэд (үл сүслэглэгсэд) Аллахыг зүй ёсоор таньж чаддаггүй юм. Ертөнцийн төгсгөлийн өдөр бүхий л дэлхий Түүний эрхшээлд баймуу. Тэнгэр Түүний сүр хүчээр хуйларна. Аллах тэдний эн зэрэгцүүлсэн хиймэл бурхадаас ангид, эрхэмсэг билээ.
  68. Сур буюу бүрээ бишгүүр үлээгдэхүйд : “Аллахын хүссэнээс бусад нь тэнгэр, газарт буй амьд ахуйн эзэд бүгд устах болно. Дараа нь дахин нэг үлээгдэхүйд тэд хөл дээрээ зогсон, ямар шийтгэл оногдохоо хүлээцгээнэ”.
  69. Эзэнтний чинь гэрэл гэгээгээр хойд ертөнц бүхэлдээ гэрэлтэж, үйлийн үрийн дэвтэр нээгдэж, гэгээн элч нар болон гэрчүүд ирнэ. Тэдний нүдэн дээр шударга шийдвэр гарах бөгөөд хэн ч үл хэлмэгдэнэ.
  70. Хүн бүрт хийсэн сайн үйлсийн төлөө буян хишиг оногдоно. Аллах тэдний хийсэн үйл бүхнийг сайн мэддэг юм.
  71. Буруу номтнууд бөөн бөөнөөрөө халуун там руу туугдана. Тэд хүрэлцэн очихуйд хаалга нээгдэж, харуулд зогссон элч-мэлэжүүд тэдэнд: “Та нарт, (дотроос чинь) Эзэнтний айлдваруудыг уншиж өгөх, өнөөдөртэй учрахаас сэрэмжлүүлэгч гэгээн элч ирээгүй үү?” хэмээн асууна. Тэд: “Тийм ээ, ирсэн. Гэвч гэсгээх тушаал нь үл сүслэглэгсэд оногдох ёстой юм байна” гэж хариулна.
  72. Тэдэнд : “Дотор нь үүрд үлдэх халуун тамын хаалгаар орцгоогтун.” хэмээгдэнэ.
  73. Харин Эзэнтнээс айж сүслэглэгсэдийг бөөн бөөнөөр нь диваажин руу

явуулна. Тэд хүрэлцэн очиход диваажингийн үүд хаалга нь цэлийтэл нээгдэхүйд харуулд зогссон мэлэжүүд тэдэнд: “Ассаламу алайкүм буюу Та нарын амар амгаланг айлтгая! Та нар нүгэлээс ангид ирцгээлээ. Ийнхүү үүрд мөнхийн диваажинд морилогтун” хэмээн угтана.

74. Диваажинд орж тухалсны дараа үнэнч сүсэгтнүүд: “Амлалтандаа үнэнч байж, бидэнд диваажингийн орныг өвлүүлсэн Аллахыг шагшин магтмуй. Бид диваажингийн дотор таалсан газарт тухлана. Сайн үйл үйлдэгсэдийн шан харамж юутай сайхан юм бэ!” гэнэ.
75. Мэлэжүүд сансар огторгуйг хүрээлэн, Эзэнтнийгээ шагшин магтаж буйг харцгаана. Мөн тэдний тухайд (мусулманууд диваажинд, буруу номтнууд тамд очих тухай) чин үнэн шийдвэр гарна. Мөн бүхий л магтаал ертөнцийн эзэнтэн Аллахад хамаарна.” хэмээн хэлэгдэнэ.

## 40.СУРЕ МҮМИН

Мекке-д илгээгдсэн. 85 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Ха Мим.
2. Энэ судар нь ид шидтэй хүчирхэг, мэргэн ухааны эзэн Аллахын зүгээс буулгагдсан.
3. Нүглийг өршөөн хэлтрүүлэгч, наминчлалыг хүлээн авагч, гэгсгээл нь хатуу, уужим энэрэлийн эзэн Аллахын зүгээс буулгагдсан. Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Эцэст нь түүний өмнө эргэж очино.
4. Буруу номтнуудаас өөр хэн ч Аллахын айлдваруудын талаар маргалддаггүй юм. Тэдний хотоос хотыг дамжин аялж яваад нь бүү хуурт. (Хэдийн аялан зугаалсан ч үл тоомсорлолынхоо гэгсгээлийг хэзээ нэгэн өдөр хүртэх болно.)
5. Тэднээс (Меккегийн үл сүсэглэгчдээс) өмнө Нухын ардууд, бас тэдгээрийн дараах (гэгээн элчүүдийн эсрэг нэгдсэн) олон түмэн ч гэгээн элчүүдийг хүлээн зөвшөөрөөгүй билээ. Үгүйсгэгч олон түмэн бүр өөрсдийн гэгээн элч нараа эсэргүүцсэн юм. Хоосон утгагүй үгээр гэгээн элч нартай маргалдан мэтгэлцэж, үнэнийг үгүйсгэхийг оролдов. Тиймээс тэднийг анхааралдаа авсан (гэгсгээн цээрлүүлсэн) билээ. Ийнхүү миний цээрлэл ямар болохыг хараг!
6. Ингэснээр буруу номтнууд халуун тамынхан хэмээсэн Эзэнтний чинь айлдвар үнэн байх болно.
7. Сансар огторгуйг тулж буй болон түүний эргэн тойрон дахь (тэнгэрийн элч) мэлэжүүд Эзэнтнийгээ магтан шагшиж, итгэн сүсэглэдэг. Мусулмануудын төлөө өршөөл эрэн, наминчлан залбирч: “Аяа, Эзэнтэн

минь! Чиний хайр энэрэл хийгээд эрдэм мэдлэг тань эрхшээдэггүй зүйл гэж үгүй билээ! Наминчлан залбирагчид болж зам мөрөөр чинь явагсадыг өршөөн хэлтрүүлэгтүн! Тэднийг халуун тамын гэсгээлээс сэргийлэгтүн!”;

8. “Аяа, Эзэнтэн минь! Чи тэднийг, тэдний өвөг дээдэс, эхнэр хүүхдийн эрхэм сайныг Гадын нэртэй диваажинд оруулж хайрла?! Чи үнэхээр ялгуулсан аугаа бөгөөд мэргэн ухааны эзэн шүү дээ”;
9. Мөн тэднийг, алив муу бүхнээс (гэсгээлээс) сэргийлэн хамгаалваас, эргэлзээгүй түүнийг хайр энэрэлдээ багтаасанд тооцогдоно. Энэ нь их аз жаргал болой” хэмээн залбирна.
10. Буруу номтнуудыг гэрчлэгч мэлэкүүд: “Аллах та нарт хилэгнэх нь Ертөнцийн төгсгөлд та нарын бие биендээ хилэгнэн уурлахаас хавгүй сүрлэг билээ. Учир нь та нар итгэл үнэмшил рүү уригдсан ч эсэргүүцэл үзүүлцгээсэн” хэмээн тунхаглах болно.
11. Тэгэхүйд тэд: “Эзэнтэн минь! Биднийг хоёр удаа үхүүлж, хоёр удаа дахин амилууллаа. Бид нүглээ хүлээн зөвшөөрлөө. Одоо биднийг тамын галаас аврах арга зам байна уу?” хэмээн гуйна.
12. Тэдэнд: “Үүний шалтгаан гэвэл Аллахыг цорын ганц болохыг уриалсан ч та нар үгүйсгэгцээсэн юм. Аллахтай элдэв юмыг эн зэрэгцүүлэхүйд (Лат, Гузза зэрэг шавар бурхадьг) шүтэн итгэгцээсэн билээ. Ийнхүү зарлиг бол нэн их аугаа, онцгой эрхэм Аллахынх шүү дээ” хэмээн хариулагдана.
13. Аллах та нарт өөрийнхөө ид шидээр янз бүрийн гайхамшгуудыг үзүүлэх болно. Тэнгэрээс хур бороо оруулан та нарт буян хишиг буулгана. Үүнээс зөвхөн Аллах руу чиглэгдсэн хүмүүс л сургамж авна.
14. Үл сүсэглэгсэдийн таалалд нийцэхгүй ч, шашнаа цэвэр ариунаар хадгалж, Аллаhad сүсэглэн залбирагтун!
15. Аугаа тэнгэрийн эзэн эрхэм дээд Аллах нь эргэлзээгүй ирэх эцсийн өдрийг урьдчилан сануулахын тулд хүссэн хүндээ өөрийн тушаалаар айлдвар буулгана.
16. Тухайн өдөр тэд (булнаасаа) гаргагдана. Тэдний юу ч тэр Аллахаас далд эс үлдэнэ. “Өнөөдөр эзэгнэл хэнийх вэ? Сүр хүчтэй Аллахынх!” хэмээгдэх болно.
17. Тэр өдөр хүн бүр хийсэн нүглийнхээ хэрээр гэсгээгдэнэ. Хэнд ч шударга бус юм хийгдэхгүй. Аллах үнэхээр тооцоо бодохдоо үтэр түргэн билээ.
18. Ойртож буй төгсгөлийн өдрийг тэдэнд сэрэмжлүүлэгтүн! Тэр өдөр зүрх нь амандаа тулж, хийсэн хэрэгээсээ болж зовцгооно. Харгис зальхай этгээдүүдэд найз нөхөд ч, үгийг нь тоох өмгөөлөн ивээгч ч олдохгүй.
19. Аллах нүдний хорыг, сэтгэлийн нууцыг мэдэж байдаг.

20. Аллах чин шударгаар шийдвэр гаргана. Харин тэдний Аллахыг орхиж шүтэн сүсэглэсэн хиймэл бурхад нь ямар ч асуудлаар шийдвэр гаргаж эс чадна. Аллах үнэхээр бүхнийг сонсогч, харж байдаг юм.
21. Тэд дэлхий даяар хэрэн хэсүүчилж, өөрсдөөс нь өмнөх одогсодын хувь заяа хэрхэн төгссөнийг хараагүй гэж үү? Урьд өмнө одогсод нь хүч чадлаараа ч, үлдээсэн өв дурсамжаараа ч эднүүдээс хавгүй илүү байсан билээ. Аллах тэднийг нүглээс нь болж цээрлүүлсэн юм. Тэднийг Аллахын гэгсгээлээс аврах хэн ч байсангүй.
22. Учир нь гэгээн элчүүд өөрсдөд нь яруу тод нотолгоо бүхий ер бусын гайхамшигууд авчирсан ч тэд эсэргүүцэн үгүйсгэсэн билээ. Иймээс Аллах тэднийг цээрлүүлсэн юм. Аллах нэн их ид шидтэй, хүчирхэг, хатуу цээрлүүлэгч шүү дээ.
23. Бид үнэндээ Мусаг яруу тод нотолгоо бүхий ер бусын гайхамшигуудтай илгээсэн юм.
24. Түүнийг Фиргаун, Хаман, Карун руу илгээсэн билээ. Тэд Мусаг: “Илбэчин, худалч!” хэмээсэн.
25. Муса Бидний зүгээс өөрсдөд нь чин үнэнээр гэгээн элч болон ирсэн ч тэд: “Мусатай хамт мөргөн сүсэглэсэн хүмүүсийн хөвгүүдийг алж, эхнэрүүдийг нь амьд үлдээгтүн” гэлцэв. Гэвч үл сүсэглэгсэдийн заль мэх мэдээж талаар өнгөрөх болой.
26. Фиргаун: “Намайг явуулагтун? Би Мусаг алчихая. Итгэлтэй байвал Аллах Эзэнтнээ дуудаг! Учир нь би түүний, та нарын шашиныг өөрчлөхөөс нь эсвэл олны дунд үймээн самуун тарихаас нь болгоомжилж байна” гэв.
27. Муса: “Би шүүн тунгаах өдрийг үгүйсгэгч алив бардамнагчаас намайг хамгаалагтун” хэмээн миний ч, та нарын ч Эзэнтэн болох Аллахт залбирнам!” хэмээн хэлэв.
28. Фиргауны ардын дунд сүсэг бишрэлээ нууж явсан нэгэн сүсэгтэн: “Та нар “Миний Эзэнтэн Аллах” гэж хэлсэн хүнийг алах гэж үү? Үнэндээ тэр Эзэнтнээсээ олон нотолгоонуудтай ирсэн. Хэрэв тэр худалч бол уршиг нь өөрт нь тусмуй. Хэрэв үнэнч (гэгээн элч) бол та нарт сэрэмжлүүлсэн аюулын зарим нь нэрвэх болно. Аллах хэрэг дээр хэмээс хэтэрсэн худалч нэгнийг зөв замд залахгүй шүү дээ!
29. Аяа, ард олон минь! Өнөөдөр захирах эрх мэдэл та нарын гарт байна. Одоо та нар газар нутагтаа (Мисирт) ялалтанд хүрсэн ч Аллахын гэгсгээл бидэн дээр ирвэл хэн биднийг түүнээс аврах вэ?” гэв. Тэгэхүйд Фиргаун: “Би юуг зөв гэж үзвэл, түүнийг та нарт тушаана. Би та нарыг зөв зам руу хөглөнө” хэмээв.
30. 31. Сүсэглэн итгэсэн нөгөө хүн: “Аяа, ард олон минь ээ! Үнэндээ би та нарын Нух, Гад, Самудын ардууд болон тэдгээрийн

- дараах олны адил зүдрэн, тэдэнд тохиосон гэсгээлтэй учрах вий хэмээн айж байна. Аллах боолуудыг шударга бусаар гэсгээхийг хүсэхгүй юм”;
32. “Аяа, ард олон минь ээ! Би та нарын хувьд бие биендээ хашгиран орилох тэр өдрөөс айж баймуй”;
  33. Тэр өдөр ар тийшээ эргэж зугтацгаах болно. Та нарыг Аллахын гэсгээлээс аврах хүн олдохгүй. Хэрэв Аллах хэн нэгнийг төөрөгдүүлвэл, түүнийг хэн ч зөв зам руу хөтөлж чадахгүй”;
  34. Үүнээс өмнө Юсуф ч та нарт яруу тод нотолгоо авч ирсэн. Гэвч түүнийг авчирсан нотолгоонуудад байнга эргэлзсэн билээ. Тэр таалал төгсөхөд та нар “Аллах үүнээс хойш гэгээн элч илгээхгүй биз” хэмээцгээсэн. Аллах хэмээс хэтрэгсэдийг, эргэлзэж байгсадыг ийнхүү төөрөгдүүлдэг юм” гэв.
  35. Тэд өөрсдөд нь ирсэн ямар ч нотолгоо байхгүй байлаа ч Аллахын айлдваруудын тухай маргалдагсад билээ. Энэ нь Аллахын өмнө ч, мусулмануудын өмнө ч ад үзэгдэнэ. Аллах биеэ тоосон, бардамнагсдын сэтгэлийн нүдийг ийнхүү хөшиглөдөг.
  36. Фиргаун зөвлөх Хаманд хандан: “Хаман! Надад нэгэн өндөр цамхаг бариул! Би замуудыг харж юу магад!
  37. Тэгвэл тэнгэрийн замуудыг олж улмаар Мусагийн Бурханыг харж юу магад. Би түүнийг үнэхээр худалч хэмээн бодном” гэж дажигнав. Ийнхүү Фиргауны хийсэн муу үйл хэрэг нь өөрт нь сайхан санагдаж, зөв шулуун замаас төөрөлдөв. Фиргауны заль мэх нь юу ч үгүй өнгөрлөө.
  38. Фиргауны зон олны доторх сүсэглэгч өнөөх хүн: “Аяа, ард олон минь ээ! Намайг дагагтун! Би та нарыг зөв шулуун замаар хөтлөмүй!;
  39. Аяа, ард олон минь ээ! Энэ хорвоогийн амьдрал ахуй бол түр зуурын хуурамч зугаа төдий зүйл. Жинхэнэ баттай мөнх орон бол хойт хорвоо мөн!;
  40. Хэн муу үйл үйлдэнэ, тэр түүндээ зохицсон гэсгээл үзнэ. Харин эрэгтэй, эмэгтэй хэн ч гэсэн мусулман болж, нэгэн сайн үйл үйлдвээс, тэд диваажинд орцгооно. Тэнд хэмжээлшгүй их хувь хишиг хүртэх болно.
  41. Аяа, ард олон минь ээ! Би та нарыг тамаас аврахаар уриалахад та нар намайг там руу дуудах нь юун учиртай юм вэ?;
  42. Та нар намайг Аллахыг үгүйсгэхэд, бас огтхон ч мэдэхгүй юмсыг Түүнтэй эн зэрэгцүүлэхэд уриалцгаалаа. Харин би та нарыг ялалтын эзэн, машид өршөөгч Аллах руу уриалан дуудаж баймуй;
  43. Үнэндээ та нарын намайг итгэн бишрэхэд уриалсан юмнууд чинь энэ хорвоод ч, хойд ертөнцөд ч урихад зохистой биш ээ. (Өөрөөр хэлбэл тэрхүү хиймэл бурхадад сүсэглэн залбирах нь зөв биш ээ) Эцсийн эцэст



- бид бүгд Аллахын өмнө очих нь огт эргэлзээгүй. Харин хэмээс хэтрэн даврагсад яриангүй халуун тамынхан мөн;
44. Удахгүй аюул заналтай учрахдаа миний хэлснийг санах болно. Би үйл хэрэгээ Аллахад даатгана. Аллах эргэлзээгүй боолуудаа сайн ажиглан харагч мөн” хэмээн хэлэв.
  45. Эцэст нь Аллах Мусаг Фиргауны талынхны хор хөнөөлөөс аварсан билээ. Фиргауны ардад гэсгээлийн хамгийн хүнд нь ирэв ээ.
  46. Тэд өглөө, оройгүй халуун гал дээр шарагдана. Ертөнцийн төгсгөлийн өдөр гэсгээлийн мэлэкүүдэд: “Фиргауныхныг гэсгээлийн хамгийн хүнд рүү оруулцгаа!” хэмээн тушаагдах болно.
  47. Тэд халуун там дотор маргалдацгаана. Сул доройчууд нь ихэмсэг бардамнагсад хандан: “Бид та нарыг дагацгаасан шүү дээ. Одоо та нар бидний гэсгээлийг хөнгөвчилж чадах юм уу?” хэмээн хариу нэхнэ.
  48. Ихэмсэглэн бардамнагсад: “Үнэндээ бид цөмөөрөө тамын гал дотор байна шүү дээ. Аллах боолуудынхаа талаар шийдвэрээ нэгэнт гаргачихсан” хэмээн хариулна.
  49. Халуун тамд оршигсад тамыг харуулдах гэсгээлийн мэлэкүүдэд хандан: “Та бүхэн Эзэнтэндээ залбирч үзээч? Тэр Бидний нэг өдрийн гэсгээлийг хасаж өгөгтүн!” хэмээн гуйна.
  50. Тамын хэргийг эрхлэх гэсгээлийн мэлэкүүд: “Та нарт гэгээн элч нар чинь яруу тод нотолгоонууд авч ирээгүй юм уу?” гэнэ. Тэд: “Тийм ээ. Авч ирсэн юмаа” хэмээнэ. Харуулын мэлэкүүд: “Тийм бол өөрсдөө залбирцгаатун. Гэвч үл сүсэглэгсэдийн залбирал талаар болдог юм даа” гэж хариулна.
  51. Бид амьд ахуйн зуурдын оронд ч, гэрчүүд бэлэн байдаг үүрдийн оронд ч (хойд хорвоод) гэгээн элч нар болон сүсэглэгсэд эргэлзээгүй туслах болно.
  52. Тэр өдөр зальхай этгээдүүдийн сайрхал ямар ч үнэд хүрэхгүй. Тэднийг хараал идэх бөгөөд хойд хорвоогийн аймшигт байр тэднийх болно.
  53. Бид Мусад зөв шулуун замыг зааж, Израйлын үр садад ариун судрыг (Тауратыг) өвлүүлсэн болой.
  54. Энэ судар нь оюун ухааны эздийн хувьд сургамж, зөв шулуун зам болой.
  55. (Аяа, Мухаммед!) Тэвчээртэй байгтун! Аллахын амлалт чин үнэн. Мөн нүглийнхээ төлөө өршөөл гуйж, өглөө орой Эзэнтнээ шагшин магтагтун.
  56. Өөрсдөд нь ирсэн ямар ч нотолгоо үгүй байхад Аллахын айлдваруудын талаар маргалдагсадын цээжинд өөрсдөө хэзээ ч үл хүүрэх хоосон санаархал, бардамнал буй. Чи Аллахад залбир. Аллах үнэхээр бүхнийг сонсч, харж байдаг юм.

57. Мэдээж тэнгэр, газрыг бүтээх нь хүмүүнийг бүтээхээс арай илүү аугаа шүү дээ. Гэвч хүмүүний олонхи нь үүнийг мэдээгүй.
58. Сохор, хараатай хоёр адил биш ээ. Сүсэглэж, сайн үйл үйлдэгсэдтэй муу үйл үйлдэгсэд адил биш ээ. Та нарын итгэл үнэмшил хэт алгуур байна.
59. Ертөнцийн төгсгөлийн цаг гарцаагүй ирмүй. Энэ тухайд ямар ч эргэлзээ үгүй. Гэвч хүмүүний олонхи нь үл итгэдэг.
60. Эзэнтэн чинь: “Надад залбирагтун, хүсэлтийг чинь хүлээн авна. Харин их зан гаргаж бардамнан Надад сүсэглэн мөргөхөөс татгалзагсад яриангүй халуун тамд орцгооно” хэмээнэ.
61. Аллах та нарыг алжаалаа тайлан амраах шөнийг, орчиноо харан ажиллахын чинь төлөө өдрийг буй болгосон. Аллах үнэндээ бүх хүмүүст ивээлтэй. Гэвч, олонх хүн үүний төлөө талархдаггүй.
62. Аллах-та нарын Эзэнтэн алив бүхнийг бүтээгч мөн. Түүнээс өөр бурхан үгүй. Ийм байхад яахлаар түүнд залбиралгүй, хиймэл бурхадыг шүтэн, зөрүүдлэнэ вэ?
63. Аллахын айлдваруудыг үгүйсгэгсэд ийнхүү нүүрээ буруулцгаадаг юм.
64. Аллах та нарт газар дэлхийг амьдрах нутаг, тэнгэрийг тооно-цамхаг болгосон. Мөн та нарыг хэлбэршүүлж, сайхан дүр төрхтэй болгож, ариун хишгүүдээрээ хооллуулсан. Ийнхүү та нарын Эзэнтэн бол ертөнцийг бүтээгч нэн их аугаа, өгөөмөр Аллах болой.
65. Тэр ашид мөнх. Түүнээс өөр бурхан үгүй. Эн зэрэгцүүлэх, хуурахаас ангид байж шашинаа чин ариунаар сахиж, сүсэглэн залбирагтун. Бүхий л магтаал ертөнцийн Эзэн Аллахынх болой.
66. Аяа, Мухаммед! тэдэнд: “Би Эзэнтнээс яруу тод нотолгоонууд ирэхүйд та нарын Аллахыг орхиж тахин шүтсэн юманд мөргөхөөс татгалзсан бөгөөд надад ертөнцийн Эзэнтэнд итгэн сүсэглэхээр тушаагдсан” хэмээн хэлэгтүн.
67. Аллах та нарыг (Адам эцгийг чинь) шороо шавраар, удам судрыг нь дусал үрээр, нүжирсэн цусаар бүтээж, эхийн чинь хэвлийгээс нярай болгон гаргасан билээ. Улмаар та нарыг нас биеэнд хүргэн, хүч чадалтай болгон, эцэст нь өвгөрч өгөлнө. Та нарын зарим нь цэл залуугаараа үхнэ. Товлосон хугацаа хүртэл амьдарцгааг хэмээн ийм болгосон. Та нар Аллахын энэхүү ид шидийг ойлгодоггүй юм.
68. Аллах үхүүлнэ, бас амилуулна. Тэр алив юмыг бий болохыг хүсвэл ердөө л “Болтугай” хэмээнэ. Тэр нь тэгээд буй болдог юм.
69. Аллахын айлдваруудын талаар маргалдаж төөрөлдөгсөдийг чи харна уу?
70. Судрыг (Кураныг) хийгээд гэгээн элч нарт илгээгдсэн нотолгоо бүхий гайхамшигуудыг маань хүлээн зөвшөөрөөгүй хүмүүс удахгүй цээрлэл үзэх болно.

71. Тэр цагт тэд хүзүүндээ төмөр дөнгө зүүж, гараа гавлуулна.
72. Тэгээд буцлам халуун усанд хаягдана. Дараа нь галд шарагдана.
73. Тэдэнд: “Та нарын Аллахыг орхиж, тахин шүтсэн хиймэл бурхад чинь хаана байна вэ?” (Ийм л үед аврахгүй юм уу?)” хэмээгдэнэ.
74. Тэд: “Тэд биднийг төөрүүлчихсэн. Үнэндээ бид урьд өмнө юунд ч мөргөн шүтдэггүй байлаа” гэнэ. Аллах үл сүсэглэгсэдийг ийн муужруулдаг болой.
75. Энэ нь та нарын зуурдын амьдралдаа (мөнгө, хөрөнгөө бузар юмны төлөө үрж) баярлан цэнгэж, баяссаны хариу мөн.
76. “Одоо тамын үүд хаалгыг татан орцгоож, тэнд үүрд үлдэцгээгтүн. Биеэ тоон бардамнагсадын орон байр юутай муухай гээч!”
77. Тийм болохоор (Аяа, Мухаммед!) тэвчээртэй байгтун! Аллахын амлалт чин үнэн. Бидний тэдэнд амалсны заримыг чамд харуулсан ч, эсвэл түүнээс өмнө чамайг үгүй хийсэн ч ялгаагүй, тэд Бидний өмнө ирэх болно. (үзээгүйгээ ч үзнэ)
78. Үнэндээ, Бид чамаас өмнө ч олон гэгээн элч нарыг илгээсэн юм. Тэдний заримынхны тухай чамд өгүүлсэн, заримынхны тухай өгүүлээгүй болой. Ямар ч гэгээн элч Аллахын зөвшөөрөлгүйгээр алив нэгэн ер бусын гайхамшигийг эс үзүүлж чадна. Аллахаас Ертөнцийн төгсгөлийн тухай зарлиг бумагц чин үнэн шийдвэр гарна. Тэр үеэр чин үнэнийг эсэргүүцэгчид хор хөнөөлд автана.
79. Аллах та нарын төлөө уналга болгоход, хүнсэнд хэрэглэхэд зориулж адгуус амьтадыг бүтээсэн юм.
80. Та нарт тэдний ашиг тус олон билээ. Хуурай газар дээр мал амьтадыг уналга болгон сансан зорилгодоо хүрнэ. Далай тэнгис дээр онгоцонд сууж зорчицгооно.
81. Аллах ер бусын гайхамшигуудаа та нарт харуулна. Та нар Аллахын аль гайхамшигуудыг үгүйсгэж чадах вэ?
82. Тэд дэлхий даяар хэрэн хэсэхдээ өмнөхүүдийн хувь тавилан хэрхэн төгссөнийг хардаггүй юм уу? Эдэнтэй зэрэгцүүлэхэд өмнөхүүд нь тоогоор илүү, хүчирхэг, ардаа үлдээсэн зүйлүүд нь хавьгүй илүү байсан юм. Гэвч энэхүү хийсэн үйл нь тэдэнд ямар ч ашиг тус өгөөгүй юм.
83. Гэгээн элчүүд тэдэнд яруу тод нотолгоо бүхий бэлгэдлүүдийг авч ирэхүйд тэд өөрсдийн өчүүхэн мэдлэгт бардамнан, гэгээн элч нарыг худал хэмээн үгүйсгэж, доог тохуу хийснээс, өөрсдөө хошиггнон хүсч байсан гэгсгээл өөрсдийг нь нөмрөн авсан ажгуу.
84. Тэд гэгсгээлийг маань хармагц: “Бид цорын ганц Аллаhad сүслэн итгэцгээлээ. Түүнтэй эн зэрэгцүүлсэн элдэв бүхнийг эсэргүүцэх болно” хэмээн хэлцгээдэг болой.
85. Гэвч Бидний гэгсгээлийг харсан даруйд хуурамчаар сүсэглэн итгэх нь

тэдэнд ямар ч ашиг тус өгөхгүй. Энэ нь Аллахын буруу номтнуудын эсрэг баримталсан ёс билээ. Ийнхүү үл сүсэглэгчэд хор хөнөөлд автацгаах болно.

## 41. СУРЕ ФУССИЛАТ

Мекке-д илгээгдсэн. 54 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Ха, Мим.
2. Энэ нь нэн их энэрэлт, нигүүлсэнгүй Аллагаас буулгасан айлдвар (Куран) мөн.
3. Ухаарах хүмүүсийн хувьд айлдварууд яруу тод өгүүлэгдсэн. Энэ судар Араб хэл дээрх Куран мөн.
4. Тэрээр сүсэгтнүүдийг диваажингаар баярлуулагч билээ. Гэвч үл сүсэглэгчдийн олонхи нь Аллагаас нүүр буруулцгаадаг. Үүнд анхаарал тавьдаггүй юм.
5. Тэд гэгээн элч нарт: “Чиний уриалсан зүйлийн хувьд бидний итгэл үнэмшил хаалттай. Мөн чих маань ч бөглөөстэй. Чи, бидний хооронд хөшиг татагдсан. Тиймээс, чи өөрийнхөө хүссэнээ хий, бид ч өөрсдийн хүссэн үйл хэрэгээ хийцгээе” гэнэ.
6. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Би ч та нарын адил жирийн хүн шүү дээ. Шүтэх бурхан чинь цорын ганц Аллах хэмээн надад айлдагдсан. Тиймээс Түүнд итгэн залбиран, өршөөл гуйгтун!” хэмээн хэл. Үл сүсэглэгчэд үнэндээ өрөвдөлтэй юм.
7. Тэд ариуслын өглөг эс өгцгөөдөг, хойд ертөнцөд үл итгэгчдэдэг.
8. Үнэнчээр сүсэглэж, сайн үйл үйлдэгсэдийн төлөө хэмжээлшгүй буян хишиг буй.
9. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Газрыг хоёр өдөрт бүтээгчийг үгүйсгэн, Түүнтэй элдэв бусдыг эн зэрэгцүүлэх гэж үү? Бүхий л ертөнцийн Эзэн-Аллах болой” хэмээн хэл.
10. Тэр газар дээр уулсыг байршуулан, тэнд буян хишигээ буй болгож, дэлхий дээрх амьтадын хэрэглээг дөрвөн өдөрт тодорхойлов.
11. Дараа нь манан будан байдалтай тэнгэрийг бүтээж эхлэв. Тэгээд тэнгэр, газарт хандан айлдахдаа: “Та нар хүссэн ч, хүсээгүй ч миний ивээлд ирэгтүн. (Зарлигийг минь биелүүлэгтүн!)” хэмээн тушаав. Тэд хоёулаа: “Бид өөрсдийн хүслээр ирцгээлээ” хэмээцгээсэн билээ.
12. Аллах долоон давхараа тэнгэрийг хоёр өдөрт бүтээж, дор бүрт нь үүрэг оногдуулан зохистой шийдвэр, хэрэгцээт бүхнээр хангав. Ийнхүү Бид

хамгийн ойр тэнгэрийг од мичидээр чимэглэн, хамгааллаа. Энэ нь аугаа хүчирхэг, алив бүхнийг мэдэгч Аллахын тодорхойлсон хувь тавилан болой.

13. Хэрэв тэд (Меккегийн үл сүсэглэгчид) итгэн залбирахаас нүүр буруулвал: “Гад, Самудын ардыг нэрвэсэн аянга мэт аюул буйг анхааруулж баймуй” хэмээн хэл.
14. Тухайн үед тэдэнд гэгээн элч нар ар өвөргүй ирж хүрээлэн: “Аллахаас бусдад бүү мөргөгтүн” гэхэд тэд: “Хэрэв, Эзэнтэн минь хүссэн бол бидэнд зарлигийн мэлэкүүдийг илгээх байсан буй за. Бид та нарын гэгээн элч нарыг хүлээн зөвшөөрөхгүй” гэв.
15. Гадын ард олон болохоор газар сайгүй зүй зохисгүй бардамнаж: “Биднээс илүү хүч чадалтай хэн байна вэ?” хэмээн хөөрцөглөв. Тэд өөрсдийгөө бүтээгч Аллах өөрсдөөс нь илүү хүчирхэг гэдгийг тэд ухаараагүй юм гэж үү? Тэд Бидний айлдваруудыг үгүйсгэж эсэргүүцсэн юм.
16. Иймээс Бид тэдэнд энэ хорвоогийн хамгийн адгийн гэсгээлийг амсуулахын тулд тэр золгүй өдрүүдэд хар салхийг илгээв. Харин хойд ертөнцийн гэсгээл мэдээж, үүнээс ч илүү, асар муу шившигтэй. Тэр цагт тэдэнд ямар ч тулалцаа эс өгөгдөнө.
17. Самудын ардад Бид зөв шулуун замыг заасан билээ. Гэвч тэд зөв шулуун замыг орхиж, сохор харанхуйг (төөрөгдлийг) сонгоцгоосон билээ. Тиймээс тэднийг үйлдсэн нүглийнхээ хэрээр шившиглэх гэсгээлийн аянга нэрвэн сүйрүүлсэн юм.
18. Үнэн сүсэглэгсэд болон итгэн дагагсдыг аварсан бөлгөө.
19. Аллахын дайснуудыг халуун там руу бөөнөөр нь туун оруулах өдөр бүгд цугларгал нэгэн газарт түр саатуулна.
20. Эцэст нь тэд тамд орохдоо чих, нүд, арьс нь хүртэл үйлдсэн хэргийг нь гэрчлэн мэдүүлнэ.
21. Тэд арьсандаа: “Яагаад бидний нүглийг гэрчлэнэ вэ?” гэхэд: “Алив бүхнийг яриулагч Аллах биднийг ч гэсэн яриулсан болой. Тэр анхлан та нарыг бүтээсэн шүү дээ. Одоо Түүний өмнө буцаж очигцооно” гэж хариулна.
22. Та нар амьд ахуй цагтаа өөрсдийн чих, нүд, арьс чинь эргэж гэрч болохоос сэрэмжилж чадсангүй. (Муу үйл үйлдэхэд зөвхөн хүн амьтнаас нуусан ч өөрсдийнхөө эрхтнээс нууж эс чадмуй) Үйлдсэн бүхний чинь ихэнхийг Аллах мэддэггүй гэж бодоцгоодог.
23. Эзэнтнийхээ тухайд тээж асан буруу бодол чинь та нарын өөрсдийг ийнхүү сүйрүүлж, хор хөнөөлд өртөцгөөсөн болой.
24. Хэрэв тэд тэсэж чадах юм бол, халуун там оромж нь мөн болой. Тэд Аллагаас өршөөл, энэрэл хүсэв ч уучлагдахгүй.

25. Бид тэдэнд чөтгөр шуламаас түншүүд бэлтгэчихсэн. Чөтгөр шуламууд тэдний урьд хойно үйлдсэн муу муухай бүхнийг нүдэнд нь сайхан болгож харагдуулсан билээ. Ийнхүү өмнөх буг чөтгөр болон хүмүүсээс буй болсон ардуудад амлагдсан гэсгээл өөрсдөд нь тохиосон болой. Тэд эргэлзээгүй хор хөнөөлд өртөгсөд мөн.
26. Буруу номтнууд: “Энэхүү Кураныг бүү сонсогтун, Куран уншигдахуйд шуугиан дэгдээгээрэй. Тэгж л байж та нар ялж юу магад” хэмээнэ.
27. Бид гарцаагүй тэрхүү буруу номтнуудыг хатуу гэсгээнэ. Үйлдсэн муухай хэргийн хариуд нь цээрлүүлэх болно.
28. Аллахын дайснуудын хувь бол халуун там мөн. Тэдний хувьд тэр нь мөнхийн газар. Бидний айлдваруудыг үгүйсгэсний хариу нь энэ болой.
29. Үл сүсэглэгсэд: “Аяа, Эзэнтэн минь! Буг чөтгөр болон хүмүүсээс биднийг төөрөгдүүлэгсэдийг бидэнд харуулж аль! Бид тэднийг шившиглэн дэвсэлье!” хэмээнэ.
30. “Бидний Эзэнтэн бол Аллах” хэмээн залбирч, зөв шулуун замаар замнагсдад мэлэжүүд бууж ирээд: “Та нар бүү айгтун, бүү гуниглагтун, та нарт амлагдсан диваажингаар хөөрөн баясагтун!” хэмээн айлдана.
31. Бид энэ хорвоод ч, хойд ертөнцөд ч та нарын андууд болой. Тэнд та нарын сэтгэлийг эзэмдэх, хүссэн бүхэн чинь буй.
32. Энэ нь үлэмж ивээгч, нэн энэрэнгүй Аллахын шагнал.
33. Аллахад (түүнийг цорын ганц хэмээн залбирч) уригдсан, сайн үйл үйлдсэн “Би жинхэнэ Мусулман мөн” гэсэн хүмүүсээс илүү сайхан боол байх гэж үү?
34. Сайн, муу хоёр тэнцүү байдаггүй юм. Муу муухайг сайн үйлээрээ арилга. Тэгвээс чамтай тэрслэгч дайсан хүн өөрийн дотны нөхөр адил болно.
35. Энэхүү эрхэм чанарыг гагцхүү хатамжит тэвчээртэнгүүд эзэмдэж чадна. Ийнхүү чанарыг агуу буян хишгийн эзэд л олж чадмуй.
36. Чамайг санаандгүй чөтгөр шулмас өдөөн хатгавал (ухуулан, дээрх эрхэм чанараас чинь салгахыг оролдвол) Аллахад залбир. Учир нь Аллах алив бүхнийг сонсч, мэдэж байдаг.
37. Шөнө болон өдөр, нар хийгээд сар Аллахын буйг, цорын ганц болохыг нотлох бэлгэдлүүд болой. Тиймээс Аллахад сүсэглэн мөргөө гэвэл нар, саранд биш, тэдгээрийг бүтээгч Аллахад сөгдөн мөргөгтүн.
38. Хэрэв буруу номтнууд үүнийг үгүйсгэн бардамнах аваас (мэдэгтүн) Эзэнтний нигур дор буй (мэлэжүүд) огтхон ч уйдаж залхалгүйгээр, өдөр шөнөгүй Түүнийг шагшин магтацгаадаг болой.
39. Чи газар дэлхийн хагсахыг харна. Бид хур бороо оруулахад тэр амилан, ногоорно. Энэ ч гэсэн Аллахын ид шидийн нотолгоо мөн. Газрыг

- амилуулсан Аллах үхэгсэдийг ч гарцаагүй амилуулна. Эргэлзээгүй, Түүний хүч чадал нь алив бүхэнд хүрэлцэх билээ.
40. Бидний айлваруудыг мушгин гуйвуулагсад Биднээс нуугдаж чадахгүй. Тиймээс халуун тамд хаягдах нь дээр үү? эсвэл ертөнцийн төгсгөлийн өдөрт Аллахын гэгсгээлээс ангид очих хүн илүү өлзийтэй юу? Хүссэнээ хийцгээгтүн! Аллах та нарын үйлдсэн бүхнийг чинь эргэлзээгүй харж байдаг.
  41. Куран илгээгдэхэд түүнийг үгүйсгэн эсэргүүцэгчид эргэлзээгүй хатуу гэгсгээлтэй учрана. Куран бол жинхэнэ эрхэм, хүчирхэг судар шүү дээ.
  42. Түүний араас нь ч, урдаас нь ч буруу ташаа зүйл эс ирмүй. Тэр гэгээн ухаанаар баян, магтвал зохилтой, Аллахын зүгээс буулгагдсан билээ.
  43. (Аяа, Элч минь!) Чамд буруу номтнуудын зүгээс хэлэгдсэн үг чамаас өмнөх гэгээн элчүүдэд ч хэлэгдсэнээс өөр биш ээ. Эзэнтэн чинь яруу тод өршөөлийн ч, хатуу гэгсгээлийн ч эзэн бөлгөө.
  44. Хэрэв, бид Кураныг арабаас өөр хэлээр илгээсэн бол тэд мэдээж л: “Айлдварууд яагаад бидэнд ойлгомжтой хэлээр тодорхой өгүүлэгдээгүй юм вэ? Гэгээн элч араб хүн атал судар харь хэл дээр юм уу?” гэх байсан. (Аяа, Мухаммед!): “Куран бол сүсэглэн итгэгсэдийн хөтлөгч, зүрх сэтгэлийн эргэлзээг тайлан анагаагч” хэмээн хэлэгтүн. Харин үл сүсэглэгсэдийн чих нь Кураныг сонсох чадамжгүй. Куран тэдэнд тунэр харанхуй мэт харагдана. Ийнхүү тэдэнд алсын алсаас арай ядан сонсогдож буй бүдэг бадаг чимээ мэт санагдана.
  45. Үнэндээ, Бид Мусад ч Судрыг хайрласан. Энэ тухайд ч маргаан дэгдсэн. Хэрэв Эзэнтний чинь тэдэнд оногдох гэгсгээлийг Ертөнцийн төгсгөлд нь үлдээх тухай амлалт байгаагүйсэн бол урьдчилан хэлсэн ганц үг тэдний талаар аль хэзээ шийдвэр гарах байсан. Тэд үнэндээ үүнд эргэлзээтэй байсан юм.
  46. Хэн сайн үйл үйлдэнэ, ашиг тус нь өөрт нь, хэн муу үйл үйлдэнэ хор уршиг нь өөрт нь оногдоно. Эзэнтэн маань боолууддаа шударга бус юм хийдэггүй.
  47. Ертөнцийн төгсгөлийн өдрийн товыг гагцхүү Аллах л мэднэ. Жимсний мод нахиалах, эмс жирэмслэн төрөх тэр бүхэн нь Аллахын эрдэм чадлаас гадуур болох зүйл биш. Аллах: “Надтай эн зэрэгцүүлсэн зүйлс чинь хаана байна вэ?” хэмээн асуух тэр өдөр тэд: “Биднээс түүнийг гэрчлэх хэн ч байхгүйг чамд мэдээлье” хэмээн хэлнэ.
  48. Өмнө нь шүтсэн зүйлс нь тэднээс зайлан одно. Тэд өөрсдөө ч оргон зайлах газаргүй болсноо сая л ойлгоцгооно.
  49. Хүмүүс сайн зүйл хүсэхээс залхдаггүй. Харин нэгэн муу юм тохиолдвол нэг мөсөн итгэл алдран мухарддаг.
  50. Хэрэв тэдэнд тохиолдсон гай зовлонгийн дараа Бид хайр энэрлээ үзүүлвэл: “Энэ бол угаасаа миний хувь хишиг, Ертөнцийн төгсгөл

тохионо ч гэж бодохгүй байна. Эзэнтний өмнө эргэж очвол эргэлзээгүй надад сайн сайхан байх болно” хэмээн бардамнана. Бид буруу номтнуудад үйлдсэн хэргийг нь гарцаагүй мэдээлэх бөгөөд хүнд гэгсгээлээ амсуулах болно.

51. Хэрэв хүмүүнд буянтай үйлс хийвэл наминчлан талархахын оронд нүүр буруулан, ихэмсэг зан гаргана. Харин гай зовлон тохиохуйд Аллахыг сая л санан мөргөж залбирна.
52. Аяа, Мухаммед, тэдэнд: “Хэрэв Аллахын зүгээс Куран илгээгдэхэд та нар үүнийг үгүйсгэвэл юу болохыг бодож үзээгүй юу? Чин үнэнээс зайлсхийж, түүнийг эсэргүүцэгчээс муухай юм гэж байх уу даа?”
53. Кураны туйлын үнэн болох нь яруу тодорхой болох хүртэл бид тэдэнд тэр орчмын ба тэдний өөрсдөд буй нотолгоонуудаа харуулсаар байх болно. Эзэнтэн чинь алив бүхнийг гэрчлэхэд хангалттай биш гэж үү дээ?
54. Мэдтүгэй! Тэд үнэндээ Эзэнтэнтэйгээ эргэж учрах тухайд эргэлздэг юм. Аллах алив бүхнийг бүрэн дүүрэн мэдэгч билээ” хэмээн хэлэгтүн.



Мекке-д илгээгдсэн. 53 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Ха, Мим.
2. Гайн Син Каф
3. (Аяа, Мухаммед!) Аугаа эрхэмсэг, мэргэн ухааны эзэн Аллах чамд, чамаас өмнөхүүдэд ийн айлдсан бөлгөө.
4. Тэнгэр, газарт буй бүхэн гагцхүү Аллахынх. Аллах бүхнээс аугаа хүчирхэг.
5. Аллахын сүр хүчнээс тэнгэрийн давхарга хагаран унах мэт хүрхэрнэ. Мэлэжүүд ч Эзэнтнээ сайшаан магтацгааж, газар дээр буй хүмүүсийн төлөө залбирна. Мэдтүгэй! Аллах үнэхээр өршөөгч, нэн их энэрэгч билээ.
6. Аллахаас бусдыг (хиймэл бурхадыг) эзэнтэн хэмээгсэдийг Аллах хянан ажиглаж байдаг. Харин чи түүний батлан даагч биш ээ.
7. Хотуудын эх болох Меккегийн иргэдийг болон түүний хавь ойрын хүмүүсийг сэрэмжлүүлэг хэмээн, мөн ямар ч эргэлзээ үгүй тохиох өдрийн талаар сэрэмжлүүлэг хэмээн чамд араб хэл дээр Кураныг илгээсэн. Тэр өдөр тэдний нэг хэсэг нь диваажинд, нэг хэсэг нь тамд байх болно.



8. Хэрэв Аллах хүсэх аваас бүхий л хүн төрөлхтнийг нэгэн шашинт ард түмэн болгох байсан. Гэвч Аллах хүссэн хүнээ хайр энэрэлдээ багтаана. Харин харгис зальхай этгээдүүдэд эзэн ч, туслан аврагч ч эс олдоно.
9. Тэд Аллагаас бусдыг эзэн хэмээдэг нь ямар учиртай юм бол доо? Жинхэнэ эзэн Аллах мөн. Тэр үхэгсэдийг амилуулна. Бүхий л юманд Түүний хүч чадал нь хүрэлцээтэй.
10. Та нарын маргаж мэтгэлцсэн зүйлийн талаарх шийдвэрийг Аллах гаргана. Аллах миний эзэнтэн болой. Би гагцхүү Түүнийг түшиж, Түүнийг дагамай.
11. Тэр тэнгэр, газрыг бүтээгч мөн. Та нарын төлөө өөрсдөөс чинь хань ижил заяаж, амьтан адгуусыг хосоор нь бүтээсэн. Ингэснээр та нарыг өсгөн үржүүлж буй. Аллахтай төстэй юу ч үгүй. Тэр бүхнийг сонсогч, харагч бөлгөө.
12. Тэнгэр, газрын баялгийн түлхүүр Түүний гарт (эрхшээлд) буй. Хүссэн хүнийхээ хувь хишгийг нэмэгдүүлж, нөгөө хэсгийн хувь хишгийг тарчиг дутуу болгоно. Тэр бүхнийг мэдэж байдаг.
13. Аллах Нух-д гэрээсэлснийг, чамд айлдсаныг, тэрчлэн Ибрахим, Муса, Исад гэрээслэл болгосныг та нарт шашин болгон төлөвшүүлсэн юм. Та нар шашинаа зүй ёсоор сахиж, хоорондоо талцан бүү хуваагдагтун. Чиний уриалсан зүйл үл сүсэглэгсдэд хүнд туссан. Чиний уриалсан шашинд Аллах хүссэн хүнээ сонгон, түүн рүү хандсан хүнийг зөв шулуун замаар хөтөлнө.
14. Тэд (Иудэй ба Христчүүд) өөрсдөд нь эрдэм мэдлэг ирсний дараа атаархлын гайгаар задран хуваагдсан юм. Хэрэв Эзэнтний чинь зүгээс тэдэнд үзүүлэх гэсгээлийг тодорхой хугацаа хүртэл хойшлуулах тухай үг байгаагүй сэн бол тэдний байдал гарцаагүй талаар болох л байсан биз. Тэд хожмын судруудыг (Таурат болон Инжил) өвлөн авагсад Кураны тухайд ихээхэн эргэлзсээр байгаа ажгуу.
15. (Аяа, Мухаммед!) Тиймээс чи бүх хүмүүсийг нэгэн зөв шашин рүү уриалан дуудагтун! Тушаасан ёсоор тууштай байгтун. Тэдний хүсэл тачаалд бүү авт. Мөн тэдэнд: “Би Аллахын буулгасан сударт итгэлээ. Та нарын дунд шударга байхаар тушаагдсан юм. Аллах бол миний ч, та нарын ч Эзэнтэн. Тиймээс бидний үйл өөрсдийнхөө төлөө, та нарын үйл та нарын төлөө болой. Та бид хоорондоо маргалдах шалтгаан үгүй. Бид бүгдийг ертөнцийн төгсгөлийн өдөр Аллах нэг дор цуглуулан уулзуулах болно. Эргэн очигцоох газар бол зөвхөн Түүний өмнө шүү дээ” хэмээн хэлэгтүн.
16. Хүмүүс Аллахын айлдварыг (шашинг) хүлээн авсны дараа Аллахын талаар маргалдагсадын нотолгоонууд Эзэнтний өмнө үр ашиггүй. Тэд амьд ахуйдаа Аллахын уур хилэгнэлтэй, хойд ертөнцөд хатуу гэсгээлтэй учрана.

17. Аллах Куран судрыг, шударга ёсны хэмжүүрийг чин үнэнээр буулгасан билээ. Чи юу мэднэ гэж, магад ертөнцийн төгсгөл ойрхон биз ээ.
18. Түүнд (ертөнцийн төгсгөлд) үл итгэгсэд, түүнийг хүсэмжлэн яарна. Харин сүсэглэгсэд түүнээс айцгаадаг бөгөөд чин үнэн хэмээн мэддэг. Мэдтүгэй! Ертөнцийн төгсгөлийн хугацааны талаар маргалдагсад бол эргэлзээгүй гүнзгий төөрөлдөгсөд мөн.
19. Аллах боолууддаа бухимдана, хүссэн хүндээ буян хишиг хайрлана. Тэр машид хүчирхэг, ялагдашгүй билээ.
20. Хэн хойд насны буяныг хүснэ, түүний буян хишгийг Бид (Аллах) нэмэгдүүлнэ. Хэн энэ хорвоогийн ашиг хонжоог хүснэ, түүнийг ч өгнө. Гэхдээ түүнд хойд ертөнцийн хувь хишиг эс оногдоно.
21. Үгүй бол тэдэнд Аллахын эс зөвшөөрсөн юмыг шашин хэмээн төлөвшүүлсэн хиймэл бурхад нь бий үү? Хэрэв гэсгээлээ хойд ертөнцийн өдөр хүртэл хойшлуулах тухай Аллахын үг үгүйсэн бол тэдний тухайд амьд ахуй цагт нь ч гэсэн гэсгээлийн шийдвэр гаргах л байсан буй за. Эргэлзээгүй, харгис зальхайчуудад хатуу цээрлэл буй.
22. Харгис зальхай этгээдүүд ертөнцийн төгсгөлийн өдөр болоход амьд ахуйдаа хийсэн нүглээсээ болж айж бэмбэгнэхийг чи харах болно. Тэд айсан, айгаагүй нүгэлийнхээ хариуг амсах болно. Харин сүсэглэн мөргөж, сайн үйл үйлдэгсэд диваажингийн цэцэрлэгүүдэд байх болно. Тэдний хүссэн бүхэн Эзэнтнийхээ нигур дор бэлэн буй. Энэ бол аугаа энэрэл нигүүлсэл билээ.
23. Аллах сүсэглэн мөргөгч, сайн үйл үйлдэгч боолуудаа ийнхүү сайн сайхан бүхнээр баярлуулана. (Аяа, Мухаммед!): “Би энэхүү баярын мэдээг хүргэсний хариуд нь та нараас ахан дүүсийн найрсаг харилцаанаас өөр юу ч хүсэхгүй” хэмээгтүн. Хэн сайн үйл үйлдэнэ, түүнд Бид илүү буян хишиг хайрлана. Аллах машид өршөөгч, бага үйлийн төлөө ихийг хайрлагч өгөөмөр билээ.
24. Үгүй бол тэд (Курайш овгийн буруу номтнууд) чамайг: “Аллахыг гүтгэж байна” гэх юм уу? Хэрэв, Аллах хүсвэл чиний ч зүрх сэтгэлийг хааж болох билээ. Аллах муу муухайг үгүй хийж, цэвэр сайн үйлийг чин үнэн болгодог. Тэр сэтгэлд буйг зүй ёсоор нь мэдэж байдаг юм.
25. Аллах боолуудынхаа наминчлалыг хүлээн авч соёрхон, нүглийг нь өршөөдөг бөгөөд үйлдсэн бүхнийг мэддэг юм.
26. Аллах сүсэглэн итгэж, сайн үйл үйлдэгсэдийн хүсэлтийг болгоон соёрхож, өөрийн ивээлээр хишиг буянаа илүү ихээр хайрладаг. Харин хатуу гэсгээл нь үл сүсэглэгсэдийн хувь болой.
27. Аллах боолуудынхаа хувь хишгийг хэт элбэг дэлбэг болговол тэд хэмээс хэтэрч, самуун дэгдээнэ. Иймд Тэр хувь хишгээ зохистой хэмжээгээр хайрладаг юм. Тэр боолуудынхаа талаар бүрэн мэдээлэлтэй бөгөөд тэднийг харж байдаг.

28. Аллах боолууд нь цөхрөнгөө барахад тэнгэрээс хур оруулж, ивээл энэрэлдээ авна. Тэр магтаалын эзэн, нэн өгөөмөр анд билээ.
29. Тэнгэр, газар бүтээгдэх нь, тэдэнд буй амьтан адгуусын дэлгэрэх нь Аллахын бэлгэдлүүдийн нэгэн мөн. Тэр хүссэн үедээ тэдний бүгдийг нэг дор цуглуулахад түүний хүч чадал нь хүрэлцээтэй.
30. Та нар гараараа үйлдсэн хэргийн гайг хар толгойгоороо даах болно. Гэхдээ Аллах түүний ихэнхийг нь өршөөн хэлтгэрүүлдэг юм.
31. Аяа, үл сүсэгтнүүд ээ! Газар дэлхий дээр (нүглийнхээ гэсгээлээс амар мултарч) Аллахыг мөхөсдүүлж чадахгүй. Та нарт Аллагаас ондоо эзэн ч, туслан дэмжигч ч үгүй.
32. Тэнгис далайд уул мэт аварга хөлөг онгоцнууд хөвөх нь Аллахын ид шидийн нэгэн тэмдэг мөн.
33. Хэрэв Тэр хүсвэл салхийг номхоруулж, усан онгоцнууд тэнгис далай дээр зогсонги байдалд орно. Үүнд ч гэсэн хүлээцтэйгээр наминчлан талархагчдын хувьд олон сургамжууд буй нь маргаангүй.
34. Эсвэл үйлдсэн хэргээс болж хөлөг онгоцыг живүүлэн, дотор нь нүгэлтнүүдийг сүйрүүлнэ. Гэвч тэдний олонхийг нь өршөөн хэлтгэрүүлнэ.
35. Бидний айлдваруудын талаар маргалдагсад өөрсдөө хоргодох газаргүй гэдгээ мэдэгтүн.
36. Харин та нарт өгөгдсөн зүйлс бол зөвхөн амьд ахуйн хэрэгцээ хангах төдий юм шүү. Аллахын эрхшээлд буй зүйлс нэн өгөөжтэй бөгөөд мөнх байх болно. Энэхүү шан харамж гагцхүү сүсэглэн залбирч, Эзэнтэндээ итгэн найдагсдад зориулагдмой.
37. Их нүгэлээс ба жигшүүртэй хэргээс ангид хүмүүст, бухимдлаа барьж уучилж чадагсдад уг шагнал зориулагдмой.
38. Мөн Эзэнтнийхээ уриалгыг хүлээн авагсдад, уншлага мөргөлөө намбатай үйлдэгсдэд, аливаа хэргийг өөр хоорондоо зөвлөлдөн гүйцэтгэгчдэд, өөрсдөд нь Бидний хайрласан хувь хишгээс ариуслын өглөг өгөгсдөд зориулагдмой.
39. Мөн өөрсдөө шударгуу бусад өртөгцөөхөд түүний эсрэг хамтран тэмцэгчдэд зориулагдмой.
40. Алив муу муухайн шийтгэл нь түүнтэй дүйцэх муу муухай байна. (Хэн нэгэн чамайг оролдвол чи оролдон эсэргүүц. Гэхдээ бүү хэтрүүл) Хэн нэгэн өшөө авах чадалтай атал хүлцэн уучилж, эвийг сахих аваас, түүний шан харамжийг Аллах өөрөө аяндаа өгнө. Аллах үнэхээр харгис зальхай явдлыг эс таалдаг юм.
41. Хэн нэгэн шударга бус харгислалд өртсөний хариуг авбал түүнд нүгэл үгүй.

42. Гэсгээгдэх нь гагцхүү бусдад харгислал үйлдэгсэд, хүчирхийлэгсэд зориулагдмой. Тийм этгээдүүд зовлонт гэгсгээлтэй учрана.
43. Хэн нэгэн хүчирхийлэлд тэвчээр гарган, өршөөн уучлах аваас энэ нь нэн зохистой явдал мөн.
44. Аллах хэн нэгнийг төөрөгдүүлэх аваас, үүнээс хойш түүнд ямар ч дэмжин туслагч үгүй. Харгис зальхай амьтад гэгсгээлтэй учрах мөчид: “Амьд хорвоод эргэж буцах ямар нэгэн зам байдаг болов уу?” хэмээн хэлэхийг чи харах болно.
45. Тэд царай алдан айж эмээгээд, нүдний булангаар гөлөлзөн харсаар л там руу эргэхийг чи харна. Харин сүсэгтнүүд: “Хор хөнөөлд өртөгсөд ертөнцийн төгсглийн өдөр үнэхээр өөрсдийгөө болоод гэр бүлийнхнийгээ ч хор хөнөөлд учруулагсад юм даа” хэмээн хэлцгээнэ. Тиймээс мэдэцгээгтүн! Харгис зальхай амьтад зайлахын аргагүй гэгсгээлтэй учрах нь эргэлзээгүй.
46. Тэдэнд Аллагаас өөр туслах хэн ч олдохгүй. Аллах хэн нэгнийг төөрөгдүүлэх аваас түүнд зөв замыг заах хүн үгүй болой.
47. Аллахын зүгээс гарцаагүй ирэх, эсэргүүцэж үл болох тэр нэгэн өдөр ирэхээс өмнө Аллахын уриалгыг хүлээн авч дагагтун. Тэр өдөр та нарт хоргодох газар эс олдоно, (хийсэн хэрэг чинь үйлийн дэвтэрт бичээстэй тул) хаашаа ч бултаж эс чадна.
48. Аяа, Мухаммед! Хэрэв тэд итгэн сүсэглэхээс нүүр буруулах аваас Бид чамайг тэднийг мануулахаар явуулаагүй юм шүү. Чиний үүрэг бол Аллахын айлдварыг (шашныг) хүргэх л явдал мөн. Бид хүмүүнд хайр энэрэлээ үзүүлбэл тэд баярлан хөөрцөглөнө. Харин үйлдсэн хэрэгээсээ болж ямар нэгэн гай барцат тохиолдвол хүн гэдэг амьтан үнэндээ Аллахыг умартана.
49. Тэнгэр, газрын эзэгнэл гагцхүү Аллахын мэдэлд болой. Тэр хүссэнээ бүтээж, хүссэн хэн нэгэнд охин үр, хүссэн нэгэнд нь хүү хайрладаг.
50. Аль эсвэл охин, хөвүүнийг хослон хайрладаг. Мөн хүссэн нэгнээ үр удамгүй болгодог. Тэр бүхнийг мэдэгч бөгөөд хүчирхэг билээ.
51. Аллах хүмүүстэй зөвхөн айлдвараар дамжуулан, эсвэл хөшигний цаанаас (үл үзэгдэх байдлаар) үгүй бол гэгээн элч илгээж, өөрийн зөвшөөрснөөр түүнд хүссэнээ амлалт айлдвар болгох замаар ярилцдаг. Аллах үнэхээр аугаа бөгөөд мэргэн ухааны эзэн билээ.
52. Ийнхүү (Бусад гэгээн элч нарт илгээсний адил) Бид өөрийн тушаалаар чамд ч Кураныг илгээлээ. Харин чи тэр болтол судар хийгээд сүсэглэл нь юу гэдгийг мэдэхгүй асан билээ. Гэвч Бид өөрсдийн боолуудаас хүссэн хүнээ зөв замд залахын тулд Кураныг сэтгэлийн гэрэл гэгээ болгосон. Эргэлзээгүй чи ч гэсэн зөв шулуун зам руу уриалан хөтлөх болно.

53. Тэрхүү зам бол тэнгэр, газарт буй бүхнийг эзэгнэсэн Аллахын зам болой. Мэдтүгэй! Бүхий л үйл хэрэг Аллахын өмнө буцах болно.

### 43.СУРЕ ЗҮХРУФ

Мекке-д илгээгдсэн. 86 айлдвар

#### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Ха, Мим.
2. Яруу тод судраар андгайлан тангараглая.
3. Үнэхээр та нарт ойлгуулах үүднээс Кураныг араб хэлээр илгээсэн.
4. Куран бол Бидний нигур дор буй үндсэн эх сударт (Лаухул Махфуз-д) ч тодорхой бөгөөд эрхэм, мэргэн ухаанаар дүүрэн судар болой.
5. Та нар хэмээс хэтэрсэн хүмүүс тул Бид ухуулан-сэнхрүүлэхээ болих юм гэж үү дээ?
6. Урьд өмнөх зон олонд хэд хэдэн гэгээн элч нарыг илгээсэн.
7. Гэгээн элч нар ирэх бүрт тэд доог тохуу хийсэн юм.
8. Бид тэдний (Меккегийн буруу номтнуудаас) доторх хүч чадалтнуудыг ч сүйрүүлсэн билээ. Куранд урьд өмнөхүүдийн тухай жишээ болгон өгүүлэгдсэн болой.
9. Хэрэв, тэднээс: “Тэнгэр, газрыг хэн бүтээсэн бэ?” хэмээн асуувал: “Ялагдашгүй, аугаа мэдлэгийн эзэн Аллах бүтээсэн” хэмээн хариулцгаана.
10. Аллах та нарт газар дэлхийг тааламжтай өлгий болгож, тэнд зөв зохистой яваг хэмээн шулуун замыг буй болгосон билээ.
11. Тэр тэнгэрээс зохих хэмжээгээр хурыг буулгаж, Бид (Аллах) түүгээр үхмэл газрыг амилуулав. Ийнхүү та нар ч (булшнаасаа) дахин гарна.
12. Аллах бүхий л амьд амьтадыг янз бүрээр бүтээсэн. Та нар сууж зорчихын тулд хөлөг онгоцыг, уналганд адгуус амьтадыг бүтээсэн билээ.
13. Та нар тэдний нуруун дээр суусны дараа Эзэнтнийхээ ивээл хайрыг ухаарч ойлгон: “Бидэнд үүнийг эрхшээж өгсөн Аллах алив муухайгаас ангид бөгөөд тэр л ийнхүү бүтээхгүй бол эдгээрт ойртож ч чадахгүй байсан”;
14. Бид үнэхээр Эзэнтнийхээ өмнө эргэж очих болно шүү” гэлцэнэ.
15. Хэдий тийм ч тэд (буруу номтнууд) Аллахын боолуудын нэг хэсгийг (мэлэкүүдийг Аллахын охин хэмээж) Түүний нэг хэсэг болгон сүсэглэсэн. Ийнхүү хүмүүн үнэхээр ачийг эс санагч харалган юм.

16. Аллах бүтээснээсээ охидыг өөртөө аваад, хөвгүүдийг та нарт заяалаа гэж үү дээ?
17. Тэдний нэгэнд нь Аллахын тухай (Аллах охинтой гэж) зохиож буйгаа адил “Эхнэр чинь охин төрүүллээ” хэмээн баярт мэдээг дуулгавал, тэр хилэгнэн уурлаж, баргар царайлана.
18. Аль эсвэл гоёж гоодон өсөж, насанд хүрсэн ч хэрүүл маргаанаар өөрийн зорилгоо тайлбарлаж чаддаггүй ичимтгий даруу охидыг л Аллахад нялцаах гэж үү?
19. Тэд энэрэн нигүүлсэгч Аллахын боолууд болох мэлэжүүдийг ч эмэгтэй хэмээн зүйрлэв. Мэлэжүүд бүтээгдэхэд тэд хажууд нь байж, гэрчлэн харсан гэж үү? Тэдний (худал) гэрчлэл бүхэн үйлийн дэвтэрт бичигдэнэ. Төгсгөлийн өдөр тэд шүүгдэх болно.
20. Тэд: “Машид нигүүлсэгч Аллах хүсвэл бид тэдэнд (мэлэжүүдэд) мөргөхгүй байсан билээ” хэмээв. Энэ тухайд тэдэнд ямар ч мэдлэг байхгүй бөгөөд бүгд худлаа цуурдаг.
21. Аль эсвэл тэдэнд Куранаас өмнө өөр нэгэн судар илгээсэн гэж үү? Тэд түүнтэй зууралдаж байгаа юм гэж үү?
22. Үгүй ээ! Тэд эсрэгээрээ: “Манай өвөг дээдэс нэгэн шашныг баримталж асныг үнэндээ мэдэх юм. Бид ч тэдний мөрөөр явж замыг олно” хэмээнэ.
23. Бид чамаас өмнө аливаа улст гэгээн элч илгээхэд тэндэхийн чинээлэг эрхэмүүд: “Манай өвөг дээдэс нэгэн шашныг баримталж асныг үнэндээ мэдэх юм. Бид ч тэдний замаар замнах болно” гэсэн билээ.
24. Гэгээн элч бүр өөрсдийнхөө ардуудад хандан: “Хэрэв Би та нарын өвөг дээдсийн итгэсэн шашныг бодоход арай зөв шударга шашныг авч ирвэл ямар вэ?” хэмээн хэлсэн. Тэд: “Чиний авчирсан шашинд итгэж чадахгүй” хэмээн хариулцгаасан юм.
25. Эцэст нь Бид ч тэднээс өшөө авсан. Зөв шударга замыг хүлээн зөвшөөрөөгүй хүмүүсийн хувь тавилан хэрхэн төгссөнийг хар л даа!
26. Нэгэнтээ Ибрахим эцэгтээ болон ард олондоо хандан: “Би та нарын тахин шүтсэн бүхнээс ангид оршимой.
27. Гагцхүү бүхнийг бүтээгч Аллах л намайг зөв шулуун замаар хөтлөнө” хэмээн хэлсэн.
28. Ибрахим энэхүү мөнхийн чин үнэн үгээ хойч үеийнхэнд ч (наминчлан сүсэглэхэд нь) захиас болгон үлдээсэн билээ.
29. Гэлээ ч гэсэн Би тэднийг (Меккегийн үл сүсэглэгчдийг) болон өвөг дээдсийг нь ч, өөрсдөд нь чин үнэн (Куран) хийгээд түүнийг тайлбарлагч гэгээн элч (Мухаммед) ирэх хүртэл энэ хорвоогийн хувь хишиг, урт удаан амьдралаар тэтгэсэн билээ.

30. Гэвч өөрсдөд нь чин үнэн ирэхүйд: “Энэ бол ердөө л илбэний ид шид, бид түүнд итгэхгүй” гэлцэв.
31. Мөн тэд: “Энэхүү Куран нь Мекке болон Тайф хотуудын нэгэн эрхмүүд (Уалид ибн Мугийра, Гаруа ибн Масгут) мэтэд яагаад илгээгдээгүй юм вэ?” хэмээн гомдоллов.
32. (Аяа, Мухаммед) Эзэнтний чинь хувь хишгийг тэд таслан хувааж болно гэж үү дээ? Бид тэдэнд амьд ахуйн хэрэгцээт бүхнийг хувааж хүртээсэн билээ. Өөрсдийгөө удирдан захираг хэмээн тэдний эрх ямбыг тогтоож өгсөн юм. Тэдний уураасан эд зүйлсээс Эзэнтний чинь хайр энэрэл хавьгүй өлзийтэй.
33. Хэрэв, хүмүүс үл сүсэглэгч нэгэн бүлэглэл болон хуваагдахгүйсэн бол Бид Машид нигүүлсэгчийг үгүйсгэгсэдийн орон гэрийн дээвэр туургыг, гишгүүр шатыг нь мөнгөөр урлаж өгөх байсан.
34. Бид тэдний орон гэрийнх нь хаалга үүдийг нь, тухлах суудлыг нь ч мөнгөөр хийж өгөхсөн дээ.
35. Бүүр заримыг нь алтаар ч урлан бүтээхсэн билээ. Гэвч энэ бүхэн нь ердөө л амьд ахуйн зуурдын тансаглал төдий юм. Харин Эзэнтний чинь мэдэлд буй сайн сайхан нь зөвхөн гэгээн сүсэгтнүүдийнх болой.
36. Хэн нэгэн нигүүлсэгч Аллаыхыг санан дурсахгүйгээр, сүсэглэн залбирахгүйгээр нүдээ аньвал Бид түүнийг нэгэн чөтгөрөөр дагалдуулах бөгөөд чөтгөрийн дотны нөхөр болно.
37. Чөтгөр шулмас тэднийг зөв шулуун замаас нь гарцаагүй төөрөгдүүлнэ. Харин тэд өөрсдийгөө зөв шулуун зам дээр буй хэмээн бодоцгооно.
38. Тэд хойд ертөнцөд бидэн дээр ирэхдээ нөгөө нөхөртөө (чөтгөрт) найздаа хандан: “Даанч дээ! Чи бид хоёрын хоорондох зай өрнө болоод дорнын хоорондын дайтай байсан ч болоосой! Чи юун лайтай нөхөр вэ?” хэмээн халаглана.
39. Тэдэнд: “Та нар өмнө нь харгис зальхай байсан. Өнөөдөр шүүгдэн гэгсээгдэнэ. Тиймээс хожимдсон харамсал чинь ямар ч ашиг тус өгөхгүй” хэмээгдэх болно.
40. (Аяа, Мухаммед!) Дүлийчүүдэд үгээ сонсгож чадна гэж үү? Сохорсон хүмүүсийг зөв замаар явуулж чадах уу? Илэрхий төөрөлдөгсөдийг төөрөгдүүлэхгүй байж чадах юм уу?
41. Хэрэв Бид чамайг тэдний дундаас авч одлоо ч (үхүүлсэн ч) тэдэнд зохих шийтгэлийг нь өгөх болно.
42. Аль эсвэл тэдэнд амалагдсан гэгсээлийг нь амьд сэрүүнд ч ирүүлж чамд харуулна. Бидний хүч чадал үүнд бүрэн хүрэлцээтэй.
43. Тиймээс чамд илгээгдсэн Кураныг сахин баримтал! Чи эргэлзээгүй зөв шулуун зам дээр буй.

44. Куран чамд болон чиний ард олонд асар их бахархал мөн. Хожим хойд ертөнцөд энэ талаар асуугдах болно шүү.
45. Чамаас өмнө илгээсэн гэгээн элчүүдээс минь: “Бид энэрэлт нигүүлсэнгүй Аллахаас ондоо сүсэглэн мөргөх бурхадыг үзсэн үү?” хэмээн асуугтун.
46. Бид үнэхээр Мусаг ер бусын гайхамшигуудтай Фиргаун болон түүний хамаатнуудад явуулсан юм. Муса тэдэнд: “Би бол бүхий л ертөнцийн Эзэнтний гэгээн элч мөн” хэмээн хэлсэн.
47. Бидний ер бусын гайхамшигуудыг авч ирсэн ч тэд доог тохуу хийсэн билээ.
48. Бид тэдэнд улам илүү гайхамшгуудыг харуулан, магад зөв зам руу орох байх хэмээн гэсгээл явуулан цээрлүүлж үзсэн.
49. Гэвч тэд: “Хүүе ээ! Илбэчин гуай! Чамд өгөгдсөн амлалт ёсоор Эзэнтэндээ залбир. Биднийг гэсгээлээс авраг. Тэгээд бид зөв шулуун зам руу орцгооё!” гэлцэв.
50. Бид тэднийг Мусагийн айлдвараар гэсгээлээс аврахад тэд хэлсэн үгнээсээ буцаж, (бас л үл тоомсорлосоор үлдсэн.)
51. Фиргаун ард олондоо хандан: “Аяа, ард олон минь! Мисирийн хаанчлал хийгээд хажуугаар минь урсаж буй гол мөрөнгүүд минийх биш гэж үү? Та нар миний аугаа болохыг харахгүй байна уу?”
52. Би бол дожоогүй дорой, үгээ ч олигтой хэлж чаддаггүй (Мусагаас) дээр биз дээ?
53. Хэрэв, үнэхээр гэгээн элч байвал түүн дээр тэнгэрээс алтан бугуйвч яагаад хур бороо мэт асгардаггүй юм вэ? Мэлэкүүд түүнтэй нөхөрлөн яагаад хамт ирдэггүй юм вэ?” гэв.
54. Ийнхүү Фиргаун олон түмнээ мэхлэн албадсан тул хүмүүс нь ч түүний үгэнд орлоо. Тэд угаас бүтэлгүй хүмүүс байсан юм.
55. Биднийг ийнхүү хилэгнүүлсэн тул зохих шийтгэлийг нь хүлээлгэж, бүгдийг нь усанд живүүлсэн билээ.
56. Тэднийг хойч үеийнхэнд сургамж, жишээ болгосон болой.
57. Мариамын хүү Исаг (Есүсийг) жишээ болгон ярихуйд түүний ард олон шуугилдан инээдэм болгосон.
58. Тэд: “Бидний бурхад сайн юм уу? Эсвэл Иса илүү сайн юм уу?” гэлцэв. Энэхүү жишээ нь тэдний хувьд хэрүүл л төдий. Учир нь тэд угаас хэрүүлч улс билээ.
59. Иса бол Христүүдийн хэлдгээр Аллахын хүү биш, бид гагцхүү гэгээн элч болгосон хүн л дээ. Израйлын үр саад (ид шидээ үзүүлэхэд) үлгэр дуурайлал, жишээ болгосон болой.
60. Хэрэв хүсвэл та нарт зориулан газар дэлхий дээр та нарыг залгамжлах мэлэкүүдийг бүтээх л байсан билээ.



61. Тэр ертөнцийн төгсгөлийн үнэний хувьд цаг хугацааны тэмдэг болой. Түүнд эргэлзэхгүйгээр намайг дагагтун. Энэ нь шулуун зам мөн.
62. Чөтгөр шулам та нарыг бүү төөрөгдүүлэг. Тэр та нарын атаат дайсан мөн.
63. Иса яруу тод нотолгоонуудтай ирээд тэдэнд: “Би та нарт эрдэм мэдлэг авч ирлээ. Та нарын маргалдаж буй зарим юмны тухайд тайлбар өгнө. Аллахаас айгтун, намайг дагагтун;
64. Аллах эргэлзээгүй миний ч, та нарын ч Эзэнтэн мөн. Түүнд залбирагтун. Энэ бол шулуун зам мөн” хэмээн хэлэв.
65. Христүүдийн бүлэглэлүүд Исагийн талаар хоорондоо маргалдаж эхлэв. Харгис зальхай этгээдүүдийн хойд ертөнц дэх гэсгээл нь юутай зовлонтой гэч!
66. Тэд ертөнцийн төгсгөлийн өдөр өөрсдөд нь анзааруулахгүй гэнэт ирэхийг л хүлээнэ үү?
67. Тэр өдөр Аллахаас айгсадаас бусад нь, анд найзууд хүртэл нэг нэгэндээ дайсагнацгааж, гагцхүү гэгээн сүсэгтнүүд л харилцан анд байх болно.
68. Аллах тэдэнд: “Аяа, боолууд минь! Өнөөдөр та нарт айдас ч, уйтгар гуниг ч үгүй” хэмээн айлдана.
69. Тэд Бидний айлдваруудад итгэсэн Муслуманчууд билээ.
70. “Та нар хань ижлүүдтэй хамт хөөрөн баясаж диваажинд орцгоогтун” хэмээгдэнэ.
71. Тэдэнд бал бурам, амтат ундаагаар дүүргэсэн алтан таваг, алтан аяга ээлжлэн баримуй. Тэнд сэтгэл сэргээх, нүд баясгах зүйлс хүрэлцээтэй буй. Та нар диваажинд эгнэгт оршимуй.
72. Хийсэн сайн үйлсийн чинь хариуд өвлүүлсэн диваажин нь энэ болой.
73. Тэнд та нарт зориулсан элбэг хангалуун жимс жимсгэнэ буй. Түүнээс хүртэцгээх болно.
74. Нүгэлтэнгүүд тамын гэсгээлд эгнэгт үлдэх нь эргэлзээгүй.
75. Тэдний гэсгээл нь хөнгөвчлөгдөхгүй. Тэд Аллахын ивээл энэрэлээс горьдлого тасарч хоцроно.
76. Бид тэдэнд муу юм хийгээгүй. Харин тэд өөрсдөө харгис зальхай байсан юм.
77. Тэд тамыг хариуцагч мэлэкүүдэд хандан: “Аяа, Малик! Эзэнтэн чинь бидний хэргийг бушуухан авч үзэг!” Аллах тунгаагтун” хэмээн орилцгооно. Малик: “Үгүй дээ, та нар мөнх ийнхүү тарчилсаар байх болно” хэмээнэ.
78. Бид та нарт чин үнэнийг (шашныг) авч ирсэн билээ. Гэвч та нарын олонхи нь чин үнэнийг голсон юм.
79. Гэгээн элч Мухаммедийн эсрэг ямар нэгэн санаа өвөрлөвөл Бид ч

Мухаммедэд туслахын тулд тэдний эсрэг ямар нэгэн арга хэмжээг авах болно.

80. Аль эсвэл тэд өөрсдийнх нь нууц санааг, далд яриаг нь Бид сонсдоггүй хэмээн бодно уу? Тийм биш ээ. Бидний элч мэлэжүүд (Хафаза нар) тэдний хийсэн бүхнийг нь бичиж байдаг юм.
81. (Аяа, Мухаммед!) “Хэрэв энэрэлт, нигүүлсэнгүй Аллахын нэгэн хүүхэд байсансан бол би ч түүнд эхлээд л сүсэглэн залбирах л байсан” хэмээн хэлэгтүн.
82. Тэнгэр, газрын Эзэнтэн, аугаа сансар огторгуйн Эзэнтэн Аллах бол тэдний зүйрлэн хэлсэн бүхнээс ангид болой.
83. Одоо тэднийг (Меккегийн буруу номтнуудыг) зөнгөөр нь орхи, амлагдсан өдөр хүртэл хууртаг, хөөрөн баясаг.
84. Тэнгэрийн ч, газрын ч бурхан Аллах мөн. Тэр эрдэм мэдлэгийн эзэн, аугаа ухаантан билээ.
85. Тэнгэр, газар хийгээд тэдгээрийн хооронд буй бүхний эзэгнэл гагцхүү Өөрт нь орших Аллах нэн эрхэмсэг болой. Ертөнцийн төгсгөлийн цагийг зөвхөн тэр л мэднэ. Та нар ч Түүний өмнө буцаж очих болно.
86. Аллахыг орхиж тахин шүтсэн зохиомол бурхад ивээн энэрэх чадваргүй. Гагцхүү чин үнэнийг мэдэж гэрчлэгсэд өөр шүү дээ.
87. Хэрэв, тэднээс: “Өөрсдийг чинь хэн бүтээсэн вэ?” гэж асуувал тэд гарцаагүй “Аллах” хэмээцгээнэ. Ийм атал Аллахт залбирахгүйгээр, хиймэл зүйлийг тахин шүтэхийн тулд яахлаар тэмүүлцгээдэг вэ?
88. Гэгээн элч нарын: “Аяа, Эзэнтэн минь! Үнэндээ тэд үл сүсэглэгч ардуудаа” хэмээн хэлснийг Аллах мэддэг билээ.
89. Аллах: “Чи тэднээс нүүр буруул, харин мэндэлж бай. Тэд үл тоомсорлолынхоо уршгийг мөдхөн ойлгох болно” хэмээн айлдав.



Мекке-д илгээгдсэн. 59 айлдвар



*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Ха, Мим.
2. Яруу тод судраар андгайлан тангараглая.
3. Бид түүнийг (Кураныг) нэгэн ивээлтэй шөнө (Кадир буюу ерөөлтэй шөнө) буулгасан юм. Бид үнэндээ сэрэмжлүүлэгсэд болой.
4. Энэхүү шөнө бүхий л ер бусын гайхамшигтай үйлс тодорхойлогдох

- аж. Ер бусаар зарлигддаг боолуудын хувь хишиг, үхэл, тавилан бүгд л тодорхойлогдоно.
5. Тэд бүгд энэхүү шөнө тохиосон үйлс бүхэн Бидний зүгээс илгээгдсэн тушаал билээ. Бид гагцхүү элч нарыг илгээгээд туршдаг юм.
  6. Энэ нь Эзэнтний чинь хайр энэрэл мөн. Тэр эргэлзээгүй бүхий л дуу чимээг сонсогч, бүхий л үйл явдлыг мэдэгч билээ.
  7. Хэрэв, та нар баттай итгэдэг юм бол Аллах тэнгэр, газар хийгээд тэдгээрийн хоорондох бүхний Эзэнтэн мөн.
  8. Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Тэр үхсэнийг амилуулна. Амьдыг үхүүлнэ. Аллах та нарын ч, урьд өмнөх өвөг дээдсийн ч Эзэнтэн мөн.
  9. Гэвч тэд (үл сүсэглэгсэд) эргэлзэн үнэнийг доог тохуу болгон тоглоно.
  10. Аяа, Мухаммед! Тэнгэрийг илэрхий утаа бүрхэх өдрийг (тэдэнд гэсгээл аюул ирэх өдрийг) хүлээ!
  11. Энэ нь хүмүүсийг бүчин бүрхэж авна. Тэр нь гашуун зовлонг гэсгээл болй.
  12. Тэр үед хүмүүс: “Аяа, Эзэнтэн минь! Биднээс энэхүү гэсгээлээ зайлуулж аль? Бид үнэхээр сүсэглэн залбирсан шүү” хэмээцгээнэ.
  13. Тэд сургамж авна ч гэж, юу байхав? Үнэндээ тэдэнд үнэнийг тайлбарлагч нэгэн гэгээн элч ирсэн билээ.
  14. Тэд түүнээс нүүр буруулцгаан: “Энэ бол зориуд сургасан солиотон байна” хэмээв.
  15. Бид гэсгээлээ та нараас түр зуурхан холдуулна. Гэтэл та нар дахин бахь байдагтаа орцгооно доо.
  16. Гэвч анхааралдаа авсан өдөр үг дуугүй хатуу цээрлүүлэн, өшөөгөө авах болно.
  17. Тэднээс өмнө Бид Фиргауны ард олныг ч сорьсон юм. Тэдэнд нэгэн эрхэм гэгээн элч (Муса) ирсэн билээ.
  18. Тэр тэдэнд: “Аллахын боолуудыг (Израйлын үр садыг) надад хүлээлгэн өгөгтүн. Учир нь би Аллахын итгэлт гэгээн элч байнам.
  19. Аллахын эсрэг өөрсдийгөө бүү өргөмжил. Яагаад гэвэл би та нарт яруу тод нотолгоо авч ирлээ.
  20. Та нар намайг чулуугаар нүдэхээс чинь айхгүй. Би та нарын болон өөрийн Эзэнтэндээ залбирнам.
  21. Хэрэв, надад эс итгэх аваас хажуунаас минь холдон, боломж өгөгтүн” хэмээн хэлэв.
  22. Мөн Муса: “Эдгээр нь нүгэлтэн ард юм аа” хэмээн Эзэнтэндээ залбирав.
  23. Аллах Мусад хандан: “Тийм бол боолуудыг маань (Израйлын үр садыг)

- шөнө авч гарагтун. Эргэлзээгүй, хойноос чинь мөшгөн мөрдөнө шүү!” хэмээн айлдав.
24. “Тэнгисийг гаталсны дараа таягаараа тэнгисийг хоёр тийш ярж хуваасан хэвээр тайван орхи. Тэдний дайчид гарцаагүй усанд живэх болно” хэмээн айлдав.
  25. Тэдний тариалангийн талбай,...
  26. мал сүрэг, орд харш, цэцэрлэг, гол горхи нь хөсөр хаягдав.
  27. Өөрсдөө ач тусыг нь үзэж тансагласан баялаг нь үлдлээ.
  28. Ийнхүү Бид тэднийг өөр хүмүүс (Израйлын ардуудад) өв хөрөнгө болгон өгсөн юм.
  29. Тэнгэр, газар ч тэдний араас гашуудан уйлаагүй. Тэдэнд хүлцэн очих хугацаа ч өгөгдөөгүй юм.
  30. Үнэндээ, Бид Израйлын үр садыг тэр гэгсгээл зовлонгоос аварсан билээ.
  31. Фиргаунаас л аварсан юм. Учир нь тэр биеэ тоосон, хэрээс хэтэрсэн нэгэн байлаа.
  32. Хэрэг дээр Бид Израйлын үр садыг эрдэм мэдлэгийн дагуу тухайн цагийн бүхнээс эрхэмлэн дээдэлсэн юм шүү.
  33. Бид тэдэнд илэрхий сорилт бүхий хэд хэдэн ер бусын гайхамшигуудыг өгсөн.
  34. Тэд (буруу номтнууд) ийн хэлж баймуй:
  35. “Бидэнд цор ганц анхны үхлээс өөр юм гэж үгүй. Бид дахин амилуулагдахгүй;
  36. Хэрэв та нарын үг үнэн бол өвөг дээдсийг маань амилуулан аваад ир л дээ!” гэнэ.
  37. Тэд (үл сүсэглэгсэд) хүчтэй юу, эсвэл Тубба-гийн ард хүчтэй юу? Тэднээс өмнөх олныг ч сөнөөсөн юм. Тэд жинхэнэ нүгэлтнүүд байсан юм.
  38. Бид тэнгэр, газар хийгээд тэдгээрийн хооронд буй бүхнийг зугаа цэнгэл болгон цаг нөхцөөхийн төлөө бүтээгээгүй юм шүү.
  39. Тэднийг чин үнэн хийгээд далдын мэргэн ухаанаар бүтээсэн. Гэвч хүмүүсийн олонхи нь үүнийг мэддэггүй.
  40. Хар, цагаан шүүгдэн ялгах өдөр бол бүгдээрээ нэг дор цугларах өдөр болой.
  41. Тэр өдөр анд нь анддаа ямар ч тусыг үзүүлж чадахгүй бөгөөд туслах чадамжгүй ч болно.
  42. Гагцхүү Аллахын хайрлан энэрсэн хэн нэгэн өөр шүү дээ. Эргэлзээгүй, Аллах машид хүчирхэг хийгээд нэн энэрэгч бөлгөө.
  43. Эргэлзээгүй, Заккумын мод нь
  44. Илэрхий нүгэлтэн нарын хоол болой;

45. Тэр бүхэн хайлсан зэс мэт ходоод гэдсэнд нь буцална.
46. Бургилан буцлах усны адил болой.
47. Аллах тамыг хариуцагч мэлхүүдэд ийн тушаадаг: “Түүнийг баривчлан, халуун тамын гол руу чирээд аваачиж хаягтун!”;
48. Дараа нь толгойд нь гэгсгээлийн буцлам усыг асгагтун!”
49. Мөн ёжлон: “Нэгэн цагт чи эрхэм ичгүүртэй амьтан юмсан. Одоо энэхүү гэгсгээлийн амтыг үзэгтүн!
50. Энэ нь амьд ахуйд та нарын эргэлзээд асан зүйл чинь билээ” хэмээгдэнэ.
51. Харин гэгээн сүсэгтнүүд аюулгүй газарт байнам. Тухайлбал:
52. Цэцэрлэгт хүрээлэн хийгээд гол горхинуудын дунд;
53. Хоргой торгоор гоёж, өөд өдөөсөө харцгаан, амирлангүй сууна.
54. Бид тэднийг тунгалаг хар нүдтэй гоо бүсгүйчүүдтэй гэрлүүлнэ.
55. Амар амгалан дунд төрөл бүрийн амтат жимсээр дайлах болно.
56. Тэд амьд хорвоогийн анхны үхлээс өөр ямар ч үхлийг үзэхгүй. Аллах тэднийг халуун тамын гэгсгээлээс хамгаалсан билээ.
57. Энэ нь Эзэнтний онцгой хайр энэрэл бөгөөд хүсэл мөрөөдлөө биелүүлнэ гэдэг энэ болой.
58. Аяа, Мухаммед! Бид Кураныг ухаарч сургамж аваг хэмээн хялбарчлан чиний хэлээр буулгасан юм шүү.
59. (Үл сүсэглэгсэд тохиох гэгсгээлийг) чи ч хүлээ, тэд ч хүлээцгээж байна.

## 45. СУРЕ ЖАСИЯ

Мекке-д илгээгдсэн. 37 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Ха, Мим.
2. Энэхүү судар нь аугаа хүчирхэг, мэргэн ухааны эзэн Аллахын зүгээс буулгагдсан болой.
3. Тэнгэр, газарт үнэн сүсэглэгсэдийн төлөө (Аллахын байгаа эсэх, түүний ид шидийн талаар) олон тооны нотолгоонууд буй.
4. Та нарын бүтээгдэх тухайд, Аллахын дэлхий даяар өсгөн үржүүлсэн адгуус амьтадын талаар итгэдэг хүмүүсийн хувьд сургамж болох нотолгоонууд буй.
5. Өдөр, шөнийн ээлжлэн солигдоход нь, Аллахын тэнгэрээс хурыг буулгаж үүгээр үхмэл газрыг амилуулахад нь, салхины чиглэлийг өөрчлөхөд нь ухаалаг хүмүүсийн хувьд олон тооны нотолгоонууд буй.

6. Аяа, Мухаммед! Эдгээр нь Аллахын айлдварууд мөн. Бид үүнийг чамд чин үнэнээр уншиж өгнө. Тэд (Меккегийн үл сүсэглэгчид) Аллах хийгээд Түүний айлдваруудаас өөр ямар үгэнд итгэцгээх гэсэн юм бэ?
7. Алив худалч хийгээд нүгэлтний хувьд энэ нь юутай харамсал гээч!
8. Тэд Аллахын айлдварууд өөрт нь уншигдахуйд сонссон атал сонсоогүй дүр эсгэн биеэ тооно. Иймд тэдэнд аюултай гэсгээлийн тухай мэдээг дуулгаарай.
9. Тэрээр Бидний айлдваруудаас нэгэн зүйлийг мэдвэл түүнийг доог тохуу болгодог. Зовлонт гэсгээл тэдэнд зориулагдмуй.
10. Тэдний өмнө халуун там хүлээж байгаа. Эд баялаг хураасан зүйлс нь ч, Аллахыг орхиж нөхөрлөсөн зүйлс нь ч өөрсдөд нь ямар ч тус хүргэж чадахгүй. Тэд хатуу гэсгээлтэй учрана.
11. Куран бол зөв шулуун зам руу залагч. Эзэнтнийхээ айлдваруудыг үгүйсгэгсдэд шийтгэлийн хувьд тарчилган зовоох гэсгээл буй.
12. Аллах тэнгис далайг та нарт эрхшээж өгнө. Түүний тушаалаар тэнгис далайг хөлөг онгоцоор гатлана. Түүний өгөөмөр баялагаас нь буян хишиг хайж олон, талархах болно.
13. Тэр тэнгэр, газарт буй бүхнийг Өөрийн зүгээс та нарт захируулж өгсөн. Үүнд эрэгцүүлэн бодох хүмүүст зохих нотолгоонууд буй.
14. (Аяа, Мухаммед!) Үнэн сүсэгнүүдэд ийн хэлэгтүн: “Аллах алив түмнийг хийснээр нь цээрлүүлдэг тул тэд Аллахын гэсгээлт өдрийг үл горьддог буруу номтнуудаас үзсэн зовлон бэрхшээлийг өршөөн хэлтэрүүлэг.
15. Хэн сайн үйл үйлдэнэ, ашиг тус нь өөрт нь, хэн муу үйл үйлдэнэ хор хөнөөл нь өөрт нь оногдоно. Дараа нь та нар бүгдээрээ Эзэнтнийхээ өмнө эргэж очих болно.
16. Бид үнэндээ Израйлын үр садад ариун судар, эрдэм мэдлэг, гэгээн элчийг хайрлан, ариун буян хишиг хүртээж, тэднийг энэ хорвоогийн ард түмнээс дээгүүр өргөмжилсөн билээ.
17. Бид шашны хувьд тэдэнд (сайн, муу хоёрыг ялгах) яруу тод нотолгоонууд өгсөн юм. Тэд өөрсдөд нь эрдэм мэдлэг ирсний (өгөгдсөний) дараа бие биесээ атаархан, маргалдан зөрчилдсөн. Эзэнтэн тэдний маргалдан зөрчилдсөн зүйлийн тухайд ертөнцийн төгсгөлийн өдөр шүүн тунгаах нь эргэлзээгүй юм.
18. Аяа, Мухаммед! Дараа нь чамайг шашны зам руу залсан. Тэрхүү замаас бүү гар. Мунхагуудын (үл сүсэглэгсэдийн) дур зоргоор жолоогоо бүү алдагтун.
19. Яагаад гэвэл тэд чамайг Аллахын шийтгэлээс хэзээ ч өмгөөлөн аварч эс чадна. Харгис зальхайнууд өөр хоорондоо анд нөхөд, харин Аллах гэгээн сүсэгтнүүдийн анд болой.

20. Куран бол хүмүүсийн хувьд яруу тод нотолгоо, сүсэглэн итгэгчдийн хувьд хөтлөн залагч, хайр энэрэл бөлгөө.
21. Муу үйл үйлдэгсэд (буруу номтнууд) бидэнд буянтай үйл үйлдэн сүсэглэгчидтэй өөрсдийг адил үзэхийг биднээс хүснэ үү? Энэ хорвоо болон хойт насанд ч өөрсдийгөө сүсэглэн, сайн үйл үйлдэгсэдтэй адилтгана хэмээн бодоцгоож байна уу? Энэ нь боломжгүй зүйл. Тэд ямар муухай шийдвэр гаргахыг санаархана вэ?
22. Аллах тэнгэр, газрыг чин үнэний үндсэн дээр бүтээсэн. Хүн бүрт хийсэн хэргийн хэрээр хариу өгөх болно. Хүмүүст шударга бусаар хандахгүй.
23. Аяа, Мухаммед! Сэтгэлд нь таалсан бүхнийг бурхан болгосон, Аллах энэ тухай мэдэж төөрөгдүүлсэн, чих болон зүрх сэтгэлийг нь битүүлэн, нүдний өмнө хөшиг татсан хүнийг харсан уу? Аллах төөрүүлсэн этгээдийг Аллахаас өөр хэн зөв замд нь оруулна гэж? Үүнийг ойлгохгүй байна гэж үү?
24. Тэд (янз бүрийн бурхан шүтэгсэд): “Бидний амь зуулга зөвхөн амьд ахуйн хорвоод л буй. Бид төрнө, амьдарна, үхнэ. Биднийг гагцхүү цаг хугацаа л үхүүлнэ” гэнэ. Гэвч тэдэнд энэ тухай ямар ч мэдлэг үгүй. Энэ бол тэдний хувьд зөвхөн таамаг, хоосон мөрөөдөл төдий зүйл.
25. Тэдэнд Бидний айлдварууд яруу тодоор уншигдахуйд тэд ямар ч нотолгоо үзүүлж эс чадна, гагцхүү: “Хэрэв та нарын хэлсэн үг үнэн юм бол өвөг дээдсийг маань амилуулан ирэгтүн” гэнэ.
26. (Аяа, Мухаммед!) “Аллах та нарыг амилуулна, дараа нь үхүүлнэ. Тэгээд эргэлзээгүй тохиох ертөнцийн төгсгөлийн өдөр та нарыг нэг дор цуглуулан уулзуулах болно. Гэвч хүмүүсийн олонхи нь үүнийг ойлгоддоггүй юм. (Дахин амилуулахыг хүлээн зөвшөөрдөггүй)” гэж хэлээрэй.
27. Тэнгэр, газрын эзэгнэл нь зөвхөн Аллахынх. Ертөнцийн төгсгөлийн өдөр бүтэлгүйчүүд хор хөнөөлд автацгаана.
28. Тэр өдөр бүхий л ард түмэн айж сөхөрсөн байхыг чи үзэх болно. Бүгдээрээ өөрсдийнхөө үйлийн дэвтэрт дуудагдахуйд тэдэнд: “Өнөөдөр үйлдсэн хэргийнхээ хэр хэмжээгээр хариугаа авцгаах болно” хэмээгдэнэ.
29. “Бидний энэхүү судар (үйлийн дэвтэр) бол та нарт чин үнэнийг өгүүлнэ. Учир нь та нарт хийсэн үйл хэргийг үйлийнхээ дэвтэрт чинь бичүүлчихсэн юм”
30. Харин итгэж сүсэглэн, сайн үйл үйлдэгсэдийг Аллах өөрийнхөө хайр энэрэлд багтаана. Энэ нь жинхэнэ хүсэл мөрөөдлөө биелүүлсэн явдал мөн.
31. Харин буруу номтнуудад: “Айлдварууд маань та нарт уншигдаагүй юм

уу? Тэр үед та нар биеэ тоон бардамнаж, итгэн сүсэглэхээс татгалзсан шүү дээ. Та нар нүгэлтэй улс мөн” хэмээгдэнэ.

32. “Аллахын амлалт чин үнэн. Ертөнцийн төгсгөл ирэх нь ямар ч эргэлзээгүй” хэмээгдэхүйд, та нар: “Ертөнцийн төгсгөл гэж юу болохыг бид эс мэдмүй, зүгээр л хий-үзэгдэл, таамаг хэмээн боддог. Түүний тухайд мэдээлэл ч бидэнд алга” хэмээн хэлцгээнэ дээ, та нар!
33. Тэдний амьд ахуйдаа үйлдсэн муу муухай бүхэн илчлэгдэж, өөрсдөө доог тохуу хийсэн зүйлс нь тэднийг зовоох болно.
34. Тэдэнд: “Энэ өдөртэй нүүр тулахаа та нар мартсан лугаа адил Бид ч өнөөдөр та нарыг мартмуй. Та нарын очих газар халуун там бөгөөд та нарыг түүнээс аврах туслагч үгүй”
35. “Энэ нь та нар Аллахын айлдваруудыг доог тохуу хийснээс шалтгааллаа. Энэ хорвоогийн амьдралд та нар хууртсан юм” хэмээн хэлэгдэнэ. Тэд халуун тамаас гаргагдахгүй. Наминчлан залбирч, хүлцэн гэмших замаар Аллахыг баярлуулах шаардлага ч тэдэнд тавигдахгүй.
36. Бүхий л магтаал тэнгэр, газрын Эзэнтэн, бүхий л хорвоо орчлонгийн Эзэнтэн болох Аллахад зохимой.
37. Тэнгэр, газар дахь аугаа сүр жавхлан ч Аллахынх мөн. Тэр ялагдашгүй, мэргэн ухааны эзэн билээ.



Мекке-д илгээгдсэн. 35 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Ха, Мим.
2. Энэхүү судар нь нэн их хүчирхэг, мэргэн ухааны эзэн Аллахын зүгээс буулгагдсан болой.
3. Тэнгэр, газар хийгээд тэдгээрийн хооронд буй бүхнийг Бид, гагцхүү чин үнэний үндсэн дээр тодорхой хугацаанд (Ертөнцийн төгсгөлийн өдөр хүртэл) бүтээсэн. Харин үл сүсэглэгчид сэрэмжлүүлсэн зүйлсээс нүүр буруулцгааж байна.
4. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Аллахыг орхиж, түүнтэй эн зэрэгцүүлсэн зүйлсээ үзүүлээд аль? Газрын аль хэсгийг бүтээсэн юм вэ? Алив, надад харуулаадах! Эсвэл тэнгэрийг бүтээхэд тэдний хувь оролцоо байгаа юм уу? Хэрэв та нарын хэлсэн үг үнэн юм бол Куранаас өмнө илгээгдсэн судар байгаа бол үүнийг, эсвэл өмнөхүүдээс чинь үлдсэн эрдэмийн ул мөр, баримтууд байвал надад авч ирэгтүн”.
5. Аллахаас зайлсхийж ертөнцийн төгсгөлийн өдөр хүртэл бусдад



- байтугай өөрсдөд чинь үгний хариу хэлж эс чадах хиймэл бурхадыг тахин шүтсэн хүнээс илүү мунхаглан төөрөгдсөн хүн байж болох уу даа? Тэр зүйлс нь мэдээж, тэдний залбирал гуйлтаас ямар ч мэдээлэлгүй, дүйнгэ мангуу болой.
6. (Ертөнцийн төгсгөлийн өдөр) Хүмүүс нэг дор цугларах үеэр тэдэнд хиймэл бурхад нь дайсагнан гай болж, тэднийг өөрсдөд нь тахин шүтэснийг үгүйсгэх болно.
  7. Бидний айлдварууд тэдэнд яруу тодоор уншигдахуйд үл сүсэглэгсэд өөрсдөд нь илгээгдсэн чин үнэнийг (Кураныг): “Энэ бол илэрхий илбэ” хэмээсэн.
  8. Эсвэл тэд: “Кураныг Мухаммед санаанаасаа зохиосон” гэх юм уу? (Аяа, Мухаммед!) Чи тэдэнд: “Хэрэв би өөрөө зохиосон юм бол Аллахын гэгсгээлээс та нар намайг өмгөөлөн аварч чадахгүй. Кураныг үгүйсгэсэн та нарын гүтгэлгийг Аллах маш сайн мэдэж буй бөгөөд та бидний хоорондын эл гүтгэлгэд Тэр гэрч байж чадна. Тэр машид өршөөгч, нэн энэрэгч” хэмээн хэл.
  9. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Би анхны гэгээн элч биш ээ. (Өмнөх гэгээн элч нарын авч ирсэн айлдварыг би ч авч ирлээ.) Аллах та нар болон надад юу хийхийг би мэдэхгүй. Би ердөө л өөртөө айлдагдсаныг даган мөрдмүй. Би зөвхөн та нарт Аллахын гэгсгээлээс ил тод сэрэмжлүүлэгч нэгэн болой” хэмээн хэлэгтүн.
  10. (Аяа, Мухаммед!) Мөн тэдэнд: “Та нар ер нь бодож үзсэн үү? Куран Аллахын зүгээс ирсэн байхад үүнийг үгүйсгэвэл та нарын байдал юу болох билээ? Израйлын үр садаас ч хэн нэгэн (Абдулла ибн Салам) үүнийг Тауратаар (Тауратын дотор буй Кураны тухай бичигдсэнийг харж) гэрчлэн, залбирсан ч та нар үл тоомсорлон итгэхгүй бол ямар байдалд хүрэхээ мэдэж байна уу? Эргэлзээгүй Аллах, харгислагч зальхай түмнийг зөв шулуун замд эс хөглөнө” гэж хэл.
  11. Үгүйсгэгсэд сүсэглэгсэдэд хандан: “Хэрэв Куран болон энэ шашинд өлзийтэй зүйл байвал тэд (мусулманууд) биднээс түрүүлж итгэхгүй байсан юм. (Бид л түрүүлж мусулман болох байсан)” гэнэ. Гэвч тэд үүгээр зөв шулуун замд хүрч чадаагүйн учир “Энэ бол хуучны нэгэн хоосон үг” гэлцдэг.
  12. Куранаас өмнө орчлон хорвоод залуурч (зам заагч) бөгөөд энэрэн хайрлагч Мусагийн судар (Таурат буюу Тора) байсан билээ. Куран бол харгис зальхай амьтадыг сэрэмжлүүлэх, сайн үйл үйлдэгсэдийг баярлуулах үүднээс Араб хэлээр буулгагдсан, өмнөхүүдийг (Тауратыг) бататгагч судар.
  13. “Бидний Эзэнтэн Аллах мөн” гэж зөв шударга зам баримтлагсдад ямар ч айдас түгшүүр, уйтгар гуниг үгүй.
  14. Тэд диваажингийнхан бөгөөд үйлдсэн сайн үйлсийнхээ хариуд нь тэнд үүрд мөнх оршино.

15. Бид хүмүүст эцэг эхээ халамжлахыг тушаасан юм. Эх нь үрээ зовон байж тээгээд, шаналан байж төрүүлдэг. Хэвлийдээ тээх, хөхнөөс гаргах хүртэлх хугацаа гучин сар үргэлжилдэг. Тэрбээр эрийн цээнд хүрч дөчин нас наслахдаа: “Аяа, Эзэнтэн минь! Надад болоод эцэг эхэд минь хайрласан хувь хишгийнхээ төлөө талархалыг минь болгоон соёрхож, чиний таалалд нийцэх сайн үйл үйлдэх хувь заяаг надад хайрлагтун. Миний үр удмыг ч сайн хүн болгон, зөв зам руу залагтун! Би гагц чамд хандан гэмшиж залбирав. Одоо жинхэнэ мусулман болов” гэнэ.
16. Тэдний үйлдсэн эрхэм үйлсийг Бид хүлээн авч соёрхон, дутагдлыг нь өршөөн хэлртүүлнэ. Тэд диваажинхны дунд байх болно. Энэ нь тэдэнд өгөгдсөн чин үнэн амлалт бөлгөө.
17. Зарим этгээд эцэг эхдээ: “Ёох (Юун яршигтай юм вэ?) Та нар намайг дахин амилна хэмээн айлгах гэсэн юм уу? Надаас өмнө олон дээдэс ирээд өнгөрснөөс тэдний хэн нь амилсан юм вэ?” гэнэ. Эцэг эх нь Аллахад залбиран: “Аяа, даанч яав даа чи минь! Сүсэглэн мөргө! Эргэлзээгүй Аллахын амлалт чин үнэн шүү” гэхэд хүү нь: “Энэ (Куран) бол хуучны үлгэр домог” гэв.
18. Ийм л этгээдүүд бол өмнөх буг чөтгөрүүд болон хүмүүсээс буй болсон түмний эгнээнд багтана. Тэд Аллахын хилэгнэлээр гэгсгээлтэй учрах бөгөөд гарцаагүй хохирол хөнөөлд автагсад бөлгөө.
19. Хүн бүрийн бүтээсэн үйлийн хэрээр хүртэх зэрэг зиндаа байна. Аллах хүмүүсийн үйлдсэн хариуд нь буян ч, гэсгээл ч өгдөг. Гэхдээ шударга бусаар эс хандмуй.
20. Үгүйсгэгсэд тамын галд бэлтгэгдэх тэр өдөр (шийтгэх үүднээс тэдэнд): “Та нар амьд ахуй цагийн хамаг сайн сайхныг эдлэн жаргаж бүхнээ барсан. Харин хэтэрхий бардамнан сагсуурч, Аллахын замаас зайлсхийсний хариуд өнөөдөр тарчилах гэсгээлээр цээрлүүлэгдэх болно” хэмээн хэлэгдэнэ.
21. Аяа, Мухаммед! Гадын садан төрөл Худ-ыг ч санагтун. Тэр тухайн үед Ахкаф хэмээх газарт өөрийнхөө ард олонд Аллахын гэсгээлийг анхааруулсан юм. “Та нар Аллагаас бусдад бүү сүсэглэн мөргөгтүн. Би та нарт тохиох тэр агуу өдрийн гэсгээлээс айж байна” хэмээн сануулсан. Түүнээс өмнө ч хойно ч өч төчнөөн сэрэмжүүлэгчид ирсэн билээ.
22. Тэд: “Чи биднийг өөрийнхөө бурхадаас минь холдуулах гэж ирсэн юм уу? Хэрэв чин үнэнч юм бол биднийг сүйрүүлэх гэсгээлээ одоохон ирүүлээд аль?!” хэмээн сагсуурав.
23. Худ тэдэнд хандан: “Та нарт хэзээ гэсгээл ирэхийг гагцхүү Аллах л мэднэ. Би та нарт илгээгдэхдээ айлдварыг хүргэх тухай надад даалгагдсан үүргээ л гүйцэтгэж байна. Гэсэн ч би та нарыг харанхуй мунхаг хүмүүс хэмээн харж баймуй” гэв.
24. Үл сүсэглэгсэд тэнгэрийн хаяаг нөмрөн айсуй гэсгээлийн хар үүлсийг

хармагц: “Бидэнд хур бороо хайрлах үүл айсуу” хэмээцгээв. Худ тэдэнд: “Үгүй дээ, тэр бол та нарын яаран хүссэн нөгөө юм чинь мөн. Түүний дотор аюул гамшиг агуулсан шороон шуурга, гэсгээлийн хуй салхи буй.

25. Эзэнтний зарлигаар бүхнийг хүйс тэмтрэнэ” хэмээн сануулав. Ийнхүү ярьж дуусаагүй байхад хар шуурга дайрч, эзгүй бууриас өөр юу ч эс үлдээн, ганцхан шөнө бүхнийг хамж орхилоо. Бид нүгэлтэй тэнэгүүдийг ийн гэсгээдэг болой.
26. Үнэндээ Бид Гадын ардуудад өгч байгаагүй боломжийг хайрласан билээ. Мөн сонсох, харах, бодох боломжийг хайрласан ч Алладын айлдваруудыг эсэргүүцэн, тэрхүү чих, нүд, зүрх сэтгэл нь тэдэнд ямар ч ашиг тусыг эс үзүүлэв. Эцэст нь тэдний доог тохуу болгосон зовлон өөрсдийн хүзүүг ороов.
27. Аяа, Меккегийн ардууд аа! Бид та нарын эргэн тойрон дахь хот сууринг сөнөөлөө. Магад, тэд зөв зам руу эргэж орох биз хэмээн айлдваруудаа давтан тунхагласан билээ.
28. Зовлонт гэсгээл ирэхэд тэдний Аллах-д дөхөм хэмээн шүтсэн Аллагаас өөр зүйлс нь яагаад гараа сунган тусалсангүй вэ? Эсрэгээр тэдгээр нь нүднээс далд орон зайлсан юм. Энэ нь тэдний худал хуурмаг зохиомол зүйлс нь болой.
29. Аяа, Мухаммед! Нэгэн цагт Бид буг чөтгөрийн нэг хэсгийг Кураныг сонсгохоор чам руу явуулсан билээ. Тэд чиний өмнө ирмэгц нэг нэгэндээ “чимээгүй байж сонсогтун” гэсэн юм. Куран уншигдан дууссаны дараа тэд өөрсдийн зон олондоо сэрэмжлүүлэгч болон буцацгаасан билээ.
30. Тэгээд тэд: “Аяа, ард олон минь! Үнэндээ бид Мусагийн дараа буулгагдсан, өмнөх судруудыг бататгагч, чин үнэн хийгээд зөв зам руу хөтлөгч судрыг сонслоо”;
31. “Аяа, ард түмэн минь! Аллахын тунхагч (Мухаммедийг) хүлээн авцгаагтун. Аллахт сүсэглэн залбирагтун. Аллах та нарын нүглийг өршөөн хэлтэрүүлж, зовлонт гэсгээлээс аварна” гэв.
32. Хэн Аллахын элчийг эс зөвшөөрнө, тэр энэ дэлхийд Аллахыг сул дорой болгож эс чадна. Тэднийг зовлонгоос аврах Аллагаас өөр эзэн олдохгүй. Тэд илэрхий төөрөлдөгсөд мөн.
33. Тэд (үхсэний дараа амилахыг хүлээн зөвшөөрөөгүй үл сүсэглэгчид) тэнгэр, газрыг бүтээгч, эдгээрийг бүтээхдээ ядарч зүдрээгүй Аллахын үхэгсэдийг амилуулахад хүч чадал нь хүрнэ гэдгийг ухаарахгүй байна уу? Тийм ээ, Түүний хүч чадлын ид шид бүхий л зүйлд хангалттай буй.
34. Үл сүсэгтэн, үгүйсгэгсэд тамын гал руу хаягдах тэр өдөр Аллах тэдэнд: “Энэхүү гэсгээл үнэн бус гэж үү?” хэмээхэд тэд: “Эзэнтнийхээ

нэрээр андгайлая, үнэн юм байна!” гэнэ. Аллах тэдэнд: “Үл сүсэглэн үгүйсгэснийхээ хариуд энэхүү гэсгээлийг амсацгаагтун!” хэмээнэ.

35. (Аяа, Мухаммед!) Чи үл сүсэглэгчдийн үзүүлсэн шахалт дарамтад тууштай гэгээн элч нар мэт тэвчээртэй байгтун! Тэдний гэсгээлийн тухайд бүү яарагтун! Тэд өөрсдөд нь амлагсдан гэсгээлийг үзэхүйд энэ хорвоод өдрийн ганц хором төдийд байсан мэтээр мэдрэх болно. Куран бол нэгэн таниулга мөн. Гагцхүү хараал идсэн улс л сүйрэх болно.

## 47. СУРЕ МУХАММЕД

Мадина-д илгээгдсэн. 38 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлбэ***

1. Үл сүсэглэн, Аллахын замд саад бологсодын үйлдсэн сайн үйлсийг ч Аллах талаар болгоно.
2. Харин сүсэглэн, сайн үйл үйлдэгсэдийн, тэрчлэн Эзэнтний зүгээс Мухаммедэд буулгасан нэгэн чин үнэн-Куранд итгэн залбирагсадын нүгэлийг Аллах өршөөж, аж байдлыг илүү дээрдүүлэх болой.
3. Үүний шалтгаан гэвэл үл сүсэглэгсэд (чөтгөр шулмаст) уярсан. Харин сүсэглэн итгэгсэд Эзэнтний зүгээс буулгасан чин үнэнд (Куранд) уярсан. Аллах хүмүүсийн жишээнүүдээ ийн тайлбарладаг.
4. Тиймийн учир та нар үл сүсэглэгсэдтэй тулалдвал хүзүүг нь хуг мушгицгаагтун. Тэднийг дарсаны дараа баривчлан олзолж авагтун. Дайн дуусмагц суллаж явуулагтун, эсвэл дайны төлөөс төлүүлсний дараа суллагтун. (Хэрэв, Аллах хүсвэл та нарыг байлдуулахгүйгээр өшөө авч болох байсан.) Гэвч Аллах та нарыг нэг нэгээр чинь сорихыг хүсэж, байлдахыг тушаасан билээ. Аллахын замд амиа зориулагсадын хийсэн үйлийг талаар болгохгүй.
5. Аллах тэднийг зөв зам руу залж, байдлыг нь дээрдүүлэнэ.
6. Тэднийг өөрсдөд нь таниулсан диваажинд оруулах болно.
7. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нар Аллахад туслах (Аллахын төлөө дайтах) аваас, Аллах та нарт хань болж, (Аллах та нарт тусалж) өлмий чинь бат орших болой.
8. Харин үл сүсэглэн үгүйсгэгсэд тэрийж хоцроно. Аллах тэдний үйлсийг талаар болгоно.
9. Учир нь тэд Аллахын буулгасан судрыг ад үзсэн юм. Тиймээс Аллах ч тэдний сайн үйлсийг хүртэл үгүй хийсэн билээ.
10. Тэд даян дэлхийгээр хэрэн хэсүүчилж өөрсдийнхөө өмнөхүүдийн хувь

заяа хэрхэн төгссөнийг хардаггүй юм уу? Аллах тэднийг сүйрүүлсэн. Одоогийн үл сүсэглэгсэд ч тэдний тавилангаар дуусах болно.

11. Аллах бол зөвхөн сүсэглэн итгэгсэдийн нөмөр нөөлөг билээ. Харин үл сүсэглэгсэд тийм нөмөр нөөлөг үгүй.
12. Аллах сүсэглэн сайн үйл үйлдэгсэдийг хаягаар нь булаг урссан диваажинд оруулна. Үл сүсэглэн үгүйсгэгсэд энэ хорвоогийн жаргал цэнгэлд умбаж, адгуус амьтадын адил идэж уун, цагсанаар санаа нь амарна. Харин ертөнцийн төгсгөлд очих газар нь там болой.
13. Аяа, Мухаммед! Чамайг хөөж явуулсан (Мекке) хотынхноос ч хүчирхэг олон хотуудыг бид сүйрүүлсэн. Тэдэнд ч туслах ямар ч дэмжигч гараагүй билээ.
14. Эзэнтнийхээ яруу тод нотолгоон дээр үндэслэсэн хүн ба муу үйл нь өөрт нь сайхан харагдаж, шунал тачаалдаа автагсад хоёр адил гэж үү?
15. Гэгээн сүсэгтнүүдэд амлагдсан диваажингийн дүр төрх гэвэл: “Хэзээ ч булингартдаггүй ариун булагууд, амт нь хувирушгүй сүүн булагууд, таачаан уух дарсан булагууд, цэвэр бал бураман булагууд байх аж. Тэнд зүйл бүрийн үр жимс болон Эзэнтний чинь ивээл, энэрэл буй. Энэ бүхэн нь тамд үүрд үлдэх, буцлам халуун ус ууж гэдэс гүзээ нь шалзлагддаг хүмүүстэй адил байна гэж үү?”
16. Урвагчдын зарим нь чиний үгийг сонсовч дэргэдээс чинь холдмогц эрдэм мэдлэгийн эзэдээс: “Мухаммед сая юу ярьчихав аа?” хэмээн асууна. Тэд бол Аллах зүрх сэтгэлийг нь бөглөсөн хүмүүс бөгөөд шуналынхаа боол бологсод мөн.
17. Аллах зөв зам ологсодын замыг улам шулуун шударга болгож, тэдэнд гэгээн ухаан хайрлана.
18. Тэд (Меккегийн үл сүсэгтнүүд) ертөнцийн төгсгөлийн өдөр өөрсдөд нь гэнэтхэн ирэхийг хүлээцгээж байгаа. Тэрхүү цагийн дохио нэгэнт ирчихээд байна. Тэгээд өөрсдийг нэгэнт нөмрөн ирсэн хойно яаж сургамж авах билээ дээ? Тэр мөчид ухуулга сэнхрүүлэг ч ач тус болохгүй.
19. Аяа, Мухаммед? Мэдэгтүн! Цорын ганц Аллахаас өөр ямар ч бурхан үгүй. Өөрийн хийгээд эрэгтэй, эмэгтэй сүсэгтэн нарын нүглийн төлөө өршөөл гуйгтун! Аллах та нарын амьд ахуй цагийн байдлыг, хойт ертөнцийн өдөр очих газрыг чинь сайн мэднэ.
20. Сүсэглэн залбирагсад: “(Дайн тулааны талаар) ганц бүлэг айлдвар буусан ч болоосой!” гэлцэв. Дайны тухай ил тод бүлэг айлдвар буухад зүрхний гажигтай урвагчид үхлээс айхдаа ухаан балартсан хүний адил нүд нь орой дээр гарч, чам руу гөлрөн харахыг нь чи үзнэ. Тэдэнд энэ л зохимой.
21. Итгэл үнэмшил, бат тууштай үг хоёр эрхэм. Алив зорилго, шийдвэр

- тодорхой болохуйд Аллахад үнэнч байвал өөрсдийн чинь төлөө өлзийтэй байхсан билээ.
22. Хэрэв та нар Ислам болон итгэл үнэмшилээсээ нүүр буруулбал, хаа сайгүй гай барцат бий болгон, ахан дүүсийн холбоогоо таслах гэж үү?
  23. Ийм этгээдийг Аллах ивээл энэрэлээсээ холдуулж, чин үнэнийг сонсох соноргүй, харах мэлмийгүй болгосон.
  24. Тэд Кураны талаар эрэгцүүлэн боддоггүй юм уу? Аль эсвэл тэдний зүрх нь битүүмжлэгдсэн юм уу?
  25. Өөрсдөд нь зөв шулуун зам яруу тод болсоны дараагаар итгэл сүсэглэлээ алдан, эргэж буцагсад үйлийг нь чөтгөр шулмас сайхан харагдуулж, хоосон горьдлогоор хөөргөж турхирдаг.
  26. Учир нь тэд (хоёр нүүртэнгүүд) Аллахын буулгасан Кураныг ад үзэгчдэд хандан: “Зарим тохиолдолд бид та нарыг дагацгаана” гэж хэлцгээв. Аллах тэдний санааг мэднэ.
  27. Мэлэкүүд тэдний нүүр рүү нь алгалан, ар нуруу руу нь балбаж, амийг нь таслах мөчид тэд яахсан бол?
  28. Учир нь тэд Аллахыг хилэгнүүлэх зүйлсийг дагаж, Аллахын тааллыг (Аллахын таалах үйлсийг) үзэн ядсанаас Аллах тэдний үйлсийг талаар болгосон юм.
  29. Зүрхний согогтонгууд өөрсдийнхөө Ислам шашинд хандсан дайсагнал, өш хонзонг Аллах илчлэхгүй гэж боддог юм уу?
  30. Хэрэв Бид хүсвэл тэднийг чамд харуулах ч байсан бөгөөд чи тэднийг царайнаас нь таних л байсан. Чи тэднийг ярианы өнгөнөөс л андахгүй. Аллах та нарын үйлдсэн бүхнийг мэдэж байдаг юм.
  31. Бид та нарын дотроос Аллахын төлөө дайтагсадыг, мөн хатамжит тэвчээртэй этгээдүүдийг таних хүртэл, бодол санааг мэдэх хүртэл сорих болно.
  32. Үл сүсэглэн бусдыг Аллахын замаас төөрөлдүүлэгсэд, чин үнэн (шашин) тодорхой болсоны дараагаар гэгээн элчийг дайсагнагсад Аллахад ямар ч хор хөнөөл учруулж эс чадна. Аллах тэдний үйлдсэн сайн үйл бүхнийг талаар болгоно.
  33. Аяа, Сүсэгтнүүд минь ээ! Аллах хийгээд түүний гэгээн элчийг дагагтун. Хийсэн сайхан үйлсээ (үл сүсэглэл, урвалт, сагсуурал зэргээр) бүү талаар болгогтун.
  34. Үл сүсэглэгчдийг Аллахын замаас төөрөлдүүлэгсэдийг, үл сүсэгтэн хэвээрээ үхэгсэдийг Аллах хэзээ ч эс өршөөно.
  35. Дайсантай байлдахад сул дорой байдал бүү гаргагтун. Тэднийг зөвшилцөлд ч бүү уригтун. Та нар ямагт хүчирхэг билээ. Аллах та нартай хамт. Хийсэн үйлийг чинь дутуу үнэлэхгүй, буян хишгээ бүрэн хүртээх болно.

36. Энэ хорвоогийн амьдрал цаг нөгцөөх зугаа төдий. Та нар сүсэглэн залбирч, гэгээрэн итгэвэл Аллах та нарт шан харамжаа өгнө. Бас та нараас мал хөрөнгөө бүрэн зарцуулахыг ч хүсэхгүй. (Буяны өглөг өгвөл болно.)
37. Хэрэв тэдгээрийг бүрэн зарцуулахыг хүсээд, харамлах сэтгэл гаргавал энэ нь гэгээрэн сүсэглэхэд харш, эд хөрөнгийн сонирхолтой байдлыг чинь харуулна.
38. Аллахын замд мал хөрөнгө зарцуулахыг уриалахад та нарын зарим нь харамч зан гаргадаг. Хэн харамлана, тэр өөрийнхөө нүглийн төлөө юм. Аллах баян, та нар ядуус мөн. Хэрэв, та нар Аллахын замаас (чин үнэнээс) нүүр буруулах аваас Аллах та нарын оронд өөр нэгэн ард түмнийг авч ирнэ. Тэд арай ч та нар шиг биш, Аллахад итгэн сүсэглэх болой.



Мадина-д илгээгдсэн. 29 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Бид чамд мэдэгдэхүйц, яруу тод ялалтаар бэлэг барилаа.
2. Аллах чиний өнгөрсөн хийгээд ирээдүйн нүглийг чинь өршөөх, чамд зориулсан буян хишгээ гүйцэлдүүлэх, чамайг зөв шулуун замаар залах үүднээс юм шүү.
3. Түүнчлэн Аллах чамд далайцтай тусламж (ялалт) үзүүлнэ.
4. Сүсэглэгчдийн бишрэлийг ахиулахын тулд Аллах тэдний үнэмшлийг бататган төлөвшүүлэв. Тэнгэр, газар дахь (Мэлэкууд, буг чөтгөр, адгуус амьтад, байгалийн үзэгдэл зэрэг) бүхий л дайчин тэмцэгчид гагцхүү Аллахынх болой. Аллах бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн мөн.
5. Энэ нь (Аллах сүсэглэгчдийн шашин, итгэл үнэмшлийг бататган төлөвшүүлсэн нь) эрэгтэй, эмэгтэй сүсэглэгчдийг хаяагаар нь булаг урсдаг диваажинд оруулж, тэнд үүрд мөнх байлгаж, тэдний нүглийг өршөөхийн төлөө юм. Энэ бүгд нь Аллахын нигур дор хосгүй жаргал мөн.
6. Бас энэ нь хоёр нүүртэй эр-эмсийг, үл сүсэглэгч (эн зэрэгцүүлэгч) эр-эмсийг, Аллахын талаар муу санаж явагсадыг гэсгээлтэй учруулахын тулд болой. Аллах тэдэнд хилэгнэн харааж зүхэв. Мөн тэдэнд халуун тамыг зэхлээ. Тэр юугай аюумшигтай газар гээч!
7. Тэнгэр, газрын бүхий л дайчин хүч Аллахынх мөн. Аллах ялагдашгүй, мэргэн ухааны эзэн мөн.

8. Аяа, Мухаммед! Бид чамайг өөрийн чинь зон олонд гэрч, баярлуулагч, сэрэмжлүүлэгч болгон илгээсэн билээ.
9. (Аяа, хүмүүс ээ!) Та нарыг Аллах хийгээд Түүний элчид сүсэглэн залбираг, түүний шашныг дээдлэн хүндэтгэг, эрт орой түүнийг шагшин магтаг хэмээн (та нарт гэгээн элч) илгээсэн юм шүү дээ.
10. Аяа, Мухаммед! Чамд итгэн дагана хэмээн тангараг өргөгсөд хэрэг дээр Аллахад тангараг өргөсөнд тооцогдоно. Аллахын аугаа хүч чадал тэдний дээр буй. Хэн тангарагаасаа няцна, түүний хор хөнөөлийг тэр өөрөө үүрнэ. Хэн Аллахад өгсөн тангарагаа сахин биелүүлнэ, Аллах түүнд их буян хишиг хайрлана.
11. Аллахын төлөө тулаанаас хоцорсон бадауичүүд (талын арабууд) чамд хандан: “Мал хөрөнгө, хүүхэд шуухадтай зууралдсаар гарч чадсангүй. Биднийг өршөөн хэлтэрүүлэхийг Аллагаас хүсэгтүн” гэнэ. Тэдний үг нь сэтгэл зүрхний угаас гараагүй, аман дээр буй үг. Тэдэнд: “Аллах та нарын төлөө нэгэн хор хөнөөл, эсвэл ашиг тус хүргэхийг хүсвэл Аллахын эсрэг хэн юу хийж чадах юм вэ? Эсрэгээр Аллах та нарын юу хийж буйг мэднэ шүү дээ” хэмээн хэл.
12. (Аяа, хоёр нүүртэнгүүд ээ!) Үнэндээ та нар Гэгээн элч хийгээд сүсэгтнүүдийг гэр рүүгээ эсэн мэнд эргэж ирэхгүй хэмээн бодоцгоосон шүү дээ. Энэ нь та нарын сэтгэлд таатай санагдсан биз. Ийнхүү та нар муу талаас нь бодож, эцэст нь хөнөөлийг хүртэх олны эгнээнд үлдэцгээсэн билээ.
13. Хэн Аллах хийгээд түүний Гэгээн элчид үл итгэнэ, бид тийм сүсэггүй амьтадад улалзах галын тамыг зэхэж тавина.
14. Тэнгэр, газрын эзэгнэл гагцхүү Аллахынх. Аллах хүссэнийгээ өршөөн хэлтэрүүлж, хүссэнийгээ гэсгээн цээрлүүлдэг. Аллах машид өршөөгч, нэн энэрэгч.
15. Тулалдаанд очилгүй сугаран үлдэгсэд та нарыг олз авахаар явахад: “Бид та нартай хамт очигцоо? Бүү дургүйлхээрэй” гэлцэнэ. Тэд (Дайны олз тулалдаанд оролцогсдын хувь мөн гэсэн) Аллахын айлдварыг гуйвуулахыг оролддоно. Аяа, Мухаммед тэдэнд: “Та нар бидэнтэй хамт очих боломжгүй. Аллах та нарын хувьд угаасаа ийн тушаасан” гэж хэл. Тэд та нарт: “Та нар биднээс харамлаж байна” гэнэ. Үгүй, тэдний цөөнхөөс бусад нь ер ойлгодоггүй.
16. Байлдаанд очоогүй үлдсэн бадауичүүдэд (талын зэрлэг арабууд): “Та нар гарцаагүй хүчирхэг нэгэн хүмүүстэй байлдаж тулалдаанд дуудагдах болно. Та нар тэдэнтэй тулалдана, эсвэл тэд байлдахгүйгээр бууж өгч мусулман болцгооно. Хэрэв энэ тушаалыг биелүүлбэл Аллах та нарт сайхан шан харамж хайрлана. Хэрэв бахь байдгаараа зайлан хоцорвол Аллах та нарыг хатуу гэсгээлээр цээрлүүлэх болно” хэмээн хэлэгтүн.
17. Сохор, доголон, өвчтөнүүд байлдаанд оролцохгүй бол шийтгэл үгүй. Хэн Аллах болон Түүний гэгээн элчийг дагана, Аллах түүнийг



- хажуугаар нь булаг урсах диваажинд оруулна. Хэн ариун дайнаас зайлсхийнэ, тэр аюулт гэсгээлтэй учрах болно.
18. Аллах тулалдааны үеэр модны нөмөр дор чамд тангараг өргөсөн сүсэгтнүүдийн сэтгэл зүрхний итгэл үнэмшлийг үнэлж, тэдэнд талархан, тууштай буурь суурийг хайрласан, мөн олз омогтой нэгэн ялалтанд тун удалгүй хүргэсэн юм.
  19. Мөн тэдэнд их хэмжээний олзыг хайрлав. Аллах ялагдашгүй, мэргэн ухааны эзэн.
  20. Аллах та нарт авбал зохих их хэмжээний олзыг амалсан билээ. Мөн энэхүү далдын олзыг асар түргэн өгсөн. Та нарыг зөв шулуун замд оруулахын тулд (олз, Меккег хүлээн авах, Масжид Аль-Харам руу чөлөөтэй орох зэргийг) сүсэгтнүүдэд бэлгэдэл болгон үлдээхийн төлөө Аллах та нараас бусдын хүйтэн зэвүүн гарыг холдуулсан юм.
  21. Тэрчлэн өөрсдийн чинь хүч чадал үл хүрэх, Аллах өөрөө сайн мэдэх, өөр нэгэн олзоор (Меккег буцааж авах) та нарыг шагнасан бөлгөө. Аллахын хүч чадал алив бүхэнд хүрэлцээтэй.
  22. Хэрэв үл сүсэглэгсэд та нартай байлдвал ухарч зугтах нь гарцаагүй байсан юм. Дараа нь тэд анд нөхөр, туслагч эс олох болой.
  23. Үл сүсэглэгчдэд ялагдал, үнэн сүсэгнтүүдэд ялалтыг оноосон нь угаасаа Аллахын гуйвашгүй зан нь байсан юм. Аллахын тогтоосон зарчмаас чи ямар ч өөрчлөлтийг олж үзэж чадахгүй. (Аллахын баримталсан зам хувиршгүй)
  24. Та нар тэднийг ялсны дараа Меккегийн хотгорд тэдний гарыг та нараас, та нарын гарыг тэднээс холдуулсан Аллах болой. Аллах та нарын үйлдсэн бүхнийг харж байлаа.
  25. Тэд (Меккегийн) үгүйсгэгсэд тийм л буруу үзэлтэн байсан юм. Тухайлбал: Та нарыг Месжид Харамд ороход хүлээгдэж байсан өргөлийн малыг байранд нь хүрэхэд саад болсон юм. Хэрэв та нар (Меккед) өөрсдөө үл таних сүсэгтэн эрэгтэй, эмэгтэйчүүдийг болгоомжгүйгээс алчихаад нүгэлтэн болох аюул үгүйсэн бол мэдээж Мекке рүү дайрахыг зөвшөөрөх л байсан. Аллах хүссэн хүнээ хайр энэрэлдээ авахын тулд ийн хийсэн болой. Хэрэв тэд (сүсэгтэн ба үл сүсэглэгчид) нэг нэгнээсээ ялгаран салбал мэдээж үл сүсэглэн үгүйсгэгчдийг гарцаагүй хагуу гэсгээлээр нэрвэх байсан шүү дээ.
  26. Үл сүсэглэгсэд харанхуй бүдүүлгээс үүдэлтэй ихэмсэг зан, хорон санаа хоёроо дотороо агуулж байхад Аллах ч Өөрийн гэгээн элч хийгээд сүсэгтэн нарт буурьтай тэвчээр хайрлаж, гэгээн ухааны сүсэглэлийг үүрүүлсэн билээ. Тэд угаас үүнд зохимжтой байсан юм. Аллах бүхнийг зүй ёсоор нь мэдэгч бөлгөө.
  27. Аллах үнэндээ гэгээн элчийнхээ зүүдэлснийг чин үнэн болгов. (Аяа, Мухаммед! Шадар нөхдийнхөө хамт) Аллах хүсвэл та нар үсээ

хусуулан эсвэл тайруулан, сэтгэл тайван, айж эмээлгүйгээр Месжид Харам (Мечит) руу орцгоох болой. Аллах (дайн үеийн хэлэлцээрийн) та нарын эс мэдэх юмыг мэдсэн юм. Тиймээс та нарт үүнээс өөр бас нэгэн ялалтыг хайрласан билээ.

28. Аллах чин үнэн шашныг бүхий л шашинаас дээгүүр болгохын тулд өөрийн гэгээн элч нарыг энэхүү шашинтайгаа, зөв шулуун замаар илгээсэн юм. Үүнийг гэрчлэхэд Аллах хангалттай.
29. Мухаммед бол Аллахын элч мөн. Түүнтэй хамт байгсад үл сүсэглэгсдэд хатуу чанга бөгөөд шашин нэгтнүүд хоорондоо элэгсэг бөгөөд тэд мэхийн сөгдөж, Аллахын агуу ивээл энэрэл, буян хишгийг хүсэж буйг чи харна. Тэдний нүүрэнд сөгдөн мөргөсний үл мөрийн шинж тодроно. Энэ нь тэдний Таурат (Тора) дахь шинж төрх болой. Харин Инжил дэхь шинж төрх гэвэл: Соёолон ургаж, ишээ бэхжүүлж, цэцгээ дэлгэн, хөл шилбээрээ бат зогсож, боловсорсон үр жимс, арвин ургацаар тарьсан эздээ баярлуулсан тариалан мэт. Аллах үл сүсэглэгсэдийг уурлуулахын төлөө сүсэгтэнүүдийг ийнхүү бат бөх болгосон. Аллах тэдний итгэн сүсэглэж, сайн үйл үйлдэгсэд өршөөл, их буян хишиг амалсан бөлгөө.

## 49. СУРЕ ХУЖУРАТ

Мадина-д илгээгдсэн. 18 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Аяа, сүсэгтнүүд ээ! (Ам, ажлын алины тухайд ч) Аллах ба Түүний гэгээн элч нарын замд бүү хөндөлдөгтүн. Аллагаас айгтун. Аллах бүхнийг сонч, мэдэж байдаг.
2. Аяа, сүсэгтнүүд ээ! Гэгээн элчийн дуунаас өндөр дуугаар бүү дугарагтун. Өөр хоорондоо шуугилдан хөөрөлдөхийн адил Түүнтэй бүү яригтун. Хэрэв ийн үйлдэх аваас та нарыг анзаараагүй байхад сайн үйл хэрэг чинь талаар өнгөрмүй.
3. Аллахын элчийн дэргэд дуугаа аядсан хүмүүсийн итгэл үнэмшлийг Аллах үнэндээ гэгээн сүсэглэлийн хувьд сорьсон болой. Тэдэнд өршөөл, аугаа буян хишиг оногдоно.
4. (Аяа, Элч минь!) Чамайг байрынхаа (эхнэрүүдийн чинь тасалгааны) гаднаас хашгиран дуудагсадын олонхи нь ухаан мунхагууд болой.
5. Хэрэв чамайг гэрээс гарч очих хүртэл тэд тэвчин хүлээвэл мэдээж өөрсдийнх нь төлөө өлзийтэй байх сан. Аллах өршөөгч, нэн энэрэгч.
6. Аяа, сүсэгтнүүд ээ! Та нарт муу ёрын хэн нэгэн мэдээ авчирвал түүний үнэн зөвийг тогтоогтун. Үгүй бол хэрэг явдлын учрыг мэдэлгүйгээр жирийн ардад хор учруулж, дараа нь хийсэн үйлдэлдээ харамсуузай.

7. Та нарын дунд Аллахын элч байна гэдгийг мэдэгтүн. Хэрэв тэр олон асуудалд та нарын үгэнд орвол, та нар зовлонд учрах билээ. Гэвч Аллах та нарт сүсэглэлийг сайтар харуулж, сэтгэлийн чинь чимэг болгосон юм. Харин үл сүсэглэл, танхайрал, нүгэлийг муу муухайгаар харуулсан билээ. Ийнхүү тэд зөв шулуун замаар замнагсад болой.
8. Энэ нь Аллахын хайр энэрэл, буян хишгийн ач тусаар болсон юм. Аллах онцгой эрдэм, мэргэн ухааны эзэн мөн.
9. Хэрэв сүсэгтнүүд хоёр хуваагдан хоорондоо дайтахад хүрвэл тэднийг эвлэрүүлэгтүн. Харин нэг хэсэг нь нөгөө талыг дээрэлхэн давшилбал тэд Аллахын айлдварыг ойлгон дагах хүртэл тэдэнтэй тэмцэгтүн. Хэрэв тэд (Аллахын тушаалыг хүлээн зөвшөөрч) буулт хийвэл хоёр талыг шударгаар эвлэрүүлэгтүн. Өөрсдөө шударга байгтун. Аллах шударга байгсадыг таалдаг билээ.
10. Сүсэглэгсэд үнэндээ шашны талаар ахан дүүс хүмүүс. Тиймийн учир ахан дүүсийг хооронд нь найрсаг байлгагтун. Аллагаас эмээн айгтун. Тэгж л байж түүний ивээл энэрэлийг хүртэх болно.
11. Аяа, сүсэгтнүүд ээ! Нэг ардууд нөгөөг, нэг бүлэг нөгөө бүлгийг, нэг хүн нөгөө хүнийг бүү доог тохуу болгог. Доог тохуу хийгсэд магад нөгөөдүүлээс илүү байж болох юм. Бас эмэгтэйчүүд ч бие биеэн бүү элэглэн доромжлог. Элэглэн дооглогсод магад нөгөөдүүлээс нь илүү байж болох юм. Гэсэн ч бие биенээсээ өө сэв бүү хайгтун, бие биеэн гомдоохоор нэр хоч бүү өгөгтүн. Сүсэглэснийхээ дараа муухай нэрээр дуудах нь хамгийн адгийн муу чанар. Хэн үл наминчлана, тэр харгис зальхай болой.
12. Аяа, сүсэгтнүүд ээ! Эргэлзэх бодол санааны ихэнхээс ангид байгтун. Эргэлзэх бодол санааны зарим нь нүгэл болно. Нэг нэгнийхээ мөрийг бүү шагай, бүү ховол. Та нарын хэн нэг нь үхсэн ахан-дүүсийнхээ махыг зулгааж идэх дуртай гэж үү? Мэдээж, үүнийг жигшэцгээдэг билээ. Тиймээс Аллагаас айгтун. Аллах эргэлзээгүй гэмшлийг хүлээн зөвшөөрөгч, нэн нигүүлсэгч мөн.
13. Аяа, хүмүүс ээ! Бид та нарыг эрэгтэй, эмэгтэй болгон (Адам эцэг, Хауа эхээс) бүтээсэн. Бие биеэн таньж мэдэг хэмээн та нарыг үндэстэн, овог аймаг болгон хуваасан. Энэ хорвоод Аллахын өмнө гэгээн сүсэгтэн байвал хамгийн эрхэмсэг болох чинь тэр ээ. Аллах хязгааргүй мэдэгч, бүхнээс мэдээлэлтэй билээ.
14. Бадауичүүд (Бүдүүлэг арабууд): “Бид сүсэглэлээ” гэгцгээнэ. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Та нар сүсэглэн залбираагүй, гагцхүү аман дээрээ “хүлээн зөвшөөрлөө” гэгцгээсэн. Та нарын зүрх сэтгэлд итгэл сүсэглэл төлөвшөөгүй. Хэрэв та на Аллах хийгээд Түүний гэгээн элч нарыг дагах аваас та нарын үйл хэргээс юуг ч үгүйсгэхгүй. Аллах эргэлзээгүй машид өршөөгч, нэн нигүүлсэгч” хэмээн хэлэгтүн.
15. Төгс сүсэглэгсэд гагцхүү Аллах болон Түүний элч нарт итгэж сүсэглэн,

- хэзээ ч үл эргэлзэн, Аллахын замд мал-хөрөнгө, амь насаараа дэнчин тавьсан байлаа. Тэд сүсэглэлд үнэнч, шударга хүмүүс мөн.
16. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Та нар шашинаа Аллахад заах гэсэн уу? Аллах газар, тэнгэр дэх бүхний үйлсийг мэддэг. Алив бүхнийг зүй ёсоор мэдэгч нь Аллах мөн” хэмээн хэлэгтүн.
  17. Тэд мусулман болсноороо чамд үнэрхэнэ. Тэдэнд: “Та нар мусулман болсноороо надад бүү үнэрх, харин ч сүсэглэлийн замд оруулснаараа Аллах та нарт үнэрхэх ёстой. Хэрэв үнэнч байгаа бол ийм шүү” гэж хэл.
  18. Аллах эргэлзээгүй тэнгэр, газрын нууцыг мэднэ. Аллах та нарын үйлдсэн бүхнийг харж байдаг юм.



Мекке-д илгээгдсэн. 45 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Каф. Ялгуусан Куранаар андгайлан тангараглая.
2. Өөрсдийнх дотроос нь нэгэн сэрэмжлүүлэгч ирсэнд гайхацгаасан үл сүсэглэгсэд: “Энэ бол гайхмаар зүй юм” гэлцэв.
3. “Бид үхээд хөрс шороо болсоныхоо дараа дахин амилах гэж үү? Ийнхүү дахин амилах нь ухаанд багтахгүй зүйл юм” гэлцэв.
4. Бид үнэндээ газар шороо тэдний биеэс нь юуг уусган үгүй хийснийг мэднэ. Бидний дэргэд бүхнийг агуулсан нэгэн судар (Лаухул махфуз) буй.
5. Харин тэд өөрсдөд нь ирсэн чин үнэнийг худал хэмээн үгүйсгэсэн билээ. Тиймээс тэд ухаарах сөхөөгүй байдалтай үлдсэн.
6. Тэд дээд тэнгэрийг Бидний тулгуургүй бүтээсэнд, од эрхэсээр чимэглэснийг, ямар ч сэв согог үгүйг анхаардаггүй юм уу?
7. Бид газар дэлхийг дэлгэн тавьж, түүн дээр уулсыг сүндүүрлүүлж, зүйл бүрийн ургамлыг хос хосоор нь ургуулсан.
8. Үүний зорилго нь Аллахад итгэн биширдэг боолуудыг ухааруулах, хүмүүжил сургамж болгох явдал байлаа.
9. Бид тэнгэрээс үр өгөөжтэй хурыг буулгаж, түүгээр бүх ургамал тариа, цэцэрлэгийг ургуулсан билээ.
10. Үр навч сагсайн дэлгэрсэн хасарваанийн дал модыг ургуулсан юм.
11. Эдгээр нь боолуудынхаа хувь хишгийн төлөө билээ. Мөн үхмэл газрыг тэрхүү хурын усаар амилуулсан. Үхэгсэдийн дахин амилах нь үүнтэй адил.

12. Тэднээс өмнө гэгээн элч нарыг үгүйсгэгсэд бол: Нухын ардууд, Рассын ард, Самудууд;
13. Гад, Фиргауны ардууд, Лутын ахан дүүс нар;
14. Айке (Шугайб элчийн ард) Туббагийн ардууд байлаа. Тэд бүгд гэгээн элч нараа худал хэмээн үгүйсгэгсэд юм. Тиймээс сэрэмжлүүлсэн гэгсгээл маань ёсоор болсон билээ.
15. Хүмүүн төрөлхтнийг анхлан бүтээх нь надад бэрхшээлтэй байсан гэж үү? Үгүй дээ, тэд дахин бүтээх (амилах) тухайд эргэлзсэн.
16. Бид үнэхээр хүмүүнийг бүтээсэн бөгөөд түүний шунал тачаал нь юун тухай шивнэснийг ч мэдмүй. Бид хүмүүнд гүрээнийх нь судаснаас ч ойрхон байдаг юм.
17. Хүмүүний баруун болон зүүн талд зогсож, үйлдсэн бүхнийг бүртгэн бичиж байдаг хоёр мэлэк элч буй.
18. Хүмүүний амнаас гарсан үг бүхнийг хальт явуулахгүй ажиглан сахиж (бичиж) байдаг юм.
19. Үхэл чин үнэнийг авч ирлээ. (Үүгээр ертөнцийн төгсгөл ойртсоныг сая л мэднэ.) Чи үүнээс ямагт зайлсхийдэг шүү дээ.
20. Бишгүүр бүрээ үлээгдэнэ. Энэ нь (үл сүсэглэгсдэд гэгсгээл) амлагдсан өдөр болой.
21. Хойт хорвоод хүн бүртэй хамт нэгэн туугч (мэлэк), нэгэн гэрч (мэлэк) ирцгээнэ.
22. Тэдэнд: “Үнэндээ чи үүнийг үл тоомсорлодогсон. Одоо Бид нүдний чинь хөшгийг нээлээ. Ийнхүү, өнөөдөр чиний хараа хурц байгаа” хэмээгдэнэ.
23. Түүнийг хянадаг мэлэк: “Ийнхүү хамаг үйлийн дэвтэр миний өмнө бэлэн байна” хэмээнэ.
24. Аллах хянадаг хоёр мэлэкдээ тушаан: “Алив үл тоомсорлогч, үл сүсэглэгч бүрийг халуун там руу шид”;
25. Энэрэлгүй, хэрээс хэтрэгч, сайн үйлд (шашинд) саад бологч амьтадыг там руу хий”;
26. Аллахтай бусдыг эн зэрэгцүүлэгчдийг хатуу гэгсгээл рүү оруулагтун” хэмээнэ.
27. Үл сүсэглэгчийн нөхөр болох чөтгөр нь: “Эзэнтэн минь! Би түүнийг төөрөгдүүлээгүй шүү. Гэвч тэд өөрөө хэзээнээс төөрөгдөлд орсон юмаа” гэнэ.
28. Аллах ийнхүү тушаана: “Та нар миний өмнө бүү хэрэлдэцгээ! Би та нарыг (амлагдсан гэгсгээлээс) урьдчилан сэрэмжлүүлсэн шүү дээ”;
29. Миний шийдвэр өөрчлөгдөхгүй. Би ямар ч боолд харгис зальхай юм хийхгүй”;

30. Гагцхүү тэр өдөр халуун тамд хандан: “Чи дүүрч гүйцэв үү?” хэмээнэ. Халуун там: “Бас л байгаа юм уу?” гэж асууна.
31. Диваажин гэгээн сүсэгнтүүдэд хол биш, ойр байх болно.
32. Та нарт амлагдсан диваажин энэ шүү дээ. Тэр бол наминчлан Аллахад итгэгсэд бөгөөд түүний тушаалыг нь хүлээн авч, баримтлагч хүн бүрт зориулагдсан болой.
33. Хэн үзээгүй атал энэрэлт Эзэнтнээсээ айж, итгэж үнэмшсэн зүрх сэтгэлээрээ ирвэл”;
34. Тэдэнд: “Диваажинд амгалан морилогтун! Энэ нь үүрд орших өдрийн эхлэл мөн” хэмээн хэлэгдэнэ.
35. Диваажинд тэдний хүссэн бүхэн буй. Бидний эрх мэдэл дор бас л их буян хишиг буй болой.
36. Бид тэднээс (буруу номтнуудаас) өмнө өөрсдөөс нь ч хүчирхэг түмнийг хүйс тэмтэрсэн юм. Тэд хаа сайгүй хэрэн хэссэн. Гэхдээ зугтан зайлах газрыг олсон гэж үү?
37. Үүнд ч гэсэн (чин үнэний тухай эргэцүүлэх) зүрх сэтгэлтэй хүмүүсийн хувьд эсвэл анхаарал тавьж сонсох хэн нэгний хувьд сургамж буй нь эргэлзээгүй.
38. Бид үнэхээр тэнгэр, газар тэдний хооронд буй бүхнийг зургаан өдөрт бүтээсэн юм. Бид үүний төлөө өчүүхэн ч ядарч жүдрээгүй билээ.
39. (Аяа, Мухаммед!) Үл сүсэглэгчийн үгэнд тэвчигтүн. Нар мандахаас болон жаргахаас өмнө Эзэнтэндээ залбиран, шагшин магтагтун.
40. Мөн шөнө дунд болон сөгдөн мөргөн уншлагаа гүйцээсний дараа Түүнийг шагшин магтаж залбирагтун.
41. Зар дуулгах мэлэк (Исрафил) дуудах тэр өдөр сонор байгтун.
42. Тэд чин үнэн дууг сонсоцгоох тэр өдөр бүрээ бишгүүр (Хоёр дахь удаа үлээгдэх өдөр) бол үхэгсэд амилан сэхээрэхүйн өдөр болой.
43. Үнэндээ Бид амилуулмай, бас үхүүлмай. Эцэст нь эргэн очих газар бол Бидний өмнө юм шүү дээ.
44. Тэр өдөр газар цууран, тэд газрын гаваас бушуухан гарцгаана. Ийнхүү цуглуулах нь Бидэнд машид хялбар билээ.
45. Бид тэдний хэлсэн үгийг илүү мэднэ. Чи тэднийг Ислам шашинд албадах хүн биш ээ. Гагцхүү Бидний амлагдсан гэгсгээлээс айхсадыг Куранаар ухуулан-сэнхрүүлэгтүн.

## 51. СУРЕ ЗАРИАТ

Мекке-д илгээгдсэн. 60 айлдвар

- Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*
1. Тоос шороог хийсгэх шуургаар;
  2. Хур бороо тээгч үүлсээр;
  3. Хөнгөн хөвөх хөлөг онгоцоор;
  4. Хүмүүст оногдох буян хишгийг, уулын энгэрт үүлсийг хуваарилан зохицуулагч мэлэкүүдээр тангараглая.
  5. Та нарт амлагдсан бүхэн (Буян , гэсгээл, ертөнцийн төгсгөл зэрэг) чин үнэн болой.
  6. Ертөнцийн төгсгөлийн шүүн тунгаах өдөр хүндэтгэл, цээрлэлийн аль алин ч буй.
  7. Зурайсн зам бүхий тэнгэрээр тангараглая.
  8. Та нар гэгээн элч нарын тухайд үнэхээр янз бүрийн саналтай билээ.
  9. (Аллахын үгийн эрдэм ёсоор чин үнэнээс) зайлсхийсэн хүн Куран судар болон Мухаммед гэгээн элчид итгэн бишрэхээс зайлсхийдэг юм.
  10. Худалчдыг хараал идэг!
  11. Тэд харанхуй бүдүүлэгийн ёроолд живэн харамсагчид мөн.
  12. Тэд гэгээн элчээс “Ертөнцийн төгсгөлийн өдөр хэзээ болох вэ?” хэмээн асууцгаадаг.
  13. Тэр өдөр тэд халуун там руу шидэгдэх болно.
  14. Тэдэнд: “Та нар гэсгээлээ амсацгаагтун! Та нарын яаран хүлээсэн зүйл чинь энэ болой” хэмээгдэнэ.
  15. Гэгээн сүсэгтнүүд диваажинд хоржигнон урсах булагийн дэргэд байх нь эргэлзээгүй.
  16. Тэд Эзэнтнийхээ хайрласан буян хишгийг хүртэцгээж байх болно. Учир нь тэд үүнээс өмнө амьд ахуйн хорвоод бидний төлөө сайн үйл үйлдэгсэд билээ.
  17. Тэд шөнө бага унтдаг байлаа.
  18. Үүрийн гэгээнээр Аллахаас өршөөл эрдэг байлаа.
  19. Тэдний мал хөрөнгө нь гуйлгачин, үгээгүйчүүдэд (гуйхгүй ч гэсэн) эрэлттэй хүмүүсийн хувьд чин үнэнээр өглөг болдог байв.
  20. Баттай итгэгсэдийн төлөө газар дэлхий дээр (Аллахын ид шид, хүч чадалыг харуулах) бэлгэдлүүд буй.
  21. Мөн та нарт ч буйг харахгүй байна гэж үү?

22. Тэнгэр огторгуйд ч та нарын хувь хишиг, бас та нарт амлагдсан зүйлүүд буй.
23. Тэнгэр, газрын Эзэнтнээр тангараглая; Та нарын хэлсэн үг ямар үнэн бол бидний амлалт тийм л үнэн болой.
24. (Аяа, Мухаммед!) Чамд Ибрахимын эрхэм зочдын тухай өгүүлэл хүрсэн үү?
25. Нэгэнтээ тэд Ибрахим дээр ирээд амрыг нь эржээ. Ибрахим ч хариу мэндлэн: “Үл таних хүмүүс юм байна” хэмээн дотороо боджээ.
26. Ибрахим сэмхэн гэр рүүгээ очиж, тарган тугалын шарсан махыг авч ирлээ.
27. Түүнийг зочдынхоо өмнө тавиад: “Та нар зооглогтун” хэмээв.
28. Тэдний идэхгүй байхыг хараад сэrvэж сэргийлж эхэлсэн байна. Тэд Ибрахимд хандан: “Бүү ай. Бид Аллахын элч нар (мэлэxүүд) байна!” хэмээгээд түүнийг цэцэн билэгт нэгэн хүүтэй болох тухай баярт мэдээг дуулгав.
29. Гэтэл Ибрахимын эхнэр нь дуу алдан хашгирч, нүүрээ алгадан: “Би хүүхэд төрүүлэхээс өнгөрсөн хөгшин эм яаж хүүхэд төрүүлэх билээ?” хэмээн халаглав.
30. Элч нар: “Эзэнтэн чинь ийнхүү айлдсан. Тэр бол мэргэн ухааны эзэн, нэн их цэцэн шүү дээ” гэв.
31. Ибрахим элч мэлэx нарт хандан: “Хэрэг зориг юусан бол, элч нараа?” гэв.
32. Элч нар: “Бид нэгэн нүгэлтэн түмэнд илгээгдсэн билээ”;
33. Тэдний дээрээс шавраар цутгасан чулуу нүүлгэхийн учир;
34. Эзэнтний зүгээс тэр чулуунуудад хэмээс хэтэрч даврагдагсдын нэр нь бичигдэж, тусгай тэмдэг тавигдсан юм” хэмээн учирлав.
35. Ийнхүү Бид (хамт сүйрэхээс сэргийлэн) тэдний дунд байсан сүсэгтнүүдийг гаргаж авсан билээ.
36. Гэвч бид тэр хотоос ганцхан мусулман айлыг олсон.
37. Тухайн хотод аюултай гэсгээлээс айхсадын хувьд сургамж авах тэмдэг (сүйрсэн оромж) үлдээсэн юм.
38. Мусагийн тухайд ч сургамжууд буй. Бид түүнийг нэгэнтээ ил тод нотолгоотойгоор Фиргаун руу илгээсэн шүү дээ.
39. Харин Фиргаун дайчин нөхдийн хамт Мусагаас урван түүнийг: “Илбэчин эсвэл солиотой” гэсэн.
40. Тиймээс бид Фиргаун болон түүний дайчдыг цээрлүүлж, далайд хаясан.
41. Гадийн тухайд ч сургамж буй. Тухайн үед тэдэн рүү догшин шуурга илгээсэн билээ.
42. Хар шуурга замд нь байсан бүхнийг хамж орхисон.



43. Самудын ардын тухайд ч сургамжууд буй. Тэр үед Бид тэдэнд “Түр зуурхан жаргаж байгаарай” хэмээн сануулсан.
44. Гэвч тэд Эзэнтнийхээ тушаалыг эсэргүүцсэн. Хариуд нь тэднийг ийш тийш харцгааж байхад аянга нэрвэсэн билээ.
45. Суудлаасаа босох ч, өөрсдийгөө хамгаалахад ч тэдний хүч чадал хүрээгүй юм.
46. Түүнээс өмнө Нухын ардыг ч Бид сүйрүүлсэн. Тэд ёстой л нэг буруу ишилсэн сүх мэт зөрүүдэлсэн хүмүүс байсан даа.
47. Сүр хүчээрээ тэнгэрийг бүтээсэн. Бид орон зайг тэлэгч мөн.
48. Газрыг тааламжтай дэвсгэр болгосон. Бид гайхамшигтай дэлгэгч шүү дээ!
49. Ухааран сургамж авахуулахын тулд алив юмсыг хосоор нь бүтээсэн.
50. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Аллах руу (түүнд залбирахад) яарагтун! Би та нарт Алладын зүгээс ирсэн яруу тод сэрэмжлүүлэгч мөн” хэмээн хэл.
51. Та нар Алладын зэрэгцээгээр өөр бурхан бүү хийгтүн. Эргэлзээгүй би та нарт Алладын илгээсэн ил тод сэрэмжлүүлэгч мөн” гэж хэл.
52. Тийнхүү тэднээс өмнөхүүд ч өөрсдөд нь ирсэн гэгээн элч нарыг “илбэчин”, эсвэл “солиотой” гэсэн юм.
53. Тэд гэгээн элч нарыг хүлээн зөвшөөрөхгүй, үгүйсгэхийг үеийн үедээ гэрээсэлсэн юм уу? Үгүй! тэд зөрүүдэлсэн улс.
54. (Аяа, Мухаммед!) Тэднээс зайгаа барь! Чи буруутай биш ээ!
55. Ухуулан сургамжил. Ухуулга сургамж мусулмануудад ач тустай.
56. Би буг ба хүмүүнийг гагцхүү Надад залбираг хэмээн бүтээсэн юм.
57. Би тэднээс хувь хишиг эс хүсэх бөгөөд хоол хүнсийг минь бэлтгэг хэмээн горьдохгүй.
58. Бүхэнд хувь хишиг хайрлагч, их сүр хүчний эзэн бол Аллах мөн.
59. Харгис зальхайчуудад өмнөх нөхдийнхөө гэсгээлтэй адил гэсгээл буй. Өөрсдийг нь гэсгээхэд намайг бүү яаруулаг!
60. Өөрсдөд нь амлагдсан тэр өдрийн ирэх нь үл сүсэглэгсэдийн хувьд маш их харамсалтай!



Мекке-д илгээгдсэн. 49 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Алладын алдраар эхэлье*

1. Тур уулаар;

2. Яруу тод бичигдсэн Куранаар;
3. Нэхий дээр бичигдсэн судраар;
4. Байтул Магмураар;
5. Өргөгдсөн тэнгэрийн мандалаар;
6. Ороон шуурсан тэнгисээр тус тус андгайлан тангараглая.
7. Эзэнтний чинь гэсгээл эргэлзээгүй хэрэгжинэ.
8. Түүнд саад болох зүйл үгүй.
9. Тэр өдөр тэнгэр хүчтэй ганхана.
10. Уулс байрнаас хөдөлнө.(Газрын хөрс бужигнаж, үрэн таран болно.)
11. 12. Тэр өдөр (гэгээн элчүүд болон ариун шашныг үгүйсгэгчид) төөрөлдсөн худалчид (хагуу гэсгээгдэн) харамсах болно.
13. Тэр өдөр тэд ямар ч өршөөлгүйгээр там руу шидэгдэнэ.
14. Тэгээд тэдэнд: “Та нарын үгүйсгэсэн там- энэ ээ!” хэмээн улаан нүүрэн дээр хэлэгдэнэ.
15. Мөн тэдэнд: “Энэ ч гэсэн илбэ юм уу? Үүнийг харахгүй байсан гэж үү? (тэгвэл үзэх чинь энэ ээ!)”;
16. Тамын гэсгээлд тэвчсэн ч, эс тэвчсэн ч ялгаагүй. Үйлдсэн хэргийнхээ хариуг хүртэцгээрэй” гэгдэх болно.
17. Гэгээн сүсэгтнүүд диваажингийн буян хишигт умбана.
18. Тэд Эзэнтнийхээ хайрласан зүйлийн сайн сайхныг эдлэнэ. Эзэнтэн нь тэднийг халуун тамын гэсгээлээс хамгаалсан юм.
19. Тэдэнд: “Үйлдсэн буяныхаа хариуд хөөрөн баясч идэж ууцгаагтун”;
20. “Зэргэцүүлэн тавьсан сэнтий дээр тухлан залрагтун!” хэмээн хэлэгдэнэ. Бид тэдэнд хархан нүдтэй гоо бүсгүйчүүдийг хань болгон өгмүй.
21. Өөрсдөө итгэн залбирч, үр удам нь ч сүсэглэн тэднийг дагавал үр хүүхдийн зэрэг зиндааг ч өөрсөдтэй нь адил тэнцүү болгоно. Тэдний үйлдсэнээс юуг ч талаар болгохгүй. Хүн бүр өөрийнхөө үйлийн хариуцлагыг хүлээнэ.
22. Тэднийг сэтгэлд нь нийцсэн үр жимс, мах зэргээр хүрэлцээтэй хангана.
23. Тэд жимсний жүүс дүүрэн хундагаа элгэмсэгээр солилцоно. Дэл сул уг, нүгэлтэй үйлдэл тэнд үгүй болно.
24. Үнэт сувд мэт үзэсгэлэнт цэвэр үйлчлэгчид тэдэнд ялдам сайхан үйлчилнэ.
25. Тэд урьд урьдаас харан сэнтийдээ суугаад өөр хоорондоо хөөрөн баясч хуучилцгаана.
26. “Бид өмнөх ертөнцөд гэртээ байхдаа ч Аллахын гэсгээлээс үнэхээр айдагсан”;

27. “Аллах биднийг өгөөмөр сэтгэлээр “Саммум”-ын гэсгээлээс (тамын шуурганаас) аварсан шүү”;
28. Бид өмнө ч Аллахт залбирдаг байсан. Яагаад гэвэл тэр их л өрөвч, нэн энэрэгч шүү дээ” гэлцэн хуучлана.
29. (Аяа, Мухаммед!) Зон олондоо ухуулга сургамж айлд. Эзэнтнийхээ хайр энэрэлээр чи зөнч мэргэн ч биш, ухаан мулгуу ч биш болсон билээ.
30. Харин ч тэд чиний тухайд: “Тэр бол найрагч. Түүний хариуцлага хүлээх өдрийг хүлээцгээе” гэлцэнэ.
31. (Аяа, Мухаммед!): “Та нар хүлээцгээгтүн! Би ч та нарын хамт хүлээе” гэж хэлээрэй.
32. Тэдэнд үүнийг ухаан нь тушааж байна уу, эсвэл өөрсдөө самуурсан улс юм уу?
33. Эсвэл тэд: “Кураныг Мухаммед санаанаасаа зохиосон гэнэ үү?” Үгүй дээ, тэд өөрсдөө Куранд итгэдэггүй хүмүүс.
34. Хэрэв тэдний хэлсэн нь үнэн юм бол (зохицол, уран сайхан, өгүүлэмж нь) Курантай адил ганц өгүүлэмж зохиож үзэг л дээ.
35. Эсвэл тэд бүтээгчгүйгээр зүв зүгээр байгаад бүтээгдсэн юм уу? Эс бөгөөс өөрийгөө өөрөө бүтээсэн юм уу?
36. Эсвэл тэнгэр, газрыг тэд бүтээсэн юм уу? Үгүй дээ, Тэд Аллахын цорын ганц гэдэгт итгэдэггүй юм.
37. Эсвэл Эзэнтний эрдэнэсийн сан тэдний гарт байгаа юм уу? Эс бөгөөс тэд (бүхнийг хүссэн хэмжээгээр хийлгэдэг) бүхнийг эрхшээгч юм гэж үү?
38. Эсвэл тэдний хувьд (тэнгэрт гарч) нууц бүхнийг сонсдог гишгүүр шаттай юм уу? Тэгвэл тэдний сонор чих нь яруу тод нотолгоог аваад ирэг.
39. Эсвэл охидууд Аллахынх, хөвгүүд та нарынх юм уу?
40. Эсвэл чи тэднээс хариу хөлс шаардсанаас тэд дааж давшгүй өрөнд баригдчихаад байгаа юм уу?
41. Эсвэл тэдэнд далдын мэдлэг байгаад тэр бүхнийг бичээд авсан юм уу?
42. Эсвэл тэд арга заль зохиолгохыг хүсэж байна уу? Хэрэг дээр заль мэхэнд урхидуулагчид бол үл сүсэглэгсэд өөрсдөө шүү дээ.
43. Эсвэл тэдэнд Аллахаас өөр бурхан байгаа юм уу? Аллах тэдний тахин шүтсэн зүйлсээс нь ангид болой.
44. Тэд тэнгэрийн нэг хэсэг нь тасран унах гэж байгааг харсан ч түүнийг “бөөн үүл төдий” гэнэ.
45. Тэднийг гэсгээн цээрлүүлэх өдөр хүртэл түр орхи.

46. Тэр өдөр заль мэх нь өөрсдөд нь өчүүхэн ч тус болохгүй, тэдэнд туслалцаа ч өгөгдөхгүй.
47. Ийм л харгис зальхай этгээдэд өөр ч гэсгээл буй. Үүнийг тэдний олонхи нь ойлгодоггүй юм.
48. Аяа, Мухаммед! Эзэнтнийхээ зарлигийг тэвчээртэй хүлээ. Чи Бидний анхаарал дор буй. Суудлаасаа босох бүртээ ч Эзэнтнийгээ шагшин магтагтун.
49. Тэрчлэн шөнийн нэг хэсэгт ч, одод жаргах үеэр ч Аллахыг шагшин магтагтун.

### 53. СУРЕ НАЖИМ

Мекке-д илгээгдсэн. 62 айлдвар

#### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Харван одож буй одоор андгайлан тангараглая.
2. Анд нөхөр (Мухаммед) чинь төөрөлдөөгүй, шулуун замаас гажаагүй.
3. Тэр өөрийнхөө хүсэл зоргоороо ярихгүй.
4. Түүний ярих зүйл нь өөрт нь яруу тод болсон айлдвар болой.
5. Түүнийг зааж сургах нь нэн хүчирхэг (Жабрейл) нэгэн.
6. Хүчирхэг (Жабрейл элч) тэр төлөв түвшин төрхөөрөө эгцлэн гарч ирэв.
7. Эхлээд өндөрлөг мандал дээр байв.
8. Дараа нь ойргон доошилсоор л наашлав.
9. Гэгээн элч тэр хоёрын хоорондох зай саадаг нумын өндөрийн дайтай, түүнээс ойрхон ирэв.
10. Аллах ийнхүү боолууддаа зориулсан айлдвараа (Жабрейл элчээрээ дамжуулан) түүнд шилжүүлэн, ой тойнд суулгав.
11. Түүний нүдээрээ харсныг зүрх сэтгэл нь худал хэмээн үгүйсгээгүй.
12. Аяа, Үл сүсэглэгчид ээ! Та нар түүний үзсэн зүйлийн талаар түүнтэй маргалдацгаах гэж үү?
13. Үнэхээр тэр Жабрейл бууж ирсэнийг хоёр дахь удаа харсан юм.
14. Сидрат-Аль-Мүнтахайгийн дэргэд шүү.
15. Түүний дэргэд Жаннатүл Мауа ч байсан юм.
16. Сидра-Аль-Мүнтахай Аллахын гэгээ ивээсэн үед;
17. Гэгээн элчийн харц нь хаашаа ч алдраагүй.
18. Тэр үнэхээр Эзэнтнийхээ аугаа билэгдлүүдийг олж харав.

19. Та нар Лаг болон Гүзза-г харсан уу?
20. Мөн гуравдагч болох Манатыг ч (гурван зохиомол бурхад) харсан уу?
21. Та нарынхаар бол хөвгүүд та нарынх, эмэгтэйчүүд нь Эзэнтэнд хамааралтай гэж үү?
22. Тэгвэл энэ нь шударга бус оноолт мөн.
23. Эдгээр (зохиомол бурхад) чинь гагцхүү та нарын болон өвөг дээдсийн чинь зохиосон хоосон нэрс төдий. Аллах тэдний тухайд ямар ч нотолгоо буулгаагүй юм. Үнэндээ тэдэнд Эзэнтнээс чинь зөв замд залах (Куран эсвэл гэгээн элч) ирсэн ч хоосон мөрөөдөл, тачаал шуналын эрхэнд хөтлөгдөж байна.
24. Хүний хүсэж мөрөөдсөн бүхэн биелэгдэнэ гэж үү дээ?
25. Хойд ертөнц хийгээд энэ насны тавилан Аллахын эрхэнд буй.
26. Тэнгэрт олон тооны мэлэжүүд буй, тэдний ивээл нь хэнд ч ашиг тус өгсөнгүй. Гагцхүү Аллах таалж, талархсан хүнийг л ивээнэ.
27. Үнэндээ хойд ертөнцийг үгүйсгэгсэд л мэлэжүүдийг (Аллахын охид хэмээн) эмэгтэй мэтээр ярьдаг.
28. Тэдэнд энэ тухайд ямар ч мэдлэг үгүй, гагцхүү хоосон бодолдоо үндэслэдэг. Гэтэл хоосон бодол чин үнэнээс хол билээ.
29. Бидний айлдваруудаас татгалзаж, амьдралын эх үүсвэрийг зорилго болгодогсодоос ангид бай.
30. Тэдний мэдлэгийн хэр хэмжээ ердөө л энэ болой. Эзэнтэн чинь замаас төөрөлдөгсөдийг эргэлзээгүй сайн мэднэ. Зөв шулуун замыг дагагчдыг ч сайн мэдэх бөлгөө.
31. Тэнгэр, газарт буй бүхэн Аллахынх мөн. Тэр муу үйл үйлдэгсэдийг муу үйлийн хэрээр гэгсгээн, сайн үйл үйлдэгсэдийг сайн үйлээр шагнана.
32. Тэд (Диваажинд очигсод) жижиг сажиг нүгэлээс бусад том нүгэл болон алдаа-дутагдлаас ангид байдаг. Эзэнтэн чинь үнэхээр өршөөлтэй. Тэр та нарыг шавраар бүтээсэн, эхийн чинь хэвлийд байсан үеэс сайн мэддэг. Тиймээс өөрсөдийгөө цэвэр ариун хэмээн бүү бодогтун. Тэр гэгээн сүсэгтнүүдийг ч сайн мэддэг юм.
33. Аяа, Мухаммед! Чин үнэн шашнаас нүүр буруулсан хүнийг харсан биз дээ?
34. Эхлээд бага зэргийн өгч дараа нь харамч байсныг үзсэн үү?
35. Тэр, далдын ухаантай байгаад нууц бүхнийг харж байсан гэж үү?
36. Үгүй бол тэр Мусагийн дээдийн бичгийн (судрын) тухайд мэдээ аваагүй гэж үү?
37. Бас итгэлт Ибрахимийн сахифа-дээдийн бичгийн тухайд мэдээ аваагүй гэж үү?
38. Ямар ч нүгэлтэн бусдын нүглийг үүрэхгүй.

39. Хүн бүр зөвхөн өөрийнхөө хөдөлмөрийн үр өгөөжийг л хүртэвэл зохино.
40. Түүний хөдөлмөрийн үр дүн нь ч ирээдүйд, хойд ертөнцөд харагдах болно.
41. Тэгээд ертөнцийн төгсгөлийн өдөр түүнд хариу болгон хойд ертөнцөд шагнал эсвэл гэсгээл хүртээнэ.
42. Эцсийн тооцоо мэдээж Эзэнтний чинь өмнө байх юм.
43. Инээлгэгч ба уйлуулагч нь Тэр (Аллах) болой.
44. Үхүүлэгч ба амилуулагч нь ч Тэр (Аллах) болой.
45. Аллах эр, эм хоёрыг хослуулан бүтээсэн.
46. Год үсрэх, үрийн дуслаар л.
47. Хоёр дахь удаа бүтээх нь ч эргэлзээгүй Түүний хэрэг мөн.
48. Хүнийг баяжуулагч нь ч, баярхуулагч нь ч Тэр ажгуу.
49. Шигра одын Эзэнтэн ч Тэр ажгуу.
50. Тэр өмнөх Гадын ардыг ч үгүй хийсэн билээ.
51. Нэгийг нь ч үлдээлгүй Самудынхныг ч тэр үгүй хийсэн.
52. Түүнээс өмнө машид харгис зальхай, урвагч Нухын ардыг ч сүйрүүлсэн юм.
53. Мөн Лутын ардын Мутафикат хотыг ч орвонгоор нь эргүүлэн, газартай нь тэгшилсэн.
54. Тэдний дээрээс аюулт чулуу буулган, дээр дээрээс нь дарагдуулсан юм.
55. Тэгвэл Эзэнтний чинь ямар хувь хишигт нь эргэлзэх вэ?
56. Ийнхүү энэ нь (Мухаммед элч) өмнөх анхааруулгуудаас нэгэн сэрэмжлүүлэг болой.
57. Ертөнцийн төгсгөлийн өдөр ойртсоор л байна.
58. Түүнийг Аллагаас өөр тодорхойлогч (хугацааг товлогч, гэсгээлээс нь өршөөгч) үгүй.
59. Аяа, үл сүсэглэгчид ээ! Одоо та нар энэ үгэнд (Куранд) гайхах юм гэж үү?
60. Сонсохуйд инээлдэх үү, уйлалдах уу?
61. Та нар үл тоомсорлон харамсагчид мөн!
62. Аллахад сөгдөн мөргөж, сүсэглэн залбирагтун!

## 54. СУРЕ КАМАР

Мекке-д илгээгдсэн. 55 айлдвар

- Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***
1. Ертөнцийн төгсгөлийн цаг ойртож, сар хагарчихуй.
  2. Тэд (буруу номтнууд) ганц нэгэн ер бусын гайхамшиг үзэх аваас даруй нүүр буруулцгааж: “Энэ нь илбэний ид шидийн үргэлжлэл” гэнэ.
  3. Тэд гэгээн элчийг худал хэмээцгээж ийнхүү үгүйсгэв. Хүсэл тачаалдаа хөтлөгдөв. Сайн ч, муу ч бай, алив хэрэг явдлын (диваажин эсвэл там гэсэн) эцсийн цэг буй.
  4. Үнэндээ, тэдний хувьд сургамж авбал зохих мэдээлэл (Куран) ирцгээж гүйцлээ.
  5. Энэ бол аугаа их мэргэн ухаан. Гэвч тэдэнд (урвагчдад) урьдчилан сэрэмжлүүлэх нь ашиг эс өгмүй.
  6. Аяа, Мухаммед! Чи тэднээс зай барь. Ертөнцийн төгсгөлийн өдөр дуудагч (Исрафил) нь тэднийг өөрсдийн үгүйсгэж буй үйлийн төлөө (шүүлтэд) дуудна.
  7. Тэр цагт тэдний нүд бүлтийж, үхсэн царцаа мэт бөөнөөр булшнаасаа гарцгаана.
  8. Дуудагчийн өмнөөс өрсөлдөн гүйсэн үл сүсэглэгсэд: “Энэ юутай бэрх өдөр билээ?!” хэмээцгэнэ.
  9. Тэднээс өмнө Нухын ардууд ч худал хэмээцгээн манай элчийг үгүйсгэцгээж: “Галзуу амьтан” гэв. Ингэж тэд түүний үүргийг саатуулав.
  10. Тэр эцэст нь Эзэнтэндээ залбиран: “Би ялагдлаа. Надад туслан, өшөөг минь аваад аль!” гэв.
  11. Бид тэнгэрийн үүдийг нээж, усан бороо оруулсан.
  12. Дараа нь олон газар булаг шанд гаргав. Эзэнтний хувь тавилан болгосноор бороо болон булаг шандын ус нийлэв.
  13. Тэгээд Бид Нухыг банз, хадаасаар хийсэн хөлөг онгоцонд суулгав.
  14. Буруу номтнуудад хүлээн зөвшөөрөгдөөгүй Нух-д шагнал болгосон уг хөлөг онгоц бидний ба тэдний өмнө сэлэн одлоо.
  15. Бид усан галавыг сургамж болгон үлдээлээ. Гэвч үүнээс сургамж авах нэгэн байна уу?
  16. Миний гэсгээл хийгээд сэрэмжлүүлэг ямар байжээ?

17. Бид Кураныг сургамж аваг хэмээн хялбар болгов. Гэвч сургамж авах нэгэн байна уу?
18. Гадын ардууд ч (гэгээн элч Худыг) худал хэмээцгээсэн билээ. Миний гэсгээл хийгээд сэрэмжлүүлэг ямар байжээ?
19. Бид тэдэнд аюул нь арилшгүй аймшигтай ширүүн шуурга явуулав.
20. Догшин шуурга тэднийг үндсээрээ булгалан унасан дал модын адил угз татан хийсгэнэ.
21. Миний гэсгээл хийгээд сэрэмжлүүлэг ямар байна даа!
22. Бид Кураныг сургамж болог хэмээн хялбар болгосон. Гэвч үүнээс сургамж авах нэгэн байна уу?
23. Самудын ардууд ч сэрэмжлүүлэгчийг худал хэмээсэн юм.
24. Тэгээд тэд: “Бидний нэгэн адил жирийн хүнийг дагах гэж үү? Тэгвэл гарцаагүй төөрөгдөлд орж, тэнэглэнэ гэсэн үг” гэв.
25. “Бидний дундах зөвхөн түүнд айлдвар буулгагдсан гэж үү? Үгүй ээ, тэр худалч, зүтгүүр нэгэн” гэлцэв.
26. Тэд хэн нь худал, зүтгүүр болохыг маргааш л мэдэх болно.
27. Бид тэднийг сорихоор ингэн тэмээ илгээв. Тиймээс чи (Аяа, Салих) тэднийг ажиглан тэвчээртэй бай!
28. Тэдэнд худгийн ус нь ээлжээр өгөгдөхийг (нэг өдөр ингэн тэмээ, нөгөө өдөр нь хүмүүс уухыг) ойлгуулаарай.
29. Тэд нөхөдөө дуудав. Тэр чинжаалаа сугалан ингийг алав.
30. Миний гэсгээл хийгээд сэрэмжлүүлэг ямар байна даа?!
31. Тэд рүү нэгэн аймшигт орь дууг илгээв. Улмаар тэд хуурай өвс мэт хорчийж хийслээ.
32. Бид Кураныг сургамж авахад хялбар болгосон. Гэвч сургамж авах нэгэн байна уу?
33. Лутын ард ч бидний сэрэмжлүүлгийг худал хэмээв.
34. Бид энд чулуу нүүлгэх шуурга явуулав. Үүрээр Лутын гэр бүлийг аварч, бусдыг хуу хөнөөсөн болой.
35. Энэ аврал нь бидний хайр энэрэл байлаа. Наминчлан залбирагсадыг ийн шагнадаг юм.
36. Лут үнэндээ тэднийг Бидний гэсгээлээр сэрэмжлүүлсэн билээ. Гэвч тэд бидний гэсгээлд эргэлзэж байсан юм.
37. Тэд Лутын зочидыг (гоолиг залуусын дураар ирсэн мэлэкүүдийг) нүдлэн, тэднийг өмгөөлөхгүй байхыг шаардав. Бид тэдний муу сансаны хариуд нь нүдийг нь сохлон: “Миний гэсгээл сэрэмжлүүлэгийн амтыг амсацгаа!” гэв.



38. Үүр сүүсээр, арилшгүй гэсгээл тэднийг нэрэвсэн болой.
39. “Миний гэсгээл, сэрэмжлүүлэгийн амтыг амсацгаа!” хэмээв.
40. Бид Кураныг сургамж авахад хялбар болгосон. Сургамж авах нэгэн байна уу?
41. Фиргауны зон олонд ч сэрэмжлүүлэг ирсэн болой.
42. Гэвч тэд Бидний бүхий л айлдваруудыг худал хэмээн үгүйсгэцгээсэн. Тиймээс давуутай, ид шидтэй сүр хүчээр тэднийг цээрлүүлсэн билээ.
43. Аяа, Меккегийн ард түмэн! Тэнгэрээс буулгасан энэхүү зүйлээс (Куран) та нарын үл сүсэглэгчид илүү өлзийтэй гэж үү? Үгүй бол хуучны судруудад та нарын төлөө (бичигдсэн) өршөөл байна уу?
44. Эсвэл тэд “Бид Мухаммедыг ялах бүлэглэл” гэнэ үү?
45. Үл сүсэглэгчдийн бүлэг нь ялагдаж, ухарч зугатах болно.
46. Үгүй. (Тэдний амсах гэсгээл энэ ялагдах төдий биш) Тэдэнд амлагдсан гэсгээлийн тов-Ертөнцийн төгсгөлийн өдөр мөн. Энэ өдөр тэдний хувьд нэн аймшигтай, маш хүнд өдөр байх билээ.
47. Нүгэлтэнгүүд энэ хорвоод энгүй төөрөгдөл хийгээд солиорол дунд буй. Эцсийн өдөр Тамд байх юм.
48. Тэр өдөр тэднийг тамын гал дээр улаан нүүрээр хаях бөгөөд тэдэнд: “Тамын гэсгээлийг амсагтун” хэмээн хэлэгдэнэ.
49. Бид алив юмсыг тодорхой хэмжүүрээр бүтээсэн.
50. (Нэгэн зүйлийг бүтээе гэвэл) бидний тушаал “Болтугай” гэсэн ганц үг бөлгөө. Тэрбээр нүд ирмэх зуур биелэгдэнэ.
51. Бид та нарын адил өмнөх олныг ч үгүй хийсэн юм. Үүнээс сургамж авах нэгэн байхгүй юу?
52. Тэдний үйлдсэн бүхэн нь үйлийн дэвтэрт бичигдсэн байгаа.
53. Их, бага алив бүхэн нь (Лаухул Махфузд) бичигдсэн болой.
54. Тэгээд сүсэгтнүүд (хойд ертөнцөд) диваажин дахь булагийн (ус, бал, бурам, сүүн булагийн) дэргэд байх юм.
55. Тэд ид шидтэй хүчирхэг эзэнийхээ мэдэл дэх сэтгэл ханамжтай, чин үнэний газарт байх болно.



Мекке-д илгээгдсэн. 78 айлдвар



*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Машид энэрэлт Аллах:

2. Кураныг зааж сургасан.
3. Хүмүүнийг бүтээсэн.
4. Түүнийг ярьдаг болгосон.
5. Нар, сар хоёр зохих төвөөр эргэлдэнэ.
6. Ургамал, модууд түүнд сөгдөнө. (эрхшээлд нь байдаг)
7. Тэр тэнгэрийг өндөр мандал болгож, жин хэмжүүр байрлуулсан.
8. Хэмжих үйл үйлдэх бүхэнд харамлах, зальдах явдал гаргуулахгүйн тулд жин хэмжүүрийг байрлуулсан.
9. Хэмжихдээ шударга хандагтун, бүү дутуу өгөгтүн.
10. Аллах газрыг амьд бүхний төлөө (тохитой амьдраг хэмээн) жигд дэлгэн, уужим болгосон.
11. Газарт төрөл бүрийн жимс жимсгэнэ, үзэсгэлэнт хасарвааний цэцэрлэг буй.
12. Бас гэжээлийн үр тариа, анхилуун үнэрт ургамалууд ургадаг.
13. Аяа, Хүмүүс ээ! Буг чөтгөрүүд ээ! Та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
14. Аллах хүмүүнийг дүнгэнэн дуугарах домбын адил шавраар бүтээсэн.
15. Буг чөтгөрийг дүрэлзсэн галаар бүтээсэн.
16. Аяа, хүмүүс ээ! Буг чөтгөрүүд ээ! Та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
17. Тэр (Аллах) хоёр дорнын, хоёр өрнийн (нар, сар хоёрын ургах, жаргах туйлын) эзэнтэн болой.
18. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
19. Аллах (цэнгэг, шорвог) хоёр тэнгисийг урсгасан. Тэд нэг бэлчирт ойртоно.
20. Гэвч тэдний хооронд нь далан буй, бие биетэйгээ нийлэн урсахгүй.
21. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
22. Тэр хоёр тэнгисийн хоёулангаас нь сувд, шүр гарна.
23. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
24. Тэнгис далайгаар сэлэх хөлөг онгоцууд ч Аллахынх болой.
25. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
26. Газар дэлхий дээр буй бүхэн мөхөж үгүй болно.
27. Аугаа бөгөөд өгөөмөр Эзэнтэн чинь ашид мөнх үлдэнэ.

28. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
29. Тэнгэр, газарт буй бүхэн Аллахаас хувь хишиг хүсдэг. Тэр агшин бүрт (өөрийн ид шидээр) шинэ үйлийг гүйцэлдүүлнэ.
30. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
31. Аяа, хүмүүн хийгээд буг чөтгөрийн бүлэгүүд! Бид удахгүй та нартай тооцоо бодох болно.
32. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
33. Аяа, хүмүүн хийгээд буг чөтгөрийн бүлэгүүд ээ! Аллахын гэгсгээлээс зугатаж, тэнгэр, газрын хязгаарыг давж чадах аваас явагтун. Гагцхүү түүнийг Эзэнтний соёрхлоор л давж чадах болой.
34. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
35. Ертөнцийн төгсгөлийн өдөр та нарт улалзсан галын дөл болон утаа илгээгдэнэ. Түүнээс хамгаалж эс чадна.
36. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
37. Тэнгэр хага үсэрч, тамын галд тос шиг хайлан, хээрийн улаан цэцэгтэй бадамлах цагт..,
38. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
39. Тэр өдөр хүмүүн ба буг чөтгөрийн хэн нь ч нүглийн тухайд эс асуугдана. (Аллах бүгдийг мэдэж байгаа)
40. Тийм атал Та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
41. Нүгэлтнүүд өөрсдийн тэмдэгээр танигдах бөгөөд тэднийг хөхөл, хөлөөс нь шүүрэн авч там руу шиднэ.
42. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
43. Нүгэлтнүүд худал хэмээсэн там энэ болой.
44. Тэд тамын гал, буцлам халуун усны дунд орлилдон уйлалдах болно.
45. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
46. Эзэнтний эрх мэдлээс айж эмээдэг хүмүүст хоёр диваажингийн цэцэрлэг буй.
47. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?

48. Хоёр цэцэрлэгт зүйл бүрийн сүүдэрлэх модод, үр жимс буй.
49. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
50. Аль алинд нь хоёр булаг урсаж байгаа.
51. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
52. Аль алинд нь тал бүрийн жимс хос хосоор (ихэрлэн) байгаа.
53. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
54. Диваажингийнхан зузаан хоргойгоор гадарласан орыг түшиж сууна. Хос цэцэрлэгийн үр жимс нь (босож, суун, хэвтсэн ч) гар хүрэхээр ойрхон байна.
55. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
56. Диваажинд өөрийнхөө нөхрөөс өөр хүнийг хулгай нүдээр хардаггүй, өдий хүртэл хүн ч, буг чөтгөр ч гар хүргээгүй гоо бүсгүйчүүд хүлээж байдаг.
57. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
58. Тэдний цэвэр ариун, гоо үзэсгэлэн нь шүр лугаа адил тунгалаг цэвэрхэн болой.
59. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
60. Сайн үйлийн хариу нь сайн үйл л болой.
61. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
62. Энэхүү хоёр диваажингаас гадна бас хоёр диваажингийн цэцэрлэг буй.
63. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
64. Энэ цэцэрлэгүүд нь нов ногоон болой.
65. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
66. Эл хоёр цэцэрлэгт газрын дороос оргилох хос булаг буй.
67. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
68. Хос диваажингийн цэцэрлэгт төрөл бүрийн жимс, хасарваань, анар буй.
69. Тийм агал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?

70. Тэнд ааш зан сайтай, гоо үзэсгэлэнт бүсгүйчүүд буй.
71. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
72. Тэд нар үл тусах асарт суудаг хархан нүдтэй бүсгүйчүүд болой.
73. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
74. Тэдэнд урьд өмнө буг ч, хүн ч халдаж ойртоогүй.
75. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
76. Диваажингийнхан зөөлөн ногоон дэр дэрлэн, гоёмсог дэвсгэр дээр тухлан хөлбөрнө.
77. Тийм атал та нар Эзэнтнийхээ хувь хишгээс алийг нь үгүйсгэж чадах вэ?
78. Нэн их өгөөмөр Эзэнтний чинь алдар нь буянтай эрхэмсэг яруу болой.

**56. СУРЕ УАКИГА**

Мекке-д илгээгдсэн. 96 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Ертөнцийн төгсгөл тохиохуйд;
2. Түүний тохиолыг хэн ч үгүйсгэж чадахгүй.
3. Энэ өдөр, (заримыг тамд оруулан) доошлуулан, (заримыг диваажинд гарган) дээшлүүлнэ.
4. Газар хүчтэй чичирч;
5. Уулс бут үсэрч;
6. Тоос болон сарнисан үед.
7. Та нар гурван бүлэг болон хуваагдана.
8. (Нэгдүгээр бүлэг) Баруун талынхан, (Өөрөөр хэлбэл үйлийн дэвтэр баруун гар талаасаа өгөгдөгсөд) Тэр баруун гар талынхан юутай сайхан вэ?
9. (Хоёр дахь бүлэг) Зүүн гар талынхан. (Үйлийн дэвтэр зүүн гар талаас өгөгдөгсөд) Тэд юутай муухай юм бэ?
10. (Гурав дахь бүлэг) Сайн үйлийн төлөө хамгийн сайн үйлс бүтээгчид. Тэд хамгийн эхний эгнээнд диваажинд орох хүмүүс.
11. Тэд Аллахад ойртогсод билээ.
12. Нагим хэмээх буянтай диваажинд ойртогсод мөн.

13. Өмнөхүүдээс арай их;
14. Сүүлийн үеийнхнээс арай бага.
15. Тэд алтаар гоёсон сэнтий дээр сууна.
16. Бие биен рүүгээ харан тухламуй.
17. Тэдэнд өтлөшгүй мөнх, нэг янзандаа байх залуус үйлчилнэ.
18. Урсаж буй дарсаар гүц, хундагыг дүүргэн барина.
19. Тэр дарсыг ууснаар толгой өвдөхгүй, согтохгүй.
20. Тэдэнд таалсан үр жимс;
21. Хүссэн шувууны мах;
22. Тунамал хар нүдэн бүсгүйчүүд зориулагдана.
23. Тэд шүр сувд мэт гоё.
24. Энэ бүхэн тэдний хийсэн сайн үйлийнх нь хариу болой.
25. Тэнд хоосон худал үг сонсохгүй.
26. Гагцхүү “Салем, Салем (амар амгалан болтугай)” гэсэн үгийг л сонсоно.
27. Баруун талынхан юутай сайхан юм бэ?
28. Тэд: “Өргөсгүй интоорын модоор;
29. Жимс нь сагсайсан гадил модоор;
30. Асарласан сүүдрэвчээр;
31. Оргилон урсах усаар;
32. Барагдашгүй жимсээр;
33. Үл дундрах буянаар;
34. Өргөмжит зөөлөн ороор хангагдана.
35. Бид үнэхээр гоо охидоор тэднийг ханилуулна.
36. Бид диваажингийн эмсийг онгон охин байдлаар бэлтгэсэн.
37. Тэд эр нөхрөө үнэнчээр хайрлагч, чацуутангууд болой.
38. Энэ бүхэн баруун талынханд зориулагдмой.
39. Эдгээрийн зарим нь өмнөхүүдээс;
40. Зарим нь ч сүүлийн үеийнхнээс бүрдэнэ.
41. Зүүн талын эзэд нь юутай муухай юм бэ?
42. Тэд халуун гал, буцламгай усны дотор оршино.
43. Мөн хар утааны сүүдэрт буй.
44. Сэрүүн ч биш, тааламжтай ч биш;
45. Яагаад гэвэл тэд үүнээс өмнө амьд хорвоогийн сайн сайхныг эдэлсэн хүмүүс билээ.
46. Тэд их нүгэлт хэргийг үйлдэхдээ маш зөрүүдлэн зогссон юм.

47. Тэд: “Бид үхэж, шороо чандруу болсон ч дахин амилах гэж үү?” хэмээнэ.
48. “Өмнөх өвөг дээдсүүд маань ч дахин амилах юм уу?” гэж асууна.
49. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Эргэлзээгүй өмнөхүүд болон хожимынхон ч...”
50. Тодорхой өдрийн товлосон хугацаанд нэг дор цугларах болно” хэмээн хэлэгтүн.
51. Дараа нь дахин амиллахыг хүлээн зөвшөөрдөггүй худалч нар аа!
52. Заккумын модноос идэцгээнэ.
53. Гэдэсээ түүгээр дүүргэцгээнэ.
54. Буцлам халуун усыг ууцгаана.
55. Ангасан тэмээ мэт залгилана.
56. Энэ нь шүүгдэх өдөр тэдэнд өгөх “дайллага” болой.
57. Аяа, Хүмүүс ээ! Бид та нарыг бүтээсэн. Та нар дахин амиллахыг яахлаар хүлээн зөвшөөрдөггүй юм вэ?
58. Хэрэв, тийм бол хэлэгтүн! Эхийн умайд дуслуулах үрийн шингэнийг...
59. Хүн болгож бүтээгч нь та нар юм уу? Эсвэл Бид юм уу?
60. Бид та нарын дунд үхлийн товыг тогтоосон. Үүнийг хэн ч эсэргүүцэж чадахгүй.
61. Бид та нарыг өөр төрлийн хүмүүс болгон өөрчлөөд ч, өөрсдөө мэддэггүй нэгэн төрөл болгон бүтээгээд ч чадна.
62. Та нар үнэндээ анхлан яаж бүтээгдсэнээ мэднэ. Анх ор хоосноос бүтээгч Аллах болохыг хүлээн зөвшөөрцгөөсөн билээ. Тэгвэл Аллах та нарыг анхлан бүтээсэн тэр байдалд оруулж чадахыг бодохгүй байна уу?
63. Одоо тарьсан тариагаа хар л даа!
64. Түүнийг та нар ургуулах юм уу? эсвэл Бид ургуулах уу?
65. Хэрэв, Бид хүсвэл түүнийг шимтгүй хуурай өвс болгон хувиргаж чадна. Тэгээд та нар ангайн гуниглаж хоцрох л байсан шүү дээ.
66. Тэгвэл та нар: “Үнэндээ бид (хөдөлмөр, үрийн талаар) маш их хохирол амслаа;
67. “Бүүр гар хоосон үлдлээ” гэхсэн биз дээ.
68. Та нар ууж буй усаа хар даа?
69. Түүнийг үүлнээс та нар бороо болгон оруулав уу? Эсвэл Бид буулгасан уу?
70. Хэрэв Бид хүсвэл түүнийг шорвог болгон хувиргаж чадна. Тийм атал яагаад наминчлан талархдаггүй юм вэ?
71. Бас асааж буй галаа хар даа!

72. (Нэг мөчирийг нөгөөтэй нь үрвэл гал гардаг) Модыг та нар бүтээсэн үү? Аль эсвэл Бид бүтээсэн үү?
73. Бид үүнийг сургаж болгон, эзгүй хээрийн зорчигчид ашиглаж хэмээн бүтээсэн билээ.
74. Тиймийн учир Эзэнтнийхээ аугаа алдрыг мандуулагтун.
75. Тийнхүү Бид ододын байрлалаар тангараглаж байна.
76. Хэрэв ухаарч чадвал энэ нь их том тангараг болой.
77. Тэр үнэхээр эрхэм Куран мөн.
78. (Энэ нь) сударт (Лаухул Махфузд) хадгалаастай буй.
79. Түүнийг цэвэр ариун хүмүүс барина.
80. Тэр бүхий л ертөнцийн Эзэнтний зүгээс буулгагдсан болой.
81. (Аяа, үл сүсэглэгч ардууд аа!) Та нар энэ үгийг (Куран судрыг) дорд үзнэ гэж үү?
82. Аллахын хайрласан хувь хишигт талархахын оронд (хувь хишиг хүртээгчийг) үгүйсгэх гэж үү дээ?
83. Та нар үхэлтэй нүүр тулахын үед;
84. (Тэнгэрт халих хүнийг) ширтэхээс цаашгүй шүү дээ.
85. Тэр агшинд үхэж буй хүнд та нарыг бодвол Бид илүү ойр байх бөгөөд та нар үүнийг мэдрэхгүй.
86. Хэрэв та нар Ертөнцийн төгсгөлд шүүгдэхгүй юм бол,
87. Та нарын хэлдэг үг үнэн юм бол, үхэгсэдийн амийг бие махбодод нь яагаад буцааж чаддаггүй юм вэ?
88. Хэрэв үхсэн хүн Аллахад ойр байсан бол,
89. Түүнд амар амгалан, сайхан хувь хишиг, буянтай диваажин буй.
90. Хэрэв, тэр баруун талын эздийн нэг нь бол,
91. “Чамд баруун талынхны эздийн мэндийг дамжуулая!” хэмээгдэнэ.
92. Харин тэр дахин амилахыг хүлээн зөвшөөрдөггүй төөрөгсөдийн нэг нь бол,
93. Түүнийг буцламгай халуун усаар угтаж авна.
94. Тэр там руу хаягдана.
95. Энэ нь яруу тод, эргэлзээгүй чин үнэн мөн.
96. Тиймийн учир аугаа Эзэнтнийхээ алдрыг яруусган шагшин магтагтун.



## 57. СУРЕ ХАДИД

Мадина-д илгээгдсэн. 29 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Тэнгэр, газарт буй бүхэн Аллахыг шагшин магтана. Тэр ялагдашгүй, мэргэн ухааны эзэн.
2. Тэнгэр, газрын эзэгнэл гагцхүү Аллахынх. Тэр үхүүлдэг, бас амилуулдаг. Түүний хүч чадал бүхнийг эрхшээнэ.
3. Түүнд эхлэл, төгсгөл үгүй. Тэр мөнх оршсоор байх болно. Ид шидийн чадалаа үзүүлдгээрээ ил тод, нүдэнд үзэгдэхгүй, ухаан хүрдэггүй нууцаараа далд байдаг. Тэр бүхнийг мэдэж байдаг.
4. Тэр тэнгэр, газрыг зургаан өдөрт бүтээсэн бөгөөд дараа нь сансар огторгуйг эзэгнэв. Тэр газар дор орсон, газар дороос гарсан зүйлийг ч, тэнгэрээс буусан, тэнгэрт хөөрсөн зүйлийг ч мэднэ. Та нар хаана байна, Тэр та нартай хамт байх бөлгөө. Аллах та нарын хийж буй бүхийг харж байдаг.
5. Тэнгэр, газрын эзэгнэл Аллахынх. Алив үйл бүхэн Аллахын өмнө ирэх болно.
6. Аллах өдрийг шөнөөр халж, шөнийг өдрөөр сольдог. Тэр хүний сэтгэлд буй бүхнийг мэднэ.
7. Тиймээс Аллах хийгээд Түүний гэгээн элч нарт сүсэглэн залбирагтун. Та нарт эзэгнүүлсэн мал хөрөнгөөс буяны өглөг өгөгтүн. Аллах болон гэгээн элч нарт сүсэглэж, өглөг өргөгсдөд буян хишиг буй.
8. (Аяа, үл сүсэглэгсэд ээ!) Гэгээн элч та нарыг Эзэнтэндээ сүсэглэн залбирахад уриалахад яагаад Аллахад итгэн сүсэглэдэггүй юм вэ? Аллах үнэндээ та нараас амлалт авсан шүү дээ. Хэрэв сүсэглэхийг хүсвэл (энэхүү уриалгыг хүлээн зөвшөөрөгтүн.)
9. Та нарыг харанхуйгаас гэрэл гэгээнд гаргахын тулд Аллах өөрийн боолуудад яруу тод айлдваруудаа илгээсэн билээ. Аллах эргэлзээгүй та нарт халамжтай, энэрэнгүй.
10. Тэнгэр, газрын бүх баялаг Аллахынх байх атал та нар яагаад Аллахын төлөө мал хөрөнгөө зориулдаггүй юм. Меккег эзлэхээс өмнө мал хөрөнгөө зарцуулан тулалдагсад ба түүний дараа мал хөрөнгөө зарцуулан тулалдагсад адил биш ээ. Өмнөхүүдийн хүндэтгэл зиндаа сүүлчийнхээс дээгүүр байх болно. Аллах бүгдэд нь диваажинг амласан. Аллах та нарын үйлдсэн бүхнээс мэдээлэлтэй байдаг.
11. Хэн Аллахын төлөө (буяны өглөг) зээл өгвөл Аллах ч хариугийг нь хэд дахин илүү өгнө. Түүний төлөө их буян хишиг хүртээнэ.

12. Тэр өдөр эрэгтэй, эмэгтэй сүсэгтнүүдийн өмнө болон баруун талаар нь гэрэл цацарч буйг харна. Тэдэнд: “Өнөөдөр та нарт баярт мэдээ ирлээ. Хаяагаар нь ариун булаг урсах диваажинд эгнэгт оршицгооно. Энэ бол аугаа баяр жаргал” хэмээгдэнэ.
13. Тэр өдөр эрэгтэй, эмэгтэй хоёр нүүртэнгүүд сүсэгтнүүдэд хандан: “Биднийг түр хүлээгээч, гэрэл гэгээгээс чинь өчүүхэн боловч хүртээ” гэлцэх юм. Тэдэнд: (Ёжтойгоор) “Амьд хорвоод буцаж очоод гэрэл гэгээ гуйгтун!” хэмээгдэнэ. Тэгээд тэдний хооронд үүд бүхий хана босохуйд, дотор тал нь энэрэл хайр, гадна тал нь Алладын гэгсгээлээр дүүрнэ.
14. Хоёр нүүртэнгүүд сүсэгтнүүдэд: “Бид амьд ахуйдаа та нартай хамт байсан биш билүү?” хэмээн хашгирахад сүсэгтэнгүүд: “Тиймээ, гэвч та нар өөртөө хор хөнөөл учруулсан, мусулмануудад муу муухайг хүссэн, өөрсдөө эргэлзээнд автсан. Хоосон мөрөөдөл чинь Алладын тушаал иргэл та нарыг хуурсан. Мөн залилан мэхлэгч чөтгөр л та нарыг хууран Алладын замаас төөрөгдүүлсэн” хэмээн хэлэв.
15. (Аяа, хоёр нүүртэнгүүд) “Өнөөдөр та нараас ч, үл сүсэглэгчдээс ч төлбөр нэхэгдэхгүй. Та нарын очих газар халуун там. Та нарт зохицох нь тэр болой. Там бол юутай муухай газар гээч!” хэмээн хэлэв.
16. Сүсэглэн итгэгсэд Алладын айлдвар болон Түүнээс буусан чин үнэнд (Куранд) сэтгэл нь уярах болоогүй гэж үү? Тэд урьд өмнө ариун судар өгөгдөгсөдийн адил цаг хугацаа улирахын эрхээр зүрх сэтгэл нь харлах вий дээ. Тэдний олонхи нь зөв замаас гажсан юм.
17. Аллах үхмэл газрыг амилуулдагийг мэдэгтүн. Үнэндээ та нарыг ухааруулахын тулд айлдваруудаа ил тод тайлбарласан билээ.
18. Буяны өглөг өгсөн эрэгтэй, эмэгтэй сүсэгтэн нар болон Алладын төлөө сайн сайхан бүхнийг зориулсан, зээл (өглөг) өгсөн хүмүүст хэд дахин илүү хариу, үнэ цэнэтэй сайхан шагнал өгөгдөнө.
19. Аллах хийгээд Түүний гэгээн элчүүдэд сүсэглэн итгэгсэд бол Эзэнтнийхээ өмнө үнэнчүүд, Алладын төлөө амиа золиослогчид болой. Тэд буян хишиг болон гэрэл гэгээнд умбана. Үл сүсэглэн Бидний айлдваруудыг үгүйсгэгсэд бол тамынхан болой.
20. Та нар мэдэгтүн! Энэ хорвоогийн амьдрал бол зугаа цэнгэл, хуурамч явдал, гоёл баярхал, харилцан магтаал, мал хөрөнгө, үр хүүхдийн олноор арсалдах явдал мөн. Энэ нь эзэн хүн хур бороогоор ургасан тарианд гайхшравч дараа гандан шарлахын адил бөлгөө. Дараа нь үрэгдэн, үнс болж хийснэ. (Үл сүсэглэгчдэд) гэгсгээл, (сайн үйл үйлдэгсдэд) Алладын уужим өршөөл буй. Энэ хорвоогийн амьдрал бол хуурамч. Зуурдын жаргал төдий.
21. Эзэнтнийхээ уужим өршөөлд, газар тэнгэр мэт уужим Аллахад, Түүний гэгээн элчүүдэд сүсэглэн итгэгсэдийн хувьд бэлтгэгдсэн диваажин руу

- тэмүүлэгтүн. Энэ нь Алладын энэрэл нигүүлсэл мөн. Аллах түүнийг хүссэн хүндээ өгдөг. Аллах аугаа өршөөл энэрэлийн эзэн мөн.
22. Газар дэлхийд буй болсон, өөрсдөд чинь тохиосон гай зовлонгууд Бид бүтээхээс аль эрт Лаухул махфуз сударт бичигдсэн болой. Энэ нь Аллахад хялбар байх нь маргаангүй шүү дээ.
  23. (Аллах үүнийг бичих учир гэвэл) Өнгөрсөн юмны хойноос эс гуниглуулах, Аллахаас хайрласан хувь хишигт хэтэрхий эс баясгахын төлөө болой. Аллах бие тоосон, онгируо сагсууг эс таалдаг юм.
  24. Тийм амьтад харамч байдаг бөгөөд бусдад харамч байхыг сургадаг. Хэн Алладын өмнө өглөг өгөхөөс татгалзана, Аллах түүгээр гачигдахгүй, бүхий л сайшаал Аллахад зохимой.
  25. Бид гэгээн элчүүдээ яруу тод нотолгоотойгоор илгээсэн бөгөөд хүн төрөлхтөн шударга ёсыг тогтоог хэмээн элч нарын хамт судар болон хуулийг (шариатыг) буулгасан юм. Бид онцгой аюултай ч хүмүүнд ач тустай төмөрийг бүтээсэн. Энэ нь хэн нэгэн Алладыг үзэлгүйгээр Аллах болоод гэгээн элч нарт туслах (итгэн сүсэглэх) эсэхийг мэдэхийн тулд байлаа. Аллах эргэлзээгүй аугаа хүчирхэг, онцгой ид шидтэй.
  26. Бид Нух болон Ибрахимыг гэгээн элчээр илгээсэн билээ. Тэдний үр удамд ч гэгээн элчийн үүрэг болон судрыг хайрласан. Тэдний хүмүүсийн цөөн хэд нь зөв шулуун замыг сонгож, олонхи нь төөрөлдсөн.
  27. Тэгээд Бид гэгээн элч нараа тасралтгүй илгээсэн. Бас Мариямын хүү Исаг (Есүсийг) илгээж, түүнд Инжил (Библи) судрыг хайрласан. Түүнийг дагагсадын зүрх сэтгэлд энэрэл, нигүүлсэл суулгав. Харин тэдэнд бид рухбаниятыг (бясалгал) үүрэг болгоогүй, тэд Алладын тааллыг хүсэмжлэн, өөрсдөө олж авсан юм. Гэвч тэд үүнийг зүй ёсоор нь биелүүлж чадаагүй билээ. Харин тэдний сүсэглэн итгэгсдэд шагналыг нь бүрэн өгсөн. Тэдний олонхи нь зөв шулуун замаас гажсан даа.
  28. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахаас айгтун. Түүний гэгээн элчид сүсэглэн итгэгтүн. Аллах энэрэл хайраа хоёр дахин нэмж, (тамын Сират гүүрээр гарахад) гийгүүлэх гэрэл өгч өршөөнө. Аллах машид өршөөгч, нэн нигүүлсэгч болой.
  29. Судрыг эзэгнэгсэд Алладын хайр энэрэлээс аливаа зүйлийг өөрийн дураар гаргаа оруулж эс чадахыг, тэрхүү ивээл энэрэл зөвхөн Алладын гарт буй гэдгийг, түүнийг Аллах зөвхөн хүссэн боолдоо хайрладаг болохыг, Аллах өгөөмөр энэрэлийн эзэн мөнхийг ухааруулахын тулд (Аллах энэхүү айлдварыг) тайлбарлав.

## 58. СУРЕ МУЖАДАЛА

Мадина-д илгээгдсэн. 22 айлдвар.

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Нөхрийнхөө тухайд чамтай (Мухаммедтэй) зөрөлдөж, бас гомдлоо Аллахад мэдүүлсэн эмэгтэйн үгийг сонссон юм. Аллах хоёулангийн үгийг сонссон. Аллах бүхнийг сонсож, мэдэж байдаг.
2. Эхнэрүүдээ зихар хийгсэдийн (ээжтэйгээ зүйрлэгсэдийн) эхнэрүүд нь тэдэнд эх нь болж чадахгүй. Тэдний өөрсдийг нь төрүүлсэн эмэгтэйчүүд л эх нь байж чадна. Эргэлзээгүй ичгүүргүйгээр худал хэлжээ. Аллах эргэлзээгүй уучлагч, ивээн энэрэгч мөн.
3. Эхнэрүүдээ ээжтэйгээ зүйрлэн, хожим хэлсэндээ гэмшсэн хүмүүс, эхнэртэй учрахаас өмнө нэг боолыг чөлөөлөх хэрэгтэй. Энэ нь та нарт сургамжилж буй зүйл мөн. Аллах та нарын хийсэн бүхнээс мэдээлэлтэй.
4. Харин боол барьдаггүй хүн эхнэртэй учрахаас өмнө хоёр сарын турш мацаг баривал зохино. Хэрэв хөгшрөл болж хүнд өвчний улмаас мацаг барих боломжгүй бол үгээгүй ядуу жаран хүнийг цагтал нэг удаа хооллуулах үүрэгтэй. Эдгээр нь Аллах болон Түүний гэгээн элчид сүсэглэн итгэхийн төлөө юм. Энэ бол Аллахын зарлиг (хууль). Үүнийг үгүйсгэн эсэргүүцэгчдэд хатуу гэсгээл буй.
5. Үнэндээ Аллах болон Түүний гэгээн элчийг үгүйсгэн эсэргүүцэгчид өөрсдөөс өмнөхүүдийн үзсэн цээрлэлийн адил цээрлэл үзэх болно. Бид тэдэнд (цэвэр ариун ба бузарыг, үүрэг ба зарлигийг хамарсан) яруу тод айлдваруудаа илгээсэн юм. Үл сүсэглэгсэдийн хувьд тарчилган зовоох гэсгээл буй.
6. Тэр өдөр Аллах тэдний бүгдийг дахин амилуулах бөгөөд үйлдсэн хэргийг нь өөрсдөд нь хэлж өгнө. Тэдний хийсэн бүхнийг Аллах мэднэ. (Бичээд тавсан) Харин тэд үүнийг мартагцаасан. Аллах алив бүхний гэрч билээ.
7. Тэнгэр, газарт буй бүхнийг Аллах мэдэж байдгийг чи ухаардаггүй юм уу? Гурван хүн шивнэлдэж буй газарт дөрөв дэх нь Аллах ажгуу. Таван хүн шивнэлдвэл зургаа дахь нь гарцаагүй Аллах мөн. Тэд олон ч, цөөн ч бай, хаана байсан ч Аллах тэдэнтэй хамт байдаг. Тэгээд ертөнцийн төгсгөлийн өдөр Аллах тэдэнд үйлдсэн бүхнийг нь хэлж өгнө. Аллах бүхнийг бүрэн мэдэгч мөн.
8. Нууцаар шивнэлдэхийг хориглосноос хойш түүнийг давтсан хүнийг чи харсан уу? Гэтэл тэд хориглосныг зөрчиж, нүгэл дайсагнал, гэгээн элчийн эсрэг үгүйсгэлийн үүднээс шивнэлдэнэ. Тэд чам дээр ирэхдээ

Аллах мэндлэхдээ хэлээгүй үгийг хэлж, мэндлэн: “Аллах биднийг энэхүү үгийнхээ төлөө цээрлүүлэхгүй” гэдэгсэн. Халуун там тэдэнд зохимой. Тэд тамд орцгооно. Тэр юутай бузар муухай газар гээч!

9. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Хэрэв хоорондоо нууцаар шивнэлдвэл нүгэл, дайсагнал гэгээн элчийг эсэргүүцэх талаар бүү шивнэлдэгтүн. Харин ч сайн үйлс, гэгээн сүсэглэлийн тухай шивнэлдэгцгээгтүн. Өмнө нь буцаж очих Аллахаас айгтун.
10. Нууцаар шивнэлдэх нь сүсэглэгсэдийг гутраахын тулд чөтгөр шулмасын үүсгэсэн арга заль. Ийм л шивнэгчид Аллахын зөвшөөрөлгүйгээр сүсэгтнүүдэд ямар ч сөрөг нөлөө үзүүлж эс чадна. Сүсэгтнүүд гагцхүү Аллахад найдагтун.
11. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Хуран чуулах үеэр та нарт “Суудал тавьж өгөгтүн.” хэмээгдэхүйд суудал тавьж өгөгцгөөгтүн. Хэрэв “Суудлаасаа босогтун” гэвэл босоод явагтун. Аллах та нараас сүсэглэгсэд хийгээд эрдэм мэдлэг өгөгдөгсөдийн зиндааг дээгүүр байлгана. Аллах та нарын үйлдсэн бүхнээс мэдээлэлтэй байгаа.
12. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нар гэгээн элчтэй тусгайлан ярилцаж гэвэл урьдаар ядуу үгээгүйчүүдэд буяны өглөг өгч, дараа нь ярилцаарай. Энэ нь та нарын хувьд өлзийтэй, нүглээс чинь аврана. Хэрэв өглөг болгох юм олохгүй бол буруугүй. Аллах машид өршөөгч, нэн нигүүлсэгч болой.
13. Та нар гэгээн элчтэй аминчлан ярилцахын өмнө буяны өглөг өгөхөөс эмээсэн юм уу? Тэгж хэрэггүй. Аллах та нарыг өршөөсөн. Одоо уншлага мөргөлөө үйлдэж, ариуслын өглөгөө өргөгтүн. Аллах хийгээд Түүний гэгээн элчийг дагагтун. Аллах та нарын үйлдсэн бүхнээс мэдээлэлтэй байгаа.
14. Аллахын уур хилэнг хүргэсэн хүмүүстэй нөхөрлөгсөдийг чи хараагүй гэж үү? Тэд та нараас ч, тэднээс ч (Иудэйчуудаас ч) биш ээ. Тэд мэдсээр байж хуурамчаар тангарагладаг.
15. Аллах тэдэнд хатуу гэсгээл зэхсэн буй. Тэдний араншин юутай бузар муухай юм гээч!
16. Тэд хуурамч тангарагаараа бамбай болгон хүмүүсийг Аллахын замаас төөрөгдүүлдэг. Тиймийн учир, тэдний төлөө тарчилгах гэсгээл буй.
17. Тэдний мал хөрөнгө, үр хүүхэд нь Аллахын гэсгээл ирэхэд ямар ч тус болохгүй. Тэд тамынхан. Тэнд үүрд үлдэцгээх болно.
18. Аллах бүгдийг дахин амилуулах өдөр тэд амьд ахуйд та нарт андгайлсны адил Аллахт ч тангараглах болно. Энэ нь өөртөө ашиг тустай гэж боддог. Тэд жинхэнэ худалч гэдгийг мэдэж авагтун.
19. Чөтгөр-шулмас тэднийг эзэгнэн, Аллахын айлдварыг мартуулсан. Тэд ийнхүү чөтгөрийн талынхан болсон. Анхаарагтун! Чөтгөр шулмасын талынх хор хөнөөлд учрагсад бөлгөө.

20. Аллах хийгээд Түүний гэгээн элчийг эсэргүүцэгчид бол хамгийн адгийн шааруудын эгнээнд орох болно.
21. Аллах: “Маргаангүй Би болоод Миний гэгээн элч нар ялна” хэмээн (Лаухул махфузд) бичсэн болой. Аллах үнэхээр машид хүчирхэг, ялагдашгүй билээ.
22. Аллах хийгээд хойд ертөнцөд сүсэглэн итгэгчдийн хувьд Аллах болон Түүний элчийг эсэргүүцэгсэд нь - эцэг нь ч бай, хөвгүүд нь ч бай, ахан дүүс нь ч бай, төрөл садан нь ч бай – тэдэнтэй нөхөрлөлж буйг чи эс харна. Аллах тэдний зүрх сэтгэлд нь сүсэглэлийг шингээчихсэн юм. Нөгөө талаар тэдний өөрийн зүгээс итгэл үнэмшлээр (Куранаар) бататгаж дэмжсэн юм. Тэднийг хажуугаар нь булаг урсдаг диваажингуудад оруулах бөгөөд тэд тэндээ үүрд оршмой. Аллах тэднийг таалдаг, тэд ч Аллахыг таалдаг. Ийнхүү тэд Аллахын дуулгавартай хүмүүс билээ. Мэдэгтүн! Аллахад дуулгавартай хүмүүс хүсэл мөрөөдлөө хангах болно.



Мадина-д илгээгдсэн. 24 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Тэнгэр, газарт буй бүхэн Аллахыг шагшин магтана. Тэр ялагдашгүй бөгөөд мэргэн ухааны эзэн мөн.
2. Аллах ариун номын эздийн дотроос үл сүсэглэгсэдийг (Иудэйчүүдийн ардуудаас) анх хөөж туугаад нутгаас нь гаргасан юм. Та нар тэднийг гараад явна хэмээн санаагүй билээ. Тэд баг цайз нь Аллахаас өөрсдийгөө хамгаална гэж бодсон юм. Гэтэл Аллахын гэсгээл санаандгүй байхад тэднийг нэрвэсэн. Аллах тэдний сэтгэлд нь айдас хуруулав. Тэгээд тэд гэр орноо өөрсдийн хийгээд сүсэгтэн нарын гараар сүйтгэв. Аяа, оюун ухааны эзэд ээ, үүнээс сургамж авагтун.
3. Хэрэв Аллах тэднийг хөөж туугаагүйсэн бол уул шугмандаа энэ хорвоод өөрөөр цээрлүүлэх байсан биз. Хойд ертөнцөд тамын гэсгээл ч тэднийх баймуй.
4. Энэхүү гэсгээл нь тэдний Аллах хийгээд Түүний гэгээн элчийг эсэргүүцсэний хариу болой. Хэн Аллахыг эсэргүүцэнэ, тэр Аллахын хатуу гэсгээлтэй учрах болно.
5. Аяа, Мусулманчууд аа! Хасарвааны модыг тайрах чинь, эсвэл босоогоор нь хэвээр үлдээх чинь бүхэлдээ Аллахын болгоосноор болой. Мөн балмад танхай Иудэйчүүдийг дорд үзэхийн төлөө билээ.
6. Аллахаас гэгээн элч нарт тэднээс олзлон авч өгсөн нь та нарын морьд,

тэмээгээр довтолсноос үүдэлтэй олз биш ээ. Гэхдээ Аллах гэгээн элч нараа хүссэн хэн бүхнээс дээгүүр өргөмжилдөг юм. Аллахын хүч чадал алив бүхэнд хүрнэ.

7. Аллахын гэгээн элчид (Хурайза, Назир, Падак, Хайбарын үл сүсэглэгсдээс) хот суурингийн ардуудаас авч өгсөн олз нь Аллахад, гэгээн элч нарт, тэдний ойрын хамаатнуудад, өнчрөгсдөд, үгээгүй ядууст, хол замын зорчигсдод зориулагдана. Энэ нь та нарын дунд буй баячуудын гараас гарт дамжин үрэгдэх вий. Гэгээн элч та нарт юуг өгнө, түүнийг авагтун. Мөн гэгээн элч хориглосон зүйлээс болгоомжлогтун. Аллагаас айгтун. Аллахын гэсгээл үнэхээр хатуу юм шүү.
8. Энэхүү олзны нэг хэсэг нь нутаг хийгээд мал хөрөнгөөсөө салсан, Аллахын ивээл энэрэлийг хүсч, Аллах хийгээд Түүний гэгээн элчид тусалсан үнэнч боолуудад өгөгдөх болно. Тэд үнэнчүүд болой.
9. Тэднээс өмнө Мадинад нутаглан, итгэл сүсэглэлдээ үнэнч байсан хүмүүс нь хожим түүнд нүүгээд ирэгсдэд ойр дотно байдаг. Тэдэнд өгсөн зүйлийн тухайд харамсан гомддоггүй юм. Өөрсдөө гачигдсан ч, тэднийг өөрсдөөсөө илүү үздэг юм. Хэн харамч зангаас тагталзвал, тэд хүсэл мөрөөдлөө биелүүлжээнэ.
10. Харин хожуу ирэгсэд: “Аяа, Эзэнтэн минь! Биднийг хийгээд биднээс өмнө сүсэглэсэн шашин нэгт ахан дүүсийг маань ивээн өршөөн соёрхогтун! Тийм сүсэгтнүүдийн эсрэг дайсагнах санааг сэтгэлд, бодолд бүү оруулагтун! Аяа, Эзэнтэн минь! Чи үнэхээр энэргч, нигүүлсэнгүй билээ” хэмээн залбирна.
11. Судар эзэмшигчдээс үгүйсгэгч ахан дүүс нартаа хандан: “Та нар нутгаасаа хөөгдөнө. Бид ч та нартай хамт явцгаана. Та нартай байлдах шаардлагыг зөвшөөрөхгүй. Хэрэв, та нарын эсрэг дайтвал бид та нарт туслана шүү дээ” хэмээн хэлцгээсэн хоёр нүүртэнгүүдийг хараагүй юу? Тэдний жинхэнэ худалчид болохыг Аллах өөрөө гэрчилнэ.
12. Тэд нутгаасаа хөөгдсөн ч хоёр нүүртэнгүүд тэдэнтэй хамт явахгүй. Дайтахад хүрсэн ч тэд туслахгүй. Туслахаар ирсэн ч шилээ харуулан зугтацгаах бөгөөд судрын эзэд туслалцаа авч чадахгүй.
13. Тэдний сэтгэлд Аллагаас илүү та нар айдас төрүүлмүй.(Аллахаас айхгүй та нараас айж байна) Учир нь тэд үл ухамсарлах ард болой.
14. Тэд бөх баг хотод, эсвэл хэрэмийн нөмөрт нуугдахгүй бол та нарын эсрэг бусадтай хүч хавсарч байлдаж чадахгүй. Тэд хоорондоо хүчтэй толхилдоно. Чи тэднийг эв нэгдэлтэй гэж бодно. Гэвч тэдний итгэл үнэмшил нь тогтвортой биш ээ. Учир нь тэд аливаа юмыг ухаарах чадваргүй хүмүүс.
15. Тэд (Иудэйчүүд) Өөрсдөөс нь яльгүй өмнөхийн өнгөрсөн үл сүсэглэгчдийн адил үйлдсэн үйлийнхээ хариуг амсацгаасан юм. Ертөнцийн төгсгөлд тэд аюултай гэсгээлтэй учрана.

16. Тэд хүмүүнийг “Буруу номтон болцгоо!” хэмээн урвуулчихаад хүмүүс үл сүсэглэсэн хойно “Чамаас ангид шүү! Үнэндээ бүхий л ертөнцийн эзэн Аллахаас айж байна” гэдэг чөтгөрийн багийг өмсөгчид билээ.
17. Тэдний (чөтгөр ба урвуулсан хүн хоёрын) эцсийн хувь тавилан тамд хамт орж, тэнд үүрд үлдэх явдал болой.
18. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахаас айгтун! Хүн бүр маргаашийн төлөө юу бэлдсэнээ эрэгцүүлэн хараг. Аллахаас айгтун! Аллах үйлдсэн бүхнээс чинь мэдээлэлтэй байгаа.
19. Та нар Аллахыг мартсан, Аллах (тиймээс) тэдэнд өөрсдийг нь мартуулсан хүмүүс шиг бүү бологтун. Тэд мунхаг хүмүүс.
20. Хойг ертөнцөд тамынхан диваажингийнхантай адил байж чадахгүй. Диваажингийнхан бол авралыг хүртэж, хүсэл мөрөөдлөө биелүүлэгсэд мөн.
21. Хэрэв Бид энэхүү Кураныг нэгэн уулан дээр буулгасан бол, уг уулс Аллахаас айхдаа бут үсэрснийг чи үзэх л байсан. Хүмүүнийг эрэгцүүлэн бодуулахын тулд Бид ийнхүү жишээ болгон өгүүлмүй.
22. Тэр бол – Аллах. Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Тэр ил, далд бүхнийг мэднэ. Тэр машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй.
23. Тэр бол – Аллах. Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Тэр бүхнийг эзэгнэгч, дутагдлаас ангид, буян хишиг хайрлагч, эрүүл саруул байллагч, хянан ажиглагч, ялагдашгүй, нэн сүрлэг, агуу ихийн эзэн. Аллах үл сүсэглэгчдийн түүнтэй эн зэрэгцүүлсэн юмнаас нь ангид.
24. Аллах - бүтээгч, хоосноос бий болгогч, бүхий л бодгалийг хэлбэршүүлэгч. Тэр - хамгийн сайхан алдарын эзэн. Тэнгэр, газарт буй бүхэн Түүнийг магтан алдаршуулмуй. Тэр – ялагдашгүй, мэргэн ухааны эзэн мөн.



## 60. СУРЕ МҮМТАХИНА

Мадина-д илгээгдсэн. 13 айлдвар



*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нар Миний хийгээд өөрсдийн дайсныг анд нөхөр бүү болгогтун. Тэд та нарт илгээгдсэн чин үнэнийг (Кураныг, Ислам шашныг) хүлээн зөвшөөрөхгүй байсан ч та нар тэдэнтэй элгэсэг харилцаж байна. Эзэнтэн Аллахад сүсэглэн итгэсний чинь төлөө та нар хийгээд гэгээн элчийг эх нутгаас нь хөөсөн билээ. Хэрэв та нар Миний төлөө залбиран тулалдаанд мордсон бол.(тэдэнтэй элгэсэг харилцаж болохгүй) Тэдэнд нууцаар энэрэн хайрлавал Би та нарын ил, далд



- бүх үйлдлийг чинь мэдэж байх болно. Хэн ийнхүү хийнэ, (тэдэнтэй үгсэн нийлж, гэгээн элчийн тухай мэдээ хүргэвэл) зөв шулуун замаас төөрөлдөх нь тэр ээ.
2. Хэрэв тэд та нарыг ялбал дайсагнан, хүч хэрэглэж, хэл амаар доромжлох болно. Ийнхүү та нарыг дахин үл сүсэгтэн болгохыг эрмэлзэнэ.
  3. Ертөнцийн төгсгөлийн өдөр ойр дотныхон хийгээд үр хүүхдүүд чинь та нарт ямар ч ашиг тус эс болно. Аллах та нарыг аяндаа холдуулна. Аллах үйлдэж буй бүхнийг харж байдаг юм.
  4. Ибрахим хийгээд түүнийг дагагсад ч та нарт үнэнхүү сайхан үлгэр дуурайлал болсон. Тухайн цагт тэд ардууддаа хандан: “Бид та нараас, мөн та нарын Аллахаг орхиж сүсэглэсэн бүхнээс чинь ангид. Бид та нарыг үл танимуй. Та нарыг цорын ганц Аллаhad итгэх хүртэл та бидний хоорондын дайсагнал, үзэн ядалт хэвээр үргэлжлэх болно” гэв. Харин Ибрахим эцэгтээ хандан: “Чиний төлөө Аллахаас өршөөл хүснэм. Гэсэн ч Аллахаас ирэх аливаа гэсгээлээс чамайг аварч чадахгүй” гэсэн үгийг үлгэр болгож болохгүй. (Ибрахим болон түүний талынхан): “Аяа, Эзэнтэн минь! Бид гагцхүү Чамд итгэж найдлаа, мөн чиний өмнө сөгдөнөм. Түшиж тулах эзэн минь Чи болой” хэмээн хэлцгээв.
  5. Аяа, Эзэнтэн минь! Үл сүсэглэгсэд биднийг эвдрэлцүүлэхэд боломж бүү өгөгтүн! Биднийг тэдний эрхэнд оруулан бүү соригтун. Аяа, Эзэнтэн минь! Биднийг өршөөн соёрхогтун. Үнэндээ ялалтын ч, мэргэн ухааны ч эзэн та билээ!
  6. Мухаммедийн ард олон оо! Тэд (Ибрахим болон түүнийг дагагсад) та нарын төлөө, Аллах хийгээд хойд ертөнцийг горьдогсодын төлөө үнэнхүү сайхан үлгэр дуурайлал болно. Хэн сүсэглэхээс нүүр буруулна, Аллах тэднээр дутахгүй. Аллах магтаалд зохимжтой.
  7. Аллах та нар болон өширхсөн хүмүүсийн хооронд нөхөрсөг байдал бий болгож юу магад. Аллах бүхий л юманд хүчирхэг бөгөөд машид өршөөгч, нэн нигүүлсэгч болой.
  8. Аллах та нартай шашны тухайд үл дайрсан, та нарыг эх нутгаас чинь үл хөөсөн хүмүүст сайн үйл үйлдэх, шударга хандахыг чинь хориглохгүй. Аллах шударгаар ханддаг хүмүүсийг хайрладаг.
  9. Аллах шашны тухайд та нартай эх нутгаас чинь хөөсөн ба хөөхөд тусалсан хүмүүстэй анд нөхөр болохыг хориглоно. Хэн тэдэнтэй анд нөхөр болно, тэр жинхэнэ зальхай этгээд мөн.
  10. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нар дээр сүсэгтэн эмэгтэйчүүд дүрвэн ирвэл сорих хэрэгтэй. Аллах тэдний сүсэг бишрэлийг сайн мэднэ. Хэрэв тэдний үнэн сүсэгтэн болохыг тогтоовол буруу номтнууд руу бүү буцаагтун. Буруу номтнууд тэдэнд ариун биш. Тэд ч буруу номтнуудад ариун биш. (нэг нэгэндээ зохихгүй) Үл сүсэглэгсэдийн тэдэнд өгсөн

сүй бэлэгийг (эд хөрөнгийг) буцааж өгөгтүн. Харин та нар сүй бэлэг тавьж тэдэнтэй гэрлэвэл буруугүй. Сүсэггүй эхнэрүүдээ бүү барьцгаа. Тэдэнд төлсөн сүй бэлэгээ буцааж шаард. Буруу номтнууд ч та нарт ирсэн эмэгтэйчүүдэд төлсөн зүйлээ буцааж аваг. Аллахын шийдвэр энэ болой. Аллах та нарын тухай шүүн тунгаана. Аллах эрдэм мэдлэгийн, мэргэн ухааны эзэн мөн.

11. Хэрэв зарим эхнэрүүд чинь үл сүсэглэгчдийн талд урвасан бол (тэдэнтэй байлдаж) ялаад дайны олз авбал, эхнэр нь үл сүсэглэгсэд руу оргож явсан хүмүүсийн өгсөн сүй бэлэгийн төлбөрийг нь өгөгтүн. Та нар сүсэглэн итгэсэн бол Аллагаас айгтун.
12. Аяа, Гэгээн элч ээ! Сүсэгтэн эмэгтэйчүүд чам дээр ирж Аллахтай алив юмыг эн зэрэгцүүлэхгүй, хулгай хийхгүй, садар самуун үйлдэхгүй, үр хүүхдээ хөнөөхгүй, бусдын хүүхдийг өөрийн нөхөрт хамруулахгүй, (бусадтай зина буюу нөхцөн хүүхэдтэй болж, түүнийг нөхрийнх хэмээн гүтгэхгүй) сайн үйлийн төлөө чамайг эсэргүүцэхгүй хэмээн тангараг өргөвөл тэдний тангарагийг хүлээн авагтун. Тэдний төлөө Аллагаас өршөөл гуйгтун. Аллах үнэхээр ивээн энэрэгч, нэн нигүүлсэгч билээ.
13. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нар Аллахыг хилэгнүүлсэн хүмүүстэй бүү нөхөрлөгтүн. Үл сүсэглэгсэд үхэгсэдээс горьдлого тасардагийн нэгэн адил, хойд ертөнцөөс ч горьдлого тасарсан байдаг юм.



Мадина-д илгээгдсэн. 14 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Тэнгэр дэх (мэлэкүүд) газарт буй (хүмүүс, ургамал, байгаль орчин) бүгд Аллахыг шагшин магтана. Тэр аугаа хүчирхэг, мэргэн ухааны эзэн.
2. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Өөрсдөө хийдэггүй зүйлээ юунд “хийнэ” хэмээн хэлнэ вэ?
3. Хийдэггүй зүйлээ хийдэг мэтээр хэлэх нь угаас Аллахын өмнө адгийн муухай нүгэл юм.
4. Аллах өөрийнхөө төлөө бат хэрэм мэт зогсон байлдагсадыг таалан соёрхоно.
5. Тухайн цагт Муса ард олондоо хандан: “Аяа, ард олон минь! Аллахын та нарт илгээсэн гэгээн элч болохыг минь мэдэх атал намайг юунд гомдоодог юм вэ?” гэж хэлсэн юм. Тэд зөв замаас төөрөлдсөн тул Аллах тэдний итгэл үнэмшлийг ч төөрөгдүүлсэн билээ. Аллах угаас нүгэлтэн хүмүүсийг зөв шулуун зам руу эс хөтөлнө.

6. Нэгэнтээ Мариямын хүү Иса (Есүс) ч: “Аяа, Израйлын үр сад аа! Би бол надаас өмнөх Тауратыг (Тораг) бататгагч миний дараа ирэх Ахмет нэртэй гэгээн элчээр баярлуулагч, Аллахын та нарт илгээсэн гэгээн элч билээ” хэмээн хэлсэн юм. (Исагийн хэлсэн гэгээн элч) тэдэнд яруу тод нотолгоонууд авч ирэхүйд тэд: “Энэ бол илэрхий илбэ мөн” гэлцэв.
7. Ислам руу уриалан дуудагдахуйд Аллахыг худал гүтгэсэн (Аллахыг үгүйсгэсэн эсвэл түүнтэй бусдыг эн зэрэгцүүлсэн) хүнээс харгис зальхай амьтан байна гэж үү? Аллах тийм зальхай амьтадыг зөв шулуун замд оруулахгүй.
8. Тэд Аллахын гэгээн гэрэлийг үлээж унтрахаар (Исламын шашин ба шариатыг таслан зогсоохоор) оролдоно. Үл сүсэглэгсэд үзэн ядаж байсан ч Аллах гэрэл гэгээгээ дөрвөн зүг, найман зовхист цацруулна. (бүрэн гүйцэнэ)
9. Хиймэл бурхан шүтэгсэд үзэн ядаж байсан ч Аллах чин үнэн шашныг бүхий л шашинаас эрхэм болгохын тулд гэгээн элчээ зөв шулуун замаар, чин үнэн шашинтайгаа илгээсэн юм.
10. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нарыг аюулт гэгсгээлээс аврах нэгэн харилцан солилцоог харуулах уу?
11. Аллах болон Түүний гэгээн элчид сүсэглэцгээн, Аллахын төлөө мал хөрөнгө, амь биеэрээ тулалдагтун. Мэдэх аваас, та нарын хувьд энэ нь өлзийтэй.
12. Ийнхүү тохиолдолд Аллах нүглийг чинь өршөөж, жажуугаар нь булаг урсадаг диваажинд оруулна. Гадын хэмээх диваажингийн гайхалтай сайн байранд байлгана. Энэ нь аугаа амжилт мөн!
13. Та нарын хувьд тааламжтай хоёр дахь сайхан зүйл гэвэл: “Аллахаас ирэх тусламж болон ойртож айсуу ялалт мөн. (Меккег чөлөөлөх явдал) Аяа, Мухаммед! Энэхүү мэдээгээр сүсэгтнүүдийг баярлуулагтун!
14. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахын төлөө туслагчид бологтун. Мариямын хүү Иса Хауари (гэгээн элч Исагийн туслахууд) нарт хандан: “Хэн Аллахын төлөө надтай хамт туслагч болох вэ?” гэхэд Хауаричууд: “Аллахад бид туслагч болно. Бидний адил туслагч болцгоорой!” гэв. Израйлын үр садаас нэг овог сүсэглэн итгэж, нэг овог нь үл сүсэглэж урван одлоо. Бид ч сүсэглэн итгэгсдэд дайсантайгаа тэмцэх үед дэмжлэг үзүүлсэн. Ийнхүү тэд ялалтанд хүрсэн билээ.

## 62. СУРЕ ЖУМА

Мадина-д илгээгдсэн. 11 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Алладын алдраар эхэлье*

1. Тэнгэр хийгээд газарт буй бүхэн бүхий л ертөнцийг эзэгнэгч, алив дутагдлаас ангид, ялгуусан, мэргэн ухааны эзэн Алладыг шагшин магтдаг.
2. Аллах ухвар мөчид хүмүүст (өөрсдийн дотороос нь) Алладын айлдваруудыг уншиж ойлгуулах, нүглийг нь ариусгагч, Куран судар болон эрдэм мэдлэгийг зааж сургагч нэгэн гэгээн элчийг илгээсэн. Энэ хүртэл тэд илэрхий төөрөгдөл дунд байсан юм.
3. Аллах тэдэнтэй нийлж амжаагүй бусад хүмүүст ч энэхүү гэгээн элчийг илгээсэн. Аллах ялагдашгүй, мэргэн ухааны эзэн.
4. Энэ нь Алладын хайр энэрэл мөн. Түүнийг хүссэн хүндээ өгнө. Аллах өгөөмөр энэрэлийн эзэн.
5. Таурат (Тора) судрыг унших заяа хайрлагдсан ч түүнийг эзэмшиж чадаагүйчүүд бол ном ачаалсан илжигтэй адил билээ. Алладын айлдваруудыг үгүйсгэсэн ардуудын жишээ нь юутай муухай юм гээч! Аллах харгис зальхай ардыг зөв шулуун зам руу эс хөтөлнө.
6. “Аяа, Иудэйчүүд ээ! Бусдыг бодвол өөрсдийгөө Алладын анд хэмээн бодож байгаа бол, энэхүү бодол чинь үнэн юм бол (хойд ертөнцийн жаргалаа хурдан хүрэхийн тулд) өөртөө үхэлийг хүсэгтүн!” хэмээн хэл.
7. Гэвч тэд өмнө нь үйлдсэн гэмт хэрэгтэй тул хэзээ ч түрүүлж үхэхийг эс хүсэцгээнэ. Аллах харгис зальхайчуудыг мэдэж байдаг.
8. Аяа, Мухаммед! Тэдэнд: “Та нарын зайлсхийсэн үхэл хэзээ нэгэн цагт тохионо. Тэгээд ил, далд бүхнийг мэдэгч Алладын өмнө очих болно. Тэр та нарын үйлдсэн хэргийг хэлж өгнө” хэмээн хэлэгтүн.
9. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Жума (Баасан) гарагт нийтийн уншлага мөргөлд дуудахад арилжаа наймаагаа түр орхин, Алладыг санан дурсахаар яравчлагтун. Мэддэгсэн бол та нарт энэ нь өлзийтэй.
10. Жума уншлага мөргөл дууссаны дараа тал-тал тийшээ тарцгааж, амьжиргаагаа бодон Алладын хишгийг хайцгаагтун. Зорьсондоо хүрээ гэвэл Алладыг олонтой дурсацгаагтун.
11. Аяа, Мухаммед! Тэд наймаа болон зугаа цэнгэлийг харангуут чамайг ганцаараа орхиод, дуртай зүг рүүгээ явцгаана, тэдэнд: “Алладын төлөөх залбирал нь, зугаа цэнгэлээс илүү өлзийтэй. Аллах хувь хишиг хайрлагсадын хамгийн эрхэм нь мөн” гэж хэлэгтүн.

## 63. СУРЕ МУНАФИКУН

Мадина-д илгээгдсэн. 11 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Мунафикууд буюу хоёр нүүртэнгүүд чиний өмнө ирэхэд: “Чи Аллахын гэгээн элч мөн. Бид үүнийг гэрчилнэ” гэсэн. Аллах чамайг гэгээн элч гэдгийг мэднэ шүү дээ. Хоёр нүүртэнгүүдийн үнэхээр худалч гэдгийг Аллах бас гэрчилнэ.
2. Тэд хуурамч тангарагаараа бамбай болгон бусдыг Аллахын замаас төөрөгдүүлдэг юм. Тэдний араншин юутай жигжүүртэй гээч!
3. Үүний шалтгаан гэвэл тэд аман дээрээ сүсэглэвч, хэрэг дээр итгэл үнэмшил болгосонгүй. Ийнхүү тэдний зүрх битүүмжлэгдсэн, сүсэглэлийг ойлгогдоггүй юм.
4. Тэдний дүр төрхийг харвал чи гайхшрах болно. Яривал амыг чинь ангайлгана. Гэвч тэд үндэс нь ялзарсан модны адил. Түгшин айхдаа дуу чимээ бүхнийг өөр лүүгээ хандсан гэж бодоцгоодог. Тэд жинхэнэ дайсан мөн. Тэднээс сэрэмжлэгтүн. Хаашаа төөрөлдөж явна вэ? Аллах тэднийг гэсгээг!
5. Өмнөхүүд нь тэдэнд: “Ирцгээгтүн, гэгээн элч та нарын төлөө өршөөл гуйна” гэхэд тэд толгойгоо сэгсрэн, их зан гаргаж, буруу харахыг чи үзнэ.
6. Аллахаас тэдний төлөө өршөөл гуйсан ч, эс гуйсан ч ялгаагүй. Аллах тэднийг өршөөхгүй. Аллах бэртэгчин хүмүүсийг зөв шулуун зам руу эс хөтөлнө.
7. Тэд: “Тэгээн элчийн дэргэдэх хүмүүст сайн сайхныг бүү зориулаг. Тэд бутран сарниж яваг” гэлцэнэ. Гэвч тэнгэр, газрын баялаг Аллахынх гэдгийг хоёр нүүртэнгүүд ойлгогдоггүй юм.
8. Мөн тэд: “Хэрэв бид Мадина рүү эргэж очвол хүчтэнгүүд (Абдулла ибн Убай тэргүүлсэн хоёр нүүртнүүд) сул доройчуудыг (гэгээн элч болон сүсэгтнүүдийг) гарцаагүй хөөн гаргана” хэмээн бурна. Жинхэнэ ид шидтэй хүч Аллахынх, Түүний гэгээн элчийнх, үнэн сүсэглэгсэдийнх болохыг хоёр нүүртэнгүүд мэддэггүй юм.
9. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Та нарын мал хөрөнгө, үр хүүхэд чинь Аллахыг (байнга) санан дурсахад (залбирахад) бүү саад болог. Хэнд саад болно, тэр гарцаагүй хохирол амсах болно.
10. Хэрэв үхэл тохиолдоход хүрвэл: “Аяа, Эзэнтэн минь! Бидний үхлийн хугацааг бага ч гэсэн хойшлуулбал өглөг өгч, сайн үйлэтэн болох сон!” гэж харамсахаас өмнө хувь хишгээсээ Аллахын төлөө өглөг өгөгтүн.

11. Гэвч Аллах хугацаа нь болсон хэний ч үхлийг хойшлуулахгүй. Аллах та нарын үйлдсэн бүхнээс мэдээлэлтэй.

## 64. СУРЕ ТАГАБУН

Мадина-д илгээгдсэн. 18 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Тэнгэр, газарт буй бүхэн Аллахыг шагшин магтана. Алив бүхний эзэгнэл, хамаг магтаал Түүнийх. Бүхий л зүйлийг тэр эрхшээх хүч чадалтай.
2. Аллах та нарыг бүтээсэн. Та нарын зарим нь сүсэгтэн, зарим нь үл сүсэглэгсэд болой. Аллах үйлдсэн бүхнийг чинь харж байдаг.
3. Аллах тэнгэр, газрыг зүй тогтолоор нь бүтээсэн. Та нарыг дүр төрхтэй болгож, түүнийг чинь төгс гоо сайхан болгосон. Эцэст нь түүний өмнө очино.
4. Тэр тэнгэр, газарт болж буй бүхнийг мэдэж байдаг. Мөн ил, далд бүхнийг чинь мэднэ. Сэтгэл дотороо нууж хадгалсаныг ч мэднэ.
5. Та нарт өдий хүртэл үл сүсэглэгсэдийн зовлон үзсэн тухай мэдээ ирээгүй гэж үү? Хойд хорвоод тэдний хувьд аюулт гэгсгээл буй.
6. Үүний шалтгаан гэвэл, өөрсөдөд нь гэгээн элч нар яруу тод нотолгоонуудтай ирэхэд тэд: “Бидний адил жирийн хүн биднийг зөв шулуун зам руу хөтөлж чадах юм гэж үү дээ?” хэмээн гэгээн элчийг үгүйсгэж, сүсэглэхээс нүүр буруулцгаасан юм. Аллах тэднээр дугахгүй гэдгээ харуулсан билээ. Аллах уй гашуугүй, магтахад зохимой.
7. Үл сүсэглэгсэд дахин амилахгүй гэж боддог. (Аяа, Мухаммед) Тэдэнд: “Үгүй дээ, Эзэнтнийхээ алдраар тангараглая, үхсэний дараа гарцаагүй дахин амилах болно. Дараа нь үйлдсэн хэргийг чинь ухааруулна. Энэ нь Аллахад хялбархан” хэмээгтүн.
8. Тиймээс Аллахад, Түүний элчид, мөн Бидний буулгасан гэрэл гэгээнд (Куранд) итгэж сүсэглэгтүн. Аллах та нарын хийсэн бүхнээс мэдээлэлтэй байгаа.
9. Ертөнцийн төгсгөлд хуран чуулах тэр өдөр та нарыг уулзуулна. Энэ нь та нарын хууртагдах өдөр болой. Аллахад хэн сүсэглэн итгэж, сайн үйлс үйлдэнэ, Аллах түүний нүгэлийг үгүйсгэж, хаяагаар нь булаг урсах диваажинд оруулна. Тэд тэндээ үүр мөнх оршицгооно. Энэ нь аугаа аз жаргал мөн.
10. Харин үл сүсэглэж, Бидний айлдваруудыг худал хэмээгсэд тамынхан бөгөөд тэндээ үүрд үлдэцгээнэ. Тэр нь юутай муухай газар гээч!

11. Аллахын зарлиггүйгээр ямар ч гай барцаг тохиолдохгүй. Хэн Аллахад итгэж сүсэглэнэ, Аллах түүний итгэл үнэмшлийг батагтана. Аллах алив бүхнийг бүрэн мэдэгч мөн.
12. Аллах болон түүний гэгээн элчийг дагагтун. Хэрэв гэгээн элчийн уриалгаас нүүр буруулвал хор хөнөөл нь өөрсдөд чинь оногдоно. Гэгээн элчийн маань үүрэг нь гагцхүү яруу тод уриалгыг хүргэх л явдал мөн.
13. Аллах цорын ганц. Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Сүсэгтнүүд Аллахад найдацгаагтун.
14. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Эхнэрүүдээс болон үр хүүхдүүдээс чинь дайсагнах явдал гардаг. Тэднийг анхааргтун. Хэрэв тэдэнтэй ойлголцож уучилвал Аллах та нарыг ч уучилна. Аллах үнэхээр машид өршөөгч, нэн нигүүлсэнгүй билээ.
15. Мал хөрөнгө хийгээд үр хүүхэд чинь та нарын хувьд нэгэн сорилт бөлгөө. Аугаа буян хишиг Аллахын эрх мэдэлд буй.
16. Болж л өгвөл Аллагаас айгтун. Өгөгдсөн зөвөлгөөг сонсогтун, зарлигийг нь дагагтун. Аллахын төлөө мал хөрөнгөө зарцуулагтун. Энэ нь та нарт өлзийтэй. Хэн нэгэн хувийн харамч сэтгэлээс сэргийлбэл, тэд зорьсондоо хүрнэ.
17. Хэрэв Аллахын төлөө (түүний таалал хүртэхээр) өглөг өгвөл, Аллах түүний хариуг хэд дахин ихээр өгнө. Мөн та нарыг ивээнэ. Аллах бага өглөгийг чинь ихээр хариулагч, нэн уужим. (цээрлүүлэхийн төлөө яардаггүй юм).
18. Тэр ил, далдыг мэдэгч, аугаа хийгээд мэргэн ухааны эзэн мөн.

## 65. СУРЕ ТАЛАК

Мадина-д илгээгдсэн. 12 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Аяа, Гэгээн элч минь ээ! (Зон олондоо дараах зүйлийг ойлгуулаарай): Эхнэрээсээ салахад хүрвэл гиддаг буюу цэвэрших хугацаанд нь салагтун. (Цус холилдохгүйн тулд) Гиддагын хугацааг тооцоорой. Аллагаас айгтун. Цэвэрших хүртэл гэрээс бүү хөөгтүн. Өөрсдөө ч гэрээсээ бүү гарцгаагтун. Хэрэв илэрхий садар самуун үйлдвэл асуудал өөр билээ. Энэ нь Аллагаас тогтоосон хэм хэмжээ мөн. Хэн нэгэн Аллахын тогтоосон хэм хэмжээг зөрчих аваас өөрийгөө нүгэлтэн болгоно. Аллах үүнээс хойш чиний үл мэдэх нэгэн байдлыг ил гаргах биз ээ.
2. Товлосон түүний цэвэршлийн хугацаа дууссаны дараа сайн сайхнаар

эргэж нийлцгээ, эсвэл муудалцалгүй салцгаагтун. Нийлсэн ч, салсан ч дундаасаа шударга хоёр хүнийг гэрчээр байлцуулаарай. Аллахын тааллын төлөө үнэнчээр гэрчлэгтүн. Аллах хийгээд хойд ертөнцөд итгэгсэдийн хувьд ийнхүү сургамж өгөгдөмүй. Хэн Аллахаас айна, түүний хувьд гарц буй.

3. Аллах түүнд санаанд оромгүй хувь хишиг хайрлана. Хэн Аллахыг түшинэ, Аллах түүнд хангалттай. Аллах зарлигаа эргэлзээгүй гүйцэтгэнэ. Аллах үнэндээ алив бүхний төлөө нэгэн хэмжүүр (тоог) тогтоосон болой.
4. Насан хэвийж сарын тэмдэг нь ирэхээ больсон эхнэрүүдийнхээ цэвэршилтэд эргэлзвэл, тэдний цэвэрших хугацаа гурван сар үргэлжилнэ. Насанд хүрээгүйгээс сарын тэмдэг нь ирээгүй эхнэрүүдийн чинь хувьд мөн адил болой. Харин жирэмсэн эхнэрүүдийн чинь хувьд төрөх хүртэл болой. Хэн Аллахаас айна, Аллах түүний үйлийг дэмжинэ.
5. Энэ нь Аллахын та нарт буулгасан зарлиг мөн. Хэн Аллахаас айна, Аллах түүний нүглийг өршөөн, зохих шагналыг хүртээнэ.
6. (Иддет буюу цэвэршилтийн хугацаанд) салсан эхнэрүүдэд боломжийн хэрээр гэр орондоо байлгагтун. Тэднийг албадан гаргаж, (гэр орон, хоол ундаар) амьжиргаагаар нь хавчиж болохгүй. Хэрэв тэд жирэмсэн бол төрөх хүртэл нь тэтгэн халамжлагтун. Та нарт хүүхэд нь хамааралтай байгаад хөхүүлэхээр бол сүүн төлөөс өгөгтүн. Хоорондоо харилцан зөвшилцөж шийдвэр гаргагтун. Хэрэв үл ойлголцвол тэр хүүхдийг өөр эмэгтэй хөхүүлэн тэжээг.
7. Баян хүн хөрөнгө чинээнийхээ хэрээр эхнэр, хүүхдээ тэтгэг. Ядуу тарчиг амьдралтай хүн Аллахын өөрт нь хайрласан хишгийнхээ хэрээр болог. Аллах хүмүүнд өөрийн хайрласнаас илүү хэрэгцээг үүсгэхгүй. Аллах нэгэн бэрхшээлийн дараа нэгэн энэрэл ивээлээр шагнана. (зовлон, жаргал ээлжлэх жамтай)
8. Олон хотын оршин суугчид Эзэнтэн хийгээд Түүний гэгээн элч нарын тушаалыг эсэргүүцсэн юм. Бид тэдэнтэй хатуу тооцоо хийж, хатуу цээрлүүлсэн билээ.
9. Тэд хийсэн хэргийнхээ гэгсгээлийг амсацгаасан, эцэст нь хор хөнөөлтэй учрав. Үйл хэргийнхээ эцэс нь хор хөнөөлөөр дуусав.
10. Аллах хойт ертөнцөд ч тэдэнд зовлонг гэгсгээл зэхсэн буй. Аяа, итгэн сүсэглэсэн ухааны эзэд ээ! Аллахаас айгтун. Аллах та нарт нэгэн чин үнэнийг (Кураныг) илгээсэн юм.
11. Сүсэглэж ,сайн үйл үйлдэгсэдийг харанхуйгаас гэрэл гэгээ рүү гаргахын тулд Аллах та нарт өөрийнхөө яруу тод айлдваруудыг уншиж ойлгуулах нэгэн гэгээн элчийг илгээлээ. Хэн Аллахад итгэн сүсэглэж, сайн үйл үйлдэнэ, Аллах түүнийг хажуугаар нь булаг урсах диваажинд



оруулан, тэндээ үүрд үлдэнэ. Аллах түүнд сайн сайхан хувь хишиг хүртээнэ.

12. Аллах тэнгэр, газрын долоон давхарааг бүтээсэн. Тэдний дунд Аллахын зарлиг гүйцэлдэж байх болно. Энэ нь Аллахын бүхий л юманд хүч чадал хүрдэгийг, бүхий л ахуй байдлыг өөрийнхөө ивээл эрхшээлд багтааж байдгийг та нарт ухааруулахын тулд болой.

## 66.СУРЕ ТАХРИМ

Мадина-д илгээгдсэн. 12 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Аяа, Гэгээн элч ээ! Чи Аллахын чамд халал (ариун) болгосон зүйлийг, эхнэрүүдээ баярлуулахын тулд яахлаар харам (бузар) болгоно вэ? Аллах машид өршөөгч, нэн нигүүлсэгч.
2. Аллах та нарт (зохих төлөөс төлж) тангарагаа нотлохыг болгоосон шүү дээ. Та нарын эзэн бол Аллах. Тэр бүхнийг мэдэгч, мэргэн ухааны эзэн.
3. Нэгэнтээ гэгээн элч эхнэрүүдийнхээ нэгэнд (Хафса-д) нэгэн үгийг нууцлан хэлсэн билээ. Тэр үүнийг өөр нэгэн эхнэр (Айша-д) дамжуулчихлаа. Аллах энэ тухай гэгээн элчид мэдэгдэхэд, Гэгээн элч Хафса эхнэрдээ илчлэгдсэн үгсийн заримыг хэлж анхааруулан нөгөө хэсгийг нь хэлэлгүй орхив. Ийнхүү эхнэр Хафса нь гэгээн элчээс: “Үүнийг чамд хэн хэлсэн бэ?” гэж асуув. Гэгээн элч: “Үүнийг надад алив бүхнийг мэдэгч, алив бүхнээс мэдээлэлтэй Аллах хэлсэн” хэмээн хариулав.
4. (Айша, Хафса) та хоёр Аллахт наминчилвал зүгээрсэн дээ. Учир нь та хоёрын зүрх сэтгэл (Аллахын зөвшөөрсөн зүйл буюу гэгээн элчийн Мариямтай гэрлэх явдалаас) хазайсан байна. Хэрэв та хоёр гэгээн элчийн эсрэг нэгдвэл Аллах гэгээн элчийг гарцаагүй дэмжинэ. Мөн Жабрейл болон чин сүсэгтнүүд ч, түүний дараа бусад мэлэкүүд ч дэмжих болно”
5. Хэрэв гэгээн элч та хоёроос салах аваас Эзэнтэн нь оронд чинь та нараас сэтгэлтэй, мусулман, даруухан, сүсэглэгч, сэтгэл-зүрхээрээ залбирагч, мацаг баригч, нөхөрт гараагүй эмэгтэй хийгээд ариун охидыг эхнэр болгон өгч магадгүй байх шүү.
6. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Өөрсдийгөө болон гэр бүлээ, хүмүүс болоод чулууг түлдэг халуун тамаас хамгаалагун. Мөн тэнд Аллахын зарлигийг үл зөрчигч, тушаасан бүхнийг гүйцэтгэгч, хатуу хэрцгий гэгээлийн мэлэкүүд бий”

## 67. СУРЕ МҮЛК

7. Аяа, үл сүсэглэгсэд ээ! Өнөөдөр (ертөнцийн төгсгөлийн өдөр) та нар хүлцэл өчих хэрэггүй. Үйлдсэн хэргийнхээ хэрээр гэсгээгдэх болно”
8. Аяа, сүсэгтнүүд минь ээ! Чин сэтгэлээр Аллахад наминчлан өршөөл гүйгтун! Эзэнтэн нүглийг чинь өршөөж, хажуугаар нь булаг урсдаг диваажинд оруулж юу магад. Аллах тэр өдөр гэгээн элч хийгээд түүнтэй хамт сүсэглэгсэдийг зовоохгүй. Тэдний урдаас болон баруун талаас нь гийлүүлэх гэрэл байх бөгөөд тэд: “Аяа, Эзэнтэн минь ээ! Гэрэл гэгээг маань улам бадраагтун. Биднийг өршөөн нигүүлс! Чиний хүч чадал алив бүхэнд хүрнэ” гэнэ.
9. Аяа, гэгээн элч ээ! Үл сүсэглэгсэд хийгээд хоёр нүүртэнгүүдтэй дайтагтун, тэдний эсрэг хатуу чанга байгтун. Тэдний очих газар нь там. Тэр юутай муухай газар гээч!
10. Аллах үл сүсэглэгсэдэд (Мусулманчуудтай ах дүүс байсан ч тус болохгүй тухайд) Нух, Лут хоёрын эхнэрийг жишээ болгосон. Тэр хоёр нь Бидний хоёр сайн хүмүүний хань байсан боловч хоёулаа үл сүсэглэн нөхрөөсөө урван тэрсэлсэн юм. Нөхрүүд нь (Нут, Лут хоёр) тэднийг Аллахын гэсгээлээс аварч чадаагүй билээ. Мөн тэр хоёр эмэгтэйд: “Тамд орогсодтой хамт орцгоогтун!” хэмээгдсэн юм.
11. Харин Аллах итгэн сүсэглэгсэдэд Фиргауны эхнэрийг жишээ болгосон юм. Тухайн үед тэр: “Аяа, Эзэнтэн минь! Надад Өөрийнхөө дэргэд диваажинд нэгэн байр барьж өгөөч. Намайг Фиргаун ба түүний муу үйлээс, мөн намайг харгис зальхай ардуудаас аварч хайрла” хэмээн залбирсан юм.
12. Ариун нэр төрөө хамгаалж чадсан Имраны охин Мариамыг ч Аллах жишээ болгосон юм. Бид сүр хүчээр үлээхэд тэр Исад бие давхар болов. Эзэнтнийхээ айлдвар хийгээд судруудыг бататгасан юм. Ийнхүү тэр чин сэтгэлээрээ Аллахад итгэн биширсэн билээ.



Мекке-д илгээгдсэн. 30 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Бүхнийг эрхшээн захирсан аугаа Аллах буянтай, арвижих заяатай. Түүний хүч чадал нь алив бүхэнд хүрэлцээтэй.
2. Тэр үхэл хийгээд амьдралыг буй болгосон. Энэ нь та нарын хэн нь өлзийтэй үйлс хийдгийг сорихын төлөө байсан юм. Аллах ялагдашгүй, нэн өршөөгч.
3. Тэр долоон давхар тэнгэрийг давхарлан бүтээсэн. Нигүүлсэгч Аллахын

- бүтээсэн бүхнээс өө сэв олохгүй. Тэнгэр огторгуйг дахин дахин эргэж хар! Ямар нэгэн өө сэв харагдана гэж үү?
4. Дараа нь дахин тогтож хар л даа. Нууцыг нь тайлж чадаагүй нүд чинь аяндаа чилэх болно.
  5. Бид хамгийн ойрхон тэнгэрийн давхаргыг гэрэлт ододоор чимэглэсэн бөгөөд эдгээрийг тэнгэрийн элчүүдийн мэдээг хулгайлах чөтгөр шулмасыг буудахад зориулав. Чөтгөр шулмаст төгсгөлийн өдөр тамын гэсгээллийг зэхсэн.
  6. Эзэнтнээ үгүйсгэгдэд тамын гэсгээл бэлэн. Тэр юутай муухай газар гээч!
  7. Тэд дотор нь шидэгдэхүйд, бургилан буцлах тамын гүнээс орилж чарласан дуу чимээ сонсогдоно.
  8. Там дүрэлзэн шатна. Түүнд хэсэг бүлэг хаягдах бүрт тэнгэрийн элч харуул мэлэкүүд: “Та нарт сэрэмжлүүлэгч ирээгүй юм уу?” хэмээн асууна.
  9. Тэд: “Үнэндээ бидэнд сэрэмжлүүлэгч элч ирсэн юмаа. Гэвч бид түүнийг худал хэмээж үгүйсгэж: “Аллах та нарт юу ч илгээсэнгүй. Та нар өөрсдөө ихээр төөрөлдсөн улс байна” гэсэн юмсан;
  10. Хэрэв бид түүнийг сонссон, зөв ухаарсан бол тамынхны дунд юу гэж байхсан билээ!” хэмээн харамсана.
  11. Ийнхүү тэд нүглээ наминчлана. Гэвч тамынхан Аллахын энэрэл хайраас ангид байгтун!
  12. Эзэнтнээ хараагүй агал Түүнээс айхсадад өршөөл, буяны дээд буй.
  13. Та нар ил, далд ярьсан ч ялгаагүй Аллах зүрх сэтгэлд буй бүхнийг мэдэж байдаг.
  14. Бүтээгч эзэн сэтгэлийн гүнд нуусныг мэдэхгүй гэж үү дээ? Тэр өчүүхэн нууц болон бүхнээс мэдээлэлтэй билээ.
  15. Аллах та нарт газрыг хэрхэн ашигласан ч хүлээцтэй болгосон юм. Тиймээс хөндлөн гулд явж, хувь хишгээ олж хүртэгтүн. Хожим Аллахын өмнө очино шүү дээ.
  16. (Аяа, үл сүсэглэгчид ээ!) Газар дэлхий донслоход (үйлдсэн нүглийнхээ төлөө) Аллахын тэнгэр дэх сүр хүч газрын гаваар оруулах байх хэмээн (айж) сандрахгүй юм уу?
  17. Эсвэл Аллахын тэнгэр дэх сүр хүч та нарын дээрээс салхитай чулуун бороо оруулахаас айдаггүй юм гэж үү дээ? Та нар гэсгээлтэй учрах мөчид л Миний сэрэмжүүлэг ямар байдгийг мэдэх болно!
  18. Үнэндээ тэдний өмнөхүүд ч гэгээн элч нараа худал хэмээн үгүйсгэсэн юм. Үгүйсгэгчдэд зориулсан Миний гэсгээл ямар байна даа?
  19. Тэд жигүүрээ дэлгэн дэвж, дээгүүр нь ниссэн шувуудыг хараагүй гэж

- үү дээ? Тэднийг (газарт унагаалгүй, агаарт) тогтоогч нь гагцхүү энэрэн нигүүлсэгч Аллах ажгуу. Тэр үнэхээр бүхнийг бүрэн харагч бөлгөө.
20. Аллахаас ондоо та нарт туслах дайчид байгаа юм уу? Үл сүсэглэгсэд ердөө л төөрөлдөгсөд мөн.
  21. Хэрэв Аллах хувь хишгээ зогсоовол та нарт өөр хэн хувь хишиг хүртээх вэ? Тэд үнэндээ улам төөрөлдөж, зөрүүдэлсээр байх юм.
  22. Газар шагайж явдаг хүн зөв зам олох уу, эсвэл харц дээшээ, бие цэх шулуун хүн зөв шулуун замыг олох уу? Бодоод үз л дээ.
  23. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Та нарыг бүтээгч нь, та нарт сонсох мэдрэмж, харах нүд, ярих хэл заяасан нь тэрхүү Аллах. Тийм атал талархахад хойрго байх чинь” хэмээн хэлэгтүн.
  24. “Газар саягүй та нарын үр удмыг өсгөн үржүүлсэн Тэр Аллах мөн. Эцэст нь түүний өмнө цугларч болно” хэмээгтүн.
  25. Тэгээд тэд: “Хэрэв та нарын хэлсэн үг үнэн юм бол уг сүрдүүлэг чинь хэзээ биелэлээ олох вэ?” гэж асууна.
  26. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Ертөнцийн төгсгөлийн өдөр хэзээ тохиохын тухай мэдлэг гагцхүү Аллахын нигур дор болой. Би зөвхөн яруу тод сэрэмжлүүлэгч билээ” гэж хэл.
  27. Гэгсгээл ойртсоныг үзэхдээ үл сүсэглэгсэд баргар царайлж эхлэнэ. Тэдэнд: “Та нарын хүссэн (гэгсгээл) зүйл чинь ирлээ” хэмээгдэх болно.
  28. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Хэрэв Аллах намайг болоод надтай хамт байгсадыг (мусулманчуудыг) үгүй хийвэл, эсвэл (бидний насыг уртасгавал) бидэнд хайр энэрэл үзүүлбэл (та нарт юугаар ашигтай вэ?) Үл сүсэглэгсэдийг аюулт гэгсгээлээс нь хэн аврах юм вэ?” гэж хэлэгтүн.
  29. (Аяа, Элч минь!): “Та нарыг уриалагч Тэр бол машид нигүүлсэнгүй Аллах мөн. Бид Түүнд итгэсэн, мөн түүнчлэн найдацгаасан. Хэн нь илэрхий төөрөгдөж буйг та нар мөдхөн мэдэх болно!” гэж хэл.
  30. Мөн тэдэнд: “Уудаг ус чинь татрах аваас хэн та нарт урсгал усыг авч ирж чадах вэ?” хэмээн хэлэгтүн.

## 68. СУРЕ КАЛАМ

Мекке-д илгээгдсэн. 52 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Нун, Каламаар (Үзэгээр), түүгээр бичсэн бүхнээр тангараглая.
2. Аяа, Мухаммед! Чи Эзэнтнийхээ хайр энэрэлийн ачаар солиороогүй.

3. (Бүхий л бэрхшээлд тэвчсэний төлөө) чамд хэмжээлшгүй их шагнал буй.
4. Чи үнэндээ аугаа ёс суртахууны эзэн мөн.
5. Ойрдоо чи ч, тэд ч харна.
6. Чухам та нарын хэн нь солиорсныг шүү ...
7. Эргэлзэх хэрэггүй Эзэнтэн чинь өөрийн замаас хэн төөрөлдсөнийг, хэн зөв шулуун зам дээр байгааг сайн мэднэ.
8. Худалчдын үгэнд бүү хөтлөгд.
9. Тэд чиний аядуу зөөлөн байдлыг чинь хүснэ, тэгээд тэд ч зөөлөн харилцаг!
10. (Аяа, Элч минь!) Дараах хүмүүст бүү итгэ: Тангараг тавих дуртай атал өөдгүй, хойрго;
11. Ховч гүжирдэгч;
12. Сайн үйлд саад хийгч, харамч, хэмээс хэтэрсэн, нүгэлтэн;
13. Бүдүүлэг (угсаа муутай) (Уалид ибн Мугира мэтэд) тус тус;
14. Тэр эд хөрөнгө, хөвгүүдтэй тул;
15. Бидний айлдварууд түүнд уншигдахуйд: “Эрт дээр үеийн улиг болсон үлгэр” хэмээнэ.
16. Мөдхөн Бид түүний хамрыг тамгалах болно.
17. Бид тэднийг (Меккегийнхнийг) нийтэд танил цэцэрлэгийн эздийг сорьсоны адил сорилоо. Тэд (тухайн үед ядуусаас нуун) ургацаа үүр сүүрээр хураахаар тохиролцон андгайлсан байлаа.
18. Гэвч “Аллах таалах юм бол” хэмээсэнгүй.
19. Тэднийг дуг нойрондоо дугжирч байхад (бүтээгч Эзэнтнээс чинь) нэгэн гамшиг ирж нэрэвсэн билээ.
20. Цэцэрлэг нь ганцхан шөнө тас хар, хөө тортог, үнс болон үлдэв.
21. Тэд үүр гэгээрэнгүүт бие биенээ дуудацгаав.
22. “Ургацаа хураах хүмүүс цэцэрлэг рүү явцгаая” гэлцэв.
23. Тэд явах зуураа амихандаа ярилцана.
24. “Өнөөдөр нэг ч ядуу цэцэрлэгт бүү орог” хэмээн шивнэлдэв.
25. Тэд ядуусаас харамлан өөрсдийн чадал хүрнэ хэмээн эртлэн хөдөлсөн билээ.
26. Тэд үнсэн товрог болсон цэцэрлэгээ харангуут: “Бид ёстой алд дэлэм алджээ” гэлцэв.
27. “Бүүр гар хоосон үлдсэн байна шүү дээ” хэмээн халаглацгаав.
28. Тэдний дотроос шударга нэг нь: “Эзэнтнээ магтан залбирцгаах ёстой” хэмээн би та нарт хэлээгүйсэн билүү? гэв.

29. Сая л тэд ухаарсан мэт: “Эзэнтэн минь! Бид чамайг магтан алдаршуулмуй. Үнэндээ тахир дутуу хүмүүст хөлс өгөхгүй гэж зальхай хэрэг үйлджээ!” гэж гэмшицгээв.
30. Тэгээд бие биенээ буруутгаж эхэлвэй.
31. “Даан ч яав даа, бид үнэхээр хэмээс хэтэрсэн байна шүү дээ”.
32. Магад Эзэнтэн маань түүний оронд илүү өлзийтэйг хайрлах биз. Үнэхээр Эзэнтэндээ итгэн сүсэглэв эй” гэлцэв.
33. Гэсгээл гэдэг ийм болой. Тэд мэддэгсэн бол хойд ертөнцийн гэсгээл нь үүнээс ч илүү догшин шүү дээ.
34. Эргэлзээгүй,гэгээн сүсэгтнүүдийн хувьд Эзэнтний мэдэл дор хувь хишгийн диваажин буй.
35. Муслмануудыг нүгэлтнүүдтэй эн зэрэгцүүлэх гэж үү?
36. Та нар яав даа? Яахлаар ийм шийдвэр гаргадаг юм вэ?
37. Аль эсвэл ямар нэгэн судраас уншаа юу?
38. Тэнд өөрсдийн чинь үнэхээр таалсан зүйл байгаа юм уу?
39. Эсвэл та нарын шийдвэрлэсэн зүйлс чинь үнэн болох тухайд ертөнцийн төгсгөлийн өдөр үргэлжлэх бидний багтай амлалт байна гэж үү?
40. Тэднээс ийнхүү асуугтун: “Үүнд тэдний хэн нь гэрч байх юм вэ?”
41. Үгүй бол маргааныг нь гэрчлэх тэдэнд хамтрагчид нь байгаа юм уу? Үнэн юм бол хамтрагсадаа аваад ирэг л дээ!
42. Тэр өдөр нууцын хөшиг нээгдэнэ. Байдал хүндэрнэ. Тэд сөгдөн мөргөхөд дуудагдана. Гэвч тэд сөгдөн мөргөж чадахгүй.
43. Тэд тарчилан зовохдоо толгойгоо өндийлгөн эгц ч харж чадахгүй. Тэд эрүүл саруул байхдаа сөгдөн мөргөхөд уригдсан юм. (Гэлээ ч тэд сөгдөн мөргөөгүй билээ)
44. (Аяа, Элч минь!) Чи энэ үгийг (Кураныг) үгүйсгэгсэдийг Надад үлдээ (өөрийгөө бүү зовоо). Би тэднийг нууцаар, зугуухан үхэлтэй учруулмой.
45. Тэдэнд нүгэлээ хураах хугацаа өгч баймуй. Үнэндээ Миний сэдсэн бүхэн бараггүй.
46. Үгүй бол чи (Ислам шашинд уриалсны төлөө) тэднээс төлөөс нэхэж, тэд өрийн дарамтанд орчихсон юм уу?
47. Аль эсвэл тэдэнд далдын нууц байгаад түүнийг бичиж байгаа юм уу?
48. Чи Эзэнтнийхээ шийдвэрийг тэвчээртэй хүлээ. Загасны эзэн (Юнус)-ыг бүү дууриагтун. (Тэр зөн олны үйлдэлд тэвчсэнгүй билээ) Нэгэнтээ тэр (Аварга загасан дотор хэвтэхдээ) гуниглан Эзэнтэндээ залбирсан билээ.
49. Хэрэв, Эзэнтний нэгэн аврал ирээгүйсэн бол тэр эзгүй эрэг дээр хаягдан зовох байсан юм.

50. Эзэнтэн түүнийг гэгээн элчээр сонгож, эрхэм хүмүүсийн эгнээнд багтаасан билээ.
51. Үл сүсэглэгсэд Кураныг сонсохдоо чамайг жигшин харж, нүдээрээ цоо ширтэнэ. Мөн: “Илэрхий солиотой юм” хэмээнэ.
52. Уул шугмандаа Куран бол бүхий л ертөнцийн хувьд (үнэнхүү гайхамшигт) ухуулга-сургамж билээ.

## 69. СУРЕ ХАККА

Мекке-д илгээгдсэн. 52 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Биелэх нь чин үнэн (Ертөнцийн төгсгөлийн өдөр).
2. Биелэх нь чин үнэн тэр юу вэ?
3. Түүний (ертөнцийн төгсгөлийн өдрийн) юу болохыг чи хаанаас мэддэг вэ?
4. Ертөнцийн төгсгөлийн гэсгээлийг Самуд болон Гадын ардууд үгүйсгэсэн билээ.
5. Самудынхан аймшигт орь дуугаар сүйрсэн.
6. Гадынхан ч хүйтэн шуургаар үгүй болсон.
7. Аллах тэр шуургыг долоон шөнө, найман өдөр шууруулсан билээ. Тэр ард түмнийг хөндий хоосон голтой хуурай хасарваань модын адил болсоныг чи харах байсан юм.
8. Тэднээс үлдсэн ганц нэгэн амьтадыг чи харсан уу? (юу ч байхгүй)
9. Фиргаун болон түүнээс өмнөхүүд, тэрчлэн хот суурин нь орвонгоор нь эргэгсэд ч (Лутын ардууд) буруудаж нүгэлтэн болцгоосон юм.
10. Тэд үргэлж Эзэнтнийхээ гэгээн элчүүдийг эсэргүүцсэн билээ. Иймээс Аллах тэднийг ч хатуу гэсгээсэн юм.
11. Үнэндээ усанд автсан үед Бид та нарыг хөлөг онгоцонд гаргасан.
12. Энэ нь та нарын сургамж авахын тулд, сонор соргог нэг нь сонсохын төлөө байв.
13. Анхны бишгүүрийн дуу үлээгдэхүйд;
14. Газар хийгээд уулс байрнаас хөдөлж хөөрөн, бие биетэй мөргөлдөн сүйрэхэд;
15. Ийнхүү тэр өдөр хамгийн их аймшигтай ертөнцийн төгсгөлийн өдөр ирнэ.
16. Тэнгэр заадсаараа хагарч, үрэн таран болж хэврэгшинэ.

17. Аллахын элч мэлэжүүд тэнгэрт Эзэнтнийхээ зарлигийг хүлээнэ. Тэр өдөр Эзэнтний чинь огторгуйн мандалыг найман элч мэлэж нь тулж байх юм.
18. Тэр өдөр тайлангаа тавихад бэлэн байцгаагтун. Та нарын ямар ч санаа нуугдаж чадахгүй.
19. Тэр мөчид үйлийн дэвтэр нь баруун гар талаас өгөгдөгсөд баярлан: “Энэхүү үйлийн дэвтэрийг минь уншаад үзээч?;
20. Хэзээ нэгэн цагт тайлангаа тавих байх гэж мэддэгсэн” гэнэ.
21. Ийнхүү тэр тааламжит байдалтай;
22. Өргөмжит диваажинд байх болно.
23. Элбэг баян үр жимс нь гар хүрэх газарт сагсайж байна.
24. Тэдэнд: “Өнгөрсөн хугацаанд үйлдсэн сайн үйлийнхээ хариуд чөлөөтэй, тайван ундаалж хооллогтун” гэж хэлэгдэнэ.
25. Харин үйлийн дэвтэрээ зүүн гар талаас гардагсад: “Харалмар юм байх гэж дээ!; Үйлийн дэвтэр маань өгөгдөхгүй байх нь яав даа!;
26. Үйлийнхээ хариуг мэдэхгүй байсан ч болоосой!;
27. Харалмар юм! (Дахин амилахгүйгээр) алив бүхэн болоод өнгөрөөсэй!;
28. Мал хөрөнгийн маань ач тус ч болсонгүй ээ!;
29. Хамаг эрх мэдлээ ч алдлаа даа!” хэмээн халаглана.
30. Аллах тамыг хариуцагч мэлэж нартаа: “Түүнийг барьж авч хүлэгтүн!;
31. Тамын гал руу хаягтун!;
32. Дараа нь далан алд гинжээр дөнгөлөн орхигтун!” хэмээн тушаана.
33. Яагаад гэвэл тэр аугаа их Аллахад итгэдэггүй байсан юм.
34. Буурай ядуусыг хооллуулах сэтгэлгүй байсан билээ.
35. Тиймээс өнөөдөр энд түүнийг энэрэх нөхөр алга.
36. Идээ бээрээс өөр хоол өгөгдөхгүй.
37. Ийм хоолыг маш хүнд нүгэлтнүүд л хүртэнэ.
38. Та нарын харж буй зүйлээр тангараглаж байна.
39. Та нарын харж үзээгүй зүйлээр ч тангараглав.
40. Ямар ч эргэлзээгүй Куран бол эрхэм гэгээн элчид (Аллахаас ирсэн) үг болой.
41. Энэ нь зүгээр нэг найрагчийн үг биш ээ. Та нарын итгэл үнэмшил хангалтгүй байна.
42. Энэ нь бөө зайраны ч үг ч биш ээ. Та нарын сургамж авах нь ч хангалтгүй байна.
43. Энэ нь бүхий л ертөнцийн Эзэнтнээс айлдсан үг мөн.
44. Хэрэв тэр гэгээн элч маань Бидний өмнөөс худал үг хүргэсэн бол;



45. Түүнийг мэдээж ид шидийн хүчээрээ шүүрэн авч;
46. Гүрээ судсыг нь таслах байсан.
47. Та нарын хэн нь ч түүнийг хамгаалж чадахгүй.
48. Энэхүү Куран бол гэгээн сүсэгтнүүдийн хувьд ухуулга- сургамж мөн.
49. Та нарын дотор үүнийг үгүйсгэгсэд буйг Бид тодорхой мэднэ.
50. Куран бол үнэндээ үл сүсэглэгсэдийн хувьд гуниг, шаналал болой.
51. Энэ бол эргэлзээгүй чин үнэн мөн.
52. Тиймээс, аугаа Эзэнтнийхээ алдрыг (үл сүсэглэгсэдийн гүтгэлэгээс) цэвэрлэн өргөмжлөгтүн!

## 70.СУРЕ МАГАРИЖ

Мекке-д илгээгдсэн. 44 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Эрмэлзлэл сайтай нэг нь (Надир ибн Харис) хожмын гэгсгээлийг хүслээ.
2. Үл сүсэглэгсэдийн төлөө гэгсгээлийг хэн ч саатуулж чадахгүй.
3. Тэр гэгсгээл нь тэнгэрийн давхараануудын эзэн Аллахын мэдэлд буй.
4. Түүн рүү мэлэк элч нар болон Жабрейл нь тавин мянган жилтэй дүйх нэг өдрийн хугацаанд залрана. (Гэвч ийм зайнаас үл сүсэглэгсэдэд нүд ирмэх зуур хүрч очино.)
5. Аяа, Мухаммед! Зон олныхоо дарамтад элэгсэг, сайн санаа гарган тэвчигтүн.
6. Тэд эл гэгсгээлийг асар хол байгаа хэмээн бодоцгоодог.
7. Харин “Бид энүүхэнд” хэмээнэ.
8. Тэр өдөр тэнгэр хайлсан зэсэн өнгөтэй болно.
9. Уулс зулсан ноосын адил болно.
10. Анд нөхөр бие биеэн харсан мөртлөө (хар толгойн гайг бодсоор) амар мэнд асууцгаах сөхөөгүй байна.
11. Нүгэлтэнгүүд тэр өдрийн гэгсгээлээс өөрийгөө аврахын тулд өөрсдийнхөө хөвгүүдийг ч;
12. Хань ижил, ахан дүүсээ ч;
13. Өөрийг нь харж хандаж байсан овог угсаатнуудыг ч;
14. Бүүр газар дэлхий дээрх бүх хүмүүсийг ч барьцаанд өгөхөөс буцахгүй.

15. Хэрхэвч тэгж чадахгүй. Там бол дүрэлзэх гал. (Ямар ч юм барьцаанд өгсөн ч тамын гэсгээлээс аврагдана гэж үгүй)
16. Тэр арьсыг түлж хуулна.
17. Тэр үнэнээс нүүр буруулан, буруу тийш хаяж одогсодыг;
18. Буурай, ядууст туслахгүй хөрөнгө хураагсэдыг дуудна.
19. Үнэндээ, хүн гэдэг амьтан тэвчээргүй заяагдсан байдаг.
20. Гай барцаг тохиолдохууд гутрах нь амархан.
21. Буян хишиг заяагдвал харам сэтгэлтэй болдог.
22. Харин уншлага мөргөл үйлдэгсэд үүнээс өөр билээ.
23. Тэд уншлага мөргөлөө тогтмол үйлдэцгээдэг.
24. Тэд хүссэн ч, хүсээгүй ч хөрөнгийнхөө зохих хувийг,
25. Буурай ядууст өглөг болгон өгдөг юм.
26. Мөн ертөнцийн төгсгөлийн өдөрт итгэцгээдэг.
27. Мөн Эзэнтнийхээ гэсгээлээс айцгаадаг.
28. Эс тэгэвээс Эзэнтнийхээ гэсгээлээс эсэн мэнд үлдэх магадлалгүй билээ.
29. Мөн садар самуунаас нэр төрөө цэврээр хамгаалцгаадаг.
30. Харин өөрийн эхнэрүүд болон аваал шивэгчингүүдтэй ойртвол буруугүй.
31. Үүнээс өөрөөр хүсэл тачаалын эрхэнд автвал хэмээс хэтэрсэнд тооцогдоно.
32. Тэрчлэн итгэмжлэл, андгай тангарагтаа үнэнч хүмүүс;
33. Үнэнч шударгаар гэрчлэгсэд;
34. Уншлага мөргөлөө хугацаанд гүйцэтгэгчид;
35. Ийнхүү тэд диваажинд очих хүмүүс мөн.
36. (Аяа, Мухаммед!) Чамайг чиглэн яаруу ирж буй үл сүсэглэгсэдэд юу болоо вэ?
37. Баруун, зүүнгүй бөөн бөөнөөрөө овооролдон суух юм гээч!
38. Тэд тус бүрдээ элбэг баян диваажинд орохыг санаархана уу?
39. Хэрхэвч тийм болохгүй. Үнэндээ Бид тэднийг өөрсдөө сайн мэдэх үрийн ганц дусалаар бүтээсэн юм.
40. Өрнийн хийгээд дорнын Эзэнтнээр тангараглая.
41. Тэднийг сүйрүүлэн, оронд нь илүү сайн хүмүүсийг авч ирэхэд Бидний хүч чадал хүрнэ. Хэн ч Биднээс хүчтэй болж чадахгүй
42. Тэд амлагдсан (гэсгээгдэх) өдөр хүртэл (хоосон, утгагүй мөрөөдөлдөө автан) инээн баясч явж л байг.
43. Тэр өдөр тэд булшнаасаа яаравчлан гарцгааж, түшүүлж тавьсан өнөөх хиймэл бурхад руугаа гүйх мэт болно.

44. Тэднийг хар дарж, (тэргүүнээ гудайлгасан чигээр) газар ширтэнэ. Тэдэнд амлагдсан өдөр энэ болой!

## 71. СУРЕ НУХ

Мекке-д илгээгдсэн. 28 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Бид Нухыг өөрийнхөө ардад: “Хүнд гэсгээл ирэхээс өмнө ард олондоо сэрэмжлүүл” хэмээн илгээсэн билээ.
2. Нух тэдэнд хандан: “Аяа, Ард олон минь ээ! Би үнэндээ та нарт Аллахаас илгээсэн ил тод сэрэмжлүүлэгч мөн.
3. Аллахад залбирагтун, Түүнээс айтгун, намайг дагагтун!
4. Тэгээд Аллах та нарын нүглийг өршөөж, амьдрах хугацааг чинь зохих хэмжээгээр уртасгана. Аллахын товлосон хугацаа ирэхүүд түүнийг хойшлуулах ямар ч боломжгүй. Үүнийг ухаардагсан ч болоосой” хэмээн сануулав.
5. Нух эцэст нь: “Аяа, Эзэнтэн минь! Би ард олондоо өдөр, шөнөгүй, амсхийлгүй итгэн сүсэглэхэд уриаллаа.
6. Уриалан дуудах тусам тэд улам зөрүүдлэв.
7. Тэднийг Өөрийн чинь өршөөлд хамрахыг уриалах бүрт тэд чихээ бөглөн, толгойгоо хувцасаараа бүтээн, зөрүүдлэн эсэргүүцэж, их зан гаргацгаалаа.
8. Дараа нь байдаг дуугаараа уриалан дуудлаа.
9. Хожим тэдэнд ил далдаар ч аминчлан зөвлөв.
10. Эцэст нь тэдэнд: “Эзэнтнээсээ өршөөл гуйгтун. Учир нь Тэр нэн ивээн өршөөгч” хэмээн хэллээ.
11. “Тэр та нарт тэнгэрээс элбэг хур бороог хайрлана;
12. Мөн та нарт эд хөрөнгө, үр хүүхэд хайрлан дэмжинэ. Сайхан цэцэрлэгүүд байгуулж, гол мөрөнг ч урсгаж өгнө;
13. Та яагаад Аллахын хайр хишгийг хүсдэггүй юм вэ?
14. Үнэхээр Тэр та нарыг хэд хэдэн дамжлагаар бүтээсэн шүү дээ;
15. Аллах долоон тэнгэрийг давхарлан бүтээснийг хараагүй гэж үү?
16. Сарыг тэнгэрийн гэрэл гэгээ, нарыг дэнлүү болгосон;
17. Аллах, та нарыг шавраар бүтээсэн дээд овог (Адамаас) эхлэн өсгөн үржүүлсэн;
18. Үхсэний дараа та нарыг эргэж газар руу буцааж, мөн дахин амилуулана;

19. Аллах, та нарын төлөө газрыг дэлгэн зөөлөн дэвсгэр болгож өгсөн;
20. Чөлөөтэй хэсэж явахын тулд түүн дээр өргөн, салаа замууд бий болгосон” хэмээн ухуулав.
21. Нух Эзэнтэндээ хандан: “Аяа, Эзэнтэн минь! Тэд үнэхээр намайг эсэргүүцлээ. Тэд хөрөнгө хийгээд үр хүүхэд нь өөрт гай болохоос өөр ашиг тус эс өгөх хүмүүсийг дагацгаалаа.
22. Тэд надад муухай заль мэх сэдэв.
23. Тэд бие биендээ: “Бурхадаа бүү хөсөр хаяарай. Уад, Суаг, Иагус, Иагук, Насырыг ч хэзээ ч бүү орхицгоо!” гэлцсэн.
24. Ийнхүү тэд олон хүнийг төөрөлдүүллээ. (Аяа, Эзэнтэн минь!) Чи ч эдгээр харгис зальхай этгээдүүдийг төөрөлдсөн дээр нь улам төөрөлдүүлэгтүн?! хэмээн залбирав.
25. Эцэст нь тэд үйлдсэн нүглээсээ болж усан галавт живцгээсэн билээ. Мөн тамын галд шидэгдэцгээн, Аллахаас ямар ч туслалцаа авч чадаагүй юм.
26. Нух эзэндээ хандан: “Аяа, Эзэнтэн минь! Газар дэлхий дээр үл сүсэглэгсдээс нэгийг нь ч бүү үлдээ;
27. Хэрэв тэднийг эсэн мэнд үлдээх аваас, боолуудыг чинь урвуулан төөрөгдүүлж, сэтгэлгүй, сүсэг бишрэлгүй хүмүүсийг өсгөн үржүүлэх болно;
28. Аяа, Эзэнтэн минь! Намайг, эцэг эхийг минь, миний гэрт сүсэгтэн бологсодыг, түүнчлэн сүсэгтэн эрэгтэй, эмэгтэйчүүдийг өршөөн хайрлагтун. Харин харгис зальхай этгээдийг улам сүйрүүлэгтүн!” хэмээн залбирав.



Мекке-д илгээгдсэн. 28 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. (Аяа, Мухаммед!) Зон олондоо хэлэгтүн: “Надад дараах зүйл айлдагдлаа. Олон тооны буг(жин) чөтгөрүүд Кураныг сонссоны дараа өөрийн бүлэгтээ очиж: “Бид үнэхээр нэгэн гайхалтай Кураныг сонслоо;
2. Тэр зөв шулуун зам руу хөтөлнө. Бид түүнд итгэцгээлээ. Эзэнтэнтэй ямар ч юмыг эн зэрэгцүүлэхгүй;
3. Үнэхээр Эзэнтний минь алдар цуу асар агуу юм. Тэр ямар ч хань ижил, үр хүүхэд эзэгнэхгүй;

4. Бидний дунд буй зарим ухаан мөчид нь (чөтгөр шулмасууд) Аллахын талаар ор үндэсгүй юм ярьсан байна.
5. Бид үнэндээ хүмүүн хийгээд (жин) буг чөтгөрүүд Аллахын талаар худлаа хэлэхгүй гэж бодоцгоож байсан билээ.
6. Зарим эрчүүд буг чөтгөрийн заримд нь итгэж сүсэглэснээр тэднийг өөгшүүлчихсэн юм.
7. Тэд (хүмүүсийн доторх үл сүсэглэгсэд) та нарын нэгэн адил Аллах үхсэн хүнийг хэзээ ч амилуулж чадахгүй гэж бодоцгоодог”
8. Бид (буг) сэмхэн чагнахын тулд тэнгэрт гарах гэтэл тэнгэрийг хүчирхэг харуулууд болон галт ододоор дүүрэн байхыг олж харсан юм.
9. Бид урьд нь нуугдаж сонсохын тулд тэнгэрийн суух боломжтой байрлалыг олоод суудагсан. Харин одоо бидний хэн нэг нь сонсохыг оролдвол тэр өөрийг нь тосч буй галт ододтой учрана.
10. Дэлхий дэх буй бүхэнд муу муухай юм нүүрлэх нь үү, эсвэл Эзэнтэн нь тэдэнд сайн сайхныг хүсэж байна уу? Бид үүнийг ялган салгаж үл чадмуй.
11. Бидний дотор сайн ч, муу ч юмнууд бий. Гиймээс бид өөр өөрийнхөө зам марийг хөөдөг болсон юм.
12. Бид ийнхүү газар дэлхийд Аллахыг сул дорой болгож чадахгүйгээ, түүнээс оргон зайлах бололцоогүйгээ ухаарсан болой.
13. Бид чин үнэнийг (Кураныг) сонсмогцоо түүнд сүсэглэн итгэцгээсэн билээ. Хэн Эзэнтэндээ бишрэн сүсэглэнэ, тэр хор хөнөөлөөс, өөрт нь шударга бус юм хийгдэхээс айдаггүй болой.
14. Бидний дотор мусулманууд ч байна. Зөв шулуун замаас төөрөлдөгсөд ч байна. Хэн мусулман болно, тэр зөв зам руу эргэнэ.
15. Харин зөв шулуун замаас төөрөлдөгсөд тамын галын түлш болцгооно.
16. (Аяа, Мухаммед! Надад ийнхүү айлдсан) : Хэрэв тэд (буг ба хүмүүс) зөв шулуун замыг баримталбал Бид тэднийг хүрэлцээтэй ус ундаагаар хангана.
17. Бид тэднийг үүгээр сорино. Хэн Эзэнтнийгээ дурсан санахаас нүүр буруулна, Аллах түүнийг хүнд гэгсгээлтэй учруулна.
18. Мечитүүд эргэлзээгүй Аллахад хамааралтай. Тэнд Аллагаас өөр хэнд ч бүү залбирагтун.
19. Аллахын боол (Мухаммед) Түүнд залбирахаар босоход буг чөтгөрүүд Кураныг сонсохын тулд шавааралдан түүнийг дайрах шахав.
20. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Би гагцхүү Эзэнтнээ тахин шүтнэ. Түүнд хэнийг ч хань эс болгомуй.
21. Миний хувьд та нарт хор ч, тус ч хүргэхэд хүч мэдэл маань хүрэхгүй.

22. Аллахыг эсэргүүцвээс намайг түүний гэгсгээлээс хэн ч аварч чадахгүй. Би Түүнээс өөр нөмөр нөөлөг олж эс чадмуй.
23. Би гагцхүү Аллахын айлдсаныг, Түүний илгээснийг хүргэнэ. Хэн Аллах болон Түүний гэгээн элчийг эсэргүүцэнэ, тэр үг сүггүй тамд орно, тэнд үүрд үлдэх болно.
24. Эцэст өөрсдөд нь амлагдсан (урьдчилан сануулсан) гэгсгээлийг харсан даруйдаа, тэд хэний туслагч нь чадваргүй, цөөн тоотой болохыг ухаарна.
25. (Аяа, Мухаммед!) Тэдэнд: “Та нарт сануулсан гэгсгээл ойрхон уу, эсвэл Эзэнтэн минь түүнд хожуу хугацааг товлов уу, үүнийг би мэдэхгүй.
26. Аллах бүхий л далдыг мэддэг ч түүний нууцыг хэнд ч хэлэхгүй.
27. Гагцхүү өөрийн таалсан элчдээ мэдэгдэнэ. Яагаад гэвэл Тэр гэгээн элчүүдийнхээ хойно нь харуул мэлжүүдийг тавьдаг юм.” хэмээн хэл.
28. Энэ нь Эзэнтнийхээ илгээснийг (зарлигийг) үнэн мөнөөр хүргэсэн эсхийг мэдэхийн тулд болой. Аллах тэдний хийсэн үйлдлийг бүрэн мэдэж байдаг бөгөөд алив бүхний тоог бүртгэн шалгадаг.



Мекке-д илгээгдсэн. 20 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Аяа, хувцасаа толгойдоо нөмөрсөн гэгээн элч ээ!
2. Шөнө болоход эсвэл шөнө дунд,
3. Үгүй бол шөнө хагасах цагаас хойш босож уншлага мөргөлөө үйлд.
4. Кураныг тайван, уянгалуулан, дэс дараалалтай, цэгцтэй уншигтун!
5. Мэдээж Бид чамд сонсголонтой айлдварыг (Кураныг) илгээмүй.
6. Үнэндээ шөнийн нойроо хугаслан босох нь хэцүү ч сэтгэлийн гэгээрэлд өлзийтэй. Уншлага залбирал үгэнд илүү зохистой.
7. Үнэндээ, өдрийн цагаар чи ажлын дарамтанд байдаг.
8. Эзэнтнийхээ алдрыг санан дурс. Эргэлзээгүй, сэтгэлээрээ Түүн рүү тэмүүл.
9. Тэр өрнө хийгээд дорнын Эзэнтэн мөн. Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Тиймээс Түүнийг “Эзэнээ” хэмээн ухааратун.
10. Тэдний (Меккегийн үл сүсэглэгсэдийн чамайг илбэчин, найрагч, солиотой гэсэн) доромжлолыг тэвчээрэй. Тэднээс дарууханаар, эв зүйгээр холд.

11. Бидний айлваруудыг худал хэмээн үгүйсгэгчдийн асуудлыг Надад үлдээ. Тэдэнд боломж өг.
12. Тэдний төлөө Бидний мэдэлд дөнгө, шатаах тамын гал буй.
13. Мөн хоолойгоор нь давахагүй хоол, тарчилган зовоох гэгсгээл буй.
14. Тэр өдөр (ертөнцийн төгсгөлийн өдөр) газар дэлхий, уулс доргин чичирнэ. Уулс элсэн нурам болно.
15. Бид Аяа, Меккегийн үл сүсэглэгсэд ээ! Фиргаун руу гэгээн элчийг хэрхэн илгээсний адил, та нарт ч гэгээн элчээр Мухаммедыг илгээсэн юм шүү. Тэр та нарыг гэрчилнэ.
16. Фиргаун гэгээн элчийг эсэргүүцсэн тул Бид ч түүнийг (байдгаараа) хатуу гэгсгээн цээрлүүлсэн билээ.
17. Аяа, Буруу номтнууд аа! Хэрэв эсэргүүцээр байвал нялх хүүхдийн үсийг цайлган өглүүлэх хүртэлх өдрөөс өөрсдийгөө хэрхэн хамгаалж чадах вэ?
18. Тэр өдрийн аймшигт сүйрлээр тэнгэр задрана. Аллахын амлалт нь (буяныг буянаар, бузарыг бузараар хариулах) гарцаагүй ёсоор болох болой.
19. Үнэндээ энэ бол зөвхөн ухуулга-сургамж юм. Үүнийг таалсан хүн Эзэнтэндээ хүрэх замыг олно.
20. (Аяа, Мухаммед!) Эзэнтэн чинь, чиний, чамтай хамт байгсад (нөхдийн) нэг хэсгийн шөнийн гуравны хоёроос бага хугацаа үлдэхэд, шөнө дунд, гуравны нэгд нь унталгүйгээр уншлага мөргөл үйлдэхээ мэднэ. Гагцхүү Аллах шөнө, өдрийн уртыг хэмжиж товлодог. Та нарын тооцоолж чадахгүйг (үүнээс илүүд нь хүч чадал нь хүрэхгүйг) мэдсэн учраас Аллах өршөөн хэлтэрүүлсэн болой. Одоо Кураны хялбарыг олж уншигтун. (Урьд нь шөнө үйлдэх Тахажжуд уншлагыг Аллах хүчингүй болгож, Нафил- уншлага мөргөл буюу сайн дурын уншлага мөргөл болгосон.) Аллах та нарын доторх нэг хэсэг нь өвчтөнгүүд, Аллахын хувь хишиг горьдон хэсүүчлэгчид, нөгөө хэсэг нь Аллахын төлөө дайн тулаанд оролцогчид буй гэдгийг мэдэж байна. Тиймээс Кураны хөнгөн хялбарыг уншиж, уншлага мөргөлөө ёсоор нь үйлдэгтүн, ариуслын өглөгөө өгөгтүн. Аллахад (Аллахын төлөө) зүрх сэтгэлийнхээ гүнээс гоё сайхан өглөө өгөгтүн. Өөрсдийн төлөө хийсэн сайн сайхны хариуд нь Аллахын мэдэлд буй хувь хишгээс бүр ч илүү шагнал хүртэх болно. Аллагаас өршөөл гуйгтун. Аллах машинд өршөөгч, нэн нигүүлсэгч шүү дээ.

## 74. СУРЕ МҮДДАССИР

Мекке-д илгээгдсэн. 56 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Аяа, хувцасаа толгойдоо нөмрөгч гэгээн элч минь!
2. Бос, (хүмүүнийг) Аллахын гэгсгээлээс сэрэмжлүүл.
3. Эзэнтнээ дээдэл.
4. Хувцасаа цэвэр ариун байлга.
5. Бохир зүйлээс хол бай.
6. Өгснөө ихэд санах юм бол буян бүү хайрла.
7. Эзэнтнийхээ төлөө тэвчээртэй бай.
8. Бүрээ бишгүүр үлээгдэх мөч;
9. Маш хүнд өдөр болно.
10. Үл сүсэглэгдэд огтхон ч хялбар биш болно.
11. Миний ганцаар (эд хөрөнгө, гэр бүлгүй) бүтээсэн буруу номтон хүнийг (Уалид ибн Мугира) надад орхи.
12. Би түүнд их баялаг өгсөн юм.
13. Мөн түүнд нүднийх нь өмнө буй хөвгүүдийг хайрласан.
14. Нэр төрийг нь өргөсөн, хайрласан билээ.
15. Гэтэл тэр улам их өгөхийг хүсдэг боллоо.
16. Үгүй, тийм байж болохгүй. Учир юу гэвэл тэр Бидний айлдваруудыг эсэргүүцлээ.
17. Би түүнийг хатуу цээрлүүлэх болно.
18. Үнэндээ тэр Кураны талаар бодсон, юу хэлэхээ төлөвлөсөн..
19. Тэр харалмар хэрхэн төлөвлөсөн гээч?
20. Тэр үхээрийн амьтан! яаж тооцоолов гээч?
21. Урдаар сайн харсан.
22. Тэгээд хөмсөгөө зангируулж, ярвайсан.
23. Тэгээд буруу харж бардамнав.
24. Тэгээд: “Энэ (Куран) бол сурсан илбэ;
25. “Жирийн нэгэн хүний үг” гэв.
26. Би түүнийг гарцаагүй Сакар хэмээх там руу хийнэ.
27. Сакарын там хэмээх юу болохыг чи мэдэх үү?
28. Тэр буруу номтныг ямар ч яс, мах үлдээхгүйгээр шатаана.



29. Хүмүүний арьсыг үргэлж хуу түлж байдаг.
30. Түүнийг харуулах гэсгээлийн арван есөн мэлэк буй.
31. Бид тамын харуулаар гагц мэлэкүүдийг томилсон. Тэдний тоогоор үл сүсэглэгсэдийг сорьсон болой. Улмаар өөрсдийнхөө судраас ч энэхүү тоог харж, Кураны чин үнэн гэдэгт судрын эзэд итгэг. Итгэн сүсэглэгсэдийн итгэл-сүсэг нь улам батжиг. Судрын эзэд болон сүсэгтнүүд бүү эргэлзэг. Зүрхний гажигтай, хоёр нүүртэнгүүд болон үл сүсэглэгсэд: “Энэхүү жишээг татахдаа Аллах юуг зорьсон бол?” хэмээн хэлэг. Аллах ийнхүү хүссэн нэгээ төөрөгдүүлж, нөгөөгийг нь зөв замд оруулдаг. Эзэнтэн чинь дайчдаа (мэлэкүүдийн тоо, цэргийн давуу тал, төрөлхийн агуу байдлыг) зөвхөн өөрөө л мэднэ. Энэ нь тамынхны хувьд бас нэгэн сургамж мөн.
32. Үгүй дээ, Сараар тангараглая,
33. Өнгөрч буй шөнөөр тангараглая,
34. Гэгээрэн цайсан үүрээр тангараглая,
35. Тэр (Сакар) там бол үнэндээ аюултай гай зовлонгийн нэг болой.
36. Хүмүүн төрөлхтний төлөө сэрэмжлүүлэг болог.
37. Та нараас (диваажинд орохын тулд) түрүүлэхийг бодогсод, (там руу явахдаа) ухран үлдэхийг санаархагчдад нэгэн сануулга мөн.
38. Алив хүмүүн өөрийн үйл араншингаасаа болж тамд ордог.
39. Харин үйлийн дэвтэр нь баруун талаас өгөгдсөн хүмүүст энэ үл хамаарна.
40. Диваажинд тухлагсад нүгэлтнүүдээс ийнхүү асууна.
41. “Ахуй байдал чинь ямар вэ?” хэмээнэ.
42. “Юуны учир тамд орсон вэ?” хэмээнэ.
43. Нүгэлтэнгүүд болохоор: “Бид уншлага мөргөл үйлдэгсэдийн эгнээнд биш байсан билээ;
44. Үгээгүй ядуусыг хооллуулж байсангүй ээ.
45. Гүтгэн ховлогсодтой нийлэн хов-жив ярьсан юм;
46. Ертөнцийн төгсгөлийн өдрийг худал хэмээн үгүйсгэсэн билээ;
47. Үхэл бидэнд тохиох хүртэл ийнхүү хийлээ;” хэмээцгээнэ.
48. Тэдэнд өмөөрөгсөдийн өмгөөлөл ямар ч ашиг тусыг эс өгнө.
49. Ийм байхад тэд яагаад ухуулга сургамжаас (Куранаас) бултаж зайлна вэ?
50. Тэд (Мухаммедыг харахдаа) арслангаас сүрдсэн зэрлэг илжиг мэт .....
51. зугтан одно.
52. Үгүй, Тэд хүн бүртгээ нэг судар өгөхийг хүснэ.
53. Хэрэг дээр тэд хойд ертөнцөөс айхгүй байна.

54. Үгүй дээ, үнэндээ Куран бол ухуулан сэнхрүүлэх сургамж юм шүү дээ.
55. Хүссэн хүн л ухааран сургамж авч чадна.
56. Гагцхүү Аллахын хүссэн хэн нэгэн сургамж авдаг. Аллах айхад ч, өршөөл гуйхад ч зохимжтой Эзэнтэн билээ.

## 75. СУРЕ КИЯМЕТ

Мекке-д илгээгдсэн. 40 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Ертөнцийн төгсгөлийн өдрөөр тангараглая.
2. Өөрийгөө буруутган зэмлэх хүсэл тачаалаар нь тангараглая.
3. Хүмүүн Биднийг өөрсдийнхөө ясыг цуглуулж авч чадахгүй гэж боддог юм уу?
4. Үгүй дээ, Бид түүний хувхайрсан хурууны үзүүрийн ясыг ч цуглуулж, хэвэнд оруулж чадмой.
5. Гэвч хүмүүн ирээдүйд буйг (гарцаагүй тохиох ертөнцийн төгсгөлийг) үгүйсгэхийг хүсдэг.
6. Тэд “Ертөнцийн төгсгөлийн өдөр хэзээ вэ?” хэмээн дооглон асуудаг.
7. Аянга цахилгаан нүд ирмэх зуур;
8. Сар хиртэх зуур;
9. Нар, сар нэг дор тохиох зуур тохионо.
10. Тэр мөчид хүмүүс “зугтах газар байна уу?” хэмээн дуу алдацгаана.
11. Үгүй ээ, Тэр өдөр зугтаж хоргодох нөмөр угаас үгүй.
12. Тэр өдөр тулж очих газар чинь гагцхүү Эзэнтний чинь нигур дор байх болно.
13. Тэр өдөр хүмүүнд урьд-хойно юу үйлдсэнийг нь мэдүүлэх юм. (хойд ертөнцийн төлөө юу үйлдсэнийг, юуг үйлдээгүйг)
14. Ийнхүү хүмүүс өөрөө өөртөө гэрч болно.
15. Хичнээн их шалтгаан тоочсон ч хүлээн авагдахгүй.
16. (Аяа, Мухаммед!) Чамд Жабрейл элчээр дамжуулан айлдвар буухад түүнийг (санаандаа хадгалахын тулд) давтан хэлэх гэж хэл амаа хөдөлгөн бүү оролдогтун.
17. Түүнийг цуглуулан уншиж ойлгуулах явдал үнэндээ бидний үүрэг мөн.
18. Бид түүнийг Жабрейлээр дамжуулан уншиж өгөхөд чи түүнийг дагаж, уншлаганд чих тавь.

19. Дараа нь тайлбарлан ойлгуулах бас л Бидний хэрэг мөн.
20. Үнэндээ та нар түр зуурхан явдлыг (энэ хорвоог) таалдаг.
21. Хойд ертөнцийг мартаж, хойш нь тавьчих юм даа.
22. Тэр өдөр олон хүний царай нь гэрэлтэнэ.
23. Тэгээд Эзэнтэн рүүгээ харна.
24. Тэр өдөр олон хүний царай нь барайна.
25. Тэд өөрсдөд нь нуруугаа хугалах нэгэн гай зовлон тохиохыг мэдэрнэ.
26. Үнэндээ хоолой дээр тулах цагт хэн нэг нь:
27. “Үүнийг аргалах хүн байна уу?” хэмээн дуу алдана.
28. Энэ нь амьд хорвоогоос хагацах мөч болохыг гүйцэт ухаарна.
29. Амь тавихын цагт хоёр хөл нь тэглэн бүдрэнэ.
30. Тэр одоо Эзэнтний өмнө туугдан очино.
31. Тэд Куранд итгээгүй. Уншлага мөргөл үйлдээгүй билээ.
32. Бүүр бүгдийг үгүйсгэн, итгэн сүсэглэхээс нэг мөсөн нүүрээ буруулсан юм.
33. Тэгээд ичиж зовохын оронд бардамнан алхсаар гэртээ харьдаг байлаа.
34. “Лай-Ланчиг хүзүүгээр чинь ороог!” хэмээгдэнэ.
35. “Хор хөнөөл толгой дээр чинь төөнөж бууг!” хэмээгдэнэ.
36. Хүн гэдэг амьтан өөрийгөө хязгааргүй эрхтэй хэмээн бодно уу?
37. Тэр эхийнхээ умайд орсон үрийн дусал төдий байсан биш билүү?
38. Дараа нь нөжирсөн цус болон хувирсан, тэгээд Аллах хүн болгон бүтээж, дүр төрхтэй болгосон юм.
39. Түүгээр эр, эм хүйсийг бүтээсэн билээ.
40. Тэгвэл (энэ бүхнийг бүтээгч) Аллахын хүч чадал үхэгсэдийг дахин амилуулахад хүрэхгүй гэж үү дээ?



## 76. СУРЕ ИНСАН

Мекке-д илгээгдсэн. 31 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Хүмүүн төрөлхтөн үнэндээ урьд өмнө ярьж байгаагүй байхад (бүтээгдээгүй байхад) урт удаан хугацаа өнгөрсөн билээ.
2. Үнэндээ Бид хүмүүнийг холилдсон нэгэн дуслаас (Эр, эм бэлгийн дуслаас) бүтээсэн билээ. Бид тэднийг сорьж, сонсох-харах эрхтэнтэй болгосон.

3. Улмаар тэдэнд талархах, эсвэл үл тоомсорлох зөв шулуун замыг харуулсан.
4. Үл сүсэглэгсэдийн төлөө гинж, дөнгө, тамыг зэхсэн.
5. Харин буянт сайн үйл үйлдэгсэд гарцаагүй кафур буюу булагийн усаар найруулсан ундааг аяга дүүрэн ууцгаана.
6. Кафур нь Аллахын итгэлт боолууд нь ханатал уух, хүссэн зүг рүүгээ урсгах ариун ундаргатай булаг болой.
7. Итгэлт боолууд нь өгсөн амлалтаа биелүүлнэ, аюулт гэгсгээл бүхий өдрөөс айдаг юм.
8. Аллахад хайртай болохоор үгээгүй ядуусыг, өнчин өрөөсөнг, дайнд олзлогсодыг хооллуулдаг билээ.
9. Тэгээд тэд: “Бид та нарыг Аллахын тааллын төлөө хооллуулж баймуй. Тиймээс та нараас ямар нэгэн хариу буюу шан харамж, талархал эс хүсмүй.”
10. “Бид аймшигт, нэн хүнд өдрөөс, түүнийг ирүүлэх Эзэнтнээс айдаг” хэмээнэ.
11. Аллах тэднийг хүнд өдрийн сүйрлээс хамгаалж, баяр баясгалангаар шагнана.
12. Тэднийг алив хүндрэл бэрхшээлийн сорилтод тэвчээр гаргасны хариуд диваажин болон хоргой торгоор шагнана.
13. Тэд диваажингийн хүндэтгэлтэй сэнтийд залран тухлана. Тэнд халуун, хүйтнийг үл мэдрэнэ.
14. Диваажингийн цэцэрлэгт сүүдэрлэх бөгөөд төрөл бүрийн жимс хажууд нь сагсайж баймуй.
15. Тэдэнд идэх зүйлээр дүүргэсэн мөнгөн таваг, ундаа дүүрэн шаазан гүц, мөнгөн аягыг урьдаас нь тосон барина.
16. Мөнгөн болор аягт ундааг зохих хэмжээгээр найруулан хийнэ.
17. Занжабил хэмээх диваажингийн цагаан гаа найруулсан ундааг болор аягаар уулгана.
18. Диваажинд Сальсабиль нэртэй нэгэн ариун булаг бий.
19. Үл өтлөх, цэврүү цэцэг мэт залуус тэднийг тойрон үйлчилнэ. Чи тэднийг харвал эргэн тойрондоо цацагдсан шүр сувд хэмээн бодно.
20. Хаашаа ч харсан элбэг буянтай хаанчлалыг үзнэ.
21. Тэд торго хоргойгоор гангаран, мөнгөн бугуйвчууд зүүсэн байх аж. Тэгээд Эзэнтэн тэднийг цэвэр ариун ундаагаар дайлана.
22. “Энэ бол үнэндээ та нарт зориулагдсан шагнал мөн. Хичээл зүтгэлийн чинь хариу талархал” хэмээгдэнэ.
23. (Аяа, Элч минь!) Бид чамд Кураныг хэсэг бүлэгээр нь хувааж буулгасан.

24. Тиймээс Эзэнтнийхээ зарлигийг тэвчигтүн. Ямар ч нүгэлтэн болон үл сүсэглэгчдийн үгэнд бүү ор.
25. Эзэнтнийхээ алдрыг өглөө үдэшгүй санан дурсч, алдаршуул;
26. Шөнийн нэгэн цагт ч Түүнд сөгдөн мөргө. Шөнийн турш Түүнийг шагшин магт.
27. Үнэндээ үл сүсэглэгсэд зуурдын зүйлийг шохоорхоно. Тосон угтах төгсгөлийн өдрийг ер бодохгүй.
28. Бид тэднийг бүтээж, дүр төрхийг нь цогцолсон юм. Хэрэв хүсвэл тэднийг үгүй хийж, оронд нь өөр нэгнийг тавих болно.
29. Энэ бол зүгээр нэг ухуулсан сургамж болой. Таалсан хүн л Эзэнтэн рүүгээ очих замыг сонсог.
30. Аллахын зарлиггүйгээр та нар ганц ч юмыг ойлгож чадахгүй. Эргээзгүй, Аллах бүхнийг мэдэгч, мэргэн ухааны Эзэн мөн.
31. Аллах хүссэн хүнээ ивээл энэрэлдээ багтаана. Харин харгис зальхайчуудад зовлонт гэсгээл зэхсэн буй.

## 77. СУРЕ МҮРСАЛАТ

Мекке-д илгээгдсэн. 50 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Тасралтгүй сэвэлзэх сэрүүн уур амьсгалаар тангараглая.
2. Ороон хуйларсан шуургаар тангараглая.
3. Үүлийг хүссэн зүг рүү тараан хөөдөг салхиар тангараглая.
4. Үнэн, худалыг дэнслэгчээр (мэлэк эсвэл куран) тангараглая.
5. Гүтгэх боломж өгөхгүй, урьдчилан сэргийлэхийн тулд;
6. Гэгээн элч нарт айлдвар авч ирсэн мэлэкүүдээрээ тангараглая.
7. Аяа, Меккегийн үл сүсэглэгсэд ээ! Та нарт амлагдсан бүхэн (төгсгөлийн өдөр, тооцоо, гэсгээл) гарцаагүй биелэгдэнэ.
8. Оддын гэгээ тасрахад;
9. Тэнгэр хагарсан цагт;
10. Уулс үнсэн товрог болон хийсэх цагт;
11. Гэгээн элчүүд товлогдсон хугацаанд цугларсан цагт дээрх бүхэн биелэгдэнэ.
12. Энэ амлалтууд аль өдөр хүртэл хойшлуулагдах вэ?
13. Зарлигийн өдөр хүртэл.

14. Зарлигийн өдөр гэж юу вэ? Түүнийг хэрхэн мэдэх вэ?
15. Тэр өдөр чин үнэнийг үгүйсгэгчдэд харамсалтаяа!
16. Эсэргүүцэл үзүүлсэн өмнөхүүдийг сүйрүүлэхгүй байсан юм уу?
17. Тэдний замаар явсан хожимийхныг ч тэдний адил болгоно.
18. Нүгэлтэнгүүдийг ч тийм л болгоно.
19. Тэр өдөр чин үнэнийг үгүйсгэгчдэд харамсалтаяа!
20. (Аяа, хүмүүс ээ!) Бид та нарыг үрийн өчүүхэн дуслаар бүтээгээгүй гэж үү?
21. Түүнийг баттай нэгэн газарт (эхийн хэвлийд) байршуулсан билээ.
22. Гэхдээ тодорхой хугацаа хүртэл шүү.
23. Түүний хувь тавиланг тодорхойлсон юм. Бид юутай хүчирхэг билээ!
24. Тэр өдөр чин үнэнийг үгүйсгэгчдэд харамсалтаяа!
25. Бид газрын хэвлийг уужим багтаамжтай болгоогүй гэж үү?
26. Амьд хийгээд үхэгсэдэд хүрэлцэнэ.
27. Бид газар дээр сүрлэг уулсыг байршуулсан. Та нарт цэнгэг усыг уулгасан.
28. Тэр өдөр чин үнэнийг үгүйсгэгчдэд харамсалтаяа!
29. Үгүйсгэгсэдэд: “та нар, тэр үгүйсгэсэн зүйл (гэгсгээл) рүүгээ явцгаагтун!
30. Гурван хэсэг (үмхий, хар утаа бүхий) харанхуй руу (там ) явцгаагтун” хэмээгдэнэ.
31. Тэр харанхуй та нарыг эс сэрүүцүүлмүй, бас галаас эс авармуй.
32. Тэр том том аварга дөлийг улалзуулна.
33. Улалзах галын дөл нь тэмээний адил их том болой.
34. Тэр өдөр чин үнэнийг үгүйсгэгчдэд харамсалтаяа!
35. Тэр өдөр тэд дугарч чадахгүй.
36. Тэдэнд шалтгаан хэлэх боломж олгогдохгүй.
37. Тэр өдөр чин үнэнийг үгүйсгэгчдэд харамсалтаяа!
38. “Энэ бол та нар хийгээд өмнөхүүдийг чинь нэг дор цуглуулах зарлигийн өдөр мөн.”
39. Арга чарга байвал хийгээд харуулагтун.
40. Тэр өдөр чин үнэнийг үгүйсгэгчдэд мөн л харамсалтаяа!
41. Гэгээн сүсэгтнүүд тэр өдөр цэцэрлэгийн сүүдэрт, булагийн дэргэд байх юм.
42. Тэд таалан болгоосон төрөл бүрийн жимсний дунд оршино.
43. Тэдэнд: “Үйлдсэн сайн үйлийнхээ хариуд чөлөөтэй тайван хооллож, ундаалагтун” хэмээгдэнэ.

44. Бид буянт сайн үйлдэгсэдийг ийнхүү урамшуулдаг юм.
45. Тэр өдөр чин үнэнийг үгүйсгэгчдэд мөн ч харамсалтаяа!
46. Үл сүсэглэгсэд: “Одоохондоо (энэ хорвоод) идэж ууж, хэрэглэцгээгтүн. Та нар жинхэнэ нүгэлтэнгүүд мөн” хэмээгдэнэ.
47. Тэр өдөр чин үнэнийг үгүйсгэгчдэд мөн ч харамсалтаяа!
48. Тэдэнд : “Мэхийн мөргөгтүн” гэвэл эс мөргөнө.
49. Тэр өдөр чин үнэнийг үгүйсгэгчдэд мөн ч харамсалтаяа!
50. Тэд ингэхлээр Куранаас өөр ямар үгэнд итгэцгээх гэсэн юм бол доо?



Мекке-д илгээгдсэн. 40 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Тэд (Меккегийнх) өөр хоорондоо юуг асууцгаана вэ?
2. Аугаа мэдээний тухай асууцгаана уу?
3. Тэд өөр хоорондоо маргалддаг аугаа мэдээ мөн. (ертөнцийн төгсгөлийн өдөр болон бусад гэгээн элчийн авчирсэн мэдээ)
4. (Тэдний бодсонтой адил биш ээ) Мөдхөн мэдэцгээх болно.
5. Үгүй дээ, тэд мөдхөн мэдэцгээх болно.
6. Бид газрыг өлгий болгоогүй билүү?
7. Мөн уулсыг түшиг (гадас) болгоогүй гэж үү?
8. Бид та нарыг эр, эм болгон хосоор бүтээсэн.
9. Та нарын нойрыг амралт болгосон.
10. Шөнийг бүрхүүл (бүтээлэг) болгосон.
11. Өдрийг амжиргааны эх сурвалж болгосон.
12. Та нарын дээгүүр долоон давхар тэнгэрийг бүтээсэн.
13. Гэрэлт дэнлүү болгон нарыг бүтээсэн.
14. Өтгөн үүлнээс элбэг хурыг буулгасан.
15. Түүгээр үр тариа, өвс ургамал ургуулсан....
16. Ойн нуга, жимсний цэцэрлэгүүдийг ургуулсан.
17. Хар цагааныг ялгах зарлигийн өдөр үнэндээ товлогдсон.
18. “Сур” буюу бүрээ бишгүүр үлээгдэх тэр өдөр, та нар бөөн бөөнөөр Аллахын өмнө ирцгээнэ.
19. Тэнгэр задрал олон үүд хаалга бий болно.

20. Уулс замхарч зэргэлээ болно.
21. Халуун там хүлээж байх юм.
22. Тэр бол нүгэлтэнгүүдийн очих газар мөн.
23. Тэд тэндээ зуун зуунаар эгнэгт оршино.
24. Тэнд тэд сэрүүн сүүдэрийг ч, уух юмыг ч олохгүй.
25. Гагцхүү буцлам ус, идээ бээр л ууна.
26. Энэ нь тэдэнд тохирсон гэсгээл мөн.
27. Яагаад гэвэл тэд тооцоо хийгдэх өдрийг үл тоомсорлосон.
28. Бидний айлдваруудыг худал хэмээсээр хүлээн зөвшөөрөөгүй юм.
29. Бид бүгдийг нь тооцож тэмдэглэж байдаг.
30. Тэдэнд: “Амсацгаагтун! Бид та нарын гэсгээлийг нэмэгдүүлсээр байх болно” хэмээгдэнэ.
31. Гэгээн сүсэгтэнүүдийн хувьд хангалттай амжилт буй.
32. Жимсний цэцэрлэгүүд хийгээд усан үзмийн талбай буй.
33. Үзэсгэлэн гоо охидууд буй.
34. Амтат ундаагаар дүүргэсэн аяганууд буй.
35. Тэд тэнд дэмий хоосон худал яриа, хов жив огтхон ч сонсохгүй.
36. Эдгээр нь Эзэнтгээс чинь та нарт зориулсан элбэг дэлбэг шагнал болой.
37. Тэр (Аллах) тэнгэр, газар хийгээд тэдгээрийн хоорондох бүхний Эзэнтэн бөгөөд түүнтэй хэн ч ярьж чадахгүй.
38. Тэр өдөр Жабрейл болон мэлэкүүд эгнэн жагсана. Хэн ч, ганц ч үг дуугарахгүй. Зөвхөн Аллах таалж зөвшөөрсөн нь шударга, чин үнэнийг хэлж чадна.
39. Тэр өдөр тохиох нь үнэн. Тиймээс хүссэн хүн бүр Эзэнтэн рүүгээ очих зөв шулуун замыг сонгогтун.
40. Бид мөдхөн тохиох нэгэн гэсгээлээс та нарыг сэрэмжлүүлсэн. Тэр өдөр хүн бүр өөрийнхөө урьд нь үйлдсэн үйл хэргийн үр дүнг үзэх болно. Үл сүсэглэгсэд: “Харамсаар юм байх гэж. Ингэсэн дор тос шороо болох минь яав даа!” хэмээн халаглана.

## 79. СУРЕ НАЗИГАТ

Мекке-д илгээгдсэн. 46 айлдвар.

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Үл сүсэгтнүүдийн амийг зовоож авагчдаар (хатуу гартай мэлэкүүдээр) тангараглая.



2. Сүсэгтэнүүдийн амийг зовоолгүйгээр авдаг мэлэкүүдээр тангараглая.
3. Аллахын зарлигийг хүргэгч тэнгэрт дүүлэх мэлэкүүдээр тангараглая.
4. Мусулманчуудын амийг авахад диваажин руу уралдагч мэлэкүүдээр тангараглая.
5. Хойч ирээдүйн үйл бүхнийг зохицуулагч (дахин амилах өдрийн үйлийг зохицуулагч) мэлэкүүдээр тангараглая.
6. Тэр өдөр газар хүчтэй доргино.
7. Үүний араас хоёр дахь доргилт ирнэ.
8. Тэр өдөр зүрх сэтгэл эвгүйрхэнэ.
9. Нүд гөлрөн айдаст автана.
10. Тэд : “Бид буцаж хуучин байдалдаа орох юмуу? (Дахин амилах юм уу?)”
11. “Бид өгөршсөн яс болсон шүү дээ” гэнэ.
12. Тэд: “Энэ удаагийн дахин амилалт бол зовлонтой дахин амилалт болох биз” гэлцэнэ.
13. Нэг л удаа бүрээ бишгүүрийн орь дуугаар л....
14. Тэд (дахин амилан) газар дээр гараад ирнэ.
15. (Аяа, Мухаммед) Чамд Мусагийн тухай мэдээ ирсэн үү?
16. Тэр үед Эзэнтэн ариун Туа хөндийд түүнд ийнхүү айлдав:
17. Чи Фиргаун дээр оч. Яагаад гэвэл тэр шударга замаас зайлсан.
18. Түүнд : “Цагааран ариусах хүсэлтэй юу?”
19. “Би чамайг Эзэнтнээ танихад хандуулвал Түүнээс айх юм уу?” хэмээн асуугтун.
20. Муса Фиргаунд агуу гайхамшигийг харуулав.
21. Фиргаун хүлээн зөвшөөрөлгүй түүнийг эсэргүүцсэн билээ.
22. Тэр аашлан, нүүрээ буруулж гүйн одлоо.
23. Борчуудаа цуглуулан мэдэгдэхдээ:
24. “Та нарын аугаа эзэнтэн бол би мөн” гэлээ.
25. Тиймээс түүнийг Аллах энэ хорвоо хийгээд нөгөө ертөнцийн гэсгээлээр цээрлүүлсэн юм.
26. Үүнд Аллагаас айхсадын хувьд нэгэн сургамж буй.
27. Та нарыг бүтээх хэцүү юу, аль эсвэл тэнгэрийг бүтээх хэцүү юу? Аллах тэнгэрийг бүтээсэн юм.
28. Түүнийг өндөрт сүндэрлүүлж, өө сэвгүй төлөвшүүлэв.
29. Шөнийг харанхуй, өдрийг гэрэл гэгээтэй болгосон.
30. Дараагаар нь газрыг сунган дэлгэсэн.

31. Түүний энгэрээс булагууд урсган, өвс ургамалууд ургуулав.
32. Уулсыг хөдлөхөөргүй болгон суурилуулав.
33. Энэ бүхэн та нарын хийгээд мал сүргийн чинь тусын тулд билээ.
34. Аюултай сүйрэл (ертөнцийн төгсгөл) ирэхүйд,
35. Хүмүүс өөрсдийн үйлдсэн үйлээ эргэн санацгаана.
36. Хараатай бүхэнд тамын гал дүрэлзэн харагдана.
37. Хэн хэмээс хэтэрсэн бол,
38. Зуурдын амьдралыг илүүтэйд үзсэн бол,
39. Түүний очих газар нь там болой.
40. Хэн Аллахын өмнө эргэн байцаагдахаас айвал, хүсэл тачаалаа тэвчвэл,
41. Түүний очих газар нь диваажин болой.
42. Тэд чамаас ертөнцийн төгсгөлийн өдөр хэзээ тохиохыг асууцгаана.
43. Үүнийг тайлбарлах нь чиний үүрэг биш ээ.
44. Түүний тухай төгс мэдээлэл гагцхүү Эзэнтний нигур дор буй.
45. Чи гагцхүү ертөнцийн төгсгөлийн өдрөөс айхсадад сэрэмжлүүлэгч билээ.
46. Тэд ертөнцийн төгсгөлийн өдрийг харсан даруйдаа, өөрсдийгөө энэ хорвоод ганц үдэш эсвэл ердөө л үүрийн гэгээнээр л байсан мэтээр бодоцгооно.



Мекке-д илгээгдсэн. 42 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдараар эхэлье***

1. Хажууд нь сохор (Абдуллах ибн Үммү Мактум) ирэхүйд,
2. Хөмсөгөө зангидан буруу харав.
3. Чи яаж мэдэх юм бэ? Магад (чамаас сурсан хүмүүжлээрээ) тэр сэтгэлээ ариусгана, чин үнэнч хүн байх ч юм билүү?
4. Аль эсвэл сургамж сонсож хүмүүжих биз.
5. Харин одоо “өөрийгөө бүхнээс хангалуун” хэмээн бодогчын тухайд,
6. Тэдэн рүү хандах болно. (Ухуулга сургамж ярьж, анхааралдаа авна.)
7. Хэрэв тэр ариусахгүй юм бол чи яалтай ч билээ?
8. Харин Аллагаас айгаад чам руу гүйж ирсэн (сургамж авахаар) хүнд:
9. Анхаарал тавьдаггүй юм,
10. Чи түүнийг эс анзаарна.

11. Үгүй, тэгж болохгүй. Энэхүү айлдварууд (Куран) үнэндээ нэгэн сургамж болой.
12. Хүссэн хүн үүнээс сургамж авна.
13. Тэр бол (Кураны айлдварууд) үнэтэй, эрхэмсэг хуудасуудад бичээстэй; (Лаухил Махфуз)
14. Тэр дээгүүр үнэлэгдсэн элч мэлэжүүдийн гараар бичигдсэн ариун хуудасууд болой.
15. Тэр эрхэмсэг бичигсэдийн гар дээр буй.
16. Тэд хүндэт, буянтай болой.
17. Үл сүсэглэгсдийг хараал идэг. Тэр яахлаар бузар булай юм хийдэг юм бэ!
18. Аллах түүнийг юунаас бүтээсэн юм бол?
19. Нэгэн дуслаас бүтээгээд (хүн болох хүртэл) шатлан өгсүүлж, зугуухан хүн төрхтэй болгосон шүү дээ.
20. Тэгээд явах замыг нь хялбар болгож өгсөн.
21. Дараа нь амийг нь авч, булшинд оруулсан.
22. Дараа нь Аллах хүссэн үедээ дахин амилуулна.
23. Үгүй дээ! Тэд Аллахын тушаалыг зөрчидөг.
24. Одоо хүн төрөлхтөн өөрсдийнхөө хоол хүнсэндээ анхаарал тавиг!
25. Бид элбэг-дэлбэг хур бороог оруулсан.
26. Тэгээд газрын хөрсийг хагалав,
27. Тэнд үр тариаг ургуулсан;
28. Усан үзэм, хүнсний ногоог ч;
29. Мод, чидун жимс, хасарваанийг ч;
30. Ой мод, цэцэрлэгүүдийг ч;
31. Төрөл бүрийн жимс, өвс ургамалыг ч ургуулсан билээ.
32. Энэ бүхэн та нар болоод мал сүргийн чинь ашиг тусын тулд шүү дээ.
33. Чих дүжирүүлэх орь дуу ирэхүйд:
34. Тэр өдөр хүмүүс төрсөн ах дүүсээсээ;
35. Эцэг, эхээсээ;
36. Эхнэр, хүүхдээсээ зугтадаг болой.
37. Тэр өдөр хүн бүр хар толгойгоо бодож, зовцгооно.
38. Тэр өдөр зарим хүний царай гэрэлтэж,
39. Инээд, баяслын салхи сэвэлзэнэ.
40. Тэр өдөр зарим хүний нүүр тоос шороонд дарагдана.
41. Түнэр харанхуй нөмөрнө.

42. Тэд бол үл сүсэглэгсэд, нүгэлтэнгүүд болой.



## 81. СУРЕ ТАКУИР

Мекке-д илгээгдсэн. 29 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Нарны илч унтарсан цагт,
2. Одод нуран унасан цагт,
3. Уулс байрнаас хөдөлсөн цагт,
4. Хээлтэй ингэ хөсөр орхигдсон цагт,
5. Араатан амьтад үргэж цугларсан цагт,
6. Далай тэнгис буцлагдсан цагт,
7. Сүнс, махбодь нэгдсэн цагт,
8. Амьдаар булагдагсад (булагдсан охидын тухай) шүүгдэх цагт,
9. “Ямар нүглээр амь нас нь хороогдсон вэ?” гэж;
10. Үйлийн дэвтэр нээгдэхүйд,
11. Тэнгэрийн мандал хуулагдсан цагт,
12. Тамын гал өрдөгдсөн цагт,
13. Диваажин сүсэгтнүүдэд ойртуулагдсан цагт,
14. Хүн бүр өөрийн хийсэн (сайн-муу) үйлээ мэдэх болно.
15. Шөнө гэрэлтэн, өдөр нуугддаг оддоор тангараглая,
16. Нартай ойр учраас шөнө харагдахгүй урсан өнгөрөгч, нуугддаг ододоор тангараглая.
17. Харанхуйлах шөнөөр тангараглая,
18. Хаяаран гийгч үүрээр тангараглая,
19. Энэхүү Куран бол үнэхээр эрхэм нэгэн мэлэк Жабрейлаар дамжин айлдсан Аллахын айлдвар мөн.
20. Тэр (Жабрейл) сүр хүчийн эзэн, тэнгэрийн эзэн Аллахын өмнө эрхэм билээ.
21. Мэлэкүүд түүнд захирагдах бөгөөд тэр тэнд найдвартай нэгэн ажгуу.
22. Та нарын анд (Мухаммед) солиотой биш ээ.
23. Тэр түүнийг (Жабрейлыг) нар мандах зүгийн тэнгэрийн хаяанд харсан билээ.
24. Тэр далдын нууцыг уламжлахаас татгалзаагүй юм.
25. Тэр (Куран бол) хараал идсэн чөтгөр шуламын үг биш ээ.

26. Тэгвэл та нар хаашаа явцгааж байна вэ?
27. Тэр (Куран бол) бүхий л ертөнцөд ухаарал сургамж билээ.
28. Та нараас зөв шулуун замаар явахыг хүсэгсдэд сургамж болой.
29. Бүхий л ертөнцийн Эзэнтэн Аллах таалан соёрхохгүй бол та нар нэг ч зүйлийг болгоож чадахгүй.

## 82. СУРЕ ИНФИТАР

Мекке-д илгээгдсэн. 19 айлдвар.

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Тэнгэр хагарсан цагт,
2. Одод нуран унасан цагт,
3. Тэнгисүүд нийлэн урссан цагт,
4. Булш орвонгоор эргэж, үхэгсэд амилсан цагт,
5. Хүн бүр урьд хойно юуг үйлдсэнээ, юуг үйлдээгүйгээ мэднэ.
6. Аяа, хүмүүн! Өгөөмөр буянт Эзэнтний чинь эсрэг чамайг юу турхирсан вэ?
7. Тэр чамайг бүтээсэн, төлөвшүүлсэн, сайхан төрхтэй болгосон.
8. Өөрөө хүссэн дүр төрхийг чинь эвлүүлж өгсөн.
9. (Меккегийн үл сүсэгтнүүд ээ) Бүү тийм зүйл хийгтүн. Та нар шүүгдэх өдрийг үгүйсгэсэн шүү дээ.
10. Үнэндээ, та нарын дээр хянан ажиглагчид (хянагч мэлэкүүд) буй.
11. Тэд эрхэм бичээч нар болой.
12. Тэд та нарын үйлдэж буй бүхнийг мэдэж байдаг юм.
13. Эрхэмүүд эргэлзээгүй буян хишигт (диваажинд) умбана.
14. Танхай балмадууд тамд очино.
15. Тэд шүүн тунгаах өдөр тамын гал руу шидэгдэнэ.
16. Тэд тэндээс хэзээ ч зайлж чадахгүй.
17. Шүүн тунгаах өдөр юу болохыг чи мэдэх үү?
18. (Давган хэлье) Тэр шүүн тунгаах өдөр юу болохыг чи мэдэх үү?
19. Тэр бол хүмүүс бие биендээ ямар ч тус болохгүй өдөр. Тэр өдрийн эрх мэдэл гагцхүү Аллахад хамаарагдмуй.

## 83. СУРЕ МУТАФФИФИН

Мекке-д илгээгдсэн. 36 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Жин хэмжүүрээр залилагсад мөн ч хөөрхийлэлтгээ!
2. Тэд бусдаас хатуу хэмжиж, бүрэн авдаг.
3. Харин бусдын төлөө жинлэн хэмжихдээ дутуу өгдөг.
4. Тэд дахин амилна гэдэгт итгэдэггүй юм уу?
5. Тэрхүү аугаа өдөрт;
6. Хүмүүс бүхий л ертөнцсийн Эзэнтний өмнө цэх шулуун гарах болно.
7. Жинлэн хэмжихдээ бүү залилагтун. Нүгэлтэнгүүдийн үйлийн дэвтэр Сижжин дотор байх юм.
8. Сижжин гэж юу болохыг чи мэдэх үү?
9. Тэр бол нүгэлтэнгүүдийн хийсэн хэрэг бичигдсэн нэгэн дэвтэр мөн.
10. Үнэнийг үгүйсгэгдэд тэр өдөр мөн ч харамсалтаяа!
11. Тийнхүү шүүн тунгаах өдрийг үгүйсгэгчдэд шүү.
12. Түүнийг гагцхүү хэмээс хэтэрсэн нүгэлтэнгүүд л үгүйсгэдэг билээ.
13. Тэдэнд Бидний айлдварууд уншигдахуйд: “Энэ бол аль дивангарын үлгэрүүд” хэмээн хэлдэг.
14. Үгүй дээ! Тэд хийсэн хэргээсээ болж зүрх сэтгэл нь зэвэнд идэгдсэн хүмүүс.
15. Тийм ээ! Тэд үнэндээ тэр өдөр Эзэнтнээ харахаас өнгөрсөн хүмүүс.
16. Дараа нь тэд эргэлзээгүй там руу орох хүмүүс.
17. Улмаар тэдэнд: “Та нарын худал хэмээн үгүйсгэсэн зүйлс (там) чинь энэ шүү дээ” хэмээгдэнэ.
18. Үнэн. Сайчуудын үйлийн дэвтэр нь мэдээж Иллиюунд байх юм.
19. Иллиюун гэж юу болохыг чи мэдэх үү?
20. Тэр бол сайчуудын эрхэм үйлс нь бичигдсэн нэгэн дэвтэр болой.
21. Түүнийг Аллахад ойр мэлэжүүд гэрчилнэ.
22. Сайчууд элбэг-дэлбэг буян хишигт умбана.
23. Сэнтий дээр заларч, умбасан хишгээ харан тухална.
24. Тэдний умбасан жаргалын гэгээг царайлаг нүүрнээс нь таних болно.
25. Тэдэнд бөглөө нь тамгалагдсан дарсыг барина.
26. Түүнийг уусны дараа анхилам үнэр ханхлана. Шохоорхогсод байваас үүнийг шохоорхог!

27. Тэр нь “тасним” найрлагатай болой.
28. Тасним бол Аллахад ойр байгсадын уух диваажин дахь нэгэн булаг юм.
29. Эргэлзээгүй, нүгэлтэнгүүд сүсэглэгсэд рүү инээн дооглож асан билээ.
30. Тэд урдуур нь сүсэглэгсэд өнгрөхдөө бие бие рүүгээ нүд ирмэцгээдэгсэн.
31. Гэр лүүгээ харьсан (сүсэглэгсдийг шоолон тохуурхаснаар тачаал авч) инээн баясдагсан.
32. Тэд сүсэгтэнүүдийг харсан үедээ : “Жинхэнэ төөрөлдөгсөд мөн” хэмээдэгсэн.
33. Үнэндээ сүсэгтнүүдийг ажиглан хянагчаар тэднийг явуулаагүй юм шүү дээ.
34. Харин өнөөдөр (хойд ертөнцөд) сүсэгтнүүд үл сүсэглэгсэдийг шоолж элэглэнэ.
35. Тэд сэнтий дээрээ заларч, нүдний булангаар харж;
36. “Үл сүсэглэгсэд үйлдсэн хэргийнхээ хариуг амсах юм болов уу?” гэлцэнэ.

## 84. СУРЕ ИНШИКАК

Мекке-д илгээгдсэн. 25 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Тэнгэр хагарсан цагт,
2. Эзэнтэндээ захирагдсан, мөн түүнд мэхийн ёслоход зохистой болсон цагт,
3. Газар тэлж сунасан цагт,
4. Газар хэвлий дэхь бүхнийг (шарилууд болон баялагийг) уудлан хаяж, суларсан цагт, бүхэн шидэгдэж хоослогдохуйд,
5. Эзэнтэндээ захирагдсан, мөн мэхийн ёслоход зохистой болсон цагт (хүмүүний санаанд оромгүй асар аюултай байдалд тулгарна)
6. Аяа, хүмүүн төрөлхтөн өө! Эзэнтэнтэйгээ учрахын төлөө хичээн их зүтгэсээр байна вэ? Тийм ээ, эцэст нь Түүнтэй учирна.
7. Хэнд үйлийн дэвтэр баруун гар талаас нь өгөгдөнө.
8. Түүнтэй хийх тооцоо хялбар болно.
9. Тэр диваажинд буй гэр бүл рүүгээ баяр хөөр дүүрэн буцах болно.
10. Хэнд үйлийн дэвтэр ар нуруу талаас нь өгөгдөнө,
11. Тэр дуу алдан, харамсана.

12. Дүрэлзэх гал руу орно.
13. Учир нь тэр (амьд хорвоод) гэртээ хэнэггүй, баяр хөөр болон суудагсан.
14. Учир нь тэр хэзээ ч Эзэнтний өмнө очихгүй гэж боддог байлаа.
15. Үгүй дээ, Эзэнтэн нь түүнийг харж байсан шүү дээ.
16. Жаргах нарны шаргал гэрлээр тангараглая,
17. Шөнөөр, түүний нөмөрт байгсадаар тангараглая,
18. Арван тавны тэргэл сараар тангараглая,
19. Та нар нэг байдлаас нөгөөд нь шилжинэ.
20. Ийм байхад тэд юунд эс сүсэглэцгээнэ вэ?
21. Тэдэнд Куран уншигдахуйд юунд сөгдөн мөргөцгөөгүй вэ?
22. Эсрэгээр үл сүсэглэгсэд чин үнэнийг худал хэмээн үгүйсгэдэг.
23. Аллах тэдний сэтгэлийн гүнд нуусныг нь сайн мэднэ.
24. (Аяа, Элч минь!) Тэдэнд тарчилгах гэсгээлийн мэдээг дуулга!
25. Харин сүсэглэн итгэж, сайн үйл үйлдэгсэд хэд дахин илүү, барагдашгүй буян хишиг хүртээнэ.



Мекке-д илгээгдсэн. 22 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Ододтой тэнгэрээр тангараглая,
2. Амлагдсан өдрөөр тангараглая,
3. Гэрчлэгч хийгээд гэрчлүүлэгчээр тангараглая,
4. Хэндэкийн (дүрэлзэх галаар дүүргэсэн агуйн) эздийг хараал идэг,
5. Тэр агуй зогсолтгүй дүрэлзсэн галтай болой.
6. Тэр үед тэд гал дүрэлзсэн агуйн дэргэд сууцгаана,
7. Тэгээд сүсэгтнүүдэд үйлдсэнээ өөрсдийн нүдээр харах болно.
8. Тэд ялагдашгүй, магтаалын эзэн Аллахад итгэсний төлөө сүсэгтнүүдэд өширхсөн юм.
9. Тэр бол тэнгэр, газрын эзэгнэл өөрт нь хамаарагдсан Аллах билээ. Аллах бүхнийг харж байдаг.
10. Сүсэгтэн эрэгтэй, эмэгтэйчүүдэд хор хөнөөл үзүүлэн, санаагаа өөрчлөлгүйгээр, эс наминчлагсад тамд гэсгээгдэн, халуун галд нь шатах болно.



11. Харин сүсэглэн итгэж, сайн үйл үйлдэгсэд хаяагаар нь булаг урсах диваажинд орно. Энэ бол хосгүй ололт мөн.
12. Эзэнтний чинь сүр хүч харьшгүй билээ.
13. Тэр хоосноос бий болгон бүтээгээд (үхсэний дараа) дахин амилуулна.
14. Тэр мусулмануудын нүгэлийг өршөөгч хийгээд нэн хайрлагч болой.
15. Арш буюу сансар огторгуйн эзэн бөгөөд нэн их эрхэмсэг Аллах ажгуу.
16. Тэр зорьсон бүхнээ гуйвалтгүй гүйцэтгэнэ.
17. (Аяа, Мухаммед) Чамд дайчдын тухай мэдээ ирсэн үү?
18. Фиргаун болон Самүдийн дайчдын тухай юм шүү.
19. Тийм ээ! Үл сүсэглэгсэд зөрүүдлэн эсэргүүцэж, Аллах болон чамайг худал хэмээн үгүйсгэсээр л байна.
20. Аллах тэднийг араас нь тойрон бүсэлсэн байгаа.
21. (Харин ч тэд үгүйсгэсэн) Тэр нь аугаа их Куран мөн билээ.
22. Тэр Лаухил-махфузд хадгалагдсан буй.

## 86. СУРЕ ТАРИК

Мекке-д илгээгдсэн. 17 айлдвар

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Тэнгэр хийгээд Тарикаар тангараглая,
2. Тарик гэж юу болохыг чи яаж мэдэх вэ?
3. Тэр бол нэгэн гэрэлт од мөн.
4. Хүн бүр нэгэн хамгаалагчтай (ажиглан хамгаалдаг) мэлэкүүдтэй байдаг билээ.
5. Хүмүүн юунаас бүтээгдсэнээ нэг хараг!
6. Год үсрэн гардаг үрийн нэгэн душлаас бүтээгдсэн болой.
7. Тэр дусал нь цээр нуруу болон хавиргын толгойн завсраас гардаг юм.
8. Ийнхүү Аллахын хүч чадал хүмүүнийг дахин бүтээхэд ч хүрмүй.
9. Далд нууц бүхэн илрэх тэр өдөр,
10. Хүмүүнийг гэгсгээлээс нь аврагч, эсвэл нэг туслагч үгүй болой.
11. Хуртай тэнгэрээр тангараглая,
12. Хагдарсан газраар тангараглая,
13. Куран үнэндээ (хар, цагааныг) тунгаан ялгагч нэгэн үг мөн.
14. Тэр хошин шог биш шүү дээ.

15. Үл сүсэглэгсэд үнэндээ заль мэх сэдэцгээнэ,
16. Би ч тэдний эсрэг заль мэх зэхнэ.
17. (Аяа, Мухаммед) Чи үл сүсэглэгсэдэд боломж өг, бага ч гэсэн эрх эдлүүл.



87. СУРЕ АГЛА

Мекке-д илгээгдсэн. 19 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Аугаа их Эзэнтнийхээ алдарыг шагшин магт.
2. Тэр бүхий л зүйлийг бүтээж, зохистойгоор төлөвшүүлсэн юм.
3. Тэр бүхий л юмны хувь тавиланг тодорхойлж, явах замыг нь зааж өглөө.
4. Тэр өвс ногоог ургуулсан.
5. Дараа нь хорчийлгон хатааж хог болгов.
6. (Аяа, Мухаммед!) Бид чамаар Кураныг уншуулах бөгөөд чи Аллахын зориуд маргуулснаас бусдыг нь мартах учиргүй.
7. Аллах ил, далд бүхнийг мэдэж байдаг.
8. Бид чамайг (шашны итгэл үнэмшлийн) хялбар замаар амжилтанд хүргэнэ.
9. Хэрэв ухуулга сургамж зохистой байвал (Куранаар) ухуулагтун.
10. Аллахаас айдаг хүмүүс ухуулга сургамжыг авна.
11. Аз нь харьсан хүмүүс түүнээс зайлсхийнэ.
12. Ийнхүү тэд аюулт тамын гал руу орно.
13. Тэнд үхсэн, амьдын завсар байх болно.
14. Бардамнал, нүгэлээс ангид ариун сэтгэлтэй хүн зорьсондоо хүрнэ.
15. Тэр Эзэнтнийхээ алдарыг санан дурсаж, уншлага мөргөлөө үйлдэгч болой.
16. Гэвч та нар энэ зуурдын амьдралыг илүүтэйд үздэг.
17. Харин хойд ертөнц илүү өлзийтэй, үүрдийнх шүү дээ.
18. Энэхүү заалтууд өмнөх судруудад ч тайлбарлагдсан.
19. Гэгээн Ибрахим хийгээд Мусагийн судруудад.

## 88. СУРЕ ГАШИЯ

Мекке-д илгээгдсэн. 26 айлдвар.

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. (Аяа, Мухаммед!) Чамд Алив бүхнийг нэрвэгч аюулын (ертөнцийн төгсгөлийн) мэдээ ирсэн үү?
2. Тэр өдөр олон хүний царайнд айдасын тэмдэг илэрнэ.
3. Тэд (мухар сүсэгтэнүүд) амьд ахуйд хичээн зүтгэсэн ч хойд ертөнцийн гэгсгээлээр цээрлүүлэгсэд.
4. Тэд дүрэлэн асах гал руу орно.
5. Бургилан буцлах уснаас ууна.
6. Тэдэнд гашуун өргөснөөс өөр хоол өгөгдөхгүй.
7. Өргөс тэнхээ ч өгөхгүй, хоол ч болохгүй.
8. Тэр өдөр сүсэглэгсэдийн царайнд баяр баясгалангийн тэмдэг илэрнэ.
9. Тэд хийснийхээ төлөө сэтгэл хангалуун байна.
10. Тэд эрхэм дээд диваажинд байх юм.
11. Ямар ч үед хангинах үг сонсохгүй.
12. Тэнд ариун тунгалаг булагууд урсана.
13. Диваажин дотор өндөрлөг сэнтийнүүд,
14. Өрөөстэй аяганууд,
15. Эгнүүлэн тавьсан түшлэг дэрнүүд,
16. Дэвссэн хивс, зассан орнууд буй.
17. Тэд тэмээ хэрхэн бүтээгдснийг анзаарахгүй гэж үү?
18. Тэнгэрийн хэрхэн өргөгдснийг,
19. Уулс хэрхэн сүндэрлэснийг,
20. Газар хэрхэн дэлгэгдснийг харахгүй гэж үү?
21. (Аяа, Мухаммед!) Чи тэднийг ухуул. Учир нь чи гагцхүү ухуулан сэнхрүүлэгч мөн.
22. Чи тэднийг шашинд албадагч биш ээ!
23. Харин хэн нэгэн ухуулгаас татгалзан, Аллахын эсрэг гарвал,
24. Аллах түүнийг хүнд, агуу гэгсгээлээр цээрлүүлнэ.
25. Тэд эргэлзээгүй Бидний өмнө ирэх болно.
26. Тэгээд Бид шүүн, тооцоо хийнэ.

## 89. СУРЕ ФАЖИР

Мекке-д илгээгдсэн. 30 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье***

1. Гэгээрэн цайх үүрээр тангараглая,
2. (Хаж мөргөлийн сарын) арван шөнөөр,
3. Тэгш болон сондгойгоор,
4. Чимээгүйхэн өнгөрсөн шөнөөр тус тус тангараглая.
5. Энэ бүхэн оюун ухааны эздийн хувьд тангараглахад хангалттай байх биз.
6. Эзэнтэн чинь Гадын ардуудад юу хийснийг харсан биз дээ.
7. Өндөр баганти (хот) Ирамынханд байсан.
8. Тийм суурин бусад хотуудад бүтээгдээгүй юм. (Түүнийг хэрхэснийг харсан биз дээ?)
9. Түүнчлэн, (Уадилкура хэмээх хавцал дахь) элгэн хадыг ухаж гэр орон болгосон Самүдийн ардийг ч хэрхэснийг харсан биз дээ?
10. Тэрчлэн гадасны эзэн Фиргауныг хэрхэн цээрлүүлэв ээ?
11. Тэд нутагтаа дур зоргоор аашлан бардамнасан юм.
12. Мөн тэнд олон удаа үймээн самуун дэгдээсэн билээ.
13. Тиймээс Эзэнтэн чинь тэдэнд гэгсгээлийн ташуураа буулгасан.
14. Эзэнтэн чинь уул шугамандаа агшин бүрийг (хүмүүсийг) ажиглагч билээ.
15. Хүн гэдэг амьтан Эзэнтэн нь сорьж, хүндтэй-нэр төртэй болговол, ивээн тэтгэвэл: “Эзэнтэн маань намайг нэр төртэй болголоо” хэмээдэг.
16. Харин түүнийг сорьж, хувь хишгийг нь багасгавал : “Эзэнтэн маань намайг дорд үзлээ” хэмээдэг.
17. Үгүй дээ, үнэндээ та нар өнчин өрөөснийг халамжилдаггүй.
18. Өвчтөн, ядуусыг хооллуулах талаар бие биенээ ухуулдаггүй.
19. Өвлөсөн зүйлийг (Халал-харам, ариун-бузар) үл тоон гулгуулцгаадаг.
20. Мал хөрөнгөнд хэтэрхий дуртай билээ.
21. Тэгж болдоггүй юм. Газар зай завсаргүй чичирхийлэхэд;
22. Эзэнтний чинь зарлиг болон мэлэжүүд нэгэн зэрэг жагсан ирсэн цагт;
23. Халуун там тохиож, хүмүүнд яг л тэр мөчид ухаарал төрнө. (хийсэн хэргээ сая л санана) Гэвч энэ нь түүнд ямар нэгэн тус болно гэж үү?

## 90. СУРЕ БАЛАД

24. “Даанч яав даа, хожмийн энэ амьдралынхаа төлөө амьд ахуйдаа сайн сайхан зүйл хийх минь яав!” хэмээн харамсана.
25. Ийнхүү тэр өдөр нүгэлтэнгүүдийг хэн ч Аллахын адил гэгсгээж чадахгүй.
26. Мөн хэн ч Аллахын адил Түүнийг дөнгөлж чадахгүй.
27. Аяа, сэтгэлийн амгаланд хүрэгсэд ээ!
28. Чи Эзэнтэндээ талархсан, Эзэнтэн чинь чамд талархсан байдалтайгаар Түүний өмнө очигтун!
29. Миний үнэнч боолуудын эгнээнд нэгдэгтүн!
30. Миний диваажинд орогтун!

## 90. СУРЕ БАЛАД

Мекке-д илгээгдсэн. 20 айлдвар.

### *Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье*

1. Энэхүү хотоор (Мекке) тангараглая,
2. (Аяа, Мухаммед!) Өөрөө оршин суугаа (энд ариун дайн хийсэн) хот болой.
3. Эцэг болон түүний үр садаар тангараглая,
4. Бид үнэндээ хүмүүнийг зовлон (сорилын) дунд бүтээсэн юм.
5. Тэр өөрийнх нь эсрэг хэний ч хүч чадал эс хүрнэ хэмээн бодож байна уу?
6. Тэр : “Би их мал хөрөнгөө зарцуулсан” хэмээнэ.
7. Түүнийг (их мал хөрөнгө зарцуулсныг) хэн ч хараагүй хэмээн бодно уу?
8. Бид түүнд хоёр нүд хайрлаагүй сэн билүү?
9. Нэг хэл, хоёр уруул заяагаагүйсэн билүү?
10. Түүнд (сайн, муу) хоёр замыг харуулсан биз дээ?
11. Тэр давааг давж чадаагүй.
12. Даваа юу болохыг чи мэдэх үү?
13. Энэ нь нэг ч гэсэн боолыг чөлөөлөх явдал мөн.
14. Үгүй бол, өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүсийг,
15. Ойр дотны өнчин өрөөсөнг,
16. Аль эсвэл амаараа шороо үмхсэн ядуус, өвчтөнүүдийг хооллуулах гэсэн үг юм шүү!

17. Мөн тэрчлэн итгэн сүсэглэж, нэг нэгэндээ тэвчээртэй байхыг ухуулагсад, бас нэг нэгэндээ энэрэлтэй байхыг зөвлөгсөд;
18. Тэд бол үйлийн (амал) дэвтэр нь баруун (зөв) талаас нь өгөгдөгсөд билээ.
19. Бидний айлдваруудыг үгүйсгэгсэд бол үйлийн (амал) дэвтэр нь зүүн (буруу) талаар нь өгөгдсөн бүтэлгүйчүүд болой.
20. Тэд хаалгыг нь битүүмжилсэн битүү там руу орох болно.



**91.СУРЕ ШАМИС**



Мекке-д илгээгдсэн. 15 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Алладын алдраар эхэлье.***

1. Нар болон түүний гэрлээр тангараглая.
2. Нарыг дагасан сараар тангараглая.
3. Нарыг тосон авсан өдрөөр тангараглая.
4. Нарыг халхалсан шөнөөр тангараглая.
5. Тэнгэр болон түүнийг бүтээгчээр тангараглая.
6. Газар хийгээд түүнийг дэвсэн дэлгэгчээр тангараглая.
7. Амиар (хүсэл тачаал), түүнийг бататгагчаар тангараглая.
8. Түүнд нүгэл, буян хоёрыг ялган өгөгчөөр тангараглая.
9. Өөрийгөө ариусгагчид гарцаагүй хүсэл зорилгоо хангаж, аз жаргал олно.
10. Өөрийгөө бузарлан хиртүүлэгсэд хоосон хоцроно.
11. Самудын ардууд хэмээс хэтэрснээс чин үнэнийг үгүйсгэсэн билээ.
12. Тухайн үед тэдний дотрох нэгэн золгүй амьтан ер бусын гайхамшиг болгосон ингэн тэмээг алахыг завдахад,
13. Алладын гэгээн элч (Салих) тэдэнд хандан : “Алладын ингэний ус уухад нь бүү саад бологтун” хэмээн сануулсан юм.
14. Гэвч тэд түүнийг (Салихыг) хүлээн зөвшөөрөөгүйгээр ингийг алсан билээ. Энэхүү хэргийнхээ улмаас нь тэднийг нэг мөсөн сүйрүүлж, бүгдийг нь газартай тэгшилсэн нь тэр ээ!
15. Аллах эцсийн уршигаас айдаггүй юм.

## 92. СУРЕ ЛАЙЛ

Мекке-д илгээгдсэн. 21 айлдвар.

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Ертөнцийг харанхуйгаар бүрхсэн цагт шөнөөр тангараглая.
2. Гэгээрэн гэрэлтсэн цагт өдрөөр тангараглая.
3. Эр, эм хоёрыг бүтээгчээр тангараглая.
4. Та нарын үйл зүтгэл бүхэн адилгүй билээ.
5. Хэн мал хөрөнгөө Аллахын төлөө өглөг болгон, Аллахаас айвал,
6. Аллахын цорын ганц гэдэгт итгэн, зөвшөөрвөл,
7. Бид түүний хамгийн хялбард (диваажинд) хүрэх замыг дардан болгомой.
8. Хэн харамч сэтгэл гарган, Аллахын буяныг өөртөө хэрэггүй гэж үзвэл,
9. Аллахын цорын ганц, хосгүйг үгүйсгэвэл,
10. Түүний хамгийн бэрхшээлтэйд (тамд) хүрэх замыг дардан болгомой.
11. Тэр там руу унасан цагт эд баялаг нь өөрт нь ямар ч тус болохгүй.
12. Тэрхүү дардан зам руу чиглүүлэх нь Бидний үүрэг билээ.
13. Энэ хорвоо болон хойд ертөнцийн ид шид гагцхүү Бидний гарт (эрхшээлд).
14. Тиймээс хүмүүнийг тамын дүрэлзсэн галаас сэрэмжлүүлмүй.
15. Түүн руу гагцхүү золгүй амьтад л орох болно.
16. Тэд ертөнцийн төгсгөлийг үгүйсгэн, сүсэглэхээс нүүрээ буруулагчид болой.
17. Тамын галаас ангирагдсан нь хамгийн илүүгээр гэгээн сүсэглэгч мөн.
18. Тэр мал хөрөнгөө Аллахын замд чин сэтгэлээс зарцуулсан болой.
19. Түүний хувьд бусдаас нэхэмжлэх ямарч хувь хишиг үгүй. (Түүний мал хөрөнгөө үрэх нь бусдын ачыг хариулахын төлөө биш ээ)
20. Гагцхүү аугаа Эзэнтнийхээ тааллыг хүртэхийн тулд ийнхүү зарцуулдаг юм.
21. Хожим тэр ч гэсэн (Эзэнтнийхээ хүргээх хувь хишигт) талархах болно.

93. СУРЕ ДУХА (ЗУХА)

Мекккe-д илгээгдсэн. 11 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Өглөөний цагаар тангараглая.
2. Нам-гүм шөнөөр тангараглая.
3. (Аяа, Мухаммед!) Эзэнтэн чинь чамайг орхиогүй, чамд гомдоогүй.
4. Мэдээж, чамд амьд ахуйг бодвол хойд ертөнц илүү элзийтэй.
5. Эзэнтэн чинь чамд мөдхөн (хойд ертөнцөд) хишгийг хүртээнэ. Чи ч түүнд талархах болно.
6. Чамайг өнчин хэмээн нөмөр нөөлөг болоогүй гэж үү?
7. Зовж зүдэрснийг чинь хараад зөв замд залаагүй гэж үү?
8. Чамайг үгээгүй ядуу байхад баяжуулаагүй гэж үү?
9. Тиймээс чи өнчинг бүү дорд үз!
10. Бадар баригчийг бүү зэмэл!
11. Эзэнтнийхээ чамд хүртээсэн хайр хишгийн тухай олонд дэлгэн ярь.

94. СУРЕ ИНШИРАХ

Мекккe-д илгээгдсэн. 8 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Аяа, Мухаммед! Бид чиний зүрх сэтгэлийг нээн уужруулаагүй билүү?
2. Бид чиний нуруун дахь ачааг авч хаяагүйсэн билүү?
3. Тэр ачаа чиний нурууг бөгтийлгөсөн биз дээ.
4. Бид нэр төрийг чинь өргөмжилсөн юм.
5. Мэдээж, зовлон бэрхшээл байгаа газарт амар амгалан ч байдаг.
6. Давтан сануулая: Зовлон бэрхшээл байгаа газарт амар амгалан ч байдаг.
7. Зав л гарвал нэгэн үйлийг хий.
8. Бүхнийг бүтээгч рүүгээ чиглэн залбирагтун.



## 95. СУРЕ ТИН

Мекке-д илгээгдсэн. 8 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Бибал болон чидун жимсээр тангараглая.
2. Сина уулаар тангараглая.
3. Энэхүү аюулгүй (Мекке) хотоор тангараглая.
4. Үнэндээ Бид хүмүүнийг хамгийн төгс сайхан бүтээсэн юм.
5. Дараа нь Бид түүнийг адгийн адагт оруулсан,
6. Гагцхүү сүсэглэн итгэж, сайн үйл үйлдэгсэд үүнээс өөр билээ. Тэдэнд барагдашгүй буян хишиг буй.
7. Аяа, хүмүүс ээ! Ийнхүү үүнээс (ил тод нотолгоонууд харуулснаас) хойш, ертөнцийн төгсгөлийн өдрийг үгүйсгэх ямар үндэслэл чинь байна вэ?
8. Аллах хамгийн шударга шийдвэр гаргагч биш гэж үү?

## 96. СУРЕ ГАЛАК

Мекке-д илгээгдсэн. 19 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Бүтээгч Эзэнтнийхээ алдраар унш!
2. Тэр хүмүүнийг цусны бөөмнөөс бүтээсэн.
3. Унш! Эзэнтэн чинь нэн эрхэмсэг.
4. Тэр үзэгээр бичихийг сургасан.
5. Хүмүүнд мэдэхгүйг нь мэдүүлсэн.
6. Гэсэн ч хүмүүс төөрөх юм.
7. Өөрийгөө гачигдах юмгүй, баян хэмээн бодно.
8. Аяа, хүмүүн! Эргэж очих газар чинь Аллахын нигур дор шүү дээ.
9. (Аяа, Мухаммед!) Чи, тэр саад учруулагчийг харсан уу?
10. Тэр уншлага мөргөл үйлдсэн хүнд саад болдог.
11. Тэр (уншлага мөргөл үйлддэг Мухаммед) зөв зам дээр байсан ч;
12. Гэгээн сүсэгтэн байсан ч, түүнд саад болохыг оролдогчийг харсан уу?
13. Кураныг үгүйсгэж, итгэн сүсэглэхээс нүүр буруулсан атал (сүсэглэн

## 97.СУРЕ КАДР

гэмшихийн оронд) бусдын уншлага мөргөл үйлдэхийг хориглохыг харсан уу?

14. Аллах өөрийг нь харж байгааг мэдэхгүй гэж үү?
15. Үгүй! Хэрэв үүнийгээ эс болих аваас, Бид түүнийг там руу үстэн чирэх болно.
16. Тэр худалч, нүгэлтэнг үстэн чирнэ.
17. Тэр ч анд нөхдөө (туслалцуулахаар) дуудаг.
18. Бид ч даруйхан Забаничуудыг (тамын хатуу гартай гэгсгээлийн мэлэжүүдийг) дуудах болно.
19. (Ийм танхайчууд) санаагаа засаг! Чи тэдэнд бүү бууж өг! Аллахад сөгдөн мөргөж, Түүн рүү ойрт!

## 97.СУРЕ КАДР

Мекке-д илгээгдсэн. 5 айлдвар.

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Бид үнэндээ Кураныг Кадр шөнө буулгасан юм.
2. Кадр шөнө гэж юу болохыг чи мэдэх үү?
3. Кадр шөнө нь буян хишгийн хувьд мянган сараас ч илүү өлзийтэй.
4. Тэр шөнө Аллагаас заяасан бүхий л үйл хэргийг гүйцэтгэхээр Эзэнтнийхээ зарлигаар мэлэжүүд болон Жабрейл газар дээр бууж ирнэ.
5. Тэр шөнө үүр хаяартал амгалан энхийн шөнө байх болно.

## 98.СУРЕ БАЙИНА

Мекке-д илгээгдсэн. 8 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Яруу тод нотолгуунууд өөрсдөд нь ирэх хүртэл судрын эзэд болон олон бурхан шүтэгсэд өөрсдийн мухар сүсэгээс салж чадахгүй юм.
2. Яруу тод нотолгоо бол бичвэрүүдийг агуулсан чин үнэн цэвэр хувилбаруудыг тэдэнд уншиж өгөх Аллахын зүгээс илгээгдсэн гэгээн элч байлаа.
3. Тэр бичвэрүүдэд хамгийн үнэн шударга шийдвэрүүд буй болой.

4. Судрын эзэд (иудэйчүүд болон христчүүд) өөрсдөд нь яруу тод нотолгоо ирсэний дараа хоорондоо зөрчилдөн хуваагдсан билээ.
5. Хэрэг дээр тэд чин үнэн шашинаас гуйвахгүйгээр Аллахад талархаж, Түүнд сүсэглэн мөргөх, уншлага мөргөлөө үйлдэх, ариуслын өглөгөө өгөхөд тушаагдсан билээ. Жинхэнэ чин шударга шашин энэ болой.
6. Судрын эзэд хийгээд олон бурхан шүтэгсэдээс гаралтай нүүр буруулагсад нь тамын галд орж, тэндээ эгнэгт оршмуй. Тэд амьд амьтадын хамгийн адаг нь мөн.
7. Харин сүсэглэн итгэж, сайн үйл үйлдэгсэд бол амьд амьтадын хамгийн эрхэм нь мөн.
8. Тэдэнд Эзэнтний өмнө өгөгдөх шагнал, хаяагаар нь булаг урсах Гадын диваажингууд байх бөгөөд тэд тэнд үүрд оршино. Аллах тэдэнд таалалтай, тэд ч Аллахад талархалтай байх болно. Энэ нь зөвхөн Эзэнтнээсээ айхсадад оногдох хувь болой.



Мекке-д илгээгдсэн. 8 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Газар хүчтэй хөдлөн доргиход,
2. Газар хэвлийдээ агуулсан (ашигт малтмал, уурхай, үхэгсэдийн шарил, бусад) хүнд ачаагаа гадагш сэгсрэн гаргахад,
3. Хүмүүс ялангуяа үл сүсэглэгсэд “Газар яасан болоо” хэмээхэд,
4. Тэр өдөр газар өөрийн нуруун дээр байсан сайн, муу үйлсийн талаар мэдээлнэ.
5. Энэ нь түүнд Эзэнтний чинь өгсөн айлдвар юм.
6. Тэр өдөр хүмүүс үйлдсэн бүхнийхээ үр дүнг үзэхээр бөөн бөөнөөрөө гарч ирнэ.
7. Хэн нэгэн хумхын тоосын чинээ (өчүүхэн төдий) буян үйлдсэн бол түүнийхээ шанг хүртэнэ.
8. Хэн нэгэн хумхын тоосын чинээ (өчүүхэн төдий) нүгэл үйлдсэн бол түүнийхээ гэсгээлийг үзнэ.

100.СУРЕ ГАДИЯТ

Мекке-д илгээгдсэн. 11 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Довтлон явагч морьдоор тангараглая,
2. Туурайгаар нь цахиур хаглагч морьдоор тангараглая,
3. Үүрээр гэнэт довтлогч морьдоор тангараглая,
4. Тоос манаргагч морьдоор тангараглая,
5. Дайсны дунд дайран орогч морьдоор тангараглая,
6. Үнэндээ хүмүүн Эзэнтнийхээ эсрэг харалган зантай.
7. Үүнд өөрсдөө ч гэрч болно.
8. Тэд эд баялагт хэтэрхий шунахай юм.
9. Тэд: булшинд байгсад хуу гаргагдахад,
10. Дотроо нуусан бүхэн ил болоход,
11. Тэр өдөр Эзэнтэн нь тэдний байдлын талаар бүрэн мэдээлэлтэй байхад, тэд энэ бүхнийг мэдэхгүй байна гэж үү?

101.СУРЕ КАРИГА

Мекке-д илгээгдсэн. 11 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Карига-түгшүүртэй явдал (ертөнцийн төгсгөл)
2. Карига (түгшүүртэй явдал) гэж юу вэ?
3. Карига буюу түгшүүртэй явдал гэж юу болохыг чи мэдэх үү?
4. Тэр өдөр хүмүүс үргэн ниссэн эрвээхэйн адил болно.
5. Уулс алаглуулан зулсан ноосны адил болно.
6. Хэний сайн үйлс нь муугаасаа илүү жин дарвал,
7. Тэр (элбэг баян диваажинд) сэтгэл хангалуун амьдарна.
8. Харин хэний муу үйлс нь илүү жин дарна,
9. Түүний очих газар нь хауия буюу ёроолгүй ангал байх болно.
10. Хауия буюу ёроолгүй ангал гэж юу болохыг чи мэдэх үү?
11. Тэр дүрэлзсэн гал болой.

## 102. СУРЕ ТАКАСУР

Мекке-д илгээгдсэн. 8 айлдвар

**Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.**

1. (Мал хөрөнгө, ам бүлийн төлөөх) Өрсөлдөөн та нарыг харамсал дунд үлдээв. (завгүй болгож Аллахад итгэн залбирахаас холдуулав)
2. Булшинд орон ортлоо. (Үхэх хүртэл)
3. Үгүй! Мөдхөн мэднэ.
4. Үгүй дээ, үгүй! Бүр удахгүй мэднэ.
5. Үнэхээр баттай мэднэ. (Иймд бүү харамса)
6. Та нар гарцаагүй тамтай учрах болно.
7. Улмаар түүнийг өөрсдийн нүдээрээ үзнэ.
8. Дараа нь тэр өдөр амьд ахуйдаа эдэлсэн эд баялагаас болж асуугдах болно.

## 103. СУРЕ ГАСЫР

Мекке-д илгээгдсэн. 3 айлдвар.

**Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.**

1. Гасыраар буюу эрин зуунаар тангараглая,
2. Хүмүүс хор хөнөөл дунд буй.
3. Сүсэглэн итгэж, сайн үйл үйлдэгсэд, нэг нэгэндээ чин үнэнийг, хатамжит тэвчээрийг гэрээслэн зөвлөгсөд өөр байх юм.

## 104. СУРЕ ХУМАЗА

Мекке-д илгээгдсэн. 9 айлдвар

**Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.**

1. Хутган үймүүлж, ховлогсодын хувьд мөн ч харамсалтаяа!
2. Тэр мал хөрөнгөө аривуулан, түүнийгээ тоолж, бөөсийлснөөр цагаа бардаг.
3. Мал, хөрөнгө нь өөрийгөө мөнхрүүлнэ хэмээн боддог.

## 105.СУРЕ ФИЛ

4. Тийм биш ээ! Тэр нь Хутама руу шидэгдэх болно.
5. Хутама гэж юу болохыг чи мэдэх үү?
6. Тэр Аллахын асаасан гал мөн.
7. Бие эрхтэнг түлж хуйхална.
8. Тэд маргаангүй тэр гал дотор хашигдах болно.
9. Өндөр баганд дөнгөлөгдөнө.

## 105.СУРЕ ФИЛ

Мекке-д илгээгдсэн. 5 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. (Аяа, Мухаммед!) Эзэнтэн чинь зааны эздийг хэрхэснийг харсан уу?
2. Тэдний заль мэхийг буд ниргэсэн шүү дээ.
3. Тэдэн рүү сүрэг сүрэг шувуудыг илгээв.
4. Шувууд тэднийг шатаасан шавран чулуугаар нүүлгэв.
5. Ийнхүү бут ниргэн, сийчүүлсэн тариан талбай мэт болгосон юм.

## 106.СУРЕ КУРАЙШ

Мекке-д илгээгдсэн. 4 айлдвар

***Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.***

1. Курайш нарын энх амгалангийн төлөө,
2. Тэдний өвөл, зуны аян замын аятай тухтай байхын төлөө,
3. Тэд Кагбагийн Эзэнд залбираг!
4. Эзэнтэн тэднийг өлсгөлөнгөөс аварч, аюулаас хамгаалсан билээ.

## 107. СУРЕ МАГУН

Мекке-д илгээгдсэн. 7 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Шашныг (шүүн тунгаах өдөрийг) худал хэмээн үгүйсгэгсэдийг чи харсан уу?
2. Тэр өнчин өрөөснийг дарамталдаг юм.
3. Ядуу зүдүүг хооллуулах дургүй.
4. Тийм атал уншлага мөргөл үйлдэгсэд шившигтэй!
5. Тэд уншлага мөргөлийг ёс төдий үйлддэг.
6. Хуурамч дүр эсгэн, хоосон нэр төрийн төлөө уншлага мөргөлөө үйлддэг.
7. Аахар шаахар хэрэглээний зүйлийг ч солилцохоос харамлана.

## 108. СУРЕ КАУСАР

Мекке-д илгээгдсэн. 3 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Бид чамд Каусарыг (диваажин дахь булаг, хишиг, эрдэм, энэрэл) зориулав.
2. Чи Эзэнтнийхээ төлөө уншлага мөргөл үйлд, тахил өргө.
3. Чамайг дутуу үнэлсэн дайсанууд чинь үр удам тасран, мөхнө.

## 109. СУРЕ КАФИРУН

Мекке-д илгээгдсэн. 6 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. (Аяа Мухаммед!) Тэдэнд ийнхүү хэлэгтүн : “Аяа, үл сүсэглэгсэд ээ!”
2. Би та нарын тахин шүтсэн зүйлд сүсэглэн мөргөхгүй.
3. Та нар ч миний залбирсанд (Аллахад) сүсэглэн залбирдаггүй шүү дээ.
4. Би та нарын тахин шүтсэн зүйлд угаасаа сүсэглэн мөргөөгүй юм шүү.
5. Та нар ч миний залбирсанд (Аллахад) сүсэглэн залбирдаггүй шүү дээ.

6. Иймээс, та нарын шашин өөрт чинь, миний шашин өөрт минь байх болой.

### 110.СУРЕ НАСЫР

Мекке-д илгээгдсэн. 3 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Аллахын тусламж болон аугаа ялалт ирэхүйд,
2. Аллахын шашинд хүмүүс бөөн бөөнөөрөө орж буйг харахуйд,
3. Эзэнтнээ сайшаан магтаалаа зориул. Түүнээс уучлал гуй! Үнэндээ Аллах наминчлалыг хүлээн авагч билээ.

### 111.СУРЕ ТАББАТ

Мекке-д илгээгдсэн. 5 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. Абу Лэхабийн хоёр гар хатаж хорчийг! Хэлсэн хэлээгүй тийм л болсон юм.
2. Мал, хөрөнгө, хийсэн бүхэн нь түүнд ямар ч тус болсонгүй.
3. Тэр эргэлзээгүй дүрэлзэн асах галд шатах болно.
4. Түүний ховч эхнэр нь ч түлээ үүрэн галд нэмэрлэж, тамд шатах болно.
5. Түүний хүзүүнд хасарваань модны хулсаар томносон бөх бат уяа зүүгдэх болно.

### 112.СУРЕ БЫХЛАС

Мекке-д илгээгдсэн. 4 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. (Аяа, Мухаммед) Ийнхүү хэлэгтүн : “Аллах бол цорын ганц”
2. Аллах ашид мөнх.
3. Тэр төрөөгүй, төрүүлээгүй.
4. Түүнтэй эн зэрэгцэх юу ч үгүй.



113.СУРЕ ФАЛАК

Мекке-д илгээгдсэн. 5 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. (Аяа, Мухаммед) : “Үүрийн гэгээний Эзэнтэнд:
2. Түүний бүтээсэн муухай бүхний хор нөлөөнөөс,
3. Түнэр харанхуй нөмөрсөн шөнийн хорлолоос,
4. Зангилаанд шившин тарнидсан гай барцадаас,
5. Атаархагчдын атаархлын цагаан хэл амнаас хамгаалаг хэмээн залбирна” гэж хэл.

114.СУРЕ НАС

Мекке-д илгээгдсэн. 6 айлдвар

*Машид энэрэлт, нэн нигүүлсэнгүй Аллахын алдраар эхэлье.*

1. (Аяа, Мухаммед!) : “Хүмүүний Эзэнтэнд,
2. Хүмүүний эзэн хаанд,
3. Хүмүүний эзэн бурханд,
4. Шивир-авир ярьж, ховлогчийн гай барцадаас авраг хэмээн залбирна” гэж хэлэгтүн.
5. Тэр хүмүүний зүрх сэтгэлд эргэлзээ төрүүлдэг.
6. Тэрхүү эргэлзүүлэгчид нь буг чөтгөр болон хүмүүсээс гаралтай.

# КУРАН СУДРЫН СУРЕ БУЮУ БҮЛЭГҮҮДИЙН ТОВЬЁОГ

дугаар	Сургийн нэр	Айлдарын тоо	Хуудас	дугаар	Сургийн нэр	Айлдарын тоо	Хуудас
1	ФАТИХА	7	4	58	МУЖАДАЛА	22	395
2	БАКАРА	286	4	59	ХАШЬЫР	24	397
3	АЛИ ИМРАН	200	34	60	МУМТАХИНА	13	399
4	НИСА	176	52	61	САФ	14	401
5	МАЙДА	120	70	62	ЖУМА	11	403
6	АНГАМ	165	84	63	МУНАФИКУН	11	404
7	АГРАФ	206	100	64	ТАГАБУН	18	405
8	АНФАЛ	75	118	65	ТАЛАК	12	406
9	ТАУБА	129	124	66	ТАХРИМ	12	408
10	ЮНУС	109	137	67	МУЛК	30	409
11	ХУД	123	146	68	КАЛАМ	52	411
12	ЮСУФ	111	157	69	ХАККА	52	414
13	РАГЫД	43	166	70	МАГАРИЖ	44	416
14	ИБРАХИМ	52	171	71	НУХ	28	418
15	ХИЖР	99	175	72	ЖИН	28	419
16	НАХЫЛ	128	180	73	МУЗЗАММИЛ	20	421
17	ИСРА	111	190	74	МУДДАССИР	56	423
18	КАХФ	110	198	75	КИЯМЕТ	40	425
19	МАРИЯМ	98	207	76	ИНСАН	31	426
20	ТАХА	135	213	77	МУРСАЛАТ	50	428
21	АНБИЯ	112	221	78	НАБА	40	430
22	ХАЖ	78	229	79	НАЗИГАТ	46	431
23	МУМИНУН	118	235	80	ГАБАСА	42	433
24	НУР	64	242	81	ТАКУИР	29	435
25	ФУРКАН	77	248	82	ИНФИТАР	19	436
26	ШУГАРА	227	254	83	МУТАФФИФИН	36	437
27	НАМИЛ	93	263	84	ИНШИКАК	25	438
28	КАСАС	88	270	85	БУРУЖ	22	439
29	ГАНКАБУТ	69	277	86	ТАРИК	17	440
30	РУМ	60	283	87	АГЛА	19	441
31	ЛУКМАН	34	287	88	ГАШИЯ	26	442
32	САЖДЭ	30	290	89	ФАЖИР	30	443
33	АХЗАБ	73	292	90	БАЛАД	20	444
34	САБА	54	299	91	ШАМИС	15	445
35	ФАТЫР	45	304	92	ЛАЙЛ	21	446
36	ЯСИН	83	308	93	ДУХА (ЗУХА)	11	447
37	САФФАТ	182	313	94	ИНШИРАХ	8	447
38	САД	88	320	95	ТИН	8	448
39	ЗУМАР	75	326	96	ГАЛАК	19	448
40	МУМИН	85	332	97	КАДР	5	449
41	ФУССИЛАТ	54	339	98	БАЙИНА	8	449
42	ШУРА	53	343	99	ЗИЛЗАЛ	8	450
43	ЗУХРУФ	89	348	100	ГАДИЯТ	11	451
44	ДУХАН	59	353	101	КАРИГА	11	451
45	ЖАСИЯ	37	356	102	ТАКАСУР	8	452
46	АХКАФ	35	359	103	ГАСЫР	3	452
47	МУХАММЕД	38	363	104	ХУМАЗА	9	452
48	ФАТХ	29	366	105	ФИЛ	5	453
49	ХУЖУРАТ	18	369	106	КУРАЙШ	4	453
50	КАФ	45	371	107	МАГУН	7	454
51	ЗАРИАТ	60	374	108	КАУСАР	3	454
52	ТУР	49	376	109	КАФИРУН	6	454
53	НАЖИМ	62	379	110	НАСЫР	3	455
54	КАМАР	55	382	111	ТАББАТ	5	455
55	РАХМАН	78	384	112	БХЛАС	4	455
56	УАКИГА	96	388	113	ФАЛАК	5	456
57	ХАДИД	29	392	114	НАС	6	456

Сурегийн нэр	Айлдварын тоо	Хуудас	Сурегийн нэр	Айлдварын тоо	Хуудас
	А		КАХФ	110	198
АГЛА	19	441	КИЯМЕТ	40	425
АГРАФ	206	100	КУРАЙШ	4	453
АЛИ ИМРАН	200	34			
АНБИЯ	112	221		Л	
АНГАМ	165	84	ЛАЙЛ	21	446
АНФАЛ	75	118	ЛУКМАН	34	287
АХЗАБ	73	292			
АХКАФ	35	359		М	
	Б		МАГАРИЖ	44	416
БАЙИНА	8	449	МАГУН	7	454
БАКАРА	286	4	МАЙДА	120	70
БАЛАД	20	444	МАРИЯМ	98	207
БУРУЖ	22	439	МУТАФФИФИН	36	437
	Г		МУХАММЕД	38	363
ГАБАСА	42	433	МҮДДАССИР	56	423
ГАДИЯТ	11	451	МҮЖАДАЛА	22	395
ГАЛАК	19	448	МҮЗЗАММИЛ	20	421
ГАНКАБУТ	69	277	МҮЛК	30	409
ГАСЬР	3	452	МҮМИН	85	332
ГАШИЯ	26	442	МҮМИНУН	118	235
	Д		МҮМТАХИНА	13	399
ДУХА (ЗУХА)	11	447	МҮНАФИКУН	11	404
ДУХАН	59	353	МҮРСАЛАТ	50	428
	Ж			Н	
ЖАСИЯ	37	356	НАБА	40	430
ЖИН	28	419	НАЖИМ	62	379
ЖУМА	11	403	НАЗИГАТ	46	431
	З		НАМИЛ	93	263
ЗАРИАТ	60	374	НАС	6	456
ЗИЛЗАЛ	8	450	НАСЬР	3	455
ЗУМАР	75	326	НАХЬЛ	128	180
ЗҮХРУФ	89	348	НИСА	176	52
	И		НУР	64	242
ИБРАХИМ	52	171	НУХ	28	418
ИНСАН	31	426		Р	
ИНФИТАР	19	436	РАГЬД	43	166
ИНШИКАК	25	438	РАХМАН	78	384
ИНШИРАХ	8	447	РУМ	60	283
ИСРА	111	190		С	
	К		САБА	54	299
КАДР	5	449	САД	88	320
КАЛАМ	52	411	САЖДЭ	30	290
КАМАР	55	382	САФ	14	401
КАРИГА	11	451	САФФАТ	182	313
КАСАС	88	270		Т	
КАУСАР	3	454	ТАББАТ	5	455
КАФ	45	371	ТАГАБУН	18	405
КАФИРУН	6	454	ТАКАСУР	8	452
			ТАКУИР	29	435
			ТАЛАК	12	406
			ТАРИК	17	440

Сурегийн нэр	Айлдарын тоо	Хуудас	Сурегийн нэр	Айлдарын тоо	Хуудас
ТАУБА	129	124	ХАККА	52	414
ТАХА	135	213	ХАШЫР	24	397
ТАХРИМ	12	408	ХИЖР	99	175
ТИН	8	448	ХУД	123	146
ТУР	49	376	ХУЖУРАТ	18	369
	У		ХҮМАЗА	9	452
УАКИГА	96	388		Ш	
	Ф		ШАМИС	15	445
ФАЖИР	30	443	ШУГАРА	227	254
ФАЛАК	5	456	ШУРА	53	343
ФАТИХА	7	4		Ы	
ФАТХ	29	366	БХЛАС	4	455
ФАГЫР	45	304		Ю	
ФИЛ	5	453	ЮНУС	109	137
ФУРКАН	77	248	ЮСУФ	111	157
ФУССИЛАТ	54	339		Я	
	Х		ЯСИН	83	308
ХАДИД	29	392			
ХАЖ	78	229			





الحمد لله رب العالمين والصلاة والسلام على رسولنا محمد وعلى آله واصحابه اجمعين

## ӨМНӨХ ҮГ

Хамаг магтаал бүхий л ертөнцийн эзэн Аллахад зохимой.

Бүхий л хайр ивээл, амар амгалан гэгээн элч Мухаммедэд (с.а.с), сахаба (гэгээн элчийн үеийн итгэн дагагсад болон шадар туслахууд) нарт, гэгээн элчийг дагасдад оногдмой.

## КУРАН СУДАР БА ТҮҮНИЙ УТГА АГУУЛГА

### Куран Карим

Куран Карим Аллахын үг мөн. Хүн төрөлхтнийг энэ хорвоо болон хойд ертөнцийн аз жаргалд хүргэхийн тулд сүүлчийн гэгээн элч Мухаммедэд (с.а.с) мэлэк буюу тэнгэрийн элч Жабрейлаар дамжуулан илгээгдсэн. Гэгээн элч Мухаммедээс (с.а.с) хойш олон түмний амаар дамжин үнэн бодитор үе үе уламжлагдан ирсэн билээ. Уншигдах нь ч мөргөл залбиралын төрөл болох энэхүү Аллахын сударт өөр ямар ч зүйрлэл үгүй. Аллахаас илгээгдсэн судруудын сүүлчийнх. Түүнтэй ижил өөр судар одоо хүртэл зохиогдоогүй, дараа ч зохиогдохгүй.

Куран Карим бүхий л ертөнцийн төлөө юм. Ертөнцийн төгсгөл хүртэл хүн төрөлхтөнд зөв замыг заана. Куран судрыг Аллах өөрийн хамгаалалтанд авсан. Куран судраас өмнөх судруудын агуулга, зүйл заалтуудыг хүмүүс дураараа өөрчилж, гажуудсан тул түүгээр өмнөх сударуудад агуулсан бүхнийг хүчингүй болгосон. (Суре Ниса 46–р айлдвар. Суре Майда 13,14-р айлдвар, Суре Бакара 85-р айлдвар)

Куран Карим өмнөх судруудад ч тайлбарлагдсан: Аллахад, түүний мэлжүүдэд, гэгээн элч нарт, хойд ертөнцөд, бүхий л зүйлсийн Аллахын товлогдож бүтээснээр болоход итгэх, амь нас, эд хөрөнгө, үр удам, оюун ухаан болон итгэл үнэмшлийг хамгаалах гэх мэтчилэн шашны гол зорилгуудыг шинэчлэн тайлбарлаж, өөрчлөгдсөн зүйл заалтуудыг зассан байна.

Үндсэндээ, гэгээн элч нараас хүн төрөлхтөнд ухуулсан шашны гол ухагдахнуудад ялгаа үгүй. Гэвч цаг үе, орон зайд байршил, олон нийтийн хэрэглээнээс шалтгаалан мөргөл залбиралын төрөл болон зарим шийдвэрүүдэд өөрчлөлт орсон. Аллах нэгэн гэгээн элчид илгээгээгүй зарим зүйлүүдийг өөр гэгээн элчид илгээсэн тохиолдол олон бий. Өмнөх гэгээн элчийн үед илгээсэн зарим шийдвэрийг дараагийн гэгээн элчийн үед хүчингүй болгосон тохиолдол ч бий. Куран судрын агуулсан шийдвэр, сургамж болон бусад зүйл заалт бүхэн ертөнцийн төгсгөлийн өдөр хүртэл хүчин төгөлдөр байх болно. Цаг үе, орон зай болон бусад нөхцлүүдийг харгалзан өөрчлөхгүй. Бүхий л үеийн мусулманчуудад зориулагдсан билээ.

### **Куран судрын илгээгдэх, бичигдэх, цээжлэгдэх, ном болгож эмхэтгэн хэвлэх үе шат**

Куран Карим ер бусын илгээлт буюу айлдвараар гэгээн элч Мухаммедэд (с.а.с) ойролцоогоор 23 жилийн дотор илгээгдэж буусан. Өмнөх судруудад тохиогоогүй онцгой хамгаалалтаар хамгаалагдсан. Тийм учраас гэгээн элч хэд хэдэн бичээчдийг томилж, айлдвар илгээгдэх бүр түүнийг Куран судрын аль хэсэг, аль бүлэг, аль бүлэг буюу сурегийн дотор яаж байршуулан бичихийг зааж байжээ. Айлдварууд илгээгдэх бүрт бичээчид тэмдэглэн авч, шадар туслагчид цээжилж байсан байна. Мусулманчуудын дотроос олон мянган хүн куран судрыг цээжилж, удам дамжуулан хойч үедээ уламжилж ирсэн. Илгээгдсэн айлдварууд тухайн үеийн бичгийн хэрэгсэл болох арьс, мод, яс гэх гэхчлэн зүйлүүдэд бичигдэж, маш хянамгай хадгалагдаж байв.

Гэгээн элч Мухаммед (с.а.с) эсэн мэнд байхад энэхүү хэлбэрээр хадгалагдаж байсан Куран судар халифа Абу Бакирын (р.а) үед айлдварын бичээчид болон куран судрыг сайн цээжилсэн хүмүүсээс бүрдсэн хороо байгуулж, Куран судрыг анх ном болгожээ.

Дараа нь Халифа Османы (р.а) үед Абу Бакирын (р.а) үед бэлтгэсэн тэрхүү судрыг олон тоогоор хуулбарлан, дэлхийн өнцөг булан бүрт буй Исламын хот суурингуудад илгээсэн бөгөөд куран судрын нэг хувийг халифа өөртөө хадгалсан байна. Куран Каримд 114 суре, байдаг. Суре гэдгийг гадаадын зарим орчуулагчид Бүлэг хэмээн томъёолжээ. Гэвч Куран ба Суре нь Аллахын үг тул бид орчуулах оролдлого хийсэнгүй.

Суре нь утгын хувьд байр суурь, цол, тэмдэг, бэлгэдэл, хоёр юмыг зааглагч зэрэг хэд хэдэн ойлголтыг илэрхийлнэ. Суре бүр олон, цөөн янз бүрийн айлдваруудаас бүрдсэн тодорхой нэртэй юм.

Айлдвар буюу “аяг” нь утгын хувьд бэлгэдэл, сургамж, ер бусын гайхамшиг, нотолгоо зэрэг ойлголтыг илэрхийлнэ. Айлдвар нь хэдэн үг, хэд хэдэн өгүүлбэрээс бүрдсэн хэсгүүд юм. Айлдваруудын олонхи нь ганц эсвэл хэд хэдэн өгүүлбэрээр бүрдсэн байдаг. Тусгай нэг өгүүлбэр болоогүй айлдварууд ч бий.

### **Куран Карим бол ер бусын гайхамшиг**

Куран Карим сүүлчийн гэгээн элч Мухаммедэд (с.а.с) илгээгдсэн хамгийн өлзийтэй, ер бусын гайхамшиг гэж үздэг. Тэр найраглал ч биш, шүлэг ч биш. Өөрийн гэсэн онцгой уран найрлагатай Аллахын үгс мөн. Тухайн үед дэлхийд хамгийн уран үгсийн баялагтай ард түмний хэлээр илгээгдсэн энэхүү судрыг атаат дайснууд нь ч сонирхож, сонсож байсан түүхтэй.

Куран судар илгээгдсэн үе нь арабын хэл шинжлэл, уран зохиол хөгжиж дэглэрсэн үе байлаа. Тийм агал Куран сударт тэр үеийн яруу найрагчдын эсрэг: “Хэрэв Бидний үнэнч боол (Мухаммедэд с.а.с) буулгасан Куранд эргэлзэж байх аваас үүнтэй эн зэрэгцэх нэгэн бүлэг судрыг зохиогтун! Хэрэв та нар шударга байвал Аллахаас бусад өөрсдийн гэрчүүдээ дуудаж, хэлсэн бүхнийхээ үнэн мөнийг нотлогтун!” хэмээн айлдсан. (Суре Бакара 23-р айлдвар)

Тэрхүү яруу найрагчид Куран судрын айлдварууд илгээгдэх үед өөрсдийн зохиосон шүлэг, найраглал нь найруулгын хувьд төгс төгөлдөр биш гэдгийг аргагүй хүлээн зөвшөөрсөн аж. Учир нь Аллахын үг ямар ч ижилгүй, ер бус билээ. Түүний утга, уран найралганд хүмүүний ухаан, хүч авьяас хүрэхгүй. Куран судрын энэхүү гайхамшиг ертөнцийн төгсгөл хүртэл үргэлжлэх болно.



Куран Каримын ер бусын гайхамшигийг харуулсан, бидний мэддэг, мэддэггүй олон нотолгоо, шинж тэмдгүүд бий. Куран карим хожим ирээдүйд тохиолдож болох мэдэгдсэн зарим явдлууд нь тэр ёсоор л мэдэгдсэнээр болсон нь; илгээгдэх хүртэл хүмүүсийн огт мэдээгүй зүйлсийн тухай өгүүлсэн нь; хүн төрөлхтний бүтээгдэх, ертөнцийн ахуйн байдал, хожим шинжлэх ухаанаар батлагдан гарч буй зарим зүйлүүд болон орчин үеийн олон улсын эрх зүйн зарим хэм хэмжээг тухайн үед тодорхойлж өгсөн нь куран судрын ер бусын гайхамшиг, Аллахын үг гэдгийн нотолгоо юм.

### **Куран судрыг орчуулах тухай**

Куран Каримын уриа дуудлага нь бүхий л хүн төрөлхтний төлөө юм. Хүн төрөлхтөнд бодит болон оюунлаг, бодгалийн болон нийгмийн бүх төрлийн салбарын төлөө илгээгдсэн нэгэн хөтөч юм. Тийм учраас хэл, үндэс угсаа ялгахгүйгээр бүхий л хүмүүн энэхүү Аллахын үгийг уншихын зэрэгцээ ойлгох нь онцгой чухал. Уншлага мөргөл болон бусад мөргөл залбиралуудад уншигдахыг тушаагдсаны гол шалтгаан бол энэ юм.

Куран судрын гол зорилго бол хүн төрөлхтнийг зөв шулуун замд хүргэх явдал юм. Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд түүнийг араб бус үндэстэнүүдийн хэлээр хөрвүүлэх шаардлагатай билээ. Үүний хамгийн зохистой арга бол ном хэлбрээр орчуулан тараах, эсвэл амаар бусад хэлээр орчуулан заах. Дээр үеэс уламжлан хэрэглэж ирсэн хялбар арга бол ном хэлбрээр орчуулах арга мөн. Тиймээс хижри он тооллын дөрөвдүгээр зуунд анх перс хэлээр орчуулагдсан байна. Түүнээс хойш эдүүгээ хүртэл дэлхийн 100 гаруй улс үндэстний хэлээр орчуулагджээ.

Орчуулахдаа нэг ч үгийн утгыг алдагдуулахгүйгээр бусад хэл дэх ижил утгатай үгээр хөрвүүлэхийг эрмэлзэх ёстой. Гэвч нэг үгийн утга, хэрэглээний түвшин, агуулж буй ойлгомжыг огт алдахгүйгээр бусад хэлээр хөрвүүлэх амаргүй билээ. Учир нь улс үндэстэн бүрийн хэл зүй, уран сэтгэмж, соёл, үгийн баялаг, хэрэглээний түвшин ондоо. Орчуулагч хүнд ч зохиогчийн хэллэг, санаа бодол, сэтгэлгээ мэдрэмжийг тэр хэвээр нь буулгахад багагүй бэрхшээл тохиолддог билээ. Тиймээс өөр хэлээр орчуулахад зарим эндэгдэл гарах магадлал бий. Гэвч үндэстэн бүрт хэл зүйн зүй тогтол, баримтлал, арга зарчим байдаг тул гол утга агуулгыг оновчтой илэрхийлэх өргөн боломж бий билээ.

## **Куран судрын утга агуулга, түүнийг тайлбарлахын учир холбогдол**

Куран Каримыг ямар ч хэлээр орчуулсан ч Аллаһын үгсийн гүнзгий утга санааг төгс илэрхийлэх боломжгүй тул утгачилсан тайлбар хэлбрээр хөрвүүлэх нь зүйтэй гэж үздэг юм байна. Өөрөөр хэлвэл орчуулга бол үгс, өгүүлбэр бүрийн төгс хөрвүүлгэ биш, утга санааны илэрхийлэл, хүрэх зорилгыг бусад хэлээр таниулах явдал юм. Тиймээс бусад хэлээр орчуулагдсан Куран судар бол жинхэнэ оргинал Куран судар биш, Куран судрын утга агуулга юм. Куран судрын араб хувилбарын хүн төрөлхтөнд үзүүлэх нөлөөг бусад хэлээр хөрвүүлэгдсэн хувилбар нь бүрэн үзүүлж чадахгүй. Айлдвар доторх үгс, өгүүлбэрүүдийн гүнзгий утгыг ч бүрэн хүргэх боломж хомс, бүрэн үзүүлж чадахгүй. Учир нь зарим үгс болон өгүүлбэрүүд хэд хэдэн утгатай. Нэг утгыг авахад нөгөө утга нь үлдэнэ гэсэн үг. Бүх утгыг зэрэг авбал орчуулга биш тафсир буюу утга агуулгын дэлгэрэнгүй тайлбар болно. Үүний зэрэгцээ Куран судрын бусад хэлээр хөрвүүлэгдсэн нь түүний ер бусын гайхамшиг, адис ерөөл, нандин байдлыг агуулахгүй.

Тиймээс Куран судрын агуулж буй утга бүхнийг төгс ойлгохыг хичээсэн хүн араб хэл, уран зохиолыг нь судлах нь зүйтэй. Эсвэл найдвартай тафсир буюу дэлгэрэнгүй тайлбарыг ашиглах хэрэгтэй. Куран судрын орчуулгыг уншсан хүн куран судрын утга нь түүгээр хязгаарлагдсан гэж ойлгож болохгүй. Куран судар олон салаа агуулгатай, гүн утгатай гэдгийг анхаарах ёстой. Айлдваруудад заагдаж буй итгэл үнэмшил, сүсэг бишрэл, эрх мэдэл, ёс суртахуун, сургамж, ухагдахуун, түүх нийгэм г.м сэдвүүдийн учир шалтгаан, тайлалыг сонирхогчид тафсир буюу дэлгэрэнгүй тайлбар номуудад хандах нь зүйтэй.

Давтан хэлэхэд Куран судрын орчуулга нь жинхэнэ Куран карим биш ч гэсэн араб хэлээр илгээгдсэн нь бүхий л хүн төрөлхтөнд зориулсан Аллаһын айлдвар нэгэн судар учраас гарал үүсэл, арьс өнгө, үндэс угсаа үл харгалзан бүх хүмүүс уншвал өлзийтэй. Энэхүү зорилгоор Куран судрын Монгол утга агуулгыг бэлдсэн болно.

## **Куран судрыг унших тухай**

Хүн төрөлхтний нэг хэсэг гэгээн элчийн үеэс хойш Куран судрыг зүй ёсоор нь уншиж, зохистой хэрэгжүүлэхийн төлөө хичээж ирсэн. Энэхүү хичээл зүтгэлийн үр дүнд Куран судрыг уншихад зориулсан “кирагат” буюу Куран

судрыг зөв унших дүрэм журмыг судалсан Кирагатын ухаан, ойлгож, тайлбарлах зориулалттай тафсир буюу дэлгэрэнгүй тайлбарлах салбар ухаан бий болсон. Хойч үед ч энэхүү арга зүйн ухаануудаас эх үүсвэр авсан олон мянган судалгаа шинжилгээний ном, судрууд бий болжээ.

Куран судрыг уншиж , судлахад дараах зүйлийг анхаарах хэрэгтэй гэж үздэг юм байна.

**Нэгдүгээрт**, Куран сударт дангаараа шууд ойлгогдох олон айлдвар бий. Үүний зэрэгцээ бусад айлдваруудтай холбож ойлгох айлдварууд ч бий. Тиймээс бусад айлдваруудтай утга учрын холбоотой айлдваруудыг дангаараа шууд ойлгож, утга гарган авч болохгүй.

**Хоёрдугаарт**, Гэгээн элч Мухаммедээс айлдваруудыг ойлгуулсан, тайлбарласан арга зүйг, амьдралд хэрхэн хэрэгжүүлснийг сайн анхаарах ёстой. Гэгээн элч Мухаммедийн (с.а.с) тайлбарласнаас өөрөөр тайлбарлаж болохгүй. Айлдваруудыг Аллахын илгээсэн утгаараа хамгийн төгс тайлбарлаж өгсөн хүн бол Гэгээн элч Мухаммед (с.а.с) мөн. Тиймээс гэгээн элч Мухаммедийн (с.а.с) суннет хадис буюу сургаал ухагдахуун нь Куран Судрын дараа Ислам шашин дахь хоёр дахь эх үүсвэр болсон юм.

**Гуравдугаарт**, Куран судрыг жинхэнэ утгаараа зөв ойлгож тайлбарлахын тулд Исламын эхний гурван үеийн тайлбаруудыг анхаарах ёстой болдог.

**Нэгдүгээр үе**: Сахабагийн үе буюу гэгээн элч Мухаммедийн (с.а.с) сургаалыг өөрөөс нь сонссон хүмүүсийн үе. Тэд Гэгээн элч Мухаммедийн (с.а.с) Куран судрыг хэрхэн тайлбарлаж, сургасныг сонссон, гэрчилсэн хүмүүс юм.

**Хоёрдугаар үе**: “Табигыны” үе буюу сахаба нарыг сонсож, тэд нараас эрдэм мэдлэг , сургаал сонссон хүмүүс. **Гуравдугаар үе**: Табигынчуудаас эрдэм мэдлэг, сургаал, боловсрол эзэмшсэн хүмүүс. Энэ нь Ислам шашны эрдэм , сургаал, номлол, боловсролын хамгийн эрчимтэй, баталгаатай дэлгэрч, эх ундарга бий болсон үе юм. Энэхүү гурван үеийн эрдэмтэд Куран судрын айлдваруудын аль нь ямар учиртай, хэзээ, хаана ямар үйл явдлын үед илгээгдсэн гэдгийг сайн мэддэг ажээ.

Үүний зэрэгцээ Куран судар нь араб хэл, уран зохиол болон ислам шашны дээд боловсрол, өндөр мэдлэгтэй, энэхүү салбарт олон жил судалгаа хийсэн хүмүүсийн зүгээс тайлбарлагдах нь зүйтэй.

Куран судрыг унших нь өөрийн гэсэн тодорхой ёс жаягтай. Куран судрыг хэт чанга биш, дотороо шивнэлгүй, дунд зэргийн намуун дуугаар уянгалуулан уншиж, чин сэтгэлээр, үгс болон өгүүлбэрүүдийн утга агуулгыг нь бодож, унших дүрэмд нийцүүлэн унших ёстой. Ийнхүү унших нь Куран сударт ил тод тушаагдсан. Муслманчууд гэгээн элчээс хойш Куран судрыг дүрэм ёс жаягын дагуу уншихын төлөө хичээнгүйлэн зүтгэж, үе дамжин олон мянган хүн цээжилж ирсэн. Куран судрыг уншлага мөргөл, залбиралын зорилгоор уншвал гагцхүү араб хэлээр унших ёстой. Утга агуулга нь зөвхөн ойлгохын төлөө юм.

Энэхүү таны гарт буй Куран судрын Монгол утга агуулга нь араб хэл-уран зохиолын дүрэм журам болон Куран судлалын салбарт өргөнөөр ашиглаж ирсэн бүтээлүүдэд буй туршлагаудад илүү анхаарал тавигдаж туурвигдснаараа онцлогтой юм. Монгол хэлний хувьд жирийн ард түмэн болон эрдэм шинжилгээ, судалгааны ажилтануудын хялбар ойлгож чаддаг хэмжээнд бэлдэхээр хичээгдсэн. Орчуулгыг хянан тохиолдуулах ажилд Куран судрын хэд хэдэн хэл дээр орчуулагдсан бүтээлүүдтэй харьцуулан, тулгаж найруулан засагдсан юм. Энэхүү бүтээл БН Турк Улсын шашны хэрэг эрхлэх газраас Монголын ард түмэнд зориулсан бэлэг болой.

Хичээл зүтгэл хүмүүнээс, Амжилтанд хүргэх нь Аллахаас.

**Орчуулгын баг**

## НЭР ТОМЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР ТОЛЬ

### А

**Аллах:** Бүхий л ертөнцийг бүтээгч, эрхшээгч, удирдагч, алив бүхнийг бий болгогч, үгүй болгогч, онцгой бэлгэ тэмдгээрээ танигддаг, цорын ганц эзэнтний нэр

**Али Имран:** Сурений нэр. Имраны гэр бүл гэсэн утгатай. Имран гэгээн Мариямын эцэг.

**Аль Акса:** Иерусалим хот дахь мечид сүм. Исламын эрт үеэс адислан ирсэн ариун мечидийн нэр.

**Абдуллах бин Салам:** Таурат судраас гэгээн элч Мухаммедийн шинж тэмдгийг уншиж мусулман болсон еврей гаралтай сахаба буюу гэгээн элчийн үеийн үнэн сүсэгтэн.

**Абдуллах бин Үммү Макгум:** Гэгээн элч нэгэнт завгүй байхад хажууд ирсэн Үммү Магумыг анзаарч амжаагүй. Тэр үед Габаса сурений эхний арван айлдвар илгээгдэж түүний тухай өгүүлсэн.

**Абил:** Адамын хоёр дахь хүү. Ах нь Кабил түүнийг атаархаж шударга бусаар өгүүтгэсэн.

**Абу Бакир:** Хамгийн алдартай сахаба нарын нэг. Гэгээн Мухаммедийн хамгийн дотны анд. Анхны халифа.

**Абу Лахаб:** Гэгээн Мухаммедийг их зовоосон, хор учруулсан дарангуйлагч, буруу номтон.

**Агла:** Сурений нэр. Агуу гэсэн утгатай.

**Аграф:** Сурений нэр. Хойд ертөнцөд диваажин болон там руу ороогүй хүмүүсийн түр хүлээх газар.

**Адам:** Аллахын анх бүтээсэн хүн. Хүн төрөлхтний эцэг бөгөөд Аллахын анхны гэгээн элч.

**Азар:** Гэгээн элч Ибрахимийн хойд эцэг. Буруу номтон байсан.

**Азрайл:** Алдартай дөрвөн их мэлэгийн нэг. Хорвоогоос халих цаг нь бологсдын амийг авагч эрлэгийн элч.

**Айке:** Гэгээн элч Шугайбын илгээгдсэн ард олон.

**Айша:** Гэгээн элч Мухаммедийн (с.а.с) нэгэн гэргий.

**Альясар:** Гэгээн элч Илиясын үед илгээгдсэн нэгэн гэгээн элчийн нэр.

**Анбия:** Сурений нэр. Гэгээн элч гэсэн утгатай “наби” хэмээх үгийн олон тоо. Гэгээн элчүүд.

**Ангам:** Сурений нэр. Тэмээ, үхэр, хонь, ямаа зэрэг дөрвөн хушуу малын нийлбэр нэрлэл.

**Ансар-Мухажир:** Мухажир бол Гэгээн элчийн үед Меккегээс Мадинад нүүдэл хийсэн, дүрвэгч мусулманууд. Ансар бол Меккегээс нүүдэллэн ирсэн мусулманчуудад тусалсан Мадинад оршин суугч мусулманууд.

**Антакия:** Гэгээн элч Исагийн явуулсан төлөөлөгч шавь нараа шашинд сургахын төлөө илгээгдсэн хот.

**Анфал:** Сурений нэр. Дайны олз.

**Арафат:** Хаж мөргөлийн үед түр байрлан мөргөл, залбирал үйлдэх газар. Меккегээс зүүн тийш 20 км.

**Ариун судар:** Таурат, Забур, Инжил, Куран зэрэг Аллагаас илгээгдсэн судрууд.

**Бадауи:** Асар майхангай, цөлд амьдардаг нүүдэлчин арабууд.

**Бадир:** Хижрийн он тооллын хоёрдахь жилд (М.Э 624) Мадинагийн мусалманууд болон Меккегийн бу-

**Ариуслын өглөг:** Эд баялаг тодорхой хэмжээнд хүрэхэд тодорхой нөхцөлд өгөх нь үүрэг болсон өглөг.

**Арыш:** Сансар огторгуй.

**Асиф бин Бархия:** Гэгээн элч Сулейманы шадар туслах.

**Асия:** Фиргауны эхнэр бөгөөд гэгээн элч Мусар асран хамгаалсан сүсэгтэн эмэгтэй.

**Ассаламү Алайкүм:** Мусулманчуудын нэг нэгэндээ “Амар амгалан болтугай” хэмээх мэндчилэх үг.

**Асхаб Кахф:** Дарангуйлагч, үл сүсэглэгч хаанаас зугтаж агуйд хоргодсон сүсэгтэн залуучууд.

**Ахзаб:** Сурений нэр. Мадина хотод гэгээн элч Мухаммедтэй тулалдахар ирсэн хэд хэдэн бүлэгээс бүрдсэн дайснууд.

**Ахкаф:** Сурений нэр. Элсэн манха толгойнууд.

**Аюб:** Гэгээн элч Ибрахимын үр удамаас ирсэн нэгэн гэгээн элчийн нэр.

## Б

руу номгнуудын хооронд болсон дайн. Тулалдаан болсон газарт буй худагны нэр.

**Байнна:** Сурений нэр. Ил тод нотолгоо.

**Байт аль Магмур:** Зарим судалгаагаар ариун Кагба гэсэн утгатай. Зарим мэдээгээр тэнгэрт буй Кагба.

**Байт аль Макдис:** Гэгээн элч Сүлейманы барьсан Аль Акса мечжидийн нэр.

**Бакара:** Сурений нэр. Үнээ гэсэн утгатай.

**Балад:** Сурений нэр. Нутаг гэсэн утгатай. Балад суред ариун Меккег балад гэж нэрлэсэн.

**Балкис:** Эрт үед одоогийн Йемений нутагт амьдарсан Саба хэмээх улсын хатан хаан.

**Бахира, Сайба, Уасила, Хам:** Арабууд мусулман болохоос өмнө зохиомол бурхадад зориулан зарим мал амьтадыг сэтэрлэж тавьдаг ёс. Түүнд зориулагдсан мал амьтадын нэрс.

**Бисмиллах:** Аллахын алдраар эхэлье.

**Бунямйн:** Гэгээн элч Юсуфын дүү.

**Буруж:** Сурений нэр. Одод.

**Буруу номтон:** Аллахыг, гэгээн элчийг, Ислам шашныг үгүйсгэн сүсэглэхгүй эсэргүүцэгчид.

## В

**Вавилон:** Эрт үеийн нэгэн хотын нэр. Одоогийн Иракийн нутаг дэвсгэрт байсан.

## Г

**Габаса:** Сурений нэр. Дургүй хүрч, нүүрээ буруулах.

**Гад:** Гэгээн элч Худын илгээгдсэн одоогийн Йемений нутагт амьдарч байсан нэгэн овог аймаг.

**Гадият:** Сурений нэр. Довтлон явагч морьд.

**Гадын:** Хамгийн дээд эрэмбэтэй диваажингийн нэр.

**Галак:** Сурений нэр. Цусны бөөм.

**Ганкабут:** Сурений нэр. Аалз (амьтан).

**Гасыр:** Сурений нэр. Зуун жил, цаг хугацаа, нар жаргахаас өмнөх уншлага мөргөл.

**Гашия:** Сурений нэр. Гэнэт дуулгасан баярт буюу муу мэдээ.

**Гузайр:** Нэгэн гэгээн элч эсвэл зөнч мэргэн хүн.

**Гэгээн элч:** Аллахын шариат, зарлиг, цээрлэл, айлдваруудыг хүн

төрөлхтөнд мэдэгдэн таниулахаар итгэмжлэгдсэн онцгой элчүүд.

## Д

**Дауид:** Нэгэн гэгээн элч бөгөөд гэгээн элч Сүлейманы эцэг.

**Духа (Зуха):** Сурений нэр. Нармандахаас үдээс өмнө хүртлэх цаг хугацаа.

**Духан:** Сурений нэр. Манан, угаа.

## Е

**Еврей:** Аллахын гэгээн элч Мусад илгээсэн шашин. Хожим хүмүүсийн өөрчилснөөр нэгэн үндэстний нэр болсон.

**Ертөнцийн төгсгөл:** Арабаар Ахирет. Энэ хорвоогийн амьдралаас хойших мөнхийн амьдрал юм.

## Ж

**Жабрейл:** Аллахын сургаал номыг гэгээн элч нарт хүргэх буюу айлдварыг дамжуулан айлтгах үйл үйлдэнэ. Аллах ба гэгээн элч нарыг хооронд нь холбогч.

**Жалут:** Гэгээн элч Дауидын үед амьдарсан Амалика хэмээх улсын эзэн хаан. Дауидын дайсан.

**Жаннат аль Мауа:** Диваажингийн найман эрэмбийн нэгний нэр.

**Жасия:** Сурений нэр. Сөхрөн суугч.

**Жибит тагут:** Хэмээс хэтэрсэн, харгис зальхай, дарангуйлагч, зөрүүд этгээд эсвэл чөтгөр шулам.

**Жин:** Хүний биеийн таван мэдрэмжээр мэдэрддэггүй, итгэх үл итгэх эрх мэдэлтэй, хүмүүн шиг Аллахад, гэгээн элчид сүсэглэх нь шаардагдсан, сүсэгтэн үл сүсэглэгч хэмээн хуваагддаг бодьгал. Буг.

**Жуди:** Гэгээн элч Нухын усан онгоцны зогссон уулын нэр.

**Жума:** Сурений нэр. Баасан гараг. Баасан гарагт үйлддэг олон нийтийн уншлага мөргөл.

## З

**Забур:** Гэгээн элч Дауидад илгээгдсэн ариун судар.

**Закария:** Нэгэн гэгээн элч. Гэгээн Мариамын нагац эгчийн нөхөр.



**Зариаг:** Сурений нэр. Хүчтэй шуурга.

**Зекат:** Ариуслын өглөг.

**Зилзал:** Сурений нэр. Газар хөдлөлт. Байгалийн гамшиг, газар хөдлөлт.

**Зина:** Садар самуун явдал. Ёс бус хурьцал.

**Зихар:** Өөрийн эхнэрийн биеийг ээжийн эсвэл эгчийн биетэй зүйрлэж, эхнэр хэмээн боддоггүй эндэгдэл.

**Иблис:** Четгөр шулам.

**Ибрахим:** Сурений нэр. Гэгээн элчийн нэр. Гэгээн элч Исмайл, Исхак нарын эцэг.

**Игтикаф:** Мөргөл залбиралын зорилгоор мезжид дотор байрлан хүлээх.

**Иддет:** Гэр бүл салсан эмэгтэйн гурван сарын тэмдэг өнгөрөх хүртэл, нөхөр нь өөд болсон эмэгтэйн дөрвөн сар арван хоног хүртэл хүлээх ёстой хугацаа.

**Идрис:** Нэгэн гэгээн элчийн нэр.

**Иемен:** Эрт үед олон гэгээн элч илгээгдсэн түүхэн орон.

**Израйлийн үр сад:** Гэгээн элч Якубаас үржсэн омог аймаг. Якубын үр удам.

**Зулькарнайн:** Нэгэн гэгээн элч, эзэн хаан.

**Зулькифил:** Нэгэн гэгээн элч.

**Зүлиха:** Гэгээн элч Юсуфыг болчлон авсан Мисирин эзэн хааны гэргий.

**Зүмар:** Сурений нэр. Бүлэглэл.

**Зүхруф:** Сурений нэр. Алт мөнгөөр хийгдсэн гоёл чимэглэлийн зүйлс.

## И

**Инжил:** Гэгээн элч Исад илгээгдсэн ариун судар. (Библи)

**Инсан:** Сурений нэр. Хүмүүн.

**Инфитар:** Сурений нэр. Тэнгэрийн хагарал.

**Иншикак:** Сурений нэр. Хагарах, бутрах.

**Инширах:** Сурений нэр. Зүрх сэтгэлийг нээн уужруулах.

**Иса:** Гэгээн элчийн нэр. (Есүс)

**Ислам:** Аз жаргал, аюулгүй, энх амгалан, итгэл сүсэглэл, Аллаха болон гэгээн элчийг хүлээн зөвшөөрөх хэмээн олон утгатай. Аллахаын гэгээн элч Мухаммедэд илгээсэн цоо шинэ шашны нэр.

**Исмагил:** Гэгээн элчийн нэр. Гэгээн элч Ибрахимийн хүү.

**Исра:** Сурений нэр. Шөнийн аялал. Аллахын гэгээн элч Мухаммедийг нэгэн шөнө маш бага хугацааны дотор мөсжид Аль Харамас мөсжид Аль Акса хүртэл аялуулсан ер бус явдал.

**Исрафил:** Ертөнцийн төгсгөлийн өдрийг эхлүүлж, дараа нь хүн төрөлхтөн мөнхийн оронд дахин амилуулахыг хариуцдаг, эдгээрийн дохио болгон бишгүүр бүрээ үлээдэг мэлэк буюу тэнгэрийн элч.

**Кабил:** Гэгээн элч Адам эцгийн том хүү. Дүү Абилийг хөнөөсөн билээ.

**Кагба:** Ариун Мекке хотод буй мөсжид Аль Харамын дунд байршилтай, дэлхийн анхны сүм. Мусулманууд уншлага мөргөлөө түүн руу чиглэн үйлддэг.

**Кадр:** Сурений нэр. Үнэ цэнэтэй гэсэн утгатай. Рамазан сард Куран судрын илгээгдсэн шөнө.

**Калам:** Сурений нэр. Үзэг.

**Камар:** Сурений нэр. Сар.

**Канган:** Гэгээн элч Нухын үл сүсэглэгч хүү.

**Карига:** Нэгэн сурений нэр. Ертөнцийн төгсгөлийн түгшүүртэй, аймшигт явдал.

**Касас:** Сурений нэр. Өгүүлэмжүүд

**Исхак:** Нэгэн гэгээн элчийн нэр. Гэгээн элч Ибрахимийн хүү.

**Иудэйчүүд:** Еврейчүүд. Еврейн шашинтнууд.

**Иффрит:** Нэгэн жин буюу бугийн нэр.

**Ихрам:** Хаж мөргөлийн үед өмсдөг, “хорио цээрийн дэглэмтэй” гэсэн утга илэрхийлдэг тусгай хувцас.

## К

**Каусар:** Сурений нэр. Диваажин дахь ариун булаг, нуурын ус.

**Каф:** Сурений нэр. Араб үсгүүдийн нэгэн.

**Кафирун:** Сурений нэр. Буруу номтнууд, үл сүсэглэгсэд.

**Кафур:** Диваажин дахь булагны ус.

**Кахыф:** Сурений нэр. Агуй.

**Кибла:** Уншлага мөргөл үйлдэхэд чиглэх зүг. Кагбагийн зүг.

**Кирамин Катибин Хафаза:** Хүний нүгэл - буяныг байнга тэмдэглэгч, хадгалагч тэнгрийн элч мэлэкүүд.

**Киямет:** Ертөнцийн төгсгөлийн дараа дахин амилах өдөр.

**Куба мөсжид:** Гэгээн элч Мухаммед Меккегээс Мадина руу нүүхэд

**Мадинагийн ойр газарт барьсан мезжид.**

**Кудус:** Одоогийн Ирусалим хотын үндсэн нэр.

**Курайш:** Арабын нэгэн омог.

**Куран:** Гэгээн элч Мухаммедд илгээгдсэн ариун судар.

**Лайл:** Нэгэн сурений нэр. Шөнө

**Лат, Узза:** Гараар урласан зохиомол бурхадын нэр.

**Лаух аль Махфуз:** Алив бүхний хувь тавилан болон үйл явдлууд

**Магариж:** Нэгэн сурений нэр. Өндөр газар, өндөрлөг.

**Магун:** Сурений нэр. Хөршүүд нэг нэгэндээ өргөн хэрэглээний бараагаар туслалцаа үзүүлэх.

**Мадина:** Гэгээн элч Мухаммедын нүүж ирээд суурьшсан, анх исламын засаглалыг үүсгэн байгуулсан, гурван ариун мезжидийн нэг болох Мезжид Набауйгийн байрласан ариун хот.

**Мадиян:** Гэгээн элч Шугайбын илгээгдсэн ард олон.

**Мажусичүүд:** Галыг шүтэн мөргөгсөд.

**Курбан:** Адуунаас бусад дөрвөн хушуу малаас Аллахад дотносох зорилгоор барьсан өргөл.

**Куффар:** Үл сүсэглэгчид, буруу номтнууд.

## Л

тэмдэглэгдсэн Аллагаас өөр хэн ч мэдэхгүй судар.

**Лукман:** Сурений нэр. Гэгээн элчийн нэр.

**Лут:** Нэгэн гэгээн элч.

## М

**Майда:** Сурений нэр. Дайллаганы ширээ.

**Манат:** Нэгэн зохиомол бурханы нэр.

**Мариям:** Гэгээнтэн эмэгтэйн нэр, гэгээн элч Исагийн (Есүс) эх.

**Масих:** Гэгээн элч Исагийн өөр нэгэн нэр.

**Махир:** Гэрлэхэд эхнэрт өгөх шаардлагатай сүй бэлэг, хэсэг хөрөнгө.

**Машгар аль Харам:** Хүндэтгэл үзүүлдэг бэлэг тэмдэгтэй газар. Хаж мөргөлийн үед залбирал хийх газар.

**Мекке:** Гэгээн элч Адамаас наана хүндэтгэлтэй ариун хот. Ислам шашны төв.

**Месжид:** Ислам шашинтнуудын уншлага мөргөл болон бусад мөргөлүүдийг үйлдэх газар, сүм.

**Месжид Аль Харам:** Ариун Меккед буй Кагбаг хүрээлсэн, адис ерөөлт сүм.

**Микайл:** Алдарт дөрвөн мэлэкийн нэг нь. Байгалийн юмс үзэгдэл, салхи, хур тундас, жимс ногоо, тариа будаа болон өвс ургамлын ургаж боловсрох ба оршиж байхыг хариуцана.

**Мисир:** Одоогийн Египет улсын хуучин араб нэр нь.

**Муззаммил:** Сурений нэр. Хувцасаа толгойдоо нөмрөн, биеэ далдлах.

**Мүмин:** Аллах болон гэгээн элчид итгэсэн сүсэгтэн.

**Мүминун:** Мүмин үгийн олон тоо. Сүсэглэгсэд.

**Муса:** Гэгээн элчийн нэр.

**Мусулман:** Аллах болон гэгээн элчид итгэсэн, хүлээн зөвшөөрсөн сүсэгтэн.

**Мутаффифин:** Сурений нэр. Жин хэмжүүрээр залилагсад.

**Мухаммед:** Гэгээн элч нарын дотор хамгийн алдартай, хүндэтгэлтэй, сүүлчийн гэгээн элч. Нэгэн сурений нэр.

**Мүддассир:** Сурений нэр. Хувцасаа нөмрөн хучигч.

**Мүжадала:** Сурений нэр. Зөрчлөх, тэмцэлдэх.

**Мүлк:** Сурений нэр. Эд хөрөнгө, эзэгнэл, эрх барих.

**Мүмтахина:** Сурений нэр. Сорилтод өртсөн эмэгтэй.

**Мүнафикун:** Сурений нэр. Хоёр нүүртэн. Амаараа болон биеэрээ сүсэгтэн шиг дүр эсгэж сэтгэлээрээ буруу номтон, үл сүсэглэгч хэвээрээ байгсад.

**Мүрсалат:** Сурений нэр. Илгээгдсэн элч мэлэкүүд.

**Мэлэк:** Туяанаас бий болсон бөгөөд хүссэн дүр, төрх, хэлбэрт орж хувирч чаддаг, цэвэр ариун бодгаль. Мелек нь эр, эмийн шинж тэмдэггүй байдаг. Тэд Аллах-ын зарлигийг огт эсэргүүцдэггүй, харин гүйцэтгэдэг, ядарч зүдэрдэггүй, идэж уухгүй. Тэнгрийн элч.

## Н

**Наба:** Сурений нэр. Мэдээ гэсэн утгатай.

**Нагим:** Найман диваажингийн нэгний нэр.

**Нажим:** Сурений нэр. Од.

**Назигат:** Сурений нэр. Хүний амийг авагч мэлэж.

**Назир бин Харис:** Меккегийн эрдэм мэдлэгтэй буруу номтнуудын нэг. Гэгээн элчийн эсрэг хүчтэй тэмцсэн, түүхч, яруу найрагч.

**Намил:** Сурений нэр. Шоргоолж.

**Нас:** Сурений нэр. Хүмүүс.

**Насыр:** Сурений нэр. Тусламж.

**Нафил:** Куран сударт үйлдэх шаардлагатай хэмээн тушаагдаагүй, гэгээн элчийн үйлдэж байсан сайн дурын уншлага мөргөл болон бусад мөргөл залбиралууд.

**Нахыл:** Сурений нэр. Бал цуглуулдаг зөөгий.

**Ниса:** Сурений нэр. Эмэгтэйчүүд.

**Нур:** Сурений нэр. Гэрэл гэгээ, туяа.

**Нух:** Сурений нэр. Нэгэн гэгээн элчийн нэр.

## О

**Олон бурхан шүтэгч:** Гараар бурхан бүтээж түүнд залбирагч, гараар бүтээсэн бурхадыг бурханы дүр эсв-

эл төлөөлөгч хэмээн итгэдэг мухар сүсэгтэн. Аллахтай бусдыг эн зэрэгцүүлэгч.

## Ө

**Өглөг:** Буян хураахын тулд, Аллахын таалал хүртэхийн төлөө бусдад эд зүйлс өгөх.

**Өргөл:** Курбан буюу Аллаhad дотныхын төлөө дөрвөн хушуу малаас төхөөрөн бусдад түгээн тараах.

## Р

**Рагид:** Сурений нэр. Тэнгэр дугарах.

**Расс:** Худаг, хонгил. Асхаб расс- Гэгээн элч Шугайбын илгээгдсэн ард олны нэр.

**Раким:** Дурсгалын хөшөө. Асхаб Кахф буюу агуйд хоргодогсодын нэр бичигдсэн чулуун хөшөө.

**Рахман:** Нэгэн сурений нэр. Машид энэрэлт Аллах. Аллахын зүйрлэл нэр

**Рамазан:** Хижрийн он тооллын есдүгээр сар. Мацаг барих сар.

**Рум:** Сурений нэр. Эртний грекчүүдийн араб нэрлэл.

**Рух:** Амь, сүнс. Хийморь

**Рух-аль Кудүс:** Жабрейл мэлэкийн нэгэн нэр. Ариун сүнс.

**Саба:** Сурений нэр. Эртний Иемений газар нутагт амьдарсан нэгэн овог аймаг.

**Сабичууд:** Христ болон еврейчүүдийн дунд гарсан нэгэн шүтлэг. Хожим зурхайн шүтлэг болсон.

**Сад:** Сурений нэр. Араб үсгүүдийн нэгний хэллэг.

**Садум:** Гэгээн элч Лутын илгээгдсэн хот суурингийн нэр.

**Саждэ:** Сурений нэр. Сөгдөн мөргөх. Уншлага мөргөлийн нэгэн үйлдэл.

**Сакар:** Долоон тамын нэгний нэр.

**Салам:** Мэнд хүргэх. Мэндчилгээ.

**Салих:** Нэгэн гэгээн элчийн нэр.

**Самири:** Гэгээн элч Муса Тур ууланд явсан үед ард нь үлдсэн сүсэгтнүүдийг төөрөгдүүлж, буруу номтон болгосон этгээд.

**Самүд:** Гэгээн элч Салихын илгээгдсэн ард олны нэр.

**Рухбаният:** Бясалгал. Даяанчлан өөрийгөө нэгэн газарт тусгаарлан, удаан хугацаагаар бясалган залбирах.

## С

**Саф:** Сурений нэр. Эгнээ эгнээгээр жагсах.

**Саффат:** Нэгэн сурений нэр. Эгнээ эгнээгээр зогссон мэлэкүүд.

**Сахаба:** Гэгээн Мухаммедэд итгэж, түүний үгийг нэг удаа ч болов биечлэн сонсож, нүдээр үзэж шадарласан мусулман хүн.

**Сидрат аль Мунтаха:** Диваажингийн эцсийн эрэмбэ. Гэгээн элч Мухаммедын Аллахтай ярилцахад хүрсэн эцсийн эрэмбэ.

**Сират:** Хойд ертөнцөд диваажинд хүрэхийн төлөө туулж өнгрөх гүүрийн нэр.

**Сур:** Ертөнцийн төгсгөлийн өдөр, дахин амилахын өдөр дохио өгөхийн тулд үлээгдэх бишгүүр бүрээ.

**Сухуф:** Аллахаас илгээгдсэн дөрвөн ариун судраас бусад Аллахын илгээсэн бичээсүүд, хуудасууд.

**Сүлейман:** Нэгэн гэгээн элчийн нэр. Гэгээн элч Дауидийн хүү.

## Т

**Таббат:** Сурений нэр. “Хор хөнөөлтэй учраг” хэмээсэн хараал үг.

**Тагабун:** Сурений нэр. Хууртагдах, ташаарах.

**Тайф:** Меккед ойр хотын нэр.

**Такасүр:** Сурений нэр. Эд баялагт шунах. Мал хөрөнгө цуглуулах.

**Такуир:** Сурений нэр. Нарны илч бөхөх.

**Талак:** Сурений нэр. Гэр бүл цуслалт.

**Талут:** Израйлийн үр садыг удирдаж байсан нэгэн удирдагчийн нэр.

**Тарик:** Сурений нэр. Шөнө дунд мандсан одод.

**Тауба:** Сурений нэр. Гэмшил, уучлал эрэх.

**Таурат:** Аллахаас илгээгдсэн дөрвөн ариун судрын нэг.

**Таха:** Сурений нэр. Та, ха хэмээх хоёр араб үсэг.

**Тахрим:** Сурений нэр. Хориглох.

**Тин:** Сурений нэр. Бибал жимс.

**Туа:** Гэгээн элч Мусад айлдвар илгээсэн нэгэн хөндий газар.

**Тур:** Сурений нэр. Гэгээн элч Мусайн Аллахтай ярилцсан уулын нэр. Заримдаа Тур Сина гэгддэг.

## У

**Уад,Суаг,Ягус, Ягук,Насыр:** Зохиомол бурхадын нэрс.

**Уади аль Кура:** Гэгээн элч Салихын илгээгдсэн Самүдийн ард олны амьдарсан уулын хавцалын нэр.

**Уакига:** Сурений нэр. Үйл явдал. Ертөнцийн төгсгөлийн өдөр.

**Уалид бин Мугира, Гуруа бин Масгуд:** Меккегийн буруу номтнуудын толгойлогчид.

**Умра:** Хаж мөргөлөөс бага зэрэг өөр, хүссэн үед үйлдэж болох мөргөл. Ихрам өмсөж Кагбаг тойрон залбирч, Сафа Маруагийн хооронд

явган гүйх залбирал, үсээ авхуулах ёснуудаас бүрдсэн мөргөл.

**Уншлага мөргөл:** Аллахад итгэсэн мусулман бүрийн босоогоор, сөхрөх, сөгдөх, суух байдлаар үйлдэх залбирал, куран судраас хэдэн айлдвар унших, тодорхой залбирал үгсээс бүрдсэн мөргөл.

**Ухуд:** Гэгээн элчийн буруу номтнуудтай Ухудын дайн болсон газрын нэр.

**Үл сүсэглэгсэд:** Аллах болон гэгээн элчид итгэхгүй, хүлээн зөвшөөрөхгүй, сүсэглэхгүй үгүйсгэдэг хүмүүс.

**Ф**

**Фажир:** Сурений нэр. Гэгээрэн цайх үүр.

**Фалак:** Сурений нэр. Нар мандахас өмнөх өглөөний цаг.

**Фарыз:** Ариун үүрэг. Куран сударт заавал биелүүлэхээр тушаагдсан үүрэг.

**Фатиха:** Сурений нэр. Нээлт, нээгч, оршил.

**Фатх:** Сурений нэр. Нээх. Ислам шашинд шинээр нээгдсэн, ислам шашинд орсон орон.

**Фатыр:** Сурений нэр. Бүтээгч, бий болгогч (Аллах).

**Фил:** Сурений нэр. Заан амьтан.

**Фиргаун:** Гэгээн элч Мусагийн үеийн дарангуйлагч, буруу номтон, өөрийгөө бурхан гэж зарласан Мусаг хүчтэй эсэргүүцэн тэмцсэн хаан.

**Фйрдаус:** Найман диваажингийн нэгний нэр.

**Фуркан:** Сурений нэр. Куран судрын хэдэн нэрийн нэг нь. Зөв бурууг, сайн мууг ялгагч.

**Фуссилат:** Сурений нэр. Нэгэн зүйлийг дэлгэрэнгүй тайлбарлах.

**Х**

**Хабиб Нажжар:** Гэгээн элч Исагийн шавь нар шашинд уриалахад дэмжсэн сүсэгтэн хүн.

**Хадид:** Сурений нэр. Төмөр.

**Хаж:** Ислам шашны таван тулгуур үүргийн нэг. Хажын улиралд Мекке хотод зорчих, ихрам хувцас өмсөх, Арафат хэмээх газарт залбирах, ариун Кагбаг тойрон залбирах зэрэг мөргөлийн төрөл.

**Хакка:** Сурений нэр. Чин үнэн, зөв буруу ялгарах бүх юм ил болох шүүн тунгаах өдөр.

**Халал:** Ислам шашинд ариун хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн зүйлс.

**Халифа:** Шашны төлөөлөн удирдагч, захирагч.

**Хаман:** Фиргауны шадар туслах.

**Ханиф:** Ислам хүртлэх шүтэгдсэн чин үнэн шашин. Гэгээн элч Ибрахимын замнал.

**Харам:** Ислам шашинд бузар хэмээн үзэж, хориглож цээрлэгдсэн зүйлс.

**Харун:** Нэгэн гэгээн элчийн нэр. Гэгээн элч Мусагийн дүү.

**Харут-марут:** Вавилон хотод байсан хоёр мэлэкийн нэр.



**Хауа:** Гэгээн элч Адам эцгийн эхнэр. Хүн төрөлхтөний эх.

**Хауаричууд:** Гэгээн элч Исагийн шавь нар, Исааг төлөөлөн шашин сургагчид.

**Хафса:** Гэгээн элч Мухаммедийн нэгэн эхнэрийн нэр.

**Хашыр:** Сурений нэр. Цуглаан. Ертөнцийн төгсгөлийн өдөр шүүн тунгаах цуглаан.

**Хижыр:** Гэгээн элч Салихын ард олон болох Самүдчүүдийн амьдарсан нутаг.

**Хижрийн он тоолол:** Гэгээн элч Мухаммедийн Меккегээс Мадинад нүүсэн оноос (М.Э 622) тоолж эхэлсэн он тоолол. Сарын тооллоор тооцогддог учраас нэг жил нь 354-356 хоногтой.

**Хизыр:** Нэгэн гэгээн элчийн нэр.

**Хоёр нүүртнүүд:** Мүнафикун гэсэн үгтэй ижил утгатай.

**Хойд ергөнц:** Арабаар Ахирет. Сур үлээгдэх буюу ертөнцийн төгсгөл эхэлж бүх үхэгсэд дахин амилж, булшнаас гарч, үйлийн дэвтрүүдийг эздэд нь өгч ,махшарын талбайд цугларч, нүгэл буяны дэнсэнд орж шүүгдэх цаг. Диваажин ба тамаас бүрдсэн мөнхийн амьдрал.

**Худ:** Сурений нэр. Нэгэн гэгээн элчийн нэр.

**Худхуд:** Нэгэн төрлийн шувуу.

**Хужурат:** Сурений нэр. Өрөөнүүд.

**Хунайн:** Гэгээн элч Мухаммедийн тал ба буруу номтнуудын хооронд болсон дайн.

**Хүмаза:** Сурений нэр. Хутган үймүүлэн, хов жив яригчид.

**Хүндэтгэлийн сарууд:** Дайн тулалдаан хориглогдсон сарууд. Хижрийн тооллоор Режеб, Зилкагда, Зилхижжа, Мухаррам сарууд.

### Ш

**Шайтан:** Зөрүүд, их зант, бузар зэрэг бүхий л муу шинж тэмдэгт бодьгал бөгөөд хүмүүнийг байнга төөрөгдүүлдэг, садар самуунд, муу муухайд, бүх төрлийн нүгэлд уруу татдаг үл харагдах хүч буюу Чөтгөр шулам.

**Шам:** Сири улсад буй эртний хот.

**Шамис:** Сурений нэр. Нар.

**Шарият:** Ислам шашны дэг жаяг, ёс зүй, хууль журмын нэгдмэл цогц.

**Шугайб:** Нэгэн гэгээн элчийн нэр.

**Шугара:** Сурений нэр. Яруу найрагчид.

**Шура:** Сурений нэр. Зөвлөлдөх, саналаа хэлэлцэх.

## Ы

**Ыхлас:** Сурений нэр. Аливаа зүйлийг чин сэтгэлээр үйлдэх, мөргөл залбиралыг үнэн сүсэгээр, зүрх сэтгэлээрээ үйлдэх.

## Э

**Эн зэрэгцүүлэгч:** Аллаштай, түүний шинж тэмдэгтэй бусдыг эн зэрэгцүүлэгч этгээд.

## Ю

**Юнус:** Сурений нэр. Нэгэн гэгээн элчийн нэр.

**Юсуф:** Сурений нэр. Нэгэн гэгээн элчийн нэр.

## Я

**Яжуж-Мажуж:** Эрт үед амьдарсан, ихэнх нутагт үймээн самуун тарьж байсан, дарангуйлагч ардууд.

**Якуб:** Нэгэн гэгээн элчийн нэр.

**Ясин:** Сурений нэр. Я, син гэдэг хоёр араб үсэг.

**Ясриб:** Мадина хотын хуучин нэр.

**Яхия:** Нэгэн гэгээн элчийн нэр.

**Яхуза:** Гэгээн элч Юсуфын ахан дүүсийн нэг.

НЭР ТОМЁОНЫ ЛАВЛАХ

А

- Аллах байгаа гэсний нотолгоо:** 7/26; 10/31-36; 14/10; 21/30-33; 22/5-6, 61-62; 23/48-49; 29/61; 30/20-25, 46; 31/29-31; 36/33-44, 71-73; 39/21, 38; 41/9-13, 37-39, 53; 42/29, 32; 45/3, 6; 88/17-22
- Аллах бүтээсний тухай:** 3/26-27; 6/14, 73, 95, 101; 7/54; 10/3, 31; 13/16; 21/30; 24/45; 25/1-2, 54; 30/17-19; 32/6-7; 37/94-96; 39/62; 40/61-62; 42/49; 51/49; 54/49-50; 87/1-4
- Аллах Ислам шашныг төгс болгосон нь:** 2/150; 5/3, 6; 12/4-6; 16/81; 48/1-3
- Аллах үр хүүхэдгүй:** 2/116-117; 4/171; 6/100-101; 10/68-69; 17/111; 18/2-4; 19/34-35, 88-92; 21/26; 23/91-92; 25/1-2; 37/149-152; 39/4; 43/81-82; 72/3; 112/1-4
- Аллах хань ижилгүй:** 6/101; 72/3
- Аллах хүмүүнийг зөв замд залах:** 2/272; 4/174-176; 6/161; 7/42-43; 10/35; 13/31; 16/9; 18/23-24; 19/58; 22/23-24; 25/31; 26/75-78; 29/69; 33/4; 48/1-3, 20; 64/11; 76/2-3; 87/1-3; 90/7-10; 92/12
- Аллах цорын ганц гэдэгт нотолгоо:** 6/40-41, 46; 16/1-18; 21/22; 23/71; 27/59-64; 40/61-65
- Аллах цорын ганц:** 2/133, 163, 255; 3/2, 6, 18, 62-64; 4/87, 171; 5/72; 6/3, 19, 102, 106; 7/59, 65, 73, 85, 140, 158; 9/31; 10/90; 11/14, 50, 61, 84; 13/16, 30; 14/52; 16/2, 22, 51; 17/42, 46, 111; 18/26, 50; 20/8, 14, 98; 21/22, 25, 87, 108; 22/34; 23/23, 32, 116; 25/1-2; 26/213; 27/26, 60-64; 28/70-72, 88; 29/46; 34/27; 35/3; 37/1-4; 38/65; 39/4, 6; 40/1-3, 61-66; 41/6; 43/84; 44/8; 51/51; 59/22; 60/4; 64/13; 73/9; 112/1
- Аллахаас айгсадын мөн чанар:** 5/94; 10/15; 14/12-14; 16/49-50; 22/34-35; 23/57, 61; 24/36-37; 39/11-14; 50/45; 55/46, 76; 76/6-10; 79/40-41
- Абил ба Кабил:** 5/27-32
- Абу Лахаб ба түүний эхнэр:** 111/1-5
- Авилга хахууль:** 2/188
- Аврал, аз жаргалыг ологсод:** 2/1-5; 3/104, 185; 7/8, 157; 9/20-22, 88; 23/101-102, 109-111; 24/51-52; 28/65-67; 30/38; 31/1-5; 58/22; 59/9, 20; 64/16; 87/14-15; 91/7-9
- Аврал, аз жаргалыг олох:** 2/189; 3/130, 200; 5/35, 90, 100; 7/69; 8/45; 22/77; 24/31; 62/10
- Аврал, аз жаргалыг эс ологсод:** 6/21, 135; 10/17, 69, 77; 12/23; 16/116; 20/69; 23/117; 28/37, 82; 91/9-10
- Адам ба Хауаг диваажингаас гаргах нь:** 2/35-39; 7/19-27; 20/115-123
- Адам эцэг:** 2/30-38; 3/33-34; 4/1; 6/98; 7/11-12, 19-25, 189; 15/28-35; 17/61; 18/50; 19/58; 20/115-123; 38/71-72; 39/6

**Айлдал (уахи):**3/44; 4/163; 5/111;  
6/19, 50, 93, 106, 145; 7/116-117;  
8/12; 10/2, 15, 87, 109; 11/12, 36,  
37, 49; 12/3, 15, 109; 13/30; 14/13;  
16/43; 17/39, 73, 86; 18/27, 110;  
19/11; 20/13, 38, 48, 77, 114; 21/7,  
45, 73, 108; 23/27; 26/52, 63; 28/7;  
29/45; 33/2; 35/31; 38/70; 41/6, 12;  
42/3, 7, 13, 51-52; 43/43; 46/9; 53/4,  
10; 72/1;99/5

**Айлдвар:** 2/41, 129, 134, 231, 252; 3/4,  
7, 19, 58, 70, 98, 101, 108, 113,118,  
164, 199; 4/140, 155; 5/44, 75; 6/4,  
93, 98, 124, 126, 130,157, 158; 7/32,  
35, 37, 58, 126, 174; 8/2, 52, 54; 9/9,  
11, 65;10/1, 5, 17, 24, 71, 95, 101;  
11/1; 12/1; 13/1-2; 15/1; 16/104-105;  
17/59; 18/56-57, 105-106; 19/58;  
21/5; 22/16, 52; 23/66,105; 24/1,  
18, 34, 46, 58-59, 61; 25/73; 26/2;  
27/1; 28/2, 87;29/23, 49-50; 30/10,  
28; 31/2; 32/22; 33/34; 36/46; 39/59,  
71;40/4, 35, 56, 69; 41/3, 44; 45/6, 8,  
11, 31, 35; 46/26-27; 57/9, 17;58/5;  
62/2, 5; 64/10; 65/11; 68/15; 74/16;  
78/28; 83/13; 90/19

**Айлдваруудыг доог тохуу болгох:**  
2/14-15, 67, 231; 4/140; 9/65

**Айша-д (р.а) гүтгэлэг:**24/11-26

**Алиясэг элч:** 6/86; 38/48

**Аллахаас айх:** 2/150; 4/77; 5/3, 44;  
9/12-13, 18; 33/37-39; 35/18,  
37; 36/10-11; 39/23; 50/32-33;  
67/12;70/27; 79/26; 87/9-10

**Аллахаас айхыг ухуулах:** 7/59; 8/48;  
10/15; 11/25-26, 61- 63, 84, 102-  
103; 17/56-57; 23/57-60; 33/21;  
39/14-16; 42/31-35; 46/21; 60/6;  
70/19, 28

**Аллахаас бусдыг тахин шүтэх:**  
4/116-120; 5/76; 6/71; 7/189-198;  
10/18, 34-36, 66; 11/100-101, 109;

12/39-40; 13/14,16, 33; 14/35-36;  
16/17, 20-21, 72-76; 17/56-57, 67;  
18/52;19/41-42, 81-82; 20/87-89,  
97; 21/43, 61-67, 98-100; 22/11-  
13,62, 71, 73; 25/3, 55; 26/69-73,  
91-93; 28/64; 29/17; 30/12-13,28,40;  
31/10-11, 29-30; 34/22; 35/13-14,  
40; 36/23, 74-75;37/91-96, 123-  
125; 39/38, 43; 40/20, 41-43, 73-74;  
41/47-48;42/21; 43/86; 46/4-6, 28;  
53/19-23

**Аллахад бусдыг эн зэрэгцүүлэг-  
чид:** 2/165; 4/48, 116-121, 123;  
5/72; 6/40- 41, 56, 63-64, 88, 100,  
106, 136-140, 148-150; 7/189-190;  
9/3,7-11, 17, 28, 33, 113-114; 10/  
104; 11/101, 109, 113; 12/103-108;  
13/33-34; 14/30; 15/95-96; 16/26-  
27, 35, 53-57, 73-74, 86-88; 17/22,  
39-43; 18/14-15, 52; 19/81-82;  
21/24, 29; 22/31, 73-74; 23/117;  
27/60-64; 29/25; 30/30-35, 42;  
33/72-73; 37/149-164; 39/2-3, 8, 65;  
40/69-76; 41/4-13; 42/6, 9, 13, 21;  
43/15-25;46/5; 48/6; 53/19-23; 61/9

**Аллахад бусдыг эн зэрэгцүүлэх  
(Ширк):** 4/36; 6/14, 56, 151; 7/33;  
10/89, 105-106; 12/38; 13/36; 16/51,  
73, 74; 17/22, 39-40, 111;18/110;  
22/26, 31; 26/213; 28/88; 30/13;  
31/13; 40/66; 42/6;51/51; 72/18

**Аллахад бусдыг эн зэрэгцүүлэхэ-  
эс сэргийлэх:** 4/48,116-117; 5/72;  
12/38; 22/31; 39/65; 43/45; 72/1-  
2,19-20

**Аллахад итгэх:** 2/186; 3/179, 193;  
4/59, 65, 170-171, 173, 175;5/111;  
7/158; 10/106; 24/2; 46/31; 48/8-9;  
57/7-8; 61/10-12;64/7-9, 11

**Аллахад ойртох:** 56/10-26; 88-89;  
83/18-21, 27-28; 94/7-8; 96/13-19

**Аллахад сүсэглэн мөргөх:** 2/21; 4/36; 5/72, 117; 6/102, 7/29, 59, 65, 73, 85; 9/30-31; 10/3; 11/1-2, 50, 61, 84, 123; 13/36-37; 19/36, 65; 20/13-14; 21/25; 22/77; 23/23, 31-32; 27/45, 91-92; 29/16-17, 36; 36/20-22, 60-61; 39/2-3, 11, 14, 17, 65-66; 41/13-14; 43/64; 46/21; 51/56-57; 53/59-62; 71/2-4; 106/1-4

**Аллахад эсэргүүцэгчдийн шийтгэл:** 3/112; 4/14; 6/15-16; 11/59-60, 64-65; 33/36; 39/13; 72/22-24

**Аллахад эсэргүүцэхээс болгоомжлогсдын шан харамж:** 2/189, 194, 212; 3/15-17, 133-136, 172, 179, 196-198, 200; 5/27; 6/32; 7/35, 128, 156-157; 9/4, 7, 36, 123; 10/62-63; 11/49; 12/57, 90-91, 109; 13/35; 15/45-48; 16/30-32; 19/59-63, 71-72, 83-86; 24/52; 25/15-16; 38/49-54; 39/19-20, 33-35, 61, 73-74; 43/33-35, 67-73; 44/51-57; 47/15; 50/31-35; 51/15-19; 52/17-20; 54/54-55; 68/34; 69/48; 77/41-44; 78/31-36; 92/5-7, 14-21

**Аллахад эсэргүүцэхээс болгоомжлогсдын шинж тэмдэг:** 2/1-5, 65-66, 177, 3/113-115, 133-134; 7/156-157, 201-202; 19/59-63; 24/34; 38/28; 92/14-21

**Аллахад эсэргүүцэхээс болгоомжлох (Такуа буюу үнэн сүсгэл):** 2/41, 194, 196-197, 203, 223, 231, 233, 278, 282; 3/50-51, 102, 123-125, 200; 4/1, 131; 5/2, 4, 7-8, 11, 35, 57, 88, 100, 108, 112; 6/72, 155; 8/1, 69; 9/119; 11/78; 15/67-69; 16/2, 52; 22/1; 23/52; 26/106-110, 124-126, 130-132, 142-144, 150, 161-163, 177-179, 183-184; 29/16; 30/30-31; 31/33; 33/1, 55, 70-71; 39/10, 16; 43/63; 48/26; 49/1, 10; 57/28; 58/9; 59/18; 60/11; 64/15-16; 65/1-5; 71/3-4

**Аллахад эсэргүүцэхээс болгоомжлохыг ухуулах:** 2/21, 63, 103, 179, 183, 187, 194, 197, 223; 3/75-76, 120, 125, 172, 179, 186; 4/77, 128-129; 5/8, 65, 93; 6/32, 51, 69; 7/26, 35, 63, 65, 96, 128, 156, 164, 169, 171; 8/29; 9/36, 44, 108-109, 123; 10/6, 31; 11/49; 12/90, 109; 16/52, 128; 20/113; 22/37; 23/23, 31-32, 86-87; 24/52; 26/106-107, 124-126, 142-144, 161-163; 28/83; 37/123-124; 39/27-28; 47/36; 49/3, 13; 58/9; 65/2-5; 74/54-56

**Аллахыг санан дурсах (Зикр):** 2/152, 198, 200, 203, 230; 3/41; 5/4; 7/205; 8/45; 18/23-24; 33/41; 62/9-10; 73/8; 76/24-25

**Аллахыг санан дурсах мөн чанар:** 3/191-194; 33/35

**Аллахыг санан дурсахыг ухуулах:** 13/28; 22/34-35; 24/36-37; 29/45; 33/21; 87/14-15

**Аллахыг үнэнээр нь хүндэтгэх:** 2/45-46; 3/199; 17/107-109; 21/90; 23/1-2; 33/35; 57/16-17; 59/21

**Аллахыг хайрлах:** 2/165; 3/31-32

**Аллахыг шагшин магтах:** 2/30-32, 116; 3/41; 5/116; 6/100; 7/143, 206; 9/31; 10/9-10; 13/12-13; 15/97-98; 16/1, 3, 57; 17/1, 42-44, 90-93, 107-108; 19/10-11; 20/130; 21/19-20, 22, 26, 87; 23/91-92, 115-116; 24/15-16, 36-37, 41; 25/17-18, 58; 27/7-8, 63; 28/68; 30/17, 40; 32/15; 33/41-42; 34/40-41; 36/36, 83; 37/158-159, 180; 39/4, 67, 75; 40/7, 55; 42/5; 43/12-14, 82; 48/8-9; 50/39-40; 52/43, 48-49; 56/71-74, 95-96; 57/1; 59/1, 23-24; 61/1; 62/1; 64/1; 68/28-29; 69/51-52; 76/26; 87/1; 110/1-3

**Аллахыг шүүгч хэмээн үзэх:** 6/114; 7/87; 10/109; 12/80; 22/68-69;

24/47-51; 27/78; 33/36; 34/26; 39/3,  
46; 60/10

**Аллахын айлдвараар захирах,  
шүүх:** 4/105; 5/44-50

**Аллахын айлдарыг ашиг сонирхо-  
лын төлөө хэрэглэх:** 2/41, 79, 174;  
3/77, 187; 5/44; 9/8-9; 16/95

**Аллахын алдар нэрс:** 7/180; 17/110;  
20/8; 59/22-24

**Аллахын амлалт чин үнэн:** 3/9,  
152, 194; 4/87, 122; 6/133-134;  
7/44; 9/111; 10/4, 55; 11/45; 13/31;  
14/47; 17/107-108; 18/21,98; 19/59-  
61; 21/7-9, 95-97, 104; 22/47;  
25/15-16; 28/12-13;30/1-6, 58-60;  
31/8-9, 33; 32/12-13; 33/22; 35/5;  
36/51-52;39/19-20; 40/53-55, 77;  
45/31-32; 46/15-17; 48/27; 51/1-  
6;52/1-10; 56/88-96

**Аллахын андууд (Аллахад дотно гэ-  
гээн сүсэгтэнүүд):** 10/62-64

**Аллахын болгоон соёрхол:** 2/185,  
253; 3/108, 176; 4/27-28; 5/1, 6, 41,  
49; 6/125; 10/107; 11/34, 105-107;  
13/10-11; 22/14-16; 28/4-6;33/17,  
33; 36/20-24, 82; 39/4, 37; 51/56-  
57; 74/31; 85/12-16

**Аллахын бүтээлийн тухай бодох:**  
2/164; 3/190; 7/185; 10/6, 67, 101;  
12/105; 13/3-4; 16/10-13, 48, 65-  
69, 79; 21/30;22/18, 63, 65; 24/41,  
43-44; 25/45-46; 26/7-8; 27/86;  
29/44;30/8, 20-25, 37, 50; 31/20,  
29, 31; 32/26-27; 35/27-28; 36/71-  
73; 39/21; 42/32-33; 45/3-6; 46/33;  
50/6-11; 51/20-21; 56/71-73; 67/19;  
86/5-7; 88/17-20

**Аллахын гэрчлэл:** 3/81, 98; 4/79, 166;  
5/117; 6/19; 9/107; 10/28-29, 46;  
11/54; 13/43; 17/96; 21/78; 29/52;

33/55; 34/47; 41/53; 46/8; 48/28;  
63/1; 85/4-9

**Аллахын ертөнцөд зориулсан хууль  
журам:** 17/77; 33/38, 60-62; 35/43;  
40/83-85; 48/22-23

**Аллахын замаас төөрөгдүүлэх:**  
4/167; 7/44-45, 86; 9/34; 11/18- 19;  
14/3; 16/88; 22/25

**Аллахын зарлигийг биелүүлэх:**  
2/186; 3/32, 130-132; 4/13, 59, 69-  
70, 80; 8/1, 20-21, 24; 9/71; 24/52,  
54, 56; 33/33, 70-71; 42/36-39,  
47; 46/31-32; 48/17; 49/14; 58/13;  
64/15-16

**Аллахын ижил үгүй:** 19/65; 42/11;  
112/1-4

**Аллахын мэргэн ухаан:** 2/250-251,  
269; 17/39

**Аллахын нигүүлсэл:** 2/63-64, 178;  
3/157; 4/83, 95-96, 113; 6/12, 15-16,  
54; 7/148-149; 10/11, 57-58; 11/43,  
47, 62-63, 72-73,118-119; 12/91-92;  
17/8, 50, 86-87; 18/15-16; 19/1-3,  
20-21,49, 53; 21/83-84, 107; 23/74-  
75, 109, 118; 24/10, 14, 20-21;28/46,  
86; 30/46, 50; 35/2; 36/41-44; 40/7;  
42/28, 47-48; 43/31-32; 44/1-6, 42;  
67/28; 90/11-18

**Аллахын нигүүлсэлд хүрэгсэд:** 3/47;  
7/55-56, 156-157; 9/20-21, 99;  
11/58, 66, 94; 12/56; 18/65; 21/74-  
75, 85-86;29/20-21, 51; 33/43;  
40/8-9; 45/29-30; 47/7-8; 48/25;  
57/28;76/30-31

**Аллахын өршөөлийг гуйх:** 2/198-  
199, 285-286; 3/159, 193; 4/106;  
7/155; 11/52-53, 61, 90; 12/29, 96-  
98; 14/41; 24/62; 38/34-35; 40/7;  
41/6; 47/19; 48/11; 59/10; 60/5;  
66/8; 71/9-10,26-28

**Аллахын сонсох тухай:** 3/181; 58/1

**Аллахын сүр хүч, ид шид:** 2/19-20, 106, 109, 148, 255, 259, 284; 3/26-27, 29, 165, 189-190; 4/132-133; 5/17, 19, 40, 120; 6/17, 37, 65,95-99, 133-134; 8/41; 9/38-39; 10/34, 53; 11/4, 19-20, 32-33;12/21; 13/12-13; 14/19-20; 16/45-46, 65-69, 77-81; 17/67-69, 99; 18/45; 19/8-9, 20-21; 20/51-54; 21/30-33; 22/5-6, 60-61, 65, 70; 23/95; 24/45; 25/45-54, 61-62; 26/7-8; 27/60-64; 28/71-73, 29/19-22; 30/20-25, 46, 50, 54; 31/16, 27-31; 32/27; 34/9, 15-19; 35/1, 12, 41, 44; 36/33-44, 71-73, 79-83; 39/5-6, 51; 40/79-81; 41/9-12, 37-39, 53; 42/9, 29-34, 49-50; 43/40-42; 46/31-33;48/20-21; 51/58; 57/2; 59/6; 60/6-7; 64/1; 65/12; 66/8; 67/1;68/17-20; 70/40-41; 71/13-20; 72/12; 75/3-4; 77/20-23; 79/27-33; 80/24-32; 88/17-20

**Аллахын талыг баригсад:** 5/56; 58/22

**Аллахын төлөө амь үрэгдэх:** 2/154; 3/169; 4/69

**Аллахын төлөө зарцуулах:** 2/3, 177, 215, 219, 254, 261-262, 267, 270, 272-274, 276; 3/16-17, 92, 133-134; 4/39, 114; 8/2-3, 60; 9/34-35, 99, 103-104, 120-121; 13/22; 14/31; 22/34-35; 28/51-54, 77; 32/15-16; 34/39; 35/29; 42/36-38; 47/36-38; 51/15-19; 57/7, 10-11; 59/9; 61/10-12; 63/10-11; 64/15-17; 70/19-25; 74/38-44; 76/5-9; 90/11-16; 92/17-18

**Аллахын төлөө тулалдах:** 2/190-195, 216; 4/71-76, 84; 8/17, 38-40, 64-66; 9/5, 12-15, 29, 36, 41, 91, 122-123

**Аллахын үг чин үнэн:** 4/87, 122; 6/73, 115, 146; 7/4-7; 11/120; 33/4; 34/23

**Аллахын үзэн ядсан хүмүүс:** 2/190, 204-205; 3/32, 57, 140; 4/36, 107; 5/64, 87; 6/141; 7/55; 16/23; 22/38; 28/76-77; 30/44- 45; 31/18; 42/40; 57/22-23

**Аллахын хайр хишиг:** 2/250-251; 6/46; 7/10, 26, 69, 74, 86; 10/22, 35,57-60, 67; 11/61; 12/38, 67-68; 14/32-34; 15/16-22; 16/18, 53,65, 69, 72, 78-83, 25/45-50; 26/132-134; 27/63, 73; 29/67;30/20-25; 31/20, 24, 27; 32/6-9; 35/3; 40/61; 42/10-11; 43/9-14,26-29; 45/12-13; 49/7-8; 55/1-4; 62/2-4; 67/23; 76/2; 79/27-33;80/17-20; 90/7-10

**Аллахын хайр энэрэлд хүрэгсэд:** 2/195, 222; 3/76, 134, 146-148,159; 5/13, 42, 54, 93; 9/108; 49/9; 60/8; 61/4

**Аллахын хүсэл, таалал:** 2/90, 105, 142, 212-213, 220, 255, 269, 272; 3/13, 26, 37, 40, 72-73, 129; 4/48-49, 116, 132-133;5/17-18, 40, 48, 54, 64; 6/35, 39-41, 80, 83, 106-107, 111-112,133, 137, 148; 7/88-89, 155-156, 175-176, 188; 9/14-15, 26-28;10/25, 49, 99, 107; 11/32-33, 105-108, 118-119; 12/56, 99, 110;13/12-13, 26-27, 31, 38-39; 14/4, 11, 19-20, 27; 16/1-2, 9, 35,93; 17/54, 86; 18/23-24; 22/18; 23/23-24; 24/21, 43, 45-46;25/10; 27/87; 28/56, 82; 29/20-21, 62; 30/2-5, 37, 48, 54; 32/13;33/23-24; 34/9, 36, 39; 35/1, 8, 15-17, 22; 36/41-43, 47, 65-67;39/23, 52, 68; 40/14-15; 42/7-8, 12-13, 19, 27, 29, 32-33, 49,52-53; 43/19-20, 60; 47/4, 29-30; 48/14, 27; 53/26; 56/63-70;57/21, 28-29; 59/6; 62/2-4; 74/31, 54-56; 76/28-31; 80/17-23;81/27-29; 82/6-8; 87/6-7

**Аллахын шударга ёс:** 2/281; 3/25, 108, 117, 161, 182; 4/40, 49, 77, 124; 6/160; 8/50-51, 60; 9/70;

10/4, 44, 47, 54; 11/100-101, 111, 117; 16/33, 111, 118; 17/71; 18/49; 19/60-61; 20/112; 21/47; 22/10; 23/62; 26/208-209; 28/59; 29/39-40; 30/9; 34/25-26; 36/54; 39/69, 75; 40/17,20,30-31; 41/46; 45/22; 46/19; 50/29; 99/6-8

**Аллахын энэрлийг хүсэх:** 2/286; 3/8; 7/155; 17/23-24; 18/9-10; 23/108-111, 117-118

**Аллахын эрдэм ухаан:** 2/29-33, 76-77, 94-96, 139-140, 215-216, 220,231, 233, 235, 255, 270-271, 273, 282-283; 3/5, 29, 62-63, 65-66, 92, 115, 119; 4/32, 39, 45, 63, 69-70, 127, 166-167; 5/7, 61,97, 99, 109; 6/3, 53, 58-60, 73, 80, 101, 116-117, 119, 124; 7/7,89, 187; 8/75; 9/16, 42, 44, 47, 78, 94, 101, 105, 115; 10/18, 36,40, 61; 11/5-6, 13-14, 31, 91-92, 110-112; 12/19, 50, 74-77;13/8-10, 42; 14/38; 15/24; 16/18-19, 22-23, 27-28, 70, 74, 91,125; 17/25, 47, 54-55, 84-85; 18/22, 25-26; 19/70; 20/7, 51-52,98, 103-104, 109-110; 21/4, 26-28, 51, 81, 110; 22/67-68, 70,75-76; 23/17, 51, 91-92; 24/19, 27-30, 35, 41, 53, 63-64; 25/5-6, 58-59; 26/186-188; 27/24-25, 74-75, 88, 93; 28/56, 69, 85;29/1-3, 10-11, 42, 45, 52, 62; 30/54; 31/16, 23, 27, 29, 34; 32/5-6; 33/2, 9, 18-19, 40, 51, 54, 63; 34/2-3, 10-11; 35/8, 11, 14, 38,45; 36/16-17, 76-77, 79; 39/7, 46, 69-70; 40/7, 15-16, 19; 41/22,53-54; 42/12, 24-25, 27, 49-50; 46/8, 22-23; 47/19, 25-26, 30;48/11, 18-19, 24, 26-27; 49/1, 13, 16, 18; 50/16, 45; 53/29-32;57/3-6, 22, 25; 58/3, 5-7, 11-13; 59/18; 60/1-3, 10; 62/6-8; 64/2-4, 11, 17-18; 65/12; 66/3; 67/13-14, 19; 68/5-7; 69/48-49;72/25-28; 74/31; 79/42-44; 84/10-13, 23; 87/6-7; 100/9-11

**Аллахын эрхшээл, удирдлага:** 2/26, 247, 253, 255, 272; 3/6,13, 26, 37, 40, 72-74, 129; 5/1, 48, 54, 117-118; 6/17-18, 35, 39,83, 88, 106-107, 111-112, 133, 137, 148-149; 7/88-89, 100, 128,155-156, 175-176, 188; 9/105-106, 116; 10/3, 25, 99-100, 107;12/56, 74, 76, 100; 13/13, 26-27, 31, 38-39, 41; 14/4, 10-11, 27

**Аллахын ярих тухай:** 2/253; 4/164; 7/143-144; 20/9-48; 27/7- 12; 28/29-35; 78/38

**Алчуур зөөх:** 24/31, 60; 33/33, 53-55, 59

**Амлалт өгөх:** 2/27; 3/35; 22/27-29; 33/23; 76/5-7

**Амьтад:** 2/164; 6/38, 142, 146; 16/5-8, 66, 68-69, 80; 22/36-37, 65; 23/21-22; 24/41, 45; 31/10; 35/27-28; 36/71-73; 39/6; 40/79-81; 42/11, 29; 43/12-14; 45/12-13; 45/3-4; 67/19; 79/27-33; 80/24-32; 81/1-6; 88/17-21; 100/1-6;

**Амьтны сэг:** 5/3

**Ан агнах:** 5/1-2, 4, 94-96; 16/14

**Андгай тангараг зөрчихийн шийтгэл:**5/89

**Андгай тангараг:** 2/224-225; 3/77; 5/89; 16/92-96; 58/14-17; 63/1-2; 66/1-2; 68/1-12

**Арилжаа наймаа:** 2/14-16, 282; 4/29; 9/24; 24/36-37; 35/29-30; 62/11

**Арилжаа наймаа:** 2/275, 282; 3/77, 177, 187, 199; 4/74; 5/44; 9/9; 12/19-21; 14/31; 24/36-37

**Ариун газар:** 5/21 **Арафат:** 2/198

**Ариун мөн чанар:** 2/273; 23/1-7; 24/33; 33/35; 70/19-31



**Ариун судрын эзэд:** 2/62, 105, 111, 113, 120, 135-141, 145-146; 3/19-25, 64-73, 78, 98-101, 110-115; 4/153, 159, 171; 5/12-19, 41-53, 57-69, 72-77, 82-85; 22/17; 29/46-47; 57/29; 59/2, 11; 98/1-6

**Ариун тулалдаан:** 3/142; 5/35; 9/19, 41, 73, 81-83, 86-88; 22/78; 25/52; 29/69; 61/10-12; 66/9

**Ариун тулалдаанд орогсодын мөн чанар:** 2/218; 4/95-96; 8/72-75; 9/20-22; 16/110; 29/6, 69

**Ариуслын өглөг өгөгдөх газрууд:** 9/60; 30/38

**Ариуслын өглөг:** 2/43,83,110,177, 277; 4/77,162; 5/11-12, 55; 6/141; 7/156; 9/5-11, 18, 60, 71; 19/31, 54-55; 21/73; 22/41, 78; 23/1-4; 24/56; 27/1-3; 30/38-39; 31/1-4; 33/33; 41/6-7; 58/13; 70/19-25; 73/20; 98/4-5

**Бадауйчүүд:** 9/97-99, 101, 120-121  
**Барьцаа:** 2/283

**Бадирын дайн:** 3/13, 123-128; 8/5-9, 41-49, 64-67; 59/14-15

**Бисмиллахын айлдвар:** 27/29-30

**Болгоомжтой байх:** 4/71, 94; 5/92; 9/122 **Ариун цэвэр:** 74/1-4; 9/107-108; 35/18

**Боол чөлөөлөх:** 2/177; 4/92; 5/89; 9/60; 24/33; 58/3; 90/11-16

**Бороо, хур:**2/21-22, 164; 6/99; 7/57; 8/11; 13/17; 14/32; 15/22; 16/10, 65; 20/51-53; 22/5, 63; 23/18; 24/43; 25/48; 27/60, 63; 29/63;30/24, 46, 48; 31/10, 34; 32/27; 35/27; 39/21;

**Асхаб Кахф буюу агуйн нөхдүүд:** 18/9-26

**Атаархах:** 2/109; 4/54; 5/27-31; 48/15; 113/1-5

**Ашиг олох:** 2/14-16, 78-79, 200-202, 225, 264, 267, 281; 3/25, 155; 4/32, 88, 110-112; 6/3, 70, 120, 128-129, 164; 7/38-39, 96; 9/81-82,95; 10/7-8, 27, 50-52; 11/85-86; 13/33, 42; 14/18, 49-51; 15/80-84; 18/58; 31/34; 33/58; 35/45; 36/63-65; 39/24, 47-51; 40/17, 82; 41/17; 42/22, 30, 32-34; 45/7-10, 14, 22; 83/10-14; 111/1-3

**Аюул тохиоход итгэн сүсэглэх:** 4/18; 6/158; 10/90-92; 26/200-203; 32/28-30; 34/51-52; 40/82-85; 44/10-

**Аюултай үед уншлага мөргөл:** 2/238-239; 4/102-103 **Айкэгийн ард олон:** 15/78-79; 38/13; 50/14

**Аялагчийн уншлага мөргөл:**4/101 **Аянга цахилгаан:** 13/12-13; 24/43; 30/24

## Б

40/13; 41/39; 42/28; 43/9-11; 45/3-5; 50/9-11; 56/68-70; 78/14-16; 80/24-32

**Булш:** 9/84; 22/7; 35/22; 60/13; 102/2

**Буруу номтнуудтай бүү андлах:** 3/28; 4/89, 144; 5/51, 57; 9/23-24; 58/22; 60/8-9, 13

**Бусдад харуулах зорилгоор мөргөл үйлдэх:** 4/36-38; 8/47; 107/4-7

**Бусдыг зовоон гарчлаах:** 2/191, 193, 217; 8/39

**Буян үйлдэгсэдийн шан харамж:** 2/195; 3/133-134, 148; 4/40; 5/84-85, 93; 6/84,160; 7/56; 9/91, 120; 10/26; 11/114-115; 12/22, 56, 90;

16/30,128; 22/37; 27/49; 28/14,84;  
29/69; 31/1-5, 22; 33/29; 37/80, 104-  
105,119-121, 129-131; 39/10, 33-35;  
42/22-23; 46/12; 51/15-16; 53/31-  
32;77/41-44

**Буян үйлдэх:** 2/110, 148, 197, 215;  
3/113-115; 4/114, 127, 149; 5/48;  
21/72-73, 89; 22/77; 23/57-61; 73/20

**Буян үйлдэх:** 2/112, 195; 3/172; 4/128;  
5/93; 7/35; 12/22; 16/90, 128; 18/30;

28/14; 29/69; 37/78-80, 108-110,  
119-121,129-131; 51/15-16

**Бүрээ бишгүүр үлээгдэх:** 18/99;  
20/101-102; 23/101; 27/87; 36/51;  
39/68; 50/19-21; 69/13-15; 74/8-10;  
78/17-18

**Бэйгат (Мухаммедэд анх захираг-  
дагсдын андгай):** 48/10, 18; 60/12  
**Бямба гараг:** 2/65; 4/47; 7/163

## Г

**Гахай:** 2/173; 5/3, 60; 6/145; 16/115

**Гол мөрнүүд:** 13/3; 14/32; 16/15;  
27/61; 36/34

**Гузайр (гэгээн элч):** 2/259; 9/30

**Гүтгэгсэд:** 7/152; 11/50; 16/56, 87, 105,  
116; 28/75; 29/12-13; 46/27-28

**Гэгээн элч Аллаx хоорондын яриа:**  
2/124, 260; 3/40- 41; 7/143-144;  
19/7-10; 20/9-48, 83-85; 26/10-17;  
28/29-35

**Гэгээн элч Аюб:** 4/163; 6/84; 21/83-84;  
38/41-44

**Гэгээн элч Дауид:** 2/250-251; 4/163;  
5/78; 6/84; 17/55; 21/78-80; 27/15;  
34/10-13; 38/17-30

**Гэгээн элч Мухаммедийн эхнэрүүд:**  
33/6, 28-34; 66/1-5 **Гэгээн элчийг**  
**дагах:** 3/31; 33/21

**Гэгээн элч мэлэx хоорондын яриа:**  
11/69-83; 15/51-65, 72-76; 29/31-35

**Гэгээн элч нар Аллаxын ач тусаар:**  
6/34; 9/40; 10/103; 11/58, 66, 94;  
12/110; 21/69-71, 74-77; 29/14-15,  
24, 31-33; 37/97-98, 114-117, 171-  
173; 40/51; 48/1-3; 54/9-14, 33-  
35;58/21; 59/6

**Гэгээн элч нар Аллаxын хайр ивээ-**  
**лд:** 4/113, 166; 6/161; 9/40; 11/48,  
58, 66, 94; 12/5-6, 15, 21-22, 24, 33-  
34, 37-38, 54-56, 90, 99-101, 110;  
14/13-14; 17/74-75, 86-87; 19/49-  
57; 20/25-41; 21/51, 68-90; 23/26-  
30, 39-41; 26/20-21, 117-120, 168-  
173;27/16, 38-40; 28/7-14, 23-25,  
30-31, 85; 29/14-15, 24, 27, 31-34;  
37/75-81, 99-122, 129-135, 139-148;  
38/17-20, 34-43, 45-47; 39/36,40;  
48/26; 54/33-35; 87/6-8; 93/1-8;  
94/1-4; 108/1-3

**Гэгээн элч нар Аллаxын хамгаа-**  
**лалтанд:** 5/67; 15/95-96; 20/65-  
69; 21/69-71; 29/24, 32-34; 37/97-  
98, 114-115, 139-147

**Гэгээн элч нарыг итгэн дагах:** 3/32,  
50-51, 132; 4/13, 59, 69, 80; 5/92;  
8/1, 20-21, 45-46; 9/71; 24/52, 54,  
56; 26/105-110, 123-131, 141-  
150,160-162, 176-179; 33/33, 70-71;  
43/63-64; 46/30-31; 47/33; 48/17;  
49/14; 58/12-13; 64/12; 71/1-4

**Гэгээн элч нарын зарим нь зарима-**  
**ас дээгүүр:** 2/253; 17/55

**Гэгээн элч нарын сорилтод өртөх**  
**нь:** 2/124; 20/40; 37/101-106;  
38/34- 40

**Гэгээн элчтэй ярих ёс зүй:** 2/104;  
3/44-46; 24/63; 49/3-8; 58/8

**Гэгээн элчүүд бол хүмүүн:** 3/144;  
13/38; 14/10-11; 17/90-94; 18/110;  
21/3-8; 23/23-24, 32-34, 45-47;  
25/20; 36/13-15; 41/6

**Гэгээн элчүүд нүгэлээс хамгаалагдсан:** 3/38-39, 161; 5/67; 12/23-24,  
33-34; 17/73-77; 38/45-47

**Гэгээн элчүүд сургаж өгөхөд ямар ч төлөөс хүсэхгүй:** 6/90; 10/71-72;  
11/29, 50-51; 12/103-104; 23/72;  
25/57; 26/105-109, 123-127, 141-145,  
160-164, 176-180; 34/47;  
36/20-21; 38/86; 42/22-23

**Гэгээн элчүүдийг илгээх:** 2/87, 101,  
119, 129, 151; 4/79, 170; 5/15-16,  
19, 32; 6/130; 7/35, 42-43, 52-53,  
59, 61, 65-67, 104; 9/33, 128-129;  
10/74; 11/96-97; 12/109; 13/30,  
38; 14/5; 15/10-11; 16/1-2, 36, 43-44,  
63, 113; 21/7-8, 25, 107; 22/52;  
23/23, 31-32, 42-46; 28/44-45;  
30/47; 33/45; 36/1-4, 13-17; 37/71-73,  
123-124, 133-135, 139-148;  
40/23-24, 78; 41/13-14; 42/51; 43/6-7,  
26-29, 45; 44/3-5, 10-13; 48/8;  
51/38-39; 57/25-27; 61/6, 9; 62/2-4;  
65/8-11; 71/1; 73/15-16

**Гэгээн элчүүдийг илгээхийн учир шалтгаан:** 2/151; 3/20, 164; 4/64,  
79-80, 105, 164-165; 5/15, 19, 92,  
98-99; 6/19, 48-49, 91; 7/1-2, 60-63,  
66-69, 76-79, 182-184, 188; 9/33;  
10/1-2; 11/1-2, 12, 25, 88; 13/7,  
30, 40; 14/1, 5, 44; 15/88-89; 16/1-2,  
35, 43-44, 64, 82-83; 17/59, 105;  
18/56; 19/97; 21/107; 22/49-51, 78;  
24/54; 25/56; 26/105-107, 114-115,  
123-125, 141-143, 160-162, 176-178,  
192-194; 27/91-92; 28/46-47;  
29/18, 50; 32/1-3; 33/45-47; 34/28,  
46; 35/23-24; 36/1-6, 10-11, 15-17,

70; 38/65-70; 39/41; 40/15, 18; 42/6-7,  
47-48, 52; 43/63; 46/9, 23; 48/8-9,  
28; 50/28, 45; 51/50-51; 52/29;  
57/8; 60/6; 62/2-3; 64/12; 65/8-11;  
67/24-26; 71/1-3; 72/22-23; 79/42-45;  
87/8-10; 88/21-23

**Гэгээн элчүүдийг шоглох:** 6/10; 9/65;  
13/32; 15/11; 21/41; 36/30; 43/7

**Гэмшигсдийн мөн чанар:** 2/54, 159-160,  
222; 3/86-90; 4/16-18, 145-146;  
5/38-39; 6/54; 7/143, 153, 155-156;  
9/10-11, 117-118; 11/1-3, 52, 110-112;  
16/119; 17/25; 19/58-63; 20/82, 120-122;  
24/4-5; 25/68-71; 28/65-67; 33/23-24, 72-73;  
34/9; 39/17-18; 40/7, 9, 13; 42/10, 13;  
46/15-16; 49/11; 50/31-32; 58/12-13;  
60/4; 66/8

**Гэмшил нь хүлээн зөвшөөрөгдөөгүй хүмүүс:** 3/90; 4/18

**Гэмшил:** 2/54, 187; 5/33-34, 70-71, 73-74;  
7/143; 9/3, 14-15, 25-27, 73-74,  
101-106; 11/1-3, 61, 89-90; 20/82;  
24/31; 28/65, 67; 30/30-31; 38/21-24;  
39/53; 42/25; 66/3-4, 8; 78/38-39

**Гэмшлийн хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл:** 2/159-160; 3/86-89; 4/16-17,  
145-146; 5/34, 38-39; 6/54; 7/153;  
9/5, 7-11; 16/119; 19/58-60; 20/82;  
24/4-5; 25/68-71; 28/65-67; 39/53-54

**Гэр бүл салалт:** 2/227-232, 236-237,  
241; 33/49; 65/1-7

**Гэр бүлд эрэгтэй:** 2/187, 228; 4/34;  
20/132; 66/6 **Гэр бүл дахь эмэгтэй:** 2/223

**Гэрлэлт:** 4/3-4, 19-28, 34-35, 128-130;  
5/5; 24/32-33; 33/36-38, 50-53;  
60/10-11; 64/14; 70/19-31

**Гэрлэх нь хоригдсон эмэгтэйчүүд:** 2/221;  
4/22-25; 60/10

**Гэрчлэл:** 2/282-283; 3/135 **Гэрчлэх шаардлагатай:** 2/282-283; 4/135; 5/106-108; 6/152; 33/70-71; 65/2; 70/33 **Гэрчлэхээс таггалзахгүй байх:** 2/139-140, 282-283; 5/106

**Гэрээ хэлэлцээрийг зөрчиж болох уу?:** 8/55-58; 9/12-13

**Гэсгээл:** 2/80; 3/23-24; 5/117-118; 6/40-41, 65; 7/155-156; 10/48-53;

11/8, 84, 105-107; 14/44; 16/45-47; 20/124-127; 22/49; 26/200-207; 27/71-72; 29/53-55; 32/18-21; 34/34-35, 42; 37/176-177; 39/24-26, 47-48; 41/43; 52/7-16; 54/9-42; 57/20; 70/1-3; 72/22-25; 73/11-14; 83/15-17; 85/12; 98/6

**Гэсгээлд нэрвэгдэгсэд:** 1/7; 4/93; 5/59-60; 8/15-16; 24/9; 48/6

**Д**

**Даган дууриасад:** 2/170; 7/173-174; 31/20-21; 37/68-70; 43/19-25

**Дайллага:** 5/112-115

**Дайнаас зугтах, зугтахсудын онцлог:** 8/15-16, 45; 3/153, 155; 8/15-16; 9/38-39, 93; 33/13-17; 48/16

**Дайнд мордохоос чөлөөлөгдөгсөд:** 24/61; 48/17

**Дайнд ялахын арга зам:** 3/13; 8/45-47; 22/38-40; 47/34-35

**Дайны олзод, олзлогдсон хүмүүс:** 8/67-71

**Дайсаны эсрэг бэлэн байх:** 3/139; 4/104; 8/60; 47/34-35

**Дайтах нь хоригдсон газар ба сарууд:** 2/191, 217

**Далай тэнгис:** 16/14; 18/60-61, 109; 22/65; 25/53; 27/61; 35/12; 45/12; 52/1-7; 55/19-23; 81/6; 82/3

**Далайн хөлөг онгоц:** 2/164; 10/22; 14/32; 16/14; 17/66; 22/65; 23/21-22; 30/46; 31/31; 35/12; 36/41-44; 40/79-81; 42/32-34; 43/12; 45/12; 55/24-25

**Далдын нууцын мэдээ:** 2/33; 5/109; 7/188; 10/20; 11/31, 49; 16/77;

18/25-26; 27/65, 75; 34/3, 14, 48; 35/38; 39/46; 41/47; 43/84-85; 49/18; 53/35; 57/25; 64/18; 67/25-26; 68/47; 72/26-28

**Диваажин:** 2/25; 3/15, 133, 136, 195-198; 4/13, 57, 122; 5/12, 84-85, 119; 9/72, 89, 100; 10/9; 13/35; 14/23; 16/30-31; 18/31; 19/60-63; 20/76; 22/14, 23; 25/15-16; 29/58; 35/33-35; 39/20; 47/12, 15; 48/5, 17; 52/17; 55/46-77; 56/10-38; 57/12, 21; 58/22; 61/12; 64/9; 66/8; 69/19-24; 81/13; 85/11; 88/8-16; 98/8

**Диваажинд орохсод:** 2/25; 3/107; 4/57; 7/42-49; 9/20-22; 10/9-10, 16; 11/108; 13/19-24; 14/23; 17/71; 18/30-31; 19/60-63; 22/23-24; 25/75-76; 28/83; 35/32-35; 36/55-59; 37/40-61; 38/49-54; 41/30-32; 42/20; 43/67-73; 44/51-57; 46/13-14; 50/31-35; 51/15-19; 52/17-28; 56/10-40; 59/20; 68/34-35; 69/19-24; 74/38-41; 76/5-22; 77/41-44; 78/31-36; 79/40-41; 83/22-28, 34-35; 88/8-16; 101/6-7

**Дирар сүм-мэсжид:** 9/107-110 **Дээрэмчид:** 5/33-34 **Дуурайлган хийх:** 2/170; 21/51-67; 31/21

**Е**

**Ертөнцийн төгсгөлийн өдөрт бэлтгэх:** 2/109; 14/31; 17/71-72; 30/43; 42/47; 56/83-96; 59/18; 69/13-37; 79/34-41; 80/33-42; 84/1-12; 102/1-8

**Ертөнцийн төгсгөлийн өдрийн онцлогууд:** 2/48, 113, 123, 165-167, 254, 281; 3/9, 25, 30, 55-57, 105-107, 185; 4/41-42, 87, 141, 159; 5/109-120; 6/12, 22-24, 27-30, 40-41, 93-94, 128-132; 7/8-9, 37-39; 10/28-30, 45, 47, 93; 11/59-60, 84, 102-108; 14/21-23, 31, 40-51; 15/36-38; 16/24-29, 77, 84-89, 92, 111, 124; 17/13-14, 49-52, 71-72, 97; 18/47-49, 52-53, 99-101; 19/37-40, 68-72, 81-87, 93-95; 20/99-112, 123-127; 21/39-40, 47, 95-104; 22/1-2, 17, 55-59, 68-69; 23/16, 76-77, 101-115; 24/23-25, 36-37; 25/17-31, 33-34; 26/87-103; 27/82-85, 87-88; 28/62-67, 74-75; 29/12-13, 25, 54-55; 30/12-16, 43-45, 55-57; 31/33; 32/12-14, 23-25, 28-30; 33/64-68; 34/23-26, 31-33, 40-42, 51-54; 35/14; 36/48-67; 37/20-34; 38/77-81; 39/24, 30-31, 47-48, 60-61, 67-75; 40/10-12, 15-20, 32-33, 44-46, 51-

52, 69-76, 82-85; 41/29, 47-48; 42/7-8, 15, 22, 44-47; 43/37-39, 67-68; 45/16-17, 26-35; 46/35; 50/20-35, 41-44; 51/12-14; 52/7-20, 45-46; 53/57-58; 54/1-8, 46-48; 55/37-45; 56/1-7, 47-56; 57/12-15; 58/5-7, 17-18; 60/3; 64/9; 66/7-8; 67/25-28; 68/42-43; 69/1-4, 13-37; 70/1-14, 42-44; 73/11-14, 17-18; 74/8-10; 75/3-15, 20-25; 76/4-22; 77/8-15, 35-40; 78/17-20, 37-40; 79/6-14, 34-41; 80/33-42; 81/1-14; 82/1-5, 17-19; 83/1-12, 34-36; 84/1-19; 86/8-10; 88/1-16; 89/21-30; 99/1-8; 100/9-11; 101/1-11

**Ертөнцийн төгсгөлийн өдрийн шинж тэмдэг:** 6/158; 54/1-2; 55/37

**Ертөнцийн төгсгөлийн тохиох хугацаа:** 7/187-188; 15/85; 17/99; 18/21; 22/7; 29/5; 31/34; 34/29-30; 38/15-16, 78-81; 40/59; 41/47; 42/17-18; 43/61-66, 85; 45/32; 47/18; 77/1-7; 79/42-46

**Ертөнцөд буй бүхний Аллаxын туншаалыг хүлээн зөвшөөрөх:** 3/83; 11/56; 13/15; 19/93-94; 22/18; 30/26; 55/5-6

## Ж

**Жабрайл:** 2/87, 97-98, 253; 16/102; 19/17, 19; 26/193; 53/6-13; 66/4; 70/4; 78/38; 81/19-21

**Жалут:** 2/249-251

**Жин буюу буг чөтгөр:** 6/100, 128, 130; 7/38, 179; 11/119; 17/88; 41/25,

29; 46/18, 29-32; 51/56-58; 55/33, 37-39; 72/1-19; 114/1-6

**Жуди уул:** 11/44

**Жумагийн уншлага мөргөл:** 62/9-10

## З

**Зааны эзэд (Асхаб фил):** 105/1

**Забур судар:** 4/163; 21/105

**Загас барих:** 5/96

**Зайд:** 33/37

**Закария (гэгээн элч):** 3/35-41; 6/85; 19/1-11; 21/89-90 **Закариягийн эхнэр:** 19/1-8; 21/89-90

**Залбиран хүсэх:** 2/186; 4/32; 6/63-64; 7/55-56, 180; 10/22; 12/85-86;

17/11, 110; 27/62; 32/15-16; 40/60, 65; 55/29

**Зальхай, харгисал үйлдэгсэд:** 2/59, 114, 140, 145, 165, 229, 254, 258, 270; 3/57, 93- 94, 117, 126-128, 140, 151, 192; 4/10, 97-99, 168; 5/29, 45, 51, 72; 6/21, 33, 42-45, 47, 52, 93-94, 128-129, 135, 144, 157; 7/4-5, 9, 37, 41, 44-45, 148, 165; 8/54; 9/19, 23, 70, 109; 10/13, 17, 39, 54, 106; 11/18-22, 37, 44, 67-68, 82-83, 94-95, 100-102, 116; 12/23, 74-75; 14/13, 22, 27, 42-46; 16/28, 85, 112-113; 17/82, 99; 18/15, 29, 35, 50-51, 57-59, 87; 19/38, 72; 20/111; 21/3, 11-15, 29; 22/25, 48, 53, 71; 23/27, 41; 24/47-50; 25/7-9, 19, 27-29, 37; 26/227; 27/10-11, 44, 50-52, 83-85; 28/37, 40- 42, 50, 59; 29/14, 31-33, 49, 68; 30/9, 29, 57; 31/10-11; 32/22; 34/19, 31-33, 42; 35/37, 40; 37/22-39; 39/24, 32, 47-48, 51;40/18, 51-52; 42/7-9, 21-22, 40-46; 43/39, 63-66, 74-76; 45/18-19; 46/10, 12; 49/11; 51/59; 52/47; 53/50-52; 59/17; 60/9; 61/7-8; 62/5; 65/1; 68/29; 76/30-31

**Зина (ёс бусын хурьцал, садар самуун):** 4/16-19, 25-26; 17/32; 23/1-7; 24/2-3; 25/68-69; 60/12; 70/19-31

**Зина үйлдэв хэмээн гүтгэх:**24/4-10, 23-25

**Зихар:**33/4; 58/1-4

**Зочлох ёс:** 24/27-29, 58-59, 61; 33/5

**Зөв замаар хөтлөгсөд:** 2/213; 22/16, 54; 24/35, 46; 28/56; 39/17-18, 23; 42/13, 52

**Зөв замаар хөтлөгсөдийн мон чанар:** 2/155-157; 6/125; 7/128; 9/18; 18/17; 27/91-92; 36/20-21; 39/37, 41; 47/17

**Зөв шулуун зам:** 1/6-7; 3/51, 101-102; 4/66-68, 174-175; 5/15-16; 6/126, 153, 161; 11/56; 14/1; 15/41; 16/9; 19/36; 22/23-24, 67; 23/73-74; 34/6; 36/1-4, 60-61; 42/52-53; 43/43-44, 61-64; 48/1-3, 20

**Зөв шулуун замыг баримтлах:** 1/6-7; 2/53, 150; 3/103; 6/117; 7/158; 16/15; 20/82; 23/49; 32/3

**Зөвлөлдөх:** 2/233; 3/159; 42/38

**Зулкарнай:** 18/33-98 **Зулкифил (гэгээн элч):** 21/85-86; 38/4

**Зүйр жишээ үзүүлэх:** 2/26; 14/44-45; 16/75-76, 112-113; 18/32- 44; 22/73-74; 25/37-39; 30/28, 58-59; 36/13, 78; 39/27-29; 43/57-58; 66/10-12; 74/31

**Зүрх:** 7/43; 10/57; 13/28; 23/78; 32/9; 33/4

**Зүүд:** 12/5, 36-37, 41, 43-49, 100; 17/60; 37/105; 48/27; 14/6; 17/101-102; 28/3-4, 6, 8-9, 32, 38-40; 29/39; 50/13;

## И

**Ибрахим (гэгээн элч):** 2/124-127, 130, 132-133, 135-136, 140, 260; 3/65, 67-68, 84, 95, 97; 4/54, 125, 163; 6/74-75, 83, 161; 9/70, 114; 11/69,74-76; 12/6, 38; 14/35; 15/51; 16/120, 123; 19/41, 46, 58; 21/51,60, 62, 69; 22/26, 43, 78; 26/69; 29/16,

31; 33/7; 37/83, 104, 109; 38/45; 42/13; 43/26; 51/24; 53/37; 57/26; 60/4; 87/19

**Ибрахимын гэр бүл:** 3/33-34; 4/54-55

**Ибрахимын үр сад:** 2/127-128; 3/33-34; 4/54; 6/84-90; 19/58; 21/72-73; 29/27; 37/112-113; 57/26

**Ибрахимын эхнэр:** 11/69-73; 51/24-30

**Иддет (гэр бүл салалтын дараа эмэгтэйн хүлээх хугацаа):** 2/228, 235; 65/1-4; 33/49

**Идрис (гэгээн элч):** 19/56-57; 21/85-86

**Ижил хүйстэний завхайрал:** 7/80-81; 27/54; 29/28-29

**Израйлийн үр сад ба Фиргаун:** 2/49-50; 7/117-128, 134-137, 141; 8/53-54; 10/90-92; 14/6; 17/103-104; 20/77-80; 26/52-68; 28/38-40; 43/54-56; 44/22-31

**Израйлийн үр сад гэгээн Мусаг гомдоож зовоох нь:** 33/69; 61/5

**Израйлийн үр сад Тых цөөлд:** 2/57; 5/24-26; 7/160; 17/101-104

**Израйлийн үр сад хориглогдсон үнээг алах нь:** 2/67-74 Тауратийн ёсыг зөрчих нь: 4/13, 66, 68

**Израйлийн үр садаас Аллахын шаардсан юмс:** 2/40-48, 54, 61, 63-64, 72-73, 122-123; 5/20; 7/161-162; 14/5-9; 17/2; 32/24

**Израйлийн үр садыг Аллахын энэрэх нь:** 2/47, 49-56, 122; 5/20; 7/138-140; 10/93; 20/47, 80-82; 40/53-54; 44/30-33; 45/16

**Израйлийн үр садын Аллахыг үзнэ хэмээн шаардсан нь:** 2/55-56; 4/153

**Израйлийн үр садын ариун зүйлсийг өөрсдөд нь бузар болгох нь:** 3/93-95; 4/160-161; 6/143-144

**Израйлийн үр садын ариун нутагт орших нь:** 2/58-59; 4/154; 5/20-26; 7/161-162

**Израйлийн үр садын бямба гарагийн ёсыг зөрчих нь:** 2/65-66; 4/47, 154; 7/163; 16/124

**Израйлийн үр садын гэгээн элч нарыг худал хэмээх нь:** 2/87-88; 3/184; 5/70-71; 6/57-58

**Израйлийн үр садын гэгээн элчүүдийг егүүтгэх нь:** 2/61, 87, 91; 3/112, 181-183; 4/154-155

**Израйлийн үр садын Жарейл элчийн эсрэг дайсагнал:** 2/97-98

**Израйлийн үр садын онцлогууд:** 2/76, 100; 3/21-24, 75, 78; 4/44-46, 49-55; 5/21-24, 41-43, 60-64, 78, 81; 6/91; 16/118; 58/8; 59/11-15; 62/5

**Израйлийн үр садын Таурат судар дахь зарим зарлигуудыг нууцлах нь:** 2/76-77, 146, 159-160, 174, 176; 3/77, 4/15; 6/91

**Израйлийн үр садын Таурат судрыг өөрчлөх нь:** 2/75, 78-79; 3/78; 4/44-46; 5/13, 41; 7/169-170

**Израйлийн үр садын тугалыг бурханчлах нь:** 2/51-52, 54, 92-93; 4/153; 7/148-155; 20/83, 93

**Израйлийн үр садын энэ хорвоог илүү үзэх нь:** 2/94-96; 62/6-8

**Израйлийн үр садын эсэргүүцснээс болж цээрлэгдэх нь:** 2/58-60, 63-66, 83-86, 92-93, 101, 211; 3/112; 4/45-46, 153-162; 5/12-14, 20-26, 32, 43, 49-50, 70-71, 78, 81; 6/146-147; 7/152, 155, 161-169, 171, 175-178; 16/118; 17/4-8; 20/83-97; 22/42-44; 61/5

**Илбэ ид шид зөн билэг:** 2/101-102; 7/104-122, 130-132; 10/75, 82;

- 20/56-73; 26/29-51, 183-189; 42/46-50; 113/1-5 **Илбэ увдис:** 113/1-4
- Илияс (гэгээн элч):** 6/85; 37/123-132
- Имраны гэр бүл:** 3/33-34 **Имраны эхнэр:** 3/33-37
- Инжил (Библи):** 3/3, 48, 65; 5/47, 110; 7/157; 9/111; 48/29; 57/27
- Инээх:** 53/42-43, 59, 62
- Исагийн гэгээн Мухаммедийн тухай баярт мэдээ:** 61/6 **Исагийн ер бус гайхамшиг:** 3/45-51; 5/110
- Исагийн мөн чанар:** 3/48-50; 4/171-173; 6/85; 19/27-35; 21/91; 23/50; 43/57-59
- Исагийн хауаричууд буюу туслачууд, бие төлөөлөгчид:** 3/52-53; 5/12-13; 57/27; 61/14
- Исагийн цорын ганц Аллахад уриалга:** 5/17, 72-75, 116-118; 9/30-31; 19/34-40; 33/7; 36/32; 42/13; 43/63-64; 61/6
- Исагийн энэггүй мэндэлсний тухай:** 3/45-47, 59-63; 19/16-30
- Исад Инжил ба бусад нотолгоонууд илгээгдэх:** 2/87, 253; 3/45-51; 5/46-47, 110; 19/29-30; 57/27; 61/6
- Ислам бүхий л гэгээн элчүүдийн шашин:** 2/132-133; 3/81-83 **Ислам:** 3/19, 85; 5/3; 6/125; 39/22; 61/7
- Ислам шашинт ард олны онцлогууд:** 2/142-143; 3/110; 9/122; 22/78; 35/31-32
- Ислам шашинт бус хүмүүсийг дурнах:** 3/105, 156; 8/21, 47; 33/69; 57/16; 59/19
- Ислам шашиныг сурталчлах:** 2/208; 3/102; 4/125; 6/14, 71, 162-163; 10/71-72; 11/13-14; 16/81; 21/108; 22/34; 27/81, 91; 39/11-12, 54; 40/66; 41/6, 33; 43/68-70; 46/15-16; 49/14
- Исмайл (гэгээн элч):** 2/125, 127, 133, 136, 140; 3/84; 4/163; 6/86; 14/39; 19/54-55; 21/85-86; 37/99-107; 38/48
- Исра ба Миграж (гэгээн Мухаммедийн сансар огторгуй болон бусад ертөнцөд аялал):** 17/1, 60; 53/1-18
- Исхак (гэгээн элч):** 2/133, 136, 140; 3/84; 4/163; 6/84; 11/71; 12/6, 38; 14/39; 15/51-53; 19/49-50; 21/72; 29/27; 37/112-113; 38/45-47; 51/24-28
- Итгэл ба мөргөл залбиралын харьцаа:** 2/25, 62, 82, 277; 4/57, 124, 172-173; 5/9, 69, 93; 7/42; 10/4; 13/29; 14/23; 18/30, 88, 107; 19/59-60, 96; 20/82; 22/14, 23, 49-50, 56; 24/55; 26/227; 29/7, 9, 58; 30/44-45; 31/7; 32/18-19; 34/4, 37; 35/7; 38/24, 28; 40/40, 58; 41/8; 42/22-23, 26; 45/21, 30; 47/2, 12; 48/29; 64/9; 65/11; 84/25; 85/11; 95/4-6; 103/1-3
- Итгэлийг урван тэрслэх:** 8/27
- Итгэн даатгагсад:** 3/121-122, 159-160; 4/11; 9/51; 10/84-85; 11/87-88; 12/67; 16/41-42; 29/58-59; 39/38; 42/36; 58/9-10; 64/13; 65/2-3
- Итгэн даатгах:** 2/283; 4/58; 23/8; 33/72-73; 70/32
- Итгэн даатгах, түших:** 3/121-122, 159-160; 4/81; 5/11, 23; 7/88-89; 9/51, 129; 10/71, 84-85; 11/53-56, 87-88, 123; 12/67; 13/30; 14/10-12, 16/41-42; 25/58; 26/217-220; 27/78-79; 29/58-59; 33/2-3, 48; 39/38;



42/10, 36; 58/9-10; 60/4; 64/13;  
65/2-3

**Иудэйчүүдийн мэдлэгтэнгүүд:** 5/44,  
62-63, 82; 9/31, 34 **Иудэйчүүд бо-  
лон христчуудын маргалдаан:**  
2/113

**Их зан гаргагсадын онцлогууд:** 4/36-  
37; 9/25-26; 11/9-11; 31/18; 57/22-  
24

**Их зан гаргах:** 17/37-38; 31/18; 40/69-  
76

**Кагба:** 2/125, 127; 3/96-97; 5/97; 9/19;  
14/37; 17/1; 22/25-26, 29, 32- 33;  
52/1-8; 106/1-4

**Кадырийн шөнө:** 4/1-6; 97/1-5

**Карун:** 28/76-83; 29/39; 40/23-24

**Киблагийн өөрчлөлт:** 2/143 **Киблаг  
зүглэх:** 2/144, 149-150

**Куран судар:** 2/23-24, 185; 6/19; 10/15,  
37-38; 11/13-14; 12/2-3; 15/9, 87;

**Лаухил Махфуз:** 6/38, 59; 8/67-69;  
10/61; 11/6; 13/39; 20/51-52; 22/70;  
27/38-40; 30/55-56; 33/6; 34/3;  
35/11; 36/12; 43/1-4; 50/1-4; 57/22;  
85/19-22

**Лукман (гэгээн элч):** 31/12-19

**Лут (гэгээн элч):** 6/86; 7/80-84; 10/74;  
11/69-70, 74, 77-83, 89; 15/57-77;  
21/71, 74-75; 25/40; 26/160-175;

**Мадиян:** 20/40; 28/22-23, 45

**Мариям:** 3/33-38, 42, 44-47; 4/155-  
156, 171; 5/17, 72, 75; 19/16-35;  
21/91; 23/50

**Их нүүдэл (Хижрет):** 4/97-100; 9/40;  
29/56

**Ихэмсэг зан гарган бардамнагсад:**  
4/36-39, 172-173; 6/93; 7/36, 40,  
48, 75-79, 132-133, 146; 10/75;  
16/22-23, 29; 29/39; 31/7, 18; 37/34-  
36, 39/59-60, 72; 40/27, 35, 56, 60,  
69-76; 41/37-38; 45/7-8, 31; 46/20;  
63/55; 71/7

**Ичгүүргүй:** 2/169, 268; 4/15-16, 22,  
24-25; 7/28, 33, 80; 12/24; 16/90;  
17/32; 60/12

## К

16/98; 17/9, 41, 45-46, 82, 89, 106;  
18/54; 20/2-3; 27/1-6, 76; 25/32;  
30/58; 32/2; 38/1

**Куран судрыг сахин баримтлах:**  
3/103; 4/145-146; 6/50-51, 57-106,  
153, 155; 7/3; 10/109; 22/78; 43/44;  
45/18; 36/10-11

**Куран судрын нэрс:** 2/2, 159, 185;  
3/3-4, 7; 4/105, 113; 7/2; 10/1; 15/6,  
9; 16/44, 64; 21/50; 25/1; 36/69;  
38/87; 39/23; 42/52; 56/81; 64/8

## Л

27/54-58; 29/26, 28-35; 37/133-  
138; 38/12-14; 50/12-14; 51/31-37;  
53/50-55; 54/33-40; 66/10; 69/9-10

**Лутын гэр бүл:** 15/57-62; 27/56;  
54/33-35

**Лутын эхнэр:** 7/82-83; 11/81; 15/57-  
60; 26/167-172; 27/56-57; 29/31-  
33; 37/133-135; 66/10

## М

**Мацаг барих:** 2/183-185, 187; 33/35

**Махр сүй бэлэг:** 2/229, 237; 4/4, 20-  
21, 24-25

**Мекке хотын эзлэн авалт:** 48/1-29;  
61/10-13; 110/1-3

**Мекке:** 2/126; 6/92; 14/35, 37; 27/91;  
28/57; 29/67; 90/1-2; 95/1-4 **Маруа:**  
2/158 **Мадина:** 9/120

**Мисир (египт):** 10/87; 12/21, 99

**Морьд:** 8/60; 100/1-6

**Мөргөлийн угаал ёс:** 5/6

**Мөргөлөө зөвхөн Аллахад зориу-**  
**лах:** 1/5; 2/172; 6/162; 7/70; 12/40;  
16/114; 17/23; 29/56; 39/14-15, 65-  
66; 41/37-38; 43/26-27; 114/1-3

**Мөрийтэй тоглоом:** 2/219; 5/90-91

**Муса (гэгээн элч):** 2/51, 53-55, 60-61,  
67, 87, 92, 108, 136, 246, 248; 3/84;  
4/153, 164; 5/20, 22, 24-25; 6/84,  
91, 154; 7/103-104, 115, 117, 122,  
127-128, 131, 134, 138, 142-144,  
148, 150, 154-155, 159-160; 10/75,  
77, 80-81, 83-84; 20/9, 11, 17, 19,  
36, 40, 49, 57, 61, 65, 67, 70, 77,  
83, 86, 88, 91; 21/48; 22/44; 23/45,  
49; 25/35; 26/10, 43, 45, 48, 52, 61,  
63, 65; 27/7, 9-10; 28/3, 7, 10, 15,  
18-20, 29-31, 36-37, 43-44, 48, 76;  
29/39; 33/7, 69; 37/114, 120; 40/23,  
26-27, 53; 41/45; 42/13; 43/46;  
46/12, 30; 51/38; 53/36; 79/15;  
87/19

**Мусагийн эх ба эгч дүү:** 20/37-41;  
28/7, 9-13

**Мухажир ба Ансар (ариун нүүд-**  
**эл үйлдэгсэд):** 2/218; 3/194-195;  
8/72-75; 9/20-22, 100, 117, 120-121;  
16/41-42, 110-111; 22/58-59; 57/7-  
9; 60/10

**Мухаммед (с.а.с) бүхий л ертөнцийн**  
**гэгээн элч:** 7/158; 9/33; 34/28;  
48/28; 61/9

**Мухаммед (с.а.с) их нүүдэл, дүрвэ-**  
**лт:** 9/40

**Мухаммедэд (с.а.с) айлдвар буухад**  
**үгүйсгэгчдийн гайхшрал:** 10/1-  
2; 38/4-5

**Мухаммедэд (с.а.с) айлдвар илгээх**  
**үе мөч:** 20/113-114; 75/16-19; 87/6-  
7

**Мухаммедэд (с.а.с) Аллах зарим нуу-**  
**цыг мэдүүлсэн:** 3/44; 7/101; 9/94;  
11/49, 100; 12/102; 18/13; 20/99;  
28/44-46; 30/1-6; 38/21-22; 5/27-31;  
18/9-27, 83-99; 53/1-2; 61/6

**Мухаммедэд (с.а.с) Аллахын сануул-**  
**га:** 2/106-107; 4/105-113; 8/67-69;  
9/43; 10/42-44, 99; 33/37; 66/1-5;  
80/1-10

**Мухаммедэд (с.а.с) итгэн дагах:**  
7/158; 8/20; 31/15; 43/61

**Мухаммедэд (с.а.с) Куран судрын**  
**илгээгдсэн нь:** 2/99, 136, 159;  
3/1-3, 7; 4/105, 113, 166, 174; 5/48;  
6/19, 92, 114, 155; 7/1-2, 196; 12/1-  
3; 13/1, 37; 14/1; 15/9, 87; 16/1-  
2, 43-44, 64, 89, 102; 17/105-106;  
18/1; 20/1-4, 99, 113; 21/50; 22/16;  
24/1, 46; 25/1; 27/6; 29/47, 51;  
32/1-2; 36/1-5; 38/29; 39/1-2, 23,  
41; 40/1-2; 41/41-42; 42/7, 17, 52;  
43/27, 30; 44/1-3; 45/1-2; 46/1-2;  
56/77-80; 57/9; 65/10; 69/40-43;  
73/5; 76/23; 97/1

**Мухаммедэд (с.а.с) үл сүсэглэгсэ-**  
**дийн эсэргүүцэл:** 8/30; 17/73- 77;  
21/36; 25/41-42

**Мухар сүсэг:** 2/189; 5/103

**Мухар сүсэгтнүүд:** 7/172-173; 29/48;  
40/78; 45/27

**Мэлэжүүдийн онцлог:** 4/172; 6/61;  
7/206; 13/12-13; 15/61-64; 16/49-

50; 19/64; 21/19-20, 26-29; 35/1;  
37/1-4, 158-166; 38/67-69; 39/75;  
40/7-9; 41/38; 42/4-5; 66/3-4, 6;  
70/1-5; 77/1-7

**Мэргэ төлөгний сум:** 5/3, 90

**Мэсжид Акса:** 17/1, 7-8

**Мэсжид Харам:** 2/144, 149-150, 191,  
196, 217; 5/2; 8/34; 9/19, 28; 17/1;  
22/25; 48/25, 27

**Мэсжидүүд:** 2/114; 7/31; 9/107-110;  
22/39-40; 24/36-38; 72/18

**Мэсжидүүдийг засах, барих:** 9/17-18,  
28, 108

## Н

**Найдлага алдах нь хориотой:** 12/87;  
15/51-56; 39/53 **Бичиг үсэггүй:**  
3/75; 7/157-158; 62/2

**Нар, сар:** 10/5; 13/2; 14/32-33; 21/33;  
25/45-46; 29/61; 31/29-30; 35/13;  
36/37-40; 39/5; 41/37; 71/15-16;  
91/1-3

**Нар, сар:** 6/96; 7/54; 10/5; 13/2; 54/1-2

**Нар:** 2/258; 6/96; 7/54; 10/5; 12/4; 13/2;  
14/33; 16/12; 17/78; 18/17, 86, 90;  
20/130; 21/33; 22/18; 25/45; 29/61;  
31/29; 35/13; 36/38, 40; 39/5; 41/37;  
50/39; 55/5; 71/16; 75/9; 76/13; 81/1

**Насх (айлдвар шийдвэрийн өөрчлөлт):** 2/106; 16/101

**Нойр:** 39/42

**Номхон дөлгөөн байх:** 4/36, 172-173;  
16/23, 29; 17/37-38; 25/63; 31/18-  
19; 32/15

**Нөхөр нь нас барсан эмэгтэй:** 2/234-235, 240

**Нух (гэгээн элч):** 3/33-34; 4/163; 6/84;  
7/59-64, 69-70; 10/71-74; 11/25-49;  
14/9; 17/2-3, 17; 19/58; 21/76-77;  
22/42; 29/14-15; 33/7; 37/75-83;  
38/12-14; 40/5, 30-31; 42/13; 50/12;

51/46; 53/52; 54/11-17; 57/26;  
66/10; 69/11-12; 71/1-28

**Нухын туфан (Нухын ард олны далай тэнгист сүйрэл):** 69/11-12

**Нүглийн хэрээр цээрлэл:** 16/126

**Нүгэлийг өршөөн далдлах:** 5/65;  
8/29; 48/4-5; 64/9; 65/4-5; 66/8

**Нүгэлтнүүд, хэрэгтнүүд:** 6/54-55, 123-  
124, 147; 7/40-41, 83-84, 133; 8/8;  
9/66; 10/13, 17, 50-51, 75, 82; 11/52,  
116; 12/110; 14/49-51; 15/12-15;  
18/49, 53; 19/85-86; 20/74, 102-  
104; 25/21-22, 31; 26/99, 200-207;  
27/69; 28/78; 30/47, 55; 32/12-  
14, 22; 36/59; 37/22-39; 43/74-80;  
44/22, 37; 45/31; 46/24-26; 51/31-  
33; 54/47-48; 55/41-44; 74/38-53;  
77/16-18, 46-50; 83/29-33

**Нүгэлтэнгүүд:** 2/26-27, 99; 3/81-83,  
110; 5/24-26, 47, 49; 6/49; 7/101-  
102; 9/8, 24, 53, 67, 80, 84, 96;  
10/33; 21/74; 24/4-5, 55; 27/12;  
28/32; 29/34; 32/20; 46/20, 35; 59/5,  
19; 61/5; 63/6

**Нэг нэгэндээ туслалцаа үзүүлэх:** 5/2,  
42/39

**Нэр хүнд:** 4/139; 10/65; 35/10; 37/180-  
182; 63/8

## О

**Одод:** 15/16-18; 25/61

**Одод:** 6/97; 7/54; 16/12, 15-16; 37/6-7;  
53/1-2; 55/5-6; 81/1-3; 82/1-3

**Ододын ач тус:** 6/97; 16/15-16; 37/6-7

**Олзнууд:** 3/161; 8/1, 41, 67-69; 59/6-8  
**Олзны хүн:** 2/85; 8/67-71; 47/4-6

**Орогнохыг хүсэх:** 9/6

**Оюун ухааныг ашиглах:** 2/44, 73,  
76, 164, 170-171, 241-242; 3/65,

118; 5/103; 6/32, 151; 7/169; 10/16;  
11/51; 12/1-2, 109; 13/4; 16/12, 67;  
21/10, 66-67; 22/46; 23/80; 24/61;  
25/44; 26/28; 28/60, 29/35, 43;  
30/24, 28; 36/62, 68; 37/137-138;  
39/43; 40/67; 43/1-3; 49/4; 57/17;  
59/14; 67/10

**Олон эхнэртэй болох:** 4/3, 129

## Ө

**Өв залгамжлах, өв хөрөнгө:** 4/7, 11-  
14, 19, 33, 176

**Өвлөл гэрээслэл:** 2/180-182; 5/106

**Өвс ургамал:** 2/22, 61, 164; 6/95,  
99, 141; 7/57-58; 13/3-4; 14/32;  
15/19; 16/10-11, 65, 67; 22/5,  
63; 23/19-20; 25/48-49; 26/7;  
27/60; 29/63; 30/19, 24, 50;  
31/10; 32/27; 35/9, 27; 36/33-36;  
39/21; 41/39, 47; 43/11; 45/5; 50/7-  
11; 55/11-12; 56/63-65, 71-73; 57/17;  
78/15-16; 79/31; 80/27-32; 87/4-5;  
95/4

**Өглөг өгөгсөдийн мөн чанар:** 2/262,  
274; 9/99; 12/88; 33/35; 57/18; 92/5-  
10, 17-18

**Өглөг:** 2/263-264, 271

**Өглөгч зан:** 17/29; 92/5, 17-18

**Өгсөн амлалтаа сахих:** 2/40, 80; 5/1;  
3/75-76; 6/152; 8/72-73; 9/1-4, 7,  
111; 13/19-20; 16/91-92; 17/34;  
23/1-11; 33/13-15; 70/32

**Өдөр, шөнийн ач тус:** 10/6, 67; 17/12;  
25/47, 62; 27/86; 28/71-73; 40/61;  
73/6-7

**Өдөр, шөнө:** 2/164; 3/27; 6/1, 96; 7/54;  
10/5, 67; 13/3; 14/32-33; 16/12;  
21/33; 22/60-61; 23/80; 24/44;  
25/47, 62; 27/86; 28/71-73; 31/29-  
30; 35/13; 36/37; 39/5; 40/61; 41/37;

45/5; 57/6; 78/10-11; 79/29; 89/1-5;  
91/1-4; 92/1-2, 93/1-3

**Өмнөх хүмүүст тохиосон сургажигт  
явдалууд:** 2/65-66, 214; 3/10- 13,  
137-138; 6/6, 10-11, 42, 45; 7/4-7,  
86, 94-103, 134-137, 145, 163, 166,  
172-174; 8/50-54; 9/69-70; 10/13-  
14, 38-39, 73, 90-92, 101-102;  
11/44, 58-60, 66-68; 81-83, 89, 94-  
103, 120; 12/7, 109-111; 13/6, 41;  
14/5, 9-17; 15/71-84; 16/26, 112-  
113; 17/17; 18/59; 19/74; 20/128;  
21/11-15, 44, 105-106, 22/42-48;  
23/29-30, 44; 25/35-40; 26/65-67,  
99-102, 119-121, 139, 157-158, 170-  
174, 189-190; 27/13-14, 50-58, 69;  
28/39-40, 58, 78-81; 29/14-15, 24-  
25, 33-40; 34/15-19, 45; 35/25-26,  
42-44; 36/28-31; 37/79-82, 132-138,  
176-177; 38/3, 41-43; 39/25-26; 40/5,  
21-45, 82-85; 41/13-18; 43/6-8, 23-  
25, 54-56; 44/17-29, 37; 46/26-28;  
47/13; 50/12-14, 36-37; 51/31-46;  
53/50-56; 54/9-42, 51; 59/2, 14-  
15; 60/4-7; 64/5-6; 65/8-10; 67/18;  
68/17-33; 69/4-12; 71/22-25; 73/15-  
16; 77/16-18; 79/15-26; 85/10; 89/6-  
14; 91/11-15; 105/1-5

**Өмөөрөлийн хүлээн зөвшөөрөгдөх  
нөхцөл:** 2/255; 19/81-87; 20/109;  
21/26-28; 22/47; 32/4; 34/23; 43/86;  
53/26

**Өмөөрөх:** 2/255; 4/85; 6/51, 70; 7/53; 10/3, 18; 19/85-87; 20/109; 21/26-28; 26/96-101; 30/12-13; 34/23; 39/43-44; 40/18; 43/ 86; 53/24-26; 74/38-48; 78/38

**Өнчин өрөөсөнүүд:** 2/83, 177, 215, 220; 4/2-6, 8-10, 36, 127; 6/152; 17/34; 89/17; 90/15; 93/9

**Өөрийгөө өгүүтгэх:** 4/29-30

**Өргөл барих:** 22/36-37; 108/2

**Өртэй болох:** 2/282-283

**Өршөөл гуйх:** 2/199; 3/39, 135, 159; 4/62, 64, 106, 110; 5/74;8/33; 9/80, 113; 11/3, 52, 61, 90; 12/29, 97-98; 18/55; 19/47;24/62; 27/46; 38/24; 40/7

**Өршөөх:** 2/51-52, 187, 237; 3/134, 152, 155, 159; 4/97-99,149,153; 5/13, 15, 95, 101; 24/22; 42/25, 30, 34, 40

**Өширхөх:** 3/118; 5/8, 14, 64, 91; 40/35; 60/4

**Рамазан сар:** 2/185

**Рассын ард олон:** 25/37-39; 50/12-14

**Рия (хүмүүст сайн харагдахын тулд мөргөл үйлдэх):** 2/264; 4/38, 142; 8/47; 107/6

**Сабагийн хатан хаан (Балкис):** 27/29, 34, 42-43 **Сабагийн ард олон:** 34/15-21

**Сабичүүд:** 2/62; 5/69; 22/17

**Саждэ буюу сөгдөх ёсны тухай айлдварууд:** 7/206; 13/15; 16/49; 17/107; 19/58; 22/18; 25/60; 27/25; 32/15; 38/24; 41/38; 53/62; 84/21; 96/19

**Сайн ба муу үед хүмүүний байр суурь:** 7/94-95; 10/12, 21-23; 11/9-11; 16/53-55; 17/11, 67-69, 83-84; 22/11-13; 23/73-77; 29/64-66; 30/33-36, 48-51; 31/31-32; 39/8, 49-52; 41/49-52; 42/47-48; 70/19-23; 89/15-20

**Сайн сайхныг ухуулж, муу муухайгаас сэрэмжлүүлэх:** 3/104, 113-114; 9/71, 112;31/17

## Р

**Рухбаният (бясалгал):** 57/27

**Рухул Кудус буюу Жабрейл:** 2/87, 253; 19/16-19; 70/4; 78/36-38 Ромчууд: 30/2-4

## С

**Сайн үйлс:** 4/124; 5/93; 11/9-11; 16/97; 17/9; 18/1-3, 46, 110; 20/74-76, 82, 112; 21/94; 23/51; 25/68-71; 26/224-227; 28/67, 79-80; 30/44-45; 32/18-19; 34/10-11, 37; 35/10, 37; 40/40;41/33, 46; 45/15; 46/15; 64/9; 65/8-11

**Сайн үйлсийн төлөө уралдах:** 2/148; 5/48; 23/57-61; 35/32; 57/21

**Сайчууд:** 3/196-198; 76/5-22; 82/13; 83/18-28

**Салауат Салэм:** 33/56

**Салих (гэгээн элч):** 7/74; 9/72-79; 11/89; 14/9; 22/42; 25/38-39; 27/45-53; 29/38; 38/12-14; 40/30-31; 41/13-14, 17; 50/12-14; 51/43-45; 53/50-52; 54/23-32; 69/4-6; 85/17-20; 89/6-14; 91/11-15

**Салхи:** 2/164; 7/57; 15/22; 25/48;  
27/63; 30/46, 48-51; 35/9; 42/33;  
45/3-5; 51/1-5; 77/1-7

**Салэм буюу мэнд хэлэх:** 4/86, 94;  
10/9-10; 13/22-24; 14/23; 16/28,  
32; 19/46-47; 20/45- 47; 24/27,  
61; 25/75; 27/59; 28/55; 33/43-  
44; 36/55-58; 37/78-80, 108-110,  
119-121, 129-131, 180-182; 39/73;  
43/87-89; 51/24-25; 56/25-26, 90-91

**Самири:** 20/88, 95-96

**Самудын ард олон:** 7/73; 9/70; 11/63,  
68, 95; 17/59; 22/42; 25/38; 27/45;  
29/38; 40/30-31; 50/14; 53/50-51;  
69/1-7; 91/11

**Сансар огторгуй:** 7/54; 10/3; 13/2;  
20/5; 23/86-87; 25/59; 32/4; 43/82;  
57/4; 69/16- 17; 85/15

**Сарын тэмдэг:** 2/222

**Сафа:** 2/158

**Сижжин:** 83/8 Сидратүл Мунтаха:  
53/14, 16

**Согтуурах:** 4/43; 16/67; 22/2

**Согтууруулах ундаа:** 2/219; 4/43;  
5/90-91

**Сур буюу бүрээ бишгүүр:** 6/73; 18/99;  
20/101-102; 23/101; 27/87; 36/51;  
39/68; 50/20; 69/13; 78/18

**Сургамж авах:** 2/221; 6/80, 126, 152;  
7/3, 26, 57, 130; 8/57; 10/3; 11/24,  
30; 14/25; 16/17, 90; 17/41; 21/84;  
23/85; 24/1, 27; 25/62; 28/43, 46, 51;  
32/4; 37/152-155; 39/21, 27; 40/58;  
44/58; 45/23; 50/36-37; 51/49;

54/15-17, 21-22, 32, 40, 51; 56/62;  
69/40-42; 73/19; 80/11-12

**Суре буюу Куран судрын бүлгүүд:**  
2/23; 9/64, 86, 124, 127; 10/38; 24/1;  
47/20

**Суух ёс жаяг:** 58/11

**Сүлейман (гэгээн элч):** 2/102; 4/163;  
6/84; 21/78-79, 81-82; 34/12-14;  
27/15- 44; 38/34-40

**Сүнс, амь:** 17/85; 42/52

**Сүсэглэгээдийн онцлогууд:** 5/55; 8/2-  
4, 74; 9/13, 18, 20, 71-72; 14/31;  
17/9; 20/82; 23/1-11; 24/62; 33/36;  
42/36-39; 47/2-3; 48/29; 49/15;  
58/22; 61/10-14; 90/11-18; 103/1-3

**Сүсэглэгээдийн сануулга авсан нь:**  
2/75; 3/142-144, 165; 4/88, 97-99;  
9/16, 38, 120; 16/71; 57/16; 61/2-3

**Сүсэглэгээдийн сорилт:** 2/155; 3/140-  
152, 165-167, 179, 186; 5/48, 94;  
7/141; 8/17; 10/13-14; 11/7; 16/92;  
18/7; 21/35; 23/30; 25/20; 27/47;  
29/1, 3; 33/11; 39/49; 47/4, 31; 49/3;  
67/1-2; 72/16-17

**Сүсэглэгээдийн шан харамж:** 2/25,  
62, 82, 256-257, 277; 3/57, 122, 145-  
146, 152-174; 5/65-66; 8/74; 9/44,  
88-89, 111-112; 10/9-10; 11/23,  
108; 13/29; 14/31; 17/9; 18/30-31,  
107-108; 22/23-24, 49-50; 29/7,  
58-59; 30/14-15; 31/8; 33/43-44;  
37/34-49; 41/8; 45/28-30; 48/-5, 29;  
57/7, 11-12, 19, 21; 61/14-10; 65/8-  
11; 85/11; 89/27-30; 93/7-8; 95/4-6;  
103/1-3

## Т

**Тагут:** 2/256-257; 4/51, 60, 76; 5/60;  
16/36; 39/17

**Талархагсадын мөн чанар:** 3/144-  
145; 7/58; 14/5, 7; 25/62; 27/38-40;  
31/12, 31; 34/18-19; 39/7; 42/32-33;  
54/33-35

**Талархах:** 2/51-52, 55-56, 151-152, 172, 185, 243; 3/123, 144-145; 4/147; 5/6, 89; 7/10, 58, 143-144; 8/26; 10/59-60; 12/37-38; 14/5, 7, 37; 16/14, 78, 114; 21/79-80; 22/36; 23/78; 27/30-40; 28/73; 29/16-17; 30/46; 31/12-14, 31; 35/12; 36/33-35, 71-73; 39/7, 65-66; 40/60-61; 42/32-33; 45/12; 46/15; 54/33-35; 56/68-70; 67/23

**Талут:** 2/246-252

**Там:** 2/24; 15/43-44; 66/9; 67/6-8; 70/15-18; 74/26-31; 77/29-33; 81/12; 104/4-9; 111/3

**Тамаас болгоомжлох:** 2/24; 3/131, 192

**Тамд нэрвэгдэгсэд:** 2/39, 80-81, 119, 217, 257, 275; 3/10, 116; 4/56; 5/86; 9/113; 10/27; 11/105-107, 119; 13/5, 25; 22/19-22, 51; 23/103-108, 112-115; 25/11-14; 32/20-21; 35/36-37; 36/59-64; 37/62-68; 38/55-64; 39/8, 14-16, 19; 40/6, 43, 45-50, 70-76; 41/19-25; 42/20; 44/43-50; 47/15-16; 50/24-30; 52/11-16; 56/41-56; 57/19; 64/10; 67/6-11; 69/25-37; 70/11-18; 78/21-30; 85/10; 87/11-13; 88/1-7; 101/8-11

**Тамынхан-Диваажингийнхан:** 7/44-53; 13/18; 37/22-74; 42/20; 44/40-57; 59/20

**Таураг судар:** 3/3, 48, 65; 5/43-44, 46, 48, 110; 7/157; 9/111; 21/105; 48/29; 61/6; 62/5

**Таяммум:** 4/43; 5/6

**Төмөр:** 57/25

**Төөрөлдөгсөд:** 3/90; 4/88, 136, 142-143; 6/125, 140; 7/30, 178, 186;

9/115; 13/33; 15/55-56; 16/37; 17/48, 97-98; 18/17, 51; 19/75; 22/3-4; 23/103-107; 27/92; 28/49-50; 30/29; 36/22-24; 37/71-74; 38/26; 39/22-23, 36, 41; 40/32-35, 73-74; 41/52; 42/44; 45/23; 46/5; 56/51-55, 92, 94

**Төөрөлдөгсөд:** 7/175-176; 15/42, 44; 26/91-103, 224; 37/27-32; 38/55-64; 51/52-55; 52/32; 53/50-52; 68/30-31; 78/21-30; 79/37-39; 96/6-7

**Төөрөлдүүлэгсэд:** 6/118-119, 144; 18/51; 22/8-10; 31/6-7; 39/8

**Туагийн хөндий:** 20/12; 79/16 **Тур:** 2/63; 4/154; 19/52; 28/29, 46; 52/1; **Туббагийн ард олон:** 44/37; 50/14

**Тэнгэр, газар:** 2/22, 29, 116-117, 164; 6/1, 14, 73, 79, 101; 7/54; 10/3, 6; 11/7; 12/101; 13/2-3; 14/10, 19, 32; 15/19-22, 85; 16/3; 17/99; 18/7-8, 51; 20/1-6, 51-53; 21/16, 30-32; 22/65; 23/17; 24/35; 25/58-59; 27/60-61; 29/44, 61; 30/22, 25; 31/10, 25; 32/5; 34/9; 35/1, 41; 36/81; 38/27; 39/5, 38, 46; 40/57, 64; 41/9-12; 42/10-11, 29; 43/9-10; 44/38-39; 45/3, 22; 46/3-4, 33; 50/6-8, 38; 51/7-8, 20-22, 47-48; 52/5-7; 55/5-7, 10-12; 57/4; 64/3-4; 65/12; 67/1-5, 15; 71/15-20; 78/6-7, 12-13; 79/27-31; 81/11; 82/1-5; 84/1-6; 85/1; 86/1; 88/18-21; 91/5-6; 99/1-6

**Тэнгэрлэг шашинуудын үндэс нь нэг юм:** 2/132-133, 136; 3/1-4, 48; 4/26, 163-166; 7/157; 21/25, 92; 23/51-52; 29/46; 39/65; 41/43; 42/1-3, 13; 43/45; 46/11-12, 21; 61/6; 87/14-19

**Уншлага мөргөл үйлдэгсдийн шан харамж:** 2/277; 4/122; 23/1-11; 35/29-30; 70/22-35; 87/14-15

**Уншлага мөргөлийг сурталчилсан айлдварууд:** 2/1-3, 45, 153, 177, 277; 4/162; 5/12, 55; 6/162; 7/170; 8/2-3; 9/5, 11, 18, 54, 71, 112; 13/22; 14/37; 19/31, 55, 59; 22/35, 41; 23/1-11; 24/36-37; 27/1-3; 31/1-5; 70/22-23, 34-35; 74/38-47

**Уншлага мөргөлийн тухай Аллахын тушаал:** 2/110, 238-239; 4/77; 6/72; 11/114; 14/31; 15/98; 17/78-79; 19/31; 20/14, 132; 21/73; 22/77-78; 29/45; 30/31; 31/17; 33/33; 58/13; 62/9-10; 73/20; 76/25-26; 93/5; 96/19; 108/2

**Уншлага мөргөлийн цагууд:** 17/78-79; 30/17-18; 50/39-40; 76/24-25

**Урвагчид:** 4/105-107; 12/50-52; 22/38

**Урвах, итгэлгүйдэх:** 3/161; 4/105, 107; 5/13; 8/27, 58, 71; 12/52; 22/38; 40/19; 66/10

**Уриалга:** 3/104, 110, 114, 159; 9/71, 112; 16/35, 37, 125; 17/53; 20/43-44; 22/41; 29/18; 31/17; 41/30-35; 80/1-12

**Ус:** 2/21-22, 60, 72-74, 164; 6/99; 7/57, 159-160; 8/11; 13/4; 15/22; 16/10, 65; 18/39-41; 20/51-54; 21/30; 22/5; 23/17-18; 24/39,45; 25/48-49, 54; 27/60; 28/23; 29/63; 30/24; 31/10; 32/27; 35/27; 39/21; 43/11; 56/68-70; 67/30; 69/9-12; 77/20-23, 25-27; 78/14-16; 79/30-31; 80/24-27; 86/5-7

**Уулс:** 13/3; 15/19; 16/15-16, 81; 20/105-107; 21/31, 78-79; 27/61, 88; 31/10; 35/27; 41/9-10; 50/6-7; 52/1-7; 77/25-27; 78/6-8; 79/30, 32; 81/1-3; 88/17-21

**Ухудын дайн:** 3/121-122, 137-179; 61/4 **Удирдагчад захирагдах:** 4/59; 5/33-34

**Ү**

**Үг, үйлдэлийн зохицол:** 2/44; 61/2-3

**Үзэг:** 68/1-2; 96/3-5

**Үйл хэргийн жин хэмжүүр:** 7/8-9; 21/47; 23/102-103; 101/6-9

**Үйлийн дэвтэр баруун талаас нь өгөгдөгсөд:** 17/71; 56/27,40,90-91; 69/19-24; 74/38-40; 84/7-9; 90/17-18

**Үймээн самуун дэгдээгсэд:** 5/64; 10/81; 13/25; 27/14; 28/4; 29/30; 38/28

**Үймээн самуун:** 2/60, 205; 7/56, 74, 85, 142; 11/85, 116; 16/88; 26/183; 28/77; 29/36; 42/40-42

**Үл сүсэглэгсэд, буруу номтнууд:** 2/6, 8, 23-24, 26, 29, 61, 89-90, 98, 102, 104, 121, 126, 161-162, 191, 211-212, 253-254, 257, 264, 276; 3/1-4, 12-13, 19, 21-22, 32, 56, 86-91, 96-98, 106, 112, 116, 126-128, 130-131, 140-141, 151, 156, 162, 176-178, 195-196; 4/18, 36, 39, 41-42, 44-46, 56, 101-102, 115, 131, 136-137, 140, 150-151, 160-161, 167-170; 5/3, 5, 10, 17, 36-37, 44, 67, 72-73, 78, 81, 86, 101-104, 114-115; 6/1-10, 25-30, 39, 70, 89, 116, 122, 125, 130, 132, 155-159; 7/27-30, 36-41, 50-53, 64, 71-72, 77-78, 90-93, 96, 101-102, 146-147, 175-178, 182-185; 8/7, 12-14, 17-19, 22-23, 30-40, 47, 50-59, 65, 73; 9/1, 3, 12-13, 17, 25-26, 32, 37,49, 62-63, 68, 73, 90, 124-125; 10/4, 7-8, 45, 69-70, 73, 100-102; 11/5, 15, 17, 22, 59-60, 66-68, 74-76, 105-107; 12/37, 87; 13/5-6, 12-14, 18, 30-35, 42; 14/2-3, 7-9, 13-20, 28-



30; 16/26-28, 33-34, 38-39, 60, 63, 71, 84, 88, 104-109, 112-113; 17/8-10, 60, 67, 69, 72, 89, 97-98; 18/32-44, 56, 100-106; 19/37-40, 68-70, 73, 77-84; 20/47-48, 60-61, 99-101, 133-135; 21/1-3, 36-46, 77, 90-100; 22/3-4, 8-10, 19-22, 25, 42-44, 46-47, 55, 57, 72; 23/24, 33, 44-48, 52-56, 63-77, 117; 24/55, 57; 25/11-14, 32-44, 50, 55, 60, 77; 26/139, 157-158, 170-174, 189-190; 27/4-5, 40-43, 50, 52, 57-58, 60-62, 65, 82-85; 28/38-42, 46-48, 81-82; 29/23-24, 47, 55; 30/16, 44-45, 58, 60; 31/6-7, 12, 23-24, 32; 32/28-29; 33/7-8, 25, 64-28; 34/5, 31-38, 43-46; 35/6-7, 25-26, 36-40; 36/1-10, 28-32, 59, 70, 37/11-15, 81-82, 127-128, 133, 136, 167, 170, 174-179; 38/1-14, 27, 84-85; 39/2-3, 7-8, 22, 32, 55, 59, 63, 66-67, 71-72; 40/4-6, 10-14, 49-50, 69-76, 82-85; 41/13-14, 26-29, 44, 50-54; 42/16, 26, 35; 43/6-8, 24-25, 29-42, 57-62, 79-80, 87-89; 44/40, 50; 45/7-11, 18-19, 31-35; 46/1-11, 20, 31-32, 34; 47/1-3, 7-9, 12, 32, 34; 48/13, 22-26; 50/1-11, 20-30; 51/7-9, 52-53, 59-60; 53/27-28, 59-62; 54/1-14; 60/1-2, 13; 61/5, 7-8; 64/5-6, 10; 65/8-10; 67/6-11, 20-21, 27-30; 70/1-3; 36-44; 71/26-27; 72/15-17; 74/31; 75/20-36; 76/4, 27-28; 78/40, 80/40-42; 83/34-36; 84/20-24; 85/17-20; 86/15-17; 87/9-17; 88/21-26; 89/15-26; 90/19-20; 93/1-6

**Үл сүсэглэгч буруу номтнуудаас болгоомжлох:** 6/70, 91; 15/1-3; 23/52-54; 32/28- 30; 37/174-179; 43/82-83; 51/52-54; 52/45; 53/27-30; 54/4-6; 70/40-42; 74/11-17

**Үл сүсэглэгчдийн хойд ертөнцөд энэ хорвоо руу буцах мөрөөдөл:** 6/27; 14/44; 23/99-100; 26/96-102; 32/12; 35/36-37; 39/55-59; 40/10-11; 42/44

**Үл сүсэглэгчдэд боломж өгөх:** 3/178; 6/110, 112, 137, 158; 7/180, 186; 10/11, 19, 102; 13/32; 14/10; 15/2-3; 16/61; 18/58; 20/128-129; 21/108-111; 22/42-44; 23/54-56; 29/65-66; 35/45; 39/8; 41/45; 42/14, 21; 43/83; 70/40-42; 86/15-17

**Үл тоомсорлогсод:** 7/136, 146, 172-173, 179; 10/7-8; 16/108; 18/28; 21/1; 30/7; 36/6

**Үл тоомсорлох, үл тоох:** 7/205; 10/90-92

**Үнэн сүсэгтний мөн чанар:** 12/23-24; 15/39-42; 17/64-65; 38/82-83

**Үнэн-худал, шударга-шударга бус:** 2/42; 7/118; 17/81; 18/56; 22/62; 31/30; 34/49; 40/5; 42/24

**Үнэнч байх:** 2/23, 94, 111; 5/119; 9/119; 17/80; 27/64; 28/48-49; 33/8, 24, 70-71; 46/16; 47/5; 54/55; 67/23-24

**Үнэнч, шударгачууд:** 5/119; 6/143; 9/119; 27/64; 28/48-49; 33/7-8, 23-24, 35; 49/15; 59/7-8; 67/23-24

**Үр хүүхдээ егүүтгэхийг хориглох:** 6/137, 140, 151; 17/31; 60/12

**Үр хүүхэд:** 2/128-129, 233; 3/14, 38; 7/189; 8/28; 14/40; 25/74; 33/5; 34/37; 46/15; 64/14-15; 66/6

**Үр хүүхэд:** 4/11-12; 8/28; 9/24, 55, 69, 85; 11/40-46; 14/35, 37, 40; 16/72; 17/6; 18/39, 46; 19/77; 25/74; 26/88, 133; 34/35-37; 42/49-50; 60/3; 63/9; 64/14-15; 71/12, 21; 80/34-36

**Үрэлгэн байх:** 6/141; 7/31; 17/26-30; 26/150-152

**Үүлс:** 2/164; 13/12; 24/43; 30/48; 35/9; 51/1-5; 78/14-16

**Үхсэний дараа дахин амилах:** 2/55-56, 258-260; 4/87; 6/12, 29, 36, 61-

62, 133, 154; 7/29, 57; 10/45-46; 11/7; 13/2, 5; 16/38-40; 17/49-52, 97-99; 18/21, 99; 19/66-67; 22/5-7; 23/15-16, 31-38, 81-83; 25/3, 40; 27/65-73; 28/39; 29/19-20; 30/11, 16, 19, 25, 48-50, 56; 31/28; 32/10-11; 34/3, 7-9; 35/9; 36/12, 31-32, 48-53, 77-83; 37/15-19; 41/39; 43/9-11; 44/34-37; 45/24-26; 46/17-19, 33; 50/3-11, 15, 41-42; 53/45-47; 56/47-

50; 58/5-6, 17-18; 64/7; 67/15; 72/7; 75/1-6, 36-40; 78/1-17; 79/1-14; 80/17-22; 81/1-14; 82/1-9; 83/1-6; 84/1-6; 86/5-10; 99/1-6; 100/6-11

**Үхэл:** 3/143, 145, 156-158, 185; 4/78; 6/61; 14/15-17; 15/97-99; 21/35; 23/12-15; 29/57; 31/34; 35/15-17; 39/30-31, 42; 44/54-56; 53/42-44; 56/60-61, 83-87; 62/6-8; 63/10; 67/1-2; 75/26-29; 80/17-21; 102/1-2

## Ф

**Фиргаун:** 2/49-50; 3/11; 8/52,54; 10/75,79,83,88, 90, 92; 11/97; 66/11; 69/9; 73/15-16; 79/17; 20-25; 89/10

**Фиргауны гэр бүл:** 3/11; 7/130; 8/50-54; 14/6; 28/7-8; 40/28, 45-46

**Фиргауны эхнэр:** 28/9; 66/11

## Х

**Хаж мөргөл:** 2/158, 189, 196-200, 203; 5/1-2, 95, 97; 9/3, 19; 22/26-37

60, 61, 64-68; 40/51-52; 47/22-23; 48/6

**Халал буюу ариун идээ:** 2/168, 172; 5/1-2, 4-5, 87-88, 96; 6/118-119, 142-145; 7/32; 16/114

**Харам буюу бузар идээнүүд:** 2/172-173; 5/1-3, 96; 6/121, 145; 16/115-117

**Халал буюу ариун хоол:** 2/168, 172-173; 5/1, 3-5, 87-88, 93; 6/118-119, 138,142, 145; 16/114-115; 22/30

**Харамч байх:** 2/195; 3/180; 4/37, 128; 9/34-35, 75-79; 17/29, 100; 47/37-38; 53/34; 57/24; 92/8-16

**Халалаар хооллох:** 2/168, 172; 6/118-119, 142; 7/160; 8/67-69; 16/114; 22/30; 23/51; 34/15

**Харанхуй бүдүүлэгүүдээс хол байх:** 4/81; 6/106; 7/199; 15/94; 28/55; 32/30; 37/174; 43/89; 51/54; 53/29; 54/6; 73/10

**Халамжлах:** 2/215, 272-273; 4/8

**Хариуцлага:** 2/132-134, 139-141, 286; 4/85, 110-112; 6/52, 104, 164; 10/41, 108; 11/35; 14/49-51; 17/7, 15-21; 18/29; 20/11-16; 24/11; 27/91-92; 29/5-6; 30/44; 34/25, 50; 35/18, 39; 39/7, 41; 41/46; 42/15, 30; 45/15; 52/21; 53/33-42; 89/21-26; 109/1-6

**Хамаатан садан:** 2/27, 83, 177, 180, 215; 4/1, 7-8, 36; 8/75; 9/23-24; 13/25; 16/90; 17/26; 24/22; 30/38; 33/6; 47/22; 60/3

**Хаман:** 28/5-8, 38; 29/39; 40/23-24, 36-37

**Хандекийн дайн:** 33/9-27

**Харун (гэгээн элч):** 2/248; 6/84; 7/121-122, 142, 150; 10/75, 87; 19/51-53; 20/24-32, 42-48, 69-70, 90-94; 21/48; 23/45-48; 25/35-36; 26/10-13, 43-48; 28/33-35; 37/114-122

**Хараал хүртэгсэд:** 2/88, 162; 3/86-88; 4/44-47, 51-52, 93, 116-118; 5/13, 60, 78; 7/44; 9/68; 11/18, 59-60, 96-99; 13/25; 15/34-35; 24/7, 23; 33/57,

**Харут-Марут:** 2/102

**Хатамжит гэвчигсэдийн мөн чанар:**  
2/153, 155-157, 249-250; 3/146;  
8/46, 66; 11/9-11; 14/5; 16/96,  
110, 126; 28/80; 29/58-59; 33/35;  
39/10;41/35; 42/32-33

**Хатамжит гэвчээр:** 2/45; 3/16-17,  
124-125, 200; 4/25; 7/87, 127, 137;  
8/46, 66;10/109; 11/9-11, 114-115;  
12/18, 83, 90; 13/22-24; 14/5; 16/41-  
42, 126-127; 18/66-69; 19/64-65;  
20/129-130; 22/34-35; 23/108-111;  
25/75; 30/60; 31/17, 31; 32/23-24;  
34/19; 37/102; 38/17; 42/33, 43;  
49/4-5; 90/17; 103/1-3

**Хижырийн ард олон:** 15/80-84

**Хов жив:** 49/12; 104/1

**Хоёр нүүртэнгүүд:** 2/8-20, 204-206;  
3/154, 167-168, 176-177; 4/60-68,  
72- 73, 81-83, 88-91, 138-143, 145-  
147; 5/41, 52-53; 8/21, 49; 9/42-43,  
45-59, 61-70, 73-87, 90, 93-96, 101-  
110, 124-127; 11/5; 22/53; 24/47-50,  
53-54; 29/10; 33/12-20, 24, 60-62,  
72- 73; 47/16-30; 48/6, 11-12, 15-  
17; 57/13-15; 58/8, 14-20; 59/11-17;  
63/1-8; 74/31

**Хоёр нүүртэнгүүдийн үгэнд бүү  
орох:** 4/81; 9/95; 33/1, 48

**Хоёр нүүртэнгүүдтэй бүү андлах:**  
4/88-89

**Хойд ертөнцийн мөнхийн тухай:**  
2/25, 39, 80-82, 161-162, 166-167,  
217, 257, 275; 3/14-15, 86-88, 106-  
107, 116, 136, 196-198; 4/13-14, 57,  
93, 122, 168-169; 5/36-37, 80, 83-  
85, 119; 6/128; 7/36, 42; 9/17, 20-22,  
62-63, 68, 72, 86-89, 100; 10/26-27,  
50-52; 11/23, 105-108; 13/5; 14/23;  
15/45-48; 18/107-108; 20/74-76,  
99-101; 21/101-102; 23/8-11, 101-

103; 25/15-16, 75-76; 29/58; 32/13-  
14; 33/64-65; 39/71-73; 40/73-76;  
41/27-28; 43/68-71, 74; 45/34-35;  
46/13-14; 47/15; 48/4-5; 50/31-34;  
57/12; 58/17, 22; 59/15-17; 64/9-  
10; 65/11; 72/23

**Хойд ертөнцийн орон:** 29/64; 40/39

**Хойд ертөнцөд дахин амилан цу-  
гларах:** 2/203; 3/12, 157-158;  
4/172; 5/96; 6/38, 71-72, 128;  
8/24, 36;10/28, 45; 15/24-25;  
17/97; 18/47; 19/66-68; 83-86;  
20/102;23/79; 25/17, 33-34; 27/83;  
34/25-26, 40; 37/20-22; 41/19;  
42/14-15; 46/5-6; 50/43-44; 58/9;  
67/42

**Хоосон яриа:** 23/3; 25/72; 28/55

**Хор хөнөөл үйлдэгсэдийн учрах  
цээрлэл:** 4/18; 12/25; 27/90; 28/84;  
35/10; 41/46;45/15, 21; 53/31

**Хор хөнөөлийн гэсгээл:** 6/160; 27/90;  
28/84; 30/41; 40/40; 42/40-41

**Хохирол амсагсад:** 2/26-27, 121; 3/85;  
4/119-121; 5/5, 52-53; 6/12, 20, 31,  
140; 7/9, 53, 92, 99, 178; 8/36-  
37; 9/69; 10/45, 95; 11/21-22, 47;  
16/108-109; 18/103-106; 22/11-13;  
23/103-115; 27/4-5; 29/52; 39/14-  
16, 63, 65; 41/22-25; 42/45; 46/17-  
18; 58/19; 63/9; 103/1-3

**Хоч нэр өгөх:** 49/11

**Хөдөлмөрлөх:** 4/32; 28/77; 53/39-41;  
92/4

**Хөөрөн төөрөлдөгсөд:** 11/9-11, 116;  
13/26; 17/16; 21/11-15; 23/33-41;  
34/34-36; 40/69-76, 82-83; 43/23-  
25; 56/41-50

**Хөрш:** 4/36

**Хөхүүлэх:** 2/233; 31/14; 46/15; 65/6-7

**Христийн сүм:** 22/40

**Христчүүд:** 2/62, 111, 113, 120, 135, 140; 5/14, 18, 51, 69, 82; 9/30; 22/17

**Хувь тавилан:** 6/59; 9/51; 10/107; 16/53; 27/75; 48/11; 54/49; 57/22-23; 85/22

**Хувь хишгийг урван тэрслэх:** 14/34; 22/66; 28/57; 30/33-34, 51; 31/20; 42/48; 80/17-32; 100/1-7

**Хувь хишиг хүсэх:** 14/37; 29/16-17; 30/23, 46; 45/12; 62/9-10; 67/15; 73/7, 20

**Хувь хишиг:** 2/57, 172, 212, 254; 3/27, 37; 5/88, 114; 6/142, 151; 7/160; 10/31, 59; 11/6, 88; 13/26; 15/20; 16/71-72, 114; 17/30-31, 70; 20/131-132; 24/38; 27/64; 28/57, 82; 29/17, 60, 62; 30/37, 40; 34/24, 36, 39; 35/3; 36/47; 40/64; 42/12, 19, 27; 51/22-23, 56-58; 65/2-3; 67/21

**Худ (гэгээн элч):** 7/65-72; 11/50-60, 89; 26/123-140; 40/30-31; 41/13-16; 46/21-26; 50/12-13; 51/41-42; 53/50-52; 54/18-22; 69/4-8; 89/6-8

**Худайбиегийн гэрээ, андгай:** 48/10-20

**Худал гэрчлэхээс болгоомжлох:** 4/135; 25/72

**Худал хэлэгсэд:** 3/61, 93-94; 4/48-50; 6/21, 93, 144; 10/17, 59-60, 69-70; 11/18, 93; 16/38-39, 104-105, 116-117; 18/15; 23/90; 24/13; 29/68; 39/2-3, 32, 60; 40/28; 45/7-10; 58/18; 59/11-12; 61/7; 63/1; 69/44-47; 72/4-5

**Худал хэмээгсэд:** 3/10-11, 137; 5/10, 86; 6/11, 21, 39, 49, 148, 157; 7/36-41, 64, 72, 92, 96, 136, 146-147, 176-177, 182-186; 8/53-54; 10/17, 45, 73; 16/36, 113; 22/57; 23/33,

47-48; 25/11, 25-39, 77; 27/83-85; 29/36-37, 68; 30/10, 16; 34/45; 37/127-128; 39/25-26, 32, 54-60; 42/139, 189; 43/24-25; 50/5; 52/11-16; 54/9-35, 41-42; 55/13-77; 56/51-56, 92-95; 57/19; 62/5; 64/10; 68/8-9; 73/11-14; 74/38-46; 75/30-36; 77/15-49; 78/26-28; 82/9-12; 83/10-17; 92/8-16; 96/9-19; 107/1-3; 7/182-183; 68/44-45; 73/11

**Худхуд шувуу:** 27/20-28

**Хулгай:** 5/38; 12/70, 73, 77, 81

**Хунейны дайн:** 9/25, 27

**Хуурах:** 7/85; 83/1-3

**Хүлцэнгүй зан гаргах:** 2/109; 5/13; 24/22; 43/87-89; 64/14

**Хүмүүний бүтээгдэх явц:** 3/6, 59; 4/1; 6/2, 98; 7/11, 189; 10/4; 15/26-27; 16/70; 18/37, 51; 21/37; 22/5; 26/75-78; 30/20, 40; 31/28; 36/20-22, 77-79; 37/11; 39/6; 40/57, 64; 41/21, 47; 42/11; 43/87; 45/3-4; 49/13; 50/16; 51/56; 53/42-46; 55/1-4, 14-15; 56/57-59; 64/2-3; 67/22-24; 70/19-22, 36-39; 76/28; 78/6-8; 82/6-8; 86/5-8; 90/1-10; 91/7-9; 92/1-4; 95/1-5; 96/1-2

**Хүмүүний газар дэлхийд төлөөлөн удирдах эрх мэдэл:** 2/30; 6/165; 10/13-14, 73; 11/56-57; 27/62; 35/39

**Хүмүүний Эзэнтнийхээ эсрэг дайсагнал:** 16/4; 36/77

**Хүн ба байгаль:** 7/22-25; 20/55; 23/79; 67/24; 71/17-20; 77/25-27

**Хүн егүүтгэх:** 4/29-30, 92-93; 5/32; 6/151; 17/33; 25/68-69

**Хүн төрөлхтний онцлог:** 2/204-207; 4/27-28; 7/181; 10/19; 11/118-119; 12/53; 14/34; 17/11, 67, 100; 18/54;

21/37; 30/8, 36; 31/6, 20; 42/48;  
43/15; 70/19-23; 76/2-3; 80/17-  
19; 82/6-7; 89/15-20; 90/4; 96/6-7;  
100/1-8; 103/1-3

**Хүндэтгэлтэй сарууд:** 2/194, 217; 5/2,  
97; 9/5, 36

**Хүний амьдралын үе шат:** 2/28;  
7/24-25; 16/70; 22/66; 30/11, 40;  
36/68; 45/25-26

**Хүний бий болох үе шат:** 2/28; 16/70,  
78; 18/37; 22/5; 23/12-16; 30/20, 54;  
32/5-9; 35/11; 36/68; 39/6; 40/67;  
46/15; 71/13-14; 75/36-39; 76/1-2;  
77/20-23; 80/17-20

**Хүний үхэх товлогдсон хугацаа:**  
3/145; 6/2; 7/34; 10/49; 15/4-5;  
16/61; 17/99; 23/43; 34/29-30;  
35/11; 39/42; 40/67; 63/10-11; 71/1-  
4

**Хүсэл залбиралын айлдварууд:** 1/6-  
7; 2/126-129, 200-201, 250, 285-  
286; 3/8-9, 15-17, 26-27, 35, 38, 52-  
53, 146-147, 191-194; 4/75; 5/24-25,  
82-83, 114; 7/22-23, 47, 88-89, 125-  
126, 151, 155-156; 10/84-85, 88-  
89; 11/45-47; 12/32-34, 101; 14/35-

41, 44; 17/24, 80; 18/9-10; 19/1-10;  
20/25-35, 113-114; 21/112; 23/26,  
28-29, 38-39, 93-94, 97-98, 117-118;  
26/83-89, 117-118, 168-169; 27/18-  
19; 28/15-17, 20-24; 29/30; 34/18-  
19; 37/99-100; 38/34-35; 39/46;  
40/7-9; 44/10-12; 46/15; 59/10;  
60/4-5; 66/8, 11; 71/26-28

**Хүсэл тачаалдаа автагсад:** 4/135;  
20/15-16; 25/43; 28/48-51; 30/29;  
38/26; 45/23; 47/14, 16

**Хүү авах:** 2/275-281; 3/130; 4/160-161;  
30/39

**Хүүхэд үрчилж авах:** 33/4-5

**Хэлнүүд:** 30/22

**Хэмжүүр:** 6/152; 7/85; 11/84-85; 17/35;  
21/47; 26/181-183; 42/17; 55/7-9;  
57/25

**Хэмжүүрээр залилан хийх:** 83/1-6

**Хэрээс хэтрэгсэд:** 2/190; 5/87; 10/74;  
20/125-127; 21/7-9; 26/150-  
152; 36/18-19; 43/5; 51/31-34

**Хэрээс хэтрэх:** 2/178, 190, 194, 231;  
3/112; 5/2, 87; 7/55

## Ц

**Цаазаар авах:** 2/178-179, 194; 25/68-  
69

**Цахилгаан аянга:** 2/19, 55; 13/13;  
41/13, 17; 51/44

**Цус:** 5/3

## Ч

**Чөтгөр шулам:** 4/116-120; 5/90-91;  
6/112, 142; 7/22, 27; 8/48; 12/5;  
15/31- 40; 16/98-99; 17/27, 53,  
61-64; 18/50-51; 22/52-53; 23/97-  
98; 25/29; 26/221-223; 28/15; 34/20;  
35/6; 36/60; 43/36; 59/16; 114/1-6

**Чөтгөр шуламыг анд найз бол-  
гох:** 35/176; 4/76, 119-121; 6/121;

7/27, 30; 16/63, 98- 100; 18/50;  
19/45; 22/3-4

**Чөтгөр шуламыг дагахыг хориглох:**  
2/168-169, 208; 6/142; 24/21; 43/62;  
22/3-4; 31/21

**Чөтгөр шуламын талыг баригсад:**  
35/6; 58/14-19

**Чөтгөр шуламын хүмүүнд дайсагнал:** 3/175; 6/112, 142; 7/22, 27; 8/48; 12/5; 14/22; 15/34-35; 16/98-100; 17/27, 53, 61-64; 18/50; 19/44, 83; 22/52-53; 23/97-98; 25/29; 26/221-223; 28/15; 34/20; 36/60; 38/74-82; 43/36-38; 59/16; 67/5; 114/1-6

**Чулуун хөшөө:** 5/3, 90

### Ш

**Шагшин магтах:** 1/2; 6/1, 44-45; 7/42-43; 10/9-10; 14/39; 15/97-99; 16/75; 17/50-52, 110-111; 23/26-28; 27/15, 59, 93; 28/70; 29/63; 30/17-18; 31/25; 34/1; 35/1, 34; 37/180-182; 39/29, 73-75; 40/7, 53-55, 65; 42/5; 45/36; 52/48-49; 64/1; 110/1-3

44; 26/176-191; 29/36-37; 38/12-14; 50/12-14

**Шударга бус ашиг олох:** 2/188; 4/29-31, 160-161; 9/34

**Шударга ёс:** 2/282; 4/58, 135; 5/8, 42; 6/115; 7/29, 159, 181; 16/90; 38/26; 42/15; 57/25; 60/8

**Шашин нэгт ахан дүүс:** 9/11; 33/5

**Шударга ёсын давуу тал:** 7/117-118; 8/7-8; 17/81; 21/17-18; 34/48-49; 42/24

**Шашин, сүсэг бишрэлээ Аллахад зонулах:** 4/145-146; 7/29; 39/2-3, 11-14; 40/13-14, 65; 98/4-5

**Шударга номхон байх:** 1/6, 8; 3/51, 100-101; 4/66-68, 174-175; 5/15-16; 6/126, 153, 161; 10/88-89; 11/56, 112; 14/1; 15/41-48; 16/9, 67; 19/23-24, 54; 42/14-15; 44/6, 30-32; 46/13-14; 81/27-28

**Шашинаас урвагсад:** 2/217; 5/54; 16/105-106

**Шашинаас урвах:** 2/217; 4/137; 5/54; 16/106-109; 47/25

**Шашинд албадах:** 2/256

**Шүлэг яруу найрагч:** 26/224-227; 36/69

**Шивэгчин боол:** 4/25, 36; 16/71; 23/6; 24/32-33; 70/30; 90/13

**Шоглох:** 2/212; 6/10; 9/79; 11/38; 21/41; 49/11 **Шоргоолж:** 27/18-19

**Шүүн тунгаах Аллахынх:** 12/39-40, 67; 13/41; 28/70, 88; 30/1-5; 40/11-12

**Шөнийн уншлага мөргөл:** 25/63-64; 32/15-16; 39/9; 51/17-18; 73/1-4, 20; 76/26

**Шүүн тунгаах, тооцоо бодох:** 2/284; 7/6; 13/40; 14/51; 21/1, 47; 23/117; 24/39; 26/112-113; 29/12-13; 33/7-8, 38-39; 51/5-6; 55/31-32; 65/8; 78/27; 82/15, 17; 84/8; 88/26; 102/8; 107/1-3

**Шугайб (гэгээн элч):** 7/85-93; 9/70; 11/84-95; 15/78-79; 22/42-

### Э

**Эв нэгдэл:** 3/103-105; 8/46

**Эдгэрэх, илаарших:** 26/75-80

**Эвлэрүүлэх:** 2/180-182; 4/34-35, 114, 129; 8/1; 49/9-10

**Эзэнтэн (Аллах):** 1/2; 2/105, 139; 3/51; 5/28, 112, 117; 6/45, 71, 102, 161-162, 164; 7/61, 67-68, 104, 121-122, 134, 172-174, 203; 10/3, 10, 32-

**Эд хөрөнгийн шунал:** 89/15-20; 100/6-8

- 33, 37, 94; 11/34, 56-57, 61, 66, 83, 88, 90, 118-119; 12/6, 24, 37, 53, 98, 100-101; 13/6, 16, 18, 27, 30; 14/39; 15/25, 28, 86, 98-99; 16/7, 24, 30, 33, 47, 55, 102, 119, 125; 17/25, 46, 57, 65-66, 102; 18/14, 22-24, 38, 58, 87; 19/1-4, 39, 46-48, 64-65; 20/12, 51-52, 67-70, 83-84, 90; 21/1-4, 55, 89, 92, 112; 22/1, 67, 77; 23/52, 57-59, 86, 93-94, 116; 25/74-75, 77; 26/9, 23-28, 47-48, 68, 77, 104, 109, 122, 127, 140, 145, 159, 164, 175, 180, 188, 191-192; 27/8, 26, 40, 73-74, 78, 93; 28/16-17, 21-22, 30, 33, 37, 53, 63, 68-69, 87; 29/26, 30; 31/33; 32/2-3, 25; 33/2; 34/19, 23, 26, 48, 50; 35/13, 18, 37; 36/16, 25, 27; 37/5, 84, 126, 180, 182; 38/9, 35, 41, 66, 71; 39/6, 10, 31, 54-55, 69, 73; 40/7-8, 11, 27-28, 55, 60, 62-66; 41/9, 14, 23, 30, 38, 43; 42/5, 10, 15-16, 22; 43/46, 64, 82; 44/6-7, 20, 22, 57; 45/17, 30, 36; 46/13, 34; 51/30; 52/7, 48; 53/55; 55/13, 16, 18, 21; 56/74, 96; 57/8, 21; 59/16; 66/5, 11-12; 68/2, 7, 19, 29, 32, 48-50; 69/43, 52; 70/27-28, 40; 72/2-3, 10, 13, 17, 20, 25, 28; 73/8-9, 20; 74/3, 7; 75/12, 30; 76/24-25, 29; 78/36-38; 79/16, 40, 44; 81/29; 82/6; 83/6, 15; 84/6, 15; 85/12; 87/1, 15; 92/19; 93/3, 11; 94/8; 96/1, 3, 8; 97/4; 98/8; 99/5; 100/6, 11; 105/1; 106/3; 108/2; 110/3; 113/1; 114/1
- Эмэгтэйчүүд:** 2/49, 187, 222-232, 235-237; 3/14, 42; 4/1, 3-4, 7, 11, 19, 22, 24, 32, 34, 43, 75, 98, 127, 129, 176; 5/6; 7/81; 24/31, 60; 27/55
- Эмэгтэйчүүдийн махрам (сахих зүйл):** 33/55
- Эмэгтэйчүүдийн эрх:** 2/228-229, 233, 237; 4/19-21, 127; 6/139; 16/58-59; 43/17; 65/6; 81/8-9
- Энэ хорвоогийн амьдрал:** 3/185; 4/77; 6/32; 10/24; 13/26; 18/7-8, 45; 29/64; 40/38-39; 47/36; 57/20
- Энэ хорвоогийн амьдралыг сонгогчид:** 3/145; 4/134; 11/15-16; 17/18; 28/79-82; 42/20; 53/29; 79/36-39
- Энэрэнгүй зан:** 3/159; 6/12; 17/24; 19/13; 30/21; 48/29; 90/12-17
- Эргэлзээ, бодол:** 10/35-36; 49/12; 53/19-30
- Эрдэм мэдлэг:** 6/80-81, 97-98, 104-105; 7/32; 10/5, 55; 12/68; 16/38, 43; 21/7; 23/84-85, 88-89; 27/50-52; 28/57; 29/64; 30/1-7, 22, 30; 31/25; 34/28, 36; 39/25-26, 49-50; 40/57; 41/1-3; 44/38-39, 45/25-26, 32-34; 52/45-47; 61/10-11; 62/9; 68/33; 71/1-4
- Эрдэмтэд:** 3/7, 18; 4/162; 17/107; 22/54; 28/80; 29/43; 35/28; 39/9; 58/11
- Эрдэс, уурхай:** 13/17; 16/12-13; 57/25
- Эрхтэний гэрчлэл:** 24/23-24; 36/63-65; 41/19-23; 75/14-15
- Эрэгцүүлэн бодох:** 2/219; 3/190-191; 6/50; 7/176; 10/24; 13/3; 16/11, 44, 68-69; 30/8, 21; 39/42; 45/13; 59/21
- Эхнэр нь төлөөс төлж гэр бүл саллт:** 2/229
- Эхнэртэй ойртохгүй хэмээн андгайлах:** 2/226-227 **Эхнэр нөхрийн хайрлал:** 7/189; 30/21
- Эцсийн эцэст очих газар нь Аллахийн өмнө:** 2/28, 45-46, 223, 245, 285; 3/28, 54-55, 83; 5/18, 48, 105; 6/36, 60-62, 108, 164; 7/123-125; 9/94, 105; 10/4, 22-23, 30, 46, 55-56, 69-70; 11/4, 29, 34, 88; 13/30, 36; 19/40; 21/35, 92-95; 22/48; 23/60, 115; 24/64; 26/49-50;

28/38- 39, 70, 88; 29/16-17, 21-22, 57; 30/11; 31/14-15, 22-23; 32/10-11; 35/18; 36/20-22, 31-32, 53, 82-83; 39/7, 43-44; 40/43, 77; 41/19-21; 42/10, 14-15; 43/12-14, 84-85; 45/15; 50/43; 53/39- 42; 60/4; 62/6-8; 64/3; 75/26-30; 88/25-26; 96/6-8

**Эцэг эхийн ачийг хариулах:** 2/83, 180, 215; 4/36; 6/151; 13/19-21, 25; 17/23- 25; 29/8; 31/14-15; 46/15; 47/22-23

**Эцэг эхээ эсэргүүцэж болох уу?:** 29/8; 31/15

## Ю

**Юнус (гэгээн элч):** 4/163; 6/85-86; 10/98; 21/87-88; 37/123-148

**Юсуф (гэгээн элч):** 6/84, 12/4, 7-11, 17, 21, 29, 46, 51, 56, 58, 69, 76-77, 80, 84-85, 87, 89-90, 94, 99; 40/34

## Я

**Якуб (гэгээн элч):** 2/132-133, 136, 140; 3/84; 4/163; 6/84; 11/71; 12/4, 11, 16-17, 38, 61, 63, 68, 78, 93-94, 97, 100; 19/49-50, 58; 21/72; 29/27; 38/45-47

**Якубын гэр бүл:** 12/4-6; 19/1-6

**Ярилцах дэг ёс:** 2/104; 4/44-46, 114; 49/1-5, 11-12

**Яжуж Мажуж:** 18/94; 21/96 **Яхия (гэгээн элч)** 3/38-39; 6/85; 19/7, 12-15; 21/89-90





